



Мормоны Номыг

гэрээр судлах семинарын суралцагчдын удирдамж

Мормоны Номыг

гэрээр судлах семинарын суралцагчдын удирдамж

Есүс Христийн Хожмын Үеийн
Гэгээнтнүүдийн Сүмээс
хэвлэв
Юта муж, Солт Лэйк Сити хот

Санал хүсэлт ба залруулгыг талархалтайгаар хүлээн авна. Та өөрийн саналаа дараах хаягаар илгээнэ үү:

Seminaries and Institutes of Religion Curriculum Services

50 East North Temple Street
Salt Lake City, UT 84150-0008
USA

Email: ces-manuals@ldschurch.org

Нэр, хаяг, тойрог ба гадсаа бүрэн гүйцэд бичнэ үү.

Мөн гарын авлагынхаа нэрийг бичээрэй. Дараа нь санал хүсэлтээ бичнэ үү.

© 2012 он Intellectual Reserve, Inc.

Бүх эрх хамгаалагдсан

Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв

Англи эхийн зөвшөөрөл: 10/09

Орчуулгын зөвшөөрөл: 10/09

Орчуулга *Book of Mormon Study Guide for Home-Study Seminary Students*

Mongolian

09410 363

Гарчиг

Гэрээр судлах семинарын хөтөлбөрийн оршил v	3 дахь өдөр 2 Нифай 21–24 70
Энэхүү гарын авлагыг өдөр тутмын семинарын хөтөлбөрт ашиглах нь v	4 дэх өдөр 2 Нифай 25 72
Гэрээр судлах суралцагчийн гарын авлагыг ашиглах нь vi	8-р хэсэг
Мормоны Номыг унших хүснэгт viii	1 дэх өдөр 2 Нифай 26–27 75
Мормоны Номонд тавтай морилно уу ix	2 дахь өдөр 2 Нифай 28 77
Мормоны Номын түүхэн он дараалал x	3 дахь өдөр 2 Нифай 29–30 80
Мормоны Номонд гардаг газрууд xi	4 дэх өдөр 2 Нифай 31 83
1-р хэсэг	9-р хэсэг
1 дэх өдөр Судруудыг судлах нь 1	1 дэх өдөр 2 Нифай 32 86
2 дахь өдөр Авралын төлөвлөгөө 4	2 дахь өдөр 2 Нифай 33 89
3 дахь өдөр Нүүр хуудас, оршил ба гэрчүүдийн гэрчлэл . 7	<i>Иаковын номын оршил</i> 92
4 дэх өдөр Мормоны Номын ерөнхий тойм 9	3 дахь өдөр Иаков 1–2 92
2-р хэсэг	4 дэх өдөр Иаков 3–4 95
1 <i>Нифайн номын оршил</i> 13	10-р хэсэг
1 дэх өдөр 1 Нифай 1 13	1 дэх өдөр Иаков 5–6 97
2 дахь өдөр 1 Нифай 2 15	2 дахь өдөр Иаков 7 101
3 дахь өдөр 1 Нифай 3–4 18	<i>Иносын номын оршил</i> 104
4 дэх өдөр 1 Нифай 5–6; 9 21	3 дахь өдөр Инос 104
3-р хэсэг	<i>Жеромын номын оршил</i> 107
1 дэх өдөр 1 Нифай 7 23	<i>Омнайн номын оршил</i> 107
2 дахь өдөр 1 Нифай 8 25	4 дэх өдөр Жером ба Омнай 108
3 дахь өдөр 1 Нифай 10–11 28	11-р хэсэг
4 дэх өдөр 1 Нифай 12–14 31	<i>Мормоны Үгс номын оршил</i> 111
4-р хэсэг	<i>Мозаягийн номын оршил</i> 111
1 дэх өдөр 1 Нифай 15 34	1 дэх өдөр Мормоны Үгс–Мозая 2 112
2 дахь өдөр 1 Нифай 16 37	2 дахь өдөр Мозая 3 116
3 дахь өдөр 1 Нифай 17 39	3 дахь өдөр Мозая 4 118
4 дэх өдөр 1 Нифай 18–19 41	4 дэх өдөр Мозая 5–6 120
5-р хэсэг	12-р хэсэг
1 дэх өдөр 1 Нифай 20–22 44	1 дэх өдөр Мозая 7–8 122
2 <i>Нифай номын оршил</i> 47	2 дахь өдөр Мозая 9–10 126
2 дахь өдөр 2 Нифай 1 47	3 дахь өдөр Мозая 11–14 128
3 дахь өдөр 2 Нифай 2 49	4 дэх өдөр Мозая 15–17 131
4 дэх өдөр 2 Нифай 3 51	13-р хэсэг
6-р хэсэг	1 дэх өдөр Мозая 18 134
1 дэх өдөр 2 Нифай 4–5 54	2 дахь өдөр Мозая 19–20 136
2 дахь өдөр 2 Нифай 6–8 56	3 дахь өдөр Мозая 21–24 139
3 дахь өдөр 2 Нифай 9 58	4 дэх өдөр Мозая 25 141
4 дэх өдөр 2 Нифай 9–10 61	14-р хэсэг
7-р хэсэг	1 дэх өдөр Мозая 26 144
1 дэх өдөр 2 Нифай 11–16 64	2 дахь өдөр Мозая 27 146
2 дахь өдөр 2 Нифай 17–20 66	3 дахь өдөр Мозая 28–29 149
	<i>Алмагийн номын оршил</i> 152
	4 дэх өдөр Алма 1–4 152

15-р хэсэг	3 дахь өдөр 3 Нифай 6–10	256
1 дэх өдөр Алма 5:1–36	4 дэх өдөр 3 Нифай 11:1–17	259
2 дахь өдөр Алма 5:37–62	25-р хэсэг	
3 дахь өдөр Алма 6–7	1 дэх өдөр 3 Нифай 11:18–12:48	262
4 дэх өдөр Алма 8–10	2 дахь өдөр 3 Нифай 13	266
16-р хэсэг	3 дахь өдөр 3 Нифай 14	268
1 дэх өдөр Алма 11	4 дэх өдөр 3 Нифай 15–16	271
2 дахь өдөр Алма 12	26-р хэсэг	
3 дахь өдөр Алма 13	1 дэх өдөр 3 Нифай 17	273
4 дэх өдөр Алма 14–16	2 дахь өдөр 3 Нифай 18	276
17-р хэсэг	3 дахь өдөр 3 Нифай 19	278
1 дэх өдөр Алма 17–18	4 дэх өдөр 3 Нифай 20–22	281
2 дахь өдөр Алма 19–20	27-р хэсэг	
3 дахь өдөр Алма 21–22	1 дэх өдөр 3 Нифай 23	284
4 дэх өдөр Алма 23–24	2 дахь өдөр 3 Нифай 24–26	286
18-р хэсэг	3 дахь өдөр 3 Нифай 27	289
1 дэх өдөр Алма 25–29	4 дэх өдөр 3 Нифай 28–30	291
2 дахь өдөр Алма 30	28-р хэсэг	
3 дахь өдөр Алма 31	4 Нифай номын оршил	294
4 дэх өдөр Алма 32	1 дэх өдөр 4 Нифай	294
19-р хэсэг	Мормоны номын оршил	297
1 дэх өдөр Алма 33–35	2 дахь өдөр Мормон 1–2	297
2 дахь өдөр Алма 36	3 дахь өдөр Мормон 3–6	300
3 дахь өдөр Алма 37	4 дэх өдөр Мормон 7:1–8:11	302
4 дэх өдөр Алма 38	29-р хэсэг	
20-р хэсэг	1 дэх өдөр Мормон 8:12–41	305
1 дэх өдөр Алма 39	2 дахь өдөр Мормон 9	307
2 дахь өдөр Алма 40–41	Иферийн номын оршил	311
3 дахь өдөр Алма 42	3 дахь өдөр Ифер 1–2	311
4 дэх өдөр Алма 43–44	4 дэх өдөр Ифер 3	314
21-р хэсэг	30-р хэсэг	
1 дэх өдөр Алма 45–49	1 дэх өдөр Ифер 4–5	317
2 дахь өдөр Алма 50–52; 54–55	2 дахь өдөр Ифер 6	319
3 дахь өдөр Алма 53; 56–58	3 дахь өдөр Ифер 7–11	320
4 дэх өдөр Алма 59–63	4 дэх өдөр Ифер 12	323
22-р хэсэг	31-р хэсэг	
Хиламаны номын оршил	1 дэх өдөр Ифер 13–15	325
1 дэх өдөр Хиламан 1–2	Моронайн номын оршил	328
2 дахь өдөр Хиламан 3–4	2 дахь өдөр Моронай 1–5	328
3 дахь өдөр Хиламан 5	3 дахь өдөр Моронай 6	331
4 дэх өдөр Хиламан 6–9	4 дэх өдөр Моронай 7:1–19	333
23-р хэсэг	32-р хэсэг	
1 дэх өдөр Хиламан 10	1 дэх өдөр Моронай 7:20–48	336
2 дахь өдөр Хиламан 11–12	2 дахь өдөр Моронай 8–9	338
3 дахь өдөр Хиламан 13–14	3 дахь өдөр Моронай 10:1–7, 27–29	341
4 дэх өдөр Хиламан 15–16	4 дэх өдөр Моронай 10:8–26, 30–34	344
24-р хэсэг		
3 Нифай номын оршил		
1 дэх өдөр 3 Нифай 1		
2 дахь өдөр 3 Нифай 2–5		

Гэрээр судлах семинарын хөтөлбөрийн оршил

Гэрээр судлах семинарын хөтөлбөр нь Есүс Христийн сайн мэдээг ойлгох ойлголтыг тань хүчирхэгжүүлж мөн судраас суралцсанаар сургаалыг өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлэхэд тань туслахад чиглэсэн юм. Энэ хичээлийн жилд та эхлээд Мормоны Номын энэ курст зориулсан судраас унших даалгавруудыг гүйцээж, дараа нь бие даан хийх хичээлүүдийг хийж дуусгана. Та долоо хоногт нэг удаа семинарын багштайгаа уулзаж хийсэн даалгавраа шалгуулан долоо хоног тутмынхаа хичээлд оролцоно.

Семинар бол өдөр тутмын шашны боловсролын хөтөлбөр юм. Судраас залбиралтайгаар судлахыг өдөр тутмынхаа дадал зуршил болгох хэрэгтэй. Хэдийгээр та өдөр бүр семинарын ангид хамрагдахгүй ч, хичээлийн бүх өдрүүдэд семинарын гэрийн даалгавраа хийх хэрэгтэй. Энэ курсийн турш хийж гүйцэтгэх 32 хэсэг байгаа. viii хуудсан дээр байгаа унших хүснэгт нь хэсэг тус бүрээс юу судлах хэрэгтэйг харуулна. Багш тань хэсэг тус бүр хэзээ дууссан байх ёстойг мэдэхэд тань тусална. Танд өдөр тутмын судрын уншлагаас гадна энэхүү судлах удирдамжид байгаа хичээлүүдийг хийж дуусгахад ойролцоогоор 30 минут зарцуулагдана.

Таны хувийн тэмдэглэлээс гадна танд судлах удирдамжийн үйл ажиллагаануудаас даалгавруудыг

бичих хоёр судар судлах тэмдэглэл (эсвэл хоёр дэвтэр) байх хэрэгтэй. Багштайгаа уулзах долоо хоног бүрдээ өнгөрсөн долоо хоногт судлах удирдамжийн үйл ажиллагаанаас судар судлах тэмдэглэлийн дэвтэр дээр хийсэн даалгавраа хураалгана. Багш таны даалгавруудыг уншиж шалгаад судар судлах тэмдэглэлийн дэвтрийг тань дараагийн долоо хоногт буцааж өгнө. Та хариултуудаа хуудас нь салдаг хавтастай дэвтэр дээр бичиж болох ба өнгөрсөн долоо хоногт цаасан дээр хийсэн даалгавруудаа хураалгаж болно. Дараа нь багш тань цааснуудыг буцааж өгөхөд та тэднийг хавтсандаа буцаан хийж болно.

Энэхүү гарын авлагыг өдөр тутмын семинарын хөтөлбөрт ашиглах нь

Багш ба суралцагчид энэ гарын авлагыг хичээлээ баяжуулах эсвэл үйл ажиллагаа зохиох зорилгоор өдөр тутмын семинарын хөтөлбөртөө ашиглаж болно. Гэсэн хэдий ч, энэ нь өдөр тутмын семинарын бүх суралцагчдад зориулагдаагүй юм. Хэрвээ суралцагч хичээл нөхөх хэрэгтэй бол багш нь гэрээр судлах хичээлээс нь нөхөх хичээлд тохирох даалгавруудыг хийлгэхээр өгч болно.

Гэрээр судлах суралцагчийн гарын авлагыг ашиглах нь

Төгс эзэмших судар

Мормоны Номонд байдаг 25 төгс эзэмших судрын хэсэг бүрийг тэдгээрийг илүү гүн гүнзгий эзэмшихэд туслах зорилгоор хичээлүүдэд нэг нэгээр нь оруулсан.

Судрын агуулгын оршил

Оршил нь хичээл бүрд зориулсан тухайн судрын агуулгын талаарх үндсэн мэдээлэл ба тоймыг агуулдаг.

Бүлэг шүлэг ба агуулгын тойм

Бүлэг шүлэг нь үйл явдал эсвэл сэдвийн өөрчлөлт гарах үед таслахыг илэрхийлдэг. Бүлэг шүлэг бүр гарч байгаа сургаал эсвэл үйл явдлуудын товч тоймыг багтаасан.

Гарын авлага дээр хариултуудыг тэмдэглэх нь

Зарим үед гарын авлага дээр өгөгдсөн хоосон зай эсвэл хүснэгтэд хариултаа бичих даалгаврууд тааралдаж болно.



6. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би 1 Нифай 2-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

2-Р ХЭСЭГ: 3 ДАХЬ ӨДӨР

1 Нифай 3–4

Оршил

Их Эзэн Лихайд, хөвгүүдээ Иерусалим руу буцаан явуулж, Лебенээс гуулин ялтсуудыг авчруул хэмээн зарлиг өгөв. Лемен Лемүел хоёр энэ зарлигийг хэрхэн биелүүлэхийг мэдэхгүй байсан бол Нифай, Их Эзэн шаардсан зүйлээ биелүүлэх арга замаар хангана гэдэгт итгэлтэй байлаа. Удаа дараа бэрхшээл тохиолдсон ч Нифай Их Эзэний хүссэн зүйлийг биелүүлэхийн төлөө итгэлтэйгээр үргэлжлүүлэв. Тэгсний үр дүнд тэр Ариун Сүнсээр удирдуулж, ялтсуудыг олж авч чадсан билээ. Шаргуу дуулгавартай байдал, хүнд үед Их Эзэний тусламжийг авахад биднийг тэнцэхээр болгодгийг Нифайн туршлага харуулж байна.

1 Нифай 3:1–9, 19–20

Лихайн хөвгүүд Иерусалимд буцаж очсон нь

Хүнд байдалтай тулгарч үүнийг хэрхэн шийдвэрлэхийг мэдэхгүй үе танд тохиолдож байсан уу? Өнөөдрийн хичээл, хүнд сорилттой тулгарсан үед итгэлээ бэхжүүлж, шийдвэр төгс, дуулгавартай байхад тань туслах болно. 1 Нифай 3:1–6-г уншиж хичээлээ эхэл. Их Эзэн Лихайгаар дамжуулан хөвгүүдэд нь өгсөн зарлигийг судартаа тэмдэглэ. Мөн Лемен Лемүел хоёр, Их Эзэний зарлигт Нифайн хандлагын эсрэг хэрхэн хандсаныг анхаар.

Их Эзэний зарлиг болгосон зүйл үнэхээр хэцүү байсныг ойлгохын тулд Иерусалимаас Улаан тэнгис (Акабагийн булан) хүртэл 290 км хол газар, дээрэмчид орогносон, хуурай, халуун цөлийг гатлах шаардлагатай байсныг мэдэх нь ашиг тустай байж болно. Лихай болон түүний гэр бүл энэ газраас яваад гурван өдөр өнгөрч (1 Нифай 2:5–6) байтал Их Эзэн хөвгүүдийг нь Иерусалим руу буцах хэрэгтэй гэж хэлсэн ажээ. 1 Нифай 3:7–8-ыг уншиж, Нифай Их Эзэний зарлигийг дуулгавартай дагах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн шалтгааныг ол.

Хэрэв бид Их Эзэний зарлигийг биелүүлдэл Тэр үүнийг гүйцэлдүүлэх арга замыг бэлтгэх болно гэсэн зарчмыг Нифай гэрчилсэн юм.

1 Нифай 3-ыг үргэлжлүүлэн судлахдаа Нифайн эр зориг, шийдвэр төгс байдлын үлгэр жишээ нь илүү дуулгавартай байж, Их Эзэнд итгэх агуу итгэлээ харуулахад маань хэрхэн сүнслэгээр нөлөөлж болох тухай бод. Нифай, хүнд сорилт бэрхшээлүүдэд хэрхэн хандаж байсанд анхаарлаа онцгойлон хандуул. Ах нарынхаа хамт гуулин ялтсуудыг олж авах үед Нифайд бэрхшээл тохиолдсон ч тэр дургүйцэж, үглэн гомдоллоогүй юм (1 Нифай 3:6).

Гуулин ялтсууд тэдний судар болох “Иудейчүүдийн цэдгийг” (1 Нифай 3:3) агуулж байжээ. Гуулин ялтсууд эдүгээ Хуучин Гэрээнд байдаг зарим бичээсүүд болон мэдээллийг түүнчлэн бошигтолын бусад бичээсүүдийг агуулж байжээ. 1 Нифай 3:19–20-ийг уншиж, гуулин ялтсуудыг Лихайн гэр бүл болон тэдний үр удмынханд тийм их ач холбогдолтой болгосон зүйлсийн доогуур зур.

Төгс эзэмших судар—1 Нифай 3:7

1 Нифай 3:7-г гурван удаа унш (өхөлж чанга уншаад дараа нь чимээгүй унших зэргээр унших байдлаа өөрчилж болно). Судраа хаагаад, шүлгийг харалгүйгээр дараах асуултаудад хариулж бичихийг хичээ:

- Нифай хэнд хандаж ярьсан бэ? _____
- Нифай юу хийхээр шийдсэн бэ? _____
- Их Эзэн яана гэдгийг Нифай мэдэж байсан бэ? _____

Судраа нээгээд 1 Нифай 3:7-г уншиж, хариултаа шалга.

Бошиглогч Иосеф Смит ийн хэлжээ: “Их Эзэн зарлигласан л бол үүнийг биелүүл гэдэг дүрмийг би өөртөө бий болгосон юм” (*History of the Church*, 2:170). Энэ өгүүлбэрийг судартаа 1 Нифай 3:7-гийн дэргэд бич.

1 Нифай 3:10–31

Лебен Лихайн өмчийг хулгайлж, Нифай болон ах нарыг нь алахыг оролдсон нь

Бид Бурханы зарлигуудыг сахих үед Тэр биднийг олон янзын арга замаар адисалдаг. Гуулин ялтсуудыг олж авсан Нифайн туршлага нь Бурхан хүүхдүүдэд зарлигуудыг нь биелүүлэх арга замаар хангадаг гэсэн түүний гэрчлэлийг баталж байна (1 Нифай 3:7-г үзнэ үү). Гуулин ялтсуудыг олж авах гэсэн Лихайн хөвгүүдийн эхний хоёр удаагийн оролдлогыг

үүний бүх адислалыг одоо болон ирээдүйд хүлээн авахын тулд юу хийх ёстойгоо тунгаан бод. Эдгээр адислалуудыг авахын тулд ямар саад бэрхшээлдүүдийг даван туулах хэрэгтэйгээ тунгаан бод.

Хичээлдээ дуу хөгжим оруул

"Дууллууд Их Эзний Сүнснийг урьж," "хүндэтгэлийн мэдрэмжийг бий болгодог" (Нутлс, ix) хэмээн Тэргүүн Зөвлөл заасан билээ. Дуулыг дуулах эсвэл сонсох нь суралцаж байгаа газарт тань тохиромжгүй бол дуулын үгсийг уншиж, дотроо бодох нь үр өгөөжтэй байж болно.

Их Эзэнд ойр дотно болж, өөрийн амьдрал дахь Түүний хайрыг илүү их хүчтэйгээр мэдрэхийн тулд хийх ёстой болон зайлсхийх ёстой зүйлсээ олж мэд.

1 Нифай 8:2-ыг уншиж, цөлд байхдаа Лихайн биеэрээ үзэж туулсан зүйлсийг тодорхойл. 1 Нифай 8:5–12-ыг уншаад Лихайн зүүдний гол тусгал эсвэл анхаарал татсан зүйлийг ол.



Лихайн зүүдний гол тусгалыг олсны дараа 1 Нифай 8:10–11-т амьдралын модны жимснийг дүрслэхэд

1 Нифай 8:1–18

Лихай амьдралын модны жимснээс идсэнийхээ дараа гэрийнхнийгээ мөн үүнээс идэхэд урьжээ.

Таныг хайрласан Их Эзний хайрыг мэдрсэн үеийнхээ тухай бод. Таны хийдэг сонголтууд Их Эзэнд ойр дотно байх болон Түүний хайрыг мэдрэх чадварт тань хэрхэн нөлөөллийг тунгаан бод. 1 Нифай 8-

ыг судлахдаа энэ бүлэг

Лихайн ашигласан үг хэллэгүүдийг жагсаан бич. ____

Их Эзэн, мөнхийн үнэнүүдийг ойлгоход туслахын тулд бидний мэдэх юмсыг бэлгэдлүүдээр олонгоо дүрсэлдэг. Лихайн зүүдэн дэх мод жимс хоёр юуг төлөөлснийг ойлгохын тулд Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Нийл А.Максвэллийн дараах үгийг унш: "Амьдралын мод бол... Бурханы хайр юм (1 Нифай 11:25-ыг үзнэ үү). Есүсийг бидний Гэтэлгэгчээр Өөрийн бэлэг болгон өгсөнд Бурханы хүүхдүүдээ хайрлах хайр хамгийн гүнзгийгээр илэрдэг: 'Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан тул цорын ганц Хүүгээ өгсөн' (Иохан 3:16). Бурханы хайрыг хүртэнэ гэдэг бол Есүсийн Цагаатгал, [нүгэл хилэнцээс чөлөөлсөн] Түүний чөлөөлөлт, үүнийг авчирдаг баяр баясгалангаас хүртэнэ гэсэн үг юм "Lessons from Laman and Lemuel," *Ensign*, 1999 оны 11-р сар, 8).

1 Нифай 8:10–12-т дүрсэлсэн сайн мэдээний нэгэн зарчмыг тодорхойлохын тулд 1 Нифай 8:11-ээс Лихай жимсийг яасныг мөн 1 Нифай 8:12-оос үүний үр дүнг олж доогуур нь зур. Лихай жимсийг "хүртсэн" шиг өөрөө Цагаатгалаас "хүртэж болох арга замуудын тухай бод."

Есүс Христэд ирж, Түүний Цагаатгалаас хүртэх нь аз жаргалд хүргэдгийг Лихайн туршлага харуулж байна.

1. Дараах асуултад судрын тэмдэглэлдээ хариулж бич: Аврагчийн Цагаатгал таны амьдралд аз жаргал, баяр баясгаланг хэзээ авчирсан бэ?

Цагаатгалын адислалуудыг өөрсдөө хүртсэний дараа бид яагаад Лихай шиг, өөрсдийн гэр бүл, найз нөхдийг тэдгээр адислалуудыг хүртээсэй хэмээн хүсэх хэрэгтэйг тунгаан бод. 1 Нифай 8:3–4, 13–18-ыг уншиж, Лихайн гэр бүлийн гишүүд амьдралын модны жимснээс хүртэх Лихайн урилгад хэрхэн хандсаныг ол.

Бусад хүмүүс Бурханы үгнээс хүртэхээр сонгох эсэхийг бид шийдэж чадахгүй. Гэвч бид Лихайн адил тэднийг урьж, урамшуулан дэмжиж чадна. Таньдаг хэн нэгнээ Христэд ирж, Түүний Цагаатгалын адислалуудыг хүлээн авахад хэрхэн урьж, урамшуулан дэмжих тухай бод.

1 Нифай 8:19–35

Зарим хүмүүс амьдралын мод руу тэмүүлж, жимснээс нь хүртэхэд амжилт олж байхад бусад нь бүтэлгүйтэж байхыг Лихай харжээ.

Та нар амьдралын модны тухай үзэгдэл Нифайд хэрхэн үзүүлэгдсэн тухай 1 Нифайгаас дараа унших

Судлах тусламжууд

Судлах тусламж нь санаа өгч таны судар судлах болон ойлголтыг баяжуулах дасгал ажлуудыг тайлбарладаг.

Судар судлах тэмдэглэлийн даалгаврууд

Судар судлах тэмдэглэл дээр даалгавруудыг хийж багшийнхаа санал зөвлөгөөг авахын тулд долоо хоног бүр хураалгана. Хариултуудаа сайтар тунгаан бодох нь судруудаас суралцаж, үнэнийг амьдралдаа хэрэгжүүлснээр утга учиртай туршлагыг олж авахад тань тусална.

Сургаалууд ба зарчмууд

Судраас сайн мэдээний сургаалууд болон зарчмууд гарах үед, тэдгээрийг танихад танд туслах үүднээс тодруулсан.

Мормоны Номыг унших хүснэгт

Хэсгийн дугаар	Энэ долоо хоногт уншсан бүлгүүд	Судар уншсан өдрүүд						
1	Нүүр хуудас Оршил Гурван гэрчийн гэрчлэл Найман гэрчийн гэрчлэл Бошиглогч Иосеф Смитийн гэрчлэл Мормоны Номын тухай товч танилцуулга	Ня	Да	Мя	Лх	Пү	Ба	Бя
2	1 Нифай 1 2 3 4 5 6 9	Ня	Да	Мя	Лх	Пү	Ба	Бя
3	1 Нифай 7 8 10 11 12 13 14	Ня	Да	Мя	Лх	Пү	Ба	Бя
4	1 Нифай 15 16 17 18 19	Ня	Да	Мя	Лх	Пү	Ба	Бя
5	1 Нифай 20 21 22 2 Нифай 1 2 3	Ня	Да	Мя	Лх	Пү	Ба	Бя
6	2 Нифай 4 5 6 7 8 9 10	Ня	Да	Мя	Лх	Пү	Ба	Бя
7	2 Нифай 11 12 13 14 15 16 17 18 19 20 21 22 23 24 25	Ня	Да	Мя	Лх	Пү	Ба	Бя
8	2 Нифай 26 27 28 29 30 31	Ня	Да	Мя	Лх	Пү	Ба	Бя
9	2 Нифай 32 33 Иаков 1 2 3 4	Ня	Да	Мя	Лх	Пү	Ба	Бя
10	Иаков 5 6 7 Инос 1 Жером 1 Омнаи 1	Ня	Да	Мя	Лх	Пү	Ба	Бя
11	Мормоны Үгс 1 Мозая 1 2 3 4 5 6	Ня	Да	Мя	Лх	Пү	Ба	Бя
12	Мозая 7 8 9 10 11 12 13 14 15 16 17	Ня	Да	Мя	Лх	Пү	Ба	Бя
13	Мозая 18 19 20 21 22 23 24 25	Ня	Да	Мя	Лх	Пү	Ба	Бя
14	Мозая 26 27 28 29 Алма 1 2 3 4	Ня	Да	Мя	Лх	Пү	Ба	Бя
15	Алма 5 6 7 8 9 10	Ня	Да	Мя	Лх	Пү	Ба	Бя
16	Алма 11 12 13 14 15 16	Ня	Да	Мя	Лх	Пү	Ба	Бя
17	Алма 17 18 19 20 21 22 23 24	Ня	Да	Мя	Лх	Пү	Ба	Бя
18	Алма 25 26 27 28 29 30 31 32	Ня	Да	Мя	Лх	Пү	Ба	Бя
19	Алма 33 34 35 36 37 38	Ня	Да	Мя	Лх	Пү	Ба	Бя
20	Алма 39 40 41 42 43 44	Ня	Да	Мя	Лх	Пү	Ба	Бя
21	Алма 45 46 47 48 49 50 51 52 53 54 55 56 57 58 59 60 61 62 63	Ня	Да	Мя	Лх	Пү	Ба	Бя
22	Хиламан 1 2 3 4 5 6 7 8 9	Ня	Да	Мя	Лх	Пү	Ба	Бя
23	Хиламан 10 11 12 13 14 15 16	Ня	Да	Мя	Лх	Пү	Ба	Бя
24	3 Нифай 1 2 3 4 5 6 7 8 9 10 11:1–17	Ня	Да	Мя	Лх	Пү	Ба	Бя
25	3 Нифай 11:18–41 12 13 14 15 16	Ня	Да	Мя	Лх	Пү	Ба	Бя
26	3 Нифай 17 18 19 20 21 22	Ня	Да	Мя	Лх	Пү	Ба	Бя
27	3 Нифай 23 24 25 26 27 28 29 30	Ня	Да	Мя	Лх	Пү	Ба	Бя
28	4 Нифай 1 Мормон 1 2 3 4 5 6 7 8:1–11	Ня	Да	Мя	Лх	Пү	Ба	Бя
29	Мормон 8:12–41 9 Ифер 1 2 3	Ня	Да	Мя	Лх	Пү	Ба	Бя
30	Ифер 4 5 6 7 8 9 10 11 12	Ня	Да	Мя	Лх	Пү	Ба	Бя
31	Ифер 13 14 15 Моронай 1 2 3 4 5 6 7:1–19	Ня	Да	Мя	Лх	Пү	Ба	Бя
32	Моронай 7:20–48 8 9 10	Ня	Да	Мя	Лх	Пү	Ба	Бя

Мормоны Номонд тавтай морилно уу

Мормоны Ном гэж юу вэ?

Мормоны Ном Есүс Христийн бас нэгэн гэрээ юм. Энэ ном нь Америк тив дэх Израилын угсааны хэсэг хүмүүстэй хийсэн Бурханы үйлүүдийн тухай эртний бошиглогчдын бичиглэлийг агуулдаг. Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн хувьд Мормоны Ном нь Библи, Сургаал ба Гэрээ, Агуу Үнэт Судын хамт ариун судар болдог. Мормоны Ном нь эртний Америкийн соёл иргэншлийн цэдэг бөлгөө.

Мормоны Ном нь 1830 онд анх англи хэл дээр хэвлэгдсэнээс хойш өдийг хүртэл олон хэл дээр орчуулагдсаар байгаа бөгөөд одоогоор 150 сая гаруй хувь хэвлэгдээд байна. Энэ номыг Бурханы бошиглогчид Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн “тулгуур чулуу” хэмээн тодорхойлжээ.

Мормоны Номыг судлах нь надад яагаад чухал вэ?

Та Мормоны Номыг чин сэтгэлээсээ судлах үед таныг Бурханд ойртуулах адислалууд хүлээж байдаг хэмээн ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон заажээ.

Бурханд илүү ойртох, өдөр тутмын амьдралдаа Түүнтэй илүү адилхан болох, Түүний оршихуйг байнга мэдрэх эрхэм нандин ямар нэг зүйл бидний зүрх сэтгэлд байдаггүй гэж үү? Хэрэв тийм аваас, Мормоны Ном өөр ямар ч номноос илүүтэйгээр бидэнд туслах болно.

Мормоны Ном нь бидэнд үнэхээр үнэнийг зааж, Христийг гэрчилдэг ч, үүнээс илүү зүйлийг уг ном агуулдаг. Энэ номыг нухацтайгаар судалж эхэлсэн цагаас эхлэн таны амьдралд урсан орж ирэх хүч энэ номонд бий. Та уруу таталтыг эсэргүүцэх агуу хүчийг олж авах болно. Та мэхлэлтээс зайлсхийх хүчийг олж авна. Та давчуу бөгөөд нарийн зам дээр үлдэх хүчийг олж авах болно. Судруудыг “амьдралын үгс” (С ба Г 84:85-ийг үзнэ үү) гэж нэрлэдэг ба Мормоны Ном үнэн гэдгээс өөр илүү үнэн гэж хаа ч үгүй. Эдгээр үгсээр өлсөж, цангадаг болсон үед та улам илүү хангалуун сайхан амьдралыг олж авах болно. (“Мормоны Ном—Манай шашны тулгуур чулуу,” *Ensign*, 1986, 11-р сарын 7).

Мормоны Номыг өнөө үеийн бидэнд зориулан бичсэн. Энэ номыг нэрээр нь нэрлэсэн эртний бошиглогч Мормон, түүний хүү Моронай олон зууны түүхэн бичиглэлүүдийг хураангуйлсан алтан ялтсуудын эмхэтгэлээс бошиглогч Иосеф Смит Мормоны Номыг орчуулсан юм. Бурхан, эхлэлээс төгсгөл хүртэлх бүх зүйлийг мэддэг бөгөөд өөрийн бошиглогчдодоо сүнслэгээр нөлөөлж энэ номыг хураангуйлахад өнөө үеийн бидний амьдралд юу хэрэгтэйг хэлж өгсөн. Мормоны Номыг бичсэн хамгийн

сүүлийн бошиглогч Моронай бидний цаг үеийг харсан: “Болгоогтун, хэдийгээр та нар үгүй ч, та нар өмнө минь буй мэтээр би та нартай ярьж байна.” Гэвч болгоогтун, Есүс Христ та нарыг надад үзүүлсэн, мөн би та нарын үйлийг мэднэ” (Мормон 8:35).

Ерөнхийлөгч Бэнсон түүнчлэн Мормоны Номыг судлах нь та нарт сайн мууг ялгахад туслах болно хэмээн заажээ.


“Мормоны Ном нь хүмүүнийг хоёр энгийн шалтгаанаар Христэд авчирдаг” Эхнийх нь, энэ нь Христийн болон Түүний сайн мэдээний тухай тодорхой хэлж өгдөг. Энэ ном нь Түүний бурханлаг байдал, Гэтэлгэгчийн зайлшгүй хэрэгцээ ба Түүнд итгэл найдвараа тавих хэрэгтэйг гэрчилдэг. Энэ нь Уналт, Цагаатгал болон харууссан зүрх, гэмшсэн сэтгэл ба сүнсээр дахин төрөх хэрэгцээ гэх мэт сайн мэдээний анхны зарчмуудыг гэрчилдэг. Энэ нь биднийг зөв шударгаар эцсээ хүртэл тэвчих ба гэгээнтэн хүний хувьд ёс суртахуунтай амьдралаар амьдрах ёстойг тунхагладаг.

“Хоёрдугаарт, Мормоны Ном нь Христийн дайснуудыг илчилдэг” Буруу сургаалуудыг мадалж, маргаан тэмцлийг намжаадаг. (2 Нифай 3:12-ыг үзнэ үү.) Энэ нь өнөө үеийн хилэнцэт төлөвлөгөө, заль мэх болон чөтгөрийн сургаалын эсрэг Христийн даруу дагалдагчдыг хүчирхэгжүүлдэг. Мормоны Номон дахь урвагчид нь бидний өнөө үеийн урвагчидтай төстэй юм. Бид энэ цаг үед боловсролын, улс төрийн, шашны ба гүн ухааны буруу ойлголтуудтай хэрхэн тэмцэхээ мэдэж, алдаануудыг харж болохын тулд Бурхан бүх зүйлийг зөгнөх төгсгөлгүй мэдлэгийнхээ дагуу Мормоны Номыг ийнхүү загварласан юм. (“The Book of Mormon Is the Word of God,” *Ensign*, 1975 оны 5-р сар, 64).

Мормоны Номын тухай

Мормоны Ном нь 15 жижиг номоос бүрддэг. Эдгээрээс найман ном нь бошиглогч Иосеф Смитийн орчуулсан алтан ялтсуудын эх хувь дээр бичигдсэн гарчгаар эхэлдэг: 1 Нифай, 2 Нифай, Иаков, Алма, Хиламан, 3 Нифай, 4 Нифай ба Ифер. Мормоны Номон дахь зарим бүлгүүд нь алтан ялтсуудын эх хувь дээр байгаагаараа гарчиглагдсан байдаг (дараах бүлгүүдийн талаарх өгүүлбэрүүдээс гадна): Мозая 9, Мозая 23, Алма 5, Алма 7, Алма 9, Алма 17, Алма 21, Алма 36, Алма 38, Алма 39, Алма 45, Хиламан 7, Хиламан 13, 3 Нифай 11 болон Моронай 9.

Мормоны Номын бүх бүлгийн эхэнд тухайн бүлгийн товч тоймыг налууугаар бичсэн байдаг. Эдгээр бүлгийн тоймуудыг Тэргүүн Зөвлөлийн удирдлага дор бичиж нэмсэн ба алтан ялтсуудаас орчуулагдсан Мормоны Номын эх хувилбарын нэг хэсэг нь биш юм.



Мормоны Номын талаарх сайтууд (хоорондоо холбоотой)*



* Баримтад тулгуурласан Мормоны Номон дахь газрууд. Энэ газрын зураг дээрх газруудыг олохдоо одоогийн газар зүйн байршлыг тогтоох оролдлого хийх хэрэггүй.



Судруудыг судлах нь

Оршил

Энэ хичээлийн зорилго нь судруудыг хэрхэн судлах болон заах үйл ажиллагаандаа Ариун Сүнснийг урьж, удирдамжийг нь хүлээн авахад танд туслах явдал юм. Энэ хичээл нь түүнчлэн судруудыг илүү сайн ойлгож, сургаалуудыг нь амьдралдаа хэрэгжүүлэхэд туслах ур чадваруудыг танд заах болно. Та энэ хичээлийг судлахдаа сайн мэдээнээс суралцах үйл ажиллагаандаа Ариун Сүнснийг урих арга замуудыг эрж ол.

Судлахын хамт итгэлээр сур

Та бие бялдраа эрүүл чийрэг байлгахыг хүссэн учраас өөрийнхөө өмнөөс биеийн тамирын дасгал хийж байхыг нэг найзаасаа хүсчээ гэж бод. Найзын чинь хийсэн биеийн тамирын дасгал чиний бие бялдарт хэрхэн нөлөөлөх вэ? Энэ жишээг өөрийн чинь сүнслэг байдлын өсөлттэй холбож үзвэл, нэг хүн нөгөөгийнхөө төлөө биеийн тамирын дасгал хийж болохгүйтэй яг адилхан хэн нэг нь өөр хүний өмнөөс сайн мэдээг судлах боломжгүй юм. Бид бүгд сайн мэдээнээс суралцаж, сүнслэг байдлаа хөгжүүлэхийн төлөө зөвхөн өөрсдөө хариуцлага хүлээх ёстой.

Сургаал ба Гэрээ 88:118-д Их Эзэн сайн мэдээнээс хэрхэн суралцахыг дүрсэлсэн байдаг. Та үүнийг уншихдаа сайн мэдээнээс суралцахын тулд юу хийх хэрэгтэйгээ мэдэхийн тулд дараах өгүүлбэрийг гүйцээж бич: “Судлахаар _____ мөн тэрчлэн _____.”

Судлахаар мөн итгэлээр суралцах нь хувь хүнээс их хүч чармайлтыг шаардана. Сайн мэдээг залбирч судлахдаа гаргасан хүч чармайлт чинь суралцах явцад Ариун Сүнснийг урих болно. Энэ жил сайн мэдээг судлахад хүч чармайлт гаргах зарим арга зам гэвэл та сайн мэдээг ойлгохын тулд залбирч, семинарын даалгавруудаа сайн хийж, өөрийн гэрчлэл болон сайн мэдээгээр амьдардаг туршлагаа бусадтай хуваалцан, сурч мэдсэн зүйлсээ амьдралд хэрэгжүүлэх ёстой.

Сүнслэгээр суралцахын салшгүй чухал хэсэг болох Ариун Сүнснийг урихын төлөө өөрийн чинь гаргах ёстой нэг чухал хүч чармайлт бол судруудыг өдөр бүр судлах явдал мөн. Өдөр бүр судар судлах нь өөрт чинь хандсан Их Эзэний дуу хоолойг сонсоход туслах болно (С ба Г 18:34–36)-г үзнэ үү). Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Робэрт Д.Хэйлс ийн амласан юм: “Бид [Бурханыг] өөртөө хандаж яриасай гэж хүсдэг бол судруудыг судал. Учир нь Түүний

үгс бошиглогчдоор нь дамжин бидэнд ирдэг. Ариун Сүнсний өдөөлтүүдийг бид анхааралтай сонссон үед Тэр бидэнд заах болно” (“Holy Scriptures: The Power of God unto Our Salvation,” *Ensign* ба *Лиакхона*, 2006 оны 11-р сар, 26–27).


Та судруудыг уншиж, сурах үйл ажиллагаандаа Ариун Сүнснийг урьснаар сүнслэг байдлын агуу өсөлтөөс болон Бурханд ойр байснаас ирдэг адислалуудын хамт нэн чухал илчлэлтүүдийг амьдралдаа хүлээн авч, уруу таталтыг эсэргүүцэх хүч чадал тань өсөн нэмэгдэж, Есүс Христийн сайн мэдээний тухай агуу гэрчлэлтэй болно.

Судар судлах

Тэргүүн Зөвлөлийн Ерөнхийлөгч Марион Ж.Ромни судар судлах үндсэн зорилгуудын нэгийг тодорхойлон, “Бидний ашиг тусын тулд зарчмуудыг хадгалан үлдээхийн төлөө судруудыг бичсэн юм” хэмээн хэлжээ (“Records of Great Worth,” *Ensign*, 1980 оны 9-р сар, 4). Бид судруудыг судалснаар сайн мэдээний зарчмууд болон сургаалуудад суралцдаг билээ. Эдгээр зарчмууд болон сургаалууд нь тэдгээрийг амьдралдаа хэрэгжүүлэхэд биднийг удирдах болно.

Судруудад агуулагдсан зарчмууд болон сургаалуудыг олоход хүч чармайлт, дадлага шаардагддаг. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Ричард Г. Скотт судар судлахыг үнэт эрдэнийн чулуу олборлохтой зүйрлүүлж, “Эрдэнэс лүгээ адил чухал үнэнийг зарим үед судрын хуудсуудаас анхааралтайгаар түүж олох ёстой болдог” гэжээ (“Four Fundamentals for Those Who Teach and Inspire Youth,” *Old Testament Symposium Speeches*, 1987 [1988], 1). Судруудыг үнэт эрдэнэс түүх лүгээ адил судлах нь гурван чухал хэсгээс бүрддэг: (1) бид судруудын түүхэн үндэс болон тухайн нөхцөл байдлыг ойлгосон байх ёстой, (2) бид заагдаж байгаа зарчмууд болон сургаалуудыг мэдсэн байх ёстой, (3) бид эдгээр үнэнүүдийг амьдралдаа хэрэгжүүлэх ёстой.



 **1.** Судрын тэмдэглэлдээ дараах асуултад хариулж бич: Алмаз олборлодог уурхайчин болон сайн мэдээний зарчмуудыг амьдралдаа хэрэгжүүлэхийн тулд тэдгээрийг судалж байгаа хүн хоёрын хооронд ямар адил төстэй зүйл байдаг вэ?

Судруудын түүхэн үндэс ба тухайн нөхцөл байдлыг ойлго


Судрын хэсгийн түүхэн үндэс ба тухайн нөхцөл байдлыг ойлгох нь судрын хэсэгт агуулагдаж байгаа


сайн мэдээний захиасыг ойлгоход таныг бэлтгэх болно. Ерөнхийлөгч Томас С.Монсон ийн зөвлөсөн юм: “Судруудын заадаг сургамжуудыг сайн судал. Тэдгээрийн түүхэн үндэс ба нөхцөл байдлыг судалж мэд. . . Тэдгээр нь үнэний тухай өөрт чинь хандан ярьж байна гэж бодон судал (“Be Your Best Self,” *Ensign* ба *Лиахона*, 2009 оны 5-р сар, 68).

Судар уншиж байхдаа “Эдгээр шүлгүүдийг хэн бичсэн билээ?” “Шүлгүүдийг хэнд зориулан бичсэн юм бол?” “Энэ түүхэнд ямар үйл явдал болж байна вэ?” “Зохиогч яагаад эдгээр шүлгүүдийг бичсэн юм бол?” гэхчлэнгийн асуултуудыг асуух нь ашигтай. Бүлгийн тойм нь (бүлэг бүрийн эхэн дэх налуу үсгээр бичсэн товч тойм) тухайн бүлэг дэх гол үйл явдлуудын хураангуйг өгч, дээрх асуултуудад ихэвчлэн хариулсан байдаг.

Бас хэцүү буюу мэдэхгүй үгсийг толь бичгээс харах нь ашигтай байж болно. Аль нэг өгүүлбэр буюу судрын хэсгийн утга тодорхой бус байвал илүү сайн ойлгохын тулд зүүлт тайлбар байвал үзэх хэрэгтэй.

Эдгээр аргуудыг ашиглан 3 Нифай 17:1–10-ыг уншиж, дараах асуултуудын хариуг ол: Өгүүлэгч нь хэн бэ? Тэр хэнд хандан ярьж байна вэ? Ямар үйл явдал болсон бэ? Болж байгаа үйл явдлуудыг түргэн нэгтгэн дүгнэхийн тулд бүлгийн тоймыг унш.

 **2.** 3 Нифай 17:1-ийн зүүлт тайлбарыг ашиглан судрын тэмдэглэлдээ дараах асуултад хариулж бич: “Цаг минь ирлээ” хэмээн Есүс хэлсэн нь юу гэсэн утгатай вэ?


 **3.** Аврагч цугласан олныг орхин явахаар бэлтгэж байх үед юу болсон тухай судрын тэмдэглэлдээ өөрийн үгээр бич. Тэр яагаад үлдсэн бэ? Тэр хүмүүсийн төлөө юу хийсэн бэ?

Сургаалууд ба зарчмуудыг ол

Сургаалууд ба зарчмууд мөнхөд орших бөгөөд сайн мэдээний өөрчлөгддөггүй үнэнүүд бидний амьдралын замыг чиглүүлдэг билээ. Эртний бошиглогчид бидэнд эдгээр үнэнүүдийг үйл явдлууд, түүхүүд буюу судруудад цэдэглэгдсэн номлолуудаар дамжуулан заадаг.

Хэрэв та судрын хэсгийн түүхэн үндэс болон нөхцөл байдлыг ойлгосон бол түүний зааж байгаа сургаалууд болон зарчмуудыг ойлгоход бэлтгэгдлээ гэсэн үг. Ахлагч Ричард Г. Скотт зарчмуудыг ойлгох ашиг тустай нэг аргыг ийн дүрсэлжээ: “Зарчмууд бол олон янзын нөхцөл байдалд хэрэглэхэд бэлэн болж, шигшигдсэн үнэн юм. Үнэн зарчмыг баримталсан үед туйлын төвөгтэй нөхцөл байдалд ч гэсэн зөв шийдвэр гаргаж чадна. Бид цуглуулсан үнэнээ энгийн зарчим болгож нэгтгэн дүгнэх нь маш чухал юм” (“Acquiring Spiritual Knowledge,” *Ensign*, 1993 оны 11-р сар, 86).

Сайн мэдээний зарим зарчмууд “бид тийн харж байна,” “гэсэн хэдий ч” гэсэн үгсийг хэрэглэснээр тодорхой болдог. Гэвч ихэнх зарчмуудыг шууд нотолсон байдаггүй, харин тэдгээр нь судрууд дахь хүмүүсийн амьдралаар дүрслэгддэг. Эдгээр сургаалууд болон зарчмуудыг “Энэ түүхийн сургамж буюу гол санаа нь юу вэ?” “Зохиогч энэ түүх буюу үйл явдлыг яагаад оруулсан бэ?” Зохиогч үүгээрээ бидэнд юу заахыг хүссэн бэ? “Судрын энэ хэсэгт ямар үнэнүүд заагдаж байна вэ?” гэхчлэнгийн асуултуудыг өөрөөсөө асууснаар эдгээр сургаалууд болон зарчмуудыг нээж болно.

 **4.** 3 Нифай 17:1–10-т ямар зарчим болон сургаалууд заагдсаныг олж мэдэхийн тулд, а, б үйл ажиллагаануудын хариуг судрын тэмдэглэлдээ бич. Бүлгийн агуулгын талаар товч мэдээлэл авахын тулд бүлгийн тоймыг унш.

а. Эдгээр шүлгүүдэд хэн ярьж байна вэ? Тэр хэнд хандан ярьж байна вэ? 3 Нифай 17:1–10-ын сургамж буюу гол санаа юу вэ?

б. Шүлэг 1, 5–6, 9–10-ын зохиогч энэ түүхээс сургамж авах ямар зүйлүүдийг бидэнд зориулж бичсэн бэ? Та эдгээр шүлгүүдээс ямар чухал үнэнүүдийг мэдсэн бэ?

Эдгээр шүлгүүдээс таны олж мэдэж болох сайн мэдээний үнэнүүдийн нэг нь: **Их Эзэн Өөрт нь ойр дотно байх бидний чин хүсэлд хариулдаг** гэсэн үнэн юм.

Сургаалууд ба зарчмуудыг хэрэгжүүлэх нь


Та сайн мэдээний сургаалууд болон зарчмуудыг ойлгож мэдсэнээр тэдгээрийг хэрэгжүүлэх талаар ямар нэг зүйлийг үйлдэх буюу *хийхэд* бэлэн болдог. Сурч мэдсэн зүйлээ амьдралд хэрэгжүүлсэн үед та уг зарчим үнэн болохыг Ариун Сүнс гэрчлэхийг мэдрэх болно (Моронай 10:4–5-ыг үз). Гэр орон, семинар, сүм дээр болон Бурханы өмнө хүлээсэн үүрэг бүрээр заадаг хичээл, Хувийн Хөгжил Дэвшлийн туршлага нь заалгасан зүйлсээ хэрэгжүүлэхэд бидэнд туслах зорилготой юм.



Ерөнхийлөгч Томас С.Монсон хэлсэн нь: “Сайн мэдээг заах зорилго нь . . . (суралцагчийн) оюун ухаанд ‘мэдээллийг юүлэх’ явдал биш. . . . *Харин хүмүүсийг сайн мэдээний зарчмуудаар амьдрах тухай бодож, хүсч, үйлдэхэд нөлөөлөх нь эрхэм зорилго мөн*” (Conference Report, 1970 оны 10-р сар, 107).

Сурч мэдсэн зарчмуудаа хэрэгжүүлэхийн тулд: “Энэ мэдлэгийг эзэмшсэн үед Их Эзэн надаар юу хийлгэхийг хүсэх бол?” “Төгөлдөржихөд надад туслах ямар сүнслэг мэдрэмжүүдийг би хүлээн авсан билээ?” “Энэ зарчим миний амьдралд ямар өөрчлөлт гаргах вэ?” “Би энэхүү үнэний дагуу амьдрахын тулд одоо

юу хийх ёстой вэ? Эсвэл юуг хийхээ болих ёстой вэ?" "Энэ судрын заасан зүйлсийг хэрэгжүүлснээр миний амьдрал хэрхэн улам сайжрах вэ?" гэх мэт асуултуудыг өөрөөсөө асуу.

 **5.** 3 Нифай 17:1–10-аас сурч мэдсэн зарчим буюу сургаалыг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлж болохыг дүрсэлсэн богинохон догол мөрийг судрын тэмдэглэлдээ бич.

Судар судлах ур чадвар ба аргууд

Дараах ур чадвар болон аргуудыг ашиглах нь судруудын түүхэн үндсийг ойлгож, тэдгээрт заагдсан сургаалууд болон зарчмуудыг олж тогтоон, хэрэгжүүлэхэд тань туслах болно. Эдгээр аргуудын тухай энэ гарын авлагын эхнээс төгсгөл хүртэл дурдах болно. Чадвар бүрийг уншиж, өөртөө хэрэгтэй гэж үзсэн нэг буюу хоёр чадварыг сонгож хувиараа судар судлахдаа байнга ашиглаж бай.

Шалтгаан ба үр дагавар *Хэрэв-тэгвэл, тийм учраас, тиймээс* гэсэн шалтгаан, үр дагаврын уялдаа холбоог ол. Жишээ нь: 2 Нифай 13:16–26; Алма 34:33.

Харьцуулах эшлэл. Хооронд нь харьцуулахад утгыг тодруулж, улам сайн ойлгоход туслах бүлэг буюу хэсэг судар. Жишээ нь, Мозая 11:2–6, 14-ийг Дэд Хууль 17:14–20-той харьцуул. Та бас харьцуулах эшлэлийг олохын тулд зүүлт тайлбаруудыг ашиглаж болно. Жишээ нь: 3 Нифай 12:28–29, зүүлт тайлбар 29а, Сургаал ба Гэрээ 42:23-ын эшлэлүүд.

Нөхцөлийг тодорхойл Судрын үйл явдлуудыг хэн, юу, хаана, хэзээ? гэсэн асуултууд тавьж тодорхойл. Жишээ нь: Алма 31:1, 6–11; 32:1–6 нь Алма 32:21–43-ын нөхцөлийг бүрдүүлж байна.

Түлхүүр үгс "Гэсэн хэдий ч," "бид тийн харж байна" гэсэн үгс болон нийлэмж үгс нь ямар нэг зүйлийг болих буюу бичигдсэн зүйлийн тайлбарыг эрж олохыг урьсан урилга юм. Жишээ нь: Алма 30:60; Хиламан 6:35–36; 3 Нифай 18:30–32.

Судруудад тэмдэглэгээ хийх нь Шүлгийн утгыг илэрхийлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байгаа үгс буюу нийлэмж үгсийг будаж тэмдэглэх, дугуйлах буюу доогуур нь зур. Бас богинохон санаа, өөртөө төрсөн мэдрэмж, ойлголт буюу зарчмуудыг судрынхаа зах дээр бич. Энэ нь өөрт чинь чухал ач холбогдолтой судрыг санахад тань туслах болно.

Нэрийг орлуулах нь Судрууд дахь хэн нэгний оронд өөрийн нэрийг тавь. Жишээ нь: 1 Нифай 3:7-д Нифайн оронд өөрийн нэрийг тавь.

Тунгаан бодох нь Тунгаан бодох гэдэг нь ямар нэг зүйлийг олон талаас гүнзгий эргэцүүлэн бодох явдал мөн. Тунгаан бодох нь асуултууд асууж, мэдэж байгаа болон сурсан зүйлдээ үнэлэлт дүгнэлт

өгөх явдал юм. Тунгаан бодох нь ихэвчлэн аль нэг зарчмыг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлэхийг мэдэх хүслээс үүдэлтэй.

Давтагдсан үгс Давтагдсан үгс, өгүүлбэрүүд нь анхаарлаа төвлөрүүлэхэд уншигчид чухал байж болно. Давтагдсан үгс нь зохиогчийн чухал гэж үзсэн зүйлд онцгой анхаарал хандуулах зорилготой юм. Жишээ нь: 2 Нифай 9:10, 19, 26–27, 39, 46–47 дахь *аймшигт* гэдэг үг; Хиламан 5:6–14 дэх *санах* гэдэг үг.


Судрын зүйрлэлүүд Бошиглогчид зарим үед өөр өөр хүмүүс, үзэл бодол буюу үйл явдлуудын ялгааг судруудад харуулсан байдаг. Хоёр зүйлийг хооронд нь харьцуулж ялгааг тогтоох нь сайн мэдээний заагдаж байгаа чухал зарчмуудыг таньж ойлгохыг илүү хялбар болгодог. Шүлэг, судрын хэсгүүд буюу бүлгүүдээс ялгааг ол. Жишээ нь: 2 Нифай 2:27; Алма 47–48.

Судар дахь жагсаалтууд Судар дахь жагсаалтуудыг олох нь Их Эзэн болон Түүний бошиглогчдын зааж байгаа зүйлийг ойлгоход тань тусалж чадна. Жагсаалтыг олсон үедээ тэнд дурдсан зүйл бүрийг дугаарлаж болно. Жишээ нь: нифайчуудын дунд оршиж байсан ёс бус заншлуудын жагсаалт Хиламан 4:11–13-т байдаг.

Судрууд дахь бэлгэдлүүд *Адил, мэт, шиг* эсвэл *адилтгах* зэрэг үгс нь бэлгэдлүүдийг олоход тусална. Бэлгэдэл юуг төлөөлж байгааг тодорхойлохыг хичээ. Бэлгэдлийн утгыг мэдэхийн тулд зүүлт тайлбарууд, Судруудын Удирдамж болон Topical Guide-ыг ашигла. Жишээ нь: Иаков 5:3, 75–77-г Иаков 6:1–7-той харьцуул.

Дүрслэн бодох нь Судар унших үедээ болж байгаа үйл явдлыг оюун ухаандаа дүрслэн бод. Үйл явдлын талаар асуултууд асууж, уг үйл явдал одоо болж байгаа гэж төсөөлөн бод. Жишээ нь: Инос 1:1–8-д болж байгаа зүйлийг дүрслэн бодохыг хичээ.

Үгийн тодорхойлолт Судруудад бидний мэдэхгүй үгсийг олонтоо хэрэглэсэн байдаг. Мэдэхгүй үг тааралдвал та Судруудын Удирдамж, зүүлт тайлбарууд эсвээс ердийн толь бичгээс утгыг нь хар.

 **6.** "Судар судлах ур чадвар ба аргууд" гэсэн өмнөх хэсэг дэх ур чадваруудаас нэгийг сонгож, ашигла. Сонгож авсан ур чадвар нь хувиараа судар судлахад чинь хэрхэн тусалсан тухай судрын тэмдэглэлдээ бич.

 **7.** Дараах өгүүлбэрийг өнөөдрийн даалгаврынхаа доод талд судрын тэмдэглэлдээ бич:

"Судруудыг судлах нь" хичээлийг би судалж дууслаа (огноо).

Багштайгаа хуваалцахыг хүссэн миний бодол санаа, ойлголтууд болон нэмэлт асуултууд:

Авралын төлөвлөгөө

Оршил

Тэнгэрлэг Эцэг Өөрийн хүүхдүүд бид бүгдийг мөнхийн аз жаргал, өргөмжлөл өөд удирдах төлөвлөгөөгөөр хангасан юм. Түүний төлөвлөгөөний төвд Есүс Христийн Цагаатгал байдаг. Цагаатгал нь Уналтын үр дагавруудыг ялсан бөгөөд энэ амьдралд болон үүрд мөнхөд баяр баясгалантай байхын тулд наманчилж, нүглээсээ цэвэрших боломжийг бидэнд олгосон билээ.

Энэ хичээл танд Тэнгэрлэг Эцэгийн авралын төлөвлөгөөний товч тоймыг танилцуулах болно. Энэ хичээл нь бас энэ жил таны судлах сайн мэдээний үнэнүүд нь өөр хоорондоо болон дэлхий дээрх таны зорилготой хэрхэн холбоотойг ойлгоход тань туслах болно. Авралын төлөвлөгөөний тухай мэдлэг тань өсөхийн хэрээр Бурхан болон Түүний Хүү Есүс Христэд итгэх итгэл, уг төлөвлөгөөн дэх өөрийн үүргийг биелүүлэх чадвар чинь өсөн нэмэгдэх болно. Авралын төлөвлөгөө бол “хүмүүнд үхэшгүй байдал ба мөнх амьдралыг тохиолгон авчрах зорилго бүхий, Есүс Христийн сайн мэдээний бүрэн байдал юм. Үүнд Бүтээлт, Уналт, Цагаатгал, Бурханаас бидэнд өгсөн бүх хууль, ёслолууд болон сургаалууд орно. Энэ төлөвлөгөө бүх хүмүүст өргөмжлөгдөж, Бурхантай хамт үүрд амьдрах боломжийг олгосон юм” (Судруудын Удирдамж, “Гэтэлгэлийн төлөвлөгөө,” scriptures.lds.org).

Авралын төлөвлөгөө мөнх бус амьдрал дахь зорилгоо ойлгоход бидэнд тусалдаг

Бидний Тэнгэрлэг Эцэгийн Авралын төлөвлөгөө амьдралынхаа аль нэгэн үед ихэнх хүмүүсийн



асуудаг олон асуултад хариулдаг. “Би хаанаас ирсэн юм бол?” “Яагаад би энд байгаа юм бол?” “Би энэ амьдралын дараа хаашаа явах вэ?” гэх мэт асуултуудыг та олон талаас нь эргэцүүлэн бодож үзсэн үү?

Бид дэлхий дээр төрөхөөсөө өмнө Тэнгэрлэг Эцэгийнхээ дэргэд Түүний сүнсэн хүүхдүүдийн хувиар амьдарч байсан билээ. Бид үнэхээр Түүний хүүхдүүд бөгөөд Тэр бидэнд хайртай. Түүний авралын төлөвлөгөө бол бид бүгдийн хувьд Түүнтэй адилхан болж, Түүний бүх адислалыг авах арга зам мөн. Бид дэлхийд ирэхээсээ өмнө Түүний авралын төлөвлөгөөг ойлгож, хүлээн зөвшөөрсөн юм.

Мормоны Ном авралын төлөвлөгөөний тухай бидний мэдлэгт чухал үүрэг гүйцэтгэдэг. Мормоны Номын бошиглогчид энэхүү төлөвлөгөөг дурдахдаа олон өөр нэр томъёог хэрэглэсэн байдаг.



1. Доор жагсаасан нэрсийг уншиж, шүлэг бүрд Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг юу гэж нэрлэснийг ол. Олсон нэрээ судрын эшлэлийн дэргэд судрын тэмдэглэлдээ бич. Эхний нэр нь танд зориулагдсан юм.

а. 2 Нифай 9:6 “Агуу Их Бүтээгчийн нигүүлсэнгүй төлөвлөгөө”

б. 2 Нифай 11:5 _

в. Алма 12:25 _

г. Алма 24:14 _

д. Алма 42:8 _

е. Алма 42:15 _

Нигүүлсэнгүй, үхлээс чөлөөлөх, авралын, аз жаргалын, гэтэлгэлийн гэх зэрэг үгс нь **Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөө Түүний хүүхдүүдэд мөнхийн аврал, аз жаргалыг авчрах зорилготой сургаалыг онцгой ач холбогдолтой болгож байна.**



2. Дараах асуултад судрын тэмдэглэлдээ хариул: Чиний аз жаргал, өргөмжлөлд зориулсан төлөвлөгөө Тэнгэрлэг Эцэгт байдгийг мэдэх нь амьдралд чинь ямар өөрчлөлт гаргасан бэ?

Судрын тэмдэглэл

Та гэрээр судлах явцдаа асуултуудад хариулж, бодол санаагаа судрын тэмдэглэлээрээ дамжуулан багштайгаа хуваалцах боломжтой. Бодол санаа сэтгэгдлээ тэмдэглэж, гарын авлагын асуултуудад бичгээр хариулах нь илчлэлийг урьж, судруудыг ойлгоход тань тусалж болно. Сурч мэдсэн зүйлээ багштайгаа ярилцаж, хийсэн ажлаа түүнд үзүүлэх бэлтгэлтэй байхын тулд долоо хоног тутмын гэрээр судлах хичээлд судрын тэмдэглэлээ авч очиж бай.


Авралын төлөвлөгөөн дэх сонгох эрх ба Адам Ева хоёрын Уналтын үүрэг

Адам Ева хоёр бол энэ дэлхийд ирсэн Тэнгэрлэг Эцэгийн анхны хүүхдүүд юм. Тэрбээр тэднийг Еденгийн цэцэрлэгт байрлуулж, тэдэнд сонгох эрх буюу “өөрсдийнхөө төлөө сонгож, үйлдэх чадвар хийгээд онцгой боломжийг” олгосон билээ (Судруудын Удирдамж, “Agency,” scriptures.lds.org). Тэр сайн ба муугийн мэдлэгийн модны жимснээс бүү ид хэмээн тэдэнд зарлиг болгосон юм. Хэрэв тэд энэ зарлигийг дагасан бол цэцэрлэгтээ үлдэж болох байсан ч мөнх бус амьдрал дахь эсрэг тэсрэг байдлыг биеэрээ үзэхгүй учраас өсч хөгжих боломжгүй байлаа. Тэд уй гашуу, өвчин шаналыг үзэхгүй учраас баяр баясгаланг мэдэх боломжгүй байх байв.

2 Нифай 2:17–20-ийг уншиж, Бурханы зарлигийг зөрчихөөр сонгосны дараа Адам, Ева хоёрт юу тохиолдсоныг мэд. Адам, Ева хоёр юу хийхээр

сонгосныг болон тэр хоёрт адилхан нөлөөлсөн Уналтын хоёр үр дагаврын тухай хоосон зайд дүрслэн бич. _____

2 Нифай 2:22–26-г уншиж, Адам Ева хоёрын хийсэн сонголтын бусад үр дагавруудыг олж мэд. Уналтын үр дагавруудын тухай олж мэдсэн нэмэлт үнэнүүдийг судартаа тэмдэглэ.

 **3.** Адам, Ева хоёрын Уналт чиний хувьд ямар үр дагавруудыг авчирсныг судрын тэмдэглэлдээ дүрслэн бичиж, дараах догол мөрийг гүйцээ. Сонголт, сонгох эрх, бие махбод, үхэл, үр хүүхэд, гэм нүглийн талаарх санаануудыг оруул.


“Адам, Ева хоёрын зөрчлийн улмаас, би бас уналтын байдалд байгаа бөгөөд . . .”



Авралын төлөвлөгөөн дэх Есүс Христийн Цагаатгалын үүрэг


Нүгэл, үхэл нь биднийг Тэнгэр дэх Эцэгийн орши-хуйгаас тусгаарласан юм. Бид тэнгэрлэг тусламж-гүйгээр Бурханы дэргэд буцаж очиж чадахгүй. Бид Түүнд итгэх итгэлтэй байж, Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг дагахын тулд авралын төлөвлөгөөн дэх Есүс Христ болон Түүний Цагаатгалын үүргийг ойлгодог байх ёстой. Мозая 3:17–19-ийг судалж, Есүс Христийн Цагаатгал Уналтын үр дагавруудыг хэрхэн даван туулдаг болон аз жаргалтай амьдарч, Тэнгэрлэг Эцэгтээ буцаж очиход бидэнд хэрхэн тусалдаг тухай өгүүлсэн өгүүлбэрүүдийг ол. Эдгээр шүлгүүдийг өөрийнхөө үгээр хураангуйлан дүгнэ: _

Бидний сурч мэдэх зарчим бол: **Есүс Христ бол авралын төлөвлөгөөн дэх гол хүн бөгөөд Түүний Цагаатгал уг төлөвлөгөөг Бурханы бүх хүүхдүүдэд хүртээмжтэй болгосон юм.**

 **4.** Дараах судрын хэсгүүдийг унш: 2 Нифай 2:8; Мозая 3:7–11; 16:4–8; Алма 34:9, 15–16; Мормон 9:13–14. Дээрх судрын хэсгүүд авралын төлөвлөгөөн дэх Есүс Христийн Цагаатгалын үүргийн тухай юу зааж байгааг тайлбарласан нэг догол мөрийг судрын тэмдэглэлдээ бич. Чиний хувьд чухал гэж үзсэн өгүүлбэрүүдийн доогуур зурж болно.

Авралын төлөвлөгөөн дэх бидний үүрэг хариуцлага

Түүнтэй болон хайртай хүмүүстэйгээ хамт аз жаргалын оргилд хүрч, өргөмжлөгдөх боломжоор Тэнгэрлэг Эцэгийн төгс төлөвлөгөө биднийг хангасан юм. Есүс Христ үхлийг ялснаар авралын төлөвлөгөөн дэх Өөрийн үүргийг биелүүлж, нүглийг даван туулж, Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очиж Түүнтэй хамт амьдрах боломжийг бидэнд олгосон билээ. Гэвч энэ нь уг төлөвлөгөөн дэх бидний үүрэг хариуцлагыг үгүй болгож байгаа юм биш.

 **5.** Авралын төлөвлөгөөн дэх миний үүрэг хариуцлага гэж бичээд, Ариун Сүнсний хүчийг амьдралдаа урьж, авралын төлөвлөгөөний адислалуудыг бүрнээр нь авахын тулд бид ямар үүрэг хариуцлага хүлээдэг тухай дараах судрууд юу зааж байгааг судрын тэмдэглэлдээ жагсаан бич:

а. 2 Нифай 2:25–27


б. Мозая 3:12–13

в. Алма 12:24–25, 32–34

г. 3 Нифай 27:13–14, 20–22, 27

Бид Есүс Христийн сайн мэдээгээр амьдарч Бурханы төлөвлөгөөг дагаснаар Аврагчийн Цагаатгалаар дамжуулан мөнх амьдралтай


болоход бэлтгэгдэнэ гэдгийг ойлгоход эдгээр судрууд бидэнд тусалж чадна.

 **6.** Авралын төлөвлөгөөний тухай сүм дээр үг хэлэхийг өөрөөс чинь хүсчээ гэж бод. Дээрх судруудаас сурч мэдсэн зүйлээ ашиглан хувь хүн бүр Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөнд ямар үүрэг хариуцлага хүлээдэг тухай юу яриаа судрын тэмдэглэлдээ бич.

Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөн дэх үүрэг хариуцлагаа улам сайн биелүүлж, Аврагчийн хүчийг амьдралдаа урих талаар юу хийж чадахаа тунгаан бод. Бодол санаагаа эцэг эх, ах эгч дүү, дотны найзтайгаа хуваалц.

Авралын төлөвлөгөө асуултуудад хариулж, удирдамж чиглэл өгдөг

Авралын төлөвлөгөөг ойлгох нь шийдвэр гаргах, өөрт чинь болон бусад хүмүүст тулгарах асуудлуудад хариу олоход таныг удирдах болно.

 **7.** Авралын төлөвлөгөөг ойлгох нь асуултуудад хариулж, удирдамж чиглэл өгдөг тухай ярьж, судрын тэмдэглэлдээ доорх асуултуудын нэгэнд хариулж бич:


а. Та өөрийгөө Бурханы хүү буюу охин гэдгээ мэдэх нь өөрийнхөө үнэ цэнийг мэдрэхэд хэрхэн нөлөөлөх вэ?

б. “Энэ бол миний амьдрал учраас би хүссэнээ хийх болно” гэж хэлсэн хүнд чи юу гэж хариулах вэ?

в. Амьдралын зорилго бол зугаа цэнгэл, хүсэл таашаалаа хангах явдал гэж боддог хүн энэ ойлголтоо орхиход нь Авралын төлөвлөгөөний тухай мэдлэг хэрхэн тусалж чадах вэ?

г. Хүнд сорилттой тулгарч, үүнийгээ Бурхан өөрийг нь хайрладаггүйнх гэж үздэг хүнд туслахын тулд чи авралын төлөвлөгөөний тухай мэдлэгээ хэрхэн ашиглах вэ?

Авралын төлөвлөгөө нь бид *яагаад* Бурханы зарлигуудыг сахих ёстойг тайлбарладаг учраас уг төлөвлөгөөний тухай мэдлэг чамд тусалж чадна (Алма 12:32-ыг үзнэ үү).

 **8.** 2 Нифай 2:25-ыг уншин, дараах асуултад судрын тэмдэглэлдээ хариулж авралын төлөвлөгөөний зорилгыг хураангуйлан дүгнэ: Авралын төлөвлөгөө ямар байдлаар танд болон таны гэр бүлд баяр баясгаланг авчирсан бэ?

 **9.** Дараах өгүүлбэрийг өнөөдрийн даалгаврынхаа доод талд судрын тэмдэглэлдээ бич:

Би “Авралын төлөвлөгөө” хичээлээ судалж дууслаа (огноо).

Багштайгаа хуваалцахыг хүссэн миний бодол санаа, ойлголтууд болон нэмэлт асуултууд:

Нүүр хуудас, Удиртгал ба Гэрчүүдийн гэрчлэл

Оршил

Бидэнд Библи байхад Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүдэд яагаад Мормоны Ном хэрэгтэй байдаг юм бэ? гэж нэг найз чинь асуужээ гэж бод. (Энэ асуултыг чамаас аль хэдийн асуусан байж болно!) Чи найздаа юу гэж хэлэх вэ?


Мормоны Номын нүүр хуудас болон удиртгалд энэхүү ариун номын зорилгыг түүний дотор Бурханы тухай бидний гэрчлэл болон Түүнтэй харилцах харилцаанд энэ ном хэрхэн нөлөөлж болохыг тайлбарласан байдаг. Мормоны Номын эхний хуудсууд нь алтан ялтсууд буюу энэ номыг орчуулж гаргасан эхийг үзэж, уг ном тэнгэрлэг гарал үүсэлтэйг гэрчилсэн хүмүүсийн гэрчлэлийг агуулдаг.

Чи энэ хичээлийг дуусгахдаа энэ жил Мормоны Номыг судалснаас ямар ашиг тусыг олж болох тухай мөн Аврагч Есүс Христ болон Түүний сэргээгдсэн сайн мэдээний тухай гэрчлэлээ хөгжүүлэхэд чинь хэрхэн тусалж болох тухай эргэцүүлэн бод.

Нүүр хуудас

Эртний бошиглогч Моронай Мормоны Номын нүүр хуудсыг алтан ялтсууд дээр буулгасныг Бошиглогч Иосеф Смит тайлбарлахдаа: “Мормоны Номын эхний хуудас бол ялтсуудын номын эмхэтгэлийн зүүн тал дахь хамгийн сүүлчийн хуудсаас авсан үгчилсэн орчуулга . . . ба . . . эхний хуудас бол аль ч талаараа миний, эсвэл өнөө үед амьдарч байсан буюу амьдарч байгаа хэн нэгний найруулан зохиож бичсэн зүйл биш” гэжээ (*Сүмийн Ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит [2007], 72*).

Нүүр хуудасны эхний догол мөрийг уншихдаа Мормоны Номыг ирэхэд Их Эзэн хэрхэн оролцсоныг дүрсэлсэн үгс болон өгүүлбэрүүдийг ол.

 **1.** Мормоны Номыг бичих болон орчуулахад Их Эзэн хэрхэн оролцсоныг мэдэх нь чамд яагаад чухал болыг судрын тэмдэглэлдээ тайлбарла.

Нүүр хуудасны хоёр дахь догол мөрийг уншихдаа Мормоны Номыг бичсэн гурван гол шалтгааныг Моронай юу гэж үзүүлснийг ол. (Эдгээр



шалтгаануудыг судартаа тэмдэглэж болно.) “Израилын угсаа” гэдэг нь Иаковын үр удмынхан болон Их Эзэний сүмийн гэрээт гишүүдийг хэлж байгаа юм (Судруудын Удирдамж, “Израил”-ыг үзнэ үү). Түүнээс гадна, “Иудейчүүд ба Харийнхан” гэдэг нь Тэнгэрлэг Эцэгийн бүх хүүхдүүд юм. Нүүр хуудсын хоёр дахь догол мөрөн дэх захиаст “Израилын угсааны үлдэгдэл,” “Иудейчүүд ба Харийнхан” гэсэн хэллэгүүдэд өөрийнхөө нэрийг тавьж унш.

 **2.** Мормоны Номын эдгээр зорилгуудыг мэдэх нь энэ номын ач холбогдлыг ойлгоход өөрт чинь хэрхэн тусалж болох тухай судрын тэмдэглэлдээ тайлбарла.

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон Мормоны Номын “үндсэн зорилгын” тухай дараах үгийг хэлжээ:

“Мормоны Номын үндсэн зорилго бол үүний нүүр хуудсанд өгүүлснээр ‘өөрийгөө бүх үндэстнүүдэд үзүүлэх тэр Есүс бол Христ, Мөнхийн Бурхан хэмээн Иудейчүүд болон Харийнханд итгүүлэх явдал’ мөн.


“Үнэнийг чин шударгаар эрэлхийлэгч хүн Мормоны Номын сүнслэг нөлөө бүхий үгсийг залбирч тунгаан бодсоноор Есүс бол Христ гэдэг гэрчлэлтэй болж чадна.

“Мормоны Номын бүх шүлгийн тэн хагасаас илүүд нь бидний Их Эзэний тухай өгүүлсэн байдаг. Христийн зарим нэрийг Мормоны Номын шүлгүүдэд бүр Шинэ Гэрээнээс ч илүү олон удаа дурдсан байдаг” (“Come unto Christ,” *Ensign*, 1987 оны 11-р сар, 83).

Мормоны Номын нүүр хуудсанд тунхагласанчлан, энэхүү ном нь Есүс бол Христ гэдгийг гэрчилдэг. Та нар энэ жил Мормоны Номыг судлахдаа Есүс Христийн тухай мэдсэн зүйл дээрээ анхаарал төвлөрүүлэн сурч мэдсэн зүйлээ Ариун Сүнсний хүчээр дамжуулан батлахын тулд залбирч, Бурханаас асуугаарай.

Мормоны Номын удиртгал

Нуман гүүр буюу барилга тулгуургүйгээр хэрхэн унахгүй, тогтож байдгийг та нар сонирхож байсан уу? Нуман хаалгыг барихдаа хоёр баганыг бэхэлгээ тургууртайгаар барьдаг. Нуман хаалганы дээд талд анхааралтайгаар нарийн хэмжээтэй зай үлдээдэг бөгөөд тэнд “тулгуурын чулууг” байрлуулдаг. Тулгуурын чулууг байрлуулсны дараа нуман хаалга ямар нэгэн тусламжгүйгээр зогсох боломжтой болдог. Хэрэв тулгуурын чулууг авбал нуман хаалга яахыг төсөөлөн бод.



Мормоны Номын удиртгалаас “Энэ цэдгийн талаар . . .” хэмээн эхэлсэн зургаа дахь догол мөрийг унш. Энэ догол мөрийг уншихдаа Мормоны Номын талаар Бошиглогч Иосеф Смитийн заасан гурван чухал зарчмыг ол.

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон Мормоны Ном бол манай шашны тулгуурын чулуу болох тухай дэлгэрэнгүй тайлбарласан юм. Энэ эшлэлийг уншаад Мормоны Ном манай шашинд гол үүрэг гүйцэтгэдэг тухай өөр хүнд тайлбарлахад тусалж болох нийлэмж үг, өгүүлбэрүүдийн доогуур зур.

“Мормоны Ном манай шашны тулгуурын чулуу болохыг батлах гурван зүйл байдаг. Энэ бол Христийн тухай гэрчлэх бидний гэрчлэл дэх тулгуурын чулуу. Энэ бол бидний сургаалын тулгуурын чулуу. Энэ бол бидний гэрчлэлийн тулгуур чулуу.

“Мормоны Ном нь бидний хийж байгаа бүх зүйлийн булангийн чулуу болох Есүс Христийн тухай бидний гэрчлэл дэх тулгуурын чулуу мөн. Энэ Ном Түүний тухай үнэн бодитойгоор хүчтэй бөгөөд тодорхой гэрчилдэг. . . .

Мормоны Ном “Есүс Христийн сайн мэдээний бүрэн байдлыг” (С ба Г 20:9) агуулдгийг Их Эзэн Өөрөө нотолсныг өмнө дурдсан билээ. Энэ нь урьд өмнө илчлэгдсэн сургаал бүрийг агуулдаг гэсэн хэрэг биш юм. Энэ нь бидний авралд шаардлагатай сургаалуудын бүрэн байдлыг бид Мормоны Номоос олж болно гэсэн үг юм. Тэдгээр сургаалуудыг хүүхдүүд ч гэсэн аврал, өргөмжлөлд хүрэх арга замуудыг ойлгож чадахаар энгийн байдлаар заасан байдаг.

Эцэст нь, Мормоны Ном бол гэрчлэлийн тулгуур чулуу мөн. Хэрэв тулгуур чулууг авбал нуман хаалга нурж унадаг шиг Мормоны Ном үнэн учраас Сүм оршин тогтнож байгаа, эс бөгөөс Сүм оршин тогтнож чадахгүй. Сүмийн дайснууд үүнийг маш сайн ойлгодог. Иймээс тэд Мормоны Номыг гутаахыг урт удаан хугацаагаар махран зүтгэсээр байгаа нь энэ номыг л гутааж чадвал Бошиглогч Иосеф Смитийг ч гутааж чадна хэмээн санаархаж байгаа хэрэг. Санваарын түлхүүрүүд, илчлэлт, сэргээгдсэн Сүмийн талаар бид ийнхүү нотолж байна. Үүнээс үүдэлтэйгээр, хэрэв Мормоны Ном үнэн юм бол, мөн эдүгээ сая сая хүн энэ ном үнэн гэдэг Сүнсний гэрчлэлтэйгээр гэрчилж байгаа тохиолдолд хүн Сэргээлтийн тухай үзэл баримтлал болон үүнтэй холбоотой бүхнийг хүлээн зөвшөөрөх ёстой” (“The Book of Mormon—Keystone of Our Religion,” *Ensign*, 1986 оны 11-р сар, 5–6).



3. Мормоны Номын удиртгалын “Бид хаа газрын бүх хүмүүнийг . . .” гэж эхэлсэн найм дахь догол мөрийг уншиж, Мормоны Ном үнэн гэдгийг чи өөрөө яаж мэдэж болохыг тодорхойл. Энэ догол мөрийг уншсаны эцэст дараах өгүүлбэрийг судрын тэмдэглэлдээ гүйцээж бич: *Хэрэв бид уншиж, тунгаан бодож, залбирах юм бол Ариун Сүнс . . .*


Тулгуурын чулуу нуман хаалганы бусад чулууг тогтоон барьдаг лугаа адил Мормоны Номын тухай гэрчлэл сайн мэдээний бусад чухал зарчмуудын тухай бидний гэрчлэлийг хүчтэй болгодог. Удиртгалын “Ариун Сүнснээс энэхүү бурханлаг гэрчлэлийг олсон хэн боловч . . .” гэж эхэлсэн ес дэх догол мөрийг уншиж, найм дахь догол мөрөн дэх зөвлөгөөг дагаснаас ямар гэрчлэлийг олж болох тухай гурван нэмэлт үнэний доогуур зур. **Хэрэв бид Мормоны Номыг уншиж, тунгаан бодож, залбирах юм бол энэ ном үнэн гэдгийг, Есүс бол Христ, Иосеф Смит бол Бурханы бошиглогч, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм бол газар дээрх Их Эзэний хаант улс гэдгийг Ариун Сүнс бидэнд гэрчлэх болно.**



4. Мормоны Номыг яагаад манай шашны тулгуурын чулуу гэж нэрлэдгийг судрын тэмдэглэлдээ тайлбарла.

Гэрчүүдийн гэрчлэл

Өөрийгөө хоёр талын хооронд үүссэн маргаан ямар учиртайг магадлан тогтоохыг хичээж байгаа шүүгч гэж төсөөлөн бод. Юу болсон тухай гэрчлэх нэг гэрчтэй байх нь яагаад чухал вэ? Харин олон гэрчтэй байх нь яагаад бүр илүү чухал вэ?




Оливер Каудери


Мартин Харрис

Давид Витмер

Иосеф Смитийн орчуулсан Мормоны Номын эх буюу алтан ялтсуудыг Их Эзэн нэлээд хэдэн гэрчид үзүүлсэн юм. “Гурван гэрчийн гэрчлэл”-ийг уншиж, ялтсууд болон Мормоны Ном ирсэн тухай тэдний гэрчлэн хэлсэн гурав, дөрвөн өгүүлбэрийг тэмдэглэ. Дараа нь “Найман гэрчийн гэрчлэл”-ийг унш. Доорх хүснэгтэд харуулсны дагуу хоёр бүлэг гэрчийн туршлага дахь ялгааг ажигла.

Гурван гэрч	Найман гэрч
1. Нэг тэнгэр элч тэдэнд Урим ба Туммим, цээжний хуяг, Лиахона болон Лебений илдийг үзүүлжээ.	1. Иосеф Смит тэдэнд ялтсуудыг үзүүлсэн аж.
2. Бурханы дуу хоолой энэ цэдгийн тэнгэрлэг чанарыг тунхагласан юм.	2. Тэд алтан ялтсуудыг гараараа барьж (“тэмтэрч”) үзжээ.

 **5.** Судрын тэмдэглэлдээ дараах асуултад хариул: Иосеф Смитээс гадна алтан ялтсуудыг гэрчлэх бусад гэрчүүд яагаад чухал байсан бэ?

 **6.** Мормоны Ном, Иосеф Смит, Есүс Христийн сэрэгэгдсэн сайн мэдээний талаарх өөрийн гэрчлэлийг судрын тэмдэглэлдээ бич. Хэрэв одоохондоо өөрт чинь гэрчлэл байхгүй гэж боддог бол, Мормоны Номын тухай гэрчлэлтэй болохын тулд энэ жил юу хийхээ бич. Гэрчлэлээ бат бөх болгохын тулд бичсэн зүйлийнхээ талаар эцэг эхийнхээ нэгэнтэй эсвэл гэр бүлийнхээ аль нэг гишүүн буюу найзтайгаа хуваалц.

 **7.** Дараах өгүүлбэрийг өнөөдрийн даалгаврынхаа доод талд судрын тэмдэглэлдээ бич:

Би “Мормоны Номын удиртгалын материалууд” хичээлийг судалж дууслаа (огноо).

Багштайгаа хуваалцахыг хүссэн миний бодол санаа, ойлголтууд болон нэмэлт асуулууд:

1-Р ХЭСЭГ: 4 ДЭХ ӨДӨР

Мормоны Номын ерөнхий тойм

Оршил

Бошиглогч Иосеф Смит Мормоны Ном ирсэн-тэй холбоотой өрнөсөн үйл явдлуудыг дүрсэлсэн. Энэ шастирыг судалснаар түүний бошиглогчийн дуудлага болон Есүс Христийн сайн мэдээний бүрэн байдал Сэргээгдэхэд Мормоны Номын гүйцэтгэсэн тэнгэрлэг үүргийн тухай чиний гэрчлэл улам гүнзгийрнэ. Энэ хичээл Мормоны Ном эрт үед хэрхэн бичигдсэнийг мэдэхэд чинь туслах болно. Бошиглогч Мормон, Моронай нар алтан ялтсууд дээрх өөрсдийн болон бусад олон бошиглогчдын судруудыг бичиж, эмхэтгэх ажлыг Их Эзэний удирдлагаар хийснээ гэрчилсэн юм. Мормоны Номыг судлах явцдаа энэ номыг авчрахад Их Эзэний мутар хэрхэн оролцсон нотолгоог олж, амьдралыг чинь удирдахад Мормоны Номын гүйцэтгэсэн үүргийн тухай бич.

Гэрчлэлийг хөгжүүлэх нь

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч Бойд К.Пакер, бид бусадтай хуваалцсанаар гэрчлэлээ хэрхэн хөгжүүлж чадах тухай ийн заажээ: “Гэрчлэлээ хуваалцсанаар гэрчлэлийг олж авдаг юм шүү дээ! . . . Уншсан зүйлээсээ эсвэл хэн нэгний хэлсэн үгсээс гэрчлэлийг хүлээн авах нь нэг хэрэг. Энэ бол эхлэх чухал алхам. Харин Сүнс таны гэрчилсэн зүйлс үнэн гэдгийг цээжин дотор тань гэрчлэх нь тэс өөр хэрэг юм” (“The Candle of the Lord,” *Ensign*, 1983 оны 1-р сар, 54–55).

“Бошиглогч Иосеф Смитийн гэрчлэл”


“Танай Сүм Мормоны Номыг яаж олж авсан юм бэ?” гэсэн асуултад чи хэрхэн хариулах вэ?


Мормоны Номын эхэн дэх оршлын материалуудад байдаг “Бошиглогч Иосеф Смитийн гэрчлэл” нь Агуу Үнэт Сувдад байдаг Иосеф Смит—Түүхээс авсан хэсгийг агуулдаг. Энэ нь Мормоны Ном хэрхэн ирснийг Бошиглогчийн өөрийнх нь үгээр дүрслэн харуулдаг. Иосеф Смит—Түүх дэх түүний

үгсийг бүхэлд нь өдөр бүрийн судар судлах цагаараа уншаарай.

“Бошиглогч Иосеф Смитийн гэрчлэл” нь шүлгийн дугааргүй учраас энэ хичээлээр өөрт чинь унших даалгаврыг Иосеф Смит—Түүхээс өгнө. Эндээс унших даалгаврыг олох нь амархан байх болно. Бошиглогч Иосефын гэрчлэлийг судлахдаа **Мормоны Ном** Бурханы хүчээр ирсэн тухай нотолгоог ол.

Иосеф Смит—Түүх 1:29–35, 42–43-ыг уншиж, хэрэв чи тэнгэр элч Моронай Иосеф Смит дээр хүрч ирсэн тухай эдгээр үйл явдлуудыг өөр хүнд тайлбарлах хэрэгтэй болсон үед ашиглах үг хэллэгийн доогуур зур. Иосеф Смит—Түүх 1:34-т, алтан ялтсууд дээр юу агуулагдаж байгаа гэж Моронай хэлсэн бэ?

 **1.** Дараах асуултуудад судрын тэмдэглэлдээ хариул: Хэрэв чи энэ түүхийг өөр хүнтэй хуваалцах боллоо гэвэл Иосеф Смит—Түүх 1:29–35, 42–43-аас ямар зүйлийг онцгойлон авч үзэхийг хүсэх вэ? Энэ нь танд яагаад чухал вэ?

 **2.** Иосеф Смит—Түүх 1:51–54-ийг уншиж, дараах асуултуудын талаарх бодлоо судрын тэмдэглэлдээ бич: Иосеф Смит тэнгэр элч Моронайтай уулзсан эхний уулзалтуудаасаа юу сурсан бэ? Ялтсуудыг олж авч, орчуулахаас өмнө удирдамж авах дөрвөн жилийн хугацаа Иосефт яагаад чухал байсан гэж чи бодож байна?

Бэлтгэл болон удирдамжийн хугацаа дууссаны дараа 1827 онд Иосеф Смитэд ялтсуудыг өгснөөр тэрээр үүнийг Бурханы бэлэг хийгээд хүчээр орчуулах үүргийг хүлээсэн. Иосеф Смит—Түүх 1:59–60-ыг уншиж, тэрээр алтан ялтсуудын талаар ямар үүрэг хүлээснийг ол.

“Мормоны Номын тухай товч тайлбар”


Мормоны Ном ямар зохион байгуулалттайг ойлгохын тулд “Бошиглогч Иосеф Смитийн гэрчлэл”-ийн дараа байдаг “Мормоны Номын тухай товч тайлбар”-ыг унш. Уншсан зүйлээ энэ хичээлийн төгсгөл дэх зурагтай харьцуулж үз. Энэ зурагт олон өөр ялтсууд хэрхэн нийлж, Мормоны Номыг бий болгосныг харуулсан байгаа.

Нифайчууд болон леменчүүдийн түүхэнд олон хүн цэдэг хөтлөгчөөр үйлчилж байв. Тэд Лихайгаар эхэлж, түүнээс хойш 1000 гаруй жилийн дараа бошиглогч-түүхч Мормон түүний хүү Моронай нараар төгссөн юм. Эдгээр эртний бошиглогчдын бичсэн цэдгүүд болон түүний хүмүүсийн 1000 жилийн түүхийг товчлон хураангуйлахад Их Эзэн Мормоныг удирдан чиглүүлсэн ажээ. Түүний хураангуй Мормоны ялтсууд дээр цэдэглэгдсэн бөгөөд эдгээр ялтсуудыг алтан ялтсууд гэдэг. Мормоныг нас барсны дараа түүний хүү Моронай цэдгийг

дуусгаж, нуусан ажээ. Энэ цэдэг Бошиглогч Иосеф Смитэд өгөгдөх хүртлээ газарт булаастай байсан.

Хиламан 3:13–15 бол Мормон нифайчуудын цэдгүүдийг хураангуйлсан тухай судрын нэлээд олон хэсгийн нэг нь юм. Үүнийг уншихдаа Мормон, Моронай хоёр алтан ялтсуудад оруулснаас илүү их зүйл бичигдсэнийг ажигла.

Мормоны Үгс 1:9, Мормон 8:34–35-ыг унш. Их Эзэн Мормоны Номыг цэдэг болгон эмхэтгэхэд Мормон, Моронай нарт хэрхэн тусалж, тэднийг хэрхэн удирдаж байсныг дүрсэлсэн үгс буюу өгүүлбэрүүдийг будаж тэмдэглэ.

 **3.** Дараах асуултад судрын тэмдэглэлдээ хариул: Хэрэв чи Мормон эсвэл Моронай байгаад бошиглогчдын олон боть бичээсүүдийг энгийн цэдэг болгон хураангуйлах үүрэг хүлээвэл, энэ цэдэгтээ юуг оруулах вэ?


Мормоны Номыг бичигчид манай өнөө үеийг угтан харсан бөгөөд бидэнд хамгийн ихээр туслах зүйлүүдийг бичсэнийг бид эдгээр шүлгүүдээс харж болно. Чи үүнийг судартаа Мормон 8:35-ын хажууд тэмдэглэж болно.

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон Мормоны Ном “манай үеийнхэнд зориулагдан бичигдсэн”-ийг гэрчилж, үүнийг мэдэх нь Мормоны Номыг судлахад бидэнд хэрхэн тусалж болохыг тайлбарласан юм.

Эртний нифайчууд, леменчүүд аль алинд нь энэ ном байгаагүй. Энэ номыг бидэнд зориулан бичсэн. Мормон нифайчуудын соёл иргэншлийн



Ялтсууд болон хэвлэгдсэн Мормоны Ном хэрхэн холбогдох тухай



төгсгөлийн үед бичиж байв. Бүх зүйлийг эхлэлээс хардаг Бурханы сүнслэг нөлөөн дор тэрбээр хэдэн зууны цэдгийг товчлон, бидэнд хамгийн чухал үй олон түүх, хэлсэн үгс, үйл явдлуудаас сонгон авч товч хураангуйг хийсэн ажээ. . . .

Хэрэв тэд өнөө үеийг харж, бидэнд агуу үнэ цэнэтэй зүйлсийг сонгосон юм бол бид Мормоны Номыг судлах ёстой биш үү? Их Эзэн юуны учир үүнийг цэдэгтээ оруулахад Мормонд (эсвэл Моронайд болон Алмад) сүнслэгээр нөлөөлсөн юм бол? Энэ номоос би яг одоо юу сурч болох вэ? гэж бид өөрөөсөө үргэлж асуух ёстой” (“The Book of Mormon—Keystone of Our Religion,” *Ensign*, 1986 оны 11-р сар, 6).

Иймэрхүү асуултуудыг судар судалж байх үедээ өөрөөсөө асуух нь амьдралд чинь хамгийн их тустай байх болно хэмээн Их Эзэний мэдэж байсан зарчмууд болон сургаалуудыг нээхэд чамд туслах болно.

Яг одоо амьдрал чинь ямар байгааг бод. Өөрөөсөө асуултууд асуух буюу өөртөө тохиолдсон нөхцөл байдлын талаар тунгаан бодох нь Бурханаас удирдамж авах боломжийг чамд бүрдүүлж өгөх болно. Тэдгээр асуултууд буюу нөхцөл байдлуудаас нэг юм уу хоёрыг хувийн тэмдэглэлдээ (багшдаа үзүүлдэг судрын тэмдэглэлдээ *биш*) бич. Мормоны Номыг өдөр бүр судлах явцдаа дээрх нөхцөл байдлуудтай холбоотой удирдамж буюу зөвлөгөөг санал болгосон зарчмуудыг ол.



Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли судруудыг өдөр бүр судалж байх талаар ийн хэлсэн: “Та нар өөрийгөө дэндүү завгүй байдаг хэмээн боддог байж болох юм. Судруудыг ялангуяа Мормоны Номыг өдөрт арваас арван таван минут унших нь Бүхнийг Чадагч Өөрийн хүчээр хүүхдүүдээ адислахын тулд бэлтгэсэн мөнхийн агуу үнэнүүдийн тухай гайхамшигтай мэдлэгийг та нарт өгөх болно. Та нар судруудыг ийнхүү уншвал. . . , бидний авралын зохиогч болох Түүнд улам ойртох болно” (“Rise to the Stature of the Divine within You,” *Ensign*, 1989 оны 11-р сар, 97).



4. Энэ жил Мормоны Номыг уншиж, судалснаасаа хамгийн их ашиг тусыг олоход туслах ямар зорилго тавихаа тунгаан бод. Тавьсан зорилгоо судрын тэмдэглэлдээ бич. Өөрийн өсөлт хөгжилтөд үнэлэлт өгөхийн тулд тогтмол цаг гаргаж болно.



5. Дараах өгүүлбэрийг өнөөдрийн даалгаврынхаа доод талд судрын тэмдэглэлдээ бич:

Би “Мормоны Номын ерөнхий тойм” хичээлийг (огноо)-нд судалж дуусгалаа.

Багштайгаа хуваалцахыг хүссэн миний бодол санаа, ойлголтууд болон нэмэлт асуултууд:

1 Нифайн

ОРШИЛ

Яагаад энэ номыг судлах хэрэгтэй вэ?

Та нар 1 Нифайг судалснаар, “итгэлийнх нь учир тэднийг хүчтэй болгохоор сонгосон бүгдийн дээр Их Эзэний нигүүлсэл байдаг” (1 Нифай 1:20)-ийг илрүүлэн нээх болно. Жишээ нь: Та нар, Нифайн гэр бүл судруудтай байхын төлөө Бурхан Нифайд гуулин ялтсуудыг олж авахад нь хэрхэн тусалсныг, Нифайн амь насанд аюул учрах үед хэрхэн аварсныг мөн Лихай болон түүний хүмүүсийг цөлд өлсгөлөнгөөс бас далайд живж үхэхээс хэрхэн аварч, тэднийг амлагдсан нутагт хэрхэн эсэн мэнд хүргэснийг мэдэх болно.

Лихай болон түүний хүмүүс зарлигуудыг сахиснаар Бурханы нигүүлсэл ба тусламжийг биеэрээ мэдэрсэн юм. Лихай Нифай хоёр Бурханаас удирдамж хүсч үүнийгээ судрууд, зүүд, үзэгдэл болон Лиахонагаар дамжуулан хүлээж авдаг байлаа. Нифай, Бурханы бүхнийг мэдэгч хүчийг түүнд харуулсан дэлхийн түүхийн тухай үзэгдлийг хүлээн авч мөн тэмдэглэсэн юм. Нифай үзэгдлүүдээр дамжуулан Есүс Христийн ирээдүйн баптисм, үйлчлэл ба цовдлуулалтыг харсан ажээ.

Та нар энэ номон дахь Нифай Лихай нарын туршлагыг судалснаар, тэнгэрийн адислалуудыг амьдралдаа хүлээж авахын төлөө хэрхэн хичээн зүтгэвэл зохихыг мэдэж чадна.

Энэ номыг хэн бичсэн бэ?

Лихайн хүү Нифай энэ номыг, хүмүүсийнхээ цэдэг хөтлөх тухай Их Эзэний зарлигийн хариуд бичсэн юм. Нифай Иерусалимын ойролцоо төрсөн бололтой. Тэрээр, бошиглогч Иеремиагийн үйлчлэл болон Хаан Зедикаягийн хаанчлалын үед амьдарч байжээ.

Нифай, Иерусалим устгагдах тухай болон гэр бүл нь яагаад тэндээс явах хэрэгтэй болсон талаарх аавынхаа үгсийн тухайд өөрийн гэрчлэлтэй болохыг хүсч байлаа. Нифай Их Эзэний зөвлөгөөг эрэлхийлж дагахын хэрээр Бурханы мутарт зэмсэг нь болсон юм. Тэр ах нартайгаа хамт Иерусалимд хоёр удаа— эргэж очсон бөгөөд эхний удаа гуулин ялтсуудыг олж авахын тулд, хоёр дахь удаад Ишмэилийн гэр бүлийг цөлд Лихайн гэр бүлтэй нэгдэхийг ятгахаар дуулгавартайгаар буцаж очжээ. Далайг гатлан амлагдсан нутаг руу гэр бүлийг нь авч явсан усан онгоцыг Нифай Их Эзэний тусламжтайгаар барьсан юм. Лихайг нас барсны дараа Нифай түүний хүмүүсийн удирдагч болов.

Энэ ном хаана, хэзээ бичигдсэн бэ?

Энэхүү шастирыг Нифай ойролцоогоор мээ 570 оны орчим—түүний гэр бүл Иерусалимыг орхин явснаас хойш 30 жилийн дараа бичжээ (2 Нифай 5:28–31-ийг үзнэ үү). Тэр үүнийг Нифайн нутагт байхдаа бичсэн ажээ.

2-Р ХЭСЭГ: 1 ДЭХ ӨДӨР

1 Нифай 1


Оршил


Мормоны Ном нь бошиглогч болон гэр бүлийнхээ санваартны удирдагчийн үүргийг итгэлтэйгээр биелүүлсэн эцэг Лихайнхаа тухай бичсэн Нифайн шастираар эхэлдэг. Лихайн үйлчлэлийг ойлгох нь өнөө үеийн бошиглогчдын үүргийг илүү сайн ойлгоход бидэнд тусалж чадна. Тэр бол “[Иудейчүүдийг] наманчлах ёстой хэмээн бошиглож байсан олон бошиглогчдын” (1 Нифай 1:4) нэг байлаа. Лихай Бурханд дуулгавартай байж, Иерусалимын устгалын тухай бошиглож байсан учраас хүмүүс түүнийг шоолж, алахыг эрэлхийлж байв. Гэсэн ч Лихай Их Эзэний нигүүлсэл ба чөлөөлөлтийн хүчинд баярлаж байлаа. Та нар 1 Нифай 1-ийг судлахдаа таны амьдралд Бурханы нигүүлсэл ба оролцоо хэрхэн харагдсан тухай тунгаан бод.

1 Нифай 1:1–3

Нифай цэдгээ эхэлсэн нь

1 Нифай 1:1-ийг уншиж, Нифайн амьдрал ямархуу байсан тухай өгүүлсэн түлхүүр үг хэллэгүүдийг ол.

 **1.** 1-р шүлгээс уншсан зүйлээсээ таны амьдрал Нифайн амьдралтай ямар талаараа адил төстэйг судрын тэмдэглэлдээ бичнэ үү.

 **2.** Дараах асуултад судрын тэмдэглэлдээ хариулж бич: Нифай

Судар судалснаар ирдэг адислалууд

Семинарын суралцагч танд энэ жил тохиож байгаа болмжуудын нэг нь Мормоны Номыг унших юм. Судруудыг унших нь Их Эзэнтэй харилцах харилцааг тань бэхжүүлэх болно. Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимбалл: “Би Бурхантай харилцах харилцаандаа хайнга байсан үед сонсох тэнгэрлэг чихгүй, ярих бурханлаг дуу хоолойгүй, хаа хамаагүй хол байгаа юм шиг санагддаг байлаа. Хэрэв би судруудыг шимтэн судалбал холын зай ойртож, сүнслэг байдал эргэж ирнэ” гэж заажээ (*Teachings of Presidents of the Church: Spencer W. Kimball* [2006], 67).

“өчнөөн зүдгүүрийг туулсан ч “Их Эзэний өндөр ээл хишиг”-ийг хэрхэн хүртсэн гэж та бодож байна вэ?

1 Нифай 1:4–20

Лихай үзэгдэл хүлээн авч, Иерусалим устгагдах тухай хүмүүст сэрэмжлүүлсэн нь

Эцэг эх тань эсвэл Сүмийн удирдагчид ямар нэг аюултай зүйлийн тухай өөрт тань сэрэмжлүүлсэн үеийн тухай бод. Өөрийг тань сэрэмжлүүлсэн тэдний учир шалтгаан юу байсан бэ?

Тэнгэрлэг Эцэг биднийг хайрладаг бөгөөд бидэнд хор хөнөөл учруулагч нүглээс ангид, аюулгүй байхыг биднээс хүсдэг. Бурхан бошиглогчдоор дамжуулан хүүхдүүдээ сэрэмжлүүлдэг нь Түүний ашигладаг арга замуудын нэг юм. **Бошиглогчид нүглээс сэрэмжлүүлж, Есүс Христээр дамжин ирдэг авралын тухай заадаг.** 1 Нифай 1-ийг судлахдаа энэ зарчмын нотолгоог ол. Хэрэв хүмүүс наманчлахгүй бол тэдэнд юу тохиолдох тухай олон бошиглогч номлож, сэрэмжлүүлж байсан тухай Нифай бидэнд ярьснаар цэдгээ эхэлжээ (1 Нифай 1:4). 1 Нифай 1:5–7-г уншиж, Лихай юуны талаар, хэрхэн залбирч байсныг судартаа тэмдэглэ. Их Эзэнд хандсан Лихайн залбирал нь тэрээр бошиглогчдын хэлсэн зүйлсэд итгэдэг байсныг харуулдаг.

1 Нифай 1:8–10-ыг уншиж, Лихайн үзэгдэлд харсан бүх зүйлийг дугуйл.

Бурхан

Тэнгэр элчүүд

Есүс Христ

Бусад Арванхоёр

1 Нифай 1:11–12-ыг уншиж, өөрт нь өгсөн номыг Лихай уншихад түүнд юу тохиолдсоныг анхаар. Их Эзэн энэ илчлэлтээр дамжуулан Лихайг Иерусалимын хүмүүсийн дунд үйлчлэхэд бэлтгэсэн юм.



1 Нифай 1:13-ыг уншиж, Лихай Иерусалимын талаар юу заасныг тэмдэглэ. Та уншихдаа өөрийгөө Лихайн оронд тавьж, эдгээр зүйлс гэр оронд тань болон төрөлх хотод тань тохиолдоно гэж Их Эзэн хэлсэн бол танд ямар санагдахыг төсөөлөн бод.

Өөрийнх нь хүмүүс болон төрөлх хот нь устгагдах болно хэмээн сэрэмжүүлсэн нь Лихайд үнэхээр хүнд байсан нь тодорхой. Гэсэн ч Лихай Иерусалимыг устгагдах болно гэдгийг мэдсэн хэрнээ яагаад баяртай байсныг, 1 Нифай 1:14–15-ыг уншиж ол.



3. Дараах асуултын талаарх бодлоо судрын тэмдэглэлдээ бич: 1 Нифай 1:5–15 дахь Лихайн туршлага нь хүмүүст зааж, тэднийг наманчлалд урих түүний хүсэлд хэрхэн нөлөөлсөн байж болох вэ?

Лихай Иерусалимын талаар сэрэмжлүүлэгдсэний дараа мэдсэн зүйлийнхээ тухай Иерусалимын хүмүүстэй хуваалцжээ. Хэрэв тэд наманчлахгүй бол устгагдах болно гэдгийг тэр тэдэнд сануулсан ажээ. 1 Нифай 1:18–20-ийг уншиж, Иерусалимын хүмүүс хэрхэн хариулсныг ол. Өөрийгөө нэг сонины эрхлэгч гэж бодоод 1 Нифай 1:18–20-ийн талаар тэргүүн өгүүлэл бичих болжээ гэж төсөөл. Таны өгүүлэл ямар байх вэ? _____

Дараах үгийг тунгаан бод:

“Эртний бошиглогчдын адил өнөөдөр бошиглогчид Есүс Христийг гэрчилж, Түүний сайн мэдээг заадаг. Тэд Бурханы хүсэл болон үнэн бодит шинж чанарыг гаргаж ирдэг. Тэд нүглийг буруушаан, үүний үр дагаврыг сануулан ил тод зоригтойгоор хэлдэг. Зарим үед тэд бидний тусын тулд ирээдүйн үйл явдлыг бошиглохоор бурханлигаар нөлөөлөгдөж болно (Итгэлдээ үнэнч байх нь [2004], 57).



4. Бошиглогч хүн эсэргүүцэлтэй тулгарлаа ч гэсэн ямар үүрэг хариуцлага хүлээдэг тухай нэг өгүүлбэрийг судрын тэмдэглэлдээ өөрийн үгээр бич.

Нифай аавдаа тохиолдсон Иерусалим дахь туршлагын талаар бичихдээ 1 Нифай 1:20-р шүлгийн дунд “Гэвч болгоогтун, . . . би, Нифай та нарт үзүүлэх болно . . .” гэсэн хэллэгээр эхэлсэн захиасыг уншигчид зориулан нэмсэн юм. Нифай бичээстээ тодорхойлсон нэгэн сэдвийг энэхүү шүлгээр илэрхийлсэн байдаг. 1 Нифай 1:20 дахь энэ сэдвийн доогуур зураад, Моронай 10:3-ыг уншиж, үүнтэй адил сэдвийг ол. (Моронай бол Мормоны Номын бошиглогчдын

сүүлчийнх нь байсан юм. Нифайн үеэс Моронайн үе хүртэлх хугацаа нь 1000 жил орчим байсан.)

Нифай, Мормоны Номын нэгдүгээр бүлэгт “Их Эзэний нигүүлсэл” байдгийг (1 Нифай 1:20) бидэнд үзүүлэх болно хэмээн бичээстээ мэдэгдсэн байгааг анхаар. Моронай, Мормоны Номын сүүлчийн бүлэгт “Их Эзэн хэчнээн нигүүлсэнгүй байсаар буйг” (Моронай 10:3) бидэнд сануулсан юм.



Нифай цэдгийнхээ бүр эхнээс, **Их Эзэн Өөрт нь итгэдэг хүмүүст нигүүлсэнгүй ханддаг гэдгийг ойлгохыг биднээс хүссэн юм.** Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Дэвид А. Бэднар, Их Эзэний нигүүлсэл бидний

амьдралд хэрхэн хэрэгждэгийг тайлбарлажээ.

Түүний тайлбарыг уншихдаа “Их Эзэний нигүүлсэл”-ийг дүрслэхийн тулд Ахлагч Бэднарын ашигласан үг хэллэгүүдийг дугуйл:

“Их Эзэний нигүүлсэл бол нэн хувийн шинжтэй өөрөөр хэлбэл, Их эзэн Есүс Христээс бидний хүлээн авдаг болон Түүгээр дамжуулан ирдэг адислал, хүч чадал, хамгаалалт, баталгаа, удирдамж, хайрын нинжин сэтгэл, тайтгаруулал, дэмжлэг, сүнсний бэлэг нь хувь хүнд зориулагдсан байдаг. . . .

. . . Их Эзэний нигүүлсэл хэн нэгэнд тохиолдлоор эсвэл санамсаргүйгээр ирдэггүй. Итгэл бишрэл, дуулгавартай байдал, даруу зан бидний амьдралд нигүүлслийг урьдаг бөгөөд ихэнхдээ эдгээр чухал адислалуудын үнэ цэнийг ойлгох боломжийг бидэнд олгодог нь Их Эзэний цаг хугацааны дагуу ирдэг.” (“The Tender Mercies of the Lord,” *Ensign* ба *Лиакхона*, 2005 оны 5-р сар, 99–100).



5. Дараах асуултад судрын тэмдэглэлдээ хариулж бич: Их Эзэн таны болон таны таньдаг хэн нэгний амьдралд нигүүлслээ үзүүлсэн ямар жишээг та харсан бэ?

Их Эзэн танд нигүүлслээ хэрхэн үзүүлснийг олж хувийн тэмдэглэлдээ бичиж эхэл, эсвэл үргэлжлүүлэн бич. Ингэснээр та, Бурхан өөрийг тань хэрхэн адисалсныг амархан олж харна.



6. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би 1 Нифай 1-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

2-Р ХЭСЭГ: 2 ДАХЬ ӨДӨР

1 Нифай 2

Оршил

Хүмүүс Бурханы илчлэлтэд янз бүрээр ханддаг. Их Эзэн Лихайд, гэр бүлээ цөл рүү авч явахыг зүүдэнд нь зарлиг болгожээ. Нифай, батлах гэрчлэгчийг хайсан бол Лемен Лемүел хоёр Бурханы зарлигуудад дургүйцэн бувтналдаж байв. Тэдний ялгаатай хандлагуудыг харьцуулах нь Их Эзэний удирдамжид хариулахын тулд, сонгох эрхээ хэрхэн ашиглахаа шийдэхэд тань туслах болно.

1 Нифай 2:1–7

Бурхан Лихайд цөл рүү явахыг зарлиг болгосон нь

Өөрийгөө Лихайн оронд тавьж, Их Эзэн танаас болон таны гэр бүлээс гэр орноо бас бүх өмч хөрөнгөө орхихыг хүсчээ хэмээн төсөөлөн бод. Та олон өдөр явган явах учраас зөвхөн гэр бүлийнхээ хэрэгцээт зүйлсийг л авч явж чадна. Ийм хүсэлтэнд хэрхэн хандах тухайгаа бод.

1 Нифай 2:1–6-г уншиж, Лихай болон түүний гэр бүлийг цөл рүү явахад хүргэсэн нөхцөл байдлыг ол.

Хүмүүс яагаад “[Лихайн] амийг бүрэлгэхээр эрэлхийлж” байсан бэ? (1 Нифай 2:1-ийг үзнэ үү.) _____

Их Эзэн Лихайд юу хийхийг зарлиг болгосон бэ? (1 Нифай 2:2-ыг үзнэ үү.) _____

Бид итгэлтэй бөгөөд дуулгавартай байвал хүнд сорилт тулгарсан үед Их Эзэн бидэнд туслах болно гэсэн сайн мэдээний зарчмын жишээ бол Лихай юм.





1. 1 Нифай 2:4-ийн тухай дараах асуултад судрын тэмдэглэлдээ хариулж бич: Юугаа авч явах болон юугаа үлдээх сонголт хийсэн Лихайн жишээнээс та юу сурч болох вэ?

Лихайн аяны газарзүйн байршлыг илүү сайн ойлгохын тулд хичээлийн төгсгөл дэх газрын зургийг сайн үз.

1 Нифай 2:7-г уншиж, Лихай гэр бүлээ авч цөл рүү гарсныхаа дараа юу хийснийг ажигла. Лихайн зан чанарын чухал талыг дүрслэхийн тулд та ямар үг ашиглаж болох вэ? _____

1 Нифай 2:8–14

Лемен Лемүел хоёр аавыгаа эсэргүүцэн бувналдсан нь

Лихайн дөрвөн хөвгүүн бүгдээрээ аянд гарсан ч Бурханы зарлигуудад өөр өөрөөр хандсан юм.

1 Нифай 2:8–10-ыг судалж, гол, хөндий гэсэн үгсийг дугуйл.



2. Дараах асуултын тухай бодлоо судрын тэмдэглэлдээ бич: Лихай, Лемен Лемүел хоёрыг гол болон хөндийтэй зүйрлүүлснээр тэдэнд юуны тухай заахыг хичээсэн гэж та бодож байна?

1 Нифай 2:11–14-ийг уншиж, Лемен Лемүел хоёр эцэгтээ дургүйцсэн шалтгааныг ол. (*Анхааруулга: Зөрүүд араншин гэдэг үг гэжүүд зан ба бардамнал гэсэн утгатай.*)

Сатан дургүйцлийг өөгшүүлэн дэмждэгийн нэг шалтгаан нь хүмүүсийг амьд бошиглогчид, сүнслэг нөлөө бүхий удирдагчид, эцэг эхээс нь холдуулахыг хүсдэг явдал юм. Далын Ахлагч Х.Росс Веркман дургүйцлийн тухай: “Дургүйцэл гурван үе шаттай бөгөөд үе шат бүр нь дараагийнх руугаа шилжихдээ дуулгаваргүй байдал руу нэг шатаар урууддаг” хэмээн хэлжээ.



Нэгдүгээрт, хүмүүс дургүйцэхдээ өөрсдийнхөө бодол санааг эн тэргүүнд тавьж, амьд бошиглогчдын сургаалуудад эргэлздэг. “Тэд эхлээд өөрсдийнхөө оюун ухаанд [эргэлзэж], дараа нь бусдын оюун ухаанд эргэлзээг [бий болгодог].

Хоёрдугаарт, дургүйцдэг хүмүүс “өөрт нь хий хэмээн зааварласан зүйлд дургүйцсэнээ зөвтгөх шалтаг эрж, өөрийгөө өмгөөлдөг. . . Тийнхүү тэд дуулгаваргүй байдлаа зөвтгөх шалтаг олдог.

“Үүнээс зайлшгүй үүдэлтэй гурав дахь алхам нь: Тэд Эзэний зарлигийг дагахаас хойргошин залхуурдаг [С ба Г 58:29-ийг үзнэ үү]. . . .

“Санаа сэтгэлийг тань хамгийн их зовоосон асуудлуудаараа, амьд бошиглогчдоос өгсөн зарлигт

анхаарлаа төвлөрүүлэхэд би та бүхнийг урьж байна. Зарлиг өөрт тань хамаатай эсэх талаар та эргэлздэг үү? Та аль нэг зарлигийг яагаад одоо сахиж болохгүй талаар шалтаг хайдаг уу? Өөрт тань зарлигийн тухай сануулсан хүмүүст та дургүйцэх эсвэл эгдүүцдэг үү? Зарлигийг сахихад та залхуурдаг уу? Сатаны заль мэхээс болгоомжил. Дургүйцлээс болгоомжил (“Beware of Murmuring,” *Ensign*, 2001 оны 11-р сар, 85–86).



3. Дараах асуултад судрын тэмдэглэлдээ хариулж бич: Аль нэг зарлиг юм уу Сүмийн жишгийн талаар та өөрөө дургүйцсэнээ (эсвэл үглэн гомдоллосноо) мэдвэл яах вэ?

1 Нифай 2:16–19

Нифай Их Эзэнээс мэдлэгийг хүссэн нь

1 Нифай 2:16, 19-ийг уншиж, Нифай юу хийхийг хүссэн болон ааваараа дамжин ирсэн Их Эзэний зарлигуудыг хүлээн авахад хүргэсэн зүйлийг тэмдэглэ. Нифай хэдийгээр дургүйцээгүй ч гэсэн 1 Нифай 2:16-д түүний бичсэнээс үзэхэд Иерусалимыг орхин явах нь түүнд ч бас хэцүү байсан учир Их Эзэн түүний зүрх сэтгэлийг хэрхэн уяруулан зөөлөн болгосон тухай бод.



4. Нифайн адилаар та Тэнгэрлэг Эцэгт хандан залбирсны дараа Ариун Сүнс зүрх сэтгэлийг тань уяруулан зөөллөсөн эсвэл Их Эзэний хэлсэн ямар нэг зүйлийн талаар гэрчлэлтэй болсон үеийнхээ нэг жишээг судрын тэмдэглэлдээ хуваалц.

Нифайн туршлага бидэнд дараах сайн мэдээний зарчмыг заадаг: **Бид Бурханд хандан залбирсан үед Тэрбээр, Түүний үгсэд итгэхээр болгож бидний зүрх сэтгэлийг зөөллөдөг.**





1 Нифай 2:17–18-ыг уншиж, Нифайн зүрх сэтгэлийг Их Эзэн зөөлрүүлсний дараах түүний хүсэл эрмэлзэл, үйлдлүүдийг тодорхойл. Нифай, Сам, Лемен, Лемүел нарын ялгаатай хариу үйлдлүүдээс юу сурч болох тухай бод. Дараах зүйл бол нэгэн чухал үнэн мөн: **Бид Ариун Сүнсээр дамжуулан сурсан зүйлээ хуваалцсан үед бусад хүмүүс бидний үгэнд итгэж болно.**



5. Сам Нифайд итгэсний адилаар хэн нэгний үгс өөрийг тань итгэхэд хүргэсэн үеийн тухай судрын тэмдэглэлдээ бич.

Ямар нэг зүйлийг үнэн гэдгийг мэдэхэд Сүнс танд тусалсан тухай хуваалцаж болох хэн нэгний тухай бод. Энэ хүн таны найз, гэр бүлийн аль нэг гишүүн эсвэл Сүмийн удирдагч юм уу багш тань байж болно. Энэ хүнтэй энэ долоо хоногт ярилцаж, гэрчлэлээ хуваалцах боломж гарга.

1 Нифай 2:20–24

Их Эзэн Нифайд, тэрээр дуулгавартай байдлынхаа ачаар хөгжин дэгжих болно гэсэн итгэлийг төрүүлжээ

1 Нифай 2:20–21 дэх амлалтыг олж, тэмдэглэ. Энэ амлалт Мормоны Номонд 34 удаа давтагддаг. Мормоны Номыг судлах явцдаа Нифайд хандаж хэлсэн Их Эзэний үгс хэрхэн биелснийг та харах болно. 1 Нифай 2:22–24-ийг уншиж, өнөөдрийн хичээлийг дуусга.

Бурхан, дуулгавартай бөгөөд итгэлтэй хүмүүсийг адисалдаг. Бурханы зарлигуудыг сахихдаа та хэр зэрэг дуулгавартай байдгаа тунгаан бод. Таны хувьд илүү дуулгавартай байх нэг арга зам юу вэ? Сүнснээс хүлээн авсан мэдрэмжээ дуулгавартай дага.



6. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би 1 Нифай 2-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

2-Р ХЭСЭГ: 3 ДАХЬ ӨДӨР

1 Нифай 3–4

Оршил

Их Эзэн Лихайд, хөвгүүдээ Иерусалим руу буцаан явуулж, Лебенээс гуулин ялтсуудыг авчруул хэмээн зарлиг өгөв. Лемен Лемүел хоёр энэ зарлигийг хэрхэн биелүүлэхийг мэдэхгүй байсан бол Нифай, Их Эзэн шаардсан зүйлээ биелүүлэх арга замаар хангана гэдэгт итгэлтэй байлаа. Удаа дараа бэрхшээл тохиолдсон ч Нифай Их Эзэний хүссэн зүйлийг биелүүлэхийн төлөө итгэлтэйгээр үргэлжлүүлэв. Тэгсний үр дүнд тэр Ариун Сүнсээр удирдуулж, ялтсуудыг олж авч чадсан билээ. Шаргуу дуулгавартай байдал, хүнд үед Их Эзэний тусламжийг авахад биднийг тэнцэхээр болгодгийг Нифайн туршлага харуулж байна.

1 Нифай 3:1–9, 19–20

Лихайн хөвгүүд Иерусалимд буцаж очсон нь

Хүнд байдалтай тулгарч үүнийг хэрхэн шийдвэрлэхийг мэдэхгүй үе танд тохиолдож байсан уу? Өнөөдрийн хичээл, хүнд сорилттой тулгарсан үед итгэлээ бэхжүүлж, шийдвэр төгс, дуулгавартай байхад тань туслах болно. 1 Нифай 3:1–6-г уншиж хичээлээ эхэл. Их Эзэн Лихайгаар дамжуулан хөвгүүдэд нь өгсөн зарлигийг судартаа тэмдэглэ. Мөн Лемен Лемүел хоёр, Их Эзэний зарлигт Нифайн хандлагын эсрэг хэрхэн хандсаныг анхаар.

Их Эзэний зарлиг болгосон зүйл үнэхээр хэцүү байсныг ойлгохын тулд Иерусалимаас Улаан тэнгис (Акабагийн булан) хүртэл 290 км хол газар, дээрэмчид орогносон, хуурай, халуун цөлийг гатлах шаардлагатай байсныг мэдэх нь ашиг тустай байж болно. Лихай болон түүний гэр бүл энэ газраас яваад гурван өдөр өнгөрч (1 Нифай 2:5–6) байтал Их Эзэн хөвгүүдийг нь Иерусалим руу буцах хэрэгтэй гэж хэлсэн ажээ. 1 Нифай 3:7–8-ыг уншиж, Нифай Их Эзэний зарлигийг дуулгавартай дагах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн шалтгааныг ол.

Хэрэв бид Их Эзэний зарлигийг биелүүлбэл Тэр үүнийг гүйцэлдүүлэх арга замыг бэлтгэх болно гэсэн зарчмыг Нифай гэрчилсэн юм.

1 Нифай 3-ыг үргэлжлүүлэн судлахдаа Нифайн эр зориг, шийдвэр төгс байдлын үлгэр жишээ нь илүү дуулгавартай байж, Их Эзэнд итгэх агуу итгэлээ харуулахад маань хэрхэн сүнслэгээр нөлөөлж болох тухай бод. Нифай, хүнд сорилт бэрхшээлүүдэд хэрхэн хандаж байсанд анхаарлаа онцгойлон хандуул. Ах нарынхаа хамт гуулин ялтсуудыг олж авах үед

Нифайд бэрхшээл тохиолдсон ч тэр дургүйцэж, үглэн гомдоллоогүй юм (1 Нифай 3:6).

Гуулин ялтсууд тэдний судар болох “Иудейчүүдийн цэдгийг” (1 Нифай 3:3) агуулж байжээ. Гуулин ялтсууд эдүгээ Хуучин Гэрээнд байдаг зарим бичээсүүд болон мэдээллийг түүнчлэн бошиглолын бусад бичээсүүдийг агуулж байжээ. 1 Нифай 3:19–20-ийг уншиж, гуулин ялтсуудыг Лихайн гэр бүл болон тэдний үр удмынханд тийм их ач холбогдолтой болгосон зүйлсийн доогуур зур.

Төгс эзэмших судар—1 Нифай 3:7

1 Нифай 3:7-г гурван удаа унш (эхэлж чанга уншаад дараа нь чимээгүй унших зэргээр унших байдлаа өөрчилж болно). Судраа хаагаад, шүлгийг харалгүйгээр дараах асуултуудад хариулж бичихийг хичээ:

- Нифай хэнд хандаж ярьсан бэ? _____
- Нифай юу хийхээр шийдсэн бэ? _____
- Их Эзэн яана гэдгийг Нифай мэдэж байсан бэ? _____

Судраа нээгээд 1 Нифай 3:7-г уншиж, хариултаа шалга.

Бошиглогч Иосеф Смит ийн хэлжээ: “Их Эзэн зарлигласан л бол үүнийг биелүүл гэдэг дүрмийг би өөртөө бий болгосон юм” (*History of the Church*, 2:170). Энэ өгүүлбэрийг судартаа 1 Нифай 3:7-гийн дэргэд бич.


1 Нифай 3:10–31


Лебен Лихайн өмчийг хулгайлж, Нифай болон ах нарыг нь алахыг оролдсон нь

Бид Бурханы зарлигуудыг сахих үед Тэр биднийг олон янзын арга замаар адисалдаг. Гуулин ялтсуудыг олж авсан Нифайн туршлага нь Бурхан хүүхдүүдээ зарлигуудыг нь биелүүлэх арга замаар хангадаг гэсэн түүний гэрчлэлийг баталж байна (1 Нифай 3:7-г үзнэ үү). Гуулин ялтсуудыг олж авах гэсэн Лихайн хөвгүүдийн эхний хоёр удаагийн оролдлогыг судлахын тулд дараах хүснэгтийг ашигла. Оролдлого бүрд зориулсан багананд асуултуудын хариултыг бич, эсвэл энэ даалгаврыг судрын тэмдэглэлдээ хий.

Анхааруулга: Нифайн үед шавга орхих нь сонголт хийх тогтсон журам байжээ (1 Нифай 3:11-ийг үзнэ үү). Нифай болон түүний ах нар шавга орхисон нь гуулин ялтсуудыг олж авах зарлигийг биелүүлэхэд Их Эзэнээс удирдамж хүлээж авах зорилготой байжээ (Сургаалт Үгс 16:33; Bible Dictionary, “Lots, Casting of”-ыг үзнэ үү).

Асуултууд	Анхны оролдлого (1 Нифай 3:10–18)	Хоёр дахь оролдлого (1 Нифай 3:21–31)
1. Хэн хэн явсан бэ?		
2. Тэд юу хийсэн бэ?		
3. Оролдлого бүтэлгүйтсэнд ах дүү нар хэрхэн хандсан бэ?		

 **1.** Гуулин ялтсуудыг авах анхны оролдлого бүтэлгүйтсэний дараа Нифай болон түүний ах нар “ихэд харамсав” (1 Нифай 3:14). 1 Нифай 3:15–16-г нэгтгэн дүгнэж, эхний удаа бүтэлгүйтэхэд Нифайн хандлага ах нарынхаасаа хэр зэрэг өөр байсныг судрын тэмдэглэлдээ дүрслэн бич.

 **2.** Хоёр дахь оролдлогыг (1 Нифай 3:21–31) тунгаан бодсоны эцэст дараах асуултад судрын тэмдэглэлдээ хариулж бич: Уур уцаар, дургүйцэн гомдоллох болон итгэлгүй байх нь Бурханыг сонсоход бидэнд хэрхэн саад болдог вэ?

1 Нифай 4:1–26

Нифай гуулин ялтсуудыг олж авсан нь

1 Нифай 3:31-д Лемен Лемүел хоёрын асуусан асуултуудыг ол. Хэрэв та Нифайн оронд байсан бол тэдний асуултуудад юу гэж хариулах вэ? 1 Нифай 4:1–3-ыг уншиж, Нифай ах нарынхаа асуултуудад хэрхэн хариулсныг ол. Нифай тэдний асуултуудад хариулахдаа яагаад Мосе болон Улаан тэнгисийг жишээ болгон татсан гэж та бодож байна? Ах нартаа өгсөн Нифайн хариултаас сүнслэг нөлөөтэй гэж үзсэн хэсгийг бич. _____

Израилын хүүхдүүдийг Египетээс гаргаж авчир гэж Мосед хэлэхэд энэ нь мөн л боломжгүй юм шиг түүнд санагдаж байсан билээ. Олон удаа оролдсон ч тэр израилчуудыг чөлөөлж явуулахад Фараоныг итгүүлж чадаагүй юм. Гэвч Мосе Их Эзэний өөрт нь зарлиг болгосон зүйлийг биелүүлэхийн төлөө шаргуу тэмцсэн учир Их Эзэн израилчуудыг чөлөөлөх арга замыг түүнд өгсөн юм.

Нифай Мосегийн жишээг өөрт нь тулгарсан нөхцөл байдалд ашигласан бөгөөд гуулин ялтсуудыг яаж ийгээд олж авахад Бурхан түүнийг арга замаар хангана гэдэгт итгэлтэй байлаа. Энэ түүхийн үлдсэн хэсгийг судлахдаа эхний оролдлогууд нь




бүтэлгүйтсэн ч Нифай няцашгүй, дуулгавартай, эршийдэмгий байсны үр дүнг эрж ол.

Яагаад, хэзээ, яаж гэдэг нь тодорхойгүй боловч ямар нэг ажлыг хийх шаардлага өөрт тань тулгарч байсан уу? Эсвэл ийм зүйлийг хийхээр сүнслэгээр нөлөөлөгдөж байсан уу? Бид ийм нөхцөл байдалд Их Эзэний удирдамжийг дагахаасаа өмнө хийх ёстой зүйлээ ихэвчлэн “эхнээс нь аваад эцсийг хүртэл” харахыг хүсдэгийг Ерөнхийлөгч Харолд Б.Лий ажиглаад дараах зөвлөгөөг өгсөн юм: “Та гэргийн ирмэг рүү алхаж сурах ёстой, тэгээд харанхуй руу хэдэн алхам хийх хэрэгтэй. Тэгвэл гэрэл харагдаж, бидний өмнөх замыг гэрэлтүүлэх болно” (Боид К. Пакэр, “The Edge of the Light,” *BYU Today*, 1991 оны 3-р сар, 23-т эш татжээ).

1 Нифай 4:4–7-г уншиж, Нифай итгэлээрээ хэрхэн харанхуй руу (үл мэдэгдэх зүйл рүү) алхан орсныг тодорхойл.


“Гэсэн хэдий ч би урагшлан яв[лаа]” (1 Нифай 4:7) гэсэн хэллэгт юу хамгийн чухал байна вэ? _____

 **3.** Судрын тэмдэглэлдээ, үр дүн нь урьдаас харагдахгүй ямар нэг зүйлийг хийхээр Ариун Сүнсээр удирдуулсан байж болох эсвэл ямар нэг зүйл хийхийг урьсан байж болох залуу эрэгтэй юм уу залуу эмэгтэйн нөхцөл байдлыг тодорхойлон бич. Жишээ нь: *Хэрхэн, хэзээ* гэдгийг нь мэдэхгүйгээр зөвхөн итгэлээрээ ямар нэг юмыг хийхээр шийдсэн тохиолдол танд байж болно. Хэрэв тийм бол энэ туршлагынхаа тухай хувийн тэмдэглэлдээ бич. Энэ туршлагаа хичээл дээр хуваалцаж болно.

Зөвхөн Ариун Сүнсэнд өөрийгөө удирдах боломж олгосны *дараа*, итгэлээр урагш явахаар шийдсэний

дараа л Нифай, ялтсуудыг олж авах зарлигийг гүйцэлдүүлэхэд нь Их Эзэн юуны учир, хэзээ, хэрхэн түүнд туслах байсныг мэдэж авсан ажээ. 1 Нифай 4:8–26-г уншиж, гуулин ялтсуудыг олж авахад нь Их Эзэн түүнд хэрхэн тусалсныг анхаар.

 **4.** Сүнс Нифайд, Лебенийг алах заавар өгсөн шалтгаануудыг судрын тэмдэглэлдээ бич (1 Нифай 4:8–13-ыг үзнэ үү).

 **5.** Дараах асуултад судрын тэмдэглэлдээ хариулж бич: Амьдралд тань тохиолдсон эсвэл тохиолдож болох сорилт бэрхшээлүүдийг амжилттай даван туулахад тусалж болох юуг, гуулин ялтсуудыг олж авахад гаргасан Нифайн сүүлчийн хүч чармайлтуудаас та сурч болох вэ?

Хэрхэн, яагаад, хэзээ гэдэг нь мэдэгдэхгүй ажил үүргийг биелүүлэх болсон үедээ Нифайн туршлагаас дараах зарчмыг сана: **Бид Бурханд итгэх итгэлээ ашиглан, үр дүнг нь урьдаас харж чадахгүй Түүний даалгасан ажил үүргийг ч гэсэн биелүүлэхийг хичээх юм бол Тэрбээр биднийг Ариун Сүнсний нөлөөгөөр удирдах болно.**



Тайлбар ба нөхцөл байдлын тухай мэдээлэл

Лебенийг алах зарлиг

Зөв ба буруу зүйлийн жишгийг Их Эзэн тогтоосон юм гэдгийг Бошиглогч Иосеф Смит заасан билээ: “Бурхан айлдахдаа, ‘Чи хүн бүү ал’ [Египетээс Гарсан нь 20:13] хэмээсэн бөгөөд өөр нэг удаа Тэрээр, ‘Чи хүйс тэмтэр’ [Дэд Хууль 20:17] хэмээсэн байдаг. Энэ бол тэнгэрийн засаглалын зарчим бөгөөд хаант улсын хүүхдүүдийн амьдарч байгаа нөхцөл байдалд тохирсон илчлэлтээр зохицуулагддаг. Үйл явдлуудын үр дагавар урт удаан хугацааны дараа илрэх байлаа ч гэсэн, бид үүний шалтгааныг огт мэдэхгүй байлаа ч гэсэн Бурханы шаардсан бүхэн зөв байдаг. Хэрэв бид юуны өмнө Бурханы хаант улсыг

эрэлхийлэх аваас бүх сайн зүйлс бидэнд ирэх болно” (*History of the Church*, 5:135).

Их Эзэн яагаад Лебенийг алахыг Нифайгаас шаардсаныг ойлгохын тулд бид дараах зүйлийг анхаарах хэрэгтэй: Гуулин ялтсуудыг сайн дураараа шилжүүлж өгөх боломжийг Их Эзэн түүнд хоёр ч удаа олгосон атал Лебен “Их Эзэний зарлигуудыг дуулахгүй байв” (1 Нифай 4:11). Лебен худалч, дээрэмчин байсан бөгөөд Лемен болон Лихайн бусад хөвгүүдийг алахыг оролдсон нь Мосегийн хуулиар үхлийн шийтгэл хүлээх ёстой байв (Египетээс Гарсан нь 21:14-ийг үзнэ үү). Судрын цэдгийг олж авах нь “нэг хүн эрсдэх ёстой байсан ч,” (1 Нифай 4:13) Лихай болон түүний үр удмынханд нэн чухал гэдгийг Их Эзэн мэдэж байжээ.

Гуулин ялтсууд зөвхөн Мормоны Номын хүмүүс болон үндэстнүүдийг адисалсан төдийгүй өнөө үед зориулсан эртний бошиглогчдын сургаалуудыг хадгалж бидэнд авчирсан билээ. Эдгээр бичээсүүдээс заримыг нь (Исаиагийн эшлэлүүд болон Зиносын ёгтлол зэрэг) алтан ялтсуудад хуулбарлан оруулсан бөгөөд тэрхүү алтан ялтсуудаас Мормоны Номыг орчуулсан юм. Гуулин ялтсуудад агуулагддаг тэдгээр сургаалууд Мормоны Номоор дамжуулан дэлхийн олон үндэстний сая сая хүмүүсийн амьдралыг адисалсан бөгөөд адисалсаар байгаа билээ. Хэрэв тэр үед Нифай Лебений дээр зогсоод, Сүнсний дуу хоолойг дагаагүй бол энэ бүхэн боломжгүй болох байсан юм.

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон, хүнд сорилтын үед мэхлэгдэхээс зайлсхийхэд туслах “гурван богинохон туршилтыг” бидэнд зөвлөмж болгожээ.



“1. Жишиг бүтээлүүдэд энэ талаар юу гэсэн байдаг вэ? Исаиа энэ тухай: ‘Хууль хийгээд гэрчлэлд анхаарагтун. Хэрэв тэд энэ үгийн дагуу ярьдаггүй бол тэдэнд гэгээ байхгүй болжээ’ гэж хэлсэн байдаг (Исаиа 8:20.) . . .

Бид судруудыг шимтэн судлах ёстой. Ялангуяа Мормоны Ном, Сургаал ба Гэрээ бидэнд маш чухал юм. . . .

“2. Бидний баримтлах хоёр дахь удирдамж гэвэл: Энэ сэдвээр Сүмийн хожмын үеийн Ерөнхийлөгчид, ялангуяа амьд Ерөнхийлөгч юу гэж хэлдэг билээ? . . .

“Өнөөдөр Сүмийг төлөөлөн ярьдаг хүн дэлхий дээр ганцхан байдаг. (С ба Г 132:7; 21:4-ийг үзнэ үү.) Тэр хүн бол [Сүмийн Ерөнхийлөгч]. Тэрбээр өнөөдөр бидэнд Их Эзэний үгийг өгдөг учраас түүний үгс нас барсан бошиглогчдын үгсээс илүү чухал юм. Ариун Сүнсний нөлөөгөөр ярих түүний үгс бол судар юм (С ба Г 68:4-ийг үзнэ үү.) . . .

“Сүмийн Ерөнхийлөгч, Гэгээнтнүүдэд хэрэгтэй гэж үзсэн ямар ч сэдвээр үгээ хэлж болно. . . .

“3. Гурав дахь буюу сүүлчийн туршилт нь Ариун Сүнс—Сүнсний туршилт юм. Бид энэ Сүнсээр ‘. . . бүх зүйл үнэнийг мэдэж болно’ Моронай 10:5. Энэхүү туршилт зөвхөн тухайн хүний Бурхантай харилцах сувгууд нь цэвэр, ариун журамтай бөгөөд нүглээр бохирдоогүй бол бүрэн дүүрэн үр өгөөжтэй байж чадна” (Conference Report, 1963 оны 10-р сар, 16–17).



6. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би 1 Нифай 3–4-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

2-Р ХЭСЭГ: 4 ДЭХ ӨДӨР

1 Нифай 5–6; 9

Оршил

Бошиглогч Лихайн эхнэр Сариа хөвгүүдээ Иерусалимаас буцаж ирэхгүй байх хэмээн айж байлаа. Лихай Их Эзэнд итгэх итгэлээ илэрхийлэн эхнэрээ тайтгаруулж байжээ. Хөвгүүд нь гуулин ялтсуудыг авч эсэн мэнд эргэж ирсэнд Сариа, гэр бүлийг нь Бурханы мутар удирдан, хамгаалдаг талаар хүчтэй гэрчлэлтэй болсон ажээ. Лихай гуулин ялтсуудыг судалснаар “Сүнсээр дүүрч, үр удмынхаа тухай бошиглож эхлэв” (1 Нифай 5:17). Энэ хичээлийг судлахдаа хувиараа судар судалдаг тухайгаа болон Бурханы үгийг судалснаас ирдэг хүчийг хүлээн авахын тулд юу хийж болохоо бод.

1 Нифай 5:1–9

Лихайн хөвгүүд цөлд гэр бүлдээ эсэн мэнд эргэж ирэв

Иерусалимд очиж, тэндээс буцаж ирэхэд Нифай болон түүний ах нарт хэдэн долоо хоног шаардагдсан байх. Ах, эгч, дүү, эцэг эх эсвэл таны таньдаг хэн нэгэн номлол, сургууль эсвэл цэргийн албанд удаан хугацаагаар гэрээ орхин явсан тохиолдлыг тунгаан бод. Тэр үед хайртай хүнээсээ удаан хугацаагаар хол байх нь таны (эсвэл эцэг эхийн тань) санааг хэрхэн зовоосон бэ? 1 Нифай 5:1–3-ыг уншиж, хөвгүүд нь Иерусалим руу буцах тухайд Сариа санаа зовж байгаагаар Лихайд хэрхэн илэрхийлснийг ол.

1 Нифай 5:4–6-г судалж, Лихай Сариагийн санаа зоволтонд хэрхэн хандсаныг ол.

Өөрийхөө үгээр тайлбарла

Судруудыг ойлгох нэг арга зам бол зарчмуудыг өөрийнхөө үгээр тайлбарлах явдал мөн. Бичгээр эсвэл амаар өөрийнхөө үгээр тайлбарлах нь судруудад агуулагддаг үнэнүүдийг илүү сайн ойлгоход тань туслах болно. Энэ нь бас үнэнүүдийг гэрчлэх боломжийг Их Эзэний Сүнсэнд олгох болно.



1. Лихай эхнэртээ хэрхэн хариулсныг судрын тэмдэглэлдээ өөрийнхөө үгээр тайлбарлан бич.

Дараах асуултуудыг тунгаан бод:

- Лихай Сариагийн санаа зоволтонд хэрхэн хандсан нь танд ямар сэтгэгдэл төрүүлэв?
- Бурханаас ирсэн илчлэлтүүд түүнд итгэл, урам зориг өгснийг Лихайн үгс хэрхэн харуулж байна вэ?

1 Нифай 5:6-д өгүүлснээр Лихайн гэрчлэл Сариад ямар нөлөө үзүүлсэн бэ? _____

Бид Лихай Сариа нарын энэ туршлагаас хоёр үнэнийг сурч болно. Үүнд: Хэрэв бид Их Эзэнээс ирсэн Сүнсний удирдамжийг дагах юм бол Тэр биднийг санаа амар байх боломжоор адислах болно. Мөн бид Бурханд итгэх итгэлээ илэрхийлснээр бусдыг тайтгаруулж, тэднийг хүчирхэгжүүлэх болно.



2. Хүнд сорилт тулгарсан үед Бурханы тайтгаруулагч нөлөөг мэдэрсэн үеийнхээ тухай, өөр хэн нэгнийг тайтгаруулж, хүчирхэгжүүлэхийн тулд гэрчлэлээ хуваалцсан эсвэл өөрөө хэн нэгний итгэлийн үгсийг сонсож тайтгаран, хүч чадлыг олж авсан тухайгаа судрын тэмдэглэлдээ бич.

1 Нифай 5:7–9-ийг уншиж, энэ туршлага Сариагийн итгэлд хэрхэн нөлөөлснийг ол.

- Сариа энэ туршлагаас юу сурсан бэ? _____



3. Судрын тэмдэглэлдээ дараах асуултад хариулж бич: 1 Нифай 5:8 дахь Сариагийн гэрчлэл 1 Нифай 3:7 дахь Нифайн гэрчлэлтэй юугаараа адилхан байна вэ?

1 Нифай 5:10–22

Лихай гуулин ялтсуудыг судалсан нь

Нифай болон түүний ах нар амь насаараа дэнчин тавьж, гэр бүлийнхээ эд хөрөнгийг золиослон, хол газар явж, гуулин ялтсуудыг авчрахад нь Бурхан тэднийг хамгаалсан юм. Хэрэв та Лихайн гэр бүлийн гишүүн байсан бол тэдний хүч чармайлт гуулин

ялтсууд дээрх цэдгийг судлах хүсэл эрмэлзэлд тань хэрхэн нөлөөлөх байсан бэ?

Лихай, хөвгүүд нь эсэн мэнд эргэж ирсний дараа гуулин ялтсууд дээрх цэдгүүдийг судалж эхэлсэн ажээ. 1 Нифай 5:11–14-ийг уншихдаа гуулин ялтсуудын агуулдаг зүйлсийн доогуур зур.

1 Нифай 5:17–20-ийг уншиж, гуулин ялтсуудыг судалсан нь Лихайд хэрхэн нөлөөлснийг ол. Эдгээр шүлгүүдээс сурч мэдсэн зүйл дээрээ үндэслэн дараах зарчмыг хэрхэн гүйцээж болох вэ? (1 Нифай 5:17-г үз): **Бид судруудыг судалснаар** _____

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Роберт Д.Хэйлс дараах үнэнийг нотолсон юм:

“Бид Бурхантай ярихыг хүссэн үедээ залбирдаг. Мөн Түүнээс бидэнд хандан ярихыг хүсэх үедээ бид судруудыг судалдаг; учир нь Түүний үгс бошиглогчдоор дамжин бидэнд ирдэг. Бид Ариун Сүнсний өдөөлтийг анхааран сонссон үед Тэрбээр бидэнд заах болно.

“Хэрэв танд хандан ярьсан Түүний дуу хоолойг та сүүлийн үед сонсоогүй бол өөр мэлмий, соргог сонортойгоор судруудад эргэн ханд. Судрууд бол бидний сүнслэг тусламж юм” (“Holy Scriptures: The Power of God unto Our Salvation,” *Ensign* ба *Лиахона*, 2006 оны 11-р сар, 26–27).



4. Судруудыг судалж байхдаа Их Эзэний Сүнсийг мэдэрсэн үеийнхээ тухай судрын тэмдэглэлдээ бич.

1 Нифай 5:21–22-ыг уншиж, ялтсууд яагаад Лихай болон түүний гэр бүлд “агуу эрхэм үнэт” зүйл байсныг олж мэд.

“As I Search the Holy Scriptures” (Би ариун судруудыг судалдаг) дууллыг гаргаж, судруудыг судалснаас ирдэг адислалуудад анхаарлаа хандуул (*Hymns*, no. 277). Судруудыг хэрхэн өдөр бүр уншиж судалдаг тунгаан бод. Судар уншиж судлахаа хэрхэн сайжруулж болох вэ? _____


Мөнх бус амьдрал дахь аяныхаа үед судруудыг мэргэн ухаанаар судлах боломж бидэнд бий. Итгэл, золиослолын ачаар олж авсан гуулин ялтсуудгүйгээр Лихай болон түүний гэр бүл аян замдаа хэрэгтэй байсан адислалуудыг хүлээн авч чадахгүй байсныг сана (1 Нифай 5:22-ыг үзнэ үү). Та судруудыг судалснаар Их Эзэний Сүнсээр дүүрч, Түүний зарлигуудыг сахих хүч чадал, итгэлийг хүлээн авах болно.

1 Нифай 6:1–6

Нифай, бүх хүмүүсийг Есүс Христэд ирэхийг ятгахын тулд бичсэн юм

Гэртээ байгаа номуудаас нэгийг сонго эсвэл уншсан нэг номынхоо тухай бод. Энэ номыг зохиогч нь ямар зорилгоор бичсэн гэж та бодож байна? Зохиогчийн зорилгыг мэдэх нь уг номыг уншихад өөрт тань хэрхэн туслах вэ?

1 Нифай 6:3–6-г уншиж, энэ цэдгийг бичсэн Нифайн зорилгын доогуур зур. “Абрамын Бурхан, Исаакийн Бурхан, Иаковын Бурхан” (4-р шүлэг) хэмээх хэллэг нь Есүс Христ болох Иеховаг хэлж байгаа юм. Нифайн зорилго бол Мормоны Номон дахь бүх бичээсийг бичсэн хүмүүсийн зорилго болон үргэлжилдэг. Үүнд: **Мормоны Номын нэг зорилго бол Есүс Христэд ирэхэд бүх хүмүүсийг ятгах явдал мөн.**

 **5.** Нифайн цэдгээ бичсэн зорилгыг ойлгох нь Мормоны Номыг судлах арга барилд тань хэрхэн нөлөөлж болохыг судрын тэмдэглэлдээ бич.




1 Нифай 9

Нифай хоёр хэсэг ялтсуудыг бүтээжээ

1 Нифай 9-д (мөн 6-р бүлгийг үз) Нифай хоёр цэдэг бүтээхийг өөрт нь зарлиг болгосон тухай өгүүлжээ. Эдгээр цэдгүүдийг Нифайн бага болон их ялтсууд хэмээн нэрлэдэг. Бага ялтсууд нь түүний хүмүүсийн ариун нандин түүх, бошиглогчдын үйлчлэл, Их Эзэний илчлэлтүүдийг агуулдаг бол их ялтсууд нь төр засаг, иргэний түүхийг агуулдаг (1 Нифай 9:2–4-ийг үзнэ үү). Их Эзэн түүнд хоёр хэсэг ялтас бүтээхийг зарлиг болгосон учир Нифай “эдгээр ялтсууд,” “нөгөө ялтсууд” гэдэг хэллэгийг хэрэглэсэн ажээ.

Судрынхаа зах дээр 1 Нифай 9-ийн хажууд, Нифай ямар ялтсын тухай өгүүлснийг санахад тань туслах дараах тэмдэглэлийг хий: “эдгээр ялтсууд” = бага ялтсууд (ариун); “нөгөө ялтсууд” = их ялтсууд (төрийн).

Мормоны Номыг судалснаар Нифай яагаад хоёр хэсэг цэдэг хөтөлснийг та ойлгох болно. Нифай бага ялтсууд дээрх аавынхаа шастираас (1 Нифай 1–8-д байгаа) хураангуйлсан буюу товчилсон цэдэг бүтээхээр сүнслэгээр нөлөөлөгдсөн ажээ. Ойролцоогоор 1000 жилийн дараа бошиглогч Мормонд Нифайн бага ялтсуудыг алтан ялтсуудтай нэгтгэхийг Их Эзэн даалгасан байна (Мормоны Үгс 1:7-г үзнэ үү). Хоёр бошиглогч яагаад ингэх ёстойг мэдэхгүй байсан ч Их Эзэний зарлигийг биелүүлжээ (1 Нифай 9:5-ыг үзнэ үү).

 **6.** 1 Нифай 9-ийг судлах явцдаа бид Их Эзэний шалтгааныг бүрэн ойлгохгүй байлаа ч Түүнийг дуулгавартай дагах нь яагаад чухал болохыг тунгаан бодож, судрын тэмдэглэлдээ бич.

 **7.** Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би 1 Нифай 5–6, 9-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

3-Р ХЭСЭГ: 1 ДЭХ ӨДӨР

1 Нифай 7

Оршил

Нифай Их Эзэнд бие сэтгэл бүхнээ зориулсан нь 1 Нифай 7-д харагддаг. Тэр ах нарынхаа хамт Иерусалимд эргэн ирж, Ишмэил болон түүний гэр бүлийг цөлд дагуулж ирэх Их Эзэний зарлигийг дуулгавартай дагасан юм. Лемен Лемүел хоёр болон Ишмэилийн гэр бүлийн зарим хүмүүс цөл рүү буцаж ирэх замдаа Нифайд уурлан түүнийг эсэргүүцэж, Иерусалим руу буцахыг хүсч байв. Тэд Нифайг хүлж, алахыг завдахад тэр итгэлээр залбирсанд Их Эзэн түүнийг суллажээ. Нифай өөрийг нь хавчсан хүмүүсийг чин сэтгэлээсээ уучлав. Энэ хичээлийг судлахдаа зарлигууд болон хүнд сорилт бэрхшээлүүдэд Нифайн адил хэрхэн итгэлээр хандаж болохыг тунгаан бод.



Нифай болон түүний ах нар Ишмэилийн гэр бүлтэй ярилцсан нь

1 Нифай 7:1–5

Их Эзэн Лихайн хөвгүүдэд, Иерусалим руу буцаж Ишмэил болон түүний гэр бүлийг авчрахыг зарлиг болгов

Гэр бүлийнхээ тухай, гэр бүлүүд яагаад Бурханы төлөвлөгөөнд чухал болохыг тунгаан бод.

1 Нифай 7:1–2-ийг уншиж, Их Эзэн Лихайд түүний хөвгүүдээр юу хийлгэх зарлиг өгсөн болон яагаад Тэр тэднээр үүнийг хийлгэснийг олж мэд. (1 Нифай 7:1 дэх үр удам гэдэг үг үр хүүхэд, хойч үеийнхэн гэсэн утгатайг мэдэх нь ашиг тустай байж болно.)

Эдгээр шүлгүүдээс бидний сурсан нэг үнэн бол **Их Эзэн бидэнд гэрлэж, үр хүүхдээ Түүнд зориулан өсгөн хүмүүжүүлэхийг зарлиг болгодог явдал мөн. Их Эзэн Нифай болон түүний ах нарыг гэрлүүлэхийн тулд цөлийг туулж, Иерусалим руу олон хоног хүнд хүчир аян хийхийг хүртэл зарлиг болгосон.** 1 Нифай 7-г үргэлжлүүлэн судлахдаа гэрлэлт ба гэр бүл яагаад ийм чухал болохыг өөрөөсөө асуу.

“Тэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхагас дараах хэсгийг уншиж, хожмын үеийн бошиглогчид гэрлэлтийн ач холбогдлын тухай юу гэж тунхагласныг ол: “Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Тэргүүн Зөвлөл ба Арванхоёр төлөөлөгчийн зөвлөлийнхөн бид эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын гэрлэлтийг Бурхан томилсон бөгөөд гэр бүл нь Түүний хүүхдүүдийн мөнхийн хувь заяаны төлөө Бүтээгчийн төлөвлөгөөний төвд байдгийг чин сэтгэлээсээ тунхаглаж байна” (Ensign ба Лиухона, 2010 оны 11-р сар, 129).

1 Нифай 7:1 дэх “Их Эзэний төлөө” гэсэн хэллэгийг дугуйлж болно. Энэ хэллэг нь өнөө үед ямар утгатайг эргэцүүлэн бод.

“Тэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”-ийн дараах сургаалыг унших үедээ Их Эзэний төлөө үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх тухай нэмэлт санаануудыг ол:

Өдгөө бид Бурхан хүүхдүүддээ “өсөн нэмэгдэж, өнөр өтгөн болж, газар дэлхийг дүүргэ” хэмээн өгсөн зарлиг хүчин төгөлдөр байгааг тунхаглаж байна. . . .

“ . . . Эцэг эхчүүд нь хүүхдүүдээ хайр, зөв шударга байдлаар өсгөн хүмүүжүүлж бие бялдар болон оюун санааных нь хэрэгцээг хангаж, бие биеэ хайрлан, үйлчилж, Бурханы зарлигуудыг дагаж, хаана ч амьдарсан хуулиа хүндэтгэн сахидаг иргэд байхыг зааж сургах нандин үүрэгтэй юм. Нөхөр, эхнэрүүд болон эцэг эхчүүд эдгээр үүргээ биелүүлээгүйн төлөө Бурханы өмнө хариуцлага хүлээх болно” (Ensign ба Лиухона, 2010 оны 11-р сар, 129).

1 Нифай 7:3–5-ыг уншиж, Их Эзэн зарлигуудыг нь биелүүлэхэд Лихайн хөвгүүдэд хэрхэн тусалсныг ол. Ишмэил болон түүний гэр бүл Лихайн гэр бүлтэй цөлд нэгдэх урилгыг хүлээн авахад нь Их Эзэн тэдэнд хэрхэн тусалсан бэ?



1. Өнөө үед залуу хүмүүс гэрлэж, үр хүүхдээ “Их Эзэний төлөө” өсгөхөд өөрсдийгөө бэлтгэх гурван арга замын талаар зөвлөгөө өгөхийг эцэг эх, Сүмийн удирдагч, эсвэл багшаасаа хүс. Тэдний зөвлөгөөг судрын тэмдэглэлдээ бич.

1 Нифай 7:6–15

Нифай ах нартаа цөл рүү хийх аянаа үргэлжлүүлэхийг ятгав

1 Нифай 7:6–7-г уншиж, Лемен Лемүел хоёр болон Ишмэилийн гэр бүлийн зарим хүмүүс цөл дэх аяныхаа үед яагаад Нифайд уурлан түүнийг хавчсаныг ол. Энэ нөхцөлд Нифайтай адилхан байх нь ямар байж болохыг төсөөлөн бод. Лемен Лемүел хоёр болон Ишмэилийнхэнд амлагдсан нутаг руу хийх аянаа үргэлжлүүлэхийг ятгахын тулд юу гэж хэлэхээ бод.


1 Нифай 7:8–12-ыг уншиж, ах нараа Иерусалим руу буцахгүй байхыг ятгахын тулд тэднээс Нифайн асуусан асуултуудыг ол. Ах нар нь мартсан хэмээн Нифайн хэлсэн гурван үнэн юу вэ?

Дараах асуултуудад судрын тэмдэглэлдээ хариулж бич:


Судруудыг төсөөлөн бод

Хэрэв та болж байгаа үйл явдлуудыг оюун ухаандаа зураглан дүрсэлбэл судар судлах нь илүү үр өгөөжтэй болно. Хэрэв та судруудад өгүүлж байгаа үйл явдлуудад өөрөө оролцсон бол ямар санагдах мөн ямар үйлдэл хийх байснаа төсөөлөн бод. Энэ нь судрын түүхүүд таны амьдрал дахь нөхцөл байдалтай хэр зэрэг адилхан болохыг мэдэж, судруудын заадаг үнэнүүдийг амьдралдаа хэрэгжүүлэхэд тань тусалж болно.

 **2.** Эдгээр гурван үнэнийг санах нь Лемен Лемүел хоёрыг Их Эзэнд итгэлтэй байхад нь хэрхэн тусалж болох байсан бэ?

 **3.** Их Эзэнээс хүлээн авсан 4-5 адислалаа жагсаан бич. Их Эзэн таны төлөө юу хийснийг санах нь Түүнийг дагахаар сонгож, итгэлтэй байхад тань хэрхэн туслах вэ?

1 Нифай 7:13–15-ыг уншиж, хэрэв Лемен, Лемүел болон Ишмэлийн гэр бүлийн эсэргүүцэн дургүйцсэн гишүүд Иерусалим руу буцвал тэдэнд юу тохиолдоно гэж Нифай хэлснийг ол.

 **4.** Их Эзэн таны төлөө юу хийснийг санаж, Түүний удирдамжийг дагах нь яагаад амин чухал болох тухай судрын тэмдэглэлдээ нэг догол мөр бич.

1 Нифай 7:16–22

Их Эзэн Нифайг хүлээснээс нь сулласан нь

1 Нифай 7:16-г уншихдаа Нифайд тохиолдсонгай адил нөхцөлд байх нь ямар байж болохыг төсөөлөн бод. Та яах байсан бэ?"

Нифай залбирсан юм. 1 Нифай 7:17–18 дахь түүний залбирлыг уншиж, Нифай юуны төлөө залбирсныг тодорхойл.


Нифай “итгэлийнхээ дагуу” хүлээснээсээ суллагдхыг гуйсныг анхаар. Эдгээр шүлгүүдээс бидний авч болох нэг сургамж бол **Бурхан бидний итгэлийн дагуу залбиралд маань хариулдаг гэсэн үнэн юм.** Итгэлээр залбирах гэдэг нь Их Эзэнд хандан Түүнд итгэх итгэлээрээ залбирч, Түүний өгсөн удирдамжийг биелүүлэх хүслээ харуулах явдал мөн.

1 Нифай 7:17 дахь Нифайн залбирал болон Цагаатгалын хүч бидний зүрх сэтгэлийг хэрхэн өөрчилдөг тухай Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Дэвид А.Бэднарын дараах үгийг судал. Бид итгэлээр залбирах үедээ үйлдэх хүсэлтэй байхын ач холбогдлыг ойлгоход туслах хэллэгүүдийн доогуур зур.



“Хэрэв миний ах нар намайг хүлсэн бол би юу гэж залбирах байсныг та нар төсөөлж байна уу? Миний залбирал ах нартаа ямар нэг муу юм тохиолдохыг хүсч, ‘Та намайг ах нарын минь гараас чөлөөлж өгнө үү?’ гэх юм уу өөрөөр хэлбэл ‘Энэ зовлонгоос намайг одоохон гаргаж аваач!’ гэсэн үгтэй байх байсан. Харин Нифай миний залбиралтай адилаар өөрийнх нь зовлон байхгүй болохын төлөө залбираагүй нь сонирхолтой юм. Тэр үүний оронд нөхцөл байдлаа өөрчлөх хүч чадлын төлөө залбирчээ. Миний бодлоор тэр Аврагчийн Цагаатгалын боломж олгогч хүчийг ойлгож, биеэрээ мэдэрсэн учраас ийм байдлаар залбирсан биз ээ. . . .


“Ах, эгч нар аа! Энэхүү үйл явдлын утга санаа бид бүгдийн хувьд тодорхой юм. Та бид Цагаатгалын боломж олгодог хүчийг ойлгож, амьдралдаа ашиглахын тулд бидний нөхцөл байдал өөрчлөгдөхийн төлөө биш харин нөхцөл байдлаа өөрчлөх хүч чадлыг гуйж залбирах ёстой. Ингэвэл бид ‘өөрсөд дээрээ үйлдүүлэх’ биш харин өөрсдөө ‘үйлдэх’ чадвартай болно (2 Нифай 2:14)” (“Их Эзэний хүчээр” (Мормоны Үгс 1:14; Мозая 9:17; Мозая 10:10; Алма 20:4),” *Brigham Young University 2001–2002 Speeches* [2002], 124).

 **5.** Дараах асуултуудын аль нэгэнд судрын тэмдэглэлдээ хариулж бич:

а. Та амьдралдаа итгэлээр залбирч, Их Эзэн залбиралд тань хариулсныг хэзээ мэдэрсэн бэ?

б. Та Нифайн үлгэр жишээг дагаж, нөхцөл байдал тань өөрчлөгдөхийн төлөө биш харин нөхцөл байдлаа өөрчлөх хүч чадлын төлөө хэрхэн залбирч болох вэ?

Нифай хүлээснээсээ суллагдсаны дараа ах нар нь түүн рүү дахин дайрахыг хүсчээ. 1 Нифай 7:19–21-ийг уншиж, танд гүнзгий сэтгэгдэл төрүүлсэн Нифайн зан төлөвийг олж мэд. Танай гэр бүлд уучлал шаардлагатай байсан тохиолдлыг бод. Гэр бүлийн гишүүд бие биеэ уучлах хүсэлтэй байх нь яагаад чухал байдгийг эргэцүүлэн бод.

 **6.** Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би 1 Нифай 7-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

3-Р ХЭСЭГ: 2 ДАХЬ ӨДӨР

1 Нифай 8

Оршил

1 Нифай 8-аас бид Лихайн зүүд болох амьдралын модны тухай уншдаг. Тэрээр Цагаатгалын адислуудын бэлгэдэл болох уг модны жимснээс идээд агуу баяр баясгаланг мэдэрчээ. Тэгээд тэр амьдралын мод болон үүний жимсэнд ялгаатайгаар хандаж байгаа өөр өөр хүмүүсийг харжээ. Та энэ хичээлд өөрийгөө бэлтгэхийн тулд “The Iron Rod” [“Төмөр бариул”] (*Hymns*, no. 274) дууллыг дуулах эсвэл үгийг нь уншиж болно. Энэ бүлгийг судлахдаа Цагаатгал танд хэрхэн агуу баяр баясгалан авчирсныг,

үүний бүх адислалыг одоо болон ирээдүйд хүлээн авахын тулд юу хийх ёстойгоо тунгаан бод. Эдгээр адислалуудыг авахын тулд ямар саад бэрхшээлдүүдийг даван туулах хэрэгтэйгээ тунгаан бод.

Хичээлдээ дуу хөгжим оруул

"Дууллууд Их Эзэний Сүнснийг урьж," "хүндэтгэлийн мэдрэмжийг бий болгодог" (Нутны, ix) хэмээн Тэргүүн Зөвлөл заасан билээ. Дуулыг дуулах эсвэл сонсох нь суралцаж байгаа газарт тань тохиромжгүй бол дуулын үгсийг уншиж, дотроо бодох нь үр өгөөжтэй байж болно.

Их Эзэнд ойр дотно болж, өөрийн амьдрал дахь Түүний хайрыг илүү их хүчтэйгээр мэдрэхийн тулд хийх ёстой болон зайлсхийх ёстой зүйлсээ олж мэд.

1 Нифай 8:2-ыг уншиж, цөлд байхдаа Лихайн биеэрээ үзэж туулсан зүйлсийг тодорхойл. 1 Нифай 8:5–12-ыг уншаад Лихайн зүүдний гол тусгал эсвэл анхаарал татсан зүйлийг ол.



Лихайн зүүдний гол тусгалыг олсны дараа 1 Нифай 8:10–11-т амьдралын модны жимсийг дүрслэхэд

1 Нифай 8:1–18

Лихай амьдралын модны жимснээс идсэнийхээ дараа гэрийнхнийгээ мөн үүнээс идэхэд урьжээ.

Таныг хайрласан Их Эзэний хайрыг мэдэрсэн үеийнхээ тухай бод. Таны хийдэг сонголтууд Их Эзэнд ойр дотно байх болон Түүний хайрыг мэдрэх чадварт тань хэрхэн нөлөөлдгийг тунгаан бод. 1 Нифай 8-

ыг судлахдаа энэ бүлэг

Лихайн ашигласан үг хэллэгүүдийг жагсаан бич. ____

Их Эзэн, мөнхийн үнэнүүдийг ойлгоход туслахын тулд бидний мэдэх юмсыг бэлгэдлүүдээр олонтоо дүрсэлдэг. Лихайн зүүдэн дэх мод жимс хоёр юуг төлөөлснийг ойлгохын тулд Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Нийл А.Максвэллийн дараах үгийг унш: "Амьдралын мод бол. . Бурханы хайр юм (1 Нифай 11:25-ыг үзнэ үү). Есүсийг бидний Гэтэлгэгчээр Өөрийн бэлэг болгон өгсөнд Бурханы хүүхдүүдээ хайрлах хайр хамгийн гүнзгийгээр илэрдэг: 'Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан тул цорын ганц Хүүгээ өгсөн' (Иохан 3:16). Бурханы хайрыг хүртэнэ гэдэг бол Есүсийн Цагаатгал, [нүгэл хилэнцээс чөлөөлсөн] Түүний чөлөөлөлт, үүний авчирдаг баяр баясгалангаас хүртэнэ гэсэн үг юм "Lessons from Laman and Lemuel," *Ensign*, 1999 оны 11-р сар, 8).

1 Нифай 8:10–12-т дүрсэлсэн сайн мэдээний нэгэн зарчмыг тодорхойлохын тулд 1 Нифай 8:11-ээс Лихай жимсийг яасныг мөн 1 Нифай 8:12-оос үүний үр дүнг олж доогуур нь зур. Лихай жимсийг "хүртсэн" шиг өөрөө Цагаатгалаас "хүртэж болох арга замуудын тухай бод."

Есүс Христэд ирж, Түүний Цагаатгалаас хүртэх нь аз жаргалд хүргэдгийг Лихайн туршлага харуулж байна.



1. Дараах асуултад судрын тэмдэглэлдээ хариулж бич: Аврагчийн Цагаатгал таны амьдралд аз жаргал, баяр баясгаланг хэзээ авчирсан бэ?

Цагаатгалын адислалуудыг өөрсдөө хүртсэний дараа бид яагаад Лихай шиг, өөрсдийн гэр бүл, найз нөхдийг тэдгээр адислалуудыг хүртээсэй хэмээн хүсэх хэрэгтэйг тунгаан бод. 1 Нифай 8:3–4, 13–18-ыг уншиж, Лихайн гэр бүлийн гишүүд амьдралын модны жимснээс хүртэх Лихайн урилгад хэрхэн хандсаныг ол.

Бусад хүмүүс Бурханы үгнээс хүртэхээр сонгох эсэхийг бид шийдэж чадахгүй. Гэвч бид Лихайн адил тэднийг урьж, урамшуулан дэмжиж чадна. Таньдаг хэн нэгнээ Христэд ирж, Түүний Цагаатгалын адислалуудыг хүлээн авахад хэрхэн урьж, урамшуулан дэмжих тухай бод.

1 Нифай 8:19–35

Зарим хүмүүс амьдралын мод руу тэмүүлж, жимснээс нь хүртэхэд амжилт олж байхад бусад нь бүтэлгүйтэж байхыг Лихай харжээ.

Та нар амьдралын модны тухай үзэгдэл Нифайд хэрхэн үзүүлэгдсэн тухай 1 Нифайгаас дараа унших

болно. Уг үзэгдэл дэх олон бэлгэдэл болон дүрслэл ямар утгатайг тэрээр цэдэглэсэн байдаг. Бэлгэдлүүд болон тэдгээрийн тайллыг мэдэхийн тулд дараах хүснэгтийг ашигла. Дараах дасгалыг гүйцээхийн тулд судруудаа үз. Та нар эхний хоёр бэлгэдлийг аль хэдийн судалж, утгыг нь мэдсэн байгаа.

Лихайн зүүдэн дэх бэлгэдэл	Нифайд өгсөн бэлгэдийн утга
Мод (1 Нифай 8:10-ыг үз; үүнийг 1 Нифай 15:22-т амьдралын мод гэсэн байдаг)	Бурханы хайр (1 Нифай 11:25-ыг үзнэ үү)
Модны жимс (1 Нифай 8:10–12-ыг үзнэ үү)	Бурханы бэлгүүдээс хамгийн агуу нь Есүс Христийн Цагаатгалын адислалууд юм (1 Нифай 15:36-г үз)
(Бохир) устай гол (1 Нифай 8:13-ыг үз)	_____ (1 Нифай 12:16; 15:27-г үз)
Төмөр бариул (1 Нифай 8:19-ийг үз)	_____ (1 Нифай 11:25; 15:23–24-ийг үз)
Харанхуй манан (1 Нифай 8:23)	_____ (1 Нифай 12:17-г үз.)
Агуу хийгээд нүсэр барилга (1 Нифай 8:26-г үз)	_____ (1 Нифай 11:36; 12:18-ыг үз)

Судартаа тэмдэглэгээ хий

Сударт бичсэн тэмдэглэл нь хувийн тэмдэглэл эсвэл цаасан дээр бичсэн мэдээллийг бодвол олоход маш амархан байдаг. Сударт тэмдэглэсэн бэлгэдлүүдийн утга, харьцуулах эшлэлүүд, бусад мэдээлэл нь судруудыг ойлгох болон дараа нь тэдгээрээс заахыг тань хөнгөвчилж өгдөг.

Бэлгэдэл бүрийн утгыг (дээрх хүснэгтийн хоёр дахь баганын хариултауд) бичиж, бэлгэдийг дурдсан шүлэг эсвэл шүлгүүдийн дэргэд (хүснэгтийн нэг дэх баганын шүлгүүд) судартаа тэмдэглэх нь тустай байж болох юм.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч Боид К.Пакэрын дараах эшлэлийг уншиж, Лихайн зүүдийг судлах

нь бидэнд яагаад чухал болох тухай түүний хэлсэн үгийн доогуур зур:

“Лихайн зүүд эсвэл үзэгдэл өөрт тань онцын чухал биш юм шиг санагдаж мэднэ, гэвч тийм биш юм. Та энэ үзэгдэл дотор байгаа. Бид бүгд үүн дотор байгаа. . . .

“Төмөр бариулын тухай Лихайн зүүд эсвэл үзэгдэл дотор Хожмын үеийн Гэгээнтэн хүн, амьдралын сорилтыг ойлгоход хэрэгтэй бүх зүйл байдаг” (“Finding Ourselves in Lehi’s Dream,” *Ensign*, 2010 оны 8-р сар, 22).

1 Нифай 8-ын үлдсэн хэсгийг судлахдаа тэндээс сурч мэдсэн зүйл тань “амьдралын сорилтыг ойлгоход” танд хэрхэн туслахыг бод. 1 Нифай 8:21–33-ыг уншиж гол, харанхуй манан, агуу хийгээд нүсэр барилга Лихайн зүүдэн дэх хүмүүст, амьдралын модны жимснээс идэх эсвэл хүртэхэд нь хэрхэн саад болж байгааг ол. Эдгээр саад тотгоруудыг болон хүмүүст үзүүлдэг нөлөөнийх нь тухай дүрсэлсэн түлхүүр үг хэллэгүүдийг судартаа тэмдэглэж болно.

Лихайн харсан саад тотгорууд өнөө үед бидний амьдралд хэрхэн тохиолдож болох вэ? Аврагчид ирж, баяр баясгаланг эдлэхэд саад учруулахыг харсан дараах саад тотгоруудын доогуур зур: Порнограф, бусдаас сайшаал магтаал хүлээх санаархал, донтолт, амин хувиа хичээх үзэл, шунал, бусдад атаархах, залбирахгүй бас судар судлахгүй байх, компьютерийн тоглоомоор хэт их тоглох, ямар нэг үйл ажиллагаа эсвэл спортод хамаг цагаа зориулах, шударга бус байх, бусдын хийдэг зүйлийг сохроор дагах. Өнөө үед бидэнд тохиолддог бусад саад тотгорын тухай бод.

1 Нифай 8:21–33 дахь саад тотгоруудаас сурч мэдсэн зүйлээ хураангуйлан дүгнэх нэг арга зам бол сайн мэдээний дараах зарчим юм: **Бардамнал, дэлхийн зан авир, уруу таталтанд автагдах нь Цагаатгалын адислалуудыг хүлээн авахад танд саад учруулж болно.**



2. Дээрх дүгнэлт болон үүний үнэн зөв байдлын талаарх мэдрэмжүүдээ бас үүнийг амьдралдаа хэрэгжүүлж болох арга замуудын тухай судрын тэмдэглэлдээ бич.

Дэлхийн бусармаг явдал, Сатаны уруу таталт, дэлхийн бардамнал бидний сүнслэг байдлын өсөлтийг хэрхэн удаашруулдгийг тунгаан бод.

1 Нифай 8:21–33-ыг дахин судал. Энэ удаад дараах асуултуудын хариултыг ол:

- Судрууд дахь төмөр бариул (Бурханы үг, бошиглогчид болон Сүмийн бусад удирдагчдын сүнслэг нөлөө бүхий үгс, хувийн илчлэлт) амьдралын

модны жимснээс хүртсэн хүмүүст яагаад маш чухал байсан бэ?

- 1 Нифай 8:30 дахь ямар хэллэг, Бурханы үг биднийг амьдралын мод руу аюулгүй удирдахын тулд бидний хийх ёстой зүйлийг дүрсэлж байна вэ?



3. Бурханы үг биднийг уруу таталтаас хамгаалахад хэрхэн удирдаж болохыг судрын тэмдэглэлдээ бич.

Эдгээр шүлгүүд сайн мэдээний дараах зарчмуудыг зааж байна: **Хэрэв бид Бурханы үгнээс зууран барьвал энэ нь уруу таталт болон дэлхийн нөлөөг даван туулахад бидэнд туслах болно. Бурханы үгнээс зууран барих нь Их Эзэнд улам ойр дотно болж, Цагаатгалын адислалуудыг хүлээн авахад бидэнд тусалдаг.**



4. Өөрийн амьдрал дахь эдгээр зарчмуудын нотолгоог харахын тулд дараах асуултуудаас нэг юм уу хоёрт нь судрын тэмдэглэлдээ хариулж бич:

- а. Бурханы үг хэзээ таныг удирдаж, уруу таталт, бардамнал, дэлхийн зан авираас хамгаалсан бэ?
- б. Бурханы үг Аврагчид ойр дотно болоход хэзээ танд тусалсан бэ?

“Тэднийг [Бурханы] үгийг дуулахыг энэрэлт эцгийн бүхий л сэтгэлээр” (1 Нифай 8:37) Лихай гэр бүлдээ ухуулж байв. Тэр гэрийнхнээ өөрийн адил Есүс Христийн Цагаатгалын баяр баясгалан болон адислалуудыг хүртэхийг хүсч байлаа.



5. Бурханы үгийг судлах зорилгоо хэрхэн сайжруулах тухай судрын тэмдэглэлдээ бич.

Бурханы үгнээс зууран барьж, дагаснаар та Цагаатгалын үр жимсийг хүртэж, жинхэнэ баяр баясгаланг эдэлж чадна.



6. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би 1 Нифай 8-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо) –нд дуусгалаа .

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

3-Р ХЭСЭГ: 3 ДАХЬ ӨДӨР

1 Нифай 10–11

Оршил

Амьдралын модны тухай Лихайн сургаалууд болон иудейчүүдийн тухай түүний бошиглолууд нь аавынхаа харсан зүйлүүдийг өөрөө үзэж, сонсон, мэдэх Нифайн хүслийг нэмэгдүүлжээ. Нифай аавынхаа хэлсэн зүйлсийг тунгаан бодсоны дараа “Их Эзэний Сүнсэнд автагдан алсад одож” (1 Нифай 11:1) амьдралын модны тухай үзэгдлийг өөрөө харсан ажээ. Нифай харсан үзэгдэлдээ Аврагчийн амьдрал, үйлчлэл, үхлийг харж, биднийг хайрладаг Түүний хайрыг гэрчилжээ. Энэ хичээлийг судлахдаа хувиараа илчлэлт авахыг хүссэн Нифайн жишээнээс юу сурч болохыг тунгаан бод. Бас Аврагчийн амьдрал, Түүний үүрэг зорилго хийгээд бид бүгдийг хайрладаг агуу хайрынх нь тухай эргэцүүлэн бод.

1 Нифай 10:1–16

Лихай бошиглосон нь

Лихай амьдралын модны тухай үзэгдлээ ярьсны дараа ирээдүйн үйл явдлуудын тухай бошигложээ. Түүний бошиглолууд 1 Нифай 10:1–16-д цэдэглэгдсэн байдаг. 1 Нифай 10:4–6-г уншиж, дараах асуултуудын хариуг судартаа тэмдэглэ:

- Мессиа болох Аврагч ирнэ гэдгийг Лихай хэзээ бошиглосон бэ?
- “Энэхүү Гэтэлгэгчид тулгуурладаггүй” хүмүүст юу тохиолдоно гэж Лихай хэлсэн бэ?

1 Нифай 10:17–11:6

Нифай аавынхаа үзсэн мөнхүү тэр үнэнүүдийг өөрөө харж, сонсож, мэдэхийг хүссэн нь

Дараах зохиомол зүйлийг уншиж, яг адилхан нөхцөл байдалд хүмүүс хэрхэн өөр өөр ойлголт, туршлагатай байдгийг анхаар: Гурван залуу Сүмийн нэг цуглаанд оролцжээ. Тэдний нэг нь цуглааныг уйтгартай юм байна, цагаа дэмий үрлээ гэж бодсон гэнэ. Өөр нэг нь цуглаан сайхан боллоо, гэвч үүнээс юу ч сурсангүй хэмээн бодож. Гурав дахь залуу Ариун Сүнсээр нөлөөлөгдөж, цуглаан дээр заагдсан зүйлээс гадна сүнслэг нөлөө, удирдамж хүлээн авчээ.

1 Нифай 10:17–11:6 дахь Нифайн туршлагыг судлахдаа, Нифай, аавынхаа зааснаас гадна нэмэлт илчлэлт хүлээн авах боломжийг түүнд олгосон ямар үйлдэл *хийсэнд* анхаарлаа хандуул.

1 Нифай 10:17-г уншиж, Лихайн үзэгдлийг сонсоны дараа Нифайд ямар санагдсан тухай дүрсэлсэн хэсгийн доогуур зур.

1 Нифай 10:19-ийг уншиж, Бурханы нууцууд бидэнд хэрхэн илчлэгддэгийг заасан хэллэгийг ол.

1 Нифай 10:19-д өгүүлснээр үнэнийг шаргуу эрж хайдаг хүмүүс Бурханы нууцуудыг хүлээн авдаг. Үнэнийг шаргуу эрж хайх гэдэг нь юу гэсэн утгатай гэж та бодож байна? _____

Үнэнийг шаргуу эрж хайхын тун сайн жишээг Нифай харуулсан юм. 1 Нифай 10:17–19 мөн 11:1–6-г унш; доорх хүснэгтэд дурдсан гурван сэдэв: Хүсэл, итгэл, тунгаан бодолтоос хоёрыг нь сонгож, хүснэгтэн дээрх холбогдох асуултуудын хариултыг бич.

Хүсэл	<p>Нифай юу мэдэхийг хүссэн бэ? _____</p> <p>Бидний хүсэл илчлэлт хүлээн авах чадварт маань хэрхэн нөлөөлдөг гэж та боддог вэ? _____</p> <p>Та Их Эзэнээс юуны тухай мэдэхийг хүсдэг вэ? _____</p>
Итгэл	<p>Өөрийг нь илчлэлтэд хөтөлсөн ямар зүйлүүдэд Нифай итгэдэг байсан бэ? _____</p> <p>Эдгээр итгэл өнөө үед илчлэлт хүлээн авах бидний чадварт хэрхэн нөлөөлдөг гэж та боддог вэ? _____</p> <p>Их Эзэний танд илчилсэн зүйлд та итгэдэг үү? _____</p>
Тунгаан бодох (ямар нэг юмны тухай гүнзгийгээр эргэцүүлэн бодох; оюун ухаан, зүрх сэтгэлээ Ариун Сүнсэнд нээх)	<p>Нифайг тунгаан бодож суухад нь юу тохиолдсон бэ? (1 Нифай 11:1-ийг үзнэ үү.) _____</p> <p>Тунгаан бодолт илчлэлт рүү хөтөлдөг гэж та боддог уу? _____</p> <p>Сайн мэдээ амьдралд тань ямар нөлөө үзүүлж байгааг тунгаан бодохын тулд та юу хийж болох вэ? _____</p>

Дараах өгүүлбэрийг гүйцээн бичиж, Нифайн туршлагаас сурч болох нэг зарчмыг гарга: **Бурхан _____ бүх хүмүүст үнэнийг илчилдэг _____.**



1. Дараах асуултуудаас нэг эсвэл хоёрт нь судрын тэмдэглэлдээ хариулж бич:

- Их Эзэнээс тусламж эсвэл удирдамжийг хичээнгүйлэн эрэлхийлсэн үед Бурхан залбиралд тань хариулж байгааг эсвэл Сүнсний өдөөлтийг та хэзээ мэдэрсэн бэ?
- Их Эзэнээс сүнслэг удирдамжийг хичээнгүйлэн эрэлхийлж болох нэг арга зам юу вэ?

1 Нифай 11:7–36

Бусдын төлөө хийсэн Есүс Христийн залбирлыг Нифай гэрчилсэн нь

Нифай үзэгдлийнхээ үед тунгаан бодож, бурханлаг удирдамж эрэлхийлэхээ үргэлжлүүлжээ. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч Бойд К.Пакэрын дараах үгийг уншиж, Нифайн үзэгдлийн хамгийн чухал зүйл юу байсан гэж тэрээр хэлснийг ол.

Мессиа хүрч ирэх тухай бошиглолууд Хуучин Гэрээнд байдаг. Харин Мормоны Ном тэр үйл явдлын тухай, Хуучин Гэрээн дэх бошиглолтой огт адилгүй үзэгдлийн тухай цэдэглэсэн байдаг.

“Лихайн хүмүүс Иерусалимыг орхиж явсны дараа Лихай амьдралын модны тухай үзэгдлийг харсан юм. Түүний хүү Нифай үзэгдлийн утгыг мэдэхийн тулд залбирсан ажээ. Залбирлынхаа хариуд тэр Христийн тухай гайхамшигтай үзэгдэл хүлээн авсан юм.

“Нифай үзэгдлээр дараах зүйлсийг харсан юм:

- Хүүхэд тэвэрсэн онгон бүсгүйг,
- Замыг бэлтгэх ёстой нэгэн, Иохан Баптистыг,
- Бурханы Хүүгийн үйлчлэлийг,
- Мессиаг дагалдагч өөр арванхоёр хүнийг,
- Тэнгэр нээгдэж, тэнгэр элчүүд тэдэнд үйлчлэхийг
- Адислагдаж, эдгэрсэн олон түмнийг,
- Христийн цовдлуулалтыг
- Түүний ажлыг эсэргүүцэгч дэлхийн мэргэн ухаан хийгээд бардамналыг харжээ. (1 Нифай 11:14–36-г үзнэ үү.)

“Энэхүү үзэгдэл бол Мормоны Номын хамгийн чухал захиас юм” (“The Things of My Soul,” *Ensign*, 1986 оны 5-р сар, 60–61).

Нэгэн тэнгэр элч амьдралын модны утгыг тайлахад нь Нифайд тусалж, “Эцгийнхээ харсан тэр мод ямар учиртайг мэдэв үү, та?” гэж асуужээ. (1 Нифай 11:21). 1 Нифай 11:21–24-т Нифай болон тэнгэр элчийн амьдралын модыг дүрслэхэд ашигласан хэллэгийн доогуур зурж, утгыг дахин бод.

1 Нифай 11:16-г уншиж, Нифайгаас тэнгэр элчийн асуусан асуултын доогуур зур. *Хулицэл* гэдэг үг

бусдад туслах эсвэл тэднийг адислахын тулд өндөр байр сууринаасаа сайн дураараа бууж ирсэн гэсэн утгатайг судартаа бичиж болно.


Ойлгоход хэцүү үгсийн утгыг тайлбарла

Судар судлах явцдаа хэцүү үгсийн утгыг ойлгох нь чухал. Энэ нь тэдгээр үгсийг илүү сайн ойлгоход тань туслах болно. Судар судлах үед ойлгохгүй үг тааралдвал судрын зүүлт тайлбарыг үзэх эсвэл толь бичгээс харж болно. Эсвэл эцэг эх, багш нараасаа асууж болно. Эдгээр үгсийн утгыг судартаа тэмдэглэх нь ашиг тустай байж болно.

1 Нифай 11:17-гоос тэнгэр элчийн асуултад хариулсан Нифайн хариултыг ол. Нифай юу мэдсэн бэ? Тэр юу мэдээгүй вэ? Нифайг хариулсны дараа тэнгэр элч, **Бусдын төлөө хийсэн Есүс Христийн үйлчлэл биднийг хайрлах Бурханы хайрыг харуулдаг** гэдгийг өгүүлжээ.

Хүлцэл гэдэг үгийн утгыг мэдсэний дараа 1 Нифай 11:13–21-ийг, дараа нь Далын гишүүнээр үйлчилж байсан


Ахлагч Жэралд Н.Ландын дараах эшлэлийг уншиж, Аврагчийн төрөлт нь Түүний хүлцэл болон биднийг хайрлах Түүний хайрыг хэрхэн харуулдгийг тунгаан бод: “Бурхан тэргүүтний нэг гишүүн, Эцэгийн Ууган Хүү, Бүтээгч, Хуучин Гэрээний Иехова тэнгэр дэх бурханлаг ариун байдал, алдар суу, сүр жавхлан-энэ бүхнээ орхиод, Өөрийн эх, дэлхийн эцэг хоёроосоо бүрэн хамааралтай, өөдсийн чинээ бяцхан хүү болж, энэ дэлхийд ирсэн билээ. Тэрбээр дэлхийн хамгийн сайхан газар төрж, ягаан торгонд [хаан язгуурын бэлгэдэл] өлгийдүүлэн, эрдэнийн зүйлсэд булхаагүй юм. Харин малын даржин хашаанд мэндэлсэн нь гайхмаар биш гэж үү? Тэнгэр элч Нифайд, ‘Бурханы хүлцлийг болгоогтун’ хэмээн хэлсэн нь бага зэрэг гайхмаар юм.” (*Jesus Christ, Key to the Plan of Salvation* [1991], 16).

 **2.** Есүс Христ “тэнгэрлэг гэрээсээ ирсэн” (“Би гайхширна,” *Сүмийн дуулал*, х. 22) болон мөнх бус дэлхий дэх алдар суут байдлаасаа өөдсийн чинээ бяцхан хүү болон мэндэлсэн гэдэг нь таны хувьд ямар утгатай болохыг судрын тэмдэглэлдээ бич.

1 Нифай 11:27-г уншиж, Аврагчийн баптисм бас Түүний хүлцлийг хэрхэн харуулж байгааг тунгаан бод. Тэр хэдийгээр нүгэлгүй байсан ч Бурханы хуулиудад дуулгавартайгаа харуулахын тулд баптисм хүртсэн юм. Мөн энэ нь, дуулгавартай дагах үлгэр жишээг бидэнд өгснөөр биднийг хайрладаг Түүний хайрыг харуулж байна.



1 Нифай 11:28–31-ийг уншиж, Есүс Христийн бусдад үйлчилсэн амьдрал нь Түүний хүлцлийг хэрхэн харуулж байгааг эргэцүүлэн бод. Аврагч ямар хүмүүст үйлчилж, тэднийг эдгээж байсанд анхаарлаа хандуул.

 **3.** 1 Нифай 11:28–31-ээс уншсан зүйл тань, хүмүүсээ хайрладаг Аврагчийн хайрыг хэрхэн харуулж байгааг судрын тэмдэглэлдээ бич. Өнөөдөр энэ нь таны төлөөх Түүний хайртай холбогддогийг та хэрхэн мэдэрдэг вэ?

1 Нифай 11:32–33-ыг уншиж, Есүс Христийн цовдлуулалт нь Түүний хүлцлийг хэрхэн харуулж байгааг тунгаан бод. Далын Ерөнхийлөгчийн Зөвлөлийн гишүүнээр үйлчилж байсан Ахлагч Өөрл К.Тинжигийн дараах үгийг уншиж, Аврагчийн Цагаатгал Түүний хайрыг хэрхэн харуулж, таныг адисалдаг тухай тэр юу гэж хэлснийг ол.

“Есүс Христ Цагаатгалын шаардлагуудыг хангах хүнээр сонгогдсоны хувьд Түүнд уруу таталт, сорилт, доромжлол, шүүлт, цовдлолтыг зайлуулах эрх мэдэл болон хүч өгөгдсөн боловч иймэрхүү үйлдлүүдийг Тэрээр хүлцэн тэвчсэн юм.



“Ерөнхийлөгч Жон Тэйлор Христийн хүлцлийг дараах сайхан үгсээр дүрсэлжээ: ‘Тэрбээр бусад хүмүүсийг бүхнээс дээгүүр тавихын тулд Өөрөө бүхнээс доогуур бууж ирэх нь зайлшгүй байсан юм’ [The Mediation and Atonement (1882), 144].

“Гетсеманий Цэцэрлэг дэх Христийн зовлон шаналал нь Түүний бүх онцгой шинж чанаруудын хамгийн их сүр жавхлантай, Христийн төгс хайрын жишээг харуулдаг. Эндээс Тэрээр бид бүхнийг үнэхээр хайрладгийг бид хардаг. . . .

“Цагаатгал бол Бурханд өөрийгөө нийцүүлэх боломжийг бидэнд олгосон үйл явдал мөн. . . . Гэр бүлийн хувьд энэ нь гэр бүлийн гишүүд бие биетэйгээ болон Бурхантай бас Түүний Хүү Есүс Христтэй нэгдэн нийлэх гэсэн утгатай юм. Тусгаарлалтаас үүдэлтэй уйтгар гуниг эргэн нэгдэлтээр аз жаргал болдог” (“The Great Plan of Happiness,” *Ensign* ба *Лиахона*, 2006 оны 5-р сар, 73–74).

Есүс Христийн Цагаатгал нь Түүний хүлцлийн нэгэн чухал хэсэг бөгөөд биднийг хайрладаг Түүний хайрын хамгийн агуу илрэл юм.



4. Есүс Христийн хүлцлийн тухай мэдэх нь таны бодол санаа, Түүнийг хайрлах хайранд тань хэрхэн нөлөөлдгийг судрын тэмдэглэлдээ бич.

Өнөөдрийн хичээлээ “Би гайхширна” дууллыг дуулах, сонсох эсвэл үгийг нь уншиж дуусга (“Би гайхширна,” *Сүмийн дуулал болон хүүхдийн дуу*, х. 22) Өнөөдрийн сурч мэдсэн зүйлийг тань гэрчилж байгаа хэллэгүүдэд анхаарлаа хандуул. Есүс Христийн Цагаатгалын адислалууд яагаад “хамгийн ихээр хүслийг татагч,” “хамгийн их баясгалант” (1 Нифай 11:22–23-ыг үзнэ үү) байдгийг тунгаан бод. Хэрэв та Нифай шиг илчлэлтээр дамжуулан мэдлэгийг шаргуу эрэлхийлбэл Их Эзэнд улам ойртож, өөрийн амьдрал дахь Түүний хүч болон үүний авчирдаг баяр баясгаланг мэдрэх болно.



5. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би 1 Нифай 10–11-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

3-Р ХЭСЭГ: 4 ДЭХ ӨДӨР

1 Нифай 12–14

Оршил

1 Нифай 11-ээс эхэлсэн Нифайн үзэгдлийн тухай түүх 1 Нифай 12–14-т үргэлжилдэг. Нифай үзэгдэлдээ аймшигтай эмгэнэлт явдлууд, түүний дотор үр удмынхан нь устгагдахыг харсан ажээ. Тэр бас ёс бус хүмүүс Библиэс тодорхой бөгөөд эрхэм үнэт үнэнүүдийг авч хаяхыг, энэ нь олон хүмүүст сүнслэг байдлын хувьд бүдрэх шалтгаан болохыг харжээ. Гэвч Нифайн үзэгдэл бас түүнд ирээдүйд итгэх агуу итгэлийн шалтгаан болсон юм. Тэр Америкийг эзэмшилдээ авах үйл явцыг бас Колумбыг харсан билээ. Их Эзэн сайн мэдээний Сэргээлтэд, түүний дотор алдагдсан олон тодорхой бөгөөд эрхэм үнэт үнэнүүдийн сэргээх замыг бэлтгэх болно гэдгийг тэр харсан юм. Эцсийн өдрүүдэд Их Эзэн зөв шударга амьдардаг хүмүүст хэрхэн тусалж, тэднийг хэрхэн хамгаалахыг Нифай гэрчилжээ. 1 Нифай 12–14-ийг судлахдаа Мормоны Номонд болон хожмын үеийн бусад судруудад заадаг эдгээр тодорхой бөгөөд эрхэм үнэт үнэнүүд амьдралд тань хэр чухал болохыг тунгаан бод. Хэрэв та зөв шударга амьдрахыг хичээж, Бурхантай байгуулсан гэрээнүүддээ хүндэтгэлтэй хандах юм бол та ч бас нүгэл хилэнцийг ялах болно.

1 Нифай 12

Нифай болон Лемен үндэстнүүдийн ирээдүйг Нифай харсан нь

1 Нифай 12-т Нифай өөрийнх нь үр удмынханд ирээдүйд юу тохиолдохыг мөн тэд харанхуй манан болон агуу хийгээд нүсэр барилгын нөлөөгөөр хэрхэн гай зовлонд унахыг харсан ажээ. Тэр хойч үеийнхнээ нэрлэхдээ *үр удам* гэдэг үгийг ашиглажээ.

Өөрийнх нь үр удмынхнаас зарим хүмүүс Цагаатгалын бүх адислалыг авах болно гэдгийг Нифай харсан байлаа. Гэвч эцэстээ леменчүүд түүний үр удмынхныг устгах болно гэдгийг тэр харжээ. 1 Нифай 12:19-ийг уншиж, нифайчуудын устгагдсан шалтгааны доогуур зур. Бардамналаас хэрхэн хамгаалж, чөтгөрийн уруу таталтуудаас хэрхэн зайлсхийхийг тунгаан бод.

1 Нифай 13:1–9

Нифай агуу хийгээд жигшүүрт сүмийг харсан нь

Тоглож байсан эсвэл үзэж байсан спортоо дугуйлж, өөр спорт тоглож байсан эсвэл үзэж байсан бол жагсаалт дээр нэм:

Хөл бөмбөг	Газрын теннис
Крикет	Рагби
Сагсан бөмбөг	Хоккей
Бейсбол	Гар бөмбөг
Ширээний теннис	Америк хөл бөмбөг

Мэргэжлийн спортод багууд өрсөлдөгчидтэйгөө тоглохоос өмнө тэдний өнгөрсөн тоглолтуудын арга тактикийг судлах нь олонтоо тохиолддог. Өрсөлдөгчийнхөө зорилго, арга, тактикийг ойлгох нь тэднээс өөрийгөө хамгаалахад бэлтгэхэд бидэнд тусалж болно.

1 Нифай 13-т Нифай хожмын өдрүүдэд Бурханы Сүмийг эсэргүүцэгчдэд юу тохиолдохыг харснаа дүрсэлжээ. 1 Нифай 13:1–6-г уншиж, Нифай харийнхны дунд юу үүсэхийг харсныг болон тэнгэр элч энэ тухай юу хэлснийг ол.



Нифайн харсан тэрхүү “агуу хийгээд жигшүүрт сүм” бол ямар нэг бүлэг, шашин эсвэл сүм биш юм. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Брүс Р.Макконки үүнийг “ямар нэртэй эсвэл ямар мөн чанартай нь хамаагүй . . . хү-

мүүсийг Бурханаас болон түүний хуулиудаас, ингэснээрээ Бурханы хаант улсад аврагдахад тэднийг холдуулан хөндийрүүлэх зорилготой аливаа байгууллагууд” хэмээн тодорхойлжээ (*Mormon Doctrine*, 2 дахь хэвлэл, [1966], 137–138). Ахлагч Макконкигийн тодорхойлолтыг 1 Нифай 13:4–6-гийн дэргэд судартаа бичиж болно.

1 Нифай 13:8–9-ийг уншиж, агуу хийгээд жигшүүрт сүмийн хүсэл бодол, санаархал, зорилгыг ол.



1. Дараах асуултад судрын тэмдэглэлдээ хариулж бич: Сатан биднийг Бурханаас болон түүний хуулиудаас холдуулахаар удирдахын тулд цэргүүдээ зохион байгуулдгийг мэдэх нь ямар ач холбогдолтой гэж та боддог вэ?

1 Нифай 13-ыг цааш нь судлахдаа Аврагчийг эрэлхийлдэг хүмүүст агуу хийгээд жигшүүрт сүм саад учруулахыг хичээдэг нэг арга замыг та мэдэх болно.



1 Нифай 13:10–42

Ирээдүйд харийнханд Библи, Мормоны Ном, хожмын үеийн бусад судрууд ирэх болно гэдгийг Нифай харсан ажээ.

Их Эзэн агуу хийгээд жигшүүрт сүмийн хүч чармайлтуудад няцаалт өгөхийн тулд сайн мэдээний-хээ Сэргээлтэд замыг бэлтгэсэн юм. 1 Нифай 13-т Нифай, “Бурханы Сүнс . . . [тэдэнд] нөлөөлсний” улмаас амлалтын нутагт Колумб болон бусад аянчид хүрч ирэхийг харсан ажээ (1 Нифай 13:12–13-ыг үзнэ үү). Тэр бас “Боолчлолоос ангижран гарсан харийнхан” “мөн эх нутгийнхан нь болох Харийнхан. . . тэдний эсрэг тулалдахаар цугларсан ч” “Бурханы хүчээр бусад бүх үндэстний гараас чөлөөлөгдсөн” (1 Нифай 13:16–19-ийг үзнэ үү) Америкийн Тусгаар Тогтнолын дайныг харжээ.

1 Нифай 13:20–23-ыг уншиж, амлалтын нутагт ирсэн анхны эзэмшигчдийн дунд тараагдсан, Нифайн харсан тэр номыг ол.

Судартаа 1 Нифай 13:20-ийн дэргэд “Библи” гэж бич. Библи бидэнд “агуу үнэт” (1 Нифай 13:23) зүйл болохын хамт энэ нь анх бичигдэхдээ “Их Эзэний сайн мэдээний бүрэн байдлыг агуулж байсныг” (1 Нифай 13:24) Нифай тайлбарлажээ. Дараах хураангуйлал дахь хоосон зайг бөглөхийн тулд 1 Нифай 13:26–27, 29-ийг ашигла.

Агуу хийгээд жигшүүрт сүм Библиэс “олон _____ болоод хамгийн _____ хэсгүүдийг _____; мөн түүнчлэн _____ Их Эзэний олон _____ зайлуулан авчээ (1 Нифай 13:26). Тэд эдгээр зүйлүүдийг зайлуулан авсан нь _____ Их Эзэний зөв замуудыг _____, _____ хүмүүний үрсийн мэлмийг _____ бас зүрх сэтгэлийг _____ тулд юм” (1 Нифай 13:27). Хурганы сайн мэдээнээс зайлуулагдан авагдсан эдгээр зүйлүүдийн учир “үлэмж агуу олон нь _____” (1 Нифай 13:29).

Хоосон зайг бөглөсний дараа дээрх өгүүлбэрүүдийг дахин унш.


Агуу хийгээд жигшүүрт сүмийн нэг зорилго бол тодорхой бөгөөд эрхэм үнэт үнэнүүдийг зайлуулан авснаар “Их Эзэний зөв замуудыг гажуудуулах” (1 Нифай 13:27) явдал юм. “Гажуудуулах” гэдэг нь зөв зүйлээс нүүр буруулах эсвэл түүнээс эргэх гэсэн утгатай. “Их Эзэний зөв замуудаас” нүүр буруулах эсвэл эргэхийн сөрөг үр дагавруудын тухай бод.

Дараах асуултуудад хариулахын тулд судруудаа ашигла:

- 1 Нифай 13:34-т өгүүлснээр, Их Эзэн нигүүлслийнхээ улмаас юуг авчрах вэ? (“Хурга” гэдэг нэр Аврагч Есүс Христийг хэлж байгааг мэдэх нь ашигтай байж болно.) _____
- 1 Нифай 13:35–36-д, далдлагдсан ямар зүйл харийнханд ирэх болно хэмээн Аврагч хэлсэн бэ? _____
- 1 Нифай 13:36-д, далдлагдсан цэдэг—Мормоны Номонд юуны тухай бичигдсэн гэж тэнгэр элч хэлсэн бэ? _____
- 1 Нифай 13:39-д Мормоны Номоос гадна “бусад номууд” гэдэг нь юуг хэлж байгаа юм бол? _____

1 Нифай 13:40–41-ийг уншиж, Мормоны Ном болон эдгээр “бусад номууд” нь юуг бүх хүмүүст мэдүүлэхийг олж доогуур нь зур. Бид “Хурганы амаар тогтоогдох үгсийн дагуу” (1 Нифай 13:41) Аврагчид ирэх ёстой гэдэгт анхаарлаа хандуулах нь чухал. Тогтоогдох үгс гэдэг нь судрууд юм.

Нифайн үзэгдлийн энэ хэсгээс бид, **Мормоны Ном болон хожмын үеийн судрууд нь Есүс Христ бол Бурханы Хүү бөгөөд Түүнд хэрхэн ирэхийг мэдэхэд бидэнд туслах тодорхой хийгээд эрхэм үнэт үнэнүүдийг сэргээснийг мэддэг.**

 **2.** Дараах асуултуудын хариултыг судрын тэмдэглэлдээ бич:

а. Мормоны Ном болон хожмын үеийн бусад судрууд дахь тодорхой болоод эрхэм үнэт үнэнүүд нь Есүс Христийн тухай гэрчлэлд тань хэрхэн нөлөөлсөн бэ?

б. Тэдгээр нь Түүний сайн мэдээг ойлгож, түүгээр амьдрахад өөрт тань хэрхэн тусалсан бэ?

Судар судалсан тань Аврагчид ойр дотно болоход хэрхэн тусалж байгаад дүгнэлт өгөхөд зориулан цаг гарга.


1 Нифай 14:1–17

Агуу хийгээд жигшүүрт сүм, Бурханы Хурганы Сүмийн хоорондох тулалдааныг Нифай харжээ.

Бид 1 Нифай 14-өөс агуу хийгээд жигшүүрт сүм, Бурханы Хурганы Сүмийн хоорондох тулалдааны тухай уншдаг. 1 Нифай 14:10–13-ыг уншиж, аль талд нь илүү олон хүмүүс байхыг олж мэд. 1 Нифай 14:12-т Хурганы Сүмийг дэмжигч хүмүүсийн тоо цөөхөн байхад агуу хийгээд жигшүүрт сүм яагаад үй олон хүмүүсийг цуглуулж чадсаныг анхаар.

Хэрэв та хүний тоогоор давамгайлсан тулалдаанд оролцох болбол энэ нь танд ямар санагдах вэ? 1 Нифай 14:14-ийг уншиж, “Хурганы сүмийн гэгээнтнүүд” болон “Их Эзэний гэрээт хүмүүс” нүгэл хилэнцийн эсрэг тэмцэхэд нь хүлээн авах тусламжийн тухай өгүүлсэн хэллэгүүдийн доогуур зур.

1 Нифай 14:1–17-д заагдсан сайн мэдээний нэг чухал зарчим бол **бид зөв шударга амьдарч гэрээнүүдээ сахисан үед Бурханы хүч бидэнд, нүгэл хилэнцийг ялахад туслах болно** гэсэн зарчим юм.

 **3.** Бурханаас болон Түүний хуулиудаас таныг хөндийрүүлж болох уруу таталтыг ялахад, “Их Эзэний гэрээт хүмүүсийн” нэг байж, “зөв шударга ёсоор зэвсэглэх” (зөв шударга амьдрах) нь танд хэрхэн тусалсан тухай судрын тэмдэглэлдээ нэг догол мөр бич.

Агуу хийгээд жигшүүрт сүмийг дэмждэг хүмүүс эцсийн өдрүүдэд “бүрмөсөн устгагдахыг” (1 Нифай 14:3) Нифай харжээ. Бурханы хаант улс эцсийн өдрүүдэд ялах болно гэдэгт та итгэлтэй байж болно.

 **4.** Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би 1 Нифай 12–14-р бүлгүүдийг судалж (огноо)-нд энэ хичээлийг дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

Судруудын тухай санаа бодлоо бич

Судруудын тухай санаа бодлоо бичихдээ хангалттай цаг гарга. Даалгавраа хийж дуусгах гэж байгаа хэдий ч энэ асуултыг анхааралтай тунгаан бод. Зарим асуулт цаг хугацаа болон олон талаас нь цэгнэн бодохыг шаардаж болно. Хариултуудыг бичихдээ Ариун Сүнсний удирдамжийг эрэлхийл.

1 Нифай 15

Оршил

1 Нифай 15-д хувийн илчлэлт хүлээж авах талаарх Нифайн шаргуу хүч чармайлт болон ах нарынх нь итгэлгүй байдлын эсрэг тэсрэг шинжийг та олж харах болно. Энэ бүлгийг судлахдаа Их Эзэнээс хариу болон удирдамж хүлээн авах талаар ямар хүч чармайлт гаргадгаа тунгаан бод.

1 Нифай 15:1–11

Нифайн ах нар Лихайн үзэгдлийг ойлгохгүй байна хэмээн гомдоллож байв


Ихэнх идэвх зүтгэлийн үр жимсийг амтлахаас өмнө бид ихээхэн хүч чармайлт гаргах шаардлагатай. —Сургууль дээр болдог үйл ажиллагаа, хөгжим тоглох эсвэл спортоор хичээллэх— зэрэг оролцдог үйл ажиллагаануудынхаа тухай бод. Тэгээд уг үйл ажиллагаанд гаргах хүч чармайлт, түүнээс гарах үр дүнгийн хоорондох уялдаа холбооны тухай тунгаан бод. 1 Нифай 15-ыг судлахдаа мөн ийм загварыг эрж ол. Хүч чармайлт гаргах нь сүнслэг үнэнүүдийг мэдэж, Их Эзэнээс илчлэлт хүлээн авахтай ямар хамааралтай болохыг анхаар.

Нифай аавынхаа үзэгдэл болон сургаалуудыг ойлгохыг шаргуу эрэлхийлж, дараа нь өөрөө илчлэлт хүлээн авсны эцэст аавынхаа майханд эргэж иржээ. Гэтэл ах нар нь тэнд маргалдаж байв. 1 Нифай 15:1–3-ыг судалж, тэд юуны тухай ярилцсаныг олж мэд.

1 Нифай 15:6–7-д Нифайн ах нарт ямар асуудал тулгарч, тэднийг маргалдахад хүргэснийг олж, доогуур нь зур. 1 Нифай 15:3-т өгүүлснээр Лихайн сургаалуудыг ойлгох нь тэдэнд яагаад хэцүү байсан бэ? ___

1 Нифай 15:8-ыг уншиж, ах нараасаа Нифайн асуусан асуултын доогуур зур. Нифай уг туршлагыг биеэрээ үзэж туулсны дараа дээрх асуултыг асуусан нь ямар учиртай вэ?

1 Нифай 15:9 дэх ах нарынх нь хариултын доогуур зур. Энэ шүлэг дэх *учир нь* гэсэн үг *тиймээс, учраас гэсэн утгатай*. Өөрөөр хэлбэл Нифайн ах нар “Их Эзэн бидэнд хандаж яриагүй учраас бид Түүнээс асуугаагүй юм” гэж тайлбарлажээ.

 1. Их Эзэн асуусан зүйлд нь хариулна гэдэгт итгэдэггүй учраас Түүнээс асуудаггүй нэг найз өөрт тань байдаг гэж бод. 1 Нифай 15:11-ийг судалж, Их Эзэнээс хариу

хүлээн авах тухай ах нартаа Нифайн өгсөн зөвлөгөөг тунгаан бод. Дараа нь Бурханаас итгэлээр асуухыг нь урамшуулан дэмжсэн захидлыг найздаа зориулж судрын тэмдэглэлдээ бич. Захидалдаа залбирлын талаарх Нифайн зөвлөгөө болон өөрийнхөө бодлыг хуваалц.

Нифай болон ах нарынх нь үйлдэл мөн туршлагаас бидний сурч болох нэг зарчим бол **хэрэв бид Их Эзэнээс итгэлээр асууж, Түүний зарлигуудыг сахивал Түүнээс агуу илчлэлт болон удирдамж хүлээн авахад бэлтгэгдэх болно.**



2. Доорх асуултуудаас нэгийг сонгож, хариултыг нь судрын тэмдэглэлдээ бич:

а. Их Эзэнээр заалгаж, Түүгээр удирдуулахын тулд биднээс юу шаардагддагийг ойлгоход нь Сүмийн шинэ гишүүнд туслахын тулд та юу гэж хэлэх вэ?

б. Сүнслэг үнэнүүдийг мэдэж, Их Эзэний удирдамжийг эрэлхийлэх таны хүч чармайлт Сүнсийг мэдэрч, сайн мэдээг ойлгох чадварт тань хэрхэн нөлөөлсөн бэ?

Маргааш дээрх даалгаврын хариултыг эцэг эх, гэр бүлийн аль нэг гишүүн, Сүмийн удирдагч эсвэл багштайгаа хуваалц. Ингэхдээ тэр хүнийг, Тэнгэрлэг Эцэгийн тусламж болон удирдамжийг эрэлхийлэхэд



итгэл, хүч чармайлт гаргасан тохиолдлоо хуваалцахад урь.

1 Нифай 15:12–20

Нифай Израилын тараагдалт ба цугларалтыг тайлбарласан нь

Нифайн ах нар чидуны мод болон харийнхны тухай Лихайн бошиглол ба сургаалуудыг ойлгосонгүй (1 Нифай 15:7-г үзнэ үү; мөн 1 Нифай 10:12–15-ыг үз). Хугарч, тараагдсан чидуны модны унаган мөчрүүд нь Израилын угсаа (Бурханы гэрээт хүмүүс) дуулгаваргүй байдлынхаа улмаас биеэр болон сүнслэг байдлын хувьд тараагдсаныг бэлгэдэж байгааг Нифай тайлбарлажээ. Тэд тараагдсанаараа сайн мэдээний мэдлэгээ алдаж бас Израилын угсааны гишүүд болохоо мэдэхээ больсон ажээ. Сэргээгдсэн сайн мэдээг бүх дэлхийн хүмүүс хүлээн авч, өөрсдийгөө Их Эзэний гэрээт хүмүүс болохыг ойлгох нь хожмын өдрүүд дэх Израилын угсааны цугларалтын нэг хэсэг байх болно (1 Нифай 15:14–15-ыг үзнэ үү).

1 Нифай 15:14-ийг уншиж, тараагдсан Израил хожмын өдрүүдэд юу ойлгохыг тэмдэглэ.

Сүмд нэгдсэн хүмүүс “жинхэнэ чидуны модонд” (1 Нифай 15:16) залгагдсантай адил болохыг Нифай заажээ. Энэхүү залгалт эсвэл цугларалт нь Израилын угсааны тараагдалтын адил “Харийнханы тусламжтайгаар” (1 Нифай 15:17) тохиох болно гэдгийг Нифай бас хэлжээ. “Судруудад *Харийнхан* гэдэг үг нэлээд хэдэн утгатайг ойлгох нь ашиг тустай байж болно. Энэ үг заримдаа Израил биш гаралтай хүмүүсийг, заримдаа Еврей биш гаралтай хүмүүсийг хэлэхэд ашиглагддаг бол заримдаа сайн мэдээгүй үндэстнүүдийг эсвээс Израил цустай ч гэсэн сайн мэдээг хүлээн аваагүй хүмүүсийг хэлэхэд хэрэглэгддэг. Хамгийн сүүлчийн хэрэглээ нь Мормоны Номонд ашигласан үгийн утгатай адил юм (Судруудын Удирдамж, “Харийнхан,” scriptures.lds.org).

Их Эзэн хүүхдүүддээ өгсөн амлалтаа биелүүлж, тэдэнтэй хийсэн гэрээнүүдээ санадаг. Тэрбээр бүх хүүхдээ үүрдийн сайн мэдээний адислалуудыг хүлээн аваасай гэж хүсдэг (1 Нифай 15:18-ыг үзнэ үү). Сайн мэдээг найз нөхөд, гэр бүлийнхэнтэйгээ хуваалцах таны хүч чармайлт болон номлолд хүндэтгэлтэйгээр үйлчлэх шийдвэр төгс байдал Лихайн бошиглолыг гүйцэлдүүлэхэд тань туслах болно.

1 Нифай 15: 21–36

Лихайн үзэгдлийн талаарх ах нарынхаа асуултад Нифай туршлагаараа хариулсан нь


1 Нифай 15-ын үлдсэн хэсэг нь Нифайн ах нар Лихайн зүүдний талаар түүнээс асуусан асуултуудын тухай өгүүлдэг. Нифайн ах нар ингэж асуусан

байдаг: “Бидний эцгийн үзсэн уг модны зүг удирдсан тэр төмөр бариул ямар утгатай вэ?” 1 Нифай 15:23, 1 Нифай 15:24–25 дахь Нифайн хариултыг уншиж, Бурханы үгийг анхааран сонсож, дагадаг хүмүүст амлагдсан адислалуудыг ол. Бурханы үгийн хүчний тухай Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсоны дараах үгсээс Нифайн заасантай адил хэллэгүүдийн доогуур зур.


- “Бурханы үг биднийг хамгаас илүү хүсүүштэй үр жимс рүү хөтөлдөг төдийгүй, бид Бурханы үгэнд болон үүгээр дамжуулан уруу таталтыг эсэргүүцэх хүчийг, Сатаны болон түүний элч нарын ажлыг зогсоох хүч чадлыг олж авдаг билээ.”
- “Бурханы үг нь . . . Гэгээнтнүүдийг нүгэл хилэнцийг эсэргүүцэж, сайн бүхнийг мөрдлөг болгон, энэ амьдралд баяр баясгаланг олоход нь Сүнсээр бэхжүүлэх хүчтэй юм.”
- “Зөв шударга амьдралд амжилт олох, залилан мэхлэлтээс зайлсхийж уруу таталтыг эсэргүүцэх, өдөр тутмынхаа амьдралд удирдамж авах, бодгалийг эдгээх—энэ бүгд бол Их Эзэний үгийг эрэлхийлж, дуулгавартай дагадаг хүмүүст Түүний өгсөн амлалтуудаас зөвхөн цөөн хэд нь юм. . . . Гэвч бид харанхуй манан дундуур амьдралын мод руу хийх аяндаа, бусад бүх зүйлүүдэд хичээл зүтгэл гаргасан ч, зарим адислалуудыг зөвхөн судруудаас, зөвхөн Их Эзэний үгийг судалж, Түүний үгийг дуулгавартай дагаснаар л олж авч чадна” (“The Power of the Word,” *Ensign*, 1986 оны 5-р сар, 80, 82).



Бид судруудыг судлах, залбирах болон удирдагчдын сүнслэг нөлөөтэй үгсийг сонсох нь Бурханы үгийг дуулгавартай дагахад нэн чухал юм.

 **3.** Бурханы үгийг судлахад урамшуулан дэмжсэн зурагт хуудас судрын тэмдэглэлдээ зур. Бурханы үгийг сонсож хэрэгжүүлдэг хүмүүст ирэх Нифайн амласан адислалуудыг зурагт хуудсандаа оруулахаа мартуузай. Бас Бурханы үгийг олох эх сурвалжуудын жагсаалт хийж болно.

1 Нифай 15:24–25-ын хажууд дараах зарчмыг бич:
Бурханы үгийг өдөр бүр судалж, дагах нь биднийг Сатаны уруу таталтын эсрэг хүчирхэгжүүлдэг.

 **4.** Энэ зарчмын тухай гэрчлэлээ бэхжүүлэхийн тулд дараах асуултуудын нэгд нь эсвэл хоёуланд нь судрын тэмдэглэлдээ хариулж бич.


а. Хувиараа судар судлах ямар туршлага тань, энэ зарчим үнэн гэдгийг мэдэхэд танд тусалсан бэ?

б. Энэ зарчим үнэн гэдгийг та яаж мэдсэн бэ?

Лихайн зүүдэнд төмөр бариулаас барьж явсан хүмүүс харанхуй манан дундуур аюулгүй өнгөрч амьдралын модонд хүрсэн байдаг. 1 Нифай 15:26-д, Нифайн ах нар амьдралын модны ойролцоох гол


ямар учиртайг түүнээс асуужээ. 1 Нифай 15:27–29-ийг уншиж, гол юуг төлөөлснийг олж мэд.

1 Нифай 15:32–36-г унш. Нифайн ах нар яагаад эдгээр сургаалыг ойлгоогүй вэ?

 **5.** Дараах асуултуудад судрын тэмдэглэлдээ хариулж бич:

а. Лихайн зүүд ба зүүдийг нь тайлсан Нифайн тайлбарын ямар хэсгүүд Нифайн ах нарыг хайрлах Бурханы хайр халамжийг харуулж байна вэ?

б. 1 Нифай 15-д таныг хайрлах Бурханы хайр халамжийг та хэрхэн харж байна вэ?

 **6.** Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би 1 Нифай 15-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:



1 Нифай 16

Оршил

Ах нар нь Нифайн үгсийн хүчийг мэдрээд Их Эзэний өмнө өөрсдийгөө даруусгажээ. Лихайн гэр бүлийг цөлд аялж явахад нь Их Эзэн, тэднийг аян замд нь удирдах Лиахонаг өгсөн билээ. Лихайн гэр бүл аяны замдаа нум нь хөвчгүй болж, Нифайн нум хугарснаас хүнс залгуулах боломжгүй болсон гэх мэт олон бэрхшээлтэй учрав. Үүнд гэр бүлийн гишүүдийн ихэнх нь дургүйцэн бувтналдсан ч Нифай шинэ нум хийж, анд хаашаа явах талаар Их Эзэнээс зөвлөгөө хүсчээ. 1 Нифай 16-г судлах нь зовлон бэрхшээл, засч залруулах зүйлд хэрхэн хандах талаар сайтар бодох боломжийг танд олгодог. Их Эзэн Лихайн гэр бүлийг бэрхшээлүүдээ даван туулахад нь удирдсан шиг, хэрэв та Түүний зөвлөгөөг даруухнаар эрэлхийлж дагах юм бол амьдралд тань тохиолдох сорилтуудын дундуур Тэр таныг удирдах болно.

1 Нифай 16:1–6

Нифай ах нарынхаа дургүйцэлд хариулсан нь

Та хэн нэгнийг ямар нэг буруу зүйл хийснийхээ төлөө зэмлүүлэх эсвэл залруулга сонсож байхыг харсан уу? Тэр хүн үүнд хэрхэн хариулсан бэ?

Ёс бус хүмүүст амьдралын модны жимснээс хүртэх боломж байдаггүйг Нифай, Лемең Лемүел хоёрт заахад тэд өөрсдийг нь зэмлэж байна гэж бодсон ажээ (1 Нифай 15:36–16:1-ийг үзнэ үү). 1 Нифай 16:1–2-ыг уншиж, зарим хүмүүс үнэний дагуу амьдрахгүй байгаа үед энэ талаар сонсоод ямар хандалага гаргадаг талаар Нифайн хэлснийг олж, доогуур нь зур.

“Тэдний зүрхийг зүсэх” гэсэн хэллэг нь тэдний гэм бурууг илчлэх гэсэн утгатай. “Гэмтнүүдэд үнэн хатуу санагдах бөлгөө” гэсэн нь юу гэсэн утгатай гэж та бодож байна? _____



1. Үнэнийг сонсоход хэцүү бөгөөд “зүрхийг [тань] зүсэх” шиг (1 Нифай 16:2) санагдсан үед ч гэсэн үнэнд дуулгавартай байхын тулд хийж чадах хэдэн зүйлээ судрын тэмдэглэлдээ жагсаан бич. Тодорхой үнэнүүдэд дуулгавартай байх нь зарим өсвөр үеийнхэнд яагаад хэцүү байдаг гэж та боддог вэ? 1 Нифай 16:3–4-т, Лемең Лемүел хоёрт Нифайн хэлсэн зүйлстэй өөрийнхөө хийсэн жагсаалтыг харьцуул.

1 Нифай 16:5-д өгүүлснээр, Лемең Лемүел хоёр Нифайн зааварт хэрхэн хандсан бэ? Ямар нэг үнэн бидний зүрхийг зүсэх шиг болсон үед бид юу хийх ёстойг энэ шүлэгт ямар үг эсвэл хэллэгээр дүрсэлсэн байна вэ? Эдгээр асуултуудын хариуг судартаа тэмдэглэ.

1 Нифай 16:7–33

Лихайн гэр бүл Лиахонагаар удирдуулсан нь

Дараах таавар дахь өгүүлбэрүүдэд зөв (З), буруу (Б) гэсэн хариултын аль нэгийг өгч хариултаа дугуйл.

- Зөв Буруу Нифай Ишмэилийн ууган охинтой гэрлэсэн.
- Зөв Буруу Бөмбөрцөг хэлбэртэй Лиахона хэмээх луужин Лихайд өгөгдсөн.
- Зөв Буруу Тэр бөмбөрцөг дөрвөн зүүтэй бөгөөд Лихай болон түүний гэр бүлд зүг чиг өгдөг байв.
- Зөв Буруу Лихайн гэр бүл уг бөмбөрцгийг хүлээж авсны дараа цөл дэх тэдний аян хөнгөрсөн.

1 Нифай 16:7–10-ыг болон бүлгийн тоймыг судлахдаа эхний гурван асуултын хариугаа нэгтгэн дүгнэ (мөн Алма 37:38-ыг үз). 1 Нифай 16:17–19-ийг уншиж, дөрөв дэх асуултад зөв хариулсан эсэхээ шалга. (Зөв хариултууд нь энэ хичээлийн төгсгөлд байгаа.)

Дуулгавартай байгаа үед ч гэсэн бидэнд урьдын адил зовлон тохиолдох л болно. Бидэнд тохиолддог зовлон зүдгүүрүүдээс олон нь буруу сонголт хийсний үр дагавар байдаггүй. Харин зовлонгууд бидэнд мөнх бус амьдралын жам ёсны үр дүн болж ирдэг ч, яг Аврагчийн адилаар, бид мөнх бус амьдралынхаа турш сурч мэдэх, өсч хөгжих боломжтой болдог (С ба 122:7–8-ыг үзнэ үү). Бидэнд тохиолддог амьдралын сорилтуудын нэг нь эдгээр зовлонгуудад хэрхэн хандах явдал юм.

1 Нифай 16:10 дахь бөмбөрцгийн тухай Нифайн дүрслэлээс үзэхэд, энэхүү бэлэг нь Лихай болон түүний гэр бүлийг амлагдсан нутаг руу аялахад нь хэрхэн тусалж болох вэ? Лиахона Лихайн гэр бүлд хэрхэн ашиг тусаа өгснийг 1 Нифай 16:16-аас олж тэмдэглэ.

1 Нифай 16:20–22-ыг судалж, Нифайг нумаа алдахад Лихайн гэр бүлийн зарим гишүүд үүнд хэрхэн хандсаныг ол. 1 Нифай 16:23–25, 30–32-ыг судалж, Нифайн хандлагыг тодорхойл. Түүний хариу үйлдэл гэр бүлд нь хэрхэн нөлөөлсөн бэ?



2. Дараах асуултад судрын тэмдэглэлдээ хариулж бич: Нэг ижил асуудалд Нифай болон түүний гэр бүлийнхэн өөрөөр хандаж байгааг харьцуулснаар та юу сурав?

Нифай үглэж гомдоллолгүй шинэ нум хийж, хүнс залгуулахын тулд хаашаа явбал зохих талаар удирдамж хүссэн юм. **Хэрэв бид чадах бүхнээ хийж, Их Эзэний удирдамжийг эрэлхийлбэл Тэр, бидэнд бэрхшээл тулгарсан үед туслах болно** гэдгийг Нифайн үлгэр жишээ харуулж байна.

Их Эзэн эдгээр үйл явдлуудын үеэр Лиахона хэрхэн ажилладгийг Лихайд тайлбарлажээ. Лихайн гэр бүлийг Лиахонагаар дамжуулан удирдахын тулд Их Эзэнд юу шаардлагатай байсныг 1 Нифай 16:26–29-өөс ол.



3. Өөрийгөө бага насны хүүхдэд Лиахонагийн тухай зааж байна гэж төсөөлөн бод. Лиахона Лихайн гэр бүлийг хэрхэн удирдаж байсан болон цаашид тэднийг энэ бөмбөрцөг удирдахын тулд тэд юу хийх ёстой байсныг судрын тэмдэглэлдээ энгийн үгээр тайлбарла.



4. Дараах асуултад судрын тэмдэглэлдээ хариулж бич: “Их Эзэн өчүүхэн жижиг зүйлсээр агуу том зүйлүүдийг тохиолгон авчирч чадна” гэдгийг Лиахона бидэнд хэрхэн харуулж байна вэ? 1 Нифай 16:29

Их Эзэн Лихайн хүмүүсийг адисалсан шиг хувийн удирдамж хүлээн авахад туслах олон бэлгээр таныг хангасан байгаа. Эдгээр бэлгүүдийн заримынх нь талаарх дараах гурван зүйлийг уншиж, Их Эзэний эдгээр бэлэг бүр нь Лиахонатай хэр зэрэг адилхан болохыг тунгаан бод.

Патриархын адислал

Ерөнхийлөгч Томас С.Монсон патриархын адислалыг хувийн Лиахона гэж үзсэн байдаг:



“Лихайг Лиахонагаар хангасан Их Эзэн өнөөдөр таныг бас намайг бидний амьдралыг залуурдаж, учирч болзошгүй аюулаас сэрэмжлүүлэн, амлагдсан нутаг руу биш харин тэнгэр дэх бидний гэр орон руу аюулгүй замаар удирдах

үнэлж баршгүй ховор бэлгүүдээр хангасан юм. Миний хэлж буй энэ бэлэг бол та нарын патриархын адислал юм. Сүмийн зохистой гишүүн бүр үнэлж баршгүй эрдэнэс лүгээ адил энэ адислалыг хүлээн авах эрхтэй юм. . . .

Таны адислал бол цэвэрхэн нугалж, цааш хийж хадгалахад зориулагдаагүй. Мөн жаазанд хийж эсвэл нийтэд зарлахад зориулагдаагүй. Харин энэ нь уншихад, эрхэмлэн нандигнахад, мөн дагахад зориулагдсан юм. Патриархын адислал тань хамгийн хүнд хэцүү цаг мөчид танд туслах болно. Энэ нь таныг амьдралын аюул дундуур удирдан хөтлөх болно.

. . . Таны патриархын адислал бол замыг тань зааж удирдах таны хувийн Лиахона юм” (“Your Patriarchal Blessing: A Liahona of Light,” *Ensign*, 1986 оны 11-р сар, 65–66).

Судрууд ба бошиглогчдын үгс



Тухайн үедээ Далын гишүүнээр үйлчилж байсан Ахлагч В.Рольф Кэпп, Христийн болон Түүний үйлчлэгчдийн үгс бол сүнсний Лиахона гэдгийг батлан ингэж хэлсэн юм: “Христийн үгс бидэнд замыг заадаг учраас бид бүгдийн хувийн

Лиахона байж чадна. Зам нь амархан гээд залхуурахгүй байцгаая. Ариун судруудад цэдэглэгдсэн бөгөөд амьд бошиглогч, үзмэрч, илчлэгчдээр дамжин ирдэг Христийн үгсийг итгэлээр оюун ухаан, зүрх сэтгэлдээ шингээцгээе. Итгэл, хичээл зүтгэлээр Христийн үгс дээр найрлацгаая. Учир нь Христийн үгс бидний хийх ёстой бүх зүйлсийг хэлж өгдөг бидний сүнсний Лиахона байх болно” (“The Words of Christ—Our Spiritual Liahona,” *Ensign* ба Лиахона, 2004 оны 5-р сар, 37).

Ариун Сүнс



Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Дэвид А.Бэднар Ариун Сүнснийг Лиахонатай зүйрлэсэн байдаг: “Бид зан төлөв, үйлдлүүдээ улам бүр зөв шударга болгохыг хичээснээр, Лихай болон түүний гэр бүлд Лиахона хэрхэн замыг зааж байсантай адил Ариун Сүнс өнөөдөр бидэнд замыг заадаг. Лихайн гэр бүлийн төлөө Лиахонаг ажиллуулдаг байсан хүчин зүйлүүд мөн тийм байдлаар Ариун Сүнснийг бидний амьдралд урьдаг. Эрт үед Лиахонаг ажиллахгүй болгодог байсан хүчин зүйлүүд мөн тийм байдлаар өнөөдөр биднийг Ариун Сүнснээс хөндийрүүлэхэд хүргэж байна” (“That We May Always Have His Spirit to Be with Us,” *Ensign* ба Лиахона, 2006 оны 5-р сар, 30).



5. Патриархын адислал, судрууд, бошиглогчдын үгс болон Ариун Сүнснийг Лиахонатай адилтгаж болох гурван арга замын тухай судрын тэмдэглэлдээ бич.



6. Дээр жагсаасан эх сурвалжуудын нэгнээс ирсэн зааврыг дагахад, таныг, Их Эзэнээс удирдамж авахад хүргэсэн үеийн тухай судрын тэмдэглэлдээ дүрслэн бич.

1 Нифай 16:34–39

Ишмэлийн охид аавыгаа нас барсанд гашуудаж байхад Лемен, Лихай Нифай хоёрыг алахаар хуйвалдаж байв

Ишмэил цөлд олон хоног аялсны эцэст нас барсныг бид 1 Нифай 16:34–38-аас мэддэг билээ. Түүний охид аавыгаа алдсаны төлөө үлэмж ихээр гашуудаж байсан бол гэр бүлийнх нь зарим гишүүд Лихай Нифай хоёрт уурлан, Иерусалим руу буцахыг хүсч байв.

Тэр ч бүү хэл Лемен, Нифай Лихай хоёрыг алахаар сэм хуйвалджээ. Нифайн ах нар Их Эзэний хүслийг эрэлхийлээгүй учраас сул дорой байдал ба итгэлгүйгээ дахин харуулсан юм. Тэд Ариун Сүнснийг болон Түүний өгсөн тусламжийг үгүйсгэж байв.

1 Нифай 16:39-ийг уншиж, Их Эзэн ийм нөхцөлд юу хийснийг олж мэд. Энэ шүлэгт дурдсанаар Их Эзэн биднийг яагаад цээрлүүлдэг вэ? _____

Их Эзэн бидний ашиг тусын төлөө биднийг удирддаг бас цээрлүүлдэг. Хэрэв бид Их Эзэнээс хүлээн авсан удирдамж эсвэл цээрлэлийн дагуу ажиллавал Тэр биднийг адислах болно.



7. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би 1 Нифай 16-р бүлгийг судалж энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

Зөв/Буруу тааврын хариу: (1) Б, (2) З, (3) Б, (4) Б.

4-Р ХЭСЭГ: 3 ДАХЬ ӨДӨР

1 Нифай 17

Оршил

Лихайн гэр бүл цөлд найман жил бэдэрсний эцэст тэнгисийн хөвөөн дэх нэгэн газарт хүрч ирэв. Тэд энэ газрыг Өгөөмөр гэж нэрлэв. Усан онгоц барь хэмээх Их Эзэний зарлигийг Нифай дуулгавартай дагалаа. Тэр бас ах нарыгаа, Их Эзэнээс сүнсний удирдамж авахад нь саад болж байсан сул дорой байдлынх нь улмаас зэмлэв. 1 Нифай 17-г болон Нифайн үлгэр жишээг судлахдаа та дуулгавартай байх юм бол Бурханы зарлигласан бүхнийг биелүүлж чадна гэдгээ харах болно. Мөн Их Эзэн намуун, зөөлхөн дуу хоолойгоор дамжуулан тантай ярьж байгааг улам сайн ойлгох болно.

1 Нифай 17:1–51

Лихайн гэр бүлийг Өгөөмөрт очиход усан онгоц барихыг Нифайд зарлиг болгов

Та өөрийнхөө амьдралыг хүнд байна гэж боддог уу? Эсвэл амар хялбар байна гэж боддог уу? Яагаад? 1 Нифай 17:1, 4, 6-г уншиж, Нифай болон түүний гэр бүлийн цөлд хийсэн аян хүнд хэцүү байсан уу эсвэл хялбар байсан уу гэдгийг тодорхойлсон үгсийг дугуйл.

1 Нифай 17:3-ыг уншиж, хүнд үед Нифай гэр бүлээ адислагдсан гэж үзэж буй шалтгааныг— хэрэв гэсэн үгтэй өгүүлбэрээс ол. Энэ зарчмыг судартаа тэмдэглэ.

Судруудад сайн мэдээний зарчмууд нь ихэвчлэн “хэрэв-тэгвэл (бал, вал4)” холбоостой нийлмэл өгүүлбэрээр илэрхийлэгдсэн байдаг. “Хэрэв-тэгвэл” гэсэн загвар нь хувь хүмүүс, гэр бүлүүд болон улс үндэстнийг хамарсан зарчмыг илэрхийлсэн байдаг. Хэрэв гэдэг үг бидний үйлдлүүдийг дүрсэлдэг бол бал, вал залгавар нь тэр үйлийн үр дагавар эсвэл бидний хүлээн авах адислалыг заадаг. 1 Нифай 17:3-т хэрэв гэдэг үг байхгүй ч гэсэн үйлдэл болон үүнээс үүдэлтэй адислалыг дүрсэлсэн байдаг. Нифайн гэрчилж буй зарчмыг та өөрийнхөө үгээр хэрхэн нотлох вэ? **Хэрэв** _____ **вал** _____

Зарчмууд ба сургаалуудыг хэрхэн таньж сурах вэ?

Судруудыг судалж байх үедээ “бид ийн харж байна,” “тиймийн тул,” “иймийн тул,” “болгоогтун,” “хэрэв. . . тэгвэл. . .” гэсэн хэллэгийг ол. Эдгээр нь ихэвчлэн сайн мэдээний аль нэг сургаал эсвэл зарчмыг илэрхийлсэн байдаг.

Энэ зарчим 1 Нифай 17:2, 12–13-т хэрхэн дүрслэгдсэнийг анхаар. Эдгээр шүлгүүдийг уншихдаа Нифай болон түүний гэр бүл зарлигуудыг сахисан үед Их Эзэн тэднийг хүчирхэгжүүлж, адисалсан зарим арга замыг тэмдэглэ. Нифайн туршлагыг цааш нь судлахдаа энэ зарчим үнэн болох тухай нэмэлт нотолгоо эрж ол.



1. Дараах асуултуудад хариулахдаа өөртөө цаг гарган сайн бодож, судрын тэмдэглэлдээ хариулж бич. Энэ дасгал нь 1 Нифай 17:3-т өгүүлсэн зарчмаар Нифай үргэлжлүүлэн амьдарч байхад, гэр бүлийнх нь бусад гишүүд үүнийг дагаж чадаагүй гэдгийг ойлгоход тань туслах болно. Энэ зарчим таны амьдралд хэрхэн хэрэгжиж байгааг эргэцүүлэн бод.

а. Их Эзэн Нифайд юу хийхийг зарлиг болгосон бэ? (1 Нифай 17:7–8-ыг үзнэ үү.) Энэ зарлигийг дагахад юу нь хэцүү байсан байж болох вэ?


б. Энэ зарлигт Нифай яаж хандсан нь танд ямар санагдав? (1 Нифай 17:9–11, 15–16-г үзнэ үү.) Ах нар нь хэрхэн хандсан бэ? (1 Нифай 17:17–21-ийг үзнэ үү.) Та эдгээр шүлгүүдээс юу сурч болох вэ?

в. Нифай ах нартаа хариулахдаа Мосегийн туршлагыг сануулсан ажээ. Их Эзэн, Мосед зарлиг болгосон зүйлээ биелүүлэхэд нь хэрхэн тусалсан бэ? (1 Нифай 17:23–29-ийг үзнэ үү.) Нифайн ах нар юугаараа Израилын хүүхдүүдтэй адилхан байсан бэ? (1 Нифай 17:30, 42-ыг үзнэ үү.)

г. Таны хувьд биелүүлэхэд хэцүү ямар зарлигууд байдаг вэ? Биелүүлэхэд хэцүү ажил эсвэл Бурханы зарлигуудад та Нифай, Мосе нарын адилаар хандаж чадах уу?

Дээрх даалгаврыг хийж дуусгахдаа 1 Нифай 17:50 дахь Нифайн итгэлийн илрэлийг унш.

1 Нифай 17:51-ийг уншихдаа, “надад” гэдэг үгийн оронд өөрийнхөө нэрийг тавьж, “усан онгоц барих” гэдэг үгийг дээрх г асуултан дахь зарлигаар орлуулж, энэ шүлгийг өөртэйгөө холбогдуулан бод.

 **2.** Бурханы танаас хүссэн зүйлийг биелүүлэхэд Түүнд итгэснээр Тэрээр танд туслах болно. Үүнийг олж мэдсэн туршлагаа (танд эсвэл таны таньдаг хэн нэгэнд тохиолдсон) судрын тэмдэглэлдээ бич.

Нифай 1 Нифай 17-д мөн насан туршдаа чанд сахисан зарчим бол, **хэрэв бид зарлигуудыг сахивал Их Эзэн биднийг хүчирхэгжүүлж, Түүний зарлиг болгосон зүйлүүдийг биелүүлэх арга замаар биднийг хангах болно** гэсэн зарчим юм.

1 Нифай 17:45–55

Нифай ах нараа ёс бус байдлынх нь улмаас зэмлэв

1 Нифай 17:48, 53–54-ийг уншиж, Нифай яагаад, “гараа ах нарынхаа зүг сунгасныг” олж мэд.

1 Нифай 17:53-т өгүүлснээр Их Эзэн Нифайн ах нарт юу хийсэн бэ? Яагаад? _____

Нифайн ах нарыг балмагдахад хүргэсэн нь Их Эзэний хүмүүстэй харилцах олон арга замын нэг нь юм. 1 Нифай 17:45-ыг уншиж, Их Эзэн тэдэнтэй харилцахыг хичээсэн өөр арга замуудыг ол.



Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч Боид К.Пакэрын дараах эшлэлийг тунгаан бод: Ариун Сүнс дуу хоолойгоор ярьдаг бөгөөд та үүнийг сонсохоос илүүгээр *мэдэрдэг*. Энэ дуу хоолойг сударт ‘*намуухан аниргүй дуу хоолой*’ хэмээн С ба Г 85:6-д дүрсэлжээ. Бид Сүнсний шивнээг ‘сонсох’ тухай ярихдаа ‘*Надад*. . . (тийм нэг)



мэдрэмж төрлөө’ хэмээн сүнсний өдөөлтийг дүрслэн хэлдэг” (“Personal Revelation: The Gift, the Test, and the Promise,” Ensign, 1994 оны 11-р сар, 60).

1 Нифай 17:45-ыг судартаа тэмдэглэж, дараах зарчмыг хажууд нь бич: **Ариун Сүнс бидэнтэй намуухан зөөлөн дуу хоолойгоор ярьдаг бөгөөд бид үүнийг сонсохоос илүү мэдэрдэг.**

 **3.** Дараах асуултуудын хариулыг судрын тэмдэглэлдээ бич.

а. Их Эзэн намуухан, зөөлөн дуу хоолойгоор ярихыг та хэзээ мэдэрсэн бэ?

б. Намуухан, зөөлөн дуу хоолойг мэдэрч, танихын тулд та юу хийж болох вэ?

1 Нифай 17:45 дахь дараах хэллэгт тэмдэглэгээ хий: “тэрээр намуухан зөөлөн дуугаар та нарт ярьсан, гэвч та нар мэдрэхээс өнгөрсөн, иймээс та нар түүний үгсийг мэдэрч чадсангүй.” 1 Нифай 17:45-ын дундуур гарч байгаа өгүүлбэрийг дахин уншиж, Нифайн ах нар яагаад “мэдрэхээс өнгөрсөн” шалтгааныг ол.

Ариун Сүнсийг мэдрэхэд нүгэл бидэнд хэрхэн саад учруулдаг вэ? Өөр ямар зүйлүүд Ариун Сүнсийг

мэдрэхэд бидэнд саад учруулж болох вэ? _____

Тэргүүн Зөвлөлийн Ерөнхийлөгч Жэймс Э. Фауст Ариун Сүнсийг мэдрэхэд бидэнд саад учруулдаг зарим нүглийн талаар нэг зүйрлэлийг ашигласан байдаг.



“Өнөө үед гар утасны харилцаа холбоог өргөн ашиглаж байна. Гэвч зарим газарт бидний гар утасны сүлжээ унадаг. Жишээ нь: Бид газар доорх хонгил, уулын хавцал эсвэл гар утасны сүлжээнд саад болох ямар нэг зүйлтэй газарт явж байхад утас холбогддоггүй.

“Бурханы бидэнтэй харицах харилцаанд ч бас ийм байдаг. . . Бид сүнсний харилцааны сувгийг хааж, бурханлаг захиаснаас салгадаг газарт эсвээс тийм нөхцөл байдалд өөрсдийгөө олонтоо оруулдаг. Эдгээрт уур уцаар, порнограф, хуулийг болон гэрээ-нүүдээ зөрчих, амин хувиа хичээх болон Сүнсийг гомдоодог бусад нөхцөл байдал ордог (“Did You Get the Right Message?” *Ensign* эсвэл *Лиахона*, 2004 оны 5-р сар, 67).



4. Сүүлийн үед Их Эзэн танд хүргэхийг хүссэн захиасыг хэр сайн сонссон тухайгаа тунгаан бод. Намуухан зөөлөн дуу хоолойг хүлээн авахад саад болж, “сүнсний харилцааны сувгийг хаадаг” газрууд болон тийм нөхцөл байдалаас зайлсхийхийн тулд юу хийх тухайгаа судрын тэмдэглэлдээ бич.

Зохистой байж, сүнсний эдгээр намуухан, зөөлөн өдөөлтүүдэд анхаарал тавьбал та Их Эзэнээс захиас хүлээн авч чадна.



5. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би 1 Нифай 17-р бүлгийг судалж, (огноо)-нд энэ хичээлийг дуусгалаа .

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

4-Р ХЭСЭГ: 4 ДЭХ ӨДӨР

1 Нифай 18–19

Оршил

Нифай болон түүний гэр бүл Их Эзэний удирдамжийг биелүүлж, усан онгоц хийж дуусаад амлагдсан

нутаг руу хөвөхөд бэлэн болов. Далайн аяллын үед усан онгоцон дээр Лемен Лемүел хоёроор удирдуулсан олон хүн уурлаж, эсэргүүцэн тэмцэлдэв. Үүний балгаар Лиахона ажиллахаа больж, далайн хүчит шуурга усан онгоцон дээрх хүмүүсийн амь насанд заналхийлжээ. Уурлан сөргөлдөгчид наманчилж, Нифай итгэлээр залбирсны дараа Лиахона ажиллаж эхлэн, Их Эзэн далайн шуургыг намдааж, тэдний аяныг дахин удирджээ. Амлагдсан нутагт ирсний дараа Нифай, Аврагчийг санаж, өөрсдийгөө судруудтай адилтгахыг гэр бүлдээ ухуулжээ. 1 Нифай 18–19-ийг судлахдаа Нифайд тохиолдсон сорилтуудыг өнөөдөр өөртөө тохиолдож байгаа сорилтуудтай харьцуулж үз. Нифайн үлгэр жишээг дагахыг хичээ.

1 Нифай 18:1–8

Лихайн гэр бүл амлагдсан нутаг руу далайгаар хөвөхөөр бэлтгэсэн нь

Шаргуу ажиллах болон Их Эзэнээс удирдамж эрэлхийлэх нь яагаад хоёулаа чухал вэ? Нифай усан онгоц барьж байхдаа энэ хоёр чанарыг хоёуланг нь хэрхэн харуулсан бэ? 1 Нифай 18:1–8-ыг унш.



1. 1 Нифай 18:1–8 дахь Нифай болон түүний гэр бүлийн гаргасан хүч чармайлтуудыг дүрсэлсэн үг хэллэгүүдийг судрын тэмдэглэлдээ жагсаан бич. Дараа нь Их Эзэн тэднийг хэрхэн удирдаж, тэдэнд хэрхэн тусалж байсныг харуулсан бүх үг хэллэгүүдийг ол. Нифайн хүч чармайлт, Их Эзэнээс түүний хүлээж авсан тусламж хоёр хоорондоо ямар холбоотой байна вэ?

Их Эзэний зарлиг болгосон зүйлүүдийг гүйцэлдүүлэхийн тулд бид Түүний тусламжийг эрэлхийлж, чадах бүхнээ хийх хэрэгтэй гэдгийг Нифайн туршлага бидэнд харуулж байна.



2. Бурханы тусламж хэрэгтэй байгаа одоогийн нөхцөл байдлынхаа тухай бод. Их Эзэний удирдамжийг эрэлхийлэхийн тулд юу хийх, ямар хүч чармайлт гаргах хэрэгтэйг судрын тэмдэглэлдээ бич.

1 Нифай 18:8–25

Лемен Лемүел хоёр усан онгоцон дээр Нифайг эсэргүүцэн тэмцэлдсэн нь амлагдсан нутаг руу хийсэн аянд саад учруулж байв

Бид амьдралд сорилт бэрхшээлтэй тулгарсан үедээ яагаад ийм сорилт бидэнд тохиолдов хэмээн бодох нь нийтлэг тохиолддог. Магадгүй та өөрөө эсвэл таньдаг хэн нэгэн тань хүнд хэцүү үед “Яагаад?” гэж асууж байсан байх.

Далын Ерөнхийлөгчийн Зөвлөлийн Ахлагч Л.Витни Клэйтон бидэнд тохиолддог гурван төрлийн сорилт бэрхшээлийн тухай өгүүлжээ. Ахлагч Клэйтоны



үгийг уншихдаа түүний дурдсан сорилт бэрхшээлүүдийн эх сурвалжийн доогуур зур.



“Ерөнхийдөө бидний ачаа дарамт гурван эх сурвалжаас үүдэлтэй байдаг. Зарим ачаа дарамт нь бидний амьдарч байгаа дэлхийн нөхцөл байдлын жам ёсны үр дагавар байдаг. Өвчин эмгэг, хөгжлийн бэрхшээл, үе үе болдог

далайн хар салхи, газар хөдлөлт нь бидний алдаа дутагдлаас шалтгаалдаггүй. . . .

“Зарим ачаа дарамт бидэнд бусдын буруугаас болж бидэн дээр ирдэг. Хүчирхийлэл болон донтолт нь гэр бүлийн гэм зэмгүй гишүүдийн хувьд гэр орныг нь дэлхий дээрх тэнгэрийн нэгэн хэсэг байх боломжгүй болгодог. Нүгэл хилэнц, буруу ёс заншил, дарангуйлал, гэмт хэрэг зэрэг нь золиос болсон хүмүүсийн амьдралын замыг алдуулдаг. Хов жив ярих, бусдад найрсаг бус хандах зэрэг төдийлөн ноцтой биш юм шиг санагдах яльгүй нүгэл ч гэсэн бусдыг зовлонд унагаж болно.

“Бидэнд тохиолддог олон асуудал өөрсдийн маань гаргадаг алдаа дутагдлаас үүдэлтэй бөгөөд тэдгээр дутагдлууд нь бидний мөрөн дээр хүнд ачаа дарамт үүрүүлж болно. Өөрсдөдөө тохоодог хамгийн хүнд ачаа дарамт маань нүглийн дарамт юм. Зарлигуудыг сахиагүйгээс үүдэлтэй сэтгэлийн зовлон, гэмшил харамсал заавал ирдгийг бид бүхэн мэднэ”

(“That Your Burdens May Be Light,” *Ensign* ба *Лиахона*, 2009 оны 11-р сар, 12–13).

Нифай гэр бүлийнхээ хамт амлагдсан нутаг руу далайгаар хөвөх аянд гарсны дараа олон хүнд бэрхшээлтэй тулгарсан юм. 1 Нифай 18-ыг судлахдаа Ахлагч Клэйтоны дурдсан зовлонгийн төрлүүдийн нэгийг ол. 1 Нифай 18:9–11-ийг уншиж, усан онгоцон дээрх зарим хүмүүсийн буруу сонсголтын жишээнүүдийг олж тодорхойл.

Бүжиглэх, хөгжим сонсох, хөгжилтэй зүйл ярилцах нь буруу биш ч гэсэн тэд эдгээр зүйлсийг “үлэмж балмадаар” хийж байсныг 1 Нифай 18:9 харуулдаг. *Балмад* гэдэг үг бүдүүлэг, соёлгүй, таатай биш гэсэн утгатай. Сатан бидний зүрх сэтгэл, оюун ухааныг зэврүүлэн мохоож, биднийг Ариун Сүнсний нөхөрлөлгүй болгохын тулд бүжиг, дуу хөгжим болон бидний хэл яриаг ашиглаж болно.

1 Нифай 18:10-т өгүүлснээр Нифай, өөрийг нь эсэргүүцэн тэмцсэн хүмүүс наманчлахгүй бол юу тохиолдох болно гэж айсан бэ? _____

Нифай энэ талаар юу хийсэн бэ? Сонсож байгаа хөгжим, бүжиглэж байгаа байдлаа өөрчлөх эсвэл бүдүүлэг үг хэллэг хэрэглэхгүй байхыг эцэг эх эсвэл Сүмийн удирдагч танаас хүсвэл та хэрхэн хандах вэ? Та үгийг нь дагаж, өөрчлөгдөхийг хүсэх үү?

1 Нифай 18:12–14, 17–19-ийг уншихдаа тэдний эсэргүүцлийн үр дагавруудыг ол. Нифай болон түүний гэр бүлийн бусад гишүүд, бусдын үйлдлийн уршгаар хэрхэн зовсон бэ? Зарим хүмүүсийн эсэргүүцэл, нийт бүлэг хүмүүсийн Бурханаас удирдамж авах чадварт хэрхэн нөлөөлдгийг анхаар.

Нүгэл нь биднийг өөрсдийг маань төдийгүй бас бусад хүмүүсийг зовлон руу хөтөлдгийг эсэргүүцэгч хүмүүсийн дээрх үйлдлүүд харуулж байна.




3. Өнөөдөр өсвөр насныханд нийтлэг тохиолддог уруу таталтуудад эцэг эх болон удирдагчдад хүндэтгэлгүй хандах, шалгалтан дээр хуулах, хов жив ярих, даруу бус хувцаслах, ариун явдлын хууль болон Мэргэн Ухааны Үгийг зөрчих (тамхи, архи, мансууруулах бодис), порнограф үзэх явдал орж байна. Эдгээр уруу таталтуудаас хоёр эсвэл түүнээс олныг сонгон авч, уруу таталтанд бууж өгсөн хүний гэр бүл, найз нөхдөд энэ нь яаж нөлөөлөхийг судрын тэмдэглэлдээ бич.

Буруу сонголт хийсэн, үгүйгээс маань үл хамааран бидэнд бэрхшээл тохиолдох үед хэрхэн хандахыг 1 Нифай 18-ын үлдсэн хэсэг бидэнд зааж байна. 1 Нифай 18:15–16, 20–23-ыг уншиж, дээрх хоёр нөхцөлд юу хийхийг заасан үг хэллэгийн доогуур зур.



Эдгээр шүлгүүдэд нэлээд хэдэн сургаал ба зарчим дүрслэгдсэн байна. Дараах хэллэг бүрийн ард, түүнд заагдсан үнэний жишээг харуулсан шүлгийн дугаарыг 1 Нифай 18:15–16, 20–23-аас олж бич.

- Хүнд сорилт тулгарсан үед бид Бурханд найдаж, итгэлтэй хэвээр үлдэх хэрэгтэй. _____
- Хүнд сорилтын үед амар амгаланг олоход залбирал бидэнд тусална. _____

 **4.** Өмнөх дасгал дахь шүлгүүдээс өөртөө онцгой хамаатай нэг шүлгийг сонгож, яагаад энэ шүлэгт дуртайгаа судрын тэмдэглэлдээ бич. Уг шүлгээс юу сурснаа болон сорилт бэрхшээлд хэрхэн хандах талаар энэ шүлэг юу зааж байгааг оруул. Энэ шүлэг таны эсвэл өөр хэн нэгний амьдралд юу заасан тухай жишээ байвал энэ тухайгаа бич.

Нифай болон түүний гэр бүл олон сорилт бэршээлтэй тулгарсан ч эцэстээ амлагдсан нутагт хүрч ирэв. Хэрэв та Их Эзэний удирдамжийг эрэлхийлж, үүнийг дагахын тулд чадах бүхнээ хийвэл Их Эзэний таныг энэ дэлхийд илгээсэн тэрхүү зорилгыг та ч бас амжилттай гүйцэлдүүлж чадна.

Ахлагч Л.Витни Клэйтон дараах гэрчлэлийг хуваалцжээ:


“Амьдралд бидний үүрдэг ачаа байгалийн гамшиг уу, бусдын буруу үйлдэл үү эсвэл бидний алдаа дутагдал уу гэдэг нь хамаагүй бид бүгд хайраар дүүрэн Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүд бөгөөд Тэрбээр биднийг, энд өсч хөгжиг хэмээн мөнхийн төлөвлөгөөнийхөө хэсэг болгон дэлхийд илгээсэн билээ. Туршлага маань бид бүгдийг Түүнд буцаж очиход бэлтгэх болно. Бидэнд тохиолддог сорилт бэрхшээл, зовлон зүдгүүр нь үүрэхэд хүнд, удаан үргэлжилж болох ч тэнгэрлэг хэтийн төлөвөөс нь авч үзвэл энэ нь ‘хэсэг хугацаанд байх болно, мөн тэгээд [бид] үүнийг дажгүй давбал Бурхан [биднийг]’ тэнгэрт өргөмжлөх болно” [С ба Г 121:7–8]. Бид ачаагаа урт удаан хугацаанд ‘дажгүй’ үүрэхийн тулд энэ ачаа ‘хэсэг хугацаанд’ үргэлжлэхийг тэвчих ёстой.

“... Бид Бурханы зарлигуудыг болон гэрээнүүдээ сахих юм бол ачаагаа үүрэхэд маань Тэр туслах болно. Тэр бидэнд хүч чадал өгнө. Хэрэв бид наманчлах юм бол Тэр биднийг уучилж, амар амгалангийн мэдрэмж болон баяр баясгалангаар адислах болно” (“That Your Burdens May Be Light,” 13–14).


1 Нифай 19

Нифай, Есүс Христийг санахад биднийг ятгахын тулд Түүний талаарх бошиглоуудыг цэдэглэсэн юм.

Нифай амлалтын нутагт ирснийхээ дараа Аврагч ирэх талаар мөн Түүнийг Өөрийнх нь хүмүүс хэрхэн хүлээж авах тухай бошигложээ. 1 Нифай 19:8–10-ыг уншиж, Есүс Христийн мөн чанар ба зан чанарын тухай заасан хэллэгүүдийг ол.

 **5.** 1 Нифай 19:8–10-аас сурсан зүйл тань Аврагчийг хайрлах хайрыг тань хэрхэн өсгөн нэмэгдүүлсэн тухай судрын тэмдэглэлдээ бич.

1 Нифай 19:18–19, 23-ыг уншиж, Нифай өөрийн хүмүүсийг болон Мормоны Номыг уншсан бүх хүмүүсийг юу хийхэд ятгасныг өгүүлсэн үг хэллэгийн доогуур зурж өнөөдрийн хичээлийг дуусга. Аврагчийн тухай гэрчлэлээ найз эсвэл гэр бүлийн гишүүнтэйгээ эсвэл Сүмийн цуглаан дээр хуваалцах боломжийг эрэлхийл. Ингэснээр та, Аврагчаа санаж түүнд итгэхэд нь тэдэнд тусалж чадна.

 **6.** Амьдралдаа Нифайн үлгэр жишээг дагах арга замуудын тухай судрын тэмдэглэлдээ бич.

 **7.** Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би 1 Нифай 18–19-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

1 Нифай 20–22

Оршил

1 Нифай 20–21-т Нифай Хуучин Гэрээний бошиглогч Исаиагийн бошиглолуудаас эш татжээ. Лебенээс салгаж авахын тулд Нифай болон түүний ах нарыг Иерусалим руу буцааж явуулсан тэр гуулин ялтсууд дээр Исаиагийн бичээсүүд агуулагдаж байжээ. Эртний Израил гэрээнүүдээ сахидаггүй байсан ч Их Эзэн тэднийг хайрласан хэвээр, наманчилж, Өөртөө ирэхэд тэднийг урьсаар байв. Эдгээр бүлгүүдийг судлахдаа Исаиа Есүс Христийн тухай юу заасан болон Өөрийн хүмүүсийг гэтэлгэх Түүний хүсэл дээр анхаарал төвлөрүүл.

1 Нифай 20

Их Эзэн Израилыг шүүмжилж, тэднийг Өөртөө эргэж ирэхийг урьсан нь

Хийсэн гэрээнүүдтэйгээ эсвэл Сүмийн жишгүүдэд үл нийцэх ямар нэг зүйл хийсэн үеийнхээ тухай санаж байна уу? Шийдвэрийнхээ талаар та ямар бодолтой байсан бэ? 1 Нифай 20:1–2-ыг унш (2-р шүлэг дэх “тулгуурлах” гэсэн үг найдах гэсэн утгатай). Исаиа хэнд хандаж ярьсан бэ? “Иаковын угсаа” гэж ямар хүмүүс вэ?




Хуучин гэрээн дэх Иаков нь Исаакийн хүү, Абрахамын ач хүү юм. Их Эзэн түүнд Израил гэдэг нэр өгчээ (Эхлэл 32:28-ыг үзнэ үү). “Израилын угсаа” гэдэг үг түүний үр удмынхныг хэлэх бөгөөд заримдаа “Иаковын угсаа” гэдэг. Энэ үг бас Есүс Христэд үнэнчээр итгэгчдийг хэлдэг. (Судруудын Удирдамж, “Израил,” “Израилын хаант улс”-ыг үз.) Өнөө үед Бурхантай гэрээнүүд хийдэг (баптисмын гэх мэт) хүмүүсийг эрт үеийнхтэй адил Израилын угсааны гишүүд гэж үздэг.

1 Нифай 20:3–4, 8, 18-ыг судалж, Израилын угсаа Их Эзэнд итгэлгүй байсныг харуулсан үгс болон хэллэгийн доогуур зур. “Та нарын хүзүү төмөр шөрмөс, та нарын магнай гууль” (1 Нифай 20:4) гэсэн хэллэг нь судруудад, олон удаа давтагддаг “гөжүүд зан” гэсэн үгийг бэлгэдлээр төлөөлдөг. Энэ хэллэгийн нэг утга бол үхэр, илжиг зэрэг мал эзнээ хөтлөхөд явах дургүй байгаа үедээ хүзүүгээ хөшүүн болгож зогсдогтой зүйрлүүлсэн байж болох юм. Өөр нэг утга бол толгойгоо бөхийлгөх хүсэлгүй хүмүүс хөшүүн хүзүүтэй буюу гөжүүд байдаг гэсэн санаа юм. Үүн лүгээ адил бардам зан, ёс бусынхаа болон Их Эзэнээр удирдуулахаас татгалзсаныхаа улмаас Израилын угсааныхан хөшүүн хүзүүтэй буюу гөжүүд байсан юм.

Эдгээр шүлгүүдийг илүү сайн ойлгож, өнөө үетэй адилтгахын тулд Израилын угсааны энэхүү тодорхойлолт нь өнөө үеийн зарим хүмүүсийн үйлдлийг хэрхэн дүрсэлж байгаа тухай бод.

1 Нифай 20:9–14, 16-г уншихдаа эдгээр шүлгүүд Их Эзэний тухай мөн Тэрбээр ямар байдалтай харагддаг тухай юу зааж байгааг тунгаан бод.

 **1.** Дараах асуултуудад товчхон хариулж, судрын тэмдэглэлдээ бич:

- Хүмүүс өнгөрсөн үед Өөрийг нь эсэргүүцдэг байсан ч Их Эзэн тэдэнд хэрхэн хандаг байсан бэ? Яагаад? (1 Нифай 20:9–11, 14-ийг үзнэ үү.)
- Их Эзэн өөрийнхөө гэрээт хүмүүсээс юу хийхийг хүссэн бэ? (1 Нифай 20:12, 16-г үзнэ үү.)

Тунгаан бодолт

Тэргүүн Зөвлөлийн Нэгдүгээр зөвлөх, Ерөнхийлөгч Хэнри Б.Айринг ийн сургажээ: “Унших, судлах, тунгаан бодох нь хоорондоо адил зүйл биш. Бид үгсийг уншаад тэдгээрээс ямар нэг санаа авч болно. Бид судруудыг судалж, загварууд болон уялдаа холбоог нээн илрүүлж болно. Харин бид тунгаан бодохдоо Сүнсээр илчлэлтийг урьдаг. Миний хувьд тунгаан бодох гэдэг нь судруудыг анхааралтайгаар уншиж, судалсны дараа эргэцүүлэн бодож, залбирах явдал мөн” (“Serve with the Spirit,” *Ensign* ба *Лиакона*, 2010 оны 11-р сар, 60). Судруудыг нам гүм анир чимээгүй газарт судалж тунгаан бодох нь Ариун Сүнсний нөлөөг мэдрэхэд тань тусалж болно.



Их Эзэн, дуулгаваргүй хүмүүсийг наманчилж, Өөртөө ирэхийг урьдаг гэдгийг бид дээрх шүлгүүдээс мэддэг боллоо. Тэргүүн Зөвлөлийн гишүүн, Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорфын дараах үгийг уншиж, энэхүү үнэнийг баталсан хэллэг(үүд)-ийн доогуур зур.

“Сатан бидэнд уучлагдахаас өнгөрсөн гэж итгүүлийг хүсдэг (Илчлэлт 12:10-ыг үзнэ үү). Сатан биднийг нүгэл үйлдсэн л бол буцах аргагүй болж, —замаа өөрчлөхөд нэгэнт оройтсон гэж бодохыг хүсдэг. . . .

“Христ биднийг аврахаар ирсэн билээ. Хэрэв бид буруу замаар орох юм бол нүгэл нь буцах аргагүй зүйл биш гэдэг итгэлийг Есүс Христийн Цагаатгал бидэнд

өгч чадна. Хэрэв бид өөрсдийнхөө авралд зориулагдсан Бурханы төлөвлөгөөг дагавал аюулгүйгээр эргэх зам бидэнд боломжтой” (“Point of Safe Return,” *Ensign* ба *Лиакона*, 2007 оны 2—5-р сар, 99).

1 Нифай 21:1–17

Мессиа Өөрийн гэрээт хүмүүсийг мартахгүй хэмээн Исаиа бошиглосон юм

1 Нифай 21:1–13-т Мессиа болох Есүс Христийн тухай Исаиагийн бошиглолуудын нэгийг Нифай цэдэглэжээ. *Христ* гэдэг грек үг, *Мессиа* гэдэг еврей үг хоёул “Тослогдсон” эсвэл “Сонгогдсон Нэгэн” гэсэн утгатай. Есүс Христ, Израил болон Харийнхан аль алиных нь Гэтэлгэгч байхаар сонгогдсон билээ.

1 Нифай 21:6–13-ыг уншихдаа Есүс Христийг болон Тэрээр Израилын Гэтэлгэгчийн хувьд юу хийхийг дүрсэлсэн хэллэгүүдийг судартаа тэмдэглэ.

Израилын хүүхдүүд гэм нүглийнхээ улмаас өөрсдийгөө Их Эзэнээс холдуулсан атлаа, Тэрбээр тэднийг мартаж, орхисон гэж боддог байжээ (1 Нифай 21:14-ийг үзнэ үү). Хэдийгээр тэд Их Эзэн өөрсдийг нь орхисон гэж боддог байсан ч 1 Нифай 21:14–16-г судалж, **Их Эзэн биднийг хайрладаг бөгөөд хэзээ ч биднийг мартахгүй гэсэн нотолгоог ол.** Эдгээр шүлгүүдээс өөртөө хамаатай чухал гэж үзсэн хэллэгүүдийг тэмдэглэж болно.

Аврагч цовдлуулах үедээ олсон шархаа биднийг хэзээ ч мартахгүй байхын нотолгоо болгон хэрхэн үлдээснийг Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Жэффри Р.Холланд: “Христ Өөрийнхөө гэтэлгэсэн хүүхдүүдийг эсвээс тэднийг Сионд аврахын төлөө тэдэнтэй хийсэн гэрээгээ хэзээ ч мартахгүй байх болно” гэж тайлбарлажээ. [Түүний] бидний төлөөх хайр халамж болон бидэнтэй хийсэн гэрээний сэтгэл өвтгөм сануулга бол гарын алган дээр нь үлдсэн Ромын хадаасны сорви юм” (*Christ and the New Covenant* [1997], 84).



2. Дараах асуултуудын товч хариултыг судрын тэмдэглэлдээ бич:

- а.** Заримдаа хүмүүс яагаад, Их Эзэн өөрсдийг нь мартсан хэмээн үздэг гэж та боддог вэ?
 - б.** Аврагчийн гарын алган дээр сийлэгдсэн байх гэдэг нь юу гэсэн утгатай гэж та боддог вэ? Загалмай дээрх Аврагчийн зовлон шаналалд талархалтай байхад энэ нь танд хэрхэн туслах вэ?
 - в.** Их Эзэн таныг мартаагүй гэдгийг мэдэхэд тань тусалсан ямар туршлага танд байдаг вэ?
- 3.** Өнгөрсөн үеийнхээ нүглийн улмаас сүмд явах нь зохисгүй гэж үздэг нэг найз танд байдаг гэж төсөөлөн

бод. Судрын тэмдэглэлдээ, 1 Нифай 20–21-ээс болон 1 Нифай 20-ийн судлах хэсэг дэх Ерөнхийлөгч Угдорфын үгнээс сурч мэдсэн зүйлээ ашиглан, найзыгаа урамшуулан дэмжсэн товч захидал бич.

1 Нифай 21:18–22:22

Нифай, Израилын тараагдалт ба цугларалтын тухай Исаиагийн бошиглолыг тайлбарласан нь

Израилын цугларалтын тухай Исаиагийн бошиглолуудаас нэгийг нь Нифай цэдэгтээ оруулжээ. Энэ нь 1 Нифай 21:18–26-д байдаг. 1 Нифай 22-т Нифай, Исаиагийн бошиглолын талаар өөрийнхөө тайлбарыг оруулжээ. 1 Нифай 22:4–12-ыг уншиж, Израил эцсийн өдрүүдэд хэрхэн цугларах тухай Нифайн тайлбарыг ол.

Мормоны Номонд “харийнхан” гэдэг нэр томьёо ихэвчлэн Иудейн үр удмынх биш хүмүүсийг хэлдгийг мэдэх нь тустай байж болно. “Тайхамшигт ажил” гэдэг хэллэг нь хожмын үе дэх сайн мэдээний Сэргээлтийг хэлж байгаа юм. Түүнчлэн Нифай гэрээнийг хэчнээн удаа дурдсаныг анхаар. Тэдгэрийг судартаа тэмдэглэж болно.

Их Эзэн эцсийн өдрүүдэд сайн мэдээг сэргээж, Израилыг цуглуулахаар амласан юм. 1 Нифай 22:17, 19–22, 25–28-ыг судлахдаа хүмүүсийн зөв шударга байдлын улмаас Сатанд юу тохиолдохыг судартаа тэмдэглэ.



4. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би 1 Нифай 20–22-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

2 Нифайн

ОРШИЛ

Энэ номыг яагаад судлах хэрэгтэй вэ?

2 Нифай ном нь Адам, Ева хоёрын уналт, Есүс Христийн Цагаатгал, сонгох эрх зэрэг сайн мэдээний үндсэн сургаалыг ойлгоход тань тусална. Үүнээс гадна энэхүү ном нь Аврагчийн онцгой гэрчүүд болох Нифай, Иаков, Исаиа нарын бошиглолуудаар дүүрэн байдаг. Тэд хожмын өдрүүд дэх сайн мэдээний сэргээлт, Бурханы гэрээт хүмүүсийн цугларалт, Есүс Христийн Хоёр дахь ирэлт болон мянган жилийн талаар бошиглосон. Түүнчлэн 2 Нифай ном нь Христийн сургаалын талаарх Нифайн тайлбарыг багтааж, Аврагчийн талаарх Нифайн гэрчлэлээр төгсдөг.

Энэ номыг хэн бичсэн бэ?

2 Нифай номыг Лихайн хүү Нифай бичжээ. Нифай нь бошиглогч бөгөөд Нифайн хүмүүсийн анхны агуу удирдагч байсан юм. Тэрээр Их Эзэний гэтэлгэлийн хүчийг мэдэрснийг (2 Нифай 4:15–35; 33:6) мөн бүхий л сэтгэл зүрхээрээ өөрийн хүмүүст авралыг авчрахыг хүсч байсныг (2 Нифай 33:3–4-ийг үзнэ үү) түүний бичээсүүд харуулдаг. Нифай энэхүү зорилгоо биелүүлэхийн тулд ариун сүм барьж, Есүс Христэд итгэхийг өөрийн хүмүүст заасан.

Энэ ном хэзээ, хаана бичигдсэн бэ?

2 Нифай номд бичигдсэн энэхүү шастирыг Нифай ойролцоогоор мээ 570 оны орчим буюу гэр бүл нь Иерусалимыг орхин явснаас хойш 30 жилийн дараа бичиж эхэлжээ (2 Нифай 5:28–31-ийг үзнэ үү). Тэрээр Нифайн нутагт байхдаа үүнийг бичжээ (2 Нифай 5:8, 28–34-ийг үзнэ үү).

5-Р ХЭСЭГ: 2 ДАХЬ ӨДӨР

2 Нифай 1

Оршил

2 Нифай 1-ийг судлахдаа энэ нь удахгүй насан эцэс болох гэж байгаа халамжит эцэг бөгөөд санваарын удирдагчийн үгсийг агуулж буйг анхаараарай. Эцэг Лихай нь Бурханы зарлигуудад дуулгавартай байхыг гэр бүлийнхнээсээ хүсэв (2 Нифай 1:16-г үзнэ

үү). Бурханы зарлигуудад дуулгавартай байх аваас тэд амлагдсан нутагт дэгжих болно хэмээн Лихай бошигложээ. Түүнчлэн тэрээр хүүхдүүддээ болон Иерусалимаас тэднийг дагаж ирсэн хүмүүст Нифайн бошиглол удирдлагыг дагахыг ухуулав. Энэхүү бүлгийг судлах явцдаа та, Их Эзэний зарлигуудыг дагах хувийн дуулгавартай байдлаа дүгнэж цэгнэ. Та сүмийн удирдагчдын зөвлөгөөг хэр сайн дагадаг вэ?

2 Нифай 1:1–23

Лихай өөрийн хүмүүст зөв шударгаар амьдрахыг ухуулдаг

Та гэр бүлээ гэнэт орхин явах болсон бөгөөд дахин хэзээ ч тэднийгээ харахгүй хэмээн төсөөлөөд үзээрэй. Та тэдэнд хандан хамгийн сүүлийн удаа ярих боломжтой байгаа. Ийм нөхцөлд та юу хэлэх байсан бэ?

2 Нифай 1–4-т эцгийнхээ гэр бүлдээ хандан хэлсэн сүүлчийн зөвлөгөөг Нифай цэдэглэжээ. Эдгээр бүлгүүдийг судлах явцдаа Лихайн сүүлчийн зөвлөгөө танд хэрхэн хамаарч байгаа талаар бодно уу.

2 Нифай 1:1–4-ийг уншаад Лихайн гэр бүлийн төлөө “Их Эзэний үйлдсэн агуу зүйлс” юу байсныг тодорхойл.



1. Дараах асуултуудын товч хариултыг судрын тэмдэглэлдээ бич:

а. Их Эзэн ямар арга замуудаар Лихайн гэр бүлд нигүүлсэл үзүүлж байсан бэ?

б. Танд болон танай гэр бүлийн төлөө Их Эзэн ямар “агуу зүйлс” үйлдсэн бэ? Их Эзэн танд болон танай гэр бүлд хэрхэн нигүүлсэнгүй хандсан талаар бодох үед танд түүний талаар ямар мэдрэмж төрдөг вэ?

Лихай амьдралдаа “Бурханы нигүүлсэл” болон “агуу зүйлс”-ийг үргэлжлүүлэн хүлээж авах эсэх нь Бурханы зарлигуудыг дагах сонголтоос шалтгаална хэмээн өөрийнхөө гэр бүлд заажээ.



2. Биднийг Их Эзэний зарлигуудыг дагах үед Тэрээр биднийг адисалдаг, харин бид зарлигуудыг нь дагахгүй байх үед Тэрээр адислалуудаа өгөхөөс татгалздаг гэдгийг харуулсан доорхтой адил бүдүүвч зургийг судрын тэмдэглэлдээ зур. 2 Нифай 1:7–11-ийг уншаад (“хэрвээ”) Лихайн хэлсэн тодорхой үр дагавруудыг авчирдаг (“дараа нь”) үйлдлүүдийг тодорхойлж бич. Судрын тэмдэглэл дэх бүдүүвч зургийн тохирох баганын доор олж мэдсэн зүйлсээ бич.

Сургаал ба зарчмуудыг тодорхойлох

Судрууд дахь сайн мэдээний сургаал ба зарчмуудыг тодорхойлж сурахын тулд хичээл зүтгэл гаргаж, дадлага хийх хэрэгтэй. Судруудаас олж мэдсэн үнэн нүүдийг “хэрвээ-дараа нь” гэсэн хэлбэрт оруулж бичих нь амьдралд тань хэрэглэгдэх зарчмуудыг ойлгоход туслах болно.

Хэрэв (үйлдлүүд)	Дараа нь (үр дагаврууд)

Лихай ялангуяа Лемен, Лемүел нарын сүнслэг байдлын төлөө санаа зовж, тэднийг наманчлах хэрэгтэй гэдгийг мэдэж байлаа. Тэрээр тэдэнд ухуулахдаа нүгэл болон наманчлалыг ойлгоход нь туслах хэд хэдэн тэмдгүүдийг ашиглав. 2 Нифай 1:13–14-ийг уншин, Лихай хөвгүүддээ наманчлахыг заах үедээ ашигласан тэмдгүүдийг олж, доорх хоосон зайнд бичнэ үү.

“ _____ -оос _____ ”

“ _____ зайлуулаасай _____ ”

“ _____ -оос _____ ”



3. Дараах асуултад судрын тэмдэглэлдээ хариулж бич: Наманчлал нь дээрх дасгал дахь үг хэллэгтэй юугаараа төстэй вэ?

2 Нифай 1:15-ыг уншаад, Лихайн Бурханы зарлигуудад дуулгавартай байснаар хүлээж авсан адислалуудаа дүрслэн хэлэхдээ ашигласан гурван үг хэллэгийг олж, судартаа тэмдэглэ. Эдгээр адислалуудыг 2 Нифай 1:17–18, 22-р шүлгүүдэд Бурханы зарлигуудыг дагадаггүй хүмүүст ирнэ хэмээн Лихайн заасан сөрөг үр дагавруудтай харьцуул.

2 Нифай 1:23-г гардаг Лихайн зөвлөгөөг тэмдэглээд энэхүү бүлэг дэх Лихайн ярьсан “сэрж”, “сэгсрэн хаяж” эсвэл “бос”-соноор ирэх адислалуудыг хүлээн авахын тулд та амьдралдаа юу хийх хэрэгтэйгээ тунгаан бод.

2 Нифай 1:24–32

Лихай хөвгүүддээ Нифайн бошиглолыг дага хэмээн ухуулав

Дараа нь Лихай гэр бүлдээ болон бусад хүмүүст тэдний хүлээж авсан, амьдралдаа зөв шийдвэрүүдийг гаргахад нь туслах сүнслэг удирдамж, чиглүүлийн өөр нэгэн эх сурвалжийг сануулав. 2 Нифай 1:24-ийг уншаад уг эх сурвалжийг ол.

2 Нифай 1:24–27-г уншихдаа Лихай хэрхэн өөрийн хүмүүсийг Нифайг дагахыг урамшуулан дэмжиж байсныг ажиглаарай. Дараах асуултуудын хариултуудыг бодоорой:

- Нифайг удирдагч хэмээн итгэхэд тань туслах ямар ямар шинж чанаруудыг Лихай онцолсон бэ?
- Та яагаад эдгээр шинж чанаруудтай удирдагчид итгэх ёстой вэ?



- Одоогийн сүмийн удирдагчид эдгээр шинж чанаруудыг харуулж байгааг та харсан уу?

2 Нифай 1:28–32-ыг уншаад, Нифайн удирдлагыг дагасан хүмүүст ирэх Лихайн амласан амлалтуудыг судартаа тэмдэглэ. Энэхүү амлалтууд нь **биднийг удирдахаар Бурханаар дуудагдсан хүмүүсийг дагах үед бид сүнслэг хөгжил дэвшил, аюулгүй байдлаар адислагдах болно гэдгийг харуулдаг**. Сүнслэгээр нөлөөлсөн зөвлөгөөг дуулгавартай дагах нь таныг сүнслэг хөгжил дэвшил, аюулгүй байдал руу хөтөлдөг тухай сүмийн удирдагчид хамгийн сүүлд юу гэж заасныг тунгаан бод.



Ерөнхийлөгч Вилфорд Вудраффын хэлсэн дараах үгсийг уншаад, Их Эзэний үйлчлэгчдийн зөвлөгөөг дагаснаар ирэх амлалтуудын доогуур зур: “Бид бүгдээрээ Их Эзэний үйлчлэгчдийн зааж өгсөн замаар явах байх хэмээн би найдаж байна. Учир нь бид уг замаар явбал энэ дэлхийд аюулгүй байж, ирэх дэлхийд аз жаргал, өргөмжлөлийг хүлээн авах болно. . . . Хэрэв бид итгэлтэй байвал тэд биднийг амьдралын замаар удирдах бөгөөд тэдний зааврууд болон тэднээр дамжуулан Ариун Сүнсний заасан зүйлсэд итгэх итгэлтэй байхын хэрээр бид үргэлж аюулгүй зам дээр байж, гарцаагүй шагнагдах болно” (*Teachings of Presidents of the Church: Wilford Woodruff* [2004], 199).



4. Их Эзэний зарлигууд болон Түүний үйлчлэгчдийн зөвлөгөөг амьдралынхаа туршид дуулгавартай дагах нь яагаад чухал гэж боддогоо судрын тэмдэглэлдээ бич.



5. Дараах өгүүлбэрийг судрын тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би 2 Нифай 1-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:



5-Р ХЭСЭГ: 3 ДАХЬ ӨДӨР

2 Нифай 2

Оршил

2 Нифай 2-р бүлэгт Тэнгэрлэг Эцэг яагаад Өөрийн хүүхдүүдийг зовлон зүдгүүр, харамсал гуниг, үхэл, нүгэл хилэнцээр дүүрэн дэлхий рүү илгээсэн тухай Лихай өөрийн хүү Иаковт заадаг. Тэрээр мөнх бус байдлын зорилгыг Иаковт ойлгуулахын тулд сонголт, Адамын уналт, Есүс Христийн Цагаатгал зэрэг гэтэлгэлийн төлөвлөгөөний үндсэн зарчмуудыг тайлбарлажээ. 2 Нифай 2-р бүлэгт заасан үнэнүүдийг суралцах нь Есүс Христийн Цагаатгал бидэнд Уналтын үр дагаврыг хэрхэн даван гарах болон мөнх амьдрал руу хөтлөх сонголтуудыг хүн бүрд боломжтой болгож өгсөн гэдэгт илүү талархалтай болоход тусалдаг.

2 Нифай 2:1–25

Лихай Адамын уналт болон Есүс Христийн Цагаатгалын талаар заав.

Сүүлийн үед өөрт тань тулгарч байсан асуудлуудын тухай бод. Та амьдралд яагаад иймэрхүү асуудлууд тулгардаг юм бол гэж бодож байсан уу? Та 2 Нифай 2:1-ийг унших үедээ Иаковын бага насны тухай дүрслэн хэлэхдээ ашигласан Лихайн үгс болон үг хэллэгүүдийг тэмдэглэх хэрэгтэй. Дараа нь 2 Нифай 2:2-ыг уншаад, зовлон зүдгүүрийнх нь үр дүн юу байх талаар Лихайн Иаковт амласан зүйлсийг тэмдэглэ. *Ариулан адислах* гэдэг үгийн нэг утга нь онцгойлон адислах эсвэл ариун болгох гэсэн үг юм. Лихай, Иаковын туйлын ашиг тусын тулд зүдгүүрүүдийг нь Их Эзэн онцгойлон адислах болно хэмээн Иаковт амлаж байна.

Лихай Адамын уналтын зайлшгүй байдал болон Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөн дэх Есүс Христийн Цагаатгал бидэнд шаардлагатай байсан талаар

Иаковт заав. Уналт болон Цагаатгал нь бидэнд сонголтоо ашиглах боломжийг бий болгож өгсөн ба ингэснээр бид өсөж хөгжиж, мөнх амьдрал руу урагшилж чадна гэдгийг Иаков мэдээсэй хэмээн Лихай хүсч байв. 2 Нифай 2:15–18-ыг уншаад дараах асуултуудад товчхон хариулж бич:

- Бурхан Адам Ева хоёрыг Едений цэцэрлэгт сонголтоо ашиглахыг нь зөвшөөрч юугаар хангасан бэ? (2 Нифай 2:15–16-г үзнэ үү.) _____
- Сатан Едений цэцэрлэгт юу эрэлхийлж байсан бэ? (2 Нифай 2:17–18-ыг үзнэ үү.) Та Сатан энэхүү зорилгоо өнөөдөр хэрхэн үргэлжлүүлж байгааг харж байна уу? _____



1. Судрын тэмдэглэлдээ доорх хүснэгтийг зур. 2 Нифай 2:19–25-ыг уншаад хэрвээ Адам, Ева хоёр хориглогдсон жимснээс идээгүй, унаагүй байсан бол ямар үр дагавар гарах байсныг, түүнчлэн уналтаас болж ямар үр дүн гарсныг олж тодорхойл.

Адам, Ева хоёр унаагүй байсан бол (2 Нифай 2:22–23)	Адам, Ева хоёр унаснаас болж (2 Нифай 2:19–20, 25)

Хүснэгтийг бөглөж дууссаныхаа дараа яагаад **Адам, Евагийн уналт нь Тэнгэрлэг Эцэгийн аз жаргалын төлөвлөгөөний нэгэн чухал хэсэг** болохыг тунгаан бод.



2. Найз тань Адам, Ева хоёр хориглогдсон жимснээс хүртэж алдаа гаргасан хэмээн танд хэлж байна гэж төсөөл. 2 Нифай 2:19–25-р шүлгүүдээс сурсан зүйлсээ ашиглан, судрын тэмдэглэлдээ бидний авралын төлөөх Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөнд Уналт яагаад чухал болохыг тайлбарлан бич.

Адам, Евагийн уналт нь бидэнд өсөж хөгжих замыг нээж өгсөн ч өөр бусад үр дагавруудыг авчирсан. Уналтаас өмнө Адам, Ева хоёр Едений цэцэрлэгт Бурханы оршихуйд байсан бөгөөд хориглогдсон жимснээс хүртсэнийхээ дараа Түүний оршихуйгаас явах хэрэгтэй болсон.

2 Нифай 2:5-ыг уншаад Уналтын дараа Адам, Ева хоёр Бурханы оршихуйгаас тусгаарлагдаж байгааг илэрхийлсэн үг хэллэгийг ол. “Зуурдын хууль” нь

уналтын үр дүнд ирсэн бие махбодын хуулинд хамаардаг. Иймээс “зуурдын хуулийн” дагуу “тусгаарлагдах” гэдэг нь Адам, Ева хоёрын үр удмын хувьд бидний өвлөж авсан мөнх бус байдалд хамаарна. Эдгээр хуулийн улмаас бид Бурханы оршихуйгаас бие махбодын хувьд тусгаарлагдаж, харамсал гуниг, өвчин шаналал, зовлон зүдгүүр, биеийн үхлийн харьяат болсон юм. “Сүнсний хуулийн” дагуу “тусгаарлагдах” гэдэг нь өөрсдийн гэм нүглийн улмаас Бурханы оршихуйгаас тусгаарлагдахыг хэлнэ.

Дараах асуултуудад тулгуурлан уналтын үр дагавруудыг биеэрээ хэрхэн үзсэн талаар тунгаан бод:

- Та энэ амьдралд ямар ямар зовлон зүдгүүр, өвчин шаналал, харамсал гунигийг амссан бэ?
- Хэн нэгэн таньдаг хүн тань нас барсан уу? Тэр хүний үхэл танд хэрхэн нөлөөлсөн бэ?
- Та хэзээ Бурханаас сүнслэгээр тусгаарлагдсан мэт мэдэрч байсан бэ?

2 Нифай 2:6–10-ыг унших үедээ Цагаатгалаар дамжуулан Есүс Христ биднийг Уналтын үр нөлөөнөөс гэтэлгэдэг бөгөөд нүглээс ангижрах боломжийг олгодог гэдгийг харуулсан түлхүүр үгс болон үг хэллэгийг олж, тэмдэглэх хэрэгтэй. 2 Нифай 2:9–10 дахь *өлгөөлөл* гэдэг нь өөр хэн нэгний ашиг тусын тулд үйлдэх гэсэн утгатай.

Төгс эзэмших судар—2 Нифай 2:25

Лихай Адамын Уналт болон мөнх бус амьдралд бидний биеэр амсдаг сөрөг зүйлсийн талаар Иаковт заахдаа бүх хүн төрөлхтөнд зориулсан Уналтын эерэг талуудыг онцлон хэлсэн.



3. Судрын тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

- а.** Уналтын талаар сурсан зүйлс тань хүн төрөлхтөнд хэрхэн баяр баяслыг авчирдаг вэ?
- б.** Та Уналтын эерэг үр дагавруудаас баяр баяслыг хэзээ мэдрч байсан бэ?


Сайн мэдээний үнэн нүүдийг тайлбарлах дадлага хий

Амьдралын тань туршид номлогчийн хувьд, сүмийн дуудлагаа хийж байхад тань, гэр бүлийнхэн, найзууд, танилууд тань таны итгэдэг зүйлс болон сайн мэдээний сургаалуудыг тайлбарлахыг танаас хүсэх болно. Сайн мэдээг тайлбарлан бичиж, дадлага хийхдээ ямар нэгэн тодорхой хүнд зориулж байгаа мэт төсөөлөн бичих нь илүү үр дүнтэй байж болно. Энэ нь сайн мэдээний захиасыг тухайн хүнд зориулан заахад тань туслах болно.

2 Нифай 2:11–18, 26–30

Лихай бидний сонгох эрх болон сонголтын үр дагаврын талаар заав

Сүүлийн үед хийсэн чухал сонголт болон уг сонголт оос ирж болох удаан хугацааны үр дагаврын талаар бод. Лихай Тэнгэрлэг Эцэгийн авралын төлөвлөгөөн дэх сонгох эрхийн гол ач холбогдлыг өөрийн хүмүүст заав. **Бид эрх чөлөө болон мөнх амьдралыг сонгох эсвэл боолчлол болон үхлийг сонгох эрхтэй** (2 Нифай 2:27-г үзнэ үү) гэдгийг ойлгоход тань туслах дараах дасгалуудыг хийж гүйцээ.

 **4.** *Залуучуудын бат бөх байдлын төлөө* ([Товхимол, 2011], 2–3)-оос авсан дараах мэдэгдэл тус бүрийг судрын тэмдэглэлдээ бич. Дараа нь 2 Нифай 2:11–18, 26–29-р шүлгүүдийг уншихдаа, мэдэгдлүүдийг баталж байгаа шүлгүүдийн дугаарыг ард нь бич. Шүлэг бүрийн дугаар аль нэг мэдэгдлийн ард бичигдсэн байх ёстой. Нэг мэдэгдэлтэй нэгээс илүү шүлэг, нэг шүлэгтэй нэгээс илүү мэдэгдэл тохирч болно. Жишээ нь: Эхний мэдэгдэлд тохирох шүлэг болох 2 Нифай 2:16-д Лихайн заасан нэгэн үнэн нь бидэнд өөрсдийнхөө төлөө үйлдэх чадвар олгогдсон явдал юм.

а. “Тэнгэрлэг Эцэг та нарт муугаас сайныг ялгах чадвар мөн өөрийнхөө төлөө сонголт хийх эрхийг өгсөн.” 2 Нифай 2:16

б. “Дэлхий дээр байх хугацаандаа та нар Бурханы зарлигуудыг дагаж, түүнд хайраа үзүүлэхээр сонгох эрхээ ашиглах эсэхээ шалгуулдаг.”

в. “Хэдийгээр та нар чөлөөтэйгөөр сонгох эрхтэй ч үр дагавруудыг нь чөлөөтэй сонгож чадахгүй.”

г. “Нүгэлт . . . сонголтууд нь таны өсөлт хөгжилд саад тотгор учруулдаг бөгөөд харуусал гуниг, сэтгэлийн зовлон руу хөтөлдөг.”


д. “Зөв шударга сонголт нь байнгын аз жаргал болон мөнхийн амьдрал руу хөтөлнө.


2 Нифай 2:26–27-г унш. Та юуг чөлөөтэй сонгох эрхтэй вэ? 2 Нифай 2:28-ыг уншаад, Бурхан танд “мөнх амьдралыг сонгоход” туслах өөр юу өгснийг олж тэмдэглэ. Амьдралдаа хийж байсан сонголт уудаасаа мөнх амьдралыг сонгосон гэдгийг тань харуулах сонголтын талаар тунгаан бод.

Төгс эзэмших судар—2 Нифай 2:27

Төгс эзэмших судар 2 Нифай 2:27-г цээжил. Эхлээд энэ шүлгийг хэд дахин уншсаны дараа судраа хаагаад доор бичигдсэн уг шүлэг дэх үг бүрийн эхний үсгийг ашиглан өөртөө юуу гэр бүлийнхээ хэн нэгэнд цээжээр уншиж өгөхийг хичээ. Цээжээр хэлж суртлаа энэ дасгалыг давт.

И т, х б м д ч б; м х ш б б з т ө б. М т б х а и З д, э ч б м а с э ч х м б д, б б ү с э; у т б х ө а з б б э б.

 **5.** Дээр бичигдсэн 2 Нифай 2:27-р шүлгийн үг бүрийн эхний үсгүүдийг ашиглан энэхүү төгс эзэмших судрыг судрын тэмдэглэлдээ бич. Харж болохгүй шүү!

 **6.** Дараах өгүүлбэрийг судрын тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би 2 Нифай 2-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

5-Р ХЭСЭГ: 4 ДЭХ ӨДӨР

2 Нифай 3

Оршил

2 Нифай 3-р бүлэгт Лихай отгон хүү Иосефтоо хандан ярьж, түүнийг адислав. Ингэхдээ Лихай сонгогдсон үзмэрч бага Иосеф Смитийн Мормоны Номыг урагш авчрах үүргийн талаар Египетийн Иосефын бошиглолыг дахин өгүүлэв. Энэ хичээлээр та Бошиглогч Иосеф Смитэд талархах агуу талархал болон сайн мэдээний сэргээлт дэх түүний тэнгэрлэг үүргийн талаар хүчтэй гэрчлэлийг олж авах боломжтой болно.

2 Нифай 3:1–25

Лихай Бошиглогч Иосеф Смитийн талаарх Египетийн Иосефын бошиглолыг дахин өгүүлэв.

Лихай гэр бүлдээ хандсан яриагаа үргэлжлүүлэхдээ хүү Иосефтоо түүнээс гадна гурван өөр Иосеф гэдэг нэртэй хүмүүсийн талаар заав. 2 Нифай 3-р бүлэг дэх судрын эшлэлээс Иосеф эсвэл уг судраас сурсан бусад Иосефууд хүртэл шугам тат.



2 Нифай 3:3 2 Нифай 3:4 2 Нифай 3:14 2 Нифай 3:15

Энэхүү хичээл нь Бошиглогч Иосеф Смитийг төрөхөөс 3,000 гаруй жилийн өмнө түүний тухай бошигложосон Египетийн Иосефын бошиглолд төвлөрнө.



1. Бошиглогч Иосеф Смит болон сайн мэдээний сэргээлт дэх түүний үүргийн тухай бодох үед таны ой ухаанд орж ирж буй үйл явдлууд болон заасан зүйлсийг судрын тэмдэглэлдээ жагсаан бичиж эхэл. Хичээлийн туршид илүү их мэдээлэл олж мэдэх үедээ энэ жагсаалтдаа нэмж бичих учраас хангалттай зай үлдээгээрэй.

Жагсаалт гаргах

Жагсаалт нь танд судраас болон бошиглогчдоос сурсан зүйлсээ эмх цэгцтэй болгоход тань тусалдаг бөгөөд та тэдгээрийг санаж, сурсан зүйлсээ бусадтай хуваалцахад бэлэн байх болно. Жагсаалт гаргахдаа тодорхой гарчиг өгч, хангалттай мэдээлэл оруул. Тэгснээр та дараа нь жагсаалтыг эргэн харахдаа ямар зорилгоор гаргаснаа санаж чадна.

2 Нифай 3:6–8-ыг уншаад Египетийн Иосеф, Бошиглогч Иосеф Смит болон түүний хийх ажлыг тайлбарлахдаа ашигласан үгс ба үг хэллэгүүдийг олж тодорхойл. Эдгээр үгс болон үг хэллэгүүдээс судрын тэмдэглэл дэх бошиглогчийн талаарх жагсаалтдаа чухал гэж үзэж байгаа үгсийг нэм. Эдгээр шүлгүүдэд **Их Эзэн сайн мэдээний сэргээлтийг гүйцэлдүүлэхэд туслуулахын тулд Бошиглогч Иосеф Смитийг**

бэлтгэсэн гэдгийг Египетийн Иосеф гэрчилдэг. 2 Нифай 3-р бүлгийг үргэлжлүүлэн судлахдаа Бошиглогч Иосеф Смитийн тэнгэрлэг зорилгын талаарх таны гэрчлэлийг хүчирхэгжүүлж байгаа нэмэлт үнэнүүдийг олж, жагсаалтдаа нэмж бич.

Египетийн Иосефын бошиглолыг илүү сайн ойлгохын тулд 2 Нифай 3:6–7, 11 болон 14-р шүлгүүдэд *үзмэрч* гэдэг үг хэдэн удаа давтагдаж байгааг анзаараарай. Нэг шүлгийнх нь хажуу талын зайд *үзмэрч* гэдэг нь өнгөрсөн, одоо, ирээдүйг мэдэж чаддаг хүн гэж тэмдэглэх хэрэгтэй (Мозая 8:13–17-г үзнэ үү).

2 Нифай 3:7-д, Иосеф Смитийг “агуу үнэт болох . . . ажил үйлдэх”-ийг Их Эзэн өөрт нь хэлсэн хэмээн Египетийн Иосеф хэлсэн. 2 Нифай 3:11–15, 19–21-т Их Эзэн бошиглогч Иосефоор дамжуулан ямар “агуу үнэт” ажлыг хийх гэж байсныг судалж мэд. Таны хувьд хэрэглэх боломжтой суралцахад туслах хэрэгслүүд (бүлгийн тойм, зүүлт тайлбар, судруудын удирдамж гэх мэт) нь Египетийн Иосефын талаар олон дэлгэрэнгүй мэдээллийг ойлгоход тань тусална. Бошиглогч Иосеф Смитийн үүргийн талаар шинэ мэдээлэл олбол судрын тэмдэглэл дэх жагсаалтдаа нэмж бич.

Судрууд дахь “[хэн нэгний] хэвлийн үр жимс” хэмээх дүрслэл нь уг хүний үр удам гэсэн үг юм. Египетийн Иосеф өөрийнх нь үр удмын нэг болох Бошиглогч Иосеф Смит хожмын өдрүүдэд



Мормоны Номыг урагш авчрах болно хэмээн бошигложээ.

2 Нифай 3:12 дахь “хэвлийн тань үрс [Египетийн Иосефын үр удам] бичиглэх болно” хэмээн хэлсэн нь Иосефын үр удмаар бичигдсэн цэдэг болох—Мормоны Ном—ыг тодорхойлж байна (2 Нифай 3:4-ийг үзнэ үү). Мормоны Номыг “Иудейн хэвлийн үрсээр” бичиглэгдсэн ариун нандин цэдэг болох Библитэй “хамтран нэгдэх” болно хэмээн бошигложээ. 2 Нифай 3:12-р шүлгээс Мормоны Ном, Библи хоёр хамтран нэгдэхдээ дэлхийд нөлөөлөх талаар дүрсэлсэн үг хэллэгүүдийг хайж ол.

Түүнчлэн Египетийн Иосеф бошиглохдоо Бошиглогч Иосеф Смит Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөнд “миний хүмүүсийг авралд авчрах” чухал үүрэг гүйцэтгэх болно хэмээжээ (2 Нифай 3:15-ыг үзнэ үү).



2. Тэнгэрлэг Эцэгийн авралын төлөвлөгөөн дэх Иосеф Смитийн үүрэгт талархах сэтгэлийг тань үргэлжлүүлэн нэмэгдүүлэхэд туслах дараах асуултуудад хариулж судрын тэмдэглэлдээ бич.

а. Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан сэргээгдсэн хүмүүст авралыг авчрахад тусалж чадах гэрээнүүд, эрх мэдэл эсвэл ёслолуудын ямар ямар жишээнүүд байна вэ?

б. Эдгээр адислалууд нь таны амьдралд ямар өөрчлөлтүүдийг авчирсан бэ?

2 Нифай 3:24-р шүлэгт Бошиглогч Иосеф Смитийг тодорхойлон бичсэн үгс, үг хэллэгүүдийг

олж, судрын тэмдэглэл дэх жагсаалтдаа нэмж бич. Ерөнхийлөгч Гордон Б.Хинклигийн хэлсэн дараах үгийг уншаад, Бошиглогч Иосеф Смитийг “Бурханы мутар дахь зэмсэг” байсан гэдгийг батлах нэмэлт сургаалуудыг жагсаалтдаа нэмж бич.

“Биднийг бусад бүх сүмээс ялгаатай болгодог, залуу бошиглогч [Иосеф Смит]-ийн илчлэлтээр ирсэн олон сургаал болон зарчмуудын заримыг би нэрлэе. . . .

“Хамгийн түрүүнд, мэдээж Бурханы Өөрийнх нь болон Түүний Хайрт Хүү амилсан Их Эзэн Есүс Христийн илэрхийлэл юм. . . .

“Хэдэн зууны турш дэлхийгээс нуугдаж байсан Бурханы талаарх энэхүү мэдлэг нь сонгогдсон үйлчлэгчдээ Түүний илчилсэн анхны бөгөөд агуу зүйл байсан юм. . . .

“Мормоны Ном Бурханы бэлэг болон хүчээр ирсэн юм. . . .

“[Бошиглогч Иосеф Смитийн үзүүлсэн бас нэгэн хувь нэмэр] бол санваарын сэргээлт билээ. . . .

“Бошиглогчид өгөгдсөн өөр нэгэн агуу хийгээд онцгой илчлэлт бол гэр бүлийн мөнхийн амьдралын төлөвлөгөө юм. . . .

“Бяцхан хүүхдийн гэм зэмгүй байдал нь Бурханы Бошиглогч Иосефээр дамжуулан өгсөн бас нэгэн илчлэлт билээ. . . .


“. . . Нас барагсдын төлөөх авралын агуу сургаал нь энэ Сүмийн хувьд онцгой зүйл юм. . . .

“Хүмүүний мөнхийн мөн чанар илчлэгдсэн. . . .

“. . . Би дахиад нэг зүйлийг энд дурдах ёстой. Энэ бол өнөө үеийн илчлэлтийн зарчим юм. . . .

“. . . Түүний амьдралын 38 жил хагасын богинохон хугацаанд зүйрлэшгүй их мэдлэг, бэлгүүд болон сургаал [Бошиглогч Иосеф Смит]-ээр дамжин ирсэн юм” (“The Great Things Which God Has Revealed,” *Ensign*, 2005 оны 5-р сар, 80–83).

Бошиглогч Иосеф Смитийг алуулсны дараа Ерөнхийлөгч Жон Тэйлор Сургаал ба Гэрээ 135-р бүлгийг бичжээ. Сургаал ба Гэрээ 135:3-ыг уншаад сайн мэдээний сэргээлтэд зориулсан Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөн дэх Иосеф Смитийн үүргийн талаар энэ хичээлээс юу сурснаа тунгаан бод.


 **3.** Судрын тэмдэглэлдээ дараах асуултуудын нэгэнд хариулж бич.

а. Өнөөдөр та 2 Нифай 3-р бүлгийг судлахдаа Бошиглогч Иосеф Смитийн талаарх гэрчлэлийг тань хүчирхэгжүүлэх юу сурч мэдэрсэн бэ?



б. Таны хувьд “агуу үнэт” (2 Нифай 3:7) болох юуг Иосеф Смит хийж, зааж, эсвэл сэргээсэн бэ?

Бошиглогч Иосеф Смитээр дамжин олон агуу үнэт зүйлс сэргээгдсэн гэдгийг ойлгоход нь туслахын тулд найзууд болон гэр бүлийнхэндээ бошиглогчийн талаарх гэрчлэлээ хуваалцах аргуудыг залбирч эрэлхийл.

 **4.** Дараах өгүүлбэрийг судрын тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би 2 Нифай 3-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

6-Р ХЭСЭГ: 1 ДЭХ ӨДӨР

2 Нифай 4–5


Оршил

Та 2 Нифай 4-р бүлгээс Лихай нас барахаасаа өмнө үр удамдаа эцсийн сургамж, адислалаа өгөхөөр тэднийг дуудаж цуглуулсан талаар сурах болно. Лихайг нас нөгчсөний дараа Нифай “Их Эзэний зэмлэл”-ийн талаар номлосонд Лемен, Лемүел хоёр уурлаж байлаа (2 Нифай 4:13–14-ийг үзнэ үү). Ах нарынхаа гаргаж буй хандлага, үйлдлүүдийн улмаас болон өөрийн сул дорой байдал, алдсуудынхаа улмаас Нифай ихэд зовж шаналан, мэдэрсэн мэдрэмжээ уран яруу шүлэг хэлбэрээр бичиж тэмдэглэжээ (2 Нифай 4:15–35-ыг үзнэ үү). 2 Нифай 5-д дурдсанаар Нифай болон түүнийг дэмждэг хүмүүст Лемен, Лемүел болон Ишмэилийн хөвгүүдээс зугтахыг Их Эзэн сэрэмжлүүлсэн. Ийнхүү салсны дараа нифайчууд зөв шударга, аз жаргалтай амьдарч байхад, Лемен, Лемүел хоёртой хамт үлдэгсэд Их Эзэнээс өөрсдийгөө сүнслэгээр тусгаарлав. Их Эзэнд үнэнч байх зан нь нүгэл, цөхрөлийг даван гарахад нь Нифайг хүчирхэгжүүлжээ. Нифай болон түүний хүмүүс “аз жаргалтай хүмүүний ёсоор амьдарч байлаа” хэмээн Нифай цэдэглэв (2 Нифай 5:27-г үзнэ үү).

2 Нифай 4:3–11

Лихай гэр бүлдээ сургамжилж мөн адислав

Эцэг, эх, удирдагчдаасаа заавар зөвлөгөө авч байсан үеийнхээ талаар бод. Зөвлөгөөг нь дагасан уу? Яагаад зөвлөгөөг нь дагасан эсвэл дагаагүй вэ? Танд ямар нэгэн харамсах зүйл байгаа юу? Гэр бүлдээ өгсөн Лихайн сүүлчийн сургамж, адислалыг Нифай 2 Нифай 4:1–11-т бичиж тэмдэглэжээ. 2 Нифай 4:4–5-ыг уншаад Лихайн хүүхдүүддээ өгсөн, танд тус болох сургамжийг тодорхойл. Эцэг эх, гэр бүлийн гишүүд, эсвэл удирдагчид тань үүнтэй төстэй сургамж зөвлөгөөг танд өгч байсан уу?

 1. Танд санаа тавьдаг хүмүүсийн зөвлөгөөг дагаснаар ирсэн зарим адислалуудаа судрын тэмдэглэлдээ жагсаан бич. Их Эзэний зарлигуудад дуулгавартай байснаар танд ямар ямар адислалууд ирсэн бэ?




2 Нифай 4:12–35

Нифай Их Эзэнд итгэх итгэлээ илэрхийлж, сул дорой байдлаа хүлээн зөвшөөрөв

2 Нифай 4:12–35-д Нифай “[өөрийн] дотоод сэтгэлийн зүйлсийг” бичив (2 Нифай 4:15-ыг үзнэ үү). 2 Нифай 4:15–16-г уншаад Нифай юунд баясаж байгааг олж мэд.

Танд баяр баяслыг авчирдаг, сайн сайхан зүйлсийн талаар бод. Дараах өгүүлбэрийг хэд хэдэн хувилбараар гүйцээж бич: Дотоод сэтгэл минь . . . -нд баясна _____

 2. Их Эзэний зүйлсэд баясна гэдэг нь таны бодлоор ямар утгатай болохыг судрын тэмдэглэлдээ бич.

“Зүрх минь судруудыг тунгаана” (2 Нифай 4:15) хэмээн Нифай бичжээ. Тунгаан бодох гэдэг нь судруудын талаар зөвхөн бясалгаж, гүн гүнзгий бодох гэсэн утгатай бус, харин илчлэлт болон ойлголт хүлээн авахад зүрх сэтгэлээ нээхийг хэлдэг.

Хэдийгээр Нифайн амьдралд хэцүү үеүд тохиолдож байсан ч агуу баяр баяслыг мөн амсаж байсан юм. 2 Нифай 4:12–13-ыг эргэн харж, Нифайн амьдралд тохиолдож байсан зарим нэг хэцүү сорилтуудын талаар судал.


Судрын үгс болон хэллэгийн талаар тунгаан бодох

Судрын үгс, хэллэгүүдийн утгын талаар тунгаан бодоход их ач холбогдол байдаг. Тунгаан бодох дадлага хийж, судрын хэллэгүүдийг ямар утгатай болохыг өөрийн үгээр илэрхийлэх нь тухайн үнэний илүү их ойлголтыг хүлээж авахад танд туслах болно.

2 Нифай 4:17–18-ыг уншаад өөр юу Нифайг гашуудахад хүргэж байсныг ол. Уншихдаа дараах тодорхойлолтуудыг санаарай: *Золгүй* гэдэг нь зовлонтой, өрөвдмөөр эсвэл хэрэггүй, тусгүй гэсэн утгатай. *Маханбод* гэдэг нь бидний мөнх бус байдлын сул дорой чанарыг илтгэнэ. *Хавчих* гэдэг нь бүх талаас нь хүрээлэх, шахах, зовоох эсвэл дарлах гэсэн утгатай. Хэдийгээр Нифай нүглүүдийнхээ төлөө гашуудаж байсан ч түүнийг ноцтой гэм нүгэл хийсэн гэж буруугаар ойлгож болохгүй.


Амьдралдаа Нифайн мэдэрч байсантай адил зүйлийг мэдэрч байсан үеэ бод (хайртай хэн нэгнээ алдах, Их Эзэнийг дагахад тань бусад хүмүүс дургүйцэх, бэрхшээл зовлон тохиолдож, урам хугарах эсвэл өөрийн гэм нүгэл, сул дорой байдал, уруу таталтуудаас болж гашуудах гэх мэт). 2 Нифай 4:19-ийг уншаад Нифай гашуудаж байсан ч түүнийг итгэл найдварыг харуулсан үг хэллэгийг ол. Нифай “Би хэнд итгэсэнээ мэдэж байна” гэж хэлсэн нь ямар утгатай гэж та бодож байна? Та хэрхэн Бурханд илүү их итгэж чадах вэ?

Үргэлжлүүлэн судлахдаа **Өөрт нь итгэсэн хүмүүсийг Бурхан дэмждэг** гэсэн сайн мэдээний зарчмын нотолгоог ол.

 **3.** Дараах хүснэгт дэх асуултуудад судрын тэмдэглэлдээ хариулж бич:

Судрын эшлэл	Эдгээр шүлгүүд Нифайд хэрхэн хамаарч байна вэ	Эдгээр шүлгүүд танд хэрхэн хамаарах вэ
2 Нифай 4:20–25	а. Өөрт нь итгэл найдвараа тавьсан Нифайг Их Эзэн урьд өмнө нь хэрхэн адисалж байсан бэ?	б. Их Эзэнд найдсан үед тань Тэрээр таныг хэрхэн адисалж байсан бэ?
2 Нифай 4:26–30	в. Адислалуудаа санах нь Нифайн зөв шударга байх хүсэлд хэрхэн нөлөөлсөн бэ?	г. Их Эзэний адислалууд таны зөв шударга байх хүсэлд хэрхэн нөлөөлсөн бэ?
2 Нифай 4:31–33	д. Нифай юуны төлөө залбирсан бэ?	е. Та залбирахдаа эдгээр шүлгүүдийг хэрхэн хэрэгжүүлж болох вэ?

2 Нифай 4:34–35-ыг уншаад, Их Эзэнд итгэх Нифайн итгэлийг харуулж байгаа хэсгийг олж тэмдэглэ.

 **4.** 2 Нифай 4:17–35-р шүлгүүдээс сурсан зүйлсээ болон Их Эзэнд итгэх итгэлээ нэмэгдүүлж болох аргуудыг судрын тэмдэглэлдээ бич.

2 Нифай 5:1–8

Их Эзэн нифайчуудыг леменчүүдээс салгав


2 Нифай 5-ыг судлахдаа танд тулгарч байсан эсвэл тулгарч байгаа хэцүү асуудал болон шийдвэрүүдийн талаар бод. Энэхүү бүлэгт ах нар нь “амийг минь авахаар эрэлхийлсэн болой” гэдгийг Нифай тайлбарласан (2 Нифай 5:2). Нифай асуудлаа шийдвэрлэхийн тулд юу хийснийг 2 Нифай 5:1-ээс олж мэд. Дараа нь 2 Нифай 5:5-аас Их Эзэн Нифайд туслахын тулд юу хийснийг судар дээрээ тэмдэглэ.



Сэрэмжлүүлгийн үр дүнд Нифай болон “Бурханы илчлэлт хийгээд сануулгад итгэсэн тэд . . . бүгд” (2 Нифай 5:6) анхны өвийн нутгаа орхин явлаа. Тэд “олон өдрийн турш” зорчиж (2 Нифай 5:7), Нифай хэмээн өөрсдийн нэрлэсэн нутагт суурьшив. Энэхүү туршлага нь **Бурханы илчлэлтүүдэд дуулгавартай байснаар аюулгүй байдлаар адислагддаг** гэдгийг харуулж байна.

Далын ахлагч Пол В.Жонсоны гэрчлэлийг унш: “Агуу хилэнц, уруу таталттай тулгарах үед Их Эзэн биднийг өөрсдөө замаа ол хэмээн орхидоггүй гэдэг нь гайхмаар зүйл биш юм. Үнэндээ, хэрэв бид сонсох юм бол хүн бүрд боломжтой арвин их удирдамж зөвлөгөө байдаг. Таныг удирдан чиглүүлж, сүнслэгээр нөлөөлөх Ариун сүнсний бэлгийг та хүлээж авсан. Танд судрууд, эцэг эх, сүмийн удирдагчид, багш нар байна. Түүнчлэн бидний үед амьдарч байгаа бошиглогч, үзмэрч, илчлэгчдийн үгс танд байна. Та хүлээж авсан удирдамжаа санаатайгаар үл тоомсорлохгүй л бол амьдралдаа ноцтой алдаа гаргахгүй


байхад тань туслах маш олон удирдамж, зөвлөгөө байдаг” (“Ерөнхий чуулганы адислалууд” *Ensign*, 2005 оны 5-р сар, 51).

 **5.** Их Эзэн, Түүний бошиглогчид эсвэл сүмийн удирдагчдаас хүлээж авсан сэрэмжлүүлгээ судрын тэмдэглэлдээ бич. Тэрхүү сэрэмжлүүлгийг анхааралдаа авахын тулд та юу хийж байгаа вэ? Сэрэмжлүүлгийг анхааралдаа авсан нь таны амьдралд хэрхэн тусалж байна вэ? Мөн ирээдүйд хэрхэн тус болох вэ?

2 Нифай 5:9–18, 26–27

Нифайчууд аз жаргалтай хүмүүний ёсоор амьдарч байлаа

Лихайн гэр бүлийг хуваагдахад хөтөлсөн тэрхүү нөхцөл байдлыг тайлбарласны дараа “Нифайн хүмүүсийн” дунд амьдрал ямар байсныг Нифай дүрслэв (2 Нифай 5:9). 2 Нифай 5:27-г уншаад, нифайчууд хэрхэн амьдарч байсныг харуулах үг хэллэгийг тэмдэглэ. Таны бодлоор “аз жаргалтай хүмүүний ёсоор” амьдрах гэдэг нь ямар утгатай вэ?

 **6.** 2 Нифай 5:10–18, 26-г анхааралтай уншаад, нифайчууд өөрсдийнхөө аз жаргалыг нэмэгдүүлэхийн тулд юу хийсэн эсвэл тэдэнд юу байсныг нь судартаа тэмдэглэ. Эдгээр зүйлүүдээс нэгийг нь сонгоод энэ үйлдэл эсвэл хандлага нь таны аз жаргалыг хэрхэн нэмэгдүүлснийг судрын тэмдэглэлдээ бич. Жишээ нь: Хэрэв та нифайчууд ариун сүм барьсан гэдгийг сонгосон бол (2 Нифай 5:16-г үзнэ үү) танд болон гэр бүлд тань ариун сүм хэрхэн илүү их аз жаргалыг авчирсан тухай бичиж болно.

Таны тодорхойлсон үйлдэл болон хандлагууд нь Есүс Христийн сайн мэдээний дагуу амьдрах нэг зам юм. Дараах зарчмыг судар дээрээ 2 Нифай 5:27-гийн хажууд бичих хэрэгтэй: **Есүс Христийн сайн мэдээ бидний амьдралын хэв маяг болох үед бид аз жаргалд өсч байдаг.** Энэ нь нифайчуудад маш хэцүү зүйлс тохиолдох үед ч үнэн болох нь харагддаг. Амьдралаа эргэцүүлэн бодоод, бүрэн аз жаргалтай амьдрахын тулд хийх зүйлээ тодорхойл. Тодорхойлсон зүйлээ судрын тэмдэглэлдээ эсвэл судар дээрээ бич. Өнөөдрийн суралцсан зарчмууд нь таныг аз жаргал руу хөтөлдөг.

 **7.** Дараах өгүүлбэрийг судрын тэмдэглэлийнхээ өнөөдрийн даалгаврын доор бич:

Би 2 Нифай 4–5-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

6-Р ХЭСЭГ: 2 ДАХЬ ӨДӨР

2 Нифай 6–8

Оршил

Нифайн дүү Иаковын заасан номлолын эхний хэсгийг 2 Нифай 6–8-д цэдэглэсэн. (2 Нифай 9–10-р бүлгүүдэд Иаковын номлолын хоёр дахь хэсэг багтсан байдаг) Лихай Иерусалимыг орхиж явснаас хойш Иудейчүүд өөрсдийн ёс бус байдлаас болж боолчлолд хүргэгдэж, тараагдсан тухай Иаков бошиглов. Гэсэн хэдий ч Их Эзэн Иудейчүүдийг нигүүлсэнгүйгээр Иерусалимд буцааж цуглуулах болно. Түүнчлэн мөнх бус үйлчлэлийнх нь үед Иудейчүүд Аврагчийг үл тоомсорлох бөгөөд тэд хоёр дахь удаагаа тараагдана. Аврагч дахин нигүүлсэнгүй хандаж, эцсийн өдрүүдэд буюу Аврагчийнхаа мэдлэгт ирэх цагт нь тэднийг цуглуулах болно хэмээн Иаков бошиглов. Мөн Өөрийн гэрээт хүмүүст итгэмжийг үзүүлэх Аврагчийн итгэлт байдал, Түүний нигүүлсэл, итгэлтнүүдэд амласан Түүний агуу амлалтуудыг харуулах Исаиагийн бошиглолыг Иаков эш татав.

2 Нифай 6

Иаков Израилын тараагдалт болон цугларалтын талаар бошиглосон нь

Таны хайртай хүмүүс тантай муухай харьцвал та яах вэ? Та нарын хоорондын харьцаа тэдний хувьд тийм ч чухал биш болсон гэдгийг тэд үйлдэл юмуу зан байдлаараа харуулбал яах вэ? Та хэзээ нэгэн цагт Их Эзэнд ингэж хандаж байсан эсэхээ тунгаан бод. 2 Нифай 6–8-д үйлдэл, зан байдлаараа Их Эзэнээс нүүрээ буруулсан хүмүүст Тэрээр хэрхэн ханддаг болохыг Иаков заажээ.

2 Нифай 6:3–5; 9:1, 3-ыг уншаад Иаков яагаад ийм номлол заасныг олж мэд.

Өнөөдөр суралцахдаа Иаковын заасан зүйлс

Зохиогчийн гол санааг ол

Сударт ярьж буй хүн эсвэл бичсэн хүн нь яагаад түүний хийсэн зүйлийг заасныг илтгэх үг хэллэг болон шүлгүүдэд анхаарлаа сайн хандуулах нь ач холбогдолтой. Жишээ нь: “Би та нарт хандан . . . та нар *Бурханыхаа нэрийг мэдэж мөн алдаршуулж болохын учир ярих ажгуу*” (2 Нифай 6:4; налуу болгов), “та нар бүх *Израилын угсаатай хийсэн Их Эзэний гэрээнүүдийн талаар мэдэж болох буюу*” (2 Нифай 9:1; налуу болгов) гэх мэт хэллэгүүд нь Иаковын санааг ойлгоход бидэнд тусалж байна. Иймэрхүү хэллэгүүд нь судар дахь гол санаа, зарчмуудыг илүү сайн ойлгоход болон анхаарлаа хандуулахад тань туслах болно.

хэрхэн “Бурханыхаа нэрийг мэдэж мөн алдаршуулахад” (2 Нифай 6:4), Их Эзэнтэй хийсэн гэрээнүүдээ илүү сайн ойлгоход (2 Нифай 9:1-ийг үзнэ үү) тань тусалж, танд “тэргүүнээ ямагт дээр өргөж, баясах” (2 Нифай 9:3) шалтгаан өгөхийг олж мэд.



1. Дараах асуултуудад судрын тэмдэглэлдээ хариулж бич:

а. Лихай Иерусалимыг орхин гарсны дараа Иудейчүүд Их Эзэнийг үл тоомсорлосноос болж тэдэнд юу тохиосон тухай бошиглолоор Иаков номлолоо эхлэв. Тэрээр үүнийг 2 Нифай 6:8-д хэрхэн дүрсэлсэн бэ?

б. Лихай, Иеремиа болон бусад бошиглогчид энэхүү устгалын талаар бошиглосон. МЭӨ 587 онд Вавилончууд Иудейчүүдийг эзлэх үед олон хүн алагдаж, бусад нь Вавилонд боолчлолд хүргэгджээ. Иудейчүүд яваандаа Их Эзэнд хандах зүрх сэтгэлээ зөөлрүүлсэн. 2 Нифай 6:9-р шүлгийн эхний өгүүлбэрт хэлснээр Иаков ямар зүйл тэдэнд тохиолдоно гэж бошиглосон бэ?

в. Иудейчүүд боолчлолоос эргэж ирсний дараа Аврагч тэдний дунд мөнх бусаар амьдрах болно хэмээн Иаков бошиглов. 2 Нифай 6:9–10-д хэлснээр Иудейчүүд Их Эзэнд хэрхэн хандах вэ?

г. 2 Нифай 6:10–11-д хэлсний дагуу Их Эзэнийг эсэргүүцсэн Иудейчүүдэд юу тохиолдох вэ?

2 Нифай 6:11, 14-ийг уншаад хэдийгээр Израилын угсаа Их Эзэнийг эсэргүүцсэн ч Тэрээр тэдэнд хэрхэн хандсаныг дүрсэлсэн хэллэгүүдийг ол. Судартаа “тэдэнд нигүүлсэнгүй хандах болно”, “буцааж авах” хэмээх хэллэгүүдийг дугуйлах хэрэгтэй.



2. Дараах асуултуудад судрын тэмдэглэл дээрээ хариулж бич.

а. Хэн нэгэн эсвэл ямар нэг зүйлийг “буцааж авах” гэдэг нь ямар утгатай вэ?

б. Израилыг хоёр дахь удаагаа буцааж авах Их Эзэний хүсэл нь Түүний нигүүлслийг хэрхэн харуулж байна вэ?

Иудейчүүд Их Эзэний адислалуудыг авахын тулд юу хийх ёстойг эдгээр шүлгүүдэд Иаков заасан. 2 Нифай 6:11, 14-ийг дахин уншаад, шүлэг бүрд гарах “ирэх цагт”, “тэр өдрийг ирэхэд” хэмээх үг хэллэгүүдийг ол. Тэрхүү хэллэгийн утгыг гүйцээх үгсийг тодруул. Эдгээр шүлгийн дагуу Израил Их Эзэний нигүүлсэлд хэрхэн тохирох вэ? Эдгээр шүлгүүд дараах зарчмыг заадаг: **Өөрт нь эргэж ирсэн хүмүүст Их Эзэн нигүүлсэнгүй ханддаг.**



3. Өөрт нь эргэж ирсэн тэднийг уучлах Их Эзэний хүсэл, нигүүлслийн гэрч болсон үеэ бод. Судрын тэмдэглэл дээрээ: *Их Эзэн нигүүлсэнгүй гэдгийг би мэднэ, учир нь . . . гээд өөрийн бодол мэдрэмжээрээ өгүүлбэрийг гүйцээж бич.* Их Эзэний үзүүлдэг нигүүлслийг өөр өөр арга замуудаар харсан бол энэхүү дасгалыг давтан хийх хэрэгтэй.

2 Нифай 6-д бид бүгдийг хамруулан Израилд зориулсан найдварын агуу амлалт гардаг. 2 Нифай 6:17–18-ыг уншаад, Аврагчийн амласан дараах амлалтыг гүйцээж бич.

“Хүчит Бурхан _____” (2 Нифай 6:17).

“... гэдгийг бүх маханбод мэдэх болно _____” (2 Нифай 6:18).

2 Нифай 7–8

Гэрээт хүмүүстээ үнэнч байх Аврагчийн итгэмжит байдал болон биднийг гэтэлгэх чадварынх нь талаарх Исаиагийн бошиглолоос Иаков эш татав

2 Нифай 7–8-д бичиглэгдсэнээр, өөрсдийн гэм нүглээс болж зовж зүдэрч буй Израилыг гэтэлгэх Их Эзэний хүсэл, хүч чадлын талаар бошиглосон Исаиагийн бошиглолоос Иаков эш татжээ. 2 Нифай 7:1–2-ыг уншаад, Их Эзэн тэдэнд хайртай хэвээр бөгөөд тэднийг гэтэлгэхийг хүсч байгааг нь илтгэх Израилаас асуусан асуултуудыг ол.

Их Эзэн тэр үеийн хүмүүст гэр бүл салалт, боолчлол болон нийгмийн ёс заншлыг үр дүнтэй, мартагдахааргүйгээр заахын тулд тэдгээртэй холбоотой бэлэгдлийг ашигласан гэдгийг ойлгох нь тустай байж болох юм. “Чамайг холдуулж,” “чиний эхийн гэрлэлт цуцлагдсан баримт,” “чамайг худалдсан” зэрэг үг хэллэгүүд нь гэрээгээ эвдэх эсвэл зөрчих гэсэн санааг илэрхийлнэ. Асуултуудын хэллэг өөрөөр хэлбэл дараах хэлбэртэй болно: “Би чамаас нүүр буруулсан уу? Та нартай хийсэн гэрээгээ би хойш тавьсан уу?” Эдгээр асуултуудын хариулт нь “Үгүй” юм. Их Эзэн хийсэн гэрээгээ хэзээ ч мартаггүй мөн хэзээ ч биднээс холдохгүй. Түүний асуултууд нь Тэрээр Израилтай хийсэн гэрээгээ хэзээ ч зөрчихгүй гэдгийг илэрхийлэх нэг хэлбэр юм.

2 Нифай 7:1-ийн төгсгөл дэх Израил яагаад Бурханаас тусгаарлагдаж, боолчлолд зовж байсан тухай Их Эзэний тайлбарласан хэсгийн доогуур зур.



4. Дараах асуултуудын аль нэгэнд судрын тэмдэглэл дээрээ хариулж бич:

а. Бодол, шийдвэр, үйлдлүүд маань биднийг Бурханаас тусгаарладаг гэдгийг ойлгох нь яагаад чухал вэ?

б. Бид Их Эзэнийг мартаж, орхиж болох ч Тэрээр биднийг хэзээ ч мартдаггүй эсвэл орхин явдаггүй гэдгийг мэдэх нь таны хувьд яагаад чухал вэ?


2 Нифай 7:2-т Их Эзэн Израилаас маш чухал асуулт асуудаг бөгөөд энэ нь бидэнд ч бас хамаатай. Асуултыг олоод, тодруулж тэмдэглэ.

Их Эзэн “аварч чадахааргүй болж гар минь өчүүхэн ч гэсэн богинодсон гэж үү? хэмээн асуухдаа ямар санааг илэрхийлсэн гэж та бодож байна вэ? Дүрслэн ойлгохын тулд та тусламж хэрэгтэй байгаа хэн нэгэнд туслахаар гараа сунгаж байна гэж төсөөлөн бод. Хэрвээ та гараа сунгах ёстой байсан бол тэр хүнд туслахаар юу хийхийг хичээх байсан бэ? Харин эсрэгээрээ та гараа татаж, буцааж авсан бол тэр хүнд туслахыг хүссэн таны хүслийг юу гэх байсан бэ? Ийн төсөөлөн бодох үедээ, Их Эзэний Израилаас асуусан асуултыг өөр маягаар авч үзвэл: “Би та нарыг гэтэлгэхгүй, гараа татаж, хойш сууж байна уу?” хэмээн асууж байгаатай адил юм.


“Надад чөлөөлөх хүч үгүй гэж үү?” гэсэн өгүүлбэр нь нүглээсээ болж амсаж буй зовлонгоос нь гаргах хүч Их Эзэнд байгаа гэдэгт итгэх итгэлийн тухай бодохыг Израилд уриалж байна.

2 Нифай 7:8-аас бусад шүлгүүдэд Өөрийн гэрээт хүмүүсийг гэтэлгэх Аврагчийн хүсэл болон хүчийг харуулсан хэд хэдэн жишээг Исаиа харуулсан.

2 Нифай 7:5–7-г уншаад, энэхүү бошиглолоос Цагаатгалын золиослолын нэгэн хэсэг буюу биднийг аврахын тулд Мессиа юу хийх, юу үзэхийг харуулсан хэллэгийг хайж ол. 2 Нифай 7:6-р шүлгийн, зүүлт тайлбар *a*, энэхүү бошиглолын биелэлтийг харуулж, тайлбарласан холбогдох эшлэлүүд байна. Та зүүлт тайлбар дахь Матай 27:26-г тэмдэглээд Матай 27:26–31-ийг уншиж, Исаиагийн бошиглол биелсэн арга замуудыг олох хэрэгтэй.

 **5.** Дараах асуултуудад судрын тэмдэглэлдээ хариулж бич: 2 Нифай 7:2, 5–7-р шүлгүүд нь биднийг гэтэлгэх Аврагчийн хүсэл зорилгын талаар юу харуулж байна вэ?

Исаиагийн бошиглол дахь Их Эзэний нигүүлсэл болон хүчний талаар илүү багтай нотолгоог мэдэхэд тань туслах үүднээс дараах сэдвээр сүмийн цуглаанд үг хэлэхээр болсон гэж төсөөл: **Аврагч гэрээт хүмүүсээ гэтэлгэхийг хүсдэг бөгөөд үүнийг үйлдэх бүхий л хүч Түүнд бий.** Хэлэх үгээ бэлдэхдээ 2 Нифай 8:3, 11–13, 16, 22-р шүлгүүдийг уншиж, хуваалцахад тохиромжтой биднийг гэтэлгэх Их Эзэний хүсэл болон хүчийг нотолсон хэллэгүүдийг сонго.

 **6.** Судрын тэмдэглэлдээ хэлэх үгийнхээ тоймыг гаргахдаа:

a. Таалагдсан хоёр юмуу гурван хэллэгийг сонгоод хэллэг бүр нь хэрхэн биднийг гэтэлгэх Их Эзэний хүсэл эсвэл үүнийг үйлдэх Түүний хүчний жишээ болж байгааг тайлбарла.

б. Тэдгээр хэллэгүүдээс нэгийг нь сонгоод амьдралдаа тэрхүү адислалыг авч байсан туршлагаа эсвэл тийм туршлагатай болохыг хүсч байгаа тухайгаа тайлбарлаж бич.

Энэхүү хичээлийн төгсгөлд өнөөдөр таны судалсан үнэнүүдийг “та нар Бурханыхаа нэрийг мэдэж мөн алдаршуулж болохын учир” (2 Нифай 6:4), “Их Эзэний гэрээнүүдийн талаар та нар мэдэж болохын тулд” (2 Нифай 9:1), “тэргүүнээ ямагт дээр өргөж мөн та нар баясаж болохын тулд” (2 Нифай 9:3) Иаков заасан гэдгийг санаарай. Өнөөдөр Их Эзэнд талархах сэтгэлээ болон таныг хайрлах Түүний хайрын талаар хэн нэгэнтэй хуваалцах боломжийг хайгаарай.

 **7.** Дараах өгүүлбэрийг судрын тэмдэглэлийнхээ өнөөдрийн даалгаврын доор бич:

Би 2 Нифай 6–8-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

6-Р ХЭСЭГ: 3 ДАХЬ ӨДӨР

2 Нифай 9

Оршил

2 Нифай 6–8-р бүлгүүдэд үзэж эхэлсэн Иаковын номлол 2 Нифай 9-р бүлэгт үргэлжилнэ. 2 Нифай 6–8-д та Аврагчийн нигүүлсэл, Израилыг алдагдсан, тараагдсан байдлаас нь аврах Түүний хүчний тухай Иаковын заасан зүйлсийг судалсан. 9-р бүлгээс та биеийн болон сүнсний үхэл, нүглүүдийн үр дагаврыг агуулах уналтын үр дүнгээс биднийг чөлөөлөх Аврагчийн Цагаатгалын хүчний талаарх Иаковын гэрчлэлийг судлах болно. Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит дараах зүйлийг хэлсэн байдаг. 2 Нифай 9-р бүлэг нь “Цагаатгалын талаар заасан хамгийн гэгээлэг номлол юм. . . Авралыг эрэлхийлж байгаа хүн бүр үүнийг анхааралтайгаар унших хэрэгтэй” (*Answers to Gospel Questions*, comp. Joseph Fielding Smith Jr., 5 vols. [1957–66], 4:57).

2 Нифай 9:1–9

Уналт нь бүх хүн төрөлхтний дээр биеийн болон сүнсний үхэл авчирсан гэдгийг Иаков заажээ.

Мангас гэдэг үгийг бодоход таны санаанд юу орж байна вэ?

Мангас гэдэг үг нь ихэвчлэн аймшигтай, агуу их хор хөнөөл учруулах чадвартай зүйлийг хэлдэг. Хэдийгээр олон хүн мангасын талаар бодохдоо зөвхөн санаандаа төсөөлсөн, бодит бус зүйл гэж боддог ч



танд асар их хохирол учруулах чадвартай, үнэхээр аймшигтай ямар нэгэн зүйл байдаг эсэхийг эргэцүүлэн бод. Иаков бид бүгдийн мөнх бус амьдралдаа нүүр тулах айдас хүрэм нөхцөл байдлыг мангасаар төлөөлүүлэн дүрсэлжээ. 2 Нифай 9:10-ыг уншаад, Иаковын дүрсэлсэн мангасыг дүрслэн илэрхийлсэн хоёр зүйлийг тодорхойл. Дараа нь энэ хүснэгтийн хоосон зайд бөглөж бич.


Аймшигт мангас	
Ү _____	Т _____
“б...-ийн _____ Ү _____”	“с...-ний _____ Ү _____”

Иаков “сүнсний үхлийн” талаар заахдаа бидний сүнс шууд утгаараа үхэх биш, харин бид Бурханы оршихуйгаас сүнслэгээр тусгаарлагдах буюу таслагдана гэсэн үг хэмээснийг ойлгох нь чухал юм


(2 Нифай 9:6-г үзнэ үү). Энэхүү тусгаарлалтыг судруудад ихэвчлэн сүнсний үхэл гэж бичсэн байдаг. Бурханы оршихуйгаас таслагдах гэдэг үгийг судар дээрээ 2 Нифай 9:10-р шүлэг дэх “сүнсний үхэл” гэдэг хэллэгийн хажууд бичиж болно.

2 Нифай 9:6-г уншаад, Иаков яриагаа биеийн үхлийн тухай ярьж эхлэн, Бурханы оршихуйгаас тусгаарлагдах талаар ярьж төгсгөснийг анзаараарай. Энэхүү эшлэлийг анхааралтай судал. Ямар үйл явдлаас болж биеийн болон сүнсний үхэл хүн төрөлхтөнд тохиох болсон бэ? _____

2 Нифай 9:7–9-ийг уншаад, хэрвээ Цагаатгал хийгдээгүй, биеийн болон сүнсний үхэл бидний дээр үүрд үлдэх байсан бол бидний бие болон сүнсэнд юу тохиох байсан тухай Иаковын заасан зүйлийг тодорхойл. Та уншихаасаа өмнө 7-р шүлэгт Иаковын ашигласан үг хэллэгийн доорх тайлбарласан утгыг мэдэх нь тустай байх болно: “Хүмүүний дээр ирсэн эхний шүүлт” (2 Нифай 9:7) гэдэг нь Адам, Евагийн уналтын үр дагаврыг хэлж байна. Ялзрал хэмээх хэллэг нь мөнх бус биед хамаарна, учир нь бие нь төгс бус бөгөөд яваандаа үхдэг. *Муудашигүй* гэдэг нь амилсан буюу мөнхөд амьдрах биед хамаатай.

 **1.** Цагаатгал хийгдээгүй байсан бол бидний бие болон сүнсэнд юу тохиолдох байсныг дүрсэлсэн 2 Нифай 9:7–9-р шүлгүүдээс тодорхойлсон үг хэллэгүүдээ судрын тэмдэглэл дээрээ жагсаан бич.

Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Д.Тодд Кристоффэрсоны Есүс Христийн Цагаатгалгүйгээр бидний хувь тавилан ямар байх байсныг ойлгомжтойгоор заасан дараах тайлбарыг унш: “Хэрвээ бидний Бурханаас тусгаарлагдсан байдал болон биеийн үхэл үүрдийнх байсан бол ёс суртахууны сонгох эрх гэдэг нь юу ч биш байх байсан. Тийм ээ, бид сонголт хийх эрх чөлөөтэй байх байсан, гэхдээ үүнд ямар утга учир байх билээ? Бидний үйлдэл ямар байхаас үл хамааран эцсийн үр дүн нь ижил байх байсан. Үхсэний дараа амилалтын найдваргүй, тэнгэрт найдах найдвар үгүй байх байсан. Сайн ч сонголт хийсэн, муу ч сонголт хийсэн эцсийн үр дүнд бид бүгдээрээ “чөтгөрийн элч” болох байсан” (“Moral Agency,” *Ensign*, 2009 оны 6-р сар, 50).

 **2.** Бидний уналтын байдлын тухай Ахлагч Кристоффэрсоны хэлсэн үгийн талаар юу бодож байгаагаа судрын тэмдэглэлдээ өөрийн үгээр тайлбарлаж бич. Иаков яагаад биеийн үхэл болон Бурханаас тусгаарлагдахыг “аймшигт мангас”-тай зүйрлэсэн талаар товчхон тайлбар бич.

2 Нифай 9:10–27

Аврагчийн зовлон шаналал биднийг хэрхэн уналтын үр нөлөө болон нүглийн үр дагавраас чөлөөлдөг болохыг Иаков заав

Бурхан биднийг “тэрхүү аймшигт мангас, үхэл болон там”-ын бүрэн нөлөөнд зовж шаналаг хэмээн орхиогүй. 2 Нифай 9:10-ыг уншаад Бурхан бидэнд юу бэлдсэнийг тэмдэглэж ав.

Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смитийн хэлсэн Аврагч бидэнд хэрэгтэй гэдгийг харуулах дараах зүйрлэлийг унш.

Нэгэн залуу замаар алхаж яваад өөрөө авиран гараад дахин эрх чөлөөтэй алхах боломжгүй, маш гүн, харанхуй нүхэнд унажээ. Тэр яаж өөрийгөө энэ бэрхшээлээс гаргаж чадах вэ? Тэр өөрийнхөө хичээл зүтгэлээр гарч чадахгүй. Учир нь нүхнээс гарах ямар ч гарц байхгүй. Тэрээр тусламж эрэн дуудах бөгөөд нэгэн сайхан сэтгэлт хүн түүний тусламж хүсэн хашгирахыг сонсоод шат тавьж өгөхөөр ирнэ. Нүхнээс гарч ирэхийн тулд өөрөө шатаар авиран гарах замыг сайхан сэтгэлт хүн түүнд өгнө.

“Энэ нь Адам хориглогдсон жимснээс хүртэх үед өөртөө болон үр удмынхаа дээр авчирсантай яг адил нөхцөл байдал юм. Бүх хүмүүс хамтдаа нэг нүхэнд байгаа бөгөөд хэн нь ч нүхнээс гарч бусдадаа тусалж чадахгүй. Нүх нь Их Эзэний оршихуйгаас тусгаарлах цөллөг, зуурдын үхэл, биеийн устгал юм. Бүх хүмүүс үхлийн харьяат болж, хэн ч гарах арга замаар хангаж чадахгүй.

“Тиймийн тул, хэмжээлшгүй нигүүлслийнхээ улмаас Эцэг хүүхдүүдийнхээ уйлахыг сонсон, үхэл болон нүглийн алиных нь ч харьяат биш Төрсөн Ганц Хүүгээ тэднийг гаргах арга замаар хангуулахаар илгээсэн. Тэрээр үүнийг хязгааргүй Цагаатгал, үүрдийн сайн мэдээгээрээ дамжуулан хийсэн



билээ” (*Doctrines of Salvation*, ed. Брүс Р.Макконки, 3 vols. [1954–1956], 1:126–127).

9-р бүлэг дэх Иаковын захиасын ихэнх хэсэг нь Их Эзэний бэлдэж өгсөн, биднийг биеийн болон сүнсний үхлийн хүлээснээс гаргах арга замд төвлөрдөг бөгөөд бид үүнээс гарч чадна гэдгийг баталдаг.



3. 2 Нифай 9:5, 19–21-ийг судлаад, дараах асуултуудад судрын тэмдэглэл дээрээ хариулж бич:

а. 2 Нифай 9:5, 21-д зааснаар биднийг үхэл болон тамаас гаргаж болохын тулд Аврагч ямар замыг туулсан бэ?

б. 2 Нифай 9:21-д зааснаар, Аврагч хэний төлөө зовж шаналсан бэ?

“Адамын гэр бүлд” хэдэн хүн багтдаг тухай бодож үз (2 Нифай 9:21). Үүнд дэлхий дээр амьдарч байсан, одоо амьдарч байгаа, цаашид амьдрах бүх хүн болон та ч мөн багтана. Таны төлөө хийсэн Аврагчийн золиослолыг санаж байхын тулд 2 Нифай 9:21-ийн хажуу талд өөрийнхөө нэрийг бичих хэрэгтэй.

Сударт нэрээ оруулах нь

Судрын эшлэлд нэрээ оруулж унших нь заасан зүйлсийг хувь хүнд илүү ойлгомжтой болгодог. Танд зориулж бичсэн мэт санагдах судрын эшлэлийг уншсаны дараа өөрийн нэрийг орлуулж унших нь тухайн захиасыг өөрийн амьдралтай адилгаж ойлгоход тань тусална.

Биднийг аймшигт мангас буюу биеийн үхэл, Бурханы оршихуйгаас үүрд тусгаарлагдахаас Аврагчийн зовлон шаналал авардаг хэмээн Иаков заав. 2 Нифай 9:22-ыг уншаад, бид биеийн үхлийг даван гарах боломжтой бөгөөд Бурханы оршихуйд эргэн очих болно гэдгийг харуулсан хэллэгүүдийг ол. Дараах өгүүлбэрүүдийг өөрийн тодорхойлсноор гүйцээж бич:

Уналтын улмаас бидний бие махбод үхэвч, Христийн шаналлын улмаас бие махбод маань _____

Уналтаас болж бид Бурханы оршихуйгаас тусгаарлагдсан. Харин Христийн шаналлын улмаас бид бүгдээрээ дахин . . . зогсох болно _____

Иаковын заасан зүйлсээс бид дараах сургаалыг сурдаг: **Есүс Христийн Цагаатгал нь уналтын улмаас ирсэн биеийн болон сүнсний үхлээс бүх хүн төрөлхтнийг чөлөөлдөг.**

Энэхүү найдварын захиас дээр нэмэлт болгон Аврагчийн шаналал нь өөрсдийн маань нүглийн улмаас ирдэг сүнсний үхлээс биднийг чөлөөлж чадна хэмээн Иаков заажээ. 2 Нифай 9:27-г уншаад,

зөрчил эсвэл нүгэл үйлдсэн хүмүүсийн байдлыг Иаков хэрхэн дүрсэлснийг тодорхойл. 2 Нифай 9:15–16-г уншаад, нүглээ наманчлахгүй бол нүглийн улмаас бидэн дээр ирдэг сүнслэг шаналал ба зовлонг судартаа тэмдэглэ.

Энэхүү зовлонд нэмэлт болгон 2 Нифай 9:16-д гардаг “тэд . . . очих болно” хэмээх хэллэгийг тэмдэглэ. Цагаатгалын улмаас бүх хүн төрөлхтөн Бурханы оршихуйд шүүгдэхээр эргэн очих болно. Гэсэн хэдий ч бид нүглээ наманчлаагүй бол Бурханы оршихуйгаас дахин тусгаарлагдах болно. Уналтаас чөлөөлөгдөх нь бүх хүн төрөлхтөнд зориулсан бэлэг бол, өөрсдийн гэм нүглийн үр дагавраас чөлөөлөгдөх нь бидний хүсэл болон үйлдлээс шалтгаална. 2 Нифай 9:21, 23–24-ийг унш. Цагаатгалаар дамжуулан нүглүүдийнхээ мөнхийн үр дагавраас аврагдахын тулд бид юу хийж болох вэ?

Иаковын үгсийг уншсаны дараа дараах зарчмыг гүйцээ: Хэрвээ бид . . . **Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан нүглүүдийнхээ үр дагаврыг даван гарч чадна**

Аврагчийн Цагаатгалын цэвэршүүлэгч хүчийг илүү бүрэн дүүрэн мэдрэхийн тулд та юу хийж болох тухайгаа эргэцүүлэн бод. Их Эзэнд наманчлах зүйл танд байна уу? Тэдгээр зүйлээ хэрхэн наманчлах тухай тунгаан бод. Та Түүний дуу хоолойг хэрхэн илүү сайн сонсож чадах вэ?



4. Таны төлөө хийсэн Аврагчийн Цагаатгалын золиослолын талаар юу мэдэрч байгаагаа илэрхийлж, судрын тэмдэглэлдээ богино тэмдэглэл бич.



5. Дараах өгүүлбэрийг судрын тэмдэглэлийнхээ өнөөдрийн даалгаврын доор бич:

Би 2 Нифай 9-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

6-Р ХЭСЭГ: 4 ДЭХ ӨДӨР

2 Нифай 9–10

Оршил

Өмнөх хичээлд та Есүс Христ өөрийн Цагаатгалаар дамжуулан бидний төлөө хийх зүйлсийн талаарх Иаковын гэрчлэлийг судалсан. Энэ хичээлээр 2 Нифай 9-р бүлэг болон Иаковын номлолын



эхний өдрийг судалж дуусах бөгөөд Цагаатгалын адислалыг хүлээж авахын тулд бид юу хийх ёстойг суралцана. Иаков Бурханаас тусгаарлагдсан байдал руу хөтлөх шийдвэр гаргахын эсрэг сэрэмжлүүлсэн ба бүх хүмүүнийг Христэд ирж, аврагдахыг урив. Та түүнчлэн 2 Нифай 10-ыг уншиж Иаков дараагийн өдөр нь хүмүүст юу хэлснийг судлах болно. Хэдийгээр Израил гэм нүглээсээ болж тараагдах боловч Их Эзэн тэдэнтэй хийсэн гэрээгээ эргэн санаж, тэд наманчилж, Өөрт нь эргэн ирэх үед нь Тэрээр тэднийг цуглуулна хэмээн Иаков дахин заажээ. “Өөрсдийн Бурханыг цовдлох өөр ямар ч үндэстэн энэ дэлхий дээр үгүй” хэмээн Иаков хэлэв (2 Нифай 10:3). Тэрээр Америк нь эрх чөлөөний нутаг байж, бусад бүх үндэстнүүдийн эсрэг бэхлэгдэн, тэнд хаан гэж үгүй байх болно хэмээн урьдчилан хэлжээ. Хүмүүс Бурханы таалалд өөрсдийгөө эвлэрүүлж, зөвхөн Бурханы ач ивээлийн дагуу аврагдана гэдгээ санах ёстой хэмээн Иаков гэрчлэв.

2 Нифай 9:28–54

Иаков биднийг Бурханаас тусгаарладаг үйлдэл болон хандлагуудын талаар сэрэмжлүүлж, бүх хүмүүнийг Христэд ирэхийг урив

Уналтын улмаас мөн өөрсдийн гэм нүглийн улмаас хүн бүрд Аврагч хэрэгтэй. Цагаатгалаар дамжуулан бид уналтын үр дагавраас чөлөөлөгддөг бөгөөд нүглийг даван гарч, мөнх амьдралыг хүлээн авах болно хэмээн Иаков гэрчлэв. Иаков үүнийг тайлбарлахын тулд хаалга болон замын зураг ашиглав. 2 Нифай 9:41-ийг уншаад, мөнх амьдралд хүрэхийн тулд бидний алхах ёстой замыг Иаков хэрхэн дүрсэлснийг ол. Дараах асуултуудыг тунгаан бод: Таны бодлоор “Их Эзэнд ирэх” гэдэг нь ямар утгатай вэ? (Таныг Аврагчид илүү ойртуулах зам дээр байгаа эсэхээ эргэцүүлэн бод.) “[Аврагчид хүрэх] харгуй нарийн, гэвч энэ нь шулуунаар зурайна” гэдэг нь таны бодлоор ямар утгатай вэ?

Иаков Аврагчийг “их хаалганы сахиул” хэмээн дүрслэв. Энэ нь биднийг шүүх Аврагчийн дүрийн бэлгэдэл юм. Энэ бол бидний хандлага болон үйлдлээс шалтгаалан Цагаатгалынхаа адислалуудыг нэмэгдүүлдэг Тэр хүн юм. Түүнчлэн Иаков Аврагчид ирэх чадварт маань бидний хандлага болон үйлдэл хэрхэн нөлөөлдөг болохыг илүү дэлгэрэнгүй заасан.



1. Биднийг Аврагч руу чиглүүлэх хандлага, бодол санаа болон үйлдлүүдээ тодорхойлоход маань тус болох зорилготой дараах зүйлсийг судрын тэмдэглэлдээ хий.

а. Судрын тэмдэглэлийнхээ нэг хуудсыг голоор нь хувааж шугам тат, тэгээд нэг талд нь *Биднийг Христээс холдуулах*, нөгөө талд нь *Христэд ирэх* гэж бич.

б. 2 Нифай 9:27–39-ийг уншаад, Иаковын сэрэмжлүүлсэн, биднийг Аврагчаас холдуулж болох ямар нэгэн үйлдэл юмуу хандлагыг тодорхойл. Судрын тэмдэглэл дэх “Биднийг Христээс холдуулах” гэсэн багананд юу тохирохыг олж, жагсаалт гарга. Олсон зүйлсээ судартаа тэмдэглэх хэрэгтэй. (2 Нифай 9:28–29 нь төгс эзэмших судар гэдгийг анхаар. Дараа нь олоход хялбар болгож бусдаас ялгагдахаар тэмдэглэх хэрэгтэй.)

в. Өөрийн тодорхойлсон үйлдэл, хандлагуудаасаа нэгийг нь сонгоод судрын тэмдэглэлийнхээ өөр нэг хуудсан дээр дараах асуултад хариулж бич: Энэхүү үйлдэл нь биднийг хэрхэн Христэд ирэхээс болон Түүний Цагаатгалын бүрэн адислалуудыг хүлээж авахаас холдуулдаг вэ?

г. Биднийг Их Эзэнээс холдуулдаг үйлдэл болон хандлагуудын тухай сэрэмжлүүлэхээс гадна Есүс Христэд ирэхэд тусалдаг үйлдэл болон хандлагуудын тухай Иаков заасан.

2 Нифай 9:23, 42, 45–46, 49–52-ыг уншаад, Иаковын зааснаар биднийг Их Эзэнд авчрах зүйлсийг ол. Хүснэгтийнхээ “Христэд ирэх” гэсэн багананд олсон зүйлсээ жагсаан бич.

2 Нифай 9:28–54-ийг судлахдаа та дараах зарчмыг сурсан: **Их Эзэнд ирж, Түүний хүслийн дагуу амьдрахыг сонгосноороо бид Цагаатгалын бүрэн адислалуудыг хүлээн авч чадна.**



2. Сурсан зүйлсээ хэрэгжүүлэхийн тулд судрын тэмдэглэлдээ дараах даалгавруудаас хоёр юмуу түүнээс дээш асуултад хариулж бич.

а. 2 Нифай 9:23-р шүлэгт Их Эзэн бидэнд наманчлаад баптисм хүртэхийг зарлиг болгосон талаар та уншсан. Харин та аль хэдийн баптисм хүртсэн байж болно. Тэгвэл ариун ёслолоор дамжуулан баптисмынхаа гэрээг шинэчлэх нь Их Эзэнд ирж, Түүний Цагаатгалын адислалуудыг хүртэхэд тань хэрхэн тусалж байна вэ?

б. “Израилын Ариун Нэгэнд төгс итгэлтэй” байх гэдэг нь таны бодлоор ямар утгатай вэ (2 Нифай 9:23)? Та Их Эзэнд итгэх итгэлээ сүүлийн үед ямар арга замаар үзүүлж байгаа вэ?

в. “Нүглүүдээсээ салах” гэдэг нь ямар утгатай вэ (2 Нифай 9:45)? Танд нүглүүдээсээ салахад тань юу тус болох вэ?


г. “Үнэт биш зүйлд” мөнгөө, “хэрэгцээ хангахгүй зүйлд” хөдөлмөрөө үрэх ямар жишээ байна вэ (2 Нифай 9:51)? Хилэнцэт болон ач холбогдолгүй зүйлсээс зайлсхийх нь Их Эзэнд



ирэхэд тань хэрхэн туслах вэ? Та сургууль, сурлага, сүм, амралт болон нийгмийн үйл ажиллагаанд оролцох цагаа хэрхэн илүү сайн зохицуулж чадах вэ?

д. “Мөхөх нь үгүй түүний дээр найрлах” ямар аргууд танд байгаа вэ (2 Нифай 9:51)?

е. Иаков хүмүүст “талархал мэдүүл”, “зүрх сэтгэлээ баясга” хэмээн ухуулав (2 Нифай 9:52). Аврагчид ирэхийг хичээх зуураа энэхүү зөвлөгөөг дагах нь яагаад чухал гэж та бодож байна вэ?

 **3.** Таны суралцсан үйлдэл болон хандлагуудын зарим нь таныг Аврагчид хэрхэн ойртуулсан тухай судрын тэмдэглэлдээ бичнэ үү.


Төгс эзэмших судар—2 Нифай 9:28–29

Одоогийн боловсролын боломжуудаа бүрэн дүүрэн ашиглахын тулд та юу хийж байгаа вэ? Ирээдүйн боловсролын тань төлөвлөгөө юу вэ? _____

Ерөнхийлөгч Гордон Б.Хинклигийн хэлсэн дараах үгсийг уншаад суралцахаас ирдэг адислалуудын доогуур зур: “Та ирээдүйд агуу сорилт бэрхшээлүүдийг амсах болно. Шируун тулааны дэлхий рүү та орж байна. Та чадах чинээгээрээ боловсрол эзэмших ёстой. Их Эзэн бидэнд боловсролын чухлын талаар

заасан. Энэ нь илүү агуу боломжуудад таныг бэлтгэх болно. Энэ нь ирээдүйн агуу боломжийн ертөнцөд ямар нэгэн үр ашигтай зүйл хийхэд таныг бэлтгэнэ. Хэрвээ та коллежид сурах боломжтой бөгөөд сурахыг хүсч байгаа бол суралц. Хэрвээ та коллежид сурах хүсэлгүй бол мэргэжлийн сургалт, бизнесийн сургуульд явж авьяас чадвараа хөгжүүлж, чадамжаа дээшлүүлээрэй” (“Converts and Young Men,” *Ensign*, 1997 оны 5-р сар, 49–50).


2 Нифай 9:28-ыг уншаад, буруу хандлагатайгаар суралцахын үр дагаврын талаар Иаковын хэлснийг тэмдэглэ.

 **4.** Судрын тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

а. “Тэд аливааг сураад өөрсдийгөө ухаантай хэмээн санадаг” гэсэн өгүүлбэр таны бодлоор юу гэсэн үг вэ?

б. Бид эцэг эх болон бишоп эсвэл салбарын ерөнхийлөгчөөсөө, бошиглогч эсвэл Тэнгэрлэг Эцэгээсээ илүү ухаантай гэж бодох нь ямар аюултай вэ?


2 Нифай 9:29-ийг уншаад, боловсрол эзэмшихдээ юуг анхаарах хэрэгтэйгээ тодорхойл.

 **5.** Судрын тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич: Судраас хичээнгүйлэн суралцах нь 2 Нифай 9:29 дэх зарчмын дагуу амьдрахад тань хэрхэн тусалж байна вэ?

2 Нифай 10

Иаков хүмүүсийг Их Эзэнд ирж, баясахыг уриалав

Хоёр дахь өдрөө зааж байхдаа Иаков нүглийн үр дагавраас чөлөөлөх Их Эзэний хүчийг дахин гэрчлэв. Иаков түүнчлэн өөрийн хүмүүст Цагаатгалын нигүүлсэнгүй бэлэгт хэрхэн хандах хэрэгтэйг заажээ. 2 Нифай 10:20, 23–25-ыг уншаад, бидний төлөөх Аврагчийн золиослолд хариу болгон юу хийх хэрэгтэй гэж Иаков заасныг харуулах хэллэгийг олж тэмдэглэ.

 **6.** Дараах асуултуудын аль нэг эсвэл тэрнээс олонд судрын тэмдэглэлдээ хариулж бич:

а. Аврагчийн тухай сурсан зүйлсийг тань авч үзвэл та яагаад үргэлж “түүнийг санахыг” хүсдэг вэ (2 Нифай 10:20)?

б. Хийж буй буруу зүйлээ наманчлах эсвэл хийхээ болих нь яагаад Аврагчийн төлөөх хайр болон талархлыг тань харуулна гэж та боддог вэ?

в. Урам хугарах үед тэргүүнээ гудайлгахаас илүү найдварыг мэдрүүлдэг Аврагчийн тухай та юу сурсан бэ?

Энэ бүлгийн нэгэн чухал хэллэг бол “Бурханы таалалд өөрсдийгөө эвлэрүүлэх” юм (2 Нифай 10:24). Энэ нь бид дуулгавартай байж, Их Эзэний хүсэлд нийцсэнээр Түүнтэй дотно харилцааг дахин тогтоох хэрэгтэй

гэсэн үг. 2 Нифай 9–10-р бүлгүүдэд тэмдэглэсэн судруудаа эргэж хар. Бурханы таалалд өөрсдийгөө эвлэрүүлэхийн тулд хийж чадах зүйлээ тодорхойлохдоо Ариун Сүнсний удирдамжийг эрэлхийл.

 **7.** Дараах өгүүлбэрийг судрын тэмдэглэлийнхээ өнөөдрийн даалгаврын доор бич:

Би 2 Нифай 9–10-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

7-Р ХЭСЭГ: 1 ДЭХ ӨДӨР

2 Нифай 11–16

Оршил

Нифайн амьдарч байсан үеэс ойролцоогоор 100 жилийн өмнө бошиглогч Исаиа амьдарч байсан. (Исаиа МЭӨ 740 оноос өмнө бошиглож эхэлсэн бөгөөд МЭӨ 701 он хүртэл буюу 40 гаруй жил бошигложээ; Судруудын удирдамж, “Исаиа”-г үзнэ үү.) Өнөөдөр бид Бошиглогч Иосеф Смитийг хайрладаг шиг Нифай олон зүйл дээр Исаиаг хайрлаж, хүндэлж байсан байх. Нифайн бичсэн зүйлсээс тэр Исаиагийн үгсэд “баяссан” гэдгийг бид мэдэж болно (2 Нифай 11:2). 2 Нифай 12–16-д бичиглэсэнээр гуулин ялтсуудаас олдсон Исаиагийн


бичвэрийг Нифай эш татжээ. Энэхүү бичвэр нь эртний Израилын бардамнал, ёс бус явдал болон тэднийг хүлээж байсан шүүлтгийг дүрсэлдэг. Түүнчлэн Исаиа өөрийг нь нүглээс цэвэршүүлсэн Их Эзэнийг харсан үзэгдлийнхээ тухай хүүрнэв.

2 Нифай 11:1–8

Нифай Есүс Христийн талаарх Исаиагийн гэрчлэлд баясав

Аврагчийн талаарх хэн нэгний гэрчлэл танд гүн сэтгэгдэл үлдээж байсан үеийг сана. 2 Нифай 11:2–3-ыг уншаад, Нифай, Иаков, Исаиа тус бүрд Есүс Христтэй холбоотой юу тохиолдсоныг тодорхойл.

Их Эзэн Өөрийнхөө тухай гэрчлүүлэхээр бошиглогчдыг дууддаг. Есүс Христийн гэрчүүдийн гэрчлэлээс суралцсанаар бид Есүс Христэд итгэх итгэлээ хүчирхэгжүүлж, Түүнд баясаж чадна.

 **1.** Олон бошиглогчдоос Есүс Христийн тухай гэрчлэлийг хүлээж авах нь яагаад чухал гэж бодож байгаага судрын тэмдэглэлдээ бич.


Исаиаг судлах нь

Хэдийгээр Мормоны Ном дахь Исаиагийн бүлгүүд нь ойлгоход хэцүү боловч Арванхоёр төлөөлөгчийн чуулгын Ерөнхийлөгч Боид К.Пакэр дараах урмын зөвлөгөөг өгсөн юм: “Уншихаа бүү зогсоо! Маш бага зүйл ойлгож байсан ч Хуучин Гэрээний үеийн бошиглолын ойлгоход хэцүү бүлгүүдийг үргэлжлүүлэн уншаарай. Гүйлгэн уншихдаа энд тэндээс нь бага сага зүйл ойлгож байсан ч үргэлжлүүлэн унш” (“The Things of My Soul,” *Ensign*, 1986 оны 5-р сар, 61).



2 Нифай 11:4–6-р шүлгүүдэд “бодгаль минь баяс-нам” гэж Нифай дөрвөн удаа хэлснийг ол. Эдгээр үгсийг судартаа тэмдэглэх хэрэгтэй.

Ямар нэг зүйлд “баясах” гэдэг нь хэн нэгэн тухайн зүйлд сэтгэл хангалуун байж, тэрхүү зүйл нь түүнд агуу баяслыг авчрахыг хэлнэ.

 **2.** Судрын тэмдэглэлдээ гурав юмуу түүнээс дээш “бодгаль минь баяснам” гэсэн өгүүлбэрийг таныг баясгадаг сайн мэдээний үндсэн хэсгүүдийг оруулан гүйцээж бич. Эдгээр нь яагаад таныг баясгадаг болохыг тус тус тайлбарла.

2 Нифай 11:8-ыг уншаад, та Исаиагийн үгсээс судалсны үр дүн нь юу байгаасай гэж Нифай хүссэнийг бич. _____


2 Нифай 12:1–5

Эцсийн өдрүүдэд ариун сүм баригдах болно хэмээн Исаиа бошиглов

Асар том уул байна хэмээн төсөөл. Уул, ариун сүм хоёрыг харьцуулах ямар нэгэн зүйрлэл таны санаанд орж байна уу?

2 Нифай 12:2–3, 5-ыг уншаад, Бурхан эцсийн өдрүүдэд юу барина гэж амласныг ол. “Их Эзэний өргөөний уул” гэдэг нь Их Эзэний ариун сүм гэсэн үг. Эдгээр шүлэгт бичигдсэний дагуу эцсийн өдрүүдэд Их Эзэний өргөөнөөс ямар адислалууд ирэх вэ?

Та судартаа иймэрхүү зүйлсийг бичих хэрэгтэй: Бурхан бидэнд Өөрийн арга замыг заахын тулд, Түүний замаар алхахад бидэнд туслахын тулд ариун сүмүүдийг бариулдаг (2 Нифай 12:3-ыг үзнэ үү).

 **3.** Судрын тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

а. Их Эзэний замуудаар алхахад ариун сүмүүд бидэнд хэрхэн тусалдаг вэ?

б. Ариун сүмд орохын тулд та өөрийгөө хэрхэн бэлдэж болох вэ?

2 Нифай 12–15

Энэхүү хичээл нь 2 Нифай 12–15-ыг ойлгоход туслах дэлгэрэнгүй мэдээллээр хангахгүй. Гэсэн хэдий ч, Мормоны Номын хувийн сургалтаараа та эдгээр бүлгүүдийг уншаад, тунгаан бодохдоо бардамнал болон гэм нүглийн үр дагаврыг олоорой. Дараах тайлбар эсвэл зааварчилгаа таны уншлагад тус болно.

2 Нифай 12:6–18. Хиймэл шүтээн шүтэх ба *ихэмсэг төрх, ихэрхэг байдал, бардам, хөөргөн зан, өндөр гэх*


мэт бардамналыг илэрхийлсэн үгс болон дүрслэлийн тухай бүх эшлэлүүдийг онцлон анхаарч унш. Энэ нь яагаад эдгээр хүмүүсийг тийм хатуу шүүлт хүлээж байсныг ойлгоход тань туслах болно.


2 Нифай 12:9–11. “Ерийн хүн” (9-р шүлэг) гэдэг нь энгийн эсвэл жирийн хүнийг илэрхийлнэ. Хэрэв “ерийн хүн”, “их хүн” Хоёр хоёулаа бардам бол Есү Христийн хоёр дахь ирэлтээр даруусгагдах болно (11-р шүлгийг үзнэ үү).

2 Нифай 12:12–13. “Их Эзэний өдөр” хэмээх хэллэг нь шүүлтийн цагийг илэрхийлж байна. Христийн Хоёр дахь ирэлтээр ёс бусчууд устгагдах ба энэ нь “Их Эзэний өдөр” байх болно.

2 Нифай 13–14. 2 Нифай 13-р бүлэг нь хэрэв Израилчууд ёс бус хэвээр үлдвэл юу тохиолдохыг хэлсэн Исаиагийн үгсийн үргэлжлэл юм. Исаиа Израил эмэгтэйчүүдэд гэрээний хүүхдүүд гэдгийг нь сануулж, тэднийг “Сионы охид” хэмээн дуудав. Исаиа тэднийг Их Эзэнээр хараагдсан, зүүлт болон биеийн бусад гоёл чимэглэл нь авагдсан бардам эмэгтэйчүүдтэй зүйрлэжээ (2 Нифай 13:16–26-г үзнэ үү). Эсрэгээрээ 2 Нифай 14-т хэрвээ Сионы охид өөрсдийгөө даруусган, наманчилж, Их Эзэнд хандвал юу тохиолдохыг тайлбарласан Исаиагийн тайлбар багтдаг. Сүмээс хэвлэсэн Библийг ашиглах боломжтой бол Исаиа 3-р бүлгийн зүүлт тайлбарыг ашиглавал 2 Нифай 13:16–26-г ойлгоход тань тусална.

2 Нифай 15:8–22. *Халаг* хэмээх үг нь гүн гүнзгий харамсал гунигийг илэрхийлнэ. Израилчуудын гэм нүглийг тодорхойлохдоо Исаиа энэ үгийг эдгээр шүлгүүдэд зургаан удаа ашиглажээ. Израилчууд наманчлагүй бол тэдний гэм нүглийн үр дагавар нь ялангуяа шүүлтийн өдөр гүн гүнзгий харамсал гунигийг авчрах болно гэдгийг Исаиа мэдэж байсан. Хэрвээ Исаиа өнөөдөр дэлхий дээрх бошиглогч байсан бол Израилчуудын дунд харсан шиг гэм нүглүүдийг олж харах байсан болов уу?



 **4.** 2 Нифай 15:20-ийг унш. Өнөөдөр сайн зүйлийг хилэнцэт, хилэнцэт зүйлийг сайн хэмээн хүмүүсийн нэрлэдэг зарим зүйлсийг судрын тэмдэглэлдээ бич.

2 Нифай 16:1–8

Исаиа бошиглогчоор үйлчлэхээр дуудагдав

Исаиагийн бичсэн зүйлс бэлгэдлээр баян байдаг. Бэлгэдлүүд нь бидэнд сайн мэдээний зарчмуудын тухай заах Их Эзэний нэг арга юм. 2 Нифай 16-д Исаиа Их Эзэнийг харсан туршлагаа дүрслэн бичжээ. 2 Нифай 16-г уншихдаа, дараах бэлгэдлүүд болон тэдний тайлбар байж болох зүйлсийг санаж уншаарай.

Серафимууд: Бурханы оршихуйд байдаг тэнгэр элчүүд. “Бурханы тэнгэр элч хэзээ ч далавчтай байдаггүй” хэмээн Бошиглогч Иосеф Смит заажээ (*History of the Church*, 3:392). Эдгээр тэнгэр элчүүдийн далавчууд нь тэдний хөдлөх болон үйлдэх хүчийг бэлгэднэ.

Утаа: Их Эзэний оршихуйг төлөөлж болох юм (Илчлэлт 15:8-ыг үзнэ үү).

Цэвэр бус уруул: Зохисгүй байдал.

Ноцож буй цог (гал): Ариун Сүнсний цэвэршүүлэх хүчний адил ариусгах хэрэгсэл.

Тахилын ширээ: Үгчилбэл, тахилын ширээ нь золиослол хийдэг газар байсан. Энэ сударт бидний төлөө хийсэн Есүс Христийн золиослол буюу Цагаатгалыг илэрхийлж байж болох юм.



5. 2 Нифай 16:1–7-г уншаад, судрын тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

а. Серафимуудын нэг нь Түмний Их Эзэний талаар юу хэлсэн бэ?

б. “Надад халаг! Би устгагдсаны улмаас болой; учир нь би цэвэр бус уруултай хүн” гэж Исаиа хэлсэн нь ямар утгатай гэж та бодож байна вэ? Тэр яагаад гэнэт ингэж бодох болов? (3 Нифай 27:19-д хариулт нь байж болох юм.)

в. Исаиагийн зохисгүй хэмээх мэдрэмжийг юу өөрчилсөн бэ?

г. Энэхүү туршлага нь хүмүүсийн дунд явж, наманчлалыг тунхаглахад нь Исаиаг хэрхэн бэлдэх вэ?

Исаиагийн заасан агуу үнэнүүдийн нэг бол **Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан бид зохисгүй байдлаасаа цэвэршиж чадна гэсэн зарчим**

юм. Амьдралдаа Цагаатгалын хүчээр цэвэршиж байсан мэдрэмжийнхээ талаар тунгаан бод.



6. Дараах өгүүлбэрийг судрын тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би 2 Нифай 11–16-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

7-Р ХЭСЭГ: 2 ДАХЬ ӨДӨР

2 Нифай 17-20

Оршил

2 Нифай 17–20-д Исаиа Иудейн хаан болон түүний хүмүүсийг дэлхийн хуйвалдаануудаас илүү Их Эзэнд итгэ хэмээн ухуулахыг оролдсоныг Нифай бичиглэв. Исаиа агуу үнэнүүдийг зааж мөн гэрчлэх тэмдэг, дүрслэл эсвэл бэлгэдэл ашиглан өөрийнх нь өдрүүдэд тохиолдох үйл явдлууд, Есүс Христийн төрөлт, Их Эзэний Хоёр дахь ирэлтийн үеийн ёсон бусчуудын устгалын талаар бошигложээ.

2 Нифай 17–18

Иудейн хаант улс Есүс Христэд итгэл найдвараа тавьснаар адислагджээ

Өнөөдрийн хичээлд бэлдэхийн тулд аймшигтай нөхцөл байдалтай тулгарч байсан үеэ бод. Анхны үйлдэл тань юу байсныг санаж байна уу? 2 Нифай 17–18-ыг судлахдаа хэцүү эсвэл аймшигтай нөхцөл байдалд орсон хүмүүст өгсөн Исаиагийн зөвлөгөө олж тодорхойлохыг хичээ.

2 Нифай 17–18-ыг судлахын тулд та Сири, Израил, Иудей гэсэн гурван жижиг үндэстэн болон эдгээр жижиг үндэстнүүдийг эзлэхийг хүссэн, хэмжээгээрээ тэднээс хамаагүй том Ассирийн эзэнт гүрний тухай мэдэх хэрэгтэй. Дараах газрын зураг болон хавсралт хүснэгтийг үз.




Үндэстэн	Сири	Израил (Ефраим)	Иуда
Хаан	Резин	Пека	Ахаз
Нийслэл	Дамаск	Самари	Иерусалим

2 Нифай 17:1–2-ыг уншаад газрын зураг дээр ол. “Сири нь Ефраимтай хуйвалдах болой” гэдэг нь уг хоёр улс хэлэлцээр, гэрээ хийсэн гэсэн утгатай. Хэн нь хэн рүүгээ дайрах гэж байгааг тодорхойлох гээд үз. 2-р шүлэгт гардаг “Давидын угсаа” хэмээх


хэллэг нь Ахаз болон Иудейн хүмүүсийг хэлж байгаа гэдгийг ойлгоорой.

Израил болон Сирийн хаант улсууд Иудейн хаант улсыг эзлэн авч, дараа нь Иудейг тэдэнтэй нэгдэж хүчирхэг Ассирийн эзэнт гүрний эсрэг тулалдах хэлэлцээрт нэгдэхийг шаардах хүсэлтэй байв. Тэр үед Ассири дэлхийн бүх нутгийг бүхлээр нь эзлэхээр айлгаж байсан улс юм. Израил, Сири хоёр улс Иудейг эзлэн авбал Ассирийн эсрэг тулалдах илүү олон хүн, илүү их нөөцтэй болно гэж бодож байв (2 Нифай 17:5–6-г үзнэ үү). Хаан Ахаз нь Израил болон Сири хоёртой хэлэлцээр хийх талаар бодож үзэв.

Хэрвээ та Хаан Ахаз байсан бол юу хийх байсан талаараа бод. Нэг талаас, Ассири улс танай хүмүүсийг дайрахаар айлгаж байгаа. Нөгөө талаас, хэрвээ та Ассирийн эсрэг тулалдах хэлэлцээрт нэгдэхгүй бол Сири, Израил хоёр танай улс руу дайрахаар сүрдүүлж байгаа. Исаиа Иудейн хаант улсад амьдардаг бөгөөд Их Эзэн түүнийг Ахаз руу мэдээ хүргүүлэхээр илгээв. Хэрвээ та Ахазын оронд байсан бол бошиглогчоос мэдээ хүлээж аваад ямар мэдрэмжтэй байх байсан бэ?

 **1.** 2 Нифай 17:3–8-ыг уншаад, Исаиагаар дамжуулан Ахаз болон түүний хүмүүст өгсөн Их Эзэний захиасын доогуур зур. (4-р шүлэг дэх “галт цуцлууд” гэж гал нь унтарсан бамбарыг хэлдэг бөгөөд үүгээр эзлэгдэж, сүйрч буй хоёр улсыг төлөөлүүлж байна.) Үүнийг Исаиа Ахазад хэлж байгааг та сонссон хэмээн төсөөл. Хожим нь найз тань Исаиа юу гэж хэлснийг асуух болно. Найздаа юу гэж хариулахаа судрын тэмдэглэлдээ хоёр эсвэл гурван өгүүлбэрт багтаан бич.

Исаиа хаанд болон түүний хүмүүст улс төрийн тогтворгүй хэлэлцээрээс илүү Их Эзэний тусламжид тулгуурлахад нь туслахыг хичээв.

 **2.** Судрын тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

а. Бидэнд тусламж хэрэгтэй үед зөвхөн бусад хүмүүсийн тусламжид тулгуурласнаас илүү Их Эзэнд хандах нь яагаад чухал байдаг вэ?

б. Залуу хүмүүс Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христэй харилцах харилцааны түрүүнд бусад хүмүүстэй харилцах харилцаагаа тавьж соригддог ямар тохиолдлууд байдаг вэ?

Их Эзэн Ахаз болон Иудейн хаант улсыг Өөрөө хамгаална гэсэн тэмдэг үзүүлэх бөгөөд дэлхийн хэлэлцээрүүдэд тулгуурлах хэрэггүй хэмээн тэдэнд хэлэв. Уг тэмдэг нь юу гэдгийг мэдэхийн тулд 2 Нифай 17:14-ийг унш. Тус шүлэгт гарсан *Иммануел* гэдэг үгийг дугуйл. Энэ шүлгийн хажууд “Матай 1:22–23” гэж бич. Иммануел гэдэг үгийн утгыг мэдэхийн тулд Матай 1:22–23-ыг унш.

Энэ үед “Бурхан бидэнтэй хамт” хэмээх утга илэрхийлэх тэмдэг Ахазд хэрхэн туслах вэ? Исаиагийн бошиглол хэдэн зууны дараа болох Есүс Христийн төрөлттэй ямар холбоотой байж болох вэ?



Төрөх хүүхдийн тэмдгийн талаар илүү ихийг ойлгохын тулд Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Жэффри Р.Холландын дараах тайлбарын талаар эргэцүүлэн бод: “Исаиагийн ихэнх бичиглэлтэй адил энэ бошиглолд олон

тооны эсвэл зэрэгцсэн зүйлс байгаа”. Хамгийн ойрын утга нь магадгүй Есүс Христийн төрөлтийн үед анзаарагдах бошиглолын илүү агуу, хожмын биелэлтийн бэлгэ тэмдэг болсон хүү төрүүлсэн цэвэр ариун, сайн эмэгтэй болох Исаиагийн эхнэр [2 Нифай 18:3] дээр төвлөрөх байсан байх (*Christ and the New Covenant* [1997], 79).

Хүүхэд өсөж том болохоос өмнө Израил (Ефраим) болон Сирийн нийт арми Ассирид эзлэгдэнэ хэмээн Исаиа бошигложээ (2 Нифай 17:15–25-ыг үзнэ үү). “Бурхан бидэнтэй хамт” гэсэн утга бүхий тэмдэг нь **хэрвээ бид Бурханд итгэлтэй байвал Тэрээр хүнд хэцүү, аймшигтай үеүдэд хүртэл бидэнтэй хамт байх болно гэдгийг Ахаз хаанд ойлгуулан, тайвшруулах зорилготой байв.** Энэхүү зарчмыг судартаа бичээрэй.


2 Нифай 18:6–8-ыг уншаад, “Шилогийн ус” гэсэн үгийн доогуур зур. Исаиагийн бодлоор Шилогийн ус нь уг үндэстний улс төрийн амьдралын нэг хэсэг байх хэрэгтэй байсан Бурханы номхон дөлгөөн, тогтвортой, баттай нөлөө болон хүчийг төлөөлж байв. (2 Нифай 18:6-г үзнэ үү). Исаиа Шилогийн усыг харьцуулалт болгон ашигласны учир нь Израил болон Иудейн хүмүүс Мессиаг, “Шилогийн ус” буюу Бурханы номхон дөлгөөн, тогтвортой, баттай хүчийг үл тоомсорлосон буюу. Тиймийн тул, Исаиа бошиглохдоо Ассирийн хаан болон Сири, Израилыг эзэлсэн түүний армийн сүрдмээр нөлөө, агуу их хүчийг “голын хүчит их усаар” төлөөлүүлжээ.

Яруу найрагч хүний хувьд Исаиа хоёр төрлийн, гэхдээ эрс тэс ялгаатай урсгал усыг Иудейд тохиолдох зүйлийг тайлбарлахад ашиглажээ. Иудейн дээр ирэх Ассирийн армийг *нутаг гэдэг үгээр төлөөлүүлжээ*. Гэхдээ Иерусалимыг эзлээгүй гэдгийг “тэрээр үерлэж мөн халих болно, энэ нь бүр хүзүүгээр татах болно” гэсэн өгүүлбэрээр төлөөлүүлсэн.

2 Нифай 18:9–12-ыг уншаад, Их Эзэн Сири болон Израилд нэгдэхгүй байхыг хэдэн удаа Иудейд зөвлөснийг ажигла. 2 Нифай 18:13-д бичиглэгдсэнээр, Их Эзэн Исаиагаар дамжуулан Иудейд хаашаа явж тусламж хүс гэж зөвлөсөн бэ?



Ассиричууд Иудейг сүйрүүлж, Иерусалимыг сүрдүүлэх үед Иудейн хаант улс шинэ хаантай болсон байжээ. Түүнийг Хезекиа гэдэг байв. Тэр Их Эзэн болон Исаиад итгэж байсан. Их Эзэний тэнгэр элч 185,000 Ассири цэргийг хуаранд нь устгажээ (Хаадын дэд 19:35; Исаиа 37:36-г үзнэ үү).

 **3.** Дараах асуултуудын аль нэгэнд судрын тэмдэглэлдээ хариулж бич:

а. Их Эзэнээс илүү дэлхийн зүйлс болон нөлөөнд итгэх нь ямар аюултай вэ? (Таныг айдасдаа тулгуурлан шийдвэр гаргахад хүргэж болох нөхцөл байдлын талаар бодож үзээрэй.)

б. Эхлээд бусдаас хүч гуйхыг эрмэлзэж байснаа болиод Их Эзэнд хандсан тохиолдол танд байгаа юу? Хэзээ тийм явдал болсон бэ? Та тэрхүү туршлагаасаа юу сурсан бэ?

в. Хаан Хезекиагийн хаанчлал дор Иудейн хүмүүс устгалаас хамгаалагдсан. Учир нь тэд Их Эзэнээс ирсэн Исаиагийн зөвлөгөөг дагасан юм. Орчин үеийн бошиглогчдыг дагах нь таныг сүнслэг хор хөнөөлөөс хэрхэн хамгаалж чадах вэ?

2 Нифай 19:1–7

Исаиа Мессиагийнхаар ярив

Та, нарыг харахгүй эсвэл нарны илчийг мэдрэхгүй удаан хугацаагаар явж байсан уу? Хэрвээ үгүй бол та нарны гэрэл, дулааныг мэдрэхгүй, сүүдэр дор байнга байна гэж төсөөлөөд үз (харанхуй өрөөнд удаан хугацаагаар байгаа мэт). Есүс Христийн гэрэлгүй амьдардаг хүмүүсийн сүнслэг нөхцөл байдлыг тайлбарлахын тулд Исаиа үүнтэй төстэй дүр төрхийг ашигласан.


2 Нифай 19:1–2-т хоёр нутгийн талаар гардаг. Эдгээр шүлгийг уншиж, уг хоёр нутгийн нэрийг тэмдэглэ.

Хэдэн зууныг дамнан Исаиа эдгээр шүлгүүдийг бичих хүртэл одоо Ариун газар хэмээн нэрлэгддэг газрыг эзлэхийг хүссэн олон дайн болжээ. Маш олон хүн энэ газар байлдаж яваад амиа алдсан болохоор зарим нь энэ газрыг “үхлийн сүүдэр татсан нутаг” хэмээн нэрлэдэг аж. Зебулун болон Нафтальн нутаг хэмээн нэрлэгддэг энэ газарт шинэ гэрээний үед Назар, Капернаум, Найн болон Кана хэмээх хотууд байрлаж байжээ. 500 гаруй жилийн дараа Есүс Христ эдгээр хотуудад хүмүүст үйлчилж, ихэнх цагаа өнгөрүүлжээ. Өнөөдөр энэ газрыг Галил гэж нэрлэдэг.

Исаиагийн хэлснээр энэ нутгийн хүмүүс эцэст нь харах зүйлийг 2 Нифай 19:2-т тэмдэглэ.

“Үхлийн сүүдэр татсан нутаг” оршдог “харанхуйд алхдаг байсан” хүмүүс “агуу гэрлийг харсан” аж хэмээх Исаиагийн үгс нь дэлхийн энэ хэсэг дэх Есүс Христийн мөнх бус үүргийн тухай бошиглол байсан юм. Галилд амьдардаг байсан хүмүүс сүнслэг

харанхуйд алхдаг байсан боловч Есүс Христ ирж, тэдний дунд тохинуулснаар тэд “агуу гэрлийг” харсан юм.


 **4.** 2 Нифай 19:6–7-г уншаад, 6-р шүлэгт гардаг Аврагчийн нэрсийн аль нь ялангуяа Иудейн хүмүүсийн хувьд утга учиртай болохыг, тэдэнд өгөгдсөн нөхцөл байдалд тулгуурлан эргэцүүлэн бод. Эдгээр нэрсээс нэг юмуу хэд хэдэн нэрс Аврагчийн талаарх таны бодлыг хэрхэн дүрсэлж байгааг судрын тэмдэглэлдээ бич.

2 Нифай 19–20

Исаиа Хоёр дахь ирэлтийн үед болох ёс бусчуудын устгалыг дүрслэв


2 Нифай 20-д бичигдсэн Ассирийн устгалын тухай Исаиагийн бошиглол бол Хоёр дахь ирэлтийн үеийн ёс бусчуудын устгалын тухай бошиглол юм. Энэхүү бүлгийг уншихдаа Хезекиа Их Эзэнээс ирсэн Исаиагийн зөвлөгөөнд итгэж адислагдсан шиг хэрэв та Их Эзэнд найдвал Хоёр дахь ирэлт ойртож буй энэ үед дэлхийн оршин суугчдын дээр ирэх шүүлтээс айх хэрэггүй гэдгийг санаарай.

2 Нифай 19:12, 17, 21 болон 2 Нифай 20:4-р шүлгүүдэд ямар өгүүлбэр давтагдаж байна вэ? Үүнийг судартаа тэмдэглэх хэрэгтэй. Өгүүлбэрийг судрын тэмдэглэлдээ бичээд, *хилэн, гар гэсэн үгсийн доогуур зур. Хилэн* гэдэг үгийн доогуур зураад *шүүлт* гэж бич, *гар* гэдэг үгийн доогуур зураад *нигүүлсэл* гэж бич. *Шүүлт* болон *нигүүлсэл* хэмээх үгсийг орлуулан *тавиад өгүүлбэрийг чангаар унш*. (“Энэ бүгд болсон ч түүний [шүүлт] зайлуулагдаагүй, гэсэн ч түүний [нигүүлсэл] үргэлжилсэн хэвээр болой.)

 **5.** Судрын тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

а. Дээрх дасгалаар бичсэн өгүүлбэр нь Их Эзэнийг үл тоомсорлосон хувь хүн, гэр бүлүүд, үндэстнүүдэд Тэрээр хэрхэн ханддагийг яаж дүрсэлж байна вэ?

б. Та дараах үгнүүдийг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлж чадах вэ? **Есүс Христ бол шүүлт болон нигүүлслийн Бурхан юм. Түүний нигүүлсэл нь наманчилж, зарлигуудыг дагасан хүмүүст сунгаастай байдаг.**

 **6.** Тодорхой зарлигт дуулгавартай байснаар Бурханы нигүүлслийг мэдэрч байсан үеийнхээ тухай судрын тэмдэглэлдээ бич.

 **7.** Дараах өгүүлбэрийг судрын тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврын доор бич:

Би 2 Нифай 17–20-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

2 Нифай 21–24

Оршил

Мормоны Ном дахь Исаиагийн бошиглолуудын ихэнх нь эцсийн өдрүүдийн тухай байдаг. Тэр сайн мэдээний сэргээлт, Бошиглогч Иосеф Смит, Хоёр дахь ирэлт болон ёс бусчуудын устгалын талаар бошиглосон. Их Эзэн эцсийн өдрүүдэд Өөрийн хүмүүсийг цуглуулахын тулд “үндэстнүүдэд зориулан далбаа босгоно” гэснийг Исаиа урьдчилан харсан (2 Нифай 21:11–12-ыг үзнэ үү). Түүнчлэн Их Эзэн Сатаныг ялж, энх тайван, баяр баяслын эрин болох мянган жилд удирдана гэдгийг Исаиа гэрчилжээ.

2 Нифай 21:1–4, 10–12

Исаиа хожмын өдрүүд дэх Есүс Христийн сайн мэдээний сэргээлтийг урьдчилан харав

Түр зогсоод, таны өөдөөс гэрэл харагдаж эхэлж байна гэж төсөөл. Гэрэл улам хурц тод болсоор байна. Гэнэт Бурханы оршихуйгаас илгээгдсэн элч таны өмнө зогсож байна. Тэрээр танд эртний бошиглолууд биелэх гэж байна, тэдгээрийг биелэхэд



та туслах болно гэж хэлэв. Таны хамгийн эхний үйлдэл, бодол, асуулт юу байх бол?

Моронай 1823 оны 9-р сарын 21-ний шөнө анх Иосеф Смитэд үзэгдэн, тэрээр Исаиа 11-т бичиглэгдсэн 2 Нифай 21-ийг эш татан ярьжээ. Моронай энэхүү бүлэг дэх бошиглолууд нь удахгүй “биелэх болно” хэмээн Иосеф Смитэд хэлдэг (Иосеф Смитийн Түүх 1:40). Исаиагийн эдгээр бошиглолыг судлахдаа Нифай яагаад эдгээр зүйлсийг бага ялтсууд дээр бичиж, Моронай яагаад түүнийг нь Иосеф Смитэд эш татан хуваалцсан юм бол гэдгийг эргэцүүлэн бод.

Бошиглогч Иосеф Смит 2 Нифай 21-р бүлэг дэх бошиглолуудын утгыг тайлбарласан илчлэлтийг хүлээн авчээ. Эрдэмтэд энэ бүлэгт хэрэглэгдсэн бэлгэдэл, тэмдгүүдийн утгыг ойлгох гэж удаан хугацаанд хичээж байгаа. Мормоны Ном болон орчин үеийн бошиглогчид үүний утгыг илүү сайн ойлгоход бидэнд тусалж байна. Жишээ нь, Исаиа мод эсвэл ургамлын дүрслэлийг ашигласан. 2 Нифай 21:1, 10-ыг уншаад, Исаиагийн ярьсан мод эсвэл ургамлын тодорхой хэсгүүдийг олж тодорхойл. Дараа нь эдгээр бэлгэдлүүд нь ямар утгатайг ойлгохын тулд Сургаал ба Гэрээ 113:1–6-г унш. Судартаа эдгээр бэлгэдлүүдийн утгыг бичвэл тустай байж болох юм.

Иессийн гол иш—Есүс Христ

Иессийн гол ишнээс ургасан салаа—Есүс Христийн үйлчлэгч

Иессийн үндэс—Санваарын түлхүүрийг атгагч хувь хүн

“Иессийн гол иш” болон “Иессийн гол ишнээс ургасан салаа” нь хоёул Бошиглогч Иосеф Смитэд хамааралтай гэдгийг тайлбарласан ахлагч Брүс Р.Макконкийн дараах үгсийн талаар бод: “Бид [С ба Г 113:5–6]-д дурдагдсан бошиглогч нь санваар болон хаант улсын түлхүүрүүдийг хүлээж авсан, бидний эрин үед Их Эзэний хүмүүсийн цугларалтын тугийг өргөсөн Иосеф Смит мөн хэмээн буруу ярьж

Судар ашиглан судрыг ойлгох нь

Судрууд нь сайн мэдээний үнэн болон бошиглолуудыг бидэнд ойлгуулахаар хамтдаа үйлчилдэг. Жишээ нь, энэ хичээл Исаиагийн бошиглол болон заасан зүйлсийг тайлбарлахад туслах Сургаал ба Гэрээ 113-тай холбоотой. Түүнчлэн Нифай Исаиагийн үгсийг ойлгоход бидэнд тусалсан. Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Брүс Р.Макконки “Мормоны Ном бол Исаиагийн номыг тайлбарласан дэлхий дээрх хамгийн агуу ном” хэмээн тэмдэглэн үлдээжээ (“Ten Keys to Understanding Isaiah,” *Ensign*, 1973 оны 10-р сар, 81).

байна гэж үү? Түүнчлэн тэр ‘Христийн мутар дахь Иессийн мөн түүнчлэн Ефраимын эсвээс Иосефын угсааны хагас удам болох, дээр нь их хүч тавигдсан үйлчлэгч’ биш гэж үү? [С ба Г 113:3–4]” (*Millennial Messiah* [1982], 339–340).

2 Нифай 21:10, 12-ыг уншаад, “Иессийн үндсээр” (Иосеф Смит) дамжуулан Их Эзэний хийх зүйлийн талаар Исаиа юу гэж бошиглосныг ол. Туг гэдэг үг нь хүмүүсийг цуглуулдаг “далбааг” хэлдэг.

Эдгээр шүлгүүд нь дараах үнэнийг заадаг: **Их Эзэн Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Өөрийн сайн мэдээ болон сүмийг сэргээсэн бөгөөд эцсийн өдрүүдэд Өөрийн хүмүүсийг цуглуулж байгаа билээ.**

 **1.** Дараах асуултад судрын тэмдэглэлдээ хариулж бич: Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм хэрхэн дэлхийн туг болж байна вэ?

2 Нифай 21:6–9; 22:1–6

Исаиа мянган жилийг тайлбарласан нь

Христэд итгэгчдийн дунд хамгийн их яригддаг сэдэв бол Аврагчийн мянган жилийн хаанчлал юм. Та үүний талаар бодож байсан уу? Мянган жилийн талаар юу гэж боддог талаар найз тань танаас асуусан гэж төсөөл. Та юу гэж хэлэх вэ?

Аврагчийн Хоёр дахь ирэлтийн дараа дэлхий дээр өөрчлөлтүүд гарах бөгөөд энэ нь мянган жил



үргэлжлэх болно хэмээн Исаиа бошиглов. Энэхүү амар амгалангийн үеийг бид мянган жил гэж нэрлэдэг. 2 Нифай 21:6–9-ийг уншаад, мянган жилийн турш дэлхий ямар байдалд байхыг олж мэд.

2 Нифай 21:9-д хэлсний дагуу мянган жилийн талаарх нэгэн бошиглолд “Их Эзэний мэдлэг дэлхийг дүүргэх болно” хэмээсэн байдаг. Энэхүү бошиглолын биелэл нь дэлхийн эргэн тойронд оршин суух хүмүүст хэрхэн нөлөөлөх талаар тунгаан бод. 2 Нифай 22:1–6-г уншихдаа мянган жилийн турш хүмүүст байх шүтлэг бишрэлийн хандлагыг анзаарч унш. Өнөөдөр бид түүнтэй адил хандлагыг хэрхэн хөгжүүлж чадах вэ?

Таны судалсан шүлгүүд энэхүү үнэнийг заадаг: **Мянган жилийн турш энэ дэлхий Их Эзэний мэдлэгээр дүүрэх учраас амар амгалангийн газар байх болно.** Мянган жилийн төрх байдлуудаас алийг нь та яг одоо өөрийнхөө амьдралд байлгахыг хүсч байна вэ? Эдгээр адислалуудыг авахын тулд та юу хийж чадах тухайгаа нэг хормын турш бод.

2 Нифай 22-ыг судлах хичээлээ сайжруулахын тулд та “The Lord Is My Light” Hymns, д. 89) дуулж, сонсож, унших хэрэгтэй.

2 Нифай 23–24

Исаиа Вавилоны уналт, ёс бусчуудын уналт болон Люсиферийн уналтыг тайлбарласан нь

2 Нифай 23–24-т хэлснээр Исаиа Израилын угсааны ёс бусыг буруушаасан бөгөөд эцсийн өдрүүдийн ёс бусчуудын устгалыг эртний Вавилоны устгалтай харьцуулав. Вавилон нь Исаиагийн үеийн хамгийн ёс бус үндэстэн байсан ба түүнээс хойш дэлхийн ёс бус зүйлсийн бэлгэ тэмдэг болжээ. (С ба Г 133:14-ийг үзнэ үү).

2 Нифай 23:1, 4–9, 11, 15, 19 болон 22-ыг уншиж, эцсийн өдрүүдэд ёс бусчуудад юу тохиолдох талаар Исаиагийн бошиглосныг судал.

Исаиа түүнчлэн эртний Вавилоны устгалыг Люсиферийн (Сатаны) тэнгэрээс унасан уналттай харьцуулжээ. Тэр Вавилоны хааны бэлгэдэл болсон Люсиферийн тухай ярихдаа бүхий л ёс бус дэлхийг хэлж байв. Мөнх бус байдлын өмнөх дэлхий дэх Люсиферийн уналтыг ёс бусчуудын ялагдалт ба уналтын жишээ болгон ашиглав. 2 Нифай 24:12–14-ийг судалж, Сатаны бардамнал болон омог бардам байдлыг тодотгон харуулсан хэллэгийг тэмдэглэ.

Эдгээр шүлгүүдэд гарсан *би* гэдэг үгийн хэрэглээг анзаарсан уу? Судартаа *би* гэдэг үгсийг тэмдэглэх хэрэгтэй. Тэргүүн Зөвлөлийн Ерөнхийлөгч Н.Элдон Таннэр нэг удаа ийн хэлжээ: Сатан “үр дүнгээс илүү алдар нэрийн төлөө санаа тавьж байсан. Алдар суу

болон магтаал сайшаал нь өөрсдийнх нь төгсгөл байсан юм” (“For They Loved the Praise of Men More Than the Praise of God,” *Ensign*, 1975 оны 11-р сар, 76).

Эцсийн дүнд Сатанд юу тохиолдох, түүнийг юу болохыг нь хүмүүс хараад юу мэдрэхийг олж мэдэхийн тулд 2 Нифай 24:15–16-г судал.

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсоны хэлсэн дараах мэдэгдлийг унш: “Мөнх бус дэлхийн өмнөх хурлаар бардамнал Люцифер буюу ‘өглөөний хүүг’ унагаажээ. (2 Нифай 24:12–15; мөн С ба Г 76:25–27; Моце 4:3-ыг үзнэ үү). . . . Люцифер өөрийн төлөвлөгөөг Есүс Христээр дэмжүүлсэн Эцэгийн төлөвлөгөөтэй өрсөлдүүлжээ. (Моце 4:1–3-ыг үзнэ үү.) Тэр бусад бүх хүмүүсээс дээгүүр өргөмжлөгдөхийг хүссэн. (2 Нифай 24:13-ыг үзнэ үү.) Товчхондоо түүний бардам хүсэл нь Бурханыг сэнтийнээс нь буулгах байсан. (С ба Г 29:36; 76:28-ыг үзнэ үү.) (“Beware of Pride,” *Ensign*, 1989 оны 5-р сар, 4–5).

2 Нифай 23:22-оос хэрвээ та зөв зохистой байвал тайвшралыг олж авна гэдгийг бид сурдаг. Бурхан танд нигүүлсэнгүй хандах болно, харин ёс бусчууд устгах болно.



2. Судрын тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

а. Би өнөөдөр илүү дуулгавартай байхын тулд амьдралынхаа юуг өөрчилж чадах вэ?

б. Би яаж дуулгавартай хэвээр үлдэж чадах вэ?

2 Нифай 23-аас сурсан үнэнүүдийн тухай гэрчлэх боломжийн төлөө залбир.



3. Дараах өгүүлбэрийг судрын тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би 2 Нифай 21–24-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

7-Р ХЭСЭГ: 4 ДЭХ ӨДӨР

2 Нифай 25

Оршил

Исаиагийн бошиглолыг бичсэний дараа (2 Нифай 12–24), бошиглогч Нифай эдгээр бошиглолын чухлыг онцлон, бошиглолын суу билэгтэй хүмүүс Исаиагийн үгсийг ойлгож, үүнд талархах болно

хэмээн тайлбарлажээ (2 Нифай 25). Түүний үгсийн зорилго нь “Христэд итгэж, мөн Бурханд нийцсэн байхыг хүүхдүүддээ мөн түүнчлэн ах дүүстээ ятгах” юм хэмээн Нифай тайлбарлав (2 Нифай 25:23). Тэрээр бүх хүмүүнийг Есүс Христэд итгэж, “өөрсдийн бүхий л хүчин чадал, оюун мөн чадлаараа, мөн өөрийн бүхэл бодгалиар бишрэн шүтэхэд” урив (2 Нифай 25:29).

2 Нифай 25:1–8

Бид бошиглолын суу билэгтэй байсан үед Исаиагийн үгсийг ойлгож чадна хэмээн Нифай заав

Хүмүүс үнэт эдлэлээ хадгалахдаа ихэвчлэн цоож ашигладаг. Тэд ганц байгаа түлхүүрээ өөртөө хадгалдаг эсвэл итгэлтэй найздаа юмуу гэр бүлийн гишүүндээ түлхүүрээ хувилаад өгч болдог. Исаиагийн бошиглол нь “агуу чухал” гэдгийг Нифай мэдэж байсан бөгөөд (2 Нифай 25:8) тэдгээрийг хүн бүр ойлгоосой хэмээн тэр хүсч байсан. Тэрээр Исаиагийн үгсийн утгын цоожийг онгойлгохыг хүссэн хүн бүрд түлхүүрийг өгсөн.



2 Нифай 25:4-ийн эхний өгүүлбэрийг уншаад Исаиагийн үгсийг ойлгох түлхүүрийг ол. “Бошиглолын суу билэгтэй” байна гэдэг нь ямар утгатай вэ? Судрууд, ялангуяа Исаиагийн үгсийг илүү сайн ойлгоход бошиглолын суу билиг танд хэрхэн тусалж чадна гэж та бодож байна?

Бошиглолын суу билиг нь илчлэлтийн суу билгийг илэрхийлдэг. Энэ нь та судруудын утгыг ойлгохыг эрэлхийлэн, хичээнгүйлэн, залбиралтайгаар судлах үедээ та илчлэлтийн суу билигтэй байж, Ариун Сүнс таны оюун бодол болон ойлголтыг тань гэгээрүүлнэ гэсэн үг юм. Түүнчлэн судрууд “Есүсийн гэрчлэл бол бошиглолын сүнс мөн” гэж заадаг (Илчлэлт 19:10 Библид “эш үзүүлэгчийн” гэж бичсэн нь “prophecy” буюу “бошиглол” гэсэн утгатай). Аврагчийн талаарх мэдлэг болон гэрчлэл тань өсөхийн хэрээр Исаиагийн заасан зүйлс болон судруудын талаарх таны ойлголт өсч, тэдгээр нь танд хэрхэн хамааралтай болохыг та илүү сайн ойлгох болно.

Нифай Исаиагийн үгсийн талаарх бидний ойлголтыг нэмэгдүүлэх өөр санаануудыг хуваалцсан юм. Дараах судруудыг судлаад, Исаиагийн үгсийг ойлгоход туслах гурван түлхүүрийг олж тодорхойл:

- 2 Нифай 25:1 _____

- 2 Нифай 25:5–6 _____
- 2 Нифай 25:7–8 _____

Эртний Иудей бошиглолуудад ихэвчлэн бэлгэдэл, яруу найргийн хэл ашигласан байдаг гэдгийг санаарай (2 Нифай 25:1). Түүнчлэн эртний Израилын соёл, түүх, газарзүйн талаар судлах нь Исаиагийн үгсийг ойлгоход тань илүү тус дэм болох болно (2 Нифай 25:5–6-г үзнэ үү). Эцсийн өдрүүдэд амьдарч, олон бошиглолын биелэлтийг харах нь мөн бидэнд Исаиаг ойлгоход тусалж байгаа (2 Нифай 25:7–8-ыг үзнэ үү).

2 Нифай 25:9–19

Нифай Иудейчүүдийн тухай бошиглосон нь

2 Нифай 25:9–19-д цэдэглэснээр Нифай Иудейчүүдийн тухай болон Иерусалим дахь тэдний өвийн нутаг, эргэн тойрны нутгийнх нь талаар бошиглов. Тэр хэлэхдээ Иерусалимын устгалын дараа Вавилонд боолчлолд аваачигдсан Иудейчүүд “өвлөсөн нутагтаа” эргэн ирэх болно гэжээ (2 Нифай 25:9–11-ийг үзнэ үү). Есүс Христ болох Мессиа тэдний дунд амьдрах болно, гэвч тэдний олон нь Түүнийг эсэргүүцэж, цовдлох болно (2 Нифай 25:12–13-ыг үзнэ үү). Аврагчийн үхэл болон амилуулалтын дараа Иерусалим дахин устгагдаж, Иудейчүүд тараагдаж, бусад үндэстнүүдээр цээрлүүлэгдэх болно (2 Нифай 25:14–15-ыг үзнэ үү). Яваандаа тэд Есүс Христ болон Түүний Цагаатгалд итгэх болно, Их Эзэн тэднийг “төөрөлдсөн мөн унасан байдлаас нь” сэргээх болно. (2 Нифай 25:16–19-ийг үзнэ үү).

2 Нифай 25:20–30

Нифай Есүс Христыг гэрчилсэн нь

Хожмын үеийн гэгээнтнүүдийг Есүс Христэд итгэдэггүй хэмээн маргалддаг хүнд ямар хариулт өгөх тухайгаа бод. 2 Нифай 25-ын үлдсэн шүлгүүдийг судлахдаа иймэрхүү нөхцөл байдалд орсон үедээ хуваалцах хэсгийг ол.

2 Нифай 25:20–30-ийг гүйлгэж уншаад, “Христ” хэмээх нэрийг нэг бүрчлэн тэмдэглэ.



1. 2 Нифай 25:28–29-ийг уншаад Нифайн ярьсан “зөв зам” гэж юу болохыг тодорхойл. Есүс Христэд итгэх нь яагаад зөв зам болох шалтгаануудыг олохын тулд 2 Нифай 25:23–26-г судал. (2 Нифай 25:23, 26 нь төгс эзэмших судар гэдгийг анхаар. Дараа нь олоход хялбар болгож бусдаас өөрөөр тэмдэглэх хэрэгтэй.) Хариултаа судрын тэмдэглэлдээ бич.

2 Нифай 25:23-г гардаг нийцсэн гэдэг үг нь Бурхантай зохицсон байх гэсэн утгатай. Их Эзэний “ач



ивээл” нь биднийг Бурханд нийцүүлдэг. Их Эзэний ач ивээлийн талаарх дараах тайлбарыг унш:

“Ач ивээл хэмээх үг нь үндсэндээ судруудад хэрэглэгдсэнээр Их Эзэн Есүс Христын Цагаатгалаар дамжуулан хүлээн авдаг тусламж хийгээд тэнгэрлэг хүч чадалтай холбоотой. . . .

“. . . Аврагчийн цагаатгах золиослолоор боломжтой болсон ач ивээлээр дамжуулан бүх хүмүүс амилуулагдаж, үхэшгүй байдлыг хүлээн авах болно. [Гэвч бид Бурханы оршихуй дахь мөнхийн амьдралд орохын тулд Түүний ач ивээлээр дамжуулан нүглүүдээсээ цэвэрших ёстой.]

“‘Бидний хийж чадах бүхний дараа’ [2 Нифай 25:23] хэмээх хэллэг нь Их Эзэний бүрэн дүүрэн ач ивээлийг хүлээн авах ба Түүнтэй хамт амьдрахад зохистой болоход бидний талаас хичээл зүтгэлийг шаарддаг гэсэн утгатай юм. Их Эзэн биднийг Түүнд итгэх итгэлтэй байх, нүглээ наманчлах, баптисм хүртэх, Ариун Сүнсний бэлгийг хүлээн авах мөн эцсээ хүртэл тэвчих зэргийг багтаасан Түүний сайн мэдээг дагахыг зарлигласан. . . .

“Таны туйлын авралд ач ивээл хэрэгтэйгээс гадна энэхүү бололцоо олгох хүч нь амьдралд тань өдөр бүр хэрэгтэй. Та Тэнгэрлэг Эцэгтээ хичээл зүтгэл,

даруу төлөв байдалтайгаар дөхөн очвоос Тэрээр ач ивээлээрээ дамжуулан таныг өргөн, хүчирхэгжүүлэх болно” (Итгэлдээ үнэнч байх нь: Судрын заалт [2004], 41-42).



2. Дараах асуултуудын хариултыг судрын тэмдэглэлдээ бич:

- а.** Их Эзэний ач ивээл, сайн мэдээгээр амьдрах бидний хичээл зүтгэл хоёр хоорондоо ямар уялдаа холбоотой вэ?
- б.** Ач ивээлээр аврагдана гэдэг нь таны хувьд ямар утгатай вэ?
- в.** “Бидний хийж чадах бүхэн” гэдэг нь таны хувьд ямар утгатай вэ?

Дараах үнэнийг тунгаан бод: **Есүс Христээр дамжуулан хийж чадах бүхнийхээ дараа ач ивээлээр бид аврагдах боломжтой.** Та өөрийн хийж чадах бүх зүйлээ хийсний дараа тэнгэрлэг тусламж, хүчээр адислагдаж байсан үеэ бод.

Туршлагаудаа эргэн дурс

Их Эзэний тусламжаар адислагдаж байсан тухай туршлагаудаа эргэн дурсах нь хэцүү үед таныг хүчирхэгжүүлэх болно. Эдгээр туршлагаудаа гэрчлэл болгон хуваалцах, өдрийн тэмдэглэлдээ бичих, ойр дотны хэн нэгэндээ тайлбарлаж өгөх нь зөвхөн танд туслаад зогсохгүй, хэцүү нөхцөл байдалтай байгаа, Бурхан үнэхээр байдаг бөгөөд бидэнд туслах хүч Түүнд байдаг гэдэгт итгэхэд нь дэмжлэг тусалцаа хэрэгтэй тэдгээр хүмүүсийг хүчирхэгжүүлж чадна.

Нифайн заасан бас нэгэн үнэн зүйл (2 Нифай 25:26-г үзнэ үү) нь: **Аврагчийн Цагаатгалаар дамжуулан бид нүглүүдийн ангижралыг хүлээн авч чадна.**

Есүс Христэд итгэх итгэлийнхээ талаар найздаа эсвэл гэр бүлийн гишүүндээ захиа бичих, гэрчлэлийн цуглаан дээр өөрийн итгэдэг зүйлсээ гэрчлэх эсвэл бусад боломжтой хуваалцах аргуудын талаар бод.



3. 2 Нифай 25:26-г дахин уншаад, судрын тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

а. Ямар замуудаар та Есүс Христийг шүтдэг эсвэл биширдэг вэ? Ямар үйл ажиллагаанууд Есүс Христийг шүтэн биширдэг итгэлийг тань бусдад харуулдаг вэ?

б. Аврагчийг бүхий л хүчин чадал, оюун хийгээд чадлаараа илүү сайн шүтэн бишрэхийн тулд та юу хийж чадах вэ?

Төгс эзэмших судар—2 Нифай 25:23, 26

2 Нифай 25:26-г чээжлэхэд тань туслах дараах загварыг ашигла:

“Мөн бидний хүүхдүүд нүглээс ангижрахын тулд ямар сурвалжийг хайж болохыг мэдэж болохын тулд бид Христийн тухай ярьж, бид Христэд баясч, бид Христийн талаар номлож, бид Христийн тухай бошиглож, мөн бид бошиглолуудынхаа дагуу бичдэг болой.”

Үүнийг хэдэн удаа давтаж уншсаны дараа эхний мөрийг гараараа дараад дахиад уншихыг хичээ. Дараа нь дахиад нэг мөрийг дар. Шүлгийг бүтнээр нь чээжилтлээ мөрүүдийг нэг нэгээр нь дар.



4. 2 Нифай 25:26-г гэр бүлийнхэндээ чээжээр уншиж үзүүл, тэгээд энэ шүлгийг чээжилсэн гэдгээ судрын тэмдэглэлдээ бич.



5. Дараах өгүүлбэрийг судрын тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би 2 Нифай 25-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:



2 Нифай 26–27


Оршил

Нифай Есүс Христ Америкт ирэхийг, түүний хүмүүсийн дээр хожим ирэх устгалыг урьдчилан харав. Түүнчлэн Нифай эцсийн өдрүүдэд амьдрах хүмүүсийг харж, тэдэнд бардамнал, нууц хуйвалдаанууд болон санваараар мэргэшихийн эсрэг сэрэмжлүүлэв. Ёс бус байдал, урвалтын үр нөлөөг даван гарах арга замаар Их Эзэн биднийг хэрхэн хангадгийг тайлбарлахын тулд Нифай хожмын өдрүүд дэх Есүс Христийн сайн мэдээний сэргээлтийн талаарх Исаиагийн бошиглолыг оруулав.

2 Нифай 26

Нифай эцсийн өдрүүдийн талаар бошиглож, бүх хүмүүнийг Христэд ирэхийг урив

Та газар хөдлөлт, аянга цахилгаантай шуурга, ямар нэгэн гамшгийн үйл явдлыг харж эсвэл тиймэрхүү үйл явдлын зураг, видео үзэж байсан уу? Дэлхийн оршин суугчид эцсийн өдрүүдэд “аянга, мөн цахилгаан, мөн газар хөдлөлт, мөн бүх төрлийн устгалуудаар дайлагдах болно” гэдгийг Нифай харжээ (2 Нифай 26:6). “Их Эзэний хилэн” (2 Нифай 26:6) эсвэл “Бурханы шүүлтүүд” (2 Нифай 25:3)-ийн талаар уншихад танд юу бодогдож байна вэ? Бурханы шүүлтүүд нь хүүхдүүдээ адислах буюу ёс бусчуудыг наманчлалд авчрахад, зөв шударгыг хамгаалахад зориулагдсан байдаг. 2 Нифай 26:1–11-т Нифай Есүс Христ Америкт ирэхийн өмнөх устгал болон өөрсдийн ёс бус байдлаас болж устгагдах хүмүүсийнхээ устгалын талаар бошигложээ. 2 Нифай 26:8–9-ийг уншаад зөв шударга үр удамд нь ирнэ гэж Нифайн хэлсэн адислалуудыг ол. Дараа нь 2 Нифай 26:12–13-ыг уншаад, бид Есүс Христэд итгэх итгэлээ үйлдэл болговол бидэнд юу амлагдсаныг ол.

 **1.** Есүс Христ Өөрт нь итгэх итгэлээ үйлдэл болгож, зөв шударга байдалд үргэлжлүүлсэн хүмүүст Өөрийгөө үзүүлдэг. Дараах асуултуудын хариултыг судрын тэмдгэлдээ бич:


а. Өөрт нь итгэх итгэлээ үйлдэл болгодог хүмүүст Есүс Христ Өөрийгөө хэрхэн үзүүлдэг вэ? (2 Нифай 26:13-ыг үзнэ үү.)

б. Та Есүс Христийн илэрхийлэлтүүдийн заримыг нь биеэр үзэж, гэрч болж байсан уу?


2 Нифай 26:14–19-д Нифай хожмын өдрүүдэд түүний хүмүүс болон ах нарынх нь үр удам итгэлгүйнхээ улмаас сул дорой болсны дараа Мормоны Ном ирэх болно хэмээн бошиглов. 2 Нифай 26:20–22-т,

хожмын өдрүүдэд хэчнээн их хүн бардамналаар дүүрэн, Бурханы гайхамшгуудыг эсэргүүцэж, өөрсдийн мэргэн ухаан, сурсан зүйлсэд найдахыг тэрээр дүрслэв. Нифайн бошиглолууд биелж байгаа жишээнүүдийг та ямар хэлбэрээр харсан бэ?

Чөтгөр биднийг устгаж, сүйрүүлэхийн тулд бардамнал, шунал, нууц ажлуудыг ашигладаг хэмээн Нифай бидэнд сэрэмжлүүлэв. Судрынхаа 2 Нифай 26:22-ын хажууд Сатан биднийг хэрхэн оосорлон хүлэхийг эрэлхийлж байдгийг тэмдэглэ. Маалинган оосор гэдэг нь амархан тасардаг, нарийхан утас юм. Гэсэн хэдий ч, олон давхар утсыг хамтад нь сүлжихэд бат бөх оосор болдог. 2 Нифай 26:32-ыг уншаад, биднийг зайлсхий хэмээн Их Эзэний зарлигласан “харанхуйн ажлууд”-ын жишээг ол. 2 Нифай 26:32-т гардаг нэг дамартай утас хэрхэн “бат бөх оосор” болж болдог тухай тунгаан бод.

 **2.** Та найздаа чөтгөрийн (Сатан) урхинаас хэрхэн зайлсхийхийг зааж байна гэж төсөөл. 2 Нифай 26:20–22, 32-ыг ашиглан чөтгөр биднийг оосорлон хүлэхийг эрэлхийлдэг тухай судрын тэмдгэлдээ тайлбарлан бич. Дайсан нь өрсөлдөгчөө бөх олсоор хүлэх хүртлээ маалинган оосрыг хэрхэн ашигладгийг ялангуяа 2 Нифай 26:22-оос олж уншиж болно.

Нифай дайснуудаас нь үүдэлтэй устгалыг харж, эцсийн өдрүүд дэх Сатаны урхи болон нөлөөллийн талаар сэрэмжлүүлэв. Нифай Сатаны харанхуйн ажилтай харьцуулан, Бурханы хайр бүх хүмүүст хүртээмжтэй бөгөөд Түүний зорилго бол Өөрт нь ирсэн бүхнийг аврах юм гэдгийг заажээ. 2 Нифай 26:23–24-ийг уншаад Бурхан хүүхдүүдтэйгээ хэрхэн ажиллагдийг тайлбарласан хэллэг болон үгсийг тодруул. 2 Нифай 26:24-т бичсэний дагуу Бурхан ямар зорилгоор бүх зүйлийг хийдэг вэ? Энэхүү сургаалыг заасан өгүүлбэрийг тодруулах хэрэгтэй: **Их Эзэний хийдэг бүх зүйл нь энэ дэлхийн ашиг тусын тулд байдаг.**

 **3.** Дараах асуултад судрын тэмдгэлдээ хариулж бич: Их Эзэний хийдэг бүх зүйл нь энэ дэлхийн ашиг тусын тулд юм гэдгийг ойлгох нь Тэнгэрлэг Эцэгт итгэх итгэлээ өсгөхөд тань хэрхэн тусалж, амьдралд тань амар амгалан, итгэлтэй байдлыг хэрхэн өгөх вэ?

2 Нифай 26:25–28, 33-ыг гүйлгэж уншаад, *бүх, нэгээхэнд ч болон нэг нь ч хэмээх үгсийг тэмдэглэ*. Дараа нь уг шүлгүүдийг дахин уншихдаа эдгээр үгсэд болон **Их Эзэн бүх хүмүүнийг хайрлаж, Түүнд ирж, Түүний авралаас хүртэхийг бүгдэд урьж байгааг Нифай хэрхэн заасанд онцгой анхаарал хандуулна уу**. Энэхүү зарчим нь зарлигууд, жишгүүд болон бусад хүмүүсийг харах хандлагад тань хэрхэн нөлөөлж байгааг тунгаан бод.



4. 2 Нифай 26:29–31-ийг унш. Судрын тэмдэглэлдээ 29-р шүлэгт гардаг санваараар мэргэшихийн хоёр юмуу гурван шинж чанарыг жагсаан бичээд, дараах асуултад хариулж бич:

а. Санваараар мэргэших нь яагаад сүмд хор хөнөөлтэй гэж та бодож байна вэ?

б. 2 Нифай 26:30-д хэлснээр, санваараар мэргэшихээс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ?

2 Нифай 27:1–23

Нифай Мормоны Ном урагш авчрагдахыг бошиглодог



5. Дараах асуултад судрын тэмдэглэлдээ хариулж бич: Та Мормоны Ном Бурханы үгс гэдгийг хэрхэн мэдэж авсан (яагаад итгэдэг) бэ?

Их Эзэн бошиглогч Исаиад Мормоны Ном урагш авчрагдах талаар нарийн тодорхой илчилсэн бөгөөд Нифай үүнийг 2 Нифай 27-д бичиглэжээ. Исаиа эцсийн өдрүүдэд олон хүн алдсаар дүүрч, бошиглогчдыг эсэргүүцэх тухай бошиглосныхоо дараа Бурхан эртний бичээс бүхий номыг илчлэх болно хэмээн заажээ (2 Нифай 27:1–7-г үзнэ үү). 2 Нифай 27:12–14-ийг уншаад, эцсийн өдрүүдэд урагш гарч ирэх номын үнэнийг нотлохын тулд Их Эзэний хийх зүйлийн талаар юу заасныг ол.

Их Эзэн Мормоны Номын үнэнийг нотолсон нэг арга зам нь алтан ялтсуудыг гэрчлэхийг бусад хүмүүст зөвшөөрсөн юм. Оливер Каудери, Давид Витмер, Мартин Харрис нар гурван гэрчээр сонгогдсон бөгөөд 2 Нифай 27:12-т дурдагджээ. (Мормоны Номын эхний хуудсан дахь “Гурван гэрчийн гэрчлэл”-ийг үзнэ үү.)

2 Нифай 27:13-т “цөөн хэд” хэмээн гардаг нь Найман гэрчийг багтаадаг (Мормоны Номын эхний хуудсан дахь “Найман гэрчийн гэрчлэл”-ийг

үзнэ үү). 2 Нифай 27:14-т гардаг “байвал зохино хэмээсэн тооны гэрчүүд” хэмээх үгсийг тэмдэглэ. Мормоны Номын талаар гэрчлэл хүлээн авч, хуваалцахаа та энэхүү номын үнэнийг гэрчлэх гэрч болдог. Мормоны Номын үнэнийг гэрчлэх нэмэлт гэрчүүдийн нэг болгон өөрийн нэрийг 2 Нифай 27:14-ийн хажууд бичиж болно.

Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Жэффри Р.Холланд Мормоны Номын талаарх өөрийн гэрчлэлийг хэлсэн юм:



Мормоны Ном болон энэ номыг гэрчилдэг Их Эзэн Есүс Христийн бурханлаг мөн чанарыг хүлээн зөвшөөрөхгүй бол, ямар ч хүн хожмын үеийн энэхүү ажилд бүрнээр итгэж, манай өнөө үед амар амгалан болон тайвшралыг бүрэн хэмжээгээр олж чадахгүй юм. . . .

“Мормоны Ном болон үүний агуулга, утга санааны талаар албан тушаал, андгай тангаргийнхаа дагуу хуваалцсан миний гэрчлэлийг энэ дэлхий дээрх хүмүүс болоод тэнгэр элчүүд тэнгэрт цэдэглэх болтугай хэмээн би хүсч байна. . . . Би Бурханы шүүлтийн өмнө зогсохдоо, Мормоны Ном үнэн бөгөөд Иосефын өгүүлсэн яг тэр замаар дэлхийд ирж, хожмын өдрүүдэд зовлон зүдгүүрийг туулан буй итгэгчдэд аз жаргал, итгэл найдварыг авчирсан юм гэдгийг эрс шулуун, тодорхой үгээр дэлхийд тунхаглахыг хүсдэг билээ” (“Бодгалийн аюулгүй байдал,” 2009 оны 10-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн үгс, 100–103).

Мормоны Номын үнэний талаарх итгэлээ хүчирхэгжүүлэхийн тулд та юу хийж чадахаа эргэцүүлэн бод.



6. Мормоны Номын үнэний тухай өөрийн гэрчлэлийг хүчирхэгжүүлэхийн тулд энэ жил юу хийхээ судрын тэмдэглэлдээ бич.

Дараах үйл ажиллагааг хийхийн тулд танд Агуу Үнэт Сувд судар дахь Иосеф Смит—Түүх ном хэрэг болох болно. Иосеф Смит—Түүх 1:63–65-ыг уншаад, үүнд гарч буй хүмүүсийг тодорхойл. Дараа нь дараах хүснэгтэд өгөгдсөний дагуу 2 Нифай 27-оос оноосон хэсгийг уншаад, шүлэг бүрдээ нэрсийг тохируул.


а. Чарльз Антон	_____ Суралцаагүй хүн (2 Нифай 27:9, 15, 19–20-ийг үзнэ үү)
б. Иосеф Смит	_____ Эрдэмт хүнд үгс буюу номыг аваачих хүн (2 Нифай 27:15, 17-г үзнэ үү)
в. Мартин Харрис	_____ Эрдэмт хүн (2 Нифай 27:15, 18-ыг үзнэ үү)

Иосеф Смит—Түүх 1:63–65-д гардаг үсгүүд хэмээх үг нь Мартин Харрисын профессор Чарльз Антонд




үзүүлсэн, Иосеф Смитийн алтан ялтсуудаас хуулан орчуулсан, шинэчлэгдсэн Египет үсгүүдийг хэлж байгаа юм. Чарльз Антон нь Колумбия коллежийн багш байсан бөгөөд эртний бичиг үсгийг мэддэгээрээ алдаршсан нэгэн байжээ. Үсгүүдийг орчуулсан Иосеф Смитийн орчуулгыг зөв хэмээн нотолж, гэрчилгээ олгосны дараа, гайхамшигт арга замаар ялтсуудыг олж авсныг профессор Антон мэдээд орчуулгын нотолгоогоо уржээ. Тэрээр цэдгийг өөрөө орчуулахыг хүссэн. Мартин Харрис зарим ялтсууд лацдагдсан гэдгийг тайлбарлахад профессор Антон лацдагдсан номыг уншиж чадахгүй гэдгээ хэлэв. 2 Нифай 27:16-д хэлсний дагуу ялтсуудыг орчуулахыг хүссэн Чарльз Антоны саналын талаар бид юу сурах вэ?

2 Нифай 27:20–23-ыг уншаад, 20, 21-р шүлгүүдэд давтагдаж буй хэллэгийг олж тэмдэглэ.

 **7.** 2 Нифай 27:1–23-р шүлгүүдээс Бурхан Өөрийн ажлыг хийх боломжтой гэдгийг батлах юу сурснаа судрын тэмдэглэлдээ бич. (Мормоны Ном урагш авчрагдах тухай нэмэлт мэдээлэл хэрэгтэй бол С ба Г 20:8–12-ыг үзнэ үү.)

Дараах үнэнүүдийг судрын тэмдэглэлдээ бичих хэрэгтэй: **Мормоны Номыг урагш авчрах нь Бурхан хожмын өдрүүдэд Өөрийн ажлыг гүйцэлдүүлэх нэгэн арга зам юм.**


 **8.** Дараах асуултад судрын тэмдэглэлдээ хариулж бич: Мормоны Номын талаарх эртний бошиглолын биелэлт нь ном болон Их Эзэний Сүмийн Сэргээлт дэх уг номын үүргийн талаарх таны гэрчлэлийг хэрхэн хүчирхэгжүүлж байна вэ?


2 Нифай 27:24–35

Нифай Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээний сайн нөлөөний талаар бошиглов

Бурхан Иосеф Смит хэмээх залуу эрэгтэйг Сэргээлтийн бошиглогч байхаар, Түүний гайхамшигт ажлыг эцсийн өдрүүдэд улиран тохиолгохоор сонгожээ. Судруудад дурдагддаг “гайхамшигт ажил” гэдэг нь Мормоны Номын ирэлтийг багтаасан Есүс Христийн сайн мэдээний Сэргээлт юм. 2 Нифай 27:25–26-г уншаад, “гайхамшигт ажил ба ер бусын үйл” хэмээх хэллэгийг тэмдэглээд, Их Эзэн гайхамшигт ажлаа эхлэх үед бий болох зарим нөхцөл байдлуудыг тодорхойл. Тэдгээр нөхцөл байдлуудаас зайлсхийхэд тань Мормоны Ном болон Сэргээлт хэрхэн тус болсон тухай тунгаан бод.

2 Нифай 27:29–30, 34–35-ыг уншаад, сайн мэдээний Сэргээлт болон Мормоны Ном урагш авчрагдсаны улмаас ирэх адислалуудыг тэмдэглэ. **Мормоны Ном болон сэргээгдсэн сайн мэдээ нь тэдгэрийг уншиж, хүлээн зөвшөөрөх хүмүүст ойлголт болон баяр баяслыг авчрах болно.**

 **9.** Дараах асуултын хариултыг судрын тэмдэглэлдээ бич: Мормоны Номын ирэлтийг багтаасан сайн мэдээний Сэргээлт нь таны амьдралд хэрхэн “гайхамшигт ажил” болж байна вэ?

 **10.** Дараах өгүүлбэрийг судрын тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би 2 Нифай 26–27-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

8-Р ХЭСЭГ: 2 ДАХЬ ӨДӨР

2 Нифай 28

Оршил

Нифай хожмын өдрүүдэд баригдах хуурамч сүмүүдийн бардамнал, хуурамч сургаал зэрэг зарим сорилтот нөхцөл байдлуудын талаар бошиглов. Тэрээр хуурамч сургаал, дэлхийн хандлагыг хэрхэн таньж мэдэх талаар зааж, зөв зохистой амьдралаас эрэгтэй, эмэгтэйчүүдийг холдуулахыг хичээж байдаг Сатаны аргуудыг тодорхойлов.



2 Нифай 28:1–19

Нифай бидний өдрүүд дэх хуурамч сүмүүд болон хуурамч санаануудыг тайлбарлав


Ихэнх улсад жолооч нарт зориулсан ямар нэгэн аюул бартаанаас болгоомжлохыг сэрэмжлүүлсэн замын тэмдгүүд байдаг. Таны амьдардаг улс эсвэл хотод дөхөн ирж буй бартаа сааднаас сэрэмжлүүлсэн замын хөдөлгөөний тэмдгүүд ямар хэлбэр дүрстэй, ямар өнгөтэй байдаг вэ? Үүний нэгэн адил хортой болон бусад аюултай материалууд нь ихэвчлэн сав баглаан дээрээ сэрэмжлүүлсэн тэмдэгтэй байдаг. Таны амьдардаг газарт эдгээр нь хэрхэн тэмдэглэгдсэн байдаг вэ?

Эдгээр бие махбодын сэрэмжлүүлгийн тэмдгүүдтэй адил сүнсэнд тань хор хөнөөлтэй нөлөөллүүдээс зайлсхийхэд тус болох сэрэмжлүүлгийг Мормоны Ном агуулсан байдаг. Мормоны Ном Сатаны хилэнцэт төлөвлөгөөний эсрэг таныг хэрхэн

хүчирхэгжүүлж, сэрэмжлүүлэх талаар Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон тодорхойлсон юм: “Мормоны Ном Христийн дайснуудыг илчилдэг. Буруу сургаалуудыг бүрмөсөн үгүйсгэж, маргаан тэмцлийг намжаадаг. (2 Нифай 3:12-ыг үзнэ үү.) Энэ нь Христийн даруухан дагалдагчдыг эдгээр өдрүүд дэх чөтгөрийн хилэнцэт төлөвлөгөө, бодлого болон сургаалын эсрэг хүчирхэгжүүлдэг. Мормоны Ном дахь урвагчид өнөөдөр бидний дэргэд байдаг урвагчидтай төстэй. Бид алдааг нь харж, өнөө үеийн боловсролын, улс төрийн, шашны, гүн ухааны худал ойлголтуудыг хэрхэн үгүйсгэхийг мэдэж болохын тулд Бурхан хэмжээлшгүй зөн билгээрээ Мормоны Номыг бүтээсэн юм” (“The Book of Mormon Is the Word of God,” *Ensign*, 1988 оны 1-р сар, 3).


Мормоны Ном чөтгөрийн хуурамч санаануудыг илчилж, түүний хилэнцэт төлөвлөгөөний эсрэг биднийг хүчирхэгжүүлдэг. 2 Нифай 28-д бичиглэснээр, бүхий л эрин үеүүдэд нийтлэг байдаг

чөтгөрийн хуурамч сургаалын заримыг Нифай тайлбарлажээ. 2 Нифай 28:3–9-ийг судлаад, Сатаны хуурамч сургаал, арга залийн талаар сурсан зүйлээ тэмдэглэ. (2 Нифай 28:7–9 нь төгс эзэмших судар гэдгийг анхаар. Дараа нь олоход хялбар болгож бусдаас өөрөөр тэмдэглэх хэрэгтэй.)

 **1.** 2 Нифай 28:3–9-р шүлгүүдээс таны бодлоор өнөөдөр өсвөр үеийнхэнд хамгийн аюултай болоод байгаа хуурамч сургаалуудын нэгийг олж судрын тэмдэглэлдээ бичээд, шалтгааныг нь тайлбарла. Түүнчлэн залуу хүмүүс тэрхүү хуурамч сургаалд хэрхэн уруу татагдаж болохыг харуулсан жишээ оруул.

2 Нифай 28:12–14-ийг уншаад, Нифайн сэрэмжлүүлсэн олон сүмүүд, хүмүүс болон “Христийн даруу дагалдагчид”-ын заримд хүртэл тохиолдох зүйлийг ол (14-р шүлэг). Эдгээр зүйлс нь 2 Нифай 28:3–9-д уншсан бардамнал, хуурамч сургаалаас үүдэлтэй юм. 2 Нифай 28:15–16, 19-ийг уншаад эдгээр хуурамч сургаалуудын зарим үр дагаврыг тодорхойл. Та 2 Нифай 28:19-д гардаг наманчилдаггүй хүмүүст чөтгөр юу хийхийг тайлбарласан өгүүлбэрийг тэмдэглэх хэрэгтэй.

Төгс эзэмших судар—2 Нифай 28:7–9

 **2.** 2 Нифай 28:7–9-ийг чангаар унш. 2 Нифай 28:8-ыг чээжлэхэд цаг зарцуул. Та судрын тэмдэглэлдээ чээжээр бичих юмуу гэр бүлийн гишүүн, найздаа чээжээр уншиж өгөх хэрэгтэй. Эцсийн өдрүүдэд олон нь хуурамч, хоосон, мунхаг сургаалуудыг заах болно. Судрын тэмдэглэлдээ мунхаг сургаалууд дэлгэрэх зарим арга замуудыг жагсаан бичиж, дэлхийн мунхаг сургаалуудыг та хэрхэн таньж, тэднээс зайлсхийх талаар товчхон тайлбарла.

2 Нифай 28:20–32

Нифай Сатаны заль мэхийн талаар сэрэмжлүүлэв

2 Нифай 28-ын үлдсэн хэсгийг суралцахад бэлтгэн, Арванхоёр төлөөлөгчийн чуулгын Ерөнхийлөгч Бойд К.Пакэрын Африкт томилолтоор явж байхдаа дархан цаазат амьд байгалиар зочилсон тухай туршлагыг унш.

“Амьтад ус уухаар ирэхийг нь харахаар бид цөөрмийн дэргэд зогссон юм. Их халуун улирал байсан болохоор ус гэх юм бараг байхгүй, шавар л харагдаж байсан. . . .



“Ялангуяа гөрөөснүүд их сандарч байлаа. Тэд шаварт ойртон ирснээ шууд эргэн, айдаст автан гүйж одов. Тэр хавьд нь ямар ч арслан байхгүй байгааг би хараад, тэд яагаад уснаас уугаагүй тухай хөтчөөсөө асуув. Түүний хариулт буюу сурах зүйл нь ‘Матар’ байсан юм.

“Түүнийг тоглож байна гэж бодоод би түүнээс ‘Ямар асуудал байгаа юм бэ?’ гэж лавлан асуулаа. Тэрээр дахиад ‘Матар’ гэж хариулав.

“‘Ойлгосонгүй’ гэж би хэлээд, ‘Тэнд ямар ч матар харагдахгүй л байна шүү дээ. Хэн ч харсан тодорхой байна’ гэв. . . .

“Би түүнд итгэхгүй байгааг тэр мэдэж байгаа нь илэрхий байсан бөгөөд тэрээр надад хичээл заахаар шийдэв. Бид машинаар дэнж өөдөө явж, шавартай цөөрөм рүү доош харж болох газарт очив. ‘Тэр,’ ‘Өөрөө хар даа’ гэж тэр хэлэв.

“Би багахан устай шавар болон хол зогсох айдаст автсан амьтдаас өөр юуг ч олж харсангүй. Тэгээд гэнэт олж харав!—Том гэгчийн матар шавар дунд ямар ч сэжиг аваагүй, цангаж, ус уухаар ирэх амьтдыг хүлээн хэвтэж байлаа.

“Тэгээд би итгэв! Сонсох хүсэлтэй байгааг минь мэдээд тэр үргэлжлүүлэн хичээлээ заав. ‘Энэ газарт матар хаа сайгүй тархсан байгаа,’ ‘зөвхөн голуудад ч биш. Энэ хавьд матаргүй ус гэж байхгүй, та итгэсэн нь дээр дээ’ гэж тэр хэллээ. . . .

“Африкт очсон бас нэгэн айлчлалаараа дархан цаазтай өөр газрын ан агнуурын хамгаалагчтай энэ талаар ярилцсан юм. . . .

“Тэр надад нэгэн харамсалт явдал тохиолдсон газрыг үзүүлэв. Англиас ирсэн залуу эр хэдэн сар зочид буудалд ажиллаж байв. Байнгын давтагддаг сэрэмжлүүлгийг үл хайхран тэрээр хашаа руу орж, гутлыг нь давахааргүй усыг туулан нэг юмыг шалгахаар явжээ.

“Тэр хоёр ч алхаж чадалгүй матарт бариулсан юм. Түүнийг аврах ямар ч арга бидэнд байгаагүй гэж хамгаалагч ярьсан юм” (“Spiritual Crocodiles,” *Ensign*, 1976 оны 5-р сар, 30–31).

Харагдахгүй байна гээд матар байдаг гэдэгт эргэлзэх нь ямар аюултай вэ? Ерөнхийлөгч Пакэр болон залуу эрийн туршлагауд нь 2 Нифай 28:22-т Нифайн дүрсэлсэнтэй юугаараа төстэй байна вэ?

Ерөнхийлөгч Пакэр ийнхүү тайлбарлажээ:

“Амьдралд түрүүлж хөл тавьсан хүмүүс нь усан цөөрмийн талаар бага зэрэг туршиж үзсэн бөгөөд матрын талаар сэрэмжлүүлгийн дуу хоолой өргөнө. Зөвхөн том саарал гүрвэл таныг хэдэн хэсэг болгон хазах биш, *сүнслэг матрууд* нь илүү аюултай, илүү хуурмаг, өөрсдийгөө сайн өнгөлөн далдалсан Африкийн хэвлээр явагчдаас ч илүү далдалсан байдаг.


“Эдгээр сүнслэг матрууд нь таны бодгалийг алж эсвэл бэртээж чадна. Тэд таны болон хайртай хүмүүсийн тань амар амгалан байдлыг устгаж

чадна. Сэрэмжлүүлэгдэх хэрэгтэй нь тэд бөгөөд өнөөгийн мөнх бус байдалд тэднээр дүүргэгдээгүй устай газар гэж тун ховор болсон байна (“Spiritual Crocodiles,” 31).

Дараах асуултын хариултыг доорх мөрүүд дээр бич: Африкийн матрууд ямар талаараа Сатаны уруу таталтууд болон арга мэхтэй төстэй вэ? _____

2 Нифай 28:20–21, 24–26-г уншаад, биднийг уст-гахаар эрэлхийлдэг Сатаны арга барилуудыг ол. (2 Нифай 28:21-г гардаг тайтгаруулах хэмээх үг нь намдаах, тайвшруулах, эсвэл сүнслэгээр унтуулах гэсэн утгатай болохыг мэдэх нь тустай байж болно.) Эдгээр шүлгүүдэд гарсны дагуу биднийг тайвшруулж, өөрийн хүч рүү удирдахын тулд Сатан ямар арга хэрэглэж байна вэ? _____

Эдгээр шүлгүүдэд заасан гол зарчим нь: **Сатан бидний дээр хүчийг олохын тулд уур хилэнд өдөөх, тайтгаруулж тайвшруулах, зусардах гэх мэт олон арга заль хэрэглэдэг.**

 **3.** Дараах асуултуудын аль нэгэнд судрын тэмдэглэлдээ хариулж бич:

- а.** Хувь хүн, гэр бүлүүд, хамт олныг төөрөгдүүлж, сүйрүүлэхийн тулд Сатан уур хилэнг хэрхэн ашигладаг вэ?
- б.** Сатан хүмүүсийг уурлуулахын тулд ямар сайн зүйлсээр тэднийг залилдаг вэ?
- в.** Зарим хүмүүс хэрхэн тайвширч, Сатаны аюулыг анзаараагүй талаар дор хаяж хоёр жишээ бичиж тайлбарла.




Биднийг урхидахдаа алгуурхан ашигладаг Сатаны арга мэхийн талаар ярьсан Тэргүүлэх Бишопын зөвлөх бишоп Ричард К.Эжлигийн дараах тайлбарыг унш: “Бид өсвөр насандаа зэрлэг овъёосны хэдхэн үр тарина эсвэл


нүглийн зах хавиар л явна даа гэж хэлж болохгүй. Нүглийн зах гэж байдаггүй. Сайн ч бай, муу ч бай үйлдэл бүр үр дагавартай байдаг. Сайн үйлдэл бүр сайн зүйл хийх чадварыг маань нэмэгдүүлж байдаг ба нүгэл, уналтын эсрэг бат бөх зогсдог. Сатан биднийг дараагийн удаа уруу татахад зөрчлүүд нь хэр зэрэг жижиг байхаас үл хамааран биднийг түүний нөлөөнд илүү өртөмтгий болгодог. Сатан биднийг том нүгэл, зөрчил үйлдэх хүртэл жижиг нүгэл хэмээн нэрлэх нүглийн үр дагавар руу ямх ямхаар мэхлэн аваачдаг. Нифай энэхүү аргыг Сатан биднийг ‘чөлөөлөгдөх нь үгүй өөрийн аймшигт гинжээр хүлж автлаа’ тайвшруулж, хуурдаг хэмээн тайлбарлажээ (2 Нифай 28:22; мөн 21-р шүлгийг


үзнэ үү)” (“That Thy Confidence Wax Strong,” *Ensign*, 1994 оны 11-р сар, 40).

Сатан биднээр буруу зүйлсийг бодуулах, хэлүүлэх, хийлгэх уран нарийн аргуудыг ашигладаг. 2 Нифай 28:27–29-ийг уншаад, нэмэлт сэрэмжлүүлгүүдийг ол.

Энэхүү бүлгийн төгсгөлд Их Эзэн бас нэгэн сэрэмжлүүлэг болон адислалыг өгсөн байдаг. 2 Нифай 28:30–32-ыг уншаад, дараах асуултуудын талаар эргэцүүлэн бод: Бурхан яагаад зарим хүмүүсийг адислагдсан гэж дууддаг вэ? Бурханы зөвлөгөөг сонсох нь чөтгөрийн арга мэхийг даван гарахад бидэнд хэрхэн туслах вэ?

 **4.** Энэхүү хичээлээс Сатаны арга мэхийг даван гарахад тань туслах ямар ямар зүйлсийг сурснаа судрын тэмдэглэлдээ бич. Та Сатаны нөлөөнд автахгүйн тулд ямар газар, үйл ажиллагаа болон зан байдлаас зайлсхийхийг хүсч байна вэ?

 **5.** Хичээлийн эхэнд сэрэмжлүүлгийн тэмдгүүдийн тухай ярилцаж байснаа сана. Таны бодлоор өнөө үед өсвөр үеийнхэн сэрэмжлэн болгоомжлох хэрэгтэй сүнслэг аюулыг харуулсан сэрэмжлүүлгийн тэмдгийг судрын тэмдэглэлдээ зур. Зурсан тэмдгээ багш болон ангийнхандаа хуваалцахад бэлд.

 **6.** Дараах өгүүлбэрийг судрын тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би 2 Нифай 28-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

8-Р ХЭСЭГ: 3 ДАХЬ ӨДӨР

2 Нифай 29–30

Оршил

Сайн мэдээний Сэргээлтгийн гайхамшигт ажлын талаарх Нифайн захиас 2 Нифай 29–30-д үргэлжилнэ. Их Эзэн Өөрийн хүүхдүүдийг санадаг гэдгийг бүх үндэстэн, ястан, хэлтэн хүмүүст харуулахын тулд эцсийн өдрүүдэд бүх судар хамтдаа ажиллах болно хэмээн тэрээр гэрчилжээ. Эдгээр цэдгүүд нь Есүс Христ бол бидний Аврагч гэдгийг гэрчлэх гэрч юм. Олон хүн Мормоны Номыг үгүйсгэх боловч итгэсэн хүмүүс нь Сүмд цуглах болно хэмээн Нифай бошиглов. Үүнээс гадна Бурханы гэрээт хүмүүс бол Бурханы Хүүд итгэж мөн наманчилдаг тэдгээр нь юм хэмээн Нифай заажээ.




2 Нифай 29:1–14

Эцсийн өдрүүдэд олон нь Мормоны Номыг эсэргүүцэх болно хэмээн Их Эзэн Нифайд хэлжээ.

Олон хүн хожмын өдрүүдэд Библи бол Бурханаас илчлэгдсэн цорын ганц судар хэмээн итгэж, Мормоны Номыг эсэргүүцэх болно гэдгийг Нифай харав. Хэрэв таны найз танаас “Мормончууд яагаад өөр нэг Библитэй юм бэ? гэж асуувал та юу гэж хариулах вэ?

Их Эзэний нэрлэснээр “гайхамшигт ажил” гэгдэх сайн мэдээний хожмын үеийн Сэргээлт дэх Мормоны Номын үүргийн талаарх Их Эзэний үгсийг бичиглэснээр Нифай энэхүү асуултад хариулсан юм (2 Нифай 29:1). 2 Нифай 29:1–2-ыг уншаад, эцсийн өдрүүдэд Их Эзэний үгс юу хийхийг тодорхойл. (Тэдгээр нь Нифайн үр удамд “шилжин ирэх” болно, мөн “дэлхийн өнцөг булан бүрд исгэрэх болно.”) “Исгэрэх” гэдэг нь цугларах дохио өгсөн “шүгэлдэх” гэсэн утгатай үг юм (Исаиа 5:26, зүүлт тайлбар 6-г үзнэ үү).

Далбаа хэмээх 2 Нифай 29:2-р шүлэгт гарч буй үг нь хүмүүсийг нэгтгэн цуглуулахад ашигладаг зүйлийг хэлж байна. Тугийг ихэвчлэн далбаа гэж хэлдэг. 2 Нифай 29:2-т хэлснээр, Их Эзэний хүмүүсийг цуглуулахын тулд “дэлхийн өнцөг булан бүрд” очих далбаа нь юу вэ? (Мормоны Ном—Нифайн үр удмын үгс гэх мэт үгсийг 2 Нифай 29:2-ын хажууд бичих хэрэгтэй.

 **1.** 2 Нифай 29:1–2-т хэлсний дагуу Мормоны Ном, бусад нэмэлт судраар хангах нь Их Эзэний зорилго болохыг судрын тэмдэглэлдээ бич.




Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Жэффри Р.Холланд Мормоны Номын талаар дараах зүйлсийг хуваалцжээ: “Мормоны Ном бол дэлхий дээрх хүүхдүүдээ хайрлах Бурханы хайр болон тэдэнтэй хийсэн Түүний гэрээний хамгийн шилдэг нотолгоо юм” (*Christ and the New Covenant: The Messianic Message of the Book of Mormon* [1997], 4).

2 Нифай 29-д дурдагдсан *Харийнхан* гэдэг үг нь Израилын угсааны бус хүмүүсийг илэрхийлдэг. Иудейчүүд гэдэг үг нь Израилын угсааг илэрхийлэх бөгөөд Лихайн гэр бүл болон тэдний үр удам үүнд багтана. 2 Нифай 29:3–6-г уншаад, нэмэлт судрын талаарх зарим харийнханы үзүүлэх үйлдлийг ол. Дараах асуултуудын хариултыг хоосон зайд бич.

Зарим хүмүүс нэмэлт сударт хэрхэн хандах вэ? _____

Иймэрхүү хандлага гаргах хүмүүсийн талаар Их Эзэн юу хэлсэн бэ? _____

Мормоны Номын талаарх хүмүүсийн хандлагыг тайлбарлахдаа Нифай бошиглож байсан. Өнөө үед хүмүүст Библи байгаа учраас тэд Мормоны Номын талаарх эргэлзээгээ байнга илэрхийлдэг. Нэмэлт судар өгөх Их Эзэний зорилгыг дүрсэлсэн 2 Нифай 29:7–11-р шүлэг дэх үг, хэллэгийг тодруул. Бурханаас нэмэлт илчлэлт хүлээж авахын үнэ цэнэ, хэрэгцээг ойлгодоггүй хэн нэгэнд эдгээр зорилгыг хэрхэн тайлбарлахаа бод.

 **2.** 2 Нифай 29:7–11-т тэмдэглэсэн зүйлсээ ашиглан энэ хичээлийн эхэнд дурдагдсан асуултад хариулж, судрын тэмдэглэлдээ бич: “Мормончууд яагаад өөр нэг Библитэй юм бэ?”

Их Эзэн судруудыг хоёр дахь гэрч болгон, хүмүүсийг гэрээндээ цуглуулахын тулд ашигладаг. 2 Нифай 29:13–14-ийг уншаад “Нифайчуудын үгс” (Мормоны Ном), “Иудейчүүдийн үгс” (Библи), “Израилын алдагдсан овгуудын үгс” болох судрууд хүмүүсийн дунд байх үед гарах үр дүнгийн адислалыг хайж ол.

2 Нифай 30:1–8

Нифай эцсийн өдрүүд дэх Мормоны Номын үүргийн талаар бошиглов

Бурхан Израилын угсааг санах болно хэмээн заасныхаа дараа Нифай, тэд харийнханаас илүү зөв шударга байсан гэж бүү бод хэмээн өөрийн хүмүүст анхааруулав. Мөн тэрээр бүх хүн Бурханы гэрээт хүмүүс болох боломжтой гэдгийг тэдэнд сануулжээ. 2 Нифай 30:2-ыг уншаад, Их Эзэн хүмүүстэй гэрээнд орохоос өмнө тэдний хийх ёстой хоёр зүйлийг дараах зайнд бич. _____

Танд болон таны ойр дотны хэн нэгэнд Мормоны Ном нөлөөлсөн талаар цаг гарган тунгаан бод. Дараа нь 2 Нифай 30:3–8-ыг уншаад, Мормоны Номыг хүлээж авдаг хүмүүст уг ном хэрхэн нөлөөлдгийг



тайлбарласан хэллэгүүдээр дараах үйл ажиллагааг гүйцээж хий.

Бүлэг хүмүүс	Мормоны Номын нөлөөлөл
Лихайн үр удам (2 Нифай 30:3–6)	
Иудейчүүд (2 Нифай 30:7)	
Харийнхан эсвэл бүх үндэстэн (2 Нифай 30:8)	

Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх, Ерөнхийлөгч Хэнри Б.Айрингийн дараах мэдэгдлийг уншаад, Мормоны Ном яагаад номлогчийн хүчирхэг хэрэгсэл болох шалтгаануудыг тодруул:



“Бошиглогч Иосеф сайн мэдээг сэргээснээс хойш Мормоны Ном нь номлолын ажлын төв нь байсаар ирсэн. Үүнийг бид өдөр бүр номлолын ажилд хэрэглэдэг. Мормоны Ном номлолын ажлын хэсэг бүрд хүч чадлын түлхүүр болж байгаагийн нэг нотолгоо нь энэ билээ:

Мормоны Ном бол Есүс Христийн гэрээ юм. Нүүр хуудсан дээр нь үүнийг бичсэн байдаг. Уг номын зорилго бол Өөрийн хүмүүсийн төлөө Их Эзэний хийсэн агуу зүйлсийг харуулах, тэдэнтэй хийсэн Түүний гэрээ хүчинтэй хэвээр гэдгийг мэдэхэд нь тэдэнд туслах бөгөөд бүх хүнд Есүс бол Христ гэдгийг ойлгуулах явдал юм” (“Why the Book of Mormon?” *New Era*, 2008 оны 5-р сар, 6, 8).

2 Нифай 30:1–8-ыг судлах нь **Мормоны Ном Есүс Христийг мэдэхэд, Түүний сайн мэдээний дагуу амьдрахад нь бүх хүмүүнд тусалдаг** гэдгийг бидэнд үзүүлдэг.



3. Дараах асуултуудаас нэгийг сонгоод, судрын тэмдэглэлдээ хариулж бич:

а. Аврагчийн талаар мэдэхэд Мормоны Ном танд хэрхэн тусалсан бэ?

б. Аврагчийн талаар мэдэхэд нь бусдад туслахын тулд та Мормоны Номыг хэрхэн ашиглах вэ?

2 Нифай 30: 9–18

Мянган жилийн туршид дэлхий ямар нөхцөл байдалтай байх талаар Нифай бошиглов

2 Нифай 30:9–10-ыг уншаад, Аврагчийн Хоёр дахь ирэлтийн дараа мянган жилийн зөв шударга, амар амгалан байдал буюу Есүс Христ “дэлхий дээр өөрийн биеэр хаанчлах” үеийн өмнө хүмүүсийн дунд юу тохиолдохыг ол (Итгэлийн тунхаг 1:10). Зөв шударгыг ёс бусаас салгах “агуу ялгалт”-ыг (2 Нифай 30:10) та харж байсан уу? Ёсон бусыг үйлдэгчдэд яваандаа юу тохиолдох вэ?

2 Нифай 30:12–18-ыг уншаад, мянган жилийн турш амьдрал ямархуу байхыг ол.



4. Судрын тэмдэглэлдээ мянган жилд болох нөхцөл байдлуудаас өөрийнхөө хамгийн их хүсэн хүлээж байгаа нөхцөлийг тайлбарлан сонингийн гарчиг бич (гол хэсэг, тоймыг цөөн хэдэн үгээр бич). Гарчиг бичсэнийхээ дараа, бичсэн гарчиг тань хэрхэн мянган жилийн турш дэлхий дээр ноёлох энх тайвны шинж тэмдэг болж байгааг тайлбарла.

Мянган жилийн турш Сатан хүмүүсийн зүрх сэтгэлд хүчийг олж чадахгүй бөгөөд зөв шударга, энх тайван ноёлох үед ямар байхыг эргэцүүлэн бод. Хэрвээ өнөөдөр эдгээр нөхцөл байдлууд ноёрхож байсан бол сургууль болон хамт олон тань хэр зэрэг өөр байх байсныг тунгаан бод.



5. Энэхүү энх тайван, амар амгалан, зөв шударга байдалд бэлтгэхэд өөртөө, гэр бүлдээ болон бусдад та юугаар тусалж чадах тухайгаа судрын тэмдэглэлдээ бич.

Тайлбар ба нөхцөл байдлын тухай мэдээлэл

Нэмэлт судрууд хэрхэн урагш авчрагдах вэ?



Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Брус Р.Макконки 2 Нифай 29:12–14-т яригдсан цэдгүүд нь “Бурханы хаант улсын түлхүүрүүдийг атгадаг, илчлэгч, орчуулагч, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн

ерөнхийлөгчийн удирдлагаар гайхамшигт аргаар ирнэ” хэмээн хэлжээ (*The Millennial Messiah* [1982], 217). Аврагч амилалтынхаа дараа Израилын алдагдсан овгуудын заримд нь айлчилсан бөгөөд мөн нифайчуудад айлчилж, Түүний амилалтын дараа тэдний дунд хийсэн тохинууллынх нь талаар тэд бас

бичиглэх болно гэдгийг бид мэднэ (3 Нифай 16:1–3; 17:4-ийг үзнэ үү).

Хэзээ “Иудейчүүд . . . Христэд итгэж эхлэх” вэ?

Ахлагч Брүс Р.Макконки түүнчлэн Иудейчүүдийн бошиглогдсон хөрвүүлгийн талаар ярих:

“Мөнхүү улиран тохиох дор бусниулагдсан тэдгээр Иудейчүүд түүнчлэн Христэд итгэж эхлэх болно; мөн тэд уг нутгийн гадаргуу дээр цуглаж эхлэх болно.” (2 Нифай 30:7.) Христийн эсрэг Иудейчүүдийн хуучин хорсол нь төгссөн бөгөөд одоо олон нь Түүнийг агуу Рабби (багш) хэмээн хүлээн зөвшөөрч байгаа боловч Бурханы Хүү гэж хүлээж авдаггүй. Цөөн хэд нь Ефраимын удам болон түүний дагалдагчдын хамт үнэн сүмд ирснээр Түүнийг бүрэн утгаар нь хүлээн зөвшөөрсөн.

“Гэвч үндэстнийхээ хувьд үнэнд эргэж ирэх Иудейчүүдийн агуу хөрвүүлэг Мессиагийн Хоёр дахь ирэлтийн дараа тохионо. Тэрхүү өдрийг уй гашууд тууштайгаар тэвчих тэд “Таны гар мөн хөл дээрх эдгээр шархнууд чинь юу вэ?” хэмээн асуух болно. Тэгээд Бибээр Их Эзэн гэдгийг тэд мэдэх болно; учир нь: Эдгээр шархнууд бол найз нарынхаа гэрт шархадсан тэрхүү шархнууд болой. Бибээр дээш өргөгдсөн тэрбээр болой. Би бол цовдлогдсон Есүс болой. Би бол Бурханы Хүү хэмээн би тэдэнд хэлэх болно.” (С ба Г 45:51–52; Зеха. 12:8–14; 13:6.)” (Mormon Doctrine, 2 дахь хэвлэл. [1966], 722–23).



6. Дараах өгүүлбэрийг судрын тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би 2 Нифай 29–30-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

8-Р ХЭСЭГ: 4 ДЭХ ӨДӨР

2 Нифай 31

Оршил

Нифай Христийн сургаалыг заав: Бид Есүс Христэд итгэх итгэлээ үйлдэл болгож, нүглүүдээ наманчилж, баптисм хүртэж, Ариун Сүнснийг хүлээн авч, эцсээ хүртэл тэвчих ёстой. Бид эдгээр сургаалыг дагавал Бурхан биднийг Ариун Сүнсний нөхөрлөлөөр адисалж, мөнхийн амьдрал руу удирдана хэмээн тэр гэрчилжээ.



2 Нифай 31:1–21

Аврагч бидэнд төгс жишээг үзүүлсэн хэмээн Нифай заав

Есүс баптисм хүртэхээр Иохан Баптист руу очжээ. Есүс ямар ч гэм нүгэл үйлдээгүй атлаа яагаад баптисм хүртсэн гэж та бодож байна? Та яагаад баптисм хүртсэн бэ? Эдгээр асуултуудын талаар тунгаан бодох нь энэхүү хичээлд бэлтгэхэд тань тус болно.

2 Нифай 31:2, 21-ийг уншаад, “Христийн сургаал” гэсэн хэллэгийг тэмдэглэ. 2-р шүлэгт Нифай өөрөө “Христийн сургаалын талаар ярих ёстой” хэмээн хэлснийг ажигла. Дараа нь 21-р шүлэгт тэрээр “Христийн сургаалын” талаар ярилаа хэмээсэн байдаг. 2 Нифай 31:3–20-д Нифайн нэрлэснээр “Христийн сургаал” гэгдэх үнэнүүдийн талаар бид суралцах болно. Бидний сурах хоёр үнэн: **Есүс Христ Эцэгийн бүх зарлигуудыг дуулгавартай дагаснаар бүх зөв шударгыг гүйцэлдүүлсэн, мөн бид баптисм хүртэж, Ариун Сүнснийг хүлээн авснаар Есүс Христийн дуулгавартай байдлын жишээг дагах ёстой.**



1. Судрын тэмдэглэлдээ дараах гарчгуудыг зэрэгцээ эгнээнд бич: *Есүсийн баптисм хүртсэн шалтгаанууд болон Бидний баптисм хүртэх шалтгаанууд.* Дараа нь 2 Нифай 31:4–12-ыг уншаад, эдгээр гарчгуудаас тус бүр юу сурснаа жагсаан бич.

2 Нифай 31:11-т хэлсний дагуу баптисмын өмнө юу байх ёстой вэ?

Баптисм нь яагаад усаар хийгдэх шаардлагатайг ойлгоход тань туслах Бошиглогч Иосеф Смитийн хэлсэн дараах үгсийг уншина уу: “Баптисм бол бид Бурханы тааллыг хэрэгжүүлж байгаагийн, хүмүүн Түүнд ирж аврагдах, Бурханы хаант улсад орох Бурханы тогтоосон өөр зам тэнгэрийн доор байхгүйг Бурханд тэнгэр элчүүдэд, түүнчлэн тэнгэрт харуулах тэмдэг мөн. Есүс Христэд итгэх итгэл, наманчлал, нүглээс ангижрахын төлөөх баптисмгүй бол бусад аливаа зам хий хоосон юм. Итгэл, наманчлал, баптисмын замыг дагасны ачаар Ариун Сүнсний бэлгийн амлалт та нарт байх болно” (*Сүмийн Ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит*[2007], 105-106).



2. Сүмийн гишүүн бус найз тань танаас баптисм яагаад тийм чухал юм бэ хэмээн асуусан гэж төсөөл. Түүний асуултад хэрхэн хариулахаа судрын тэмдэглэлдээ бич.



3. Баптисм хүртэж, Есүс Христийн жишээг дагах нь таны амьдралд хэрхэн нөлөөлж, мөн адисалж байгааг судрын тэмдэглэлдээ бич.

Баптисм хүртсэний дараа бидэнд хийх зүйл их байдаг. 2 Нифай 31:13-ийг уншаад, Аврагчийн жишээг дагахад байх ёстой хандлага, зан чанарыг тодорхойлсон хэллэгүүдийг тэмдэглэ.

2 Нифай 31:13-т хэлсний дагуу бид гэрээгээ бүх зүрх сэтгэлээрээ, үнэн санаатайгаар гүйцэлдүүлсний хариуд Тэнгэрлэг Эцэг маань бидэнд юу амладаг вэ? (Үүнийг судартаа тэмдэглэх хэрэгтэй.) 2 Нифай 31:17-гийн сүүлийн өгүүлбэрийг уншаад, бид яагаад Ариун Сүнсийг хүлээн авах хэрэгтэйг тодорхойл. Дараах зайнд Ариун Сүнс бидний төлөө юу хийдгийг тайлбарласан сударт үндэслэсэн сургаал эсвэл зарчмыг бич. _____

Металлын төрлийн материалуудыг ариутгахын тулд галыг ашигладаг. Гал нь бохир зүйлсийг шатааж гаргаад цэвэр материалыг цэвэршүүлдэг. Ариун Сүнсний бэлгийг хүлээж авахад бидний сүнслэг байдалд иймэрхүү зүйл тохиолддог юм. Үүнийг бас “галын баптисм” гэдэг. (2 Нифай 31:13-ыг үзнэ үү). **Ариун Сүнс нь Эцэг мөн Хүүг гэрчилдэг бөгөөд нүглүүдийн ангижралыг авчирдаг.** Тэргүүн Зөвлөлийн Ерөнхийлөгч Марион Ж.Ромни “Энэхүү галын болон Ариун Сүнсний баптисм нь . . . бодгалийг цэвэршүүлж, эдгээж мөн ариусгадаг”

хэмээн заажээ (*Learning for the Eternities*, comp. George J. Romney [1977], 133).

Христийн сургаалын өөр нэгэн хэсгийг олохын тулд 2 Нифай 31:15–16-г уншаад, олсон зүйлээ тодруулан тэмдэглэ. 2 Нифай 31:13-аас олсон хэллэгээ 2 Нифай 31:15–16-д өгөгдсөн заавартай холбож, та хэрхэн “үнэн санаатайгаар”, “бүх зүрх сэтгэлээрээ” эцсээ хүртэл тэвчиж чадах тухайгаа бод.



4. Судрын тэмдэглэлдээ дараах асуултаудад хариулж бич:

а. “Бүх зүрх сэтгэлээрээ”, “хоёр нүүр гаргахгүй”, “үнэн санаатайгаар” зэрэг хэллэгүүд нь өдөр бүр судар судлах, сүмийн цуглаанд оролцох зэрэг үйл ажиллагаануудад хэрхэн хамаарах вэ?

б. “Залбирлаа хэлдэг” болон “бүх зүрх сэтгэлээрээ” залбирдаг хүмүүсийн хоорондын ялгаа юу вэ?

в. “Ариун ёслолоос хүртдэг” болон ариун ёслолоос “үнэн санаатайгаар” хүртдэг хүмүүсийн хоорондын ялгаа юу вэ?

2 Нифай 31:18-ыг уншаад, бид наманчлал болон баптисмын хаалгаар орсны дараа хаана байгааг ол. Бид итгэлээ бодитой болгож, наманчлан, баптисм хүртэж, Ариун Сүнсний бэлэг хүлээж аваад “давчуу бөгөөд нарийн замд” ордог. *Давчуу* гэдэг нь нарийн, хатуу, хэцүү, гажилтгүй гэсэн утгатай. 2 Нифай 31:18-д хэлсний дагуу бид давчуу бөгөөд нарийн зам дээр байгаа эсэхээ яаж мэдэх вэ? _____

Ариун Сүнсний бэлгийг мэдэрнэ гэдэг нь бидний хааяа хааяа мэдэрдэг энгийн сайхан мэдрэмж биш юм. Ариун Сүнсний хамтрал бол биднийг мөнх амьдрал руу хөтөлдөг зам дээр байгааг гэрчилдэг Бурханы гэрч юм.



5. Судрын тэмдэглэлдээ дараах асуултаудад хариулж бич:

а. Давчуу бөгөөд нарийн зам дээр үлдэхэд тань Ариун Сүнсний хамтрал танд хэрхэн тусалсан бэ?


б. Өөр ямар замуудаар Ариун Сүнс таны амьдралыг адисалсан бэ?

2 Нифай 31:19–21-ийг уншаад, зам дээр үлдэхийн тулд бидний хийх ёстой бусад зүйлсийг судартаа дугаарлан, жагсаалт гарга. (2 Нифай 31:19–20 нь төгс эзэмших судар гэдгийг анхаар.)

Жагсаалтыг тэмдэглэх

Их Эзэн болон Түүний бошиглогчдын зааж байгаа зүйлсийг ойлгохын тулд судар дээрээ жагсаалтуудыг олоод тэмдэглэх хэрэгтэй. Зүйл бүрийг дугаарлах нь бичвэрт байгаа зүйлүүдийг амархан олж харахад тань туслах болно. Зүйл бүрийг дугаарлаж, жагсаалтад энгийн нэр өгөх нь тэдгээрийг нэг бүрчлэн харахад болон сурсан зүйлсээ эргүүлэн санахад тустай.

Дараа нь олоход хялбар болгож бусдаас өөрөөр тэмдэглэж болно.)

 **6.** “Христэд туштайгаар итгэн урагш тэмүүлэх” гэдэг нь таны хувьд ямар утгатай болохыг тайлбарласан нэг өгүүлбэр судрын тэмдэглэлдээ бич (2 Нифай 31:20).


Дараах зайд 2 Нифай 31:19–20-ийн зарчмыг товчлон бич:


Хэрвээ бид _____,
дараа нь бид _____.
(Үүнийг та судартаа бичих хэрэгтэй.)

Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Рассэлл М.Нэлсон өөрсдийгөө давчуу бөгөөд нарийн замаас хазайсан гэж бодож байгаа хүмүүст энэхүү итгэл найдвар төрүүлсэн зөвлөгөөг өгсөн юм: “Амьдралынхаа аялалд та олон саад бэрхшээлтэй тулгарч, зарим нэг алдаа гаргадаг. Судрын удирдамж нь алдаагаа ухаарч, шаардалагатай зүйлийг засахад тань тусалдаг. Та буруу чиглэлээр явахад болино. Та анхааралтайгаар судрын газрын зургийг судалж эхэлнэ. Тэгээд та ‘мөнх амьдралд хүргэдэг давчуу бөгөөд нарийн замд’ ороход шаардлагатай наманчлал, нөхөн төлөлт зэргийг хийдэг [2 Нифай 31:18]” (“Living by Scriptural Guidance,” *Ensign*, 2000 оны 11-р сар, 17).

Энэхүү хэлсэн үг болон өнөөдөр судалсан судрууд танд хэрхэн “найдварын гэрлийг” авчирсан талаар тунгаан бод (2 Нифай 31:20).

Төгс эзэмших судар—2 Нифай 31:19–20

 **7.** 2 Нифай 31:20-ийг цээжлэхэд таван минут зарцуул. Гэр бүлийн гишүүн юмуу найзаараа судрын мэдлэгээ шалгуул, эсвэл уг шүлгийг гараараа халхлаад, харахгүйгээр уншихыг хичээ. Цээжилснээ судрын тэмдэглэлдээ бичихийг оролдоод үз.

 **8.** 2 Нифай 31:20-ийг ашиглан, зөв зам дээр үлдэхийн тулд хийх ёстой зүйлсээс өөрийнхөө хамгийн сайн хийж байгаа нэг зүйлийг сонго. Үүнийг хэрхэн хийж байгаагаа судрын тэмдэглэлдээ тайлбарлан бич. Дараа нь сайжруулах хэрэгтэй нэг зүйлээ сонгоод, хэрхэн сайжруулах тухайгаа бич.

Тайлбар ба нөхцөл байдлын тухай мэдээлэл

Бид хоёр нүүр гаргахаас хэрхэн зайлсхийх вэ?

2 Нифай 31:13-р шүлэгт Нифай хоёр нүүр гаргахгүй байхыг сэрэмжлүүлсэн. *Хоёр нүүр гаргах* гэдэг нь жинхэнэ байдлаа үзүүлэхгүй, өөр дүрд тоглож, дүр эсгэхийг хэлдэг. Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Жозеф Б.Вертлин хоёр нүүр гаргахгүй байх талаар ярьсан юм.



“Бид үнэхээр сургаалын дагуу амьдарч байна уу, эсвэл зүгээр л эргэн тойрны маань хүмүүс биднийг итгэлтэй гэж бодож болохын тулд зөв шударга мэт дүр эсгэж байна уу? Үнэн хэрэгтээ бидний зүрх сэтгэл, нүднээс далд хийдэг үйлдлүүд маань Их Эзэний заасан зүйлсэд үнэнч биш байна уу?”

Бид ‘бурханлиг байдлын’ дүртэй боловч ‘түүний хүчийг’ үгүйсгэж байна уу [Иосеф Смит—Түүх 1:19-ийг үзнэ үү]?

Бид үнэхээр зөв шударга уу, эсвэл зөвхөн бусад хүн намайг харж байна гэж бодсон үедээ дуулгавартай мэт дүр үзүүлдэг [дүр эсгэдэг] үү?


“Их Эзэн харагдах байдлаар хууртахгүй хэмээн тодорхой хэлсэн бөгөөд Түүнд болон бусад худалч байж болохгүй хэмээн сануулсан. Бараан үнэнээ нуун шударга царай гаргасан хуурамч төрхтэй тэднээс болгоомжлохыг Тэр бидэнд сануулсан. Их Эзэн ‘гаднах төрхийг’ биш, ‘зүрх сэтгэлийг хардаг’ гэдгийг бид мэднэ [1 Самуел 16:7]” (“True to the Truth,” *Ensign*, 1997 оны 5-р сар, 15–16).

Бид яаж “эцсээ хүртэл тэвчих” вэ?

“Эцсээ хүртэл тэвчих” (2 Нифай 31:16) хэмээх хэллэгийг ихэвчлэн амьдралынхаа турш бэрхшээл зовлонг тэвчээртэйгээр даван туулахыг зөвлөхдөө ашигладаг. Ахлагч Жозеф Б.Вертлин эцсээ хүртэл тэвчих гэдгийг бас амьдралынхаа эцсийг хүртэл Христэд итгэлтэйгээр үргэлжлүүлэх гэсэн утгатай хэмээн тайлбарлажээ.

Эцсээ хүртэл тэвчих гэдэг нь итгэл, наманчлал, баптисм, Ариун Сүнсний бэлэг хүлээн авалтаар зам дээр гарч ирсний дараа мөнх амьдрал руу удирддаг зам дээр үргэлжлүүлэн явах сургаалыг хэлнэ. Эцсээ хүртэл тэвчих нь биднээс бүх зүрх сэтгэлээ зориулахыг шаарддаг. . . .

“Эцсээ хүртэл тэвчих гэдэг нь бид сайн мэдээний хөрсөн дээр амьдралаа баттайгаар суулгаад, сүмийн баримталдаг зарчмаар үргэлжлүүлэн, бусдаа даруухнаар үйлчилж, Христ шиг амьдарч, гэрээнүүдээ сахих гэсэн утгатай. Тэвчдэг тэд нь тогтвортой, туштай, даруу, байнга хөгжин дэвшдэг мөн заль мэхгүй байдаг. Тэдний гэрчлэл нь дэлхийн шалтгаанууд дээр биш үнэн, мэдлэг, туршлага болон Сүнсэнд тулгуурласан байдаг.” (“Press On,” *Ensign*, 2004 оны 11-р сар, 101).

 **9.** Дараах өгүүлбэрийг судрын тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би 2 Нифай 31-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

9-Р ХЭСЭГ: 1 ДЭХ ӨДӨР

2 Нифай 32

Оршил

Нифай “мөнх амьдралд хүргэдэг давчуу бөгөөд нарийн зам”-ын (2 Нифай 31:18) талаар заасныхаа дараа түүний хүмүүс тэрхүү зам дээр гарсныхаа дараа юу хийх талаар гайхашран байгааг харав. Тэрээр тэдний асуултад “Христийн үгэн дээр найрла”, “үргэлж залбир” хэмээн урамшуулан хариулав (2 Нифай 32:3, 9). Хэрэв тэд эдгээр зүйлийг хийх аваас Ариун Сүнс тэдэнд юу хийх хэрэгтэйг мэдүүлэх болно хэмээн тэр амлав.

2 Нифай 32:1–7

Нифай бидэнд Есүс Христийн үгсээр дамжуулан бурханлаг удирдамжийг эрэлхийлэхийг зөвлөдөг

Хэн нэгэн танд нэг газраас нөгөө газар руу очих зам зааж өгч байсан тухай бод. Тэрхүү зааврыг ойлгоход амархан байсан уу, хэцүү байсан уу? Бидэнд ойлгомжтой заавар өгдөг хэн нэгэн байх нь яагаад чухал вэ?

Өмнөх хичээлд та Нифайн өөрийн хүмүүст өгсөн зарим зааврын талаар суралцсан. Эдгээр зөвлөгөө өгснийхөө дараа “зам нь энэ” хэмээн тэрээр хэлжээ (2 Нифай 31:21). 2 Нифай 31:17–18-ыг түргэн судлаад, мөнх амьдрал руу хөтөлдөг замыг хэрхэн эхэлдэг талаар дахин үз. Дараа нь 2 Нифай 32:1-ийг уншаад, Нифайн заасан зүйлийн талаар хүмүүс дотроо ямар асуулттай байсныг ол. Хүмүүсийн асуултыг өөрийн үгээр тайлбарла: _____

2 Нифай 32:2–3-ыг уншаад, уг зам дээр гарсныхаа дараа Нифайн хэлснээр бид юу хийх ёстойг ол. Арванхоёр төлөөлөгчийн чуулгын Ерөнхийлөгч Бойд К.Пакэрын хэлсний дагуу тэнгэр элчийн хэлээр ярих гэдэг нь “та Ариун Сүнсний хүчээр ярина” гэсэн утгатай болохыг ойлгох нь тустай байж болох юм (“The Gift of the Holy Ghost: What Every Member Should Know,” *Ensign*, 2006 оны 8-р сар, 50).

Та 2 Нифай 32:3-т гардаг “Христийн үгэн дээр найрла” хэмээх хэллэгийг тэмдэглэх хэрэгтэй (энэ

шүлэг нь төгс эзэмших судар юм). Нифай Ариун Сүнсний нөлөөллөөр заасан зүйлсийг тайлбарлахдаа “Христийн үгс” гэсэн үгийг ашиглажээ. Та Ариун Сүнсний нөлөөллөөр заасан зүйлсийг уншиж, сонсож, хүлээн авч болох арга замууд эсвэл газруудыг жагсаан бич. _____

Христийн үгс гэдэгт судрууд болон өнөө үеийн бошиглогчдын үгс багтана. “Христийн үгэн дээр найрла” гэдэг нь ямар утгатай болох талаар тунгаан бодоход тань туслах дараах эшлэлүүдийг унш:



Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Рассэлл М.Нэлсон заахдаа: “Найрлах, зооглох гэдэг нь амсах гэдгээс илүү гэсэн утгатай. Зооглох гэдэг нь амтархан идэх, шимтэх гэсэн утгатай. Бид шинэ зүйлийг олж нээгээд түүндээ баясах хандлагаар, итгэлтэй дуулгавартай байдлаар судраас судалснаар шимтэж, амтархан суралцдаг. Бид Христийн үгэн дээр найрлах үед тэдгээр нь . . . бидний мөн чанарын салшгүй нэгэн хэсэг болдог” гэжээ (“Living by Scriptural Guidance,” *Ensign*, 2000 оны 11-р сар, 17).

Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Робэрт Д.Хэйлс ийн хэлжээ: “Хэрэв та бид Христийн үгэн дээр найрлах гэж байгаа бол судраас суралцаж, тэдгээрийн талаар тунгаан бодож, бодол санаа, үйлдэл бүрийнхээ нэг хэсэг болгон Түүний үгсийг шингээж авах ёстой” (“Healing Soul and Body,” *Ensign*, 1998 оны 11-р сар, 15).



1. Христийн үгэн дээр найрлах гэдэг нь таны бодлоор ямар утгатай болохыг өөрийн үгээр тайлбарлан судрын тэмдэглэлдээ бич.

Зооглох, зууш идэх болон өлсөх гэсэн үгсийн ялгааг тунгаан бод. Христийн үгсээс үр дүнгүй суралцахыг хэрхэн зууш идэх эсвэл бүр өлсөхтэй харьцуулж болохыг хэсэг зуур тунгаан бод.

2 Нифай 32:3-т хэлсний дагуу дараах зарчмуудыг нөхөж бич: **Бид Христийн үгэн дээр найрлах үед Христийн үг нь** _____



2. Христийн үгэн дээр найрлах нь амьдралдаа юу хийхээ мэдэхэд тань тусалсан үе, эсвэл одоо тохиолдож байгаа нөхцөл байдалд тань Христийн үгэн дээр найрлах нь тус болж болох талаар судрын тэмдэглэлдээ бич.

Дараах хоосон зайнд та Христийн үгсээс хэр сайн зооглож байгаа болон хэрхэн сайжрахаа дүгнэ. Дараах жишээ бүрд *зооглох, зууш идэх* эсвэл *өлсөх* гэсэн үгсээс Христийн үгийг хэр сайн эрэлхийлдгийг тань хамгийн сайн дүрслэх үгийг сонгож бич.

Жишээлбэл, та хувийн сургалтаараа судраас *зоог-лодог*, харин ерөнхий чуулганаар Христийн үгсээс *зууш идэж* байгаа мэт суралцдаг байж болно.

Хувийн судрын сургалт: _____

Ариун ёслолын цуглаан: _____

Ерөнхий чуулган: _____

Гэр бүлийн судрын сургалт: _____

Семинар: _____

Гэр бүлийн үдэш: _____

Аароны санваарын чуулгын цуглаан эсвэл Залуу эмэгтэйчүүдийн анги: _____

Ням гаргийн анги: _____

Хувийн залбирал: _____

Амьдралаа үнэлэх нь:

Тодорхой зарчмын дагуу хэр сайн амьдарч байгаагаа өөрсдөдөө цаг гарган шударгаар дүгнэх үедээ бид юуг сайн хийж, юугаа сайжруулах хэрэгтэй гэдгийг ухаарахад маань туслах боломжийг Ариун Сүнсэнд олгодог. Өөртөө дүгнэлт хийхдээ Ариун Сүнсний удирдамжийг эрэлхийлэхийг хичээж, шударга бай.



3. Та “зууш идэх” эсвэл “өлсөх” гэж бичсэн үйл ажиллагаанаасаа нэгийг нь сонго. Тэр үйл ажиллагаанд Христийн үгэн дээр хэрхэн илүү сайн найрлахаа судрын тэмдэглэлдээ бич. Дараа нь үүнийгээ дага мөн хий.

2 Нифай 32:4–7-г уншаад, дараах асуултуудын хариултыг тунгаан бод (4-р даалгаварт нэг асуултын хариултыг бичих болно):

- 4-р шүлэгт гарсан “асуух” эсвэл “тогших” гэдэг үгс нь таны бодлоор ямар утгатай вэ? Залбирах нь хэрхэн асуух эсвэл тогшихын сайн жишээ байж болох вэ?
- Түүнчлэн 4-р шүлэгт асууж мөн тогшдоггүй хүмүүст ирэх үр дагавар нь юу байх болно гэж Нифай хэлсэн бэ?
- 5-р шүлэгт, бид Ариун Сүнсийг хүлээж аваад ямар адислалуудыг авах боломжтой гэж Нифай амласан бэ?
- 7-р шүлэгт, Нифайн хүмүүсийн ямар зан чанар, хандлага нь Нифайг гашуудахад хүргэсэн бэ? Яагаад эдгээр зан чанар, хандлага нь “агуу мэдлэгийг” ойлгох мөн эрэлхийлэхэд нь хүмүүст саад болж байна вэ?



4. 2 Нифай 32:4-өөс сурсан нэгэн үнэнийг судрын тэмдэглэлдээ бичиж, энэхүү үнэн нь яагаад таны амьдралд чухал болохыг тайлбарла.

Төгс эзэмших судар—2 Нифай 32:3



5. Хэрвээ та хоол идэх бүрдээ давтал 2 Нифай 32:3-ыг цээжлэхэд хэр хугацаа зарцуулна гэж бодож байна? Шүлгийг жижиг цаасан дээр бичээд, биедээ авч яв. Дараагийн хэдэн өдөр, хоол идэхийн өмнө ба дараа 2 Нифай 32:3-ыг цээжлэхийг хичээн Христийн үгэн дээр найрла. Уг судрыг цээжлэх хүртэл хэдэн удаа хоол идсэнээ судрын тэмдэглэлдээ бич.

2 Нифай 32:8–9

Нифай бидэнд үргэлж залбирахыг зөвлөв

Олон хүн нүгэл үйлдсэнийхээ дараа Тэнгэрлэг Эцэгт хандан залбирмааргүй байна гэж хэлдэг. Яагаад тэгдэг талаар бодож үз. Ялангуяа нүгэл үйлдсэний дараа хэн таныг хэзээ ч битгий залбираасай гэж хүсдэг вэ? Яагаад? 2 Нифай 32:8-д залбирлын талаар Ариун Сүнс бидэнд юу хийх хэрэгтэй гэж заасныг ол. Дараах асуултуудыг тунгаан бод: Их Эзэн яагаад таныг залбираасай хэмээн хүсдэг гэж та бодож байна? Сатан яагаад таныг битгий залбираасай хэмээн хүсдэг гэж та бодож байна?


2 Нифай 32:9-ийг уншаад, бид хэр ойр ойрхон залбирах хэрэгтэй, залбирвал Их Эзэн бидэнд ямар адислалуудыг амладаг болохыг ол. Энэхүү шүлгийг уншихад *ариулах* гэдэг нь Бурханы үйлчлэлд зориулах эсвэл ариун болгох гэсэн утгатайг мэдэх нь танд тус болж болох юм.

2 Нифай 32:9-өөс бид дараах зарчмыг сурдаг: **Бид үргэлж залбирах аваас бодгалийнхаа зол жаргалын тулд Их Эзэний биднээр үйлдүүлэх бүхий л зүйлийг үйлдэх боломжтой байх болно.** 2 Нифай 32:8–9 нь төгс эзэмших судар гэдгийг анхаар. Дараа нь олоход хялбар болгож бусдаас өөрөөр тэмдэглэх хэрэгтэй.)

Үргэлж залбирах гэдэг нь ямар утгатай болохыг тунгаан бод. Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Дэвид А.Бэднарын хэлсэн дараах үгсийг уншихдаа “үргэлж залбир” хэмээх зарлигийг бид гүйцэлдүүлж болох нэг юмуу түүнээс дээш арга замын доогуур зур.



“Тэнгэрлэг Эцэгтэй зөвлөлдөх бидний өглөөний залбиралд зан төлөв, биеэ авч явах байдал, эсвээс бидний сүнслэг байдлын өсөлттэй холбоотой зөвлөгөө авах зүйлүүд байж болно. Бид хүлээн авсан адислалуудынхаа төлөө зохих ёсоор талархал илэрхийлсний дараа өөрсдийнхөө хүчээр хийж чадахгүй байгаа зүйлсээ хийхэд ухаарал, чиглэл, тусламж гуйдаг. . . .



“Тусламж, удирдамж байнга авч байхын төлөө бид залбирлаа өдрийн турш тээж явдаг билээ. . . .

“Хатуу үг хэлмээр байсан ч хэлээ хазаад өнгөрсөн, уурлаж уцаарламаар санагдсан ч биеэ бариад өнгөрөх тийм өдрүүд бидэнд байдаг. Бид тэнгэрлэг тусламж, хүч чадлыг ойлгон, залбирлынхаа хариуг даруухнаар танин мэддэг. Бид ойлголт ухаарлын энэхүү агшинд талархлын залбирлыг чимээгүй өргөдөг билээ.

“Орой болоход бид дахин өвдөг сөгдөж Эцэгтээ эргэн тайлагнадаг. Бид тухайн өдөр болж өнгөрсөн үйл явдлуудыг нэгтгэн дүгнэж, хүлээн авсан адислалууд болон тусламжийн төлөө зүрх сэтгэлийнхээ талархлыг өргөдөг билээ. Бид наманчилж, Их Эзэний тусламжтайгаар маргааш нь илүү сайнаар үйлдэх арга замуудыг мэддэг. Тийнхүү бидний оройн залбирал маань өглөөний залбирал дээр тулгуурлагдан үргэлжилдэг. Үүний хамт бидний оройн залбирал маргааш өглөөний утга учиртай залбирлын бэлтгэл болдог юм.

“Өглөө оройн залбирал, тэрчлэн эдгээрийн хоорондох бүх залбирал нь хоорондоо холбоогүй, салангид тусдаа үйл явдлууд биш, харин өдрийн турш, долоон хоног, сарын турш, тэр ч байтугай олон жилийн турш хоорондоо нягт холбоотой байдаг юм. Энэ


бол ‘үргэлж залбир’ хэмээсэн судрын анхааруулгыг бид хэрхэн биелүүлдгийн жишээ юм. (Лук 21:36; 3 Нифай 18:15, 18; С ба Г 31:12). Ийм утга учиртай залбирал нь Бурхан Өөрийн итгэлтэй хүүхдүүдэд зориулж нөөцөлсөн хамгийн дээд адислалуудад хүрэх зэмсэг юм. (“Үргэлж залбир,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2008 оны 11-р сар, 41–42).




6. Ахлагч Бэднарын хэрхэн “үргэлж залбирах” тухай зөвлөгөөг дагах нь амьдралд тань хэрхэн тус болох талаар судрын тэмдэглэлдээ бич.

Энэхүү хичээлийг төгсгөхдөө далын гишүүнээр үйлчилж байсан ахлагч Спэнсэр Ж.Кондигийн Христийн үгэн дээр найрлах тухай дараах гэрчлэлийг унш: “Та номлол, ирээдүйн мэргэжил, цаашлаад гэрлэлтийн талаар шийдвэр гаргах хэрэгтэй байгаа байж болох юм. Судраас уншиж, заавар зөвлөгөө эрэлхийлэн залбирахдаа та цаасан дээр хэвлэсэн хариултыг харахгүй байж болно, харин та уншвал онцгой сэтгэгдэл, мэдрэмж хүлээж авах ба амлагдсаны дагуу Ариун Сүнс ‘та нарын хийвэл зохих тэр бүхнийг та нарт үзүүлэх болно’ [2 Нифай 32:5]” (“Becoming a Great Benefit to Our Fellow Beings,” *Ensign*, 2002 оны 5-р сар, 45).

📖 Төгс эзэмших судар—2 Нифай 32:8–9

 **7.** Одооноос эхлэн 24 цагийн турш “үргэлж залбирах” тухай сурсан зүйлсээ амьдралдаа хэрэгжүүлэхийг хичээ. Дараагийн хичээлийн эхэнд энэхүү туршлагынхаа талаар бодол санаа болон мэдрэмжээ хуваалцахад таныг урих болно. “Үргэлж залбирах”-ыг хичээх нь залбирлыг тань хэрхэн өөрчилж болдгийг судрын тэмдэглэлдээ бич.

 **8.** Дараах өгүүлбэрийг судрын тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би 2 Нифай 32-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.


Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

9-Р ХЭСЭГ: 2 ДАХЬ ӨДӨР

2 Нифай 33

Оршил

Нифайн цэдгээ дуусгахдаа бичсэн үгс нь Есүс Христийг гэрчилдэг бөгөөд хүмүүст сайн зүйл хийж, эцсээ хүртэл тэвчихийг уриалан тунхаглажээ. Тэр “сул дорой” байдалдаа бичсэн хэдий ч түүний захиас “агуу чухал зүйл” бөгөөд уншсан хүмүүс “хүчтэй болгогдох” болно хэмээн тэрээр хэлжээ. (2 Нифай 33:3–4-ийг үзнэ үү). Тэрээр бичсэн зүйлс нь “Христийн үгс” бөгөөд хүмүүс үүнд хэрхэн хандсанаараа Бурханы өмнө хариуцлага хүлээнэ хэмээн гэрчилжээ (2 Нифай 33:10–15-ыг үзнэ үү).

 **1.** Өмнөх хичээл дээр таныг 24 цагийн турш “үргэлж залбирахыг” хичээхэд урьсан. Туршлагынхаа талаар бодол санаа, мэдрэмжээ судрын тэмдэглэлдээ бич.

2 Нифай 33:1–15

Нифай бичсэн зорилгоо тайлбарлав

Ариун Сүнс таны зүрх сэтгэлд захиас авчрахыг хүсэх шалтгаануудын талаар хэсэг зуур бод.

Хүний зүрх сэтгэлд захиас *хүрэх* болон хүний зүрх сэтгэлд захиас *орох* хоёрын ялгаа нь юу вэ?

Хүрэх



2 Нифай 33:1-ийг уншаад, Ариун Сүнс бидэнд захиасыг авчрах талаар Нифай дүрслэхдээ *хүрэх*,



орох гэсэн үгсийн алийг нь ашигласныг ол. Олсон зүйлээ тэмдэглэх хэрэгтэй.

Таны бодлоор Ариун Сүнс үнэнийг бидний зүрх сэтгэлд *оруулах* бус харин зүрх сэтгэлд *хүргэдэг* нь яагаад чухал вэ? _____

2 Нифай 33:1-ийн талаар Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Дэвид А.Бэднар дараах үгсийг хэлжээ: “Сүнсний хүч захиасыг зүрх сэтгэлд *оруулах* биш, харин *хүргэдэг* болохыг анзаараарай. Багш агуу их сүнслэг хүч хийгээд хичээл зүтгэлээр тайлбарлаж, баталж, ухуулж мөн үйлдэж чадна. Гэхдээ эцсийн эцэст зөвхөн хүлээн авах хүн захиасын утга учир болон Ариун Сүнсний гэрчлэлийг зүрх сэтгэлдээ оруулахыг зөвшөөрсөн тохиолдолд л энэ нь нэвтрэн ордог. Итгэлээр суралцах нь зүрх сэтгэлд *орох* замыг нээдэг” (“Seek Learning by Faith,” *Ensign*, 2007 оны 9-р сар, 61).




Далын гишүүнээр үйлчилж байсан ахлагч Жэралд Н.Ланд Ариун Сүнс яагаад үгийг бидний зүрх сэтгэлд *оруулах* бус, *хүргэдэг* болохыг тайлбарлажээ: “Яагаад зөвхөн зүрх сэтгэлд


хүргэдэг гэж? Хувь хүний сонгох эрх бол маш ариун юм. Иймээс Тэнгэрлэг Эцэг хэдийгээр хязгааргүй хүчтэй ч гэсэн хүмүүний зүрх сэтгэлийг хэзээ ч албадахгүй. Хүн ингэхийг оролдож болох ч Бурхан хэзээ ч тэгэхгүй. Өөрөөр хэлбэл зүрх сэтгэлийнхээ харуул, манаач байх боломжийг Бурхан бидэнд олгодог. Бурхан биднийг албадахгүй учраас бид чөлөөт хүслээрээ зүрх сэтгэлээ Сүнсэнд нээж өгөх ёстой” (“Opening Our Hearts,” *Ensign* буюу *Лиахона*, 2008 оны 5-р сар, 33).

Хүмүүс Сүнсэнд зүрх сэтгэлээ нээхийн тулд юу хийх хэрэгтэй гэж та бодож байна вэ? _____

2 Нифай 33:2-ыг уншаад, хүмүүс зүрх сэтгэлээ хатууруулахыг сонгох үед юу болдгийг тодорхойл. “Хоосон зүйлүүд” гэдэг нь “үнэ цэнэгүй” гэсэн утгатай үг болохыг мэдэх нь тустай байж болно.

 **2.** Таны бодлоор зүрх сэтгэл нь нээлтэй хүн хувийн сургалт, гэрээр судлах семинар болон ариун ёслолын үеэр ямар зан төлөв, хандлага гаргахыг судрын тэмдэглэлдээ бич.

2 Нифай 33:1–2 бидэнд энэхүү зарчмыг заасан: **Бид зүрх сэтгэлээ нээх үед Ариун Сүнсээр ирдэг захиас бидний зүрх сэтгэлд орж чаддаг.** Энэ зарчмыг судартаа тэмдэглэх хэрэгтэй.

 **3.** Судрын тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

а. Сайн мэдээний захиас таны зүрх сэтгэлд нэвтрэн орохыг та хэзээ мэдэрсэн бэ? Ямар тохиолдолд, ямар үр дүнтэй байсан бэ?

б. Энэ нь тухайн үе дэх таны зүрх сэтгэлийн талаар юу хэлж байна вэ?

2 Нифай 33:3–7-г уншаад, үгсийг нь унших хүмүүсийн төлөөх Нифайн итгэл найдварыг ол. Дараа нь өөрийн эсвэл Нифайн үгсийг ашиглан дараах өгүүлбэрийг гүйцээж бич. Зарим өгүүлбэр нь нэгээс олон хариулттай байж болохыг анхаараарай:

2 Нифай 33:3—Би . . . төлөө үргэлжлүүлэн залбирна . . .


2 Нифай 33:4—Би . . . гэдгийг мэднэ _____

2 Нифай 33:6—Би . . .-г бахаднам _____


2 Нифай 33:7—Би . . .-г агуулна _____

Та 2 Нифай 33-ыг судалж дуусахдаа эдгээр шүлгүүд нь сударт бичигдсэн Нифайн сүүлчийн гэрчлэл

гэдгийг санаарай. 2 Нифай 33:10–14-ийг уншаад, эдгээр үгсийг Нифайгаас өөрөөс нь сонсож байна гэж төсөөл. Таны хувьд утга учиртай хэллэгүүдийн доогуур зурж болно.

 **4.** 2 Нифай 33:10–14-р шүлгүүдээс өөртөө утга учир бүхий санагдсан зарим хэллэгийг судрын тэмдэглэлдээ бичээд, яагаад гэдгийг тайлбарла. Мөн дараах асуултад хариулж, судрын тэмдэглэлдээ бич: Хүмүүс Христэд итгэдэг бол Мормоны Номын талаар юу гэж бодох вэ? (2 Нифай 33:10-ыг үзнэ үү.)

2 Нифай 33:15-ыг уншаад, “би дагах ёстой” хэмээх Нифайн сүүлчийн үгсийн талаар тунгаан бод. “1 Нифай 3:7”-г судартаа 2 Нифай 33:15-ын хажууд холбогдох эшлэл болгон бичих хэрэгтэй. 1 Нифай 3:7-г дахин уншаад, энэ хоёр судар хэрхэн холбогдож байгааг тодорхойл.

 **5.** 1 болон 2 Нифайг дахин тоймлон үзэхдээ Нифайн дуулгавартай байдлын жишээг тодорхойл. Олсон жишээнийхээ заримыг судрын тэмдэглэлдээ бич. Түүнчлэн өөрийнхөө хамгийн дуртай, эсвэл Нифайн хэлснээр танд сайн зүйл хийхийг, илүү сайн байхыг эсвэл Аврагчид итгэхийг урамшуулсан утга учир бүхий шүлгийг ол (2 Нифай 33:1-ийг үзнэ үү). Энэ шүлгээ судрын тэмдэглэлдээ бич.

Нифайн үгсийг эсэргүүцэж болох хүмүүст зориулсан түүний сүүлчийн гэрчлэл болон сэрэмжлүүлэг нь Мормоны Номд хэрхэн хандах бидний хариуцлагыг нэмэгдүүлдэг. Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит, сүмийн гишүүдийн хувьд бид Мормоны Номоос судлах үүрэгтэй хэмээн заажээ.

“ . . . Энэ Сүмийн аль ч гишүүн Мормоны Номыг олон дахин уншиж, тал бүрээс нь тунгаан бодож, энэ ном бол үнэхээр Бүхнийг Чадагчийн Сүнсний нөлөөгөөр бичигдсэн цэдэг бөгөөд үүний түүх нь үнэн гэдгийг гэрчлэх хүртлээ хэзээ ч санаа нь амардаггүй юм шиг надад санагддаг.” . . .


“ . . . Мормоны Номыг анхааралтайгаар, нухацтайгаар уншаагүй сүмийн ямар ч гишүүн Бурханы оршихуйд сайшаагдан зогсож чадахгүй” (in Conference Report, 1961 оны 10-р сар, 18).

Нифайн үгс болон Мормоны Номд хэрхэн хандахаа шийдэх боломж танд байгаа.

Холбогдох эшлэлүүдийг ашиглах нь

Холбогдох эшлэл гэдэг нь таны судалж байгаа сэдвийн дагуу нэмэлт мэдээлэл, ойлголт өгдөг судрын эшлэл юм. Судалж байх явцдаа судрын өөр шүлэг эсвэл сэдвийг ойлгоход тань тус болох шүлгийг олоод судартаа холбогдох эшлэл болгон бичих нь танд их тустай байх болно.




 **6.** Мормоны Номоос судлах хичээл зүтгэлээ үнэлж, сургалтаа сайжруулах нэг арга замыг судрын тэмдэглэлдээ бич.



Энэхүү хичээлийг дуусгахдаа Мормоны Номыг хичээнгүйлэн судалдаг бүхий л хүмүүст Ерөнхийлөгч Гордон Б.Хинклигийн өгсөн амлалтыг унш: “Та нар Мормоны Номыг өмнө нь хэдэн удаа уншсанаас үл хамааран Их Эзэний Сүнсний нэмэлт хувь, Түүний зарлигуудад дуулгавартай алхах хүчирхэг шийдвэр болон Бурханы Хүүгийн амьдралын үнэн мөний талаарх илүү

хүчирхэг гэрчлэл та бүхний амьдрал болон гэрт ирэх болно” (“A Testimony Vibrant and True,” *Ensign*, 2005 оны 8-р сар, 6).

 **7.** Дараах өгүүлбэрийг судрын тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би 2 Нифай 33-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

Иаковын

ОРШИЛ

Яагаад энэ номыг судлах хэрэгтэй вэ?

Иаковын номыг судалснаар Есүс Христэд итгэх итгэл нь гуйвшгүй нэгэн хүний чухал сургамжуудыг бид суралцах болно. Иаков Аврагчийг удаа дараа гэрчилсэн ба өөрийн хүмүүс болон түүний үгсийг унших тэдгээр хүмүүсийг наманчлалд урьсан юм. Тэр Их Эзэний дуудлагуудыг хичээнгүйлэн, бүрэн биелүүлэхийн ач холбогдлыг зааж мөн биечлэн үзүүлжээ. Тэрээр өөрийн хүмүүст бардамнал, эд баялаг, ёс суртахуунгүй явдлаас зайлсхийхийг анхааруулсан. Түүнчлэн Иаков Бурханы бүх хүүхдэд авралыг авчрах Аврагчийн цуцашгүй хичээл зүтгэлийн талаарх Зиносын чидуны модны ёгтлолыг эш татан тайлбарлажээ. Христийг эсэргүүцэгч Шеримтэй нүүр тулан маргахдаа Иаков бидний итгэлд эргэлзэж, шүүмжилдэг хүмүүст хэрхэн зөв шударгаар хариулахыг үзүүлсэн юм.

Энэ номыг хэн бичсэн бэ?

Сариа, Лихай нарын тав дахь хүү Иаков энэ номыг бичсэн. Амлагдсан газар руу хийсэн түүний гэр бүлийн аяны үеэр аглаг буйдад тэр төрсөн ажээ. Өсвөр насандаа Иаков “ах нарынхаа балмадын учир их харамсал мөн зовлонг үзсэн билээ” (2 Нифай 2:1). Гэсэн хэдий ч Лихай, Иаковт Бурхан “зовлонгуудыг чинь чиний өсөлт хөгжлийн тул ариулан адисалж” мөн тэрээр өөрийн өдрүүдийг “өөрийн Бурханд үйлчлэхэд” зориулах (2 Нифай 2:2–3) болно гэдгийг түүнд амласан байдаг. Өсвөр насандаа Иаков Аврагчийн алдар сууг үзсэн (2 Нифай 2:3–4-ийг үзнэ үү). Нифай Иаковыг нифайчуудын прист болон багш байхаар томилон адисалж (2 Нифай 5:26), хожим нь Нифайн жижиг ялтсыг итгэн гардуулсан юм (Иаков 1:1–4-ийг үзнэ үү). Итгэлтэй санваарын удирдагч, багшийн хувьд Иаков (Иаков 1:7-г үзнэ үү) Христэд итгэхийг өөрийн хүмүүст ухуулахын тулд шаргуу хөдөлмөрлөсөн. Тэр Аврагчийн талаар илчлэлтийг хүлээн авч, тэнгэр элчүүдийн тохинууллыг үзэж, Их Эзэний дуу хоолойг сонсож (Иаков 7:5), мөн өөрийн Гэтэлгэгчийг харсан билээ. (2 Нифай 11:2–3-ыг үзнэ үү). Нас барахынх нь өмнө итгэл хүлээн ялтсуудыг гардаж авсан Иносын эцэг нь Иаков байсан юм.

Энэ ном хаана, хэзээ бичигдсэн бэ?

Иаковын ном ойролцоогоор мээ 544 оноос буюу Нифай Иаковт жижиг ялтсуудыг итгэмжлэн өгсөн

үеэс эхэлдэг бөгөөд энэ нь өөрийн хүү Иност ялтсуудыг гардуулан өгч, Иаковын нас барах үе хүртэл үргэлжлэн дуусдаг. Иаков энэ цэдгийг Нифайн нутагт амьдарч байхдаа бичсэн.

9-Р ХЭСЭГ: 3 ДАХЬ ӨДӨР

Иаков 1–2

Оршил

Нифайг нас барсны дараа нифайчууд шинэ хааны хаанчлал дор “ёсон бус дадлуудад өөрсдийгөө өөгшүүлж эхэлсэн” (Иаков 1:15). Иаков, Иосеф хэмээх хоёр дүүгээ хүмүүсийн прист болон багш байхаар Нифай томилсон бөгөөд тэд наманчилж, Христэд ирэхийг хүмүүст уриалан, хичээнгүйлэн хөдөлмөрлөж байв. Нандин сургаалууд, илчлэлтүүд болон бошиглолуудыг жижиг ялтсан дээр цэдэглэ хэмээх Нифайн тушаалыг Иаков дуулгавартайгаар биелүүлсэн. Иаков тэнгэрлэгээр өгөгдсөн үүрэг хариуцлагадаа үнэнч байж, өөрийн хүмүүсийг наманчлалд дуудаж, тэдэнд бардамнах нүгэл, эд баялагт татагдан шунах, садар самуун байдлын талаар сэрэмжлүүлэв. Тэрээр энэхүү гурван өргөн дэлгэрсэн нүглийн аюул болоод үр дагавруудын талаар заажээ.

Иаков 1:1–2:11



Иаков хүмүүст тэдний ёс бус явдлыг сануулдаг

Та дараах нөхцөл байдалд юу хэлэх тухайгаа эргэцүүлэн бод: Сүм дээр нэг найз тань санваарын удирдагчдынхаа талаар сөрөг үзэл бодлоо илэрхийлэн “Тэд жинхэнэ ертөнцтэй холбоогүй байдаг юм шиг ээ. Тэд тийм ч сүртэй биш сонголтуудын талаар

сэрэмжлүүлсээр л байх юм. Зайлсхийх хэрэгтэй бүхий л муу зүйлсийн талаар бидэнд хэлж хамаг цагаа барахаа болиосой гэж би хүсч байна. Тэд эерэг зүйлсийн талаар ярих хэрэгтэй” хэмээн хэлжээ.

Санваарын удирдагчид заримдаа яагаад нүглийн эсрэг сэрэмжлүүлэг өгдөг талаар бод. Нифайн үхлийн дараа (Иаков 1:9-ийг үзнэ үү) хүмүүс ёс бус дадлуудад анхаарлаа хандуулж эхэлсэн тухай Иаков цэдэглэв. Иаков 1:15–16-г уншаад, Иаковын санааг зовоосон юуг хүмүүс хийж байсныг тодорхойл.

Иаков 1:15–16-д гардаг эхэлсэн гэдэг үгийг дугуйлах хэрэгтэй. Асуудал гарах үед эсвэл бүр гарахаас нь өмнө бидэнд сэрэмжлүүлж байдаг санваарын удирдагчидтай байх нь яагаад адислал болдог вэ? _____

Иаков 1:6–8-ыг уншаад, Иаков болон түүний хамтран удирдагчид *яагаад* Нифайн хүмүүст нүглийн эсрэг зөвлөж байсныг тодорхойл. Гэр бүл дэх мөн харьяа болон ерөнхий санваарын удирдагчид тань яагаад нүглээс сэрэмжлүүлж, сайн мэдээг танд хичээнгүйлэн заадаг гэж та бодож байна вэ? Дараах үнэний тухай Иаков 1:7-д заадаг өгүүлбэрийг тэмдэглэх хэрэгтэй: **Санваарын удирдагчид Христэд ирэхэд бидэнд туслахын тулд хичээнгүйлэн ажилладаг.**


Иаков 1:17–19-ийг уншаад, яагаад Иаков болон түүний дүү Иосеф хоёр хүмүүст заахын тулд хичээнгүйлэн ажиллаж байсан нэмэлт шалтгаануудыг ол.

“Их Эзэнээс үүрэг даалгавар” авах гэдэг нь ямар утгатай гэж та бодож байна (Иаков 1:17)? _____

Дараах зарчмыг заахад тус болох өөр хэллэгүүдийг тэмдэглэх хэрэгтэй: **Санваарын удирдагчдад Бурханы үгийг заах, нүглийн эсрэг сэрэмжлүүлэх тэнгэрлэг үүрэг хариуцлага өгөгдсөн байдаг.**

Их Эзэний биднийг мэдээсэй хэмээн хүсдэг зүйлсийг заах гэж хичээн зүтгэх үүрэг хариуцлага нь сүмийн удирдагчдад өгөгдсөн гэдгийг ойлгох нь яагаад чухал болохыг хэсэг зуур тунгаан бод.

Иаков 2:1–3, 6–7, 10–11-ийг уншихдаа, өөрийн хүмүүсийг наманчлалд дуудах хэцүү даалгаврынхаа талаар Иаков юу мэдэрч байсныг илтгэх хэллэгийг ол.

 **1.** Хэцүү даалгавраа биелүүлэх Иаковын учир шалгааныг танд заах дараах өгүүлбэрийн талаар эргэцүүлэн бод: “Би энэ өдөр өдийг хүртэл байснаас үлэмж илүүгээр та нарын бодгалиудын аз жаргалын төлөө хүсэл тэмүүлэл хийгээд зовнилдоо дарагдан байна” (Иаков 2:3) болон “Би Бурханы чанд зарлигуудын дагуу үйлдэх ёстой” (Иаков 2:10). Дараах асуулуудад хариулж, судрын тэмдэглэлдээ бич:

а. Та хэзээ санваарын удирдагчийнхаа хайр болон таны төлөө санаа тавихыг мэдэрсэн бэ?

б. Та хэзээ санваарын удирдагчийн тань хэлсэн үгс болон үйлдэл нь танд туслахаар Бурханаар нөлөөлөгдсөн байгааг мэдэрсэн бэ?

Хичээлийн эхэнд танилцуулсан нөхцөл байдлын талаар дахин эргэцүүлэн бод. Өнөөдрийн суралцсан зүйлс дээрээ тулгуурлан найздаа юу гэж хариулах тухайгаа бод.

Иаков 2:12–21


Иаков бардамналынх нь улмаас өөрийн хүмүүсийг зэмлэв

Их Эзэн Иаковт юу заахыг зарлигласан тухай суралцахаар бэлтгэхэд тань туслах дараах зүйлүүд дээр Их Эзэний танд өгсөн адислалуудын талаар бод: гэр бүл, найзууд, сүмийн удирдагчид болон багш нар, урлагийн болон хөгжмийн ур чадвар, спортын ур чадвар, авьяас, сурлага, өсөж хөгжих боломжууд, сайн мэдээний мэдлэг болон материаллаг хэрэгцээнүүд. Их Эзэн таныг адисалсан бусад арга замуудыг бод.

Иаков 2:12–13-ыг уншаад, нифайчууд юу эрэлхийлж байсныг тодорхойл. “Хангагч ариун мутар” нифайчуудыг эд баялгаар адисалсан хэмээн Иаковын заасныг анхаар. Энэхүү хэллэг нь Тэнгэр дэх Эцэгийг хэлж байгаа билээ.

Өдөр тутмын амьдралдаа судруудыг холбох нь

Судраас суралцахдаа түр зогсоод, тодорхой зарчим нь таны амьдралтай хэрхэн холбогдож болохыг тунгаан бодох нь чухал. Сударт заасан зарчмыг ойлгон, үүний дагуу амьдардаг байсан бол та хэрхэн үйлдэх байсан тухайгаа бод. Энэ тохиолдолд, санваарын удирдагчдынхаа талаар сөрөг үзэл бодолтой байдаг найздаа хэрхэн хариулахаа тунгаан бодох нь танд удирдагчид маань яагаад нүглийн эсрэг сэрэмжлүүлдэг болохыг ойлгоход тусална.

 **2.** Их Эзэн танд байгаа адислал болон авьяас чадваруудыг өгсөн гэдгийг санах нь яагаад чухал болохыг судрын тэмдэглэлдээ бич.

Хэрвээ бид болгоомжтой байхгүй бол нифайчуудын адил эрэлхийлж байсан адислалуудаа авсны дараа бид өөрсдийгөө бардамналд өргөх болно. Дараах зайд “зүрх сэтгэлийн бардамналд өргөгдөнө” гэдэг нь ямар утгатай болохыг өөрийн бодлоор бич. _____

Иаков 2:13-т цэдэглэгдсэнээр, нифайчуудын бардамналд унах болсон шалтгаанууд нь юу байсан гэж Иаков хэлсэн бэ? _____

Өнөө үед бусдаас “илүү баялаг эзэмшсэний” улмаас бусдыг ад үзэж, үл ойшоож, хавчдаг хүн эсвэл бүлэг хүмүүсийн талаар бод (Иаков 2:13). Жишээлбэл, зарим хүн бусдаас илүү мөнгө, илүү олон найз, илүү спортын авьяас, бүр сайн мэдээний илүү мэдлэгтэйгээ улмаас өөрсдийгөө бусдаас илүү сайн гэж андууран боддог эсвэл бүр бусдыг хавчин гадуурхдаг байж болох юм. Та амьдралдаа бардам зан гаргаж байсан үе байвал тэрхүү үеийнхээ талаар тунгаан бод.

Иаков 2:17–21-ийг уншаад, бардамнахгүй байхад тань туслах өгүүлбэрүүдийг олж тэмдэглэ.



3. Иаков 2:17–21-р шүлгүүдээс олсон хоёр юмуу түүнээс дээш өгүүлбэрээ судрын тэмдэглэлдээ бичээд, бардамналаа давж гарахад эдгээр өгүүлбэрүүд танд хэрхэн туслахыг тайлбарла. Дараах асуултуудын зарим нь энэхүү даалгаврыг гүйцэтгэхдээ эргэцүүлэн бодоход тань тусалж болно: Бурханы хаант улсыг эрэлхийлэх гэдэг нь ямар утгатай гэж та бодож байна? Христэд найдах найдварыг олж авах гэдэг нь ямар утгатай вэ? Бурханы хаант улсыг эрэлхийлэх, Христэд найдах найдварыг олж авах нь бусдыг үзэх үзэл, тэдэнд хандах хандлагад тань хэрхэн нөлөөлөх вэ?

Аав, ээж эсвэл удирдагч тань танаас өнөөдөр юу сурсан бэ гэж асуусан гэж төсөөл. Тэдний асуултад хариулж болох нэг зарчмыг Иаков 2:17–21-р шүлгүүдээс бичиж ав. _____

Иаков 2:17–21 дэх нэг зарчим бол **Бид бусад бүх сонирхлуудаасаа дээгүүр Бурханы хаант улсыг эрэлхийлэх хэрэгтэй.**



4. Их Эзэний танд өгсөн адислал ба боломжуудыг Бурханы хаант улсыг байгуулахад туслах болон бусдын амьдралыг адислахдаа ашиглаж болох нэг арга замыг судрын тэмдэглэлдээ бич.

Иаков 2:22–30

Иаков өөрийн хүмүүсийн садар самуун явдлыг буруушаав

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон дараах үгсийг хэлжээ. Хоосон зайд ямар гурван үг бичих ёстойг таа:

“Энэ үеийнхний нүгэлт тахал бол _____” (“Cleansing the Inner Vessel,” *Ensign*, 1986 оны 5-р сар, 4; хичээлийн төгсгөлөөс зөв хариултыг хараарай).

Иаков 2:22–23, 28-ыг уншаад, ноцтой садар самуун явдлыг дүрслэхдээ Иаковын ашигласан үгсийг олж тэмдэглэ. *Завхайрал* гэдэг нь садар самууныг үйлдэх нүгэл гэсэн утгатай болохыг ойлгох нь тустай байж болно.



Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Ричард Г. Скотт нь Их Эзэний өгсөн ариун явдлын хуулийг зөрчих зарим үйлдлүүдийг тайлбарласан юм: “Гэрлэлтийн харилцаанаас гадуурх аливаа бэлгийн дотно харилцаа, өөрөөр

хэлбэл бусдын биеийн нууцлаг далд, ариун хэсгүүдэд хувцасны гаднаас болон дотуур санаатайгаар хүрэх нь Бурханаар хориглогдсон бөгөөд энэ нь нүгэл юм. Өөрийнхөө биед иймэрхүү мэдрэмжийг санаатайгаар өдөөх нь түүнчлэн зөрчил мөн” (“Making the Right Choices,” *Ensign*, 1994 оны 11-р сар, 38).

Ижил хүйстэнтэйгээ хийх аливаа үйлдлүүд болон порнограф үзэх нь Их Эзэний ариун явдлын хуулийг зөрчсөн хэрэг болно.

Иаков 2:23–24-т цэдэглэгдсэнээр нифайчууд хэрхэн өөрсдийн нүглийг зөвтгөж байсныг анхаар. Өнөөдөр хүмүүс хэрхэн садар самуун явдлаа зөвтгөхийг эрэлхийлж байгаа тухай бод.

Нифайчуудын үйлдсэн нүглүүдийн нэг нь зөвшөөрөгдөөгүй олон эхнэртэй байх явдал байлаа. Иаков эрэгтэй хүн нэг эхнэртэй байх ёстой хэмээх Их Эзэний зарлигийг заав (Иаков 2:27-г үзнэ үү). Их Эзэний томилогдсон санваарын удирдагчаар дамжуулсан Түүний зөвшөөрөлгүйгээр нэгээс олон эхнэртэй байх нь садар самууныг үйлдсэн нүглийн нэг жишээ байв. Садар самууныг үйлдсэн нүгэл нь Бурханы мэлмийд ноцтой билээ (Алма 39:5-ыг үзнэ үү).

Зөвхөн Их Эзэн зарлигласан үед Түүний хүмүүс олон эхнэртэй байж болно (Иаков 2:30-ийг үзнэ үү). Дэлхийн түүхийн тодорхой цаг үедэд Их Эзэн Өөрийн хүмүүст олон эхнэртэй байхыг зарлиглаж байсан. Жишээлбэл, Хуучин Гэрээний Абрахам ба Сариа нарын үед (Эхлэл 16:1–3; С ба Г 132:34–35, 37) мөн тэдний ач хүү Иаков (С ба Г 132:37), түүнчлэн Иосеф Смитээс эхлэн Сүм сэргээгдсэний дараахан олон эхнэртэй байх тушаал нь мөрдөгдсөн (С ба Г 132:32–33, 53-ыг үзнэ үү). Гэсэн хэдий ч, Бурхан өөрийн бошиглогч Вилфорд Вудрафт олон эхнэртэй байх тушаалыг мөрдөхөө зогсоо хэмээн зарлигласан (Сургаал ба Гэрээн дэх Албан тунхаг 1).

Иаков 2:31–35-ыг уншаад, бэлгийн нүглийн зарим сөрөг үр дагавруудыг үзүүлсэн өгүүлбэрүүдийг тэмдэглэ.



5. Судрын тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

а. Иаковын хэлснээр садар самуун явдал нь гэр бүлүүдэд хэрхэн нөлөөлдөг вэ?

б. Зарим өсвөр насны хүүхдүүд гэрлээгүй мөн хүүхэдгүй болохоор садар самууныг үйлдэж болно, энэ нь эхнэр юмуу нөхрөө хуурсан хэрэг биш гэж боддог. Садар самуун явдал өсвөр үеийнхнийг болон тэдний гэр бүлд хэрхэн нөлөөлж болох вэ?

в. Их Эзэн яагаад садар самуун явдлыг тийм ноцтой нүгэл хэмээн үздэг гэж та бодож байна вэ?

Иаков 2:28-ын эхний хэсгийг дахин үзээд, Их Эзэн юунд баясдагийг олж тэмдэглэ. (Энэхүү шүлэгт Иаков хэдийгээр эмэгтэй хүн хэмээн онцолж хэлсэн ч Их Эзэн эрэгтэй хүний ариун явдалд мөн адил баясдаг нь үнэн гэдгийг анхаар.) Энэ шүлэг дараах зарчмыг заадаг: **Их Эзэн ариун явдалд баясдаг.**

Өнөөдөр сурсан зүйлдээ тулгуурлан Их Эзэн яагаад Өөрийн хүүхдүүдийн ариун явдалд баясдаг болохыг эргэцүүлэн бод. Өөрийн гэр бүл болон ирээдүйн гэр бүлийнхээ тухай бод. Бурханы ариун явдлын хуулийн дагуу амьдрах нь таныг болон гэр бүлийг тань хэрхэн адислах вэ? Таны ариун явдал болон цэвэр ариун байхаар хийж буй сонголтууд Их Эзэнийг хэрхэн баясгаж байгаа тухай тунгаан бод.

Та цэвэр ариун үлдэж чадна. Хэрвээ та ариун явдлын хуулийн эсрэг нүгэл үйлдсэн бол Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан наманчилж, цэвэр болох боломжтой. Ариун явдлын хуулийг зөрчихгүйн тулд өөрийгөө илүү сайн хамгаалах нэг юмуу илүү олон аргыг бодож олохдоо Ариун Сүнсний удирдамжийг эрэлхийл. Хэрэв та садар самуун явдлыг ямар нэгэн байдлаар үйлдсэн бол бишоп эсвэл салбарын ерөнхийлөгчтэйгөө уулзан Их Эзэний ариун явдлын хуулийг зөрчих ямар үйлдэл хийснээ хүлээн зөвшөөрөх зэрэг шаардлагатай бүх зүйлийг хий.



6. Дараах өгүүлбэрийг судрын тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Иаков 1, 2-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.



Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

Хичээлийн эхэнд гарсан эшлэлийг гүйцээж бичих дасгалын хариу: Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон “Энэ үеийнхний нүгэлт тахал бол *садар самуун явдал юм*” гэж хэлжээ.

9-Р ХЭСЭГ: 4 ДЭХ ӨДӨР

Иаков 3–4

Оршил

Иаков 3 нь өөрийн хүмүүст номлосон Иаковын сургаалын төгсгөл хэсгийг багтаадаг. Энэ хэсэгт Иаков амар амгалан болоод амлалтын үгсийг зүрх сэтгэлдээ цэвэр тэдгээрт санал болгосон. Тэр мөн өөрийн хүмүүсийн дундах бардамнал ба цэвэр ариун бус байдлыг буруушаан зэмлээд, хэрэв тэд наманчлахгүй бол үр дагавар нь юу болохыг анхааруулсан. Иаков 4 нь түүний цэдгийг хэзээ нэгэн өдөр унших хүмүүст зориулан сүнслэгээр өдөөгдөн бичсэн Иаковын үгсийг багтаадаг. Тэр Есүс Христийн Цагаатгалыг гэрчилж, өөрийн уншигчдыг Цагаатгалаар дамжуулан өөрсдийгөө Бурхан Эцэгтээ нийцүүлэхийг ухуулсан. Тэрээр, Есүс Христ болон Түүний сайн мэдээний шударга үнэнийг эсэргүүцэх Иудейчүүдийн талаар сэрэмжлүүлгийн дуу хоолойгоор ярьсан.

Иаков 3

Иаков зүрх сэтгэлдээ цэвэр ариун хүмүүсийг урамшуулж, бусдыг наманчлахад ухуулав

Дараах тохиолдолд та залуу эрэгтэй эсвэл эмэгтэйд ямар зөвлөгөө өгөх тухайгаа бод:

- Нэгэн залуу эмэгтэй зөв шударга амьдрахыг хичээсэн ч эцэг нь архинд донтсон тул зовж байна.
- Сайн мэдээний дагуу хамгийн сайнаараа амьдардаг нэгэн залуу эрэгтэй эцэг эхийнхээ салалтаас болоод зовж байгаа.
- Нэг залуу эмэгтэй гэр бүлээ хайрлахыг хичээж байгаа боловч эгчийнх нь хувиа хичээсэн, халамжгүй зан ааш нь түүнд гэртээ байхад хүндрэл учруулдаг.

Та зөв шударга амьдрахыг хичээж байсан ч бэрхшээл сорилттой тулгарч байсан үеийнхээ талаар тунгаан бод. Иймэрхүү тохиолдолд юу хийх хэрэгтэйг Иаков бидэнд заасан. Иаков 3:1-ийн эхний

өгүүлбэрийг уншаад, 3-р бүлэгт Иаков хамгийн түрүүнд хэнд хандсаныг тодорхойл.

Бусдын бардамнал болон ёсон бус үйлүүдээс болж (Иаков 2-р бүлэгт түүний сэрэмжлүүлснээр) зүрх сэтгэлээрээ цэвэр хүмүүс зовдог хэмээн Иаков хэлсэн. Иаков 3:1–2-ыг уншаад, дараах хүснэгтийг бөглө:

Иаков зүрх сэтгэлдээ цэвэр хүмүүсийг юу хий гэж ухуулсан бэ?	Бурхан зүрх сэтгэлдээ цэвэр хүмүүст юу амласан бэ?



1. Эхний эгнээн дэх хариултуудаа дахин унш. Энэхүү зарчмын талаар илүү гүн эргэцүүлэн бодоход туслахын тулд дараах асуултуудын хоёрт нь судрын тэмдэглэлдээ хариулж бич:

а. Залуу хүн хэрхэн “Бурханд шийдэмгий оюунаар хандаж” чадна гэж та бодож байна вэ?

б. Зовлон зүдгүүр тохиолдсон үедээ Бурханд “үлэмж итгэлтэйгээр залбирах” гэдэг нь таны бодлоор ямар утгатай вэ?

в. Таны бодлоор залуу хүн “Бурханы таалалт үгийг хүлээн авахын” тулд юу хийж чадах вэ?



2. Хоёр дахь багананд байгаа хариултуудаа дахин унш. Эдгээр шүлгүүд нь **Бурхан зүрх сэтгэлээрээ цэвэр тэднийг зовлонд нь тайтгаруулна хэмээн заадаг.** Энэхүү зарчмыг илүү гүн эргэцүүлэн бодоход туслахын тулд дараах асуултуудаас нэг юмуу түүнээс олныг сонгож, судрын тэмдэглэлдээ хариулж бич:

а. Бурханыг дагахаар хичээх үед Тэрээр зовлонд тань таныг хэрхэн тайтгаруулж байсан бэ?

б. Зовлон зүдгүүртэй үедээ итгэлтэйгээр залбирах нь хэрхэн тусалсан бэ?

в. Түүний хайрыг мэдрэхэд Бурханы үг танд хэрхэн тусалсан бэ?

Зүрх сэтгэлээрээ цэвэр тэдэнд хандан ярьсныхаа дараа Иаков зүрх сэтгэлдээ цэвэр бус хүмүүст хандан ярив. Иаков 3:3–4, 10–12-ыг уншаад, Иаков эдгээр хүмүүст юу хийхийг ятгасныг тодруул. “Чадвараа сэргээ” хэмээх хэллэг нь авьяас чадвар, мэдрэмжээ сэрээ гэсэн утгатай ба *хууль бусаар эр эм боллоцох, тачаал* хэмээх үгс нь садар самуун явдал, шунал тачаалыг илэрхийлж байгааг мэдэх нь тустай байж болно.

Иаков 3:3–4, 10–12-г Иаковын хүмүүс наманчлахгүй бол юу тохиолдохыг сануулж байгаа түүний сэрэмжлүүлгийг бид уншдаг. Эдгээр шүлгүүдийг

судалсны дараа дараах нөхцөл байдлыг дүрслэх өгүүлбэрийг олж дугуйл: (а) Леменчүүд тэднийг устгах болно. (б) Тэдний үлгэр жишээ нь хүүхдүүдийг нь устгал руу хөтлөх болно. (в) Тэд хоёр дахь үхлийг үзэх буюу өөрөөр хэлбэл Бурханаас тусгаарлагдах болно.

Иаковын сэрэмжлүүлэг түүний хүмүүст хэрхэн агуу адислал болох талаар эргэцүүлэн бод.

Иаков 3:5–7-д цэдэглэгдсэнээр, Иаков леменчүүдийг нифайчуудаас “илүү зөв шударга” байгааг зоригтойгоор хэлсэн. Учир нь “тэдний эр нөхрүүд эхнэрээ хайрладаг, мөн тэдний эхнэрүүд эр нөхрөө хайрладаг, мөн тэдний эр нөхрүүд мөн тэдний эхнэрүүд хүүхдүүдээ хайрладаг” хэмээжээ. Нифайчууд бүх нүглээ, ялангуяа гэр бүлдээ итгэх итгэл, тэднийгээ хайрлах хайрыг нь бууруулсан тэдгээр нүглээ наманчлах ёстой.

Иаков 3:11–12-ын талаар тунгаан бодоод, захиасыг өөрийн үгээр тоймлон бич. _____

Танд учирч байсан уруу таталтууд хийгээд хийсэн буруу зүйлсээ наманчилснаар ямар муу үр дагавруудаас зайлсхийсэн тухайгаа хэсэг зуур бод.

Иаков 4

Иаков өөрийн хүмүүст Бурханы оршихуйд буцаж очих найдварыг олж авахыг ухуулдаг

Иаков 4-ийг судлахад бэлдэхийн тулд бал юмуу харандаагаа суралцах удирдамжаасаа дээш нэг метрт өргөөд, байны төв буюу “зорилгоо” онож балаа унагахыг хичээ. Хэд хэдэн удаа оролдож болно. Байнаасаа өөр зүйл рүү харж байгаад унагавал үр дүн нь хэр зэрэг бага байхыг бод. Хэрвээ харваачид харвахдаа бай буюу зорилго руугаа ерөөсөө харахгүй, эсвэл зорилгоосоо алсуур харвал хэр сайн харваж чадна гэж та бодож байна вэ? Иаков 4:14-ийг уншаад, Иаковын бошиглосон, “зорилгоосоо алсуур” хардаг хүмүүсийн зан аашийг тодорхойл.


Судруудыг өөрийн үгээр тоймлох нь

Судрыг өөрийн үгээр тоймлон бичихийн тулд уг судар яг юу зааж байгааг ойлгохыг хичээн, тэр талаар бодоод өөрийн ойлгож байгаагаар тухайн захиасыг хэлэх буюу бич. Үүнийг хийх нь судрын үнэнийг амьдралдаа хэрэгжүүлэхэд тань тус болно. Нэг юмуу хэд хэдэн шүлгийг тоймлосныхоо дараа таны тойм уг шүлгийн гол утга санааг гаргаж байгаа эсэхийг шалгахын тулд дахин унш.



Судартаа Иаков 4:14-ийн хажууд “зорилго бол Христ” гэж бичиж болно (Нийл А.Максвэлл, “Jesus of Nazareth, Savior and King,” *Ensign*, 1976 оны 5-р сар, 26). Паул үүнтэй төстэй буюу “Христ Есүс дотор Бурханы дээш чиглэсэн дуудлагын шагналыг авахын төлөө бариа руу урагшилдаг” (Филиппой 3:14) хэмээн заажээ.

Бошиглогч Иаков Мосегийн хууль болон тэднийг Аврагч руу хөтлөх үүний зорилгыг буруу ойлгосон Иудейчүүдийн төлөө шаналж байв. Ихэнх Иудейчүүд Мессиа буюу Есүсийн үзүүлснээс өөр маягийн чөлөөлөлтийг хүлээж байсан ба тэд гаднын эрх барилт, дарлалаас чөлөөлнө хэмээн хүлээж байжээ.

 **3.** Судрын тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

а. Зорилгоосоо (Есүс Христ) алсуур харна гэдэг нь таны бодлоор ямар утгатай вэ?

б. Иаков 4:14-т бичигдсэн ямар зан араншин, үйлдлүүд Иудейчүүдийг харалган болгож, Есүс Христийг хүлээн зөвшөөрөхөд нь саад болсон бэ?

в. Өнөөдөр зорилгоосоо алсуур харах, Аврагчид анхаарлаа хандуулахад саад болж байгаа ямар жишээнүүд байна вэ?

Үүнийг унших хүмүүсийг зорилгоо умартсан Иудейчүүдийн хандлага, зан аашаас тэс өөр хандлагатай байгаасай хэмээн Иаков хүсч байв. Иаков 4:4-ийг уншаад, түүний цэдгийг унших бүх хүмүүнийг юу мэдээсэй хэмээн Иаков хүсч байсныг тодорхойл. Түүнчлэн Иаков 4:12-ыг уншаад, “яагаад Христийн цагаатгалыг ярихгүй байх билээ” хэмээх өгүүлбэрийг тэмдэглэ. Иаков 4:4-т Иаков яагаад Христэд итгэсэн, Цагаатгалын тухай бусдад мэдүүлэх нь яагаад чухал болохыг мэдэрсэн хэд хэдэн шалтгаанаа бичжээ.

 **4.** Дараах судрын эшлэлүүдийг судрын тэмдэглэлдээ бичээд, дараа нь Иаков Есүс Христ болон Цагаатгалын талаар эшлэл бүрд юу заасныг тоймлон бич.

- а.** Иаков 4:4–6
- б.** Иаков 4:7–8
- в.** Иаков 4:9–10
- г.** Иаков 4:11

Иаков 4:4–6 дахь ямар ямар үгс эсвэл хэллэгүүд Иаковын хүмүүс Бурхан Тэргүүтэний мөн чанарыг ойлгосныг илэрхийлж байна вэ?

“Бурханд Христийн анхны үр жимс хэмээн танилцуулагдах” (Иаков 4:11) гэдэг нь селестиеел хаант улсад орохуйц зохистойгоор Бурханы өмнө зогсохыг хэлж байгааг мэдэх нь тустай байж болно. Түүнчлэн хэрэв бид “[Аврагчийн] сүр жавхланг хүлээн авна гэж найдаж” (Иаков 4:4) байвал Тэнгэрлэг Эцэгийнхээ оршихуйд эргэн очиж болохын тулд Есүс Христ биднийг нүглээс гэтэлгэгдэх, амилуулагдах арга замаар хангасан гэдэгт бид итгэх ёстой гэдгийг ойлгох нь чухал юм.


Иаков 4-өөс бидний суралцах нэгэн үнэн бол: **Есүс Христийн цагаатгалаар дамжуулан бид найдвараар дүүргэгдэж, Бурханд өөрсдийгөө нийцүүлэх боломжтой.**

 **5.** Дараах асуултуудын товч хариулыг судрын тэмдэглэлдээ бич:

а. Иаков 4:4–12-р шүлгүүдээс суралцсан Есүс Христийн тухай үнэнүүдийг дахин уншаад, Цагаатгалын талаар ярихыг урамшуулдаг тодорхой нэг үнэнийг сонго. Сонгосон үнэнээ бичээд, яагаад сонгосноо тайлбарла.

б. Өөр ямар хувийн шалтгаанууд таныг Есүс Христ болон Цагаатгалын тухай ярихыг урамшуулдаг вэ?

Энэхүү хичээлийг төгсгөхдөө Аврагчид яагаад талархалтай байдгаа тунгаан бод. Гэр бүлийн гишүүн эсвэл дотны найзтайгаа энэхүү шалтгаанаа хуваалцахыг эрмэлз.

 **6.** Дараах өгүүлбэрийг судрын тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Иаков 3–4-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

10-Р ХЭСЭГ: 1 ДЭХ ӨДӨР

Иаков 5–6

Оршил

Иаков 5 Зинос хэмээх нэртэй бошиглогчийн ярьсан таримал болон зэрлэг чидуны модны тухай ёстлолыг агуулдаг. Их Эзэний хүмүүс Түүнээс нүүр буруулдаг ч Өөрийн гэрээт хүмүүст авралыг авчрахын тулд Тэрбээр үргэлж хөдөлмөрлөж байдгийг заахын

тулд Иаков энэ ёгтлолыг ашиглажээ. Уг ёгтлол нь Их Эзэн Өөрийн гэрээт хүмүүс болох Израилын угсааны хэсгийг дэлхий даяар тараасан бөгөөд хожмын өдрүүдэд тэднийг цуглуулах болно гэдгийг харуулдаг. Энэхүү ёгтлол нь Израилын угсааны гишүүд болон Их Эзэний үйлчлэгч бидэнд өнөө үед хандсан хувийн бөгөөд тодорхой утга агуулгатай. Иаков 6-д Иаков өөрийн хүмүүст болон бидэнд наманчлахыг ухуулж байхдаа Их Эзэний нигүүлсэл болон шударга ёсыг онцгойлон яриу.

Иаков 5:1–12

Иаков Израилын овгийг таримал чидуны модтой зүйрлэсэн Зиносоос эш татдаг

Өөрөө Бурханаас холдсон үедээ зовлон бэрхшээлтэй тулгараад, өөрийг нь хайрлах Түүний хайранд эргэлзэж байсан хэн нэгэн дотны хүн эсвэл найз танд байгаа юу? Дараах жишээнүүдийг эргэцүүлэн бод:

- Нэгэн залуу санваартан муу буюу нүгэлт зуршилтай болжээ. Тэр бусад хүмүүс уучлагдана гэдэгт итгэдэг ч Их Эзэн түүний наманчлалыг хүлээн авна гэдэгт эргэлздэг байв.
- Нэгэн залуу эмэгтэй зарлигийг зөрчив. Тэр алдаа гаргаснаа ойлгож, өөрийгөө буруутган зовж, Их Эзэн түүнд хайртай хэвээр байгаа эсэхэд эргэлзжээ.

Иудейчүүд Есүс Христийг хүлээн авахгүй гэдгийг Иаков бошиглосон. (Иаков 4:15-ыг үзнэ үү). Мөн

Түүнийг хүлээн авахгүй байсан ч Өөрийн хүмүүсийн авралын төлөө Есүс Христ үргэлжлүүлэн ажилласаар байх болно гэдгийг тэр заасан юм. Энэхүү үнэнийг үзүүлэхийн тулд Иаков бошиглогч Зиносын чидуны модны ёгтлолоос эш татсан. (Иаков 5:1-ийг үзнэ үү). Ёгтлол нь сургаалт үлгэр мэт бөгөөд үнэнийг заахын тулд бэлгэдлийн дүр, эд зүйлс болон үйл явдлыг ашигладаг түүх юм. Иаков 5-ыг судлахдаа, та нүгэл үйлдсэн байсан ч Их Эзэн үргэлж тань руу гараа сунгаж байдгийг сана.

Иаков 5:2-ыг уншаад, Зинос үүнийг хэнд хандан заасныг олж судартаа тэмдэглэ.

Та баптисмаар дамжуулан Их Эзэнтэй гэрээ хийсэн учраас та Израилын угсааны нэгэн гишүүн юм. Та бол Иаков 5-д яригдсан түүхийн нэг хэсэг. Иаков 5:3-ыг уншаад, Зинос энэхүү ёгтлолд Израилын угсааг төлөөлүүлэхээр юу ашигласныг олж тэмдэглэ. Түүнчлэн таримал чидуны модонд юу тохиолдож эхэлснийг олж тэмдэглэ.

Иаков 5:3 дахь 2 гэсэн зүүлт тайлбар модны өмхрөл нь урвалтыг илтгэдэг гэдгийг анхаар. Хувь хүмүүс юмуу бүлэг хүмүүс Их Эзэнээс болон Түүний сайн мэдээнээс татгалзах үед урвалт тохиолддог.

Дараах хүснэгт дэх бэлгэдлүүд нь Зиносын ёгтлолын утгыг ойлгоход бидэнд тусалдаг. Түүнчлэн эдгээр бэлгэдлүүд хамгийн түрүүнд гардаг шүлгүүдийг жагсаав. Бэлгэдлүүдийг судартаа тэмдэглэ.



Усан үзмийн талбай бол усан үзмийн ороонго болон чидуны мод тарихад ашигладаг хэсэг газар юм. Эртний Израилд чидуны модод нь маш их үнэ цэнэтэй байжээ. Чидуныг хүнсэнд хэрэглэдэг байсан бөгөөд тосыг нь хоол хүнс, эм болон дэнлүүний гэрэлд ашигладаг байжээ. Гэсэн ч чидуны модноос сайн үр жимс гарган авахын тулд маш их арчилгаа, хөдөлмөр шаардагддаг.

Судрынхаа хажуугийн зайд бэлгэдлүүдийн утгыг бичих хэрэгтэй.

Иаков 5: Таримал ба зэрлэг чидуны модны ёгтлол	
Бэлгэдэл	Утга
Таримал чидуны мод (3-р шүлэг)	Израилын овог, Бурханы гэрээт хүмүүс
Усан үзмийн талбай (3-р шүлэг)	Дэлхий
Өмхрөл (3-р шүлэг)	Нүгэл ба урвалт
Талбайн эзэн (4-р шүлэг)	Есүс Христ
Тайрах, сийрүүлэх ба арчлах (4-р шүлэг)	Биднийг зөв шударга байж, сайн үйл хийхэд туслах Их Эзэний хичээл зүтгэл
Мөчрүүд (6-р шүлэг)	Бүлэг хүмүүс
Зэрлэг чидуны мод (7-р шүлэг)	Харийнхан—Их Эзэнтэй гэрээнд ороогүй хүмүүс. Ёгтлолын төгсгөлд, урвалтын үе дэх Израилын угсааны хэсгийг төлөөлөх чидуны унаган моддыг “зэрлэг” хэмээн дүрсэлсэн байдаг.
Мөчрүүдийг тайрч авах болон залгаж суулгах (7–8-р шүлгүүд)	Их Эзэний гэрээт хүмүүсийн тараагдалт ба цугларалт. Мөн түүнчлэн, зэрлэг мөчрүүдийг таримал чидуны модтой залган суулгах нь баптисмаар дамжуулан Их Эзэний гэрээт хүмүүс болсон Харийнханы хөрвөлтийг төлөөлнө.
Мөчрүүдийг шатаах (7-р шүлэг)	Ёсон бусчуудын дээрх Бурханы шүүлт
Жимс (8-р шүлэг)	Хүмүүсийн амьдрал ба үйлс
Таримал чидуны модны үндсүүд (11-р шүлэг)	Өөрийг нь дагадаг хүмүүстэй хийдэг Их Эзэний гэрээнүүд Үндэс нь эрт үед Их Эзэнтэй гэрээнд орсон Абрахам, Исаак болон Иаков зэрэг хувь хүмүүсийг төлөөлж болно (Иаков 6:4-ийг үзнэ үү).

Иаков 5:4–6-г уншаад, таримал чидуны модоо аврахын тулд талбайн Эзэн анх юу хийснийг олж тэмдэглэ. Дээрх хүснэгтийг хараад талбайн эзэн

нь хэн болох мөн тайрч, сийрүүлж, арчлах Түүний үйлдлүүд нь юуг төлөөлж байгааг анхаар.



Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Жэффри Р.Холланд уг ёгтлол нь юунд зориулагдсаныг тайлбарлажээ. Тайлбарыг уншихдаа ёгтлолын илүү гүнзгий утга учрыг заасан хэсгийн доогуур зураарай.

“Иаковаар дахин өгүүлэгдсэн энэхүү ёгтлол нь Христийн [талбайн Эзэн] тухай заах зориулалттай юм. . . .

. . . Хэдийгээр усан үзмийн талбайн эзэн болон түүний зарц нар моднуудаа хүчирхэгжүүлэх, тайрах, цэвэршүүлэх зэрэг аргаар үр өгөөжтэй болгохыг хичээж байгааг Израилын угсааны тараагдалт болон цугларалтын тухай түүхэн тоймын нэг бүлэгт багтаасан ч тэдний хөдөлмөрийг даван гарахуйц Цагаатгал бол илүү гүнзгий утга учиртай билээ (*Christ and the New Covenant: The Messianic Message of the Book of Mormon* [1997], 165).


Иаков 5 нь чидуны модны тухай өгүүлдэг боловч энэ нь нүгэл үйлдэн Их Эзэнээс холдсон хүмүүс болон Өөрт нь эргэн ирэхэд тэдэнд туслах Их Эзэний хичээл зүтгэлийн тухай ёгтлол юм. Энэ бүлэгт **Их Эзэн бидэнд хайртай бөгөөд бидний авралын төлөө хичээнгүйлэн хөдөлмөрлөдөг гэдгийг заадаг.** Ёгтлолыг үргэлжлүүлэн судлахдаа, Израил буюу таримал чидуны модны төлөөх Их Эзэний анхаарал халамж болон үүнийг аврахыг хичээх Түүний мятрашгүй хичээл зүтгэлд анхаарлаа хандуулснаар энэхүү үнэний нотолгоог ол. Жишээлбэл, Иаков 5:7-г уншаад, “Би энэ модыг алдах ёстой болсон нь намайг гонсойлгож байна” гэсэн өгүүлбэрийн талаар тунгаан бод. Их Эзэн энд ямар сэтгэл хөдлөл гаргасан байна вэ, яагаад? _____

Уг өгүүлбэрийг дахин уншихдаа “энэ мод” гэдгийн оронд өөрийнхөө нэрийг тавиад унш: “[Таны нэр]-г алдах болсон нь намайг их гонсойлгож байна.” Иаков 5-р бүлэгт таарамжтай, утга учир бүхий хэсгүүдэд өөрийн нэрийг оруулан уншсанаар та өөрийгөө ёгтлолтой хамааруулж ойлгох боломжтой бөгөөд таны төлөөх Их Эзэний анхаарал халамжийн талаар илүү ихийг ойлгох болно.

Суралцаж байгаа шүлгүүддээ өөрийн нэрийг оруулах нь

Судрын тохиромжтой хэсгүүдэд би эсвэл надад, намайг гэсэн үгсийг орлуулан уншиж болно. Энэхүү дадлага нь үр дүн бүхий судрын сургалт хийхэд, судрын тодорхой хэсгүүд нь тантай хэрхэн холбоотой болохыг харахад тань туслах болно.

Иаков 5:7–11-ийг уншаад, таримал модыг авч үлдэхийн тулд талбайн эзэн дараагийн ээлжинд юу хийснийг ол.



Залган суулгах үйл явц нь нэг модноос эрүүл, амьд мөчрүүдийг тайран авч, ургуулах гэж байгаа модны их биед залгах явдал юм.



1. Хүснэгт дэх бэлгэдлүүдийн утгыг ашиглан, Иаков 5:7–11-т Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдийг аврахын тулд талбайн эзэн болон түүний зарц нар юу хийдгийг судрын тэмдэглэлдээ тайлбарлан бич.

Их Эзэн Израилын угсааны бус хүмүүсийг Өөрийн гэрээт хүмүүсийн нэг хэсэг болгон Израилын угсаанд залгадаг. Израилын угсааг аврахын тулд Тэрээр хамгийн ёс бус мөчрүүд (хүмүүс)-ийг таслан авч, устгадаг.

Иаков 5:13–14-ийг уншаад, 6-р шүлэгт дурдагдсан таримал чидуны модны залуу бас туяхан мөчрүүдээр Их Эзэн юу хийснийг ол. Та судрынхаа захад *хамгийн алс* гэдэг нь хамгийн нам дор эсвэл хамгийн алсад харагдах гэсэн утгатай гэж бичиж болно.



2. Хүснэгт дэх бэлгэдлүүдийн утгыг ашиглан, Лихайн гэр бүлийг талбайн хамгийн алсын хэсэгт нуугдсан залуу бас туяхан мөчиртэй хэрхэн харьцуулж болохыг судрын тэмдэглэлдээ тайлбарлан бич.

Эзэний зарц нар “зарим мөчрийг аван бүх зэрлэг чидуны модонд залган суулгав” гэдгийг Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит ийн тайлбарлажээ. Зэрлэг чидуны модод нь хэн байсан бэ? Харийнхан. Мөн эзэн зарц нараа талбайн бүх хэсэг буюу дэлхий рүү илгээж, модны эдгээр мөчрүүдийг суулгав. . . .



“Одоо сургаалт үлгэрт гардаг чидуны мод нь Израилын угсаа юм. . . . Төрөлх нутагтаа энэ нь үхэж эхлэв. Тэгээд Их Эзэн нифайчууд, алдагдсан овгууд болон дэлхийн бусад хэсгүүд рүү Их Эзэний удирдсан, бидний мэдэхгүй бусад хүмүүс шиг мөчрүүдийг авав. Тэр талбайн буюу дэлхийн бүх хэсэгт тэднийг тарив. Зарим мөчрүүдийг Япон, Солонгос, Хятадад суулгасан байхад эргэлзэх юун. Үүний талаар асуух шаардлагагүй, учир нь тэр

дэлхийн бүх хэсгүүдэд тэднийг илгээсэн” (*Answers to Gospel Questions*, comp. Joseph Fielding Smith Jr., 5 vols. [1957–1966], 4:204–205).

Ерөнхийлөгч Смит заахдаа “энэхүү сургаалт үлгэрийг тайлбарлавал . . . Израилын тараагдалт болон дэлхийн бүхий л хэсгүүдэд Израилын цусыг зэрлэг чидуны мод буюу харийнхантай хольж байгаа тухай түүх юм. Тиймээс бид харийнханы амьдардаг Хятад, Япон, Энэтхэг болон бусад бүх улсуудад тэдний дунд Израилын цус тараагдсан байгааг, өөрөөр хэлбэл ‘залгагдсан’ байгааг олддог” (*Answers to Gospel Questions*, 4:40–41).

Иаков 5:15–77

Усан үзмийн талбайн эзэн ба түүний зарц нар усан үзмийн талбайгаас сайн үр жимс гаргахаар хөдөлмөрлөдөг


Иаков 5-р бүлгийн ихэнх шүлгүүд нь Израилын угсаа олон хэсгүүд болон өөр өөр цагуудад тараагдаж байгаа тухай үйл явдлуудыг болон тэднийг цуглуулах Аврагчийн ажлыг дүрсэлсэн байдаг. Тус бүлэг мянган жил болон дэлхийн эцсийн цэвэрлэгээний тухай өгүүлснээр төгсдөг.

Талбайнхаа моднуудад тавьж буй Их Эзэний анхаарал халамж болон тэднийг аварч үлдэх гэсэн Түүний үргэлжилсэн хичээл зүтгэлийг онцлохын тулд Зинос ёгтлолынхоо туршид хэдэн чухал хэллэгийг давтан өгүүлсэн. Иаков 5:20, 23–25, 28, 31-ийг уншаад, Их Эзэн талбайнхаа моддыг арчлах оролдлогуудаа дурдсан хэсэг бүрийг тэмдэглэ.

Талбайдаа сайн жимс ургуулах гэсэн Их Эзэн болон Түүний зарц нарын хичээл зүтгэлийг үл хайхран талбай дахь жимснүүд яваандаа өмхөрч эхэлжээ (Иаков 5:39-ийг үзнэ үү). Иаков 5:41–42, 46–47-г уншаад, Их Эзэний талбайгаа хайрлах хайр, анхаарал халамж, харууслыг харуулсан өгүүлбэрүүдийг олоод судартаа тэмдэглэ.

Хийсэн бүх зүйлсийг нь үл харгалзан моднууд муу үр жимс ургуулсан тул талбайн Их Эзэн бүх моднуудаа тайрахаар шийддэг (Иаков 5:49-ийг үзнэ үү). Иаков 5:50–51-ийг унш. Иаков 5-р бүлгийн үлдсэн хэсэг эцсийн өдрүүдэд амьдрах хүмүүсийг аврах Их Эзэн болон Түүний үйлчлэгчдийн хичээл зүтгэлийг төлөөлдөг. Тэрээр хүмүүсээ цуглуулж, эцсийн удаа тэднийг арчилдаг (Иаков 5:52–77-г үзнэ үү).

Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит Иаков 5-р бүлэгт дүрслэгдсэн Израилын цугларалт одоо биеллээ олж байна хэмээн заасан: “Цугларалтын энэ өдөр Их Эзэн зорилгоо биелүүлж, Абрахамын хүүхдүүдийг Жинхэнэ Хоньчны сүрэгт буцаж нийлэхийг дуудаж байна” (*Answers to Gospel Questions*, 4:41).


 **3.** Иаков 5-р бүлгээс таныг хайрлах Их Эзэний хайрын талаар юу сурснаа судрын тэмдэглэлдээ бич. Өөрийнхөө эсвэл таны мэддэг хэн нэгний амьдралд Их Эзэний хайр хэрхэн илэрхийлэгдэхийг харсан жишээгээ бич.

Иаков 6

Иаков Бурханы нигүүлсэл болон шударга ёсыг зааж, биднийг наманчлалд урьдаг


Иаков 6-р бүлэг нь чидуны модны ёгтлолоос Иаковын тоймлосон чухал үнэнүүдийг багтаадаг. Иаков 6:4–6-г уншаад, Бурханы дүрийн талаар Иаковын онцолсон зүйлийг ол. Биднийг Бурханы тухай сураасай гэсэн Иаковын хүслийг тоймлохдоо та ямар үг ашиглах вэ? _____

Иаков 6:7–13-т Иаков **бид одооноос наманчилж, Их Эзэний нигүүлслийг хүлээн авч шүүлтэд бэлтгэх ухаалаг хүмүүс** хэмээн гэрчилж захиасаа төгсгөдөг.

 **4.** Иаков 6:5-ыг дахин унш. Иаков биднийг “тэрбээр та нарт үнэнчин адил Бурханд ч үнэнч бай” хэмээн урамшуулдаг. Үнэнч байх гэдэг нь атгах, зуурах гэсэн утгатай. Судрын тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

а. Бурхан бидэнд хэрхэн үнэнч хэвээр үлддэгийг тайлбарласан чидуны модны ёгтлолоос та юу сурсан бэ?

б. Тэр танд үнэнч байдгийн адил та Түүнд илүү баттай үнэнч байхын тулд юу хийж чадах вэ?

 **5.** Дараах өгүүлбэрийг судрын тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Иаков 5–6-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

10-Р ХЭСЭГ: 2 ДАХЬ ӨДӨР

Иаков 7

Оршил

Иаков Христийг эсэргүүцэгч Шеримтэй маргаж, худал санаануудыг нь даван гарахын тулд Их Эзэн болон өөрийн гэрчлэлд тулгуурлав. Христийг эсэргүүцэгч гэдэг нь Христийг хүчтэйгээр, шаргуу эсэргүүцдэг бөгөөд Түүнд итгэдэг бусад хүмүүсийн итгэлийг, Түүний үнэн сүмийг, Түүний сайн мэдээг, авралын төлөвлөгөөг устгахыг хичээдэг хүн юм.

Шеримийн зүтгэлийн эсрэг, Иаков Есүс Христэд итгэх итгэлийг нь нэмэгдүүлж байсан өмнөх туршлагаудаасаа хүчийг олж авав. Тэр мөн Ариун Сүнсний удирдамж, судрууд болон бошиглогчдын үгсийн талаарх өөрийн мэдлэг болоод Есүс Христийн тухай өөрийн гэрчлэлд найдлагаа тавьсан. Иаковын үгсийг бататгах тэмдэг үзүүлэхийг шаардах үедээ Шерим Бурханаар цохигдсон. Тэд леменчүүдийн эсрэг бэхлэлт босгохдоо нифайчууд хэрхэн Их Эзэнд итгэсэн болохыг дүрсэлж Иаков өөрийн цэдгийг төгсгөсөн. Иаков нас барахаасаа өмнө өөрийн хүү



Иност жижиг ялтсуудыг итгэн шилжүүлсэн.

Иаков 7:1–14

Иаков Христийг эсэргүүцэгч Шеримтэй нүүр тулах үедээ Их Эзэнд найдлагаа тавьдаг

Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Робэрт Д.Хэйлс ийн заажээ: “Мөнх бус амьдралын хамгийн гол шалгууруудын нэг нь бидний итгэл бишрэлийг шүүмжилж, байцааж шалгаах үед ирдэг юм. Иймэрхүү тохиолдолд бид маргахыг хүсч байж болох юм. . . . Гэвч эдгээр нь дахин дахин тунгаан бодож, залбирч Аврагчийн жишээг дагах чухал боломжууд болдог. Дэлхий Есүсийг хүлээн зөвшөөрөхгүй үзэн ядаж байсныг санагтун. . . . Биднийг буруутгагчдад Аврагчийнхтай адил хандсанаар бид зөвхөн Христтэй адил болоод зогсохгүй, бусад хүмүүсийг Түүний хайрыг мэдэрч мөн Түүнийг дагахад урин дууддаг” (“Christian Courage: The Price of Discipleship,” *Ensign* ба *Луахона*, 2008 оны 11-р сар, 72).

Итгэлийг тань шүүмжилж, байцааж шалгааж байсан үеийг бод. Иаков 7-г судлахдаа та, Шерим нэртэй эр Иаковын итгэлийг хэрхэн шүүмжилж, энэхүү сорилтыг тэрээр хэрхэн амжилттайгаар даван гарсан түүний туршлагын талаар сурах болно.

Иаков 7:1–5-ыг уншаад, (1) Шерим юу хийхийг хичээж байсан, (2) зорилгоо биелүүлэхийн тулд тэрээр хэрхэн тэмцэж байсныг харуулах үг хэллэгүүдийг ол. Эдгээрийг судартаа тэмдэглэх хэрэгтэй.

Иаков 7:3-т хэлсний дагуу Шерим бусад хүмүүсийн дунд ямар үр нөлөө үзүүлсэн бэ? _____



1. Иаков 7:4-т Шерим “эрдэмт нэгэн” бөгөөд “хэл ярианы төгс мэдлэгийг” эзэмшсэн байсан гэж гардаг. Шерим шиг хүний эсрэг итгэлээ хамгаалах нь заримдаа яагаад хэцүү байдгийг судрын тэмдэглэлдээ бич.

Бидний итгэлийг шүүмжилж, асууж шалгаадаг бүх хүн Шерим шиг хандлагатай байдаггүй гэдгийг санаарай. Зарим хүмүүс Шеримийн адил итгэлийг устгах санааг эрэлхийлдэг хэдий ч бусад нь манай шашныг сонирхсондоо эсвэл бидний итгэлийн талаар буруу мэдээлэлтэй байдаг учраас асуудаг.

Иаков 7:5–14-ийг уншихдаа, Шерим шиг хүнд хэрхэн хариулахаа тунгаан бод. Иаковын хариултыг судлахдаа та, **бид Их Эзэнд найдлагаа тавих үед итгэлийнхээ сорилтыг даван гарч чаддаг гэдгийг харах болно.** Энэхүү зарчмыг судрынхаа захад эдгээр шүлгүүдийн хажууд бичих хэрэгтэй. Иаков Шеримийг маргахад энэхүү зарчмыг үзүүлсэн арга замуудыг ол.

Дараах хүснэгтийн эхний багана дахь Иаков 7:5–14-өөс авсан шүлгүүдийг уншаад, Иаков Их Эзэнд хэрхэн найдлагаа тавьсныг хамгийн сайн дүрслэх тайлбарыг хоёр дахь багананд бичигдсэн шүлгийн эшлэлүүдтэй тохируул. Судрын эшлэлийн өмнөх шугаманд тохирох эшлэлийн үсгийг бич.

Иаков Их Эзэнд найдлагаа тавихын тулд хийсэн зүйл	
1. ____ Иаков 7:5	а. Тэр судрууд болон бошиглогчдын үгсийг гэрчлэв.
2. ____ Иаков 7:8	б. Тэрээр үр дүнг нь Бурханы мутарт үлдээсэн.
3. ____ Иаков 7:10–11	в. Тэрээр Ариун Сүнсний удирдамж ба хүчинд найдсан.
4. ____ Иаков 7:12	г. Тэрээр итгэлийг нь хүчирхэгжүүлж байсан өнгөрсөн туршлагаудаа санасан.
5. ____ Иаков 7:13–14	д. Тэр Ариун Сүнсээр дамжуулан хүлээн авсан гэрчлэлээ хуваалцсан.

Тохируулах дасгалын хариуг шалгахдаа хичээлийн төгсгөл дэх зөв хариултуудыг харж болно.

Таны итгэлийг шүүмжлэх, асууж шалгаах үед гэрчлэл тань сулрахгүй байж болохын тулд та гэрчлэлээ хэрхэн хүчирхэгжүүлэх вэ? Иаков 7:5-д Иаков дараах үнэнийг үзүүлсэн гэдгийг анхаар: **Бидний гэрчлэл илчлэлт болон жинхэнэ сүнслэг туршлагауд дээр тулгуурласан бол итгэл маань сулрахгүй.** Есүс Христийн тухай гэрчлэлийнхээ хүч болон илүү хүчирхэгжүүлэхийн тулд юу хийж болох тухайгаа тунгаан бод.

Бидний итгэлийг шүүмжилж, асууж шалгаадаг хүмүүст хариулахад Иаковын Шеримд өгсөн хариулт жишээ болдог.



2. Их Эзэнд найдлагаа тавихын тулд Иаковын хийсэн зүйлс болон бусад хүмүүс итгэлийг тань сорих үед түүнтэй адил зүйл хийснээр энэ нь танд хэрхэн тусалсан эсвэл тусалж болох тухай бодоход тань туслах дараах асуултуудад судрын тэмдэглэлдээ хариулж бич:

а. Иаков 7:5-д Иаковын өмнөх сүнслэг туршлагаас үүдэн түүний итгэл сулрашгүй болсон тухай гардгийг анхаар. Өөр ямар туршлагауд таны итгэлийг хүчирхэгжүүлж байсан бэ? Эдгээр туршлагаудыг санах эсвэл бичиж авах нь хэн нэгэн итгэлийг тань шүүмжилж, асууж шалгаах үед танд хэрхэн тусалж болох вэ?

б. Иаков 7:8-д Иаков “Их Эзэн Бурхан өөрийн Сүнсийг миний бодгальд юүлсэн” хэмээн өгүүлсэн. Бодгальд тань Сүнсийг юүлэх боломжтой байж болохын тулд та юу хийх хэрэгтэй вэ? Таны итгэлийг шүүмжилж, асууж шалгаах үед Ариун Сүнс танд хэрхэн тусалсан бэ?

в. Таны итгэлийг бусад хүмүүс шүүмжлэх, асууж шалгаах үед судрууд болон хожмын үеийн бошиглогчдын үгсээс өдөр бүр судлах дадал нь танд хэрхэн тусалсан бэ? (Иаков 7:10–11-ийг үзнэ үү).

г. Таны итгэлийг шүүмжилж, асууж шалгаасан хэн нэгэнтэй хэзээ гэрчлэлээ хуваалцсан бэ? (Иаков 7:12-ыг үзнэ үү). Үр дүн нь ямар байсан бэ?

д. Шерим тэмдэг хүсэх үед Иаков гэрчлэлээ үнэн гэдгийг нотлохыг эрэлхийлээгүй, харин Их Эзэний мутарт үр дүнг нь үлдээсэн (Иаков 7:14-ийг үзнэ үү). Итгэлийг тань сорьдог хүмүүст гэрчлэлээ үнэн гэдгийг нотлох хэрэггүй гэдгийг мэдэх нь танд хэрхэн тусалж чадах вэ?

Иаков 7:15–23

Шерим цохигдож, буруугаа хүлээж, үхсэн бөгөөд цугласан олон нифайчуудыг Их Эзэн рүү эргүүлэн удирдав

Ахлагч Роберт Д.Хэйлс ийн заажээ:



“Бид хариу нэхэлгүй, нөгөө хацраа тавьж өгөн, уур хилэнгийн эсрэг тэвчин зогсож байхдаа Аврагчтай хамт байдаг. Дайсныг намжааж, биднийг гүтгэгчидтэй сөргөлдөхгүйгээр хариулж чадах цорын ганц хүч болох Түүний хайрыг бид үзүүлж чадна. Энэ нь сул дорой байдал биш юм. Энэ нь Христэд итгэгчийн эр зориг юм.

“Бидний итгэлийн сорилтууд нь шинэлэг зүйл биш бөгөөд хурдхан алга болдог зүйл ч биш юм гэдгийг бид олон жилийн туршид суралцаж байна. Гэвч Христийн үнэн шавь нар нь эсрэг тэсрэгийн дундаас боломжийг олж хардаг. . . .


“. . . Аз болоход Их Эзэн биднийг эсэргүүцэгчдийн зүрх сэтгэлийг болоод хэрхэн хамгийн үр дүнтэйгээр хариу өгөх вэ гэдгийг мэддэг. *Үнэнч шавь нар Сүнсний удирдамжийг хайдаг бөгөөд сөргөлдөөн бүрд тохирох сүнсний удирдамжийг хүлээн авдаг. Ямар ч тохиолдолд жинхэнэ шавь нар Их Эзэний Сүнснийг урин дуудах замаар хариу үйлддэг*” (“Christian Courage: The Price of Discipleship,” 72–73).

“Эсрэг тэсрэгийн дундаас боломжийг олж хардаг” гэдэг нь ямар утгатай гэж та бодож байна вэ? _____

Итгэлийг маань сорьдог хүмүүст Их Эзэний Сүнснийг урин дуудах замаар хариулах нь сайн үр дүнг үзүүлнэ. Иаков 7:15–23-ыг уншаад, Шеримтэй сөргөлдсөн Иаковын сайн үр дүнг ол.

Иаков 7:21–22-т Шеримтэй сөргөлдсөн туршлага нь бусдад туслаасай хэмээн хүссэн Иаковын хүслийн ямар нотолгоог та харж байна вэ? _____

Иаков 7:23-т хэлсэнчлэн Иаковын Шеримтэй хийсэн маргаан эцсийн дүндээ олон түмэнд хэрхэн нөлөөлсөн бэ? _____

 **3.** Шеримтэй хийсэн Иаковын маргаанаас суралцаж болох нэг зарчим бол итгэлийнхээ талаарх шүүмжлэл, асуултад хариулахдаа Сүнснийг урих замаар хариулах нь бусдыг Их Эзэнд хандахад нь тусалдаг гэсэн зарчим юм. Энэхүү зарчмын талаарх дараах асуултаудад судрын тэмдэглэлдээ хариулж бич:


а. Энэхүү зарчмыг мэдэж авах нь бусдыг Их Эзэнд хандахад нь хэрхэн тусалж болох вэ?

б. Та энэ зарчмыг хэрхэн хэрэгжүүлж болох вэ?


Иаков 7:24–27

Иаков нифайчууд леменчүүдийн харилцааг тайлбарлан, цэдгээ төгсгөв

Иаков 7:24–27-г унш. Иаков 7:25-д гардаг сорилт бэрхшээлтэй тулгарах үедээ Их Эзэнд найдлагаа тавихын чухлын тухай Иаковын захиасыг онцолсон хэллэгийг тодруул.

 **4.** Судрын тэмдэглэлдээ дараах асуултаудад хариулж бич: Хэн нэгэн итгэлийг тань сорих үед бэлтгэхийн тулд таны хийх нэг зүйл юу вэ?

Хэрэв та итгэлийнхээ талаарх тодорхой асуулт, шүүмжлэлд хэрхэн хариулахаа мэдэхгүй байвал *Итгэлдээ үнэнч байх нь: Судрын заалт*, ахлагч Роберт Д.Хэйлсийн “Christian Courage: The Price of Discipleship” (*Ensign* эсвэл *Лиакхона*, 2008 оны 11-р сар, 72–75) чуулган дээр хэлсэн үгс, LDS.org болон youth.lds.org вэбсайтууд дээрх материалуудыг судлах боломжтой.

 **5.** Дараах өгүүлбэрийг судрын тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Иаков 7-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

Хичээлийн эхэнд хийсэн тохируулах дасгалын хариу: 1) г, 2) в, 3) а, 4) д, 5) б.

Инос

НОМЫН ОРШИЛ

Яагаад энэ номыг судлах хэрэгтэй вэ?

Иносын ном нь Есүс Христийн Цагаатгалын хүч хүмүүсийг нүглээс ариусган цэвэрлэж, тэднийг эдгээдэг болохыг үзүүлдэг. Нүглүүдийнхээ ангижралыг хүлээн авахын өмнө Инос Бурханы өмнө өөртэйгөө тэмцэлддэг. Дараа нь тэр нифайчууд болон леменчүүдийн сүнслэг зол жаргалын төлөө залбирав. Тэрээр амьдралынхаа үлдсэн хугацааг тэдний авралын төлөө хөдөлмөрлөн өнгөрүүлэв. Иносын номыг судлахдаа та залбирал, наманчлал болон илчлэлтийн тухай чухал хичээлүүдийг олж мэдэх болно. Мөн хувь хүмүүс Цагаатгалын адислалуудыг хүлээн авахдаа, тэдгээр адислалуудаа бусадтай хуваалцахыг хүсэх болно гэдгийг та суралцана.

Энэ номыг хэн бичсэн бэ?

Иаковын хүү буюу Лихай, Сариа нарын ач хүү Инос энэ номыг бичсэн. Иносын эцэг түүнд “Их Эзэний халамж хийгээд зөвлөгөөнд” (Инос 1:1) заасныг тэрээр цэдэглэсэн. Амьдралынхаа төгсгөлд ойртох үедээ Инос “Христ дэх тэрхүү үнэний дагуу үгийг” (Инос 1:26) амьдралынхаа турш тунхагласан хэмээн бичжээ. Нас барахаасаа өмнө Инос Нифайн жижиг ялтсуудыг өөрийн хүү Жеромд дамжуулан өгсөн. Инос Гэтэлгэгчийнхээ өмнө зогсох тэрхүү өдрийн төлөө баясан, цэдгээ бичиглэж дуусав. Тэрээр “Тэгээд түүний царайг тааламжтайгаар харж, мөн тэрээр надад: Надад ирэгтүн, адислагдсан болой чи, миний Эцэгийн харшуудад чамд зориулан бэлтгэгдсэн байр буй гэж хэлэх болно” (Инос 1:27) хэмээн тунхагласан.

Энэ ном хаана, хэзээ бичигдсэн бэ?

Инос өөрийн цэдгийг Лихай Иерусалимыг орхин гарснаас хойш 179 жил өнгөрснийг (Инос 1:25-ыг үз) тунхаглан төгсгөдөг. Энэ ялтсуудыг мээ 544 он (Иаков өөрийн цэдгийг дуусгах үед) ба мээ 420 оны хооронд, Инос Нифайн нутагт амьдарч байхдаа бичсэн.

10-Р ХЭСЭГ: 3 ДАХЬ ӨДӨР

Инос

Оршил

Эцгийнхээ үгсийг эргэцүүлэн бодсоныхоо дараа Инос залбирч, өөрийн нүглүүдийн ангижралыг хүлээн авсан. Дараа нь тэр нифайчууд болон леменчүүдийн сүнслэг зол жаргалын төлөө залбирч, өөрийн амьдралыг тэдний авралын төлөө хөдөлмөрлөхөд зориулсан.

Инос 1:1–8

Эцгийнхээ үгсийг эргэцүүлэн бодсоныхоо дараа Инос залбирч, өөрийн нүглүүдийн ангижралыг хүлээн авдаг

Инос 1:1, 3-ыг уншаад, Иност нөлөөлсөн Иаковын нөлөөг анхаар. Инос хэдийгээр бошиглогчдын хүү, ач хүү байсан боловч Есүс Христийн Цагаатгалын хүчийг өөрийн биеэр мэдрэх хэрэгтэй байсан юм.


Маш их өлсөж байсан үеийнхээ тухай бод. Өлсөх үедээ ямар мэдрэмж мэдэрдэг болохоо дараах үгсээ сонгон дугуйл:

хоосон	өвчин
сул дорой	бачимдсан
сэтгэл хангалуун бус	хорхойссон
өлбөрсөн	


Инос 1:4 дэх “бодгаль минь өлссөн” гэдэг үгийг тодруул. Энэ нь юу гэсэн утгатай гэж та нар бодож байна? _____

“Бодгаль минь өлссөн” гэдэг үг нь сүнслэг хоосрол, өвчин, эсвэл сүнслэгээр дүүргэгдэх хүсэл зэрэг мэдрэмжүүдийг багтааж болно. Сүнслэгээр өлссөн туршлагынхаа талаар Инос бичжээ. Эцгийнх нь ярьж байсан үгс “зүрх сэтгэлд нь гүнзгий шингэсэн” талаар Инос бичиглэв (Инос 1:3). Тэдгээр үгсийг тунгаан бодох үед итгэлээр үйлдэхэд хүргэсэн хүсэл эрмэлзлийг тэр мэдрэв. Түүний итгэлтэй үйлдэл амьдралд нь өөрчлөлт болон Их Эзэний адислалыг авчирдаг.




 **1.** Иносын туршлагыг ойлгож, амьдралтайгаа холбоход тань туслах цуврал дасгал хийж эхэл. Ингэхдээ судрын тэмдэглэлийнхээ хуудсыг зургаан хэсэгт хуваагаад, хэсэг бүрийг дараах байдлаар нэрлэ:

Иносын хүссэн зүйл:	Миний хүсэх зүйл:
Иносын хийсэн зүйлс:	Миний хийх хэрэгтэй зүйлс:
Иносын туршлага:	Миний туршлага:


 **2.** Инос 1:2–3-ыг уншаад, шүлэг бүрд гарах амьдралдаа юутай байхыг хүссэнээ илэрхийлэх Иносын үгсийг ол. Судрын тэмдэглэл дэх хүснэгтнийхээ “Иносын хүссэн зүйл” хэмээх хэсэгт эдгээр үгсийг бич.

Нүглийнхээ ангижралыг хүссэн Иносын хүсэл Инос 1:4-т “Бодгаль минь өлссөн” хэмээсэн нь ямар утгатайг ойлгоход бидэнд тусалдаг. Инос өршөөлийн төлөө өлссөнөөс гадна “мөнх амьдрал, бас гэгээнтнүүдийн баясал”-ыг хүссэн юм (Инос 1:3). Их Эзэн болон бусад зөв шударга хүмүүстэй хамт байхуйц зохистой байдлаас ирдэг аз жаргалыг мэдрэхийг тэр хүссэн.


 **3.** Иносын дүрсэлсэн сүнслэг өлсгөлөнгийн зарим мэдрэмж танд байгаа ээхийг эргэцүүлэн бод. Судрын


тэмдэглэл дэх хүснэгтнийхээ “Миний хүсэх зүйл” хэсэгт амьдралдаа өлсдөг сүнслэг хүслийнхээ заримыг бич.

Иносын хүсэл нь түүнийг итгэлээ бодитой болгож, үйлдэл хийхэд хөтөлсөн. Инос 1:2 дахь гаргасан хичээл зүтгэлээ тайлбарлахдаа ашигласан Иносын үгсийг олж тэмдэглэ. Инос *Бурхантай* тэмцэлддэггүй, харин Бурханы *өмнө* залбиралд тэмцэлдсэн гэдгийг анхаар. Иймэрхүү тэмцэлдээн нь Тэнгэрлэг Эцэгт наманчилж, амьдралдаа хэрэгцээтэй өөрчлөлтүүдийг хийх үнэн хүсэл болон чин сэтгэлээ илэрхийлэхийн тулд оюун санаандаа болон сүнслэгээр зовохыг багтаадаг. Инос 1:4-т Инос тэмцэлддэг нээ нарийвчлан дүрслэв.

 **4.** Инос 1:4-ийг уншаад, нүглийнхээ ангижралыг чин сэтгэлээсээ хүсч байсан гэдгээ илэрхийлэх Иносын хийсэн зарим зүйлсийг тэмдэглэ. Судрын тэмдэглэл дэх хүснэгтнийхээ “Иносын хийсэн зүйлс” хэсэгт тодорхойлсон зүйлсээ жагсаан бич.

Инос 1:4-т гардаг гуйлт хэмээх үг нь даруухнаар, агуу их хүсэлтэйгээр асуух гэсэн утгатай. Бидний залбирал Иносынх шиг урт биш байж болно, гэхдээ бид чин сэтгэлээсээ залбирах хэрэгтэй.

 **5.** Судрын тэмдэглэл дэх хүснэгтнийхээ “Миний хийх хэрэгтэй зүйлс” хэсэгт залбирч, түүний сүнслэг адислалуудыг хүсэхдээ чин сэтгэлээ Их Эзэнд харуулахын тулд хийж чадах зүйлсийнхээ талаарх бодлоо бич.

 **6.** Иносын итгэлтэй, чин сэтгэлийн хичээл зүтгэл нь түүний амьдралд агуу адислалуудыг авчирсан. Инос 1:5–8-ыг уншаад, Инос юу тохиолдсоныг тэмдэглэ. Эдгээрийг судрын тэмдэглэл дэх хүснэгтнийхээ “Иносын туршлага” хэсэгт жагсаан бич. 5, 6-р шүлгийг уншихдаа Инос өршөөгдсөнөө хэрхэн мэдэж авсныг анхаар. 5-р шүлэгт дурдагдсан дуу хоолой Иносын оюун ухаанд ирсэн (Инос 1:10-ыг үзнэ үү).

Инос 1:7–8-р шүлгүүд **бид Есүс Христэд итгэх итгэлээ үйлдэл болгох үед бидний нүгэл өршөөгдөж, эдгээгдэх боломжтой гэдгийг заадаг**. Өсөж хөгжих бидний хүсэл, чин сэтгэлийн залбирлууд хийгээд наманчлах хичээл зүтгэл нь Есүс Христэд итгэх итгэлээ харуулах бидний арга замууд юм.

Тэргүүн Зөвлөлийн гишүүн Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф бид Есүс Христэд итгэх итгэлээ үйлдэл болгож, нүглүүдээ наманчлах үед бидний гэм буруу хэрхэн арчигддагийг тайлбарласан юм:




“Бид нэгэнт чин сэтгэлээсээ наманчилсан бол Христ бидний гэм нүглийн ачааг авч хаях болно. Бид өршөөгдөж, эдгэрсэн гэдгээ өөрсдөө мэдэж болно. Ариун Сүнс үүнийг бидэнд батлах болно. Тэр бол Ариусагч. Өршөөлийн талаарх өөр ямар ч гэрчлэл илүү агуу байж чадахгүй. . . .”

“Болгоогтун, нүглүүдээ наманчилсан тэрээр, мөнхүү тэр нь өршөөгддөг ажгуу, Их Эзэн бибээр тэдгээрийг цаашид санах нь үгүй” хэмээн [Их Эзэн] тунхагласан (С ба Г 58:42).


“Бид нүглүүдээ санадаг учраас нүглүүд маань өршөөгдөөгүй гэж Сатан бидэнд итгүүлэхийг хичээдэг. Сатан бол худалч. Тэр бидний нүдийг харанхуйлж, наманчлал болон уучлалын замаас биднийг холдуулахыг хичээдэг. Бид нүглүүдээ санахгүй байх болно гэж Бурхан амлаагүй. Нүглүүдээ санах нь дахин тийм алдаа гаргахгүй байхад маань бидэнд тусалдаг. Гэвч бид үнэнч, итгэлтэй хэвээр үлдвэл, цаг хугацааны туршид нүглүүдийн маань дурсамж хөнгөрөх болно. Энэ нь эдгэрэл болон ариусгалын үйл явцын шаардлагатай нэг хэсэг юм” *Ensign* эсвэл *Лиахона*, 2007 оны 5-р сар, 101).

Ерөнхийлөгч Угдорфын үгсийг хэрэгжүүлэхэд тань туслах дараах асуултуудыг эргэцүүлэн бод: Их Эзэн нүглүүдийг тань өршөөхийг та хэзээ мэдэрсэн бэ? Та өршөөгдсөн гэдгээ хэрхэн мэдсэн бэ? Та Их Эзэний өршөөлийг ойрын үед мэдэрсэн үү?


 **7.** Дээрх асуултуудыг тунгаан бодсоныхоо дараа судрын тэмдэглэл дэх хүснэгтийн “Миний туршлага” хэсэгт уучлалын мэдрэмж хүлээн авсан туршлагаа бич. Эсвэл Есүс Христэд итгэх итгэлээ үйлдэл болгох үед юу мэдэрнэ хэмээн найдаж байгаагаа бичиж болно.

Инос 1:9–27

Инос нифайчууд болон леменчүүдийн төлөө залбирч, бусадтай хамт тэдний авралын төлөө хөдөлмөрлөв



Энэ бүдүүвч зурганд Иносын залбирлыг харуулдаг. Тэрээр эхлээд өөрийнхөө төлөө залбирч, дараа нь залбирлаа бусдын төлөө болгон өргөсгөдөг. Инос 1:9–10-ыг уншаад, Инос хоёрдугаарт хэний төлөө залбирсныг олж, судартаа тэмдэглэ. Инос 1:11–14-ийг уншаад, Инос гуравдугаарт хэний төлөө залбирсныг тэмдэглэ.

 **8.** Дараах асуултад судрын тэмдэглэлдээ хариулж бич: Инос 1:14-т бичсэн леменчүүдийн талаарх Иносын тайлбарыг харахад тэдний төлөөх түүний залбирлын юу нь таныг гайхшруулж байна вэ?

Есүс Христийн Цагаатгалын адислалыг амсах үедээ бид бусдад авралыг хүлээн авахад нь туслахыг эрэлхийлэх болно гэдгийг Иносын үлгэр жишээнээс бид суралцдаг. Энэхүү үнэнийг санахын тулд Ерөнхийлөгч Ховард В.Хантэрын хэлсэн дараах үгсийг бүтнээр нь эсвэл зарим хэсгийг судрынхаа хажуугийн зайд бичих хэрэгтэй:




“Бид Цагаатгалын адислалуудыг өөрсдийн амьдралд амсах үедээ ах дүүсдээ тусалж чадахгүй ч, тэднийхээ зол жаргалын төлөө санаа тавьдаг. . . .

“Хувь хүний хөрвүүлгийн нэг чухал үзүүлэлт бол сайн мэдээг бусадтай хуваалцах хүсэл юм” (*The Teachings of Howard W. Hunter*, Clyde J. Williams [1997] хэвлэл, 248–249).

Инос 1:19–20, 26-г уншаад, нифайчууд болон леменчүүдийн төлөө залбирсны дараах Иносын тэдний төлөө гэсэн чин хүслийг харуулсан үгс эсвэл хэллэгийг олж тэмдэглэ.

Инос 1:27-г уншаад, Иносын хичээл зүтгэлийнхээ хариуд авсан баяр баясал болон мөнх амьдралыг хүлээж авна гэсэн амлалтыг харуулсан хэсгийг ол.


 **9.** Энэ хичээлээс сурсан зүйлсээ хэрэгжүүлэхийн тулд Иносын үлгэр жишээг дагаж болох нэг юмуу хоёр аргыг залбиралтайгаар сонго. Дараах өгүүлбэрүүдээс нэгийг сонгоод, судрын тэмдэглэлдээ гүйцээж бич:

а. Иносын адил би нүглүүдийнхээ ангижралыг хүлээн авахыг хүсч байна. Би үүнийг чин сэтгэлээсээ хүсч байгаагаа . . . -р Их Эзэнд үзүүлэх болно.

б. Иносын адил би өөрийн гэр бүлийн гишүүд болон найз нөхдөө Христэд ирэхэд нь туслах хүсэлтэй байна. Туслахыг хүсч байгаа нэг хүн бол (хүний нэр). Би энэ хүнд . . . -р тусална.

в. Инос өөрийнх нь дайсанд тооцогдох леменчүүдийн төлөө залбирсан. Иносын адил надад елдэг бус ханддаг хүмүүст би Их Эзэний хайрыг үзүүлэхийг хүсч байна. Би үүнийг хийх нэг арга зам бол . . .

Судрын тэмдэглэлдээ бичсэн зүйлсээ биелүүлэхийн төлөө хичээ. Есүс Христийн цагаатгалд итгэх итгэлээ үйлдэл болгож, наманчилснаар та уучлал, баяр баясал, бусдад туслах илүү их хүслийг мэдрэх боломжтой.

 **10.** Дараах өгүүлбэрийг судрын тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Инос 1-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

Жером

НОМЫН ОРШИЛ

Яагаад энэ номыг судлах хэрэгтэй вэ?

Та Жеромын номыг судалснаар Бурхан тушаалуудыг нь дагадаг хүмүүсийг адисална гэсэн амлалтаа биелүүлдэг болохыг мэдэж авна. Мөн Жеромын үед амьдарч байсан нифайчуудын хаад, бошиглогчид, багш нар болон пристүүд хүмүүсийг наманчилж, сүйрлээс зайлсхийхэд нь тусалж байсан тухай сурах болно.

Энэ номыг хэн бичсэн бэ?

Иносын хүү Жером энэ номыг бичсэн. Жером өөрийн эцэг болон өвөө Иаков, элэнц эцэг Лихайн нэгэн адил бошиглол болон илчлэлтийн сүнстэй байв (Жером 1:2-ыг үзнэ үү). Тэрээр цэдгүүдээ бичиж дуусаад ялтсуудыг хүү Омнаидаа дамжуулан өгчээ.

Энэ ном хаана, хэзээ бичигдсэн бэ?

Жеромын номд мээ 420-оос мээ 361 оны хоорондох 59 жилийн түүхийг багтаасан байдаг (Инос 1:25; Жером 1:13-ыг үзнэ үү). Энэ номыг Нифайн нутагт бичсэн.

Омнаи

НОМЫН ОРШИЛ

Яагаад энэ номыг судлах хэрэгтэй вэ?

Омнаин номыг судалснаар Их Эзэн зөв шударга нифайчуудыг хамгаалж, тэднийг Зарахемла руу удирдсан болохыг мэднэ (Омнаи 1:7, 12–13-ыг үзнэ үү). Омнаин номд түүнчлэн Мюлекчүүд (Зарахемлагийн хүмүүс) болон амлалтын нутаг руу Их Эзэний удирдан авчирсан Жаредчууд гэсэн бүлэг хүмүүсийг мөн дурсдаг.

Энэ номыг хэн бичсэн бэ?

Омнаин номыг Омнаи, Амарон, Чемиш, Абинадом, Амаликай гэсэн таван хүн бичсэн. Омнаи бол Жеромын хүү бөгөөд Лихай, Сариа нарын жичинцэр байсан. Тэрээр өөрийгөө “Их Эзэний зарлигуудыг дагадаггүй . . . хилэнцэт нэгэн” хэмээн дүрсэлсэн байдаг (Омнаи 1:2). Амарон (Омнаин хүү), Чемиш (Амароны ах), Абинадом (Чемишийн хүү) нар бүгдээрээ бага зэрэг бичвэрүүдийг бичиж үлдээсэн. Абинадомын хүү Амаликай Омнаин номын ихэнх хэсгийг бичсэн бөгөөд Нифайн бага ялтсууд дээр бичсэн сүүлчийн хүн нь байсан. Тэр ялтсуудыг Бенжамин хаанд дамжуулан өгсөн.

Энэ ном хаана, хэзээ бичигдсэн бэ?

Омнаин номын зохиогчид уг номыг мээ 361-ээс мээ 130 оны хооронд бичсэн. Эхний дөрвөн зохиогч нь өөрсдийн цэдгийг Нифайн нутагт байхдаа бичсэн. Амаликай өөрийн цэдгийг Зарахемлагийн нутагт бичсэн.

Жером ба Омнаи

Оршил

Жером ба Омнаин номууд нь Нифайн бага ялтсуудын төгсгөлийн бичвэрүүдийг агуулдаг. Жером ялтсуудыг эцэг Иносоос авч, нифайчуудын 60 жилийн зовлон зүдгүүр ба адислалын талаар тэмдэглэн үлдээжээ. Тэгээд уг ялтсуудыг өөрийн хүү Омнаид дамжуулан өгчээ. Омнаин ном нь нифайчуудын таван өөр цэдэг хөтлөгчийн бичсэн 230 орчим жилийн түүхийг агуулдаг.

Жером 1:1–15; Омнаи 1:5–7

Их Эзний тушаалуудыг дагах үедээ нифайчууд хэрхэн дэгжиж байсан тухай Жером өгүүлсэн.

Жером ба Омнаин номд заагдсан чухал зарчмыг суралцахад бэлтгэхийн тулд Тэргүүн Зөвлөлийн гишүүн ерөнхийлөгч Дийтр Ф. Угдорфын дараах туршлагыг унш:

“Би цэргийн нисгэгч болохоор бэлтгэгдэж байснаа санадаг. Бид ийн бэлтгэгдэх явцдаа биеийн хүчний дасгал маш их хийдэг байв. Эцэс төгсгөлгүй гүйх нь нисгэгч болоход яагаад тийм их чухал байсныг би одоо ч сайн ойлгодоггүй юм. Бид гүйгээд л, гүйгээд л, гүйгээд л байдаг байлаа.

Би гүйж байхдаа санааг минь зовоосон нэг зүйлийг анзаарсан юм. Гүйж байхад тамхи татдаг, архи уудаг, сайн мэдээний, ялангуяа Мэргэн ухааны үгийн эсрэг зүйлсийг хийдэг хүмүүс миний хажуугаар өнгөрөн гардаг байв.

Тэр үед би: “Байзаарай! Би чинь гүйхэд мөн ядрах нь үгүй байх ёстой биш билүү?” хэмээн бодож байснаа санадаг. Гэвч би *ядарч*, мөн Мэргэн ухааны үгийг дагадаггүй хүмүүст гүйцэгдэж байлаа. Тэр үед энэ нь миний сэтгэлийг зовоодог байсныг би хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Тэр амлалт үнэн юмуу худлаа юмуу гэж би өөрөөсөө асуусан юм.” (“Тэвчээрээр үргэлжлүүл,” 2010 оны 4-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн үгс, 67).

Их Эзэн зарлигуудыг нь дагадаг хүмүүсийг адислах амлалтаа биелүүлдэг эсэх, эсвэл хэрхэн биелүүлдэг бол хэмээн та бодож үзэж байсан уу?

Иносын хүү бошиглогч Жером эцгүүдэд нь өгсөн Их Эзний тодорхой амлалт хэрхэн биелэгдсэн эсвэл үнэн гэдэг нь нотлогдсоныг тайлбарлажээ. Жером 1:9-ийг уншаад, хүмүүст амласан Их Эзний биелэгдсэн амлалтуудыг тэмдэглэ.



1. Бид Бурханы зарлигуудад дуулгавартай байх үедээ дэгжих болно гэдгийг Жером харуулсан.

Энэхүү үнэний жишээг харахын тулд доорх судруудыг судалж, холбогдолтой асуултуудад судрын тэмдэглэлдээ хариулж бич:

а. Жером 1:4–5, 8. Нифайчууд дуулгавартай байж, адислагдсан ямар жишээнүүд байна вэ?

б. Жером 1:7, 10–12. Нифайчуудад дуулгавартай байж, дэгжихэд нь туслахын тулд бошиглогчид болон бусад удирдагчид ямар үүрэг гүйцэтгэсэн бэ?

в. Омнаи 1:5–7. Бурханы амлалт дараа нь ямар өөр арга замаар нотлогдсон бэ?



Мэргэн ухааны үгийн амлалтыг Их Эзэн нотлох эсэхэд эргэлзэж байсан талаар Ерөнхийлөгч Угдорф туршлагаасаа зааж мөн гэрчилсэн зүйлсийг унш: “Хариулт нь тэр даруй ирээгүй. Гэвч яваандаа би Бурханы амлалтууд бидний

хүссэн арга замаар, бидний хүссэн шиг хурдан ирдэггүй, харин Түүний арга замаар, Түүний цаг хугацаанд ирдэг гэдгийг ойлгосон юм. Олон жилийн дараа би Мэргэн ухааны үгийг дагадаг хүмүүст ирдэг материаллаг адислалуудыг болон Бурханы аливаа хуулийг дуулгавартай дагахад даруй ирдэг сүнслэг адислалуудын баталгааг тодоор харсан юм. Одоо би эргээд харахад *Их Эзний амлалтууд үргэлж тэр дороо биш ч заавал биелдэг болохыг мэддэг болсон*” (“Тэвчээрээр үргэлжлүүл,” 67).



2. Их Эзний зарлигуудыг дагасны тань төлөө Тэрээр таныг адисалж, дэгжүүлсэн туршлагаа судрын тэмдэглэлдээ бич. Өөрийн туршлага дээр үндэслэн Их Эзний амлалтуудын тухай та юу гэрчилж чадах вэ?


Омнаи 1:1–30

Цэдэг хөтлөгчид Нифайн түүхийг өгүүлсэн

Жеромын үр удам 230 жилийн түүхийг багтаасан Омнаин номыг бичжээ. Жеромын дараа бага ялтсуудыг хадгалсан хүмүүсийн нэрсийг тэмдэглэ. Омнаи 1:1, 4, 9, 10, 12, 25-р шүлгүүдээс тэднийг олж болно.

Мормоны Номын түүхэн дэх хэдэн чухал үйл явдлуудыг Омнаин ном дүрсэлдэг. Нифайн үед нифайчууд леменчүүдийг орхин явж, Нифайн нутаг хэмээн нэрлэсэн газар оршин суудаг байсныг та санаж байгаа байх. Анхны эзэмшил газраасаа Нифайн нутаг руу нүүснийг газрын зураг дээр сумаар дүрслэв.

Омнаи 1:12–13-ыг уншаад, нифайчууд хэрхэн Зарахемлагийн нутагт амьдрахаар ирснийг ол. Эдгээр шүлэгт нифайчууд Их Эзний удирдлага болон хүчээр аялсан гэдгийг харуулсан ямар ч хэллэгийн доогуур зурж болно. Газрын зураг дээрх Нифайн нутгаас Зарахемлагийн нутаг руу чиглүүлэн зурсан сум нь энэхүү нүүдлийг төлөөлдөг.



Омнаи 1:14–19-ийг уншаад, нифайчууд болон Зарахемлагийн нутагт оршин сууж байсан хүмүүсийн ижил төстэй байдал болон ялгаатай талуудыг ол.

3. Судрын тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

- Сударгүй байх нь Зарахемлагийн хүмүүст хэрхэн нөлөөлсөн бэ?
- Үүнийг мэдэх нь судруудад талархалтай байж, илүү хичээнгүйлэн судлахад тань хэрхэн туслах вэ?

Омнаин ном нь түүнчлэн Мормоны Номын төгсгөл хэсгээр судлах хоёр өөр бүлэг хүмүүсийг танилцуулна. Нэг бүлэг хүмүүсийг нь мэдэхийн тулд Омнаи 1:20–22-ыг уншаад *Жаредчууд* гэдэг үгийг судартаа уг шүлгүүдийн хажууд бич. Кориантумр бол Жаред үндэстнээс амьд үлдсэн хоёр хүний нэг нь бөгөөд нөгөө хүн нь бошиглогч Ифер байсан юм.

Та Жаредчуудын талаар Иферийн номоос судлах болно.

Омнаин номд дурдагдсан сүүлчийн бүлэг хүмүүсийн тухай сурахын тулд газрын зураг дээр Зарахемлагийн нутгаас Нифайн нутгийн ойролцоо очоод, буцаж Зарахемла руу явсан сум болон дахиад Зарахемлагийн нутгаас Нифайн нутаг хүртэл явсан сумыг хар. Эдгээр сумнууд нь Омнаи 1:27–30-д гардаг Зенифийн хүмүүсийн нүүдлийг төлөөлдөг. (Эдгээр шүлгүүдийн хажууд “Зенифийн хүмүүс” гэж бичиж болно.) Та Мозаягийн номоос судлахдаа энэхүү бүлэг хүмүүсийн талаар суралцах болно.

Мормоны Ном нь Америкт амьдарч байсан бүх бүлэг хүмүүсийн цэдгийг багтаадаггүй. Жаредчууд, Зарахемлагийн хүмүүс, Лихайн үр удмаас гадна өөр бусад хүмүүс мөн адил Америк тивд очсон. Тэргүүн Зөвлөлийн гишүүн ерөнхийлөгч Антони В.Ивинс 1929 оны Ерөнхий чуулган дээр ингэж хэлжээ: “Мормоны Ном . . . [Мормоны Номд гардаг хүмүүсээс] өмнө энд хэн ч амьдарч байгаагүй гэж хэлдэггүй. Тэднээс хойш өөр хүмүүс ирээгүй гэж бас хэлдэггүй” (in Conference Report, 1929 оны 4-р сар, 15).

Энэ номын төгсгөл хэсгийг Амаликай бичиглэсэн гэж Омнаи 1:23–24-т гардгийг анхаар. Тэрээр нифайчууд Зарахемла руу нүүсний дараа, Хаан Бенжамини үед амьдарч байсан. Омнаи 1:25–26-г уншаад, Амаликайгийн гурван удаа хэлсэн урилгыг тэмдэглэ.

Омнаи 1:25–26-д гардаг Христэд ирэхийг урьсан гурван урилга тус бүрийн ард *мөн* хэмээх үг байгаа бөгөөд Христэд хэрхэн ирэхийг бидэнд мэдүүлсэн тодорхой чиглүүлэл байгааг анхаар. Омнаи 1:25–26-г дахин уншиж, Амаликай бидэнд Христэд ирэхийн тулд юу хийхийг урамшуулж байгааг олж тэмдэглэ.


Христэд хэрхэн ирэхийг зөвлөсөн дараах зөвлөгөөг та олсон байх ёстой:

- Итгэх
- Түүний авралаас хүртэх (Түүний Цагаатгалын адислалуудыг хүлээн авах)
- Өөрийн бодгалийг Түүнд өргөл болгон өгөх (зүрх сэтгэл, хүсэл эрмэлзэл, юуг ч хойш тавилгүй хамгийн сайн хичээл зүтгэлээ өгөх)
- Мацаг барьж, залбир
- Эцсийг хүртэл тэвч

Сударт давтан хэлэгдсэн үгс, хэллэг болон санаануудыг олж хар


Судрыг бичсэн хүмүүс чухал үнэнүүдийг давтан өгүүлж онцолдог. Та давтагдсан үг хэллэг, санаануудыг олоод, тэдгээрийг яагаад онцолсон болохыг түүнчлэн Их Эзэн таныг тэдгээрээс юу сураасай гэж хүсч байгааг ойлгохыг эрэлхийл.

Омнаи 1:26-ийн төгсгөлд Амаликай түүний зөвлөгөөг дагах хүмүүст амлалт өгөв. Амлалтыг олж, дараах зарчмыг гүйцээ: **Хэрэв бид Христэд ирж, эцсээ хүртэл тэвчвэл** _____

 **4.** Дээр жагсаасан Христэд хэрхэн ирэх зөвлөгөөнөөс нэг өгүүлбэрийг сонгоод, энэхүү зарчмыг дагаснаар бид хэрхэн Христэд ирэхийг тайлбарласан нэгээс хоёр минутын яриаг судрын тэмдэглэлдээ тоймлон бич.

Жишээ нь, Христэд ирэхэд мацаг барьж, залбирах нь бидэнд хэрхэн тусалж болох талаар яриа бэлдэж болно. Та яриандаа (1) Омнаи 1:25–26-г уншаад, өөрийн үгээр сонгосон хэллэгээ тайлбарлах; (2) уг хэллэгт нэмэлт утга санаа өгөх, эсвэл илүү ойлгомжтой болгох өөр судар хуваалцах; (3) сонгосон хэллэгт тань жишээ болох өөрийн эсвэл таньдаг хэн нэгний тань амьдралд тохиолдсон туршлагыг хуваалцах; (4) өөрийнхөө бодол, мэдрэмж болон гэрчлэлийг хуваалцах зэрэг багтаж болно.

Дараагийн удаа багштайгаа уулзахад тань яриагаа хуваалцахыг тэр танаас хүсч магадгүй. Та гэр бүлийн үдэш эсвэл өөр нөхцөл байдалд энэ яриагаа хуваалцаж болно.

 **5.** Дараах өгүүлбэрийг судрын тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Жером–Омнаин бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:



Мормоны Үгс НОМЫН

ОРШИЛ

Яагаад энэ номыг судлах хэрэгтэй вэ?

Мормоны Үгсийг судалснаар та “Их Эзэн бүх зүйлийг мэддэг” (Мормоны Үгс 1:7) ба Тэрээр зорилгуудаа гүйцэлдүүлэхийн тулд Өөрийн үйлчлэгчдийг удирддаг гэдэгт итгэх итгэлээ өсгөж чадна. Түүхийн бичвэрийн хувьд энэ ном нь Нифайн бага ялтсууд (1 Нифай–Омнаи) ба Нифайн их ялтсуудын хураангуйлсан бичвэрийн (Мозая–4 Нифай) хоорондын гүүр нь болдог. Мормоны Үгс нь танд Мормоны Номыг бошиглогч Мормон эмхэтгэхдээ аль цэдгүүдийг хураангуйлсан гэдгийг илүү сайн ойлгоход тусална. Энэ нь мөн Хаан Бенжамини итгэл ба амжилт ололтын тухай танилцуулдаг.

Энэ номыг хэн бичсэн бэ?

Мормон энэ номыг бичсэн. Тэр бол бошиглогч, цэдэг хөтлөгч, Мормоны Номын хураангуйлан эмхэтгэгч байсан. Мормоны Номыг түүний нэрээр нэрлэжээ. Тэрээр түүнчлэн нифайчуудын генерал, зөв шударга эцэг байсан. Бошиглогч Моронай бол түүний хүү юм.

Энэ ном хаана, хэзээ бичигдсэн бэ?

Мормон энэ номоо “өөрийн хүмүүс, нифайчуудын бараг л бүх устгалыг гэрчилсэн” хойноо буюу мэ 385 оны үед бичсэн (Мормоны Үгс 1:1). Мормон энэ номоо хаана бичсэнээ өөрийн цэдэгт дурдаагүй.

Мозая номын

ОРШИЛ

Яагаад энэ номыг судлах хэрэгтэй вэ?

Та Мозаягийн номыг судалснаар Есүс Христийн номлолын тухай хүчирхэг гэрчлэлүүдийг унших болно. Та Их Эзэн нүглийн хүлээснээс эсвэл бие махбодын хүлээснээс нь сулласан хүмүүсийн тухай мөн судлах болно. Цаашлаад хаан Бенжамин, Абинадай болон Алма зэрэг зөв шударга хүмүүсийн хичээл зүтгэл нь бусад хүмүүст ямар агуу адислалуудыг авчирсан болохыг суралцана. Та мөн Зениф ба түүний хүү Ноа хаан зэрэг хүмүүсийн буруу сонголтууд өөрсдөд нь болон тэдний ард түмэнд ямар сөрөг үр дагавруудыг авчирч байгааг харах болно.

Энэ номыг хэн бичсэн бэ?

Мормон Мозаягийн номыг гаргахдаа хэд хэдэн зохиогчдын цэдгүүдийг нийлүүлэн хураангуйлсан. Энэ номыг хаан Бенжамини хүү Мозаягийн нэрээр нэрлэжээ. Мозая бол бошиглогч, үзмэрч, илчлэгч бөгөөд МЭӨ 124-өөс МЭӨ 91 оны хооронд Зарахемлагийн хаан байсан юм. Түүнд Зарахемлагийн хаан байсан өвөөгийнх нь Мозая гэдэг нэрийг өгчээ (Омнаи 1:12–13, 19-ийг үзнэ үү).

Мормон олон цэдгүүдийг нийлүүлэн Мозаягийн номыг эмхэтгэжээ. Тэрээр Зарахемлагийн нутагт амьдардаг нифайчуудын түүхийг агуулсан Нифайн том ялтсууд дахь Мозаягийн хадгалсан ялтсуудаас эш татан, хураангуйлсан (Мозая 1–7; 25–29-ийг үзнэ үү). Тэр мөн Зарахемлаг орхин гараад, дараа нь буцаж ирсэн Зенифийн хүмүүсийн тухай өгүүлсэн Зенифийн цэдгүүдийг ашигласан (Мозая 7–22-ыг үзнэ үү). Мормон Абинадайн үгсийг (Мозая 17:4-ийг үзнэ үү) мөн өөрийн ард түмний цэдгийг агуулсан Алмагийн бичвэрийн хураангуйлсан хэсгээс эш татсан (Мозая 18; 23–24-ийг үзнэ үү).

Энэ ном хаана, хэзээ бичигдсэн бэ?

Мозаягийн номыг бичихэд ашигласан эх цэдгүүдийг МЭӨ 200-аас МЭӨ 91 оны үед бичсэн байх магадлалтай бөгөөд Мормон эдгээр цэдгийг МЭ 345-аас МЭ 385 оны хооронд хураангуйлсан. Мормон энэ номыг хаана эмхэтгэсэнээ бичээгүй.

Мормоны Үгс— Мозая 2

Оршил

Мормоны Үгс хэмээх энэ ном нь Нифайн бага ялтсууд ба Мормоны хураангуйлсан Нифайн их ялтсуудын хоорондын гүүр нь болдог. Есүс Христийн төрөлтөөс бараг 400 жилийн дараа бичигдсэн энэхүү ном нь Нифайн бага ялтсууд гэж юу болох, эдгээр нь Мормоны хувьд яагаад бусад ариун бичээсүүдийг багтаах ёстой гэж санагдсаныг товчхон тайлбарладаг. Түүнчлэн Мормоны Үгс нь Хаан Бенжамин яагаад хүмүүс агуу нөлөө үзүүлж байсныг тайлбарласан үнэ цэнэтэй тайлбарыг багтаадаг.

Нифайн бага ялтсууд нь үндсэндээ сүнслэг зүйлс, бошиглогчдын тохинуулал ба заасан зүйлсэд зориулагдсан байдаг. Нифайн их ялтсууд дээр Нифайн эхлүүлсэн, хаадаар бичиглэгдсэн хүмүүсийн шашны бус түүхийг голчлон багтаасан аж. (1 Нифай 9:2–4-ийг үз.) Мозаягийн үеэс эхлээд их ялтсууд дээр мөн чухал сүнслэг зүйлсийг бичиглэжээ.

Иосеф Смитэд хүргэгдсэн Мормоны буюу алтан ялтсууд нь Нифайн их ялтсуудаас Мормоны хураангуйлсан олон тайлбарыг агуулсан байдаг. Эдгээр ялтсууд нь мөн Мормоноор бичигдсэн түүхийн үргэлжлэл болон түүний хүү Моронайн нэмэлтүүдийг багтаадаг.



Мозая 1 нь хаан Бенжамин хөвгүүддээ заасан зүйлсийн цэдэг юм. Бурханыг санахад мөн Түүний тушаалуудыг сахихад судрууд бидэнд тусалдаг хэмээн тэрээр заасан. Амьдралынхаа төгсгөлд хаан Бенжамин өөрийн хүмүүст хандан хааны хувьд өөрийн үйлчлэлийн талаар ярьж, тэднийг Бурханд дуулгавартай байхыг уриалахыг хүсч байлаа. Бенжамин хааны яриа Мозая 2–5-д цэдэглэгдсэн бөгөөд Христийн зовлон шаналал, Цагаатгал, шударга ёс ба нигүүлслийн үүрэг болон гэрээгээр дамжуулан Христийн нэрийг өөрсдөдөө хүлээн авах хэрэгтэйг тайлбарласан байдаг. Мозая 2-т цэдэглэгдсэн ярианыхаа эхэнд Бенжамин хаан бусдад үйлчилснээр



Бурхандаа үйлчлэх нь шаардлагатай бөгөөд зарлигуудыг дагадаг хүмүүсийн аз жаргалын тухай онцлон ярьжээ.

Мормоны Үгс 1:1–11

Бурхан олон цэдгийг мэргэн зорилгын төлөө хадгалсан гэдгийг Мормон гэрчлэв

Ямар нэгэн юм хийх хэрэгтэй гэж Сүнсээр өдөөгдөж байсан үеэ бод. Хүлээн авсан сүнслэг нөлөөллөө дагаснаар юу тохиолдохыг та мэдэж байсан уу? Таныг сүнслэг нөлөөллөө дагахад юу нөлөөлсөн бэ?

Нифайн ялтсууд дээр бичигдсэн хүмүүсийн цэдгүүдийг хураангуйл хэмээн бошиглогч Мормонд Бурхан зарлиглажээ. мэ 385 оны үед өөрийн хүү Моронайд хураангуйллаа өгөх гэж байхдаа тэр үр дагаврыг нь мэдээгүй ч сүнслэг нөлөөллийг дагасан.

Мормон цэдгүүдийг судалж байхдаа нэгэн зүйлийг олов. Тэрээр юу олсныг мэдэхийн тулд Мормоны Үгс 1:3-ыг унш. (“Эдгээр ялтсууд” гэдэг нь Нифайн бага ялтсууд бөгөөд энэ нь 1 Нифайгаас Омнаиг хүртэлх цэдгийг агуулдаг.) Мормоны Үгс 1:4–6-г уншаад, эдгээр бага ялтсууд дээр бичиглэгдсэн зүйлсийг Мормон олоод, яагаад баясаж байсныг судартаа тэмдэглэ.

Мормоны Үгс 1:7-г уншаад, Мормон яагаад эдгээр бага ялтсуудыг Нифайн ялтсуудын хураангуйлалтай нийлүүлснийг тодорхойл. Энэ зарчмыг судартаа тэмдэглэх хэрэгтэй: **“Их Эзэн бүх зүйлийг мэддэг.”** Энэхүү үнэнд итгэж, ойлгосноор та Ариун Сүнснээс хүлээн авах сүнслэг нөлөөллүүдэд дуулгавартай байх итгэлийг хөгжүүлж чадна.

Их Эзэн Нифайд бага ялтсуудыг хийж, тэдгээр дээр өөрийн хүмүүсийн ариун зүйлүүдийг бичиглэ хэмээн зарлиглажээ (1 Нифай 9:3-ыг үзнэ үү). Тэр үед Нифай “эдгээр ялтсуудыг түүний мэргэн зорилгын тулд бүтээхийг Их Эзэн надад зарлигласан, миний мэдэх нь үгүй тэрхүү зорилго буюу” хэмээсэн (1 Нифай 9:5).

Энэхүү зорилго нь хэдэн зууны дараа 1828 онд Бошиглогч Иосеф Смит алтан ялтсуудыг орчуулж эхлэх үед ойлгомжтой болсон юм. Тэрээр эхлээд Нифайн их ялтсуудын Мормоны хураангуйллаас 116 хуудас гар бичмэлийг орчуулсан бөгөөд Мартин Харрист эдгээр хуудсуудыг авч явахыг зөвшөөрөхөд эдгээр нь алдагдсан эсвэл хулгайлагджээ. Их Эзэн Иосефт алдагдсан хуудсуудыг дахин орчуулах хэрэггүй, учир нь муу хүмүүс алдагдсан хуудсууд дээрх үгсийг өөрчлөөд, Мормоны Номын бодит байдлыг худал хэмээн шившиглэхээр төлөвлөсөн хэмээн хэлжээ. Их Эзэн түүнд их ялтсуудтай нэгэн үед бичигдсэн бага ялтсууд дээрх түүхийг орчуул хэмээн хэлэв. Энэхүү түүх нь ариун зүйлс дээр илүү төвлөрсөн юм. (С ба Г 10:10, 41–43; мөн 1 Нифай 9:3–4-ийг үзнэ үү.)

Энэ явдал нь Их Эзэн ирэх бүх зүйлийг мэддэг гэдгийн томоохон нотолгоо юм. Тэрээр бага ялтсууд дээрх түүх хэрэг болно гэдгийг мэдсэн бөгөөд ялтсуудыг хураангуйлалтайгаа нийлүүл хэмээх сүнслэг нөлөөллийг Мормонд өгсөн.

Энэхүү үнэнийг мэдэх нь Сүнснээс ирэх нөлөөллийг хүлээн авах үед танд хэрхэн тусалж болох вэ?



1. Та эсвэл таны таньдаг хэн нэгэн Ариун Сүнснээс ирсэн нөлөөллийг эхлээд ойлгоогүй байсан ч дагаж, үйлдэл хийсэн үеэ судрын тэмдэглэлдээ дүрслэн бич. Их Эзэний сүнслэг нөлөөллүүдийг таньж мэдэн, хариу үйлдэл хийхэд хэрхэн илүү сайн бэлдэж чадах тухайгаа бич. Их Эзэний Сүнсний нөлөөлөлд итгэлтэй байвал Тэрээр “тааллынхаа дагуу [танд] оршин ажиллах болно” гэдгийг сана (Мормоны Үгс 1:7).

Мормоны Үгс 1:12–18

Бенжамин хаан леменчүүдийг ялж, зөв шударгаар хаанчлав

Хаан Бенжамин хаанчлалынхаа үед леменчүүдтэй хийсэн дайн, хүмүүсийнх нь дундах сургаалын зөрчилдөөн зэрэг олон саад бэрхшээлтэй нүүр тулгарч байсан зөв шударга хаан юм. Хаан Бенжамин нифайчуудын армийг дайсных нь эсрэг “Их Эзэний хүчээр” удирдан, яваандаа уг нутагт амар амгаланг тогтоов (Мормоны Үгс 1:13–14-ийг үзнэ үү). “Олон ариун хүмүүсийн” тусламжтайгаар, олон хүнийг зөрчилдөөнд удирдсан хуурамч бошиглогчид,



хуурамч багш нарыг зэмлэхээр хөдөлмөрлөж, зөв шударгаас ирдэг амар амгаланг тогтоов (Мормоны Үгс 1:15–18-ыг үзнэ үү).

Мормоны Үгс 1:12–18-ыг уншаад, дараах үнэнүүдийг хамгийн сайн заасан шүлгүүдийн тоог хоосон зайд бөглө.


- Их Эзэн сорилт бэрхшээлийг үл харгалзан хүмүүсийг амар амгалан руу удирдаж чадах бошиглогчдыг дууддаг. _____
- Бид бошиглогчдын сүнслэгээр нөлөөлөгдсөн удирдамжийг дагаснаар амар амгаланг олж чадна. _____
- Их Эзэний хүч чадалтайгаар бид бэрхшээлүүдийг даван туулж чаддаг. _____

Мозая 1:1–18

Хаан Бенжамин өөрийн хөвгүүдэд судруудын ач холбогдлыг заадаг.

Хэрвээ танд унших, судлах, заалгах судар огт байгаагүй бол таны амьдрал ямар байх байсныг төсөөл.

Хаан Бенжамин хөвгүүддээ хэрэв тэдэнд судар байгаагүй бол тэдний амьдрал ямар өөр байх байсныг заадаг. Мозая 1:3–5-д цэдэглэснээр, судруудын ач холбогдлыг хөвгүүддээ ойлгуулахын тулд “эдгээр зүйлүүд [судрууд] байгаагүй аваас” хэмээн гурван удаа хэлжээ.

 **2.** Мозая 1:1–8-ыг уншихдаа, тэдэнд судар байгаагүй бол нифайчуудын алдах байсан адислалуудыг олж мэд. Сурсан зүйлсээ Омнаи 1:17–18-тай харьцуул. Дараах өгүүлбэрийг гүйцээхдээ гурав юмуу дөрвөн өөр янзаар хариулан судрын тэмдэглэлдээ бич: Хэрвээ надад судар байгаагүй бол . . .

Дараах зарчмыг судартаа Мозая 1:1–8-ын хажууд бичих хэрэгтэй: **Судруудыг судлах нь бидэнд зарлигуудыг мэдэж, тэдгээрийг дагахад тусалдаг.**

Хаан Бенжамин зарлигуудад итгэлтэй байхын чухлыг өөрийн хүмүүст зааж, “Их Эзэний ихэд таалсан хүмүүс” зөрчилд унавал юу тохиолддогийг тайлбарлав (Мозая 1:13). Мозая 1:13–17-г уншаад, Мозая 1:13-ыг Алма 24:30-тай харьцуул. Дараа нь Их Эзэнээс нүүр буруулдаг хүмүүсийн дээр ирдэг хамгийн багадаа таван үр дагаврыг олж тодорхойл. Эдгээр үр дагавруудыг судартаа тэмдэглэж эсвэл дугаарлах хэрэгтэй.

Мозая 2:1–41

Нифайчууд хаан Бенжамин үгийг сонсохоор цугларав

Мозая 2:1–9-ийг уншаад, дараах асуултуудын хариултыг бич:



- Хэн цугласан бэ? _____
- Тэд хаана цугласан бэ? _____
- Цугласан олонд Бенжамин хааны үгийг сонсгохын тулд юу хийсэн бэ? _____

Бенжамин хааны дүрийг илүү сайн ойлгохын тулд Мозая 2:11–15-ыг уншаад, Бенжамин хаан нэр хүнд эсвэл сайшаал магтаалаас илүү зөв шударга байдал болон үйлчлэлд анхаарлаа хандуулдаг хүн байсныг харуулсан хэллэгүүдийг тодорхойл.




Дараа нь Ерөнхийлөгч Ховард В.Хантэрын хэлсэн дараах үгсийг тунгаан бод: “Нэр хүндэд санаагаа хэт их бүү зовоо. ‘Тэргүүн эгнээ’ эсвэл ‘тэргүүн суудлыг’ эрэлхийлдэг хүмүүсийн талаар хэлсэн Их Эзэний зөвлөгөөг санаж байна уу? ‘Харин та нарын дундах хамгийн агуу нь зарц болог’ (Матай 23:6, 11.) . . . Хүмүүсийн талархлыг хүлээх чухал ч гэсэн бид сайшаал магтаалд бус зөв шударга байдалд; нэр хүндэд биш үйлчлэлд анхаарлаа хандуулах ёстой (“To the Women of the Church,” *Ensign*, 1992 оны 11-р сар, 96).

Мозая 2:16–17-г судлаад, Бенжамин хаанаас үйлчлэлийн тухай сурч болох зарчмыг олж тэмдэглэ: **Бид бусдад үйлчилж байхдаа Бурхандаа үйлчилж байдаг.** (Мозая 2:17 бол төгс эзэмших судар юм. Дараа нь олоход хялбар болгож бусдаас өөрөөр тэмдэглэх хэрэгтэй.)

Хэн нэгэн танд үйлчилснээр таны амьдралыг адисалсан үеийн талаар бод. Танд болон Бурханд зөв шударгаар үйлчилсэн хүний төлөө та Бурханд

хэрхэн талархсан бэ (эсвэл талархаж болох вэ)? Тэр хүнд талархлаа хэрхэн илэрхийлсэн бэ?

Хүмүүстээ бусдад үйлчлэх хэрэгтэй талаар заасны дараа хаан Бенжамин Бурхан биднийг адисалдаг олон арга замууд болон бид Түүнд талархалтай байх хэрэгтэй талаар заав.

 **3.** Мозая 2:19–24, 34-ийг судлахдаа, Бурхан таныг адисалдаг олон арга замуудын талаар тунгаан бод. Та Түүнд талархлаа хэрхэн илэрхийлж болох тухайгаа бод. Судрын тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

а. Хаан Бенжамин яагаад өөрийгөө, өөрийн хүмүүсийг болон биднийг “ашиггүй зарц нар” гэсэн бэ?

б. Бид Бурханд өртэй гэдгээ санах нь яагаад чухал вэ?

Бид Бурханд өртэй гэдгээ санахдаа бусдад үйлчлэхийг хүсч, бидний талархал өсдөг хэмээн Хаан Бенжамин үгс бидэнд заадаг.

Бид Бурханд өөрт байгаа бүхнээ мөн өөрийгөө “өгөх” хэрэгтэй гэж хаан Бенжамин Мозая 2:34-т заасан. Өгөх гэдэг нь “зориулах, захирагдах” гэсэн утгатай. Судартаа уг үгийн хажууд тодорхойлолтыг нь бичиж болно. Та өөрт байгаа бүхнээ мөн өөрийгөө хэрхэн Бурханд өгч болохыг тунгаан бод. Бурханы зарлигуудыг дагаж, үйлчлэхийг эрэлхийлэх үед Тэр таныг үүний тань төлөө адислах болно гэдгийг санаарай.

Мозая 2-ын сүүлийн шүлгүүд Хаан Бенжамин хүмүүстээ өгсөн чухал сэрэмжлүүлгийг багтаасан байдаг. Та урьд нь “болгоомжтой бай” гэсэн тэмдгийг харж байсан уу? (Жишээлбэл: өндөр хүчдэлийн шугам, дээрээс чулуу унах, зэрлэг амьтад, эсвэл усны хүчтэй урсгал зэргийн талаар сэрэмжлүүлсэн тэмдэг.) Хаан Бенжамин өөрийн хүмүүсийг юунаас сэрэмжлүүлснийг олж мэдэхийн тулд Мозая 2:32–33, 36–38-ыг унш. (33-р шүлэгт гардаг халаг гэдэг үг нь “харамсал ба гаслан” гэсэн утгатай.) “Бурханы эсрэг тэмцлээр гарч ирэх” (37-р шүлэг) эсвэл Бурханы зарлигуудыг санаатайгаар зөрчдөг тэдэнд юу тохиолдохыг дүрсэлсэн нэг өгүүлбэр бич. _____

Дараах зүйлсийг унш: “Зарим хүмүүс ариун сүмд орох, эсвэл номлолд үйлчлэхээсээ өмнө наманчилна гэж бодон санаатайгаар Бурханы зарлигуудыг зөрчдөг. Иймэрхүү санаатайгаар үйлдсэн нүгэл нь Аврагчийн Цагаатгалыг тохуурхаж байгаа хэрэг юм” (*Залуучуудын бат бөх байдлын төлөө* [товхимол, 2011], 29).

Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Дэвид А.Бэднар Сүнсийг үргээж байгаагаар таньж мэдэхийн чухлыг ийн онцлон хэлсэн:



“Бид [өөрсдийгөө] Их Эзэний Сүнснээс холдуулах . . . үедээ үүнийгээ мэдэхийн тулд хичээх хэрэгтэй (Мозая 2:36). . . .

“Жишиг нь ойлгомжтой байдаг. Хэрэв бид Ариун Сүнсийг үргээх ямар нэг зүйлийг бодож, харж аль эсвэл хийж байгаа бол тэр зүйлээ даруй бодож, харж, үйлдэхээ зогсоох хэрэгтэй. Ариун Сүнснээс холдуулах зугаа цэнгэл нь бидэнд тохирохгүй. Сүнс нь соёлгүй бүдүүлэг, даруу бус зүйлстэй хамт оршдоггүй учраас энэ нь ч бас бидэнд тохирохгүй. Бид оролцох ёсгүй үйл ажиллагаануудад оролцсоноор Их Эзэний Сүнсийг үргээдэг тул тиймэрхүү төрлийн үйл ажиллагаанууд нь бидэнд явч тохирохгүй” (“That We May Always Have His Spirit to Be with Us,” *Ensign, Лиахона*, 2006 оны 5-р сар, 30).

Хүмүүс заримдаа өөрсдөө ч анзааралгүйгээр Сүнснээс өөрсдийгөө холдуулахдаа юу алддаг тухай тунгаан бод. Мозая 2:40–41-ийг уншаад, Бенжамин хаан юуг санаж, юуны тухай эргэцүүлэн бодохыг биднээс хүссэнийг олж тодорхойл.

 **4.** Судрын тэмдэглэлдээ:

а. Хэрэв та Их Эзэнд дуулгавартай байвал материаллаг болон сүнслэг байдлын аль алианаар нь адислагдах болно гэдгийг танд заасан туршлагаа бич.

б. Бурханы зарлигуудад илүү дуулгавартай байхыг хүсч байгаа нэг зүйлийг сонго. Тэр зүйлээ хэрхэн сайжруулах зорилгоо бич.

Төгс эзэмших судар—Мозая 2:17


Матай 22:36–40; 25:40 болон Мозая 2:17-г унш. Эдгээр судруудыг хамтад нь холбогдох эшлэл болгон судрын жагсаалт, гинж, эсвэл багц хий. Судар судлах энэхүү арга нь утгыг илүү тодорхой болгож, ойлголтыг нэмэгдүүлэхэд тусална.

Холбоос үүсгэсэн хэсгүүдийн хоорондын холбоог тайлбарла. _____

Дараах асуултуудыг тунгаан бод:

- Та хэн нэгэнд үйлчилж байхдаа Бурханд үйлчилж байгаа мэдрэмжийг хэзээ мэдэрсэн бэ?
- Хэрэв Аврагч энд байсан бол таны эргэн тойронд байгаа хүмүүст хийх байсан ямар зүйлсийг та хийж өгч чадах вэ?

 **5.** Мозая 2:17-г цээжлэхээр давтсаныхаа дараа судрын тэмдэглэлдээ цээжээр бич.

 **6.** Дараах өгүүлбэрийг судрын тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Мормоны Үгс-Мозая 2-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

11-Р ХЭСЭГ: 2 ДАХЬ ӨДӨР

Мозая 3

Оршил

Өөрийн хүмүүст хандан хэлэх үгээ үргэлжлүүлэхдээ хаан Бенжамин Есүс Христийн тохинууллын талаар тэнгэр элч түүнд ярьсан хэмээн хэлжээ. Нүгэл үйлдэгсэд нь Есүс Христэд итгэх итгэл ба наманчлалаар дамжуулан авралыг хүлээн авч чадна гэдгийг хаан Бенжамин гэрчилсэн. Түүнчлэн Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан хувь хүн нь Ариун Сүнсний таталтанд автагдан, эгэл хүнээ орхиж чадна хэмээн тэрээр заав.

Мозая 3:1–10

Хаан Бенжамин Цагаатгалын талаар тэнгэр элчийн үгийг хүргэв



Зөвхөн амсахын тулд та шилэн аяганд хэр их ус хийх байснаа зур.



Цангаагаа тайлахын тулд та шилэн аяганд хэр их ус хийх байснаа зур.



Ус нь аз жаргалыг төлөөлж байгааг мэдсэн бол та шилэн аяганд хэр их ус хийх байснаа зур.

Мозая 3-ыг судлахдаа “агуу их баясгалангийн баярт мэдээ”-ний эх сурвалж нь юу болохыг ол (Мозая 3:3).

Мозая 3:1–5-ыг уншаад, тэнгэр элч хаан Бенжаминд юу гэж хэлснийг ол. Тэнгэр элч хаан Бенжаминь хүмүүст баясч, баяр баясгалангаар дүүргэгдэх шалтгаан байгаа хэмээн тунхаглажээ.

Тэнгэр элчийн мэдээнд нифайчуудыг баяр баяслаар дүүргэх юу байсан бэ? _____

Мозая 3:5–10-ыг уншаад, Аврагчийн мөнх бус тохинуулалд илүү талархалтай байхад тань туслах Аврагч болон Түүний тохинууллын тухай үг хэллэгүүдийг олж тэмдэглэ.



1. Тэмдэглэсэн хоёр өгүүлбэрээ сонгоод, тэдгээр нь Аврагчийн тохинууллыг илүү сайн ойлгож, үүнд илүү талархалтай байхад тань туслах юу зааж байгааг судрын тэмдэглэлдээ тайлбарлан бич.

Мозая 3:5–10-т олон сургаал болон зарчмуудыг заадаг. Хамгийн чухал зүйлсийн нэг нь: **Есүс Христ зовж шаналсан болохоор бид нүглүүдээсээ аврагдах боломжтой гэдэг сургаал юм.** Энэ сургаалыг судартаа Мозая 3:7–9-ийн хажууд бичих хэрэгтэй.

Мозая 3:7–9-ийг уншсаны дараа Лук 22:44 болон Сургаал ба Гэрээ 19:16–18-ыг унш. Мозая 3-р бүлэг ямар нэмэлт ойлголтыг өгдөг вэ? Аврагчид тохиолдсон зүйлд талархалтай байхад Мозая 3 бидэнд хэрхэн туслах вэ?

Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Жэймс И.Талмэжийн Гетсемани цэцэрлэг дэх Аврагчийн шаналлын талаар хэлсэн дараах үгсийг унш.



“Цэцэрлэг дэх Христийн тарчлалын хэр хэмжээ болон учир шалтгааныг аль ч талаас нь эгэл хүний хязгаарлагдмал оюун ухаанаар ойлгох аргагүй юм. . . . Дэлхий дээр амьдарч байсан өөр ямар ч хүн дааж давж чадахааргүй тийм ачаан дор тэр зовон тарчилж байсан юм. Түүний сүв бүрээс цус шүүрэхэд хүргэсэн тарчлал нь зөвхөн бие махбодын өвдөлт эсвэл оюун ухааны шаналлаас болоогүй, харин гагцхүү Бурхан л тэсэн гарч чадах бодгалийн шаналал байлаа. . . . Шаналлын тэрхүү мөчид Христ “энэ дэлхийн хун тайж” [Иохан 14:30] Сатантай тулгарч, түүний учруулж болох бүхий л аймшгийг даван туулсан юм.

“. . . Аврагч Адамаас эхлээд дэлхийн төгсгөл хүртэл бүх хүн төрөлхтний нүглийн зовлонг Өөртөө хүлээн авсан нь зарим талаар энгийн хүмүүс ойлгох аргагүй явдал юм” (*Jesus the Christ*, 3 дахь хэвлэл, [1916], 613).

Туршлагуудаа дурсан санах нь



2. Есүс Христ бол Аврагч гэдгийг мэдэхэд тань тусалсан туршлагынхаа талаар судрын тэмдэглэлдээ бич. Энэ туршлагаа дурсан санах нь таны амьдралд баяр баяслыг хэрхэн нэмэгдүүлдэг вэ?

Сүнслэг туршлагуудаа эргэн санах үед Ариун Сүнс таны сурсан үнэнийг дахин гэрчилдэг. Эдгээр туршлагаа судрын тэмдэглэлдээ бичсэнээр та өөрийн амьдрал дахь Их Эзэний мутрыг санах хүслээ Түүнд харуулж, тэдгээрийг санахад тань тусалдаг.



Мозая 3:11–27

Хаан Бенжамин эгэл хүнээ хэрхэн орхихыг тайлбарлав

Хаан Бенжамин хүмүүстээ үргэлжлүүлэн заахдаа Цагаатгал нь Бурханы хүүхдүүдийг хэрхэн адисалдгийг заалаа. Түүнчлэн тэрээр Аврагчийн Цагаатгалаар дамжуулан бид хэрхэн эгэл хүнээ орхиж, гэгээнтнүүд болох боломжтойг заав.

Цагаатгал Бурханы хүүхдүүдийг хэрхэн адисалдгийг илүү сайн ойлгохын тулд дараах судрын хэсгүүдийг уншаад, уг шүлгийн гэрчилдэг Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан адислагдах бүлэг хүмүүсийн дүрслэлийг бич.

- Мозая 3:11 _____
- Мозая 3:16 _____

Сургаалын мэдлэггүйгээр нас барсан хүмүүсийн нүглийг Есүс Христ цагаатгасан ч тэд аврагдахын тулд сүнсний дэлхийд байхдаа наманчилж, Есүс Христэд итгэх итгэлээ үйлдэл болгох ёстой гэдгийг мэдэх нь чухал (С ба Г 131:6; 138:31–34-ийг үзнэ үү).

Түүнчлэн Бурханы мэлмийд хүүхдүүд гэнэн цагаан төрдөг бөгөөд Сатан тэднийг уруу татах хүчгүй байдаг хэмээн Их Эзэн илчилсэн. Найман нас буюу хариуцлагын насанд хүртлээ бяцхан хүүхдүүд наманчилж, баптисм хүртэх шаардлагагүйгээр Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан аврагддаг (Моронай 8:8–15; С ба Г 29:46–47; 137:10-ыг үзнэ үү).


Бид Есүс Христийн сайн мэдээний мэдлэгээ дагах ёстой. Мозая 3:12–13-ыг уншаад, **бид Есүс Христэд итгэх итгэлээ үйлдэл болгож, наманчлах үед нүглүүдээсээ аврагдаж, баясах боломжтой** гэдгийг заасан үг хэллэгүүдийн доогуур зур.

“Аз жаргалаар” дүүрсэн аяганы зургийг эргэн сана. Аврагчийн номлол болон цагаатгалыг ойлгосноор баяр баясал ирдэг хэмээн тунхагласан тэнгэр элчийн үгсийг сана (Мозая 3:4–5-ийг үзнэ үү). Энэхүү дүрслэлийн эсрэг утгыг ойлгохын тулд Мозая 3:24–27-г унш. Наманчлахгүй байхыг сонгосон хүмүүс шүүлтийн өдөр юу уухыг олж доогуур нь зур.

Есүс Христэд итгэх итгэлээ үйлдэл болгохгүй, наманчлахгүй байхыг сонгох хүмүүст юу тохиолдох вэ? _____

Аврагчийн Цагаатгал ба наманчилж, Есүс Христэд итгэх итгэлтэй байхын хэрэгцээний тухай заасныхаа дараа хаан Бенжамин хүмүүстээ Цагаатгалаар дамжуулан өөрсдийн шинж чанарын нүгэлт хэсгийг орхиж, гэгээнтнүүд болох тухай заав.


Мозая 3:19-ийг уншаад, ойлгохгүй байгаа үг хэллэгээ тодорхойл. Судартаа энэ шүлгийн хажууд гурван тодорхойлолт бичих нь тустай байж болно. “Эгэл хүн” бол Ариун Сүнсний удирдамжаар биш, харин маханбодын хүсэл эрмэлзэл хийгээд дур таашаал, мэдрэмжээр нөлөөлөгдөхийг сонгодог хүн. “Автагдах” гэдэг нь хэн нэгэнд эсвэл ямар нэг зүйлд захирагдах гэсэн утгатай. “Таталт” бол итгэл төрүүлэм, тааламжтай урилга юм. Мозая 3:19 бол төгс эзэмших судар юм. Дараа нь олоход хялбар болгож бусдаас өөрөөр тэмдэглэх хэрэгтэй.


 **3.** Судрын тэмдэглэлдээ “Эгэл хүнээ орхи” гэсэн гарчиг тавь. Доор нь Мозая 3:19-д зааснаар бид “эгэл хүнээ” орхихын тулд юу хийх ёстойг жагсаан бич: Энэ удаа юун дээр ажиллах нь хамгийн чухал хэмээн бодож байгаагаа дугуйл. Энэ үйлдлийг хийх төлөвлөгөө гарга.


Мозая 3:19-д заадаг нэг зарчим бол хэрэв бид Ариун Сүнсний таталтанд автагдвал Христийн Цагаатгалаар дамжуулан эгэл хүнээ орхиж чадна гэсэн зарчим юм.

“Ариун Сүнсний таталтанд” автагдах гэдэг нь таны бодлоор ямар утгатай вэ? _____


Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Нийл А.Максвэллийн эгэл хүнээ орхих талаар хэлсэн дараах үгсийг унш: “Хувийн зөв шударга байдал, шүтлэг, залбирал, судраас судлах зэрэг нь ‘эгэл хүнээ [орхиход]’ нэн чухал нь билээ (Мозая 3:19)” (“The Tugs and Pulls of the World,” *Ensign*, 2000 оны 11-р сар, 36).


 **4.** Судрын тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич: Та амьдралдаа ямар арга замуудаар Ариун Сүнсний таталтанд автагдахыг эрэлхийлж байгаа вэ?

 **5.** Та амьдралдаа “Ариун Сүнсний таталтанд” бүрэн автагдахын тулд юу хийж болох вэ? Энэ долоо хоногт уг зүйл дээрээ сайжрахад туслах зорилго гарган судрын тэмдэглэлдээ бич. Та Мозая 3:19-д бичигдсэн хүүхэд шиг болоход бидэнд туслах зан чанаруудын нэг дээр ажиллаж болно. Жишээлбэл: илүү хүлцэнгүй, номхон, даруухан, тэвчээртэй, хайраар дүүрэн, Их Эзэн тань “дээр ноогдуулах” бүх зүйлийг хүлцэхэд бэлэн байх.

 **6.** Амьдралд тань таныг сүнсний таталтанд автагдахад тань саад болдог зарим бэрхшээлүүдийг судрын тэмдэглэлдээ бич.

Төгс эзэмших судар—Мозая 3:19

 **7.** Мозая 3:19-ийг санах эсвэл цээжлэхийн тулд үүнийг гурван удаа унш. Давтан унших нь шүлгийн агуулгатай илүү танил болоход тань тусална. Үүнийг хийснийхээ дараа судраасаа харалгүйгээр санаж байгаа бүх зүйлээ судрын тэмдэглэлдээ бичихийг хичээ. Алхаж байхдаа, дасгал хийж байхдаа эсвэл унтахаар бэлдэж байхдаа уг шүлгийг олон удаа давтан хэл. Хэдэн өдөр үүнийг хийвэл энэ шүлгийн чухал зарчмуудыг та санаж, мөн цээжилж чадна.

 **8.** Дараах өгүүлбэрийг судрын тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Мозая 3-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

11-Р ХЭСЭГ: 3 ДАХЬ ӨДӨР

Мозая 4

Оршил

Хаан Бенжамины заасан зүйлс түүнийг сонссон хүмүүст гүн нөлөө үзүүлэв. Эдгээр хүмүүс Цагаатгалд итгэж, наманчилж, нүглүүдийнхээ ангижралыг хүлээн авсан байв. Дараа нь хаан Бенжамин нүглүүдээсээ уучлагдсан хэвээр байхын тулд тэд юу хийх ёстойг

заав. Бидний аврал Бурханаас бүрэн хамааралтай байдаг учраас бид яг л гуйлгачин мэт хэмээн тэр тунхаглав. Бид үргэлж бодол санаа, үйлс болон үйл хөдлөлөө хянаж байх ёстойг хаан Бенжамин сэрэмжлүүлэв.

Мозая 4:1–8

Цугласан олон Сүнсээр бүрхэгдэж, нүглүүдийнхээ ангижралыг хүлээн авав

Нэг тодорхой нүгэл минь уучлагдсаныг би яаж мэдэх вэ? гэж нэг найз тань асуусан гэж төсөөл. Та юу гэж хариулах вэ?

Мозая 4:1–3-ыг уншаад, найзынхаа асуултад хариулахад туслах санаануудыг хайж ол. Юу гэж хариулахаа бич: _____


Эдгээр шүлгүүдэд заагддаг зарчмуудын нэг бол: **Бид Есүс Христэд итгэх итгэлээ үйлдэл болгож, чин сэтгэлээсээ наманчлах үед нүглүүдийнхээ ангижралыг хүлээн авдаг.** Тийн наманчлах нь дотоод сэтгэлийн баяр хөөр, амар амгаланг хүлээн авах чухал алхам юм.

Ер нь хэн нэгэн хүн асуулт асуухад бид хариулт өгөхийг хүсдэг. Энэ удаад та найзынхаа асуултад хэрхэн хариулахаа бодож байхдаа асуултад нь хэрхэн асуултаар хариулж болохыг бод. Мозая 4:1–3 болон чөлөөнд гарсан Далын гишүүд ахлагч Ф.Бартон Ховардын хэлсэн дараах үгсийг эргэцүүлэн бод: “Бүрэн наманчилсан үедээ та дотоод амар амгаланг мэдэрдэг. Удаан хугацааны турш сэтгэлийн хүнд ачаа үүрч явснаа, гэнэт тэр тань үгүй болохыг мэдрэх үедээ та ямар нэгэн байдлаар уучлагдсан гэдгээ мэднэ. Ачаа *авагдаж*, үгүй болсон гэдгийг *та мэдэж авна* (“Repentance,” *Ensign*, 1983 оны 5-р сар, 59).

Уучлагдсан гэдгээ бид хэрхэн мэдэж болохыг өөрөө олж мэдэхэд нь туслахын тулд найзаасаа асууж болох асуултыг бодож бол.

Асуултаа бодож олохдоо Мозая 4:1–3 дахь хоёр нөхцөлийг ойлгох нь тустай. Өөрсдийгөө “зуурдын байдалд” буйгаа харах гэдэг нь унасан эсвэл дэлхийн байдлаа ухаарах гэсэн утгатай. Өөрсдийгөө “газрын тоосноос ч өчүүхэн” гэдгээ харах гэдэг нь газрын тоос Бурханы зарлигуудад дуулгавартай байдаг (Хиламан 12:7–8), харин Бурханы хүүхдүүд Түүний зарлигуудад үргэлж дуулгавартай байдаггүй гэсэн үг.

Найзынхаа асуултад асуултаар хариулах нэг жишээ бол: “Чи нүглээ наманчлах талаар бодохдоо дотоод сэтгэлдээ амар амгаланг мэдэрдэг үү? гэж асууж болно. Баяр хөөрөөр дүүргэгддэг үү?”

 **1.** Судрын тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

а. “Есүс Христэд итгэх үлэмж итгэлийнхээ” улмаас хаан Бенжамины хүмүүс уучлагдсан (Мозая 4:3). Мозая 4:1–2-т гардаг ямар үйлдэл тэдний итгэлийг харуулдаг вэ? Та Мозаягийн хүмүүсийнхтэй ижил төстэй ямар хандлага болон мэдрэмжтэй байх хэрэгтэй вэ?

б. Та нүглүүдийнхээ ангижралыг эрэлхийлэхдээ Есүс Христэд итгэх итгэлээ хэрхэн бодитой болгож чадах вэ?

Хүмүүсийнхээ гэмшсэн сэтгэлийг харсныхаа дараа хаан Бенжамин тэдэнд авралыг олж авахын тулд хийх ёстой зарим зүйлсийг заав. Мозая 4:4–8-ыг уншихдаа, бид авралыг хүлээн авахын тулд юу хийх ёстойг олж мэд.

Хаан Бенжамины тайлбарласан зүйлсийг та хийхийн тулд хэрхэн хичээж байгаагаа тайлбарлах эсвэл жишээ өгнө үү.

“Их Эзэнд найдлагаа тавь”: _____

“Түүний зарлигуудыг сахихдаа хичээнгүй бай”: _____

“Амьдралынхаа төгсгөл хүртэл итгэлтэй бай” _____


Мозая 4:9–30

Хаан Бенжамин хэрхэн нүглээсээ уучлагдсан хэвээр байх тухай заасан

Нифайчууд нүглүүдээсээ уучлагдсаны дараа хаан Бенжамин тэдэнд хэрхэн цэвэр ариун хэвээрээ байх тухай заадаг. Мозая 4:9–11, 26, 28, 30-ийг судлаад, бид нүглүүдээсээ уучлагдсан хэвээр байхын тулд юунд *итгэж*, юу *хийх* ёстойг ол. Дараах хүснэгтээс юу олж мэдсэнээ бич:


Нүглүүдээсээ уучлагдсан хэвээр үлдэх	
Итгэх	Хийх

Мозая 4:9–30-д хэлсэнчлэн хаан Бенжамин өөрийн хүмүүст олон зүйлийг заав. Гэхдээ түүний заасан хамгийн чухал зарчмуудын нэг нь: **Хэрэв бид өөрсдийгөө Бурханы өмнө даруусгаж, Христтэй адил зан чанаруудыг хөгжүүлэхийг хичээвэл нүглүүдээсээ уучлагдсан хэвээр үлдэж чадна гэсэн зарчим юм.**

 **2.** Бид “Бурханд итгэх” ёстой (Мозая 4:9) бөгөөд үргэлж “Бурханы агуу ихийг” санаж байх ёстой гэж хаан Бенжамин заав (Мозая 4:11). Бурхан бол жинхэнэ, Тэр

хүчирхэг, Тэр чамд хайртай гэдгийг ухаарахад тань тусалсан туршлагаа, эсвэл таньдаг хүнийхээ туршлагыг судрын тэмдэглэлдээ тайлбарлан бич. Таны бодлоор Бурханы хүч, сайн сайхан, хайрыг санаж, ойлгох нь яагаад чухал вэ? Эдгээр зүйлийг санах үед тэд таны амьдралд хэрхэн нөлөөлдөг вэ?


Нүглүүдээсээ уучлагдсан хэвээр үлдэхийг хичээж байгаа хүмүүсийн үйлдлийг хаан Бенжамин дүрслэв. Хаан Бенжамины тодорхойлсон зарим зүйлсийг сурахын тулд Мозая 4:12–16-г судал. (Мозая 4:16-д гардаг халамжлах гэдэг нь хэрэгцээтэй үед нь туслах, дэмжлэг өгөх гэсэн утгатай.)


 **3.** Хэн нэгэн нүглүүдээсээ уучлагдсан хэвээр үлдэхийг хичээж байгаа үйлдлийг хаан Бенжамин хэрхэн дүрсэлснийг судрын тэмдэглэлдээ бич. Хэн нэгэн нүглүүдээсээ уучлагдсан хэвээр үлдэхийг хичээж байгааг харуулах өөр үйлдлүүдийг та жагсаан гаргаж чадах уу? Тусламж хэрэгцээтэй тэдэнд халамж үзүүлсэн аргуудаа жагсаан гарга.

Бид бүгд бидэнд байгаа зүйлүүдийнхээ төлөө Бурханаас бүрэн хамааралтай учир хаан Бенжамин биднийг гуйлгачинтай харьцуулсан. Энэхүү харьцуулалт нь Их Эзэнээс хүлээж авсан адислалууддаа талархалтай байхад бидэнд тусалдаг. Мозая 4:19–21-ийг уншаад, Бурханы мэлмийд бид хэрхэн гуйлгачин шиг байдаг болохыг ол.

Бурханаас хамааралтай байдаг тухайгаа бод. Яг одоо таны Тэнгэрлэг Эцэгт талархах нэг адислал юу вэ?

Бидэнд Бурханы тусламж үргэлж хэрэгтэй байдаг тухай заасны дараа хаан Бенжамин тусламж гуйсан хүмүүст бид хэрхэн хандах хэрэгтэйг бодож үзэхийг биднээс хүссэн. Мозая 4:26–27-г судлаад, тусламж хэрэгтэй хүмүүст бид хэрхэн хандах хэрэгтэйг ол.

 **4.** Судрын тэмдэглэлдээ дараах асуултад хариулж бич: Мозая 4 дэх хаан Бенжамины заасан зүйлсийг санах нь сүнслэг болон материаллаг тусламж хэрэгтэй хүмүүст энэрэнгүй хандахад тань хэрхэн тусалж чадах вэ?

 **5.** Өнөөдөр сурсан судрынхаа талаар хэсэг зуур тунгаан бод. Хаан Бенжамины заасан

Хүлээж авсан мэдрэмжээ бичих нь

Хүлээж авсан мэдрэмжүүдээ бичиж тэмдэглэхийг Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Ричард Г. Скотт бидэнд уриалсан юм: “Сүнснээс суралцсан чухал зүйлсээ аюулгүй газарт бичиж авч бай. Нандин мэдрэмжүүдээ бичих тусам илүү их нандин мэдрэмжийг хүлээж авдаг гэдгийг та мэдэж авах болно. Түүнчлэн та олж авсан мэдлэгээ амьдралынхаа туршид ашиглаж болно. Өдөр шөнийн алинд нь ч, хаана ч, юу ч хийж байсан гэсэн үргэлж Сүнсний удирдамжийг танин мэдэж, дагахыг хичээ” (“To Acquire Knowledge and the Strength to Use It Wisely,” *Ensign*, 2002 оны 6-р сар, 32).

сургаалаас сурсан зүйлс дээрээ үндэслэн та юу хийх хэрэгтэйгээ Ариун Сүнсний зөвлөмжөөр мэдэрсэн үү? Тэрхүү мэдрэмжээ судрын тэмдэглэлдээ бич.


Их Эзэнд таныг хайрлах гүн гүнзгий хайр байдгийг сана. Хийсэн аливаа буруу зүйлсээ наманчилж, Аврагчийн жишээг дагахыг хамаг чадлаараа хичээх үедээ та нүглүүдээсээ уучлагдсан хэвээр үлдэж чадна.


Төгс эзэмших судар—Мозая 4:30

Мозая 4:30-ийг чангаар унш. Таны бодол санаа, үгс, үйлдлийн хооронд ямар холбоо байдаг вэ?



Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон энэхүү холбоогийн тайлбарласан: “Цэвэр бодлуудыг бод. Цэвэр ариун бодолтой хүн бохир үйл хэрэг хийдэггүй. Та Бурханы өмнө зөвхөн үйлдлийнхээ төлөө бус, мөн бодол санаагаа хянаж байгаагаараа хариуцлага хүлээдэг. . . . Та бодлоо тарьж үйлсээ хураадаг, та үйлдлээ тарьж зуршлаа хураадаг, та зуршлаа тарьж зан араншингаа хураадаг. Таны зан араншин таны мөнх амьдралын хувь заяаг шийддэг гэсэн хуучны зүйр үг одоо ч үнэн хэвээр байна. ‘Учир нь тэр дотроо боддогтойгоо адил юм.’ (Сургаалт үгс 23:7-г үзнэ үү.) (Conference Report, 1964 оны 10-р сар, 60).

 **6.** Та бодол санаагаа хянаж сурвал үгс болон үйлдэлдээ Христтэй илүү адил байх адислалыг хурааж авах болно. Христтэй илүү адилхан байж, бодол санаагаа хянах нэг юмуу хоёр арга замыг судрын тэмдэглэлдээ бич.

 **7.** Дараах өгүүлбэрийг судрын тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Мозая 4-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

11-Р ХЭСЭГ: 4 ДЭХ ӨДӨР

Мозая 5–6

Оршил

Мозая 5-р бүлэг нь Мозая 2-р бүлэгт эхэлсэн хаан Бенжамины хүмүүстээ хандан хэлсэн үгсийг төгсгөдөг. Хаан Бенжамины хэлсэн үгэнд итгэсэн хүмүүс зүрх сэтгэлийн хүчирхэг өөрчлөлтийг мэдэрсэн. Тэд Бурхантай гэрээнд орж, өөрсдөдөө Есүс Христийн нэрийг хүлээн авсан юм. Мозая 6-р бүлэгт цэдэглэснээр, Бенжамин хаант улсаа засаглах эрхийг өөрийн хүү Мозаяд шилжүүлэн өгдөг бөгөөд Мозая эцгийнхээ жишээг даган зөв шударгаар засаглав.

Мозая 5:1–4

Хаан Бенжамины хүмүүс агуу өөрчлөлтийг мэдрэв

Дараах асуултуудын талаар бод: Та өөрийнхөө ямар нэгэн юмыг өөрчлөхийг хүсч байсан уу? Та тэр талаараа юу хийсэн бэ?

Хүн бүр амьдралдаа агуу өөрчлөлт хийх хэрэгтэйг Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Дэвид А.Бэднар ийн тайлбарлажээ: “Есүс Христийн сайн мэдээний үнэн мөн чанар нь ‘Ариун Мессиагийн сайн үйл мөн нигүүлсэл, мөн ач ивээлд’ найдсанаар бий болдог бидний мөн чанарын хөдлөшгүй гол өөрчлөлтийг шаарддаг (2 Нифай 2:8). Эзэнийг дагахаар сонгох үедээ бид өөрчлөгдөхийг, сүнслэгээр дахин төрөхийг сонгодог” (“Ye Must Be Born Again,” *Ensign*, Лиахона, 2007 оны 5-р сар, 20).

Дараах өгүүлбэрийг судартаа Мозая 5:2-ын хажууд бичих хэрэгтэй: “Эзэнийг дагахаар сонгосноор бид өөрчлөгдөхийг сонгодог.”

Есүс Христийг дагахаар сонгохдоо бид ямар замаар өөрчлөгдөхийг сонгодог гэж та бодож байна вэ? ___

Хаан Бенжамины үгсийн гол хэсгийг санахын тулд Мозая 3 болон Мозая 4-р бүлгүүдийн бүлгийн тоймыг дахин унш. Номлолынхоо төгсгөлд хаан Бенжамин Есүс Христийн Цагаатгалын талаар заасан үгсэд нь итгэсэн эсэхийг хүмүүсээсээ асуув (Мозая 5:1-ийг үзнэ үү). Мозая 5:2–4-ийг уншаад, хааныхаа үгийг сонссоны дараа хүмүүсийн зүрх сэтгэлд юу өөрчлөгдсөнийг ол. Уншихдаа “Хүсэл” (Мозая 5:2) гэдэг нь хувь хүний хандлага, хүсэл эсвэл зан ааш гэсэн утгыг илэрхийлдэг болохыг мэдэх нь тустай.



Ахлагч Дэвид А.Беднарын хэлсэн дараах үгсийг унш: “Есүс Христийн сайн мэдээ нь бидний амьдрал дахь муу нөлөө, нүглээс зайлсхийх, түүнийг ялан дийлэх, мөн түүнээс цэвэрлэгдэхээс хамаагүй илүү цар хүрээтэй. Энэ нь түүнчлэн сайныг үйлдэж, сайн байж, илүү сайн болохыг шаарддаг. . . . Бенжамин хааны хүмүүсийн адилаар зүрх сэтгэлээ Ариун Сүнсээр өөрчлүүлснээр, ‘бид хилэнцийг үйлдэх хүслээ үгүй болгож, харин үргэлж сайныг хийнэ’ (Мозая 5:2) гэдэг нь гэрээ хийхдээ бидний хүлээн авсан үүрэг хариуцлага билээ. Энэхүү хүчирхэг өөрчлөлт нь зүгээр л илүү хичээнгүй чармайснаар эсвэл хувийн сахилга батаа дээшлүүлснээр л бий болдог зүйл биш юм. Харин энэ нь Их Эзэн Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан хүсэл, зорилго, мөн чанартаа үндсэн өөрчлөлт гаргасны үр дүн билээ. Нүгэл болон нүглийг үйлдэх хүслийг хоёуланг нь даван дийлэх нь бидний сүнслэг зорилго юм” (“Clean Hands and a Pure Heart,” *Ensign*, 2007 оны 11-р сар, 81–82).



1. Судрын тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

- а.** Зүрх сэтгэлдээ “хүчирхэг өөрчлөлтийг” мэдрэх нь таны бодлоор ямар утгатай вэ? (Мозая 5:2).
- б.** Есүс Христийг дагахаар сонгох үедээ бид яагаад зөвхөн биеэ авч явах байдлаа бус, мөн шинж чанараа өөрчлөх хэрэгтэй вэ?
- в.** Бидэнд гардаг өөрчлөлтөд Есүс Христийн Цагаатгал яагаад хэрэгтэй гэж та бодож байна вэ?

Мозая 5:2, 4-ийг судлахдаа, тэдгээр хүмүүс юу хийснээр зүрх сэтгэлд нь хүчирхэг өөрчлөлт гарахад хүргэснийг олж мэд. Эдгээр зүйлсийг судартаа тэмдэглэж болно. Хаан Бенжамин үгс Есүс Христийн Цагаатгалын хүчний талаар байсан бөгөөд хүмүүс эдгээр үгсэд үлэмж итгэлтэй байсан гэдгийг сана.

Эдгээр шүлгүүдээс бидний сурах зарчмуудын нэг бол: **Бид Есүс Христэд итгэх итгэлээ үйлдэл болгож, Ариун Сүнийг хүлээн авснаар зүрх сэтгэлийн хүчит өөрчлөлтийг мэдэрч чадна** гэсэн зарчим юм.



2. Мозая 5:1–4-р шүлгүүдээс судалсан зүйл болон дээрх зарчим дээр үндэслэн, Аврагчид итгэх илүү их итгэлийг үйлдэл болгохын тулд та юу хийж чадахаа судрын тэмдэглэлдээ бич. Амьдралдаа зүрх сэтгэлийн хүчирхэг өөрчлөлтийг дэмжин урамшуулж мөн үүнийгээ хадгалж болохын тулд та илүү их итгэлийг үйлдэл болгох ямар тодорхой зүйлсийг өнөөдрөөс эхлэн хийж чадах вэ?

Мозая 5:5–15

Хаан Бенжамин хүмүүс Бурхантай гэрээнд орж, шинэ нэрийг хүлээн авдаг

Хаан Бенжамин хүмүүс зүрх сэтгэлийн хүчирхэг өөрчлөлтийг мэдэрснийхээ дараа Их Эзэнтэй гэрээнд орохыг хүсэв. Гэрээ хийж, түүнийгээ сахихын тулд хаан Бенжамин хүмүүсийн мэдэрсэн амлалтын түвшинг харуулсан үг хэллэгийг Мозая 5:5-аас ол.

Бид Бурхантай гэрээ хийхэд Тэрээр гэрээний нөхцөлийг тодорхойлж, бид зөвшөөрдөг. Тэгээд Бурхан бидний дуулгавартай байдлын төлөө тодорхой адислалуудыг амладаг (С ба Г 82:10-ыг үзнэ үү). Гэрээ байгуулах нь бид Түүнд үйлчлэх чин хүсэлтэй байгаагаа илэрхийлэх нэг арга зам билээ.



3. Судрын тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

- а.** Мозая 5:5-ын ямар үгс нь танд ариун ёслолоос хүртэх бүрдээ шинэчилдэг амлалтуудын тухай сануулж байна вэ?
- б.** Гэрээ байгуулж, сахих нь “зүрх сэтгэлийн өөрчлөлтөө” авч үлдэхэд тань хэрхэн тусалдаг гэж та бодож байна вэ?

Мозая 1:11–12-ыг дахин хар. Хаан Бенжамин хүмүүсээ цуглуулсан нэг зорилго бол тэдэнд нэр өгөх явдал байсан юм. Мозая 5:6–7-г уншаад, хүмүүс нь Их Эзэнтэй гэрээ хийсний дараа хаан Бенжамин хүмүүстээ өгсөн нэрийг тэмдэглэ.

Эдгээр шүлгүүд нь дараах зарчмыг заадаг: **Ариун гэрээнүүдээр дамжуулан бид Есүс Христийн нэрийг өөрсдөдөө хүлээн авдаг.** Мозая 5:8–14-ийг уншаад, бид яагаад Есүс Христийн нэрийг өөрсдөдөө хүлээн авах шаардлагатай вэ гэдгийг олж мэд.

Есүс Христийн нэрийг зүрх сэтгэлдээ бичсэнээр хүлээн авдаг ямар адислалууд байдаг вэ? _____

Таны эсвэл хэн нэгний зүрх сэтгэлээс уг нэр “арилгагдахад” юу нөлөөлдөг вэ? _____

Мозая 5:15-ыг уншаад, гэрээнүүдээ сахидаг хүмүүст Их Эзэний өгдөг амлалтуудыг ол.



4. Есүс Христийн нэр таны зүрх сэтгэлд бичээстэй байна гэж бодоход танд юу мэдрэгдэж байгааг судрын тэмдэглэлдээ бич. Та яагаад энэ нэрийг хадгалж, хэзээ ч хаяхгүй байхыг хүсч байгаа нэг юмуу түүнээс олон шалтгааныг бич.




Мозая 6:1–7


Мозаягийн хаанчлал эхлэв

Мозая 6:3-ыг уншаад, хаан Бенжамин цугласан олныг тараахаас өмнө юу хийснийг тодорхойл.

Хийсэн гэрээгээ санахад нь өөрийн хүмүүст туслахын тулд хаан Бенжамин юу хийсэн бэ? _____

 **5.** Гэрээнүүдээ сахихад тань санваарын удирдагчид болон багш нар тань танд хэрхэн тусалдгийг судрын тэмдэглэлдээ бич.

Хаан Бенжамин хүмүүстээ хандан ярьснаас хойш гурван жилийн дараа нас барав. Мозая 6:6–7-г уншаад, хаан Мозая зөв шударга удирдагчийн хувьд аавынхаа жишээг хэрхэн дагасныг олж мэд.

 **6.** Дараах өгүүлбэрийг судрын тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Мозая 5–6-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

12-Р ХЭСЭГ: 1 ДЭХ ӨДӨР

Мозая 7–8

Оршил

Мозая хаан бол Мормоны Номд дурдагдсан анхны Мозаягийн хүү хаан Бенжамин хүү юм. Мозаяг хаан болохоос 80 орчим жилийн өмнө Зениф нэртэй нэгэн эр бүлэг нифайчуудыг удирдан Зарахемлагийн нутгаас Нифайн нутагт очиж амьдрахаар явсан (Омнаи 1:27–30). Мозая 7-р бүлэг дээр Мозая хаан Аммон нэртэй “хүчтэй мөн чадалтай” (Мозая 7:3) эр болон цөөн хэдэн хүний бүрэлдэхүүнтэй бүлэг хүмүүсийг Нифайн нутаг руу (заримдаа Лихай-Нифайн нутаг гэж нэрлэдэг) Зенифийн бүлэг хүмүүсийн талаар сураглахаар явуулсныг тайлбарладаг. Аммон Зенифийн ач хүү Лимхайгаар удирдуулж байгаа Зенифийн үр удмыг олов. Аммон ирсэн нь өөрсдийн алдсын улмаас леменчүүдийн боолчлолд орсон Лимхай болон түүний хүмүүст найдвар авчрав. Лимхайн бүлэг хүмүүс өмнө нь тусламж гуйхаар Зарахемлаг хайж байхдаа сийлбэр бүхий 24 хуудас алтан ялтсуудыг олсон юм. Уг сийлбэрийг орчуулж чадах эсэхийг Лимхай Аммоноос асуухад Мозая хаан шиг үзмэрч хүн эртний цэдгүүдийг орчуулж чадна гэдгийг тайлбарлав.

Мозая 7–24-р бүлгүүдийн тойм

Урьд нь та муухай мэдрэмж, хүнд хэцүү тохиолдол, сорилтот эсвэл шударга бус нөхцөл байдал эсвэл нүгэл үйлдсэнээс ирэх гэмшлээс чөлөөлөгдөхийг хүсэж байсан уу? Мозая 7–24-р бүлгүүдэд судлах гэж байгаа хүмүүсийн тань туршлага танд чөлөөлөлтийн талаар болон үүнийг хаанаас эрэх, хэрхэн урих, бүр

хэрхэн хүлээх тухай заах болно. Зенифийн хүмүүс болон тэдний үр удмын түүхээс өөрийг тань зовоож буй ямар нэгэн зүйлээс чөлөөлөгдөх хүсэл, өөрийн амьдралд ашиглаж болох арга замуудыг олж хар.

Мозая 7-р бүлгийг судлахаасаа өмнө Мозая 7–24-р бүлгүүдэд цэдэглэгдсэн олон аяллуудтай танил болох нь танд тустай байх болно. Дараах үйл ажиллагаа нь ойролцоогоор 80 жилийн туршид болсон эдгээр аяллуудын (мээ 200-аас мээ 120 он хүртэл) тоймыг танд харуулна. Доорх хүснэгтийн сүүдэрлэсэн нүднүүд дэх мэдээлэл аяллуудын хоорондох хугацаанд юу тохиолдсоныг тайлбарлана.

Аялал	Хэн хаашаа аялсан бэ
1	Зениф болон бусад нифайчууд Зарахемлагаас Нифайн нутаг руу аялсан бөгөөд леменчүүдэд олзлогдов. Тэдгээр нифайчууд хоорондоо байлдан, амьд үлдэгсэд нь Зарахемлад эргэн ирэв (Омнаи 1:27–28; Мозая 9:1–2-ыг үзнэ үү).
2	Зениф болон бусад нь Зарахемлаг орхин явж, Нифайн нутагт суурьшив (Омнаи 1:29–30; Мозая 9:3–7).
Зенифийг нас барсны дараа түүний хүү Ноа ёсон бусаар засаглав. Их Эзэн Абинадайг илгээж хүмүүст наманчлахыг анхааруулав. Ноа хааны пристүүдийн нэг Алма Абинадайн захиасыг дуулгавартай дагаж, бусдад заав (Мозая 11–18-р бүлгүүдийг үзнэ үү).	
3	Алма Мормоны ус руу зугтаж, дараа нь бүлэг итгэгчдийг Хиламын нутаг руу удирдав (Мозая 18:4–5, 32–35; 23:1–5, 19–20-ийг үзнэ үү).
Леменчүүд Нифайн нутагт Ноагийн хүмүүс рүү довтлов. Ноа хожим нь алуулж, түүний хүү Лимхай засаглав. Лимхайн хүмүүс леменчүүдийн боолчлолд байв (Мозая 19–20-р бүлгийг үзнэ үү).	
4	Лимхай бүлэг нифайчуудыг Зарахемлаг олуулахаар илгээв. Аглаг буйдад төөрснийхөө дараа устгагдсан нэгэн үндэстний балгасыг олсон бөгөөд 24 хуудастай цэдэг бүхий алтан ялтсуудыг олов (Мозая 8:7–9; 21:25–27-г үзнэ үү).
5	Аммон болон бусад 15 хүн Нифайн нутаг руу буцсан хүмүүсийг олохоор Зарахемлагаас аялав (Мозая 7:1–6; 21:22–24).
6	Лимхай болон түүний хүмүүс леменчүүдээс зугтан Аммон болон түүний ах дүү нараар Зарахемлагийн зүг удирдуулав (Мозая 22:10–13-ыг үзнэ үү).

Аялал	Хэн хаашаа аялсан бэ
	Лимхайн хүмүүс зугтсаны дараа леменчүүд тэдний араас цэргүүдээ илгээв. Леменчүүдийн арми аглаг буйдад төөрч, Хиламын нутагт байсан Алма болон түүний хүмүүстэй тааралдав. Леменчүүд тэднийг боолчлолд авчрав. Алмагийн хүмүүс оргон зугтах тусламж хүсэн залбирав (Мозая 22–24-ийг үзнэ үү).
7	Их Эзэн Алма болон түүний хүмүүсийг чөлөөлж, Зарахемлагийн нутаг өөд удирдав (Мозая 24:20–25-ыг үзнэ үү).

Аялал бүрийн өмнөх дугаарыг газрын зураг дээрх зөв тойрогт байрлуул:

Мозая 7:1–8:4

Аммон Нифайн нутгийг (Лихай-Нифайн) олж, Лимхай хаан хүмүүс нь хэрхэн боолчлолд орсныг тайлбарлав


Мозая 7-р бүлэгт Аммон болон 15 хүчирхэг эрс Зарахемлагийн нутгаас 80 жилийн өмнө Зенифээр удирдуулан Нифайн нутаг руу явсан хүмүүст юу тохиолдсоныг олж мэдэхээр аялав (Мозая 7:2-ыг үз; түүнчлэн 5 дахь аяллыг газрын зураг дээр хар). Нифайн нутагт ирээд Аммон болон түүний ах дүүсийн гурав нь баригдан шоронд хоригдов (Мозая 7:6–11-ийг үзнэ үү). Хоёр өдрийн дараа тэд шоронгоос Зенифийн ач хүү Лимхай хааны өмнө авчрагдан, байцаагдав. Нифайн нутагт ямар зорилготой явж байсан тухайгаа Аммон хэрхэн тайлбарласныг болон Лимхай хэрхэн хариулсныг олж мэдэхийн тулд Мозая 7:12–15-ыг унш.

Мозая 7:14 дэх б гэсэн зүүлт тайлбар нь Мозая 21:25–26-г илэрхийлдэг болохыг анхаар. Аммоныг хаанаас ирснийг мэдээд Лимхай хаан яагаад “үлэмж баярласныг” илүү сайн ойлгохын тулд эдгээр шүлгүүдийг унш.

Мозая 21:25–26-р шүлгүүдээс сурсан зүйлсээ ашиглан, Аммоныг Зарахемлагаас ирсэн гэдгийг мэдээд Лимхай хаан яагаад тийм их баяртай байсныг товчхон тайлбарла. _____

Зүүлт тайлбаруудыг ашиглах нь

Зүүлт тайлбарууд нь бусад судрууд болон Судруудын удирдамж дахь сэдвүүдтэй холбогдох хамааралтай эшлэлүүдийг агуулдаг. Зүүлт тайлбаруудыг ашиглах нь сургаал болон зарчмууд, түүх, хэцүү үгс, санаануудыг илүү сайн ойлгоход тань тусална. Даалгавраа уншихдаа хэд хэдэн шүлэг эсвэл бүлгийн зүүлт тайлбаруудыг судлахыг хичээ. Онцгой хэрэгтэй зүүлт тайлбаруудыг тэмдэглэ.



Тусламж эрэхээр илгээсэн Лимхайн хүмүүс нь Жаред үндэстний балгасыг олов. Тэд балгасыг Зарахемла байна гэж андуурсан бөгөөд нифайчууд бүгдээрээ устгагдсан гэж бодож байв. (газрын зураг дээрх 4 дэх аяллыг хар). Та Иферийн номоос Жаред үндэстний тухай сурах болно.

Лимхайн хаан Аммоныг танилцуулахаар хүмүүсээ цуглуулав. Лимхай хүмүүстээ леменчүүдийн боолчлолын тухай ярьж, Бурхан тэднийг удахгүй чөлөөлнө гэдэгт найдаж байгаагаа илэрхийлэв (Мозая 7:17–19). Мозая 7:20, 24–26-г уншаад, Лимхайн хүмүүс яагаад боолчлолд орсон шалтгаануудыг тэмдэглэ. (Мозая 7:26-д дурдагдсан бошиглогч бол Аммоныг уг нутагт ирэхээс өмнө ёс бус хаан Ноагийн засаглалын үед хүмүүсийн шатааж алсан Абинадай юм.)

Алдас, нүгэл нь үр дагавартай гэдгийг санахын тулд Мозая 7:24 дэх “бидний гашуудах шалтгаанууд нь агуу болой” гэсэн хэллэгийг тэмдэглэх хэрэгтэй. Энэ тохиолдолд леменчүүд довтлох үед олон нь алагдаж, бусад нь боолчлолд авчрагдсан. Гашуудах гэдэг нь гуниг, харамслыг мэдрэх гэсэн үг. Хэрэв та “алдсаасаа болж” гашуудаж байсан бол тэр үеийнхээ талаар тунгаан бод.



Хэдийгээр нүгэл үйлдэхгүй байх нь илүү сайн ч алдаанаасаа суралцаж, тусламж эрэн Бурханд хандаж, наманчлах нь таныг Бурхантай илүү ойр болгодог. Мозая 7:29–32-ыг уншаад, Лимхай хүмүүсийнх нь зөрчлүүд болон тэдний амсаж байгаа харамсал гашуудал хоёрын хоорондын холбоосыг ойлгосон нотолгоог ол. (30-р шүлэг дэх “хаягдлыг хураах” гэдэг нь хэрэгцээгүй зүйлсийг хүлээж авах гэсэн утгатай. 31-р шүлэг дэх “дорнын салхийг хураан авах” гэдэг нь устгагдах гэсэн утгатай.)



1. Судрын тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

а. Нүглийн үр дагаврууд ямар арга замаар бидний амьдралд тустай байж болох вэ? Бид сурсан зүйлсээ хэрхэн хэрэгжүүлж, нүглээ давтахгүй байж чадах вэ?

б. Нүглүүдээ хэр ноцтой гэдгийг ухаарч, хүлээн зөвшөөрөх нь яагаад чухал вэ? Тэдний төлөө бурханлаг харууслыг мэдрэх нь яагаад чухал вэ? (2 Коринт 7:10-ыг үз; бурханлаг харуусал нь Тэнгэр дэх Эцэгээ гомдоосон үйлдлүүдийн маань гүн ухаарал юм.) Нүглүүдээ ухаарч, харамслыг мэдрэхээ хойшлуулахгүй байх нь яагаад чухал вэ?

Лимхай нүглүүдийнх нь ноцтой байдлыг хүмүүстээ тайлбарласныхаа дараа тэднийг тодорхой зүйлс хийхийг уриалав. Мозая 7:33-т Лимхай өөрийн хүмүүст юу хийхийг уриалсныг тэмдэглэ.

Лимхайн хүмүүсийн туршлагаас бид **алдсуудаа ухаарч, бурханлаг харууслыг мэдрэх нь биднийг аврал эрэн Их Эзэнд хандахад удирддаг** гэдгийг сурдаг.

Найз эсвэл гэр бүлийн гишүүн тань хийсэн нүглийнхээ төлөө гэмшиж, наманчилж Их Эзэнд хандах чин хүсэлтэй боловч хэрхэн үйлдэхээ мэдэхгүй байна гэж төсөөл. Мозая 7:33-ыг судлаад, хэрхэн чин сэтгэлээсээ “Их Эзэнд хандахыг” заасан хэллэгүүдийг дахин унш.



2. Тухайн найз эсвэл гэр бүлийн гишүүндээ Их Эзэнд хэрхэн хандахыг заасан захидлаа судрын тэмдэглэлдээ бич. Мозая 7:33-аас сурсан гурван хэллэгээ хуваалцаж, тус бүрийн утгыг нь (1) өөрийн үгээр тайлбарлах эсвэл (2) тус өгүүлбэрийг хэрэгжүүлэхийг хичээж буй хэн нэгний амьдралаас харж болох үйлдэл, хандлагын жишээ бичиж тайлбарлаж болно.

Танд болон таны хайртай хүмүүст харамсал, гашуудлыг авчирч байгаа наманчлаагүй нүгэл танд байгаа эсэхийг эргэцүүлэн бод. Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Ричард Г. Скотт наманчлалын үйл явцыг эхлүүлэх тухай дараах зөвлөгөөг өгсөн юм: “Таны зөрчлийг Их Эзэн хэр ноцтой хэмээн тодорхойлж байгааг судалж, тунгаан бод. Энэ нь эдгээгч харуусал, шаналлыг авчрах болно. Энэ нь өөрчлөгдөх чин хүсэл, өршөөгдөх шаардлага бүрийг хангах хүслийг авчирдаг” (“Finding Forgiveness,” *Ensign*, May 1995, 76).

Мозая 8:5–21

Аммон Жаредчуудын 24 ялтсыг судлаад, үүнийг орчуулж чадах үзмэрчийн талаар Лимхайд хэлэв

Зарахемлаг олохоор яваад бүхэл бүтэн устгагдсан үндэстний балгасыг олсон хүмүүсийн тухай энэ хичээлийн эхлэлд дурдагдсан газрын зураг дээрх 4 дэх аяллыг эргэн сана. Тэд Лимхайд аваачиж өгсөн



тэрхүү 24 алтан ялтсыг бас олсон (Мозая 8:5–9-ийг үзнэ үү). Лимхай Аммоноос уг ялтсуудыг орчуулах авьяас билэгтэй хэн нэгнийг таних эсэхийг нь асуув (Мозая 8:12-ыг үзнэ үү). Бурхан зарим хүнд орчуулах хүч өгсөн байж болно гэдгийг Аммон тайлбарлав. Мозая 8:13-ыг уншаад, энэхүү бэлэг өгөгдсөн хүмүүсийг Аммон юу гэж дуудсаныг тэмдэглэ.

Зарахемла дахь нифайчуудын хаан Мозаяг үзмэрч хүн хэмээн Аммон тайлбарлав. Мозая 8:16–18-ыг судлаад, орчуулах хүчнээс гадна үзмэрчид ямар бэлэг өгөгдсөн байдгийг олж тэмдэглэ.

Эдгээр шүлгүүд нь **Их Эзэн бошиглогч, үзмэрч, илчлэгчдийг хүмүүн төрөлхтөнд ашиг тус болох боломжоор хангадаг гэдгийг заадаг**. Өнөөдөр Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр төлөөлөгчийн чуулгын гишүүн бүр бошиглогч, үзмэрч, илчлэгчид юм.

Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Нийл Л.Андэрсэн ийн заажээ: “Бошиглогч, үзмэрч, илчлэгчээр бидний дэмжин баталдаг эдгээр 15 эрэгтэйд [бусад] хүний зарим хардаггүй зүйлийг харах тэнгэрлэг хүч өгөгдсөн байдаг. (“Beware of the Evil behind the Smiling Eyes,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2005 оны 5-р сар, 47).



3. Судрын тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

а. Таны харж чадахгүй зүйлсийг харж чаддаг хүмүүсийг сонсох нь яагаад ухаалаг зүйл гэж та боддог вэ?

б. Өнөө үеийн бошиглогч, үзмэрч, илчлэгчдийг сонсох нь танд хэрхэн тус нэмэр болж байсан бэ?

в. Өнөө үеийн бошиглогч, үзмэрч, илчлэгчдээс суралцах ямар арга замууд байдаг вэ?



4. Дараах өгүүлбэрийг судрын тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Мозая 7–8-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

12-Р ХЭСЭГ: 2 ДАХЬ ӨДӨР

Мозая 9–10

Оршил

Хаан Бенжамины хаанчлалын үед Зениф хэсэг нифайчуудыг удирдан Зарахемлагаас нифайн нутаг руу нүүж леменчүүдийн дунд суурьшихаар гардаг. Леменчүүдийн хаан нь Зенифийн хүмүүсийг боолчлох төлөвлөгөөтэй байсан учраас тэднийг үлдэхийг зөвшөөрсөн. Леменчүүдийн буруу уламжлал болон нифайчуудыг үзэн ядах үзэл нь эцэстээ дайнд хүргэв. Леменчүүд тэднийг боолчлолд оруулахаар эрэлхийлэх үед Зенифийн хүмүүс Их Эзэнд хандсан бөгөөд Тэр тэднийг хүчирхэгжүүлж нутгаасаа леменчүүдийг хөөхөд туслав.

Мозая 9:1–13

Зениф хэсэг нифайчуудыг нифайн нутаг руу буцахад нь удирдав

Та ямар нэг зүйлийг маш их хүсэж байсан уу? Өнөөдөр та нэг юмыг маш ихээр хүссэн хүний тухай мөн хүслийнхээ дагуу үйлдсэнийх нь үр дагаврын талаар сурах болно.

Судар дахь огноо

Мормоны Ном дээр гардаг огноог анзаарах боломж гарга. Эдгээр огноотой (зүүлт тайлбар эсвэл бүлгийн тойм дээр гардаг) танилцах нь судалж байгаа үйл явдлынхаа дарааллыг илүү сайн ойлгоход тань тусална.

Өнгөрсөн хичээлийн аяллын газрын зургийг үзнэ үү. Та Лимхай болон түүний хүмүүсийг олсон Аммоны аяллыг санаж байна уу? Судраасаа Мозая 7–8-ыг нээж энэхүү үйл явдал тохиолдсон огноог нь үз (хуудасны доод талд эсвэл бүлгийн тойм дээр гардаг). Үүнийгээ Мозая 9:1-ийн

огноотой харьцуулж үз. Мозая 8-аас Мозая 9-ийн хооронд хэдэн жил өнгөрсөн бэ?

Мозая 9-ийн өмнөх Мормоны бичсэн Зенифийн цэдгийг унш.

Лимхайн өвөө Зениф нэг хэсэг нифайчуудыг Нифайн нутаг руу буцахад нь удирдсан. Тэр нэг юмыг маш ихээр хүссэн бөгөөд хүсэл нь хаашаа удирдаж байгааг сайн бодож үзээгүй. Мозая 9:1–4 дээр гардаг Зениф хүссэн юмаа олохын тулд юу хийсэн талаар нь унш. (“Хэт чармайлттай” байх гэдэг нь ямар нэгэн зүйлд хүслэн болсон, эсвэл хэт сонирхолтой байх гэсэн утгатай.)

Зениф хэт чармайлттай байдлаасаа болж леменчүүдийн хаанд хууртсан. Мозая 9:5–7, 10-ыг уншиж Зенифийн хэт чармайлттай байдлын үр дүнг үз.



1. Дараах асуултуудын хариултыг судрын тэмдэглэлдээ бич.

а. Зениф Нифайн нутгийг авахыг дэндүү их хүсч байснаасаа болоод юуг анзааралгүй өнгөрсөн бэ?

б. Одоо үеийн залуу хүмүүсийн заримынх нь авахыг дэндүү их хүссэн зүйлсийн жишээ нь юу байж болох вэ?

в. Амьдралдаа сонголт хийхдээ Их Эзэнийг санахдаа хойрго байх нь ямар аюултай гэж та бодож байна?

Арван хоёр жилийн дараа Зенифийн хүмүүс ихэд дэгжив. Леменчүүдийн хаан нь тэднийг төлөвлөгөөнийхөө дагуу боолчлолд оруулж чадахгүй байхвий хэмээн айж, тэдний эсрэг дайн хийхээр бэлдсэн. (Мозая 9:11–13-ыг үзнэ үү)

Мозая 9:14–10:22

Леменчүүд Зенифийн хүмүүсийг боолчлохыг оролдов

Амьдралдаа илүү их дэмжлэг болон хүч авмаар байгаа талууд дээрээ дараахаас сонгож дугуйл: хичээл, уруу таталтыг тэвчих, найзуудтайгаа харилцах харилцаа, удирдлага, ажил төрөл, гэр бүлийнхээ гишүүдтэй харилцах харилцаа, туршлага, авьяас, чадвараа хөгжүүлэх зэрэг.

Мозая 9–10-ыг судлахдаа амьдралынхаа эдгээр талууд дээр яаж илүү их хүч авахыг ойлгоход тань туслах зарчмыг олж хар. Мозая 9–10-т леменчүүд хоёр удаа Зениф болон түүний хүмүүсийн эсрэг байлдахаар ирсэн талаарх цэдгийг агуулдаг.





2. Дараах хүснэгтийг судрын тэмдэглэл дээрээ хуулж аваад, судрын заалт бүрийн доор хариу бичих хангалттай зай үлдээ. Заасан шүлгүүдийг судлаад, Зенифийн хүмүүс болон леменчүүд хүч чадал олохын тулд юу хийснийг нь ол. Олсон мэдээллээ ашиглан хүснэгтээ бөглө.

	Хүмүүс бэлтгэхийн тулд юу хийсэн бэ?	Тэд Их Эзэнд итгэл найдвараа тавихын тулд юу хийсэн бэ?	Үр дүн нь ямар байсан бэ?
Зениф ба түүний хүмүүс	Мозая 9:14–16	Мозая 9:17	Мозая 9:18
Леменчүүд	Мозая 10:6–8	Мозая 10:11	Мозая 10:19–20

- Зенифийн хүмүүс, леменчүүд хоёрын байлдаанд хандах хандлага нь юугаараа төстэй байсан бэ? _____
- Зенифийн хүмүүс, леменчүүд хоёрын байлдаанд хандах хандлага нь юугаараа ялгаатай байсан бэ? _____

Мозая 9:17–18-р шүлгүүдээс бидний сурч болох нэг зүйл нь **биднийг хийж чадах бүхнээ хийж, Бурханд бүх найдвараа тавьбал Тэр биднийг хүчирхэгжүүлнэ.**

 **3.** Судрын тэмдэглэлдээ дараах асуултад хариул: Би амьдралынхаа аль тал дээр Бурханд илүү бүрэн итгэж, Түүнээс хүчийг гуйж болох вэ?

 **4.** Мозая 9:18-ын эхний гурван мөрийг тэмдэглэ. Тэгээд нэгэн итгэгч насанд хүрэгчээс (аав, ээж, сүмийн удирдагч, багш) Бурханаас тусламжийг гуйгаад хүчийг авсан талаарх туршлагаасаа хуваалцахыг хүс. Тэр хүн Бурханаас хүч авахын тулд юу хийснийг нь сонс. Сурсан зүйлийнхээ талаар судрын тэмдэглэлдээ бич.

Та өмнө нь хэн нэгэн хүний хийсэн зүйлийг уучилж бас мартаж чадахгүй юм шиг санагдан, өшөө хорсол санан, уурлаж гомдож байсан уу? Таныг үзэн яддаг юм шиг санагддаг хэн нэгнийг та таних уу? Зениф болон түүний хүмүүс хоёр дахь удаагаа тулалдахаар явахаас өмнө Зениф өөрийн хүмүүстээ леменчүүд яагаад нифайчуудыг үзэн яддаг болохыг тайлбарласан. Мозая 10:11–18-д байгаа Зенифийн үгсийг судлахдаа “сүйтгэгдсэн” гэдэг нь гомдсон, хилсээр болон шударга бусаар харьцсан гэсэн үг ба “хилэгнэх” гэдэг нь маш их уурлах гэсэн утгатай гэдгийг санах нь тустай. Мозая 10:11–18-ыг судлаад, Лемен Лемүел хоёрын үр удмынхан яагаад Нифайн үр удмыг үзэн ядсаар байсныг ол. Уншихдаа *сүйтгэсэн* болон *хилэгнэх* гэсэн үгсийг тэмдэглэж бай.

Дараах асуултуудыг тунгаан бодож үз:

- Яагаад леменчүүд нифайчуудыг тэгж ихээр үзэн яддаг байсан бэ?
- Бид ууртай эсвэл уучлахыг хүсэхгүй байснаар хэнийг хохироодог вэ?
- Уурлаж, өш хонзон санах нь таны гэр бүл болон ирээдүйн хүүхдүүдэд тань хэрхэн нөлөөлж болох вэ?

Далын ахлагч Доналд Л.Холлстромын дараах туршлагыг уншаад, хүнд уурласан эсвэл гомдсон үедээ юу хийхийг санал болгосныг ол:



“Олон жилийн өмнө би эмгэнэл болсон гансралыг ажигласан. Нэг залуу хос анхны хүүхдээ төрүүлэх дөхөж байлаа. Тэдний амьдрал энэхүү гайхалтай явдлын төлөө баяр хөөр, сэтгэл хөдлөлөөр дүүрэн байв. Хүүхдийг нь төрж байхад асуудал гарч, хүүхэд нь нас баржээ. Гансрал нь зовлон болж, зовлон нь уур болоод, уур нь буруушаалт болж, тэгээд буруушаалтаас нь болж эмчээс өшөө авмаар болж, тэд бүх хариуцлагыг эмчид тохсон байна. Тэдний аав ээж, хамаатан садангууд нь ихээр оролцож, тэд хамтдаа эмчийн нэр хүнд, ажил төрлийг нь сүйтгэхийг оролджээ. Гэр бүл нь хэдэн долоо хоног, тэгээд хэдэн сарын турш ширүүн маргаан дунд байсны эцэст тэд гомдлоо Их Эзэн рүү чиглүүллээ. ‘Тэр яаж ийм аймшигт явдал болохыг зөвшөөрч чадаж байна аа?’ Тэд Сүмийн удирдагчид болон гишүүдийг сүнслэг байдал болон сэтгэл санааны хувьд тайтгаруулахыг хичээхэд нь эсэргүүцсэн бөгөөд яваандаа Сүмээс холджээ. Энэ нь одоо тэр гэр бүлийн дөрвөн үе удамд нөлөөлж байна. Өмнө нь итгэлтэй, Бурхан болон Түүний сүмд үнэнч байсан ч хэдэн арван жилийн хугацаанд тэр гэр бүлийн ямар ч хүн ямар ч сүнслэг үйл ажиллагаанд оролцоогүй. . . .

Миний аавын талын эмээ өвөө хоёр нэг хүү (миний аав) бас нэг охин хүүхэдтэй байсан. Тэдний охин 1946 онд гэрлэж дараа нь хүүхэд төрүүлэх гэж байсан. Түүнийг ихэр хүүхэд төрүүлэх гэж байсныг нь хэн ч мэдээгүй. Харамсалтай нь тэр төрөхдөө хоёр ихэр хүүхэдтэйгээ гурвуулаа нас барсан юм.

Манай эмээ өвөө хоёрын элэг нь эмтэрсэн. Хэдий тийм ч тэдний уй гашуу тэр даруй тэднийг Их Эзэн болон Түүний Цагаатгал руу чиглүүлсэн аж. Ийм юм яагаад тохиолдсон, хэн нь буруутай вэ гэдэг дээр анхаарлаа төвлөрүүлэхгүйгээр тэд шударгаар амьдрахыг л бодсон. . . .

Манай эмээ өвөө хоёрын итгэлтэй байдал нь, ялангуяа бэрхшээл тулгарах үед дараагийнх нь дөрвөн үе удамд нөлөөлсөн юм. Тэдний хүү (миний аав) бас миний ээж хоёрын бага хүүхэд болох охиныг төрөх үед хүндрэл үүсч охин нь нас барахад бас энэ нь тэдэнд шууд нөлөөлсөн. Өмнөх үе удмын үзүүлсэн

үлгэр жишээг санаж манай аав ээж хоёр тайтгарал авахаар шууд Их Эзэнд хандсан. . . .

“Хэн нэгэн (гэр бүлийн гишүүн, найз, сүмийн гишүүн, сүмийн удирдагч, бизнесийн танил) эсвэл ямар нэгэн зүйл (хайртай хүн тань нас барсан, эрүүл мэнд болон санхүүгийн асуудал, хүчирхийлэл, донтолт) таныг сүйтгэхээр хандсан эсвэл тохиолдсон юм шиг танд санагдвал өөрт байгаа бүх чадлаараа үүнтэй тулж ажилла. . . . Мөн цаг алдалгүй Их Эзэнд ханд. Түүнд бүх итгэлээрээ ханд. Таны зовлонг хуваалцах боломжийг Түүнд олго. Таны ачааг ач ивээлээрээ хөнгөлөх боломжийг Түүнд өг. . . . Дэлхийн нөхцөл байдалд таны сүнслэг байдлыг гэмтээх боломжийг бүү олго” (“Turn to the Lord,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2010 оны 5-р сар, 78–80).

Леменчүүд болон анхны хүүхдээ алдсан залуу хосын гэр бүлийнхний жишээнүүдээс харахад уур, гомдол нь олон үе удмын хүмүүст нөлөөлсөн байгааг анзаараарай.



5. Сүйтгэгдсэн эсвэл хэн нэгэнд уурлаж байсан үеэ сана. Танд одоо тийм мэдрэмжүүд байгаа юу? Судрын тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

а. Би уучлахыг хичээхдээ яаж тусламж авч болох вэ?

б. Би хэрхэн ахлагч Холлстромын эмээ өвөөгийн жишээг дагаж, түүний ярьсан сүүлийн догол мөр дэх зөвлөгөөг амьдралдаа хэрэгжүүлэх вэ?



6. Дараах өгүүлбэрийг судрын тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Мозая 9–10-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

12-Р ХЭСЭГ: 3 ДАХЬ ӨДӨР

Мозая 11–14

Оршил

Хаан Ноа самуун амьдралд баярлаж, хүмүүсээсээ олныг ёс бус амьдрал руу удирдсан. Их Эзэн бошиглогч Абинадайг Ноагийн хүмүүст наманчлалыг тунхаглаж, ирээдүйн боолчлолын тухай сэрэмжлүүлэхээр явуулсан. Хүмүүс нь түүний сэрэмжлүүлгийг тоохгүй байхаар сонгосон бөгөөд Абинадай бошиглогчдынхоо улмаас шоронд хоригдсон. Хаан Ноагийн пристүүд Абинадайгаас асуулт асуухад нь бошиглогч тэднийг зарлигуудыг зааж, тэдгээрийн дагуу

амьдраагүй хэмээн зэмлэсэн. Бурхан Абинадайг хамгаалж, түүнд хаан Ноа болон түүний пристүүдэд өгөх захиасыг дуусгах хүч өгсөн. Абинадай Исаиагаас эш татан, хүмүүсийг Есүс Христ болон Түүний Цагаатгалд итгэн найдах ёстой хэмээн гэрчилсэн.

Мозая 11:1–19

Хаан Ноа өөрийн хүмүүсийг ёс бус зүйлд уруу татав

Дараах асуултуудын талаар тунгаан бод:

- Хэрвээ таны аав ээж, эсвэл удирдагч таны найзуудын зарим нь танд муугаар нөлөөлж байгааг хэлбэл та юу хийх вэ?
- Хэрвээ таны аав ээж эсвэл сүмийн аль нэг удирдагч таныг Ариун ёслол болон сүмийн бусад үйл ажиллагаанд илүү зохистой хувцаслахыг гуйсан бол та юу хийх вэ?
- Хэрвээ бошиглогч таныг зугаа цэнгэлийнхээ жишгийг өөрчлөх хэрэгтэй гэвэл та юу хийх вэ?

Хүмүүс дээрх асуултуудад өөрөөр хандаж магадгүй. Энэ хичээлийг судлахдаа Их Эзэн таныг шударгаар амьдрахад туслуулахаар Түүний явуулсан хүмүүст хандах таны хандлагыг ямар байгаасай гэж хүсэж байгааг ол.

Мозая 11-р бүлгийг судлахад бэлдэхдээ Зенифийг нас барсны дараа түүний хүү Ноа Нифайн нутагт байсан нифайчуудыг удирддаг байсныг мэдэх нь тустай байж болох юм. Мозая 11:1–2, 5–7, 14–19-ийг уншиж, Ноаг хаан болсны дараа түүний үйл явдал болон хүслийг нь тайлбарласан үг хэллэгийг тэмдэглэ. Дараа нь Мозая 11:2, 6–7, 15, 19-ийг уншиж, өөр өнгөөр (боломжтой бол) Ноагийн хийсэн үйлүүдээс хаант улсын хүмүүст нөлөөлсөн нөлөөг нь тэмдэглэ.

Эдгээр шүлгүүд нь бидний харилцдаг хүмүүс бидний үйлдэлд нөлөөлж болохыг харуулж байна. Үе тэнгийнхэн тань таны хийдэг сонголтуудад хэрхэн нөлөөлдгийг тунгаан бод. Өнөөдрийн дэлхийд хүмүүсийн “алдсыг тэтгэхийн тулд” хөдөлмөрлөхтэй адилхан гэж үзэж болох хүмүүсийн хийдэг зүйлсийн тухай тунгаан бод (Мозая 11:6).

Мозая 11:20–12:17


Абинадай хүмүүсийг наманчлахыг ятгаж боолчлолын талаар сэрэмжлүүлдэг.

Хаан Ноагийн хүмүүс ёс бусыг сонгож байсан ч, Бурхан тэднийг хайрлаж тэдэнд туслахыг хүссэн. Мозая 11:20-ийн эхний дөрвөн мөрийг гүйлгэн уншаад, Ноагийн хүмүүст тусалсан Бурханы үйлдлийг тодорхойл.




Судар дээрээ Мозая 11:20-ийн хажууд дараах үнэнийг бич: **Бурхан бидэнд наманчилж, зовлонгоос зайлсхийхэд туслуулахаар бошиглогчдыг илгээдэг.**

Бурхан Абинадайг хүмүүст сэрэмжлүүлэхээр хоёр удаа зарлигласан.

 **1.** Дараах хүснэгтийг судрын тэмдэглэл дээрээ хуулж аваад, судрын заалт бүрийн доор хариу бичих хангалттай зай үлдээ. Заасан шүлгүүдийг судалж, Абинадайн сэрэмжлүүлэг болон хүмүүсийн хариу үйлдлийг тоймлон бич.

	Абинадайн захиас	Хүмүүсийн хариу үйлдэл
Эхний анхааруулга	Мозая 11:20–25	Мозая 11:26–29
Хоёр дахь анхааруулга	Мозая 12:1–8	Мозая 12:9–10, 13–17

 **2.** Абинадайн анхааруулгад хүмүүс хэрхэн хариу үйлдэл үзүүлсэн талаар судрын тэмдэглэлдээ дараах асуултаудад хариулж бич.

а. Хүмүүс яагаад тэдэнд туслахыг хичээж байсан Абинадайд уурлаж байсан бэ? Хүмүүс яагаад өөрсдийг нь зовлон руу удирдан чиглүүлж байсан хаан Ноаг хамгаалж байсан гэж та бодож байна вэ?

б. Мозая 11:29-д гардаг “хүмүүсийн нүд харалган болсон байв” гэдэг үгийг анхаар. Одоогийн дэлхийд Сатан ямар ямар зан байдал, нөлөөгөөр сайн хүмүүсийг “харалган” болгохоор хичээнгүйлэн хөдөлмөрлөж байгаа жишээнүүд байна вэ?

в. Гэр бүлийн гишүүд, сүмийн удирдагч болон бошиглогчид таныг Бурханы үгийг дагахыг урамшуулахад та даруу байдлыг яаж үзүүлэх вэ?

Мозая 12:18–13:26

Хаан Ноа болон түүний пристүүд зарлигуудыг дагаагүй мөн тэдгээрийг заагаагүй хэмээн Абинадай зэмлэхэд Бурхан түүнийг хамгаалсан.

Мозая 12-ыг судалж, үргэлжлүүлэхээсээ өмнө дараах тодорхойлолт нь яг одоо тантай хэр сайн зохицож байгааг 1-ээс 10-ын хооронд хэмж (10 бол төгс зохицож байна гэсэн үг):

___ Би Есүс Христийн сайн мэдээний дагуу амьдрахын тулд яах ёстойгоо мэдэж байна.

___ Би Есүс Христийн сайн мэдээний дагуу амьдардаг.

Хаан Ноа болон түүний пристүүдийн талаар судлахдаа тэднийг зарлигуудыг хэр сайн мэдэж мөн тэдгээрийн дагуу хэр сайн амьдардаг байсан талаар нь бодоорой. Ноа Абинадайг шоронгоос гаргасны дараа пристүүд нь түүнээс судрын талаар асуулт асууж эхэлсэн. Мозая 12:26–30-ийг уншиж Ноа болон түүний пристүүдийг зэмлэхээр Абинадайн юу хэлснийг тэмдэглэ.

Ноа болон түүний пристүүд 1-ээс 10-ын хооронд зарлигуудыг хэр сайн мэдэж тэдгээрийн дагуу хэр сайн амьдардаг байсан гэж та бодож байна? Таны бодлоор “ойлгохын тулд зүрх сэтгэлээ зориулах” гэдэг нь юу гэсэн үг вэ? (Мозая 12:27-г үзнэ үү). Мозая 12:33-ыг үзэж, зарлигуудын дагуу амьдрахын чухлыг илэрхийлдэг зарчмын доогуур нь зур.

Абинадай энэ үнэнийг тунхагласан: **Хэрвээ бид Бурханы зарлигуудын дагуу амьдарвал бид аврагдах болно.** Яаж амьдрах ёстойгоо мэдэх нь яагаад аврагдахад маань хангалтгүй байдаг вэ? _____

Абинадай хаан Ноа болон түүний пристүүдийг зарлигуудын дагуу амьдрахгүй, бас тэдгээрийг заахгүй байгааг нь хэлж Арван Зарлигийг жагсаан ярьж эхэлсэн. Иймээс хаан уурлаж, Абинадайг цаазлахыг зарлиг болгосон. Бурхан Абинадайг хамгаалж, Арван Зарлигийн талаар зааж, үргэлжлүүлэх хүчийг түүнд өгсөн. Та тэдгээрийг Мозая 12:35–36 болон Мозая 13:12–24 дээр тэмдэглэн дугаарлах хэрэгтэй. Дараах хүснэгт танд Арван Зарлигийн зарлиг бүрийг тодорхойлоход тус болно.

Абинадай Арван Зарлигийг заав
1. Мозая 12:35
2. Мозая 12:36; 13:12–13
3. Мозая 13:15
4. Мозая 13:16–19
5. Мозая 13:20
6. Мозая 13:21
7. Мозая 13:22
8. Мозая 13:22
9. Мозая 13:23
10. Мозая 13:24

Абинадай зоригтойгоор Ноа болон түүний пристүүдийг Арван Зарлигийг дагаагүйн улмаас зэмлэн хэлэхдээ “Тэдгээр нь та нарын зүрх сэтгэлд бичигдсэн нь үгүй гэдгийг би харна” гэжээ (Мозая 13:11). Арван Зарлигийг хэр сайн даган амьдарч байгаагаа бодоход тань туслах дараах өөрийгөө дүгнэх үнэлгээг бөглө.

Доорх тодорхойлолтуудад хариулсан хариултууд таныг Арван Зарлигийг зүрх сэтгэлдээ хэр сайн бичсэн болохыг харуулна. Эдгээр тодорхойлолтууд таны хувьд хэр зэрэг үнэн гэдгийг тэмдэглэ.	Бараг хэзээ ч үгүй	Ховорхон	Ихэнхдээ	Бараг дандаа
Би Тэнгэрлэг Эцэгтэй хайртай.				
Би амьдралдаа хамгийн түрүүнд Бурханыг тавьдаг (найзууд, хобби, өмч, өөрийн хүсэл болон бусад зүйлсийн өмнө).				
Би Их Эзэний нэрийг хүндэтгэлтэйгээр хэрэглэдэг.				
Намайг Их Эзэнд ойртуулдаг үйл ажиллагаанд оролцож, Хүндэтгэлийн өдрийг би ариунаар сахидаг; Би үүнийг минийх биш, Түүний өдөр гэдгийг хүлээн зөвшөөрдөг.				
Би хүндэтгэлтэй мөн дуулгавартай байж эцэг эхээ хүндэлдэг.				
Би уураа захирч мөн бусдад хэрцгийгээр ханддаггүй.				
Би бэлгийн амьдралын хувьд цэвэр ариун. Би зохисгүй харагдах зүйл, хэл яриа болон үйлдлээс зайлсхийдэг.				
Би хулгай хийж, хууран мэхлэхийг цээрлэдэг.				
Би үнэнийг ярьдаг.				
Би шуналтай байхаас зайлсхийдэг (өөр хүнд байгаа зүйлийг зохисгүйгээр маш ихээр хүсэх гэсэн үг).				



3. Бичсэн хариултуудаа эргэн харж, Арван Зарлигуудын нэгийг нь илүү сайн дагах зорилго тавь. Зорилгоо судрын тэмдэглэлдээ бич.

Мозая 13:27–14:12


Абинадай Есүс Христийн ирэлтийн талаар заадаг


Мозая 13:28, 32–35-ыг уншиж, Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Даллин Х.Өүксийн хэлсэн эшлэлийг төгсгөж болох үг хэллэгийг тэмдэглэ: “Бидний дуулгавартай байдал, сайн үйлдлийн дараа, бид ___ гүйгээр үхэл болон өөрийн хийсэн нүг-лийн нөлөөллөөс аврагдаж чадахгүй” _____.”

Ахлагч Өүксийн хэлсэн үгс нь бүтнээрээ: “Бидний дуулгавартай байдал, сайн үйлдлийн дараа, бид Есүс Христийн Цагаатгалын өгдөг ач ивээлгүйгээр үхэл болон өөрийн хийсэн нүглийн нөлөөллөөс аврагдаж чадахгүй” (“Another Testament of Jesus Christ,” *Ensign*, 1994 оны 3-р сар, 67).

Та энэ үнэнийг Мозая 13:28-ын хажууд бичих хэрэгтэй: **Есүс Христийн Цагаатгалгүйгээр хэн ч аврагдаж чадахгүй.**

Мозая 14:1–12-ыг хэдэн минутад судалж, бидэнд Тэнгэрлэг Эцэгтээ дахин очиход туслах Есүс Христийн мөнх бус амьдралдаа хийсэн үйлдлийг нь дүрслэх үг хэллэгийг тэмдэглэ. Таны төлөө Есүс Христийн үүрсэн зовлон, уй гашуу болон нүглийг бодож үз. Эдгээр шүлэг Исаиа 53:1–12-тай тохирдог. Абинадай Исаиагийн бичсэнээс эш татан ярьсан (Мозая 14:1-ийг үзнэ үү).

 **4.** Судрын тэмдэглэлдээ Мозая 14:4–5 эдгээр шүлгүүд Есүс Христийн талаар юу заадгийг найздаа яаж тайлбарлахаа бич.

 **5.** Дараах өгүүлбэрийг судрын тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Мозая 11–14-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

12-Р ХЭСЭГ: 4 ДЭХ ӨДӨР

Мозая 15–17

Оршил

Абинадай, хаан Ноа болон түүний пристүүдэд хандан заасан цэдэг нь Мозая 15–17-д үргэлжилдэг. Тэр Есүс Христийн Гэтэлгэгчийн үүргийн талаар гэрчилсэн. Ноагийн пристүүдийн нэг болох Алма Абинадайн үгсэд итгэсэн. Хаан Ноа Алмаг хамт


олноосоо хөөж, Абинадайг шатааж алсан. Абинадай бүхий л талаараа Бурханд үнэнч байсан.

Мозая 15–16

Абинадай Есүс Христийн Гэтэлгэгчийн үүргийн талаар заадаг

Мозая 15–16-р бүлгүүдэд гардаг *гэтэлгэх, гэтэлгэсэн*, болон *гэтэлгэл* гэдэг үгсийг хэдэн хором хайж олоод дугуйл. Судрын нэг хэсэг дээр нэг үг олон давтсан бол тэр нь ихэвчлэн бичигчийн захиас дахь чухал зарчмыг тодорхойлдог. Өнөөдөр үүнийг судлахдаа гэтэлгэгдсэн байх талаар Абинадай юу заасныг нь анхаар.

Танд Есүс Христийн Гэтэлгэгчийн үүргийг илүү сайн ойлгоход тань туслахын тулд дараах бүдүүвч зураг байгааг хараарай:



Гэмт хэрэгтэн

Торгууль?
Шорон?
Үхэл?

Шийтгэл

Та нэг хууль зөрчсөнөөсөө болж хуулийн хамгийн хүнд шийтгэлийг хүлээхээр шийтгэгдсэн гэж төсөөл. Шийтгэлд нь их хэмжээний торгууль, шоронд хоригдох, эсвэл бүр цаазлагдах ч байж болно. Та тиймэрхүү шийтгэл хүлээвэл ямар санагдах вэ? Шударга буюу хуулийн дагуу энэ шийтгэлээс зугтах арга байна уу?

Бүдүүвч зурган дээр *Гэмт хэрэгтэн* гэсэн үгийн доор *Би* гэж бичээд *Шийтгэл* гэсэн үгийн доор *Шударга Ёс* гэж бич. Бид бүгд хэзээ нэгэн цагт Бурханы хуулийг зөрчсөн бөгөөд шударга ёсны шаардлагыг хангах хэрэгтэй. Шударга ёсны шаардлагын дагуу нүгэл үйлдсэн хүн болгон хийсэн гэм нүгэлтэйгээ холбоотой шийтгэл авах шаардлагатай.



Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Ричард Г.Скоттын хэлсэн үгсийг уншиж, Бурханы хуулиудыг зөрчихөд гарах хоёр үр дагаврын доогуур зур:

“Шударга ёс . . . зөрчигдсөн хууль бүр нөхөн төлөгдсөн байхыг шаарддаг. Та

Бурханы хуулиудыг сахиснаар адислагддаг боловч энэ нь таны зөрчсөн хуулийн үр дагаврыг цайруулахгүй. Зөрчсөн хуулиудынхаа асуудлыг шийдвэрлэхгүй бол энэ нь таны амьдралыг золгүй болгон, таныг Бурхан руу буцахад саад болох болно (“The Atonement Can Secure Your Peace and Happiness,” *Ensign*, *Луахона*, 2006 оны 11-р сар, 42).

Бурханы хуулиудыг зөрчсөний үр дагаварт золгүй байдал ба Бурхантай хамт амьдарч чадахгүй байх нь хамаардаг. Мозая 15:1, 7–9-ийг уншиж, Аврагчийн Цагаатгал нь яаж шударга ёсны шаардлагыг бие-лүүлдгийг тайлбарласан хэллэгүүдийг тэмдэглэ.

Толь бичгээс дараах үгсийн утгыг хайж үз:

Гэтэлгэх (Мозая 15:1) _____

Өмгөөлөл (Мозая 15:8) _____

хооронд (Мозая 15:9) _____

Та эдгээр үгсийн утгуудыг тухайн шүлгийн хажууд нь бичих хэрэгтэй.

Заримдаа хүмүүс Мозая 15:2–5 шүлгүүдэд Есүс Христийг (1) Эцэг Бурханы Хүү болон (2) Эцэг хэмээн Абинадай тайлбарласныг нь ойлгодоггүй. Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Жэффри Р.Холланд Есүс Христийн бурханлаг чанарыг ийн тайлбарладаг: “Абинадайн заасанчлан, Христ ‘Бурханы хүчээр бий болгогдсон’ (Мозая 15:3) тул Эцэгийн хүчнүүд Түүнд байдаг. Тэрхүү тэнгэрлэг угсаанаас гадна Христ тэнгэр ба газрыг бүтээсэн Бүтээгчийн хувьд Эцэгийн үүргийг гүйцэтгэдэг [Мозая 15:4-ийг үзнэ үү], Тэрээр бидний сүнслэг дахин төрөлт ба авралын эцэг болж, Тэр Тэнгэрлэг Эцэгт хүндэтгэлтэй ханддаг учраас Эцэгийнхээ хүслийг Өөрийнхөө хүслээс дээгүүр тавьдаг юм” (*Christ and the New Covenant: The Messianic Message of the Book of Mormon* [1997], 183–184).

Мозая 15:5–7-г судлахдаа, Есүс Христ таныг гэтэлгэх эсвэл та болон шударга ёсны шаардлага хоёрын хооронд зогсохын тулд Түүний төлсөн төлөөсийг бод. Дээрх бүдүүвч зураг дээр *Гэмт хэрэгтэн*, *Шийтгэл* хоёрын дунд *Есүс Христ* гэж бич.

Аврагч шударга ёсны шаардлагыг устгадаггүй, харин шударга ёс бид хоёрын хооронд зогсдог гэдгийг ойлгох нь чухал. Хэрвээ бид наманчлах юм бол Тэр бидний оронд шийтгэлийг Өөр дээрээ авч шударга ёсны шаардлагыг хангадаг.



1. Дараах үйл ажиллагаануудыг судрын тэмдэглэлдээ гүйцээж хий:

а. Гэтэлгэгдэхийг сонгодог хүмүүс (Мозая 15:11–12; 16:13) гэж бич. Дараа нь Мозая 15:11–12 болон 16:13-ыг үзэж, хэн гэтэлгэгдэхийг хайж ол. Олсноо тайлбарла.

б. Гэтэлгэгдэхээс татгалздаг хүмүүс (Мозая 15:26–27 болон 16:2–5, 12) гэж бич. Тэгээд Мозая 15:26–27 болон 16:2–5, 12-ыг уншиж, зарим хүмүүс яагаад гэтэлгэгдэхгүй вэ гэдгийг хайж үз. Олсноо тайлбарла.



2. Өмнөх даалгавраас сурсан зүйлсээ ашиглан судрын тэмдэглэлдээ дараах асуултуудад хариул:

а. Хэн нүглээсээ гэтэлгэгдэхийг юу шийдэх вэ?

б. Та Мозая 15:7-д гардаг Есүс Христийн “хүсэл,” Мозая 16:12-т гардаг хилэнцийг үйлддэг хүмүүсийн “хүсэл” хоёрын ялгаанаас юу сурдаг вэ?

Есүс Христ наманчлах хүн бүрийн төлөө шударга ёсны шаардлагыг хангадаг. Наманчилж, Эцэгийн хүслийг үйлдэхийг сонгодог хүмүүсийн хувьд Аврагчийн бидний төлөө төлсөн төлөөс нь маш онцгой хувийн бэлэг юм. Мозая 15:10-ыг уншиж, “тэрээр өөрийн үрсийг харах болно” гэдэг хэллэгийн доогуур зур.



Мозая 15:10–12 болон чөлөөнд гарсан Далын гишүүн ахлагч Мэррилл Ж.Бэйтманы хэлсэн дараах үгийг унш:

“Бошиглогч Абинадай ‘түүний бодгаль нүглийн төлөөс болсон байхад тэрээр өөрийн үрсийг харах болно’ гэдгийг

хэлдэг (Мозая 15:10). Дараа нь Абинадай Аврагчийн үрсийг бошиглогчид болон тэднийг дагадаг хүмүүс хэмээн тодорхойлдог. Би олон жилийн турш цэцэрлэгт болон загалмай дээрх Аврагчийн туршлагыг нь их хэмжээний нүгэл түүн дээр буулгасан газар гэж боддог байсан. Харин Алма, Абинадай, Исаиа болон бусад бошиглогчдын үгсээс болж миний үзэл өөрчлөгдсөн. Есүс бидний ‘мөхөс байдлыг’ мэдэрч (Еврей 4:15), ‘бидний өвчнийг [тээж], . . . бидний уй гашууг үүрч, . . . [мөн] бидний гэм нүглийн төлөө бяцрахад’ (Исаиа 53:4–5) эзэн биегүй овоорсон нүглийн оронд эгнээд зогссон хүмүүс байв.

“Цагаатгал нь Есүсийн хүн тус бүрд яаж туслахыг мэдэж авсан дотны хувийн туршлага байсан юм” (“A Pattern for All,” *Ensign* болон *Лиухона*, 2005 оны 11-р сар, 75–76).



3. Судрын тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

а. Таны бодлоор Есүс Христийн үрс болох гэдэг нь юу гэсэн үг вэ? (Мозая 15:12-ыг үз).


б. Та Есүс Христийн үрсэд тооцогдохын тулд юу хийж байгаа вэ?

Та Мозая 15:10-ыг өөр дээрээ авч үзэхийн тулд доор нь зурсан шүлэг дээр “түүний үрс”-ийн оронд өөрийн нэрийг бичиж болно. Таныг харж, онцгойлон мэддэг Гэтэлгэгчтэй байх нь ямар утгатай гэдгийг тунгаан бодож үз.

Гэтэлгэгдэхээс татгалзахын үр дагавар нь юу вэ? Мозая 16:5-ыг дахин үз. Энэ хичээлийн эхэнд үзүүлсэн бүдүүвч зураг дээр гэмт хэрэгтэн нь үргэлжлүүлэн нүгэл үйлдэж наманчлахаас татгалзвал юу болох

вэ? Сургаал ба Гэрээ 19:16–17-г уншиж, Аврагчийн гэтэлгэх үйлдлийг наманчлалаар хүлээн зөвшөөрөхийг хүсэхгүй байгаа хүмүүст юу тохиолдохыг мэдэж ав.

Абинадай Есүс Христийн гэтэлгэл нь зөвхөн нүглээс бус, мөн үхлээс аврах болно гэж заасан. Бүх хүн амилагдах болно, харин зарим нь бусдаас түрүүлж амилагдана. Абинадай шударга болон гэмгүй хүмүүсийг дуулгаваргүй хүмүүсийн өмнө амилагдахыг тайлбарлахдаа “анхны амилуулалт” гэдэг үгийг ашигласан (Мозая 15:21–22-ыг үз). **Шударга хүмүүс үхлээс анхны амилуулалтаар гэтэлгэгдэж** харин ёс бусчууд мянган жилийн дараа хүртэл амилагдахыг хүлээнэ (С ба Г 76:85, 106-г үзнэ үү).

 **4.** Мозая 15-д судалсан шүлгүүдийг тунгаан бод. Та өөрөөсөө Аврагч руу захиас хүргэж өгөх боломжтой боллоо гэж төсөөл. Түүний таны төлөө хийсэн бүхэн дээр тулгуурлан та тэр захиас дээр хүссэн зүйлээ бич.

Аврагч биднийг Тэнгэрлэг Эцэгийн оршихуйд буцаан авчрахыг хүсдэг. Тэр бидний өмнөөс өмгөөлж, зуучилж, гуйдаг. Хэрвээ бид наманчлах юм бол Аврагч бидний төлөө шударга ёсны шаардлагыг төлсөн байна.


Мозая 17

Алма Абинадайд итгэж зайлуулагддаг; Абинадай алуулдаг

Шударга ёсны төлөө эсэргүүцэн зогсох нь хэцүү байсан ч гэсэн тэмцэн зогсох хэн нэгнийг та харж байсан уу? Үр дүн нь юу байсан бэ?

Абинадайд захиасаа дуусгахад пристүүдийн нэг болох Алма хаанд, Абинадай үнэнийг ярьсан бөгөөд чөлөөлөгдөх ёстой гэж ятгасан. Хаан Алмаг хөөж, түүнийг алуулахаар зарц нараа илгээв. Алма нуугдан, Абинадайн үгсийг бичив.

Алмагийн хөрвөлт нь ач холбогдолтой байлаа. Тэрээр Абинадайн үгсийг бичиж авсан учраас олон үеийн хүмүүс адислагдсан. Ирэх бүлгүүдийг судлах үеэр Алмагийн хөрвөлтийн үр жимс нь илүү тодорхой болно. Абинадайд цаазлахыг зарлиглахаас өмнө хаан пристүүдтэйгээ гурван хоногийн турш зөвлөлдсөн (Мозая 17:1–6, 13-ыг үзнэ үү).

 **5.** Мозая 17:7–10 болон Мозая 17:11–12-т Абинадай, Ноа хаан хоёрын хийсэн сонголтуудыг харьцуулдаг. Эдгээр шүлгүүдийг судалсныхаа дараа судрын тэмдэглэлдээ дараах асуултуудад хариул.

а. Абинадайн сүүлчийн үгсээс аль нь танд илүү таалагдсан бэ?

б. Абинадайн хэлсэн үгс Ноа хаанд яагаад тэгэж туссан бэ?



в. Пристүүд Ноа хаанд ямар нөлөө үзүүлсэн бэ?

г. Абинадайн жишээ таныг ямар ч үед Бурханд үнэнч байх-ад хэрхэн нөлөөлж байна вэ?

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли ийн тунхагласан: “Зөвийн төлөө зогсохдоо хүчтэй бай. Бид тохиролцох, хүлцэх үед амьдарч байна. Бидний өдөр болгон тулгардаг нөхцөл байдлуудад юуг нь зөв гэдгийг бид мэддэг боловч бидний хамт олноос ирдэг шахалт, биднийг ятгах хүмүүсийн хуурах дуу хоолойноос болж бид бууж өгдөг. Бид тохиролцон буудаг. Бид хүлцдэг. Бид бууж өгөөд өөрсдөөсөө ичдэг. . . . Бид өөрсдийнхөө итгэлийг дагах хүч чадлаа хөгжүүлэн өсгөх ёстой” (“Building Your Tabernacle,” *Ensign*, 1992 оны 11-р сар, 52).

Судар дээрээ Мозая 17:9–12-ын хажууд *Би Бурханд ямар ч үед үнэнч байж чадна* гэж бич.

 **6.** Абинадайн ёс суртахууны зориг болон хувийн итгэлийг өөрийн болгохын тулд Мозая 17:20-ийг уншиж,

дараах өгүүлбэрийг судрын тэмдэглэлдээ гүйцээж бич: Би _____ үед Бурханд үнэнч байх хэрэгтэй.

Өнөөдрийн хичээлийг дуусгахад өнөөдрийн сурсан зүйлсийг тань сонсох хэрэгтэй байж болох гэр бүлийн гишүүн эсвэл найзынхаа талаар бодоорой. Боломжтой бол сурсан зүйлс болон хэцүү үед Их Эзэнд үнэнч байх хүслээ түүнтэй хуваалц.



7. Дараах өгүүлбэрийг судрын тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Мозая 15–17-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

13-Р ХЭСЭГ: 1 ДЭХ ӨДӨР

Мозая 18

Оршил

Ёс бус Ноа хааны прист байсан Алма бошиглогч Абинадайн үгэнд итгэж, нүглээ наманчилсан. Абинадайг нас барсны дараа Алма бусдад Есүс Христийн тухай хувиараа заав. Алмагийн үгэнд итгэсэн хүмүүс нь Бурханы хороонд ирэх хүсэлтэй байсан. Тэд Мормоны Ус гэдэг газарт баптисмын гэрээнд орсон. Та Мозая 18-ыг судлахдаа баптисм хүртэхэд хийдэг амлалт болон тэр амлалтаа биелүүлэх тохиолдолд Их Эзэн юу хийх талаар Алмагийн заасан зүйлсийг анхаар.



Мозая 18:1–16

Алма хүмүүст зааж тэдэнд баптисм хүртээсэн

Өөрийнхөө баптисмыг бод. Та баптисмынхаа талаар юу юу санадаг вэ? Та баптисм хүртэхдээ хэрхэн бэлдсэн бэ? Та баптисмынхаа үед мэдэрсэн ямар мэдрэмжүүдийг санадаг вэ? Та одоо баптисмынхаа талаар юуг тэр үеэс илүү ихээр үнэлж болох вэ гэдгийг тунгаан бод.

Мозая 18-р бүлэг бидэнд баптисмын үеэр Бурхантай хийсэн гэрээгээ ойлгоход маань тусалдаг. Гэрээ гэдэг нь “Бурхан хүн хоёрын хоорондох тохиролцоо боловч тэрхүү тохиролцоонд хоёр тал тэгш эрхтэй байдаггүй. Бурхан гэрээний нөхцөлүүдийг өгч, хүн түүний хүссэн зүйлсийг хийхийг зөвшөөрдөг. Хүмүүний дуулгавартай байдлын хариуд Бурхан зарим нэг адислалуудыг амладаг” (Guide to the Scriptures, “Covenant,” scriptures.lds.org).

Мозая 18-р бүлэг бидэнд баптисмын гэрээг ойлгоход хэрхэн тусалдгийг харахын тулд энэхүү бүлгийн тоймыг анхаар: Мозая 18:1–7, Гэрээнд бэлдэх; Мозая 18:8–16, Гэрээг хийх; Мозая 18:17–30, Гэрээний дагуу амьдрах. Та судар дээрээ сэдэв бүрийг (жишээ нь, *Гэрээнд бэлдэх*) тухайн шүлгүүдийн хажууд нь бичих хэрэгтэй.

Мозая 18:1–2, 6–7-г уншаад, хүмүүсийг баптисмд бэлдэхийн тулд Алмагийн заасан сургаал ба зарчмуудыг анхаар. Доорх зайд Алмагийн хүмүүстээ заасан зүйлсийг ойлгох ойлголт нь өнөөдөр хэн нэгнийг баптисмд хэрхэн бэлдэхэд туслахыг бич. —

Мозая 18:8–11-т Алма хүмүүстээ баптисмаар дамжуулан хийх, авах амлалтуудыг ойлгоход хэрхэн тусалсан талаар гардаг.



1. Доорх бүдүүвч зургийг судрын тэмдэглэлдээ зур. Мозая 18:8–11-р шүлгүүдээс бамтисм хүртэхдээ Бурхантай хийдэг амлалт (бидний хийх “хүсэлтэй” зүйлс) болон Бурханы хийдэг амлалтуудын талаар Алмагийн заасныг хай. Сурсан зүйлсээ бүдүүвч зургийнхаа зохих мөрөнд бич.

Би амладаг	Бурхан амладаг

Мозая 18:8–11-т тодорхой үзэгдэх сайн мэдээний зарчмуудын нэг бол: **Бид баптисмын гэрээг хийж, сахиснаараа Их Эзэний Сүнс болон мөнх амьдралын амлалтыг хүлээн авдаг.**



2. Судрын тэмдэглэл дэх бүдүүвч зургийнхаа доор баптисмын гэрээ хийж, түүнийгээ сахихын ач холбогдлын тухай юу сурснаа тоймлон бич.

Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Жозеф Б.Вөртлиний хэлсэн дараах үгсийг уншаад, баптисм хүртэхдээ хүлээн авч, хийдэг амлалтуудыг ойлгоход бидэнд ирж болох адислалуудын доогуур зур: “Шинэхэн хөрвөгч эсвэл бүх л амьдралынхаа туршид сүмийн гишүүн байсан эсэхээс үл хамааран хүмүүс баптисмын гэрээний адислал болон хүчийг бүрэн дүүрэн ойлгох үед үлэмж баяр баясал тэдний амьдралд ирж, хаант улс дахь үүрэг хариуцлагадаа бусдад амархан нөлөөлдөг урам зоригтойгоор ханддагийг би амьдралынхаа турш анзаарсаар ирсэн” (“Alma the Elder: A Role Model for Today,” in *Heroes from the Book of Mormon* [1995], 84).



3. Баптисмын гэрээ өдөр бүрийн амьдралын тань хэв маягт хэрхэн нөлөөлж болохыг судрын тэмдэглэлдээ бич. (Жишээлбэл, гэр бүлдээ хэрхэн ханддаг, бусадтай харилцах харилцаа, найзууд болон танилуудтайгаа ярилцдаг зүйлс, хэрэглэдэг үг яриа, үздэг кино, телевизийн нэвтрүүлгүүд, сонсдог хөгжим, болзоо болон олон нийттэй харьцах харилцаа, итгэлийг тань шүүмжилдэг хүмүүст хэрхэн ханддаг зэрэгтэй холбоотой болоход “ямар ч цагт Бурханы гэрчлэгч болж зогсох” гэсэн амлалтаа сана.)

Мозая 18:12–16-г анхааралтайгаар судлаад, баптисмынх нь дараа Алма болон түүний хүмүүстэй хийсэн гэрээнийхээ Өөрийн хийх талыг Их Эзэн хэрхэн биелүүлсэн жишээнүүдийг тодорхойл. Олсон зүйлсээ тэмдэглэх хэрэгтэй.



4. Баптисм хүртэхдээ хийсэн Түүнд үйлчилнэ гэсэн амлалтаа биелүүлэхэд Их Эзэн Өөрийн Сүнсээр таныг адисалсныг мэдэрсэн цаг мөчөө судрын тэмдэглэлдээ бич.

Мозая 18:17–30

Алма хүмүүсийн дунд Есүс Христийн Сүмийг байгуулав

Баптисм хүртэхдээ хийсэн болон ариун ёслолоос хүртэхдээ шинэчилдэг гэрээнүүдийнхээ талаар та хэр ойр ойрхон боддог вэ? Гэрээнүүдийнхээ талаар та хэр ойрхон бодож байх хэрэгтэй вэ? Эдгээр гэрээнүүдийн тухай та ихэвчлэн хэзээ цаг гарган боддог вэ?



Тэргүүн Зөвлөлийн гишүүн, Ерөнхийлөгч Хэнри Б.Айринг Их Эзэнтэй хийсэн гэрээнүүдээ сахихын ач холбогдлын талаар заасан: “Хожмын үеийн гэгээнтнүүд бол гэрээт хүмүүс. Баптисм хийлгэсэн өдрөөс эхлээд бидний амьдралын онцгой сүнслэг мөчүүд хүртэл бид Бурханд амлалт өгч, Бурхан ч бидэнд амлалт өгдөг. Тэрээр бидэнд өгсөн амлалтаа Өөрийн эрх мэдэл

бүхий үйлчлэгчдээрээ дамжуулан сахидаг. Харин бид Түүнтэй гэрээнүүд хийж, сахих эсэх нь бидний амьдралын маш чухал шалгуур болдог (“Witnesses for God,” *Ensign*, 1996 оны 11-р сар, 30).

Мозая 18:17–18, 20–23, 27–29-ийг уншихдаа Алмагийн үеийн Сүмийн гишүүд баптисмынхаа гэрээг хэрхэн сахиж байсныг олж мэд. Мозая 18:22, 26, 30-д гардаг **баптисмынхаа гэрээг сахидаг хүмүүст ирдэг агуу адислалуудыг** харуулсан үгс болон өгүүлбэрүүдийг тэмдэглэ.



5. Судрын тэмдэглэлдээ дараах асуултаудад хариулж бич: Баптисм хүртэхдээ хийсэн гэрээнүүдээ илүү сайнаар сахихын тулд таны хийх нэг зүйл юу вэ? Та яаж энэ амлалтаа сахих вэ?

Мозая 18:31–35

Сүмд харьяалагддаг хүмүүс хаан Ноагийн хавчлагаас оргон зугтав

Алма болон түүний хүмүүс Мормоны Усны ойролцоо агуу адислалуудыг хүртэн баясч байх үед Ноа хаан Лихай-Нифайн хотод юу хийж байсныг мэдэхийн тулд Мозая 18:31–33-ыг судал. Хүмүүст нь тохиолдох аюулыг Алма хэрхэн мэдсэнийг олж мэдэхийн тулд Мозая 18:34 болон Мозая 23:1–2-ыг унш.

Мозая 18:34-ийн хажууд энэхүү үнэнийг бичиж болно: **Зөв шударга хүмүүсийг аюулд учрах үед Их Эзэн тэдэнд сэрэмжлүүлж чадна.**

Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Нийл Л.Андэрсэний энэ үнэнийг харуулсан дараах туршлагыг унш.



“Нэг найз минь Холбооны Мөрдөх Товчоонд мөрдөгчөөр ажиллаж байхдаа АНУ руу хууль бусаар мансуурах бодис зөөдөг зохион байгуулалттай гэмт хэргийн бүлгүүдийг мөрддөг байжээ.

“Нэг удаа найз минь хамтрагчтайгаа мансууруулах бодис зардаг хүн кокаин нийлүүлж байж болзошгүй нэгэн нийтийн байранд очжээ. Миний найз юу тохиолдсоныг өөрөө ийн өгүүлсэн билээ:

“Бид мансууруулах бодис зарагчийн хаалгыг нь тогшлоо. Сэжигтэн үүдээ нээгээд биднийг харангуугаа ард талынхаа зүйлсийг халхлахыг оролдов. Гэсэн ч бид түүний ширээн дээр мансууруулах бодис болох кокаин байгааг харчихсан байлаа.

Ширээний цаана сууж байсан хүүхэн залуу хоёр ширээн дээрх кокаиныг бушуухан хамж эхлэв. Тэд нотолгоог алга болгохоос сэргийлэхийн тулд би үүд халхлан зогссон сэжигтнийг бушуухан хажуу тийш

нь түлхлээ. Түүнийг түлхэх үед бидний харц тулгарсан юм. Хачирхалтай нь тэр ер уурласан эсвэл айсан шинжгүй байв. Тэрээр над руу хараад инээмсэглэж байлаа.

Түүний харц бас гэмгүй инээмсэглэл нь түүнийг ямар ч гэм хоргүй хүн мэт надад санагдуулсан тул би түүнийг орхин ширээ рүү очив. Одоо сэжигтэн миний ард талд байлаа. Тэр даруй надад “хуурамч инээмсэглэлийн цаадах чөтгөрөөс болгоомжил” гэсэн бодол маш хүчтэйгээр төрөв.

Би сэжигтэн рүү тэр даруй эргэн харлаа. Тэрээр гарраа өмднийхөө халаасанд шургуулсан байв. Би түүний гарыг бушуухан халааснаас нь сугалж гаргав. Тэгэхэд л би түүний халаасанд байсан хагас автомат гар буу галлахад бэлэн байсныг харж билээ. Сандарч үймсэн үйлдлүүдийн дараа би түүний зэвсгийг хураасан юм. . . .

“ . . . Ариун Сүнс найзад маань бие махбодын аюул нүүрлэж буйг сэрэмжлүүлсэн; Ариун Сүнс та нарыг ч гэсэн сүнслэг байдлын аюулаас сэрэмжлүүлэх болно” (“Beware of the Evil behind the Smiling Eyes,” *Ensign* ба *Лиакхона*, 2005 оны 5-р сар, 46–47).



6. Ариун Сүнснээс хүлээж авсан мэдрэмж эсвэл биеийн болон сүнслэг аюулаас хамгаалагдсан, сэрэмжлүүлэгдсэн туршлагаа, эсвэл таны таньдаг хүнд тохиолдсон явдал эсвэл сонссон, уншсан зүйлийнхээ талаарх мэдрэмжүүдээ судрын тэмдэглэлдээ бич.



7. Дараах өгүүлбэрийг судрын тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Мозая 18-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

13-Р ХЭСЭГ: 2 ДАХЬ ӨДӨР

Мозая 19–20

Оршил

Алма болон түүний хүмүүс Ноа хааны армиас зугтсаны дараа Ноатай үлдсэн хүмүүс Абинадайн бошиглосон үр дагавруудыг амсан зовж эхлэв. Лихай-Нифайн нутаг дахь нифайчуудын цэдэг бидэнд Их Эзэний үйлчлэгчдийн зөвлөгөөг эсэргүүцэх үед бид ноцтой үр дагаврыг амсдаг гэдгийг сануулдаг. Нөгөө талаар бид бошиглогчдыг дуулгавартай дагах үедээ хэцүү сорилт тохиолдсон ч амар



амгалан, аюулгүй байдалд баясдаг. Энэ хичээлийг судлахдаа Их Эзэний өнөө үеийн бошиглогчдын зөвлөгөөг сонссоноос ирэх амар амгалан, аюулгүй байдлыг та хэрхэн хүлээн авч болох тухай бод.

Мозая 19–20

Лихай-Нифайн нутаг дахь нифайчууд Абинадайн бошиглол биелэхийг үзэв

Далын гишүүнээр үйлчилж байсан ахлагч Дэвид Р.Стөүн ахын хуваалцсан дараах туршлагыг уншаад, бошиглогчдоор дамжуулан хүлээн авдаг сүнслэг сэрэмжлүүлгийн ач холбогдлын талаар бод.

“Нэгэн ням гаргийн өглөө . . . бид Бүгд Найрамдах Доминикан Улсын Санто Доминго хотод сэрсэн. Карибын тэнгисийн нар мандан, тэнгэр цэлмэг байлаа. Салхи модны навчсыг хөдөлгөхтэй үгүйтэй салхилж, дулаахан, амар амгалан, тайван байв. Гэвч далайд бидний харж чадахгүй тэртээд үхлийн сүйтгэгч хар шуурга бидэн рүү гарцаагүй ирж байлаа. Хар салхи хянах төвөөс Жорж хар салхины талаар цаг алдалгүй интернетээр мэдээлж байлаа. Тайван, намуухан тэр өглөө би хар салхи хянах төвийн хиймэл дагуулаар Санто Домингогийн яг төв хэсэг рүү айсуу шуурга ирэх замыг таамаглаж билээ.

“48 цагийн дотор шуурга арал руу ирж . . . ширүүнээр замдаа тааралдсан бүхнийг нураан, сүйрэл ба үхлийг үлдээсээр одов. . . .

Энэхүү шуурганаас үүдсэн хохирол, сүйрэл, үхэл маш их байсантай адилаар хүмүүсийн сүнслэг байдалд бүр илүү их хохирол учирдаг. Ийм хар шуурганууд нь бие махбодын хохирлоос илүү их хохирлыг учруулдаг. Учир нь эдгээр нь бидний зүрх сэтгэлийг сүйрүүлж, биднийг мөнхийн хэтийн төлөв ба амлалтаас маань сатааруулдаг. . . .

“Бид уур хилэн, архи дарс, хүчирхийлэл, шунал тачаал, садар самуун, замбараагүй байдал, порнограф, мансууруулах бодис, бардамнал, шунаг сэтгэл, , атаа хорсол, худал хуурмаг гэх мэт нэрлээд байвал барагдахгүй олон зүйлсийн араас хөөцөлдвөл өөрсдийгөө сүнслэг шуурганы замд тавьж өгдөг. . . .

“Гэхдээ биднийг хамгаалан сэрэмжлүүлж, сүнслэг уналт, сүйрэл ба бүр үхлээс сэргийлэхэд тусалдаг сүнслэг байдлын хар шуурганаас хамгаалагчид бидэнд байдаг. Бидний цамхагийн харуулууд бол бошиглогч, төлөөлөгчид юм. Тэд бол бидний тэнгэр дэх сүнслэг байдлын нүд бөгөөд тэд эдгээр шуурга хаашаа чиглэж байгааг илчлэлт, алсын хараа, билиг ухаанаараа мэддэг. Бидэнд Их Эзэний зарлигуудыг зориудаар зөрчихийн аюултай үр дагавруудыг сануулахаар тэд өөрсдийн дуу хоолойг өргөсөөр байна. Тэдний сэрэмжлүүлгийг зориудаар үл тоомсорлох нь гай зовлон болон устгалыг авчирдаг. Тэднийг дагах нь Их Эзэний сонгогдсон үйлчлэгчдийг энх тайван, сүнслэг адислалуудаар элбэг дэлбэг

нутаг руу дагахаар сонгохтой ижил юм (“Spiritual Hurricanes,” *Ensign*, 1999 оны 11-р сар, 31–32).

Бошиглогч, төлөөлөгчдийн бидэнд сэрэмжлүүлсэн аюулуудын талаар хэсэг зуур тунгаан бод. Тэдний үгс биднийг “сүнслэг хар шуурганаас” хэрхэн хамгаалж чадах вэ?

Бурхан Лихай-Нифайн хүмүүс наманчлахгүй бол тэдэн дээр ирэх устгалын талаар сэрэмжлүүлэхээр Абинадайг илгээсэн.



1. Дараах хүснэгтийг судрын тэмдэглэлдээ зурахдаа эшлэл бүрийн доор бичих хангалттай зай үлдээ.

Ноа хааны хүмүүсийн тухай бошиглол (Мозая 12:1–2)	Бошиглолын биелэлт (Мозая 19:10, 14–15; 20:20–21; 21:3–4, 8, 10–13)
Ноа хааны тухай бошиглол (Мозая 12:3)	Бошиглолын биелэлт (Мозая 19:18–20)
А	Б.

Хүснэгтийн зүүн багана дахь судрын эшлэлүүдийг уншиж, Лихай-Нифайн нутаг дахь нифайчуудад Абинадайн бошиглогчдыг эргэн сана. Тохирох судрын эшлэлийн доор Абинадайн хэлсэнчлэн Ноа хаан болон түүний хүмүүс наманчлахгүй бол тэдэнд учрах үр дагавруудыг бич. Зүүн талын баганын доор (А) хэрэв та Абинадайн үгсийг сонссон бол юу хийх байснаа болон юу мэдрэх байснаа бич.

Баруун гар талын хүснэгтийн даалгаврыг хийж эхлэхээсээ өмнө удирдамжийн доод хэсэгт байрлах үйл ажиллагааг гүйцээж хий. Энэ үйл ажиллагаа нь Мозая 19–20 дахь үйл явдлуудтай илүү танил болж, эдгээр бүлгүүдэд бичигдсэн Абинадайн бошиглолуудын биелэлтийг ойлгоход тань тус болно.

Мозая 19–20-ийг судлахдаа, дараах 11 үйл явдлыг сударт гардаг дарааллаар нь дугаарла. Бүлэг бүрийн эхэнд гардаг бүлгийн тойм нь танд туслах хэрэгтэй мэдээллийг өгнө.

- ___ Гидеон Ноа хааныг хөнөөхийг эрэлхийлдэг
- ___ Нифайчуудын эмэгтэйчүүд ба хүүхдүүд леменчүүдээс өөрсдийг нь битгий алаач хэмээн гуйдаг.
- ___ Ноа хаан галд шатан үхэв.
- ___ Леменчүүдийн арми Шимлоны хил дээр ирэв.
- ___ Ноа хааны пристүүд леменчүүдийн 24 охиныг хулгайлав.
- ___ Леменчүүдийн хаан, Лимхайн хүмүүсийн амийг гэтэлгэхийг өөрийн цэргүүдээс гуйв.

- ___ Ноагийн зарим хүмүүс леменчүүдийн өмнө эмэгтэйчүүд, хүүхдүүдээ орхин зугтав.
- ___ Лимхай өөрийн хүмүүст леменчүүдийн хааныг алахгүй байх тушаал өгөв.
- ___ Нифайчууд болон леменчүүдийн хооронд хоёр жилийн турш энх амгалан оршив.
- ___ Лимхай ард түмэн нь леменчүүдэд өөрсдийн эд баялгийн талыг нь өгнө хэмээн амлав.
- ___ Нифайчууд леменчүүдийн эсрэг тэмцэн мөн леменчүүдийн хааныг барьж авав.

(Эдгээр үйл ажиллагааны хариултууд нь хичээлийн төгсгөлд байгаа.)



2. 11 тодорхойлолтыг дугаарласныхаа дараа судрын тэмдэглэл дэх хүснэгтэд анхаарлаа хандуул. Абинадайн бошиглол хэрхэн биелсэн тухай нарийвчилсан мэдээлэл олохын тулд баруун талын багана дахь судруудыг судал. Хүснэгтнийхээ баруун талын багананд тэдгээр мэдээллийг бич. Баруун талын баганын доор (Б) бошиглогчийн сэрэмжлүүлгийн үгсийг эсэргүүцэхэд ямар үр дагавар ирдэг тухай сурсан зүйлсээ тайлбарлан бич.

Мозая 20:21-ийг уншаад, **Их Эзэний үйлчлэгчдийн үгсийг эсэргүүцэх нь гай зовлон, харууслыг авчирдаг** гэсэн Гидеоны ойлголтыг харуулах түүний хэлсэн үгсийг тэмдэглэ.

Эцсийн өдрүүдэд Их Эзэний эсвэл Түүний үйлчлэгчдийн үгсийг сонсохгүй хүмүүст энэ зарчим нь хэрхэн хэрэгжихийг харахын тулд Сургаал ба Гэрээ 133:63, 70–72-ыг унш. Энэ эшлэлийг Мозая 20:21-ийн холбогдох эшлэл болгон судартаа бичиж болно. Хамгийн сүүлчийн Ерөнхий чуулган дээр хэлсэн үгсийг *Ensign* эсвэл *Лиакхона* сэтгүүлүүдийн (5 ба 11-р саруудын) дугаараас эсвэл LDS.org-оос энэхүү зарчмын талаар бошиглогчдын хэлсэн үгсийг хайж ол.

Энэ асуултыг тунгаан бод: Сүүлийн үед бошиглогчид хувь хүмүүс, гэр бүлүүд, улс үндэстнийг зовлон харууслаас хол байхад туслах юуг заасан бэ?

Их Эзэний бошиглогчдыг эсэргүүцсэнээс ирэх гай зовлон, харууслын жишээг олж харахын тулд Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Даллин Х.Өүксийн хэлсэн порнографт донтсон хүмүүст ирэх үр дагавруудыг олж хар.




“Порнограф нь хүмүүсийн эсрэг хүйснийхээ хүнтэй харилцах сэтгэлийн, романтик, сүнслэг хэвийн харилцаанаас баяр баяслыг олж авах чадварыг гэмтээдэг. Энэ нь зохисгүй, гаж буруу, хууль бус байдлын эсрэг зогсох ёс суртахууны хаалтыг устгадаг. Ухамсар нь мэдээгээ алдах үед порнографыг үзсэн хүмүүс өөрсдийн

болон бусдын амьдралд тохиолдох нөлөөг харгалзахгүйгээр харсан зүйлсээ үйлддэг.

“Түүнчлэн порнограф нь донтуулдаг. Энэ нь шийдвэр гаргах чадварыг гэмтээж, үзэж буй хүмүүсээ донтуулж, дахин дахин үзэхэд уруу татдаг. (“Pornography,” *Ensign* ба *Лиахона*, May 2005, 89).


Мөрийтэй тоглоом, порнограф, мэргэн ухааны үг, эхнэр нөхрөө хуурах, шивээс, биеийн элдэв хэсгүүдэд ээмэг зүүх, зохисгүй хувцаслалт, 16 наснаас өмнө болзоонд явах зэрэг бошиглогчдын зөвлөгөөг үл тоомсорлохоос ирэх гай зовлон, харууслын зарим жишээг бод.


 **3.** Судрын тэмдэглэлдээ дараах асуултад хариулж бич: Гэр бүлүүдийг хүчирхэгжүүлэх, ариун явдлын хуулийн дагуу амьдрах, мэргэн ухааны үгийг дагах зэрэг сэдвүүдээр өгсөн Их Эзэний үйлчлэгчдийн зөвлөгөөг дагах нь хувь хүмүүс, гэр бүлүүдэд тохиолддог зарим зовлон бэрхшээл, харамслаас зайлсхийхэд хэрхэн тусалж чадах вэ?

Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Робэрт Д.Хэйлс бид бошиглогчдыг дагаснаар амар амгалан байж, Бурханы оршихуйд буцаж очиж чадна хэмээн гэрчилсэн:

“Өнөөгийн бошиглогчид эрт үеийн болон энэ эрин үеийн бусад бошиглогчдын адил чадвартай хэмээн би гэрчилж байна. . . .

“ . . . Бидний сүнслэг аюулгүй байдал амьд бошиглогчдынхоо тодхон дуу хоолойг сонсох эсэхээс хамаардаг. Бид түүний дуу хоолойг сонсон, зөвлөгөөг нь дагах аваас Христийн хүслийн дагуу амьдарч мөн эцсээ хүртэл тэвчин, хэзээ нэгэн өдөр гэр бүлийнхэнтэйгээ Тэнгэрлэг Эцэг ба Аврагч Есүс Христийн оршихуйд эргэн очих болно (“Hear the Prophet’s Voice and Obey,” *Ensign*, 1995 оны 5-р сар, 17).

 **4.** Мозая 19–20-ийг судлахад Их Эзэний бошиглогчдын зөвлөгөөг сонсох таны арга замд хэрхэн нөлөөлөхийг хүсч байгаагаа судрын тэмдэглэлдээ бич. Их Эзэний үйлчлэгчдийн зөвлөгөөг дагаснаар амар амгалан, сүнслэг аюулгүй байдлыг хэрхэн хүлээн авсан туршлагынхаа тухай бодож, үүнийгээ судрын тэмдэглэлдээ бич.

 **5.** Дараах өгүүлбэрийг судрын тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Мозая 19–20-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

Дугаарлах үйл ажиллагааны хариу: 1, 4, 5, 2, 8, 11, 3, 10, 7, 6, 9.

13-Р ХЭСЭГ: 3 ДАХЬ ӨДӨР

Мозая 21–24

Оршил

Лимхайн хүмүүс ёсон бус байдлынхаа үр дагавраар леменчүүдийн боолчлолд оров (Мозая 20:21-ийг үзнэ үү). Боолчлолын улмаас тэд даруусч, Бурханд эргэн хандав. Алмагийн хүмүүс итгэлийнхээ сорилтын улмаас боолчлолд авчрагдав (Мозая 23:21-ийг үзнэ үү). Энэ хоёр бүлэг хүмүүс хоёулаа боолчлолоос гарахын тулд үлэмж итгэлтэйгээр залбирав. Тэд яваандаа чөлөөлөгдөж, Зарахемлад ирсэн ч Их Эзэн тэдэнд өөр өөр замуудаар тусалсан. Лимхайн хүмүүсийн сорилт болон чөлөөлөлтийг судлаад, бид өөрсдийгөө даруусгах үед Их Эзэн Өөрийн арга замаар, Өөрийн цаг хугацаанд бидний залбирлуудад хариулдаг гэдгийг харах болно. Алмагийн хүмүүсийн сорилт болон чөлөөлөлтийг судлаад, өөрийн бэрхшээл зовлон, сорилтуудын дунд хүч чадлын төлөө хэрхэн Их Эзэнд хандахыг та сурна.



Мозая 21–24

Лихай-Нифайн нутаг дахь нифайчууд Абинадайн бошиглол биелэхийг үзэв

Та Ноа хааны засаглалын үед Лихай-Нифайн нутагт амьдарч, Абинадайн заасан зүйлсийг эсэргүүцсэн гэж төсөөл. Одоо та болон таны хүмүүс яг Абинадайн бошиггосноор леменчүүдийн боолчлолд байна. Та юу хийнэ гэж бодож байна?

Одоо өөрт тань тохиолдож байгаа бэрхшээл, сорилтуудын талаар бод. Дараах судруудыг уншаад, чөлөөлөлтийг эрэлхийлэх болон чөлөөлөгдөх талаар заасан зүйлсийг тэмдэглэ Мозая 21:5, 14; 22:1–2; 23:23; ба 24:21. Чөлөөлөгдөх гэдэг нь чөлөөтэй болох, туслуулах, эсвэл ямар нэгэн юмнаас гаргагдах гэсэн утгатай.



Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Ричард Г. Скоттын хэлсэн дараах үгсийг уншихдаа, түүний хэлсэн, бидний амьдралд тохиолддог хоёр төрлийн бэрхшээл, зовлонгийн доогуур зур: “Хэн ч бэрхшээлтэй тулгарахыг хүсдэггүй. Сорилт, урам хугарах, уйтгар гуниг, сэтгэл шаналал нь бидэнд үндсэндээ хоёр эх сурвалжаас ирдэг. Бурханы хуулиудыг зөрчдөг хүмүүст эдгээр бэрхшээлүүд үргэлж тохиолдох болно. Бэрхшээлийн өөр нэг зорилго нь бид сорилтоос хатуужиж, Их Эзэний зорилгуудыг амьдралдаа гүйцэлдүүлэхэд оршино. Бидэнд тохиолддог сорилт бэрхшээлүүд энэ хоёр эх сурвалжаас ирдгийг мэдэх нь бид бүгдэд амин чухал юм. Учир нь залруулах үйлдэл нь маш их ялгаатай байдаг” (“Trust in the Lord,” *Ensign*, 1995 оны 11-р сар, 16).

Лимхайн хүмүүс өөрсдийн дуулгаваргүй байдлаас болж боолчлолд орсон бол Алмагийн зөв шударга хүмүүс тэднийг хатуужуулах сорилтод орсон. Лимхайн хүмүүс боолчлолын үр дүнд даруусч, Бурханд ирдэг. Энэхүү тэнгэрлэг чөлөөлөлтүүдийн талаар суралцах нь өөрт тохиолдох ямар ч бэрхшээлээс чөлөөлөгдөхийн тулд Их Эзэнээс тусламж хүсэх таны итгэлийг нэмэгдүүлнэ.



1. Доорх хүснэгтийн эхний асуулт болох Тэд боолчлолд хэрхэн орсон бэ? гэсэн асуулт хариулагдав. Хоёр дахь асуултад судрын тэмдэглэлдээ хариулж бич: Тэд хэрхэн чөлөөлөгдсөн бэ?

	Лимхайн хүмүүс	Алмагийн хүмүүс
Тэд боолчлолд хэрхэн орсон бэ?	(Мозая 20:21–22; 21:1–4) Хүмүүс наманчлаагүй учир Их Эзэн тэднийг боолчлолд оруулах хүчийг леменчүүдэд өгсөн.	(Мозая 23:1–4, 19–20, 25–38; 24:8–9) Хүмүүс гэрээгээ сахиж байсан ч ёс бус хүмүүст хууртаж, баривчлагдаж, хавчигдаж байсан.
Тэд хэрхэн чөлөөлөгдсөн бэ?	(Мозая 22:1–9, 13–14)	(Мозая 24:17–25)

Лимхайн хүмүүсийн тухай дараах асуултуудыг тунгаан бодож хариул:

- Мозая 21:6-д хэлсэнчлэн Лимхайн хүмүүс хараахан өөрсдийгөө даруусгаж, Их Эзэнд хандаагүй гэсэн ямар үндэслэл байна вэ? Алмагийн хүмүүс боолчлолд байхдаа үзүүлж байсан хариу үйлдлийг үүнтэй хэрхэн харьцуулах вэ? Лимхайн хүмүүсийн туршлагааас та өөрийн бэрхшээл сорилтод зохистойгоор хандахад туслах юуг сурч болох вэ?
- Лимхайн хүмүүс зовлонгоосоо тэр даруй чөлөөлөгдөөгүй ч Их Эзэн тэднийг хэрхэн адисалсан бэ? (Мозая 21:16-д гардаг “бага багаар дэгжих” гэдэг хэллэгийг тэмдэглэх хэрэгтэй.) Сорилт бэрхшээлээс гарахад тань Их Эзэн танд бага багаар тусалж байсныг та мэдэрч байсан уу?
- Мозая 21:30–33-г дүрслэгдсэн хүмүүсийн хандлага яваандаа тэднийг чөлөөлөгдөхөд нь хэрхэн нөлөөлсөн гэж та бодож байна вэ?



2. Лимхайн хүмүүсийн сорилт бэрхшээл болон чөлөөлөлтийн тухай таны сурсан дараах үнэнүүдээс анхаарлыг тань татсан нэг үнэнийг сонго. Тухайн үнэнийг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлж болохыг судрын тэмдэглэлдээ тайлбарлан бич.

а. Бид өөрсдийгөө даруусгаж, Их Эзэнийг дуудан мөн нүглээ наманчлах аваас Тэр бидний залбирлыг сонсож, Өөрийн тогтоосон цагт бидний нүглийн ачааг хөнгөлөх болно.

б. Бид Бурханд үйлчилнэ гэж гэрээ байгуулан, Түүний зарлигуудыг дагах үед Их Эзэн биднийг чөлөөлөх арга замаар хангана.

Ахлагч Ричард Г. Скоттын хэлсэн дараах үгсийг уншихдаа Алмагийн хүмүүсийн зовлон зүдгүүр, чөлөөлөлтийн тухай бод: “Бүх зүйл болж бүтэж байгаа мэт санагдах үед сорилтууд ихэвчлэн нэгэн зэрэг бөөнөөрөө ирдэг. Тэрхүү сорилтууд таны дуулгаваргүй байдлын үр дагавар биш л бол Их Эзэн таныг улам өсч хөгжихөд бэлтгэж байгаагийн нотолгоо мөн. (Сургаалт Үгс 3:11–12-ыг үзнэ үү). Тиймээс Тэрбээр танд үүрдийн ашиг тусыг авчрах өсөлт хөгжилт, ойлголт ба өрөвч сэтгэлийг дэмжих туршлага өгч байгаа юм. Таны байгаа түвшнээс Бурханы хүссэн түвшинд хүртэл өсч хөгжих нь маш ихийг буюу ихэвчлэн тавгүй байдал болон өвдөлтийг шаарддаг” (“Trust in the Lord,” 16–17).

Мозая 23:21–22 дахь **Их Эзэн Өөрт нь найдах бидний найдварыг өсгөхийн тулд бидний тэвчээр, итгэлийг сорьдог** гэдгийг харуулсан үг хэллэгийг олж тэмдэглэ (түүнчлэн С ба Г 122:5–7-г үзнэ үү).

Удирдамж дээрээ дараах асуултуудад товч хариулан бич:

- Мозая 23–24-т цэдэглэгдсэн үйл явдлуудын үед та Алмагийн хүмүүсийн дунд байсан бол тэвчихэд хамгийн хэцүү сорилт нь юу байх байсан гэж та бодож байна вэ? Яагаад? _____
- Алма болон түүний хүмүүс өөрсдийн зовлон зүдгүүрт хэрхэн хандсан байдлаас та юу сурч болох вэ? (Мозая 24:1–12, 15–16-г үзнэ үү.) _____
- Их Эзэн Алмагийн хүмүүсийг тэр даруй чөлөөлөөгүй ч гэсэн анхнаасаа тэдний төлөө юу хийсэн бэ? (Мозая 24:15-ыг үзнэ үү.) _____

Алмагийн хүмүүсийн туршлагаас бидний сурах нэг зарчим бол **Их Эзэний хүсэлд тэвчээртэйгээр захирагдахад Тэр биднийг хүчирхэгжүүлж, Өөрийн цаг хугацаанд биднийг зовлонгоос чөлөөлдөг** хэмээх зарчим юм.



3. Зовлон бэрхшээлтэй үедээ Их Эзэний хүсэлд тэвчээртэйгээр захирагдахыг тайлбарлаж, энэ нь хэцүү цаг үед тань туслахаар Түүний бэлдсэн адислалууд болон хүчийг хүлээн авахад хэрхэн тусалж болох тухай өөрийн бодлыг судрын тэмдэглэлдээ тайлбарлан бич.

Энэ хичээлийн эхэнд танд тохиолдож байгаа зовлон бэрхшээлийн талаар бодохыг танаас хүссэн. Тэдгээрийг эргэн санахдаа судрын тэмдэглэлдээ юмуу тусдаа цаасан дээр дараах асуултуудад хариулж бич.

- Би сүүлийн үед амьдралдаа ямар сорилт бэрхшээлтэй тулгарч байгаа вэ?
- Амьдралдаа Их Эзэний хүч, чөлөөлөлтийг хүлээн авахад бэлдэхийн тулд би юу хийх хэрэгтэй вэ?



4. Дараах өгүүлбэрийг судрын тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Мозая 21–24-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

13-Р ХЭСЭГ: 4 ДЭХ ӨДӨР

Мозая 25

Оршил

Мозая 25-р бүлэгт цэдэглэснээр, Лимхайн хүмүүс болон Алмаг дагагчид Мозая хааны засаглал дор аюулгүйгээр нэгдэхээр Зарахемлагийн зүг аялдаг. Эдгээр бүлэг нифайчууд цуглаад Бурханы сайн сайхан болон Түүний чөлөөлөх хүчийг таньж мэдэв. Мөн тэд нэгдмэл сүмийг байгуулав. Та энэ хичээлийг судлахдаа, амьдралдаа Бурханы сайн сайхныг хэрхэн харж байгаа болон Есүс Христийн үнэн сүмд харьяалагдсанаас ирэх адислалуудынхаа тухай бодсоноор давуу талыг нь харах болно.

Мозая 25:1–13


Зарахемлад цугларсан хүмүүс нэгдэж мөн нифайчууд хэмээн дуудагдах болов.

Залуу эмэгтэйчүүдийн бүлгийнхэнтэйгээ ууланд явж байхдаа Сүнснийг сонссоноор хамгаалагдсан нэгэн залуу эмэгтэйн тухай дараах түүхийг унш.

“Буцаж явахдаа би таван охин, нэг удирдагчтайгаа хамт удаан явж байсан бүлэгт алхаж байсан. Тэд зураг аваад завгүй байсан болохоор би түрүүлээд явахаар шийдсэн. Би уруудан алхаж байхдаа үхэр мөөрөхийг [яг үхэж байгаа мэт] сонссон. Анхааруулсан дуу хоолой намайг “Буц” хэмээн намуухан боловч баттайгаар хэлсэн. Би үүнийг бараг ойшоогоогүй боловч энэ дуу хоолой дахин ирсэн юм. Энэ удаа би дуу хоолойг дагаж, бүлэг рүүгээ буцсан. Бид доош алхаж байхдаа маш том хоёр хар бух ууртайгаар хурдан нашилж байгааг харлаа. Тэдний том бух нь бидэн рүү хараад туурайгаараа газар сэндийчиг эхлэв. . . . Бид маш их айж, яахаа мэдэхгүй байлаа. Харин манай санваарын удирдагч бухнуудыг саатуулж, бид аюулгүйгээр хашаа даван гарч чадсан.

“Буудалласан газартаа ирэх үедээ би хэрэв Сүнсний анхааруулах үгсийг сонсоогүй бол маш хүнд гэмтэж эсвэл бүр үхэж ч болох байснаа ухаарсан билээ. Тэнгэрлэг Эцэг маань надад анхаарал халамж тавьж, намайг аюулаас сэргийлдэг гэдгийг би мэдсэн. Их Эзэний тэрхүү анхааруулгад би гүнээ талархдаг. Энэ үйл явдал миний гэрчлэлийг өсгөж, Их Эзэнийг илүү их хайрлах хайрыг надад өгсөн” (Marrisa W., “Turn Back,” *New Era*, 2010 оны 11-р сар, 47).

Бусад хүмүүсийн Бурханы хүч, сайн сайхныг амьдралдаа мэдэрсэн туршлагуудыг унших эсвэл сонсох нь таныг хэрхэн хүчирхэгжүүлдэг вэ?



Лимхай болон Алмагийн хүмүүс Зарахемла дахь хүмүүстэй нэгдэхэд Мозая хаан тэдний цэдгүүдийг бүх хүмүүст уншиж өгөв (Мозая 25:1–6-г үзнэ үү). Эдгээр хүмүүст Бурхан хэрхэн хандаж байсныг сонсоод Мозая хааны хүмүүс яасныг мэдэхийн тулд Мозая 25:7-г судал.



1. Мозая 25:8–11-р шүлэг бүр дэх ах дүү нарынхаа тухай сонсоод хариулсан хүмүүсийн хариултыг судрын тэмдэглэлдээ бичиж ав. Жишээ нь, Мозая 25:8-д тэд леменчүүдийн боолчлолоос чөлөөлөгдсөн хүмүүсийг хараад “үлэмж агуу баяр хөөрөөр дүүргэгдсэн” байв.

- а. Мозая 25:8
- б. Мозая 25:9
- в. Мозая 25:10
- г. Мозая 25:11

Дараах зарчмыг судартаа Мозая 25:8–11-ийн хажууд бичиж болно: **Бурхан бусад хүмүүст хэрхэн хандаж байсан тухай цэдгүүдийг судалснаар бид Бурханы сайн сайхны төлөө талархаж, баяр баяслыг мэдэрнэ.**

Бурханы сайн сайхныг мэдэрсэн хүмүүсээс суралцаж болох боломжит эх сурвалжуудын талаар бод. Үүнд судрууд, сүмийн түүх, сүмийн сэтгүүлүүд, ерөнхий чуулган дээр хэлсэн үгс, таны гэр бүлийн түүхийн бүртгэл, гэрчлэлийн цуглаанууд, Ням гаргийн ангийн хичээл, Санваарын болон Залуу Эмэгтэйчүүдийн ангиуд багтаж болно. Эдгээр эх сурвалжуудаас Бурханы сайн сайхны талаар суралцаж байсан үеэ бод. Тэгээд дараах асуултуудын хариултыг тунгаан бод:

- Бурхан хүмүүсийг адисалсныг мэдэж авах нь надад талархал, баяр баясал төрүүлсэн тохиолдол байсан уу?
- Судраас болон бусад эх сурвалжуудаас хүмүүст үзүүлж байсан Бурханы сайн сайхны талаарх

туршлагауудыг би тогтмол судалбал урт хугацааны ямар үр нөлөө надад үзүүлэх бол?

Ирэх долоо хоногийн турш тэдгээр эх сурвалжуудын нэгээс таныг гайхширал, бахдал, баяр баясал, талархлаар дүүргэсэн Бурханы сайн сайхны талаарх түүхийг ол. Юу сурснаа болон энэ нь танд хэрхэн нөлөөлснийг хувийн тэмдэглэлдээ бичиж болно. Та энэ түүхээ гэр бүлийн үдшээр Бурханы сайн сайхны талаар хичээл заахдаа эсвэл семинарын ангидаа юмуу найзтайгаа хуваалцаж болно.

Мозая 25:14–24

Алма нифайчуудын бүх нутагт Бурханы сүмүүдийг байгуулав

Мозая хаан хүмүүст хандан үг хэлж, цэдгүүдийг уншиж өгсний дараа Алма тэдэнд хандан яриулав. Мозая 25:14–16-г уншаад, Алма юу заасныг тодорхойл. Дараах асуултад удирдамждаа хариулж бич:

- Алмагийн заасан зүйлс нь хэрхэн Лимхайн хүмүүс болон Алмаг дагагсдад тохиолдсон зүйлсийг зөвөөр тоймлож байна вэ? _____

- Зенифийн хүмүүсийн түүхийг сонссоны дараа Алмагийн үгсийг сонсох нь хүмүүст яагаад чухал байсан гэж та бодож байна вэ? _____

Мозая 25-ыг үргэлжлүүлэн уншихаасаа өмнө өөрийн явдаг тойрог салбараасаа өөр Хожмын үеийн гэгээнтнүүдийн бусад тойрог, салбарт очиж байсан үеэ бод. Өөрийн тойрог, салбар болон очиж үзсэн тойрог, салбарын хоорондын төстэй байдлуудын талаар бод.

Мозая 25:17–22-ыг уншаад, Алмагийн өдрүүдэд нифайчуудын дунд сүмийг хэрхэн удирдаж байсныг олж мэд. Мозая 25:21 дэх “сүмүүд” гэдэг нь өнөө үед бид сүмийн тойргууд болон салбарууд гэдэгтэй адилхан. Алмагийн үетэй адил **Бурхан өнөөдөр ч сүмээ удирдуулахаар удирдагчдыг дууддаг.**

Мозая 23:16-аас та Алма “тэдний дээд прист”, “тэдний сүмийг үндэслэгч” байсан гэдгийг сурдаг (Мозая 23:16). Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит тайлбарласан нь: “Хоёрдугаар Мозая хаанаар удирдуулсан нифайчуудын гол хэсэг нь Зарахемлагийн нутагт нэгдмэл байдалд амьдарсаар байсан. Алма тэдний сүмийн үндэслэгч байсан хэмээх эшлэл нь зөвхөн нифайчуудын анхны өвийн газраас зугтаж байсан дүрвэгсдэд хамааралтай. Цагийн явцад тэд сүмийн гол хэсэгтэй нийлэхээр буцах замаа олсон бөгөөд Алма нифайчуудын эзэмшлийн бүх газар нутаг дахь сүмийн дээд прист байхаар томилогдсон



(*Answers to Gospel Questions*, comp. Жозеф Фийлдинг Смит Бага, 5 vols, [1957–1966], 3:39–40).



2. Дараах асуултуудын товч хариултыг судрын тэмдэглэлдээ бич:

- а.** Нифайчуудын сүм ямар замаар өнөөгийн сүмийг санагдуулж байна вэ?
- б.** Удирдагчдыг Бурханаас эрх мэдлийг хүлээж авсан Алма дуудах нь яагаад чухал байсан гэж та бодож байна вэ?
- в.** Дэлхий даяар удирдагчид сүмийн бүх гишүүдэд ижил үнэнийг заах нь яагаад чухал вэ?

Мозая 25:23–24-ийг уншихдаа Христийн сүмд элсэн хүмүүсийг болон Их Эзэний өнөөгийн сүмийн гишүүдийг тодорхойлсон өгүүлбэрүүдийг ол. Эдгээр шүлгүүдээс бид нэг зарчим сурдаг: **Бид өөрсдөө Есүс Христийн нэрийг авч, зохистойгоор амьдрахад Их Эзэн Өөрийн Сүнснийг бидний дээр цутгадаг.**



3. Дараах асуултуудын хариултыг судрын тэмдэглэлдээ бич.

- а.** Мозая 25:23–24 дэх Нифай үндэстэн сүмийн гишүүдийг тодорхойлсон өгүүлбэрүүд өнөөгийн сүмийн гишүүдэд хэрхэн хамаарч байна вэ?
- б.** Есүс Христийн нэрийг өөр дээрээ авсан гэдгээ санах нь таны бодлууд болон өдөр тутам хийдэг сонголтуудад тань хэрхэн нөлөөлж чадах вэ?

Мозая 25:24-т “Их Эзэн Өөрийн хүмүүсийн дээр Сүнсээ юүлсэн” гэдгийг анхаар. Арванхоёр

төлөөлөгчийн чуулгын ахлагч Жозеф Б.Вертлин сүмийн гишүүдэд өгөгддөг Ариун Сүнсний бэлгийн үнэ цэнийг онцлон ярьжээ:



“Ариун Сүнсний байнгын нөхөрлөлийг хүлээж авах эрх буюу Ариун Сүнсний бэлгийг зөвхөн Христэд итгэх итгэл, наманчлал, усанд умбуулах баптисм болон Мелкизедек санваар атгах эрх мэдэл бүхий үйлчлэгчдээс толгой дээрх гар тавилтаар авдаг. Энэ нь зөвхөн Их Эзэний сүмийн зохистой гишүүдэд боломжтой байдаг хамгийн нандин бэлэг юм.

“... Энэ нь гэрчлэл болон сүнслэг бэлгүүдийн эх сурвалж билээ. Оюун ухааныг гэрэлтүүлж, бидний бодгалийг баяр баяслаар дүүргэж, бүх зүйлийг зааж, мартагдсан мэдлэгийг бидний санаанд эргүүлэн авчирдаг. Түүнчлэн Ариун Сүнс нь [бидний] хийвэл зохих тэр бүх зүйлийг [бидэнд] үзүүлэх болно [2 Нифай 32:5] (“The Unspeakable Gift,” *Ensign* ба *Луахона*, 2003 оны 5-р сар, 26).



4. Судрын тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

- а.** Есүс Христийн сүм дэх оролцоо тань Сүнснийг мэдрэхэд ямар арга замаар танд тусалдаг вэ?
- б.** Та итгэлтэй байдал болон зөв шударга үйлүүдээ нэмэгдүүлж, Сүнсэнд илүү ойр байгаагаа мэдэрч болохын тулд юуг хийж чадах вэ?

Ариун Сүнсний бэлэг таны амьдралыг хэрхэн адисалсныг хэн нэгэнтэй хуваалцах боломжийг эрж хай. Ариун Сүнсээр дамжуулан хүлээн авсан адисла-лууд тань Түүний нөхөрлөлд зохистой байхыг хичээх үед өсөх боломжтой.



5. Дараах өгүүлбэрийг судрын тэмдэглэлдээ өнөөд-рийн даалгаврынхаа доор бич:

Би Мозая 25-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуус-галаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

14-Р ХЭСЭГ: 1 ДЭХ ӨДӨР

Мозая 26

Оршил

Мозая 26-д цэдэглэснээр, үл итгэгч өсвөр үеийн зарим нифайчууд сүмийн гишүүдийг бялдууч үгсээр нүгэл үйлдэхэд уруу татаж байв. Алма Бурханы хүслийн дагуу эдгээр гишүүдийг хэрхэн шүүх арга замыг олохоор залбирав. Их Эзэн сүмийн гишүү-дэд өөрсдийнх нь нүгэлд хэрхэн хариуцлага хү-лээлгэхийг Алмад илэрхийлэв. Түүнчлэн Их Эзэн наманчлалын нөхцөл тогтоов. Алма чин сэтгэлээсээ наманчилдаг хүмүүсийг уучлах Бурханы хүслийн талаар сурав.

Мозая 26:1–6

Олон өсвөр үеийнхэн Бурханд итгэдэггүй бөгөөд нүгэл үйлддэг

Дараах асуултын талаар хэсэг зуур тунгаан бод: Зарим залуу хүмүүс бүр бошиглогчдыг сонсож, эцэг эхээрээ заалгаж байсан ч яагаад гэрчлэлгүй эсвэл хүчирхэг гэрчлэлгүй байдаг гэж та бодож байна вэ?

Мозая 26-р бүлэг энэ асуултад хариулдаг. Шүл-гүүдийг судалж хүснэгтэн дэх асуултуудад хариул (хариултыг удирдамждаа бич):

Мозая 26:1–2	Олон өсвөр үеийнхэн ямар гурван зүйлд итгэхгүй байсан бэ? _____
(Мозая 26:3)	Итгэлгүй байдалтайгаар судруудаас суралцах, бошиглогчдын үгсийг сонсох нь бидэнд хэрхэн нөлөөлдөг вэ? _____

Мозая 26:4	Эдгээр хүмүүс Аврагчид итгэх итгэлгүй байж, сүмд элсэхгүй байсан гол шалтгаануудын нэг нь юу вэ? _____
Эдгээр шүлгүүдийг судлаад сурсан нэг зарчмаа бич: _____	

Мозая 26:1-т гардаг “эцэг өвгөдийн уламжлал” гэсэн хэллэг нь өмнөх үеэс уламжлагдан ирсэн сайн мэдээний үнэн юм. Энэ хэллэг нь заримдаа худал санаануудыг төлөөлдөг (жишээ нь, Алма 9:16-г үзнэ үү). Мозая 26:1–4-т заагддаг нэг зарчим бол: **Итгэх хүсэл болон хувийн хичээл зүтгэл нь гэрчлэлээ өсгөхөд шаардлагатай** гэсэн зарчим юм.

Тэргүүн Зөвлөлийн гишүүн, ерөнхийлөгч Хэни Б.Айрингийн хэлсэн дараах үгсийг уншаад, гэрчлэл олж авч, өсгөхөд шаардлагатай үйлдлүүдийн доо-гуур зур:



“Гэрчлэлийг итгэлийн залбирал, судрууд дахь Бурханы үгсээр цангах болон хүлээн авсан үнэндээ дуулгавар-тай байх зэргээр тэжээх шаардлагатай. Залбирлыг үл тоомсорлох нь аюултай. Судруудыг хайнга байдлаар судлах, унших нь бидний гэрчлэлд аюул учруулдаг. Тэдгээр нь бидний гэрчлэлд зориулсан зайлшгүй шаардла-гатай шим тэжээлүүд байдаг. . . .

“Гэрчлэлээ өсгөж, хөгжүүлэхийн тулд үргэлж Бур-ханы үгэн дээр найрлаж, зүрх сэтгэлээсээ залбирч мөн Их Эзэний зарлигуудад дуулгавартай байх ёстой” (“A Living Testimony,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2011 оны 5-р сар, 127).

Алмагийн үед өсвөр үеийнхэн Ерөнхийлөгч Ай-рингийн дурдсан эдгээр зүйлсийг хийхгүй байсан гэдгийг анхаар.



1. Судрын тэмдэглэлдээ дараах асуултуудад ха-риулж бич:

а. Таны туршлагаар залбирах, судраас унших, зарлигуудад дуулгавартай байхыг хичээх үедээ итгэх хандлагатай байх нь яагаад чухал вэ?

б. Итгэлтэй залбирал, судрын уншлага, эсвэл зарлигуудад дуулгавартай байх нь таны гэрчлэлийг хүчирхэгжүүлсэн туршлагаа тайлбарла.

Сайн мэдээний гэрчлэлгүй хүмүүс сүмийн гишүүдэд нөлөөлж байгааг харж байсан эсэхээ эргэцүүлэн бод. Мозая 26:5–6-г уншаад, үл итгэгчид сүмийн гишүүдэд хэрхэн нөлөөлж байсныг ол.

Үргэлжлүүлэн суралцахдаа Мозая 26:6-д гардаг энэ мэдэгдлийн утгыг мэдэх нь тустай байж болох юм:

“Сүмд байж нүгэл үйлдсэн хүмүүсийг сүм зэмлэх [анхааруулах, залруулах] ёстой.” Энэ нь сүмийн дуулгаваргүй гишүүд үйлдсэн нүглүүдийнхээ дагуу шүүгдэж, наманчлах боломжийг авах ёстой гэсэн үг юм.


Мозая 26:7–39

Алма нүгэл үйлдсэн хүмүүсийг хэрхэн шүүхээ асуув




Мозая 26-ийн үлдсэн хэсгийг судлахад бэлдэхдээ, өөрийгөө нэгэн тойргийн бишоп бөгөөд танай тойргийн зарим гишүүд ноцтой нүгэл үйлдсэн гэж төсөөл. Бишопын хувьд эдгээр гишүүдэд хариуцлага хүлээлгэж, наманчлахад нь туслах үүргийг Их Эзэн танд даалгасан. Эдгээр гишүүдэд хэрхэн хандаж, хамгийн сайнаараа хэрхэн тусалж чадах тухайгаа бод.

Яг ийм нөхцөл байдал Алмад хэцүү байв. Өнөөдрийн эрх мэдэл бүхий санваарын удирдагчдын адил тэрээр ноцтой нүгэл үйлдсэн сүмийн гишүүдэд наманчилж, өршөөлийг хүлээн авч, сүмд идэвхтэй, нэр хүндтэй гишүүд болон эргэж ирэхэд нь туслах хариуцлагатай байсан. Мозая 26:7–14-ийг уншаад, Алма энэ нөхцөл байдалд хэрхэн хандаж, Их Эзэнээс хариулт хүлээн авахын тулд юу хийснийг ол.


 **2.** Санваарын удирдагчид нүгэл үйлдсэн хүмүүст туслахдаа Их Эзэний удирдамжийг эрэлхийлж, хүлээн авдаг гэдгийг мэдэх нь бидэнд яагаад чухал болохыг судрын тэмдэглэлдээ бич.

Алма хөрвөгдөхөөсөө өмнө ёс бус Ноа хааны прист байсан гэдгийг сана. Мозая 26:15–18-ыг уншаад, Алма болон түүний хүмүүс Их Эзэнд ирэхийн тулд юу хийснийг болон Их Эзэн тэдэнд ямар адислал өгсөн болохыг тодорхойл.

 **3.** Мозая 26:29–30-ийг унш. Тэгээд дараах даалгавруудын нэг юмуу хоёуланд нь хариул:

- а.** Дараах зарчмыг яагаад хүн бүр, ноцтой нүгэл үйлдсэн хүн ч гэсэн ойлгох нь чухал гэж бодож байгаагаа тайлбарла: **Зүрх сэтгэлээсээ наманчилсан хүнийг Их Эзэн уучилна.**
- б.** Дараах зарчмын талаарх гэрчлэлээ бичээрэй: **Зүрх сэтгэлээсээ наманчилсан хүнийг Их Эзэн уучилна.**

Алма ноцтой нүгэл үйлдсэн сүмийн гишүүдэд хэрхэн туслах тухай удирдамж авахаар залбирсны дараа Их Эзэн түүнд заавар өгсөн. Тэрээр гишүүдэд наманчлах боломж өгөх ёстой бөгөөд, хэрэв тэд наманчлагүй бол Их Эзэний хүмүүсийн дунд тоологдохгүй. Эдгээр заавар нь наманчлах зарчмын талаар чухал ойлголт өгдөг. Мозая 26:21–31-ийг уншихдаа наманчлалын талаарх ойлголтыг ол.


 **4.** Эдгээр шүлгүүдэд юу уншсанаа дүгнэхийн тулд дараах даалгавруудын хоёр юмуу түүнээс олонд судрын тэмдэглэлдээ хариулж бич:

- а.** Та Мозая 26:23-т ярьсан Аврагчийн үгсийг хэрхэн товчлох вэ? Аврагч Өөрөө бидний нүглийн төлөөсийг төлсөн гэдгийг ойлгох нь яагаад чухал байдаг вэ?
- б.** Мозая 26:21–31-ийн аль хэллэг нь санваарын удирдагчийн хувьд Алмад итгэх Аврагчийн итгэл, найдварыг илэрхийлдэг вэ? Ноцтой гэм нүгэл, хүнд уруу таталтанд орсон хүнд санваарын удирдагчийн тусламж хэрхэн тус болох вэ?
- в.** “Чин зүрхнийхээ угаас” наманчлах гэдэг нь юу гэсэн үг вэ? (Мозая 26:29).
- г.** Бид Их Эзэний өршөөлийг хүлээн авахын тулд яагаад бусдыг уучлах хэрэгтэй вэ? (Мозая 26:31-ийг үзнэ үү.)

Мозая 26:21–31-р шүлгүүдээс олж авсан зарчмаа өөрийн үгээр бич. _____

Та өөр зарчмыг тодорхойлсон эсвэл өөр үгээр илэрхийлсэн байж болох ч доорх зарчмууд бол Мозая 26:21–31-т заагдсан зарчмууд юм:

- **Наманчилж, өршөөгдөхөд бишопууд болон салбарын ерөнхийлөгчид Их Эзэнийг төлөөлж бидэнд тусалдаг.**
- **Нүгэл хийснээ хүлээх нь өршөөл рүү хөтөлдөг.** (Бүх нүглээ Бурханы өмнө хүлээх ёстой бөгөөд ноцтой гэм нүглийг наманчлалын явцад тусалж чадах санваарын удирдагчийн өмнө хүлээх ёстой.)
- **Бид Их Эзэний өршөөлийг хүлээн авахын тулд бусдыг уучлах ёстой.**


 **5.** Эдгээр зарчмуудыг дүгнэхэд тань туслах дараах жишээнүүдийг унш. Нэг жишээг сонгож аваад өнөөдрийн судалсан судар, зарчмуудаа тэрхүү тайлбарласан тохиолдолд байгаа хүнд хэрхэн тусалж болохыг судрын тэмдэглэлдээ бич.

а. Нэгэн залуу эмэгтэй ноцтой гэм нүгэл үйлдсэн ч энэ тухай бишоптойгоо ярихаас эмээж байна.


б. Нэгэн залуу эрэгтэй наманчлах хүсэлтэй боловч хэрхэн наманчлахаа мэдэхгүй байна.

в. Залуу эмэгтэй урьд нь үйлдсэн нүглээ давтан үйлдсэн бөгөөд энэ удаа түүнийг Их Эзэн уучлахгүй болов уу хэмээн санаа зовж байна.

г. Залуу эрэгтэй нүглээ наманчлахаар шийдсэн боловч өөрийг нь гомдоосон нэгнийг уучлахыг хүсэхгүй байна.

 **6.** Энэ хичээлд заасан нэг зарчмыг сонгон авч түүнийгээ өөрийн наманчлалд хэрхэн хэрэгжүүлж болохоо тунгаан бод. Энэ зарчмаа хэрхэн ашиглахаа судрын тэмдэглэлдээ бич.

Мозая 26:37–39-ийг уншиж Алма их Эзэний зөвлөгөөг хэрэгжүүлэхэд юу тохиолдсоныг олж мэдээрэй. Алма болон түүний хүмүүсийн туршлагаас бид наманчилж шударгаар амьдарвал мөн амар амгалан болон амжилттайгаар амьдрах боломжтой гэдгийг сурч болно.

 **7.** Дараах өгүүлбэрийг судрын тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Мозая 26-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:



Тэнгэр элч Залуу Алма болон Мозаягийн хөвгүүдийг наманчлахыг уриалав

Өөрийн таньдаг сайн мэдээний тухай гэрчлэлгүй эсвэл сүмээс урвасан хүмүүсийн тухай бод. Тэдний нэг нь түүнд туслах таны чармайлтыг эсэргүүцсэн бол та юу хийх вэ? Өнөөдөр суралцахдаа энэ асуултын талаар бодож үзээрэй.

Мозая 27:8–10-р шүлгүүдийг уншиж эдгээр шүлгүүд нь Алма болон Мозаягийн хөвгүүдийг хэрхэн дүрсэлснийг анхаар. Алма болон Мозаягийн хөвгүүд Сүм болон гишүүдэд юу хийх гэж оролдож байсан бэ?

Алма болон Мозаягийн хөвгүүдийн тухай дүрсэлсний ямар хэсэг нь танд хамгийн сонирхолтой санагдаж байна вэ? Яагаад? _____

Бид зарим үед хүмүүсийг хэзээ ч өөрчлөгдөхгүй бөгөөд Их Эзэнд ирэхгүй гэж итгэхэд уруу татагддаг. Мозая 27-г судлахдаа энэ хандлагын талаар бод.

14-Р ХЭСЭГ: 2 ДАХЬ ӨДӨР

Мозая 27

Оршил

Мозая 27-р бүлэгт Алма (Алмагийн хүү) болон Мозаягийн хөвгүүдийн хөрвөлтийн түүх оршдог. Энэ нь Бурханы Сүмийг устгахаар тэд оролдсон талаар, тэнгэр элчтэй уулзсан уулзалт, Алмагийн гайхамшигт өөрчлөлт болон эдгээр залуусын буруугаа засахыг хичээсэн талаар нь өгүүлдэг. Алмагийн хөрвөлтийн түүх нь хүн бүр дахин төрөөд, шударгаар амьдрах хэрэгтэйг илэрхийлдэг. Энэ бүлэг нь мөн Есүс Христийн сайн мэдээний дагуу амьдрахгүй байхаар шийдсэн хүмүүсийн төлөө залбирахаас ирдэг адислалуудыг харуулдаг.



Мозая 27:11–14-ийг уншаад, Алма болон Мозаягийн хөвгүүд дээр тэнгэр элчийн ирсэн шалтгааны доогуур зур.

Мозая 27:14 энэ зарчмыг заадаг: **Их Эзэн бидний бусдын төлөөх итгэлт залбирлуудад хариулдаг.** Энэ зарчмыг судар дээрээ Мозая 27:14-ийн хажууд бичих хэрэгтэй. Наманчлах хэрэгтэй хүн бүрд болон бидний залбирдаг хүн бүрд тэнгэр элч ирнэ гэсэн үг биш юм. Их Эзэн Өөрийн мэргэн ухааны дагуу бидний итгэлтэй залбирлуудад хариулдаг.



1. Дараах асуултуудын нэг юмуу хоёуланд нь судрын тэмдэглэлдээ хариул:

а. Хэзээ таны залбирал хэн нэгний амьдралыг өөрчилсөн юм шиг санагдсан бэ?

б. Бидний бусдын төлөө өргөсөн итгэлтэй залбирлуудад Их Эзэн хариулдаг гэдгийг мэдсэнээр таны залбирах хандлагад хэрхэн нөлөөлж болох вэ?

Алма болон Мозаягийн түүхийг өөрийн амьдралтай хэрхэн адилтгаж болох тухайгаа тунгаан бод. Та Их Эзэний заасны дагуу амьдардаггүй өөрийн мэддэг болон хайртай хүмүүсийнхээ төлөө үргэлжлүүлэн залбирч болно. Их Эзэн таны залбирлуудыг сонсож Өөрийн аргаар, Өөрийн цагаар хариулдаг ч харин хүн бүрд сонгох эрх чөлөөг олгодог гэдгийг санах

хэрэгтэй. Дараах асуултуудын талаар бас сайтар бод: Хэн таны сайн сайхны төлөө залбирч байж болох вэ? Их Эзэн таныг хэрхэн өөрчлөгдөөсэй гэж хүсдэг юм бол? Тэрхүү өөрчлөлтийг хийхийн тулд та юу хийх ёстой вэ?

Мозая 27:15–16-д бичигдсэн тэнгэр элчийн Алмад хэлсэн бусад үгсийг нь унш. Тэнгэр элч “газрыг доргиход хүргэсэн аянгын дуу лугаа адил дуу хоолойгоор” ярьсан гэдгийг сана (Мозая 27:11). Хэрвээ та Алма эсвэл Мозаягийн хөвгүүдтэй цуг байсан бол энэ явдал танд хэрхэн нөлөөлөх байсныг бод.

Та тэнгэр элчийн захиасыг хэрхэн товчлон хэлэх вэ?


Тэнгэр элчийн захиасын дараа Алма ярьж чадахаа больсон. Тэр доройтож, эцэгтээ “арчаагүйгээр зөөгдөн” (Мозая 27:19) очжээ. Алмагийн эцэг юу болсныг дуулаад “баясав, учир нь энэ бол Бурханы хүч байсныг тэрээр мэдэж байлаа” (Мозая 27:20). “Тэрээр хүүд нь, Их Эзэн юу хийснийг хүмүүст” харуулахын тулд тэднийг цуглуулав (Мозая 27:21). Алмагийн эцэг хүүгээ хүч орж, ярих чадвартай болоосой хэмээн пристүүдийг түүний төлөө мацаг барин залбирахыг гуйсан (Мозая 27:22-ыг үзнэ үү). Их Эзэн тэдний залбирлуудад хариулсан.

Мозая 27:24–31

Бага Алма болон Мозаягийн хөвгүүд наманчилж, дахин төрсөн нь

Мозая 27:23–24, 28–30-ийг уншиж, Бага Алмаг тэнгэр элчийг харсан туршлагынхаа улмаас хэрхэн өөрчлөгдсөнийг нь анхаар. Дараах хүснэгтэд эдгээр шүлгээс Алмагийн зүрх сэтгэлийн өөрчлөлтийн өмнөх болон дараах байдлыг нь тайлбарласан үг хэллэгүүдийг сонгож бич.


Өмнө	Дараа


 **2.** Судрын тэмдэглэлдээ *Дараа* мөрийн дор бичсэн өөрийн тань бүхий л амьдралыг тодорхойлж чадна гэж найдах нэг хэллэгийг сонгож бич. Тэрийг яагаад сонгноо тайлбарла.

Мозая 27:24, 28-ыг судалж, Алмагийн зүрх сэтгэлийн өөрчлөлтийг авчирсан Алмагийн болон Их Эзэний хийсэн үйлийг тэмдэглэ.

Өөр өөр тэмдэглэх аргыг ашиглах нь

Судраа тэмдэглэхдээ сэдэв болон үнэнүүдийг ялгахын тулд өөр өөр тэмдэглэх аргыг ашиглах нь тустай байж болно. Жишээ нь: Мозая 27:24, 28-д Алмагийн хийсэн үйлийн доогуур зурж, Их Эзэний хийснийг дугуйлж болно. Тэгвэл та тэр хоёрыг ганц хараад л ялгааг нь шууд анзаарна. Өөртөө тэмдэглэгээнийхээ утга учрыг нь сануулахын тулд тэдний утгын тайлбарыг судрынхаа аль нэг газарт бичих хэрэгтэй.

 **3.** Амьдралаа өөрчлөхийг хичээхдээ өөрөө юу хийх ёстой болон Их Эзэн бидний төлөө юу хийхийг ойлгох нь яагаад чухал гэдгийг судрын тэмдэглэлдээ бич.


 **4.** Судрын тэмдэглэлдээ дараах асуултуудын нэг юмуу хоёуланд нь хариулж бич:

а. Мозая 27-р бүлэг наманчилж, Их Эзэнд ирж чадахгүй гэж боддог, шантарсан хүмүүст хэрхэн тусалж болох вэ?

б. Мозая 27-р бүлэг хэн нэгнийг хэзээ ч наманчилж, Их Эзэнд ирэхгүй гэж боддог хүмүүст хэрхэн тусалж болох вэ?

Мозая 27:25–26-г уншин Цагаатгалаар хэн өөрчлөгдөх ёстой эсвэл хэн Бурханаар төрөх ёстойг тодорхойл.

Эдгээр шүлгүүд энэ зарчмыг заадаг: **Бидний хүн бүр Есүс Христийн Цагаатгалаар дахин төрөх ёстой.** Бурханаар төрөх гэдэг нь Их Эзэний Сүнс хүний зүрх сэтгэлд агуу өөрчлөлт гаргаж тэр хүн хилэнцийг үйлдэх хүсэлгүй болж, Бурханы зүйлүүдийг эрэлхийлэх хүсэлтэй болдог гэсэн үг. (Мозая 5:2-ыг үз). Алма болон Мозаягийн хөвгүүд маш хурдан зүрх сэтгэлийн өөрчлөлтийг үзсэн бол харин бидний ихэнх нь Цагаатгалаар дамжуулан аажмаар өөрчлөгддөг. Бурханаар төрөх гэдэг нь үйл явдал биш харин үйл явц юм.

 **5.** Судрын тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

а. Та нүглээ наманчилж Аврагчийг дагахыг хичээхдээ Цагаатгалаар хэрхэн өөрчлөгдсөн бэ?

б. Та Их Эзэнд илүү ойртож, Цагаатгалыг таны амьдралд илүү их нөлөөтэй болгохын тулд юу хийж болох вэ?

Мозая 27:32–37

Бага Алма болон Мозаягийн хөвгүүд газар нутгаар аялж, нүглээ хүлээж, Сүмийг хүчирхэгжүүлэв



Мозая 27-р бүлэг дэх таны судлах шүлгүүд нь энэ зарчмыг харуулдаг: **Чин сэтгэлээсээ наманчлахын тулд хүн буруугаа засахаар чадах бүхнээ хийх ёстой.** Буруугаа засах гэдэг нь хийсэн буруу сонголтуудынхаа нөлөөг арилгаж, бидний үйлдлийн улмаас гэмтсэн бүхнийг сэргээх гэсэн үг юм. Жишээ нь, хэрвээ хэн нэгэн хүн хөршөөсөө нэг юм хулгайлсан бол буруугаа засах гэдэг нь хулгайлсан юмыг буцааж өгөхийг хэлнэ. Мозая 27:32–37-г уншаад Алма болон Мозаягийн хөвгүүд гэмээ цайруулахын тулд юу хийснийг нь тодорхойл.

Хүн дараах нүглийн төлөө хэрхэн гэмээ цайруулж болохыг бич:

- Эцэг эхдээ худлаа ярих: _____

- Өөр хүний талаар хов ярих: _____
- Хичээлээ хуулах: _____

Та Цагаатгалаар дамжуулан хэрхэн өөрчлөгдөж болох тухайгаа бодохдоо хэрхэн нүглээ наманчилж, гэмээ цайруулах тухайгаа тунгаан бод.



6. Дараах өгүүлбэрийг судрын тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Мозая 27-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

14-Р ХЭСЭГ: 3 ДАХЬ ӨДӨР

Мозая 28–29

Оршил

Хөрвөлтийнхөө дараа Мозаягийн хөвгүүд леменчүүдэд сайн мэдээг номлох чин хүсэлтэй болсон. Мозая хаан тэдний сонголтыг дэмжсэн ч тэрээр түүний сэнтийг өвлөж, судрын цэдгүүдийг хариуцуулах хүнгүй үлдсэн байв. Тэр Алмад (Алмагийн хүү) судрын цэдгийн хариуцлагыг өгсөн. Өөр хааныг томилохын оронд тэр шинэ удирдлагын хэлбэр болох шүүхийн систем тогтоосон.



Мозая 28:1–9

Мозаягийн хөвгүүд леменчүүдэд номлохыг хүсэв

Доорх өгүүлбэр бүрийн хажууд өөртөө тохирох үнэлгээ өг. 1-ээс 10-ын хоорондын хэмжээсийг

ашигла (1 гэдэг нь “ямар ч хүсэлгүй” ба 10 гэдэг нь “маш их хүсэлтэй” гэсэн үг).

_____ Би бусдад мөнхийн аз жаргалыг олоход нь туслах чин хүсэлтэй.

_____ Би бусдад туслахын тулд золиослол гаргах хүсэлтэй байдаг.

_____ Би сайн мэдээг бусадтай хуваалцахыг хүсдэг.

_____ Хэрвээ та залуу эрэгтэй бол бүрэн цагийн номлолд үйлчлэх хүслээ дүгнэ. (Хэрвээ та залуу эмэгтэй бол мөн адил хүслээ дүгнэж болно.)

Мозая 27:8–10-ыг уншиж дээрх өгүүлбэрүүдийн талаар Алма болон Мозаягийн хөвгүүдийн хөрвөлтийнх нь өмнөх хүслийг дүгнэ.

Одоо Мозая 28:1–3-ыг уншаад дээр тодорхойлсон зүйлсийн талаар Мозаягийн хөвгүүдийг хэрхэн өөрчлөгдсөнийг нь тодорхойл. Уншихдаа *мөхөх* гэдэг үгийг сүнслэг байдлын хувьд алдагдах гэсэн утгатайг санаарай.

Дараах асуултуудад хариулж бич:

Мозаягийн хөвгүүд сайн мэдээг хэнтэй хуваалцахыг хүссэн бэ? _____

Энэ хүртэлх Мормоны Номоос таны сурсан зүйлсээс харахад леменчүүдэд номлохоор яваа Мозаягийн хөвгүүдэд ямар хүндрэл бэрхшээл эсвэл аюул тохиолдож болох байсан вэ? _____

Мозая 28:4-ийг уншаад та энийг өөрийн үгээр хэрхэн давтан хэлэхээ тунгаан бод. Мозаягийн хөвгүүдийн хөрвөлт нь сайн мэдээг хуваалцах хүсэлд нь хэрхэн нөлөөлснийг анхаар. Мозая 28:1–4-т бид энэ зарчмыг сурдаг: **Бидний хөрвөлт гүнзгийрэх тусам бидний сайн мэдээг хуваалцах хүсэл улам нэмэгддэг.**



Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Даллин Х.Өүксийн хэлсэн үгсийг унш (та судар дээрээ Мозая 28:1–4-ийн хажууд бичиж болно): “Бидний сайн мэдээг хуваалцах хүслийн хэр хэмжээ нь бидний хувийн хөрвөлтийн түвшинг харуулдаг сайн шалгуур мөн” (“Sharing the Gospel,” *Ensign*, болон Лиахона, 2001 оны 11-р сар, 7).

Мозая 28:4-ийн эхний өгүүлбэрт Мозаягийн хөвгүүд нь сайн мэдээг хуваалцах хүслээр хэрхэн нөлөөлөгдсөнийг нь тэмдэглэ. Их Эзэний Сүнс бидний сайн мэдээг хуваалцах хүслийг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэйг анхаар.



1. Дараах асуултуудын аль нэгэнд судрын тэмдэглэлдээ хариулж бич:

- а.** Гэрчлэлээ хүчирхэгжүүлэх үед таны сайн мэдээг хуваалцах хүсэл хэрхэн өссөн бэ?
- б.** Таны амьдралд тохиолдсон ямар туршлагауд сайн мэдээг бусадтай хуваалцах хүсэл рүү хөтөлсөн бэ?
- в.** Энэ удаа сайн мэдээг хуваалцах хүсэл тань тийм ч хүчтэй биш байвал хүслээ хүчирхэгжүүлэхийн тулд та юу хийж чаддаг вэ? (Алма 17:2–3-ыг унш.)

Сайн мэдээний зарчмуудыг жишээн дээр хэрэгжүүлэх нь

Амьдралдаа сайн мэдээний зарчмыг түгээмэл тохиолдолд хэрэгжүүлэх үедээ та уг зарчмыг илүү сайн дүгнэж, үүний ач холбогдлыг амьдралдаа илүү амархан танин мэдэж чадна. Жишээнд хэдий чинээ чин сэтгэлээсээ хариулна, энэ нь суралцах явцад төдий чинээ үр дүнгээ өгөх болно.



2. Нэгэн залуу эрэгтэй сүмийн гишүүн боловч номлолд үйлчлэх хүсэл түүнд бараг эсвэл огт байхгүй гэж төсөөл. Сайн мэдээг хуваалцах хүслээ нэмэгдүүлэхийн тулд тэр юу хийж болохыг түүнд зөвлөсөн захиаг судрын тэмдэглэлдээ бич. Есүс Христийн сайн мэдээнд хөрвөгдсөн хөрвөлтийг тань гүнзгийрүүлсэн зүйлсийн талаар дурсаж, түүнд зориулан төстэй үйл ажиллагаа эсвэл тохиолдлуудыг санал болгож болно. Та энэхүү агуу хөрвүүлгээ бичсэнээрээ сайн

мэдээг бусадтай хуваалцах хүслээ нэмэгдүүлэхэд удирдана гэдгийг санаарай.

Мозая 28-р бүлгийг үргэлжлүүлэн судлахдаа таны хайрладаг хэн нэгэн өөрсдөөс нь өөр хүмүүсийг үзэн яддаг, хэрцгий хүмүүсийн дунд амьдрахыг хүсвэл танд ямар санагдахыг төсөөл. Мозая 28:5–8-ыг уншаад, Мозая яагаад ийм аюултай номлолд хөвгүүдээ явуулахыг зөвшөөрснийг ол. Алмагийн номоос та “тэдний үгсэд итгэх олон хүмүүс” (Мозая 28:7) байх буюу Мозаягийн хөвгүүдийн хичээл зүтгэлийн үр дүнд хөрвүүлэгдсэн мянга мянган леменчүүдийн талаар сурах болно.

Мозая 28:10–20

Мозая жаредчуудын ялтсуудыг орчуулж, бүх цэдгүүдийг хадгалуулахаар Алмад өгөв

Мозая 28-р бүлгийн үлдсэн хэсэгт Мозая хаан өгөлж, нас барахаасаа өмнө ариун цэдгүүдийг хариуцах дараагийн хүнийг сонгох хэрэгтэй гэдгээ мэдэрснээ цэдэглэв. Өмнөх хоёр үеийн хаад ялтсуудыг дараагийнхаа хаанд шилжүүлсэн. Харин Мозая хааны хөвгүүд номлолд явсан байсан учир түүний суудлыг өвлөн авах хүү байгаагүй. Тиймээс цэдгүүдийг хариуцах хүн байгаагүй юм. Эдгээр цэдгүүдэд Мозая хааны Бурханы хүчээр орчуулсан

жаредчуудын ялтсууд багтаж байсан (Мозая 28:11–19-ийг үзнэ үү).



Хэрвээ та цэдгүүдийг авч явах хүнийг сонгохоор болбол ямархуу шинж чанартай хүнийг сонгох байсан бэ? _____

Хэрэв ялтсуудыг хариуцуулахаар хэн нэгэн таныг сонговол танд ямар санагдах байсныг дүрсэл. _____

Мозая 28:20-ийг уншаад, ялтсуудыг хариуцуулахаар Мозая хааны сонгосон хүний нэрийг ол.



3. Мозая хааны шийдвэр Алмагийн зүрх сэтгэлийн өөрчлөлтийн талаар танд юу зааж байгааг судрын тэмдэглэлдээ бич. (Энэ асуултад хариулахын тулд Мозая 27-р бүлэгт цэдэглэгдсэн Алмагийн урьдын үйлдлүүдийн талаар дахин унших хэрэгтэй байж болно.) Түүнчлэн Алмад итгэх Мозаягийн итгэл наманчилдаг хүмүүст хэрхэн найдвар төрүүлэхийг тайлбарла.

Мозая 29

Мозаягийн хүмүүс шинэ засаглалын хэлбэрээр шүүхийн системийг сонгов




Мозая 29-д цэдэглэсэнээр, Мозая хаан Нифайн засгийн газар хаанаар удирдуулахаа больж,

шүүхийн системтэй болж байгааг танилцуулав. Мозая 23:7–8 болон Мозая 29:13, 16–18-ыг уншаад харьцуул. Эдгээр судруудад гарсны дагуу ямар нөхцөл байдал, учир шалтгааны дор хаант засаглал нь (хаан юмуу хатнаар удирдуулах) засаглалын сайн хэлбэр болох вэ? Мозая яагаад нифайчуудад хаант засаглалыг үргэлжлүүлэхгүй байхыг зөвлөсөн бэ?

Мозая 29:11, 25-ыг уншаад, шүүгчид хүмүүсийг хэрхэн шүүх талаар Мозаягийн хэлсэн үгсийг нотлох дараах хариултуудыг дугуйл: (а) агуу нигүүлсэлтэй, (б) хуулийн дагуу, (в) Бурханы зарлигуудын дагуу, (г) чанд байдалд.


Мозая 29:26, 30, 33–34, 37–38-ыг уншаад, Мозая хааны танилцуулсан шинэ засаглал дахь хүмүүсийн үүргийг ол.


 **4.** Аль нэг улсын иргэн бүр эх орондоо үйлчлэхдээ “өөрийн хувийг үүрэх” нь яагаад чухал гэдгийг судрын тэмдэглэлдээ бич (Мозая 29:34).

Алма анхны дээд шүүгч байхаар томилогдсон бөгөөд тэр үүргээ шударгаар биелүүлсэн (Мозая 29:41–43-ыг үз).

Мозая 29-р бүлгээс сурсан нэг зарчмыг өөрийн үгээр бич: _____

Энэ бүлгийн заадаг нэг зарчим бол: **Хүн бүр шударга хууль ба удирдагчийг дэмжих үүрэгтэй.**

 **5.** Өөрийн улсдаа шударга хууль ба удирдагчийг хэрхэн дэмжиж болохоо судрын тэмдэглэлдээ бич.

 **6.** Дараах өгүүлбэрийг судрын тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Мозая 28–29-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

Алма

ГИЙН ОРШИЛ

Яагаад энэ номыг судлах хэрэгтэй вэ?

Та Алмагийн номыг судалснаар Есүс Христийн тухай, мөн түүний Цагаатгал ба амилалт нь Тэнгэрлэг Эцэгийн аз жаргалын төлөвлөгөөнд зайлшгүй шаардлагатай гэдгийг мэдэх болно. Мөн та хувь хүмүүсийг зүрх сэтгэлийн хүчит өөрчлөлтийг хүлээн авахад болон дахин төрөх явцад нь удирдах үедээ, санваараар мэргэших, буруу сургаал, нүгэл, үзэн ядалт, урвалтыг даван туулахын тулд Бурханы үгийн хүчний талаар суралцах болно. Та Мозаягийн хөвгүүдийн номлолын хүч чармайлт, Аммоны хүмүүс буюу Антай-Нифай-Лихайчууд хөрвөгдөж, хожим нь итгэлтэй болсон тухай унших явцдаа сүнслэг байдлаараа өсч хөгжих болно. Түүнчлэн та нифайчууд болон леменчүүдийн хоорондох дайн тулаануудыг нарийвчлан харуулсан бүлгүүдийг судлах үедээ өөрийн амьдарч буй үймээн самуунтай цаг үед өөрийгөө удирдах болоод дайсны эсрэг хувийн тулаандаа ялахад тань туслах зарчмуудыг суралцаж чадна.

Энэ номыг хэн бичсэн бэ?

Мормон Нифайн их ялтсуудаас цэдгүүдийг эмхэтгэн хураангуйлж Алмагийн номыг бүтээсэн юм. Энэ ном нь Алмагийн хүү Алма буюу ихэвчлэн залуу Алма гэгддэг Алмагийн нэрээр нэрлэгдсэн. Мозая хаан нифайчуудын дунд шүүгчдийн засаглалыг тогтоох үед Алма тэргүүн ерөнхий шүүгч болж, мөн эцгээсээ сүмийн дээд пристийн дуудлагыг залгамжлан хүлээн авчээ (Мозая 29:42-ыг үзнэ үү). Эцэст нь тэрээр өөрийгөө “тэр чигээр нь Бурханы ариун жаягийн дээд санваарт” болон Зарахемлагийн нутаг даяарх бүх “хүмүүст Бурханы үгийг хүргэхэд” (Алма 4:20; 5:1) зориулахын төлөө ерөнхий шүүгчийн суудлаа шилжүүлэн өгдөг. Мормон Алмагийн номыг эмхэтгэхдээ Алмагийн тохинууллын цэдгүүд (Алма 1–44) болон түүний хөвгүүд Хиламан (Алма 45–62), Шиблон (Алма 63) нарын бичээсүүдийг ашигласан юм.

Энэ ном хаана, хэзээ бичигдсэн бэ?

Алмагийн номыг бичихэд ашигласан эх цэдгүүдийг мээ 91-ээс мээ 52 оны үед бичсэн байх магадлалтай ба Мормон эдгээр цэдгүүдийг мээ 345-аас мээ 385 оны хооронд хураангуйлжээ. Мормон хураангуйллаа хаана хийж байсан тухайгаа цэдэглэж үлдээгээгүй юм.

14-Р ХЭСЭГ: 4 ДЭХ ӨДӨР

Алма 1–4

Оршил

Алмаг ерөнхий шүүгчээр томилогдсоны дараахан Нихор хэмээх нэгэн хүн нифайчуудын дунд буруу сургаал зааж, санваараар мэргэшихийг зааж эхэлжээ. Тэрээр нэгэн зөв шударга хүнийг алж, үйлдсэн гэмт хэргийнхээ төлөө цаазлуулдаг. Хэдэн жилийн дараа Амлисай нифайчуудын хаан болохоор оролдсон нь амжилтгүй болжээ. Хүмүүс түүнийг хаан болгохгүй хэмээн санал өгөхөд тэрээр нифайчуудын эсрэг дай-тахаар—амлисайчууд хэмээн нэрлэгдэх— дэмжигч-дээ цуглуулав. Нифайчууд ялсан ч, хэдэн арван мянган хүн алагджээ. Нифайчууд дайнаар даруусгагдаж, олон нь үүргээ санаж, мянга мянгаараа сүмд нэгддэг. Гэвч ганцхан жилийн дотор сүмийн олон гишүүд бардам болж, бусдыг хавчиж эхлэв. Алма ерөнхий шүүгчийн үүргээсээ татгалзаж, Есүс Христийн сайн мэдээг гэрчлэхэд анхаарлаа төвлөрүүлэхээр шийддэг.



Алма 1

Санваараар мэргэших явдал, мөрдлөг хавчлага газар авсан ч сүмийн гишүүд хөгжин дэгжив

Хүмүүс заримдаа нэр хүндтэй болохыг эрэлхийлдэг. Ийм хүслээс үүдэлтэй болзошгүй аюулын тухай тунгаан бод. Хэрэв та Бурхан таныг юу гэж бодох бол гэдгээс илүүтэйгээр найзууд тань юу гэж бодох бол гэдэгт анхаарлаа төвлөрүүлбэл юу болох вэ?

Алма 1-т цэдэглэснээр Нихор гэгч хүн хэсэг хүмүүсийн дунд маш их нэр хүндийг олжээ. Алма 1:2–6-г уншиж, Нихорын юу заасан болон хүмүүс үүнд нь хэрхэн хандаж байсныг олж мэд.

Алма 1:12-ын эхлэл хэсгийг судалж, Нихорын заасан зүйлсийг нифайчуудад тайлбарлахдаа Алма ямар үгс ашигласныг хайж ол. Дараа нь зүүвэр тайлбар 12а.-г үзээрэй. Зүүвэр тайлбарын хамгийн эхний холбогдох

эшлэл 2 Нифай 26:29-ийг уншиж, санваараар мэргэ- шигчид юу хийдэг мөн юу хийдэггүйг олж мэд.

Холбогдох эшлэлүү- дийг ашиглах нь

Судрын хуудас бүрийн доор байдаг зүүвэр тайлбар нь таныг судраас судлах үед илүү сайн ойлголт өгч чадах бусад судрууд руу хөтлөх холбогдох эшлэлүүдийг агуулдаг. Судалж байгаа судруудынхаа холбогдох эшлэлүүдийг уншдаг дадал- тай бол. Судруудыг илүү сайн ойлгоход тань туслах холбогдох эшлэлүүдийг та зүүвэр тайлбар дээрээ тэм- дэглэж болно.

Санваараар мэргэших гэдэг нь хүмүүс “хуу- рамч сургаалыг . . . баялаг болоод алдрын төлөө” номлож, “өөрс- дийгөө хорвоогийн гэрэл болгох” явдал юм (Алма 1:16; 2 Нифай 26:29). Тэд өөрсдийн номлолоор дамжуулан Бурханы хаант улсыг байгуулахыг хүсдэггүй. Харин тэд эд бая- лаг, нийгмийн давуу байдал, эсвэл бусдыг захирах эрх мэдэлтэй болж, бусад хүмүүсийн зүгээс магтаал сай- шаал олохыг хүсдэг. Тэд Бурхан болон түүний

сайн мэдээнд бус, харин өөртөө бусдын анхаарлыг татахыг хүсдэг. Алма Нихорт хандан “санваараар мэргэших нь энэ хүмүүсийн дунд албаар тулгагдвас энэ нь тэдний бүрэн устгалын шалтгаан болохсон” (Алма 1:12) гэж тодорхой хэлсэнчлэн санваараар мэргэших нь Бурханы мэлмийд ноцтой нүгэл юм.

Нихор “сүмийн хүмүүсийг зайцуулан удирдахыг” хичээсэн үед, Гидеон гэгч нэгэн зөв шударга хүн “Бурханы үгсээр түүнийг зэмлэн эсэргүүцэв” (Алма 1:7). Хариуд нь Нихор сэлмээ сугалан Гидеоныг хөнөөв. Нихор гэмт хэргийнхээ төлөө шүүгдэхээр зогсож, цаазлуулжээ. Нифайчуудын дундах санваа- раар мэргэших явдал нь Нихорын үхлээр төгсгөл болсон эсэхийг олж мэдэхийн тулд Алма 1:16-г унш.

Алма 1:26–27-г уншиж, Бурханы нифай пристүүд Нихор болон санваараар мэргэшигч бусад хүмүүсээс өөр байдлаар үйлдсэн арга замуудыг тодорхойл.



1. Нифай пристүүд хэрхэн үйлдэж байсныг судар судлах тэмдэглэлдээ бич. Нифай пристүүдийн үйлд- лүүд санваараар мэргэшигчдийн үйлдлүүдээс юугаараа ял- гаатай байсан бэ?

Тус нутаг даяар санваараар мэргэших явдал тархахад олон хүмүүс Сүмийн итгэлтэй гишүүдийг хавчин гадуурхаж эхэлсэн ажээ. Алма 1-ийн үлдсэн шүлгүү- дийг судлахад бэлтгэхийн тулд Бурханы зарлигуудыг дагадаг хүмүүсийг бусад хүмүүс шоолж, эсвэл хавчин гадуурхаж байгааг харсан тухайгаа бод.

Алма 1:19–20-ийг уншиж, сүмийн гишүүдийг зарим хүмүүс яагаад хавчин гадуурхаж байсныг олж мэд.

Алма 1:21–31-д сүмийн гишүүд хавчлагад хэрхэн хандсаныг цэдэглэсэн байдаг. Доорх судрын хэсгүү- дийг уншиж, хүснэгтийг бөглө:

Алма 1:21–24	Алма 1:25, 27–31
Зарим гишүүд хавчлагад хэрхэн хандсан бэ? _____	Сүмийн бусад гишүүд хэрхэн хавчлагыг эс хайхран амьдарсан бэ? _____
Тэдний үйлдлүүдийн үр дагавар юу байсан бэ? _____	Тэд ямар адислалууд хүлээн авсан бэ? _____

Энэ хүснэгтийг судалснаар сурсан зарчмаа бич: _____

Таны олсон байж болох зарчмуудын нэг нь: **Хэрэв бид сайн мэдээний дагуу амьдарвал, хавчин гадуурхагдсан ч бидний амьдрал амар амгалан байх болно** гэдэг зарчим юм.



2. Хавчлага эсвэл зарлигуудад дуулгаваргүй байлгах дарамт шахалттай тулгарах үед сайн мэдээн дээрх зарчмууд танд хэрхэн тусалж болохыг судар судлах тэмдэг- лэлдээ тайлбарла. Тэгээд дараах асуулуудын нэгэнд хариул:

- Та хэзээ хавчлага, дарамт шахалтыг эс хайхран зарлигуудыг дагаж байсан бэ, тэгснээр та ямар адислалууд хүлээн авсан бэ?
- Та дайснууддаа хэрхэн хандах вэ?

Алма 2

Амлисайчууд болон леменчүүд нифайчуудын эсрэг дайтахаар нэгдсэн нь

Алма 2-т нифайчуудад тулгарсан сорилтуудын талаар өгүүлдэг. Амлисай хэмээх хүн болон түүний дагалдагчид нифайчуудыг хэрхэн эсэргүүцсэнийг олж мэдэхийн тулд уг бүлгийн тоймыг унш. Ам- лисай нифайчуудыг захирах хаан болохыг хүссэн ч, нифайчууд саналаа өгөхөөр нэгдэн цугларч, түүнийг эсэргүүцэн, шүүгчдийн засаглалаа хэвээр үлдээхээр сонгожээ. Амлисайн дагалдагчид нэг- дэн цугларцгааж, түүнийг хаанаа болгов. Амлисай дагалдагчдаа нифайчуудтай дайтахаар явахыг тушаасан бөгөөд удалгүй леменчүүд, нифайчуудтай тулалдахаар амлисайчуудтай нэгдсэн ажээ.

Нифайчууд Их Эзэнд итгэлтэй байсан учраас Их Эзэн тэдэнд амлисайчууд болон леменчүүдийн эс- рэг дайтахад нь тусалсан юм. Алма 2:18, 28–31, 36-г уншиж, *хүчирхэгжүүлсэн, хүчирхэгжсэн* гэсэн үг бүрийг тэмдэглэ. Их Эзэн нифайчуудыг хэрхэн хүчирхэгжүүлснийг олж мэд.



3. Таныг зөв зүйл хийхийг хичээх үед, Их Эзэн таныг хүчирхэгжүүлснийг мэдэрсэн үеийнхээ тухай судар судлах тэмдэглэлдээ бич.

Алма 3

Амлисайчууд өөрсдийгөө Бурханаас тусгаарласан нь

Зарим хүмүүс хувцаслалт, үс засалт, ээмэг, бусад зүүлт чимэглэл, шивээс, биеэ цоолсон байдлаараа өөрийгөө илэрхийлдэг. Тэдгээр зүйлсийн тухай эргэцүүлэн бод.



Алма 3:4-ийг уншиж, амлисайчууд гадаад төрхөө хэрхэн өөрчилснийг тодорхойл.

Амлисайчууд хэнээс “онцлогдсон” бэ? _____

Тэд хэнтэй илүү адилхан харагдахыг хүссэн бэ? _____

Амлисайчуудын харагдах байдлын өөрчлөлт нь тэдний эсэргүүцлийн илрэл байв. Алма 3-т цэдэглэснээр леменчүүд хэдэн зуун жилийн өмнө Бурханыг эсэргүүцсэний улмаас тэдний дээр ирсэн зүхэл болох тэрхүү тэмдгийн талаар Мормон бидэнд сануулсан юм (Алма 3:6–10-ыг үзнэ үү; мөн 2 Нифай 5:20–24-ийг үзнэ үү). Амлисайчууд сайн дураараа духан дээрээ тэрхүү тэмдгийг тавьсан ч уг тэмдэг нь леменчүүд дээр Их Эзэний тавьсан тэмдэгтэй төстэй зорилгыг агуулсан ажээ.

Алма 3:18 дахь Бурханд хандах амлисайчуудын хандлагыг дүрсэлсэн хэллэгийг тэмдэглэ. Мөн Алма 3:19-д амлисайчууд эсэргүүцлийнхээ улмаас өөрсдийнхөө дээр юу авчирсныг тэмдэглэ.

Та Их Эзэнээр зүхэгдсэн хүмүүсийн талаар Алма 3:18–19-өөс юу сурч мэдсэн бэ? (Бурханы эсрэг илэрхий тэмдэг хүмүүс өөрсдийн дээр зүхлийг авчирдаг.) Зүхэл нь “Их Эзэний дэргэдээс тусгаарлагдах” (2 Нифай 5:20) явдал гэдгийг ойлгох нь чухал юм. Амлисайчууд өөрсдийн үйлдлүүдээр өөрсдийгөө Бурханаас тусгаарлажээ.

Бурханаас өөрсдийгөө тусгаарлах нь бидний өөрсдийн сонголт байдгийг бид амлисайчуудын жишээнээс сурлаа. “Бурханы эсрэг илэрхий эсэргүүцэлд гарч ирсэн” хүмүүс (Алма 3:18) өөрсдийгөө Бурханаас тусгаарласан юм. Өөрөөр хэлбэл тэд өөрсдийн дээр зүхлийг авчирсан юм.



4. Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултад хариулж бич: Амлисайчуудын хийсний эсрэгээр таны хийдэг зүйлс таныг Бурханаас тусгаарлахгүй байхад анхааралын тулд та одоо амьдралдаа юу хийж болох вэ?

Алма 3:20–25-д нифайчууд өөр нэгэн дайнд леменчүүдийг хэрхэн ялсан тухай, мөн хоёр талаас олон хүн дайнд алагдсан тухай өгүүлдэг. Алма 3:26–27-г уншиж, амлисайчуудын шастир болон нифайчууд ба леменчүүдийн хоорондох дайн тулаануудаас Мормон бидэнд заахыг хүссэн гол сургамжийг олж мэд.

Алма 3:26–27-оос уншсан зүйл дээрээ үндэслэн дараах зарчмыг гүйцээн бич: **Бид . . .-аасаа хамаарч аз жаргалыг эсвэл зовлонг хүлээн авдаг.** _____

Та амьдралдаа хэнийг дагахаар сонгохоо хэсэг хугацаанд тунгаан бод. Дараах асуултаудыг тунгаан бод: Сатан өөрийг нь дагадаг хүмүүст ямар хөлс, шан харамж санал болгодог вэ? (Тэдгээр шагнал, шан харамж нь эхлээд хорхой хүрмээр сайхан санагддаг ч эцэстээ аз жаргалгүй байдал, донтолтод хүргэдэг.) Үүний эсрэгээр, та Их Эзэнийг дагахаар сонгосноороо ямар шагнал хүлээн авсан бэ?



5. Их Эзэнийг дагаснаар аз жаргалтай байсан үеийнхээ талаар судар судлах тэмдэглэлдээ бич.

Алма 4

Хэсэг хугацаанд сүм хөгжин дэгжсэний дараа, сүмийн гишүүд бардамналд хөөрч, Алма тэднийг наманчлалд дуудахын тулд ерөнхий шүүгчийн суудлаа шилжүүлдэг.

Нифайчууд, леменчүүд болон амлисайчуудтай хийсэн дайны дараа “үүргийнхээ санамжид сэрээгдэж,” тэд “сүмийг илүү бүрнээр нь байгуулж эхлэв” (Алма 4:3–4). Үүний үр дүнд 3500 орчим хүн сүмд нэгдэв (Алма 4:5-ыг үзнэ үү). Харамсалтай нь, ганцхан жилийн богино хугацаанд сүмийн олон хүмүүс бардамнаж эхлэв. Алма 4:8–12-ыг уншиж, сүмийн гишүүдийн дундах бардамналын улмаас гарсан ёс бус үйлдлүүдийг тодорхойл. Энэхүү судрын хэсгээс бидний сурч болох зарчим бол: **Хэрэв бид буруу үлгэр жишээ үзүүлбэл, бидний үйлдлүүд сайн мэдээг хүлээн авахад нь бусдад саад болж мэднэ гэсэн зарчим юм.** (Алма 4:10-ыг үзнэ үү.)




6. Нифайчуудын Алма 4:8–12-т үзүүлсэн ёс бус үйлдэл эсвэл тэдний ёс бус зан авирын тухай

жишээнүүдийн нэгийг судар судлах тэмдэглэлдээ бич. Өнөөдөр сүмийн гишүүн ийм үйлдэл эсвэл ийм зан авираас зайлсхийх нь яагаад чухал болохыг тайлбарла.

Сүм дэх ёс бус байдлын улмаас, Алма сүмийн дээд пристийн дуудлагадаа бүх цаг заваа зориулж, “шударга гэрчлэлийг үзүүлснээр” бардамнал болон нүглүүдээ даван туулахад нь гишүүдэд туслахын тулд ерөнхий шүүгчийн суудалд өөрийнхөө оронд өөр хүнийг томилов (Алма 4:19). Алма 4:19-ийг уншиж, Алма хүмүүстээ туслахын тулд юу хийхийг хүссэн тухай хэсгийн доогуур зур.

Алма 4:19-д дараах зарчмуудыг тайлбарладаг: **Сүнс-лэг үүргүүдээ биелүүлэх нь биднээс золиослолыг шаардаж болно. Их Эзэний үйлчлэгчид гэрчлэлээ хуваалцаж, нүгэлтнүүдийг наманчлалд дууддаг. Шударга гэрчлэлийг хуваалцах нь бусдыг Бурханд илүү ойртоход тусалдаг.**

Та хэн нэгнийг номлолд үйлчлэхийн тулд улсын ерөнхийлөгч мэт нэр хүндтэй, улс төрийн албан тушаалаа орхиж байгаагаар төсөөлж чадах уу? Алма тэгсэн юм!

 **7.** (Алма 4:19)-д Алмагийн хэрхэн заах талаар дурдсан “шударга гэрчлэлийг үзүүлэх” гэсэн хэллэгийн талаар юу бодож байгаагаа судар судлах тэмдэглэлдээ бич. Мөн хэн нэгнийг сайн мэдээний талаарх гэрчлэлээ хуваалцахыг сонсох нь танд өөрийгөө өөрчлөх эсвэл хурцлахад хэрхэн нөлөөлсөн тухайгаа бич.

 **8.** Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Алма 1–4-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

15-Р ХЭСЭГ: 1 ДЭХ ӨДӨР

Алма 5:1–36

Оршил

Сүм ёс бус байдал, зөрчилдөөнтэй байсан үед (Алма 4:9–11-ийг үзнэ үү), жинхэнэ шинэчлэлт нь зөвхөн сүмийн гишүүдийн зүрх сэтгэлийн хүчит өөрчлөлтөөр ирэх болно гэдгийг Алма мэдэж байв. Алма сүмийн дээд пристийн хувьд Зарахемлагийн хүмүүсийг буцаан авчрах номлолоо Есүс Христийг гэрчлэн, хүмүүсийг наманчлалд дуудсанаар эхэлсэн юм. Тэрээр тэднийг Бурханы үгэнд итгэлтэй байж, зүрх сэтгэлийнхээ сүнс-лэг байдлыг дүгнэснээр Их

Эзэний шүүлтэнд бэлтгэхэд уриалж байв. Та Алма 5-р бүлгийн эхний хагасыг судлахдаа сурсан зүйлүүдээ хэрхэн хэрэгжүүлж болохыг бод, тэгснээр та энэ бүлэгт гарч байгаа зүрх сэтгэлийн хүчит өөрчлөлтийг хүлээн авч эсвэл энэхүү үйл явцыг үргэлжлүүлж чадна.

Алма 5:1–13

Алма аавынхаа болон түүнийг дагасан хүмүүсийн хөрвөлтийн тухай өгүүлсэн нь

Та 8 настайгаасаа хойш хэр зэрэг их өөрчлөгдсөн бэ? Та 12 настайгаасаа хойш хэр зэрэг их өөрчлөгдсөн бэ? Хүмүүсийн гаднах төрх, зан авир, хандлага өөрчлөгдөж болох янз бүрийн арга замуудын талаар бод. Хүмүүст гардаг эдгээр өөрчлөлтүүдэд юу нөлөөлж болохыг эсвэл юу ийм өөрчлөлтийг авчирч болохыг тунгаан бод. Дараа нь Алма 5:12-ыг уншиж, ахмад Алмад гарсан өөрчлөлтүүдийг олж мэд. Алма 5:1–13-ыг судлахдаа хүний зүрх сэтгэл хэрхэн өөрчлөгдөж болох талаар бод.

Хожим нь дальн гишүүнээр үйлчилж байсан ахлагч Жэралд Н.Ланд *зүрх сэтгэл* гэдэг үг нь сударт хэрэглэгдэхдээ ихэвчлэн “хүний жинхэнэ дотоод сэтгэл” гэсэн утгыг илэрхийлдэг гэж заажээ (“Understanding Scriptural Symbols,” *Ensign*, 1986 оны 10-р сар, 25). Энэ хичээлийг судалж эхлэхдээ бодсон зүйлүүдээ оролцуулан хүмүүсийг өөрчилж болох бусад зүйлүүдээс “зүрх сэтгэлийн хүчит өөрчлөлт” ямар ялгаатайг хэсэг хугацаанд бод.

Бенжамин хааны хүмүүс “хилэнцийг үйлдэх хүслийг үгүй болгож, харин үргэлж сайныг хийх болгосон” (Мозая 5:2) зүрх сэтгэлийн “хүчит өөрчлөлтийг” мэдэрсэн юм гэдгийг эргэн сана. Та ахлагч Ландын тайлбар болон Мозая 5:2-ын эшлэлийг судартаа Алма 5:11–13-ын хажууд бичих хэрэгтэй.



Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Д.Тодд Кристоффэрсон тайлбарласан нь: “Надад энэ хүчит өөрчлөлт яагаад хурдан ирэхгүй байна вэ? гэж та асууж болох юм. Та Бенжамин хааны хүмүүс, Алма болон судар дахь бусад хүмүүсийн

Сурснаа хэрэг-жүүлэх нь

Тэргүүн Зөвлөлийн Ерөнхийлөгч Марион Ж.Ромни заасан нь: “Сайн мэдээг бичигдсэн үгсээс судлах нь. . . хангалттай биш юм. Мөн сайн мэдээгээр амьдрах ёстой. . . Хүн сайн мэдээний дагуу амьдрахгүйгээр үүнийг бүрэн суралцаж чадахгүй” (“Records of Great Worth,” *Ensign*, 1980 оны 9-р сар, 4). Таныг энэ хичээлийн хэд хэдэн хэсэгт сурсан зүйлсээ амьдралдаа хэрэгжүүлэхийг урамшуулан дэмжих болно. Сурсан зүйлсээ хэрэгжүүлэх нь таны хувьд сайн мэдээг судлах аяллын тань чухал хэсэг байх ёстой.


онцгой жишээнүүд нь зөвхөн онцгой тохиолдлууд байсан бөгөөд байнга тохиолддоггүйг санах хэрэгтэй. Ихэнх хүмүүсийн хувьд өөрчлөлтүүд нь алгуураар, удаан хугацааны дараа ирдэг. Дахин төрөх гэдэг нь бидний бие махбодын төрөлттэй адилгүй зүйл бөгөөд нэг удаагийн үйл явдал биш, харин урт хугацааны үйл явц юм. Энэхүү үйл явцыг туулах нь мөнх бус амьдралын гол зорилго юм” (“Born Again,” *Ensign* ба *Лиахона*, 2008 оны 5-р сар, 78).


Алма 5:3–7-г уншиж, Алма Зарахемлагийн хүмүүст зүрх сэтгэлээ өөрчлөхөд бэлтгэхэд нь туслахын тулд юу гэж хэлснийг олж мэд.

Гарын авлага дээрээ дараах асуултад хариулан бич: Алма Зарахемлагийн хүмүүст эцгийнхээ болон бусад хүмүүсийн хөрвөлт ба тэд боолчлолоос хэрхэн чөлөөлөгдсөн тухай ярьжээ. Та эдгээр туршлагауд нь тэдгээр хүмүүст зүрх сэтгэлийн өөрчлөлтийг мэдрэхдээ бэлтгэхэд нь хэрхэн тусална гэж бодож байна вэ? _____

Алма 5:10-ыг уншиж, хүмүүсээс Алмагийн асуусан гурван асуултын төгсгөл дэх асуултын тэмдгүүдийг дугуйл. Дараа нь Алмагийн эдгээр асуултад хариулсан хэсэг болох Алма 5:11–13 дахь дараах нотолгоог дэмжих мэдээллийг ол: **Бид Бурханы үгэнд итгэж, Есүс Христэд итгэх итгэлээ үйлдэл болгох үед зүрх сэтгэлийн хүчит өөрчлөлтийг мэдэрч чадна.**

Бурханы үг бидэнд Аврагчийн тухай заадаг учраас Бурханы үгэнд итгэх итгэл нь зүрх сэтгэлийн хүчит өөрчлөлт рүү хөтөлдөг. Алмагийн хүмүүс ариун бошиглогчдоор дамжин тэдэнд ирсэн Бурханы үгэнд итгэсэн юм. Тэд Есүс Христийн Цагаатгалын гэтэлгэгч хүчийг мэдэж, Аврагчид итгэх итгэлээ хөгжүүлснээр, зүрх сэтгэл нь өөрчлөгдөж байв.

 **1.** Есүс Христийн Цагаатгалд итгэх итгэл нь зүрх сэтгэлийн хүчит өөрчлөлт рүү хөтөлдгийг судар судлах тэмдэглэлдээ өөрийн үгээр тайлбарла.

 **2.** Зүрх сэтгэл тань хэрхэн өөрчлөгдсөн тухай судар судлах тэмдэглэлдээ бич. Хэрэв та энэ жилийн семинарт Мормоны Номыг судалснаар зүрх сэтгэлдээ гарсан өөрчлөлтийг анзаарсан бол хариултынхаа нэгэн хэсэг болгон туршлагаа бичиж болно.


Алма 5:14–36

Алма тэнгэрийн хаант улсад ороход зүрх сэтгэлийн хүчит өөрчлөлт шаардлагатайг заав

Бурханы үгэнд итгэх итгэл нь бидэнд зүрх сэтгэлийн хүчит өөрчлөлтийг хүлээн авах үйл явцыг эхлүүлэхэд тусалдгийг Алма заасныхаа дараа, хүмүүсийг маш олон асуултын тухай бодож үзэхэд урьжээ.

Эдгээр асуултууд нь, зүрх сэтгэлийнхээ сүнслэг байдал—дотоод сэтгэлийн хүсэл, мэдрэмжүүдээ дүгнэхэд бидэнд тусалж чадна.

Алма 5:14-ийг уншиж, хүмүүсийг өөрсдийнхөө талаар бодож үзэхэд урьсан Алмагийн гурван асуултыг тэмдэглэ. Эдгээр гурван асуулт нь Есүс Христийн санал болгодог гэтэлгэлийн талаарх итгэлээ үйлдэл болгоход ирдэг өөрчлөлтийг дүрслэн харуулдаг. Өмнөх хичээлүүдээс үзвэл (Мозая 5, Мозая 27-г үзнэ үү) “дахин төрөх” гэдэг нь хүн зөвхөн Есүс Христийн дагалдагчийнхаа хувьд бус мөн Түүний сүнсэн хүү эсвэл охины хувьд Түүнийг хүлээн зөвшөөрч, шинэ амьдралаа эхлэх гэсэн утгатай юм (Мозая 27:25-ыг үзнэ үү).

 **3.** Зүрх сэтгэлийн өөрчлөлтийг хүний царай төрхөөс хэрхэн харж болох талаар судар судлах тэмдэглэлдээ бич. Энэхүү хам сэдэвт *царай төрх* гэдэг үг нь хүний зан авир, санаа сэтгэлийн байдал эсвэл сүнслэг байдлыг илэрхийлдэг нүүр царайны төрх гэсэн утгатай. Аврагчийн дүр төрхийг царай төрхөндөө хүлээн авсан, өөрийнхөө мэддэг нэг хүнийг дүрсэл.

Эрүүл мэндийн салбарт хэрэглэдэг зүрхний бичлэг нь эмч нар бидний зүрхний үйл ажиллагааг шалгахдаа ашигладаг зураг юм. Энэ нь эмчилгээ хэрэгтэй эсэхийг оношлоход тусалдаг. Доорх сүнслэг байдлын зүрхний бичлэгийн төгсгөлд жагсаасан Алма 5-р бүлгийн шүлгүүдийг судал. Та шүлэг тус бүрийг судлахдаа, шүлэг бүр дэх асуултуудад хариулах таны хариултыг хамгийн сайн дүрсэлсэн үгийн нүдийг тэмдэглэ. (Хэрэв та хариултуудаа нууц байлгахыг хүсвэл, энэ хүснэгтийг өөр цаасан дээр эсвэл хувийн тэмдэглэлдээ хуулж авсныхаа дараа бөглөж болно.)

Алма 5 Сүнслэг байдлын зүрхний бичлэг								
Үргэлж								
Бараг үргэлж								
Ихэнхдээ								
Заримдаа								
Хааяа нэг								
Алма 5-р бүлгийн шүлгүүд	15	16	19	26	27	28	29	30–31

Сүнслэг байдлын зүрхний бичлэгээ бөглөж дуусаад, Алма 5:21–25-ыг унш. Алма дараах үнэний талаар

юу гэж заасныг олж мэд: **Бид зүрх сэтгэлийн өөрчлөлтийг мэдэрснээр өөрсдийгөө тэнгэрийн хаант улсад (селестиел хаант улсад) байр хүлээн авахад бэлтгэдэг.**



4. Судар судлах тэмдэглэлдээ дараах дасгалыг хий:

а. Таны одоо байхыг хүсч байгаа нөхцөл байдлыг дүрслэхийн тулд Алма 5:21–25-д Алмагийн ашигласан үг хэллэгүүдийг жагсаан бич.

б. Зүрх сэтгэлийн өөрчлөлт нь биднийг тэнгэрийн хаант улсад байрыг хүлээн авахад хэрхэн бэлтгэдгийг тайлбарла.

Та Алма 5:33–36-г уншиж, Алмагийн захиасын талаар юу мэдэрч байгаагаа бодож үзнэ үү. Дараах асуултуудад хариулахад тань туслах үг хэллэгүүдийг ол:

- Их Эзэн намайг юу хийхэд урьж байна вэ?
- Энэ урилгыг хүлээн авснаар ямар шагнал авах вэ?
- Эдгээр шүлгүүд Аврагчийн талаар надад юу зааж байна вэ?

Зүрх сэтгэлийн өөрчлөлтийг хүлээн авсан хүн яаж амьдрах хүсэлтэй байдгийг харуулсан Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсоны дараах үгсийг унш:



“Та Христийг дагахаар сонгохдоо өөрчлөгдөхийг сонгодог. . . .

“Их Эзэн эхлээд хүний дотоод сэтгэл дээр, дараа нь гадаад төрх байдал дээр ажилладаг. Харин дэлхий хүний гадаад төрх байдлаас эхэлж, дотоод сэтгэл рүү нь орж ажилладаг. Дэлхий хүмүүсийг ядууралд нэрвэгдсэн нутгуудаас гаргаж болох юм. Харин Христ ядуурлыг хүмүүсийн дотоод сэтгэлээс гаргасны дараа тэд өөрсдийгөө ядуурлаас гаргадаг. Дэлхий хүмүүсийн хүрээлэн буй орчинг өөрчлөх байдлаар тэднийг төлөвшүүлдэг. Харин Христ эхлээд хүмүүсийг өөрчлөхөд, тэд дараа нь хүрээлэн байгаа орчноо өөрчилдөг. Дэлхий хүмүүсийн зан төлөвт нөлөөлж болох ч, харин Христ хүмүүсийн зан төлөвийг өөрчилж чадна. . . .

Христийн төлөө өөрчлөгдсөн “эрэгтэй, [эмэгтэйчүүд] Христээр удирдуулах болно. Тэд Паулын адил, ‘Их Эзэн, та надаар юу хийлгэхийг хүсэж байна вэ?’ гэж асуух болно. (Үйлс 9:6.) . . .

“Тэдний хүсэл нь Эзэний хүслийг хүлцэх юм. (Иохан 5:30-ыг үзнэ үү.)

“Тэд үргэлж Их Эзэнд тааламжтай зүйлсийг үйлддэг. (Иохан 8:29-ийг үзнэ үү.)

“Тэд Их Эзэний төлөө зөвхөн үхэх төдийгүй, үүнээс илүү чухал нь тэд Түүний төлөө амьдрахыг хүсдэг.

“Тэдний гэрт ороход, хананд нь өлгөөстэй зургууд, тавиурт нь байгаа номууд, эгшиглэх дуу хөгжим,

тэдний үгс ба үйлдлүүд нь тэднийг Христэд итгэдгийг харуулдаг.

“Тэд бүх цагт, бүх зүйлд, бүх газарт Бурханы гэрчлэгч болж зогсдог. (Мозая 18:9-ийг үзнэ үү.)

“Тэд санаа бодол болгондоо Христ рүү харахдаа тэд оюун ухаандаа Түүнийг байлгадаг. (С ба Г 6:36-г үзнэ үү.)

“Тэдний хайр Христэд үүрд байрлахад, тэд Түүнийг зүрх сэтгэлдээ шингээдэг. (Алма 37:36-г үзнэ үү.)

“Тэд бараг долоо хоног бүр ариун ёслолоос хүртэж, өөрсдөдөө Түүний Хүүгийн нэрийг авч, үргэлж түүнийг санаж, түүний зарлигуудыг дагахад бэлэн гэдгээ Мөнхийн Эцэгтээ гэрчлэн гэрээгээ шинэчилдэг. (Моронай 4:3-ыг үзнэ үү.)” (“Born of God,” *Ensign*, 1985 оны 11-р сарын 5–7).

Энэ хичээлийн төгсгөлд та зүрх сэтгэлийн өөрчлөлтийг мэдрэхийн тулд хэрхэн амьдрах талаар бодоход тань туслах Ерөнхийлөгч Бэнсоны мэдэгдлүүдээс нэг санааны доогуур зур. Зүрх сэтгэлийн өөрчлөлтийг мэдрэх талаар Алмагийн заасан зүйлийг судлах үед мэдэрсэн зүйлээ хэрэгжүүлэхэд тань туслахуйц зорилго тавь (та үүнийг тусдаа цаасан дээр эсвэл хувийн тэмдэглэлдээ бичиж болно). Та үргэлжлүүлэн Бурханаар төрөхийг үргэлж эрэлхийлэн, зүрх сэтгэлийн өөрчлөлтийг мэдэрч байвал Бурханы хаант улсад орохоор бэлтгэгдэж байна гэсэн үг.



5. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Алма 5:1–36-р шүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

15-Р ХЭСЭГ: 2 ДАХЬ ӨДӨР

Алма 5:37–62

Оршил

Алма Зарахемла дахь номлолоо үргэлжлүүлж, түүний үгийг сонсох эсвэл эсэргүүцэх хүмүүсийн шийдвэрээс хамаарч тэд тодорхой адислалуудыг эсвэл сөрөг үр дагавруудыг хүлээн авах болно гэдгийг тэдэнд анхааруулав. Тэднийг араас нь дуудаж, сүрэгтээ буцаан авчрахыг хүсдэг Сайн Хоньчин, Их Эзэн Есүс Христийн дуу хоолойд хариулахыг Алма тэдэнд уриалжээ. Та энэ хичээлийг судлахдаа Сайн

Хоньчны дуу хоолойг дагах нь дэлхийн бузар зүйлсээс зайлсхийж, Бурханд эргэн очиход тань хэрхэн тусалж болохыг бодож үзнэ үү.

Алма 5:37–42, 53–62

Алма бүх хүмүүсийг Аврагч, Сайн Хоньчныг дагахад урьдаг байв

Зарим үед судруудад Есүс Христийг “Сайн Хоньчин” хэмээн дүрсэлдэг (Иохан 10:11–15-ыг үзнэ үү). Та яагаад хоньчин нь Аврагчийг дүрслэх сайн бэлгэдэл гэж бодож байна вэ? Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон эртний хоньчдыг дараах байдлаар дүрсэлжээ:

“Есүсийн үед Палестин хоньчид сүргээ сайн хамгаалдгаараа алдартай байжээ. Өнөө үеийн хоньчдоос ялгаатай нь тэр үеийн хоньчин үргэлж сүргийнхээ урд явдаг байжээ. Тэр хонио удирдан өмнө нь явдаг байв. Хоньчин нь хонь бүрээ мэддэг бөгөөд ихэвчлэн хонь бүр нь нэртэй байжээ. Хонь нь хоньчныхоо дууг таньдаг, түүнд итгэдэг бөгөөд танихгүй хүнийг дагадаггүй байсан ажээ. Тиймээс түүнийг хонио дуудахад хонь нь түүн рүү хүрч ирдэг байв. (Иохан 10:14–16-г үзнэ үү.)

“Орой болоход хоньчид хонио хонины саравч гэж нэрлэгддэг хашаанд оруулдаг байв. Хонины саравчийг тойруулан өндөр хашаа барьдаг байсан бөгөөд зэрлэг амьтад болон хулгайчдыг хашаан дээгүүр давж орохоос сэргийлж өргөст тор татдаг байжээ.

“Тэсэн хэдий ч заримдаа өлсгөлөн зэрлэг амьтад хашаан дээгүүр үсрэн, хонины дунд орж, тэднийг

үргээдэг байв. Ийм нөхцөл байдалд хонио хайрладаг—жинхэнэ хоньчин нь мөнгөний төлөө ажилладаг хөлсний хоньчноос ялгаатай нь харагддаг.

“Жинхэнэ хоньчин хониныхоо төлөө амиа өгөхөд ч бэлэн байдаг. Тэр хониныхоо дунд орж, тэдний төлөө тэмцдэг. Харин хөлсний хоньчин өөрийнхөө аюулгүй байдлыг хониныхоо аюулгүй байдлаас дээгүүр тавьж, аюул тулгарахад ихэвчлэн зугтдаг.

“Есүс амьралынхаа өдрүүдэд Сайн Хоньчин, Жинхэнэ Хоньчин байсан гэдгээ харуулахын тулд энэхүү нийтлэг жишээг ашигласан ажээ. Тэр ах, эгч нартаа хайртай учраас Өөрийн амийг тэдний төлөө сайн дураараа, хүслээрээ өгсөн юм. (Иохан 10:17–18-ыг үзнэ үү.)” (“A Call to the Priesthood: ‘Feed My Sheep,’” *Ensign*, 1983 оны 5-р сар, 43).

Гарын авлага дээрээ дараах асуултуудад товч хариулан бич:

- Хэрэв хонь хоньчноо сонсохгүй бол тэдэнд юу тохиолдох вэ? _____
- Бид хоньтой, харин Аврагч бидний хоньчинтой хэрхэн адилхан байж болох вэ? _____
- Түүний сүрэг авчрагдах гэдэг нь юу гэсэн утгатай вэ? (Алма 5:60-ыг үзнэ үү.) _____

Алма 5:37-д Алма Зарахемлагийн хүмүүсийг “төөрч одсон” хонь хэмээн дүрсэлжээ. Алма 5:37–42-ыг уншиж, Алма Аврагчийн дуу хоолойг сонсох талаар юу заасныг олж мэд.



1. Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултуудын хариултыг бич:

а. Алма 5:37–38-ыг судалж, Өөрийг нь дага хэмээн бидний араас дууддаг Аврагчийн хүч чармайлтын талаар Алмагийн заасан зүйлийг өөрийн үгээр тайлбарла.

б. Алма 5:41-т бид Сайн Хоньчны дуу хоолойг сонсож байгаа эсэхээ хэрхэн мэдэх талаар Алма юу гэж заасан бэ? Хожмын үеийн гэгээнтэн өсвөр үеийнхэн Сайн Хоньчныг дагаж байгааг харуулах тэдний “сайн үйлс” юу байж болох вэ?

Аврагчийн дуу хоолойг таньж, дагах нь үргэлж амархан байдаггүй. Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Даллин Х.Өүксийн дараах эшлэлийг тунгаан бод: “Бид мөнх бус амьдралд өөрсдийн сонсдог олон янзын дуу хоолойнуудын дундаас, тэнгэрлэг гэр рүүгээ дагаж явахыг уриалан дууддаг Сайн Хоньчны дуу хоолойг таних ёстой” (“Alternate Voices,” *Ensign*, 1989 оны 5-р сар, 27).

Алма 5:53–56-г уншиж, Аврагчийн дуу хоолойг сонсоход хүнд саад болдог зан авир, үйлдлүүдийг тэмдэглэ.

Өнөөгийн дэлхийд Аврагчийн дуу хоолойг сонсоход нь хүмүүст саад болдог өөр ямар зан авир болон үйлдлүүд байдгийг бод. Яагаад эдгээр зан авир, үйлдлүүд Аврагчийн дуу хоолойг сонсоход хүмүүст саад болдгийг товчхон тайлбарла. _____

Алма 5:57 дахь “сайн хоньчны дуу хоолойг дагахыг хүсэх та нар бүгд” гэсэн хэсгийг тэмдэглэ. Дараа нь 57-р шүлэг дэх Аврагчийн дуу хоолойг дагахын тулд та юу хийж болохыг өгүүлсэн өөр гурван хэллэгийг тэмдэглэ.



2. Танай сургууль эсвэл танай нутаг дахь хожмын үеийн гэгээнтэн өсвөр үеийнхэн юу хийж болохыг харуулсан дараах гурван зүйл тус бүрд нэг нэг жишээ гаргаж, судар судлах тэмдэглэлдээ бич: (а) ёс бусыг үйлдэгчдийн дундаас гарч ирцгээ, (б) тусдаа байгтун, мөн (в) цэвэр бус зүйлүүдэд бүү хүрэгтүн. Дараа нь өсвөр үеийнхэнд Сайн Хоньчны дуу хоолойг илүү сайн сонсоход нь туслах хоёр зөв шударга үйл ажиллагаа эсвэл хоёр дадал зуршлын талаар бод. Хэрэв эдгээр үйл ажиллагаа эсвэл дадал зуршлуудын нэг нь танд Аврагчийн дуу хоолойг сонсоход тусалсан бол энэ тухайгаа багш эсвэл ангийнхантайгаа хуваалцахын тулд судар судлах тэмдэглэлдээ бичиж болно.

Алма 5:58–60-д цэдэглэсэнээр Алма уг үнэнийг заасан байна: **Хэрэв бид Их Эзэний (Сайн Хоньчны) дуу хоолойг дагавал Түүний хаант улсад цуглуулагдах болно.** Бурханы баруун гар талд өвийг өвлөн авах хүмүүст ирэх амлалтууд эсвэл адислалуудыг Алма 5:58–60-аас тэмдэглэж ав.



3. Таны тэмдэглэсэн эдгээр амлалт эсвэл адислал бүр нь таны хувьд ямар ач холбогдолтойг бодож үзнэ үү. Дараа нь өөрийгөө ёс бус зүйлүүдээс тусгаарлах нь эдгээр адислалуудыг хүлээн авахад хүргэнэ гэж та яагаад бодож байгаагаа судар судлах тэмдэглэлдээ бич.

Та Аврагчийн дуу хоолойг дагаснаар эдгээр адислалуудыг хүлээн авч, эцэст нь өргөмжлөлийн адислалуудыг хүртэх болно.

Алма 5:43–52

Алма гэрчлэлээ хэрхэн олж авснаа өгүүлж, наманчлалын тухай заав

Та таван мэдрэхүй болох харах, сонсох, хүрэх, үнэрлэх, амтлах мэдрэмжүүдээр дамжуулан сурч мэдсэн зүйлийнхээ талаар бод. Танд мэдрэхүйн таван эрхтнийхээ аль нэгийг нь ашиглахгүйгээр ямар нэг зүйлийг мэдэх арга зам байдаг уу? Алма 5:45–48-ыг уншиж, Алма юуг мэдсэн болон үүнийг тэр хэрхэн мэдсэн талаараа юу гэж хэлснийг олж мэд.

Алма Алма 5:48-д Есүс Христийн талаар юу заасныг тэмдэглэ. Алма 5:45–48 дахь захиасыг ингэж нэгтгэн дүгнэж болно: **Есүс Христ бол бүх хүмүүний**

Гэтэлгэгч гэдгийг бид өөрсдөө Ариун Сүнсний хүчээр мэдэж авч чадна.

Хүн бүр итгэл, гэрчлэлийнхээ эсрэг сорилт бэрхшээлтэй тулгардаг. Ариун Сүнсний хүчээр мэдэрсэн сайн мэдээний бүрэн байдлын талаар хувийн гэрчлэлтэй байх нь таныг эдгээр сорилт бэрхшээлийн үед хүчирхэгжүүлж чадна. Та Алмагийн адил Ариун Сүнсний талаарх хувийн гэрчлэлээ санах нь сорилт бэрхшээлийн үед гуйвшгүй бат зогсоход тань тусалж чадна. Мацаг барилт ба залбирал нь Сүнс үнэнүүдийг дахин баталж, бидний гэрчлэл улам хүчтэй болох хэрэгтэй үед тусалдгийг бид Алмагийн жишээнээс түүнчлэн сурч чадна.



Есүс Христийн талаарх хувийн гэрчлэлтэй болохыг эрэлхийлэхэд биднийг уриалсан Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч М.Рассэлл Баллардын дараах эшлэлийг уншихдаа өөрийнхөө гэрчлэлийг тунгаан бод: “Сайн мэдээний үнэний талаарх, ялангуяа Их Эзэн Есүс Христийн бурханлаг амьдрал болон зорилгын талаарх тусдаа хувийн гэрчлэлтэй байх нь бидний мөнх амьдралд нэн чухал. ‘Цорын ганц үнэн Бурхан Таныг болон Таны илгээсэн Есүс Христийг мэдэх нь’ ‘мөнхийн амь мөн’ [Иохан 17:3] хэмээн Аврагч хэлжээ. Өөрөөр хэлбэл, мөнх амьдрал нь Тэнгэр дэх Эцэгийнхээ болон Түүний Ариун Хүүгийн талаарх бидний тус бүрийн хувийн мэдлэг дээр тулгуурлагддаг. Тэдний талаарх энгийн мэдлэг нь хангалттай бус юм. Бид өөрсдийгөө бат бөх итгэлтэй байлгах хувийн, сүнслэг туршлагатай байх ёстой” (“Feasting at the Lord’s Table,” *Ensign*, 1996 оны 5-р сар, 80).



4. Судар судлах тэмдэглэлдээ дараах үйл ажиллагаануудын нэгийг эсвэл илүү олныг нь хий:

а. Есүс Христ бол хүн төрөлхтний Гэтэлгэгч гэдгийг хэн нэгэн нь Ариун Сүнсний хүчээр гэрчилснийг сонссон тохиолдлынхоо тухай бич. Уг гэрчлэлийг сонсоод юу мэдэрснээ бич.

б. Алма 5:46-г уншиж, Алма Есүс Христийн талаарх гэрчлэлээ хэрхэн хүлээж авсныг өөрийн үгээр бич. Та гэрчлэлээ улам хүчтэй болгохын тулд Алмагийн үлгэр жишээг хэрхэн дагаж болох талаараа бодож, санаагаа нэмж бич.

в. Ариун Сүнс танд Есүс Христ бол дэлхийн Гэтэлгэгч гэдгийг гэрчлэхэд төрсөн мэдрэмжийнхээ талаар бич. Мацаг барих, илүү чин сэтгэлээсээ залбирах эсвэл судруудыг илүү нухацтайгаар судлах зэрэг Аврагчийн талаар гэрчлэлтэй болоход тань эсвэл энэхүү гэрчлэлээ хүчирхэгжүүлэхэд тань туслах тодорхой нэг зорилго бич. Хэдийгээр үүнд “олон өдөр” шаардагдсан ч зорилгодоо хүрэхийн төлөө ажилла (Алма 5:46). (Энэ үйл ажиллагааг хийх нь Хувийн хөгжил дэвшил эсвэл Бурханы өмнө хүлээсэн үүрэг номууд дахь шаардлагуудыг биелүүлэхэд тань туслах болно.)

Алма 5:49–52-ыг уншиж, Алма хүмүүст наманчлалын талаар юу заасныг олж мэд. Тэнгэрлэг Эцэг


болон Есүс Христтэй хамт мөнх амьдрахын тулд бүх хүмүүс яагаад наманчлах ёстой гэж боддоогоо доорх мөрүүдэд тайлбарлан бич: _____

Ахлагч Даллин Х.Өүкс биднийг наманчлал болон Бурханы хаант улсад ороход бэлтгэх талаар Алмагийн заасан зүйлсийг хэрэгжүүлэхэд тусалж болох хэдэн асуултыг эргэцүүлэн бодож үзэхэд урьжээ:



“Түүний ирэлтийн өдөр маргааш байвал яах вэ? Хэрэв бид маргааш —зуурдын үхлээр эсвэл Түүний гэнэтийн ирэлтээр—Их Эзэнтэй уулзана гэдгээ мэдэж байгаа бол, бид өнөөдөр юу хийх байсан бэ? Бид юуны төлөө наманчлах байсан бэ? Бид ямар зуршлуудаа хаях байсан бэ? Бид ямар асуудлуудаа шийдэх байсан бэ? Бид хэр зэрэг өршөөл үзүүлэх байсан бол? Бид ямар гэрчлэлүүдийг хуваалцах байсан бэ?”

“Хэрэв бид эдгээр зүйлүүдийг хийх байсан бол яагаад эдгээрийг одоо хийж болохгүй байх билээ? Амар амгаланг олох боломжтой үедээ яагаад үүнийг эрэлхийлж болохгүй гэж? (“Хоёр дахь ирэлтэд бэлтгэх нь,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2004 оны 5-р сар, 9).

 **5.** Ахлагч Өүксийн асуусан нэг асуултын талаар бод. Өдөр бүр Их Эзэнтэй уулзахаар бэлтгэж байгаа юм шиг амьдрах нь яагаад чухал гэж бодож байгаа талаараа судар судлах тэмдэглэлдээ бич.

Та өнөөдөр сурсан зүйлээ хэрхэн хэрэгжүүлж болох талаараа залбирч, тунгаан бод. Тэгснээр та Аврагчтай уулзахад мөн Түүний хаант улсад ороход бэлтгэгдэж чадна.

 **6.** Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Алма 5:37–62-р шүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

15-Р ХЭСЭГ: 3 ДАХЬ ӨДӨР

Алма 6–7

Оршил

Алма Зарахемла дахь хүмүүст зааж, сүмийг зохион байгуулсныхаа дараа Гидеон хот руу явжээ. Тэр тэнд

Зарахемла дахь хүмүүсээс илүү итгэлтэй оршин суугчидтай уулзав. Тиймээс, тэр Гидеон дахь хүмүүсийг Их Эзэнд үргэлжлүүлэн найдаж, амьдралдаа Түүний Цагаатгалын нөлөөг хүлээн авахаар эрэлхийлэхэд нь тэднийг урамшуулан дэмжжээ. Есүс Христийн талаарх Алмагийн гэрчлэл нь Есүс Христийн Цагаатгалын цар хүрээг илүү сайн ойлгоход тань тусалж, Бурханы хаант улс хүрэх зам дээр үргэлжлүүлэн алхсанаар хэрхэн Есүс Христийн Цагаатгалын адислалуудыг өдөр тутам хүлээн авахыг танд зааж чадна.

Алма 6


Алма Зарахемла дахь сүмийг хүчирхэгжүүлж, Гидеонд номлохоор явсан нь

Дараах өгүүлбэрийг гүйцээж бич: Би сүмд явдаг, учир нь _____

Та Алма 6-г судлахдаа сүмийн цуглаануудын зорилгыг ойлгох нь таны хувьд цуглаануудыг хэрхэн илүү утга учиртай болгохыг эргэцүүлэн бод.

Алма Зарахемлаг орхихоосоо өмнө тэндхийн сүмийг хүчирхэгжүүлжээ. Алма 6:1–4-ийг уншиж, сүмийн санваарын удирдагчдын үүрэг хариуцлагыг тодорхойлсон хоёр эсвэл гурван хэллэгийг ол.

Алмагийн туршлагаас бидний суралцагч нэг чухал зарчим бол: Мормоны Номын үеийн адил одоо ч гэсэн **сүм нь бүх хүмүүсийн сайн сайхны төлөө байгуулагддаг**. Алма 6:5–6-г уншиж, дараах хоёр хэллэгийг тэмдэглэ: “Бурханы үгийг сонсохоор”, “Бурханыг мэдэхгүй тэдний бодгалиудын аз жаргалын төлөө мацаг барих болон хүчирхэг залбиралд нэгдэхээр.” Эдгээр хэллэгүүд нь бүх хүмүүст өсөж хөгжих, бусдад туслах боломжуудыг олгох сүмийн арга замуудыг тодорхойлдог. Таны дээр гүйцээсэн өгүүлбэрийг Зарахемла дахь сүмийн гишүүд хэрхэн гүйцээн бичиж болох байсныг бод.

 **1.** Алма 6:5–6-д дурдсан шалтгаануудын улмаас сүмд явах нь сүм дээр мэдрэх туршлагаудад тань өөрчлөлт гаргах хэдэн санааг судар судлах тэмдэглэлдээ бич.

Сүмийн гишүүчлэлийн адислалууд нь Бурханы бүх хүүхдүүдэд зориулагдсан юм. Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Жэффри Р.Холланд заасан нь:



“Хүн бүр номлогчдын төлөө залбирдаг. Үргэлж ийм байх болтугай. Бид мөн адил сүнсээр, номлогчидтой уулзаж байгаа (эсвэл уулзах хэрэгтэй) хүмүүсийн төлөө залбирах ёстой. Зарахемла дахь гишүүд Бурханы Сүмд хараахан нэгдээгүй байгаа

хүмүүсийн төлөө ‘мацаг барих болон хүчирхэг залбиралд нэгдэхээр’ [Алма 6:6] зарлиг болгогдсон билээ. Бид тэдний адилаар үйлдэж чадна.

“Бид бас номлогчийн хувийн туршлагатай болохын төлөө өдөр бүр залбирч болно. Эдгээр зүйлсийн бурханлаг удирдамжаар таны хүсч буй номлогчийн боломж танд байгаа зүйлийг хүсэн хүлээж, эрж хайж буй хэн нэгний зүрх сэтгэлд урьдаас бэлтгэгдсэн байхын төлөө залбир. Тэд үүнийг хаанаас олохыг мэддэггүйн улмаас . . . гагцхүү үнэнээс хол байдаг нь дэлхий дээр олон буй” [С ба Г 123:12]. Тэд таныг олохын төлөө залбир! Дараа нь сэргэг бай, учир нь талхаар өлсөх, усаар цангах бус харин Их Эзэний үгийг сонсохын төлөө амьдралдаа өлсгөлөн байгаа маш олон хүмүүс энэ дэлхийд байна [Амос 8:11-ийг үз]” (“Witnesses unto Me,” *Ensign*, 2001 оны 5-р сар, 15).

Ахлагч Холландын зөвлөгөөг дагахын тулд танд бэлтгэгдсэн номлогчийн боломжуудыг таньж, үүний дагуу үйлдэхдээ тусламж авахын төлөө Тэнгэрлэг Эцэгт хандан залбирахаар бэлтгэ. Сүмийн гишүүнийхээ хувьд эдэлдэг адислалуудаа хуваалцахад бусдыг урих боломжуудыг эрж хай.


Алма 7:1–13

Алма Гидеоны хүмүүст Есүс Христийн Цагаатгалын тухай заасан нь

Сүмийн идэвхтэй, гишүүн найз нартайгаа наманчлалын талаар ярилцаж байна гэж бод. Найз нар тань өөрсдийгөө ямар нэгэн том нүгэл үйлдсэн гэж бодохгүй байгаа бөгөөд Цагаатгалын хүчийг хэрхэн үнэхээр мэдрэх талаараа гайхан бодож байна. Та найз нартайгаа юу хуваалцаж болох талаар бод. Алма 7:1–13-ыг судлахдаа эдгээр санаануудыг эргэн сана.

Алма Зарахемлаг орхисны дараа Гидеон хот дахь хүмүүстэй ярилцжээ. Алма Гидеон дахь хүмүүсийн дунд ямархуу сүнслэг байдал олно гэж найдаж байсныг мэдэхийн тулд Алма 7:3–6-г унш. Дараа нь Алмагийн найдвар батлагдсан эсэхийг олж мэдэхийн тулд Алма 7:17–19-ийг унш. Дараах мөрүүдэд Гидеоны хүмүүсийн сүнслэг байдлыг дүрсэл: _____

Алма 7:7–10-ыг уншиж, тэдгээр хүмүүсийн мэдэх хэрэгтэй гэж Алмагийн бодсон хамгийн чухал үйл явдлыг болон үүнд бэлдэхийн тулд тэд юу хийх хэрэгтэй байсныг ол.


 **2.** Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултад хариулж бич: Алма яагаад аль хэдийн хүчтэй итгэлтэй болчихсон хүмүүст (Алма 7:17-г үзнэ үү) Аврагчийн ирэлтэд бэлтгэхийн тулд тэд наманчлах хэрэгтэй хэмээн хэлсэн гэж та бодож байна вэ? (Ром 3:23-ыг үзнэ үү.)

Алма Гидеоны хүмүүст дараах чухал зарчмыг заажээ: **Есүс Христ биднийг нүгэл ба үхлээс аврахын тулд мөн мөнх бус байдлын сорилт**

бэрхшээлүүдийг даван туулахад туслахын тулд зовлон шаналлыг амссан билээ. Алма 7:11–13-ыг уншиж, бидний ашиг тусын төлөө Аврагч Өөр “дээрээ авахыг” хүссэн нөхцөлүүдийг судартаа тэмдэглэ.

Сул дорой чанарууд гэдэг нь сул дорой, чадваргүй байдал, өвчин эмгэгтэй гэхчлэн олон өөр утгатай байж болохыг мэдэх нь тустай. *Халамжлах* гэдэг үг нь хэрэгтэй үед эсвэл гай зовлонгийн үед туслах гэсэн утгатай юм. Энэ үгийн Латин хэлний үндэс нь бидэнд туслах Бурханы үлэмж их хүслийг илэрхийлдэг бөгөөд хэн нэгэнд туслах гэсэн утгатай юм.

Та далын гишүүнээр үйлчилж байсан ахлагч Брүс К. Хэйфэний дараах үгсийг судрынхаа Алма 7:11–13-ын хажууд эсвэл судар судлах тэмдэглэлдээ бичих хэрэгтэй: “Цагаатгал нь зөвхөн нүгэлтнүүдийн төлөө бус юм” (“Beauty for Ashes: The Atonement of Jesus Christ,” *Ensign*, 1990 оны 4-р сар, 7). (Алма 7:11–13 нь төгс эзэмших судар юм. Та дараа нь үүнийг амархан олохын тулд тусгайлан тэмдэглэх хэрэгтэй.)


 **3.** Дараах хүснэгт нь Аврагчийн Өөр дээрээ авсан нөхцөлүүдийг дүрсэлсэн Алма 7:11–13 дахь үгсийг агуулдаг. Уг хүснэгтийг судар судлах тэмдэглэлдээ зураад эдгээр үгсээс хэдийг сонгож, та өөрөө эсвэл таны мэддэг хүмүүс эдгээр нөхцөлүүдийг хэрхэн мэдэрч байсан жишээнүүдийг бич. Есүс Христ эдгээр зүйлүүдийг өөр дээрээ авсан гэдэг нь юу гэсэн утгатайг бод.

Өвчин	
Гай зовлон	
Уруу таталт	
Шаналал	
Үхэл	
Сул дорой байдал	
Нүгэл	

Ахлагч Жэффри Р.Холланд Цагаатгал нь бидний ачаа дарамтыг биднээс авч чадна гэсэн дараах гэрчлэлээ хуваалцсан юм:

“Та тамхи, мансууруулах бодис, мөрийтэй тоглоом, эсвэл өнөө үеийн хөнөөлт тахал болох порнографт донтох чөтгөрийн сүнстэй тэмцэж байна уу? Таны гэрлэлт асуудалтай байна уу эсвэл таны хүүхдэд аюул тулгараад байна уу? Та хүйсийн ялгаатай байдлын талаар эргэлзэж байна уу эсвэл өөртөө хүндэтгэлтэй хандахыг эрмэлзэж байна уу? Та өөрөө эсвэл таны хайртай хүн өвчин эмгэг, гутрал цөхрөл, үхэл хагачалтай учраад байна уу? Эдгээр асуудлуудыг шийдвэрлэхийн тулд ямар ч алхам хийх хэрэгтэй байлаа гэсэн *нэн тэргүүнд* Есүс Христийн сайн мэдээнд ирэгтүн. Тэнгэрийн амлалтуудад найд. Энэ талаас нь авч үзвэл Алмагийн гэрчлэл миний гэрчлэл юм. Тэрээр ингэж хэлсэн: ‘Бурханд найдлага тавьсан хэн боловч өөрсдийн зүдгүүрүүдэд, мөн өөрсдийн бэрхшээлүүдэд хийгээд өөрсдийн зовлонгуудад дэмжигдэх болно гэдгийг би мэднэ’ [Алма 36:3].

“Бурханы нигүүлсэнгүй зан чанарт тулгуурлах нь Христийн заасан сайн мэдээний яг гол цөм нь юм. Аврагчийн Цагаатгал нь биднээс зөвхөн бидний нүглүүдийн ачаа дарамтыг авах бус мөн бидний гутрал цөхрөл, гуниг зовлон, сэтгэлийн шаналал болон урам хугаралтын ачаа дарамтыг биднээс авдгийг би гэрчилж байна [Алма 7:11–12-ыг үз]. Ийм тусламжид найдах нь бидний ачаа дарамтыг үгүй болгож, бидний авралыг авчрах хөшүүрэг болдог бөгөөд бидний өсөж хөгжих учир шалтгаан, арга зам нь эхлээд өгөгдсөн байдаг юм” (“Broken Things to Mend,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2006 оны 5-р сар, 70–71).

 **4.** Есүс Христ болон Түүний Цагаатгалаараа дамжуулан таны төлөө хийсэн зүйлийн талаарх мэдрэмжээ судар судлах тэмдэглэлдээ бич. Тэгээд дараах багц асуултуудын нэгэнд эсвэл хоёуланд нь хариул:

- а.** Цагаатгал нь Алма 7:11–13-т Алмагийн дүрсэлсэн аргуудын аль нэгээр танд хэзээ тусалсан бэ? Тэр үед Цагаатгал танд хэрхэн тусалсан бэ?
- б.** Аврагчийн Цагаатгал одоо танд тулгараад байгаа сорилт бэрхшээлийг шийдэхэд хэрхэн тусалж чадах вэ? Та энэхүү сорилттой тулгарах үед Цагаатгалд найдахын тулд юу хийх вэ?

Төгс эзэмших судар—Алма 7:11–13

Алма 7:11–13 нь төгс эзэмших урт судар хэдий ч Цагаатгалын хүч, цар хүрээг амьдралынхаа турш санаж явахад тань туслах тодорхой үгсийг агуулдаг. Та эдгээр түлхүүр үгсийг цээжлэхэд өөртөө туслахын тулд дараах зүйлийг хий. Тусдаа цаасан дээр Алма 7:11–13-ыг дахин хуулж бичихдээ энэ хичээл дээр ашигласан хүснэгтэд байгаа үгсийг орхин бич. Орхиж бичсэн үгсээ судраас харахгүйгээр нөхөж чаддаг болох хүртлээ бичсэн судрын хэсгээ унш. Та дараачийн хэд хоногт эдгээр шүлгүүдийг давтан унших хэрэгтэй. Энэ нь Аврагч таны төлөө мөн




бусдын төлөө бүх амьдралын тань турш юу хийж чадахыг санахад тань туслах болно. Алма 7:11–13-ыг өөртөө эсвэл гэр бүлийн гишүүн, найз нөхдийнхөө нэгэнд нь цээжээр уншиж өгөх эсвэл судар судлах тэмдэглэлдээ бичих маягаар уг төгс эзэмших судрыг цээжилсэн эсэхээ шалга.

Алма 7:14–27

Алма хүмүүсийг Бурханы хаант улсын замаар үргэлжлүүлэн алхахыг уриалав

Алма Гидеон дахь хүмүүсийн сүнслэг нөхцөл байдлыг хэрхэн дүрсэлснийг санахын тулд Алма 7:19-ийг унш. Алма энэхүү чухал зарчмыг зааж байв: **Бид сайн мэдээний зарчмуудаар амьдарснаар Бурханы хаант улс руу хөтлөх замыг дагадаг.** (Бурханы хаант улс гэдэг нь селестиел хаант улс юм.) Алма 7:14–16-гаас Бурханы хаант улс руу удирдах замыг дагахын тулд бид юу *хийх* хэрэгтэйг харуулсан үг хэллэгүүдийг олж, доогуур нь зур. Дараа нь Алма 7:22–25-аас бид уг замыг дагахын тулд ямар *байх* хэрэгтэйг харуулсан үг хэллэгүүдийг олж, доогуур нь зур.

 **5.** Судар судлах тэмдэглэл дээрээ хуудасныхаа зүүн доод булангаас баруун дээд булан руу чиглэсэн нэг зам зур. Замынхаа доод талд *Мөнх бус байдал* гэж, замынхаа дээд талд *Бурханы хаант улс* гэж бич. Таныг Бурханы хаант улс руу удирдахад *хийх* ёстой зүйлүүдээ болон та өөрөө ямар *байх* ёстойгоо замын дагуу бич.



6. Зам дээрээсээ нэг үйлдлийг сонгож, хэн нэгэн үүнийг хэрхэн хийхийг харсан тухайгаа бич. Дараа нь зам дээрээсээ зан чанарын нэг чанарыг сонгож, хэн нэгэн нь хэрхэн ийм байсныг харсан тухайгаа бич. Энэ хоёр зүйлээрээ өсөж хөгжихөд тань туслах зорилго тавь, тэгснээр та нэг өдөр Бурханы хаант улсад орж чадна.

Алма 7:27-г уншиж, хүмүүс итгэл болон сайн үйлүүдээ үргэлжлүүлснээр хүлээн авна гэж Алмагийн мэдэж байсан адислалуудыг олж мэд. Та Бурханы хаант улс руу удирдах замыг итгэлтэйгээр дагавал, та ч мөн эдгээр адислалуудыг хүлээн авч чадна гэдгийг сана.



7. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Алма 6–7-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

15-Р ХЭСЭГ: 4 ДЭХ ӨДӨР

Алма 8–10

Оршил

Алма Зарахемла, Гидеон болон Мелект зааж, олон хүн түүний захиасыг хүлээн авсны дараа Аммонайха дахь хүмүүс түүний захиасыг эсэргүүцэж, түүнийг хотоосоо хөөн гаргав. Гэсэн ч Алма Их Эзэний зарлигт дуулгавартай байж, Аммонайха руу буцжээ. Их Эзэн Алмаг Аммонайхад хүлээн авахад болон хүмүүст сайн мэдээг гэрчлэхэд нь Амюлекийг Алматай нэгдэхэд бэлтгэдэг. Алма, Амюлек хоёр Аммонайхагийн хүмүүст хэрэв тэд наманчлахгүй аваас устгагдах болно гэдгийг анхааруулав. Амюлек Бурханыг итгэлтэйгээр дуулгавартай дагаж, өөрийн нэр хүнд, сайн нөлөөгөө ашиглан бошиглогч Алмаг дэмжин, Есүс Христийг гэрчилдэг.

Алма 8

Алма Амюлекийг номлоход бэлтгэх газар болох Аммонайха руу дуулгавартайгаар буцав

Алма Зарахемла болон Гидеонд сайн мэдээг заасныхаа дараа (Алма 5–7-г үзнэ үү) Мелек рүү явжээ. Алма 8:4–5-ыг уншиж, Мелекийн хүмүүс Алмагийн заасныг хэрхэн хүлээж авсныг олж тогтоо. (Алма 8:4 дэх “Бурханы ариун жаяг” гэсэн хэллэг нь Алма 13-аас таны олж үзэх санваарт хамаатай юм.)

Алма Мелект заахаа төгсгөл болгосныхоо дараа Аммонайхагийн нутагт номлохоор явжээ. Тэр тэнд амьдарч байсан хүмүүсийн тухайд огт өөр зүйлтэй тулгарав. Дараах зургууд болон судрын хэсгүүдийг судалж, дараа нь Аммонайхад байх хугацаанд нь Алмад юу тохиолдсон талаар товч тайлбар зураг болон судар бүрийн талаар бич.



Алма 8:8–13. _____



Алма 8:14–16. _____



Алма 8:18–26. _____

Дараах асуултуудыг бодож үз (та хариултуудаа бичих шаардлагагүй):

- Алмад үзэгдсэн тэнгэр элч бол өмнө нь түүнд болон Мозаягийн хөвгүүдэд үзэгдсэн тэнгэр элч юм. Тэнгэр элчийн үгс Алмаг хэрхэн тайвшруулсан байж болох вэ (Алма 8:15-ыг үзнэ үү)?
- Алма Аммонайха руу буцаж очиход яагаад хэцүү байсан байж болох вэ (Алма 8:16-г үзнэ үү)?

Алма уг зарлигийн хэцүүг эс хайхран “Аммонайха нутгийн зүг хурдан эргэлээ” (Алма 8:18) Ерөнхийлөгч Ховард В.Хантэр Их Эзэн ийм дуулгавартай байдалд дуртай гэж заажээ: “Их Эзэн Өөрийнх нь зөвлөгөөнд дуулгавартай байх шийдвэр төгс байдалд юу юунаас илүү дуртай.” (“Commitment to God,” *Ensign*, 1982 оны 11-р сар, 58).



1. Дараах нөхцөл байдлуудаас нэгийг эсвэл илүү олныг сонго. Дараа нь тухайн хувь хүн дуулгавартай байсан бол хэрхэн адислагдаж болох байсныг судар судлах тэмдэглэлдээ бич:

а. Нэгэн залуу эмэгтэйг сургуульдаа явахад нь ээж нь түүнээс илүү даруухан, зохистой цамц өмсөхийг хүсчээ.

б. Шинээр пристийн албанд томилогдсон залуу эрэгтэйг бишоп нь эсвэл салбарын ерөнхийлөгч нь Бурханы өмнө хүлээсэн үүргийн шагналыг авахаар хичээн чармайхад урив.

в. Хоёр номлогч сүмийн гишүүн биш ээжтэй нэгэн идэвх султай гэр бүлтэй очиж уулзах хэрэгтэйгээ мэдэрчээ.

Та судартаа Алма 8:18–20-ийн хажууд дараах зарчмыг бичих хэрэгтэй: **Хэрэв бид Их Эзэний үгэнд хурдан хариу өгвөл, Тэр бидэнд Өөрийнхөө зарлигуудыг биелүүлэхэд туслах болно.**



2. Таныг бэрхшээлтэй нөхцөл байдлуудыг эс хайхран, зөв шударга, дуулгавартай байхад тань Их Эзэн тусалсан талаар судар судлах тэмдэглэлдээ бич.

Алма 8:27–32-ыг уншиж, Алма зарлигдуулсан зүйлсээ хийхэд Их Эзэн түүнд тусалсан олон арга замуудыг олж мэд.

Алма 9

Алма Аммонайхагийн хүмүүсийг наманчилж, Есүс Христийн ирэлтэд бэлтгэхийг анхааруулжээ.

Алма 9-д Аммонайхагийн хүмүүст тэд наманчлах хэрэгтэйг болон Аврагч, Есүс Христээр дамжуулан гэтэлгэгдэх болно гэдгийг заасан Алмагийн хүч чармайлтын тухай өгүүлдэг. Алма эдгээр ёс бус хүмүүст наманчлах хэрэгтэйгээ ойлгоход нь туслахыг хичээж, тэдний төлөө болон тэдний өвөг дээдсийн төлөө Бурхан юу хийснийг сануулахын тулд тэднийг дууддаг.

Алма 9:8–10, 13-аас сана болон мартав гэсэн үгсийн давталтыг хар. Аммонайхагийн оршин суугчид Алмагийн ярьсан зүйлсийг санасан бол тэд одоо байгаагаасаа хэр зэрэг өөр байх байсан гэж та бодож байна?



3. Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултад хариулж бич: Урьд нь өөртөө тохиолдсон сүнслэг туршлагаа санаж байх нь яагаад чухал гэж та боддог вэ? Дараа нь мартахагүй байхыг хүсдэг нэг сүнслэг туршлагынхаа тухай бич.

Алма Аммонайха дахь хүмүүсийг наманчлалд дуудсаныхаа дараа Аврагч дэлхийд ирэхэд бэлтгэх ёстойг тэдэнд заав. Алма 9:26–27-г уншиж, Аврагчийн зан чанаруудыг илүү сайн ойлгоход тань туслах үг хэллэгүүдийг тэмдэглэ. (*Тэгш эрх* гэдэг үг нь шударга байдал, шударга ёс гэсэн утгатай.) Эдгээр үг, хэллэгүүд Аврагчийн талаар танд юу зааж байна вэ? Ирэх долоо хоногийн турш эдгээр үг хэллэгүүдийн талаар бодох цагийг өөртөө гарга.

Алма 10

Амюлек тэнгэр элчийг үзсэн туршлагаа дүрсэлж, хүмүүсийг наманчлахад уриалав

Таныг өнөө өглөө хэрхэн сэрснийг хамгийн сайн дүрсэлж байгаа өгүүлбэрийг дугуйл:

- Би сэрүүлэг ашиглалгүйгээр эсвэл хэн нэгнээр дуудуулалгүйгээр өөрөө сэрсэн.
- Би сэрүүлгээ эхний удаа дуугарахад эсвэл хэн нэгэн намайг эхний удаа дуудахад сэрсэн.
- Намайг сэрэхээс өмнө сэрүүлэг хэд хэдэн удаа дуугарсан эсвэл хэн нэгэн намайг хэд хэдэн удаа дуудсан.

Алма 10:6-г уншиж, Амюлек Их Эзэнийг эсэргүүцэхдээ хэдэн удаа сүнсний “сэрэх дуудлагыг” хүлээн авсныг олж мэд. Дараах асуултын хариуг өгөгдсөн мөрөнд бич: “Би сонсохоос татгалзсан,” “Би мэдэхийг хүссэнгүй” гэсэн хэллэгүүд нь Амюлек дээр тэнгэр элч ирснээс өмнөх түүний сүнслэг нөхцөл байдал ямар байсныг илэрхийлж байна вэ? _____

Алма 10:2–11-д цэдэглэснээр Амюлек тэнгэр элч түүн дээр зочилж, сайн мэдээнд хөрвөгдөхөөс өмнөх амьдралаа дүрсэлжээ. Алма 10:1–6-гаас Амюлекийн талаар дэлгэрэнгүй мэдэхэд тань туслах нарийн мэдээллийг эрж ол.

Амюлек тэнгэр элч өөрийг нь Алмаг гэртээ хүлээн авч, анхаарал халамж тавихад хэрхэн удирдсаныг яриу. Алма 10:7–11-ийг уншиж, Амюлек тэнгэр элчийг дуулгавартай дагасан учраас Амюлек болон бусад хүмүүс хэрхэн адислагдсаныг олж мэд.

Энэ зарчмыг Алма 10:11–12-ын хажууд бич: **Их Эзэн биднийг дуудахад сонсож, дуулгавартай байсан үед адислалууд нь бидний болон бусдын дээр ирдэг юм.** Их Эзэн Сүнсний өдөөлтөөр, мэдрэмжээр, зүүдээр, сүмийн удирдагч, багш эсвэл бидний эцэг эхийн үгсээр, сүмийн ажлуудад дуудагдсанаар, зовлон бэрхшээлээр, эсвэл бусад арга замуудаар дамжуулан биднийг “дуудаж” болох олон арга замууд байдаг.



4. Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултад хариул: Их Эзэний “дуудлагыг” дуулгавартай дагасан учраас адислагдсанаа та хэзээ мэдэрсэн бэ?

Алма 10-р бүлгийн үлдсэн хэсэг нь Аммонайхагийн олон хүмүүс Амюлекийн үгсийг сонсохоос татгалзсан тухай өгүүлдэг. Хэрэв тэд наманчлахгүй аваас тэд устгагдсан байх өдөр ирэх болно гэдгийг хүмүүст анхааруулав. Алма 10:22–23-ыг уншиж, тэдгээр хүмүүс тэр үеийн устгалаас яагаад аврагдсаныг олж мэд. Эдгээр шүлгүүд таны эргэн тойрндахь хүмүүс зөв шударга биш байсан ч та өөрөө зөв шударга байх нь чухал болох талаар танд юу зааж байна вэ?

5. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Алма 8–10-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

16-Р ХЭСЭГ: 1 ДЭХ ӨДӨР

Алма 11

Оршил

Амюлек өөрөөр нь үнэн бөгөөд амьд Бурханыг үгүйсгүүлэхийг оролдсон хуульч Зиезромтой маргалдав. Түүнийг урхиндаа оруулах гэсэн Зиезромын оролдлогын эсрэг Амюлек итгэлээ хамгаалан, нүглээс аврагдах аврал нь зөвхөн Есүс Христээр ирдгийг гэрчилжээ. Амюлек бүх хүн төрөлхтөн амилуулагдаж, Бурханаар шүүгдэх болно гэсэн

хүчтэй гэрчлэлийг хуваалцсан ажээ. Та Аврагчийн Цагаатгалын улмаас нэгэн өдөр амилуулагдаж, дэлхий дээр хэрхэн амьдарснаа тайлагнахаар Бурханы өмнө зогсох болно.

Алма 11:1–25

Бурхан оршдогийг үгүйсгэсэн Зиезромын уруу таталтыг Амюлек эсэргүүцэв

Өөртөө байдаг, хэзээ ч зарахгүй тийм их үнэ цэнэтэй нэг зүйлийг бод. Энэ нь яагаад танд тийм их үнэ цэнэтэйг бод. Алма 11-т Алма, Амюлек хоёр Аммонайхагийн хүмүүст үргэлжлүүлэн зааж байх үед, Зиезром хэмээх нэгэн ёс бус хуульч Амюлектэй сөргөлдөж, Амюлект их үнэтэй нэг зүйлийг нь мөнгөөр авахыг санал болгодог. Судруудад Зиезромыг “чөтгөрийн аргуудад мэргэшсэн хүн байв” гэж дүрсэлдэг (Алма 11:21), энэ нь тэрээр бусдыг зөв шударга, үнэн байдлаас хөндийрүүлэхдээ Сатаны ашигладагтай адилхан арга барил, төлөвлөгөө, хууран мэхлэлт болон заль мэхийг хэрхэн ашиглахад суралцсан гэсэн утгатай юм.

Алма 11:21–22-ыг судалж, Зиезром Амюлект хэр зэрэг их мөнгө санал болгосон болон үүний хариуд тэрээр Амюлекийг юу хийхийг хүссэнийг олж мэд. “Онтай” нь нифайчуудын хамгийн үнэтэй мөнгөн зоос байжээ (Алма 11:6, 11–13-ыг үзнэ үү). Нэг онтай нь ойролцоогоор шүүгчийн нэг долоо хоногийн хөдөлмөрийн хөлстэй тэнцдэг байв (Алма 11:3-ыг үзнэ үү).

Дараах асуултуудад хариул:

- Амюлект санал болгосон шиг дэлхийн хууран мэхлэлтүүдийг хэн нэгэн эсэргүүцэхийг та хэзээ харсан бэ? _____
- Үүнийг харснаар энэ нь таныг итгэлтэй байхад хэрхэн нөлөөлсөн бэ? _____

Зиезромын саналд Амюлек хэрхэн хариулсныг харахын тулд Алма 11:23–25-ыг унш. Тэгээд гарын авлага дээрээ дараах асуултуудад хариулан бич:

- Амюлек яагаад Зиезромын саналыг хүлээж аваагүй гэж та бодож байна вэ? _____
- Алма 11:25-д өгүүлснээр Зиезром Амюлект зургаан онтай санал болгосон нь ямар санаа агуулж байсан бэ? _____

- Энэ нь хүмүүс Сатаны уруу таталтуудад бууж өгөх үед түүний хийдэг зүйлүүдтэй юугаараа адилхан бэ? _____



1. Дараах дасгалуудыг судар судлах тэмдэглэлдээ гүйцээж хий:

а. Амюлек Зиезромын саналыг хэрхэн эсэргүүцсэнийг илүү сайн ойлгохын тулд Алма 11:22-ыг уншиж, дараах өгүүлбэрийг гүйцээ: *“Би Их Эзэний сүнсний эсрэг юу ч _____ ёсгүй.”* Дараа нь үнэн тодорхойлолт өгч болох гурав эсвэл дөрвөн үгийг хоосон зайд бич. (жишээ нь, *хийх, унших, өмсөх, үзэх, болон бичих* зэрэг байж болно).

б. Та Ариун Сүнсний тусламжтайгаар уруу таталтыг хэрхэн ялж болохыг санахад тань тусалж чадах нэг өгүүлбэрийг Алма 11:22-р шүлэг дээр тулгуурлан бич. **Бид Ариун Сүнсэнд найдсанаар уруу таталтуудыг ялж чадна** гэсэн үгнийг та өөрийн үгээр илэрхийлэх хэрэгтэй.

Суралцах явцдаа түр зогсож, дараах асуултыг тунгаан бод: Би тийм байдлаар амьдарснаар хэрхэн Ариун Сүнсийг мэдрэхдээ илүү сайн байж, надад уруу таталтыг давахад туслах түүний өдөөлтүүдийг дагах вэ?

Арванхоёр төлөөлөгчийн чуулгын Ерөнхийлөгч Бойд К.Пакэрын дараах зөвлөгөөг уншиж, Ариун Сүнсэнд найдах нь уруу таталтыг давахад тань хэрхэн тусалж чадахыг хар.



“Хэрэв та орох ёсгүй зүйл рүү гулсан орж байгаа бол эсвэл таныг буруу зам руу хөтөлж байгаа хүмүүстэй нийлж байгаа бол энэ нь таны хувьд өөрийн бие даасан байдал, сонгох эрхээ хамгаалан тэмцэх цаг болжээ гэсэн үг юм.

Сүнсний дуу хоолойг сонс, тэгвэл та замаа алдахгүй байх болно. . . .

“. . . Их Эзэний үйлчлэгчийн хувьд, би танд, хэрэв та Ариун Сүнснээс ирдэг өдөөлтүүдэд анхаарлаа хандуулах юм бол дайсны дайралтаас хамгаалагдах болно гэдгийг амлаж байна” (*“Counsel to Youth,” Ensign* буюу *Лиакхона*, 2011 оны 11-р сар, 18).



2. Сурсан зүйлүүдээ хэрхэн хэрэгжүүлж болохыг бодож үзэхийн тулд судар судлах тэмдэглэлдээ дараах асуултуудад хариул:

а. Өсвөр үеийнхэн гэрчлэлээ сулруулахад уруу татагдах эсвэл дэлхийн зүйлүүдийн төлөө гэрчлэлдээ хайхрамжгүй хандах ямар тохиолдлууд байдаг вэ?

б. Хамт суралцагч тань иймэрхүү төрлийн уруу таталтуудтай тулгарах үед Ариун Сүнсэнд найдахад нь тусалж болох ямар санаануудыг та түүнд хэлж болох вэ?

Дараагийн удаа итгэл эсвэл жишгээ бууруулах уруу таталтад орох үедээ Амюлекийн үлгэр жишээг санаж,

сурсан зүйлээ хэрэгжүүл. Та зохистой амьдарч, Ариун Сүнсний өдөөлтүүдийг дагаснаар илүү агуу итгэл болон баталгааг мэдэрч чадна гэдгийг санагтун.

Алма 11:26–40

Амюлек Бурханы Хүүг гэрчилж, түүний үгийг үгүйсгэхийг оролдсон Зиезромыг ялав

Зиезром Амюлекийн Есүс Христэд итгэх итгэлийг дайрч давшлав. Амюлекээр Бурхан оршдогийг үгүйсгүүлэх гэсэн Зиезромын оролдлого талаар болсны дараа энэхүү үйл явдалтай өөрийгөө холбож, таны итгэлийг хэн нэгэн эсэргүүцэж байсан үеийн тухай бод. Алма 11:26–34 дэх Амюлек, Зиезром нарын харилцан яриаг уншиж, дараа нь Зиезром Амюлекийн үгсийг хэрхэн гуйвуулсныг Алма 11:35-аас унш.

Энэхүү хуурмаг яриаг Амюлек хэрхэн залруулсныг Алма 11:36–37-гоос унш. Та судартаа зүүвэр тайлбар 34а-г тэмдэглэж мөн Хиламан 5:10–11-ийг унших хэрэгтэй. Дараа нь “өөрсдийн нүглүүд-эд” аврагдах болон “өөрсдийн нүглүүд-ээс” аврагдах хоёрын ялгааг өөрийн үгээр тайлбарла (налуу бичлэг нэмэгдсэн): _____

Алма 11:40-ийг уншиж, хүмүүс нүглүүдээсээ аврагдахын тулд тэд хийх ёстой гэж Амюлекийн хэлсэн эхний алхмыг тодорхойл. Зарим хүмүүс Есүс Христэд итгэдэг гэх боловч, зан байдлаа өөрчлөхийг хүсдэггүй. Есүс Христийн нэрэнд итгэх гэдэг нь түүнд итгэх гэсэн утгатай юм.



“Түүний нэрэнд итгэх” (Есүс Христэд итгэх итгэлтэй байх)-ийг илүү сайн ойлгох нь наманчлал руу хөтөлдөг, Тэргүүн зөвлөлийн Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорфын дараах эшлэлийг унш: “Бид наманчлах боломжтой

байхын тулд Христэд итгэх бат итгэлтэй байх хэрэгтэй. Бидний итгэл ‘[Бурханы] зан чанар, төгс байдал, шинж чанарын зөв ойлголтыг багтаадаг’ (*Lectures on Faith* [1985], 38). Хэрэв бид Бурхан бүх зүйлийг мэддэг, бүхнийг хайрладаг, нигүүлсэнгүй гэдэгт итгэвэл авралынхаа төлөө Түүнд огтхон ч эргэлзээгүйгээр найдвараа тавих боломжтой байх


Хэрэгжүүлэлт

Сайн мэдээний зарчмуудын мэдлэгийг хүлээн авсан ч, үүнийг үйлдлээр хэрэгжүүлэхгүй бол сурч мэдсэн зүйл нь бүрэн биш бөгөөд тухайн хүн дээр Сүнс ажиллахаа больж болох юм. Та сурсан зүйлээ зүрх сэтгэл, оюун ухаандаа хүлээн зөвшөөрч, тэрхүү үгнээ дагуу үйлдэж, амьдрах үед сурч мэдсэн зүйлээ хэрэгжүүлж байгаа нь тэр.



болно. Христэд итгэх итгэл нь Бурханы хүсэлтэй нийцдэггүй бидний бодол санаа, итгэл бишрэл, зан төлөвийг өөрчлөх болно” (“Point of Safe Return,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2007 оны 5-р сар, 100).

Есүс Христэд итгэх итгэл нь бодол санаа, итгэл бишрэл, зан төлөвөө өөрчлөхөд тань хэрхэн нөлөөлдөг вэ?


 **3.** Хүн наманчлахад яагаад түүнд Есүс Христэд итгэх итгэл хэрэгтэй байдаг вэ? Та Амюлек болон


Ерөнхийлөгч Угдорфоос сурсан зүйлүүдээ ашиглан дараах зарчмыг хэрхэн тайлбарлахаа судар судлах тэмдэглэлдээ бич: **Есүс Христэд итгэх жинхэнэ итгэл нь бид нүглүүдийнхээ гэтэлгэлийг хүлээн авах үйл явцын эхлэл юм.**

Алма 11:41–46

Амюлек бүх хүн төрөлхтний амилуулалт, шүүлтийн талаар заасан нь

Зиезромд хэлсэн Амюлекийн гэрчлэлийн төгсгөлийг уншихаасаа өмнө, дараах асуултыг тунгаан бод: Үхлийн дараах амьдралд итгэхгүй байх нь тухайн хүний үйлдэлд хэрхэн нөлөөлөх вэ?

 **4.** *Амилуулалт, Шүүлт* гэсэн үгсийг судар судлах тэмдэглэлдээ хоёр тусдаа баганын гарчиг болгон бич. Дараа нь Алма 11:41–45-аас амилуулалт болон шүүлтийн тухай мэдээллийг олж, гарчиг бүрийн доор сурч мэдсэн зүйлээ бич. Та дараах өгүүлбэрийг судрынхаа хуудасны дээд талд эсвэл судар судлах тэмдэглэлдээ бичих хэрэгтэй: **Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан бүх хүмүүн амилуулагдаж, ажлуудаараа шүүгдэх болно.** Мөн эдгээр шүлгүүд нь *амилуулалт* бол бидний бие махбод сүнстэйгээ “төгс хэлбэртээ,” “зохих байдлаараа” дахин хэзээ ч салахгүйгээр нэгдэх гэсэн утгатай гэдгийг заадаг (Алма 11:43, 45-ыг үзнэ үү).

 **5.** Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултуудын нэгэнд эсвэл хоёуланд нь хариулж бич:

a. Амилуулагдаж, шүүгдэх болно гэж бодох үед танд ямар бодол, мэдрэмж төрдөг вэ?

б. Амилуулагдаж, шүүгдэх болно гэсэн таны итгэл өдөр бүр амьдралдаа хийдэг сонголтуудад тань хэрхэн нөлөөлдөг вэ?

 **6.** Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Алма 11-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

16-Р ХЭСЭГ: 2 ДАХЬ ӨДӨР

Алма 12

Оршил


Алма 11-р бүлэгт Амюлекийн үгс Зиезромыг хүмүүст худал ярьж, хууран мэхэлсэн гэм нүглээ ухамсарлах болгов. Амюлек Аммонайхагийн хүмүүст ярихаа төгсгөл болгосны дараа Алма тэдний өмнө босч зогсов. Аммонайхагийн хүмүүс даруусгагдсаны учир Алма тэднийг зүрх сэтгэлийн хатуурал болон бусад нүглүүдээ наманчлахад нь туслах зарчмуудад

анхаарал төвлөрүүлэн ярив. Тэрээр Сатаны урхины талаар мөн шүүлт нь ёс бусчууд дээр ирдэг бөгөөд Бурханы Хүүгээр бэлтгэгдсэн гэтэлгэлийн төлөвлөгөө нь Бурханы оршихуйд эргэн очих боломжийг наманчилсан хүмүүст олгодгийг тодотгон ярьжээ.

Алма 12:1–7

Алма Зиезромын ёс бус зорилгыг илчилсэн нь

Урхиар амьтан яаж барьдгийг бод: Урхины гогцоог өгөөшний гадуур тойруулан тавьдаг. Амьтан өгөөшийг идэхээр гогцоо гарган тавьсан урхинд ороход урхи нь чангарч амьтныг барьдаг,



Алма 11:21–25-д Зиезром Амюлекийг хэрхэн урхинд оруулах гэж оролдсонг дахин хар. Амюлек Зиезромын зорилгыг мэдэж, түүнд хариу өгсний дараа Алма босч, Зиезромд хандан эргэн тойрны хүмүүст сонсогдохоор ярив (Алма 12:1–2-ыг үзнэ үү). Алма 12:3–6-д чөтгөрөөс ирсэн гэж Алмагийн хэлсэн Зиезромын арга барилыг дүрслэхдээ Алмагийн ашигласан үг хэллэгүүдийг ол (Алма 12:5-ыг үзнэ үү).

Алма 12:3-т цэдэглэснээр Алма Зиезромын төлөвлөгөөг хэрхэн мэдсэн бэ? _____

Алма 12:6-д чөтгөрийн зорилго нь юу гэж Алма хэлсэн бэ? _____

Ариун Сүнс бидэнд дайсны уруу таталтыг танихад тусалж чадна гэдгийг Алма заасан.

Та бид Алма 11-р бүлгийн хичээлээс Ариун Сүнсэнд найдвал, уруу таталтуудыг даван туулж чадна гэдгийг суралцлаа. Уруу таталтыг даван туулахын нэгэн чухал арга зам нь уруу таталт болон түүнээс учирч болох хор уршгийг танихад бидэнд тусалдаг Сүнс тэй хамт байх явдал юм. Тэгээд бид уруу таталтаас зайлсхийснээр цэвэр ариун бөгөөд итгэлтэй байхыг сонгож чадна. Ариун Сүнс чөтгөрийн уруу таталтуудыг таньж, зайлсхийхэд тань тусалсан туршлага танд байдаг уу?



1. Дайсны “урхийг” таньж, зайлсхийхэд тань туслах Ариун Сүнсний шивнээг сонсож, ажиллах чадвараа сайжруулахын тулд юу хийж болохоо мөн юу хийхээ судар судлах тэмдэглэлдээ бич.

Алма 12:7–18

Алма бүх хүн төрөлхтний эцсийн шүүлтийн талаар заасан нь

Сонирхдог ажил мэргэжлийнхээ тухай бод. Уг ажил мэргэжлээр амжилт олоход тань шаардлагатай мэдлэгийг эзэмшихийн тулд хэр зэрэг их төлбөрийг (сургалтын төлбөр) сургуульд эсвэл сургалтын хөтөлбөрт төлөх хэрэгтэйг тооцоол.



Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Дэвид А.Беднарын хэлсэн дараах эшлэлийг уншиж, сүнсний мэдлэгийг эзэмшихийн тулд төлөх шаардлагатай “төлбөр”-ийг хайж ол: “Таны болон миний зүрх сэтгэлд үнэн хэмээн

нотлогдож, биднийг адисалсан сүнслэг ойлголтыг [бусдад] өгөх боломжгүй юм. Ийм мэдлэгийг олж авч, хувиараа ‘эзэмших’-ийн тулд төлбөр төлөх ёстой бөгөөд энэ нь хичээл зүтгэл болон итгэлээр судалж суралцах явдал юм. Зөвхөн ийм арга замаар оюун ухаанд мэдэгдсэн зүйл нь зүрхэнд мэдрэгдэх боломжтой юм” (“Бүх хичээл зүтгэлээрээ харах нь,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2010 оны 5-р сар, 43).

Алма 12:7–8 дахь сүнсний мэдлэгийг олж авахад хэрэгтэй сүнслэг “төлбөр”-ийг Зиезром төлөх хүсэлтэй болсон тухай нотолгоог ол. Зиезром зүрхээ өөрчилж эхэлснээр сүнслэг зүйлүүдэд суралцаж чадна гэдгийг гэрчилж байгаа ямар зүйлүүдийг та харж байна вэ?


Алма 12:9–11-ийг уншиж, Алма Зиезромд сүнслэг мэдлэгийг олж авах талаар юу заасныг олж мэд. “Бурханы нууцууд бол зөвхөн илчлэлтээр мэдэгддэг сүнслэг үнэнүүд юм. Бурхан Өөрийнхөө нууцуудыг сайн мэдээнд дуулгавартай тэдэнд илчилдэг” гэдгийг мэдэх нь тустай байж болно” (Судруудын удирдамж, “Бурханы нууцууд,” scriptures.lds.org). Та энэ тодорхойлолтыг судартаа Алма 12:9-ийн хажууд бичих хэрэгтэй. Алма 12:9-д Бурхан Өөрийн үгийн нэг хэсгийг хүмүүнд юуны дагуу өгөх болно гэж Алма тайлбарласан бэ? _____

Алма 12:10–11-т цэдэглэснээр зүрх сэтгэлийн нөхцөл байдал болон сүнслэг үнэнүүдийг хүлээн авах хоёрын хооронд ямар уялдаа холбоо байдаг вэ? _____

Зүрхээ “хатууруулах” гэдэг нь юу гэсэн утгатай болох мөн (Алма 12:10–11-ийг үзнэ үү) хэн нэгний амьдралд ийм зүйл тохиолдвол та үүнийг юу гэж бодох вэ? _____

Зиезромд өгсөн Алмагийн захиас нь дараах зарчмыг заадаг: **Их Эзэн сүнсний үнэнүүдийг Түүний**


үгсэд бид хэр зэрэг анхааралтай, хэр зэрэг шаргуу хичээл зүтгэлтэй ханддагийн дагуу илчилдэг.

 **2.** Та “анхаарал болон шаргуу хичээл зүтгэл”-ээ хандуулан дагахыг хичээж буй Их Эзэний зарлиг эсвэл Түүний зөвлөгөөний тухай судар судлах тэмдэглэлдээ бич. Их Эзэн таныг Өөрийнх нь заасан зүйлийг хэрэгжүүлсэн учраас хэрхэн нэмэлт удирдамж, ойлголт эсвэл Өөрийн Сүнсний шивнээгээр адисалсан бэ?

Бид сүнслэг үнэнийг хэрхэн мэдэж авдгийг Алма тайлбарласныхаа дараа Алма 12:8-д бид хэрхэн шүүгдэх талаар асуусан Зиезромын асуултад хариулдаг. Алма 12:12–15-д Алма Зиезромд амилуулалт ба шүүлтийн талаар юу заасныг ол. Дараах зайнуудыг бөглө: **Бид Бурханы өмнө өөрсдийн болон** _____ **ныхаа төлөө хариуцлага хүлээх болно.**

Дараах асуултыг тунгаан бод: Та үг, үйлдэл болон бодол санааныхаа төлөө хариуцлага хүлээх болно гэдгээ санах нь таны өдөр тутмын сонголтуудад ямар өөрчлөлт гаргах вэ?

Зүүвэр тайлбар 14a дахь холбогдох эшлэл болох төгс эзэмших судрын хэсэг Мозая 4:30-ийг тэмдэглэ, дараа нь Мозая 4:30-ийг цээжээр эсвэл харж унш.


 **3.** Судар судлах тэмдэглэлдээ Ариун Сүнсийг мэдрэхдээ хэрхэн илүү сайн байх талаар өнөөдрийн хичээлийн 1-р даалгавар дээр бичсэн зүйлээ эргэн хар. Бурханы өмнө хүлээсэн хувийн хариуцлагаа ойлгох нь уруу таталтыг таньж мөн зайлсхийх хүслийг тань хэрхэн нэмэгдүүлэх талаар өөрийнхөө бодлыг нэмж бич.

Алма 12:19–37

Алма хүн төрөлхтөн хэрхэн гэтэлгэлийн төлөвлөгөөгөөр дамжуулан уналтын үр дагавруудыг даван туулж чадахыг тайлбарлав

Аммонайха дахь ерөнхий захирагч Антиона хүмүүн үхэшгүй болж чадна гэдэгт итгэхгүй байв. Учир нь Уналт үүнийг боломжгүй болгосон хэмээн дурдав (Алма 12:20–21-ийг үзнэ үү). Дараах хүснэгтэд жагсаасан Алма 12-р бүлгийн шүлгүүдийг уншиж, гарчгийн доорх багануудад Алмагийн заасан зүйлсийг бич.

Уналтын үр дагаврууд (Алма 12:22, 24)	Бурхан бидний гэтэлгэлийг авчрахын тулд юу хийсэн бэ? (Алма 12:24–25, 28–33)	Бид гэтэлгэгдэхийн тулд юу хийх ёстой вэ? (Алма 12:24, 30, 34, 37)

 **4.** Хүснэгтийг бөглөж дуусаад, судар судлах тэмдэглэлдээ дараах асуултуудад хариул:

а. Уналтын үр дагавруудыг даван туулахад Есүс Христийн Цагаатгал бидэнд хэрхэн тусалдаг вэ?



6. Алма 12:24-т уналтын үр дагавруудыг даван туулах явдлыг Аврагч боломжтой болгосон гэж гардаг. Тэгэхээр Алмагийн зааснаар амьдралын зорилго юу байсан бэ?



Алма 12:24-т байгаа “сорилтын нөхцөл” гэсэн хэллэгийг Мормоны Номд зөвхөн Алма ашигласан байдаг (мөн Алма 42:4, 10, 13-ыг үзнэ үү). Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч

Л.Том Пэрри энэхүү сорилтын цагийг ингэж тайлбарлажээ: “Дэлхийн амьдралын үндсэн зорилго нь дэлхийн үүслээс өмнө оршиж байсан бидний сүнсэнд агуу боломж бүхий мөнх бус амьдралын турш бие махбодтойгоо нэгдэх боломжийг олгох явдал мөн. Бид зөвхөн сүнс ба бие махбодын нэгдэлд байснаараа өсч хөгжих, сурч боловсрох, төлөвших боломжтой юм. Сүнс ба бие махбодын нэгдэл энэхүү боломжийг бидэнд олгодог билээ. Бие махбодтойгоор бид оршин байгаа сорилтын байдалдаа тодорхой хэмжээний бэрхшээлдүүдийг туулдаг. Энэ нь бид өөрсдийгөө мөнхийн боломжуудыг хүлээн авахуйц зохистой гэдгээ батлан харуулахын тулд суралцах мөн соригдох үе юм. Энэ бүхэн нь бидний Эцэгийн хүүхдүүддээ зориулсан бурханлаг төлөвлөгөөний нэг хэсэг юм” (“Proclaim My Gospel from Land to Land,” *Ensign*, 1989 оны 5-р сар, 14).

Алма **мөнх бус амьдрал бол бидний хувьд Бурхантай уулзахаар бэлтгэх цаг юм гэж гэрчилдэг.** Та энэ сургаалыг зааж байгаа Алма 12:24 дэх хэллэгүүдийг тэмдэглэх хэрэгтэй. Алма 34:32-ыг Алма 12:24-ийн холбогдох эшлэлтэй хамт унш.



5. Сурч мэдсэн зүйлээ хэрэгжүүлэхийн тулд судар судлах тэмдэглэлдээ дараах асуултуудын нэгэнд нь эсвэл хоёуланд нь хариулж бич:

а. Мөнх бус амьдралын зорилгыг мэдэх нь амьдралаа авч явахад тань хэрхэн тусалдаг вэ?

б. Есүс Христийн Цагаатгалд итгэх итгэл тань энэхүү мөнх бус сорилтын үед хэрхэн тусалдаг вэ?

Алма 12:33–35-ыг уншиж, наманчилдаг болон наманчилдаггүй хүмүүст тохиолдох зүйлүүдийн ялгааг ажигла. Их Эзэний амралтад орох гэдэг нь нүглүүдийнхээ уучлалыг хүлээн авч, эцэст нь Их Эзэний оршихуйн алдар сууд орохыг багтаадаг гэдгийг мэдэх нь эдгээр шүлгүүдийг илүү сайн ойлгоход тань тусалж болох юм (С ба Г 84:24-ийг үзнэ үү).



6. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Алма 12-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

16-Р ХЭСЭГ: 3 ДАХЬ ӨДӨР

Алма 13

Оршил

Алма хүмүүсийг наманчилж, Их Эзэний амралтад ороход нь туслахын тулд Мелкезедек санваарт томилогдсон дээд пристүүдийн талаар Аммонайхагийн эсэргүүцэгч хүмүүст заав. Тэрээр хүмүүстээ наманчлахад нь болон амар амгаланд ороход нь тусалсан Мелкезедекийн үлгэр жишээг яриу. Алма Аммонайхагийн хүмүүст итгэл найдвараар дүүрэн байж, Их Эзэний амралтад ороход бэлтгэгдэж болохын тулд өөрчлөгдөхөд нь туслан гэдэнд заахыг хичээв.

Алма 13:1–12

Алма Аммонайхагийн хүмүүст дээд пристүүдийн дуудлагын тухай заасан нь



1. Дараах эшлэлийг уншаад асуултуудад хариул:

“Бурхан мөнх бус байдлын өмнөх сүнсний дэлхийд зарим сүнснүүдийг мөнх бус амьдралынх нь үед онцгой үүрэг гүйцэтгүүлэхээр томилсон юм. Үүнийг урьдчилсан томилолт гэдэг.

“Урьдчилсан томилолт нь хувь хүмүүс тодорхой дуудлага эсвэл ажил үүрэг хүлээж авна гэсэн баталгаа биш юм. Мөнх бус байдлын өмнөх амьдрал дахь зөв шударга байдлын үр дүнд урьдчилсан томилолт ирсэн шиг сонгох эрхээ зөв шударга ашигласны үр дүнд энэ амьдралд ч мөн тийм боломжууд ирдэг” (*True to the Faith: A Gospel Reference* [2004], 69).

а. Мөнх бус байдлын өмнөх амьдралд хийгдсэн сонголтууд болон урьдчилсан томилолт хоёр хоорондоо ямар холбоотой вэ?

б. Мөнх бус амьдралын үед хийсэн сонголтууд урьдчилсан томилолтод хэрхэн нөлөөлдөг вэ?

Хэдийгээр Алма 13-т санваар атгагчдын талаар яригдаж байгаа ч, Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимбалл мөнх бус байдлын өмнөх амьдралд эгч нарт ч мөн хүндтэй дуудлагууд өгөгдсөнийг бидэнд ийн сануулжээ: “Биднийг энд ирэхээс урьд, өмнөх дэлхийд итгэлтэй эрэгтэйчүүд санваарын тодорхой үүргүүдэд урьдчилан томилогдсон хэдий ч итгэлтэй эмэгтэйчүүдэд ч бас тодорхой үүргүүд өгөгдсөн гэдгийг санаарай” (“The Role of Righteous Women,” *Ensign*, 1979 оны 11-р сар, 102).

Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Нийл А. Максвэлл заасан нь: “Мөнх бус байдлын өмнөх амьдрал нь амар тайван байх талаар сургаал биш юм. Бидний хүн нэг бүрд хийх ёстой сонголтууд, биелүүлэх ёстой байнгын хүнд хэцүү ажил үүрэг, тэвчиж өнгөрүүлэх ёстой доог тохуу болон сорилт



бэрхшээлүүд, үр дүнтэй өнгөрүүлэх ёстой цаг зав, сайтар хөгжүүлж ашиглах ёстой авьяас билиг байдаг. Бид зөвхөн ‘тэнд тэр үед’ сонгогдсон учраас ‘одоо энд’ хайхрамжгүй байж болно гэсэн хэрэг биш юм. Урьдчилан томилогдсон эрэгтэйчүүд эсвэл урьдчилан тодорхойлогдсон эмэгтэйчүүд болох дуудагдаж мөн бэлтгэгдсэн тэдгээр хүмүүс ‘сонгогдсон бөгөөд итгэлтэй’ гэдгээ мөн нотлох ёстой. (Илчлэлт 17:14; С ба Г 121:34–36-г үзнэ үү.)” (“Premortality, a Glorious Reality,” *Ensign*, 1985 оны 11-р сар, 17).

Олон эрэгтэйчүүд мөнх бус байдлын өмнөх амьдралд санваарыг хүлээн авахаар урьдчилан томилогдсон талаар Алма Аммонайхагийн ах дүүст заав. Алма 13:1, 8–9-ийг уншиж, Алма ямар санваарын талаар ярьсныг тодорхойл. Энэ бүлэг дэх “ариун жаяг” гэсэн хэллэг нь Мелкизедек санваар эсвэл “Бурханы Хүүгийн жаягаар Ариун санваар хэмээн нэрлэгддэг” гэдгийг ойлгох хэрэгтэй (С ба Г 107:3). Та энэ бүлгийн үргэлжлэлийг судлахдаа “ариун жаяг” гэсэн хэллэгийг тэмдэглэх хэрэгтэй (Алма 13:2, 6–7, 10–11, 16, 18-ыг үзнэ үү). Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Брүс Р.Макконки ийн хэлжээ: “Итгэлтэй бөгөөд Мосегийн хуулийг үнэнч дагадаг нифайчууд Мелкизедек санваартай байсан нь тэдэнд бүрэн сайн мэдээ байсан гэсэн үг юм” (*The Promised Messiah: The First Coming of Christ* [1978], 421). Энэ нь Мормоны Номын бошиглогчид Мелкизедек санваартай байсан бөгөөд энэхүү санваараар хэрхэн үйлддэгийг мэддэг байсан гэсэн үг юм.


Дараах асуултуудын хариултыг Алма 13:2–6, 10-аас олж, гарын авлага дээрээ бич.


- Мелкизедек санваарт томилогдсон хүмүүс ямар зан төлөвтэй байдаг вэ? (Алма 13:3–5, 10-ыг үзнэ үү.) _____
- Эдгээр Мелкизедек санваартнууд юу хийхээр томилогдсон бэ? (Алма 13:6-г үзнэ үү.) _____

- Танай тойрог эсвэл салбарын Мелкизедек санваартнууд хийхээр томилогдсон зүйлсээ хэрхэн хийж байгааг болон тэр нь таны эсвэл бусдын амьдралыг хэрхэн адисалж байгааг та харсан уу? _____

Алма 13-р бүлэг нь Мелкизедек санваарын талаар маш тодорхой мэдээллийг агуулдаг. Энэ нь уг санваарыг хүлээн авсан эрэгтэйчүүд үүнийг хүлээн авахаар урьдчилан томилогдсоныг заадаг (3-р шүлэг-ийг үзнэ үү). Энэ санваарыг атгадаг хүмүүс Бурханы зарлигуудыг бусдад заадаг бөгөөд энэ нь “тэд ч бас түүний амралтад орж болохын тулд” юм (6-р шүлэг). Санваар нь үүрдийнх (9-р шүлгийг үзнэ үү) бөгөөд энэ нь эрэгтэйчүүдэд “тэдний үлэмж итгэл хийгээд наманчлал, мөн Бурханы өмнөх тэдний зөв шударга байдлаас нь үндэслэн” олгогддог (10-р шүлэг). Санваартнууд нүглийг жигшиж (үзэн ядаж) сурсан үедээ Ариун сүнсээр ариусгагдан “цэвэршигдэж мөн Их Эзэн Бурханыхаа амралтад [орно]” (12-р шүлэг).

Алма 13:11–12-ыг уншиж, итгэл, наманчлал болон зөв шударга байдлынхаа улмаас санваартнуудын хүлээн авсан Есүс Христийн Цагаатгалын ариусгагч нөлөөг тодорхойл.

 **2.** Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултад хариулж бич: Та эдгээр Мелкизедек санваартнуудын үлгэр жишээнээс Цагаатгалын ариусгагч нөлөөг амьдралдаа хүлээн авахын тулд хийж болох зүйлсийн талаар юу сурсан бэ?

 **3.** Судартаа Алма 13:1–12-ын хажууд эсвэл судлах тэмдэглэлдээ дараах үнэнийг бич: **Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн бөгөөд агуу итгэлээ ашиглан, зөв шударга сонголт хийдэг эрэгтэйчүүд бусдыг Бурханд авчрахаар Мелкизедек санваарт дуудагддаг.** Тиймээс сайн мэдээний энэ зарчмыг мэдэх нь бүх амьдралынхаа туршид санваарын удирдагчдаа хандах таны хандлагад хэрхэн нөлөөлж болохыг судар судлах тэмдэглэлдээ бич.

Алма 13:13–20

Алма хүмүүсийнхээ дунд амар амгаланг тогтоосон агуу дээд прист Мелкиздекийн тухай заасан нь


Алма 13:13–18-ыг уншиж, Мелкиздекийг тодорхойлохдоо хэрэглэсэн Алмагийн үгсийг болон хүмүүсийнхээ төлөө Мелкиздекийн хийсэн зүйлсийг олж мэд. Эдгээр үгс нь Мелкизедек Христийн адилаар амьдарч байсныг харуулж байгааг бод. Мелкизедек санваартнууд нь “Эцэгийн Төрсөн Ганц Хүү, Есүс Христийн жаягийн дагуу” томилогддог бөгөөд (Алма 13:9; мөн С ба Г 107:2–4-ийг үзнэ үү) тэд биднийг үлгэр жишээ, заавар зөвлөгөөгөөрөө Түүн рүү чиглүүлдгийг Алма заадаг. Ахлагч Брүс Р.



Макконки ийн хэлжээ: “Олон бошиглогчдын амьдралд тэдгээр зөв шударга хүмүүсийг өөрсдийнх нь Мессиагийн хэв шинж ба загвар болгон онцгойлон адисалсан олон үйл явдал тохиосон нь эргэлзээгүй юм. Христтэй адил зүйлсийг хаа сайгүй эрж хайн, Түүнийг болон Түүний хуулиудыг оюун ухааныхаа гүнд байлгахын тулд дээрх зүйлсийг дахин дахин ашиглах нь ашиг тустай бөгөөд зүй ёсны хэрэг юм” (*The Promised Messiah*, 453).

Алма 13:19-ийг уншиж, энэ шүлэг бидэнд Мелкизедекийн талаар юу зааж байгааг олж мэд. Мелкизедекийг хаан болох үед Салемийн хүмүүс ямар байсныг Алма хэрхэн дүрсэлснийг мэдэхийн тулд Алма 13:17-г дахин хар. Эдгээр үгс мөн Аммонайхагийн хүмүүсийг хэрхэн дүрсэлж байгааг ажигла (Алма 8:9; 9:28-ыг үзнэ үү). Салем дахь хүмүүс Мелкизедекийн тавьсан саналын үр дүн болгон юу хийсэн бэ? (Алма 13:18-ыг үзнэ үү.) _____

Алма 13:18-д Мелкизедек юуг хэрэгжүүлж, юу хүлээн авсан болон заасныг ажигла. Мелкизедекийн үлгэр жишээнээс санваарын удирдагч ямар байх ёстой талаар сурч мэдсэн зүйлээ эргэцүүлэн бод.

 **4.** Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултад хариулж бич: Та эсвэл таны мэддэг хэн нэгэн хэзээ зөв шударга санваарын удирдагчийнхаа зөвлөгөөг дагасны дараа амар амгаланг мэдэрсэн бэ?

Алма 13:21–31

Алма хүмүүсийг Их Эзэний дууг сонсож, Түүний амралтад ороход урьсан нь

Алма 13:12, 13, 16 болон 29 дэх “Их Эзэний амралт” гэсэн (эсвэл ойролцоо утгатай) хэллэгүүдийг

олж тэмдэглэжээ хий. Их Эзэн хүмүүст Их Эзэний амралтад ороход нь туслахын тулд эрэгтэйчүүдийг санваарт дууддагийг Аммонайхагийн хүмүүст Алма заав. Тэрээр алдас болоод ёс бус байдлаар дүүрэн хүмүүс наманчилж, Их Эзэний амралтад орж болно гэдгийг тэдэнд харуулахын тулд Мелкизедекийн үлгэр жишээг ашиглажээ (Алма 13:17–18-ыг үз; мөн С ба Г 84:24-ийг үзнэ үү).


Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит Бурханы амралтад орно гэдэг нь юу болох тухай ийн хэлжээ: “Бид Бурханыг мэдэж, хайранд нь багтан, түүний зорилго, төлөвлөгөөнд итгэн, үүгээр өөрсдийгөө зөв зам дээр байгааг болон бид үүнээс өөр зүйлийг эрэлхийлдэггүйгээ мэдэх явдал мөн. Бид аливаа сургаалын салхинд эсвэл хууран мэхлэх санаа өвөрлөсөн хүмүүний башир аргуудад автдаггүй. Энэ бол Бурханы сургаал гэдгийг бид мэднэ” (*Teachings of Presidents of the Church: Joseph F. Smith* [1998], 56).

Ерөнхийлөгч Жозеф Ф.Смитийн тодорхойлсноор энэ амьдралдаа Их Эзэний амралтад орсон эрэгтэй, эмэгтэйчүүд ямар зан төлөвтэй байх ёстой гэж та боддог вэ? _____

Ахлагч Брүс Р.Макконки ийн заажээ: “Үнэнч шударга гэгээнтнүүд үнэнийг дагаснаар энэ амьдралдаа *Их Эзэний амралт*-д ордог бөгөөд тэрхүү адислагдсан байдлаа тэнгэр дэх Их Эзэнийхээ амралтад орох хүртлээ хадгалах болно. . . . Үүрд мөнх дэх Их Эзэний амралт нь мөнхийн амьдралыг өвлөн, Их Эзэний алдар суугийн бүрэн байдлыг олж авах явдал юм” (*Mormon Doctrine*, 2 дахь хэвлэл [1966], 633).

Алма Христийн ирэлтэд бэлтгэхийг Аммонайхагийн хүмүүст анхааруулсныхаа дараа (Алма 13:21–26-г үзнэ үү) Их Эзэний амралтад яаж орох талаар нэмэлт удирдамж өгчээ. Энэхүү удирдамж нь юу болохыг мэдэхийн тулд Алма 13:27–29-ийг унш.

Алмагийн заасан зүйлсийг дараах зарчмаар хураангуйлан дүгнэж болно: **Бид наманчлах урилгыг даруухнаар хүлээн авч хэрэгжүүлснээр эцэст нь Сүнс биднийг Их Эзэний амралт руу удирдах болно.**

 **5.** Та Алма 13:27–29-д дурдсан адислалуудаас хүлээн авахыг хүссэн нэг адислалаа нэрлэ. Уг адислалыг нэрлэсний дараа түүнийг хүлээн авахад бэлтгэхэд тань туслах Алмагийн өгсөн зөвлөгөөг олж мэд. Дараа нь энэ болон ирэх амьдралд Их Эзэний амралтад орохын тулд Алмагийн зөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлэх нэг зорилгыг судар судлах тэмдэглэлдээ бич.

 **6.** Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Алма 13-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

16-Р ХЭСЭГ: 4 ДЭХ ӨДӨР

Алма 14–16

Оршил

Алма, Амюлек хоёрын заасан зүйлийг сонссоны дараа Зиезром болон Аммонайхагийн хүмүүсийн зарим нь итгэж наманчлав. Бусад нь уурлаж, Алма Амюлек нарыг шоронд хорихоор болгов. Аммонайхагийн ёс бус хүмүүс итгэлтэй хүмүүсийг хөөн гаргаж, эхнэр хүүхдүүдийг нь шатаажээ. Их Эзэн олон өдрийн дараа Алма, Амюлек хоёрыг шоронгоос суллан, Аммонайхагийн ёс бус удирдагчдыг устгажээ. Зиезром Сайдомд байхдаа биеэрээ мөн сүнсээрээ зовж байв. Тэр Есүс Христэд итгэх итгэлээ Алмад илчилж эдгээгдэв. Леменчүүдийн их цэрэг Аммонайха хотыг устгаснаар бошиглол биелэгдэв. Алмагийн бошиглолын удирдамж нь Нифайн цэргүүдэд леменчүүдийн дайралтыг зогсоох боломж олгожээ. Алма, Амюлек болон бусад олон хүмүүс нифайчуудын нутаг даяар Сүмийг бэхжүүлжээ.

Алма 14

Алма Амюлек хоёр шоронгоос суллагдаж, итгэгчид хөөгдөн шатаагдав

Хэн нэгэн гэмгүй хүн өөр хүний гарт зовж байгааг харсан эсвэл сонссон тухайгаа бод. Жишээ нь итгэлээсээ болж хавчин гадуурхагдсан хэн нэгний тухай. Дараах асуултуудыг тунгаан бод:



- Зовж шаналсан хүний төлөө та ямар мэдрэмжтэй байсан бэ?
- Бусдад зовлон учруулсан хүний тухайд та юу мэдрсэн бэ?
- Гэмгүй, зөв шударга хүмүүст заримдаа яагаад муу зүйлүүд тохиолддог гэж та боддог вэ?

Алма 14-р бүлгийг уншихдаа эдгээр асуултуудыг Алма, Амюлек хоёрын туршлагатай холбон бод.

Алма 14:1–10-ыг уншаад хэн, яаж зовсныг олж мэд. Тэгээд дараах хүснэгтийг бөглө:

Хэн зовсон бэ?	Тэд хэрхэн зовсон бэ?

Алма 14:10-т цэдэглэснээр Амюлек юу хийхийг хүссэн бэ? Алма 14:11-ийг уншиж, заримдаа яагаад гэм зэмгүй эсвэл зөв шударга хүмүүсийг ёс бус хүмүүс зовоохыг зөвшөөрдгийг ойлгоход хүндрэлтэй байгаа хэн нэгэнд тусалж чадах үнэнийг олж мэд.

Алма 14:11 дэх үнэнийг илэрхийлэх нэг арга нь: **Их Эзэн Өөрийнх нь шүүлт шударга байхын тулд зөв шударга хүмүүс ёс бусчуудын гарт зовохыг зөвшөөрдөг.** Нас барсан дээрх хүмүүс Их Эзэний “алдар суунд” хүлээн авагдсан нь Алмад илчлэгдсэнийг анхаар (Алма 14:11). Тэргүүн Зөвлөлийн Ерөнхийлөгч Хэнри Б.Айринг энэхүү үйл явдлыг мөнхийн хэтийн төлөвөөс нь ийн заажээ: “Бурханы нинжин сэтгэл ба шударга ёсыг аймшигтай эмгэнэлт байдалд харахаар Амюлек адислагдсан юм” гэжээ (“Amulek: The Blessings of Obedience,” *Heroes from the Book of Mormon* [1995], 110).

Алма 60:12–13-ыг Алма 14:10–11-ийн холбогдох эшлэл болгон тэмдэглэ. Зөв шударга хүмүүсийг зовлонд унахаар болгодог шалтгаануудын дотор, тэд гэрчлэлээ амьдралтайгаа лацдан (С ба Г 135:3-ыг үзнэ үү), ёс бусчуудын эсрэг гэрч болон зогсох явдал байдгийг бид мэддэг билээ.

Бурхан яагаад зөв шударга хүмүүсийг зовохыг зөвшөөрдгийг ойлгох нь бидний хувьд ойлгоход хэцүү зарчим байж болох юм. Бурхан хүмүүсийг буруу сонголт хийх байсан ч өөрсдийн сонгох эрхээ ашиглахыг нь яагаад зөвшөөрдгийг илүү сайн ойлгохын тулд Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимбаллын дараах мэдэгдлийг тунгаан бод.

“Хэрэв бид мөнх бус амьдралыг бүхэлд нь нэгэн оршихуй гэж үзвэл өвдөлт, зовлон, алдаа дутагдал болон богинохон амьдрал нь маш хэцүү санагдах болно. Харин бид амьдралыг мөнх бус байдлын

өмнөх оршихуйгаас үхлийн дараах мөнхийн ирээдүйг хүртэл мөнхийн цар хүрээгээр нь харвал бүхий л зүйлс зохих байрандаа тавигдах болно. . . .



“... Хэрэв бүх зөв шударга хүмүүс хамгаалагдаж, ёс бусчууд устгагдвал Эцэгийн төлөвлөгөө бүхэлдээ ашиггүй болж, сайн мэдээний үндсэн зарчим болох чөлөөт сонголт нь төгсгөл болно.

Хэн ч итгэлээр амьдрах шаардлагагүй байх байсан” (*Teachings of Presidents of the Church: Spencer W. Kimball* [2006], 15).



1. Алма 14:11-ээс сурсан үнэнүүд болон Ерөнхийлөгч Кимбаллын хэлсэн үг Бурхан яагаад зарим үед зөв шударга хүмүүсийг ёс бус хүмүүсийн гарт зовохыг зөвшөөрдгийг ойлгоход тань хэрхэн тусалсныг судар судлах тэмдэглэлдээ бич.

Алма 14:12–13-ыг уншиж, Алма тэдний туулж байсан зовлонгуудыг давж гарахад нь Амюлект туслахын тулд түүнд юу заасныг олж мэд. Алма яагаад тийм итгэлтэйгээр хариулах боломжтой байсан гэж та бодож байна вэ? _____

Алма Амюлект Их Эзэнд найдах талаар юу заасныг ойлгоход тань туслах Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Ричард Г. Скоттын дараах үгсийг унш: “Энэ амьдрал бол гүн итгэл найдварын туршлага буюу Есүс Христэд итгэн найдах, Түүний сургаалуудад итгэн найдах, энэ амьдрал дахь аз жаргалын төлөө бас зорилго чиглэлтэй, дээдийн дээд аз жаргалтай мөнх оршихуйн төлөө бид эдгээр сургаалуудыг дуулгавартай дагахад Ариун сүнсээр удирдуулах чадвартаа итгэн найдах туршлага юм. Итгэн найдах гэдэг нь эхлэлээс төгсгөлийг нь хүртэл мэдэлгүйгээр сайн дураараа дуулгавартай дагах гэсэн утгатай юм (Сургаалт Үгс 3:5–7-г үзнэ үү). Үр дүн гаргахын тулд таны Их Эзэнд найдах найдлага, хувийн мэдрэмж, өөрийнхөө туршлагад итгэх итгэлээс тань илүү хүчтэй бөгөөд гуйвшгүй байх ёстой” (“Trust in the Lord,” *Ensign*, 1995 оны 11-р сар, 17).

Судрынхаа Алма 14:12–13-р шүлгийн хажууд энэ үнэнийг онцлон бичих хэрэгтэй: **Бид Их Эзэнд найдахад Тэр биднийг зовлон бэрхшээл тулгарсан үед хүчирхэгжүүлдэг.**



2. Дараах нөхцөлүүдээс нэгийг эсвэл илүү олныг сонгож, таны судартаа бичсэн зарчим нь энд дүрсэлсэн хүмүүст хэрхэн тусалж чадах талаар судар судлах тэмдэглэлдээ тайлбар бич:

а. Нэг залуу эрэгтэйн спортын багийн хэдэн тоглогч түүнийг илт гадуурхдаг бөгөөд түүнийг сайн мэдээний жишгүүдийг баримталдаг талаар нь шоолж, дооглодог ажээ. Тэр залуу итгэл үнэмшлээсээ болоод бусад залуустай хамт оролцох бо-

ломжгүй үйл ажиллагаануудыг тэд зориудаар төлөвлөдөг байжээ.

б. Нэг залуу эмэгтэй сайн найзынхаа ажилладаг дэлгүүрт ажилд орох өргөдөл өгчээ. Тэр ажилд орж чадаагүй бөгөөд нөгөө дэлгүүрийн эзэн Мормон хүнийг хэзээ ч ажилд авахгүй гэснийг найз нь түүнд дараа нь хэлжээ.

в. Нэг залуу эрэгтэй сургууль дээрээ хэсэг залуу эрэгтэйчүүдэд түүний дэргэд бүдүүлэг үг хэлэхээ болихыг хүсэхэд тэд түүнийг бие бие рүүгээ түлхэж, хэрэв яаж ярихыг тэдэнд дахиж заах юм бол түүнийг бүр илүү өвтгөнө гэж сүрдүүлжээ.

Алма 14:14–17-г уншиж, Алма, Амюлек хоёр Аммоннайхагийн ёс бус удирдагчдын гарт цаашид зовсоор байхад тэдний итгэл тэдэнд хэрхэн тусалсан талаар бод. Тухайн нөхцөлд ямар ч хариу өгөхгүй байсан нь яагаад хамгийн сайн арга байсан гэж та бодож байна вэ? (Мөн Матай 27:11–14-ийг үзнэ үү.)

Алма 14:18–28-д Бурхан Алма, Амюлек хоёрыг чөлөөлж, Аммоннайхагийн маш олон ёс бус удирдагчдыг устгахаас өмнө тэд их зовлонг хэрхэн туулсан тухай өгүүлдэг. “Шүдээ хавирцгааж” (21-р шүлэг) гэсэн хэллэг нь уурласандаа эсвэл уур хилэндээ шүдээ хавирах гэсэн утгатай юм.



3. Алма 14:18–25-д Алма, Амюлек хоёрын туулсан зовлонгуудын аль нь таны хувьд хамгийн хэцүү байх байсан гэдгийг судар судлах тэмдэглэлдээ тайлбарлан бич. Дараа нь шударга амьдрахыг хичээсэн ч зовлон бэрхшээлүүдтэй тулгарсан хувийн туршлагаа эсвэл өөрийнхөө мэддэг хэн нэгийг туршлагын талаар бич.

Алма 14:25-д цэдэглэсэнээр юу Алма, Амюлек хоёрыг хөл дээрээ зогсохыг нь боломжтой болгосон бэ?

Алма 14:26–29-ийг уншиж, энэхүү үнэнийг хамгийн сайн баталж байна гэж бодсон үг хэллэгүүдийгээ тэмдэглэ: **Хэрэв бид итгэлтэйгээр Их Эзэнийг дуудвал, Тэр биднийг зовлон зүдгүүрийн үед хүчирхэгжүүлж, Өөрийн арга замаар, Өөрийн цагт биднийг чөлөөлнө.**

Их Эзэн хүчээ үзүүлэн таныг саад бэрхшээлүүд болон зовлон зүдгүүрүүдээс тань Өөрийн арга замаар, Өөрийн цагт чөлөөлж чадна. Бид Их Эзэний хүсэлд найдаж сурснаар амьдралынхаа турш хэцүү зүйлүүдийг даван гарах илүү агуу хүч чадал, эрч хүчийг олох болно.

Алма 15–16

Зиезром эдгээгдэж, леменчүүдийн их цэрэг Аммоннайхаг устгаж, Алма, Амюлек хоёр үргэлжлүүлэн нифайчуудад номлов

Алма, Амюлек хоёр Аммоннайхаг орхисныхоо дараа Зиезромыг оролцуулан Аммоннайхагаас итгэгчдийг олсон ойролцоох хот болох Сайдом руу явжээ.

Зиезромын нөхцөл байдлыг мэдэхийн тулд Алма 15:3–5-ыг унш.

Дараах зүйлийг бодож үз: Зиезромыг юу өвдөх болгосон бэ? Зиезром тусламж болон амар амгаланг олж авахын тулд юу хийсэн бэ?

Алма 15:6–10-ыг анхааралтай уншиж, Алма Зиезромд Есүс Христ болон Түүний Цагаатгал дээр анхаарлаа төвлөрүүлэхэд нь тусалсныг харуулсан хоёр юмуу гурван хэллэгийн доогуур зур. Цагаатгалаар дамжуулан нигүүлслийг хүлээн авахад нь хүмүүст тусалдаг санваарын удирдагчдын ашигладаг нэг арга замыг ойлгохын тулд Далын ерөнхийлөгчийн зөвлөлийн ахлагч Жэй Э.Жэнсэний дараах туршлагыг унш:

“Би бишопоор үйлчилж байхдаа ноцтой гэм нүгэл үйлдсэн сүмийн гишүүдийн амьдралд ирдэг Цагаатгалын адислалуудын гэрч болсон юм. . . .

“Манай тойргийн нэгэн ганц бие залуу нэг залуу эмэгтэйтэй болздог байлаа. Тэр хоёр хайр сэтгэлдээ шатаж, биеэ барих, үйлдлээ хянах чадваргүй болсон байлаа. Тэр залуу надаас зөвлөгөө, тусламж авахаар ирсэн юм. Тэр гэм буруугаа хүлээсэн болон надад төрсөн Сүнсний мэдрэмж түүнчлэн бусад зүйл дээр үндэслэн, би түүнийг хэсэг хугацаанд ариун ёслолоос хүртэхийг зөвшөөрөөгүй. Бид түүний наманчлал бүрэн хийгдэхэд анхаарахын тулд ойр ойрхон уулздаг байсан бөгөөд тохиромжтой хугацааны дараа би түүнд ариун ёслолоос дахин хүртэх эрх олгосон юм.

“Би ариун ёслолын цуглаанд индэр дээр сууж байхдаа ариун ёслолыг зохистойгоор хүртэж байгаа түүнийг харлаа. Би амлагдсан уучлал, амар амгалан, аз жаргал үр дүнд нь ирдэг Цагаатгалын эдгээгч хүч түүний бодгалийг дулаацуулж, ачааг нь өргөснөөр энэрэл, хайр, хамгаалалтын гар түүнийг тэврэхийг гэрчилсэн билээ” (“Arms of Safety,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2008 оны 11-р сар, 49).

Бишоп болон санваарын бусад удирдагчид биднийг Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан нигүүлсэл болон өөртөө хэрэгтэй хүч чадлыг олж авахад тусалж чадна. Та Алма 15:11–12-оос Зиезром наманчилж, Их Эзэний нигүүлслийг хүлээн авсан гэсэн ямар нотолгоог олсон бэ? _____

Алма 15:6–12-ын талаар судартаа эсвэл судар судлах тэмдэглэлдээ таны бичиж болох нэг зарчим бол:

Бид Есүс Христэд итгэх итгэлээрээ эдгээгдэж, хүчирхэгжиж чадна. Алма 15:16, 18-д цэдэглэснээр энэ зарчим Амюлекийн амьдралд хэрхэн батлагдсан бэ?

Алма, Амюлек хоёр Сайдомын хүмүүсийн дунд сүм байгуулаад Зарахемла руу буцав.

Бид Алма 16-р бүлгээс, хэрэв хүмүүс наманчлахгүй бол тэд устгагдах болно гэсэн Алма, Амюлек нарын бошиглолын биелэлт болох леменчүүдийн их цэрэг нифайчуудын газар нутгийг булаан эзэлж, Аммонайха хотыг устгасан тухай уншдаг (Алма 9:12-ыг үзнэ үү). Алма 16-р бүлгийг уншихдаа нифайчууд леменчүүдийн их цэргийг ялахын тулд хэнээс тусламж хүссэнийг олж мэд. Энэ туршлагыг хувийн тулалдаан болон дайснуудтайгаа адилтга.



4. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Алма 14–16-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:



Алма 17–18

Оршил

Алма 17–18-р бүлгүүд нь Мозаягийн хөвгүүдийн леменчүүдийн дунд хийсэн номлолын талаарх Мормоны бичээсийг агуулдаг. Эдгээр цэдгүүд өнөө үеийн номлогчид хэрхэн бэлтгэж, үйлчлэх ёстой талаар үлгэр жишээ болж чадна. Мозаягийн хөвгүүд сайн мэдээг леменчүүдэд номлохоор бэлтгэхдээ Их Эзэний удирдамжийг эрэлхийлжээ. Тэднийг тус тусын замаараа явахад нь Их Эзэн тэднийг тайтгаруулж, тэд Түүнд бодгалиудыг авчрах болно гэж амласан ажээ. Аммон Ишмэлийн нутагт очиж, леменчүүдийн хаан Лемонайд үйлчлэн, зааж эхлэв. Лемонай хаан хонин сүргийг нь Аммон хамгаалахад түүний хүч чадлыг гайхан бишрэв. Энэ үйлчлэл хаан болон түүний хүмүүсийн зүрх сэтгэлийг зөөлөжээ. Тэд Бурхан болон авралын төлөвлөгөөний талаар Аммоны заахыг сонсох болов. Лемонай хаан Аммоны заасан зүйлүүдэд итгэж, өөрт нь Аврагч хэрэгтэйг ойлгож, Их Эзэнээс нигүүлслийг гуйн залбирахад Сүнсээр дүүргэгдэв.

Алма 17:1–18

Мозаягийн хөвгүүд леменчүүдэд сайн мэдээг номлоход бэлтгэв

Өнөө үеийн ахлагчид болон эгч нарын номлолдоо үйлчилдэг хугацааны талаар бод. Алма 17:4-ийг уншиж, Мозаягийн хөвгүүд леменчүүдийн дунд сайн мэдээг хэдэн жил заасныг доогуур нь зур.

Алма Мантайн нутаг руу явах замдаа Мозаягийн хөвгүүдийг урт удаан номлолоосоо буцаж явахад нь тааралдаж, бүгд баярлав. Алма 17:2–4-ийг уншиж, Мозаягийн хөвгүүд ямар номлогчид байсныг дүрсэлсэн үг хэллэгүүдийг тодруулан тэмдэглэ.



1. Алма 17:2–4. Дараах зүйлсийг судар судлах тэмдэглэлдээ бич:

а. Мозаягийн хөвгүүд үр дүнтэй номлогчид байхад бэлтгэхийн тулд юу хийснийг жагсааж, бэлтгэлийнх нь үр дүн ямар байсныг дүрслэн ярь.

б. Эдгээр номлогчдын хийсэн зүйлүүдээс амьдралдаа илүү сайн хийхийг хүсч байгаа зарим зүйлүүд эсвэл илүү бүрэн дүүрнээр хөгжүүлэхийг хүсч байгаа зан чанарыг сонго. Та үүнийг хэрхэн хийж болох талаараа тэмдэглэл бич.

Та хувиараа болон гэр бүлээрээ хэрхэн залбирдаг болон судраас суралцдаг талаараа тунгаан бодож,

мацаг барих боломжуудынхаа талаар бод. Эдгээр дадал хэвшлүүд таныг “үнэний мэдлэгт хүчтэй” (Алма 17:2) болоход ямар арга замаар тусалсан бэ?

Бид Мозаягийн хөвгүүдийн жишээнээс дараах зарчмыг суралцдаг: **Бид судруудаас судалж, залбирч, мацаг барьснаар Ариун сүнсийг хүлээн авч, сүнсний хүчтэйгээр зааж чадна.** Бид Ариун сүнсийг хүлээн авснаар сайн мэдээг бусадтай хуваалцахад илүү сайн бэлтгэгдэж чадна.

Өсвөр үеийнхэнд номлогч болохын тулд бэлтгэх арга замуудын талаар Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Дэвид А.Бэднэрын хэлсэн дараах үгсийг унш. Сайн мэдээг Мозаягийн хөвгүүд шиг хуваалцахад өөрийгөө бэлтгэх тодорхой арга замуудыг олж мэд.




“Та Бурханд үйлчлэх хүслээ нэмэгдүүлж чадна (С ба Г 4:3-ыг үзнэ үү), мөн та номлогчдын боддогийг бодож, номлогчдын уншдагийг уншиж, номлогчдын залбирдаг шиг залбирч мөн тэдний мэдэрдэг зүйлийг мэдэрч чадна. Та

Ариун Сүнснээс холдоход хүргэдэг дэлхийн нөлөөнүүдээс зайлсхийж, сүнсний өдөөлтүүдийг таньж, тэдгээрт хариулах итгэлтэй байдлаа өсгөж чадна. Та шат шатаар, дүрэм дүрмээр, энд бяцхан мөн тэнд бяцханыг хүлээн авч, ямар номлогч болохыг хүсдэг шигээ тийм номлогч болж мөн Аврагчийн танаас ямар номлогч болохыг хүсдэг шиг тийм номлогч болж чадна.

“Сургаалыг тунхаглах нь . . . Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүд бидний зүгээр л нэг хязгаарлагдмал цагт багтаан хийдэг эсвэл хийх ёстой ажил үүрэг төдий зүйл биш юм. Харин номлолын ажил нь бидний сүнслэг мөн чанар, үнэт өвийн илэрхийлэл юм” (“Номлогч болох нь,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2005 оны 11-р сар, 46–47).



Алма 17:9-ийг уншиж, Мозаягийн хөвгүүд номлолд үйлчлэхээр бэлтгэхдээ залбирсан зүйлүүдийнх нь доогуур зур. Алма 17:11-ийг уншиж, Их Эзэн тэдэнд хэрхэн Түүний мутар дахь зэмсгүүд байх талаар заасан зүйлсийг тунгаан бод. Эдгээр шүлгүүд нь дараах зарчмыг заадаг: **Сайн үлгэр жишээ үзүүлсэн үед, ялангуяа зовлон зүдгүүр тохиолдсон үед Их Эзэн биднийг Өөрийн мутар дахь зэмсэг байлгаж чадна.**

 2. Та өөрийнхөө сайн үлгэр жишээ үзүүлж чадах нөхцөл байдлыг судар судлах тэмдэглэлдээ бич. Сургууль дээрх нөхцөл байдал, гэр бүлээрээ гэртээ байх эсвэл хамаатан саднуудтайгаа хамт байх мөн нүүр тулан ярилцсан эсвэл онлайн аар харилцсан нийгмийн нөхцөл байдлуудын талаар бод. Та эдгээр нөхцөл байдлуудад хэрхэн сайн үлгэр жишээ үзүүлэхээ дүрслэн бич.

Зарим нөхцөл байдлуудад сайн үлгэр жишээ үзүүлэх нь илүү хэцүү байдаг. Алма 17:12–16-д леменчүүдийг хэрхэн дүрсэлснийг харж, дараа нь энэ нөхцөл байдалд заахад Мозаягийн хөвгүүдэд яагаад хэцүү байсныг бод.

Мозаягийн хөвгүүд нифайчуудыг үзэн яддаг байсан хүмүүст туслахын тулд яагаад зовлон зүдгүүрийг туулахад бэлэн байсан гэж та бодож байна вэ? Мозаягийн хөвгүүд юу гүйцэлдүүлэхийг хүсэж байсныг ойлгоход тань туслах үүднээс Алма 17:16-гаас авсан хэсгийн хоосон зайнуудыг бөглө: Мозаягийн хөвгүүд леменчүүдийг _____ авчрахыг хүсэв, учир нь тэд леменчүүдэд гэтэлгэлийн төлөвлөгөөг мэдүүлэхийг хүссэн юм.

Таныг хэрхэн бусдад сайн үлгэр жишээ үзүүлэхээ ойлгоход тань туслах дараах даалгаврыг ирэх хэдэн өдрийн дотор биелүүл: Гэр бүлийн нэг гишүүнээс эсвэл найзаасаа хэн нэгний Христийнх шиг үлгэр жишээ нь түүний амьдралыг хэрхэн өөрчилсөн тухай ярихыг хүс.

Алма 17:19–39

Аммон Лемонай хааны зарц болж, хааны хонин сүргийг хамгаалав

Алма 17:19–39-ийг уншихдаа Аммон Лемонай хаанд болон түүний зарц нарт хэрхэн үйлчилснийг олж мэд. Аммоны үйлчлэл нь леменчүүдэд сайн мэдээг хүлээн авахад нь хэрхэн тусалсан талаар бод. Хааны хонин сүргийг Аммон хэрхэн хамгаалсан талаарх түүхийг гэр бүлийн гишүүнтэйгээ эсвэл найзтайгаа хуваалцахаар төлөвлө. Түүхээ хуваалцах үедээ дараах үнэнийг тодотго: **Бид үйлчлэлээр дамжуулан бусдад сайн мэдээг хүлээн авахад бэлтгэхэд нь тусалж чадна.** Сүнслэг байдлын хувьд илүү хүчтэй болоход нь туслахыг хүсч байгаа нэг хүний



талаар дээрх гэр бүлийн гишүүнтэй эсвэл найзтайгаа ярилц. Та тэр хүнд хэрхэн тусалж чадах талаар бодож, хэрхэн үйлчлэл хийхээ шийд.

Алма 18

Аммоны итгэлтэй байдал Лемонай хааныг гайхшруулж, Аммон түүнд сайн мэдээг заасан нь


Лемонай хааны зарц нар Аммон хааны хонин сүргийг хамгаалахын тулд юу хийснийг хаанд ярьжээ. Алма 18:4–6-г уншиж, Аммоны хийсэн зүйлд хаан ямар хариу үйлдэл гаргасныг олж мэд.

Хаан зарц нараасаа Аммоныг хаана байгааг асуухад тэд түүнд Нифайн нутаг болох эцгийнхээ амьдардаг газар руу явах аян замд унах морьдыг бэлдүүлэх хааны хүсэлтийг Аммон биелүүлж байгааг хэлжээ. Алма 18:12–15-ыг уншиж, Аммоны үйлчлэл Лемонай хаанд хэрхэн нөлөөлснийг олж мэд.


Алма 18:16–21-ийг уншиж, Аммоныг Лемонай хаанд заахад Их Эзэн түүнийг удирдаж байсан гэдгийн нотолгоог ол. Энэ нөхцөл байдалд Бурханы Сүнс Аммонд хэрхэн тусалсан талаар өгөгдсөн зайнд бич. _____

Алма 18:22–32-ыг уншихдаа Лемонай хаанд Аммоны заасан сайн мэдээний тодорхой үнэнүүдийг олж мэд. Та эдгээр үнэнүүдийг судартаа тэмдэглэх эсвэл судар судлах тэмдэглэлдээ бичиж авах хэрэгтэй. Аммон өөрийн болон Лемонайн итгэл дээр үндэслэн заажээ. Лемонай өөрийнх нь хувьд Агуу Сүнс байсан Бурханд—итгэдэг байсан ч Бурханы жинхэнэ мөн чанарыг ойлгодоггүй байжээ.

Алма 18:33–35-ыг уншиж, хаан Аммонаас тэрбээр Бурханаас илгээгдсэн эсэхийг асуухад Аммон хэрхэн хариулсныг олж мэд.

 **3.** Алма 17–18-ыг судалснаасаа Аммон Бурханы тусламжтайгаар леменчүүдийн дунд юу хийх боломжтой байсан талаар богинохон догол мөрийг судар судлах тэмдэглэлдээ бич.


Та дараах зарчмыг судартаа Алма 18:35-ын хажууд бичих хэрэгтэй: **Бид Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христэд үйлчлэх үед Тэдний ажлыг хийх бидний чадварыг Тэд өсгөн нэмэгдүүлдэг.**

 **4.** Дараах асуултуудын нэгэнд эсвэл хоёуланд нь судар судлах тэмдэглэлдээ хариулж бич:

а. Дээрх зарчим нь сүм дэх одоогийн болон ирээдүйн үүрэгт ажлуудад тань хэрхэн туслах вэ?

б. Их Эзэний ажлыг хийх таны чадварыг Тэрээр өсгөн нэмэгдүүлэхийн тулд та Түүнд хэрхэн илүү итгэлтэйгээр үйлчилж чадах вэ?

Аммон итгэлтэй үлгэр жишээ болон үйлчлэлийнхээ ачаар Лемонай хаанд Тэнгэрлэг Эцэгийн гэтэлгэлийн төлөвлөгөөний талаар заах боломжтой байсан юм. Лемонай үйлдсэн аллагууддаа гэмшиж байсныг сана (Алма 18:4–6-г үзнэ үү). Алма 18:36–43-ыг уншиж, Лемонайд Аммон гэтэлгэлийн төлөвлөгөөг хэрхэн заасныг болон эдгээр сургаалд Лемонай хэрхэн хандсаныг олж мэд.

 **5.** Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултад хариулж бич: Есүс Христийн Цагаатгалыг ойлгох нь Лемонай хаанд яагаад нэн чухал байсан гэж та бодож байна вэ?

Бүтээлт, Уналт болон Цагаатгалын тухай сургаалуудаас суралцах нь Лемонайд Аврагч хэрэгтэйг ойлгоход нь хэрхэн тусалж болох байсныг тунгаан бод. Арванхоёр төлөөлөгчийн чуулгын Ахлагч Бүс Р. Макконки Бүтээлт, Уналт болон Цагаатгалын ач холбогдлыг заажээ:



“Эдгээр гурван тэнгэрлэг үйл явдал нь—авралын мөнхийн төлөвлөгөө гэсэн нэгэн асар том уран хатгамалд хоорондоо салшгүйгээр хамт нэхэгдсэн—мөнх оршихуйн гурван багана юм. Бид Их Эзэн, Есүс Христийн Цагаатгалыг

илчлэгдсэн шашныхаа гол цөм бөгөөд зүрх нь мөн гэж үздэг билээ. Энэ нь үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчирдаг. Аврал Христээр дамжин ирдэг.

“Гэвч уналт байгаагүй бол Цагаатгал гэж байхгүй байх байсан. Адамын уналт биеийн ба сүнсний үхлийг дэлхийд авчирсан бол, хүн төрөлхтөн болон амьдралын бүх хэлбэр нь Их Эзэн Есүс Христийн Цагаатгалын ачаар эдгээр үхлээс чөлөөлөгдсөн юм. Адам мөнх бус байдлыг, харин Христ үхэшгүй байдлыг авчирсан юм. Аврал нь уналт болон Цагаатгалын улмаас ирсэн юм.

“Хэдий тийм ч, хэрэв дэлхий хийгээд хүмүүн, мөн бүх амьд зүйлс нь өөрсдийн биет байдал болоод диваажингийн төрх буюу үхэшгүй байдалд бүтээгдээгүй бол уналт гэж байхгүй байх байсан. . . . Огторгуй ба дэлхий, эдгээрийн доторх болон дээрх бүх зүйлсийн бүтээлтэд, мөн үүгээр, мөн үүний улмаас аврал боломжтой болсон билээ. Аврал нь Бүтээлт, Уналт Цагаатгалын улмаас ирдэг; эдгээр гурван зүйл нь нэг тэнгэрлэг төлөвлөгөөний бие даасан хэсгүүд юм” (*A New Witness for the Articles of Faith* [1985], 81–82).

Бид Лемонайн туршлагаас дараах үнэнийг сурч болно: **Бид Аврагчийг өөрсдөдөө хэрэгтэй гэдгийг ойлгосон үед наманчлахыг хүсэх болно.**

Өнөөдрийн хичээлийг дуусгахдаа танд Аврагч хэрэгтэй гэдгийг санахад тань туслах ямар зүйлүүдийг хийж чадахаа тунгаан бод.

 **6.** Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Алма 17–18-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.


Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

17-Р ХЭСЭГ: 2 ДАХЬ ӨДӨР

Алма 19–20

Оршил

Алма 19–20-д цэдэглэснээр, Лемонай хаан өөрийнх нь олон хүмүүсийг хөрвөлт рүү удирдсан зүрх сэтгэлийн хүчит өөрчлөлтийг мэдэрчээ. Аммон болон Лемонай хаан Аммоны ах дүүсийг шоронгоос суллахаар Миддонай нутаг руу явдаг. Тэд замдаа бүх нутгийн хаан болох Лемонайн эцэгтэй тааралддаг.



Аммоны зоригтой гэрчлэл болон Лемонайг хайраар хамгаалсан нь Лемонай хааны эцгийг зүрх сэтгэлээ зөөллөж, Аммоны ах дүүсийг чөлөөлөхийг зөвшөөрөхөд хүргэжээ. Аммоны гэрчлэл, үлгэр жишээний ачаар олон хүмүүс Ариун Сүнсний нөлөөг мэдэрч, сайн мэдээг заалган хөрвөгдөв.

Алма 19

Лемонай хаан болон түүний олон хүмүүс наманчилж, баптисм хүртэв

Та тогтоол усанд чулуу хаяхад үүсдэг гадагш тэлэн долгиолох үзэгдлийн талаар бод.


Хүний үйлдлүүд нь усанд хаясан чулуутай хэрхэн адилхан байж болох вэ? _____

Дараах жишиг зургийн голд (зууван дотор) *Аммон* гэж бич.

Алма 19:1, 6-г уншиж, Аммоны гэрчлэл хамгийн түрүүнд хэнд нөлөөлснийг олж, жишиг зурагны эхний тойрогт нэрийг нь бич. Та Лемонайд юу тохиолдсоныг хамгийн сайн тодорхойлж байна гэж бодсон нэг хэллэгийг эдгээр шүлгүүдээс сонго. Сонгосон хэллэгээ болон энэ нь юу гэсэн утгатай гэж бодож байгаагаа бич: _____

Алма 19:7–10-аас Аммоны гэрчлэл нөлөөлсөн дараагийн хүнийг олж, жишиг зургийн хоёр дахь тойрогт нэрийг нь бич. Алма 19:10-т цэдэглэснээр Лемонайн эхнэрийн итгэлийн гайхалтай зүйл нь юу байсан бэ? _____

Алма 19:11–13-т цэдэглэснээр Лемонайн гэрчлэл эхнэрт нь хэрхэн нөлөөлсөн бэ? _____


 **1.** Алма 19:13–14-ийг уншиж, судар судлах тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич: “Сүнсээр

давамгайлагдах” эсвэл “баясалдаа дийлдэн байв” гэсэн нь юу гэсэн утгатай гэж та бодож байна вэ? Та амьдралдаа Ариун Сүнсний нөлөөг хэзээ хүчтэйгээр мэдэрч байсан бэ?

Алма 19:15-ыг уншиж, Аммоны гэрчлэл нөлөөлсөн дараагийн хүнийг олж, жишиг зурагны гурав дахь тойрогт нэрийг нь бич.


Алма 19:16–17-г уншиж түүний гэрчлэл нөлөөлсөн дараагийн хүнийг олж, дөрөв дэх тойрогт бич.

Аммон, Лемонай болон Лемонайн эхнэрт тохиолдсон үйл явдлууд хааны бүх зарц нарт хэрхэн нөлөөлснийг бод. Алма 19:15–17 дахь Лемонайн зарц нар Бурхан руу эргэснийг харуулсан үг хэллэгүүдийг тодруул.

 **2.** Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултад хариулж бич: Лемонайн болон түүний гэр бүлийнхний сүнслэг туршлагауд Абишийг олон жил “хэзээ ч мэдүүлээгүй” гэрчлэлээ бусадтай хуваалцах шийдвэр гаргахад нь хэрхэн нөлөөлсөн бэ (Алма 19:17)?

Хааны өргөөнд цугларсан хүмүүс харсан зүйлээ хэрхэн тайлбарласныг мэдэхийн тулд Алма 19:18–22-ыг унш. Өөрийгөө Абишийн оронд байсан гэж төсөөл. Та хүмүүсийн дундах зөрчилдөөнийг харсныхаа дараа юу хийх байсан бэ? Абиш юу хийснийг мэдэхийн тулд Алма 19:23–29-ийг унш.

Алма 19:30–36-г уншиж, Аммоны гэрчлэл хүмүүст хэрхэн нөлөөлснийг бодож үзнэ үү. Жишиг зургийн тав дахь цагирагт “бусад олон леменчүүд” гэж тэмдэглэ.”

 **3.** Аммоны гэрчлэл нөлөөлсөн бүх хүмүүсийн талаар бодож үзээд дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ гүйцээж бич: **Би гэрчлэлээ хуваалцаж, зөв шударга үлгэр жишээ үзүүлснээр . . . чадна.**

Аммон гэрчлэл, үлгэр жишээгээрээ дамжуулан Лемонай болон бусад хүмүүст Их Эзэн рүү эргэхэд нь тусалдаг. Амьдралд тань онцгой сүнслэг үүрэг гүйцэтгэсэн хүмүүсийн талаар бод. Зөв шударга үлгэр

жишээ болон гэрчлэл нь танд нөлөөлсөн хэн нэгний талаар бод. Энэ хүн бусдад мөн адил сайнаар нөлөөлсөн арга замуудын талаар та санаж байна уу?



4. Та дараах асуултад судар судлах тэмдэглэлдээ хариулж бичээд Аммоны үлгэр жишээнээс сурсан зүйлээ хэрхэн хэрэгжүүлж болохыг бод.

а. Та Аммоны зөв шударга амьдрах, бусдад үйлчлэх, гэрчлэлээ хуваалцах үлгэр жишээнүүдийг дагавал танай гэр бүлийн гишүүд, найз нөхөд хэрхэн адислагдаж болох вэ?

б. Таны үлгэр жишээ болон гэрчлэл танай гэр бүл, найз нөхөд, танилуудад хэрхэн үл харагдах байдлаар “нөлөө” үзүүлж болох вэ?

Алма 20

Лемонай хааны эцгийнх нь зүрх сэтгэл өөрчлөгдөж, сайн мэдээний талаар суралцахыг хүсэв

Дараах гурван нөхцөл байдлыг уншиж, та ямар хариу үйлдэл үзүүлэх байснаа бод:

- Нэгэн спортын тэмцээний үеэр ерөнхий шүүгч эсвэл хажуугийн шүүгч буруу шүүж, чамд шударга бус хандаж байх шиг санагджээ.
- Багш чинь чамайг бусдаас хуулаагүй байхад хуулаа гэж ангийнхны чинь өмнө гүтгэжээ.
- Эцэг эх чинь чамайг ах, эгчийн чинь хийсэн зүйлээс болж буруутгажээ.

Алма 20-д цэдэглэснээр Аммон, Лемонай хоёр ууртайгаар хариулж болохуйц нөхцөлд оржээ. Та энэ бүлгийг судлахдаа өөрийгөө Аммон эсвэл Лемонайн оронд байна гэж төсөөл.

Лемонай хаан Аммоныг бүх леменчүүдийн хаан байсан эцэгтээ танилцуулахыг хүссэн үед юу болсныг мэдэхийн тулд Алма 20:1–7-г унш. Дараа нь доорх багц шүлгүүдийг уншиж, холбогдох асуултуудад хэрхэн хариулахаа эргэцүүлэн бод.

Алма 20:8–13	Хэрэв та Аммоны оронд байсан бол хэн нэгэн таныг худалч, дээрэмчин гэж гүтгэвэл танд ямар санагдах байсан бэ?
Алма 20:14–16	Эцэгтээ өгсөн Лемонайн хариултаас юу нь таныг гайхшруулж байна вэ?
Алма 20:17–25	Аммон Лемонайн эцгийг уурлахад нь хэрхэн хариу үйлдэл үзүүлсэн бэ? Аммон Лемонайг хайрлах хайраа хэрхэн харуулсан бэ?

Аммоны хариу үйлдлийн үр дагавруудыг мэдэхийн тулд Алма 20:26–27-г унш. Аммоны үзүүлсэн хайрыг харсныхаа дараа Лемонайн эцэг юу мэдэхийг хүссэн бэ? _____

Лемонайн эцгийг уурлахад Аммоны үзүүлсэн хариу үйлдлээс бид юу сурч болох вэ? _____

Дараах үнэнийг судартаа Алма 20:26–27-гийн хажууд эсвэл судар судлах тэмдэглэлдээ бич: **Бид хайраар үйлдэхэд энэ нь бусдыг зүрх сэтгэлээ зөөллөж, үнэнийг мэдэхийг эрэлхийлэхэд чиглүүлж чадна.** Гэртээ эсвэл найзуудтайгаа хамт байхдаа, сургууль дээр бусад хүмүүсийн уур уцаарт хайраар хариу үйлдэл үзүүлэх боломжийн талаар бодож үзнэ үү.



5. Та Аммон леменчүүдийн хаанд хандсаны адил уур уцаарт хэрхэн илүү сайнаар, хайраар хариу үйлдэл үзүүлж болохыг харуулах нэг зорилгыг судар судлах тэмдэглэлдээ бич.



6. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Алма 19–20-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

17-Р ХЭСЭГ: 3 ДАХЬ ӨДӨР

Алма 21–22

Оршил

Аммоны дүү нарын нэг Аарон Есүс Христ болон Цагаатгалын талаар амаликайчууд болон амюлончуудад заахыг хичээсэн ч, хүмүүс түүнийг эсэргүүцдэг. Эцэст нь Аарон болон түүний хамтрагчдын зарим нь Миддонайн нутаг дахь шоронд хоригджээ. Тэд гай зовлон тохиолдсон үед итгэлтэй хэвээр үлддэг. Аммон болон Лемонай хаан тэднийг чөлөөлсний дараа Аарон Лемонайн эцэгт хэрхэн “Бурханаар төрөх” (Алма 22:15) тухай заадаг. Хаан нүглүүдээ наманчилснаар Бурханы талаарх мэдлэгтэй болж, эцэст нь мөнх амьдралыг хүлээн авах болно гэдгийг суралцдаг. Аарон болон түүний ах дүү нарын итгэл



бишрэл олон леменчүүдийг Бурханы тухай мэдэж, Түүний гэтэлгэлийн зам дээр гарахад тусалсан ажээ.

Алма 21:1–23

Аарон болон түүний ах дүү нар зовлон зүдгүүр болон шоронд хоригдохыг эс хайхран сайн мэдээг номлов

Зарлигуудыг дагахыг маш их хичээсэн ч бэрхшээлүүдтэй тулгарч байсан үеийнхээ талаар бод. Тэгээд дараах асуултуудыг тунгаан бод: Та туулсан зовлон зүдгүүрүүдээ үл харгалзан итгэлтэй байхын тулд юу хийсэн бэ? Та энэхүү туршлагаа эргэн хараад Их Эзэн таныг тэр үед хэрхэн адисалсан гэж боддог вэ?

Аммоныг Лемонай хаан болон түүний хүмүүст зааж байх үед (Алма 17–19-ийг үзнэ үү) Аарон болон түүний хамтрагчид уг нутгийн өөр хэсгүүдэд заахыг хичээж, их зовлон үздэг. Аарон болон түүний хамтрагчид шоронд зовж байсныг эргэн харахын тулд Алма 20:28–30-ийг унш. Дараа нь доорх үйл ажиллагаанд харуулсан Алма 21:1–17 дахь захиасыг унш. Аарон болон түүний ах дүү нар тохиолдсон зовлон зүдгүүрээ хэрхэн даван туулсныг олж мэд.



1. Дараах хүснэгтийг судар судлах тэмдэглэлдээ хуулж, судар болгоны ард сэтгэгдлээ бичих зай үлдээ:

Шалгуур эсвэл бэрхшээл	Аарон болон түүний хамтрагчид ямар хариу үйлдэл гаргасан бэ
Алма 21:3	Алма 21:4
Алма 21:5–6, 8	Алма 21:7, 9
Алма 21:10–11	Алма 21:11–12
Алма 21:13–14	Алма 21:15

Судрын хэсэг бүрийг уншсаныхаа дараа Аарон болон түүний хамтрагчдад тулгарсан шалгуур эсвэл бэрхшээлүүдийг хүснэгтийнхээ зүүн багананд бич. Аарон болон түүний хамтрагчид сорилт бэрхшээлүүдэд хэрхэн хандсаныг баруун талын багананд бич. Тэгээд дараах асуултуудад хариул:

- Тэд шантарч, итгэл найдваргүй болж, нифайчууд тэдэнд илүү найрсаг ханддаг газарт буцах нь тэдний хувьд яагаад илүү амархан байх байсан гэж та бодож байна вэ?
- Бид гишүүн номлогчийн хувьд энэ хэсгийг судалснаар хэрхэн ашиг тусыг олж чадах вэ?

Алма 21:16–17-г уншиж, Их Эзэн Аарон болон түүний ах дүүсийг итгэлдээ тууштай алхах үед Түүний ажлыг хийхэд тэдэнд хэрхэн тусалсныг олж мэд. Бид Аарон болон түүний ах дүүсээр дамжуулан дараах зарчмыг сурдаг: **Хэрэв бид зовлон зүдгүүрийнхээ үед итгэлээрээ тууштай байвал, Их Эзэн бидэнд Түүний ажлыг хийхэд туслах болно.** Та энэ зарчмыг судартаа эсвэл судар судлах тэмдэглэлдээ бичих хэрэгтэй.

Бурхан танаар одоо болон ирээдүйд ямар ажил хийлгэхээр бэлтгэсэн болон тэрхүү ажлыг биелүүлэхээр хичээх үед та ямар бэрхшээлүүдтэй тулгарч болохыг бод. Бид Их Эзэний ажлыг хийхээр хичээх үед бэрхшээлүүдтэй тулгарч болно гэдгийг заасан Ерөнхийлөгч Томас С.Монсоны хэлсэн дараах үгсийг унш:



“Тэнгэрлэг Эцэг захиасаа хүргэхээр бэлтгэсэн онцгой бодгалиудад хүрч очиж, зааж, тэдэнд нөлөөлөх нь агуу чухал ажил юм. Амжилтад амар хялбар хүрэх нь ховорхон байдаг. Харин амжилтын өмнө ихэнхдээ нулимс, зовлон бэрхшээл, итгэл найдвар, гэрчлэл ирдэг. . . .

“ . . . Бурханы үйлчлэгчид ‘Би та нартай үргэлж хамт байх болно’ (Матай 28:20) гэсэн Их Эзэний амлалтаас тайтгарлыг олдог. Энэхүү агуу амлалт таныг дэмждэг юм. . . . Энэ нь таныг бүх хүмүүсийн адил урам хугаран шантрах үед таныг тайтгаруулдаг” (“Tears, Trials, Trust, Testimony,” *Ensign*, 1987 оны 5-р сар, 43).



2. Зовлон бэрхшээлийг итгэлтэйгээр даван туулсан нэг туршлагынхаа тухай судар судлах тэмдэглэлдээ бич. Эсвэл та одоо тулгараад байгаа бэрхшээлийг энэ хичээлийн зарчмыг ашиглан хэрхэн итгэлтэй байхаар төлөвлөж байгаагаа бичиж болно. Мөн ирээдүйд Их Эзэний ажлыг хийхэд тань бэрхшээлүүд тулгарч, тууштай байдлыг шаардаж магадгүй гэж бодож буй зарим нөхцөл байдлынхаа талаар бич.

Аарон болон түүний ах дүүсийг шоронгоос сулгадахад нь тусалсныхаа дараа Аммон юу хийснийг мэдэхийн тулд Алма 21:18–23-ыг унш. Аммон леменчүүдэд сайн мэдээг зааснаар тэдний амьдрал хэрхэн өөрчлөгдсөнийг олж мэд.

Есүс Христийн сайн мэдээ таны мэддэг хэн нэгний амьдралыг хэрхэн өөрчилснийг бод. Өөрийнхөө таньдаг хэн нэгэнтэй сайн мэдээг хэрхэн хуваалцаж болох талаар тунгаан бод, эсвэл Аарон болон түүний ах дүүсийн үлгэр жишээ нь хэнд нөлөөлж болох талаар бод. Тэр хүнтэйгээ Аарон болон түүний ах дүүс Их Эзэний ажлыг хийхдээ итгэлээрээ тууштай байсан жишээнээс та юу сурснаа хуваалцахыг бод.

Алма 22

Лемонайн эцэг болох бүх нутгийн хаан Аароны заасан сайн мэдээнд итгэжээ

Өмнөх хичээлээр Аммон Лемонайн эцэгтэй хэрхэн уулзсаныг эргэн сана. Аммоноос гуйсан хааны тодорхой хүсэлтийг Алма 20:27-гоос дахин унш. Алма 22:1–3-ыг уншихдаа Аароны айлчлалд хаан хэрхэн хандсаныг олж мэд.

Алма 22:4–6-г уншиж, Лемонайн хаан эцгийг юу зооож байсныг олж мэд. Алма 22:7–14-өөс Лемонайн эцэгт Аароны заасан үнэнүүдийг эрж ол.

Дараах асуултуудыг тунгаан бод (Алма 17–18 дахь Лемонай хааны тухай төстэй ярилцлагыг санаарай):

- Хаан наманчлалыг ойлгохын тулд яагаад Бурханд итгэх хэрэгтэй байсан бэ?
- Уналтыг мэдэх нь наманчлалыг ойлгоход хаанд хэрхэн тусалсан бэ?



3. Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултад хариулж бич: Наманчлалыг ойлгохын тулд Адамын уналт болон Есүс Христийн Цагаатгалыг ойлгох нь яагаад чухал вэ?

Алма 22:15-ыг уншиж, Лемонай хааны эцэг баяр баясгалан, мөнх амьдралыг хүлээн авахын тулд юугаа орхиход бэлэн байсныг олж мэдээд, судартаа үүнийг тэмдэглэж болно.



4. Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултад хариулж бич: Бурханы мэдэхийг хүсч байгаа хүн болгон Лемонай хааны эцэгтэй адил зан чанартай байх нь яагаад чухал гэж та бодож байна вэ?

Хааны мөнх амьдралыг хэрхэн хүлээж авах талаарх асуултад Аарон хэрхэн хариулсныг мэдэхийн тулд Алма 22:16-г унш. (Энэ шүлэгт заагдаж байгаа чухал үнэнүүдийг судартаа тэмдэглэж болно.) Аароны заасан үнэнүүдийг хүлээн зөвшөөрч, үүгээр амьдрах нь мөнх амьдралыг хүлээн авахад хүнийг хэрхэн удирдаж чадах вэ? _____

Алма 22:17–18-ыг уншиж, Аароны зааварт хаан хэрхэн хариу үйлдэл үзүүлснийг олж мэд. Дараах асуултыг тунгаан бод: Бид Бурханаас төрөх талаар Лемонай хааны эцгээс юу суралцаж болох вэ?

Та Алма 22:18 дахь дараах хэллэгийг судартаа тэмдэглэх хэрэгтэй: “Таныг мэдэхийн тулд . . . би бүх нүглүүдээ орхих болно.” Дараах үнэнийг тунгаан бодож, үүнийг судартаа эсвэл судар судлах тэмдэглэлдээ бич: **Бид сүнслэгээр өөрчлөгдөж, Бурханаас төрөхийн тулд бүх нүглээ орхих хүсэлтэй байх ёстой.**



Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Даллин Х.Өүксийн дараах үгсийг унш: “Есүс Христийн сайн мэдээ биднийг өөрчлөгдөхөд урьдаг. ‘Наманчил’ гэдэг нь хамгийн их өгөгддөг урилга бөгөөд наманчлах гэдэг нь Бурханы зарлигуудтай зөрчилдөх бүх хувийн, гэр бүлийн, гарал угсаа болон үндэсний зан заншлаа орхих гэсэн утгатай юм. Сайн мэдээний зорилго нь ердийн бүтээлүүдийг селестиел иргэд болгох бөгөөд энэ нь өөрчлөлтийг шаарддаг” (“Repentance and Change,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2003 оны 11-р сар, 37).

Та сүнслэгээр өөрчлөгдөхийн тулд одоо амьдралдаа юу хийх хэрэгтэйгээ тунгаан бод.

Хааны залбирлын дараа ямар үйл явдлууд болсныг мэдэхийн тулд Алма 22:19–22-ыг унш. Алма 22:23–27-г уншиж, Лемонайн эцэг зүрх сэтгэлийн өөрчлөлтийг хүлээн авч, өөртөө Их Эзэний Сүнсийг мэдэрсний улмаас юу хийснийг олж мэд.



5. Та Лемонай хааны эцгийн тухай судалснаар дахин төрөх талаар мэдсэн зүйлээ судрын тэмдэглэлдээ бич. Одоогийн өсвөр үеийнхэнд Бурханаас төрөхөд нь туслах өөрчлөлтүүдийг амьдралдаа хийхэд нь түүний жишээ хэрхэн тусалж болохыг тэдэнд тайлбарла.



6. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Алма 21–22-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

17-Р ХЭСЭГ: 4 ДЭХ ӨДӨР

Алма 23–24

Оршил

Леменчүүдийн хаан хөрвөгдсөнийхөө дараа ард түмнийхээ дунд шашны эрх чөлөөг тунхаглажээ. Энэхүү тунхаглал нь Аарон болон түүний ах дүүст сайн мэдээг номлож, леменчүүдийн олон хотод сүм байгуулах боломжийг олгосон юм. Мянга мянган леменчүүд хөрвөгдөж, хэзээ ч итгэл алдраагүй ажээ. Их Эзэнд хөрвөгдсөн леменчүүд дайны зэр зэвсгээ хаях гэрээ хийжээ. Тэд өөрсдөдөө Антай-Нифай-Лихай хэмээх нэрийг авав. Хөрвөгдөөгүй леменчүүд тэдний эсрэг дайрахад олон Антай-Нифай-Лихайчууд гэрээгээр зөрчихийн оронд амиа золиосолсон.

Алма 23

Мянга мянган леменчүүд Их Эзэнд хөрвөгдөж, нэрээ Антай-Нифай-Лихайчууд хэмээн өөрчилжээ.



1. Судар судлах тэмдэглэлдээ жаргалтай ба гунигтай хүний царай нэг нэгийг зур. Жаргалтай байгаа зургаа *Итгэлтэй*, гунигтай байгаа зургаа *Тогтворгүй* гэж нэрлэ. Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Ричард Г. Скоттын дараах мэдэгдлийг уншихдаа энэ хоёр төрлийн хүмүүсийн талаар дүрсэлж буй үг хэллэгүүдийг ол. Эдгээр үг хэллэгүүдийг тохирох зургийнх нь доор бич.



“Зарим хүмүүс амьдралынхаа туршид тууштайгаар зөв зүйлсийг хийдгийг бид бүгд хардаг. Тэд аз жаргалтай, амьдралдаа их урам зоригтой байдаг. Тэд хэцүү сонголттой тулгарсан үедээ хорхой хүргэм хуурмаг сонголтыг хийх боломжтой байдаг ч эргэлзэлгүйгээр зөв сонголт хийдэг. Бид тэднийг уруу таталтуудтай тулгардгийг мэднэ, гэвч тэд уруу таталтыг тоодоггүй бололтой. Нөгөө талаар, зарим хүмүүс гаргаж буй шийдвэртээ тийм ч шийдэмгий бус байгаа нь бидэнд ажиглагддаг. Ийм хүмүүс хүчтэй сүнслэг орчинд байгаа үедээ илүү сайн хүн болж, амьдралынхаа хэв маягийг өөрчлөх, доройтуулагч зуршлуудаас салах шийдвэр

гаргадаг. Тэд өөрчлөгдөхийг чин сэтгэлээсээ хүсдэг ч, хаяхаар шийдсэн зүйлүүдээ удалгүй дахин хийж эхэлдэг.

“Энэ хоёр бүлэг хүмүүсийн амьдралыг юу өөр болгодог вэ? Та хэрхэн тууштайгаар зөв сонголт хийж чадах вэ?” (“Full Conversion Brings Happiness,” *Ensign*, 2002 оны 5-р сар, 24).

Та ахлагч Скоттын асуусан хоёр асуултад хэрхэн хариулахаа тунгаан бод. Алма 23–24-ийг судлахдаа яагаад Сүмийн олон гишүүд Есүс Христийн сайн мэдээнд итгэлтэй хэвээрээ үлддэгийг тунгаан бод.

Леменчүүдийн хаан Есүс Христийн сайн мэдээнд хөрвөгдсөнийхөө дараа бүх хүмүүсийн дунд тунхаг илгээж, нэгэн гайхамшиг тохиолджээ. Мянга мянган леменчүүд бас хөрвөгдсөн байлаа. Ямар тунхаг байсан болон гайхамшиг хэрхэн тохиосныг мэдэхийн тулд Алма 23:1–5-ыг унш.

Алма 23:6–7-г унш. “Их Эзэнд хөрвөгдсөн” мянга мянган хүмүүсийн хэд нь амьдралынхаа турш хөрвөгдсөн хэвээрээ үлдсэн бэ? _____

Эдгээр леменчүүд хөрвөгдсөнийхөө дараа леменчүүд хэмээн дахин дуудагдахгүйн тулд шинэ нэртэй болохыг хүсчээ. Алма 23:16–18-ыг уншиж, тэдний сонгосон нэр болон итгэлийнх нь ачаар тэдэнд ирсэн адислалуудыг олж мэд.



2. Антай-Нифай-Лихайчуудаас амьдралынхаа турш Их Эзэнд итгэлтэй байх талаар сурсан зүйлээ судар судлах тэмдэглэлдээ “Итгэлтэй” гэж тэмдэглэгдсэн дүрсийн доор бич.


Дараах үнэнийг судартаа эсвэл судар судлах тэмдэглэлдээ бич: **Хөрвөлт нь сүнслэг байдлын хувьд өөрчлөгдөж, Бурханы хүчээр шинэ хүн болох явдал юм.** Антай-Нифай-Лихайчууд өөрчлөгдсөний адил хэрэв та итгэл, наманчлалаараа дамжуулан Цагаатгалын хүчийг амьдралдаа хүлээн авахыг хүсч байвал та Бурханы хүчээр шинэ хүн болж, амьдралынхаа турш хөрвөлтөө хэвээр хадгалах болно.

Ахлагч Скоттын хоёр асуултыг дахин харсныхаа дараа түүний хариултыг унш: “Жинхэнэ хөрвөлт бол *итгэл, наманчлал ба тууштай дуулгавартай байдлын үр жимс юм. . . .* Жинхэнэ хөрвөлт бол нөхцөл байдлаас үл хамааран хийх ёстой зүйлээ мөн үүнийг хэзээ хийх ёстойгоо мэдэж хийх чадварыг тань хүчирхэгжүүлэх болно.



3. Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултад хариулж бич: Алма 23:18-д цэдэглэснээр хөрвөгдсөн леменчүүд хөдөлмөрч байж мөн нифайчуудтай нөхөрлөж


эхэлдэг. Хүмүүс наманчилж, амьдралаа өөрчлөхийг хичээж байгаа үед зөв шударга амьдрахын төлөө тэдний адил хичээж буй бусад хүмүүстэй нөхөрлөх нь тэдэнд яагаад чухал байдаг вэ?

 4. Судар судлах тэмдэглэлдээ “Итгэлтэй” гэсэн дүрсийн доор жагсаасан зүйлсээ шалга. Эдгээр зүйлүүд таны хөрвөлтийн түвшинг хэр сайн тодорхойлж байгааг бод. Та Их Эзэнд илүү бүрэн хөрвөгдөхийн тулд юу хийхээ судар судлах тэмдэглэлдээ бич.

Алма 24

Антай-Нифай-Лихайчууд зэр зэвсгээ дахин агсахгүй хэмээн гэрээ хийв

Алма 24:3-т цэдэглэснээр леменчүүдийн хаан нас эцэслэхийнхээ өмнөхөн хүүдээ хаант улсаа өгч, түүнд Антай-Нифай-Лихай гэдэг нэрийг өгчээ. Аммон болон түүний ах дүүсийг хаантай зөвлөлдөхөд хүргэсэн ямар асуудлууд удалгүй гарсныг мэдэхийн тулд Алма 24:1–5-ыг унш. Хөрвөгдөөгүй леменчүүд Антай-Нифай-Лихайчуудын эсрэг дайтах гэж байгаа нь мэдэгдэх үед эдгээр зөв шударга хүмүүс өөрсдийгөө хамгаалах ямар ч бэлтгэл хийхгүй байхаар шийдсэн ажээ (Алма 24:6-г үзнэ үү). Алма 24:7–14-ийг уншиж, Антай-Нифай-Лихайчууд яагаад ийм шийдвэр гаргасныг олж мэд.

 5. Бид наманчилснаар нүглүүдээ орхидог гэдэг нь юу гэсэн утгатай тухай Антай-Нифай-Лихайчуудаас сурч мэдсэн зүйлээ судар судлах тэмдэглэлдээ бич.




Алма 24:15–18-ыг уншиж, Антай-Нифай-Лихайчууд Их Эзэнд үнэхээр наманчилсан гэдгээ харуулахын тулд юу хийснийг олж мэд. Эдгээр хүмүүс яагаад өөрсдийн илд болон бусад зэр зэвсгийг газрын гүнд булсан бэ? (Алма 24:17–18-ыг үзнэ үү.)



Бид хувийн амьдралдаа нүглээ наманчилсан үед тэдгээр нүглүүдийг дахин үйлдэхгүй байхын төлөө хичээх ёстой. Нүглийг орхих нь наманчлалын чухал хэсэг болох талаар Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимбаллын заасан зүйлийг унш: “Хүн нүглээ орхихдоо ердөө илүү сайн нөхцөлтэй байхыг хүсээд өнгөрч болохгүй. Тэрээр өөрчлөлтийг өөрөө хийх ёстой. . . Тэр хүн зөвхөн нүглүүдээ орхиод зогсохгүй, гэм нүглийг тойрон байдаг нөхцөл байдлыг өөрчлөхөд анхаарах ёстой. Нүгэл үйлдэгдэж байсан газрууд, нөхцөл байдал болоод орчин нь нүгэл дахин үйлдэхэд хамгийн амархан хүргэх зүйлүүд учраас эдгээрээс зайлсхийх ёстой. Тэрээр нүгэл хамт үйлдсэн хүмүүсээ орхих ёстой. Тэрээр нүгэлтэй нь хамаатай хүмүүсийг үзэн ядахгүй ч тэднээс болон нүгэлтэй нь холбоотой бүх зүйлүүдээс зайлсхийх ёстой. Тэрээр . . . амьдралаа шинээр эхлэх ёстой. Тэрээр хуучин дурсамжуудыг нь хөндөж болох бүх зүйлийг алга болгох ёстой” (*The Miracle of Forgiveness* [1969], 171–72).

Алма 24:10–12-т байгаа Антай-Нифай-Лихайчуудын наманчлал болон Бурхан тэдний нүглийг уучилсан тухай үг хэллэгүүдийг тэмдэглэ. Эдгээр шүлгүүдийн хажууд дараах зарчмыг бич: **Хэрэв бид наманчлахын тулд чадах бүхнээ хийвэл, Бурхан бидний гэм буруугийн мэдрэмжийг авч, биднийг цэвэр ариун хэвээр үлдэхэд тусалдаг.** Антай-Нифай-Лихайчууд зэр зэвсгээ газарт булсан тухай хэсгийг үзнэ үү. Өнөө үед ч гэсэн бид наманчилж, урьдын нүглээ давтахгүйн тулд чадах бүхнээ хийж байгаагаа Их Эзэнд харуулахын тулд нүглүүдээ “булшлах” хэрэгтэй.

 6. Дараах нөхцөл байдалд орсон хүмүүс урьдын нүглээ дахин үйлдэхгүй байх баталгааг хэрхэн бий болгож болохыг бодож үзнэ үү. Нөхцөл байдал бүр дэх зөвлөмжүүдээ судар судлах тэмдэглэлдээ бич:

- а. Нэг хүнийг найзууд нь кинонд хамт явахыг урьсан болохоор тэр киноны порнографтай хэсгийг үзжээ.
- б. Бүлгээрээ орой салхинд гарах үеэр нэг хүн найзуудтайгаа хамт мэргэн ухааны үгийг нууцаар зөрчжээ.
- в. Хэн нэгэн нь бүрэн хийсэн шалгалтын хариунуудаа үдээс хойш яг адилхан шалгалт өгөх гэж байгаа найздаа үзүүлжээ.

Дараах асуултыг тунгаан бод: Та наманчилсан нүглээ дахин үйлдэхэд уруу татагдахгүйн тулд амьдралд тань байгаа юуг “булшлах” хэрэгтэй вэ?

Леменчүүд Антай-Нифай-Лихайчуудын эсрэг дайтахаар ирэхэд тэд юу хийснийг мэдэхийн тулд Алма 24:19–22-ыг унш. Эдгээр хүмүүс Их Эзэнд өгсөн амлалтаа зөрчихийн оронд амиа өгөх хүсэлтэй байснаараа Их Эзэнд бүхнээ зориулж байгаагаа харуулсан юм. Тэд Их Эзэнд амьдралаа бүрэн зориулсан бөгөөд бүх амьдралынхаа турш Түүнд бүрэн итгэлтэй хэвээр үлдсэн ажээ.

Их Эзэнд амьдралаа зориулах талаар Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон юу гэж заасныг унш.



“Христийн төлөө өөрчлөгдсөн хүмүүс Христээр удирдагдах болно. Тэд Паулын адил ‘Эзэн, та надаар юу хийлгэхийг хүснэм?’ гэж асуух болно. (Үйлс 9:6.) . . .

“Тэдний хүсэл нь Түүний хүсэлд багтдаг. (Иохан 5:30-ийг үзнэ үү.)

“Тэд үргэлж Их Эзэнд тааламжтай зүйлсийг үйлддэг. (Иохан 8:29-ийг үзнэ үү.)


“Тэд зөвхөн Их Эзэний төлөө үхээд зогсохгүй илүү чухал нь тэд Түүний төлөө амьдрахыг хүсдэг.

“Тэдний гэрт нь ороход тэдний ханан дахь зургууд, тавиур дээрх номууд, тэнд сонсогдох хөгжим, тэдний үгс болон үйлдлүүд нь тэднийг Христэд итгэгчид гэдгийг илтгэдэг.

Тэд бүх цаг мөч, бүх зүйлс, бүх газарт Бурханы гэрч болон зогсдог. (Мозая 18:9-ийг үзнэ үү.)

Тэд санаа бодол болгондоо Христ рүү харах үедээ оюун бодолдоо Түүнийг агуулдаг. (С ба Г 6:36-г үзнэ үү.)

“Тэд дур хүслээ Түүнд мөнхөд захируулснаар тэдний зүрх сэтгэлд Христ оршдог. (Алма 37:36-г үзнэ үү.)” (“Born of God,” *Ensign*, 1985 оны 11-р сар, 6–7).

 **7.** Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултад хариулж бич: Та энэ долоо хоногийн турш Их Эзэнд амьдралаа бүрэн зориулж байгаагаа харуулж болох ямар арга замууд байна вэ?

Алма 24:23–27-г уншиж, леменчүүд Антай-Нифай-Лихайчуудыг байлдахгүй байгааг хараад ямар үйлдэл хийснийг олж мэд. Энэ судрыг уншихдаа дараах зарчмыг зааж байгаа үг хэллэгүүдийг ол: **Бид Их Эзэнд итгэлтэй байснаараа бусдад хөрвөгдөхөд нь тусалж чадна.** Их Эзэнд итгэлтэй байх шийдвэр тань танай гэр бүлийн тодорхой гишүүд эсвэл зарим найзуудад тань хэрхэн нөлөөлж болохыг бод.

 **8.** Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Алма 23–24-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

18-Р ХЭСЭГ: 1 ДЭХ ӨДӨР

Алма 25–29

Оршил

Аммон олон жилийн турш сайн мэдээг номлосныхоо дараа Их Эзэнийг магтан, леменчүүдэд сайн мэдээг хүргэхэд Түүний мутар дахь зэмсэг байсан адислалынхаа төлөө талархлаа илэрхийлжээ. Олон леменчүүд Их Эзэнд итгэж, наманчилж эхэлдэг бөгөөд өөрсдийгөө Антай-Нифай-Лихайчууд хэмээн нэрлэв. Антай-Нифай-Лихайчууд дайны зэр зэвсгээ дахин хэзээ ч агсахгүй хэмээн Их Эзэнтэй гэрээ хийсний дараа амаликайчууд болон леменчүүд тэдэнтэй дайтахаар бэлтгэж эхэлдэг. Тэдэнд Их Эзэнтэй хийсэн гэрээгээ сахихад нь тусалж, тэднийг хамгаалахыг хүссэн нифайчуудын саналыг Антай-Нифай-Лихайчууд хүлээн авдаг. Нифай үндэстний бошиглогч Алма сайн мэдээг номлохоор мөн бусдыг Есүс Христэд ирэхэд урьснаар мэдэрсэн баяр баяслаа илэрхийлэв.

Алма 25

Абинадайн бошиглол биелж, олон леменчүүд хөрвөгдөв

Та Есүс Христийн сайн мэдээнд илүү ихээр хөрвөгдсөн үеийнхээ өөрчлөлтүүдийн талаар бод. Алма 25 нь Ноагийн пристүүд баригдаж, алагдах болно гэсэн Абинадайн бошиглолын биелэлтийг өгүүлдэг бөгөөд Их Эзэн бошиглогчдоо хамгаалж, тэдний



сүнслэгээр өдөөгдсөн бошиглолуудыг биелүүлдгийг харуулдаг (Алма 25:9-ийг үзнэ үү). Мөн хэчнээн леменчүүд наманчилж, Антай-Нифай-Лихайчуудтай нэгддэг тухай өгүүлдэг. Алма 25:14-ийг уншиж, эдгээр леменчүүд сайн мэдээнд хөрвөгдөх үедээ юу хийснийг тодорхойл. Алма 25:15-аас тэд яагаад Мосегийн хуулийг дагадаг байсны хоёр шалтгааныг бид олж мэддэг.

Алма 26

Аммон леменчүүд болон Мозаягийн хөвгүүдэд хандсан Их Эзний нигүүлсэлд баярладаг.

Байшин эсвэл сүм барихад юу хэрэгтэй вэ? Чадварлаг дархан тохирох багаж хэрэгсэл ашиглан ямар сүм барьж чадах вэ? Алма 26-д Аммон өөрийгөө болон дүү нараа Бурханы агуу ажилд Түүний мутар дахь зэмсгүүд байсан хэмээн дүрсэлжээ. Алма 26:1–5, 12–13-ыг уншиж, Их Эзэн Аммон болон түүний дүү нарыг мутар дахь зэмсгээ болгосноор юуг гүйцэлдүүлснийг тодорхойл. (Та олсон хариултаа судартаа тэмдэглэх хэрэгтэй.) 5-р шүлэг дэх “чадлаараа хадах” нь хичээнгүйлэн ажиллах гэсэн утгатай, “боодлууд” нь хөрвөгчдийг, “тариа хадгалах газрууд” нь сүмийг төлөөлдөг бөгөөд цугларагсад нь “үрэгдэхгүй” гэсэн нь Бурхан хөрвөгчдийг хамгаалж мөн тэдэнд мөнх амьдралыг өгөх болно гэсэн утгыг илэрхийлдэг.

Алма 26:12 дахь Аммоны тэрээр зөвхөн Их Эзний мутар дахь зэмсэг байсан бөгөөд түүний номлолын турш гайхамшгуудыг үйлдсэн нь Их Эзэн байсан гэдгийг ойлгосныг харуулж байгаа нэг эсвэл илүү олон хэллэгүүдийг тодорхойлох эсвэл тэмдэглэ.

Бид эдгээр шүлгүүдээс дараах зарчмыг сурдаг: **Бид өөрсдийгөө бэлтгэж, даруусгах үед Их Эзэн биднийг хүчирхэгжүүлж, мутар дахь зэмсгээ болгодог.** Бид бас Алма 26-аас хамтрагч байх зарчмыг сурч болно: **Бид Их Эзэнд болон Түүний хүүхдүүдэд итгэлтэйгээр үйлчилснээр баяр баяслыг мэдэрдэг.** Алма 26:11, 13, 16-г уншиж, баясал эсвэл баярлах гэсэн үг бүрийг тэмдэглэ.

Алма 26:13–16-г уншиж, Аммоны дурдсан баясах шалгаануудыг ол.



1. Бид Их Эзэнд үйлчлэх үедээ яагаад баяр баяслыг мэдэрдэг гэж бодож байгаагаа судар судлах тэмдэглэлдээ бич. Мөн та сүмд үйлчилснээр баяр баяслыг мэдэрсэн үеийнхээ тухай бичих хэрэгтэй.

Дараах шүлгүүдийг уншиж, дагалдах асуултуудын хариултыг бод:

Алма 26:22–23, 26–29. Бурханы нууцуудыг мэдэхэд шаардлагатай зүйлсийн жагсаалтыг анхаар. Эдгээр шаардлагуудыг хангасан номлогчдод ямар амлалт өгөгдсөн бэ? Аммон болон түүний ах дүүс Их Эзэн болон леменчүүдэд үйлчлэх үйлчлэлийнхээ үед ямар саад бэрхшээлүүдтэй тулгарч байсан бэ? Эдгээр саад бэрхшээлүүдээс аль нь эдүгээ Их Эзэнд үйлчилж байгаа хүмүүст тулгарч байгаа саад бэрхшээлүүдтэй төстэй байна вэ? Өнөө үеийн номлогчид сайн мэдээг хаана заах ёстой талаар Алма 26:29-өөс юу сурч болох вэ?

Алма 26:30. Мозаягийн хөвгүүдийг хэцүү цаг үед ч үргэлжлүүлэн үйлчилсээр байхад нь юу урам дэм өгч байсан бэ?



2. Алма 26:35–37-г уншиж, дараах асуултуудад судар судлах тэмдэглэлдээ хариулж бич:

а. Эдгээр шүлгүүдэд заагдсан ямар үнэнүүд таны хувьд Бурханы сайн сайханд баясах шалтгаан болж болох вэ? (Та эдгээр үнэнүүдийг харуулсан хэллэгүүдийг тэмдэглэх хэрэгтэй.)

б. Бурхан танд анхаарал тавьдгийг мэдэх нь танд ямар өөрчлөлт гаргах вэ?

Алма 27

Аммон Антай-Нифай-Лихайчуудыг нифайчуудын дундах аюулгүй байдал руу удирдав

Алма 27-г судлахаар бэлтгэх үедээ дараах асуултуудын хариултыг бод:

- Хэн нэгэн чамд амлалт өгчихөөд амлалтаа зөрчсөн тохиолдол бий юү?
- Танд амласан зүйлээ үргэлж биелүүлдэг байсан хэн нэгнийг та мэдэх үү?
- Амлалтаа биелүүлдэг хүмүүсийн талаар та ямар бодолтой байдаг вэ? Яагаад?

Нифайчуудыг устгах амжилтгүй оролдлогуудынхаа дараа леменчүүд Аммон болон түүний дүү нараар хөрвөгдсөн леменчүүдийг (Антай-Нифай-Лихайчуудыг) устгахаар оролддог. Антай-Нифай-Лихайчууд дахин хэзээ ч хүний амь хөнөөхгүй гэсэн гэрээгээ сахих болно гэдгээ харуулахын тулд дайны зэр зэвсгээ булшилсныг сана. Антай-Нифай-Лихайчууд тэрхүү гэрээгээ сахихдаа хэр зэрэг үнэнч байсныг мэдэхийн тулд Алма 27:2–3-ыг унш.

Дайралтад өртөх үедээ ч зэр зэвсгээ агсахгүй гэсэн гэрээгээ эрхэмлэн сахисан Антай-Нифай-Лихайчуудын амлалтынх нь хүчийг төсөөлөн бод. Та гэрээгээ сахих нь хэцүү юм шиг санагдсан үед ч Тэнгэрлэг Эцэгтэй хийсэн гэрээнүүдээ сахихын тулд амлалтаа хэрхэн хүчирхэгжүүлж болохыг бодож үзнэ үү.



Аммон ёс бус леменчүүдийн аллага болон дайралтуудаас болж Антай-Нифай-Лихайчуудыг Зарахемла хот руу удирдав. Энэ хот нифайчуудын хот байсан бөгөөд тэнд нифайчууд тэднийг дайснаас нь хамгаалах болно хэмээн амласан ажээ. Та эргэн тойрныхоо хүмүүст Их Эзэнтэй хийсэн гэрээгээ сахихад нь туслахын тулд юу хийж болохыг бодож үзнэ үү.

Антай-Нифай-Лихайчуудыг Зарахемлад очсоных нь дараа нифайчууд тэднийг Аммоны хүмүүс гэж нэрлэв. Алма 27:27–30-ийг уншиж, Аммоны хүмүүс юугаараа танигдах болсныг олж мэд. Дараах зарчмыг зааж байгаа үг хэллэгүүдийг тэмдэглэ: **Бид Их Эзэнд бүрэн хөрвөгдсөн үед Түүнтэй хийсэн гэрээнүүдээ сахидаг.**



3. Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултуудын нэгэнд эсвэл хоёуланд нь хариулж бич:

- Их Эзэнтэй хийсэн гэрээнүүдээ сахихад хэцүү байсан ч гэрээнүүдээ тууштай сахисан ямар туршлагууд танд байдаг вэ?
- Их Эзэнтэй хийсэн гэрээнүүдээ үнэнч итгэлтэй байсан ямар хүн танд үлгэр жишээ үзүүлсэн бэ? Тэр хүн гэрээнүүдээ итгэлтэй байдлыг хэрхэн харуулсан бэ?

Алма 28

Нифайчууд леменчүүдийг агуу тулаанд ялав



4. Та өөрийгөө Алма 28 дахь бүх үйл явдлын тухай илтгэх даалгавар авсан сурвалжлагч гэж төсөөлөн бод. Алма 28:1–6, 11–14-ийг уншиж, болсон үйл явдлуудын товч тэмдэглэлийг судар судлах тэмдэглэлдээ бич. Дараах асуултуудын хариултыг тэмдэглэлдээ оруулахад анхаар.

- Нифайчууд Аммоны хүмүүст гэрээгээ сахихад нь туслахын тулд хэр зэрэг их төлөөс төлсөн бэ? (Алма 28:1–3-ыг үзнэ үү.)
- Олон хүн амь насаараа төлөөс хийсэн нь нифайчуудад хэрхэн нөлөөлсөн бэ? (Алма 28:4–6-г үзнэ үү.)

в. Зарим хүмүүс баярлаж, итгэл найдвараар дүүрэн байхад яагаад зарим нь хайртай хүмүүсээ үхэх үед айж байсан бэ? (Алма 28:11–12-ыг үзнэ үү.)

Алма 28:11–12-оос сурсан зүйлийнхээ гол зарчмыг агуулсан нэг өгүүлбэр бич. _____

Алма 28-д заагдсан зарчмуудын нэг нь: **Бид Есүс Христ болон Түүний амлалтуудад итгэх үедээ үхлийг үл харгалзан найдвар болон баяр баясгалантай байж чадна** гэсэн зарчим юм.



5. Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултуудын нэгэнд эсвэл хоёуланд нь хариулж бич:

- Та хэн нэгнийг Есүс Христэд итгэх итгэлийнхээ улмаас өөрийнхөө эсвэл хайртай хүнийхээ үхэлтэй итгэл найдвараар нүүр тулсныг харж байсан уу?
- Та хэн нэгнийг хайртай хүнийхээ үхлийн дараа итгэл найдвартай байхад нь туслахын тулд үхлийн талаар хэрхэн тайлбарлах вэ?

Алма 28:13–14-өөс “бид харлаа” хэмээн Мормоны бичсэн гурван өгүүлбэрийг ол. Та эдгээрийг судартаа тэмдэглэх хэрэгтэй. Мормон леменчүүдэд хийсэн Мозаягийн хөвгүүдийн номлолын талаарх цэдгийг дуусгахдаа ямар зүйлүүдийг онцолсон бэ? Яагаад эдгээр үнэнүүдийг мэдэх нь танд чухал болохыг тунгаан бод.

Алма 29

Алма бодгалиудыг Бурханд авчрахад баясав

Та зарим агуу зүйлсийг ганцаараа авчрахыг эсвэл дэлхийд болж байгаа аймшигтай муу зүйлсийг ганцаараа таслан зогсоох хүчтэй ч болоосой гэж мөрөөдөж байсан уу? Алма 29 нь Алма Их Эзэний мутар дахь зэмсэг байх хүслээ илэрхийлснийг агуулдаг. Алма 29:1–3-аас Алмагийн зүрх сэтгэлийн чин хүслүүдийг олж мэд.

Алмаг залуу эр байхад юу тохиолдсоныг санаж, Алма яагаад ийнхүү хүслээ илэрхийлснийг анхаарч үзнэ үү. Алма 29:3-т Алма яагаад хүсэлдээ нүгэл үйлдэж байна гэж бодсон бэ? Алма 29:4–5-ыг уншиж, Их Эзэн зөв шударга хүсэлтэй хүмүүст юу өгдгийг олж мэд.

Алма 29:10, 14–16-гаас Христэд хүмүүсийг авчирсны төлөө Алмагийн хүлээн авсан шагналуудыг олж тэмдэглэ. Та эдгээр шүлгүүд дэх Алмагийн хэлсэн *баясал* гэсэн үг бүрийг тэмдэглэх хэрэгтэй.

Алма 29-д заагдсан нэг зарчим бол: **Бид бусдыг наманчилж, Есүс Христэд ирэхэд нь тусалснаар баяслыг мэдэрдэг.** Христэд ирэхэд нь бусдад



тусалснаар баяр баяслыг мэдрэхэд тань нөлөөлсөн ямар туршлага танд байдаг вэ?

Та дараах бүлэг хүмүүсийн хүн нэг бүрд амьдралд нь хэрэгтэй өөрчлөлтүүдийг хийж, Есүс Христэд ирэхэд нь тусалж болох арга замуудыг тунгаан бод: (а) таны найзууд, (б) гэр бүлийн тань гишүүд, мөн (в) тийм ч сайн мэдэхгүй хүмүүс. Бусдыг Есүс Христэд авчрах боломжуудыг хайхдаа Сүнсний удирдамжийг эрэлхийл.



4. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Алма 25–29-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна.

18-Р ХЭСЭГ: 2 ДАХЬ ӨДӨР

Алма 30

Оршил

Леменчүүдтэй хийсэн агуу тулааны дараа Зарахемла нутаг даяар амар амгалан тогтов. Энэхүү амар амгалангийн дунд үед Корихор хэмээх нэгэн, Христ гэж байхгүй хэмээн номлож эхлэв. Түүний хуурамч сургаал түүнд итгэсэн хүмүүсийг нүгэл рүү хөтлөв. Тэрээр сүмийн удирдагчдын эсрэг ярьж, тэднийг “мунхаг уламжлал” (Алма 30:27) зааж байна хэмээн мэдэгджээ. Корихорыг Алмагийн өмнө авчирсанд, Алма түүнд бүх зүйл Христийг гэрчилдгийг заав. Эцэст нь, Корихор үйлдлүүдийг нь чөтгөр удирдаж байсныг хүлээв.

Алма 30:1–29

Христийг үгүйсгэгч Корихор Христийн сургаалаар доог тохуу хийв

Хэн нэгэн танд хоол хийж өгсөн байна гэж төсөөлөн бод. Энэ нь амттай харагдаж бас үнэртэж байсан ч таныг тэр хоолыг идэхэд та гүн хордлого авав. Хуурамч сургаалууд нь амттай юм шиг харагдавч нууцаар хордуулдаг хоолтой хэрхэн адилхан байж болохыг хэсэг хугацаанд бод.

Та өмнө нь Христийг эсэргүүцэгч Шерим (Иаков 7-г үзнэ үү), Нихор нарын тухай (Алма 1-ийг үзнэ үү) үзсэн. *Христийг эсэргүүцэгч* гэдэг нь “үнэн сайн мэдээний авралын төлөвлөгөөг хуурамчаар дуурайдаг, түүнчлэн Христтэй ил эсвэл далд сөргөлддөг ямар нэг юм эсвэл хүн” гэсэн тодорхойлолтыг сана (Судруудын удирдамж, “Христийг эсэргүүцэгч,” scriptures.lds.org). Өнөөдөр та Христийн дайсан байсан мөн хуурамч сургаалуудаар бусдыг мэхэлж, нүгэл рүү хөтөлсөн өөр нэгэн хүний тухай үзэх болно. Одоо ч дэлхий дээр олон хүмүүс Бурханд итгэх итгэлээ илэрхийлдэг хүмүүсийн эсрэг Корихорын адил маргалддаг.

Корихор нифайчуудын дунд номлож эхлэв. Алма 30:6, 12-ыг уншиж, Корихор бол Христийг эсэргүүцэгч гэдгийг нотолж байгаа хэллэгүүдийг ол.

Алма 30:12–18-ыг уншиж, Корихорын хуурамч заалтуудыг тэдний далд санаархалтай тохируул.

Христийг эсэргүүцэгч Корихорын зарим хуурамч сургаал	Хуурамч сургаалуудын боломжит зарим тайлбар ба далд санаархал
___ 1. Алма 30:13–14	А. Шашны үнэнүүдийн талаар бодит нотолгоо байхгүй бол та Есүс Христ эсвэл Түүний сайн мэдээнд итгэх ёсгүй. Ариун Сүнсээр дамжин ирдэг хувийн илчлэлт гэгч зүйл байдаггүй.
___ 2. Алма 30:15	Б. Нүгэл гэж байдаггүй. Юу зөв эсвэл юу нь буруу гэсэн бүх нийтийн жишиг гэж байдаггүй.
___ 3. Алма 30:16	В. Хүмүүс зөвхөн өөрсдийн хичээл зүтгэлээр хөгжин дэгждэг. Хүмүүний ажил үйлсэд Бурхан хэрэггүй.
___ 4. Алма 30:17 (“хүн бүр . . . удирдах”)	Г. Бошиглогчдын үгс болон судрууд үнэн биш, тиймээс та тэдний бошиглолуудад итгэх ёсгүй.
___ 5. Алма 30:17 (“хүмүүний хийсэн юу боловч . . .”)	Д. Нүглүүдийн уучлал гэж байдаггүй. Цагаатгалаар дамжуулан тусламжийг эрэлхийлэх хэрэггүй, учир нь Цагаатгал гэж байхгүй.
___ 6. Алма 30:18	Е. Үхлийн дараах амьдрал гэж байхгүй, тиймээс энэ амьдралын дараах шүүлтэнд бэлтгэх хэрэггүй.

(Энэхүү тааруулах дасгалын хариултууд нь энэ хичээлийн төгсгөлд байгаа.)

Алма 30:18 нь уг зарчмыг заадаг: **Сатан биднийг нүгэл үйлдэхэд уруу татахын тулд хуурамч сургаалуудыг ашигладаг.**

Арванхоёр төлөөлөгчийн чуулгын Ерөнхийлөгч Бойд К.Пакэр заасан нь:



“Бидний зан байдал төрөлх хүслээр бүрэн хянагддаггүй. Зан байдал нь мөн итгэл үнэмшлээр эхэлдэг.

“Итгэл үнэмшил нь гүн ухаанаас эсвэл сургаалаас төрдөг. Сургаал нь сүнслэг эсвэл дэлхийн, үр ашигтай эсвэл хор хөнөөлтэй, үнэн эсвэл худал байж болно. . . .

“Үнэн сургаалыг ойлгох нь хүмүүсийн зан төлөв, харьцаа хандлагыг өөрчилдөг” (“Little Children,” *Ensign*, 1986 оны 11-р сар, 17).



1. Тааруулах дасгалын хүснэгтэд жагсаасан Корихорын хуурамч сургаалуудаас хоёрыг эсвэл үүнээс олныг сонго. Судар судлах тэмдэглэлдээ үнэн сургаалуудыг бичиж, үнэнийг мэдэх нь таны зан байдал болон хандлагад хэрхэн нөлөөлөхийг хэл.

Корихор Зарахемлагийн нутагт амжилт олсныхоо дараа Жершоны нутаг руу Аммоны хүмүүст номлохоор явав. Алма 30:19–20-ыг уншиж, тэд түүний хуурамч сургаалуудыг хүлээн зөвшөөрсөн эсэхийг олж мэд.

Аммоны хүмүүс “нифайчуудын олноос илүү цэцэн байв” мөн “түүнийг уг нутгаас гаргуулав” (Алма 30:20–21). Та Аммоны хүмүүсийн талаар мэдсэн зүйлээсээ үндэслэн тэд яагаад Корихорын хуурамч сургаалуудад итгээгүй гэж бодож байна вэ?



Алма 30:21–29-д Корихор Гидеоны нутаг руу явж, “мөн энд тэрээр их амжилттай байсангүй” (Алма 30:21) гэж гардаг. Сүмийн эсрэг Корихорын гаргасан зарим маргаан болон сургаалууд нь Алма 30:24, 27-д байдаг бөгөөд тэдгээрээс хоёр нь: (1) Бурханд итгэдэг хүмүүс боолчлолд байдаг, (2) шашин нь эрх чөлөөгүй болгодог гэсэн хуурамч сургаалууд юм. Шашныг эсэргүүцэгчид эдгээр хуурамч сургаалуудыг өнөөдөр ч ашигласаар байна.

Тэргүүн зөвлөлийн Ерөнхийлөгч Хэнри Б.Айринг Бурханд итгэх итгэл нь бидэнд эрх чөлөө олгодгийг ийн заасан юм: “Корихор Бурханы үйлчлэгчдийн зөвлөгөөг дагана гэдэг нь Бурханаас соёрхсон бие даасан байдлын эрхүүдээсээ татгалзана гэсэн хэрэг хэмээн цаг хугацааны эхлэлээс буруу маргаан дэгдээсээр ирсэн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдтэй адилаар маргаж байлаа. Гэвч уг маргаан бодит байдлыг

мушгин гуйвуулдаг учраас худал юм. Бид Бурханаас ирэх зөвлөгөөг эсэргүүцсэнээрээ гадны нөлөөнөөс ангид байж чаддаггүй. Харин бид өөр нөлөөллийг сонгодог. Бид ингэснээрээ бүхнийг чадагч, бүхнийг мэдэгч, биднийг төгс хайрлагч Тэнгэрлэг Эцэгийнхээ хамгаалалтаас татгалздаг. Түүний туйлын зорилго нь Хүүгийнхтэйгээ яг адил бидэнд мөнх амьдралыг мөн Өөртөө байгаа бүхнийг өгч, биднийг гэр бүлээр нь тэнгэрлэг гэртээ буцаан аваачиж, хайрын мутартаа тэврэх явдал юм. Бид Түүний зөвлөгөөг эсэргүүцсэнээр Сатаны нөлөөг сонгодог. Сатаны зорилго нь биднийг олиггүй муухай болгох явдал бөгөөд түүний хөдөлгөгч хүч нь үзэн ядалт юм. Бурханы бэлэг болох ёс суртахууны сонгох эрх бидэнд байдаг. Энэ нь аливаа нөлөөнөөс ангид байхыг сонгох эрх гэхээс илүүтэйгээр аль нэг сонгосон хүчинд нь захирагдах салшгүй эрх юм” (“Finding Safety in Counsel,” *Ensign*, 1997 оны 5-р сар, 25).



2. Корихорын заасан шиг хуурамч сургаалуудад итгэхээ өөрийгөө хамгаалахад нь өөр хүнд туслухын тулд та юу гэж зөвлөхөө судар судлах тэмдэглэлдээ бич.

Алма 30:30–60

Корихор Алмагаас тэмдэг шаардаж, Бурханы хүчээр цохигдон хэлгүй болов

Эцэст нь, Корихор Алмагийн өмнө авчрагдав. Алма 30:30–31-ийг уншиж, Алма болон сүмийн бусад удирдагчдыг Корихор юу гэж гүжирдсэнийг олж мэд. “Хүмүүсийн хөдөлмөрөөр хөрөнгөжих” гэдэг нь Алма болон бусад удирдагчид сүмийн үйлчлэлийнхээ улмаас баяжиж байна гэсэн далд утгыг агуулж байгаа юм. Дараах асуултуудын хариултыг бод:

- Сүмийн удирдагчидтайгаа харилцсан туршлагаас тань үзвэл, эдгээр гүтгэлгүүд яагаад худал вэ?
- Хэрэв та Алмагийн оронд байсан бол Корихорын гүтгэлгүүдэд хэрхэн хариулах байсан гэж бодож байна вэ?

Алма 30:32–35-ыг уншиж, Корихорт өгсөн Алмагийн хариултыг олж мэд. Алмагийн хариултын үнэн байдлыг тойрог, салбарынхаа удирдагчдын эсвэл таны хүндэлж явдаг сүмийн гишүүдийн амьдралд харж байсан талаараа бод.

Боломжтой бол нэг найзаасаа эсвэл гэр бүлийн гишүүнээсээ Алма 30:37–45-ын хамт уншихыг хүс. Нэг нь Алмагийн үгсийг, нөгөө нь Корихорын үгсийг унш. Хамтдаа уншиж байхдаа Бурхан оршдогийн нотолгоо болгон Алма юу гэж хэлснийг олж мэд. (Хэрэв хэн нэгэн тантай хамт унших боломжгүй бол уншихдаа хоёр хүний хооронд болж буй харилцан яриаг төсөөлөн бод.)



3. Дараах даалгавруудыг судар судлах тэмдэглэлдээ хий:

а. Алмагийн эш татсан нотолгоонуудын аль нь танд Бурхан байдгийг онцгой утга учиртайгаар гэрчилж байгааг мөн энэ нь яагаад таны хувьд Тэрээр оршдог гэсэн хүчтэй гэрчлэл болж байгааг бич.

б. Таны амьдралдаа харсан, “Бурхан байдгийг үзүүлдэг” (Алма 30:44) дор хаяж гурван өөр нотолгоог бичиж, нотолгоо бүр нь Бурханд итгэх итгэлийг тань хэрхэн бэхжүүлснийг товчхон тайлбарла.

Таны судалсан шүлгүүдэд байдаг нэг сургаал нь: **Бүх зүйл Эрхэм дээд Бүтээгч, Бурхан байдгийг гэрчилдэг.** Эдгээр нотолгоо, гэрчлэлүүдийг олж мэдэн, санаж байхыг сонгох үед таны итгэлд юу тохиолдохыг бодож үзнэ үү.

Бошиглогч Алма Корихортой харилцахдаа юу хийснийг олж мэд: тэрээр хуурамч сургаалуудыг залруулж (Алма 30:32–35-ыг үзнэ үү), үнэнийг гэрчилж (Алма 30:37–39-ийг үзнэ үү), Корихорт нотолгооны хүндийг үүрүүлж (Алма 30:40–42-ыг үзнэ үү), Бурхан оршдогийг нотолжээ (Алма 30:44-ийг үзнэ үү). Үнэний эсрэг маргалддаг хүмүүстэй хэрхэн харьцах талаарх Алмагийн үлгэр жишээнээс та юу сурч болох вэ?



Зарим үед бидний итгэлийг дайрч давшилдаг хүмүүсийн эсрэг хийж болох цорын ганц хамгаалалт нь үнэний гэрчлэлээ хуваалцах явдал юм. Энэ аргыг хэрэглэхдээ санаа зовох хэрэг огт байхгүй. Бурханы бошиглогч, Алма

Корихортой харилцахдаа үүнийг ашигласан юм. Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Жэффри Р. Холланд тайлбарласан нь: “Корихорын маргаан нь орчин үеийн уншигчдад өнөө үеийнх шиг санагддаг, гэвч Алма хариултдаа энэ нь тодорхой цагт хамаарахгүй бөгөөд эцэст нь үгүйсгэж болшгүй зэмсэг буюу —хувийн гэрчлэлийн хүчийг ашигласан юм (*Christ and the New Covenant* [1997], 121).

Бурхан оршдогийг Алма Корихорт батлахаар хуваалцсан олон нотолгоо эсвэл тэмдгүүдийг эс хайхран, Корихор өөр тэмдгийг хүсч, цохигдон хэлгүй болдог (тэр ярьж чадахгүй болжээ; Алма 30:45–50-ийг үзнэ үү). Алма 30:51–53-ыг уншиж, Корихор яагаад тэдгээр зүйлүүдийг заасан гэж хэлснийг олж мэд.

Корихор худал сургаалуудыг цаашид зааж чадахаа больсон үед хуурамч санаануудаа “тэдгээр нь эгэл оюунд таалагдах байсан учир” (Алма 30:53) зааснаа хүлээн зөвшөөрдөг. “Эгэл оюунтай” байна гэдэг нь дэлхийн таашаалд эсвэл биеийн шунал хүсэлд нийцсэн зүйлүүдэд анхаарал төвлөрүүлэх гэсэн утгатай юм. Корихорын сургаалуудад итгэсэн хүмүүс махан

биеийн таашаал болон материаллаг зүйлүүдээр юу ч хийлээ гэсэн ямар нэгэн үр дагавар байхгүй гэж боджээ. Эдгээр санаанууд нүгэлт амьдрал руу хөтөлдөг (Алма 30:18-ыг үзнэ үү).

Алма 30:54–59-д Корихор хөөгдөж, айлаас айл дамжин хоол гуйж явсан бөгөөд эцэст нь түүнийг хүмүүс дэвсэлж алжээ. Алма 30:60-ыг уншиж, Сатаныг дагахаар сонгосон хүмүүст эцэст нь юу тохиолддог тухай чухал үнэнийг олж мэд. Судартаа дараах хэллэгийг тэмдэглэ: **“Чөтгөр эцсийн өдөр өөрийн хүүхдүүдийг [өөрийн дагалдагчдыг] эс дэмждэг.”** (Энэ шүлэгт хүүхдүүд гэдэг нь дагалдагчид гэсэн утгатай.)

 **4.** Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

а. Алма 30:60-д таны тэмдэглэсэн үнэн нь Корихорын амьдралд хэрхэн тодорхой харагдсан бэ?

б. Алма 30:60-ыг Алма 36:3-тай харьцуул. Бурхан зарлигуудыг нь дагахыг хичээдэг хүмүүсийг дэмжсээр байдаг гэсэн ямар нотолгоог та өөрийнхөө амьдралд эсвэл бусдын амьдралд харсан бэ?

Өнөөдөр судалсан үнэн зарчмууд болон сургаалуудаа эргэн хар. Корихорын заасантай адил хуурамч сургаалуудад мэхлэгдэхээс зайлсхийж болох арга замуудын талаар бод.

 **5.** Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Алма 30-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

Тааруулах дасгалын хариултууд: (1) Г, (2) А, (3) Д, (4) В, (5) Б, (6) Е

18-Р ХЭСЭГ: 3 ДАХЬ ӨДӨР

Алма 31

Оршил

Зорамчууд гэж нэрлэгдсэн нифайчуудаас тэрслэгч хэсэг хүмүүс сайн мэдээний үнэнээс нүүр буруулсныг Алма мэджээ. Алма эдгээр ёс бус явдлуудын тухай мэдээнд шаналж, Бурханы үгийг зорамчуудад заахаар бусад хүмүүсийг авч явав. Тэд зорамчуудын урвасан сүсэг бишрэл болон бардамналыг үзэв.

Алма зорамчуудыг Их Эзэнд буцаан авчрахад тэрээр хамтрагчидтайгаа тайтгарал болон амжилтын төлөө чин сэтгэлээсээ залбирчээ.

Алма 31:1–7

Алма болон түүний хамтрагчид урвасан зорамчуудад Бурханы үгийг номлосон нь


Таны нэг найз эсвэл гэр бүлийн гишүүн сайн мэдээнээс нүүр буруулж эхэлж байна эсвэл сайн мэдээний дагуу хэрхэн амьдрах ёстойгоороо бүрэн амьдрахгүй байна гэж төсөөлөн бод. Дараах асуултуудын хариултын талаар бод:

- Та энэ хүнд сүмд буцан ирж, зарлигуудыг сахих хүсэлтэй болоход нь туслахын тулд юу хийж болох вэ?
- Та энэ хүний асуудлууд болон буруу ойлголтуудыг залруулахыг хичээхдээ хэнээс тусламж хүсч болох вэ?

Энэ хичээл нь Алма болон бусад хүмүүс сайн мэдээний үнэнүүдээс нүүр буруулан урвасан хэсэг хүмүүст туслахаар хэрхэн хичээж байсныг онцлон харуулдаг. Алма 31:1–2-ыг унш. Алма зорамчуудын хийж буй зүйлүүдийн талаар сонсоод юу мэдэрсэн бэ? _____

Алма 31:3–4-ийг уншиж, зорамчуудын үйлдлүүдээ болж нифайчууд яагаад айж эхэлснийг тодорхойл.

Мормоны Номыг судлах үедээ сурч мэдсэн зүйлүүдийнхээ талаар бодож, зорамчуудыг наманчилж, сайн мэдээний үнэнүүдэд буцан ирэхэд нь юу урамшуулж чадна гэж та бодож байна вэ? Алма 31:5-ыг уншиж, зорамчуудыг буцаан авчрахад хамгийн үр дүнтэй байж болох Алмагийн мэдэж байсан аргыг олж тогтоо.

 **1.** Та яагаад албадлага эсвэл бусад зүйлүүдийг ашиглах биш, харин Бурханы үгээр хүмүүст өөрчлөгдөхөд туслах нь илүү хүчтэй гэж бодож байгаагаа судар судлах тэмдэглэлдээ бич.

Бурханы үгийн хүчийн талаарх Арванхоёр төлөөлөгчийн чуулгын Ерөнхийлөгч Боид К. Пакэрын дараах үгсийг тунгаан бод:

“Үнэн сургаалыг ойлгох нь хүмүүсийн зан төлөв, харьцаа хандлагыг өөрчилдөг.



“Сайн мэдээний сургаалуудыг судлах нь зан төлөвийг судалж зан төлөвөө сайжруулснаас илүү хурднаар зан төлөвийг сайжруулах болно. Зохисгүй зан төлөвт автах нь зохисгүй зан төлөв рүү удирдаж болдог. Иймээс бид сайн

мэдээний сургаалуудыг судлахыг онцгой чухалчлан үздэг юм” (“Little Children,” *Ensign*, 1986 оны 11-р сар, 17).

Алма 31:5 болон Ерөнхийлөгч Пакэрын үгс дээр тулгуурлан дараах зарчмыг гүйцээж бич: **Би Бурханы үгийг судалснаар, энэ нь намайг** -д удирдах болно.

Энэ өгүүлбэрийг гүйцээж бичих олон боломжит хувилбар байгаа бөгөөд та дээрх зарчмыг ийм байдлаар гүйцээн бичиж болно: Би Бурханы үгийг судалснаар, энэ нь намайг зөв зүйлийг хийхэд удирдах болно.



2. Сударуудаас судалсан болон Бурханы үгийг сонссон туршлагаа тунгаан бод. Бурханы үг таныг, гэр бүлийг тань, эсвэл найз нарыг тань зөв зүйл хийхэд удирдсан үеийн талаар бич.

Алма 31:8–23

Зорамчууд буруу хэв маягаар залбирч, шүтэн биширдэг байв

Алма болон өөр долоон хүн зорамчуудад Бурханы үгийг номлохоор явав. Тэд хүрч ирсэн үедээ зорамчууд Бурханыг цочирдом байдлаар шүтэн биширч байгааг харжээ. Танд *шүтэн бишрэх* гэдэг үг юу бодогдуулж байна вэ?

Шүтэн бишрэх нь бид хэрхэн хайр, хүндэтгэл, мөн Бурханд бүхнээ зориулж байгааг харуулдаг. Шүтэн бишрэх нь ихэвчлэн залбирах, мацаг барих, сүмийн цуглаануудад оролцох үйлдлүүдийг багтаадаг. Хэдий тийм ч, жинхэнэ сүсэг бишрэл нь үргэлж зүрх сэтгэлтэй холбоотой байдаг. Алма 31:8–11-ийг уншиж, зорамчуудын шүтлэг бишрэлийг дүрсэлсэн үг хэллэгүүдийг олж тэмдэглэ.

“Сүмийн үйлүүд” (Алма 31:10) нь Мосегийн хуулийн үед шаардагддаг байсан өргөлүүд эсвэл өнөө үеийн ариун ёслол зэрэг “ёслолуудтай” холбоотой. Бид өдөр бүр шүтэн биширч, залбирах ёстой гэсэн нэг шалтгааныг Алма 31:10-аас олж тэмдэглэх хэрэгтэй.

Дараах зарчмыг судрынхаа Алма 31:9–11-ийн хажууд бичиж болно: **Бидний залбирах болон зарлигуудыг сахих өдөр тутмын хүчин чармайлт нь биднийг уруу таталтын эсрэг тэмцэхэд хүчирхэгжүүлдэг.**

Ахлагч Рулон Г.Крэйвэн далын гишүүнээр үйлчилж байхдаа өдөр тутмын хувийн шүтлэг бишрэл нь биднийг уруу таталт болон алдаанаас хамгаалдаг ач холбогдолтойг онцлон тэмдэглэжээ: “Сүүлийн



хэдэн жилд ах нар надаас наманчилж байгаа сүмийн гишүүдтэй тэдний ариун сүмийн адислалуудыг сэргээх ярилцлага хийж өгөөч гэж хүслээ. Нүглээ наманчилсан тэдгээр гайхалтай хүмүүсийн адислалуудыг сэргээх нь үргэлж сэтгэл догдлуулсан сүнслэг туршлага байсаар ирсэн билээ. Би тэдний заримаас нь, ‘Сүмийн гишүүнчлэлээ түр хугацаагаар алдахад хүргэсэн ямар зүйл таны амьдралд тохиолдсон юм бэ?’ гэж асуудаг байв. Тэд нүд дүүрэн нулимстайгаар ийн хариулдаг байлаа: ‘Би залбирах, сүмийн цуглаанд тогтмол оролцох, сүмд үйлчилж, сайн мэдээнээс суралцах зэрэг сайн мэдээний үндсэн зарчмуудыг дагаагүй. Тэгснээр би уруу таталтад бууж өгч, Ариун Сүнсний удирдамжийг алдсан’” (“Temptation,” *Ensign*, 1996 оны 5-р сар, 76).

Ахлагч Крэйвэний үгс Алма 31:9–11 дэх үнэнийг хэрхэн дэмжиж байна вэ?

Алма 31:12–23-ыг уншиж, зорамчуудын залбирахыг цамхаг дээрээс нь сонсвол ямар байхыг төсөөлөн бод. Дараах асуултуудын хариултын талаар бод:

- Хэрэв та хэн нэгнийг ийм байдлаар залбирч байгааг сонсвол юу сэтгэлийг тань зовоох байсан бол?
- Зорамчууд залбирлынхаа үеэр ямар худал сургаалуудыг хэлсэн бэ?
- Бусад хүмүүст хандсан тэдний хандлага ямар байсан бэ? Зорамчуудын залбиралд *бид*, *бидэнд* гэсэн үгс хэр зэрэг олон удаа давтагдаж байгааг олж мэд.)

Хүн бүр нэг л залбирлаа улиглан давтсаны дараа “гэд гэртээ эргэж очоод, гэд өөрсдөө мөнөөх ариун индэрт өөрсдийн маягаар талархал өргөхөөр дахин цугларах хүртлээ Бурханыхаа тухай дахин огт ярьдаггүй [байжээ]” (Алма 31:23).



3. Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултуудад харуулж бич:

- а.** Долоо хоногт ганцхан удаа шүтэн биширч, зарбирч, Бурханы талаар ганцхан удаа ярихын аюул нь юу вэ?
- б.** Бурханыг долоо хоногийн турш шүтэн биширч болох ямар арга замууд байдаг вэ?

Шүтэн бишрэхэд бидний хандлага мөн чухал юм. Бидний хандлага шүтлэг бишрэлд нөлөөлдөг тухай Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Даллин Х.Өүксийн дараах үгсийг унш:

“Шүтлэг бишрэл ихэнхдээ үйлдлээр илэрдэг. Харин жинхэнэ шүтлэг бишрэл нь үргэлж оюун санааны тодорхой хандлагыг агуулж байдаг.



“Шүтэн бишрэх хандлага нь үнэнч байдал, хайр хүндлэл, гайхал бахдлын гүнзгий мэдрэмжийг төрүүлдэг. Шүтлэг бишрэл нь хайр, хүндэтгэл хоёрыг нэгтгэдэг бөгөөд энэ нь бидний сүнсийг Бурханд илүү их ойртуулдаг үнэнч байдалд тохиодог юм” (*Pure in Heart* [1988], 125).



4. Та дараах зүйлүүдийг хийхдээ шүтлэг бишрэлдээ хэр зэрэг итгэлтэй байдаг болон хандлага тань ямар байдгийг судар судлах тэмдэглэлдээ бич: (а) өдөр тутмын хувийн залбирал, (б) өдөр тутам хувиараа судар судлах, (в) зарлигуудад дуулгавартай байх, (г) сүмийн цуглаануудад оролцож, долоо хоног бүр ариун ёслолоос хүртэх. Өдөр тутмын хувийн шүтлэг бишрэлээ дээшлүүлэх зорилго тавь. Та эцэг эх, удирдагч, эсвэл найз нөхдөдөө зорилгынхоо талаар ярьж болно. Ингэснээр тэд ирэх долоо хоногуудад танд урам дэм өгч чадна.

Алма 31:24–38

Алма зорамчуудыг Их Эзэнд буцаан авчрахдаа номлогчид хүч чадалтай байж, амжилт олохын төлөө залбирдаг

Алма зорамчуудын урвагч шүтлэг бишрэлийг үзсэнийхээ дараа Их Эзэнд хандан залбирчээ. Алма 31:30–35-ыг уншиж, Алмагийн залбирал зорамчуудынхаас хэрхэн ялгарч байгааг олж мэд.



5. Алмагийн болон зорамчуудын залбирлуудыг харьцуулснаар хэрхэн залбирах талаар юу сурснаа судар судлах тэмдэглэлдээ бич. Мөн Алмагийн зөв шударга залбирлын жишээ нь таны хувийн залбиралд хэрхэн нөлөөлж болохыг бич.

Алма 31:36–38-ыг уншиж, Алма болон түүний хамтрагчдад санваарын адислалуудыг хүлээн авч, сайн мэдээг заах үед тэдэнд ирсэн адислалуудыг олж мэдэн “өөртэйгөө хамт байсан тэд бүгдийн дээр гараа хавсрав” (Алма 31:36) гэдэг хэллэг нь гар тавилтыг хэлж байгаа гэдгийг анхаар.

Алма болон түүний хамтрагчдын туршлага нь дараах зарчмыг заадаг: **Хэрэв бид итгэлтэйгээр залбирч мөн үйлдвэл зовлон бэрхшээлүүддээ бурханлаг тусламж хүлээн авах болно.**



Алмагийн залбирлын дараа Алма болон түүний хамтрагчид хөдөлмөрлөж мөн Их Эзэнд болон Түүний хүүхдүүдэд үйлчлэх үедээ Их Эзэнээс дэмжлэгийг хүлээн авна гэж Их Эзэнд найдлагаа тавьснаар итгэлээ харуулсан юм. Итгэлтэйгээр залбирах Алмагийн үлгэр жишээг дагаж болох арга замуудыг ол.



6. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Алма 31-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

18-Р ХЭСЭГ: 4 ДЭХ ӨДӨР

Алма 32

Оршил

Зорамчуудын урвалтын шүтлэг бишрэлийн хэлбэрийг үзсэнийхээ дараа Алма болон түүний хамтрагчид зорамчуудад Бурханы үгийг номлов. Тэд зорамчуудын синагогуудаас хөөгдсөн ядуу хүмүүсийн дунд амжилт олж эхэлдэг. Алма тэдэнд үрийг суулгаж, арчлах зүйрлэлийг ашиглан Бурханы үгэнд итгэх итгэлийг хүлээн авч, арчлан тордохын тулд юу хийх ёстойг заав. Алма тэднийг (мөн биднийг) үгийг туршиж, итгэл ба гэрчлэлээ өдөр бүр арчлахад урьдаг.

Алма 32:1–16

Ядуугийнхаа улмаас даруусгагдсан зорамчуудад Алма заасан нь



1. Нэг найз тань танаас сүм үнэн эсэхийг хүн яаж мэдэж болохыг асууж байна гэж төсөөл. Хэрхэн гэрчлэлтэй болох тухай хариултаа судар судлах тэмдэглэлдээ бич. Тэгээд тэмдэглэлийнхээ дараагийн мөрөнд *Гэрчлэл хүлээн авч, хүчирхэгжүүлэх нь* гэж гарчигла. Та Алма 32-ыг судлахдаа гэрчлэл хэрхэн хүлээн авч, хүчирхэгжүүлэх талаар олж мэдсэн ойлголтуудаа уг гарчгийн доор жагсаан бич. Та энэ хичээлийн турш сурч мэдсэн ойлголтуудаа жагсаалтдаа нэмж бичих болно; тиймээс, та судар судлах тэмдэглэлдээ эхний болон хоёр дахь даалгаврынхаа хооронд зай үлдээх хэрэгтэй.

Та өмнөх хичээлээс (Алма 31) Алма болон түүний ах дүүс үнэнээс урваж холдсон нифайчуудын бүлэг болох зорамчуудын хуурамч шүтлэг бишрэлийг үзсэн тухай уншидаг. Алмагийн итгэлийн залбирлын дараа ах дүүсийнхээ хамт эдгээр хүмүүсийн дунд сайн мэдээг номлож эхэлдэг. Алма 32:1–3-ыг уншиж, зорамчуудын ямар хэсэг нь номлогчдын захиаст анхаарлаа хандуулсныг олж мэд.

Алма 32:4–6-г уншиж, тэдний ядуу зүдүү байдал хэрхэн адислал болон хувирсныг ол.

Эдгээр шүлгүүдэд дүрслэгдсэн нэг зарчим нь: **Даруу байдал нь биднийг Бурханы үгийг хүлээн авахад бэлтгэдэг гэсэн зарчим юм.** Судар судлах тэмдэглэлдээ “Гэрчлэл хүлээн авч, хүчирхэгжүүлэх нь” гэсэн гарчгийн доор *даруу бай* гэж бич.



2. Та яагаад даруу байдал нь гэрчлэлийг хүлээн авч, хүчирхэгжүүлэхэд зайлшгүй чухал гэж боддогоо судар судлах тэмдэглэлдээ бич.

Алма 32:13–16-г уншиж, хүмүүс даруусч болох өөр өөр арга замуудыг олж мэд. Алмагийн заасан дээр тулгуурлан та даруу байхаар сонгох эсвэл даруу байхаар албадуулах хоёрын алийг нь сонгох вэ? Яагаад?

Та “үгийн учир” (Алма 32:14) өөрийгөө даруусгана гэдэг нь ямар утгатай гэж бодож байгаагаа тунгаан бод. Энэ нь сүмийн үйл ажиллагаа, семинар, эсвэл гэр бүлийн үдэшт хандах хандлагыг тань хэрхэн өөрчилж болох вэ?

Та даруу байдлынхаа улмаас хүлээн авсан өдөөлтүүдээ хэрэгжүүлснээр даруу байхыг сонго.

Алма 32:17–43

Алма зорамчуудад итгэлээ хэрхэн хөгжүүлэхийг заасан нь

Алма зорамчуудад заах үедээ гэрчлэлтэй болох талаар олон хүмүүст байсан нэгэн буруу ойлголтыг

олж мэджээ. Алма 32:17–18-ыг уншиж, энэхүү буруу ойлголтыг ол.

Тэмдэг шаардах нь итгэл ба гэрчлэлийг бий болгоход хэрхэн саад болж болох талаар хэдэн хором бодож үз. (Та нэмэлт ойлголт авахын тулд *С ба Г 63:9–11*-ийг уншиж, үүнийг судартаа Алма 32:17–18-ын хажууд бичиж болно.)

Төгс эзэмших судар Алма 32:21-ийг уншиж, юу итгэл болох, юу итгэл биш болохыг Алма хэрхэн тодорхойлсныг ол. (Та дараа нь үүнийг амархан олохын тулд тусгайлан тэмдэглэх хэрэгтэй.)

Алма 32:22-ыг унш. Та илүү агуу итгэл болон хувийн гэрчлэлээ хөгжүүлэхийн тулд юу хийж чадахаа тунгаан бод.

Судар судлах тэмдэглэлдээ “Гэрчлэл хүлээн авч, хүчирхэгжүүлэх нь” гэсэн жагсаалтдаа *Бурханы нигүүлслийг санах, итгэхийг сонгох* гэж нэмж бич.

Алма Зорамчуудад туршиж үзсэнээр Бурханы үгэнд хэрхэн итгэж болохыг заав. Шинжлэх ухааны болон бусад хичээлүүдээр хийсэн туршилт болон дагаж мөрдсөн алхмуудынхаа талаар бодож үзнэ үү. Туршилт нь судалгаа хийж байгаа хүнээс үйлдэл шаардагийг анхаар. Үүнтэй адил, гэрчлэл хүлээж авах болон гэрчлэлээ бэхжүүлэх үйл явц нь танаас үйлдэл шаарддаг. Алма 32:27-г уншиж, Алма зорамчуудыг хийж үзэхэд урьсан туршилтыг олж мэд.

Чадвар гэдэг үг бидний эргэн тойрон дахь ертөнцийг ойлгож, ухаарахаар адислагдсан хүч эсвэл чадвар гэсэн утгатай. Эдгээр нь бидний сонсох, харах, хүрэх мэдрэхүй; ухаант бодол; ой санамж зэргийг багтаадаг.


Судар судлах тэмдэглэлдээ “Гэрчлэл хүлээн авч, хүчирхэгжүүлэх нь” гэсэн жагсаалтдаа *үгийг туршиж үз (эсвэл үйлд)* гэж нэмж бич.

Та Алма 32:28-ыг судлахдаа “өсөж эхлэх”, “бодгалийг минь тэлж”, “ойлголтыг минь гэгээрүүлж”, “надад амтат байх” гэсэн хэллэгүүдийг судартаа тэмдэглэх хэрэгтэй. Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Брүс Р.Макконки бидний итгэл хэрхэн өсдөг талаар заасан нь:



“Бид итгэлээрээ өсч хөгжихдөө доод түвшнээс дээд түвшин рүү алхам алхмаар ахидаг. Бид итгэлээ төгөлдөржүүлж, хамгийн наад тал нь мөнх бус хүмүүний хүрч чадах зөв шударга байдлын ерөнхий түвшинд хүртлээ нигүүлсэл дээр нигүүлслийг нэмсээр, үүрдийн өсөлт дэвшлээ мөнхөд үргэлжлүүлэх түвшинд хүрсэн байх болно. . . .

“Цаашид олон төсөл дээр ажиллаж, итгэлийг олж авахын төлөө нэг алхам хийвэл энэ нь улам урагш ахих итгэлийг бодгальд тань бий болгох бөгөөд дараагийн шат руу ахиж чадна гэсэн баталгааг өгч, таны хүч эсвэл нөлөө бага багаар өсөн нэмэгдэх болно” (*Lord, Increase Our Faith*, Brigham Young University Speeches of the Year [10-р сарын 31, 1967], 9, 11).


 **3.** Алма 32:28-ыг уншаад судар судлах тэмдэглэлдээ дараах даалгавруудаас хоёр эсвэл түүнээс олныг хий.

а. Бид үгийг турших үедээ ямар үйлдэл хийх эсвэл хийхгүй байх ёстой вэ? (Байж болох хариултуудын жагсаалт энэ хичээлийн төгсгөлд байгаа.)

б. “Зүрх сэтгэлд тань [Бурханы үг] суулгагдаж болохын тулд зай тавьж өг” гэсэн нь юу гэсэн утгатай гэж та бодож байна вэ?

в. Бурханы үг таны бодгалийг тэлж, ойлголтыг тань гэгээрүүлж байгааг та хэзээ мэдэрсэн бэ? Энэ нь танд ямар мэдэрэмж төрүүлснийг өөрийн үгээр дүрсэл.

Алма 32:29–34-ийг уншиж, хувь хүн туршиж үзсэнээр Бурханы үгийн талаар юу сурахыг дүрсэлсэн үг хэллэгүүдийг тэмдэглэ. *Арчлах* гэдэг үг нь хооллох, тордох, эсвэл халамжлах гэсэн утгатай.



Алма 32:28

Алма 32:30

Алма 32:30–34

Мод ургахад туслах үйл явц нь гэрчлэлээ өсгөхөд туслахтай юугаараа адилхан болохыг хэсэг хугацаанд бод. Мөн Бурханы үгийг туршин үр дүнг нь хүлээн авсны дараа ч тухайн хүний итгэл болон гэрчлэл яагаад төгс байдаггүйг бодож үзнэ үү. Сайн мэдээний бат гэрчлэлтэй байхын тулд өөр юу хийх хэрэгтэй гэж та бодож байна вэ?

Алма 32:35–40-ийг уншиж, туршилтаа хийж гүйцээхийн тулд бид юу хийх ёстой талаар Алмагийн хэлсэн зүйлийг анхааралтайгаар хайж ол. Та модыг ургуулахад эсвэл гэрчлэлээ өсгөхөд юу хийх ёстойг тунгаан бод. Та эдгээр зүйлүүдийг хийхгүй бол юу болох вэ?



Алма 32:37

Судраа хаагаад дараах асуултуудаас хэдийг нь хариулж чадахаа үз:


- Бид Бурханы үгэнд итгэх итгэлээ үр жимстэй мод болгон ургуулахын тулд юу хийх ёстой вэ?
- Жимс нь юуг төлөөлдөг гэж та бодож байна вэ?
- Бид модыг тоохгүй орхих юмуу арчлахгүй бол юу болох вэ?
- Энэ нь бид гэрчлэлээ тоохгүй орхих юмуу арчлахгүй бол тохиолддог зүйлтэй юугаараа адилхан бэ?

Хэрэв шаардлагатай бол судраа нээж асуултуудад хариулахад тань туслах Алма 32:35–40-ийг эргэн хар. Судар судлах тэмдэглэл дэх “Гэрчлэл хүлээн авч, хүчирхэгжүүлэх нь” гэсэн жагсаалтдаа *хичээнгүйлэн арчлах* гэж нэмж бич.


Гэрчлэл хүлээн авах эсвэл хүчирхэгжүүлэхэд юу шаардлагатай талаар Алма 32-р бүлгээс сурсан зүйлээ нэг өгүүлбэрт багтаан бичиж, энэ зарчмыг судрынхаа Алма 32:37–43-ын хажууд бич.

Та үүнтэй төстэй зүйл бичсэн байж болох юм: **Хэрэв бид зүрх сэтгэлдээ Бурханы үгэнд итгэх итгэлээ хичээнгүйлэн арчлах юм бол Есүс Христ болон Түүний сайн мэдээнд итгэх бидний итгэл өсөх болно.**

Алма 32:41–43-ыг уншиж, гэрчлэлээ итгэлтэйгээр арчилдаг хүмүүст ирдэг үр жимсийг Алма хэрхэн дүрсэлснийг олж мэд. Алма 32:42-т шаргуу зүтгэл, тэвчээрийн тухай өгүүлдэг. Мод ургаж томрох эсвэл таны гэрчлэл өсөхөд яагаад шаргуу зүтгэл, тэвчээр шаардагддаг гэж та боддог вэ?




Алма 32:41–42

 **4.** Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултуудын нэгэнд эсвэл хоёуланд нь хариулж бич:

- а.** Алма 32-р бүлэгт дүрсэлсэн Алмагийн туршилтыг хэрэгжүүлэх үед та амьдралдаа ямар үр дүнгүүдийг харсан бэ?
- б.** Та Алма 32-р бүлэгт Алмагийн дүрсэлсэн туршилтыг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлэх вэ?

Төгс эзэмших судар—Алма 32:21

 5. Алма 32:21-ийг дахин унш. Энэ шүлгийг цээжлэхийг хичээж, дараа нь нэг найздаа эсвэл гэр бүлийнхээ нэг гишүүнд цээжээр уншиж өг. Энэ шүлэг танд итгэлийн талаар юу зааж байгааг судар судлах тэмдэглэлдээ хэдэн өгүүлбэрээр тайлбарлан бич.

Даалгавар 3а-гийн боломжит хариултууд: (а) зүрх сэтгэлдээ үг (эсвэл үр) суулгагдахыг зөвшөөр, (б) итгэлгүй байдлаараа үүнийг бүү гаргаж хая, мөн (в) үр ургаж байгааг мэдэр.

 6. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Алма 32-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

19-Р ХЭСЭГ: 1 ДЭХ ӨДӨР

Алма 33–35

Оршил


Алма судрууд дахь сургаалуудыг ашиглан олон зорамчуудад нөхцөл байдлаас үл хамааран тэд Бурханыг шүтэн биширч болно гэдгийг ойлгоход нь тусалжээ. Тэр тэднийг Есүс Христэд найдвар тавин, Түүний Цагаатгалд итгэхэд урамшуулан дэмжсэн ажээ. Амюлек Алмагийн сургаалуудыг батлахын хамт Есүс Христийн тухай гэрчлэлээ тунхагладаг. Амюлек зөвхөн Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан хүн төрөлхтөн аврагдах боломжтой гэдгийг онцолсон. Хүмүүс наманчлалд хөтлөх итгэлээ ашигласнаар Есүс Христийн Цагаатгалын бүх адислалуудыг хүлээн авч чадна гэдгийг тэр амлажээ. Олон зорамчууд Амюлекийн сэрэмжлүүлгийг анхааран сонсож, наманчилж мөн нифайчуудтай эргэн нэгддэг.

Алма 33:1–10

Хүмүүс синагогуудаасаа гадуур Бурханыг шүтэн биширч болно гэдгийг Алма хэсэг зорамчуудад заав

Алма 32-т цэдэглэсэнээр, Алма Бурханы үгийг зүрх сэтгэлдээ суулгах болон Бурханы үгэнд итгэх итгэлээ үйлдэл болгох шаардлагатайг зорамчуудад заасныг сана. Алма 33:1-ийг уншиж, Алмагийн

заасан зүйлсийн талаар зорамчуудад ямар асуултууд байсныг олж мэд.

 1. Итгэлээ бодит болгохын тулд юу хийж эхлэх ёстой вэ гэсэн зорамчуудын асуултад та хэрхэн хариулахаа судар судлах тэмдэглэлдээ бич. Дараа нь та Алма 33–34-ийг судлахдаа Алма болон Амюлекийн зорамчуудад заасан зүйлүүдтэй өөрийнхөө хариултыг харьцуулж үзнэ үү.

Алма зорамчуудын асуултад хариулахдаа тэднийг итгэлээ бүрэн ашиглахад саад болж байсан, шүтлэг бишрэлийн талаарх тэдний буруу ойлголтыг залруулжээ. Алма 33:2-ыг уншиж, энэхүү буруу ойлголтыг олж тогтоо. Зорамчууд ядуусыг синагогууддаа орж шүтэн бишрэхийг хориглодог байсныг эргэн сана (Алма 32:1–3-ыг үзнэ үү). Алма 33:2-т цэдэглэсэнээр Алма энэхүү буруу ойлголтыг хэрхэн залруулах хариултыг олохын тулд хүмүүс юу хийх ёстой гэж хэлсэн бэ?


Алма Бурханыг шүтэн бишрэх талаарх зорамчуудын буруу ойлголтыг залруулахын тулд Зинос хэмээх бошиглогчийн бичсэн судраас эш татдаг. Зинос Хуучин Гэрээний үеийн Израилын хүмүүст зааж байсан боловч түүний бошиглолууд зөвхөн Мормоны Номд цэдэглэгдсэн байдаг. Алма 33:3-ыг уншиж, Алма шүтлэг бишрэлийг дүрслэхдээ ашигласан үгийг ол.

Дараах зарчмыг судрынхаа Алма 33:3-ын хажууд эсвэл судар судлах тэмдэглэлдээ бичиж болно: **Бид залбирлаар дамжуулан Бурханыг байнга шүтэн биширч чадна.**

Алма 33:4–11-ийг уншиж, Зиносын залбирсан бүх нөхцөл байдлыг тэмдэглэ. Их Эзэн Зиносыг залбирах бүрд юу хийсэн бэ? Эдгээр шүлгүүдийг амьдралтайгаа адилтгахад тань туслах дараах даалгаврыг хий. Та өөрийнхөө амьдралд байдагтай адилхан нөхцөл байдлыг Зиносын залбирч байсан нөхцөл байдлуудтай тохируулан хооронд нь зураасаар холбо. (Таны амьдралтай хамгийн их холбогдож байгаа нөхцөл байдлуудыг сонго. Энэ дасгалд буруу эсвэл зөв хариулт гэж байхгүй.)

Зиносын нөхцөл байдлууд	Таны нөхцөл байдлууд
Аглаг буйдад	Ажил дээрээ
Дайснуудынхаа талаар санаа зовох	Сүм дээр
Талбайдаа байхад	Гэр бүлийн залбирал
Гэртээ байхад	Та юу хийхээ мэдэхгүй байхад эсвэл айсан үед

Зиносын нөхцөл байдлууд	Таны нөхцөл байдлууд
Гонхондоо байхад	Та ганцаардах үед
Их Эзэний цугларалтад	Хувийн залбирал
Хөөгдөж, гадуурхагдсан үед	Таны бүх хэцүү нөхцөл байдлуудад
Түүний бүх зовлон зүдгүүрт	Та найзуудтайгаа асуудалтай байх үед

 **2.** Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултад хариулж бич: Дээрх бүх нөхцөл байдлуудад залбирах нь таны амьдралыг хэрхэн адисалж болох вэ? Та хэрхэн байнга залбирч болох талаар хувийн зорилгоо бич.

Алма 33:4–5, 8–9 дэх Бурханы нигүүлслийн талаарх хэллэгүүдийг тэмдэглэж, илүү ойр ойрхон залбирах нь танд Бурханы нигүүлсэл ба хайрыг мэдрэхэд хэрхэн туслахыг тунгаан бод. Алма 33-ыг үргэлжлүүлэн судлахдаа энэхүү нигүүлсэл нь яагаад боломжтой байдгийг олж мэдэхэд анхаар.

Алма 33:11–23

Алма зорамчуудад Есүс Христэд итгэхийг заасан нь Зорамчуудын зарим нь Бурханыг хэрхэн шүтэн бишрэхийг мэдэхгүй байсан нэг шалтгаан нь тэд




Есүс Христэд итгэх итгэлтэй байх ёстойг мэдэхгүй байсных юм. Тэд авралын төлөвлөгөөн дэх Түүний үүргийг ойлгохгүй эсвэл үүнд итгэхгүй байлаа (Алма 33:14-ийг үзнэ үү). Алма Зиносын заасан зүйлсийг ярилцаж, дараа нь Хуучин Гэрээний өөр нэг бошиглогч Зинокийн үгсийг тэдэнд танилцуулсныг Алма 33:12–16-гаас унш. Есүс Христийн ачаар бидэнд ирдэг Алмагийн тодорхойлсон адислалуудыг эрж ол. “Таны Хүүгийн учир” гэсэн хэллэг бүрийг та тэмдэглэх хэрэгтэй. Бид эдгээр шүлгүүдээс дараах үнэнийг ойлгодог: **Бид Есүс Христийн Цагаатгалын ачаар Тэнгэрлэг Эцэгийн нигүүлслийг, түүний дотор өөрсдийн нүглийн уучлалыг хүлээн авдаг.** Наманчлах чадвар болон нүглүүдээсээ уучлагдах гэх зэрэг Аврагчийн Цагаатгалын ачаар Тэнгэрлэг Эцэг танд соёрхсон нигүүллийг тунгаан бод.

Алма зорамчуудад Зинос, Зинок нарын заасан зүйлсээс гадна тэдэнд Аврагчийн Цагаатгалын талаар Мосегийн зааж байсан үеийн тухай сануулжээ. Мосе болон Израилын хүүхдүүдийг аглаг буйдаа байх үед хорт могойнууд хүмүүсийг хаздаг. Их Эзэн Мосед гуулин могой хийж, саваанд бэхлээд могойнд хатгуулсан израилчуудыг могой руу харахыг зарлиг болго гэсэн ажээ. Саваанд бэхэлсэн гуулин могой нь Есүс Христийн загалмай дээрх “хэв шинж” эсвэл бэлгэдэл байсан юм (Алма 33:19-ийг үзнэ үү).

Алма 33:19–20-ийг уншиж, хазуулсан үедээ гуулин могой руу харсан израилчуудад юу тохиолдсон мөн могойг хараагүй хүмүүст юу тохиолдсоныг олж мэд.

Дараах асуултуудын хариултуудыг тунгаан бод: Израилчуудын болон гуулин могойны талаарх цэдэг нь сүнслэг байдлын хувьд эдгээгдэхийн тулд бид юу хийх ёстойг зааж байна вэ? Аврагч танд сүнслэгээр тусалж болохын тулд та Түүн рүү харах ёстой. Та Түүн рүү харахын тулд юу хийж болох вэ?



 **3.** Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултад хариулж бич: Та өдөр тутмын амьдралдаа Есүс Христ рүү харж болох ямар тодорхой арга замууд байна вэ?

Алма 33:22–23-ыг уншиж, Есүс Христэд итгэх итгэлээ үйлдэл болгохын тулд Түүний тухай юунд бид итгэх хэрэгтэйг тэмдэглэ.

Алма 34:1–14

Амюлек зорамчуудад Есүс Христийн Цагаатгалын тухай заасан нь

Алма 34-т цэдэглэсэнээр зорамчуудад өгсөн Амюлекийн гэрчлэл Есүс Христийн талаарх Алмагийн гэрчлэлийн хоёр дахь гэрч юм. Алма 34:8–9 дэх Амюлекийн гэрчлэлийн нэг хэсгийг уншиж, Есүс Христийн Цагаатгал шаардлагатай талаар Амюлекийн заасан зүйлийг тэмдэглэж болно. Дараах асуултыг тунгаан бод: Есүс Христ ирж, онцгой үүргээ биелүүлээгүй бол миний амьдрал ямар байх байсан бол?

Алма 34:10–14-ийг уншиж, *хэмжээлиггүй, мөнхийн гэсэн үгс орсон хэллэгүүдийг ол*. Дараах үнэнүүдийг судартаа эсвэл судар судлах тэмдэглэлдээ бич: **Есүс Христийн хэмжээлшгүй, мөнхийн Цагаатгал нь бүх хүн төрөлхтөнд авралыг боломжтой болгосон юм.**

Цагаатгал нь хэмжээлшгүй хийгээд мөнхийн юм гэдгийг ойлгоход бидэнд туслахын тулд Тэргүүлэх Бишопын зөвлөлийн Бишоп Ричард К.Эжли ийн заажээ: “Христийн Цагаатгалын талаар ярих үед толь бичигт *хэмжээлиггүй, мөнхийн* гэж тодорхойлсон нь надад таалагддаг. Учир нь энэ нь Бурханы илэрхийлэхийг хүссэн яг тэр хэлбэрээр тайлбарлагдсан гэдэгт би итгэдэг. *Хэмжээлиггүй*: ‘Ямар ч хил хязгааргүй.’ *Мөнхийн* гэдэг үгийн тайлбар: ‘Эхлэл ба төгсгөлгүй оршдог’ (*The American Heritage Dictionary of the English Language*, 4th ed. [2000], “infinite,” “eternal,” 898, 611)” (“For Thy Good,” *Ensign*, 2002 оны 5-р сар, 66).



4. Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

а. Есүс Христийн Цагаатгал ямар байдлаар хэмжээлшгүй, мөнхийн байж болох вэ?

б. Цагаатгал хэмжээлшгүй, мөнхийн гэдгийг мэдэх нь Аврагчид талархах сэтгэлийг тань хэрхэн өсгөх вэ? Энэ нь Түүнд итгэх таны итгэлийг хэрхэн өсгөх вэ?

Алма 34:15–41

Амюлек Цагаатгалын адислалуудыг хэрхэн хүлээж авах тухай заасан нь

Аврагч Цагаатгалаараа дамжуулан бидэнд өгөхийг хүсдэг адислалуудыг хүлээн авахын тулд зорамчууд юу хийх ёстой талаар Амюлекийн тэдэнд заасан зүйлсийг мэдэхийн тулд Алма 34:15–17-г унш. Дараах үнэнийг судартаа эсвэл судар судлах тэмдэглэлдээ бич: **Бид Цагаатгалын бүрэн адислалуудыг хүлээн авахын тулд наманчлалд хөтлөх итгэлээ ашиглах ёстой.**

Тэргүүн Зөвлөлийн Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорфын хэлсэн дараах үгсийг унш:



“Бид наманчлах боломжтой байхын тулд Христэд итгэх хүчтэй итгэлтэй байх хэрэгтэй. . . . Хэрэв бид Бурхан бүх зүйлийг мэддэг, хайраар дүүрэн, нигүүлсэнгүй гэдэгт итгэвэл авралынхаа төлөө Түүнд огтхон ч эргэлзээгүйгээр найдвараа тавих боломжтой байх болно.

Христэд итгэх итгэл нь Бурханы хүсэлтэй нийцдэггүй бидний бодол санаа, итгэл үнэмшил, зан авирыг өөрчлөх болно.

“Жинхэнэ наманчлал нь биднийг зөв зүйл хийхэд буцаан авчирдаг. . . . Наманчлал гэдэг нь бодол санаа, зүрх сэтгэлийн өөрчлөлт бөгөөд буруу зүйл хийхээ больж, зөв зүйлсийг хийж эхэлдэг. Энэ нь Бурханд, өөртөө болон амьдралд ерөнхийд нь хандах шинэ хандлагыг бидэнд авчирдаг” (“Point of Safe Return,” *Ensign* эсвэл *Луахона*, 2007 оны 5-р сар, 100).



5. Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултад хариулж бич: Бид наманчлах үедээ Есүс Христэд итгэх итгэлээ хэрхэн ашигладаг вэ?

Алма 34:17–27-г уншиж, бид хэзээ залбирах ёстой, юу гэж залбирах ёстой талаар Амюлекийн заасан зүйлийг олж мэд. Энэ зөвлөгөө долоо хоногт ганцхан удаа шүтэн биширч болно гэж бодож байсан зорамчуудад хэрхэн тусалсан гэж та бодож байна вэ? Ялангуяа танд тусалж чадна гэж бодож байгаа нэг шүлгийг сонго. Энэ шүлэг дэх залбирлын талаарх зөвлөгөөг та ирэх долоо хоногийн турш хэрхэн дагаж болохыг бод.

Бид наманчлалаа хойшлуулахынхаа оронд одоо нүглүүдээ наманчилснаар Аврагчийн Цагаатгалын адислалуудыг хүлээн зөвшөөрөх хүсэлтэй байх ёстой гэж Амюлек заажээ. Алма 34:30–35-ыг уншиж, бид яагаад наманчлалаа хойшлуулах ёсгүйг заасан үг хэллэгүүдийн доогуур зур. 31-р шүлгээс одоо наманчлахаар сонгосон хүмүүст ирэх болно гэж Амюлекийн заасан адислалуудыг ол. 32-р шүлгийг дахин анхааралтайгаар уншиж, дараах асуултын талаар бодож үз: Энэ шүлэг миний өдөр тутмын амьдралын хэв маягт хэрхэн нөлөөлж чадах вэ?

Алма 34:33-ыг эргэн харж, Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смитийн хэлсэн дараах үгийг бодож үз: “Сайн мэдээний зарчмуудыг хэрэгжүүлэхээ хойш тавих нь Эцэг болон Хүүгийн оршихуй дахь амьдрал буюу мөнхийн амьдралыг хулгайлдаг. Сайн мэдээний зарчмуудаар амьдрах болон зарлигуудыг дагахдаа яарах хэрэггүй гэж боддог олон хүн, бүр сүмийн гишүүд ч бидний дунд байдаг.

Алма 35

Наманчилсан зорамчууд зөв шударга хүмүүсийн дунд амьдарч байв

Олон зорамчууд наманчлалаа бүү хойшлуул гэсэн Амюлекийн сэрэмжлүүлэгт анхаарч, наманчилж, амьдралаа өөрчилжээ. Зорамчуудын удирдагчид тэднийг газар нутгаасаа хөөсөн учир тэднийг Жершоны нутагт ирэхэд Антай-Нифай-Лихайчууд буюу Аммоны хүмүүс халуун дотноор хүлээн авдаг (Алма 35:6–7-г үзнэ үү). Ёс бус зорамчууд болон леменчүүд Аммоны хүмүүст наманчилсан зорамчуудыг хүлээн авсанд нь уурлаж, нифайчуудын эсрэг дайтах бэлтгэлээ хийж эхэлжээ (Алма 35:8–11-ийг үзнэ үү).



6. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Алма 33–35-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.


Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

19-Р ХЭСЭГ: 2 ДАХЬ ӨДӨР

Алма 36

Оршил

Алма зорамчуудын дундах номлолоосоо эргэн ирснийхээ дараа гурван хүүгээ цуглуулаад тус бүрд нь зориулан зөвлөгөө өгчээ (Алма 35:16-г үзнэ үү). Хиламанд өгсөн түүний зөвлөгөө Алма 36–37-д, Шиблонд өгсөн зөвлөгөө нь Алма 38-д, Кориантонд өгсөн зөвлөгөө нь Алма 39–42-т цэдэглэгдсэн байна. Алма Хиламанд хандан Бурханд найдвараа



тавьдаг хүмүүсийг Тэрээр чөлөөлөх болно гэдгийг гэрчилжээ. Алма энэхүү найдварыг дүрслэхийн тулд олон жилийн өмнө гэм нүглээсээ хэрхэн чөлөөлөгдсөн тухайгаа ярьжээ. Тэр Есүс Христийн нэрээр залбирсныхаа дараа Бурханаас төрж, баяр баяслаар дүүргэгдсэн ажээ. Тэгээд тэр бусдыг Есүс Христэд авчрахаар хөдөлмөрлөсөн юм.

Алма 36:1–5

Алма бидэнд зовлон бэрхшээл тохиолдох үед Бурханы хүч бидэнд тусалдаг тухай хүү Хиламандаа заажээ.

Гэр бүлийн гишүүн, найз эсвэл сүмийн удирдагчийн гэрчлэл эсвэл сургаж хэлсэн онцгой үгс амьдралыг тань хэрхэн адисалсныг тунгаан бод.

Алма 36:1–5-ыг уншиж, аавынхаа гэрчлэлийг сонсож байгаа Хиламаны оронд өөрийгөө тавьж төсөөлөн бод. Алма Хиламанаас юуг санаж явахыг хүссэн бэ? (2-р шүлгийг үзнэ үү.) Алма өөрөөсөө юу сурахыг Хиламанаас хүссэн бэ? (3-р шүлгийг үзнэ үү.)

Дараах зарчмыг судартаа Алма 36:3-ын хажууд бич: **Бид Бурханд найдвараа тавих үед Тэр биднийг бүх зовлон бэрхшээл тохиолдсон үед дэмжиж тусалдаг.** Амьдралдаа зовлон бэрхшээлтэй тулгарч байсан үеийнхээ тухай бод. Тэр үед Бурхан танд тусалж, дэмжиж байсан хэд хэдэн арга замыг доорх зайнд бич. _____

Алма 36:6–22

Алма эсэргүүцлийнхээ талаар ярьж, уучлалыг хэрхэн хүлээн авснаа тайлбарласан нь

Алма Бурхан өөрийг нь гэм нүглийн зовлон шаналлаас хэрхэн чөлөөлснийг хүү Хиламандаа дүрслэн ярьжээ. Алма 36:6–10-ыг уншиж, Алма өсвөр насандаа Мозаягийн хөвгүүдтэй хамт Сүмийг устгахыг эрэлхийлсэн үед түүнд юу тохиолдсоныг эргэн сана.

Мормоны Номд Алма болон Мозаягийн хөвгүүд дээр тэнгэр элч айлчлан ирсэн тухай гурван цэдэг байдаг. Алма 36-р бүлэгт Алма гурван өдөр, гурван шөнийн турш хөдөлж, ярьж чадахгүй байхад юу мэдэрсэн тухай хамгийн дэлгэрэнгүй цэдэглэгдсэн байдаг. (Бусад цэдгүүдийг уншихын тулд, Мозая 27 болон Алма 38-ыг үзнэ үү.) Алма 36:11–16-г уншиж, тэнгэр элч айлчилсны дараа өөрийнхөө мэдэрсэн айдас, зовлон шаналлын талаар Алмагийн дүрсэлсэн үг хэллэгүүдийг тэмдэглэ.

Арванхоёр төлөөлөгчийн чуулгын Ерөнхийлөгч Бойд К.Пакэр *тамлагдаж* мөн *тарчлагдаж* гэсэн үгсийн утгыг ойлгоход бидэнд тусалсан юм:




“Тамлагдаж гэдэг нь ‘гэсгээгдсэн’ гэсэн утгатай. Эрт үеийн тамлах хэрэгсэл нь хэрэгтний хоёр бугуй болон шагайнаас бэхлэн, сунгаж татсанаар хүнийг тэсэхийн аргагүй өвтгөдөг хэрэгсэл байжээ.

“Борной бол хурц үзүүртэй төмрүүд доош нь харуулан бэхэлсэн төмөр хүрээ юм. Борнойг газар дээгүүр чирэхэд газрын хөрсийг сийрүүлж, сэндийчдэг. Гэм буруугийнхаа улмаас зүрх сэтгэл, оюун санаагаараа ‘тарчлан шаналдаг’ тухай судруудад олонтоо цэдэглэсэн байдаг” (“The Touch of the Master’s Hand,” *Ensign*, 2001 оны 5-р сар, 23).




1. Алма мэдэрсэн зүйлээ дүрслэхдээ яагаад ийм хүчтэй үгсийг ашигласан гэж бодож байгаагаа судар судлах тэмдэглэлдээ бич. Мөн эдгээр үгс нь нүгэл үйлдсэн, наманчлаагүй хүний гэм буруугийн мэдрэмж болон зовлон шаналлыг хэрхэн дүрсэлснийг бич.


Та дараах үнэнийг судартаа Алма 36:11–16-гийн хажууд бичих хэрэгтэй: **Нүгэл нь зовлон шаналал, харамсалд хүргэдэг.**



Алма 36:17–18-ыг уншиж, Алма эцгийнхээ бошиг-
лолын талаар юу санасныг олж мэд. Алма өөрт нь
эцгийнхээ заасан зүйлсийг санах үедээ юу хийснийг
олж мэдэхэд анхаар.

Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Жэф-
фри Р.Холланд Алмагийн туршлагын талаар дараах
бодол санааг хуваалцжээ: “Алмад эцгийнх нь заасан
зүйлүүд гүнзгий сэтгэгдэл үлдээсэн бөгөөд тэрээр
‘дэлхийн нүглүүдийг цагаатгахаар, Бурханы Хүү,
Есүс Христ гэгч нэгний ирэлтийн’ талаарх бошиг-
лолыг санасан гэдэг нь нэн чухал юм. (Алма 36:17.)
Энэ нь хүн бүрийн сонсох ёстой нэр ба захиас юм.
Алма үүнийг сонсоод өөрийг нь шатаах мэт шанал-
гаж байсан тамын зовлон болон эдгэрэх аргагүй мэт
санагдсан ухамсрынхаа шаналлын улмаас чангаар
залбирчээ. ‘Ай Есүс, Бурханы Хүү та, . . . намайг ни-
гүүлсээч.’ (Алма 36:18.) . . . Бидний хэлдэг өөр ямар
ч залбирал, бидэнд байдаг бусад ямар ч хэрэгцээ,
бүгд ямар нэгэн байдлаар: ‘Ай Есүс, Бурханы Хүү
та, . . . намайг нигүүлсээч’ гэсэн энэхүү гуйлт дээр
тулгуурладаг. Тэрбээр энэхүү нигүүлслээр хангахын
төлөө бэлтгэгдсэн юм. Тэрбээр үүнийг боломжтой
болгохын тулд амиараа төлөөсийг нь төлсөн юм”
(*However Long and Hard the Road* [1985], 85).

 **2.** Есүс Христийн Цагаатгалын адислалуудыг, түүний
дотор нүглийн уучлалын адислалыг хүлээн авахын тө-
лөө залбирсан үеэ эргэн сана. Их Эзэнээс Цагаатгалын адис-
лалуудыг амьдралдаа гуйх нь яагаад чухал гэж бодож
байгаагаа судар судлах тэмдэглэлдээ бич.

 **3.** Алма 36:19–22-ыг уншиж, Алма нигүүлслийн тө-
лөө залбирсныхаа дараа хэрхэн өөрчлөгдсөнийг дүр-
сэлсэн үг хэллэгүүдийг тэмдэглэ. Эдгээр үг хэллэгүүдийн
заримыг судар судлах тэмдэглэлдээ бичиж, тэдгээр нь Авраг-
чийн Цагаатгалын хүчний талаар юу зааж байгааг тайлбарла.


Эдгээр шүлгүүдээс бид дараах зарчмыг сурдаг:
**Есүс Христ биднийг Түүний Цагаатгалд итгэх
итгэлээ ашиглахад нүглүүдийн маань шанал-
лаас чөлөөлж, баяр баяслаар дүүргэдэг.** Та Есүс
Христэд итгэх итгэлээ илүү их ашигласнаар Алма-
гийн адил нүглийнхээ зовлон шаналал, харууслын
мэдрэмжээс чөлөөлөгдөхийн тулд юу хийж болохыг
тунгаан бод.

Дараах нөхцөл байдлыг уншиж, та хэрхэн хандах
талаараа бодож үз: Мормоны Номыг уншиж байгаа
нэг найз тань танаас Алма 36:19 дэх Алмагийн
үгсийг ойлгоход өөрт нь туслахыг хүсчээ. Найзын
тань асуулт, “Би нүглүүдээ санаж, харамссан хэвээ-
рээ байвал, уучлагдаагүй байна гэсэн үг үү?”

Тэргүүн зөвлөлийн гишүүн Ерөнхийлөгч Дийтр Ф.
Угдорфын дараах тайлбарыг уншиж, найзад тань ту-
салж болно гэж бодсон хэллэгүүдийнхээ доогуур зур:

“Бид нүглүүдээ санадаг учраас Сатан бидний нүгэл
уучлагдаагүй гэж бидэнд итгүүлэхийг хичээх болно.
Сатан бол худалч; тэрээр биднийг харалган болгож,
биднийг наманчлал, өршөөлөөс холдуулахыг хичээ-
дэг. Бурхан *биднийг* нүглүүдээ санахгүй гэж амлаа-
гүй юм. Нүглүүдээ санаж байх нь урьдын алдаагаа
дахин гаргахаас зайлсхийхэд бидэнд тусалдаг. Хэдий
тийм ч бид үнэнч, итгэлтэй хэвээр байвал бидний
нүглүүдийн дурсамж цагийн явцад багасах болно.
Энэ нь эдгээлт болон ариуслын үйл явцын нэгэн чу-
хал хэсэг байх болно. Алма нигүүлслийн төлөө Есүс
хандан залбирсныхаа дараа нүглээ санаж байсан ч
уучлагдсанаа мэдсэн учраас нүглийнх нь санамж
түүнийг дахин тарчилгаж, зовоогоогүй юм (Алма
36:17–19-ийг үзнэ үү).

“Өнгөрсөн нүглийн дурсамжуудыг эргэн санаг-
дуулах аливаа зүйлээс зайлсхийх нь бидний үүрэг
юм. Бид үргэлжлүүлэн ‘харууссан зүрх, гэмшсэн
сэтгэлтэй’ (3 Нифай 12:19) байвал Бурхан [‘бидний
нүглүүдийг’ цаашид санах нь үгүй’ [С ба Г 58:42]
гэдэгт найдаж болно” (“Point of Safe Return,” *Ensign*
ба *Луахона*, 2007 оны 5-р сар, 101).



Мөн Алма нүглүүдээ дахин санаагүй гэж хэлээгүй, харин тэрээр нүглүүдийнхээ төлөөх зовлон шаналлыг цаашид санаагүй бөгөөд тэдгээрийг санаж дахин “тарчлаагүй” анхаарах нь чухал юм (Алма 36:19). Жинхэнэ наманчлал нь нүглийн зовлон шаналал ба гэм буруугийн мэдрэмжийг зайлуулдаг (Инос 1:6–8-ыг үзнэ үү).



4. Ерөнхийлөгч Угдорфын тайлбараас сурсан зүйлсээ ашиглан дээр дурдсан найзынхаа асуултын хариултыг судар судлах тэмдэглэлдээ бич. Бид наманчлалынхаа дараа “нүглүүдийнхээ санамжид тарчлагдахгүй” (Алма 36:19) байж болох ч нүглүүдээ санаж байх нь яагаад адислал болдог гэж боддогоо хариултдаа оруулж бич.

Алма 36:23–30

Алма бусдыг наманчлалд авчрахын тулд яагаад үргэлжлүүлэн хөдөлмөрлөснөө тайлбарлав

Найзтайгаа амттай хоол хувааж идэхэд танд ямар мэдрэмж төрдөг вэ? Та сэтгэл догдлуулсан мэдээ хүлээн аваад хамгийн түрүүнд юу хийхийг хүсдэг вэ? Яагаад ихэнх хүмүүс сонссон зүйлээ тэр даруйд хэн нэгэнтэй хуваалцахыг хүсдэг гэж та боддог вэ? Алма 36:23–24-ийг уншиж, эдгээр асуултад дүрслэгдсэн мэдрэмжүүд нь Алмагийн хөрвөлтийн дараах туршлагаудтай ямар холбоотойг олж мэд. Алма бусад хүмүүсийг юу мэдрээсэй гэж хүссэн бэ?

Алма 36:25–26-г уншиж, сайн мэдээг заах Алмагийн хичээл зүтгэл өөрт нь болон бусдад хэрхэн нөлөөлснийг олж мэд. Эдгээр шүлгүүдээс сайн мэдээг хуваалцах талаар сурсан зүйлүүд дээрээ тулгуурлан дараах зарчмыг гүйцээн бич: **Бид сайн мэдээг бусадтай хуваалцсанаар** _____

хүлээн авдаг.



5. Гүйцээсэн зарчмаа судар судлах тэмдэглэлдээ бичиж, та яагаад энэ зарчим үнэн гэдэгт итгэдгээ тайлбарла. Тайлбарынхаа нэг хэсэгт та бусадтай сайн мэдээг хуваалцсанаар баяр баяслыг мэдэрсэн туршлагаасаа оруулж болно.

Аврагч болон Түүний сэргээгдсэн сайн мэдээний тухай таны гэрчлэл хэрэгтэй байж болох өөрийнхөө мэддэг хэн нэгэн—найз, гэр бүлийн гишүүн, эсвэл тойрог, салбарынхаа аль нэг гишүүнийг бод. Та тэрхүү бодсон хүнтэйгээ Есүс Христ биднийг зовлон шаналлаас чөлөөлж, баяр баяслаар дүүргэх боломжтой талаар хэрхэн гэрчлэлээ хуваалцаж болох вэ гэдгийг тунгаан бод. Та тэр хүндээ хандан захиа эсвэл и-мэйл бичиж болно. Эсвэл тэр хүнтэйгээ ярилцахдаа бэлтгэхийн тулд бага зэрэг тэмдэглэл хийж болно.



6. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Алма 36-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

Алма 37

Оршил

Алма 37-д цэдэглэснээр Алма хүү Хиламандаа өгөх зөвлөгөөгөө үргэжлүүлж, түүнд ариун цэдгүүдийг хариуцуулан өгдөг. Тэрээр судрууд нь мянга мянган леменчүүдийг Их Эзэнд авчрах арга хэрэгсэл байсан гэдгийг Хиламанд сануулж, мөн Их Эзэнд эдгээр цэдгүүдээр гүйцэлдүүлэх өөр олон агуу зорилго байгааг бошигложээ. Алма хүмүүст юу заах ёстой талаар Хиламанд удирдамж өгч, Аврагчийн үгсийг Лиахонатай харьцуулан, Есүс Христийн үгсээс удирдамж эрэлхийлэхийн ач холбогдлыг заав.

Алма 37

Алма Хиламанд цэдгүүдийг хадгалах итгэл хүлээлгэж, зарлигуудыг дагахыг түүнд зөвлөж, Лиахона итгэлийн дагуу ажилладгийг түүнд сануулав

Дараах жишиг зургийн талаар бод:




Дэлхийд өөрчлөлт гаргасан гэрлийн чийдэн гэх зэрэг өчүүхэн бөгөөд энгийн хоёр, гурван зүйлийн талаар бод. Таны амьдралд сайн бөгөөд том өөрчлөлт гаргасан өчүүхэн зүйлсийн талаар бод. Тэдгээр өчүүхэн зүйлсийн хоёрыг нь дээрх жишиг зургийн зүүн талд бич. Эдгээр өчүүхэн зүйлсийн амьдралд тань гаргасан том өөрчлөлтүүдийг дүрсэлсэн хэдэн үгийг баруун талд нь бич.

Алма 37-д цэдэглэснээр Алма өөрийн хүү Хиламаныг ариун цэдгүүдийн дараачийн хариуцагч болгон бэлтгэсэн ажээ. Алма Хиламанд Их Эзэний төлөвлөгөөн дэх өчүүхэн бөгөөд энгийн зүйлсийн үүргийн талаарх зарчмыг заажээ. Алма 37:6–7-г уншиж, дараах зарчмыг гүйцээн бич: **Их Эзэн мөнхийн зорилгоо тохиолгохын тулд** _____

_____ аар ажилладаг.

Алма 37:1–7-г уншиж, Алма өчүүхэн бөгөөд энгийн зүйлсийг юу гэж дүрсэлснийг олж мэд. Мөн Алма 37:8–10-аас гуулин ялтсууд Мормоны Номын хүмүүсийг (судруудыг агуулсан) агуу зүйлс рүү удирдсан арга замуудыг олж мэд. Та эдгээр адислалуудыг

унших үедээ хувиараа судар судалснаар хүлээн авсан адислалуудаа судартаа тэмдэглэ.

 **1.** Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултад хариулж бич: Судрууд таны амьдралд ямар арга замаар агуу зүйлс тохиолдоход хүргэсэн бэ? Тэдгээрээс хоёр эсвэл гурвыг нь бичнэ үү.

Алма ариун цэдгүүдийг хүү Хиламандаа хариуцуулан өгөхдөө түүнд өгсөн зөвлөгөөг Алма 37:13–16-д цэдэглэсэн байдаг. Эдгээр шүлгүүдийг судалж, Алмагийн заасан зарчмуудыг ол. Эдгээр зарчмуудын нэг нь: **Хэрэв бид Их Эзэний зарлигуудыг дагавал, бид дэгжих болно.** Энэ зарчим нь уг хичээлийн эхэнд байгаа жишиг зурагтай хэрхэн холбогдож байгааг тунгаан бод.

Алма 37:35–47-д цэдэглэснээр Их Эзэн, Есүс Христэд итгэх итгэлээр ёс бус явдал болон уруу таталтыг хэрхэн даван туулахыг хүмүүст заах тухай зааврыг Алма Хиламанд өгсөн байна. Эдгээр сургаалуудыг хамарсан хоёр хичээлийн тоймыг доор өгөв. Хичээл бүрийг холбогдох судруудын хамт судал. Дараа нь эдгээр хичээлүүдийн нэгийг гэр бүлийнхээ нэг гишүүнд, гэр бүлдээ (боломжтой бол гэр бүлийн үдшийн хичээлийн нэг хэсэг болгон), эсвэл найздаа заахаар бэлтгэ. Та хичээлээ хэнд, хаана заахаас хамааран зарим өөрчлөлтүүдийг оруулж болно. Заах цагаа товлож, сонгосон өдрөө хичээлээ заа. Мөн гэрээр суралцах дараагийн ангидаа хичээлийн тоймоо авчирч, нэр дуудсан тохиолдолд ангийхандаа уг хичээлийг заахад бэлэн бай.


1-р хичээл—Алма 37:35–37

Мод тарьдаг хүмүүс зулзган модыг тулгуур шонд уяж бэхэлдэг бөгөөд модыг томорсны дараа тулгуураа авах нь нийтлэг байдгийг заадаг хүмүүстэй тайлбарла. Асуулт: Яагаад зулзган модонд ургаж байх үед нь тулгуур хэрэгтэй гэж та бодож байна вэ?

Ерөнхийлөгч Гордон Б.Хинклигийн амьдралд тохиолдсон дараах туршлагыг унш:

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли гэрлэснийхээ дараахан гэрийнхээ ойролцоо нэг зулзган мод тарьжээ. Он жилүүд улиран өнгөрөх тусам тэрээр модондоо улам бага анхаарал тавьдаг болсон гэнэ. Нэг өдөр тэрээр модыг нялх, уян хатан байх үед нь зүүнээс салхилдаг салхинаас болж хэлбэрээ алдаж, баруун тийш





хазайсныг харжээ. Тэр гарч очоод, модоо тэгшлэхээр оролдсон ч модны гол хэтэрхий бүдүүн байлаа. Тэр олс, дамартай татлага ашиглан модоо тэгшлэхийг хичээсэн ч мод огт тэгширсэнгүй. Эцэст нь, тэрээр хөрөөгөө авч баруун талд нь ургасан том мөчрийг тайрахад модонд муухай ором үлдээсэн байна. Тэрээр хожим нь модныхоо талаар ийн ярьжээ:

“Би тэр модыг тарьснаас хойш хагас зуун жил өнгөрчээ. Одоо тэнд манай охин гэр бүлтэйгээ амьдардаг. Би нэг өдөр нөгөөх модоо дахин харлаа. Мод маш том болжээ. Мөн хэлбэр нь ч сайжирсан байлаа. Энэ мод гэрийнх нь хувьд үнэт өв юм. Гэвч модыг залуу байхад нь тэгшлэх гэж оролдоод түүнийг гэмтээсэн миний арга хэчнээн муйхар байж вэ.



“Энэ модыг анх тарих үед жижигхэн уяа л үүнийг салхины хүчнээс хамгаалж чадах байсан юм. Би багахан хүч чармайлт гаргаж, модыг уяж болох байсан, тэгэх ч ёстой байсан юм. Гэвч би ингэж уяагүйгээс энэ мод салхины хүчинд бөхийжээ” (“Bring up a Child in the Way He Should Go,” *Ensign*, 1993 оны 11-р сар, 59).

Алма 37:35 дахь Хиламанд Алмагийн өгсөн зөвлөгөөг хэн нэгнээр уншуулж, энэ шүлэг нь Ерөнхийлөгч Хинклигийн модны талаарх туршлагатай хэрхэн холбогдож байгааг ярилц. (Алма 37:35 нь төгс эзэмших судар юм. Та дараа нь үүнийг амархан олохын тулд тусгайлан тэмдэглэх хэрэгтэй.)

Заадаг хүмүүсээсээ Алма 37:35-д агуулагдсан зарчмыг олохыг хүс. (Иймэрхүү зарчим байж болно: **Бид бага залуугаасаа Бурханы зарлигуудыг дагаж сурах ёстой.**) Та дараах асуултуудаас нэгийг эсвэл хэд хэдийг асууж болно:

- Хүмүүс залуудаа Бурханы зарлигуудыг дагаж сурах нь тэдний амьдралд ямар өөрчлөлтийг авчирна гэж та бодож байна вэ?
- Та өсвөр насандаа зарлигуудыг дагасан нь танд ямар өөрчлөлтүүдийг авчирсан бэ?
- Залуудаа зарлигуудыг дуулгавартай дагаж сурснаар үлдсэн амьдралдаа адислагдсан хэн нэгний тухай та санаж байна уу? Энэ хүн хэрхэн адислагдсан бэ?

Хэн нэгнийг Алма 37:36–37-г чангаар уншихад урьж, зарлигуудыг дагахад нь тусалж чадах онцгой зөвлөгөөг тэндээс олохыг хүс. Дараах асуултуудыг асуу:

- Энэ зөвлөгөөг өдөр бүр дагах нь зарлигуудын дагуу амьдрахад тань хэрхэн туслах вэ?
- Та ямар арга замуудаар бодол санаа, үйлдэлдээ Их Эзэнийг нэгдүгээрт тавихыг хичээдэг вэ? Та хэрхэн сайжирч болох вэ?
- Залбирдаг хүмүүст ямар амлалтууд өгөгдсөн бэ?

Их Эзэнтэй зөвлөлдөх нь зарлигуудыг сахихад тань хэрхэн тусалсан талаар гэрчлэлээ хуваалц. Зааж буй хүмүүсээ Их Эзэнтэй зөвлөлд гэсэн Алмагийн үгсийг дагахад урь.

2-р хичээл—Алма 37:38–45

Лихайн гэр бүлийг амлагдсан нутагт хүрэхэд нь туслахаар Их Эзэний өгсөн луужингийн нэрийг мэддэг эсэхийг тэднээс асуу. Тэгээд хэн нэгнээс Алма 37:38-ыг уншихыг хүс. Алма Хиламанд Лиахонаг сануулснаар Бурхан хүүхдүүдээ хэрхэн удирддаг талаар чухал зарчмыг заасан гэдгийг тайлбарла.

Зааж буй хүмүүсээрээ дурдсан шүлгүүдийг уншуулж, дараах асуултуудын хариултыг олуулж хариултыг нь сонс.

- Алма 37:38–40-д цэдэглэснээр Лиахона хэрхэн ажилладаг байсан бэ?
- Алма 37:41–42-т цэдэглэснээр зарим үед Лиахона яагаад ажилладаггүй байсан бэ?





- Алма 37:43–45-д цэдэглэсэнээр Лиахона юугаараа Христийн үгтэй адилхан бэ?

Далд утга, хэв шинж (Алма 37:43, 45) гэсэн үгсийн утга нь илүү том зүйлсийн бэлгэдэл болон ашиглагдаж байгааг тайлбарла. Жишээ нь: Лихайн гэр бүл Лиахонагийн чиглүүлэгт дуулгавартай эсвэл дуулгаваргүй байсан нь бид Христийн үгэнд дуулгавартай эсвэл дуулгаваргүй байдгийн бэлгэдэл юм. Лихайн гэр бүл Лиахонаг дагаснаар амлагдсан нутагт хүрсний адил бид Христийн үгийг дагавал мөнхийн амьдралыг хүлээн авах болно.

Бид амьдралдаа Есүс Христийн үгсийг хаанаас олж болохыг тайлбарлахыг хэн нэгнээс хүс. (Зарим боломжит хариултууд нь судрууд, орчин үеийн бошиглогчдын үгс, патриархын адислал, Сүнсний өдөөлт зэрэг байж болно.)

Асуулт: Алма Лиахонагийн жишээнүүдийг ашиглан Хиламанд ямар зарчмуудыг заасан бэ? (Хариултууд нь дараах зарчимтай төстэй байж болно: **Хэрэв бид Есүс Христийн үгэнд анхаарлаа хандуулбал, тэдгээр нь биднийг мөнхийн амьдралыг хүлээн авахад чиглүүлэх болно.**) Та Их Эзэний үгийг сонсож, дуулгавартай дагах нь бидний амьдралд агуу адислалуудыг авчирдаг гэсэн гэрчлэлээ хуваалцах хэрэгтэй.


 **2.** Заахаар сонгосон хичээлээ судлахдаа юу сурснаа дүрсэлсэн хэдэн өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ бич.

 **3.** Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ бич: *Би дараах шүлгүүдийн талаар хичээл заахаар шийдлээ Алма 37: _____ (заах шүлгүүдээ бич). Би энэ хичээлийг _____ (хэнд заахаар сонгосноо бич) -д _____ (энэ хичээлийг заахаар товлосон өдрөө бич) -нд заах болно.*

Төгс эзэмших судар—Алма 37:35

Алма 37:35-ыг тэмдэглэ. Энэ шүлгийг цээжлэхийг хичээ. Дараа нь үүнийг эцэг эх эсвэл өөр нэгэн итгэлтэй насанд хүрэгчид цээжээр эсвэл судраасаа уншиж өг. Тэгээд тэр хүнээсээ дараах асуултуудыг асуу:

- Бурханы зарлигуудад дуулгавартай байх нь таны амьдралд хэрхэн тусалсан бэ?
- Танд өсвөр насандаа илүү ухаалаг байхад надад туслах ямар зөвлөгөө байна вэ?

 **4.** Та ярилцсан хүнээсээ Алма 37:35-ын талаар сурсан зүйлээ судар судлах тэмдэглэлдээ бич.

 **5.** Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Алма 37-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

19-Р ХЭСЭГ: 4 ДЭХ ӨДӨР

Алма 38

Оршил

Хүү Шиблон нь Алматай хамт зорамчуудад номлов. Алма энэхүү номлолынхоо дараа зорамчуудын хавчлагад зовж байхдаа Шиблоны харуулсан гуйвшгүй бөгөөд итгэлтэй байдалд баярласнаа илэрхийлдэг. Алма Шиблонд Есүс Христийн чөлөөлөх хүчийг гэрчилж, сайн мэдээг үргэлжлүүлэн заахыг зөвлөдөг.

Алма 38:1–3

Алма Шиблоны итгэлтэй байдалд баярласнаа илэрхийлэв

Таны эсвэл танай гэр бүлийн өөр нэг гишүүний хийсэн зөв сонголтоос эсвэл таны амьдралын хэв маягийн улмаас эцэг эх тань баярласан үеийн талаар бод.



Алма 38:1–3-ыг уншиж, Шиблоны талаар Алма ямар бодол санаатай байсан болон яагаад гэдгийг дүрсэлсэн хэллэгүүдийг ол. Олсон хэллэгүүдээсээ заримыг нь бич: _____

Бид эдгээр шүлгүүдээс дараах зарчмыг сурдаг: **Бид өсвөр наснаасаа зарлигуудыг дагахдаа гуйвшгүй бөгөөд итгэлтэй байснаар эцэг эхдээ агуу баяр баяслыг авчирч чадна.**



1. Эцэг эх, асран хамгаалагч, эсвэл сүмийн удирдагчаасаа таны зөв шийдвэр түүнд хэрхэн нөлөөлснийг асуу. Тэдний хариултыг судар судлах тэмдэглэлдээ бич.

Алма 38:4–9

Алма Аврагчийн чөлөөлөх хүчний талаар гэрчилсэн нь

Тэд хэдийгээр өөр өөр байдлаар ч гэсэн Аврагчийн чөлөөлөх хүчийг хоёул мэдэрсэн юм гэдгийг Алма Шиблонд сануулдаг. Алма 38:4–8-ыг уншиж, дараах хүснэгтийг бөглө. Алма 38:2–3-аас Шиблоны талаар юу мэддэгээ болон Мормоны Номын бусад бүлгүүдээс Алмагийн талаар мэдсэн зүйлээ хүснэгт бөглөхөд ашигла.

	Шиблон (Алма 38:2–5)	Алма (Алма 38:6–8)
Тэр юунаас чөлөөлөгдсөн бэ?		
Тэр чөлөөлөлтийн адислалыг хэрхэн хүлээж авсан бэ?		

Бид Шиблоны туршлагаас дараах зүйлийг сурч чадна: **Хэрэв бид бүх зүйлсэд тэвчээр болон Бурханд итгэх найдвараар хандвал Тэр биднийг зовлон зүдгүүр, саад бэрхшээл, өвчин шаналлаас чөлөөлж, биднийг эцсийн өдөр өргөмжлөх болно.** Мөн бид Алмагийн туршлагаас дараах зүйлийг сурдаг: **Бид нүглийнхээ уучлалыг хүлээн авч, бодгальдаа амар амгаланг олохын тулд Есүс Христэд итгэх итгэлээ ашиглаж, Түүний нигүүлслийг эрэлхийлэх ёстой.**



2. Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

- а.** Таныг чөлөөлөх Аврагчийн хүчний талаар Шиблон болон Алмагийн цэдгээс та юу сурсан бэ?
- б.** Өмнөх догол мөрөнд тод үсгээр бичсэн зарчмуудаас нэгийг сонгож, тэр зарчмаа амьдралдаа хэрхэн хэрэгжүүлж болох талаар хэдэн өгүүлбэр бич.



Алма 38:9-ийг уншиж, Алма Шиблоныг юу сураасай гэж хүссэнийг олж мэд. Та энэ шүлэг дэх Алма хүүгээ ойлгоосой гэж хүссэн зүйлийг товчхон өгүүлж байна гэж бодсон хэллэгээ тэмдэглэх хэрэгтэй.

Аврагчийн хүч таныг зовлон зүдгүүр, саад бэрхшээл, эсвэл урьдын зүйлүүдээс тань чөлөөлсөн үеийн талаар бод. Та тэрхүү чөлөөлөлтийг эрэлхийлэхийн тулд юу хийсэн бэ? Таны амьдралд одоо зовлон бэрхшээл эсвэл нүгэл байгаа юу? Та чөлөөлөлтийн төлөө Аврагчид хэрхэн хандаж болох вэ?



3. Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултад хариулж бич: Аврагдаж болох ганцхан “зам эсвээс арга” нь Аврагчаар дамжих юм гэдгийг мэдэх нь танд яагаад чухал гэж та бодож байна вэ? (Алма 38:9-ийг үзнэ үү).

Алма 38:10–15

Алма Шиблонд зөв шударга зан чанарыг үргэлжлүүлэн хөгжүүлэхийг зөвлөв

Таны амьдралд сайн нөлөө үзүүлсэн нэг багш эсвэл сүмийн удирдагчийн талаар бод. Тэрхүү хүндэлдэг хүнийхээ сайн чанаруудыг эргэцүүлэн бод.

Алма 38:10–15-д цэдэглэсэнээр Алма Шиблоныг сайн мэдээг цаашид заахад болон бусад үйлчлэхэд нь тусалж болох сайн чанаруудыг өөртөө үргэлжлүүлэн хөгжүүлэхийг урамшуулан дэмждэг. Үйлчлэхийг, заахыг мөн өөр аргуудаар бусад сайнаар нөлөөлөхийг

хүссэн хэн ч гэсэн Шиблонд өгсөн Алмагийн зөвлөгөөг хэрэгжүүлж болно. Алма 38:10–15-ыг судалж, ялангуяа танд тустай байж болох зөвлөгөөнүүдийг ол. Та олсон зөвлөгөөнүүдээ тэмдэглэх хэрэгтэй.



4. Хүү Шиблондоо өгсөн Алмагийн зөвлөгөөг (Алма 38:10–15-ыг үзнэ үү) улам сайн ойлгож, хэрэгжүүлэхэд тань туслах доорх судлах удирдамжийг үзнэ үү. Зүүн багана дахь Алмагийн зөвлөгөөнүүдээс танд хамгийн их хэрэг болно гэж бодсон хоёр эсвэл гурван зөвлөгөөг сонго. Баруун талын багана дахь тохирох суралцах үйл ажиллагаануудыг гүйцээ. Хариултаа судар судлах тэмдэглэлдээ бич.

Алма 38:10–12 Судлах удирдамж	
Алмагийн зөвлөгөө	Суралцах үйл ажиллагаа
“Бүх зүйлд хичээнгүй мөн өөрийгөө захирах чадвартай бай” (Алма 38:10).	Хичээнгүй хүн амьдралын үйл ажиллагаануудад тууштай бөгөөд эрч хүчтэй байдаг. <i>Өөрийгөө захирах чадвартай</i> хүн бүх зүйлд тэвчээртэй хандаж, өөрийгөө хянаж чаддаг. Энэ хоёр зан чанар бусдад үйлчлэхэд яагаад хэрэгтэйг судар судлах тэмдэглэлдээ бич. Та хэрхэн амьдралынхаа нэг эсвэл олон нөхцөл байдлуудад илүү хичээнгүй эсвэл өөрийгөө илүү захирах чадвартай байж, тэгснээр энэ нь бусдад илүү үр дүнтэйгээр үйлчлэхэд тань хэрхэн тусалж чадах тухай бич.
“Бардамналд хөөрөхгүйгээ мэд; тийм ээ, . . . сагсуурахгүй байхаа мэд” (Алма 38:11).	Сударт <i>бардамнал</i> гэдэг нь хэн нэгэн Бурханаас илүүгээр өөртөө итгэл найдвар тавихыг хэлдэг. Мөн энэ нь хүн өөрийгөө бусдаас илүү гэж боддог гэсэн утгатай юм. Энэхүү зөв шударга бус бардамналын эсрэг зүйл нь <i>даруу байдал</i> юм. Даруу хүмүүс бусдыг өөрсөдтэйгээ адилхан гэж боддог. Мөн тэд Бурханыг хайрлаж, Түүнийг амьдралдаа нэгдүгээрт тавьдаг. Хэрэв хэн нэг сүмийн гишүүн дуудлагадаа бардамнаж, сагсуурах юм бол түүнд юу тохиолдож болохыг судар судлах тэмдэглэлдээ бич. Сүмийн дуудлага эсвэл үйлчлэх аль нэг өөр боломжийн тухай бод. Үйлчлэхдээ даруу байхыг эрэлхийлж, бардамнал, сагсуурлаас зайлсхийж болох нэг эсвэл хоёр арга замыг бич.

Алма 38:10–12 Судлах удирдамж	
Алмагийн зөвлөгөө	Суралцах үйл ажиллагаа
“Зоригийг хэрэглэ, гэвч бүү дээрэлх” (Алма 38:12).	Зоригтой байна гэдэг нь Бурхан бидэнтэй хамт гэдэгт итгэлтэй байж, Түүний үйлчлэлийг айдасгүйгээр хийх явдал юм. <i>Дээрэлхүү</i> байх нь бусдын хэрэгцээ, мэдрэмжийг хайхралгүйгээр тэдэнд өөрийнхөө итгэл, байр суурийг тулгах гэсэн утгатай байж болно. Та яагаад Бурхан биднээс зоригтой байхыг хүсдэг гэж бодож байгаагаа судар судлах тэмдэглэлдээ бич. Мөн та бусдад үйлчлэхийг эрэлхийлэхдээ зоригийг хэрэглэ, гэвч бүү дээрэлх гэсэн зөвлөгөөг хэрэгжүүлж болох тодорхой арга замуудыг бич.
“Бүх хүслээ хазаарла” (Алма 38:12).	<i>Хазаарлах</i> нь удирдах эсвэл хянах гэсэн утгатай юм. <i>Хүсэл</i> нь хүчтэй мэдрэмж юм. Дараах асуултуудыг тунгаан бодож, хариултаа судар судлах тэмдэглэлдээ бич: Хүслээ хазаарлах нь—өөрөөр хэлбэл, хүчтэй мэдрэмжүүдээ удирдах эсвэл хянах нь яагаад чухал гэж та бодож байна вэ? Хүслээ хазаарлах нь таныг хайраар дүүрэн байхад хэрхэн тусалж чадах вэ? Бүх хүслүүдээ хазаарла гэсэн Алмагийн зөвлөгөөг дагахын тулд та юу хийх вэ?
“Залхаг байдлаас татгалзах” (Алма 38:12).	Залхаг байх гэдэг үг ямар утгатай болохыг илүү сайн мэдэхийн тулд судруудын удирдамж (scriptures.lds.org) дахь “залхуу, залхуу хойрго байдал” эсвэл сэдэвчилсэн удирдамж дахь “залхуу хойрго байдал, залхуу, залхуурагч” гэсэн тайлбарыг үзнэ үү. Энэ сэдвийн доор жагсаасан шүлгүүдээс хоёрыг сонгож судал. Эдгээр шүлгүүдээс юу сурснаа судар судлах тэмдэглэлдээ бич. Энэхүү залхуу хойрго байдлаас татгалзах зөвлөгөө нь таныг бусдад илүү үр дүнтэйгээр үйлчлэхэд хэрхэн туслах тухай бич. Төгсгөлд нь, залхуурлаас татгалзахыг эрэлхийлэх тодорхой нэг арга замыг бич.

Алма 38:10–15 дахь Шиблонд Алмагийн өгсөн зөвлөгөө нь дараах зарчмыг заадаг: **Зөв шударга зан чанаруудыг хөгжүүлэх нь биднийг бусдад заах болон үйлчлэхэд бэлтгэдэг.** Алма 38-д таны уншсан зөв шударга зан чанаруудыг хөгжүүлэх нь таны болон таны эргэн тойронд байгаа хүмүүсийн амьдралыг хэрхэн адисалж болох талаар тунгаан бод.



5. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Алма 38-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

20-Р ХЭСЭГ: 1 ДЭХ ӨДӨР

Алма 39

Оршил

Алма Кориантон хэмээх эрх дураараа хүүгээ үйлчлэлээ орхиж, бэлгийн харилцааны жигшүүрт нүгэл үйлдсэнийх нь төлөө зэмлэжээ. Алма Кориантонд түүний үйлдлийн ноцтойг хэлж, Кориантоныг маш ноцтой буруу үйлдлийнхээ улмаас гэм нүгэлд унасанд нь харууссанаа илэрхийлдэг. Алма Кориантоныг “нүдээрээ шунасныхаа араас” явахаа зогсоож, наманчлахыг тушаажээ (Алма 39:9). Кориантонд өгсөн Алмагийн захиас Алма 39–42-т байдаг.

Алма 39:1–6

Алма хүү Кориантондоо бэлгийн харилцааны нүглийн ноцтойг тайлбарласан нь

Дараах мэдэгдлийг тунгаан бод: Зарим нүглүүд нь бусад нүглүүдээс илүү ноцтой байдаг.



1. Дараах асуултуудад судар судлах тэмдэглэлдээ хариулж бич: Та зарим нүглүүд бусад нүглүүдээс илүү ноцтой гэдэгтэй санал нийлж байна уу? Яагаад эсвэл яагаадгүй гэж?

Алма 39-д цэдэглэснээр хүү Кориантондоо өгсөн Алмагийн зөвлөгөө зарим нүглүүдийн ноцтой байдлыг ойлгоход тань тусалж чадна. Кориантон Алма болон ах Шиблоны хамт зорамчуудад сайн мэдээг номлохоор явжээ. Тэр үед Кориантон бэлгийн харилцааны ноцтой нүгэл үйлдсэн байна.

Алма 39:1–4-ийг уншиж, Кориантон ямар гэм бурууг үйлдсэнийг олж мэд. Янхан эм гэдэг нь завхай

эмэгтэй эсвэл биеэ үнэлэгч гэсэн утгатайг мэдэх нь эдгээр шүлгүүдийг ойлгоход тань тусалж болох юм. “Их Эзэн нүглийг өчүүхэн төдий ч хүлцсэн янзаар хүлээн зөвшөөрч чадах нь үгүй” (С ба Г 1:31) гэдгийг ойлгох нь чухал бөгөөд бэлгийн харилцааны нүгэл нь үнэхээр ноцтой юм. Кориантон янхан эм Изабелийн араас явахын тулд номлолоо санаатайгаар орхисон нь түүнийг ноцтой нүгэл рүү хөтөлснийг бас анхаар.

Алма 39:5-ыг уншиж, Алма бэлгийн харилцааны ноцтой нүглийг бусад нүгэлтэй хэрхэн харьцуулж тайлбарласныг олж мэд. Жигшүүрт хэрэг нь нүгэлт, ёс бус эсвэл бузар булай зүйл юм. Бид эдгээр шүлгүүдээс **бэлгийн харилцааны нүгэл нь Бурханы мэлмийд жигшүүрт хэрэг гэдгийг сурдаг.** Бэлгийн харилцааны нүгэл нь яагаад хүн амины хэргийн дараа ордог ноцтой нүгэл болохыг тунгаан бод.

Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Жэффри Р.Холланд бэлгийн харилцааны нүгэл нь яагаад Их Эзэнд жигшүүрт хэрэг байдаг талаар дараах тайлбарыг өгчээ: “Бурхан бүх нийтэд өгөгдсөн бие махбодын дур таашаалд онцгойлон хязгаар тогтоосноор бүх эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн төлөөх түүний төлөвлөгөөнд энэ нь ямар байр суурь эзэлдэг талаар бидэнд юу хэлэхийг хичээж байна вэ? Тэрээр амьдралын жинхэнэ төлөвлөгөөний талаарх тайлбарыг маш тодорхойгоор өгсөн гэдгийг би та нарт мэдэгдэж байна. Хүн энэ дэлхийд хэрхэн ирдэг бас хэрхэн явдаг нь мөнх бус амьдралын хувьд Түүний хамгийн их анхаардаг зүйл нь юм. Тэрбээр эдгээр асуудлуудад маш нарийн хязгаар тогтоосон юм” (“Personal Purity,” *Ensign*, 1998 оны 11-р сар, 76).

Дараах хэсгүүдийг уншиж, уг асуултын хариултыг олж тэмдэглэ: Бэлгийн цэвэр ариун харилцаанаас ямар адислалууд ирдэг вэ?

Эхнэр нөхрийн хоорондох бие махбодын дотно харилцаа нь сайхан бөгөөд ариун нандин зүйл юм. Энэ нь хүүхэд төрүүлэх, эхнэр ба нөхрийн хоорондын хайрын илрэл байхаар Бурханаас томилогдсон юм. Гэрлэлтээс өмнө бэлгийн харилцаанд орохгүй байхыг Бурхан зарлиг болгосон билээ.

Та нар бэлгийн харилцааны хувьд цэвэр ариун байснаар ариун сүм дэх эрхэм нандин гэрээнүүдийг хийж, дагахад өөрсдийгөө бэлтгэдэг. Та нар хайр халамжаар дүүрэн мөнхийн гэр бүлийн нэг хэсэг болох хүүхдүүдийг энэ дэлхийд авчрах бат бөх гэрлэлтэд өөрсдийгөө бэлддэг. Та нар гэрлэлтээс гадуур бэлгийн харилцаанаас үүдэлтэй сэтгэл санаа болон сүнслэг байдлын уналтаас өөрсдийгөө хамгаалах болно. Та нар бас хор хөнөөлтэй өвчнүүдээс өөрсдийгөө хамгаалдаг. Бэлгийн харилцааны хувьд цэвэр ариун байх нь таныг өөртөө итгэлтэй, жинхэнэ аз

жаргалтай байхад тусалдаг бөгөөд одоо ба ирээдүйд зөв шийдвэр гаргах чадварыг тань өсгөдөг” (*Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* [товхимол, 2011], 35).

Одоо дараах догол мөрүүдийг уншиж, уг асуултын хариултыг олж мэд: Бэлгийн харилцааны цэвэр ариун байдлын талаар Их Эзэний ямар жишгүүд байдаг вэ?

“Бэлгийн харилцааны талаарх Их Эзэний жишиг тодорхой бөгөөд хувирдаггүй. Гэрлэлтээс өмнө ямар ч бэлгийн харилцаанд бүү ор, гэрлэлтийн дараа ч эхнэр нөхөртөө чин үнэнч бай. Гэрлэлтээс өмнөх бэлгийн харилцаа нь хэвийн зүйл хэмээн ятгах хэвлэл мэдээллийн хэрэгсэл, найз нөхөд болон бусдын уруу таталтад бүү ор. Энэ бол худлаа юм. Бэлгийн харилцааны нүгэл нь Бурханы мэлмийд үнэхээр ноцтой зүйл мөн. Энэ нь амьдрал бүтээх зорилгоор Бурханы өгсөн ариун хүчийг бузарладаг юм. Бэлгийн харилцааны нүгэл бол хүн алах болон Ариун Сүнсийг үгүйсгэхээс бусад бүх нүглүүдээс хамгийн жигшүүрт нүгэл мөн хэмээн бошиглогч Алма сургасан байдаг (Алма 39:5-ыг үзнэ үү).

“Бэлгийн харилцааны нүгэлд хөтлөх аливаа зүйлийг бүү хий. Бусдыг хүндэтгэн харьцаж, тэднийг хэзээ ч тачаангуй, хувиа хичээсэн хүслийнхээ бай бүү болго. Гэрлэхээсээ өмнө тачаангуй үнсэлцэх, өөр хүний дээр гарч хэвтэх эсвэл өөр хүний нууцлаг эрхтнүүд эсвэл биенд хувцастай болон хувцасгүйгээр хүрэх зэрэг зүйлсийг хийж болохгүй. Бэлгийн харилцааны мэдрэмжийг өдөөх зүйл бүү хий. Өөрийнхөө биед ийм хүслийг өдөөх зүйл бүү хий. Ариун Сүнсийн өдөөлтийг анхааралтай сонс, тэгвэл та нар цэвэр мөн ариун журамтай байж чадна. Бэлгийн харилцааны гэм нүгэлтэй хүнээс Их Эзэний Сүнс авагдах болно.

Орой үдшийн цагаар болон гэрээсээ хол хоногоор явах үйл ажиллагаанууд эсвэл насанд хүрэгчдийн хараа хяналтаас гадуурх үйл ажиллагаанууд зэрэг уруу таталт ихтэй нөхцөл байдлуудаас зайлсхий. Бэлгийн харилцааны мэдрэмжүүдийг өдөөх аливаа мэдээллийн хэрэгсэл ашиглах болон ийм ярианд бүү оролц. Садар самууны ямар ч зүйлд оролцож болохгүй. Ариун Сүнс танд эгзэгтэй үед тусалж, ийм нөхцөл байдлаас өөрийгөө татан гаргах хүч чадлыг өгч чадна. Итгэлтэй байж, эцэг эх болон удирдагчдынхаа зөв зөвлөгөөнд дуулгавартай бай.

“Ижил хүйстэнтэйгээ явалдах нь маш ноцтой нүгэл юм. Хэрвээ ижил хүйстэндээ татагдах явдалд шаналж байгаа эсвэл зүй бус зүйлд уруу татагдаж байгаа бол эцэг эх болон бишопоосоо зөвлөгөө хүс. Тэд та нарт туслах болно.

Бэлгийн харилцааны хүчирхийлэлд өртөгсөд нь нүгэл үйлдсэнд тооцогдохгүй бөгөөд наманчлах

шаардлагагүй байдаг. Хэрвээ та хүчирхийллийн хохирогч болсон бол та гэмгүй бөгөөд Бурхан та нарт хайртай гэдгийг мэдэх хэрэгтэй. Эцэг эхтэйгээ эсвэл насанд хүрсэн итгэдэг хүнтэйгээ энэ талаар ярилцаж, бишопоосоо даруй тусламж хүс. Тэд та нарыг сүнслэг байдлаар дэмжиж, шаардлагатай тусламж, хамгаалалтыг авахад тань туслах болно. Эдгэрэлтийн үйл явц цаг хугацаа шаарддаг. Аврагчид итгэ. Тэрбээр таныг эдгээж, амар амгаланг өгөх болно.

“Хэрэв та нар бэлгийн харилцааны ямар нэгэн хэлбэрийн нүгэл хийхэд уруу татагдсан бол эцэг эх, бишопоосоо тусламж хүс. Уруу таталтыг тэсвэрлэж, зохисгүй бодол, мэдрэмжүүдийг давж гарахад тань туслах Тэнгэр дэх Эцэгтээ хандан залбир. Хэрвээ та бэлгийн харилцааны нүгэл үйлдсэн бол яг одоо нүгэлээ наманчлах үйл явцыг эхэл. Ингэснээр та амар амгаланг олж, Сүнсийн бүрэн нөхөрлөлтэй байж чадна.

“Бэлгийн харилцааны хувьд цэвэр ариун байх хувийн амлалт өг. Үг үйлдлээрээ бусдыг өөрийн адил үйлдэхийг уриал (*Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө Товхимол* 35–37).

Их Эзэн таныг уншсан зүйлээсээ ямар захиаст анхаарлаа хандуулаасай гэж хүсэж байгааг тунгаан бод.

Алма 39:7–19

Алма Кориантоныг наманчлахад уриалсан нь

Эцэг эх, залуу эрэгтэйчүүд эсвэл залуу эмэгтэйчүүдийн удирдагчид, бишоп эсвэл салбарын ерөнхийлөгчтэйгөө бэлгийн харилцааны цэвэр ариун байдлын ач холбогдлын тухай ярилцаж байна гэж төсөөлөн бод. Таны эцэг эх эсвэл сүмийн удирдагчид танд бэлгийн харилцааны цэвэр ариун байдлын ач холбогдлын талаар зөвлөхөд та ямар хариулт өгөхөө бодож үзнэ үү. Алма 39:7–8-ыг уншиж, Кориантонд нүглийнх нь ноцтой байдлын талаар Алмагийн заасан зүйлийн зорилго нь юу байсныг олж мэд. Цэвэр ариун байх, наманчлах болон Бурханы шүүлтээс зайлсхийх эцэг эхийнхээ эсвэл сүмийн удирдагчдын зөвлөгөөг хайрын урилга гэж үзэх нь тэдэнд өгөх таны хариултад хэрхэн нөлөөлөхийг тунгаан бод.



Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Д. Тодд Кристоффerson эцэг эхчүүд яагаад Алмагийн адил хүүхдүүдээ наманчлахад урьдгийг тайлбарлажээ: “Наманчлахыг урих нь хайрын илрэл юм. . . . Хэрэв бид бусдыг өөрчлөгдөхөд урихгүй эсвэл өөрсдөө наманчлалыг хүсэхгүй бол бид бие биенийхээ өмнө, өөрсдийнхөө өмнө хүлээх үндсэн үүргийг биелүүлж чадахгүй. Зөвлөн эцэг эх, хүлцэнгүй найз, сэтгэл зовнисон сүмийн удирдагчид өөрсдөдөө биш харин тусалж

чадах хүмүүсийнхээ сайн сайхан байдал, аз жаргалд үнэхээр илүү санаа тавьдаг. Тийм ээ, зарим үед наманчлалд урих нь хүлээн зөвшөөрч боломгүй эсвэл гомдмоор бүр дургүй хүрмээр юм шиг санагдаж болох ч, Сүнсээр удирдагдсан үед энэ нь үнэхээр чин сэтгэлийн хайр халамжийн үйлдэл байх болно” (“The Divine Gift of Repentance,” *Ensign* ба *Лиахона*, 2011 оны 11-р сар 39).



2. Дараах бүрэн биш өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ бич: *Наманчлал нь . . . -г багтаадаг.* Дараа нь та Алма 39:9–14-ийг судлахдаа уг өгүүлбэрийг гүйцээж болох наманчлалын тухай юуг Алма Кориантонд заасныг судар судлах тэмдэглэлдээ жагсаан бич.

Алмагийн зөвлөгөөг ойлгож хэрэгжүүлэхдээ дараах асуултууд болон тайлбаруудыг ашигла. Судар судлах тэмдэглэлдээ дээрх өгүүлбэрийг гүйцээхэд тань туслах доор жагсаасан шүлэг тус бүрээс дор хаяж нэг үнэнийг олж бичихийг хичээ. Та эдгээр асуултуудын хариултыг судар судлах тэмдэглэлдээ бичих шаардлагагүй.

Алма 39:9-ийг унш. (Алма 39:9 нь төгс эзэмших судар юм. Та дараа нь үүнийг амархан олохын тулд тусгайлан тэмдэглэх хэрэгтэй.) “Нүдээрээ шунасныхаа араас дахин бүү яв,” “эдгээр зүйлүүдэд өөртөө хориг тавь” гэсэн хэллэгүүд нүглээ орхихтой ямар холбоотой вэ?

Одоо үед “нүдээрээ шунах” гэсэн хэллэгт мөнх бус амьдралын хүчтэй хандлага буюу бүх төрлийн садар самуун зураг, мэдээллийн хэрэгсэл ордог. Алма 39:9-д байгаа “өөртөө хориг тавь” гэсэн хэллэг нь ямар нэг зүйлээс татгалз гэсэн утгатай юм. Бид энэ хэллэгийг өнөө үед тийм ч их ашигладаггүй. Хэдий тийм ч, Иосеф Смитийн үед *хориг тавих* гэсэн үйл үг нь заримдаа “арилгах, цуцлах, . . . саад учруулах . . . ; зогсоох” гэсэн утгуудыг илэрхийлдэг байжээ (*Noah Webster’s First Edition of an American Dictionary of the English Language*, facsimile ed. [1967]). Хэрэв бид эдгээр тодорхойлолтуудыг Алмагийн хүүдээ заасан зүйлүүдийг ойлгоход ашиглавал (эдгээрт бидний хяналтад байдаг ёс суртахуунгүй байдлын уруу таталтуудын эх сурвалжууд орно) “Бурханы хаант улсыг өвлөж” болохын тулд ёс суртахуунгүй байдлын бүх зүйлээс ангижрахын ач холбогдлыг ойлгож чадна. Хожмын үеийн гэгээнтэн өсвөр үеийнхэн өнөөдөр бэлгийн харилцааны цэвэр ариун байдлын асуудлуудад болон нүдээрээ шунасныхаа араас гүйхээс зайлсхийхэд өөрсдөдөө өндөр шаардлага тавьж болох ямар арга замууд байна вэ?

Алма 39:10-ыг унш. —Эцэг эх, сүмийн удирдагчид, ах дүүс, эсвэл итгэлтэй найз нөхдөөсөө— сүнслэг тусламжийг эрэлхийлэх нь хүнийг наманчлахад хэрхэн тусалж чадах вэ?

Алма 39:11–12-ыг уншиж, дараах асуултуудыг тунгаан бод:

- Хүн дахин нүгэл үйлдэхэд чөтгөрөөр удирдуулахгүй байхын тулд түүний наманчлалын үйл явцад зүрх сэтгэлд нь ямар өөрчлөлт гарах ёстой вэ?
- Хоосон, мунхаг зүйлсийн хойноос хөөцөлдөхөөс зайлсхийх нь хүнийг наманчлахад хэрхэн тусалж чадах вэ?

Алма 39:13-ыг унш. Зорамчууд Кориантоны биеэ авч явах байдлыг хараад Алмагийн үгсэд итгэх байсан эсэхийг Алма Кориантонд хэлснийг эргэн сана (Алма 39:11-ийг үзнэ үү). Судруудад “Их Эзэнд ханд” гэсэн хэллэг нь наманчлалыг илэрхийлдгийг ойлгох нь тустай байж болох юм. Наманчлал нь “зүрх сэтгэл болон хүслээ Бурхан руу эргүүлэх үйл явц” юм (Судруудын Удирдамж, “Наманчлал”).

- Бүх “оюун, зүрх сэтгэл, мөн чадлаараа” наманчилна гэдэг нь юу гэсэн утгатай гэж та бодож байна вэ?
- Бидний нүглүүд бусдад нөлөөлөх үед бид наманчлалынхаа хэсэг болгож юу хийх ёстой вэ?
- Ноцтой нүгэл үйлдэгдсэн үед яагаад бишоп эсвэл салбарын ерөнхийлөгчөөсөө тусламж хүсэх шаардлагатай байдаг вэ?

Алма 39:9–13-аас бид үүнийг сурдаг: **Наманчлалд нүглээ хүлээж, орхих болон Их Эзэнд бүх оюун, бүх зүрх сэтгэл, бүх хүч чадлаараа хандах нь ордог.**

Их Эзэн танаас зүрх сэтгэл, хүслээ Түүн рүү бүрэн хандуулахын тулд юу хийхийг хүсдэг гэж бодож байгаагаа тунгаан бод. Та эдгээр өдөөлтүүдийг хэрэгжүүлж эхлэхийн тулд өнөөдөр юу хийж болох вэ?

Есүс Христ болон Түүний Цагаатгалгүйгээр та нүглээсээ уучлагдах боломжгүй юм. Алма 39:15–16, 19-ийг уншиж, Алма Есүс Христ ирж, дэлхийн нүглүүдийг зайлуулах болно гэсэн мэдлэгийг хэрхэн дүрсэлснийг олж мэд.




3. Есүс Христийн ирэлт Кориантонд болон танд яагаад сайн мэдээ болохыг судар судлах тэмдэглэлдээ бич.

Төгс эзэмших судар—Алма 39:9

Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Ричард Г. Скотт судруудыг цээжлэх талаар ингэж хэлжээ:

“Судруудыг судлах, тунгаан бодох, судруудаас эрж хайх болон цээжлэх нь дэлхий дээр хэзээ ч, хаана ч хандаж болох найз нөхөд, үнэт зүйлс болон үнэнүүдээр дүүргэсэн бичиг баримтын шүүгээтэй байхтай адил юм.

“Судруудыг цээжилснээр агуу хүчийг хүлээн авч чадна. Нэг судрыг цээжлэх нь нэг шинэ найзтай болохтой адил юм. Энэ нь хэрэгтэй үед тусалж, сүнслэг удирдамж, тайтгарлыг өгч, хэрэгтэй өөрчлөлтийг хийх урам зоригийн эх сурвалж байж чадах шинэ хүнийг таньж мэдэхтэй адил юм” (“The Power of Scripture,” *Ensign* ба *Лиакхона*, 2011 оны 11-р сар, 6).

 **4.** Алма 39:9-ийг цээжлэхийг хичээ. Энэ шүлгийг цээжлэх нь таныг уруу таталтын үед хэрхэн хамгаалах талаар нэг эсвэл хоёр өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ бич.

 **5.** Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Алма 39-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

20-Р ХЭСЭГ: 2 ДАХЬ ӨДӨР

Алма 40–41

Оршил

Алма 40–41-т цэдэглэснээр Алма хүү Кориантондоо үхлийн дараах амьдралтай холбоотой чухал сургаалуудыг заажээ. Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан бүх хүмүүн амилуулагдах болно гэдгийг Алма тайлбарладаг. Алма бас Кориантонд нас барагсад нь мөнх бус байдлынхаа үед хийсэн сонголтынхоо улмаас диваажинд эсвэл сүнсний шоронд амилуулалтыг хүлээн сүнсний ертөнцөд байдаг тухай заав. Сэргээлтийн төлөвлөгөө нь зөвхөн бие махбодын амилуулалтыг төдийгүй бас бид үйлдэл болон хүслийн үр дагавруудаа хүлээн авдаг сүнсний амилуулалтыг мөн багтаадаг гэдгийг Кориантон Алмагаас сурчээ. Алма эцэст нь, ёс бус явдал хэзээ ч жинхэнэ аз жаргал руу хөтөлж чадахгүй гэсэн үнэн нь энэхүү сэргээлтийн төлөвлөгөөний хамгийн гол зүйл юм гэдгийг онцолдог.


Алма 40

Алма Кориантонд сүнсний дэлхий болон амилуулалтын талаар заасан нь

Саяхан танай нэг найз ойр дотны хүнээ алдсан гэж төсөөлөн бод. Тэр найз чинь чамайг сүсэг бишрэлтэйг мэддэг учраас дараах асуултуудыг асуухаар чам дээр иржээ:

- Биднийг юу дахин амьдрах боломжтой болгодог вэ? Ямар хүмүүс амилуулагдах вэ?
- Бид нас барсныхаа дараа хаана очдог вэ? Энэ нь ямар байдаг бол?
- Амилуулалт гэж юу вэ? Бидний мөнх бус бие махбод, амилуулагдсан бие махбод хоёр хоорондоо ямар ялгаатай вэ? Биднийг амилуулагдсаны дараа юу болох вэ?

Алма 40-р бүлэг дэх мэдээлэл эдгээр асуултуудад хариулахад тусалж чадна. Энэ бүлэг нь хүү Кориантондоо заасан Алмагийн сургаалуудын үргэлжлэл юм. Кориантон нас барагсдын амилуулалтын талаар санаа зовних болов.

 **1.** Дараах гурван судрын хэсгийг бүгдийг нь унш. Нэг эсвэл илүү олон хэсгийг сонгож, Алмагийн заасан зүйлүүд нь холбогдох асуултуудад хэрхэн хариулж байгааг судар судлах тэмдэглэлдээ тайлбарлан бич. (Хэрэв танд энэ хичээлийн төгсгөлд цаг гарвал энэ хэсгийг дахин үзэж, Алмагийн бусад шүлгүүдэд юу заасныг харж болно.)

а. Алма 40:1–5-ыг судал. Бидэнд дахин амьдрах боломжийг юу олгодог вэ? Ямар хүмүүс амилуулагдах вэ?

б. Алма 40:6–7, 11–14-ийг судал. Бид нас барсныхаа дараа хаана очдог вэ, мөн энэ нь ямар байдаг вэ? (Алма бүх хүмүүсийн сүнс “өөрсдөд нь амьдралыг өгсөн Бурханд, гэртээ аваачигддаг” (Алма 40:11) гэж заасан нь энэ нь Бурханы шүүлтийн дараах эцсийн хувь тавилан биш харин бидний сүнс үхлийн дараа амилуулалтын өмнө сүнсний дэлхий рүү буцах болно гэдгийг заасан юм. Алма “гадаад харанхуйн” талаар дурдахдаа ямар утгыг илэрхийлснийг ойлгохын тулд 13-р шүлгийн зүүвэр тайлбарыг үзэх хэрэгтэй. Мөн гадаад харанхуйн талаарх энэхүү үг ихэнхдээ сүнсний шорон гэж бидний нэрлэдэг газрыг хэлж байгаа бөгөөд энэ нь ялагд-



сан хүмүүсийн орших эцсийн эсвэл байнгын газар биш харин амилуулалтын өмнөх байдал гэдгийг ойлгоход Алма 40:14 бидэнд тусалдаг.

В. Алма 40:21–26-г судал. Амилуулалт гэж юу вэ? Бидний мөнх бус бие махбод, амилуулагдсан бие махбодын хоорондох ялгаа юу вэ? Биднийг амилуулагдсаны дараа юу болох вэ?

Тэргүүн зөвлөлийн Ерөнхийлөгч Жорж К.Каннон Алма 40:11–12-ын талаар, “хүмүүс нас барсан даруйдаа Бурханы оршихуйд хүлээн авагддаг гэсэн санааг илэрхийлэхийг Алма зориогүй юм. Тэрээр энэхүү хэллэгийг тохирох утгаар хэрэглэсэн нь тодорхой юм” хэмээн тайлбарлажээ (*Gospel Truth: Discourses and Writings of President George Q. Cannon*, sel. Jerreld L. Newquist, 2 vols. [1957–74], 1:73).

Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Нийл А. Максвэлл бидний амилуулалтын дараа тохиолдох зарим туршлагын талаар дүрсэлсэн нь:

“Шүүлтийн өдөр . . . бүх зүйл бодитоор дүгнэгдэх болно. Мормоны Номд өгүүлснээр бид буруу үйлдлүүдийнхээ “тодорхой дурдатгал” болон “төгс санамжид” байхаас гадна баяртай үйл явдал ч бас тохиож, сэргээгдэх болно. Бид ‘бүр одоо мэдэж байгаагийнхаа адилаар’ тэр үед мэдэх болно. (Алма 5:18; 11:43; мөн С ба Г 93:33-ыг үзнэ үү.) Хамтран эзэмших мэдээллийн сан байх учраас бид үүнийг ‘нүдээрээ’ (Мозая 12:22; 15:29) үзэх болно.

“Эцэст нь ‘сэргээгдсэн байх ёстой бүх зүйлсийн’ (Алма 40:23) дунд бидний мөнх бус байдлын өмнөх оршихуйн дурсамжуудыг багтаасан санамж байх болно. Оюун ухаан ба зүрх сэтгэл нь анхны болон хоёр дахь байдалтай холбоотой санамжуудаар нэгдсэн байхын баяр баясгалангийн талаар бодож үзнэ үү.

“Тэгвэл бидний хайрт Бурхан бидний ой санамжуудыг мэргэн ухаанаар бүрэн сэргээснээр ямар мэдрэмж биднийг бялхтал дүүргэх болоо! Энэхүү сэтгэл сэргээсэн үнэн нь Бурханы нэн их тэвчээр болон Есүсийн сайн дураараа хийсэн Цагаатгалын хайраар дүүрэн нинжин сэтгэлийн төлөөх бидний талархлыг цаашид өсгөн нэмэгдүүлэх болно!” (*Lord Increase Our Faith* [1994], 103).

Амилуулалт нь сүнс болон биеийг дахин нэгтгэх бөгөөд бүх зүйл зохих байдалдаа төгс хэлбэрээрээ сэргээгдэх болно. Бид бүгд амилуулалтын дараа Бурханы өмнө шүүгдэхээр зогсох болно. Алма 40:25–26-г уншиж, энэ амьдралд зөв шударгыг үйлдэгчдийн эцсийн байдлыг ёс бусыг үйлдэгчдийн эцсийн байдалтай харьцуулсан Алмагийн дүрслэлийг ол. Энэхүү захиас нь Бурханы өмнө цэвэр ариун байх таны хүсэлд хэрхэн нөлөөлөхийг бодож үзнэ үү.

Алма 40:16–22-т цэдэглэснээр Алмагийн ярьсан амилуулалт нь дэлхийн цаг хугацаатай холбоотой юм. Есүс Христ анхны амилуулагдсан хүн бөгөөд удалгүй Адамын үеэс Христийн амилалтын үе хүртэлх хугацаанд зөв шударга амьдарч байгаад нас барсан хүмүүс амилуулагдсан билээ (Алма 40:16, 20; С ба Г 133:54–55-ыг үзнэ үү). Энэхүү амилуулалтыг Алма “эхний амилуулалт” гэж нэрлэсэн юм.

Алма 41

Алма Кориантонд сэргээлтийн төлөвлөгөөний талаар заасан нь

Амилуулалт, сүнсний дэлхий, шүүлтийн талаар Алмагийн заасан үнэнүүдийг бодож үзээд, эдгээр нь дараах зүйлсэд итгэдэг хүмүүсийн үйлдлүүдэд хэрхэн нөлөөлж болохыг тунгаан бод:

- Үхлийн дараах амьдрал гэж байхгүй.
- Биднийг нас барсны дараа дэлхий дээрх бидний үйлс сайн эсвэл муу байснаас үл хамааран бид төгс болгогдоно.
- Бид шүүлтийн үед сайн үйлсийнхээ улмаас шагнагдаж, муу үйлсийнхээ улмаас шийтгэгдэх болно.



Бид Алма 41-ээс зарим хүмүүсийн амилуулалтын талаар заасан зүйлүүдийн улмаас Кориантон төөрөлдсөнийг мэдэж авдаг. Алма 41:1 дэх “хол төөрөн одсон” гэсэн хэллэгийг тэмдэглээд зарим хүмүүсийг төөрөлдөхөд юу хүргэснийг олж мэдэхийн тулд энэ шүлгийг дахин унш. Судруудыг *гуйвуулах* гэдэг нь судруудын утгыг мушгин


гажуудуулах, эсвэл өөрчлөх гэсэн утгатайг мэдэх нь энэ шүлгийг ойлгоход тань туслах болно.

Алма ямар санааг Кориантонд зориулж тодруулан тайлбарлах гэж байна гэж хэлсэн бэ? _____

Сэргээлт нь буцаан авчрах гэсэн утгатай. Алма Кориантоныг “сэргээлтийн төлөвлөгөө” гэж нэрлэсэн зүйлдээ бие махбодын болон сүнсний тал байдгийг ойлгоосой гэж хүссэн ажээ (Алма 41:2). Алма 41:2–5-ыг судалж, үхлийн дараа бидэнд бие махбод ба сүнс хэрхэн сэргээгдэхийг тэмдэглэ. (Энэ шүлгүүд дэх *зайлишгүй* гэсэн үг нь хэрэгцээтэй эсвэл шаардлагатай гэсэн утгатай юм.)

Алма 41:2-т сэргээлтийн төлөвлөгөөн дэх бие махбодын ямар тал нь дурдагдсан бэ? _____


Алма 40:3–5-д сэргээлтийн төлөвлөгөөн дэх сүнсний талыг ийнхүү дүрсэлжээ: **Бид мөнх бус байдал дахь үйлүүд болон хүслүүдийнхээ дагуу аз жаргалд эсвэл зовлонг байдалд сэргээгдэх болно.**

 **2.** Та Алма 40:3–5-ыг хүүхдийн хэсгийн ангид заахаар боллоо гэж бод. Та сүнсний сэргээлтийн талаар Алмагийн заасан зүйлийг хүүхдүүдэд ойлгомжтой, энгийн аргаар хэрхэн тайлбарлахаа судар судлах тэмдэглэлдээ бич.

Сэргээлтийн сургаалыг ойлгох нь таны үйлдэл болон хүсэлд хэрхэн нөлөөлж болохыг бас хэрхэн нөлөөлөх ёстойг тунгаан бод.

Бид сэргээлтийн сургаалыг ойлгосноор нүгэл болон буруу сонголтынхоо үр дагавруудын талаар аяндаа санаа зовж эхэлдэг. Бидний буруу хүсэл болон үйлдлүүдийн муу үр дагавруудыг өөрчлөх ямар нэг арга зам бий юу? Алма Кориантонд найдах шалтгааныг санал болгов. Алма 41:6–9-ийг уншиж, бид ноцтой нүгэл үйлдсэн ч бидэнд зориулан бэлтгэсэн сайн сайхан байдал, аз жаргалыг хүлээн авахын тулд юу хийж болохыг олж мэд. Та амилуулалтаар хүлээн авах зүйлүүддээ хариуцлагатай байхыг бидэнд зөвлөсөн үг хэллэгүүдийг Алма 41:6–7-гоос олж тэмдэглэх хэрэгтэй. Дараах асуултын талаар бод: Эдгээр шүлгүүд дээр үндэслэн бид ямар тал дээр өөрсдийнхөө шүүгчид байдаг вэ?

Үйлдлүүдийнхээ талаар хувийн хариуцлага хүлээхгүйгээр Бурханд эргэн очиж чадна гэж боддог хүмүүс байдаг. Тэд ихэнхдээ өөрсдийн нүгэлт сонголтуудыг хөгжилтэй зүйл гэж хэлдэг. Нүгэл үйлдсэн хүмүүс заримдаа аз жаргалтай юм шиг харагддаг. Гэвч Алма 41:10-ыг уншиж, Алма ёс бус явдлын талаар юу гэж заасныг олж мэд. (Алма 41:10 нь төгс эзэмших судар юм. Та дараа нь үүнийг амархан олохын тулд тусгайлан тэмдэглэх хэрэгтэй.

 **3.** Алма 41:10-т Алма хүүдээ “ёс бус явдал хэзээ ч аз жаргал байгаагүй” гэдгийг гэрчилжээ. Судар судлах тэмдэглэлдээ дараах даалгавруудыг хий:

- а.** Та Алмагийн үгс яагаад үнэн гэж бодож байгаага бич.
- б.** Бид Бурханы зарлигуудыг зөрчсөн ч аз жаргалтай хэвээр байж чадна гэж Сатан бидэнд итгүүлэхийг хичээж болох нэг жишээ бич.

Та судрынхаа Алма 41:10-ын хажууд Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсоны дараах мэдэгдлийг бичиж болно: “Та буруу зүйл хийсэн атлаа зөв гэсэн мэдэрэмжтэй байж чадахгүй. Энэ бол боломжгүй зүйл!” (“A Message to the Rising Generation,” *Ensign*, 1977 оны 11-р сар, 30).

Алма 41:11-д буруу зүйл хийсэн үед яагаад жинхэнэ аз жаргалтай байх боломжгүйг тайлбарладаг. Энэ шүлгийг ойлгоход өөртөө туслахын тулд судрын хэллэг бүрийг тохирох утгатай нь тохируулж дараах хүснэгтийг бөглө. (Дууссаныхаа дараа хариултуудаа хичээлийн төгсгөл дэх хариутай тулга.)

“Төрөлхийн чанарт” байхыг дүрсэлсэн Алма 41:11 дэх үг хэллэгүүд	Утга
___ 1. “Зуурдын чанарт буй”	А. Нүглүүддээ баригдсан, дарамтад байгаа
___ 2. “Шаналлын гүн мөн алдсын хүлээсэнд байна”	Б. Ариун Сүнсний нөхөрлөлөө алдсан
___ 3. “Дэлхийд Бурхангүй”	В. Махан биеийн хүслүүдэд захирагдсан

Та одоо эдгээр хэллэгүүдийг тодорхойлж, буруу сонголт хийсэн үед яагаад аз жаргалтай байх боломжгүйг ойлгохын тулд Алма 41:11-ийг дахин унш. Ёс бус явдлыг сонгодог зарим хүмүүс тухайн үедээ аз жаргалтай байна гэж бодож болох ч тэдний сонголтууд эцэстээ гуниг зовлон, аз жаргалгүй байдал руу хөтөлдөг.

 **4.** Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

- а.** Та яагаад “төрөлхийн чанарт” эсвэл нүгэлт эсвэл “эгэл чанарт” байх нь аз жаргалын мөн чанарын эсрэг зүйл гэж боддог вэ?
- б.** Залуу хүмүүс өөрсдийгөө Ариун сүнсний нөхөрлөлөө алдсан, нүглүүддээ баригдсан, дарамтад буйгаа эсвэл махан биеийн хүслүүддээ захирагдсанаа мэддэг ямар жишээнүүд байна вэ?

Алма 41:12-ыг уншиж, Кориантоноос сэргээлтийн талаар асуусан Алмагийн асуултыг ол. Одоо Алма

41:13-ыг уншиж, энэ асуултад Алма хэрхэн хариулсныг тэмдэглэ.



5. Аз жаргалтай байхыг хүсдэг боловч Их Эзэний зарлигуудын эсрэг арга замуудаар үйлдэхийг сонгодог нэг найзтайгаа ярилцаж байна гэж төсөөл. Та өнөөдөр судалсан сэргээлтийн сургаалаа ашиглан найзыгаа яагаад аз жаргалыг мэдрэхгүй байгааг болон жинхэнэ аз жаргалтай болохын тулд тэрээр юу хийх ёстойг судар судлах тэмдэглэлдээ тайлбарлан бич.

Бүмэранг гэдэг нь анх ан авлахад ашиглагддаг хэрэгсэл байжээ. Үүнийг зөв шидвэл шидсэн хүн рүүгээ эргэж ирдэг. Алма 41:14–15-ыг уншиж, бүмэранг нь дээрх шүлгүүд дэх үнэнүүдийг хэрхэн бэлгэдэж байгааг олж мэд. Та 15-р шүлэг дэх “гадагш илгээсэн” гэсэн хэллэгийг тэмдэглэх хэрэгтэй. Та сайн сайхан, нигүүлсэл эсвэл өгөөмөр сэтгэлийг бусдад илгээгээд үүнийгээ буцаан хүлээн авсан үеийнхээ талаар бод.



Та ямар зөв шударга үйлдлийг бусдад үйлдэж эсвэл ямар зөв шударга зан байдлаа бусдад харуулж мөн үүнийгээ бусдаас хүлээн авахыг хүсдэг вэ? Та эдгээр зан байдал эсвэл үйлдлүүдийн нэгийг “гадагш илгээх” ямар зорилго тавьж болох вэ? _____

Төгс эзэмших судар—Алма 41:10



6. Алма 41:10-ыг уншиж, дараах бүрэн бус өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ бич: *Хэрэв ёс бус явдал хэзээ ч аз жаргал байгаагүй юм бол _____ нь үргэлж аз жаргал руу хөтөлдөг.* Энэ өгүүлбэрийг гүйцээхэд хамгийн сайн тохирч байгаа нэг үгийг хоосон зайд бич. Одоо энэ хоосон зайд мөн адил тохирч болох хэдэн тодорхой зөв шударга үйлдлийг жагсаан бич (жишээ нь, *бусдад үйлчлэх*). Эдгээр зөв шударга үйлдлүүдийн зарим нь хэрхэн аз жаргал руу хөтөлж байгааг харсан тухай гэрчлэлээ бич.

Зөв шударга байдлаас ирдэг аз жаргал нь энэхүү мөнх бус амьдралд үргэлж тэр даруй ирдэггүй, өөрчлөгддөггүй эсвэл байнга байдаггүйг ойлгох нь чухал юм. Хэдий тийм ч, амар амгалан, аз жаргал нь үргэлж Их Эзэний арга замаар мөн Түүний цагт Түүний сургаалууд болон зарлигуудад зохистой байдаг хувь хүмүүст ирдэг юм.



7. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Алма 40–41-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

Утгыг нь тохируулах үйл ажиллагааны хариу: (1) в, (2) а, (3) б.

20-Р ХЭСЭГ: 3 ДАХЬ ӨДӨР

Алма 42

Оршил


Нүгэл үйлддэг хүмүүст нигүүлслийг олох арга замыг Тэнгэрлэг Эцэг боломжтой болгосныг Алма тайлбарласнаар шаналан буй хүү Кориантондоо өгөх зөвлөгөөгөө дуусгав. Тэрээр нүглийн төлөө шударга ёсны хуулийн шаарддаг шийтгэлийн тухай хүүдээ заасан ажээ. Дараа нь тэр Есүс Христ нүгэл үйлдсэн ч наманчлах хүсэлтэй бүгдийн төлөө зовлон шаналлыг амссанаар “шударга ёсны шаардлагыг хангасныг” (Алма 42:15) гэрчилжээ. Их Эзэн гэмшигчдэд (наманчлагчдад) нигүүлслийг боломжтой болгосон юм.

Алма 42:1–14

Алма Кориантонд шударга ёсны хуулийн талаар заав

Нэг хором нүдээ аньж, эцсийн шүүлт тань дээр ирэх үед ямар санагдахыг тунгаан бод. Та амьдралаа эргэж хараад эцсийн шүүлт шударга байхыг хүсч байна уу? Та яагаад өөрийнхөө шүүлт шударга байхыг хүсэх вэ?

Одоо *шударга* гэдэг үгийн утгыг бодож үзнэ үү. *Шударга* гэдэг үгийн нэг тодорхойлолт нь хүртээ ёстой зүйлээ авах юм; шударга байдлын энэ утга нь *шударга ёс* гэсэн судрын нэр томьёотой холбоотой юм.





1. Энд харагдаж байгаатай адил энгийн жинлүүрийг судар судлах тэмдэглэлдээ зур. Дараа нь зургийнхаа доор *Шударга ёс* гэж бич. Судар судлах тэмдэглэл дэх зургийнхаа доор энэ хичээлийг үргэлжлүүлэн судлах явцдаа нэмэлт зүйлсийг бичих зай үлдээ.

Шударга ёсны тухай үзэл баримтлалыг илүү сайн ойлгоход тань туслах Арванхоёр төлөөлөгчийн чуулгын Ахлагч Даллин Х.Өүксийн дараах тайлбарыг унш:



“Шударга ёс нь олон утгатай. Нэг утга нь тэнцвэртэй байдал юм. Шударга ёсны нийтлэг бэлгэдэл нь жинлүүр юм. . . .

“ . . . Хүний хүртэх ёстой шударга ёсны санаа нь үйлүүдийнхээ дагуу шүүгдэж буй хүмүүсийн талаар гардаг бүх судруудын үндсэн нөхцөл юм” (“Sins, Crimes, and Atonement” [Сүмийн Боловсролын Системийн шашны боловсролынхонд хандаж хэлсэн үгнээс, 1992 оны 2-р сарын 7], 1).

Алмагийн хүү Кориантон эцсийн шүүлт шударга байх эсэхэд санаа зовж байжээ. Алма 42:1-ийг уншиж, Кориантон эцсийн шүүлтийн юу нь шударга бус байна гэж бодсоныг олж тэмдэглэ.

Кориантон олон төрлийн нүглийг түүний дотор маш ноцтой зарим нүглийг үйлдсэнийг сана (Алма 39:2–3); тиймээс Кориантон нүгэл үйлдэгчид шийтгэгдэх нь шударга бус хэрэг гэж бодож байсан байж болох юм.



2. Та яагаад нүглүүдээ наманчлаагүй хүмүүс шүүлтээр “хүртэх ёстойгоо” хүлээн авах тухайд санаа зовдог гэж боддогоо судар судлах тэмдэглэлдээ бич.

Алма 42:2–11-т Алма Адамын уналт нь биеийн үхэл (бие болон сүнс нь биеийн үхлээр салдаг) ба сүнсний үхлийг (нүглийн улмаас Бурханаас салах) авчирсныг тайлбарласнаар Кориантоны санаа зовнилыг арилгаж өгдөг. Тиймээс хүн төрөлхтнийг унасан байдлаас нь буцаан гаргах төлөвлөгөөг бий болгох шаардлагатай байсан юм. Ингэхгүй бол бүх хүн төрөлхтөн нүгэлт байдалдаа үлдэж, шударга ёсны шаардлагын дагуу үргэлж зовлонтой байх байсан юм.

Алма 42:12-ыг уншиж, хүн төрөлхтнийг унасан байдалд юу оруулсныг мэд. Одоо Алма 42:14-ийг уншиж, бидний дуулгаваргүй байдлын хариуд шударга ёсны дагуу ирэх үр дагавруудыг тэмдэглэ. Судар судлах тэмдэглэлдээ зурсан жинлүүрийнхээ зүүн жинлүүрийн доор *зөрчил—дуулгаваргүй байдал эсвэл нүгэл* гэж, харин баруун жинлүүрийн доор *торгууль—Бурханы оршихуйгаас тусгаарлагдах* гэж бич.



3. Алма 42:18-ыг унш. Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

- “Ухамсрын гэмшил” (Алма 42:18) гэдэг нь юу гэсэн утгатай гэж та бодож байна вэ?
- Ухамсрын гэмшил нь биднийг юу хийхэд хөтөлж болох вэ?

Алма хувь хүн дуулгаваргүй байвал шударга ёсны хууль юуг шаарддаг гэж заасан бэ? (Бидний дуулгаваргүй байдлын улмаас шударга ёсны хууль нь биднээс гэмшлийг мэдэрч, Бурханы оршихуйгаас тусгаарлагдахыг шаарддаг.) Та хийсэн буруу зүйлээсээ болж харамсал, шаналлыг эсвэл Ариун Сүнснээс холдсоноо мэдэрсэн үеийнхээ тухай нэг хором тунгаан бод. Тэр мэдрэмжээ хийсэн бүх буруу зүйлийнхээ тоогоор үржүүлэн бодоод энэхүү мэдрэмж танд үүрд байх болно гэдгийг төсөөлөн бод.

Та Алмагийн заасан зүйл дээр үндэслэн эцсийн шүүлт зөвхөн шударга ёсонд тулгуурласан байхыг хүсч байна уу? Та хийсэн буруу зүйлүүдийнхээ уршгаар “хүртэх ёстой зүйлээ” хүлээн авахыг хүсч байна уу?

Алма 42:15–31

Алма Кориантонд нигүүлслийн төлөвлөгөөний талаар заасан нь

Бурханы тэнгэрлэг мөн чанаруудын нэг нь Түүний



шударга байдал юм. Шударга ёсны шаардлага нь Тэнгэрлэг Эцэгийн хүүхэд бүрийг буруутгах бөгөөд бидний хэнд нь ч нүгэлт байдалдаа Түүнтэй хамт оршихыг зөвшөөрдөггүй юм. Дараах асуултыг бодож үз: Энэхүү шударга ёсны шаардлагыг арилгах эсвэл хэрэгсэхгүй болгох ямар нэгэн арга зам байдаг уу?

Олон хүмүүс энэ асуултад, хэрэв бид наманчилбал нүглүүдийнхээ үр дагаврын улмаас зовох шаардлагагүй болно гэж хариулж болох юм. Хэдийгээр

энэ хариулт ерөнхийдөө зөв боловч шударга ёсны шаардлагуудыг хангаагүй нөхцөлд үр дагавруудыг арилгах эсвэл уучлах нь шударга бус байх болно гэдгийг ойлгох нь чухал юм. Алма шударга ёсны шаардлагуудыг хангахгүйгээр шийтгэлийг хэрэгсэхгүй болгох нь боломжгүй гэдгийг заадаг. Алма 42:25-ыг уншиж, хэрэв Бурхан зүгээр л нүглийн үр дагавруудыг арилгаж, шударга ёсны шаардлагыг хангалгүй үлдээвэл юу болохыг олж мэд.

Алма 42:15-ыг уншиж хариултыг нь олохоосоо өмнө дараах асуултыг тунгаан бод: Хэрэв бидний нүглүүдийн шийтгэлийг холдуулж болохгүй юм бол бид хэзээ, хэрхэн ухамсрын амар амгаланг олж, Бурханы оршихуйд сэргээгдэж чадах юм бэ?

Асуултыг тунгаан бодох

Та судруудыг судлах үедээ асуултуудыг тунгаан бодох хэрэгтэй. Энэ нь асуултуудын хариуг олохын тулд судруудыг судлах хүсэл төрүүлэх болно. Та судруудыг судлахдаа тунгаан бодох хэдэн асуултуудаа тэмдэглэж авч болно. Судруудыг тунгаан бодох нь зарчмууд ба үнэнүүдийг ойлгож, амьдралдаа хэрэгжүүлэх чадварыг тань нэмэгдүүлэх болно.

Энэ нь “шударга ёсны шаардлагыг хангах” гэсэн хэллэг нь шударга ёсны шаарддаг шийтгэлүүдийг биелүүлэх эсвэл төлөх гэсэн утгатайг ойлгоход тусалж болох юм.

Бид Алма 42:15-аас үүнийг сурдаг: **Есүс Христийн Цагаатгал нь шударга ёсны шаардлагыг хангасан учраас нигүүлсэл нь наманчлагчид хүрэх боломжтой болсон юм.** “Торгууль . . .” -ын доор *нигүүлслээр*—Есүс

Христийн Цагаатгалаар шаардлагыг хангасан гэсэн хэллэгийг бичсэнээр судрын тэмдэглэлдээ зурсан жинлүүрийн зургаа гүйцээ.



4. Гэм нүглийнх нь уршгаар бий болсон ачаа дарамтад шаналж буй нэг найз чамд байдаг гэж төсөөл. Та найздаа Есүс Христийн Цагаатгал нь бидний хүн нэг бүрд нигүүлслийг хэрхэн боломжтой болгохыг хэрхэн тайлбарлахаа судар судлах тэмдэглэлдээ бич.

Аврагч нигүүлслийг хүлээн авах боломжийг танд олгохын тулд таны өмнөөс шударга ёсны шаардлагын шийтгэлийг сайн дураараа амсан зовсныг мэдэх нь таны хувьд ямар утга учиртайг тунгаан бод.

Алма 42:22–24-ийг уншиж, Есүс Христ бидэнд нигүүлслийг боломжтой болгохын тулд биднээс юу шаарддагийг олж тэмдэглэ. 24-р шүлэг дэх “үнэнээр гэмшигч” гэсэн хэллэг нь чин сэтгэлээсээ наманчлагч гэсэн утгатай юм. Уншсан зүйл дээрээ тулгуурлан дараах зарчмыг гүйцээн бич: **Хэрэв бид**

наманчилбал Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан _____ хүлээн авах болно.

Арванхоёр төлөөлөгчийн чуулгын Ерөнхийлөгч Бойд К.Пакэр Есүс Христийг зууч хэмээн хэлсэн байдаг. Зууч нь оролцогч хоёр талын хооронд асуудлыг шийдвэрлэхэд тусалдаг хүн юм. Та эдгээр үгсийг уншихдаа ямар учраас нүгэлтэнд нигүүлслийг боломжтой болгоход Аврагч хэрэгтэйг олж мэд.



“Мөнхийн хуулиар бидний өрийг өөр дээрээ авч, төлөөсийг төлөн, бидний гэтэлгэлийн нөхцөлийг тогтоох хүсэлтэй бөгөөд ийм чадвартай хэн нэгэнгүйгээр нигүүлсэл боломжтой болж чадахгүй юм.

“Хэрэв зууч байхгүй байсан бол, хэрэв бидэнд найз байхгүй байсан бол, чанд хатуу, өршөөлгүй шударга ёсны бүх ачаа дарамт бидэн дээр зайлшгүй буух болно. Өчүүхэн ч байна уу, ноцтой ч байна уу ялгаагүй гэм нүгэл бүрд зориулсан шийтгэл биднээс шаардагдах болно.

“Харин үүнийг мэд: Үнэн, алдар суут үнэн нь ийм Зууч байдгийг тунхагладаг. . . .

“Түүгээр дамжин шударга ёсны мөнхийн хуулийг зөрчихгүйгээр бидний хүн нэг бүрд нигүүлсэл боломжтой болж чадна. . . .


“Нигүүлсэл нь бидэнд өөрөө аяндаа ирдэггүй, харин Түүнтэй гэрээ хийснээр ирдэг. Гэрээ нь Түүний нөхцөлөөр, Түүний өгөөмөр нөхцөлөөр хийгдэх болно” (“The Mediator,” *Ensign*, 1977 оны 5-р сар, 55–56).

Алма Кориантонтой хийсэн яриагаа дуусгаад хүүдээ заах гэсэн бүх зүйлээ хураангуйлан дүгнэжээ. Алма 42:26–31-ийг уншиж, Кориантон энэ бүлэгт Алмагийн заасан сургаалууд болон зарчмуудыг ойлгосон үед Алма түүний төлөө юу хүссэнийг тэмдэглэ. Алма Кориантоныг нүглээ хаацайлах шалтаг эрэхийн оронд шударга ёс, нигүүлсэл ба Цагаатгалтай холбоотой сургаал болон зарчмуудад “зүрх [сэтгэлдээ] бүрэн нөлөөлөх” (Алма 42:30) боломж олгохыг хүссэнийг анхаар. Та хэрхэн эдгээр сургаал болон зарчмуудыг зүрх сэтгэлдээ бүрэн нөлөөлөх боломжийг олгох вэ?



5. Дараах асуултын талаарх бодлуудаа судар судлах тэмдэглэлдээ бич: Хэрэв та Аврагчийн таны төлөө хийсэн золиослолд талархаж байгаага Түүнд өөрийн биеэр илэрхийлэх боломжтой байсан бол та Түүнд юу гэж хэлэх вэ?

Кориантон наманчилж, эцэст нь Сүмийн өсөлт хөгжилд агуу нөлөө үзүүлснийг мэдэх нь чухал юм (Алма 49:30-ийг үзнэ үү).

 **6.** Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Алма 42-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

20-Р ХЭСЭГ: 4 ДЭХ ӨДӨР


Алма 43–44

Оршил

Алма 43–44-т леменчүүд болон нифайчуудын хоорондох дайны талаар Мормон бичиж эхэлдэг. Алма болон түүний хөвгүүд хүмүүст үргэлжлүүлэн үйлчилж байх үед нифайчууд руу дайрахаар зорамчууд леменчүүдтэй нэгддэг. Ахмад Моронай леменчүүдийн эсрэг нифайчуудыг хамгаалах итгэл болон мэргэн ухаанаа харуулав. Хэдийгээр леменчүүд тоогоор илүү байсан ч, нифайчуудын их цэргийн бэлтгэл болон Есүс Христэд итгэх итгэл нь тулалдаанд тэдэнд давуу талыг олгосон байна. Леменчүүд ялагдах гэж байгаага мэдээд энхийн гэрээ хийж, нэг улирлын турш уг нутгаас гарчээ.

Алма 43

Ахмад Моронайн бэлтгэл болон арга мэх нь леменчүүдийн их цэргийн төлөвлөгөөг нураав

 **1.** Ирээдүйн төлөвлөгөө, зорилго болон хүсэл бодлоо судар судлах тэмдэглэлдээ жагсаан бич. Та бичихдээ номлолын ажил, ариун сүмийн гэрлэлт, гэр бүл зэрэг сүнслэг зорилго болон хүслээ оруулахад анхаар.

Жагсаалтаа бичиж дууссаны дараа Сатан чамайг ямар хүсэл бодол, зорилгоо биелүүлэхийг хүсэхгүй гэж бодож байгааг тогтоо. Алма 43–44-ийг судлахдаа таны амжилтад саад болох эсэргүүцлийн хүчнүүдийг үл харгалзан зөв шударга зорилгуудаа гүйцэлдүүлэхэд тань туслах зарчмуудыг олж мэд.


Алма 43:1–4-т зорамчуудыг сүмд буцаан авчрах Алмагийн хүч чармайлтыг эс тооцвол тэднээс маш олон нь леменчүүдийг нифайчууд руу дайрахаар бэлтгэхэд нь нэгддэг. Алма 43:5–8-ыг уншиж, леменчүүдийн удирдагч Зерахемнагийн “бодлогуудыг” (төлөвлөгөөнүүдийг) ол. Та Зерахемнагийн зорилгуудыг тодорхойлж, тэдгээрийг тэмдэглэж болно. Нифайчуудад зориулсан Зерахемнагийн бодлогууд



эсвэл хүслүүд нь танд хандсан Сатаны бодлогуудтай хэрхэн адилхан байж болохыг тунгаан бод.

Дараа нь Алма 43:9–11-ийг уншиж, нифайчуудын бодлого эсвэл хүслүүдийг тодорхойл. Одоо эдгээр хүслүүд таны зөв шударга хүслүүдтэй хэрхэн адилхан байж болохыг тунгаан бод.


Нифайчуудын их цэргийн ерөнхий ахлагч ахмад Моронай хүмүүсээ газар нутаг, гэр бүлээ Зерахемнагийн хилэнцэт зорилгуудаас хамгаалахад нь бэлтгэдэг. Алма 43:16–19-ийг уншиж, ахмад Моронай болон нифайчуудын хийсэн бэлтгэлийг олж мэд.

 **2.** Моронай хүмүүстээ тулалдаанд бэлтгэхэд нь өгсөн зүйлүүдээс хоёрыг нь судар судлах тэмдэглэлдээ зур.

Одоо Алма 43:20–22-ыг уншиж, нифайчуудын бэлтгэлд леменчүүд ямар хариу үйлдэл үзүүлснийг олж мэд. Леменчүүдийн тоо нифайчуудынхаас илүү олон байсан ч тэд яагаад дайралтаасаа ухарсныг тунгаан бод.

Бид Мормоны Номд байгаа бие махбодын дайнуудын талаарх цэдгүүдийг судлах үедээ тэдгээрийг


өөрсдөдөө тулгардаг сүнсний дайнуудтай адилтгаж болно.

 **3.** Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултад хариулж бич: Та Моронайн дайнд бэлтгэлтэй байснаас нь Сатаны дайралт болон уруу таталтуудын эсрэг өөрийгөө хамгаалах талаар юу сурч болох вэ?

Моронай леменчүүдийг ухарсны дараа дайснууд нь дараа хаанаас дайрахыг мэдэхгүй байлаа. Хэрэв та Моронайн оронд байсан бол дараагийн дайралтад бэлтгэхийн тулд юу хийх байсан бэ? _____

Моронай юу хийснийг мэдэхийн тулд Алма 43:23–24-ийг унш.

Бид Моронайн жишээнээс үүнийг сурдаг: **Хэрэв бид бошиглолын зөвлөгөөг эрэлхийлж дагавал дайснаас өөрсдийгөө илүү сайн хамгаалах болно.** Бошиглогч Алма Моронайд нифайчуудыг дайснуудаасаа хэрхэн хамгаалахыг хэлэх боломжтой байсан шиг өнөө үеийн Их Эзэний бошиглогчид дайсны дайралтаас сүнслэг байдлын хувьд өөрсдийгөө хэрхэн хамгаалахыг бидэнд заадаг.

 **4.** Хэрэв та анхаарал тавин сонвол Сатаны төлөвлөгөө болон уруу таталтуудаас өөрийгөө хамгаалахад тань тусалж чадах хожмын өдрүүдэд өгөгдсөн бошиглолын зөвлөгөөний талаар хэдэн өгүүлбэр судар судлах тэмдэглэлдээ бич.

Алма 43:25–43-т цэдэглэснээр Моронай бошиглогчоос хүлээн авсан мэдлэгийнхээ дагуу их цэргээ хувааж, леменчүүдийн ирэх замын хажуугаар тэднийг нуувчинд байрлуулжээ. Леменчүүдийг ирэх үед нифайчуудын их цэргийн нэг хэсэг нь леменчүүд рүү дайрч, тэднийг Сидон гол руу шахан түрэв. Леменчүүдийг гол гаталсны дараа нифайчуудын нөгөө хэсэг тэдэн рүү дайрдаг. Леменчүүд бүслэгдсэнээ хараад нифайчуудын хүчийг суларгал ширүүн тулалдав.

Та Алма 43-ын үлдсэн хэсгийг судалж, зөв шударга зорилго болон хүсэл бодлоо хэрхэн биелүүлэх зарчмуудыг сурч болно. Алма 43:43–54-ийг уншиж, леменчүүд болон нифайчуудын хүчний эх сурвалжийн ялгааг олж харьцуул.

Нифайчуудын дайтсан зорилго нь леменчүүдийн дайтсан шалтгаанаас юугаараа илүү болохыг тунгаан бод. Бид Моронай болон түүний итгэлтэй их цэргийг Сатаны эсрэг хийдэг тулалдаануудтайгаа харьцуулж, **зөв шударга төлөвлөгөө болон хүслээ гүйцэлдүүлэхэд туслаач хэмээн залбирвал, Бурхан бидэнд туслах болно.**




 **5.** Та зөв шударга зорилгоо биелүүлэхэд Их Эзэний тусламжийг мэдэрсэн үеийнхээ тухай судар судлах тэмдэглэлдээ бич.

Алма 44

Ахмад Моронай нифайчуудын ялалтын дараа энх тайвны гэрээ хийхийг леменчүүдэд тушаадаг

Алма 43-т ахмад Моронай леменчүүд бүслэгдэж, айсныг харсан даруйдаа хүмүүстээ тулалдахаа зогсоохыг тушаадаг. Алма 44:1–6 дахь Моронайн үгсийг уншиж, Моронай нифайчуудын ялалтад хэнийг алдаршуулсныг олж мэд.

 **6.** Алма 44:4–6 дахь Моронайн гэрчлэл дээр үндэслэн сүнсний тулалдаантай учрахад тань туслах нэг үнэнийг судар судлах тэмдэглэлдээ бич.

Арванхоёр төлөөлөгчийн чуулгын Ерөнхийлөгч Бойд К.Пакэр залуучуудад хэрэв тэд итгэлтэй хэвээр

байвал Их Эзэн тэднийг хамгаалах болно гэдгийг амлажээ. Та үүнийг уншихдаа танд тайтгарал өгч байгаа болон тантай холбоотой гэж бодож байгаа хэсгүүдийг тодруулан тэмдэглэ.



“Өнөө үед өсвөр үеийнхэн ёс суртахууны жишиг унаж байгаа үед дайсны нутагт өсөн хүмүүжиж байна. Гэвч хэрэв та нар Ариун Сүнснээс ирэх өдөөлтүүдэд анхаарлаа хандуулбал та нар дайсны дайралтуудаас хамгаалагдах болно гэдгийг би Их Эзэний үйлчлэгчийн хувьд амлаж байна.

“Зохистой хувцасла; хүндэтгэлтэйгээр ярь; сүнслэг байдлыг дэмжих дуу хөгжмийг сонс. Ёс суртахуунгүй бөгөөд хувийн жишгийг тань доройтуулагч аливаа дадал зуршлуудаас зайлсхий. Амьдралаа хянаж, зоригтой байхад биеэ дайчил. Бид та нарт маш их итгэл хүлээлгэж байгаа учраас та нар гайхалтайгаар адислагдах болно. Та бүхэн хайрт Тэнгэрлэг Эцэгийнхээ хараанаас хэзээ ч хол байдаггүй” (“Counsel to Youth,” *Ensign* ба *Луахона*, 2011 оны 11-р сар, 18).

Алма 44:7–10-т Зерахемна нифайчуудын хүч чадлын эх сурвалж нь Бурхан гэдэгт итгээгүйгээ хэлдэг. Тэрээр леменчүүд зэвсгээ хаях болно гэдгийг санал болгосон ч энх тайвны гэрээ хийхээс татгалздаг. Алма 44:11 дэх Моронайн хариуг унш. Та Моронайд леменчүүдтэй энх тайвны гэрээ хийх нь яагаад чухал байсан гэж бодож байгаагаа тунгаан бод.

Леменчүүдээс олон нь энх тайвны гэрээ хийсэн боловч Зерахемна Моронайн их цэрэгтэй тулалдахын тулд үлдсэн хүмүүсээ цуглуулж байв. Нифайчууд леменчүүдийг довтолж, тэднийг хөнөөж эхлэхэд Зерахемна их цэрэг нь устгагдахыг хараад энх тайвны гэрээнд орохыг амладаг (Алма 44:12–20-ийг үзнэ үү).



7. Та уруу таталтууд, дайсны дайралтуудаас өөрийгөө хамгаалж, зөв шударга хүсэл, зорилгуудаа биелүүлэхийн тулд энэ хичээлээс сурсан зарчмууд болон үнэнүүдийг хэрхэн хэрэгжүүлэхээ судар судлах тэмдэглэлдээ бич.



8. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Алма 43–44-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

21-Р ХЭСЭГ: 1 ДЭХ ӨДӨР

Алма 45–49

Оршил

Алма хүү Хиламандаа сүүлчийн сургамжаа өгсний дараа Нифайн хүмүүсийн дундаас явсан бөгөөд түүний талаар дахин хэзээ ч сонсогдоогүй юм. Нифайчуудад тохиолдсон хүнд хэцүү үед нь Хиламан, Ахмад Моронай хоёр тэдний сүнслэг байдлын болон цэргийн удирдагчид болдог. Леменчүүдийн удирдагч Амаликая хувиа хичээн чөтгөрийн арга мэхтэй адил бусармаг аргуудыг хэрэглэн шударга бус хүслээ дагадаг. Ахмад Моронай хүмүүсээ тэрхүү аюултай цаг үедэд Бурханд итгэлтэй байхад нь бэлтгэдэг.

Алма 45

Хиламан эцэг Алмагийнхаа үгсэд итгэж, үйлчлэлээ эхэлсэн нь


Эцэг эхтэйгээ эсвэл санваарын удирдагчтайгаа хийж байсан ярилцлагаа эргэн сана. Танаас тэдний асуусан асуултуудын талаар бод. Алма уг нутгаас гарахаасаа өмнө Хиламанаас гурван чухал асуултыг асуудаг. Алма 45:2–7-г уншиж, эдгээр асуултуудыг олж тэмдэглэ. (2-р шүлэгт Алмагийн дурдсан “үгс” Алма 37:1-т мөн байдаг.) Та Алмагийн асуултуудад хэрхэн хариулах байснаа бод: Та судруудад итгэдэг үү? Та Есүс Христэд итгэдэг үү? Та зарлигуудыг дагах уу?

Хиламаныг гэрчлэлээ хэлсний дараа Алма түүнд нифайчуудын ирээдүйн талаар ярьжээ. Алма тэдний устгалыг болон энэхүү сонгогдсон нутагт ёс бус байдалд боловсрох бусад хүмүүсийн устгалыг бошиглодог. Алма 45:16-г уншиж, энэ шүлэг дэх дараах үнэний талаар бодож үз: **Их Эзэн нүглийг хамгийн бага хэмжээгээр ч гэсэн хүлээн зөвшөөрч чаддаггүй.**



Биднийг наманчилж, Аврагчийн уучлалыг эрэлхийлэхэд бидний бүх нүглийн төлөөсийг Тэрбээр Цагаатгалаараа дамжуулан төлдөг гэдгийг санах нь энэхүү зарчмыг ойлгоход тань туслах болно. Бурхан гэм нүглийг өчүүхэн төдий ч тэвчиж чаддаггүй. Хэдий тийм ч Аврагч бидний өмнөөс зовох хүсэлтэй байсны учир бид наманчилсан бол нүглийнхээ төлөө зовох шаардлагагүй болсон юм.

Сургаал ба Гэрээ 1:31–33-ыг унш. Та эдгээр шүлгүүдийг Алма 45:16-гийн хажууд холбогдох эшлэл болгон бичиж болно.

 **1.** Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултуудад хариул: Таны нүглийн төлөөсийг төлөх Аврагчийн хүслийн талаар та ямар бодолтой байдаг вэ?

Алма 45:20–24-т цэдэглэснээр Хиламан үйлчлэлээ Их Эзэний бошиглогч бөгөөд сүмийн удирдагчийн хувьд эхэлсэн ажээ. Тэр болон сүмийн бусад удирдагчид сүм даяар үйлчлэх пристүүд болон багш нарыг томилсон ч зөрчилдөөн ба бардамнал газар авснаас болж хүмүүс удирдагчдаа сонсохоос татгалздаг.


Алма 46

Ахмад Моронай эрх болон шүтлэгээ хамгаалахын тулд зөв шударга хүмүүсийг нэгтгэн цуглуулав

Алма 46:1–7-д цэдэглэснээр Хиламан болон түүний ах дүүст уурласан зарим хүмүүс сүмийг орхиж, хаан болохыг хүсэгч Амаликая хэмээх нэгэн ёс бус хүнийг дагахаар сонгодог. Алма 46:8–10-ыг уншиж, Мормон биднийг энэхүү аюултай нөхцөл байдлаас юу сураасай гэж хүссэнийг олж мэд.

Нифайчуудын их цэргийн ерөнхий ахмад Моронай хүмүүсийн эрх чөлөөг хамгаалахын тулд тэднийг нэгтгэн цуглуулахаар нөмрөгөө урж, үүнийхээ нэг хэсгээр “эрх чөлөөний туг” хийжээ.

Алма 46:12–13-ыг уншиж, Моронай эрх чөлөөний туган дээрээ юу гэж бичсэнийг олж тэмдэглэ. Тэрээр хүмүүст эрх чөлөөний тугаа таниулахын тулд хэрхэн бэлтгэснийг ол. Эдгээр шүлгүүд Моронайн зан чанарын талаар юу зааж байгааг тунгаан бод. Мөн ахмад Моронайн зан чанарын талаар илүү сайн ойлголттой болохын тулд Алма 48:11–13, 17–18-ыг унш. Та Моронайн зан чанаруудаас амьдралдаа хөгжүүлэхийг хүсч буй зан чанаруудыг тэмдэглэж болно.

 **2.** Алма 46:12–13, Алма 48:11–13, 17–18 дахь Моронайн зан чанаруудаас нэгийг эсвэл илүү олныг судар судлах тэмдэглэлдээ бич. Та яагаад ийм зан чанаруудтай байхыг хүсч байгаа болон эдгээрийг хөгжүүлэхээр хэрхэн хичээхээ тайлбарлан бич.



Алма 46:18–22-ыг уншиж, эрх чөлөөний төлөө тэмцэх Моронайн уриалгад хүмүүс хэрхэн хариулсныг олж мэд. 20-р шүлэгт дүрслэгдсэн уг гэрээ нь нифайчуудын энэ бүлгээс Бурханд өгсөн онцгой амлалт юм.

Алма 46:20-д цэдэглэснээр Моронай яагаад нифайчууд эрх чөлөө, шүтлэг бишрэлээ хамгаалахын тулд Бурхантай гэрээ хийхийг хүссэн бэ? _____

Алма 46:28–37-д цэдэглэснээр Ахмад Моронайтай нэгдсэн нифайчууд Амаликаягийн их цэргийг олзолдог. Гэвч Амаликая зарим хүмүүсийнхээ хамт зугтаж, леменчүүдтэй нэгддэг. Амаликаягийн олзлогдсон дагалдагчдаас олон нь эрх чөлөөг дэмжих гэрээнд оржээ. Гэрээнд ороогүй хүмүүс үхэлд хүргэгдэв. Бид нифайчуудын туршлагаас дараах зарчмыг сурч чадна: **Бид Ахмад Моронайн адил зарлигуудыг дагах зоригтой байвал Бурхан биднийг хүчирхэгжүүлж, адисалдаг.**

Ахмад Моронай тулалдааны дараа тэд юуны төлөө тэмцэж, юуг хамгаалах гэрээ хийснийхээ “жишиг” эсвэл сануулга болгон бүх нифайчуудын цамхаг бүр

дээр эрх чөлөөний тугийг мандуулсан юм (Алма 46:36-г үзнэ үү).

Залуучуудын бат бөх байдлын төлөө товхимолд Тэргүүн Зөвлөл ийн хэлжээ: “Хайрт залуу эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд ээ бид та нарт агуу итгэл найдвар хүлээлгэдэг билээ. Та нар бол Бурханы хайртай охид хөвгүүд бөгөөд Тэр та нарыг мэддэг, та нарт санаа тавьдаг. Та нар агуу их боломжууд болоод мөн асар их сорилт бэрхшээлүүдийн үед энэ дэлхийд мэндэлсэн билээ. Энэ товхимол дахь жишгүүд одоо болон ирээдүйд чухал сонголтуудыг хийхэд тань та нарт туслах болно. Та нар хийсэн гэрээнүүд болон эдгээр жишгүүдээ дагаснаар Ариун Сүнсний нөхөрлөлөөр адислагдаж, итгэл, гэрчлэл тань өсөн хүчирхэгжиж, үлэмж их аз жаргалтай болно гэдгийг бид амлаж байна.



3. Та судар судлах тэмдэглэлдээ Тэргүүн Зөвлөлийн энэхүү захиасаас сурсан зүйлээсээ дараах асуултуудад хариулж бич:

а. Хэрэв та нар хийсэн сайн мэдээний гэрээнүүд болон *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимол дахь жишгүүдээр амьдарвал, та нарт ямар амлалтууд өгөгдсөн бэ?

б. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимлын гарчгийг харж, товхимол дахь жишгүүдээс нэгийг сонго. Энэ жишгийг дагаснаар таны амьдрал хэрхэн адислагдсан бэ? Эсвэл энэ нь таны амьдралыг ирээдүйд хэрхэн адисалж болох вэ?

Алма 47

Амаликая урван тэрслэлт болон заль мэхээр леменчүүдийн хаан болов

Таныг тулалдаж байх үед хэн нэгэн нь таныг болон гэр бүлийг тань устгах дайсны төлөвлөгөөг илчилсэн нэгэн номыг танд өгвөл та яах вэ? Алма 47-р бүлэг нь бидний дайсан болох чөтгөрийн төлөвлөгөөний талаар зарим ойлголтуудыг өгч чадна.

Алма 47-д Амаликая леменчүүдийн их цэргийг нифайчуудын эсрэг дайнд удирдахын тулд леменчүүдийн хаан болохыг хичээсэн олон оролдлогыг цэдэглэсэн байдаг. Түүний эцсийн хүсэл бол бүх нифайчуудыг боолчлолд авчирч, өөрөө хаан нь болох явдал байлаа.

Амаликая болон түүний дагалдагчид эхлээд леменчүүдийн амьдарч байсан Нифайн нутаг руу очдог. Леменчүүдийн хаан нифайчуудын эсрэг дайтахыг хүссэн ч ихэнх хүмүүс нь айж байв. Тиймээс уг хаан Амаликаягаас тэрхүү айсан леменчүүдийг дайнд нэгдэхэд албадахыг хүсдэг. Амаликая тэдгээр хүмүүсийн зугтсан газар уулын бэхлэлт рүү хүрч очсон ч хаанд туслахыг хүссэнгүй. Тэрээр айж хулчийсан леменчүүдийн удирдагч Лихонтиг мэхлэн уулын бэхлэлтээс бууж ирүүлээд өөрөө тэдний хаан болохыг

хүсчээ. Амаликая Лихонтиг уулнаас бууж ирснийх нь дараа түүнд хор өгч хөнөөхөөр төлөвлөдөг.

Алма 47:10–12-ыг судал. Амаликая Лихонтиг аюулгүй газраасаа гарч ирүүлэхийг хэдэн удаа оролдсон бэ? Мөн Алма 47:17–19-ийг унш. Амаликая Лихонтиг уулнаас бууж ирснийх нь дараа түүнийг хэрхэн хөнөөсөн бэ?



Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Роберт Д.Хэйлс өнөө үеийн хүмүүс биднийг сүнслэг байдлын аюулгүй газраасаа гарч, чөтгөрийн нутаг руу ороход уруу татсанаар бидний итгэл болон гэрчлэлийг устгахыг хичээж болно гэдгийг заадаг: “Бид Мормоны Номоос Лихонти болон түүний хүмүүс уулын орой дээр байрласан тухай уншдаг. Урвагч Амаликая Лихонтиг ‘бууж ирээд’ түүнтэй хөндийд уулзахыг ятгадаг. Гэвч Лихонти өндөр газрыг орхисноор үхэх хүртлээ ‘бага багаар’ хордож, түүний их цэрэг Амаликаягийн гарт ордог (Алма 47-г үзнэ үү). Зарим хүмүүс маргаан болон гүтгэлгээр дамжуулан биднийг өндөр газрыг орхиход өдөөн хатгадаг. Өндөр газар нь гэрэл байдаг. . . . Энэ нь аюулгүй газар юм. Өндөр газар нь үнэн бөгөөд мэдлэг тэнд оршдог” (“Christian Courage: The Price of Discipleship,” *Ensign* эсвэл *Луахона*, 2008 оны 11-р сар, 74).



4. Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

а. Биднийг сүнслэг байдлын өндөр газруудаас “бууж ирүүлэхийг” эрэлхийлдэг Сатаны зарим аргууд юу вэ?

б. Сатан залуу хүмүүсийг жишгүүдээ “бага багаар” бууруулах байдлаар мэхлэхийг хичээдэг гэж та боддог уу? Үүний ямар жишээ байна вэ?

в. Сүнслэг байдлын хувьд өндөр газарт үлдэхийн тулд та ямар тодорхой зүйл хийж чадах вэ? Та энэхүү жишгийг “бага багаар” бууруулахгүйн тулд сайн мэдээний ямар жишиг дээр ажиллах шаардлагатай байгаа вэ?

Сатан Амаликаяг хөнөөснийхөө адил **биднийг устгахыг эрэлхийлдэг бөгөөд жишгүүдээ бага багаар бууруулахад биднийг уруу татдаг.**

Алма 48–49


Ахмад Моронай нифайчуудад өөрсдийгөө бие махбод болон сүнслэг байдлын хувьд хүчирхэгжүүлэхэд сүнслэгээр нөлөөлөв

Амаликая “заль мэх мөн луйвраар” (Алма 48:7) леменчүүд болон нифайчуудын дээр хүч ба эрх мэдлийг олохыг улайран хичээж байсан бол Моронай маш өөр арга замаар ажиллаж байлаа. Алма 48:7–10-г уншиж, Моронай Амаликаяг леменчүүдийн их цэргийг нифайчуудын эсрэг удалгүй удирдан ирэх

болно гэдгийг мэдээд юу хийснийг ол. Та эдгээр санаануудыг тэмдэглэх хэрэгтэй: (1) Тэрээр хүмүүсийг хэцүү цаг үеүдэд Бурханд итгэлтэй байхад нь бэлтгэсэн юм (7-р шүлгийг үзнэ үү). (2) Тэрээр хүмүүст сул дорой байдлаа хүчирхэгжүүлэхэд нь туслав (8—9-р шүлгийг үзнэ үү). (3) Тэрээр хүмүүсийг “Христэд итгэгчдийн зорилго” эсвэл сүмийг дэмжиж, хамгаалахад бэлтгэдэг (10-р шүлгийг үзнэ үү).

Моронай хүмүүсээ хүнд бэрх үеүдэд эцсээ хүртэл тэвчихэд бэлтгэхэд нь тусалсны адилаар өнөө үеийн сүмийн удирдагчид хүнд цаг үеүдэд бэлтгэхэд бидэнд туслахын тулд зөвлөгөө өгдөг. Та дараах үнэнийг судартаа Алма 48:7–10-ын хажууд бичиж болно: **Бид Их Эзний үйлчлэгчдийн зөвлөгөөг дагаснаар амьдралын сорилт бэрхшээлүүдийг даван туулахад бэлтгэгдэх болно.**

Леменчүүд эхлээд нифайчуудын сул дорой хотууд болох Аммонайха хот, дараа нь Ноа хот руу дайрахаар төлөвлөж байв. Леменчүүд Аммонайха хот дахь нифайчуудын бэлтгэлийг хараад ямар хариу үйлдэл үзүүлснийг мэдэхийн тулд Алма 49:4–5-ыг унш. Тэр хот нь дайсны дайралтад маш сайн бэлтгэгдсэн учраас леменчүүд хот руу дайрахгүй байхаар шийддэг. Леменчүүд Ноа хот руу дайрахыг хичээх үедээ юу хийснийг мэдэхийн тулд Алма 49:12–14-ийг унш.

 **5.** Хамгийн сүүлчийн ерөнхий чуулган дээр хэлсэн үгсийг хэдэн хором дахин хар (*Ensign* эсвэл *Лиакона*). Нэг эсвэл илүү олон үг хэлэгчдийн өгсөн зөвлөгөөг судар судлах тэмдэглэлдээ товчлон бич. Энэ зөвлөгөө амьдралын хүнд хэцүү үеүдэд бэлтгэлтэй байхад тань хэрхэн тусалж чадах вэ? Та энэ зөвлөгөөг амьдралдаа хэрхэн ашиглаж болох вэ?

 **6.** Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Алма 45–49-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

21-Р ХЭСЭГ: 2 ДАХЬ ӨДӨР

Алма 50–52; 54–55

Оршил

Ахмад Моронай хотуудынхаа бэхлэлтийг сайжруулснаар хүмүүстээ өөрсдийгөө хамгаалахад нь туслахаа үргэлжлүүлэв. Нифайчууд эсэргүүцэл болон ёс бус байдал нь тэднийг сул дорой болгох

хүртэл леменчүүдийг амжилттай эсэргүүцэж байв. Моронай хүмүүсээ нэгтгэж, тэднийг хамгаалахыг чармайж байсан ч нифайчууд зөрчилдөөнийхөө уршгаар олон хотоо алддаг. Эцэст нь Моронай, Тианкам, Лихай нар Мюлек хотыг буцаан авч, леменчүүдийн хамгийн том армиудын нэгийг бутцохидог. Леменчүүдийн ёс бус удирдагч Амморон олзлогсдоо солилцох хэлэлцээр хийхийг оролдсон ч Моронай олзлогдсон нифайчуудыг цус урсгалгүйгээр суллан авдаг. Моронай бат зогсож, Амморон болон түүний дагалдагчидтай хэлэлцээр хийсэнгүй.

Алма 50–51

Нифайчууд Их Эзэнд дуулгавартай, эв нэгдэлтэй байх үедээ хүчирхэгжиж, хөгжин цэцэглэж байв

Та уруу таталт, эрүүл мэндийн асуудал, сургууль дээрх асуудал, найз нөхөд эсвэл гэр бүлийн гишүүдийн харилцаан дахь асуудал зэрэг амьдралдаа тохиолдсон бэрхшээлийг даван туулахаар тэмцсэн үеийнхээ талаар бод. Та тэр үед илүү их сүнслэг хүчтэй байсан ч болоосой гэж хүсч байсан уу?



Тэргүүн зөвлөлийн гишүүн Ерөнхийлөгч Хэнри Б.Айринг ийн хэлжээ: “Бидний эргэн тойрон дахь [нүглийн] хүч эрчимтэй өсөхөд нэгэн цагт хангалттай байсан сүнслэг хүч чадал эдүгээ хангалттай байж чадахгүй болж байна.

Нэгэн цагт боломжтой гэж бидний боддог байсан сүнслэг хүч чадлын өсөлт эдүгээ илүү агуу өсөлтийг бидэнд боломжтой болгох болно. Сүнслийн хүч чадлын хэрэгцээ болон үүнийг олж авах боломж аль аль нь бид тохиолдох аюулыг дутуу үнэлсэн үед улам нэмэгддэг” (“Always,” *Ensign*, 1999 оны 10-р сар, 9).


Нифайчуудын тулаандаа хийсэн бэлтгэл нь бидэнд дараах үнэнийг сурч авахад тусалдаг: **Хэрэв бид өөрсдийгөө сүнслэг байдлын хувьд бэлтгэвэл амьдралын сорилт бэрхшээлүүдийг даван туулж чадна.**

Алма 50:1–6-г унш. Нифайчууд хотуудаа тойруулан бэхлэлт барихын тулд юу хийсэн бэ? Алма 50:7-г унш. Нифайчууд дайнд бэлтгэхийн тулд өөр юу хийсэн бэ?

Нифайчууд маш хүнд хэцүү цаг үед тэдэнд хүч чадал өгсөн бэхлэлтүүдийг барьжээ. Бид хэцүү цаг үед шаардагдах хүч чадалтай байхын тулд одоо сүнслэг хүч чадлаа бий болгосноор тэдний үлгэр жишээг дагаж чадна. Сүнслэг хүч чадал нь өдөр тутмын, байнгын хүч чармайлтын үр дүнд хамгийн үр ашигтайгаар төлөвшин бий болдог. Бид судруудыг тогтмол судлах, залбирах, сүмийн цуглаануудад оролцох, дуудлагаа биелүүлэх, Бурханд талархал илэрхийлэх, бусдад үйлчлэх, сүмийн удирдагчдынхаа зөвлөгөөг



анхааралтай сонсох зэрэг энгийн зүйлсээр дамжуулан сүнслэг байдлын хувьд хүчтэй болдог.

 **1.** Судар судлах тэмдэглэлдээ дараах өгүүлбэрдийг гүйцээн бид:

а. Би . . . аар (хийж чадах зүйлүүдээ жагсаан бич) илүү их сүнсний хүч чадлыг бий болгож чадна.


б. Би сүнслэг хүч чадлаа өдөр бүр хүчирхэгжүүлэхийн тулд (жагсааж бичсэн зүйлсээсээ нэгийг сонго) _____ илүү тогтмол хийх болно.

Алма 50:19–23-ыг уншиж, өөрсдийн өдрүүд дэх хэцүү нөхцөл байдлуудыг үл харгалзан Түүнд итгэлтэй байсан нифайчуудыг Их Эзэн хэрхэн адисалсныг олж мэд. Та эдгээр шүлгүүдийн хажууд дараах зарчмыг бичиж болно: **Бурханд итгэх итгэлтэй байдал нь бүр үймээн самуунтай үед ч адислалуудыг авчирдаг.** Нифайчуудыг эдгээр адислалуудыг алдахад хүргэсэн зүйл юу байсан гэж Мормон хэлснийг мэдэхийн тулд Алма 50:21-ийг унш.

Ахмад Моронай леменчүүдийн эсрэг дайнуудад нифайчуудыг удирдаж байх үед Пахоран нифайчуудын ерөнхий шүүгч болжээ. Тэрээр зөв шударга хүн байсан бөгөөд уг нутагт амар амгалан тогтоохоор

ажилласан ажээ. Хэдий тийм ч нифайчуудын нэг хэсэг нь шүүгчдийн засаглалаар бус хаанаар удирдуулахаар нифайчуудын хуулийг өөрчлөхийг хүсдэг. Энэ асуудлыг сонгуулиар шийдэхээр болж, хүмүүс шүүгчдийн засаглалаа авч үлдэхээр сонгожээ. Гэвч “хааныг хүсэгчид” хүмүүсийн сонголтыг дэмжихийг хүсээгүй бөгөөд леменчүүдийг дайтахаар ирэх үед бусад нифайчуудтайгаа хамт тулалдахаас татгалздаг. Моронай хааныг хүсэгч хүмүүсийг нифайчуудтай нэгдэхэд албадахын тулд их цэргээ тэдний эсрэг удирдахаас өөр аргагүй болов. Энэ нь нифайчуудыг леменчүүдийн эсрэг дайнд ихэд сулруулахад хүргэсэн ажээ (Алма 51:1–21-ийг үзнэ үү).

Алма 51:22–27-г уншиж, хааныг хүсэгчдийн зөрчилдөөнөөс болж леменчүүд нифайчуудыг давамгайлах хүч, эрх мэдлийг олох боломжтой байсны нотолгоог олж мэд. Дараах зарчмын талаар бод: **Хагарал, зөрчилдөөн нь амар амгаланг устгадаг.**


 **2.** Алма 50:39–40 болон Алма 51:22-ыг уншиж, Пахоран, Ахмад Моронай нар ард түмнийхээ дунд амар амгаланг тогтоохыг хэрхэн хичээнгүйлэн эрэлхийлснийг олж мэд. Та амьдралдаа найз нөхөд, гэр бүлийн гишүүд, сургуулийн хамт олон эсвэл бусад хүмүүсийн дундах зөрчилдөөнийг харсан үеийнхээ талаар бод. Мөн амар амгалан тогтоохыг хичээдэг хэн нэгний зан чанарын талаар бод. Амар амгаланг тогтоогч хүнд байж болох зан чанаруудын талаар судар судлах тэмдэглэлдээ бич.

Алма 52

Моронай, Тианкам нар леменчүүдийг ялахын төлөө хамтран ажилласан нь

Алма 51:33–34-г цэдэглэснээр нифайчуудын агуу удирдагчдын нэг Тианкам Амаликаяг устгажээ.

Тулалдаанаас өмнө хөгжүүлсэн зан чанарууд



Дайны үеэр харуулсан зан чанарууд

Залуу дайчин—Залуу Хожмын Үеийн Гэгээнтэн

Амаликаягийн үхлийн дараа түүний дүү Амморон леменчүүдийн их цэргийн удирдагыг гартаа авчээ. Моронай Тианкамд Өгөөмөр нутгийн хойд хэсгийг бэхлэн, хамгаалахаа үргэлжлүүлэх мөн леменчүүдийн эзэлсэн Нифайн хотуудыг боломжтой нөхцөлд буцаан авахыг зааварладаг (Алма 52:1–10-ыг үзнэ

үү). Алма 52:15–17-г уншиж, Тианкам яагаад Мюлек хот руу дайрахгүй байхаар шийдсэнийг олж мэд.

Тианкам дайснаа бэхлэлтэндээ байх үед нь ялахад хэцүү байх болно гэдгийг мэдэж байв. Бид энэхүү туршлагаас дараах зарчмыг сурч болно: **Хэрэв бид дайсны бэхлэлтүүдээс зайлсхийвэл уруу таталтаас зайлсхийж, эсэргүүцэх илүү боломжтой байдаг.**



3. Дайсны бэхлэлт гэж тооцогдохуйц ямар газрууд байдаг вэ? (Хэрэв та дараах газрууд руу явбал нүгэл үйлдэх нөлөөнд автаж болно. Жишээ нь: хүмүүс архи ууж эсвэл зохисгүй кино үзэж байгаа үдэшлэг) Хэдэн ийм газрыг судар судлах тэмдэглэлдээ бич. Мөн та яагаад эдгээр газруудад очихоос зайлсхийх ёстой гэж бодож байгаагаа бич.

Нифайчууд хааныг хүсэгч хүмүүстэй тулалдаж байх үедээ тэд леменчүүдэд олон хотоо алдсан учраас энэ нь тэдний хувьд маш хэцүү үе байжээ. Леменчүүд эдгээр хотуудыг бэхлэлт болгон ашиглаж байсан бөгөөд алдсан хотуудыг буцаан авах нь нифайчуудад маш хэцүү байв. Моронай Мюлек хотыг буцаан авахын тулд леменчүүдийг уг хотоос гаргах төлөвлөгөө зохиодог. Моронай, Тианкам нар юу хийснийг мэдэхийн тулд Алма 52:21–26-г унш.



4. Моронай, Тианкам нар Мюлек хотыг эзлэхийн тулд юу хийснийг судар судлах тэмдэглэлдээ бич (Алма 52:21–26-г үзнэ үү). Мөн та Моронайг ерөнхий ахмадынх нь хувьд юу гэж бодож байгаагаа бич. Тэр юугаараа нифайчуудын сайн ерөнхий ахмад байсан бэ?

Алма 54–55

Моронай Амморонтой олзлогдогсдоо солилцохоос татгалзаж, Гид хотыг буцаан авсан нь

Леменчүүд ба нифайчуудын хоорондох дайны үеэр хоёр тал хоёул дайны олон олзлогдогсодтой болдог. Леменчүүдийн удирдагч Амморон Моронайд олзлогдогсдоо солилцохыг санал болгосон захидал илгээжээ. Олзлогдсон нифайчууд буцан ирж, тэдний их цэрэг леменчүүдийн олзлогдогсдыг цаашид хооллох эсвэл тэдэнд анхаарал тавих шаардлагагүй болох учраас Моронай олзлогдогсдоо солилцох дуртай байв. (Алма 54:1–2-ыг үзнэ үү.)

Гэвч тэрээр Амморонтой захидлаар харилцах үед Амморон нифайчуудыг бууж өгөн, леменчүүдийн захиргаанд орохыг шаарджээ. Тэрээр нифайчууд алуурчид учраас леменчүүд тэдний эсрэг тулалдах нь зөв хэмээн хэлжээ. Мөн тэр Бурхан байхгүй хэмээн тунхагласан. (Алма 54:16–24-ийг үзнэ үү.)

Моронай Аммороны захидлыг хүлээн аваад түүнийг худал хэлснийг мэдэж байлаа. Леменчүүд

нифайчуудын эсрэг тулалдах ямар ч зөв шударга шалтгаан байгаагүй гэдгийг Амморон мэдэж байсан юм. Моронай олзлогсдоо солилцож леменчүүдийг илүү хүчтэй болгохгүй гэж хэлжээ. Тэрээр олзлогдсон нифайчуудаа солилцохгүйгээр тэднийг аврах арга зам олсон байна. (Алма 55:1–2-ыг үзнэ үү.)

Моронай олзлогдсон нифайчуудаа аврахын тулд юу хийснийг олж мэдэхийн тулд Алма 55:3–24-ийг унш.

Моронай Аммороны шаардлагад бууж өгөхийг эсэргүүцэж, олзлогдсон нифайчуудаа аврах арга зам олох үедээ леменчүүд нифайчуудыг хүчээр давамгайлахаас сэргийлснээр нифайчууд давуу байдалтай болжээ. Бид Моронайн энэхүү жишээнээс дараах үнэнийг сурч болно: **Хэрэв бид Их Эзэнд итгэн найдаж, Түүнд яг таг дуулгавартай байвал хэцүү цаг үед Тэр биднийг дэмжих болно.**

Алма 55:3–24-т гардаг түүх нь аварч суллах тухай сэтгэл догдлуулам түүх юм. Энэ түүхийг сонирхон сонсох хүсэлтэй байж болох гэр бүлийн гишүүн эсвэл найзынхаа талаар бодож, түүнд энэ түүхийг ярьж өгөх цагийг төлөвлө. Мөн та тэр хүнтэй дээрх тодоор бичсэн зарчмыг хуваалцаж, Моронай хэрхэн энэ зарчмын жишээ болж байгааг тайлбарлаж болно.



5. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Алма 50–52; 54–55-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

21-Р ХЭСЭГ: 3 ДАХЬ ӨДӨР

Алма 53; 56–58


Оршил

Хиламан, Ахмад Моронай нар леменчүүдтэй нутгийн өөр өөр хэсгүүдэд тулалджээ. Хиламан их цэргийнхээ леменчүүдтэй хийсэн дайныг дүрсэлж, 2060 залуу дайчдынхаа агуу итгэлд сэтгэл хангалуун бөгөөд бат итгэлтэй байгаагаа илэрхийлсэн захидлыг Моронайд илгээжээ. Их Эзэн эдгээр дайчдын итгэл, зоригийнх нь улмаас тэдэнд тулаануудад ялахад нь тусалж, зовж зүдрэх үед нь бат бөх итгэл болоод найдвараар адисалж байв.

Алма 53; 56

Антипус, Хиламан нарын их цэрэг леменчүүдийн хамгийн хүчтэй их цэргийг ялав

Ахмад Моронай леменчүүдтэй нутгийн нэг хэсэгт тулалдаж байх үед Хиламан их цэргээ нутгийн өөр хэсэг рүү удирддаг. Түүний их цэрэгт Аммоны хүмүүсийн 2000 залуу хөвгүүд багтаж байв. Эдгээр залуу эрсийн эцэг эх нь дайснуудынхаа эсрэг зэр зэвсгээ дахин хэзээ ч агсахгүй гэсэн гэрээнд орсон ч хөвгүүд нь энэхүү гэрээнд ороогүй учраас тэд нифайчуудын их цэрэгт туслах боломжтой байв (Алма 53:10–18-ыг үзнэ үү).

 **1.** Дараах жишиг зургийг судар судлах тэмдэглэлдээ зур. Алма 53:18–21-ийг уншиж, тэдгээр 2000 залуу эрс цэргийн албанд явахаасаа өмнө ямар зан чанаруудыг хөгжүүлснийг дүрсэлсэн хэллэгүүдийг ол. Олсон хэллэгүүдээ “Тулалдаанаас өмнө хөгжүүлсэн зан чанарууд” гэсэн гарчгийн доор жагсаан бич. Та эдгээр хэллэгүүдийг судартаа тэмдэглэх хэрэгтэй.

Нифайчуудын цэргийн удирдагч Антипус болон түүний их цэрэг нутгийн өөрсдийн хэсгийг хамгаалах үед леменчүүд тэднийг тоогоор үлэмж их давамгайлж байв. Хиламаныг түүнд туслахаар 2000 залуу дайчдаа авчрахад Антипус ихэд баярлажээ (Алма 56:9–10-ыг үзнэ үү).

Тэд дайсны эсрэг эхний тулаандаа 2000 залуу дайчид леменчүүдийн хамгийн хүчтэй их цэргийг холдуулан чиглүүлэхэд нифайчуудын цэргийн захирагч Антипус их цэрэгтээ леменчүүдийн цэргийн араас нэхэн хөөхийг тушаасан байна. Антипусын их цэрэг леменчүүдийн их цэргийг гүйцэж, тэднийг зогсоон дайтав. Үргэлжлүүлэн урагшилж байсан залуу дайчид леменчүүд тэдний араас хөөхөө зогссон байгааг мэддэг. Леменчүүд тэднийг буцах үед нь дайрч устгахаар заль мэх хэрэглэн зогссон уу эсвэл Антипусын их цэрэг тэдний араас дайрсан учраас леменчүүд зогссон уу гэдгийг тэд мэдэхгүй байв. Тиймээс Хиламан леменчүүд рүү дайрахаар эргэх ёстой эсэхээ мэдэхгүй байв. (Алма 56:29–43-ыг үзнэ үү.)

Алма 56:43–48-ыг уншиж, тулалдааны нэн чухал үед эдгээр залуу эрсийн харуулсан чанаруудыг дүрсэлсэн хэллэгүүдийг ол. Олж мэдсэн зүйлсээ судар судлах тэмдэглэлдээ “Тулалдааны үеэр харуулсан зан чанарууд” гэсэн гарчгийн доор жагсаан бич. Та мөн эдгээр хэллэгүүдийг судартаа тэмдэглэж болно.

2000 залуу дайчдыг леменчүүдтэй тулалдахаар эргэх үед юу тохиолдсоныг мэдэхийн тулд Алма 56:49, 54–56-г судал. Дараах үнэнийг харуулсан хэллэгүүдийг ол: **Бид итгэлээрээ үйлдсэн үед Бурханаас хүч чадлыг хүлээн авч чадна.**

 **2.** Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

- Эдгээр залуу дайчдын зан чанаруудыг өөртөө хөгжүүлэх нь таныг сорилтын нөхцөл байдалтай тулгарах үед танд хэрхэн тусалж чадах вэ?
- Та (эсвэл таны мэддэг хэн нэгэн) итгэлээрээ үйлдэн, хүнд нөхцөл байдлыг амжилттай шийдвэрлэх хүч чадлыг Бурханаас хүлээн авсан үеийнхээ тухай дүрсэл.

Алма 57

Хиламаны их цэрэг Антипара, Кууманай хотуудыг буцаан авсан нь

Хиламан болон түүний их цэрэг Антипара болон Кууманай хотуудыг леменчүүдээс буцааж авах боломжтой байв. Энэ үед Хиламан их цэрэгтээ нэмэлт хүч хүлээн авчээ. Зарахемла нутгаас ирсэн мянга мянган дайчид болон Аммоны хүмүүсийн 60 хөвгүүн түүний их цэрэгт нэгдэв (Алма 57:1–12-ыг үзнэ үү).

Хиламаны их цэрэг Кууманай хотыг буцаан авсны яг дараахан Леменчүүд тэдний эсрэг дахин дайрав. Хиламаны их цэрэг асар их зовж байх үед 2060 залуу дайчин бүх их цэргийнхээ агуу хүч чадал болж байв. Энэхүү тулаанд залуу дайчдын харуулсан зан



чанаруудыг мэдэхийн тулд Алма 57:19–21-ийг унш. Эдгээр зан чанаруудыг судартаа тодруулж, судар судлах тэмдэглэлдээ “Тулалдааны үеэр харуулсан зан чанарууд” гэсэн гарчгийн доор жагсаан бич.



3. Залуу дайчдын гол зан чанаруудын нэг нь тэд “яг таг” дуулгавартай байсан явдал юм (Алма 57:21). Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

а. Зарлигийг “яг таг” дуулгавартай дагана гэдэг нь юу гэсэн утгатай гэж та бодож байна вэ?

б. Захирагчийнхаа үгийг яг таг дагасан нь залуу дайчдыг тулалдаанд ялахад хэрхэн тусалсан гэж та бодож байна вэ?

в. Их Эзэний зарлигуудыг яг таг дагах нь таны амьдрал дахь сүнслэг байдлын дайнд танд хэрхэн туслах вэ?

Дараах зарчмыг судартаа эсвэл судар судлах тэмдэглэлдээ бич: **Бид Их Эзэнийг яг таг дуулгавартай дагах үед Тэр биднийг амьдрал дахь тулаануудад хүчирхэгжүүлэх болно.** Бурханы зарлигуудыг “яг таг” дуулгавартай дагах нь яагаад чухал болохыг тайлбарласан Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Рассэлл М.Нэлсонгийн дараах үгсийг унш:

“Зөвхөн сонгосон зарлигуудаа л дуулгавартай дагаж, бусад зарлигуудыг үл тоомсорлохыг сонгодог хүмүүстэй та тааралдах болно. Би үүнийг зоогийн газарт хоол сонгохтой адилаар дуулгавартай байдалд



хандаж байгаа хэрэг гэж боддог. Зарлигуудыг сонгон сахих нь явуургүй бөгөөд зөвхөн зовлон руу хөтөлнө. Хүн Бурхантай уулзахаар бэлтгэхийн тулд Түүний бүх зарлигуудыг сахих ёстой. Зарлигуудыг дуулгавартай дагахад итгэл шаарддаг бөгөөд Түүний зарлигуудыг дагах нь итгэлийг бэхжүүлдэг.

“Дуулгавартай байдал нь Бурханы адислалууд саад тотгоргүйгээр ирэх боломжийг олгодог. Тэрбээр дуулгавартай хүүхдүүдээ боолчлол, гай зовлонгоос ангид байх эрх чөлөөгөөр мөн илүү их гэрлээр адислах болно.

“... Бурханы зарлигуудад дуулгавартай байх нь бие махбодын болон сүнсний хамгаалалтаар хангадаг” (“Ирээдүйг итгэлээр угт,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2011 оны 5-р сар, 34–37).

Алма 57:25–27-г уншиж, Их Эзэн яагаад тэдгээр залуу дайчдыг хамгаалахын тулд хүчээ илгээсэн талаарх зарим шалтгаануудыг олж мэд. Эдгээр шүлгүүд дэх залуу дайчдын ямар зүйлс танд хамгийн гүнзгий сэтгэгдэл төрүүлж байна вэ?

Бурхан биднийг зөв шударга байх үед ч хэцүү зүйлсээс үргэлж хамгаалдаггүй. Эдгээр залуу дайчид үхлээс хамгаалагдсан ч бүгд шархдаж (Алма 57:25-ыг үзнэ үү), зөв шударга бусад олон нифайчууд алагдсан юм (Алма 57:26-г үзнэ үү). Хэдий тийм ч Бурхан биднийг хэцүү цаг үеүдэд үргэлж хүчирхэгжүүлж, биднийг хэрэгтэй зүйлсээр адислах болно. Эцэст нь Тэрээр зарлигуудыг нь дагадаг бүх хүмүүст мөнхийн адислалуудаа өгөх болно.

Алма 58

Нифайчуудын их цэрэг хангамж, нэмэлт хүч хүлээн авсныхаа дараа Мантай хотыг буцаан эзэлдэг.

Хиламаны их цэрэг леменчүүдтэй тулалдахын хажуугаар бас өөр нэгэн бэрхшээлтэй тулгарчээ. Тэдний тулалдаанууд нифайчуудын төв засгийн газар байрлаж байсан Зарахемлагаас хэсэг зайтай газар болж байжээ. Хиламаны их цэрэг хэд хэдэн хүнд тулалдаанд ялсан ч тэдэнд хэрэгтэй байсан хоол хүнс, хангамж, нэмэлт хүчийг засгийн газраас хүлээн аваагүй юм. Засгийн газар нь яагаад тэднийг дэмжихгүй байсныг тэд мэдэхгүй байв. (Алма 58:7–9-ийг үзнэ үү.)



4. Алма 58:10–12-ыг уншиж, дараах асуултуудад хариул:

а. Нифайчууд ийм хүнд нөхцөл байдалтай тулгарсан үедээ юу хийсэн бэ?


б. Их Эзэн тэдний чин сэтгэлийн гуйлтууд болон залбирлуудад хэрхэн хариулсан бэ?

в. Алма 58:12-т цэдэглэсэнээр Хиламан болон түүний их цэрэгт Их Эзэний амлалт хэрхэн нөлөөлсөн бэ?

Дараах зарчмыг судартаа эсвэл судар судлах тэмдэглэлдээ бич: **Хэрэв бид хүнд хэцүү үедээ Бурханд хандах юм бол бидний итгэлийг хүчирхэгжүүлж, бидэнд найдвар өгч чадах тэнгэрлэг амлалтыг бид хүлээн авч чадна.**

Хиламан болон түүний их цэргийн сул дорой байдалаас үл хамааран тэд Мантай хотыг буцааж авах боломжтой байв (Алма 58:13–41-ийг үзнэ үү). Хиламан их цэргийнх нь бүх амжилт Их Эзэний тусламж байсан гэдгийг онцолдог (Алма 58:37-г үзнэ үү).

Хиламан залуу дайчдынхаа амжилтуудыг бахадсаар байв. Алма 58:39–40-ийг судалж, хүнд нөхцөл байдалд залуу дайчид хэрхэн зоригтой байсныг харуулсан үг хэллэгүүдийг ол. Судартаа эдгээр үг хэллэгүүдийг тэмдэглэж болно.

 **5.** Судар судлах тэмдэглэлдээ хүнд үед тусламж хүсэн Бурханд хандаж, Түүний дэмжлэгийг мэдэрсэн үеийнхээ тухай бич.

 **6.** Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Алма 53; 56–58-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

21-Р ХЭСЭГ: 4 ДЭХ ӨДӨР

Алма 59–63

Оршил


Хиламан ахмад Моронайд их цэргийнхээ хүч чармайлтын талаар захидал бичин, нифайчуудын засгийн газраас тусламж хүсчээ. Ахмад Моронай Хиламаны амжилтын талаар мэдээд баярласан ч засгийн газрыг нэмэлт хүч явуулахад хайхрамжгүй хандсаны улмаас уурладаг. Ахмад Моронай ерөнхий шүүгч Пахоранд түүнийг зэмлэсэн захидал илгээв. Пахоран засгийн газрын эсрэг гарсан бослогын тухай хариу захидалдаа өгүүлжээ. Моронай түүнд туслахаар очиж, босогчдыг дарав. Тэгснээр нифайчуудын их цэрэг нэгдмэл хүчээр леменчүүдийг ялах боломжтой болов. 14 жил үргэлжилсэн дайны дараа нифайчуудын нутагт амар амгалан дахин тогтож, Хиламан болон түүний ах дүүс Сүмийг төлөвшүүлэхэд анхаарлаа төвлөрүүлэв.

Алма 59

Нифайчууд бэхлэлтээ алдаж, ахмад Моронай хүмүүсийн ёс бусын улмаас гашуудан харамссан нь

Ахмад Моронай Хиламанаас их цэргийнхээ амжилтын талаар өгүүлсэн захидал хүлээн авч, Моронай болон түүний хүмүүс баярлажээ. Тэгээд Моронай нифайчуудын удирдагч Пахоранаас Хиламанд нэмэлт хүч, хүнс илгээхийг хүссэн захидал илгээжээ. Гэвч ямар ч нэмэлт хүч илгээсэнгүй. Тиймээс леменчүүд Нифайха хот руу дайрах үед Нифайхагийн хүмүүс зугтаж, леменчүүд хотыг эзэлдэг.

Леменчүүдийн ялалтад Моронайн үзүүлсэн хариу үйлдлийг мэдэхийн тулд Алма 59:9–12-ыг унш. Судрынхаа Алма 59:9 дэх дараах хэллэгийг тэмдэглэ: “Леменчүүдээс үүнийг дахин авах гэснээс уг хотыг тэдний гарт орохоос хамгаалах нь илүү амархан.” Бид дараах хэллэгээс энэ зарчмыг сурч болно: **Итгэлтэй хэвээр үлдэх нь алдагдсаныхаа дараа дахин итгэлтэй болохоос илүү амархан бөгөөд илүү дээр юм.**

 **1.** Алма 59:9-д тэмдэглэсэн хэллэг болон өмнөх догол мөрөнд тодруулсан зарчмыг судал. Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

а. Донтолтоо даван туулахаас хор хөнөөлтэй донтуулагч зүйлсээс зайлсхийх нь яагаад илүү амархан байдаг вэ?

б. Гэрчлэлээ алдсаныхаа дараа эргэн олж авахаас гэрчлэлээ хэвээр хадгалах нь яагаад илүү амархан байдаг вэ?

в. Идэвхгүй болсныхоо дараа сүмд буцан ирэхээс сүмд идэвхтэй хэвээр байх нь яагаад илүү амархан бэ?

Алма 60–62

Моронай Пахоранаас засгийн газрын хайхрамжгүй байдлын шалтгааны талаар асуув

Нифайха хот леменчүүдийн гарт орсны дараа ахмад Моронай Зарахемлагийн ерөнхий шүүгч Пахоранд хандан захидал бичжээ. Алма 60:17–24-ийг уншиж,



Пахоран болон Зарахемла дахь хүмүүсийн тухай Моронайн хэлсэн зэмлэлийг ол.

Алма 60:23-ыг дахин уншиж, эхлээд “дотоод хэсэг нь” цэвэршигдэж гэж хэлсэн ахмад Моронайн эшлэлийг анхаар. Тэр нифайчуудын засгийн газар болон төр засгийн эрх баригчдын дундах ялзралыг устгах хэрэгтэй гэж ярьж байв. Хэдий тийм ч энэ шүлэг бидний амьдралтай холбоотой байж болно. Нэг аяган дотор шороо эсвэл шавар хийлээ гэж төсөөлөн бод. Хэрэв та энэ аяганыхаа зөвхөн гадна талыг цэвэрлэсэн бол энэ аягаараа уухад таатай байх уу?



2. Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

а. Хэрэв бид өөрсдийгөө “савнууд” гэж бодвол савны дотор талыг цэвэрлэх нь юу гэсэн утгатай гэж та боддог вэ?

б. Савныхаа дотор талыг цэвэрлэх нь яагаад бидэнд Их Эзэний хаант улсын илүү агуу үйлчлэгчид байхад туслах вэ?

Алма 60:33–36-д цэдэглэснээр, ахмад Моронай Пахоранд хандан өөрийн ба Хиламаны их цэрэгт яаралтай нэмэлт хүн хүч болон хүнс илгээ гэжээ. Хэрэв Пахоран эдгээр зүйлүүдийг хийхгүй бол Моронай их цэргээ Зарахемлагийн зүг удирдаж, Пахоранаар эдгээр зүйлсийг хүчээр хийлгэх болно гэдгийг анхааруулсан байна. Пахоран Моронайн захидлыг хүлээж аваад түүнд яаралтай хариу бичив. Зарахемлад юу болж байсныг мэдэхийн тулд Алма 61:1–5-ыг унш.

Алма 61:9–14-ийг уншиж, Пахоран Моронайн зэмлэлд хэрхэн хандсаныг эргэцүүлэн бод. Пахораны агуу зан чанарыг харуулсан хэсгүүдийг тодруулан тэмдэглэж болно. Пахоран гомдохын оронд Моронайг дайсны эсрэг тулалдахад өөртэйгөө Их Эзэний хүчээр нэгдэхийг урив. Моронай Пахораны хариуг хүлээн аваад юу мэдэрснийг мэдэхийн тулд Алма 62:1-ийг унш.

Дараах үнэнүүдийг судар судлах тэмдэглэлдээ бичиж болно: **Бид бусдын үг, үйлдэлд гомдохгүй байж чадна. Бид бусад хүмүүстэй зөв шударга байдалд нэгдсэнээрээ нүгэл хилэнцийн эсрэг тулаанд илүү хүчтэй байдаг.**

Арванхоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Дэвид А.Бэднар заасан нь:



“Та бид Есүс Христийн Цагаатгалын хүч чадал өгөгч хүчээр дамжуулан гомдохоос зайлсхийж, гомдлыг даван туулахаар адислагдаж чадна. Таны хуулийг хайрлагчид агуу амар амгалан байдаг бөгөөд Тэднийг бүдрүүлэх зүйл ч байдаггүй” (Дуулал 119:165). . . .

“ . . . Моронай . . . Пахоранд бичихдээ түүнийг ‘зэмлэж’ (Алма 60:2) мөн түүнийг бодлогогүй, залхуу хойрго, хайхрамжгүй байна хэмээн хатуухан буруутгажээ. Пахоран Моронай болон түүний захиаг амархан эсэргүүцэж болох байсан ч зөрчил гомдлыг сонгосонгүй. . . .

“Бидний хувьд хүний сүнслэг байдлын төлөвшилтийн хамгийн агуу үзүүлэлтүүдийн нэг нь бид бусдын сул дорой, туршлагагүй байдал болон бусдын түрэмгий үйлдлүүдэд хэрхэн ханддагаар илэрдэг. Ямар нэгэн зүйл, үйл явдал эсвэл хэн нэгний илэрхийлэл биднийг гомдоохоор байж болох ч та бид бусдад гомдохгүй байж—мөн Пахоран шиг ‘энэ нь хамаагүй’ [Алма 61:9] гэж хэлж чадна” (“Тэднийг хэн ч гомдохгүй,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2006 оны 11-р сар, 90–91).



3. Бусдын үг, үйлдэлд гомдохгүй байхыг сонгосон тохиолдлынхоо талаар бод. Бусдад гомдохгүй байхын ач холбогдлын талаар богинохон тэмдэглэл бич.

Алма 62-т цэдэглэснээр, хааныг өргөмжилж, леменчүүдтэй холбоотон болохыг хүсч байсан Нифайн тэрслэгчид буюу хааныг хүсэгч хүмүүсийг ялахад нь Пахоранд туслахын тулд ахмад Моронай их цэргээ Зарахемлад авчрав. Хааныг хүсэгч хүмүүс Моронай, Хиламан нарт цэрэг эрс, хангамжийн бусад зүйлсийг явуулахад нь Пахоранд саад учруулж байжээ. Дараа нь Моронай, Пахоран нар цэргүүдээ нэгтгэж, леменчүүдийг уг нутгаас хөөн гаргахын тулд нифайчуудын бусад армиас тусламж авчээ. Тухайн үед леменчүүдээс олон нь наманчилж, Аммоны хүмүүстэй нэгдэв.

Тийм дайны дараа гэр бүлүүд болон хувь хүмүүст тулгарсан байж болох бэрхшээлүүдийг төсөөлөн бод. Дайны бэрхшээлүүд нь нифайчуудад хэрхэн нөлөөлснийг мэдэхийн тулд Алма 62:39–41-ийг унш. Уншихдаа эдгээр шүлгүүдээс харж чадах үнэнүүдээ ол.

Судрынхаа Алма 62:39–41-р шүлгүүдийн хажууд эсвэл судар судлах тэмдэглэлдээ дараах үнэний зарчим эсвэл үнэнийг бич: **Бид зовлон бэрхшээлийнхээ үед Их Эзэнд илүү ойртож чаддаг.**



4. Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

а. Зарим хүмүүс бэрхшээлтэй тулгарсан үедээ Их Эзэнээс нүүр буруулж байхад, яагаад зарим нь Түүнд илүү ойртдог гэж та боддог вэ?

б. Дайны талаарх бүлгүүд нь танд хэцүү эсвэл бэрхшээлтэй үед Есүс Христийн дагалдагч байх талаар юу заасан бэ?

Алма 63

Олон нифайчууд умард нутаг руу явав

Хиламаныг нас барсны дараа (Алма 62:52-ыг үзнэ үү), түүний дүү Шиблон ариун цэдгүүдийг хариуцаж авчээ. Шиблон ямар хүн байсныг мэдэхийн тулд Алма 63:1–2-ыг унш. Алма 63-т цэдэглэснээр Моронай, Шиблон нар нас барж, Моронайн хүү Моронайха нифайчуудын их цэргийн удирдлагыг авав.

Алма 63:10–13-ыг унш. Шиблон нас барахынхаа өмнө Хиламаны хүү Хиламанд ариун цэдгүүдийг хариуцуулан өгөв. Хиламан урьд нь бичигдсэн цэдгүүдийг хадгалж мөн Хиламаны ном болсон цэдгүүдээ үргэлжлүүлэн бичиж эхлэв.

Алма 63:5–8-д олон нифайчууд умард (хойд) нутаг руу завиар явснаас хойш тэдний талаар дахин сонсогдсонгүй хэмээн цэдэглэжээ. Мөн Алма 63-р бүлгийн төгсгөлд леменчүүд болон нифайчуудын хооронд дахин зөрчилдөөн гарч эхэлснээр энэхүү урт бөгөөд сүнслэг нөлөөлөл бүхий Алмагийн ном дуусдаг.



5. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Алма 59–63-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

Хиламаны номын ОРШИЛ

Яагаад энэ номыг судлах хэрэгтэй вэ?

Та нар Хиламаны номыг судлах явцдаа Хиламан, Нифай, Лихай, лемен үндэстэн Самуел гэх мэт Их Эзэнийг зоригтойгоор дуулгавартай дагаж, Есүс Христийг гэрчилсэн агуу эрчүүдийн үлгэр дуурайл, сургаалуудыг сурч мэдэх болно. Эдгээр хүмүүсийн үйлчлэл нь Бурхан үйлчлэгчдэдээ Өөрийнх нь хүслийг биелүүлэхэд туслах хүчийг өгдөг бөгөөд зөв шударга хүмүүсийн хичээл зүтгэл мянга мянган хүмүүст адислал авчирдгийг харуулдаг билээ. Мөн та нар бардамнал, ёс бус явдал болон нууц хуйвалдааны хор уршгийн талаар сурах болно.

Энэ номыг хэн бичсэн бэ?

Мормон Нифайн их ялтсуудын цэдгүүдийг эмхэтгэн хураангуйлж Хиламаны номыг бүтээжээ. Энэхүү ном нь Хиламаны хүү бөгөөд залуу Алмагийн ач хүү Хиламаны нэрээр нэрлэгдсэн юм. Хиламан өөрийн авга ах Шиблоноос цэдгүүдийг хүлээн авсан бөгөөд нифайчуудын зөв шударга ерөнхий шүүгчээр үйлчилж байлаа. Тэр өөрийн хөвгүүд Нифай, Лихай нарт өөрсдийн Гэтэлгэгч, Есүс Христийг санадаг байхыг заажээ (Хиламан 5:9–14-ийг үзнэ үү). Эдгээр сургаалууд хожим нь нифайчууд болон леменчүүдэд наманчлалыг номлохын тулд ерөнхий шүүгчийн албан тушаалаа орхиход Нифайд сүнслэгээр нөлөөлсөн юм. Мянга мянган леменчүүд хөрвөгдсөний дараа Самуел хэмээх лемен үндэстэн бошиглогч нифайчуудын дунд наманчлал болон бошиглолыг номлохоор сүнсээр өдөөгдсөн бөгөөд энэ нь Нифайн номлолтой нэгэн цаг үед байв. Хиламаны ном нь Хиламан (Хиламан 1–3) болон Нифайн (Хиламан 4–16) засаглал ба үйлчлэлийн үед бичигдэж, хадгалагдан үлдсэн цэдгүүдээс бүрддэг. Нифайн цэдгүүдэд лемен үндэстэн Самуелын бошиглол болон сургаалууд агуулагддаг.

Энэ ном хэзээ, хаана бичигдсэн бэ?

Хиламаны номыг бичихэд ашигласан эх цэдгүүдийг мээ 52-оос мээ 1 оны хооронд бичсэн байх магадлалтай бөгөөд Мормон эдгээр цэдгүүдийг мээ 345-аас мээ 385 оны хооронд хураангуйлжээ. Мормон энэ номыг эмхэтгэхдээ хаана байснаа цэдэглээгүй.

22-Р ХЭСЭГ: 1 ДЭХ ӨДӨР

Хиламан 1–2

Оршил

Ерөнхий шүүгч Пахоран нас барсны дараа түүний хөвгүүд Пахоран, Пейнкай, Пекүменай нарын хэн нь шинэ ерөнхий шүүгч болох ёстой талаар нифайчуудын дунд ноцтой зөрчилдөөн бий болжээ. Хүмүүс Пахораныг шинэ ерөнхий шүүгчээр сонгов. Пейнкайн дагалдагчдын нэг Кишкумен гэгч эр нууц бүлэглэлийн гишүүн байсан бөгөөд Пахораныг хөнөөснөөр Пекүменай ерөнхий шүүгчээр томилогдов. Энэхүү зөрчилдөөн, хагарал бутралыг ашиглан леменчүүд нифайчуудын нийслэл хот Зарахемлаг булаан эзэлж, Пекүменайг хөнөөсөн юм. Нифайчуудын жанжин Моронайха Зарахемла хотыг эзэмшилдээ буцаан авч, Хиламан ерөнхий шүүгчээр томилогдов. Кишкумен Хиламаныг устгахаар завдахдаа алагдаж, Гадиантон нууц бүлэглэлийн удирдагч болов.

Хиламан 1

Хэн ерөнхий шүүгч болбол зохих талаарх зөрчилдөөн нь леменчүүдэд, нифайчуудын нийслэл хот Зарахемлаг булаан эзлэх боломжийг олгожээ.

Хамгийн сүүлд хэн нэгэнтэй өөрөө маргаснаа эсвэл бусад хүмүүс маргалдаж байсныг харснаа бод. Ийм зөрчилдөөнөөс болж ямар асуудлууд үүсдэг вэ? Хиламан 1-р бүлгийг судлахдаа тэрхүү зөрчилдөөн нифайчуудад ямар асуудлуудыг бий болгосныг олж, тэдний туршлагаас та юу сурч болохоо тунгаан бод.

Дараах судрын хэсгүүдийг уншаад өгөгдсөн зайд асуултуудын хариуг бич.

- Хиламан 1:1–4. Нифайн хүмүүсийн дунд юуны улмаас зөрчилдөөн, хагарал бутрал үүссэн бэ? _____
- Хиламан 1:5–8. Хэн ерөнхий шүүгчээр томилогдсон бэ? Шинэ ерөнхий шүүгчийн хоёр дүү нь ямар хариу үйлдэл хийв? _____
- Хиламан 1:9–12. Кишкумен юу хийсэн бэ? Кишкумен нууц бүлэглэлтэйгээ ямар гэрээ байгуулсан бэ? _____

Нифайчуудын дундах энэхүү зөрчилдөөний үед Кориантумр гэгч эр Зарахемла хотын эсрэг тулаанд леменчүүдийг удирдав. Хиламан 1:18–22-ыг уншаад

нифайчуудын зөрчилдөөний улмаас леменчүүд юу хийх боломжтой болсныг олж мэд.

Энэ шастираас бидний сурч болох үнэнүүдийн нэг бол: **Зөрчилдөөн нь хагарал бутралд хүргэдэг бөгөөд биднийг дайсны эрхшээлд ороход хялбар болгодог гэсэн зарчим юм.** Та энэ зарчмыг судартаа Хиламан 1:18-ын хажууд бич.



1. Энэ зарчмыг илүү сайн ойлгохын тулд судар судлах тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич.

а. Нэг залуу эмэгтэй найзуудынхаа талаар эцэг эхтэйгээ маргалддаг байв. Энэхүү зөрчилдөөн нь амьдралынхаа бусад зүйлсэд эцэг эхийнхээ зөвлөгөөг сонсох түүний хандлагад хэрхэн нөлөөлж болох вэ?

б. Нэг залуу эрэгтэй санваарын чуулгынхаа нэг гишүүнд уур нь хүрдэг байжээ. Энэхүү зөрчилдөөн сүм дээрх түүний үйлдлүүдэд хэрхэн нөлөөлж болох вэ?

в. Та болон бусад хүмүүсийн хооронд зөрчилдөөн байгаа гэж бодож буй амьдралын аль нэг зүйлийн тухай бод. Амьдралаасаа энэхүү зөрчилдөөнийг арилгахын тулд таны хийж болох тодорхой зүйл юу вэ? Та түүнийгээ хэрхэн хэрэгжүүлж чадах вэ?

Хиламан 1:22–30-д леменчүүд Зарахемлаг булаан эзэлсэн даруйдаа Өгөөмөр хотыг эзлэхээр хөдөлсөн тухай гардаг. Нифайн их цэрэг леменчүүдийг бүслэн авч, бут цохив. Олон леменчүүд алагдсан бөгөөд бууж өгсөн хүмүүст нутагтаа буцах боломжийг олгожээ.

Хиламан 2

Хиламан ерөнхий шүүгч болж, нууц бүлэглэл түүнийг хөнөөх гэсэн халдлагаас зарц нь хамгаалав

Хиламан 2-р бүлгийг судлахаасаа өмнө, итгэлтэй залуу эмэгтэй эсвэл залуу эрэгтэй алдаагаа эсвэл гэм нүглээ засахын тулд хэр зэрэг хүч чармайлт гаргах ёстойг бод. Залуу эмэгтэй эсвэл залуу эрэгтэй алдаагаа нуухыг оролдох хэрэгтэй юу эсвэл Их Эзэн болон гомдоосон хүмүүсээс уучлал гуйх ёстой юу?

Кишкумен Пахораныг хөнөөсний дараа нууц бүлэглэлийн гишүүдтэйгээ тэрхүү хүн амины хэргийн эзнийг хэнд ч, хэзээ ч хэлэхгүй гэж бие биедээ амлажээ. Хиламан 2:3–4-ийг уншаад “түүний ёс бусыг хэн ч мэдэхгүй хэмээх гэрээнд орсон” гэсэн хэсэгт анхаарлаа хандуул. Дараа нь Сургаал ба Гэрээ 58:43-ыг уншаад Их Эзэн биднийг ямар нэгэн буруу зүйл үйлдсэн үед юу хийгээсэй гэж хүсдэгийг олж мэд.



2. Хиламан 2:3–4 ба Сургаал ба Гэрээ 58:43-р шүлгүүдээс судалсан зүйл дээрээ тулгуурлан, Их Эзэн биднийг нүгэл үйлдвэл юу хийгээсэй гэж хүсдэг болон Кишкумен ба түүний бүлэглэлийнхний хийсэн үйлдэл хоёрын ялгааг судар судлах тэмдэглэлдээ бич.

Хиламан Пахораны дүү Пекүменайн үхлийн дараа шинэ ерөнхий шүүгч болоход Кишкумен болон түүний нууц бүлэглэл Хиламаныг ч мөн хөнөөхөөр шийджээ. Энэ үед Гадантон гэгч эр нууц бүлэглэлийн удирдагч болов. Хиламан 2:2–9-ийг уншаад Кишкумен хэрхэн алагдсаныг доорх зайд бич. _____

Хиламан 2:10–14-ийг уншаад Гадантоны дээрэмчдийн бүлэглэлд юу тохиолдсоныг олж мэд. Гадантоны дээрэмчдийн адил нууц бүлэглэлүүд нь “нууц хуйвалдаанууд” гэгддэг бөгөөд (жишээ болгон Хиламан 3:23-ыг үзнэ үү) эдгээр нь Нифайн хүмүүсийг сүйрэлд хүргэх болно гэдгийг Мормон анхааруулжээ. Өмнө гарсан Мормоны Номын бошиглогчид мөн нууц хуйвалдаанд оролцох ёсгүйг анхааруулсан байна (2 Нифай 26:22; Алма 1:12-ыг үзнэ үү). Мормоны Ном: Нууц хуйвалдаан нийгмийг сүйрэлд хүргэдэг хэмээн заасан байдаг.

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч М.Рассэлл Баллард өнөөгийн нууц хуйвалдааны аюулын талаар анхааруулжээ. Та түүний анхааруулгыг уншихдаа нууц хуйвалдааны эсрэг хийж чадах зүйлээ тэмдэглэ.



“Гэмт хэрэг үйлддэг нууц хуйвалдаан нь хувь хүмүүс болон гэр бүлүүдэд төдийгүй соёл иргэншилд бүхэлд нь ноцтой аюул учруулдгийг Мормоны Номд заасан байдаг. Өнөө үеийн нууц хуйвалдаануудад бүлэглэсэн гэмт этгээдүүд мансууруулах бодисын наймаа эрхлэгчид, зохион байгуулалттай гэмт хэргийн гэр бүлүүд орно. Өнөө үеийн нууц хуйвалдаанууд нь Мормоны Ном дахь Гадантоны дээрэмчидтэй нэн төстэй байдлаар ажилладаг. . . . Тэдний зорилго бол ‘улс орныхоо болон Бурханыхаа хуулиудын эсрэг тэд алж, тонон дээрэмдэж, хулгайлж, садар самуун болон бүхий л ёс бусыг үйлдэх’ [Хиламан 6:23] явдал мөн.

“Хэрэв бид анхааралтай байхгүй бол өнөө үеийн нууц хуйвалдаанууд хүчээ авч, нөлөө нь Мормоны Номын үеийнх шиг түргэн өсөх болно. . . .

“Мормоны Ном, чөтгөр бол ‘бүх нүглийг зохиогч’ бөгөөд эдгээр нууц хуйвалдаануудыг үндэслэгч мөн гэдгийг заадаг [Хиламан 6:30]. . . . Түүний зорилго нь хувь хүмүүс, гэр бүлүүд, нийгмийн бүлгүүд болон улс орнуудыг сүйрүүлэх явдал юм [2 Нифай 9:9-ийг үзнэ үү]. Чөтгөр Мормоны Номын үед тодорхой хэмжээгээр амжилтад хүрсэн. Мөн тэр өнөө цагт ихээхэн амжилт олж байна. Тиймээс бид . . . нийгмийн бүлгүүдийг аюулгүй байлгахад чадах бүхнээ хийж, үнэн ба зөв зүйлийн төлөө бат зогсох нь маш чухал юм.

“. . . [Бид] үлгэр дуурайл болж, сүмийн жишгүүдийг сахиж, эргэн тойрныхоо хүмүүстэй гэрчлэлээ

хуваалцсанаар ‘Бурханы гэрчүүд болон зогсож’ чадна [Мозая 18:9-ийг үз]” (“Standing for Truth and Right,” *Ensign*, 1997 оны 11-р сар, 38).

Ахлагч Баллардын заасан зүйлийг нийгэм, улс орондоо үнэн ба зөв зүйлийн төлөө зогсохдоо хэрэгжүүлэх нэг эсвэл түүнээс олон арга замыг бод.



3. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Хиламан 1–2-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

22-Р ХЭСЭГ: 2 ДАХЬ ӨДӨР

Хиламан 3–4

Оршил

Хиламаны номын эхний бүлгүүдэд дүрсэлсэн цаг үед нифайчууд амар амгалан байж, зөрчилдөөнийг даван туулсан юм. Амар амгалан үед хэдэн арван мянган нифайчууд сүмд нэгдэв. Энэхүү агуу хөгжил цэцэглэлтийн дараа, бардамнагч хүмүүс тэднийг хавчиж байсан ч сүмийн даруухан олон гишүүдийн итгэл өсөн нэмэгджээ. Олон нифайчууд ёс бус болсны улмаас тэд өмнөдийн бүх нутгуудаа леменчүүдэд алджээ.

Хиламан 3

Сүм ёс бус явдал болон мөрдлөг хавчлагын дунд хөгжин цэцэглэж байхад олон нифайчууд умард нутаг руу нүүв

Хиламан 3:1–2-ыг уншаад Нифайн хүмүүсийн дунд хэдэн жилийн турш “ямар ч зөрчилдөөн” байгаагүйг ажигла. Одоо Хиламан 3:3, 19-ийг уншаад нифайчуудын дунд гарсан өөрчлөлтүүдийг харуулсан үг хэллэгүүдийг ол.

Хиламан 3:4–16-д нифайчуудын дунд зөрчилдөөн үүсч, олон хүмүүс умард нутаг тийш дүрвэн нүүснийг тайлбарлажээ. Олон нифайчууд ёс бус болж, леменчүүдтэй нэгдэв.

Хиламан зөрчилдөөн, ёс бус явдлыг үл харгалзан өөрөөр амьдрахыг сонгосон юм. Хиламан нифайчуудын ерөнхий шүүгч мөн тэдний дундах бошиглогчоор үйлчилж байлаа. Хиламан 3:20-ийг уншаад Хиламаныг хэрхэн дүрсэлснийг олж мэд. (*Эрх тэгш байдал* гэдэг үг нь шударга байх, ялгаварлан

гадуурхахгүй эсвэл хэт нэг талыг барихгүй байх гэсэн утгатай юм.)

Хиламаны юу нь танд онцгой сэтгэгдэл төрүүлж байна вэ? Тэр яагаад тэрхүү зөрчилдөөн, ёс бус явдлын үед тийн хүчирхэг хэвээр байсан гэж та бодож байна? Та *үргэлж* гэсэн үгийг Хиламан 3:20-р шүлэгт тэмдэглэж аваарай.

Хиламан 3:22–26-г уншаад нифайчууд хэрхэн өөрчлөгдөн сайжирч эхэлснийг тэмдэглэ. Хэчнээн хүн сүмд нэгдсэн бэ? _____

Мормон ихэвчлэн “бид ийн үзэж болно,” “ бид тийн харлаа,” ба “бид харсан” гэсэн хэллэгүүдийг хэрэглэсэн нь тэрээр биднийг мэдээсэй гэсэн үнэнүүдийг онцлон заасан хэрэг ажээ. Хиламан 3:27–30-д эдгээр хэллэгүүд олон удаа хэрэглэгдсэн нь Мормон биднийг зарим чухал сургамжуудыг сураасай гэж хүссэнийг харуулж байна. Хиламан 3:27–30-ийг уншаад гол хэллэгүүдийг тэмдэглэж, Мормон биднийг сураасай гэж хүссэн сургамжуудыг олж мэд.



1. Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

а. Мормон таныг Хиламан 3:27–30-р шүлгүүдээс Бурханы үгийн талаар юу мэдээсэй гэж хүссэнийг бич.

б. Судруудыг судлах нь таныг ёс бус явдлаас зайлсхийж мөн Бурханы оршихуй руу хөтлөх зам дээр үлдэхэд тань хэрхэн тусалсныг бич.

Хиламан 3:32–34-ийг уншаад сүмийн зарим гишүүд хэрхэн бусад гишүүдийг хавчиж эхэлснийг ажигла. Хавчигч хүмүүс нь сүмд харьяалагддаг ч үнэн хэрэгтээ тэд бардамналаар дүүрэн бөгөөд сүмийн сургаалуудад итгэдэггүй байсан ажээ. Тэдний үйлдлүүд нь сүмийн даруухан гишүүдийг олон зовлон зүдгүүр амсахад хүргэв. Сүмдээ явж, Бурханы бошиглогчид болон зарлигуудыг дагахаар сонгосныхоо улмаас сүмийн бусад гишүүдээр хавчигдах нь хэчнээн хэцүү болохыг эргэцүүлэн бод.

Хиламан 3:35-ыг уншаад сүмийн итгэлтэй гишүүд хавчлага, зовлон зүдгүүрийн үед хэрхэн үйлдсэнийг сурч мэд.



2. Хиламан 3:35-аас сурсан зүйл дээрээ үндэслэн судар судлах тэмдэглэлдээ дараах асуултуудад хариул.


а. Зовлон зүдгүүрийн үед сүмийн даруухан гишүүдийн итгэл нэмэгдсэн үү эсвэл буурсан уу?

б. Сүмийн даруухан гишүүд итгэлээ хүчирхэгжүүлэхийн тулд юу хийсэн бэ?

в. Сүмийн эдгээр гишүүд ямар адислалуудыг хүлээн авсан бэ?

Бид Хиламан 3:33–35-ыг судалснаар хувь хүн бүр хавчлага, зовлон зүдгүүр өөрт нь хэрхэн нөлөөлөхийг өөрсдөө тодорхойлдог болохыг мэдэж болно. Эдгээр шүлгүүдээс сурсан зүйл дээрээ үндэслэн дараах өгүүлбэрийг гүйцээж бич: **Бид хавчлага, сорилтуудыг үл харгалзан** _____

-снаар Есүс Христэд итгэх итгэлээ нэмэгдүүлж чадна. (Энэ өгүүлбэрийг гүйцээж бичих олон арга бий.) Энэ өгүүлбэрээ судартаа Хиламан 3:33–35-ын хажууд бичиж болно.

 **3.** Эдгээр шүлгүүдийг илүү сайн ойлгохын тулд судар судлах тэмдэглэлдээ дараах асуултуудын хоёрт нь эсвэл бүгдэд нь хариулж бич.

а. Хавчлага эсвэл сорилтын үед залбирал болон мацаг барилт танд хэрхэн тусалсан бэ?

б. Зүрх сэтгэлээ Бурханд зориулах гэдэг нь юу гэсэн утгатай гэж та бодож байна вэ?

в. Хавчлага эсвэл сорилтын үед Есүс Христэд итгэх итгэл тань нэмэгдсэн үү?

Хиламан 3:36–37-г уншаад Хиламаныг нас барах үед ихэнх нифайчуудын сүнслэг байдлын түвшин ямар байсныг тодорхойл.


Хиламан 4

Их Эзэний Сүнс нифайчуудаас холдож, леменчүүд нифайчуудын өмнөд нутгийг тэр чигт нь эзлэв

Хиламан 4-р бүлэгт цэдэглэгдсэнээр Хиламаныг нас барсны дараа, нифайчуудын дундах бардамнал, зөрчилдөөн олон нифайчуудыг леменчүүдтэй




нэгдэхэд хүргэжээ. Леменчүүд нифайчуудын эсрэг тулалдав. Хиламан 4:4–8-ыг уншаад леменчүүд эзлэн авсан гэж бодож байгаа нутгуудаа газрын зурагт тэмдэглэ.

 **4.** Судар судлах тэмдэглэлийнхээ нэг хуудасны голд босоо шугам зурж хуудсыг хоёр хэсэг болгон хуваа. Хоёр хэсгийн нэгнийг нь дээд талд *Нифайчуудын хандлага ба үйлдлүүдийг харуулсан хэллэгүүд гэж бич.* Нөгөө талд нь *Эдгээр үйлдлүүдийн улмаас тохиолдсон зүйлсийг харуулсан хэллэгүүд гэж бич.* Тэгээд Хиламан 4:11–13, 21–26-г уншаад гарчиг бүрд хамгийн багадаа 3 өгүүлбэр бич.

Хиламан 4-р бүлгээс сурч болох чухал зарчмуудын нэг нь **бардамнал ба ёс бус явдал биднийг Их Эзэний Сүнснээс тусгаарлаж, биднийг зөвхөн өөрийн хүч чадалтай үлдээдэг гэсэн зарчим юм.** Та энэ зарчмыг судартаа Хиламан 4:23–25-ын хажууд бичих хэрэгтэй.

Нифайчуудын туршлагаас харахад зөвхөн өөрийн хүч чадалтай үлдэнэ гэдэг нь ихэвчлэн тулалдаанд ялагдаж, газар нутгаа алдана гэсэн утгатай байдаг (Хиламан 4:25–26-г үзнэ үү). Бидний хувьд өөрийн хүч чадалтай үлдэнэ гэдэг нь Сүнсстэй нөхөрлөхөө болино гэсэн үг юм.

 **5.** Амьдралдаа ямар “тулаанууд”-тай учирдаг тухайгаа бод. Тэгээд тэдгээрээс нэг эсвэл илүү олныг нь судар судлах тэмдэглэлдээ бич. Амьдралдаа Сүнсний нөхөрлөлийг хадгалахын тулд өөрийнхөө хийж чадах дор хаяж нэг зүйлийг бич. Мөн амьдралынхаа тулаанд Их Эзэний хүч чадалтайгаар оролцоход тань туслах Сүнсстэй хамт байхын ач холбогдлын талаарх сэтгэгдлээ бич.

 **6.** Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Хиламан 3–4-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

22-Р ХЭСЭГ: 3 ДАХЬ ӨДӨР

Хиламан 5

Оршил

Нифайчуудын ихэнх нь зөв шударга байдлаас илүү хилэнцэт байдлыг сонгох хүртэл тэд ёс бус явдлаа үргэлжлүүлсэн юм. Эцгийнхээ үгсээр сүнслэгээр нөлөөлөгдсөн Нифай, Лихай хоёр өөрсдийгөө сайн мэдээг номлоход зориулжээ. Эцэг Хиламан нь

тэдэнд Аврагчийн суурин дээр амьдралаа барьж босгохын ач холбогдлыг заав. Лихай, Нифай хоёр нифайчуудад заасныхаа дараа леменчүүдэд номлон, шоронд оржээ. Их Эзэн Нифай, Лихай хоёрыг гайхамшигтайгаар аварсны дараа леменчүүдийн ихэнх нь сайн мэдээнд хөрвөгдөв.

Хиламан 5:1–13

Хиламан өөрийн хөвгүүд Нифай, Лихай хоёрт Бурханы зарлигууд болон Есүс Христийн сүр хүч тэдэнд тусална гэдгийг санахыг заав

Дараах зургаан үг хэллэгийг унш. Дараах үйл ажиллагааг хийхийн тулд эдгээр үг хэллэг бүрийг санахыг хичээгээрэй. Та эдгээр үг хэллэгүүдийг судар судлах тэмдэглэлдээ цээжээр бичих болно: *гэр бүл, эцэг эх, Есүс Христийн Цагаатгал, бошиглогчид, наманчлал аврал руу хөтөлнө, зарлигуудыг сахих.*



1. Гарын авлагаа хаагаад судар судлах тэмдэглэлдээ эдгээр зургаан үг хэллэгийг цээжээр бич.

Хариултуудаа шалга. Хэллэгүүдийг санахад амархан байсан уу, хэцүү байсан уу гэдгийг нэг хором бод. Танд эдгээр үгсийг цээжээр бичнэ гэдгийг урьдчилан сануулсан нь нөлөөлсөн гэж бодож байна уу?



Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимбаллын хэлсэн дараах үгсийг уншаад яагаад санах гэдэг үг биднийг сайн мэдээний дагуу амьдрахыг хичээхэд нэн чухал болохыг эргэцүүлэн бод: “Та толь бичгээс хараад ямар үг хамгийн чухал

болохыг мэдэх үү? Тэр үг нь *санах гэдэг үг байж болох юм*. Та бүхэн гэрээнүүдийг байгуулсан учраас юу хийх ёстойгоо мөн түүнийгээ хэрхэн хийхийг мэддэг. Харин бидний хамгийн чухал хэрэгцээ бол санах явдал юм” (“Circles of Exaltation” [Сүмийн Боловсролын Системийн шашны боловсролынхонд хандаж хэлсэн үгнээс,] 1968 оны 6-р сар 28, 5).

Өнөөдөр та, аавуудынхаа заасны дагуу үнэнүүдийг санаж явсныхаа ачаар мянга мянган хүмүүсийн амьдралд өөрчлөлтийг авчирсан хоёр хүний тухай үзэх болно. Их Эзэн танаас юуг санаж явахыг хүсдэгийг өнөөдрийн хичээлийн турш тунгаан бод.

Хиламан 5:1–4-т тайлбарласнаар хүмүүс ихэд ёс бус болсон учир Нифай ерөнхий шүүгчийн албан тушаалаасаа огцорчээ. Тэр өөрийн ах Лихайн хамт бүх цаг заваа Бурханы үгийг номлоход зориулахыг хүссэн билээ. Тэд үйлчлэлээ эхлэхдээ эцэг Хиламаныхаа заасан зүйлсийг санажээ. Дараах шүлгүүдийг уншаад Хиламан хөвгүүддээ юуг санаж явах хэрэгтэй хэмээн захисныг өгөгдсөн зайд товчилж бич. Та *санагтун* гэсэн үгийг шүлэг бүрд гарахаар нь тэмдэглэх хэрэгтэй.

- Хиламан 5:5–7 _____
- Хиламан 5:9–11 _____
- Хиламан 5:12 _____



2. Уншсан зүйлээ илүү сайн ойлгохын тулд судар судлах тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич.

а. Бусдын зөв шударга үлгэр дуурайлыг санах нь “тэр зөв зүйлийг хийхийг” сонгоход тань хэрхэн тусалдаг вэ? (Хиламан 5:7).

б. Та Есүс Христийн Цагаатгалыг санахын тулд юу хийдэг вэ?

Хиламан 5:12-ыг дахин уншаад **Хэрэв бид Есүс Христ дээр сууриа тавьбал, Сатан биднийг дийлэх хүчгүй болно гэсэн зарчмыг нотолсон хэллэгүүдийг ол.** (Хиламан 5:12 бол төгс эзэмших судар юм. Та дараа нь үүнийг амархан олохын тулд тусгайлан тэмдэглэх хэрэгтэй.)



Танаас хэзээ ч нурахгүй бат бөх барилгын зураг төсөл хийхийг хүсчээ гэж бод. Дараах асуултуудын хариултыг бод.

- Тийм барилга ямархуу суурьтай байх хэрэгтэй вэ?
- Бат бөх суурь нь барилгыг цаг агаар, байгалийн гамшиг эсвэл бусад хүнд нөхцөлүүдийг тэсэн гарахад хэрхэн тусалдаг вэ?
- Хиламан 5:12-р шүлэг дэх ямар үг хэллэгүүд бидний Гэтэлгэгч, Есүс Христийн суурин дээр барих нь дайсны дайралтуудаас сэргийлэхгүй, харин уг дайралтуудыг даван туулах хүч чадлыг танд өгнө гэдгийг илэрхийлж байна вэ?



3. Дараах асуултуудын хариултыг судар судлах тэмдэглэлдээ бич.

а. Есүс Христийн хадан дээр амьдралынхаа суурийг барих гэдэг нь юу гэсэн утгатай вэ? Та үүнийг амьдралдаа хэрэгжүүлэхийн тулд хэр зэрэг хичээн чармайж байгаа вэ?

б. Есүс Христ таны амьдралын суурь болсны ачаар та хэзээ уруу таталт эсвэл сорилтыг тэсэн гарч байсан бэ?

в. Та Аврагчийг амьдралынхаа суурь болгох тал дээр хэрхэн илүү сайн байж болох вэ?

Хиламан 5:14–52

Их Эзэн Нифай, Лихай хоёрыг шоронд байхад нь хамгаалж, тэднийг олзлогсод Их Эзэнд хандан залбирч наманчлахад нь харанхуйг зайлуулав

Хиламан 5:14–19-д цэдэглэгдсэнээр Нифай, Лихай хоёр Зарахемлагийн нутагт агуу хүчээр сайн мэдээг номлож, мянга мянган хүмүүст баптисм хүртээжээ. Тэгээд тэд леменчүүдийн нутаг байсан Нифайн нутаг руу явав. Дараах үйл ажиллагаа нь леменчүүдийн дунд байхдаа Нифай, Лихай хоёрын олж авсан гайхалтай туршлагуудыг ойлгоход тань туслах зорилготой юм.



4. Судар судлах тэмдэглэлийнхээ нэг хуудсан дээр бүхэлд нь дараах хүснэгтийг зур. Дараа нь хайрцаг бүр дэх шүлгүүдийг уншаад тухайн бүлэг шүлэг юуны тухай өгүүлж байгаа харуулсан энгийн зураг зурах юмуу товч хураангуйг бич.

Нифай, Лихай хоёр леменчүүдийн дунд		
Хиламан 5:20–21	Хиламан 5:22–25	Хиламан 5:26–28
Хиламан 5:29–34	Хиламан 5:35–39	Хиламан 5:40–44

Энэ үйл явдалд харанхуйн үүл нь гэм нүглийг, хүн бүрийг хүрээлэх галан багана нь Ариун Сүнснийг тус тус төлөөлж болох юм.

28 ба 34-ийг дахин харж, хүмүүс харанхуйн үүлтэй байхад юу мэдэрснийг бич. _____

43 ба 44-ийг дахин харж, хүмүүс галан баганаар хүрээлэгдсэн үед юу мэдэрснийг бич. _____

41 ба 42-ыг дахин харж, хүмүүс харанхуйн үүлсийг сарниулахын тулд, өөрөөр хэлбэл гэм нүглээ наманчлахын тулд юу хийснийг бич. _____

Хиламан 5:45–47-г уншаад энэ үйл явдлаас наманчлалын талаар ямар үнэнүүдийг сурснаа тунгаан бод. Эндэх нэг зарчим бол: **Бид Есүс Христэд итгэх итгэлээ үйлдэл болгож, гэм нүглээ наманчилбал Ариун Сүнс бидний зүрх сэтгэлийг амар амгалан, баяр баясгалангаар дүүргэнэ** гэсэн зарчим юм.

Бид Хиламан 5:48–52-р шүлгүүдээс 300 орчим леменчүүд энэхүү гайхамшгийн хэсэг болж, сайн мэдээнд бүрэн хөрвөгдсөнийг мэдэх болно. Тэд цааш явж, “леменчүүдийн ихэнх хэсэг” хөрвөгдөх хүртлээ хүмүүст үйлчилжээ (Хиламан 5:50). Тэдгээр хөрвөгчид “дайны зэр зэвсгүүдээ орхиж” (Хиламан 5:51), “эзэмшлийнх нь нутгуудыг нифайчуудад буцаан өгөв” (Хиламан 5:52). Мормоны Номд ихэнх тохиолдолд, хүмүүс дайнаар газар нутгаа эргүүлэн авдаг бол энэ тохиолдолд дайсан нь наманчилж, сайн мэдээг хүлээн авсан учраас нифайчууд газар нутгаа эргүүлэн авсан юм.



5. Та амьдралдаа амар амгалан, баяр хөөрийг мэдрдэг эсэхээ эргэцүүлэн бод. Наманчлаагүй нүгэл, гэр бүлийн гишүүд эсвэл найзуудтайгаа зөрчилдөж маргалдах эсвэл судруудыг унших, тогтмол залбирах зэрэг зүйлсийг хийхгүй байгаа гэх мэт амьдралд тань байж мэдэх ямар нэгэн харанхуйн үүлний талаар бод. Эдгээрээс нэг эсвэл илүү олныг судар судлах тэмдэглэлдээ бич. Хиламан 5-р бүлэг дэх леменчүүдийн жишээг дагахын тулд та юу хийж болохоо тунгаан бод. Мөн таныг бүрхэх харанхуйн үүлийг сарниулан зайлуулахын тулд Аврагчийг урих талаар юу хийж болохоо бич. Наманчлал хэрхэн таны хайж байгаа шийдлийн нэг хэсэг байж болох вэ? Наманчлал таныг Есүс Христийн суурин дээр барихад хэрхэн туслах вэ?

Төгс эзэмших судар—Хиламан 5:12

Хиламан 5:12-ыг уншаад зургаар дүрсэлж болох үгсийг ол (жишээлбэл, *хад, суурь, салхи, мөндөр, шуурга*). Энэ шүлгийг цээжлэхэд өөртөө туслах зорилгоор нэг цаас аваад түүн дээрээ шүлэгт буй зургаар дүрслэх боломжгүй үгсийн эхний үсгүүдийг бич. Харин зургаар дүрслэх боломжтой үгсийн оронд тухайн үгийн утгыг илэрхийлж болох хялбар зургийг зур. Зөвхөн тэр цаасаа ашиглан шүлгээ цээжээр уншиж давт. Энэ шүлэг дэх үнэнүүдийг санахын тулд уг цаасаа байнга харагдах газарт тавь.



6. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Хиламан 5-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

Хиламан 6–9

Оршил

Нифай, Лихай хоёрын номлолын хүч чармайлтын ачаар леменчүүд зөв шударга байдлаа нэмэгдүүлжээ. Харамсалтай нь яг тэр үед нифайчууд ёс бус болж, Гадиантоны дээрэмчдийг дэмжсэн учраас Их Эзэний Сүнс тэднээс холдов. Бошиглогч Нифай, хэрэв нифайчууд ёс бус явдлаараа цаашид амьдарвал тэд мөхөх болно хэмээн бошигложээ. Үүний хариуд ёс бус байдалдаа ялзарсан шүүгчид олон хүмүүсийг Нифайн эсрэг уурлан хилэгнэхэд өдөөн турхирсан бол зарим хүмүүс бошиглогчийг зоригтойгоор өмөөрөв. Түүний үгс биелэгдэхийн баталгаа болгож, ерөнхий шүүгч дүүдээ алуулсныг Нифай илрүүлжээ. Нифайн үгс батлагдахад хүмүүсийн зарим нь түүнийг бошиглогч мөн гэдгийг хүлээн зөвшөөрөв.

Хиламан 6

Леменчүүд зөв шударга болж, Гадиантоны дээрэмчдийн эсрэг тэмцэж байхад нифайчууд нууц хуйвалдаануудыг дэмжиж байлаа.



1. Дараах зургийг судар судлах тэмдэглэлдээ зурагдаа дээд, доод талд нь бичих зай үлдээ.



Та Хиламаны номыг судлахдаа нифайчууд Их Эзэний Сүнс өөрсдийнх нь амьдралаас холдоход хүргэсэн сонголтууд хийж байсан бол леменчүүд Сүнсийг урих сонголтуудыг амьдралдаа хийснийг харсан. Хиламан 6:1–5, 16–17, 34–36-г уншаад леменчүүд Их Эзэний Сүнсийг улам нэмэгдүүлэхэд хүргэсэн юу хийснийг олоод сумны дээд талд бич. Мөн эдгээр шүлгүүдэд нифайчууд Их Эзэний Сүнсийг өөрсдөөсөө улам холдоход хүргэсэн юу хийснийг олж сумны доор бич.

Нифайчууд болон леменчүүдээс суралцах нэг чухал зарчим бол: **Бид Их Эзэний үгэнд итгэж, дуулгавартай дагаснаар Тэр Өөрийн Сүнсийг бидний дээр юүлэх болно гэсэн зарчим юм.** Энэ зарчмын эсрэг тал нь мөн үнэн юм: **Хэрэв бид Их Эзэний үгэнд итгэж, дуулгавартай байхгүй бол Түүний Сүнс биднийг орхино.**

Судар судлах тэмдэглэлдээ зурсан жишиг зурган дээрээ юу бичсэнээ хар. Дээд талд нь бичсэн үгс нь

Их Эзэний үгэнд итгэж, дуулгавартай байх жишээ бол доор бичсэн үгс нь зүрх сэтгэл нь хатуу бөгөөд Их Эзэнийг сонсох дургүй хүмүүсийн жишээ юм.



2. Дараах асуултуудад судар судлах тэмдэглэлдээ хариулж бич:

а. Амьдралдаа хийж байгаа эсвэл хийж байсан сайн үйлүүдээсээ (жишиг зургийн дээд тал дахь) нэгийг нь сонго. Энэ үйлдэл ямар байдлаар Ариун Сүнсийг амьдралд тань урьсан бэ?

б. Жишиг зургийнхаа доод хагас дахь үйлдлүүдийг хар. Та яагаад эдгээр зүйлсийг хийхээс зайлсхийхийг хүсдэг вэ?

Амьдралаа сайжруулахын тулд Их Эзэний Сүнсийг урихаар хийж болох нэг зүйлийг сонгоод ирэх долоо хоногийн турш түүнийгээ хэрэгжүүлэхийг хичээ.

Хиламан 7

Нифай ёс бус нифайчуудад номлож, тэдэнд наманчлахыг тушаав

Бошиглогч Нифай умард нутагт зургаан жилийн турш номлогчоор үйлчилжээ. Түүний үгсийг эсэргүүцэж, ёс бус байдалдаа үлдсэн нифайчуудад заах гэж оролдсоныхоо эцэст Нифай гэртээ харив. Тэр сэтгэлээр маш их унасан байлаа. Хиламан 7:6–11-ийг уншаад Нифай юу хийснийг олж мэд.

Нифайг өөрийнхөө цэцэрлэг дэх цамхагт залбирч байгааг сонсохоор хүмүүс цугларсны дараа Нифай тэдэнд зааж эхлэв (Хиламан 7:12–29-ийг үзнэ үү). Тэр тэдэнд гаргасан шийдвэрийнх нь үр дагавруудыг анхааруулан: **Хэрэв бид нүглээ наманчлахаас татгалзвал Их Эзэний хамгаалалт болон мөнх амьдралын адислалуудыг алдах болно** гэсэн зарчмыг онцлон хэлэв.

Хиламан 8:1–26

Ёс бус явдалд ялзарсан шүүгчид Нифайн эсрэг хүмүүсийг уурлахад өдөөн хатгав

Бошиглогчдын үгсийг сонсохоос анхаарлыг тань сарниулагч ямар нөлөөнүүд байдаг вэ? Та Хиламан 8-р бүлгийг судлахдаа тиймэрхүү нөлөөтэй тулгарсан үед юу хийх ёстой тухай санаануудыг олж мэд.

Хиламан 8:1–6-г уншаад нифайчуудын шүүгчид (тэд мөн Гадиантоны дээрэмчдийн нэг хэсэг байв) Нифайн сургаалд яаж хандсаныг мэд. Унших явцдаа, дараах асуултуудыг тунгаан бод: Хүмүүст хандан хэлсэн шүүгчдийн гол захиас юу байв? Хиламан 8:4-г цэдэглэснээр шүүгчид яагаад Нифайг баривчлахгүй байсан бэ?

Бошиглогчдын заасан зүйлсийг үл тоомсорлохыг хэн нэгэн нь танд ятгавал яахаа бод. Хиламан 8-р бүлэгт зарим хүмүүс Нифайн талаар шүүгчдийн хэлсэн зүйлийн эсрэг ярьжээ. Хиламан 8:7–9-ийг

уншаад хүмүүс Нифайг дэмжин юу хэлснийг тодруулж ав.

Хиламан 8:10-ыг хараад тэдний хэлсэн үгс тухайн нөхцөлд ямар нөлөө үзүүлснийг анхаар. Та дараах зарчмыг судартаа Хиламан 8:7–10-ын хажууд бичих хэрэгтэй: **Хэрэв бид хилэнцийг эсэргүүцвэл үүнийг цаашид газар авахаас сэргийлж чадна.**



3. Дээр дурдсан зарчим нь бидний үед яагаад чухал болохыг судар судлах тэмдэглэлдээ тайлбарлан богинохон догол мөр бич.



4. Дараах асуултуудын нэгийг эсвэл илүү олныг судар судлах тэмдэглэлдээ хариулж бич:

а. Бошиглогчийн заасан зүйлийг үл ойшоох эсвэл эсэргүүцэхийг танд ягтахыг оролдсон хэн нэгний нөлөөг та хэрхэн эсэргүүцэж чадах вэ?

б. Тиймэрхүү нөлөөний эсрэг дуу хоолойгоо бусдад сонсгож, Их Эзэний бошиглогчдыг дэмжих тохиромжтой арга замууд юу байж болох вэ?

в. Та болон таны мэддэг хүмүүс хэзээ тийм нөлөөг эсэргүүцэж байсан бэ? Үр дүн нь ямар байв?

Хиламан 8:11–23-г цэдэглэгдсэнээр Нифай Есүс Христийн тухай гэрчилсэн бошиглогчдын талаар хүмүүст сануулжээ. Тэр нифайчуудад дараах зарчмыг заав: **Бид Есүс Христэд итгэх итгэлээ үйлдэл болгож, дуулгавартай байвал мөнх амьдралыг хүлээн авах болно.** Хэдийгээр олон бошиглогчдын заасан зүйлс Нифайн үгсийг баталж байсан ч хүмүүс Нифай болон түүний захиасыг эсэргүүцэв. Хиламан 8:24–26-г уншаад хэрэв нифайчууд бошиглогчдын гэрчлэлүүдийг цаашид эсэргүүцсэн хэвээр байсан бол тэдэнд ямар зүйлс тохиолдож болох байсныг олж мэд. Тэгээд дараах асуултыг тунгаан бод: Үнэнийг байнга үгүйсгэж, Бурханыг эсэргүүцэгч хүмүүс яагаад тийм ноцтой үр дагавруудтай тулгардаг гэж та боддог вэ?

Хиламан 8:27–9:41

Нифай ерөнхий шүүгч дүүдээ алуулсныг илчлэв

Нифай хүмүүс нүгэлт байдалд байсан бөгөөд тэдний сүйрэл биелэгдэхийн баталгаа болгож, ерөнхий шүүгч алагдсаныг илчлэв. Мөн Нифай алуулсан эр, түүний дүү хоёр хоёулаа Гадиантоны дээрэмчдийн бүлгийн гишүүд байсныг зарлав. (Хиламан 8:27–28-ыг үз.)



5. Та энэ зарчмыг судар судлах тэмдэглэлдээ бич: **Бошиглогчдын үгс биелэгдэх болно.** Та өөрийгөө ерөнхий шүүгчийн аллагыг мөрдөж байгаа мөрдөн байцаагч

гэж төсөөл. Хаалтан дахь шүлгүүдийг уншаад дараах асуултуудад хариул. Хариултаа судар судлах тэмдэглэлдээ бич.

Мөрдөн байцаалтын нэг дэх өдөр

а. Нифайн мэдүүлгийг таван хүн магадлан шинжлээд юу олж мэдсэн бэ? Тэд яагаад газарт унав? (Хиламан 9:1–5)

б. Хүмүүс хэнийг алуурчид хэмээн сэжиглэсэн бэ? (Хиламан 9:7–8)

Мөрдөн байцаалтын хоёр дахь өдөр:

в. Хэн гэм буруугүй болох нь нотлогдсон бэ? (Хиламан 9:10–14, 18)

г. Хэн гүтгэгдсэн бэ? (Хиламан 9:16, 19)

д. Нифай өөрийгөө гэм буруугүйг ямар нотлох баримтаар баталсан бэ? (Хиламан 9:25–36)

е. Алуурчин нь хэн байсан бэ? (Хиламан 9:37–38)

Судартаа дараах асуултуудын хариултыг тэмдэглэ:

- Хиламан 9:5-д цэдэглэснээр ерөнхий шүүгч алагдсаныг илрүүлсэн таван эр юунд итгэсэн ба юунаас айцгаасан бэ?
- Хиламан 9:36-д цэдэглэснээр, Сийнтум ахыгаа алснаа хүлээхдээ юуны талаар гэрчлэх болно хэмээн Нифай хэлсэн бэ?
- Хиламан 9:39–41-т цэдэглэснээр яагаад зарим хүмүүс Нифайд итгэсэн бэ?



6. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Хиламан 6–9-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна.

23-Р ХЭСЭГ: 1 ДЭХ ӨДӨР

Хиламан 10

Оршил

Ерөнхий шүүгчийг хөнөөсөн хэрэг хаагдсаны дараа (Хиламан 7–9-ийг үзнэ үү), Нифай гэртээ харихаар явав. Тэр Их Эзэн өөрт нь үзүүлсэн зүйлсийг тунгаан бодож, мөн хүмүүсийн ёс бус явдлын талаар санаа нь зовж байлаа. Нифайг сэтгэлээр унасан үед Их Эзэн түүнтэй ярилцаж, лацдалтын хүчээр түүнийг үүрд адисалсан юм. Их Эзэн Нифайг үргэлжлүүлэн хүмүүст наманчлалыг номлохыг зарлиг болгоход Нифай тэр даруй уг зарлигийг дуулгавартай дагав.

Суралцах орчныг бүрдүүлэх нь

Сайн мэдээнээс суралцах тохиромжтой орчин нь дэг журам, хүндэтгэлтэй байдал ба амар амгалангийн мэдэрэмжээс бүрддэг. Судрыг судлах, тунгаан бодоход анхаарлыг тань сарниулж, саад болох зүйлсийг үгүй болгохыг хичээ. Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын Ахлагч Бойд К.Пакэр, “сүнсний удирдамж амар тайван орчинд чөлөөтэй ирдэг” бөгөөд “хүндэтгэлтэй байдал илчлэлтийг урьдаг” хэмээн заажээ (“Reverence Invites Revelation,” *Ensign*, 1991 оны 11-р сар, 21–22).

сэн гэнэтийн үйл явдлуудыг нүдээр үзсэн хэрнээ итгэлтэй болж, наманчлаагүйг олж мэджээ. Нифай сэтгэлээр унан, гэртээ харив. Хиламан 10:1–3-ыг уншаад гэртээ харих замдаа Нифай юуны тухай тунгаан бодсоныг олж мэд. Та *тунгаан бодох* гэсэн үгийг эдгээр шүлгүүдэд гарах бүрд нь тэмдэглэж ав. Тунгаан бодох гэдэг нь судруудыг эсвэл Бурханы бусад зүйлсийн тухай бясалгах, олон талаас нь гүнзгий бодох гэсэн утгатай. Бурханы зүйлсийг залбиралтай нэгтгэвэл, тунгаан бодох нь илүү сайн ойлголтыг авчрах болно.

Дараах асуултуудын талаар бод:

- Нифай юуны тухай тунгаан бодсон бэ?
- Тэр яагаад “гутарсан” эсвэл гунигтай байсан бэ?
- Түүнийг тунгаан бодох үед юу болов?

Хиламан 10:1–3-ыг харуулсан нэг зарчим бол: **Их Эзэний зүйлсийг тунгаан бодох нь биднийг илчлэлт хүлээн авахад бэлтгэдэг гэсэн зарчим юм.** Судрууд дахь бусад жишээнүүд бас энэ зарчмыг харуулдаг: Нифай, өөрийн эцэг Лихайн заасан зүйлсийг тунгаан бодож, тэдгээр нь үнэн зөв гэдгийг мэдсэн (1 Нифай 10:17; 11:1-ийг үзнэ үү); залуу Иосеф Смит Иаков 1:5-р шүлгийг “дахин дахин тунгаан бодсон”-ы үр дүнд үнэн түүнд илчлэгдсэн билээ (Иосеф Смит—Түүх 1:11–19-ийг үзнэ үү); Жозеф Ф.Смит нас барагсдын гэтэлгэлийн талаарх судруудыг тунгаан бодож, бясалгахад түүнд үнэн илчлэгдсэн юм (С ба Г 138:1–6, 11-ийг үзнэ үү).

Хиламан 10:1–11

Нифай лацдах хүчийг хүлээн авсан нь

Та зөв зүйлийг хийх гэж бүх чадлаараа хичээсэн үед бусад хүмүүсээс хүлээн авсан хариу эсвэл гарсан үр дүн нь өөрийн тань бодсоноос өөр байсан үеийн тухай бод. Та Хиламан 10-р бүлгээс Нифай хүнд нөхцөлд итгэлтэй хэвээр байсан учраас Их Эзэн түүнийг хэрхэн адисалсан тухай унших болно.

Нифай ерөнхий шүүчийн амийг хөнөөсөн хэргээс цагаадсаныхаа дараа, хүмүүс Хиламан 9-р бүлэгт өгүүл-

Хүмүүс ихэнх илчлэлтийг Их Эзэний зүйлсийг тунгаан бодох үедээ хүлээн авдаг ч эдгээр нь дуу хоолойг сонсох, үзэгдэл үзэх болон сэтгэл догдлом бусад арга замуудаар ирдэггүй. Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын Ахлагч Дэвид А.Бэднар ийн тайлбарлажээ:



“Илчлэлтүүд нь зүүд, үзэгдэл, тэнгэр элчүүдтэй ярилцах, сүнсний өдөөлт зэрэг олон янзын арга замаар ирдэг. Зарим илчлэлтийг шууд, хүчтэй хүлээн авдаг бол зарим нь алгуураар, үлэмж нарийн мэдрэмжээр танигддаг. . . .

“ . . . Ихэнх тохиолдолд илчлэлт нь бага багаар бидний хүсэл, зохистой байдал ба бэлтгэлийн дагуу ирдэг. Тэнгэрлэг Эцэгээс ирэх ийм харилцаа нь эцэстээ “тэнгэрээс буух шүүдэр лүгээ адил [бидний сүнсэнд] намуухан буух болно” (С ба Г 121:45). Илчлэлтийн энэ хэв маяг нь Нифай Лебенээс гуулин ялтсуудыг амжилттай олж авахын өмнөх хэдэн удаагийн оролдлогод илэрдэг (1 Нифай 3–4-ийг үзнэ үү). . . .

“ . . . Бошиглогч Иосеф Смитэд сэргээгдсэн сайн мэдээний үндсэн гол үнэнүүд Ариун ойн цоорхойд шууд нэг дор, бүгдээрээ өгөгдөөгүй юм. Эдгээр үнэлж баршгүй эрдэнэсийн сан хөмрөг нөхцөл байдал баталгаатай болсон үед зөв цагт илчлэгдсэн билээ.

“Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит илчлэлтийн энэ хэв маяг түүний амьдралд хэрхэн ирснийг тайлбарлахдаа: ‘Би хөвгүүн байхдаа . . . гэрчлэлтэй болохын тулд Их Эзэнээс зарим гайхамшигийг надад үзүүлэхийг . . . байнга хүсдэг байлаа. Гэвч Их Эзэн надаас гайхамшгуудыг нууж, үнэнийг надад бүрэн мэдүүлэх хүртэл, эргэлзээ ба айдас надаас бүрэн алга болтол үнэнийг шат шатаар үзүүлсэн юм’ (Conference Report, 1900 оны 4-р сар, 40–41).

Сүмийн гишүүд бид гайхамшигтай бөгөөд үр нөлөө ихтэй сүнсний илэрхийллийн төлөө онцгойлон талархахаа мартаж, Ариун Сүнсээр гүйцэлдүүлдэг Түүний ажлын ердийн хэв маягийг анзааралгүй өнгөрөх хандлагатай байдаг” (“Илчлэлтийн Сүнс,” *Ensign* буюу *Лиакхона*, 2011 оны 5-р сар, 88).



1. Хувиараа илчлэлт хүлээн авснаа мэдэрсэн үеийнхээ тухай судар судлах тэмдэглэлдээ бич. Илчлэлт ирэх ямар нөхцөлүүд бүрдсэн байв? Тунгаан бодох нь илчлэлт хүлээн авахад тань хэрхэн тусалсан бэ? (Илчлэлт олон арга замаар ирдгийг сана. Илчлэлт гэнэт ирэх эсвэл ойлголт, гэгээрлийн аажим, алгуурхан мөчүүдээр эсвэл амар амгалан болон өөртөө итгэлтэй байх мэдрэмжээр ирж болно.)

Сүмийн цуглаануудын үеэр, хувийн залбирал болон судраа судлахынхаа өмнө ба дараа, ерөнхий чуулганыг үзэх эсвэл сонссоны дараа, мацаг барьж байхдаа,




эсвэл Хүндэтгэлийн өдрийг сахих үеэр гэхчлэн амьдралдаа байнга тунгаан бодох цаг гаргаж бай.

Таны хувьд их үнэ цэнэтэй нэг зүйлийг та өөр хүнд итгэмжлэл хүлээлгэн үлдээх хэрэг гарчээ гэж бод. Та хэнд үүнийг итгэмжлэл хүлээлгэн үлдээх вэ? Та яагаад тэр хүнийг сонгох вэ? Тэр хүн таны итгэл найдварыг хүлээх юу хийсэн бэ?

Хиламан 10:4–5-ыг уншиж, Их Эзэн яагаад Нифайд итгэснийг олж мэд. *Цуцашгүй* гэдэг үг нь “хэзээ ч ядардаггүй” гэсэн утгатай. Ямар ч нөхцөл байдлыг үл харгалзан Их Эзэнд цуцашгүй үйлчилдэг, өөрийнхөө мэддэг хүмүүсийн үлгэр дуурайлыг тунгаан бод.

Хиламан 10:4-т Нифайд Их Эзэний өгсөн хариулт дараах зарчмыг зааж байна: **Бид өөрийн ашиг сонирхлыг биш, харин Их Эзэний хүслийг урьтал болговол Тэр бидэнд адислалууд болон үүрэг хариуцлагуудыг итгэл хүлээлгэн өгөх болно.**

 **2.** Дараах асуултуудын нэгэнд эсвэл түүнээс олонд нь судар судлах тэмдэглэлдээ хариулж бич:

- а.** Таны амьдралын талаарх Их Эзэний хүсэл юу болохыг та ямар арга замаар мэдэж болох вэ?
- б.** Түүний хүсэл таныхаас хавьгүй чухал бөгөөд үүнийг үргэлж баримтална гэдгээ Их Эзэнд харуулах ямар зүйлийг та саяхан хийсэн бэ?
- в.** Та амьдралынхаа ямар зүйлд өөрийнхөө хүслийг биш харин Их Эзэний хүслийг эрэлхийлж, дагахыг улам илүү хичээх хэрэгтэй вэ?

Хиламан 10:5–7-г уншаад Нифай итгэл хүлээсэн учир Их Эзэнээс түүнд өгсөн адислалууд ба амлалтуудыг олж мэд. Адислалууд ба амлалтуудыг холбогдох шүлгийнх нь хажууд бич:

5-р шүлэг: _____

6-р шүлэг: _____

7-р шүлэг: _____

Хиламан 10:7-р шүлэг дэх адислал нь Есүс Христийн сайн мэдээний гол сургаал юм: **Лацдах хүч нь дэлхий дээр болон тэнгэрт холбодог мөн цуцалдаг.** Судар дахь өөр ямар хүмүүст энэхүү лацдах хүч өгөгдсөнийг та мэдэх үү? Хиламан 10:7-г дараах судруудын холбогдох эшлэлтэй жишиж болно: 1 Хаадын Дээд 17 (Елиа); Матай 16:15–19 (Петр); Сургаал ба Гэрээ 132:46 (Иосеф Смит).

Сургаал ба Гэрээ 128:9-ийг уншаад Бошиглогч Иосеф Смит лацдах хүчийн тухай юу заасныг олж мэд.


Өнөөдөр Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтүүдийн Сүмийн Ерөнхийлөгч мөн ийм лацдах хүчийн түлхүүрүүдийг атгадаг. Их Эзэн Нифайд итгэснийхээ нэгэн адил сүмийн Ерөнхийлөгч энэхүү хүчийг Түүний хүсэлд харшлах аливаа арга замаар хэрэглэхгүй гэдгийг мөн мэддэг. Энэхүү лацдах эрх мэдэл нь дэлхий даяарх бусад зохистой санваартнуудад өгөгдөн дэлхий дээр болон тэнгэрт санваарын ёслолуудыг холбох боломжийг тэдэнд олгодог.

Энэхүү лацдах хүчний ач холбогдлын тухай Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Брүс Р.Макконкигийн дараах үгсийг бод:



Энэ хүчээр лацдагдаагүй бүх зүйлс тэднийг нас барахад дуусгавар болдог. Баптисмд энэхүү бөх бат лацдалт байхгүй бол тухайн хүн селестиел хаант улсад орохгүй, мөнхийн гэрлэлтийн гэрээ энэхүү эрх мэдлээр лацдагдахаас нааш гэрлэгч хосууд селестиел дэлхийн хамгийн дээд тэнгэрт өргөмжлөлийг хүртэхгүй.

“Энэхүү лацдах хүчийн ачаар бүх зүйлс төгсөшгүй хүчтэй бөгөөд хүчин төгөлдөр болдог” (*Mormon Doctrine*, 2 дахь хэвлэл, [1966], 683).

 **3.** Дараах асуултуудад судар судлах тэмдэглэлдээ хариулж бич:

- а.** Ахлагч Макконкигийн хэлснээр, тухайн ёслол зохих эрх мэдлээр лацдагдаагүй бол юу тохиолдох вэ?



6. Лацдах хүч таны амьдралд ямар нөлөө үзүүлсэн бэ? Энэ хүч ирээдүйн амьдралыг тань хэрхэн адислаасай гэж та хүсдэг вэ?

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Рассэлл М.Нэлсон Бурханы лацдах хүч сэргээгдсэнийг батлан ийн хэлжээ: “Ариун сүм, ёслолууд гэрээнүүд, хишиг хүртэлт болон лацдан холболт нь яг бошиглогдсонхоо дагуу сэргээгдсэн юм. Ариун сүмийн ёслолууд Их Эзэнтэй эвлэрэх явдлыг хангаж, гэр бүлүүдийг үүрд мөнх лацдан холбодог. Ариун сүмд хийгддэг ариун нандин гэрээнүүдэд дуулгавартай байх нь хүмүүнд өгдөг Бурханы хамгийн агуу бэлэг болох мөнх амьдралыг хүлээн авахад биднийг тэнцэхээр болгодог” (“Prepare for the Blessings of the Temple,” *Ensign*, 2010 оны 10-р сар, 42).

Ахлагч Нэлсонгийн хэлснээр, юу биднийг лацдах хүчийн амлагдсан адислалуудыг хүлээн авахад тэнцэхээр болгодог вэ?

Хиламан 10:12–19

Нифай хүмүүст наманчлалыг номло гэсэн Их Эзэний зарлигийг дуулгавартай дагав

Эцэг эх, ажил олгогч эсвэл удирдагчийнхаа хүссэн зүйлийг хийхийг хойш тавьсан эсвэл хийгээгүй

тохиолдол танд бий юу? Та өөрөөсөө хүссэн зүйлийг хийхээ хойш тавьснаар бусдад ямар сэтгэгдэл үлдээдгээ эргэцүүлэн бод.

Хиламан 10:11–12-ыг уншиж, Нифай хүмүүст наманчлалыг номло гэсэн Их Эзэний зарлигт хэрхэн хандсаныг олж мэд. Бид Их Эзэний зөвлөгөө, зарлигуудад тэр даруй хурдан хариулснаар Түүнд юуг харуулдаг вэ?



4. Хиламан 10:13–18-ыг унш. Тэгээд, Их Эзэний зарлигт хариулсан Нифайн жишээнээс юу сурч мэдсэн зүйлээ судар судлах тэмдэглэлдээ цөөн өгүүлбэрт багтаан бич. Үүнийг амьдралдаа хэрэгжүүлэх нэг арга замыг бич.

Нифайн итгэлтэй байдал Их Эзэн түүнд итгэл хүлээлгэж болохыг харуулсан бөгөөд Нифай агуу хүч ба хамгаалалтаар адислагджээ.

Төгс эзэмших судрын давтлага

Төгс эзэмших судрын давтлага болгож 1 Нифай 3:7; 2 Нифай 2:27; 2 Нифай 31:19–20; ба Мозая 2:17-г унш. Эдгээр төгс эзэмших судрын шүлгүүд Хиламан 10-р бүлэг дэх Нифай болон түүний үйлчлэлтэй хэрхэн холбогдож байгааг эргэцүүлэн бод.

Их Эзэний хүслийг өөрийнхөөсөө дээгүүрт тавьж, дагахдаа түргэн шуурхай байх арга замуудыг эрэлхийл.

Та Нифайн адил Их Эзэнд итгэлтэй үйлчилбэл Тэр танд итгэл хүлээлгэж, таныг адислах болно.

 **5.** Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Хиламан 10-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

23-Р ХЭСЭГ: 2 ДАХЬ ӨДӨР


Хиламан 11–12


Оршил

Хиламан 11–12-р бүлгүүд нифайчуудын 14 жилийн түүхийг хамардаг бөгөөд хүмүүс зөв шударга байдал болон ёс бус явдлын мөчлөгөөр дамжин өнгөрснийг харуулдаг. Хүмүүс бардамналаасаа болж ёс бус явдлаа наманчлахаас татгалзав. Нифай тэнгэрийг лацадсанаас болж ган гачиг, өлсгөлөн болжээ. Ган гачиг, өлсгөлөн хүмүүсийг даруусгаж, тэд наманчилж, Их Эзэн рүү эргэлээ. Хүмүүс даруу байхыг сонгоогүйн улмаас тэдэнд Бурханы тусламж хэчнээн их хэрэгтэйг ойлгох хүртлээ тэд Их Эзэн, Бурханаа амархан мартдаг. Бурхан Өөрийн хүмүүсийг нигүүлслийнхээ ачаар наманчлал ба авралд авчрахын тулд зэмлэдэг.

Хиламан 11

Нифайчууд зөв шударга байдал ба ёс бус явдлын мөчлөгөөр дамжин өнгөрсөн нь

 **1.** Дараах зөв шударга байдал ба ёс бус явдлын мөчлөгийг судар судлах тэмдэглэлдээ зур. Энэ үе шатыг ихэнхдээ “бардамналын мөчлөг” гэж нэрлэдэг. Мөчлөгийн уг бүрэлдэхүүн хэсгийн 4-р жишиг зураг байхгүй байгааг анхаар. Хүмүүсийг сүйрэл ба зовлонгоос зөв шударга байдал ба хөгжил дэвшилд хүргэхэд юу хэрэгтэй гэж та бодож байна? Хиламан 11-р бүлгийг судлахдаа уг мөчлөг дэх энэ алхмыг бөглөхөд тань туслах мэдээллийг хайж ол.



Бошиглогч Нифайн дамжуулсан Бурханы үгсийг хүмүүс сонсохгүй байгааг та Хиламан 10-р бүлгээс уншсан билээ. Хиламан 10:18-ыг дахин уншаад тухайн үед нифайчууд бардамналын мөчлөгийн хаана нь байсныг олж мэд (шүүгчдийн засаглалын далан нэгэн оны сүүлчээр).

Түүхийнх нь 14 жилийн турш Мормоны Номын хүмүүсийн дунд байсан зөв шударга байдал ба ёс бус явдлын энэхүү мөчлөгийг ойлгоход тань дараах судрын үйл ажиллагаа туслах болно. Хиламан 11-р бүлгийн судрын эшлэлүүдийг уншаад дараах хүснэгтэд нифайчуудын нөхцөл байдлыг товч дүрслэн бичиж, тэд бардамналын мөчлөгийн хаана нь байсныг дугаарла. Танд хоёр жишээ өгөгдсөн байгаа. Судар судлах тэмдэглэлдээ зурсан мөчлөгт байхгүй байгаа дөрөвдүгээр алхмыг бөглөхөд тань туслах үгсийг хайж ол.

Шүүгчдийн засаглалын жил	Хиламан 11	Нифайчуудын нөхцөл байдлын товч дүрслэл	Мөчлөг дэх байршил
72–73	1–2-р шүлгүүд	Зөрчилдөөн, дайн дажин газар авч, дээрэмчдийн нууц бүлэглэл сүйрлийн үйл ажиллагаа явуулж байлаа.	2, 3
73–75	3–6-р шүлгүүд		
75	7, 9–12-р шүлгүүд		
76–77	17–18, 20–21-р шүлгүүд	Хүмүүс баярлаж, Бурханыг алдаршуулав; тэд зөв шударга байж, дахин хөгжин цэцэглэж эхлэв.	4, 1

Шүүгч-дийн засаглалын жил	Хиламан 11	Нифайчуудын нөхцөл байдлын товч дүрслэл	Мөчлөг дэх байршил
78–79	22–23-р шүлгүүд		
80	24–26-р шүлгүүд		
80–81	27–30, 32–35-р шүлгүүд		
82–85	36–37-р шүлгүүд		

Судрын үйл ажиллагаанд харуулсны дагуу бардамналын мөчлөгийн 4-р хэсэг бол “даруу байдал ба наманчлал” юм. Үүнийг судар судлах тэмдэглэл дэх хүснэгтдээ бич.



2. Бардамналын мөчлөг нь зөвхөн нийгмийн дүр зураг төдий зүйл биш юм. Энэ нь мөн гэр бүлд эсвэл хувь хүний амьдралд харагдаж болно. Энэ мөчлөг хэрхэн явагддагийг мэдэх нь үүнээс зайлсхийхэд бидэнд тусална. Мөчлөгийн “бардамнал ба ёс бус явдал” эсвэл “сүйрэл ба зовлон зүдгүүр” гэсэн үе шатуудад орохоос зайлсхийхэд танд юу хэрэгтэй болохыг судар судлах тэмдэглэлдээ бич.

Та дараах зарчмыг судартаа Хиламан 11-р бүлэгт бич: **Бид даруу байдал ба наманчлалаар бардамнал ба сүйрлээс зайлсхийж чадна.** Өлсгөлөн хүмүүст нь хэрхэн нөлөөлнө гэж Нифай найдсаныг та Хиламан 11:4-т тэмдэглэж болно.

Дараах асуултуудын хариултын тухай бод:

- Нийгэм, гэр бүл, эсвэл хувь хүн бардамналын мөчлөгийг дагах шаардлагатай юу?

- Нийгэм, гэр бүл эсвэл хувь хүн бардамналын мөчлөгт орохоос зайлсхийхийн тулд юу хийх хэрэгтэй гэж та бодож байна вэ?

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Ричард Г. Скотт Нифайн залбирлын талаар ийн хэлжээ: “Их Эзэн Өөрийн үйлчлэгчийн гуйлтыг [Хиламан 11:10–14-т] сонссон ч өлсгөлөнг дараа жил нь зогсоосон юм. Энэ явдал Их Эзэн бидний гуйлтыг тэр даруй сондог ч Өөрийн мэргэн ухаанаар бид Түүний хариултаас хамгийн их ашиг тусыг хүртэж болох үед л хариу өгдгийг харуулж байна” (“Nephi, Son of Helaman,” *Heroes from the Book of Mormon* [1995,] 154.)

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон, бид бардамналын мөчлөгт орохоос зайлсхийхийн тулд юу хийж болохыг заасан юм:



“Бурхан даруу хүмүүстэй хамт байх болно. Бид даруу байхыг нэг бол өөрсдөө сонгоно эсвэл бидэнд даруу байхыг албадаж болно. Алма хэлэхдээ ‘даруу байхыг албадуулалгүйгээр өөрсдийгөө даруу болгох тэд адислагдсан болой’ гэжээ. (Алма 32:16.)

Даруу байхыг сонгоцгооё.

“Бид ах, эгч, дүү нарынхаа эсрэг дайсагналаа [үзэн ядалт] ялж, тэднийг өөрсдийн адил үзэж, өөрсдөөсөө илүү өндрөөр үнэлснээр өөрсдийгөө даруусгахыг сонгож чадна. . . .

“Бид зөвлөгөө болон зэмлэлийг хүлээн авч өөрсдийгөө даруусгахыг сонгож чадна. . . .

“Бид өөрсдийгөө гомдоосон хүмүүсийг уучилснаар өөрсдийгөө даруусгаж чадна. . . .

“Бид амь биеэ хайрлахгүй үйлчилснээр өөрсдийгөө даруусгаж чадна. . . .

“Бид номлолд явж, бусдыг даруусгаж чадах үгийг номлосноор өөрсдийгөө даруусгахыг сонгож чадна. . . .

“Бид ариун сүмд дахин дахин орсноор өөрсдийгөө даруусгахыг сонгож чадна.

Бид гэм нүглээ хүлээж, орхиж мөн Бурханаас дахин төрснөөр өөрсдийгөө даруусгахыг сонгож чадна. . . .

“Бид Бурханыг хайрлаж, Түүний хүсэлд өөрсдийн хүслийг захируулж, Түүнийг амьдралдаа эн тэргүүнд тавьснаар өөрсдийгөө даруусгаж чадна. . . .

Даруу байхыг сонгоцгооё. Бид үүнийг хийж чадна. Бид чадна гэдгийг би мэдэж байна” (“Beware of Pride,” *Ensign*, 1989 оны 5-р сар 6–7).


Хиламан 12

Их Эзэн яагаад хүмүүсийг зэмлэдгийг Мормон тайлбарлажээ

Та өөрийгөө бошиглогч Мормон байсан гэж төсөөлөөд Хиламан 11-р бүлэг дэх нифайчуудын 14 жилийн түүхийг бичиж дуусгалаа гэж бод. Та дараах өгүүлбэрийг хэрхэн үргэлжлүүлж төгсгөх байсан бол: “Мөн тийн бид харж болно _____”.

Хиламан 12:1-ийг уншаад Мормон биднийг юуг ойлгоосой гэж хүссэнийг олж мэд. “Хүмүүний үрсийн зүрх сэтгэл тогтворгүй” хэмээн Мормон яг юуг хэлсэн байж болохыг бод.

Хиламан 12:2–3-ийг уншиж, Мормон биднийг сураасай гэсэн бусад сургамжуудыг олж мэд. “Бид харж болох бөлгөө” (2-р шүлэг), “бид ийн харлаа” (3-р шүлэг) гэсэн хэллэгүүдийг илүү анхаар.

 3. Дараах асуултуудад судар судлах тэмдэглэлдээ хариулж бич:

а. Хөгжин дэвжиж байгаа хүмүүс яагаад Бурханыг амархан мартдаг гэж та боддог вэ?

б. Бидний үе дэх амар хөнгөн амьдрал, хөгжил цэцэглэлт хүмүүс Бурханыг мартахад хүргэж болзошгүй ямар жишээнүүд байна вэ?

в. Хувь хүн эсвэл бүлэг хүмүүс хөгжил цэцэглэлтийнхээ үед Их Эзэнээ умартсан ямар нөхцөл байдлыг та мэддэг вэ?

Мормон уншигчдаа мэдээсэй гэж хүссэн зарим сургамжууд нь: **Хэрэв бид сэрэмжлэхгүй аваас бидний хөгжил цэцэглэлт биднийг Их Эзэнийг мартахад хүргэх бөгөөд Их Эзэн Өөрийн хүмүүсийг Түүнийг санахад хүргэхийн тулд зэмлэдэг юм.**




Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Д.Тодд Кристоффэрсон Их Эзэн яагаад биднийг зэмлэдгийг ийн заажээ:

“Энэ нь ихэвчлэн тэвчихэд хэцүү байдаг ч Бурхан бидний алдаа дутагдлыг залруулахад цаг заваа зориулж, анхаарал тавьдагт бид үнэхээр баярлах ёстой.

“Бурханлаг зэмлэл нь хамгийн багаар бодоход: (1) биднийг наманчлахад ятгах, (2) биднийг төгөлдөржүүлж, ариусгах, (3) заримдаа бидний амьдралын замналыг Бурханы мэддэг илүү сайн зам руу өөрчлөн чиглүүлэх гэсэн гурван зорилготой юм” (“Би хайртай хүмүүсээ зэмлэж, сахилгажуулдаг” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2011 оны 5-р сар, 98).

Их Эзэн Хиламан 11–12-р бүлгүүдэд нифайчууд болон леменчүүдийг зэмлэсэн нь дээрх зорилгуудын

аль нь вэ? Их Эзэн ямар зорилгын улмаас таны амьдралд зэмлэлийг хэрэглэсэн бэ?

 4. Дараах асуултуудад судар судлах тэмдэглэлдээ хариулж бич:

а. Хиламан 12:4–6-г уншаад Бурханыг мартагч хүмүүсийн тухай илүү ихийг олж мэд. Хувийн ямар зан чанарууд хүмүүст Бурханыг санахад саад тотгор учруулдаг вэ?

б. Хиламан 12:7–13-ыг унш. Яагаад Мормон “хүмүүний үрс . . . газрын тоосноос ч өчүүхэн” гэж хэлсэн юм бол? Хүмүүсийн заримдаа хийхийг хүсдэггүй ямар зүйлийг тоос хийдэг вэ?



Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит заасан нь: “Энэ бошиглогч [Мормон] Их Эзэн газрын тоосыг хүүхдүүдээсээ илүү анхаарч хайрладаг хэмээн хэлээгүй юм. . . . Түүний хэлсэн гол санаа нь газрын тоос дуулгавартай гэдэгт

оршино. Тоос Их Эзэний тушааснаар нааш цааш хөдөлдөг. Бүх зүйлс Түүний хуулийн дагуу зохицон оршдог. Миний мэдэхээр орчлон ертөнц дэх хүмүүнээс бусад бүх зүйлс өгөгдсөн хуулийг дагадаг. Та хаашаа ч харсан хууль дүрэм журмыг олж харна. Байгалийн үзэгдлүүд өөр өөрийн хуулийг сахиж, үүрэгтээ үнэнч байдаг. Гэтэл хүн эсэргүүцэж, Их Эзэний зөвлөгөөг эсэргүүцдэгээрээ газрын тоосноос ч өчүүхэн юм” (Conference Report, 1929 оны 4-р сар, 55).

Бурханыг өөрсдийн удирдан чиглүүлэгчээр сонгосон хүмүүс л газрын тоосноос агуу гэдгийг Мормон ойлгосон ажээ. Түүний энэхүү зүйрлэл бардам бөгөөд Их Эзэний дуу хоолойг эсэргүүцдэг, тогтворгүй зүрх сэтгэлтэй хүмүүст анхаарал хандуулах зорилготой юм. Хиламан 12:9–20-д цэдэглэгдсэнээр Мормон бидэнд биет элементүүдийг захирах Их Эзэний агуу хүч чадлыг сануулсан юм. Тэдгээр нь бүгд Түүний зарлигаар хөдөлдөг. Та Их Эзэний зарлигуудад хэр зэрэг дуулгавартай байдгаа түр зуур тунгаан бод. Түүний зарлигуудыг дуулгавартай дагах хүсэл тань даруу байдлыг хэрхэн харуулдаг вэ? Бид сонгох эрхээ Түүний үгсийг дагахгүй байхад ашиглах нь бардамналыг хэрхэн харуулдаг вэ?

 **5.** Судар судлах тэмдэглэлдээ дараах өгүүлбэрүүдийг гүйцээж бич:

а. Хиламан 11–12-р бүлгүүд дэх Мөн түүнчлэн би . . . харлаа

б. Тиймээс, би . . . болно

Бид Их Эзэнийг санаж, Түүний дуу хоолойг сонсч, наманчилснаар даруу байдал болон Түүнд итгэх итгэлээ харуулдаг. Үүний хариуд Тэр биднийг адисалж, хөгжүүлж, эцэстээ бидэнд мөнх амьдралыг өгнө гэсэн амлалтаа биелүүлдэг.

 **6.** Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Хиламан 11–12-р бүлгүүдийг судалж энэ хичээлийг ((огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

23-Р ХЭСЭГ: 3 ДАХЬ ӨДӨР

Хиламан 13–14

Оршил


Их Эзэн Аврагчийн төрөлтөөс хэдэн жилийн өмнө нифайчуудад наманчлалыг номлуулахаар Самуел гэгч лемен үндэстэн бошиглогчийг Зарахемла руу илгээжээ. Бошиглогч Самуел, бошиглогч Нифайн хамтаар Есүс Христийн хоёр дахь гэрч болсон юм. Тэр нифайчуудад хэрэв тэд наманчлахгүй бол сүйрнэ гэдгийг урьдчилан анхааруулжээ. Самуел тэдний бошиглогчдыг үл ойшоох болон алдсыг үйлдэхээс аз жаргалыг эрэлхийлэх хандлагатай нүүр тулав. Тэр Есүс Христийн төрөлт ба үхлийн тэмдгүүдийг зарлан мэдэгджээ. Тэр мөн Есүс Христийн гэтэлгэлээр дамжин бүх хүн төрөлхтөн Бурханы өмнө шүүгдэхээр аваачигдах болно гэдгийг заасан.

Хиламан 13

Самуел нифайчуудад хэрэв тэд наманчлахгүй бол сүйрнэ гэдгийг анхааруулав.


Таныг ямар нэг буруу зүйл хийхэд, эцэг эх тань эсвэл өөр аль нэг удирдагч таныг засч залруулах хэрэгтэй болбол та яах вэ?

Хиламан 13–16-р бүлгүүдэд цэдэглэгдсэнээр бошиглогч хүмүүсийг наманчлалд дуудаж байгаа шастир



тун өвөрмөц бөгөөд Мормоны Номд лемен үндэстэн бошиглогч нифайчуудыг наманчлалд дуудсан анхны тохиолдол юм.

Яагаад Самуел нифайчуудад номлох болсныг түүнчлэн Их Эзэн түүнийг юу хэлэхэд удирдсаныг ойлгохын тулд Хиламан 13:1–8, 11-ийг унш. Эдгээр шүлгүүд дараах зарчмыг харуулдаг: **Бошиглогчид Бурхан тэдний зүрх сэтгэлд оруулсан захиасыг хүлээн авч, ярьдаг.** Бурхан Самуелын зүрх сэтгэлд ямар захиасыг оруулсан бэ? Хиламан 13:7-д цэдэглэгдсэнээр Самуел өөрийнх нь захиас нифайчуудад ямар нөлөө үзүүлнэ гэж найдаж байсан бэ?

 **1.** Эцэг эх эсвэл сүмийн удирдагч танд ямар нэгэн тодорхой захиас өгөхөөр сүнсээр өдөөгдсөнийг мэдэрсэн үеийнхээ тухай судар судлах тэмдэглэлдээ бич. Тэр захиас танд хэрхэн нөлөөлсөн бэ?

Хиламан 13:17–23 болон Хиламан 13:24–30-ийг судлаад дараах хүснэгтүүдийн асуултуудад өгөгдсөн зайд хариулж бич.

ХИЛАМАН 13:17–23

Зарчим: Бид Их Эзэнийг санахгүй үедээ бардамнал ба алдаст илүү өртөмтгий болдог.

Аль шүлгүүд танд дээрх зарчмыг зааж байна вэ?

Самуел нифайчуудад ямар зүхэл ирнэ гэсэн бэ?

Самуелын хэлснээр нифайчууд эд баялаг дээр зүрх сэтгэлээ тавьснаар юуг хийхгүй байсан бэ?

Өнөөдөр залуус зүрх сэтгэлээ эд баялаг, эзэмшил хөрөнгө, дадал хэвшил, хүсэл сонирхол дээрээ тавих нь тэднийг ямар замаар бардамнал болон алдас руу хөтөлж байна вэ?

“Таныг адисалсан зүйлүүдэд Их Эзэн Бурханаа санах” нь яагаад чухал гэж та бодож байна? (22-р шүлэг).

ХИЛАМАН 13:24–30

Зарчим: Хэрэв бид Их Эзэний бошиглогчдын үгсийг эсэргүүцвэл, харуусал болон уй гашууг амсах болно.

Дээрх зарчмыг аль шүлгүүд зааж байна гэж та бодож байна?

Нифайчууд Их Эзэний бошиглогчийг эсэргүүцэхдээ ямар шалтаг тоочсон гэж Самуел хэлсэн бэ?

Самуелын дүрсэлснээр яагаад хүмүүс ихэнхдээ хуурамч бошиглогчдыг хүлээн зөвшөөрдөг гэж та боддог вэ?

Ensign эсвэл *Лиахона* дээрээс сүүлчийн ерөнхий чуулган дээр хэлсэн үгсийг судлаад доорх хоёр асуултад хариул.

Бидний амьд бошиглогчид болон төлөөлөгчид ямар тодорхой зүйлсийг заасан бэ?

Бошиглогчид болон төлөөлөгчид биднийг ямар тодорхой асуудлуудаас зайлсхийхийг анхааруулсан бэ?

Хиламан 13:26–28-ыг дахин хараад нифайчууд хуурамч бошиглогчдод хэрхэн хандсаныг олж мэд. Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон ийн хэлжээ: “Амьд бошиглогчид бидний мэдэх ёстой зүйлсийг хэлэхэд бид тэдгээрийг хэрхэн хүлээн авах нь бидний итгэлийн сорилт болдог” (*The Teachings of Ezra Taft Benson* [1988], 140).



2. Дараах асуултаудад судар судлах тэмдэглэлдээ хариулж бич:

а. Та бошиглогчдын ямар зөвлөгөөнүүдийг дуулгавартай дагахаар сонгосон бэ?

б. Уг зөвлөгөөг дагаснаар та хэрхэн адислагдсан бэ?

в. Та амьд бошиглогчдын зөвлөгөөг дагахаа хэрхэн сайжруулж чадах вэ?

Самуел нифайчууд наманчлахгүй бол 400 жилийн дараа устгагдана гэж бошиглосон (Хиламан

13:9–10-ыг үзнэ үү) бөгөөд тэд өдий хүртэл устгагдаагүй байгаагийн шалтгаан нь тэдний дунд зөв шударга хүмүүс амьдарч байсан явдал гэж заажээ (Хиламан 13:12–14-ийг үзнэ үү).

Самуелын үед маш олон нифайчууд хэрхэн ёс бус болсныг Хиламан 13:38-ыг уншаад олж мэд.

Бид алдсыг үйлдсэнээр аз жаргалыг олж чадахгүй хэмээн Самуел тунхагласан нь **жинхэнэ аз жаргал Бурханы зарлигуудыг дагаснаар ирдгийг ойлгоход бидэнд тусалдаг**. Төгс эзэмших ямар судар энэхүү үнэнийг мөн заадаг вэ? (Хиламан 13:38-ын зүүвэр тайлбар 6-г үзнэ үү.)



Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон бидэнд энэхүү зарчмыг ойлгоход тусалж ийн хэлсэн юм: “Засаж залруулан, наманчлахаас бэлтгэж, урьдчилан сэргийлэх нь дээр” гэсэн эртний нэгэн зүйр үг

байдаг. Ямар үнэн үг вэ. . . Бид өөрсдийгөө ёс суртахууны хувьд цэвэр ариун байлгаж, хамгаал- хын тулд хамгийн түрүүнд хийх зүйл бол уруу татал- тыг эсэргүүцэж, гэм нүгэлд өртөхөөс сэргийлэхэд бэлтгэх явдал юм” (“The Law of Chastity,” in *Бригам Янгийн Их Сургууль, 1987–88 Devotional and Fireside Speeches* [1988], 51; speeches.byu.edu).

Нифайчууд наманчлалаа хойшлуулахаар шийдсэн нь тэднийг гай зовлон, сүйрэлд хүргэнэ гэж Самуел заажээ. Мормоны Номын бусад номууд хувь хүмүүс наманчлалын сүнс тэднийг орхин одох хүртэл эсэргүүцэл ба ёс бус явдлаа үргэлжлүүлсээр байдгийг заадаг. Тухайлбал Лемен, Лемуел хоёр Бурханыг сонсохгүй байснаас “мэдрэхээс өнгөрсөн” билээ (1 Нифай 17:45). Бид наманчлалаа хойш тавихгүй байх нь яагаад чухал болохыг ийм жишээнүүд харуулдаг. Бид наманчлалаар дамжуулан аливаа зүйлийг засч залруулж, гэм нүгэл болон уруу таталтууд Бурханыг дагах бидний хүслийг давамгайлахаас сэргэмжилж чадна.

Хэрэв та буруу замаар орсон бол амьдралдаа зөв замыг дахин олж авч чадна гэдгийг ойлгохын тулд Тэргүүн Зөвлөлийн Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорфын дараах үгсийг унш:



Нисэх онгоцны ахмад болох сургалтын- хаа явцад би онгоцыг хэрхэн нисгэж, холын зайг хэрхэн туулдгийг сурах шаардлагатай байлаа. Хязгааргүй их далай, өргөн уудам цөлийн дээгүүр тив алгасан хийдэг нислэгийг зорьсон

газарт нь эсэн мэнд хүргэхийн тулд ихэд анхаарал- тай, нягт нямбай төлөвлөх хэрэгтэй байдаг. Буулгүй нисдэг ийм нислэгүүдийн зарим нь 14 хүртэл цаг үргэлжилж, 9000 бээр (14000 км) замыг туулдаг.

Ийм урт нислэгийн үед *аюулгүйгээр эргэж ирэх цэг гэж нэрлэгддэг чухал шийдвэр гаргах үе байдаг*. Нисэх онгоц энэ цэгт хүрчихээд буцах замдаа орж, ниссэн буудалдаа эргэж ирэхэд хангалттай түлштэй байх ёстой. Аюулгүйгээр эргэх цэгийг өнгөрөөсний да- раа ахмад энэ үйлдлийг дахин хийхгүй болж, зүгээр л цаашаа ниснэ гэсэн үг. Энэ цэгийг *эргэлтгүй цэг* гэж олонтоо нэрлэдэг нь ийм учиртай юм.

“. . . Сатан биднийг нүгэл үйлдсэн л бол замаа өөрч- лөхөд нэгэнт оройтож, өнгөрсөн борооны хойноос цув нөмрөхтэй адил ‘буцах гарцгүй’ болсон гэж бодуулахыг хүсдэг. . . .

“. . . Сатан биднийг найдвараа алдаж, түүний нэ- гэн адил гутарч, уучлагдахаасаа өнгөрсөн бөгөөд нигүүлсэл байхгүй гэж итгүүлэхийн тулд Бурханы шударга ёсыг онцолсон судрын үгсийг буруугаар ашиглаж ч болох юм. . . .

“Христ биднийг аврахаар ирсэн билээ. Хэрэв бид буруу замаар орсон бол нүгэл нь эргэх гарцгүй цэг *биш юм* гэдэг итгэлийг Есүс Христийн Цагаатгал бидэнд өгч чадна. Хэрэв бид өөрсдийнхөө авралд зориулагдсан Бурханы төлөвлөгөөг дагавал аюул- гүйгээр эргэх зам бидэнд боломжтой” (“Point of Safe Return,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2007 оны 5-р сар, 99).

Их нүгэл үйлдэж, “эргэлтгүй цэг”-ээс хэтэрсэн гэж боддог хүмүүст Ерөнхийлөгч Угдорфын хэлсэн үг хэрхэн найдвар төрүүлж болох вэ? _____

Хиламан 14

Самуел Аврагчийн төрөлт ба үхлийн тэмдгүүдийг бошиглосон нь

Саяхан танай улсаас өөр газар болсон, дэлхий да- хины анхаарлыг татсан нэг үйл явдлыг бод. Байга- лийн гамшиг, дайн дажин зэрэг дэлхийн өөр хэсэгт болж байгаа үйл явдлуудыг хүмүүс хэрхэн олж мэддэг вэ? Яагаад хүмүүс дэлхийн өөр хэсэгт болж байгаа үйл явдлуудыг мэдэхийг хүсдэг вэ?

Самуел Зарахемлагаас хол орших газарт тохиох Аврагчийн төрөлт ба үхлийн талаар бошигложээ. Хиламан 14:3–6-г уншаад Есүс Христийн төрөлтийн тэмдгүүдийг судартаа тэмдэглэ. Хиламан 14:20–27-г судлаад, Есүс Христийн үхлийн тэмдгүүдийг судар- таа тэмдэглэ.



3. Самуел эдгээр бошиглоуудыг хэлж байхад та тэнд байж, бошиглохыг нь сонссон бол хэрхэн хандах байснаа судар судлах тэмдэглэлдээ бич. Өгөгдсөн бүх тэмд- гүүдээ аль нь таныг наманчлах хэрэгтэйгээ ойлгоход хам- гийн ихээр нөлөөлөх байсан гэж та бодож байна вэ?

Эдгээр тэмдгүүд сургамжтай бөгөөд бэлгэдлийн шинжтэй юм. Есүс Христийг дэлхийд ирэхэд гэрэл гэгээ нэмэгдсэн. Харин Түүнийг нас барахад харан- хуй нэмэгдсэн. Бид Түүнийг зүрх сэтгэлдээ оруула- хыг зөвшөөрөх болон оруулахгүй байхаар шийдэхэд мөн дээрхтэй адил зүйлс бидний амьдралд тохиодог.

Хиламан 14:11–13-ыг уншаад Самуел нифайчуудад номлох болсон зорилгыг олж мэд. Нифайчуудыг мэдэж, мөн хийгээсэй гэж Самуелын хүссэн зүйл- сийг судартаа дугаарлах хэрэгтэй. (13-р шүлэг дэх “түүний сайн үйлсээр” гэсэн хэллэг нь Есүс Хри- стийн Цагаатгалаар гэсэн утгатай.) **Есүс Христэд итгэх итгэл нь наманчлал ба нүглийн уучлалд хүргэдгийг бид эдгээр шүлгүүдээс сурч болно.**

Хиламан 14:28–29-ийг уншаад Их Эзэн яагаад тэмдгүүд болон гайхамшгуудыг өгдгийг олж мэд. Бидний сурах нэг үнэн бол: **Их Эзэн Өөрт нь**

ИТГЭХЭД ХҮМҮҮСТ ТУСЛАХЫН ТУЛД ТЭМДГҮҮД БОЛОН ГАЙХАМШГУУДЫГ ӨГДӨГ. Есүс Христэд итгэхэд тань тусалдаг тэмдгүүдийг (нотолгоонууд) бод.

Та Самуелын бошиглосон тэмдгүүдийг судлахдаа, Их Эзэн зөв шударга хүмүүст итгэж наманчлахад нь туслахын тулд тэмдгүүдийг өгдөг байхад ёс бусчууд амин хувиа бодсон шалтгааны улмаас тэмдгүүдийг хайж, шаарддаг гэдгийг санах нь чухал (С ба Г 46:9-ийг үзнэ үү). Их Эзэний нас баралт болон Түүний Хоёр дахь ирэлтийн тэмдгүүдийг мэдэх нь чухал боловч Есүс Христийн нас баралт ба амилалтын ач холбогдлын талаарх Самуелын заасан зүйлсийг мэдэх нь нэн чухал юм.


Хиламан 14:15–19-ийг анхааралтай уншаад доорх жишиг зургийг судал.

Хиламан 14:15–19-ийг уншиж, жишиг зургийг судалсны эцэст дараах санаануудыг эргэцүүлэн бод:

- Бид Тэнгэрлэг Эцэгийн оршихуйгаас тусгаарлагдсан учир мөнх бус амьдралд төрөх нь сүнсний үхэлд тооцогдож болох юм.
- Есүс Христ Өөрийн үхэл ба Амилалтаар, **бүх хүн төрөлхтнийг Уналтаас гэтэлгэсэн учир бид Бурханы оршихуйд эргэн очиж чадна.**
- Есүс Христийн Цагаатгалаар бүх хүн төрөлхтөн шүүгдэхийн тулд Бурханы оршихуйд буцаан авчрагдана.

- Эцсийн шүүлтэд наманчлахаас цаашид татгалзсан хүмүүс сүнсний өөр нэг үхлийг амсаж, Бурханы оршихуйгаас үүрд тусгаарлагдах болно.
- **Есүс Христ биднийг наманчлалын нөхцөлөөр сүнсний үхлээс гэтэлгэсэн юм.**


Сая уншсан тодоор бичсэн сургаалуудтай холбоотой хэллэгүүдийг Хиламан 14:15–19-р шүлгүүдэд тэмдэглэ. Хиламан 14:30–31-ийг уншиж, хичээлээ дуусга.

 **4.** Найздаа бидний энэ амьдрал дахь сонголтууд маш чухал гэдгийг тайлбарлахдаа Хиламан 14:30–31-ийг хэрхэн ашиглахыг судар судлах тэмдэглэлдээ бич.

 **5.** Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Хиламан 13–14-р бүлгүүдийг судалж энэ хичээлийг ((огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:



Хиламан 15–16

Оршил

Зарахемла дахь хэрэм дээрээс лемен үндэстэн Самуел нифайчуудад хандан хэлэхдээ, тэд наманчлахгүй бол Бурхан “тэднийг бүрмөсөн устгах болно” гэж бошиглосон билээ (Хиламан 15:17). Тэрээр леменчүүд нифайчуудаас илүү зөв шударга болсон бөгөөд Их Эзэн леменчүүдийн амьдралыг уртасгана гэдгийг тунхаглажээ. Зарим нифайчууд Самуелын заасан зүйлсэд итгэж, Нифай тэдэнд баптисм хүртээв. Самуелд итгээгүй бусад нь түүнийг алах гэж оролдов. Тэр Бурханы хүчээр хамгаалагдаж, эх нутагтаа буцав.

Хиламан 15

Самуел нифайчуудад анхааруулж, леменчүүд яагаад амлалтын хүмүүс болсон тухай тайлбарлав

Дараах үйл явдлууд нь хоёр залуугийн тухай зохиомол түүх юм:

Нэг залуу эрэгтэйн эцэг эх Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүд биш бөгөөд Есүс Христийн сургаалуудыг онцлон үздэггүй байв. Тэд өсвөр насны хүүгээ согтууруулах ундаа хэрэглэхийг зөвшөөрдөг байсан бөгөөд хүү нь энэ зуршлаа коллежид байхдаа ч үргэлжлүүлжээ. Хожим нь тэр Хожмын Үеийн Гэгээнтэн номлогчидтой уулзав. Тэр номлогчидтой хэдэн удаа уулзсаны дараа согтууруулах ундаа хэрэглэхээ зогсооно гэж амлажээ. Хэдэн өдрийн дараа тэр хэсэг найзуудтайгаа хамт байв. Тэд түүнд согтууруулах ундаа уухыг санал болгосон гэнэ.

Өөр нэг залуу эрэгтэй Хожмын Үеийн Гэгээнтэн гэр бүлд өсчээ. Эцэг эх нь гэр бүлийн үдшийг тогтмол хийж, гэр бүлээрээ судар судалдаг байлаа. Тэр өдөр бүр судар судалж, хувиараа залбирдаг хэвшилтэй болсон ажээ. Тэр Хүүхдийн хэсэгт явж, Аароны санваарын чуулгуудад үйлчилж, семинар төгссөн байна. Тэр Есүс Христийн сайн мэдээ болон Бурханы зарлигуудыг мэддэг мөн ойлгодог байв. Коллежид байхдаа тэр шинэ найз нөхөдтэй болжээ. Нэг орой хэсэг найзууд нь түүнд согтууруулах ундаа санал болгосон гэнэ.

Тухайн нөхцөлд энэ хоёр залуу эрэгтэйн сүнслэг хүч чадлын түвшинг авч үзэж, үүнийг Хиламан 15-р бүлгээс сурсан леменчүүд болон нифайчуудын сүнслэг хүч чадалтай харьцуул.



1. Дараах асуултуудад судар судлах тэмдэглэлдээ хариулж бич:

а. Хиламан 15:3, 17-д цэдэглэснээр нифайчуудын сүнслэг байдал ямархуу байсан бэ?

б. Хиламан 15:4–8-д цэдэглэснээр леменчүүдийн сүнслэг байдал ямар байсан бэ? (Хиламан 15:5-д *сонор сэрэмжтэй* гэдэг үг “болгоомжтой” эсвэл “анхааралтай” байх гэсэн утгатай.)

Леменчүүд хэдийгээр “эцэг өвгөдийнх нь уламжлалын алдсын учир” урт удаан хугацааны ёс бус явдлын түүхтэй ч тэд үнэний мэдлэгт ирж, наманчилж, “сүсэг бишрэлдээ чанд гуйвшгүй” (Хиламан 15:4, 8) болсон байлаа. Үүний эсрэгээр нифайчууд бардамналаар дүүрэн болж, сайн мэдээний үнэнүүдээс татгалзсан юм.

Хиламан 15:7–8-ыг анхааралтай уншаад дараах өгүүлбэрийн хоосон зайг нөхөж бич: Үнэний мэдлэг ба ариун судруудад итгэх итгэл нь _____ ба _____-д хөтлөх ба энэ нь _____ авчирна; тиймээс, үүнд аль болох олон хүн ирснээр _____.

Леменчүүд судруудыг судалж, итгэснээр үнэнийг мэдэж, Есүс Христэд итгэх итгэлийг хөгжүүлсэн нь тэднийг наманчлалд хүргэжээ. Тэд зүрх сэтгэлийн өөрчлөлтийг мэдэрч, сүсэг бишрэлдээ чанд гуйвшгүй болсон.



2. Дараах асуултуудын аль нэгэнд судар судлах тэмдэглэлдээ хариулж бич:

а. Судруудыг судалсан нь хэзээ танд амьдралдаа шаардлагатай өөрчлөлтүүдийг хийхэд тусалсан бэ?

б. Итгэлтэйгээр судар судлах дадал хэн нэгэнд зүрх сэтгэлийн өөрчлөлт гаргахад хэрхэн тусалдаг гэж та бодож байна вэ?

Самуелын заасан зүйлс олж авсан итгэл болон мэдлэгтээ үнэнч үлдэхийн ач холбогдлыг ойлгоход бидэнд тусалдаг. Хиламан 15:14–17-г уншаад сайн мэдээний дараах зарчмыг харуулсан хэллэгүүдийг ол: **Хэрэв хүмүүс сайн мэдээний бүрэн байдлыг хүлээн авсныхаа дараа үл итгэгчид болох юм бол тэд илүү хүндээр шийтгэгдэх болно.** Энэхүү үнэнийг судартаа холбогдох шүлгүүдийнх нь дэргэд бич. Та мөн *С ба Г 82:3*-ыг холбогдох эшлэл болгон судрынхаа захад бичиж болно.

Таны амьдралд энэ зарчим хэрхэн хэрэгждэг вэ? Ямар нэгэн зүйлийг үнэн гэдгийг нь мэдсэн мөртлөө санаатайгаар үүний эсрэг үйлдэл хийсэн тохиолдол танд бий юу? Та Аврагчид итгэх итгэлээ хүчирхэгжүүлж, наманчилж, сайн мэдээний үнэнд чанд тууштай байхын тулд юу хийх хэрэгтэй вэ?

Хиламан 16

Самуелд итгэсэн хүмүүс баптисм хүртэж, бусад нь зүрх сэтгэлээ хатууруулав

Та амьд бошиглогчид болон төлөөлөгчдийн үгсэд ихэвчлэн хэрхэн хариулдгаа эргэцүүлэн бод. Лемен үндэстэн бошиглогч Самуелын үгсийг хүлээн авах боломж нифайчуудад олджээ. Хиламан 16:1–7-р шүлгүүдээс сурч мэдсэн зүйлээ хүмүүсийн итгэсэн зүйлс болон нифайчуудын хэрхэн хариулсныг харуулах дараах хүснэгтийг бөглөхөд ашигла.

Хиламан 16	Нифайчуудын энэ бүлэг итгэсэн үү?		Эдгээр хүмүүс бошиглогч Самуелын үгсэд хэрхэн хариулсан бэ?
	Тийм	Үгүй	
1-р шүлэг			
2-р шүлэг			
3–5-р шүлэг			
6–7-р шүлэг			



3. Дараах асуултуудад судар судлах тэмдэглэлдээ хариулж бич:

а. Өнөө үед зарим залуу хүмүүс яагаад уурлаж, бошиглогчдын зөвлөгөөг эсэргүүцдэг гэж та бодож байна?

б. Бусад хүмүүс эсэргүүцэж байсан ч бошиглогчийн зөвлөгөөг дагахыг сонгосон хэн нэгнийг та хэзээ харсан бэ?

в. Эргэн тойрны хүмүүс тань эсэргүүцэж байхад, та хэзээ бошиглогчийн зөвлөгөөг дагхаар сонгосон бэ?

г. Та Хиламан 16:13–14-р шүлгүүдээс бошиглогчдын үгсийн тухай юу сурав?



Дэлхийн хүмүүс өнөө үеийн бошиглогчдын талаар юу гэж үздэг талаар Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсоны хэлсэн дараах үгсийг тунгаан бод: “Бошиглогч нь дэлхий дээр эсвэл дэлхийн хүмүүсийн дунд нэр хүндтэй байх шаардлагагүй. Бошиглогч үнэнийг илчлэхэд хүмүүс хоёр хуваагддаг. Зүрх сэтгэлдээ шударга хүмүүс түүний үгсийг анхаардаг бол зөв шударга бус хүмүүс бошиглогчийг нэг бол үл ойшоох эсвэл түүнийг эсэргүүцдэг. Бошиглогч дэлхийн гэм нүглийг онцлон хэлэхэд дэлхийн хүмүүс нүглээ наманчлахын оронд бошиглогчийн амыг таглахыг хүсэх эсвэл бошиглогч байдаггүй мэтээр авирладаг. Алдар нэр нь хэзээ ч үнэний шалгуур байдаггүй. Олон бошиглогчид алагдаж эсвэл хөөн зайлуулагдсан. Бид Их Эзэний Хоёр дахь ирэлтэд ойртох тусам, дэлхийн хүмүүс илүү их ёс бус болж, бошиглогч тэдний дунд улам нэр хүндгүй болно гэдгийг та хүлээж болно” (*The Teachings of Ezra Taft Benson* [1988], 133).

Үл итгэгчид бошиглоруудын биелэлт ба тэнгэрийн тэмдгүүдийг эсэргүүцдэг шалтгаанаа хэрхэн зөвтгөдгийг Хиламан 16:16–21-р шүлгүүдийг уншаад олж мэдээрэй. Бошиглогчдын эсрэг тэдгээр шалтаг болон маргаануудаас аль нь өнөө үед хамгийн түгээмэл гэж бодож байгаагаа судартаа тэмдэглэ.

Хиламан 16:23-ыг уншаад Их Эзэний гэрчүүдийг эсэргүүцдэг хүмүүст юу тохиолддогийг судартаа эсвэл судар судлах тэмдэглэлдээ бич. Таны бичсэн өгүүлбэр дараах зарчимтай төстэй байж болно: **Бид Их Эзэний гэрчүүдийг эсэргүүцсэнээр Сатанд зүрх сэтгэлээ захируулахыг зөвшөөрдөг.**



Тэргүүн Зөвлөлийн Ерөнхийлөгч Хэнри Б.Айрингийн хэлсэн дараах үгсийг уншаад Хиламан 16-аас сурсан зүйлсийг тань батлах үгсийг тэмдэглэ: “Бид Бурханы зөвлөгөөг эсэргүүцсэнээр гадны нөлөөнөөс хамааралгүй байж чаддаггүй. Бид өөр нөлөөг сонгодог. Бид ингэснээрээ бүхнийг чадагч, бүхнийг мэдэгч, биднийг төгс хайрлагч Тэнгэрлэг Эцэгийнхээ хамгаалалтаас татгалздаг. Түүний туйлын зорилго нь Хүүгийнхтэйгээ яг адил бидэнд мөнх амьдралыг мөн Өөртөө байгаа бүхнийг өгч, биднийг гэр бүлээр нь

тэнгэрлэг гэртээ буцаан аваачиж, хайрын мутартаа тэврэх явдал юм. Бид Түүний зөвлөгөөг эсэргүүцсэнээр Сатаны нөлөөг сонгодог. Сатаны зорилго нь биднийг олиггүй муухай болгох явдал бөгөөд түүний хөдөлгөгч хүч нь үзэн ядалт юм. Бурханы бэлэг болох ёс суртахууны сонгох эрх бидэнд бий. Энэ нь аливаа нөлөөнөөс ангид байхыг сонгох эрх гэхээс илүүтэйгээр аль нэг сонгосон хүчинд нь захирагдах салшгүй эрх юм" ("Finding Safety in Counsel," *Ensign*, 1997 оны 5-р сар, 25).

Бид өөрсдийн амьдрал дахь Бурханы нөлөөг эсэргүүцвэл юу тохиолддог гэж Ерөнхийлөгч Хэнри Б.Айринг хэлсэн бэ? Бид Бурханы нөлөөг эсэргүүцвэл Сатаны нөлөөнд ордгийг ойлгох нь яагаад чухал вэ?

Та бошиглогчид болон төлөөлөгчдийн зөвлөгөөний эсрэг зүрх сэтгэлээ ямар нэгэн байдлаар хатууруулсан эсэхээ эргэцүүлэн бод. Тэд юу заадаг талаар болон тэдний зөвлөгөөг хэрхэн хүлээн авах тухай бодохдоо *Залуучуудын бат бөх байдлын төлөө*

товхимлыг дахин уншвал тустай. Сайн мэдээгээр амьдрах болон Их Эзэний бошиглогчдын зөвлөгөөнд анхаарал хандуулахдаа чанд тууштай байхын тулд юу хийхээ өнөөдөр шийд.



4. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Хиламан 15–16-р бүлгүүдийг судалж энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

3 Нифайн

ОРШИЛ

Яагаад энэ номыг судлах хэрэгтэй вэ?

Та 3 Нифайг судалснаар Мормоны Номын хүмүүсийн дунд хийсэн Аврагчийн үйлчлэлийн үгс болон үйлдлүүдээс суралцах болно. Сүмийн удирдагчид 3 Нифайг бидний Их Эзэний “тав дахь сайн мэдээ” гэж нэрлэдгийн учир нь Шинэ Гэрээн дэх дөрвөн сайн мэдээний адил энэ ном Есүс Христийн сургаал болон үйлчлэл дээр голлон төвлөрсөнд оршдог (Гордон Б.Хинкли, “The Cornerstones of Our Faith,” *Ensign*, 1984 оны 11-р сар, 52-ыг үзнэ үү). Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон ингэж заажээ: “3 Нифай бүх судруудын хамгийн их сэтгэл хөдөлгөм, хүчирхэг хэсгүүдийн заримыг агуулдаг. Энэ нь Есүс Христ, Түүний бошиглогчид болон авралын сургаалуудыг гэрчилдэг” (“The Savior’s Visit to America,” *Ensign*, 1987 оны 5-р сар, 6). Та Есүс Христ хүмүүст “нэг нэгээр” (3 Нифай 11:15; 17:21-р шүлгүүд) нь өрөвч энэрэнгүй сэтгэлээр хандсаныг хараад Тэрбээр таны төлөө хэрхэн санаа тавьдгийг илүү сайн ойлгох болно. Зарим хүмүүс өөрсдийгөө гайхамшигт адислалуудыг хүртэх боломжгүй болгож байхад зарим нь Аврагчтай уулзахаар өөрсдийгөө хэрхэн бэлтгэдгийг мэдэж авснаар та чухал сургамжууд сурах болно.

Энэ номыг хэн бичсэн бэ?

Мормон Нифайн их ялтсуудын цэдгүүдийг хураангуйлж 3 Нифайн номыг бүтээжээ. Энэ ном нь Аврагч хүмүүс дээр хүрч ирэхээс өмнөх үе мөн тэдэн дээр хүрч ирсэн болон түүнээс хойших үеийн туршид хөдөлмөрлөсөн Нифайн хүү Нифайн нэрээр нэрлэгдсэн юм. Есүс Христийн айлчлалын өмнөх олон ёс бус явдлын үеэр Нифай “хүчтэйгээр мөн асар их эрх мэдэлтэйгээр” (3 Нифай 7:17) үйлчилсэн ажээ. Хэдий тийм ч Нифайн үйлчлэл нь Есүс Христийн үйлчлэлийн зөвхөн оршил нь байсан бөгөөд Түүний үгс болон үйл хэрэг 3 Нифайн гол хэсгийг бүрдүүлдэг. Мормон Нифайн цэдгүүдийг хураангуйлахдаа өөрийн тайлбар болон гэрчлэлийг энэ номд мөн нэмсэн байна (3 Нифай 5:8–26; 26:6–12; 29–30-ийг үзнэ үү).

Энэ ном хаана, хэзээ бичигдсэн бэ?

3 Нифайн номыг бичихэд ашигласан эх цэдгүүдийг мээ 1-ээс мээ 34 оны үед бичсэн байх магадлалтай бөгөөд Мормон эдгээр цэдгүүдийг мээ 345-аас мээ 385 оны хооронд хураангуйлсан байна. Мормон энэ номыг хаана эмхэтгэсэнээ бичээгүй.

24-Р ХЭСЭГ: 1 ДЭХ ӨДӨР

3 Нифай 1

Оршил

Бошиглогч Нифай (Хиламаны хүү) уг нутгаас гарч явахынхаа өмнө, цэдгүүдийг ууган хүү Нифайдаа шилжүүлэн өгөв. Үл итгэгчид Есүс Христийн төрөлтийн тухай бошиглол нэгэн өдөр биелэхгүй бол итгэгчдийг ална хэмээн сэм хуйвалдацгаав. Нифай итгэгчдийн өмнөөс Их Эзэнээс гуйхад Их Эзэний дуу хоолой түүн дээр ирж Түүний төрөлтийн тэмдэг тэр шөнө үзэгдэх болно гэжээ. Лемен үндэстэн Самуелын бошиглол биелэгдэж, нар жаргахад харанхуй болоогүй бөгөөд шинэ од гарч ирэв. Хүмүүсийн итгэлийг устгах гэсэн Сатаны оролдлогууд үргэлжилж байсан ч “хүмүүсийн ихэнх хэсэг нь итгэж, мөн Их Эзэнд хөрвүүлэгдэв” (3 Нифай 1:22).

3 Нифай 1:1–26

Есүс Христийн төрөлтийн тухай бошиглолууд биелж, олон нифайчууд хөрвөгджээ

Судруудад эсвэл сүмийн түүхэнд гардаг, Есүс Христийн сайн мэдээний төлөө амиа золиосолсон зарим хүмүүсийн тухай бод. Тэд яагаад ийм золиослол хийх хүсэлтэй байсан гэж та бодож байна?

3 Нифай 1-р бүлэгт цэдэглэгдсэнээр итгэлтэй нифайчуудын бүлэг итгэлдээ үнэнч үлдэхийн тулд амь насаа ч өгөхөд бэлэн байгаа эсэхээ шийдэх хэрэгтэй болсон юм. Уг бүлэг нь Нифай ариун цэдгүүдийг мөн Нифай гэдэг хүүдээ өгөөд уг нутгаас гарч явсныг тайлбарласнаар эхэлдэг (3 Нифай 1:1–3-р шүлгүүдийг үзнэ үү). Тэгээд цааш үргэлжилж олон нифайчуудын итгэлийг сорьсон үйл явдлуудын тухай өгүүлдэг.

3 Нифай 1:4–9-ийг уншаад итгэлтэй нифайчуудад тулгарсан сорилтын нөхцөлийг ол. Хэрэв та өөрийгөө Нифай байсан гэж төсөөлөхөд итгэгчид устгагдах цаг ирвэл танд ямар мэдрэмж төрөх байсан бэ? Ийм нөхцөлд зарим хүмүүсийн хувьд итгэлтэй хэвээр үлдэхэд яагаад хэцүү байж болохыг түр зуур тунгаан бод.

3 Нифай 1:10–12-ыг уншаад Нифай энэхүү шийдвэрлэх үед юу хийснийг олж мэд. 3 Нифай 1:13–14-р шүлгүүд дэх Нифайд өгсөн Их Эзэний хариултыг унш. 3 Нифай 1:13-р шүлэг дэх дараах зарчмыг тэмдэглэж ав: **Их Эзэн бошиглогчдоороо яриулсан Өөрийн бүх үгсийг биелүүлэх болно.**



1. Аврагчийн төрөлтийн тэмдгүүд өгөгдсөн даруйд Нифайд ямархуу байсныг төсөөлөн бодохыг хичээ. Та тэр үед тэнд байсан бол яах байснаа судар судлах тэмдэглэлдээ бич. Хэрэв та өөрийгөө Нифай байсан гэж төсөөлөхөд тэрхүү тэмдэг саяхан үзэгдсэн бол танд ямар санагдах байсан гэж та бодож байна?

Судруудыг бичсэн хүмүүсийн оронд өөрийгөө тавьж бодох нь

Бригам Янг нэгэнтээ “Та судруудыг уншихдаа өөрийгөө тэдгээрийг бичсэн хүмүүсийн оронд тавьдаг уу? гэж асуужээ. . . . Та ингэснээрээ Бурханы бичигдсэн үгсийн сүнс болоод утгыг өдөр тутмынхаа ажил үйлс, яриа хөөрөө мэт сайн ойлгох онцгой боломжтой байдаг билээ” (*Teachings of Presidents of the Church: Brigham Young* [1997], 119).

3 Нифай 1:4, 14–15, 19–21-р шүлгүүдийг уншаад Их Эзэний бошиглогчдынхоо үгсийг биелүүлдэг тууштай байдлыг онцолсон нэмэлт хэллэгүүдийг хайж ол. (Эдгээр хэллэгүүдийг судартаа тэмдэглэж болно.) Та 3 Нифай 1:14-ийг уншихдаа уг шүлэгт ярьж буй хүн: Иехова (эрх мэдлийн бурханлаг албын дагуу Эцэг), тун удахгүй Бурханы мөнх бус Хүү болох Есүс Христ гэсэн хоёр хүнийг төлөөлөн ярьж байгааг ойлгох хэрэгтэй.

Аврагчийн төрөлтийн тухай бошиглолууд яаж биелсэнийг харахын тулд Лемен үндэстэн Самуелын өгсөн бошиглолыг дараах хүснэгтийн зүүн багананд бич. Тэгээд баруун багананд 3 Нифай 1-р бүлгээс тухайн шүлгийг болон үүний биелэлтийг товчхон бич.

Лемен үндэстэн Самуелын бошиглолууд	Биелэлт
Эхний бошиглол (Хиламан 14:3–4):	3 Нифай 1:
Хоёр дахь бошиглол (Хиламан 14:5):	3 Нифай 1:
Гурав дахь бошиглол (Хиламан 14:6):	3 Нифай 1:
Дөрөв дэх бошиглол (Хиламан 14:7):	3 Нифай 1:

3 Нифай 1:16–18-ыг уншихдаа тэмдгүүдийг тохиоход ёс бусчууд ямар хариу үйлдэл үзүүлснийг ажигла. Тэдний хариу үйлдлийн заримыг тэмдэглэ. Бид 3 Нифай 1:18-аас зарим хүмүүс “тэд өөрсдийн алдас мөн итгэлгүйнхээ учир айж эхэлсэн” гэдгийг хардаг. Дараах асуултыг тунгаан бод: Гэм нүгэл болон итгэлгүй байдал хэрхэн айдас төрүүлдэг вэ?

3 Нифай 1:22–23-ыг уншаад Их Эзэний төрөлтийн тэмдгүүд өгөгдсөний дараа чөтгөр юу хийх гэж оролдсоныг олж мэд. 22-р шүлэг дэх зарчмыг харуулсан дараах өгүүлбэрийг гүйцээн бич: **Бид Сатаны худал хуурмаг үгтэй тулгарсан үедээ** _____


-г сонгож чадна.

Тэргүүлэх Бишопын зөвлөлд үйлчилсэн бишоп Ричард К.Эжли, бид итгэлийн шалгуурынхаа үед хэрхэн хариу үйлдэл үзүүлэх талаар зөвлөгөө өгчээ. Сатан эргэлзээ төрүүлж, уруу татлаа ч гэсэн итгэхийг сонгохыг танд урамшуулах түүний үг хэллэгүүдийг тэмдэглэ.



“Өнөө үед дэлхий дээр бидэнд тулгардаг зөрчилдөөн, сорилт бэрхшээлүүдийн улмаас би хүн бүрд тохирох нэгэн сонголтыг буюу амар амгалан ба хамгаалалтын сонголтыг санал болгохыг хүсч байна. Тэр сонголт нь итгэл юм. Итгэл нь бодол санаа, хүсэл эрмэлзэл, хүч чармайлтгүйгээр өгөгдсөн үнэгүй бэлэг биш гэдгийг мэдэгтүн. . . Аврагч ‘Над руу ир’ (Матай 11:28) мөн ‘Тогш, тэгвэл танд [нээгдэнэ]’ (Матай 7:7) гэж хэлсэн билээ. Эдгээр *ир, тогш гэсэн үгс нь үйл үгс бөгөөд* сонголтууд юм. Тиймээс би итгэлийг сонго гэж хэлж байна. Эргэлзээний оронд итгэлийг сонго, айдсын оронд итгэлийг сонго, тодорхойгүй бөгөөд харагдахгүй байгаа зүйлсийн оронд итгэлийг сонго, гутранги үзлийн оронд итгэлийг сонго. . . .

“ . . . Логик, учир шалтгаан эсвэл хувь хүний оюун ухаан ариун сургаал болон номлолтой зөрчилдөхөд, эсвэл зөрчилтэй захиас та нарын итгэл бишрэлийг дайран довтлох үед . . . [итгэлийн] үрийг зүрх сэтгэлээсээ итгэлгүйн улмаас авч хаяхгүй байхыг *сонгоорой*. Бид итгэлийнхээ сорилтын дарааг хүртэл гэрчийг хүлээн авахгүй гэдгийг санагтун (Ифер 12:6-г үзнэ үү)” (“Итгэл—Сонголт нь таных,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2010 оны 11-р сар, 31–33).

 **2.** Хүмүүсийн зүрх сэтгэлийг үнэний эсрэг хатууруулахын тулд чөтгөр өнөө үед ямар худал хуурмаг зүйл, заль мэхийг илгээдэг вэ? Хэдийгээр чөтгөр таны итгэлд эргэлзээ төрүүлэхийг хичээсэн ч Есүс Христэд болон Түүний сэргээгдсэн сайн мэдээнд итгэх итгэлээ хамгаалж үлдэхийн тулд юу хийж чадахаа судар судлах тэмдэглэлдээ бич.

3 Нифай 1:24–25-ыг уншаад итгэгчдийн заримд нь тулгарсан нэмэлт сорилтуудыг олж мэд. Эдгээр хүмүүс буруу байснаа мэдээд хийсэн хариу үйлдлээ та юу сурч болохыг тунгаан бод.


3 Нифай 1:27–30

Нифай үндэстэн урвагчид болон Лемен үндэстэн өсвөр үеийнхэн Гадиантоны дээрэмчидтэй нэгдсэн нь

Есүс Христийн төрөлтийн тэмдэг үзэгдсэнээс хойш хэдэн жилийн дараа, зарим нифай үндэстэн урвагчид сайн мэдээнд баттай зогсох хүмүүсийн чадварт нөлөөлж эхэлжээ. Сүмийг дайрч давшилж байгаа өнөө үед та сайн мэдээнд хэрхэн бат бөх зогсож чадах вэ? 3 Нифай 1:27–30-ийг уншаад леменчүүдийн “залуу үеийнхэн” бусдын итгэлд сайн нөлөө эсвэл муу нөлөө үзүүлсэн эсэхийг олж мэд.


Лемен үндэстэн өсвөр үеийнхний ихэнх нь “бие даах болж” (3 Нифай 1:29), сайн мэдээнээс хазайн оджээ. Халамжийн Нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлд үйлчилсэн Катлийн Х.Хюс эгч “бие даах болсон” гэсэн хэллэг ямар утгатайг ийн тайлбарлажээ: “[Энэ] нь миний ойлгосноор тэд өөрсдийгөө эн түрүүнд анхаарч, бошиглогчдын зайлсхийхийг анхааруулсан хүслүүдээ хойш тавьсныг илэрхийлдэг. Тэд Сатаны өгөөш болон уруу таталтуудад бууж өгсөн юм” (“Grow Up unto the Lord,” *Ensign*, 2010 оны 2-р сар, 18).

Дараах зарчмыг судартаа 3 Нифай 1:29–30-ийн хажууд эсвэл судар судлах тэмдэглэлдээ бич: **Хэрэв бид уруу таталтад автвал бидний үлгэр дуурайл бусдын итгэл болон зөв шударга байдалд муу нөлөө үзүүлдэг.**

 **3.** Энэ зарчим танд ямар хамааралтай болохыг ойлгохын тулд дараах асуултуудад судар судлах тэмдэглэлдээ хариулж бич:

а. Та дээрх зарчмын жишээг харж байсан уу? Таны эргэн тойрон дахь хүмүүс итгэлтэй байхыг сонгохгүй байсан ч та яаж итгэлтэй хэвээр үлдэх вэ?

б. Бидний үлгэр дуурайл бусдад муу нөлөө үзүүлж болохыг мэдэх нь чухал ч бидний үлгэр дуурайл хэн нэгнийг хүчирхэгжүүлэхэд тусалж болохыг санах нь мөн адил чухал юм. Өнөөдөр “залуу үеийнхэн” эсвэл сүмийн өсвөр насныхан бусдын итгэлд сайн нөлөө үзүүлж байгааг та хэзээ харсан бэ?

 **4.** Та гэр бүл, тойрог эсвэл салбар, эсвэл үеийнхний хээ итгэлд сайн нөлөө үзүүлэх арга замуудаас судар судлах тэмдэглэлдээ жагсаан бич. Жагсаалтаасаа хоёр санааг сонгож, тэдгээрийг хэрэгжүүлэхийн тулд юу хийхээ тодорхой бич.

 **5.** Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би 3 Нифай 1-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

24-Р ХЭСЭГ: 2 ДАХЬ ӨДӨР

3 Нифай 2–5

Оршил

Хүмүүс Есүс Христийн төрөлтийн тэмдгүүдийг харснаасаа хойш тун удалгүй хүлээн авсан гэрчүүдээ мартаж эхэлсэн бөгөөд тэдний зүрх сэтгэл хатуурчээ. Нифайчууд ба леменчүүдээс олон нь ирж буй тэмдгүүд болон гайхамшгуудыг эсэргүүцэж, ёс бус явдал газар авчээ. Үүний уршгаар Гадантоны дээрэмчид хүчирхэгжиж, нифайчуудыг устгахаар заналхийлэв. Нифайчуудын ерөнхий шүүгч Лаконеус бүх зөв шударга нифайчууд ба леменчүүдийг нэг дор цуглуулан хүмүүсээ наманчилж, тулаанд бэлтгэхийг уриалсан байна. Тэд эв нэгдэл болон Их Эзэнд итгэх итгэлийнхээ ачаар дайснаа ялжээ. Зөв шударга нифайчууд ба леменчүүд чөлөөлөгдсөний-хөө дараа Бурханы хүч тэднийг хамгаалсныг хүлээн зөвшөөрсөн юм.

3 Нифай 2

Зөв шударга нифайчууд ба леменчүүд Гадантоны дээрэмчдийн эсрэг өөрсдийгөө хамгаалахаар нэгдэцгээв

Амьдралдаа тохиолдсон онцгой сүнслэг туршлагааас хэдэн хором бод. (Сүнслэг туршлага нь утга учиртай байхын тулд сүр дуулиантай эсвэл ер бусын байх албагүйг санагтун). Эдгээр сүнслэг туршлагуудыг санах нь яагаад чухал гэж та бодож байна вэ?

3 Нифай 2:1–3-ыг уншаад хүмүүс Аврагчийн төрөлттэй холбоотой тэмдгүүдийг мартаж эхлэхэд тэдэнд юу тохиолдсоныг олж мэд. Энэ түүх бидэнд сүнслэг туршлагаадаа мартагын аюулын талаар юу зааж байна вэ?

Нифайчуудад тохиолдсон зүйлсээс бидний суралцах зарчмуудын нэг бол **хэрэв бид өмнөх сүнслэг туршлагаадаа мартвал Сатаны уруу таталт, хууран мэхлэлтэд илүү өртөмтгий болно**. Та энэ зарчмыг судартаа 3 Нифай 2:1–3-ын хажууд бич. Бичихдээ, сүнслэг туршлагаадаа мартагын нь яагаад биднийг Сатаны эрхшээлд өртөмтгий болгодгийг бод.

Сүнслэг туршлагаадаа таньж, санахын тулд юу хийж чадахаа тунгаан бод. Хамгийн их тус болно гэж

бодож байгаа хэдэн санаагаа жагсаан бич: _____

Тэргүүн Зөвлөлийн Ерөнхийлөгч Хэнри Б.Айринг өдрийн тэмдэглэлдээ сүнслэг туршлагаадаа тэмдэглэсэн нь түүнд тусалсан тухай ярьжээ. Түүний туршлагыг уншихдаа сүнслэг туршлагаадаа бичихээс ирж болох адислалуудын доогуур зур.



Би олон жилийн туршид өдөр бүр цөөн хэдэн мөр бичдэг байлаа. Би хэчнээн их ядарсан ч эсвэл маргааш нь хэчнээн эрт босох байсан ч нэг ч өдрийг алгасаагүй юм. Би бичихээсээ өмнө дараах асуултыг тунгаан боддог: ‘Би өнөөдөр

биднийг, хүүхдүүдийг маань эсвэл гэр бүлийг минь адисалж буй Бурханы мутрыг харсан уу?’ Ингэж бодох үед ямар нэгэн зүйл тохиолддог. Тухайн өдрийг эргэж харахдаа Бурханы бидний хэн нэгнийх нь төлөө хийсэн зүйлийг завгүй үедээ ажиглаагүй байсныгаа би олж хардаг юм. Энэ нь олонтоо тохиолдсон бөгөөд тохиолдох үед санахыг хичээх нь Бурханд бидний төлөө юу хийснийг нь надад харуулах боломжийг олгосноо би ухаарсан.

Зүрх сэтгэл минь талархлаар бялхаж эхэлсэн юм. Гэрчлэл минь өсөн нэмэгдсэн. Тэнгэрлэг Эцэг маань миний залбирлуудыг сонсч, хариулдгийг би илүү баттай мэдсэн билээ. Аврагч Есүс Христийн Цагаатгалаар ирдэг зүрх сэтгэлийн зөөлрөл болон ариусалд би илүү талархлыг мэдэрсэн. Мөн би Ариун Сүнс бидэнд бүх зүйлсийг, бүр тохиолдож байхад нь анзаараагүй эсвэл анхаарал хандуулаагүй зүйлсийг сануулж чадна гэдэгт улам итгэлтэй болсон” (“O Remember, Remember,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2007 оны 11-р сар, 67).



1. Сүнслэг туршлагаадаа санах нь таныг уруу татах эсвэл хууран мэхлэх гэсэн Сатаны оролдлогуудыг үл харгалзан итгэлтэй хэвээр үлдэхэд хэрхэн тусалсныг судар судлах тэмдэглэлдээ дүрслэн бич. (Үүнд сүнслэг туршлагаадаа санахын тулд өдрийн тэмдэглэлдээ бичих нь орж болно.)

3 Нифай 2:4–19-д цэдэглэгдсэнээр нифайчуудаас олон нь ёс бус явдлаа үргэлжлүүлж, Гадантоны дээрэмчдийн тоо өсч, хүчирхэгжсэн ажээ. Тэд улам түрэмгий болсноос, хөрвүүлэгдсэн леменчүүд тэдний эсрэг тэмцэхээр нифайчуудтай хүч хавсрав. Хэдийгээр тэд Гадантоны дээрэмчдийг нутгаасаа хөөн гаргахад тодорхой амжилт олсон ч нифайчууд болон леменчүүд Есүс Христийн төрөлтийн тэмдгүүд өгөгдсөнөөс хойш 15 жилийн дараа хүнд нөхцөлд хэвээр байв.

3 Нифай 3:1–10

Гадантоны дээрэмчдийн удирдагч нифайчууд болон леменчүүдийг бууж өгөхийг шаардсан нь

Бид 3 Нифай 3:1–10-р шүлгүүдээс чөтгөр заримдаа бусдаар дамжуулан бидний итгэлийг сулруулж, замаа алдахад хүргэдгийн жишээг хардаг. Гадантоны дээрэмчдийн удирдагч Гидианхай, нифайчууд болон леменчүүдийн хүмүүсийг нэгтгэн захирагч бөгөөд ерөнхий шүүгч Лаконеуст захиа бичиж түүнийг Гадантоны дээрэмчдэд бууж өгөхийг ятгажээ. 3 Нифай 3:2–10-ыг уншаад Гидианхайн Лаконеусын итгэлийг ганхуулж, түүнийг замаас нь гаргахыг хичээхдээ ашигласан аргуудыг харуулсан үг хэллэгүүдийг ол. Эдгээр үг хэллэгүүдийг олохоороо тэмдэглэж ав.

Эдгээр шүлгүүд **Сатан болон түүний дагалдагчид хүмүүсийг замаа алдахад удирдахдаа ихэвчлэн зусар, хуурамч амлалтууд болон заналхийллийг ашигладгийг заадаг**. Сатаны арга мэх ихэвчлэн маш овжин байдгийг ойлгох нь чухал бөгөөд тэр биднийг уруу татахдаа амархан танигдах дайснаас илүүгээр бидний найз нөхөд, хүндэлдэг хүмүүсийг ашигладаг. Гидианхайн зорилго, арга мэх болон өнөөдөр Сатан хүмүүсийг замаасаа гажихад хүргэдэг арга замуудын хооронд адил төстэй зүйлс байсаар байдаг.



2. Гидианхайн арга тактикуудын нэгийг сонгоод чөтгөр өнөөгийн өсвөр үеийнхэнд үүнтэй төстэй арга мэхийг хэрхэн ашиглаж болохыг судар судлах тэмдэглэлдээ тайлбарла. Та энэ арга тактикийг яаж сөрөн зогсохоо бич.

3 Нифай 3:11–4:33

Лаконеусын хүмүүс өөрсдийгөө хамгаалахаар бэлтгэж, Гадантоны дээрэмчдийг ялсан нь



Лаконеус Гидианхайн сүрдүүлсэн захианд цочирдож, хүмүүсээ дайсны болзошгүй довтлогоонд

бэлтгэхээр шийдэв. Дараах судрын хэсгийг уншаад Лаконеус Гадантоны дээрэмчдийн довтлогоог сөрөн зогсохын тулд хүмүүсээ сүнслэг болон материаллаг байдлаар (бие махбодын хувьд) бэлтгэсэн аргуудаас хамгийн багадаа дөрвийг олж мэд. (Санамж: та эдгээр шүлгүүдийг судлахдаа Гадантоны дээрэмчдийн удирдагч Гидианхай, нифайчуудын агуу бошиглогч, ерөнхий ахмад Гидгиддонай нарыг ялгаж таних хэрэгтэй.)

- 3 Нифай 3:12
- 3 Нифай 3:13–14
- 3 Нифай 3:15
- 3 Нифай 3:17–19



3. Судрын тэмдэглэлийнхээ нэг хуудсан дээр голоор нь хуваасан босоо шугам зур. Нэг талынх нь дээд хэсэгт *Лаконеусын бэлтгэл*, нөгөө талынх нь дээд хэсэгт *Өнөө үеийн адил зүйлс* гэсэн үгсийг тус тус бич. “Лаконеусын бэлтгэл” гэсэн гарчгийн доор, дайсны довтолгоог сөрөн зогсохын тулд Лаконеус болон нифайчуудын бэлтгэсэн дөрвөн аргыг бичих эсвэл зур. “Өнөө үеийн адил зүйлс” гэсэн гарчгийн доор, Лаконеус хүмүүсээ бэлтгэхийн тулд хийсэн зүйлстэй адил төстэй орчин үеийн аргуудаас хэдэн жишээг бичих эсвэл зур. Эдгээр аргууд нь хожмын өдрүүдэд хий хэмээн бидэнд зөвлөсөн сүнслэг болон материаллаг бэлтгэлийг харуулах ёстой.



4. Сурсан зүйлээ хэрхэн хэрэгжүүлэх талаар бодоход тань туслахын тулд дараах асуултуудын нэг юмуу түүнээс олонд нь судар судлах тэмдэглэлдээ хариулж бич.

а. Та дайсны дайралтаас гэр орноо хэрхэн хамгаалж болох вэ?

б. Гэр бүлээрээ, тойрог эсвэл салбараараа цугларах нь бидэнд хэрхэн хамгаалалт болдог вэ?

в. Өөрийгөө хүчирхэгжүүлэхийн тулд өдөр бүр судар судлах нь яагаад маш чухал арга байдаг вэ?

г. Залбирал хэзээ таныг дайсны эсвэл аюулын эсрэг сүнслэг хүчтэй болоход тусалсан бэ?

д. Наманчлал нь биднийг ирээдүйд хэрхэн бэлтгэж болох вэ?

е. Бошиглолын болон илчлэлтийн сүнстэй хүмүүсийг дагахыг сонгох нь бидэнд тэр тусмаа өнөөдөр яагаад чухал вэ?

Гадантоны дээрэмчид Лаконеус болон түүний хүмүүсийг довтлоход юу болсныг харахын тулд 3 Нифай 4:7–12-ыг унш. Бид энэ түүхээс **өөрсдийгөө сүнслэг болон материаллаг байдлын хувьд бэлтгэвэл Их Эзэний хүчээр сорилтуудаа даван туулж чадна** гэдгийг сурдаг.

Лаконеус ба түүний хүмүүс Гадантоны дээрэмчдийг ялж, удирдагчдыг нь устгав. Тэд удирдагчдаа сонгосон сонголт (3 Нифай 3:19; 4:17-г үзнэ үү), өөрсдийн дуулгавартай байдал (3 Нифай 3:21; 4:18-ыг үзнэ үү), Бурханд тавьдаг найдварынхаа (3 Нифай 4:30–31-ийг үзнэ үү) ачаар ялсан юм. 3 Нифай



4:30–33-ыг уншаад хүмүүс Гадиантоны дээрэмчдийг ялсныхаа дараа хэрхэн хариу үйлдэл үзүүлснийг олж мэд. Гадиантоны дээрэмчдээс тэднийг юу чөлөөлсөн хэмээн хүмүүс хүлээн зөвшөөрсөн бэ? Эдгээр шүлгүүдийн харуулдаг нэг зарчим бол: **Биднийг хүнд хэцүү байдлаас чөлөөлсөн Бурханы сайн сайхан болон нигүүлслийг хүлээн зөвшөөрөх нь биднийг даруу байхад тусалдаг** гэсэн зарчим юм.


3 Нифай 5

Хүмүүсийн дунд амар амгалан сэргэв; Мормон цэдгүүдийг хэрхэн хураангуйлснаа тайлбарлав

Хувийн сүнслэг туршлага нь таны итгэл, хүсэл эрмэлзэл, үйлдлүүдэд хэрхэн нөлөөлснийг бод. 3 Нифай 5:3–4-ийг уншаад нифайчууд Их Эзэнээс хүлээн авсан тусламж болон адислалынхаа үр дүнд юу хийснийг олж мэд. Хүмүүсийн хариу үйлдэл үзүүлсэн арга замуудын нэг нь бусдадаа сайн мэдээг номлох явдал байлаа.

Мормон яагаад хураангуйлсан цэдгээ хийснийг 3 Нифай 5:14–26-д, тайлбарлажээ. 3 Нифай 5:12–13-ыг уншаад Мормон Нифайн хүмүүсийн цэдгүүдийг хураангуйлан бичих хариуцлагынхаа тухай юу хэлснийг ол.

Бид эдгээр шүлгүүдээс **Есүс Христийн шавь нарын хувьд, бид бусдад үүрдийн амьдралд хүрэх замыг нь заах үүрэгтэй гэдгээ мэдэж авдаг**. Бидний төлөө Их Эзэний хийсэн зүйлсэд талархдагаа харуулах хамгийн чухал аргуудын нэг бол бусдыг Түүнд ирж, тэдэнд өгөх Түүний адислалуудыг хүлээн авахад нь туслах явдал юм.

 **5.** Есүс Христийн шавийн хувьд та бусдад үүрдийн амьдралд хүрэх замыг зааж болох хэдэн аргыг судар судлах тэмдэглэлдээ бич. Мөн үүнийг бусдад заах боломжтой байх зарим нөхцөлийг бод.

 **6.** Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би 3 Нифай 2–5-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

24-Р ХЭСЭГ: 3 ДАХЬ ӨДӨР

3 Нифай 6–10

Оршил

Нифайчууд болон леменчүүд Гадиантоны дээрэмчдээс гайхалтай чөлөөлөгдсөний дараа, нифайчууд гурван жилийн турш амар амгалан байв. Бардамнал, анги давхаргын ялгаа, хавчлага бий болж, ёс бус явдал ихэд газар авч, сүүлдээ Нифайн засгийн газрыг түлхэн унагав. Нифайн олон хотыг ёс бус оршин суугчдынх нь хамт устгасан үлэмж их сүйрлүүд Иерусалим дахь Есүс Христийн үхлийн тэмдгүүдэд оржээ. Харанхуй уг нутгийг гурван өдөр бүрхэв. Харанхуйн дунд, Аврагчийн дуу хоолой хүмүүсийг Түүнд эргэн ирэхийг урьсан ажээ. Харанхуй арилахад, хүмүүсийн уй гашуу баяр хөөр, Есүс Христийг магтан дуулах магтаалаар солигдов.

3 Нифай 6–7


Нифайчууд бардам болцгоож, сүм хуваагдаж, нууц хуйвалдаанууд засгийн газрыг унагаж, хүмүүс аймаг овгуудад хуваагдав

Бошиглогчийг дагах эсэхээ шийдэх асуудал танд тулгарч байсан тохиолдлыг бод. 3 Нифай 6–7-р бүлгүүдэд цэдэглэгдсэнээр нифайчуудын зарим нь бошиглогчдыг эсэргүүцсэнийхээ хариуд эмгэнэлт үр дагавруудыг амссан байхад бусад нь Их Эзэний

сонгосон үйлчлэгчдийг сонсож, наманчлахаас ирдэг адислалуудыг авчээ.

Та 3 Нифай 5-р бүлгээс нифайчууд наманчилж, Бурхандаа хичээнгүйлэн үйлчилсэн бөгөөд Гадиантоны дээрэмчдээс гайхамшигтайгаар чөлөөлөгдсөнийг уншсан билээ. Нифайчууд богинохон хугацаанд цэцэглэн хөгжив. Гэвч олон хүний зүрх сэтгэлд бардамнал хурдан нэвтэрсэн нь сүм дотор хэсэг бүлгүүд үүсэхэд хүргэжээ. Бошиглогчид хүмүүсийн ёс бус явдлын эсрэг номлохоор илгээгдсэн ч шүүгчид тэднийг барьж, нууцаар хороож байв (3 Нифай 6:4–23-ыг үзнэ үү). Хүмүүс ойролцоогоор зургаан жилийн дотор, “өөрсдийгөө Сатаны хүчинд” (3 Нифай 7:5) тушаасан бөгөөд тэд бүх зөв шударга зүйлийн эсрэг тэмцэж, улам ёс бус болцгоосон юм. Нууц бүлэглэлүүд улс орны засгийн газрыг устгаж, хүмүүс овгуудад хуваагдахад хүрчээ.

Нифай хүмүүсийн ёс бус явдлыг үл харгалзан тэдний гэм нүглийг үргэлжлүүлэн гэрчилж, тэднийг наманчлалд дуудсаар байв (3 Нифай 7:15–20-ийг үзнэ үү). 3 Нифай 7:21–22-ыг уншаад Нифайг дагаснаар хүмүүс хэрхэн адислагдсан тухай хэдэн жишээг тэмдэглэ. **Бид наманчилж, Их Эзэний үйлчлэгчдийг дагавал Ариун Сүнсний нөлөөг хүлээн авна** гэдгийг эдгээр шүлгүүдээс сурдаг.


 **1.** Та бошиглогчийн эсвэл санваарын бусад удирдагчдын зөвлөгөөг дагахаар сонгосон тохиолдлынхоо тухай судар судлах тэмдэглэлдээ бич. Та ингэснээрээ хэрхэн адислагдсан бэ?

3 Нифай 8:1–18

Их сүйрэл Есүс Христийн үхлийг тэмдгийг гүйцэлдүүлэв

Аврагчийн Хоёр дахь ирэлтийн ирэх өдрийг төсөөлөн бод. Тэр цаг ирэхэд танд ямар санагдана гэж бодож байна? Үүнтэй адил нифайчууд Есүс Христийн ирэлтийг урт удаан хугацаанд хүсэн хүлээсээр байв. Лемен үндэстэн Самеул Есүс Христийн нас баралтын тэмдгүүдийг бошиглосон юм (Хиламан 14:20–27-г үзнэ үү). 3 Нифай 8:3–4-ийг уншаад зарим нифайчууд тэмдгүүдийн тухай өөр бодолтой байсныг анзаарч хар.

3 Нифай 8:5–7-г уншаад Аврагчийн төрөлтийн тэмдгээс хойш гучин дөрөв дэх жилд юу болсныг олж мэд. 3 Нифай 8:8–18-ыг гүйлгэн хараад шуурга болон газар хөдлөлтөд өртсөн хотуудын оршин суугчдад юу тохиолдсоныг олж мэд. 3 Нифай 10:11–12-ыг уншаад энэхүү сүйрлээс хэн амьд гарч чадсаныг тэмдэглэ. Амьд үлдэгсэд нь нифайчуудын “хамгийн зөв шударга хэсэг” байсан ч тэд наманчилж, Есүс Христэд ирэх шаардлагатай байлаа.


 **2.** Судрын тэмдэглэлийнхээ нэг хуудсанд 3 Нифай 8:5–18-р шүлгүүд дэх үйл явдлуудыг мэдээлсэн сонинны өгүүлэл бич. Гарчиг өгч, ноорог зураг гарган, сүйрлийн тухай мэдээ бич.

3 Нифай 8:19–25

Харанхуй уг нутгийг гурван өдрийн турш нөмрөв

Та хэн нэгэн нь гэрэл унтраахад агуй эсвэл цонхгүй өрөө гэх мэт таг харанхуй газар байсан тохиолдлоо сана (эсвэл тийм нөхцөлд ямар байхыг төсөөлөн бод). Харанхуйд юу ч харах боломжгүй байх нь ямар санагдсан бэ? 3 Нифай 8:19–23-ыг уншаад шуурга болон сүйрлүүд зогссоны дараа юу болсныг олж мэд. (Та хэр зэрэг харанхуй байсныг харуулсан үг хэллэгүүдийг тэмдэглэж болно.)

3 Нифай 8:24–25-ыг уншаад нифайчууд өөрсдийн олон хүнийг үхэл болон сүйрлээс юу хамгаалж болно гэж хэлж байсныг олж мэд.

 **3.** Дараах асуултуудад судар судлах тэмдэглэлдээ хариулж бич:

- Нүглийн үр дагаврууд нь харанхуйд байхтай хэр зэрэг адилхан бэ?
- Наманчлалыг харанхуй өрөөнд гэрэл гаргахтай хэрхэн адилгаж болох вэ?

3 Нифай 9:1–14

Харанхуйд Есүс Христийн дуу хоолой сүйрлээс амьд үлдэгсдийг наманчилж, Түүнд ирэхийг урьжээ.

Аврагчийн дуу хоолой гурван өдрийн харанхуйн турш, амь хэлтрүүлэгдсэн хүмүүст хандан яриу. 3 Нифай 9:1–2, 7-г уншаад Аврагч хүмүүсийн дунд уг сүйрэл яагаад болсон хэмээн хэлснийг ол. Дараа нь 3 Нифай 9:13–14-ийг уншиж, Аврагч хүмүүсийг зовлон зүдгүүрийнх нь үед тайтгаруулахын тулд юу гэж хэлснийг олж мэд. Эдгээр шүлгүүдээс танд чухал гэсэн хэсгийг нь тэмдэглэ.

Аврагч бид бүхнийг Түүнд ирж, эдгэрэхийг урьдаг хэмээн Далын ахлагч С.Скотт Греү гэрчилжээ.



“Есүс Христ бол бидний бодгалийн Агуу Эдгээгч мөн. Мөхлийн нүглээс бусад аливаа гэм нүгэл ба зөрчил, өвчин эмгэг ба уй гашуу Түүний Цагаатгалын эдгээгч хүчнээс гадуур байдаггүй.

“Биднийг нүгэл үйлдэхэд Сатан биднийг өнгөрсөн хүмүүс гэдэг. Үүний эсрэгээр бидний Гэтэлгэгч бид ямар ч буруу зүйл хийлээ гэсэн хүн бүхэнд, бүр танд бас надад гэтэлгэлийг санал болгодог” (“The Miracle of the Atonement,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2011 оны 5-р сар, 109).

Түүнд ирж, Түүний эдгээлтийн хүчийг хүлээн ав гэсэн 3 Нифай 9:13-р шүлэг дэх Аврагчийн урилга бидний хүн бүрд өгөгдсөн юм. Аврагч биднийг эдгээхийн тулд бид Түүний урилгыг хүлээн авч, Түүнд ирж, нүглүүдээ наманчилж, хөрвөгдсөн байх ёстой.



4. Аврагчийн эдгээлтийн хүчээс ашиг тусыг олж болох амьдралынхаа аль нэг зүйлийн тухай судар судлах тэмдэглэлдээ бич. Та өөрийгөө эдгээлгэхээр Аврагчийг урихын тулд юу хийх шаардлагатай вэ?

3 Нифай 9:15–22

Аврагчийн золиослолоор Мосегийн хууль гүйцэлдсэнийг Түүний дуу хоолой тунхаглав

Нифайчууд амьдралдаа энэ мөчийг хүртэл дагасаар ирсэн Мосегийн хуулийн дагуу Их Эзэн Өөрийн хүмүүст Цагаатгалаар дамжуулан өргөх хамгийн сүүлчийн золиослолын хэлбэр бөгөөд хэв шинж болох малаар тахил өргөхийг тушаажээ. 3 Нифай 9:17 дахь Аврагчийн үгсийг дараах өгүүлбэрийг гүйцээн бичихэд хэрэглэ: “Надаар гэтэлгэл ирдэг, мөн надаар _____

.”

Мосегийн хуулийн бүх ёслол ба хуулиуд, зан үйл ба бэлгэдлүүд нь хүмүүсийг Түүнд хандуулахын тулд өгөгдсөн бөгөөд Тэрбээр цагаатгагч золиослолоо гүйцэтгэснээр тэдгээр нь биелэгдсэн юм хэмээн Аврагч тунхагласан билээ. 3 Нифай 9:19-ийг уншаад Аврагч нифайчууд юуг дахиж өргөх хэрэггүй болсон хэмээн мэдэгдсэнийг олж мэд. Тэгээд 3 Нифай 9:20-оос түүний оронд тэд юу өргөхөөр болсныг тэмдэглэ.

“Харууссан зүрх, гэмшсэн сэтгэл”-ийн өргөл гэдэг нь юу гэсэн утгатай гэж та бодож байна вэ? Гэмшсэн сэтгэл нь даруу төлөв, амархан ойлгодог бөгөөд наманчлагч сэтгэл юм. Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Д.Тодд Кристоффэрсоны хэлсэн үгсийг уншиж, харууссан зүрх, гэмшсэн сэтгэлтэй байх нь юу гэсэн утгатайг ойлгох ойлголтоо нэмэгдүүлж мөн түүний “харууссан зүрх”, “гэмшсэн сэтгэл” гэсэн үгсийн утгыг тодорхойлоход түүний ашигласан үгсийг тэмдэглэ:



“Эрт үед хүмүүс Их Эзэнийг шүтэн биширч, Түүний адислалуудыг олж авахын тулд ихэвчлэн бэлэг авчирдаг байжээ. . . Та хөрвөлтийн адислалуудыг эрэлхийлэхдээ харууссан буюу наманчлагч зүрхнийхээ, гэмшсэн буюу дуулгавартай сэтгэлийнхээ бэлгийг Их Эзэнд өргөл болгож

болно. Чухамдаа, та өөрөө одоо ямар хүн байгаа нь мөн ямар хүн болох гэж байгаа нь бэлэг юм.

“Таны дотор эсвэл амьдралд тань ямар нэгэн цэвэр ариун бус, зохисгүй зүйл байдаг уу? Та үүнээсээ салж чадвал энэ нь Аврагчид барих бэлэг юм. Амьдралд тань үгүйлэгдэж байгаа ямар нэг сайн хэвшил эсвэл зан чанар байна уу? Та үүнийг өөртөө төлөвшүүлж зан чанарынхаа нэг хэсэг болгох юм бол та Их Эзэнд бэлэг барьж байгаа нь тэр” (“When Thou Art Converted,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2004 оны 5-р сар, 12).

3 Нифай 9:21–22-ыг уншаад бид Түүнд очихын тулд ямар байх хэрэгтэй талаар Аврагч юу гэж заасныг эрж ол.



5. Өөрийнхөө таньдаг бага насны хүүхдүүдийн талаар бод. Аврагчид очихын тулд бидэнд байх ёстой бяцхан хүүхдийн зан чанаруудыг судар судлах тэмдэглэлдээ дүрслэн бич.



3 Нифай 9:13–14, 20–22-р шүлгүүд дэх тохирох үг хэллэгүүдийг ашиглан дараах зарчмыг гүйцээж бич: **Хэрэв бид Есүс Христэд харууссан зүрх, гэмшсэн сэтгэлтэйгээр ирвэл Тэр _____**

(Олон зөв хариултууд байж болно.)



6. Энэхүү үнэнийг хэрэгжүүлэхийн тулд дараах асуултаудад хариул:

а. Их Эзэнд харууссан зүрх, гэмшсэн сэтгэлээ өргөхөд ямар зан чанарууд бидэнд саад болж болох вэ?

б. Их Эзэн таныг Түүнд наманчлагч зүрх, дуулгавартай сүнс тэйгээр ирэхэд хэрхэн адисалж байсан бэ?

в. Та Их Эзэнд харууссан зүрх, гэмшсэн сэтгэлээ илүү сайнаар яаж өргөж болох вэ?

3 Нифай 10

Их Эзэн Өөрийн хүмүүсийг тахиа дэгдээхийнүүдээ цуглуулдаг шиг цуглуулахаар амласан юм



Хүмүүс Аврагчийн дуу хоолойг сонссоны дараа уг нутагт олон цагийн турш нам гүм байсанд мэл гайхав. Тэгтэл нөгөөх дуу хоолой хүмүүст хандан дахин ярьж эхлэв (3 Нифай 10:1–3-ыг үзнэ үү). 3 Нифай 10:4–6-г уншаад Аврагч хүмүүсийг хамгаалж, өргөн дэмжихийн тулд Тэр юу хийхийг хичээсэн гэж хэлснийг олж мэд. 6-р шүлэгт наманчилж мөн Аврагчид бүх зүрх сэтгэлээрээ ирэх хүмүүст өгөгдсөн амлалтыг тэмдэглэ.

Аврагч дэгдээхийнүүдээ аюулаас хамгаалан далавчин дороо цуглуулдаг эм тахианы зүйрлэлийг ашиглажээ. Аврагч ямар байдлаар дэгдээхийнүүдээ аюулаас хамгаалдаг эм тахиатай адил болохыг бод. Түүнээс гадна 3 Нифай 10:4–6-д цэдэглэснээр, Израилын бүх угсаа яагаад цуглуулагдаагүй вэ?

3 Нифай 10:8–10-ыг уншаад Аврагчийн дуу хоолойг сонссоны дараа хүмүүст юу тохиолдсоныг олж мэд.



7. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би 3 Нифай 6–10-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

24-Р ХЭСЭГ: ДӨРӨВ ДЭХ ӨДӨР

3 Нифай 11:1–17

Оршил

Их сүйрэл болон гурав хоногийн харанхуйн дараа ойролцоогоор 2500 эрэгтэй, эмэгтэйчүүд, хүүхдүүд Өгөөмөр нутаг дахь ариун сүмийн эргэн тойронд цуглав (3 Нифай 17:25-ыг үзнэ үү). Тэд нэг дуу хоолойг сонссон ч эхлээд ойлгосонгүй. Тэд сонсохыг хичээхэд энэ нь Өөрийн Хүү Есүс Христийг танилцуулж байгаа Тэнгэрлэг Эцэгийн дуу хоолой байсныг ойлгожээ. Ийнхүү дэлхийн Аврагч хүрч ирэв. Есүс Христ хүмүүсийг нэг нэгээрээ Түүний хажуугийн шарх, Түүний гар хөл дээрх хадаасны сорвийг тэмтэрч үзэн Тэрээр дэлхийн гэм нүглийн төлөө егүүтгэгдсэнийг гэрчлэхэд урьсан билээ.

3 Нифай 11:1–7

Тэнгэрлэг Эцэг Хүүгээ хүрч ирснийг зарласан дуу хоолойг хүмүүс сонсов

Харандаа болон энэ судлах удирдамжаа аваад гадаа гарч, 60 секундийн турш чимээ чагна. Өгөгдсөн зайд аль болох олон янзын дуу чимээг тэмдэглэ. _____

Таньж мэдэхэд хэцүү эсвэл сонсохыг хичээгээгүй үед анзаардаггүй дуу чимээнүүдийн хажууд од тавь. Тэгээд дотогшоо буцаж ор.

Аврагчийн үхлийг бэлгэдсэн их сүйрэл болон харанхуйгаас хойш хүмүүс тун удалгүй Өгөөмөр нутаг дахь ариун сүмд цугларцгаав. Тэд юу болсон талаар ярилцацгааж байтал ойлгохын аргагүй гайхамшигт явдал болжээ. 3 Нифай 11:1–3-ыг уншаад хүмүүст юуг ойлгох нь хэцүү байсныг олж мэд. Бурханы дуу хоолой хэрхэн дүрслэгдсэнийг болон үүнийг сонссон хүмүүст уг дуу хоолой ямар нөлөө үзүүлснийг тэмдэглэ.

Хүмүүсийн сонссон тэр дуу хоолойн шинж чанарууд нь бид Ариун Сүнснээс хүлээн авдаг өдөөлтүүдтэй хэр зэрэг төстэй болохыг түр зуур бод. 3 Нифай 11:1–3-р шүлгүүдээс Их Эзэн болон Ариун Сүнс бидэнтэй хэрхэн ойр ойрхон ярьдаг талаар ямар үнэнийг сурч болох вэ? Эдгээр шүлгүүдэд дүрслэгдсэн нэг сургаал бол: **Ариун Сүнс ихэнхдээ бидний зүрх сэтгэлд мэдрэгдэхээр намуун, зөөлөн ярьдаг** гэсэн сургаал юм.

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Боид К. Пакэр Их Эзэний дуу хоолойг Ариун Сүнсээр

дамжуулан сонссоноор энэ нь бидний оюун санаа, зүрх сэтгэлд хүрдгийг тайлбарлажээ:



“Мормоны Номыг уншсанаар миний сурсан хамгийн чухал нэг зүйл бол Сүнсний дуу хоолой нь дуу чимээ гэхээсээ илүү *мэдрэмж* болж ирдэг явдал юм. Та миний сурч мэдсэн шиг сонсогдох биш харин *мэдрэгддэг* дуу хоолойг

‘сонсож’ сурна. . . .

“Хэрэв та боломж олговол Ариун Сүнсний бэлэг таныг удирдаж, хамгаалж, тэр ч байтугай буруу үйлдлийг тань залруулах болно. Оюун ухаанд тань ирж байгаа бодол, зүрх сэтгэлийн тань мэдрэмж бол сүнсний дуу хоолой юм” (“Counsel to Youth,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2011 оны 11-р сар, 17–18).



1. Их Эзэний дуу хоолой эсвэл Сүнсний мэдрэмж оюун санаа, зүрх сэтгэлд тань мэдрэгдсэн тохиолдлын тухай бод. Танд ямар мэдрэмж төрснийг туршлага дээрээ үндэслэн судар судлах тэмдэглэлдээ бич.

Нифайчууд тэр дуу хоолойг хоёр удаа сонссон ч ойлгоогүй. 3 Нифай 11:4–7-г уншаад нифайчууд тэр дуу хоолойг ойлгохын тулд гурав дахь удаагаа юуг өөрөөр хийснийг олж мэд. Хүмүүс тэр дуу хоолойг “сонсохоор сонороо” дэлгэсэн гэдэг нь юу гэсэн утгатай гэж та бодож байна? (3 Нифай 11:5).

Ерөнхийлөгч Боид К.Пакэр бид Их Эзэний дуу хоолойг Ариун Сүнсээр дамжуулан сонсож, ойлгохын тулд юу хийх хэрэгтэй тухай дараах зөвлөгөөг өгчээ. Их Эзэний дуу хоолойг Ариун Сүнсээр дамжуулан сайн сонсохын тулд таныг юу хийх, эсвэл юунаас зайлсхийхийг мэдэхэд туслах үг хэллэгүүдийн доогуур зур.

“Сүнс хашгирч бидний анхаарлыг татдаггүй. Энэ нь биднийг хэзээ ч чанга угзардаггүй. Сүнс шивнэдэг. Сүнс намуун зөөлөн ярьдаг учраас хэрэв бид өөр зүйлд сатаарсан бол үүнийг бүр мэдрэх ч үгүй өнгөрнө.

“Сүнс хааяа биднийг анхаарлаа төвлөрүүлэхэд хангалттай эсвэл дөнгөж хангалттай төдий мэдрэгддэг ч миний туршлагаар бол ихэнх тохиолдолд, хэрэв бид энэхүү намуун зөөлөн мэдрэмжийг анзаарахгүй өнгөрвөл, хэрэв бид эдгээр мэдрэмжүүдийг сонсохгүй бол Сүнс биднээс холдож, биднийг өөрийн хэв маяг, өөрийн илэрхийллээр түүнийг эрэлхийлж, сонсох хүртэл хүлээдэг” (“How Does the Spirit Speak to Us?” *New Era*, 2010 оны 2-р сар, 3).

Та судартаа 3 Нифай 11:5–6-р шүлгүүдийн хажууд болон судар судлах тэмдэглэлдээ дараах зарчмыг бич: **Бид Их Эзэний дуу хоолойг Ариун Сүнсээр дамжуулан хэрхэн сонсвол зохихыг сурснаар бидэнтэй харилцах Түүний харилцааг ойлгож чадна.**



2. Дараах асуулуудад судар судлах тэмдэглэлдээ харуулж бич:

а. Таныг Их Эзэний дуу хоолойг сонсож, ойлгохын тулд оюун санаа, зүрх сэтгэлээ бэлтгэхэд тань юу туслах вэ?

б. Сонсохыг хичээгээгүй бол ойлгохгүй өнгөрөх байсан тэрхүү Их Эзэний харилцааг та хэзээ ойлгосон бэ?

в. Ариун Сүнсний өдөөлтийг нэгээс илүү олон удаа хүлээн авч байж ойлгож, түүнийг дагасан тохиолдол танд бий юу?

3 Нифай 11:8–17

Есүс Христ нифайчууд дээр хүрч ирэн тэднийг нэг нэгээрээ ирж, шархыг нь тэмтэрч үзэхэд урив




3 Нифай 11:8–10-ыг уншихдаа болж байгаа үйл явдлуудыг зураглан дүрслэхийг хичээ.

**Болж байгаа
үйл явдлыг
бодол санаандаа
зураглан төсөөл**

Судруудыг судлахдаа болж байгаа үйл явдлыг зураглан төсөөлж, тодорхой үйл явдлын үеэр тэнд байгаа хүмүүстэй хамт байхад ямархуу байх байсныг бодох нь тустай. Суралцах ийм чадвар нь судруудын үйл явдалд хүмүүсийг илүү бодитой болгож, Ариун Сүнсний нөлөөг мэдрэх боломжийг танд олгоно.

мын бүхий л түүхэн дэх хамгийн гол цэг, хамгийн онцгой үйл явдал мөн. Энэ нь өмнөх зургаан зуун жилийн турш Нифай үндэстэн бошиглогч бүрд, мөн түүнээс өмнө олон мянган жилийн турш тэдний өвөг дээдэс Израил болон Жаред үндэстнүүдэд

 **3.** Та амилсан Есүс Христ Мормоны Номын хүмүүс дээр хүрч ирснийг харсан бол ямар байх байсныг төсөөлөн бодоод тэдний дунд байсан бол танд ямар бодол, мэдрэмж төрөх байсныг судар судлах тэмдэглэлдээ бич.

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Жэффри Р.Холланд, Аврагч нифайчууд дээр хүрч ирсний ач холбогдлын тухай ярьсан нь:

“Тийнхүү хүрч ирсэн болон тэр тухай тунхагласан нь Мормоны Но-

мэдэгдэж, тэдэнд сүнслэг нөлөө үзүүлсээр ирсэн илэрхийлэлт ба тунхаг байлаа.

“Хүн бүхэн Түүний талаар ярьж, Түүний тухай дуулж, Түүнийг мөрөөдөн, Түүнийг хүрч ирэхийн төлөө залбирч байсан юм. Тэгтэл Тэрбээр үнэхээр хүрээд ирэх нь тэр! Удаан хүлээсэн тэр өдөр тийнхүү хүрээд ирэх нь тэр! Харанхуй шөнө бүрийг өглөөний гэрэл болгон хувиргадаг Бурхан хүрээд ирэх нь тэр” (*Christ and the New Covenant: The Messianic Message of the Book of Mormon* [1997], 250–51).

Үлдсэн нифайчууд ба леменчүүд саяхан аймшигт сүйрэл, гурван өдрийн харанхуйг үзсэн гэдгийг сана. 3 Нифай 11:10–12-ыг уншаад Есүс Христ хүмүүсээс Өөрийнхөө тухай болон Тэрбээр мөнх бус оршихуйн үйлчлэлдээ юу хийснийг мэдээсэй гэж хүссэнийг олж мэд. Хэрэв та тэнд байсан бол Аврагчийн хэлсэн үгсээс аль нь танд хамгийн их тайтгарал өгөх байсан гэж бодож байна вэ? Яагаад тэр үг танд туйлын чухал болохыг тунгаан бод. Таны хувьд хамгийн чухал хэллэгийг судартаа тэмдэглэ.

3 Нифай 11:13–15-ыг уншаад Есүс Христ хүмүүсийг Өөрийнх нь талаарх хувийн мэдлэгийг хүлээн авахын тулд юу хийхийг урьсан бэ? Дараах асуултуудын хариултыг бод: 3 Нифай 11:14-т цэдэглэсэнээр,



Аврагч хүмүүсийг энэ туршлагаас юу мэдээсэй гэж хүссэн бэ? Тэр үед тэнд 2500 орчим хүн байсныг бодолцвол (3 Нифай 17:25-ыг үзнэ үү), энэ үйл явдал хэр зэрэг удаан үргэлжилсэн бол? Энэ нь танд Аврагчийн тухай юу зааж байна вэ?



4. Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултуудад хариул:

а. Яагаад Их Эзэн хүмүүсийг Түүнд “нэг нэгээрээ” ирж, биенд нь гар хүрэхийг хүссэн гэж та бодож байна вэ? (3 Нифай 11:15).

б. Таны гэм нүглийн төлөө Аврагч цагаатгах үед олсон шархны сорвиудыг тэмтэрч үзэх нь танд хэрхэн нөлөөлж болох вэ?

Та дараах үнэнийг судартаа 3 Нифай 11:11–15-ын дэргэд эсвэл судар судлах тэмдэглэлдээ бич: **Есүс Христ намайг Тэр бол миний Аврагч гэсэн хувийн гэрчлэлтэй болоход урьдаг.**



5. Дараах асуултуудад судар судлах тэмдэглэлдээ хариул:

а. Аврагчийн талаарх таны хувийн гэрчлэл хэр зэрэг хүчтэй гэж та боддог вэ? Сүүлийн үед гэрчлэл тань өсч, илүү бат бөх болсон уу?

б. Ямар туршлагауд таныг Аврагчийн тухай хувийн гэрчлэлтэй болоход хүргэсэн бэ? Эсвэл та илүү хүчтэй гэрчлэлийг олохын тулд юу хийх хэрэгтэй вэ?

в. Аврагч таны төлөө анхаарал тавьдгийг та яаж мэдэж болох вэ?

3 Нифай 11:16–17-г уншаад хүмүүс Аврагчтай холбоотой хувийн туршлагатай болсныхоо дараа юу хийснийг олж мэд. “Хосанна” бол Аврагчийг магтан дуулсан уриа юм.

3 Нифай 11:15-ыг анхааралтай ажиглаад хүмүүс Аврагчийн шархны сорвийг харж, тэмтэрч үзсэний дараа яасныг олж мэд. Та 3 Нифайд бичигдсэн хүмүүстэй адилаар тэнд байж, Аврагчийн шархны сорвийг тэмтэрч үзээгүй учир Есүс бол Христ гэдгийг яаж мэдэж болох вэ? (Иохан 20:30–31; Моронай 10:3–7; С ба Г 46:13–14-ийг үзэж, тохирох хариултуудыг ол.)

3 Нифай 11:15-ыг өөртэйгөө адилтгахын тулд дараах өгүүлбэрийг гүйцээж бич: **Би Есүс Христийн тухай хувийн гэрчлэл хүлээн авснаар _____**

үүрэг хариуцлагатай болдог.

Есүс Христийн тухай гэрчлэлтэй хүн Түүнийг хэрхэн “гэрчилж” болох арга замуудын талаар бод.

Ерөнхийлөгч Боид К.Пакэр гэрчлэлийн талаар заасан нь: “Та сүнсний зүйлсийг албадаж чадахгүй. Гэрчлэл танд гэнэт ирдэггүй, харин алгуураар өсөн

нэмэгддэг. Гэрчлэл бол чухал зүйл, иймээс их ч бай, бага ч бай, гэрчлэлд хүндэтгэлтэй хандах ёстой. Бид бие бялдраараа өсдөгийн адил гэрчлэлээрээ өсч өндөр болдог ч тийнхүү өсч байгаагаа бараг л мэддэггүй. Учир нь гэрчлэл бага багаар өсөн нэмэгддэг” (“How Does the Spirit Speak to Us?” 3).



6. Есүс Христийн тухай гэрчлэлээ судар судлах тэмдэглэлдээ бичиж энэ хичээлийг дуусга. Гэрчлэлтэй болохын тулд юу хийснээ эсвэл гэрчлэлээ улам бат бөх болгохын төлөө юу хийхээр төлөвлөж байгаагаа бичиж болно. Сүнсээр өдөөгдвөл гэрчлэлээ хэн нэгэнд уншиж өгөх эсвэл хэн нэгнийг гэрчлэлээ уншихад урь.



7. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би 3 Нифай 11:1–17-р шүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

25-Р ХЭСЭГ: 1 ДЭХ ӨДӨР

3 Нифай 11:18–12:48

Оршил

Өгөөмөр нутаг дахь ариун сүмд байсан хүн бүр Есүс Христийн хавирга, гар, хөл дээрх шархны сорвиудыг тэмтэрч үзсэний дараа, Аврагч Нифай болон бусад хүмүүст баптисм хүртээх эрх мэдлийг өгөв. Аврагч мөн хүмүүст зөрчилдөөнөөс зайлсхийхийг анхааруулаад, сайн мэдээгээр амьдардаг хүмүүс Бурханы хаант улсыг өвлөх болно хэмээн амлажээ. Тэр мөн хүмүүст Түүний сайн мэдээний адислалуудыг хэрхэн хүлээн авахыг зааж, бусдад сайн нөлөө үзүүлдэг байхыг сургав. Аврагч Мосегийн хуулийг гүйцэлдүүлснээ мэдэгдээд Тэрбээр хүмүүсийг Түүнтэй болон Тэнгэр дэх Эцэгтэй адил болоход бэлтгэхийн тулд тэдэнд илүү өндөр түвшний хуулийг өгчээ.

3 Нифай 11:18–30

Есүс Христ Нифай болон бусад хүмүүст баптисм хүртээх эрх мэдлийг өгч, зөрчилдөөнийг буруутгав

Өөрийнхөө баптисмд бэлтгэж байх үед эсвэл найз болон гэр бүлийн гишүүн тань баптисм хүртэхээр бэлтгэж байхад танд ямар бодол, мэдрэмж төрснийг санаж байна уу? Олон хүмүүс “Хэн надад баптисм


хүртээж болох вэ?” “Баптисмын ёслолыг хэрхэн гүйцэтгэдэг вэ?” гэх мэт асуултуудыг асуудаг. Эдгээр асуултуудад та хэрхэн хариулахаа сайтар бод.


Та 3 Нифай 11:1–17-г судлаад “Өгөөмөр нутагт байрлах ариун сүмийн эргэн тойронд байсан Нифайн хүмүүс” (3 Нифай 11:1) дээр Есүс Христ хүрч ирснийг мэдсэн билээ. Тэдгээр хүмүүс Түүний шархны сорвиудыг тэмтэрч үзэн Түүний амилалт болон бурханлаг чанарын талаар хувийн гэрчлэлтэй болсон байлаа. Энэхүү үйл явдлын дараахан Аврагч тэдэнд баптисмын тухай, хэн баптисм хүртээж болох, баптисмыг хэрхэн хүртээх талаар заажээ.

3 Нифай 11:18–22, 24–25-ыг уншаад “Хэн надад баптисм хүртээж болох вэ?” гэсэн асуултад хариулж бич. _____

3 Нифай 11-р бүлэгт цэдэглэгдсэнээр Аврагчийн хэлсэн болон хийсэн зүйлсээс бид дараах зүйлийг сурдаг: **Баптисм нь зохих эрх мэдлийг атгадаг хүнээр хийгдэх ёстой.** Орчин цагийн илчлэлтүүд нь баптисмыг зөвхөн Аароны санваарын пристийн албыг атгадаг хүн (С ба Г 20:46) эсвэл Мелкизедек санваартан гүйцэтгэж болохыг тодруулжээ (С ба Г 20:38–39; 107:10–11-ийг үзнэ үү). Түүнээс гадна уг хүн тухайн ёслолыг гүйцэтгэх зөвшөөрлийг олгоход шаардлагатай санваарын түлхүүрүүдийг атгадаг санваарын удирдагчийн (бишоп, салбарын ерөнхийлөгч, номлолын ерөнхийлөгч эсвэл Ерөнхий эрх мэдэлтэн) удирдлага дор үйлдэх ёстой.

3 Нифай 11:23–27-г уншаад “Баптисмын ёслолыг хэрхэн гүйцэтгэдэг вэ?” гэсэн асуултад хариулж бич. _____

 **1.** Яагаад баптисм нь Их Эзэний үзүүлсэн маягаар хийгдэх ёстой гэж боддогоо судар судлах тэмдэглэлдээ бич. Баптисмын үед баптисмын ёслолын үгсийг буруу хэлэх эсвэл баптисм хүртэж байгаа хүн усанд бүрэн дүрэгдээгүй бол яах вэ?

 **2.** Судар судлах тэмдэглэлдээ дараах багц асуултуудаас нэгд нь эсвэл түүнээс олонд нь хариулж бич.

а. Та яагаад баптисм хүртсэн, мөн баптисмын ёслолын талаар юу санаж байна вэ? Хэн танд баптисм хүртээсэн бэ? Та хэдэн настай байв? Баптисм хүртэх үед танд ямар мэдрэмж төрсөн бэ? Зохих санваартнаар, Их Эзэний үзүүлсэн маягаар баптисм хүртсэн гэдэг нь танд ямар утга учиртай вэ?

б. Та ойрд хэн нэгэн нь баптисм хүртсэнийг харсан уу? Танд ямар мэдрэмж төрсөн бэ?

в. Хэрэв та Аароны санваарын пристийн албыг атгадаг бол, баптисм хүртээх эрх мэдэлтэйгээ мэдэх нь танд хэрхэн нөлөөлдөг вэ? Хэрэв танд хэн нэгэнд баптисм хүртээх боломж олдсон бол, уг туршлагын явцад юуг мэдэрч, юу сурсан бэ?



3 Нифай 11:28–30-д цэдэглэгдсэнээр Их Эзэн хүмүүсийг баптисмын тухай эсвэл уг сургаалын бусад хэсгүүдийн талаар хоорондоо зөрчилдөхгүй (маргалдахгүй) байхыг зөвлөжээ. Есүс Христ зөрчилдөөн чөтгөрөөс ирдэг бөгөөд үүнийг зайлуулах ёстой гэж заасан билээ.

3 Нифай 11:31–41

Есүс Христ сургаалаа тунхагласан нь

Өнөөдөр хийсэн сайн үр дагавартай ямар нэгэн зүйлийнхээ (үйлдэл) тухай бод. Үйлдэл болон үр дүнг нь дараах жишиг зургийн холбогдох талуудад нь бич. Тэгээд өнөөдөр хийсэн муу үр дагавартай нэг үйлдлийнхээ тухай бод.

Үйлдэл —————> Үр дагавар

Үйлдэл ба үр дагаврын холбоог заримдаа ургац хураалтын хууль гэж нэрлэдэг. Орчин цагийн илчлэлтэд үүнийг: “Та нар юу тарина, та нар мөн түүнчлэн хурааж авах болно; тиймийн тул, хэрэв та нар сайныг тарьвал та нар шагналдаа түүнчлэн сайныг хурааж авах болно” (С ба Г 6:33) гэж тайлбарлажээ.

3 Нифай 11:31-ийг уншаад Есүс Христ хүмүүст хандан юуг тунхаглах гэж байсныг ол.



3. 3 Нифай 11:32–39-д цэдэглэгдсэнээр Есүс Христ “Эцэгийн [Түүнд] өгсөн” (3 Нифай 11:32 Өөрийн сургаалыг тунхагласан юм). Дараах хүснэгтийг судар судлах тэмдэглэлдээ хуулж бич. Судрын эшлэл бүрийг уншиж, Есүс Христ Өөрийн сургаалтай холбогдуулан заасан үйлдлүүд ба тэдгээрийн үр дагавруудыг олж мэд. Жагсаалтаас олсон зүйлээ судар судлах тэмдэглэлдээ бич.

	Үйлдлүүд	Үр дагаврууд
3 Нифай 11:32–34		
3 Нифай 11:35–36		
3 Нифай 11:37–38		
3 Нифай 11:39–40		

Та нарын жагсаалтын дагуу Тэнгэрлэг Эцэгийн бүх хүүхдүүд тэнгэрийн хаант улсад орохын тулд ямар чухал үйлдлүүдийг хийх ёстой хэмээн Есүс Христ заасан бэ?

Та 3 Нифай 11:32-т **Ариун Сүнс Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрыг гэрчилдэг гэсэн байгааг анзаарсан байх.** Хамгийн сүүлд Ариун Сүнс танд Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрын үнэн чанар болон хайрыг гэрчилсэн тохиолдлыг тунгаан бод.

3 Нифай 12:1–16

Есүс Христ Өөрийнх нь сургаалын дагуу амьдарвал бидний хүлээн авах адислалуудын тухай цугласан олонд заав

Үнэн, худал гэсэн хоёр үгийн аль тохирохыг ашиглан доорх хариултуудыг дугуйл.

- Үнэн Худал Тэнгэрлэг Эцэг биднийг төгс байхыг хүсдэг.
- Үнэн Худал Бид селестиел хаант улсад орохын тулд энэ амьдралдаа төгс байх хэрэгтэй.
- Үнэн Худал Бид төгс болж чадна.

Хариултуудыг шалгахдаа эхлээд 3 Нифай 12:48-ыг унш. (Энэ бол төгс эзэмших судар. Та дараа нь үүнийг амархан олохын тулд тусгайлан тэмдэглэх хэрэгтэй.)



Төгс байх нь ямар учраас боломжтой байдаг вэ? Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Рассэлл М.Нэлсон төгс байх зарлигийн талаар дараах үгсийг

хэлжээ: “Төгс төгөлдөр болох бидний чин сэтгэлийн хүч чармайлт одоогоор хэрээс хэтэрсэн [дэндүү хэцүү] юм шиг, бүр эцэс төгсгөлгүй юм шиг санагдсан ч бид шантрах ёсгүй. Төгөлдөржилт бол хожим ирэх зүйл юм. Энэ нь зөвхөн Их Эзэнээр дамжин амилуулалтын дараа бүрэн хэрэгжих бөгөөд Түүнийг хайрладаг бөгөөд зарлигуудыг нь дагадаг бүх хүмүүсийг хүлээж байдаг” (“Perfection Pending,” *Ensign*, 1995 оны 11-р сар, 88).

Дараах асуултыг тунгаан бод: Төгөлдөржилт “зөвхөн Их Эзэнээр дамжин” ирнэ гэдэг нь юу гэсэн утгатай гэж та боддог вэ?

Өмнөх үнэн, худал гэсэн асуулт хариултыг эргэж хараад 3 Нифай 12:48 ба ахлагч Нэлсоны хэлсэн үгсээс сурсан зүйл дээрээ үндэслэн хариултаа өөрчил.

3 Нифай 12–14-р бүлгүүд дэх Есүс Христийн сургаалуудыг заримдаа “ариун сүм дэх номлол” гэж нэрлэдэг. Учир нь тэдгээр нь уулан дээрх Аврагчийн алдартай номлолтой (Матай 5–7-р бүлгүүдийг үзнэ үү) ойролцоо бөгөөд энэхүү номлолын талаарх бидний ойлголтыг гүнзгийрүүлдэг билээ. Ерөнхийлөгч Харолд Б.Лий ингэж заажээ: “Эзэн уулан дээрх номлолдоо, Өөрийн төгс зан чанарын талаар бага зэргийн илчлэлт эсвэл ‘үгийн үе бүрийг үйлсээрээ бичсэн намтраа’ бидэнд өгсөн бөгөөд тэр нь бидний амьдралд даган дуурайх загвар болдог” (*Decisions for Successful Living* [1973], 56). 3 Нифай 12–14-р бүлгүүдийг судлахдаа төгс төгөлдөр болохыг хичээхдээ ямар арга замуудыг хэрэглэхийг Аврагч танаас хүссэнийг олж мэд.

Аврагч Уулан дээрх номлолдоо ашигласан шиг, итгэлтэй хүмүүст өгөгдсөн адислал ба баяр баясгалангийн амлалт болох нэлээд хэдэн ерөөлөөр нифайчуудад хийсэн номлолоо эхэлжээ (3 Нифай 12:1–12-ыг үзнэ үү). Та эдгээр ерөөлүүдийг уншихдаа Аврагч бидэнд ямар чанаруудыг хөгжүүлэхийг чин сэтгэлээсээ хүссэнийг, бид эдгээр чанаруудыг хөгжүүлснээр ямар адислалуудыг авна гэж Тэр амласныг олж мэд. Та уншихдаа эдгээр чанарууд болон амлагдсан адислалуудыг тэмдэглэж авах хэрэгтэй. *Сүнсэндээ ядуу* (3 Нифай 12:3) гэдэг нь даруу бөгөөд Бурханаас хамааралтай, *гашуудах* (3 Нифай 12:4) гэдэг нь гэм нүгэлдээ харамсах мэдрэмж бөгөөд тэр нь наманчлалд хүргэдэг, *хүлцэнгүй номхон* (3 Нифай 12:5) байх нь даруу, номхон дөлгөөн байх, Бурханы хүсэлд дуулгавартай байх эсвэл дургүйцэл гомдолгүйгээр шударга бус явдлыг даван туулахдаа тэвчээртэй байх гэсэн утгуудыг тус тус илэрхийлдэг.



4. Та сая уншсан чанаруудаас олж авахыг хүсч байгаа эсвэл олж авахаар хичээн чармайх нэг чанарыг олж мэд. Та уг чанарыг хөгжүүлснээр хүлээн авсан эсвэл хүлээн



авна гэж найдаж байгаа адислалуудаа судар судлах тэмдэглэлдээ бич.

Хэрэв бид Есүс Христийн сургаалын дагуу амьдарвал адислагдаж, тэнгэрийн хаант улсад ороход бэлтгэгдэнэ гэдгийг 3 Нифай 12:1–12-р шүлгүүд дэх олон үнэнээс сурсан билээ. Бид ингэснээрээ дэлхийд үлгэр жишээ эсвэл гэрэл гэгээ байх болно (3 Нифай 12:14–16-г үзнэ үү).

3 Нифай 12:17–48

Есүс Христ Түүнтэй болон Тэнгэрлэг Эцэгтэй адилхан болоход туслах илүү өндөр түвшний хуулийг цугласан олонд заав

Есүс Христ нифайчуудад наманчилж, Түүний зарлигуудыг дагаснаар хэрхэн Түүнд ирэхийг заасан (3 Нифай 12:19–20-ийг үзнэ үү). 3 Нифай 12-р бүлгийн үлдсэн хэсэгт, Тэр Мосегийн хуулийн заалтуудыг дурдаад дараа нь илүү өндөр түвшний хуулийг заажээ. Тэрээр Мосегийн хуулийн заалтуудыг танилцуулахдаа “хуучин цагийн тэднээр хэлэгдсэнийг” эсвэл “бичигдсэнийг” гэх мэт үгсийг ашигласан юм. Тэгээд Тэрээр өнөөдөр биднийг сахиж амьдраасай гэж хүссэн тэрхүү шинэ бөгөөд илүү өндөр түвшний хуулийг танилцуулахдаа, “би та нарт хэлнэ . . .” гэсэн хэллэгийг ашигласан байна.



5. Дараах судрын эшлэлүүдийг уншаад ямар зан төлөв төгөлдөржилтөд хүргэдэг гэж Аврагч хэлснийг судар судлах тэмдэглэлдээ бич:

а. 3 Нифай 12:21–22. *Хоосон толгой* гэдэг үг нь басамжилсан, илт дургүйцсэн эсвэл үзэн ядалтыг илэрхийлсэн доромжилсон хэллэг болохыг ойлгох нь зүйтэй.

б. 3 Нифай 12:23–24. 24а зүүлт тайлбарыг хэн нэгэнтэй эвлэрнэ гэдэг нь юу гэсэн утгатай болохыг олж мэдэхэд ашигла.

в. 3 Нифай 12:25. “Өстөнтэйгээ . . . хурдхан эвлэр” гэсэн нь бусадтай зөрчилддөг асуудлаа хурдан шийдвэрлэх, энэ нь цаашид үргэлжилж, илүү том асуудал болохгүй байх ёстойг хэлж байгааг ойлгох хэрэгтэй. Ахлагч Дэвид Ю.Сорэнсэн, Далын гишүүнээр үйлчилж байхдаа: “Энэ зарчим нь өөр юунаас ч илүүгээр бидний гэр бүлд хамаатай” хэмээн заажээ (“Forgiveness Will Change Bitterness to Love,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2003 оны 5-р сар, 11).

г. 3 Нифай 12:27–30. *Шунал тачаал* нь зохисгүй, хилэнцэт, аминч хүслийг хэлдгийг ойлгох хэрэгтэй.

д. 3 Нифай 12:38–42.

е. 3 Нифай 12:43–45.

3 Нифай 12-р бүлгийн эдгээр шүлгүүдээс бидний сурч болох нэг зарчим бол: **Бид Христэд ирж, Түүний зарлигуудыг сахивал төгс төгөлдөр хүмүүс болж, Түүнтэй болон Тэнгэр дэх Эцэгтэйгээ илүү адилхан болж чадна** гэсэн зарчим юм.



Бид энэ амьдралд биш ч гэсэн ирэх амьдралд төгс төгөлдөр болохын тулд одоо л энэ тал дээр ахиц дэвшил гаргахыг хичээх ёстой хэмээн Тэргүүн Зөвлөлийн Ерөнхийлөгч Жэймс Э.Фауст тайлбарласан юм: “Төгөлдөржилт нь мөнхийн зорилго юм. Бид мөнх бус амьдралдаа төгс төгөлдөр болж чадахгүй ч төгөлдөржилтийн төлөө хичээн чармайх нь Цагаатгалаар дамжуулан бидний сахиж чадах зарлиг юм” (“This Is Our Day,” *Ensign*, 1999 оны 5-р сар, 19).

Төгс эзэмших судар—3 Нифай 12:48



6. 3 Нифай 12:48-р шүлгийг үг үсэгчлэн цээжлээрэй. Энэ шүлгийг цээжлээд судар судлах тэмдэглэлдээ бич.

Их Эзэн биднийг мөнх бус амьдралдаа бүх зүйлд төгс болохыг шаарддаггүй. Харин бид Түүнийг

дагаж, Цагаатгалын адислалаас хүртэхийг хичээн чармайвал эцэстээ төгс төгөлдөр болно гэдгийг санагтун.



7. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би 3 Нифай 11:18–12:48-р шүлгүүдийг судалж энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

25-Р ХЭСЭГ: 2 ДАХЬ ӨДӨР

3 Нифай 13

Оршил

3 Нифай 14-р бүлэгт цэдэглэгдсэнээр Аврагч Өгөөмөр нутгийн ариун сүмд номлолоо үргэлжлүүлэв. Тэр хүмүүсийг хоёр нүүр гаргахаас сэрэмжлүүлээд тэдний зөв шударга үйлс Тэнгэрлэг Эцэгийн таалалд нийцдэгийг заажээ. Тэр мөн цугласан олонд тэнгэрийн баялаг хураахыг зааварчлаад Өөрийн арван-хоёр шавийг дэлхийн зүйлсэд санаа зовохоосоо өмнө эхлээд Бурханы хаант улсыг эрэлхийлэхийг сургав.

3 Нифай 13:1–18

Аврагч нифайчуудыг хоёр нүүр гаргахаас сэрэмжлүүлээд, Тэнгэрлэг Эцэгийн таалалд нийцэх зөв шударга үйлс бүтээхийг тэдэнд заажээ.

Таны өглөг өгөх (бусад буян үйлдэх), залбирах, мацаг барих учир шалтгааныг дараах өгүүлбэрүүдийн аль нь хамгийн сайн тодорхойлж байгааг дотроо сонгож, доорх үнэлэлтийг өөртөө өг:

Би өглөг өгдөг, яагаад гэвэл:

- Би өглөг өгөх ёстой учраас.
- Би Бурханд хайртай бөгөөд бусад хүмүүст туслах нь сайхан байдаг.
- Би бусад хүмүүс намайг сайнаар бодоосой гэж хүсдэг.

Би залбирдаг яагаад гэвэл:

- Намайг залбирал хэлээч гэхэд би бусад хүмүүсийн өмнө “үгүй” гэж хариулахыг хүсдэггүй.
- Залбирал бол зүгээр л миний өдөр тутам хийдэг зүйл.
- Би Тэнгэрлэг Эцэгтэйгээ харилцахыг хүсдэг.

Би мацаг барьдаг яагаад гэвэл:

- Мацаг барилт нь надад Их Эзэнтэй илүү ойр болоход тусалдаг.
- Хэрэв би мацаг барихгүй бол бусад хүмүүс намайг муу хэлнэ.
- Мацаг барих ёстой үед эцэг эх маань намайг юм идүүлдэггүй.

3 Нифай 13-р бүлэгт, Есүс Христ Нифай үндэстний цугласан олонд өглөг өгдөг, залбирдаг болон мацаг барьдаг шалтгаануудын ач холбогдлыг заажээ. Дээрх өөртөө үнэлэлт өгөх хариултууд нь шашны эдгээр болон бусад зан үйлийг гүйцэтгэх бидний учир шалтгаан өөр өөр байдгийг харуулдаг.



1. Дараах асуултуудад судар судлах тэмдэглэлдээ хариулж бич: Бид зөв шударга үйлс хийх нь яагаад чухал вэ? Яагаад эсвэл яагаад үгүй гэж?



2. Дараах жишиг зургийг судар судлах тэмдэглэлдээ хуулаад судрын эшлэл бүрийг уншиж, хоёр асуултад хариулан нөхөж бөглөөрэй. Та уншихдаа хоёр нүүртэн гэдэг нь зөв шударга хүний дүр эсгэдэг эсвэл нэгийг хэлж нөгөөг хийдэг хүнийг хэлдгийг мэдэх нь зүйтэй.

Үйл ажиллагаа	Энэ үйл ажиллагааг хийхдээ ямар зорилготой байх ёсгүйг Их Эзэн анхааруулсан бэ?	Их Эзэн биднийг энэ үйл ажиллагааг хэрхэн хийх ёстой гэсэн бэ?
Өглөг өг (3 Нифай 13:1–4)		
Залбир (3 Нифай 13:5–6)		
Мацаг барь (3 Нифай 13:16–18)		

Дараах асуултуудыг тунгаан бод:


- Зөв шударга үйлсийг бүтээх бидний учир шалтгаан тэдгээрийг хийхэд хэрхэн нөлөөлж болох вэ?
- Хэн нэгэнд нууцаар өглөг өгч, залбирч, мацаг барихыг сүнслэгээр урамшуулдаг ямар зөв шударга учир шалтгаанууд байдаг вэ?

Эдгээр зүйлсийг хийх нэг зөв шалтгаан бол Тэнгэрлэг Эцэгээ баярлуулах явдал юм. 3 Нифай 13:4, 6, 18-ыг уншаад хувиараа зөв шударга үйлс бүтээдэг хүнд Их Эзэн юу амласныг олж мэд.

Эдгээр шүлгүүдэд Аврагчийн заасан нэг чухал зарчим нь: **Хэрэв бид Тэнгэрлэг Эцэгийг хайрладаг**




учраас зөв шударга үйлсийг хийвэл Тэр биднийг ил тод шагнана гэсэн зарчим юм.

 **3.** Та бусдад харуулахын тулд биш харин Тэнгэрлэг Эцэгийг баярлуулахын тулд ямар нэг зүйл хийхийг хичээснээрээ адислагдсан тохиолдлынхоо тухай судар судлах тэмдэглэлдээ бич.

Энэ хичээлийн эхэнд өгөгдсөн өөрийгөө үнэлэх сорилыг товчхон дахин нэг хараад өөрийнхөө өглөг өгөх, залбирах болон мацаг барих шалтгаанууддаа үнэлэлт өг. Эдгээрийг болон Их Эзэнд зориулсан бусад зан үйлүүдийг хийдэг учир шалтгаанаа сайжруулахын тулд Аврагчийн сургаалуудыг хэрхэн хэрэгжүүлэхээ эргэцүүлэн бод.

Аврагч нифайчуудад залбирлын тухай нэмэлт зааврыг өгчээ. 3 Нифай 13:7-г уншаад залбиралд дахин давтагдсан эсвэл ойлгоход төвөгтэй хэллэгүүд хүний чин сэтгэлийг илэрхийлдэггүйг Их Эзэн хэрхэн дүрсэлснийг олж мэд. *Хоосон* гэдэг үг нь хоосон хөндий, бодолгүй эсвэл мэдрэмжгүй гэсэн утгатай. Хоосон давталт нь адил утгатай үгсийг бодлогогүйгээр давтан хэлэх эсвэл итгэлгүйгээр залбирал хэлэх гэсэн утгыг бас илэрхийлдэг.

 **4.** Дараах асуултуудад судар судлах тэмдэглэлдээ хариулж бич:

- a.** Тэнгэрлэг Эцэгт хандан залбирахдаа хоосон давталтаас зайлсхийх нь яагаад чухал гэж та бодож байна вэ?
- б.** Та залбирахдаа хоосон давталтаас зайлсхийхийн тулд юу хийж болох вэ?


3 Нифай 13:8-ыг уншаад Есүс Христ Тэнгэрлэг Эцэгийн тухай хэлсэн зарчмыг олж мэд. Энэ зарчмыг судартаа тэмдэглэ. Бидний залбирлын нэг зорилго нь “хэрэв бид итгэлээр асуух аваас Бурхан аль хэдийн өгөхөөр бэлтгэсэн адислалуудыг өөрсдөдөө болон бусдад баталгаатай болгох явдал” юм (Судруудын Удирдамж, “Залбирал”-тай харьцуул).

3 Нифай 13:9–15-ыг уншаад Их Эзэн танаас залбирлын тухай сурахыг хүсдэг зүйлсийг тунгаан бод. Аврагчийн сургаалуудаас сурч мэдсэн зүйлээ хэрэгжүүлэн залбирлаа сайжруулах арга замуудын тухай бод.

3 Нифай 13:19–24

Есүс Христ цугласан олонд тэнгэрийн баялаг хураахыг заасан нь

Та алдагдсан эсвэл газарт булагдсан баялгийн тухай түүхийг ер нь уншиж эсвэл сонсч байсан уу? Заримдаа эдгээр түүхүүдэд эрдэнэс баялаг хайгчид тэрхүү үнэт баялаг нь алга болсон эсвэл тийм эрдэнэс ерөөсөө байгаагүйг эцэст нь олж мэддэг. 3 Нифай 13:19–20-ийг уншаад Их Эзэний ярьсан хоёр төрлийн баялгийг олж мэд. Хэрэв бид хайвал тэдгээр баялгуудаас аль нь үргэлж байх болно хэмээн Тэр хэлсэн бэ?

 **5.** Дараах асуултуудад судар судлах тэмдэглэлдээ хариулж бич:

- a.** “Дэлхийн баялаг,” “тэнгэр дэх баялаг” хоорондоо ямар ялгаатай вэ?
- б.** 3 Нифай 13:21–24-р шүлгүүдээс таны сурснаар дэлхийн болон тэнгэрийн баялгийг эрэлхийлэх талаар Аврагчийн заасан зарим үнэнүүд юу вэ? (*Маммон* гэдэг үг дэлхийн байдал эсвэл эд хөрөнгө гэсэн утгатайг мэдэх нь эдгээр шүлгүүдийг сайн ойлгоход тусална.)
- в.** Дэлхийн баялгийг эрэлхийлэх нь биднийг тэнгэр дэх баялгийг эрэлхийлэхээс хэрхэн хөндийрүүлдэг вэ?

Аврагч мөнгө эсвэл дэлхийн эд баялаг нь хилэнцэт хэмээн заагаагүй юм. Харин Тэрээр биднийг дэлхийн баялагт бус, үрэгдэж үгүй болохгүй тэнгэрлэг баялагт зүрх сэтгэлээ зориулахын ач холбогдлыг онцлон тэмдэглэсэн юм.

3 Нифай 13:19–24-р шүлгүүдээс бидний сурч болох нэг зарчим бол: **Бид Бурханыг өөрсдийн эзэн байлгахын тулд Түүнийг дэлхийн бүх зүйлсээс**

илүү хайрлаж, Түүнд үйлчлэх ёстой гэсэн зарчим мөн.

Бурханд болон эд баялагт нэг зэрэг үйлчлэхийн ямар жишээнүүд байж болох вэ? Дэлхийн зүйлсийг биш харин Бурханыг үргэлж хайрлаж, Түүнд үйлчлэх нь яагаад хэцүү байж болох вэ? Бурханыг эн тэрүүнд тавих нь яагаад үнэ цэнэтэй вэ?



6. Дараах жишээнүүдийг унш. Тухайн хүн аль эзэнд үйлчилж байгааг судрын тэмдэглэлдээ тэмдэглэ: Бурханд эсвэл эд баялагт (дэлхийн байдалд).

а. Нэг залуу эрэгтэй ням гаргийн цуглааныг таслахыг шаарддаг ажлаас татгалзаж, оронд нь бага цалинтай ч цуглаануудыг таслахыг шаарддаггүй ажлыг сонгожээ.

б. Нэг залуу эмэгтэй түүнд шинэ хувцас хэрэгтэй байна гэж эцэг, эхдээ байнга гомдоллодог ажээ. Гэвч авахыг хүссэн хувцаснууд нь гэр бүлийнх нь бэл бэнчингээс хэтэрсэн өндөр үнэтэй гэнэ.

в. Нэг залуу эрэгтэй цалингаасаа аравны нэгээ тогтмол төлдөг. Гэвч цалингийнхаа үлдсэн хэсгийг зарим зохисгүй кино, дуу хөгжим зэрэг үзвэр, зугаа цэнгээний зүйлс худалдан авахад зарцуулдаг атлаа номлолдоо эсвэл боловсролдоо зориулан мөнгө хадгалдаггүй гэнэ.

г. Нэг залуу эмэгтэй мөнгөө бусдад хайраа үзүүлэхийн тулд жижиг сажиг бэлэгнүүд авахад байнга зарцуулдаг.

3 Нифай 13:25–34

Аврагч арванхоёр шавьдаа хувийнхаа хэрэгцээнд санаа тавихаасаа тэрүүнд Бурханы хаант улсыг эрэлхийлэхийг заадаг



Есүс Христ арванхоёр Нифай үндэстэн шавь нартаа тэднийг хүмүүсийн дунд үйлчлэхээр явахад махан биеийн хэрэгцээ болох хоол хүнс, хувцас хунартаа санаа зовох хэрэггүйг зааварчилжээ (3 Нифай 13:25–31-ийг үзнэ үү). 3 Нифай 13:32–33-ыг уншаад Аврагч шавь нартаа махан биеийнх нь хэрэгцээний тухай юу гэж хэлснийг олж мэд. Бурхан болон

Түүний хаант улсыг амьдралдаа нэгдүгээрт тавьдаг хүмүүст Тэр юу амласан бэ?

Эдгээр шүлгүүдээс бидний сурах нэг зарчим бол: **Хэрэв бид хамгийн тэрүүнд Бурханы хаант улсыг эрэлхийлбэл Тэр бидэнд хэрэгцээгээ хангахад тусална** гэсэн зарчим юм.



7. Дараах асуултуудад судар судлах тэмдэглэлдээ хариул:

а. Хүн хэрхэн “Бурханы хаант улсыг эхлээд . . . эрэлхийлэх” вэ? (3 Нифай 13:33).

б. Таныг амьдралдаа Их Эзэнийг нэгдүгээрт тавихад Тэр таны хэрэгцээнд ямар арга замуудаар санаа тавьсан бэ?

Бид Бурханыг амьдралдаа нэгдүгээрт тавьснаар ирэх адислалуудын талаар Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон ингэж гэрчилжээ (та дахиж унших эсвэл хуваалцахын тулд энэ хэлсэн үгийг цаасан дээр бичээд судрууддаа хадгал):



“Бид Бурханыг нэгдүгээрт тавьсан үед бусад бүх зүйл зохих байрандаа орох эсвэл бидний амьдралаас гээгдэж алга болдог. Их Эзэнийг хайрлах бидний хайр нь бидний дур хүсэл, цаг зав, сонирхдог зүйлс болон эн тэргүүнд тавих ёстой зүйлсийн дэс дарааг зохицуулах болно. . . .

“Бид Бурхан, сүнсний Эцэгтээ амьдралынхаа хамгийн эрхэм зүйлсийг зориулах ёстой” (“The Great Commandment—Love the Lord,” *Ensign*, 1988 оны 5-р сар, 4–5).

Та болон таны таньдаг хүмүүс Бурханыг амьдралдаа нэгдүгээрт тавьснаар хэрхэн адислагдсаныг тунгаан бод.



8. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би 3 Нифай 13-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

3 Нифай 14

Оршил

3 Нифай 13-р бүлэгт Есүс Христ Ариун сүм дэх номлолоо үргэлжлүүлэв. Тэрээр хүмүүст бусдыг шүүх талаар болон Тэнгэрлэг Эцэгээсээ адислалуудыг залбирлаар дамжуулан эрэлхийлэхийг заав. Аврагч мөн тэднийг хуурамч бошиглогчдоос сэрэмжлүүлж, Бурханы хүслийг биелүүлэхийн ач холбогдлыг онцолжээ.

3 Нифай 14:1–6

Аврагч бусдыг шүүх талаар заасан нь

“Их Эзэн, таныг дагая” (*Нутис*, х. 220) дууллын хоёрдугаар бадгийн үгсийг унших эсвэл тохиромтой гэж үзвэл дуул:

*Өөрөө би төгс биш байж
Өрөөлийг шүүх би хэн билээ?
Нүд үл харах уй гашиу
Тайван зүрхэнд далд нуугджээ.
Өрөөлийг шүүх би хэн билээ?
Их Эзэн, таныг дагая*

3 Нифай 14-р бүлэгт цэдэглэгдсэнээр Аврагч ариун сүмд нифайчуудад үргэлжлүүлэн заав. 3 Нифай 14:1–2-ыг уншаад Аврагчийн энэхүү заавар таны уншсан дууллын хоёрдугаар бадагтай ямар уялдаатайг бод. (“Та ямар хэмжээгээр хэмжинэ” гэдэг хэллэг нь хүн бусад хүмүүсийг хэмжихдээ эсвэл шүүхдээ хэрэглэдэг жишгийг илэрхийлдгийг ойлгох хэрэгтэй.)



1. Дараах асуултуудын хариулыг судар судлах тэмдэглэлдээ бич.

а. 3 Нифай 14:1–2-р шүлгүүд дэх Аврагчийн зөвлөгөө “Их Эзэн, таныг дагая” дууллын хоёрдугаар бадагтай хэрхэн холбогдож байна вэ?

б. Та 3 Нифай 14:2-т Аврагчийн заасан чухал үнэнийг хэрхэн өөрийнхөө үгээр илэрхийлэх вэ? (Та энэхүү үнэн эсвэл зарчмыг судрынхаа захад бич.)

3 Нифай 14:1-р шүлэг дэх “бүү шүүгтүн” гэсэн Аврагчийн зарлигийг ойлгоход бидэнд туслахын тулд Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Даллин Х. Өүкс үзэл бодлоо хуваалцжээ. Та уншихдаа биднийг зайлсхийх ёстой гэж түүний хэлсэн шүүлтийн төрлүүдийг болон яагаад гэдгийнх нь доогуур зур.



“Хоёр төрлийн шүүлт байдаг: Бид хийх нь хориотой эцсийн шүүлт ба зөв шударга зарчмууд дээр үндэслэн, хийхийг бидэнд зааварласан завсрын шүүлт гэж байдаг. . . .

“Эцсийн шүүлт . . . нь бид бүгд ажил үйлсийнхээ дагуу шүүгдэхээр Христийн шүүлтийн суудлын өмнө зогсох ирээдүйн үйл явдал юм. . . . ‘Бүү шүүгтүн’ гэсэн судрын зарлиг нь энэхүү эцсийн шүүлттэй маш тодорхой холбоотой гэдэгт би итгэдэг. . . .

“ . . . Аврагч яагаад биднийг эцсийн шүүлтийг хийхгүй байхыг зарлиг болгосон юм бол? Энэхүү зарлиг нь бид хэн нэгэн хүнийг аль нэг үйлдлийнх нь төлөө эсвэл тодорхой нэг цагт тамд (эсвэл тэнгэрт) очно гэж хэлэх юм бол эцсийн шүүлт хийх үүргийг өөртөө авч байгаа хэрэг болох учраас эцсийн шүүлтийг хийхгүй байх зарлиг өгөгдсөн гэдэгт би итгэдэг. Хэрэв бид ингэх юм бол өөрийгөө болон зүй бусаар шүүж буй тэр хүнийг гомдоох болно. Ийм уруу таталт их байдаг. . . .

“ . . . Завсрын шүүлт шударга байх ёстой. Ийм шүүлт нь хэн нэг хүнийг өргөмжлөл хүртэнэ эсвэл тамын галд эргэлт буцалтгүйгээр хаягдана хэмээн мэдэгдэхээс татгалздаг. Хэн нэг хүнийг өргөмжлөлийн бүх боломжоо алдсан эсвэл Их Эзэний ажилд чухал үүрэг гүйцэтгэх боломжоо алдсан хэмээн мэдэгдэхээс татгалздаг. “Сайн мэдээ бол найдварын сайн мэдээ бөгөөд бидний хэн нь ч хувийн нүглүүдээс цэвэршүүлэх, уучлал болон зохих нөхцөл дэх амьдралын шинэчлэлтийг авчирдаг Цагаатгалын хүчийг үгүйсгэх эрхгүй” (“Judge Not’ and Judging,” *Ensign*, 1999 оны 8-р сар, 7, 9).

Ахлагч Өүксийн хэлсэн үгс “бүү шүүгтүн” гэсэн Аврагчийн зарлигийг ойлгоход хэрхэн туслахыг тунгаан бод.



2. Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултуудад хариул: 3 Нифай 14:2-р шүлэг дэх **Бид хэрхэн шүүдгийнхээ адил шүүгдэх болно** гэсэн зарчим нь бусдын алдаа, сул талуудыг харах өнцгийг хэрхэн өөрчилж чадах вэ? 3 Нифай 14:12-р шүлгийг унш. Энэ шүлэг өмнө өгүүлсэн зарчимтай хэрхэн холбогдож байна вэ?

Сормуус эсвэл тоосонцор зэрэг жижиг зүйл таны нүдэнд орж байсан уу? Судрууд нүдэнд орсон зүйлийг *үртэс гэдэг*. Урт, зузаан модны тайрдсыг *дүнз гэдэг*. Бид бусдыг шударга бусаар шүүхэд эсвэл тэднээс зүй зохисгүйгээр алдаа дутагдал хайхад бий болох асуудлуудыг ойлгоход бидэнд туслахын тулд Аврагч эдгээр дүрслэлийг ашиглажээ. 3 Нифай 14:3–5-ыг уншаад үртэс болон дүнз юуг төлөөлж байгааг бод.



3. Судрын тэмдэглэлдээ 3 Нифай 14:4-т Аврагчийн дүрсэлсэн зүйлсийн зургийг зур. Тэгээд дараах асуултуудад хариул:

а. Үртэс юуг төлөөлдөг вэ?

б. Дүнз юуг төлөөлдөг гэж та бодож байна?

в. Яагаад үртэснээс илүү дүнз нь бусдыг шударга бусаар шүүсэн хүмүүсийн алдааг дүрслэхэд хэрэглэгддэг гэж та бодож байна вэ?

Аврагчийн адилтгал нүдэнд ордог зүйлс дээр төвлөрснийг ажигла. Гиймээс тэр зүйл нүдний хараанд нөлөөлдөг. Өөрийнхөө тухай дараах асуултуудыг тунгаан бод: Миний алдаа дутагдал бусдыг ойлгоход надад хэрхэн нөлөөлдөг вэ? Би 3 Нифай 14:5-р шүлэг дэх Есүс Христийн зөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлж болох вэ?

Та бусад хүмүүсийн зан төлөвийг шүүмжлэх ер нь зохистой эсвэл шаардлагатай гэж бодож байна уу? Бошиглогч Иосеф Смит бид бусдыг шударга бусаар шүүх ёсгүй, харин шударгаар шүүхийг бидэнд зааварласан байдаг гэдгийг тайлбарласан юм (Иосеф Смитийн Орчуулга, Матай 7:1 [Матай 7:1-ийн зүүлт тайлбар а]-г үзнэ үү).

Дараах тайлбар бусдыг шүүх тухай асуултад нэмэлт санааг өгдөг: “Заримдаа хүмүүс бусдыг ямар нэг байдлаар шүүх нь буруу гэж үздэг. Та бусдыг шударга бусаар буруутгах эсвэл шүүх ёсгүй ч амьдралынхаа турш бодол санаа, нөхцөл байдал, хүмүүсийн талаар шүүн тунгаах хэрэгтэй болно. Их Эзэн бидэнд шүүн тунгаахгүйгээр сахиж болохооргүй олон зарлигийг өгсөн билээ” (*Итгэлдээ үнэнч байх нь: Сайн мэдээний эшлэл* [2004], 90).

Зөв шударгаар шүүхийн чухлыг ойлгохын тулд 3 Нифай 14:6-г уншаад Есүс Христ бидэнд хийхийг зааварласан зарим шүүлтийг олж мэд. Та уншихаасаа өмнө “ариун зүйлсийг ноход . . . өгөх,” “гахайн өмнө сувд . . . хаях” гэдэг нь ариун нандин зүйлсийг үнэлдэггүй эсвэл ариун байдлыг нь ойлгодоггүй хүмүүстэй ямар нэг нандин зүйлийг хуваалцах ёсгүй гэсэн утгатайг ойлгох хэрэгтэй.

3 Нифай 14:6 зөв шударгаар шүүх шаардлагыг ойлгоход тань хэрхэн тусалдаг вэ? Бид зөв шударгаар шүүх ёстой бусад нөхцөл байдлуудын тухай ахлагч Даллин Х.Өүкс ингэж тайлбарлажээ:



“Бид бүгд найз нөхдөө сонгох, цаг зав, мөнгөө хэрхэн зарцуулахыг шийдэхдээ мөн мэдээж мөнхийн ханиа сонгохын тулд сайтар шүүн тунгаадаг. . . .

“ . . . Зөв шударгаар дүгнэн шүүх нь уур хилэн, өс хонзон, атаа жөтөө, амин хувиа хичээсэн үзэл бодлоор бус харин Их Эзэний Сүнсээр удирдагдах ёстой” (“Judge Not’ and Judging,” 9).



4. Дараах асуултуудад судар судлах тэмдэглэлдээ хариул:

а. Найз нөхдөө сонгох, цаг зав, мөнгөө хэрхэн зарцуулахыг шийдэх, мөнхийн ханиа сонгох зэрэгт зөв шударгаар шүүн тунгаах нь яагаад чухал вэ? Бусдын талаар зөв шударгаар шүүх, тохиромжтой зарим жишээ юу байж болох вэ?

б. Та хэрхэн илүү зөв шударгаар шүүж болох вэ? Та илүү энэрэнгүй хандах эсвэл шударга бус шүүлт хийхээс татгалзах хэрэгтэй хүн байгаа эсэхийг тунгаан бод.

3 Нифай 14:7–12

Аврагч Тэнгэрлэг Эцэгээс адислалуудыг эрэлхийлэх тухай заасан нь

Тэнгэрлэг Эцэг залбиралд тань хариулсан тохиолдлуудын тухай бод. 3 Нифай 14:7–11-ийг уншаад Тэнгэрлэг Эцэг бидний залбиралд хариулахыг хүсдэг тухай Аврагч юу гэж заасныг олж мэд.

3 Нифай 14:7–11-р шүлгүүдээс бидний сурч болох нэг зарчим бол **Тэнгэрлэг Эцэг биднийг Түүнээс тусламж гуйн залбирахад адислах болно гэсэн зарчим юм.** Тэнгэрлэг Эцэг залбиралд тань хариулахаар тэсэн ядан хүлээж байдгийг мэдэх нь таны залбирах хандлагыг хэрхэн өөрчилж болох вэ?



5. Итгэл хүлээсэн насанд хүрэгчээс дараах асуулыг асуу: Та хэзээ Тэнгэрлэг Эцэг залбиралд тань хариулсан байдлаар нь таныг гэсэн Түүний хайрыг мэдэрсэн бэ? Судар судлах тэмдэглэлдээ түүний хариулыг болон түүнээс юу сурснаа хураангуйлан бич.

3 Нифай 14:13–27

Аврагч Тэнгэрлэг Эцэгийн хүслийг биелүүлэхийн ач холбогдлыг заасан нь

Аврагч ариун сүмд цугларсан нифайчуудад үргэлжлүүлэн заахдаа Түүний сургаалуудыг дагахын ач холбогдлыг ойлгоход бидэнд туслах хэд хэдэн зүйрлэлийг хэрэглэжээ. Зүйрлэл бүр нь нэг сайн, нэг муу жишээг агуулж байна.



6. Дараах судрын гурван хэсэг бүрд байгаа сайн ба муу зүйлийг судрын тэмдэглэлдээ энгийнээр дүрслэн зур. Мөн сайн ба муу жишээнүүдийг харьцуулснаар Аврагч биднийг юу сураасай гэж хүссэн тухай өөрийн бодлыг бич. Зургаа ангийнхандаа үзүүлж, эдгээр зүйрлэлээс юу сурснаа тайлбарлахад бэлэн бай.

а. 3 Нифай 14:13–14

б. 3 Нифай 14:15–20

в. 3 Нифай 14:24–27

3 Нифай 14:21–23-ыг уншаад Бурханы хаант улсад аврагдахын тулд таны хийх ёстой бүх зүйл бол би Есүс Христэд итгэдэг гэж хэлэх явдал хэмээн ярьж байгаа хүнд та юу хэлэхээ бод.



7. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

3 Нифай 14-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

25-Р ХЭСЭГ: 4 ДЭХ ӨДӨР

3 Нифай 15–16

Оршил

Аврагч Өгөөмөр нутаг дахь ариун сүмд хийсэн номлолоо үргэлжлүүлэхдээ Мосегийн хууль Түүгээр гүйцэлдсэн бөгөөд Тэр бол хүмүүсийн харах ёстой тэрхүү гэрэл ба хууль мөн гэдгийг тунхаглав. Аврагч дараа нь Нифай үндэстэн арванхоёр шавьдаа Америк тив дэх хүмүүс бол Иерусалимын хүмүүст Түүний ярьсан “бусад хоньд” мөн гэдгийг тайлбарлажээ (Иохан 10:14–16-г үзнэ үү). Тэр мөн наманчилж, Түүнд эргэж ирсэн хүмүүс Түүний гэрээт хүмүүсийн дунд тоологдох болно гэж амлав.

3 Нифай 15:1–10

Аврагч Өөрийгөө Мосегийн хуулийг гүйцэлдүүлсэн хэмээн тунхагласан нь

Их Эзэн яагаад аравны нэгээ төлөх, Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь сахих, эцэг эхээ хүндлэх зэрэг тодорхой хууль, зарлигуудыг дагахыг биднээс хүсдэг юм бол гэж та бодож байсан уу? Есүс Христ нифайчуудад цааш нь зааварчлагдаа, Өөрийн хууль, зарлигуудын үндсэн зорилгыг тэдэнд заасан байна. Та 3 Нифай 15-р бүлгийг судлахдаа уг зорилгод анхаарлаа хандуулаарай.

Аврагч цугласан олонд хандан үг хэлэх үеэрээ зарим хүмүүст асуулт байгааг ажиглажээ. 3 Нифай 15:1–2-ыг уншаад хүмүүс юуны талаар хачирхан гайхширч байсныг бич. _____

Мосегийн хуулийн “хуучин зүйлс” улиран одож, “бүх зүйлс шинэ болсныг” Аврагч тунхаглахад нифайчууд яагаад ихэд гайхсаныг ойлгохын тулд тэд олон зууны турш Мосегийн хуулийг мэддэг мөн уг хуулийн дагуу амьдардаг байсныг ойлгох хэрэгтэй. Тэдний хууль, ёслолууд болон сүмийн зохион байгуулалт нь Мосегийн хууль дээр тулгуурладаг байлаа. Уг хуулийг мөнх бус байдлын өмнөх Есүс Христ эрт дээр үед хүмүүсийн анхаарлыг Түүний



ирэлтэд бэлтгэх болон Түүний цагаатгагч золиослолд хандуулахад туслахын тулд өгсөн юм. Тэр үед Бурханлаг Хууль Өгөгч нь тэдний өмнө зогсоод Цагаатгал хийгдсэнийг (3 Нифай 11:10–14) мөн Түүгээр Мосегийн хууль гүйцэлдсэнийг зарлаж байлаа (3 Нифай 9:16–20; 12:46–47-г үзнэ үү). Мосегийн хуулийн хуучин зүйлс “улиран одож,” тэр хуулийн оронд шинэ зүйлс бий болсон тухай Түүний тунхаглал нь Бурханыг шүтэн бишрэх тэдний арга замыг гэнэт өөрчилжээ.

Аврагч маш чухал сургаалыг онцлон тэмдэглэснээр тэдний санаа зовнилд хариулсан юм. 3 Нифай 15:3–5, 9-ийг уншаад нифайчуудад өгсөн Аврагчийн хариулт дахь хуулийн эх сурвалж нь өөрчлөгдөөгүй гэдгийг ойлгуулсан хэллэгүүдийг тодруул.



1. Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултад хариул: Есүс “Би бол хууль” хэмээн хэлэхдээ нифайчуудад юуг заасан гэж та бодож байна? (3 Нифай 15:9).

Есүс Христ бол сайн мэдээний бүх хууль, зарлигуудын хөдөлгөгч хүч юм гэдгийг бид эдгээр шүлгүүд дэх Аврагчийн сургаалаас сурч болно. Мосегийн хуучин хууль илүү өндөр түвшний хуулиар солигдож, тэдний бишрэн шүтэх арга барил өөрчлөгдсөнийг нифайчууд мэдэхэд энэхүү үнэн яагаад чухал байсныг тунгаан бод.

3 Нифай 15:9–10-ыг уншаад Их Эзэн биднийг энэ сургаалын үр дүн болгож юу *хийхийг* хүссэнийг тэмдэглэ. Эдгээр шүлгүүдээс сурсан зүйлээ ашиглан, дараах зарчмыг гүйцээж бич: **Хэрэв бид _____ сахиснаар Есүс Христэд _____ Тэр бидэнд _____ өгөх болно.**



2. Аравны нэгээ төлөх, Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахих, эцэг эхээ хүндлэх зэрэг тодорхой зарлигуудын талаар бодоод судар судлах тэмдэглэлдээ дараах асуултуудад хариул.

а. Хэн нэгэн зарлигуудыг сахидаг боловч Есүс Христэд ханддаггүй байж болох уу?

б. Хэрэв бидний анхаарал зөвхөн дүрмүүдийг сахихад төдийгүй бас Есүс Христэд найдахад төвлөрвөл бидний зарлигуудад дуулгавартай байх нь ямар байдлаар өөрчлөгдөж болох вэ?

Хэрэв бид Есүс Христэд найдах юм бол зарлигуудыг дагах бидний дуулгавартай байдал өөрчлөгдөх нэг арга зам нь бидний дуулгавартай байдлын учир шалтгаан үүрэг хариуцлагаас дүрмийг хайрлах хайр, бүр Их Эзэнийг хайрлах хайр болж өөрчлөгдөх явдал мөн.



Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Марвин Ж. Аштоны хэлсэн дараах үгсийг унш: “Хэрэв бид өөрсдийнхөө Аврагч Есүс Христэд найдаж, эцсээ хүртэл тэвчвэл мөнх амьдрал болон өргөмжлөл биднийх байх болно

гэдгийг мэдэх нь ямар сайхан сүнслэг тайтгарал бөгөөд адислал билээ. . . . Бид түүнд найдахад Бурхан бидэнд илүү ойрхон болдог. Бурханд хандах нь бидэнд шахалт шаардлагагүйгээр [ямар нэгэн зүйлийг хүчээр эсвэл дарамтаар хийхгүй байх] үйлчилж, амьдрахыг заадаг” (“There Are Many Gifts,” *Ensign*, 1987 оны 11-р сар, 21).



3. Та яагаад дагах ёстой юм бол гэж боддог нэг зарлигийг сонгоод уг зарлигийг сахих нь таныг Есүс Христ рүү хэрхэн хөтөлдгийг эргэцүүлэн бод. Сонгосон зарлигтаа илүү дуулгавартай байх зорилго тавиад түүнийгээ хэрэгжүүлэх хэдэн санааг бич. Бодол санаагаа судар судлах тэмдэглэлдээ бич.

3 Нифай 15:11–16:5

Есүс Христ шавь нартаа Өөрийн бусад хоньдын тухай ярьсан нь

Та хэзээ нэгэн цагт өөрийгөө мартагдсан эсвэл ганцаардсан юм шигээр бодож, Тэнгэрлэг Эцэг таныг хэн бэ гэдгийг мэддэг эсэхэд эргэлзэж байсан уу? Бид хэдийгээр заримдаа ганцаардаж, бусдаас илүү дорд мэт санагдаж болох ч **Бурхан бүх хүүхдүүдэд санаа тавьж, Өөрийгөө тэдэнд үзүүлдэг.**

Энэхүү үнэний нотолгоог 3 Нифай 15-р бүлгийн үлдсэн хэсэг болон 3 Нифай 16-р бүлгийн эхний хэсгийг судлахдаа анхаар.

Шинэ Гэрээ болон Мормоны Номд цэдэглэгдсэнээр Есүс Христ Хуучин Дэлхийн болон Америк тивийн хүмүүст үйлчилсэн билээ. 3 Нифай 15:11–17-г уншаад Их Эзэн Иерусалим дахь хүмүүст Америк тив дэх Өөрийн хүмүүсийн тухай юу хэлснийг олж мэд.

“Бусад хоньд” гэдэг нь Хоньчин болох Есүс Христийн бусад дагалдагчдыг хэлж байгаа юм. *Хороо* гэдэг үг хонины хашаа боловч энэ тохиолдолд Есүс Христэд итгэлтэй бүлэг хүмүүсийг хэлж байгаа юм. 3 Нифай 15:17-д цэдэглэснээр Их Эзэн Өөрийгөө бусад хоньдоо хэрхэн үзүүлнэ гэж хэлсэн бэ?

Тэнгэрлэг Эцэг яагаад Иерусалим дахь хүмүүст Өөрийн бусад хонины тухай мэдэгдэхгүй байхыг Өөрт нь тушаасныг Есүс Христ тайлбарлажээ. 3 Нифай 15:18–20-ийг уншаад Аврагчийн тайлбарыг тэмдэглэ. Иудейчүүдийн алдсын улмаас нифайчуудын тухай үүнээс илүү мэдлэгийг Эцэг нууцалсныг харахад бид Их Эзэнээс мэдлэг болон үнэнийг хүлээн авах талаар чухал зарчмыг сурч болно. Та эдгээр шүлгүүд дээр үндэслэн дараах зарчмыг хэрхэн гүйцээж бичих вэ? **Бурхан бидэнд мэдлэг болон үнэнийг бидний _____-ын дагуу өгдөг.**

Их Эзэн нифайчуудад тэд бол Иерусалимд Түүний ярьсан бусад хоньд мөн гэдгийг хэлсэн. Иудейчүүд Түүнийг харийн хүмүүсийн (Израил биш) тухай ярьж байсан гэж боджээ. Харийнхан Аврагчийн дуу



хоолойг “сонсохгүй” гэдгийг тэд ойлгоогүй (3 Нифай 15:21–23-ыг үзнэ үү).

3 Нифай 15:24-ийг уншаад Их Эзэн нифайчуудад Өөрийн онцгой анхаарал халамжийг хэрхэн харуулсныг олж мэд.


3 Нифай 16:1–3-ыг уншаад өөр хэн Аврагчийн дуу хоолойг сонссоныг олж мэд. Аврагчийн айлчлан очсон бусад хүмүүсийн тухай судрын цэдэг байхгүй ч Тэр бусад бүлгүүдэд айлчилж, тэднийг Өөрийн “хороонд” авчирсан нь тодорхой юм.

Есүс Христ Өөрийнх нь дуу хоолойг сонсох боломжгүй хүмүүсийн төлөө санаа тавьдгаа хэрхэн харуулдаг вэ? 3 Нифай 15:22–23 ба 3 Нифай 16:4-ийг уншаад Их Эзэн өөрийгөө Харийнханд үзүүлэх болно гэдгээ хэрхэн тунхагласныг ол.

Та 3 Нифай 15, 16-р бүлгээс судалсан зүйлсээс, Бурхан Өөрийн хүмүүст анхаарал тавьж, тэдэнд Өөрийгөө илэрхийлдэг тухай ямар нотолгоог олж харсан бэ? _____

3 Нифай 16:5-ыг уншаад Харийнхан Есүс Христ болон Түүний сайн мэдээний мэдлэгт ирсний дараа эцсийн өдрүүдэд юу тохиолдохыг олж мэд.

Есүс Өөрийн бүх хүүхдүүд болох Израилын угсаа ба Харийнханд нифайчуудаар бичигдсэн Түүний үгсийг өгч адисална гэж амласан билээ. Нифайчуудын бичээсүүд Харийнханыг хөрвүүлэхэд туслах бөгөөд Харийнхан эцсийн өдрүүдэд Израилын угсааг цуглуулахад туслах болно (3 Нифай 16:4–5-ыг үзнэ үү).

 **4.** Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултад хариул: Есүс Христ бид бүгдэд анхаарал тавьдгийг харуулах ямар баталгааг та амьдралаасаа харсан бэ?

3 Нифай 16:6–20


Есүс Христ хожмын өдрүүдэд амьдрах Харийнханд адислалуудыг тунхаглаж, тэднийг сэрэмжлүүлсэн нь

Та урьд нь ямар нэг бүлэг, клуб эсвэл багийн гишүүн болохыг хүсдэг байсан уу? Тодорхой жишээний талаар бод. Гийм бүлгийн гишүүн болоход юу шаардлагатай вэ? Таны гишүүн нь болж болох хамгийн агуу бүлэг бол Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм, Их Эзэний гэрээт хүмүүс юм.

3 Нифай 16:6–7-г уншаад хожмын өдрүүдэд Харийнханы итгэл ба Израилын угсааныханы итгэлгүй байдлаас болж юу тохиолдохыг олж мэд. Тэр үед үл итгэгч Харийнхан эцсийн өдрүүдэд Израилын угсааны гишүүдийг тарааж, тэдэнд муугаар хандах болно гэдгийг ойлгох хэрэгтэй (3 Нифай 16:8–9-ийг

үзнэ үү). Их Эзэн эцсийн өдрүүдэд Өөрийн сайн мэдээг израилчууд болон Харийнханы ёс бусчуудаас буцаан авч, шударга хүмүүст нь илчлэх болно (3 Нифай 16:10–12-ыг үзнэ үү).

3 Нифай 16:13-ыг уншаад Их Эзэний гэрээт хүмүүсийн нэг болоход юу шаардлагатайг олж мэд. 3 Нифай 16:13-аас сурсан зүйлээ ашиглан дараах зарчмыг гүйцээж бич: **Хэрэв бид _____ бид Түүний хүмүүсийн дунд тоологдох болно.**

 **5.** Дараах асуултад судар судлах тэмдэглэлдээ хариул:

a. Та өөрийгөө Их Эзэний гэрээт хүмүүсийн хэсэг гэдгээ яаж мэддэг вэ?

б. Түүний хүмүүсийн дунд тоологдсон нь амьдралыг тань хэрхэн адисалсан бэ?

 **6.** Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би 3 Нифай 15–16-р бүлгүүдийг судалж энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

26-Р ХЭСЭГ: 1 ДЭХ ӨДӨР

3 Нифай 17

Оршил

Аврагч нифайчуудтай өнгөрүүлсэн эхний өдөр дуусах тийшээ хандахад Тэрбээр олон хүмүүс Түүний заасан зүйлсийг бүрэн ойлгоогүйг олж мэдэв. Тиймээс Тэр тэдэнд хэрхэн нэмэлт ойлголт хүлээн авахыг заажээ. Тэрээр Өөрийгөө явах болно гэдгийг мэдэгдэхэд хүмүүс уйлав. Аврагч энэрэнгүй сэтгэлээр дүүрч, тэдэнтэй хамт арай удаан үлдэв. Тэрээр өвчтнүүдийг эдгээж, хүүхдүүдийг адисалж, хүмүүсийн төлөө залбирчээ. Цугласан олон Аврагчтай харилцахдаа Түүнээс баяр баясал, хайр энэрлийг мэдэрсэн ажээ.

3 Нифай 17:1–3

Есүс Өөрийнх нь үгсийг эргэцүүлэн бодож, ойлголтын төлөө залбирахыг хүмүүст зарлиглав

Та судрууд дахь аль нэг сургаал эсвэл сүмийн хэн нэг удирдагчийн заасан зүйлийг уншаад ойлгохгүй бол яадаг вэ? Тохирох хариултуудыг дугуйл:

- Би тэр заасан зүйлийг зүгээр л тоохгүй орхичихдог.
- Өөр хүнээс ойлгоход маань туслахыг гуйдаг.
- Би уг зүйлийн талаар анхааралтай эргэцүүлэн боддог.
- Би Тэнгэрлэг Эцэгээс надад ойлгоход туслахыг гуйдаг.

3 Нифай 17-р бүлэгт цэдэглэгдсэн үйл явдлууд, цугласан нифайчуудтай хамт өнгөрүүлсэн Есүс Христийн эхний өдөр дуусаж байхад болсон юм. 3 Нифай 17:1–3-ыг уншаад Аврагч нифайчуудад Өөрийнх нь заасныг илүү сайн ойлгохын тулд юу хий хэмээн хэлснийг тэмдэглэ. Гэртээ хариад тунгаан бодож, залбирах нь сайн мэдээний үнэнийг илүү сайн ойлгоход тань хэрхэн туслахыг эргэцүүлэн бод.



Тэргүүн Зөвлөлийн Ерөнхийлөгч Хэнри Б.Айринг тунгаан бодохын учир утгыг тайлбарлажээ. Түүний тайлбарыг уншаад тунгаан бодохын учир утгыг дүрсэлсэн үг хэллэгүүдийг тодруулж тэмдэглэ. “Унших, судлах, тунгаан

бодох нь адилгүй юм. Бид үгсийг уншаад тэдгээрээс ямар нэг санаа авч болох юм. Бид судруудыг судалж, загварууд болон уялдаа холбоог нээн илрүүлж болно. Харин бид тунгаан бодсоноороо илчлэлтийг

Сүнсээр урьдаг. Миний хувьд тунгаан бодох нь, судруудыг анхааралтайгаар уншиж судалсны дараа эргэцүүлэн бодож, залбирах явдал мөн” (“Serve with the Spirit,” *Ensign* ба *Лиакона*, 2010 оны 11-р сар, 60).

3 Нифай 17:3-ыг анхааралтай ажиглаад Аврагч хүмүүсийг Түүнтэй хамт хийх дараачийн зүйлсдээ “[өөрсдийн] оюун санааг бэлтгэх” ёстой гэж зааварласныг анзаар. Цааш үргэлжлүүлэн судлахаасаа өмнө, дараах асуултуудад хэрхэн хариулахаа тунгаан бод. Та Сүмд ирэхээсээ өмнө оюун санаагаа бэлтгэхийн тулд юу хийж болох вэ, Семинарт ирэхээсээ өмнө, Ерөнхий чуулганыг сонсохоосоо өмнө, судруудыг судлахаасаа өмнө, оюун санаагаа бэлтгэх нь суралцах боломжуудаас таны олж авах зүйлд ямар нөлөө үзүүлдэг гэж та бодож байна?

Эдгээр шүлгүүдээс сурах зарчмуудын нэг бол: **Бид тунгаан бодож, Эцэгт хандан залбирснаар илүү сайн ойлголтыг хүлээн авч болно.** (Та үүнийг судартаа 3 Нифай 17:1–3-ын хажууд бич.)



1. Энэ зарчмыг амьдралдаа хэрэгжүүлэхийн тулд дор бичигдсэн зүйлсээс нэгийг эсвэл хоёуланг нь сонгоод ирэх долоо хоногийн турш амьдралдаа хэрэгжүүл. Хийсэн зүйлээ судар судлах тэмдэглэлдээ бич. Мөн энэ нь сүм дээр, семинарт, ерөнхий чуулганаас эсвэл судруудаас сурах



зүйлийг тань хэрхэн нэмэгдүүлсэн тухай бич. Тэмдэглэлдээ бичсэн зүйлээ багштайгаа хуваалцахад бэлтгэ. Мөн ирэх долоо хоногийн турш эдгээр зүйлсийн аль нэгийг цаашид улам сайжруулах төлөвлөгөө гарга.

а. Би сүм эсвэл семинарт явахаасаа өмнө оюун санаагаа бэлтгэдэг болно.


б. Би сүм дээр эсвэл семинарт сонссон зүйлийнхээ талаар тунгаан бодож, залбирна.

3 Нифай 17:4–25

Аврагч нифайчуудын өвдсөнийг эдгээж, хүүхдүүдийг нь адисалсан нь

Байнга мэдэрч баймаар тийм их урам зориг, баяр баясгаланг мэдэрсэн тохиолдлынхоо тухай бод. 3 Нифай 17:4–5-ыг уншиж, Их Эзэн Эцэгтээ очихоор буцах гэж байгаагаа хэлэхэд нифайчууд хэрхэн хариулсныг олж мэд.


Аврагч нифайчуудын зөв шударга хүсэлд агуу өрөвч сэтгэлээр хариулжээ. Дараах үйл ажиллагаа нь биднийг хайрлах Есүс Христийн хайрыг илүү сайн ойлгоход тань тусална. Мөн энэ нь Есүс Христийн зан төлөв, шинж чанаруудын талаарх судрын үнэнүүдийг нээн илрүүлэхэд тань тусална.

 **2.** Дараах судрын эшлэлүүдийг судар судлах тэмдэглэлдээ бич. Эшлэл бүрийн дор нэмэлт мэдээлэл бичих зай үлдээ: 3 Нифай 17:6–10; 3 Нифай 17:11–18; 3 Нифай 17:19–25. Эдгээр судрын хэсгүүдийг нэг бүрчлэн судлахдаа Аврагчийн зан төлөвийн талаар болон Тэр чухамдаа ямар хүн болох тухай үнэнүүдийг олж мэд. Судрын эшлэл бүрд нэг үнэнийг, хамгийн багадаа гурван үнэнийг олж, холбогдох эшлэлийнх нь дор бич.

Мормоны Номд дүрслэгдсэн хамгийн сэтгэл хөдөлгөм үйл явдлын нэг бол Есүс тэр үед тэнд байсан бяцхан хүүхдүүдийг адисалсан явдал юм. Энэ хэсэг бидэнд Есүс Христийн зан төлөв, шинж чанаруудыг ойлгоход тусална. Ерөнхийлөгч Боид К.Пакэр 3 Нифай 17:11–12, 21–25-р шүлгүүд дэх Аврагч болон хүүхдүүдийн тухай шастирыг эш татахаасаа өмнө, “Бид нифайчуудын дунд хийсэн Аврагчийн үйлчлэлийн тухай шастираас Түүний бодгалийг өөр хаанаас ч илүүгээр гүн гүнзгий харж болно” гэж хэлжээ (“Teach the Children,” *Ensign*, 2000 оны 2-р сар, 16–17).


Цугласан олон өвчин зовлонтой, “ямар нэгэн байдлаар зовж зүдэрсэн” (3 Нифай 17:9) хүмүүсийг Аврагч руу авчирсан гэдгийг анзаараарай. Эдгээр зовлонгууд нь бие махбод, сэтгэл санааны болон оюун ухааных байсан байж болно. Өөрийнхөө “зовж зүдэрсэн” байж болох зүйлсийг тунгаан бод.


Аврагч таныг Өөрийн биеэр адислах байсан бол таныг зовж байхад Тэр хэрхэн туслах байсан бэ?

 **3.** Энэ хичээлийн эхэнд сурч мэдсэн тунгаан бодох тухай зарчмыг давт. Эргэцүүлэн бодох нэг арга нь судрын шаштирт дүрсэлсэн нөхцөл байдалд өөрсдийгөө тавьж төсөөлөн бодох явдал юм. 3 Нифай 17-д цэдэглэгдсэн үйл явдлуудад та оролцсон бол ямар байх байсан талаар төсөөлөн бод. Тэр үед та юу сонсож, харж, мэдэрч, мөн Аврагчаас юу сурч болох байсныг судрын тэмдэглэлдээ дүрслэн бич. Мөн та Аврагчаас ямар адислал хүсэх байсан тухайгаа бич.

3 Нифай 17:6–25-р шүлгүүдээс өөрийнхөө сурсан нэг үнэнийг дүрсэлсэн нэг өгүүлбэрийг бодож ол. Тэр өгүүлбэрээ судартаа эдгээр шүлгүүдийн хажууд эсвэл судар судлах тэмдэглэлдээ бич. Эдгээр судрууд дахь нэг үнэн бол: **Аврагч бидний төлөө асар их өрөвч нинжин сэтгэлтэй байдаг гэсэн мэдрэмж юм.** Эдгээр шүлгүүдээс сурсан Аврагчийн зан чанарын тухай үнэнүүдийг мэдэх нь таны хувьд яагаад чухал вэ?

Итгэлийн тухай дараах үгсийг унш: “Итгэл тань таныг аврал руу хөтөлдөг байхын тулд энэ нь Их Эзэн Есүс Христ дээр төвлөрсөн байх ёстой. . . . Та Түүнийг амьд гэдэгт бат итгэдэг бөгөөд Түүний зан төлөвийн талаар зөв ойлголттой байдаг бол мөн Түүний хүслийн дагуу амьдрахыг хичээн чармайдгаа мэддэг бол та Христэд итгэх итгэлээ үйлдэл болгож чадна” (*Итгэлдээ үнэнч байх нь: Сайн мэдээний эшлэл* [2004], 54).

 **4.** Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултад хариул: Аврагчийн нинжин сэтгэлийг ойлгох нь таныг Түүнд итгэх итгэлээ ашиглахад хэрхэн туслах вэ?

 **5.** 3 Нифай 17-р бүлгээс Аврагчийн тухай сурсан зүйлээ өөр хүнтэй хуваалц. Тэр хүний нэрийг болон та түүнд юу хэлэхээ судар судлах тэмдэглэлдээ товч бич.

Есүс Христ нифайчууд дээр хүрч ирсэн шиг тийм агуу үйл явдал хэдийгээр бидэнд тохиогоогүй ч бид бүгд Түүнийг харж мөн сонсох тэр өдөр ирэх болно. Нэг эсвэл хоёр өдрийн турш энэ хичээлийг тунгаан бод. Та өөрийн хүсэл эрмэлзэл, сул дорой байдал, сэтгэл санааны зовлон болон сорилтуудын талаар залбирахдаа Аврагчийн өрөвч энэрэнгүй сэтгэлийг эргэцүүлэн бод.

Зураглал төсөөлөх нь

Та зураглал төсөөлөх зарчмыг ашиглан судруудыг тунгаан бодож болно. Тэгэхийн тулд судрууд дахь үйл явдлыг оюун санаандаа зураглал харахыг хичээх эсвэл өөрийгөө уншиж байгаа түүхийнхээ оролцоцг болгож төсөөлөн бод. Зураглал төсөөлөх нь судраас уншсанаа бодох, ойлгох болон хэрэгжүүлэхэд тань тусална.



6. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би 3 Нифай 17-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

26-Р ХЭСЭГ: 2 ДАХЬ ӨДӨР

3 Нифай 18

Оршил

Есүс Христ нифайчуудын дундах үйлчлэлийнхээ эхний өдрийг дуусгаад ариун ёслолыг гүйцэтгэж, хүмүүсийг Эцэгт хандан ямагт залбирдаг байхыг, мөн бүх хүмүүстэй нөхөрсөг байхыг зарлиг болгов. Аврагч зарлигуудыг сахидаг хүмүүст агуу адислалуудыг амласан юм. Тэр дараа нь Нифай үндэстэн арванхоёр шавьдаа сүм дэх тэдний үйлчлэлийн талаар заавар өгчээ. Тэрбээр тэнгэрт буцахаасаа өмнө Ариун Сүнсний бэлэг өгөх хүчийг тэдэнд өгсөн ажээ.

3 Нифай 18:1–14

Есүс Христ нифайчуудад ариун ёслолыг гүйцэтгэсэн нь

Далын гишүүнээр үйлчилж байсан ахлагч Жэ-ралд Н.Ландын ярьсан дараах түүхийг уншаад уг түүхэн дэх хүний оронд байвал ямар байх байсныг төсөөлөн бод:

“Үр ашиггүй үйлчлэгчид бид өөрсдийнхөө төлөө Христийн хийсэн зүйлийн хариуг Түүнд эргүүлэн төлөхийн тулд юу хийж чадах вэ?” гэсэн асуултын гайхалтай хариултыг санал болгосон, ууланд авирах тухай нэгэн сонирхолтой өгүүлэл хэдэн жилийн өмнө нийтлэгдсэн юм.

“Уг өгүүлэл нь ууланд авиралтын сургууль ажиллуулдаг Чэнкүш гэгч хүний тухай юм. . . . Чэнкүш ууланд авирах үед олсоор бэхэлгээ хийж хамгаалах тогтолцооны тухай ярилцлага авагчид ярьжээ. Энэ бол ууланд авирагчид өөрсдийгөө унахаас хамгаалах тогтолцоо юм. Нэг авирагч аюулгүй байрлалд очоод ихэвчлэн бэхэлгээний олсоор биеэ ороон ар талынхаа авирагчийн аюулгүй байдлыг хангана. ‘Таныг бэхэллээ’ гэдэг нь ‘Би таныг хамгаалсан, Ямар нэг юм тохиолдвол би таныг унахаас хамгаална’ гэсэн үг ажээ. Энэ бол ууланд авиралтын нэг чухал хэсэг юм. Одоо уг өгүүлэлд дараа нь юу гэж өгүүлснийг ажигла: ‘Олсоор хамгаалах тогтолцоо

Чэнкүшт ууланд авиралтын талаар хамгийн сайхан, бас хамгийн тоогүй дурсамжийн аль алийг нь үлдээсэн гэнэ. Нэг удаа Чэнкүш гурван механик холбоосыг мулт татан өөрийн олсны хамгаалалтаа ирмэг рүү алдсанаар өндөр хавцлаас унажээ. Түүнийг доош унахад ар талыг нь хамгаалж явсан уулчин гараа сунган тосч, түүнийг газраас 3.05 метрийн зайтай барьж авч зогсоожээ. Чэнкүш “Дон ингэж миний амийг аварсан юм даа” гэж хэллээ. “Та тэр залуугийн ачийг яаж хариулах вэ? Түүнд Христийн Мэндэлсний баярын бэлэг болгож ууланд авирахад хэрэглэдэг хуучин олс өгөх үү? Үгүй ээ, та түүнийг дурсан санана. Та түүнийг үргэлж дурсан санана” [Эрик Г.Андэрсон, “The Vertical Wilderness,” *Private Practice*, 1979 оны 11-р сар, 21; тэмдэглэл нэмэгдсэн] (“The Grace and Mercy of Jesus Christ,” *Jesus Christ: Son of God, Savior*, хянан тохиолдуулсан Пол Х.Питэрсон, Гари Л.Хач, Лора Д.Кард [2002], 48).

3 Нифай 18:1–11-р шүлгүүдийг уншаад Есүс Христ нифайчуудаас Өөрийг нь санахын тулд юу хийхийг хүссэнийг олж мэд. *Дурсан санах* ба *санах* гэсэн үгсийг 7 ба 11-р шүлгүүдэд тэмдэглэ. Таны төлөө хийсэн Аврагчийн цагаатгагч золиослолыг үргэлж санах нь яагаад чухал гэж та бодож байна? Та Аврагчийг санасан үедээ хэрхэн өөрөөр үйлддэг вэ?

Түүний бие болон цусыг сана гэсэн Аврагчийн зарлиг тухайн хүмүүст бүр илүү утга учиртай байх байсан. Учир нь тэд дөнгөж өмнөхөн нь Түүний бие дээрх шархны сорвиудыг тэмтэрч үзсэн шүү дээ. Хэдийгээр та Мормоны Номын хүмүүсийн адил Аврагчийн биен дээрх шархны сорвиудыг хараагүй ч ариун ёслолоос хүртэхдээ Түүний цагаатгагч золиослолыг санаж чадна.



1. Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултад хариул: Ариун ёслолын үеэр Аврагчийн золиослолыг санах нь Түүнд талархалтай байхад тань хэрхэн тусалсан бэ?

3 Нифай 18:7–11-т цэдэглэгдсэн Есүс Христийн үгс дараах зарчмуудыг заадаг: **Бид ариун ёслолоос хүртсэнээр Түүний зарлигласан бүхнийг хийхэд бэлэн гэдгээ Тэнгэрлэг Эцэгтээ гэрчилдэг. Бид ариун ёслолоос хүртсэнээр Есүс Христийг үргэлж санана гэдгээ Эцэгт гэрчилдэг.** 3 Нифай 18:7–11-ийг дахиж уншаад эдгээр зарчмуудыг заасан үг хэллэгүүдийг тэмдэглэ. 11-р шүлгийг уншаад хэрэв Аврагч эдгээр үгсийг танд хэлбэл ямар санагдахыг бод.



2. Дараах асуултаудаас хоёрыг нь сонгон судар судлах тэмдэглэлдээ хариул:


а. Та ариун ёслолын үеэр Аврагчийн амьдрал, үйлчлэлээс ямар зүйлсийг санадаг вэ?


б. Аврагчийг долоо хоногийн үлдсэн өдрүүдийн турш үргэлж санахын тулд та юу хийж болох вэ?

в. Ариун ёслолын үеэр Аврагчийг санахыг чин сэтгэлээсээ хичээх нь танд ирэх долоо хоногийн турш хэрхэн нөлөөлж болох вэ?

Дараах өгүүлбэрийг ариун ёслолоос хүртэж, Түүнийг санадаг хүмүүст Аврагч юу амласныг тайлбарласан хэллэгээр гүйцээн бичиж, 3 Нифай 18:7, 11-т заагдсан өөр нэг зарчмыг олж мэд. **Бид ариун ёслолоос хүртэж, Аврагчийг үргэлж дурсан санавал бид** _____



 **3.** 3 Нифай 18:12–14-ийг Хиламан 5:12-той харьцуул. Долоо хоног бүр ариун ёслолоос хүртэх нь Есүс Христийг амьдралынхаа суурь болгоход тань хэрхэн тусалж болохыг судар судлах тэмдэглэлдээ бич.

 **4.** Аврагчийг илүү сайн санахад өөртөө туслахын тулд дараагийн долоо хоногт өдөр бүр Түүнийг санахын тулд юу хийснээ судар судлах тэмдэглэлдээ бич. Та ариун ёслолын үеэр бодсон зүйлсийнхээ тухай эсвэл Аврагчийг дурсан санах нь бодол санаа, үг хэл, үйлдэлд тань хэрхэн нөлөөлснийг бичиж болно.

3 Нифай 18:15–25


Есүс нифайчуудад Эцэгт хандан үргэлж залбирч, ойр ойрхон цуглаж байхыг заав

Есүс Христ нифайчуудад ариун ёслолыг гүйцэтгэснийхээ дараа тэдэнд залбирлын тухай чухал зарчмыг заажээ. Түүний заасан зарчмуудын нэг нь: **Хэрэв бид сэрэмжтэй байж, Эцэгт хандан үргэлж залбирвал Сатаны уруу таталтуудыг эсэргүүцэж чадна гэсэн зарчим юм.** Бид *сэрэмжтэй* байхдаа сүнслэг байдлын хувьд анхаарал сэргэг, сонор сэрэмжтэй, хамгаалагдсан байдаг.

3 Нифай 18:15–21-ийг уншаад дээр үзүүлсэн зарчмыг заасан үг хэллэгүүдийг тэмдэглэ. Та сэрэмжтэй

байж, залбирах нь уруу таталтыг эсэргүүцэхэд яагаад чухал гэж боддог вэ?

3 Нифай 18:15, 20–21-р шүлгүүд нь төгс эзэмших судар болохыг анхаар. Эдгээр шүлгүүдийг судартаа тэмдэглэж ав.

 **5.** Дараах асуултуудыг уншиж, бодсоныхоо дараа судар судлах тэмдэглэлдээ хоёр эсвэл илүү олон асуултад хариул:

а. Сатаны уруу таталтыг эсэргүүцэхэд тань залбирал хэрхэн тусалж байсан бэ?

б. Та хувийн залбирлаа сайжруулахын тулд юу хийж болох вэ?

в. Та гэр бүлтэйгээ залбирснаар ямар адислалуудыг хүлээн авч байсан бэ? (3 Нифай 18:21-ийг үзнэ үү.)

г. Та гэр бүлдээ тогтмол бөгөөд утга учиртай гэр бүлийн залбирал хийхэд нь туслахын тулд юу хийж болох вэ?

Бид Тэнгэрлэг Эцэгт хандан залбирч, өөрсдийн Аврагч, Есүс Христтэй ойр болсноор бусад хүмүүсийг Түүнд ойр болоход нь туслахыг хүсдэг. Та Аврагчид илүү ойр болоход нь тусалмаар байгаа хэн нэгний талаар бод. 3 Нифай 18:22–24-ийг уншаад дараах зарчмыг уг шүлгүүдээс ол: **Бид бусдад үйлчилснээр тэднийг Христэд ирэхэд нь тусалж чадна.**

3 Нифай 18:24-г цэдэглэгдсэнээр бид өөрсдийн гэрлийг дээш өргөх ёстой бөгөөд энэ нь дэлхийг гэрэлтүүлдэг гэж Аврагч заасан билээ. Мөн Аврагч Өөрийгөө бидний дээш өргөх тэрхүү гэрэл юм гэж хэлсэн. Бид Түүний зарлигуудыг сахиж, үлгэр жишээг нь дагаснаар Аврагчийн гэрлийг дээш өргөдөг гэж Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Роберт Д.Хэйлс заажээ:



“Тэр биднийг ‘Ирж, намайг дага’ хэмээн сургасан шиг бид Аврагчтай адилхан байх ёстой. “Хэрэв бид өөрсдийн гэрлийг, биднийг дагадаг хүмүүс Аврагчийг дагахын төлөө гэрэлтүүлбэл Есүс баярлахгүй гэж үү? Тэрхүү гэрлийг хайж буй [хүмүүс] байгаа бөгөөд тэд баптисмын хаалгаар баяртайгаар орж, мөнх амьдрал руу хөтлөх давчуу бөгөөд нарийн зам дээр гарах болно (2 Нифай 31-р бүлгийг үзнэ үү). Та тэднийг аюулгүй боомт руу удирдах гэрэл байх уу? . . .

“Та өмнө нь өөрийгөө хэн нэгнийг гэр рүү нь эсэн мэнд хүргэх эсвэл мөнх амьдралд хүргэх нарийн бөгөөд давчуу замд орох замыг холоос гэрэлтүүлдэг гэрэлт цамхаг байхаар Тэнгэрлэг Эцэгийн илгээсэн гэрэл байж болохыг бодож үзэж байсан уу? Таны гэрэл бол хэзээ ч бөхөхгүй эсвэл гэртээ харих замаа хайж байгаа хүмүүсийг хэзээ ч буруу зүг рүү хөтлөхгүй гэрэлт цамхаг мөн. . . .

“... Есүс Христ бол бидний дагах ёстой, хаашаа явахыг мэдэж болохын тулд бидэнд өгөгдсөн гэрэл юм. Бидний хүн нэг бүр эргэн тойрныхноо хүмүүсийг хүчирхэгжүүлэхийн тулд зөв зүйлийг сонгох болтугай хэмээн [би залбирч байна]” (“That Ye May Be Children of Light” [Church Educational System fireside for young adults, 1996 оны 11-р сарын 3], 6–7).

Бид бусдын төлөө залбирах, тэднийг сүмийн цуглаануудад оролцоход урих, Христийн адил үлгэр жишээ үзүүлэх зэрэг арга замуудаар бусдад үйлчилж чадна. Та Есүс Христийн үлгэр жишээг дагаж, хэн нэгнийг Аврагчид ойртоход нь туслахад ямар санагдсанаа тунгаан бод. Таныг дагадаг хүмүүс мөн Аврагчийг дагах боломжтой байхын тулд та өнөөдөр эсвэл энэ долоо хоногт юу хийх вэ?

3 Нифай 18:26–39

Аврагч шавь нартаа бүх хүмүүстэй нөхөрлөхийг заасан юм

Аврагч нифайчуудад ариун ёслолыг танилцуулж, залбирлын тухай заасныхаа дараа, Өөрийн сонгосон арванхоёр шавьд хандаж, сүмийн ажил хэргийг хэрхэн удирдах болон зохион байгуулахыг зааварлав (3 Нифай 18:26–39-ийг үзнэ үү). 3 Нифай 18:26-р бүлэгт Аврагч цугласан олонд хандан ярихаа зогсоод “өөрийн сонгосон” удирдагчид руу очсоныг анхаар. 28–29-р шүлгүүд дэх Түүний захиас санваарын удирдагчдад зохисгүй хүмүүсийг ариун ёслолоос хүртэхийг зөвшөөрөхийн эсрэг анхааруулга болж өгөгдсөн юм.

Сүмийн гишүүд ариун ёслолоос хүртэхээр зохистой байгаа эсэхдээ өөрсдөө анхаарах ёстой бол бусад хүмүүс ариун ёслолоос хүртэхүйц зохистой байгаа эсэхийг тодорхойлох үүрэг хариуцлагыг ийм шүүлт хийлгэхээр Их Эзэний дуудсан бишоп эсвэл гадасны ерөнхийлөгч зэрэг хүмүүс хүлээх ёстой. 3 Нифай 18:32-ыг уншаад Аврагч шавь нартаа итгэлээсээ гажсан хүмүүст хэрхэн хандах талаар юу гэж заасныг олж мэд. Та итгэлээсээ гажсан найз, гэр бүлийн гишүүн эсвэл тойрог, салбарынхаа хэн нэгэнд хэрхэн “үйлчлэхээ үргэлжлүүлэх” тухай бод.

Төгс эзэмших судар—3 Нифай 18:15, 20–21

3 Нифай 18:15, 20–21-ийг цээжлэхэд хэдэн минут зориул. Гурван шүлгээ цаасан дээр бичээд цээжлэх дадлага хий. Шүлгүүдийг хэдэн удаа уншаад хэсгүүдийг нь ээлжлэн арилгах юмуу дарах байдлаар цээжлэх дадлага хий. Бүх үгийг арилгаж эсвэл дарж дуустал энэ дасгалыг үргэлжлүүлж болно.

Эдгээр шүлгүүдийг цээжлэхдээ Аврагчийн зааж байсан зүйлсийг бод. 3 Нифай 18:15-д

цэдэглэгдсэнээр Есүс Христ нифайчуудад чөтгөрийн уруу таталтыг хэрхэн сөрөн зогсох талаар заажээ. Залбирлаас ирэх хүч чадлыг анхаар. Уруу таталтыг эсэргүүцэх хүч бидэнд залбирлаар ирдэг.

3 Нифай 18:20–21-т цэдэглэгдсэнээр Есүс Христ биднийг итгэлтэйгээр залбирахад, Тэнгэрлэг Эцэг бидний залбиралд үргэлж хариулдаг, гэвч Тэр хүүхдүүддээ зориулсан төлөвлөгөөнийхөө дагуу хариулдаг бөгөөд Тэр бидэнд юу зөв сайн болохыг мэддэг гэж заажээ. 20-р шүлгийг чангаар давтан унш: “Мөн та нар хүлээж авах болно гэж итгээд, миний нэрээр Эцэгээс гуйх, зөв болох юу боловч, болгоогтун энэ нь та нарт өгөгдөх болно.” Та энэ шүлэг дэх “зөв болох юу боловч” гэсэн хэллэг юу гэсэн утгатай гэж бодож байна вэ? (Та Иаков 4:3-ыг уншиж болно.)



Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли дараах гэрчлэлийг хуваалцсан юм. “Бурхан, бидний Мөнхийн Эцэг амьд, Тэр бол Бүтээгч, орчлон ертөнцийг Захирагч бөгөөд түүнчлэн бидний Эцэг юм. Тэр бол Бүхнийг Чадагч бөгөөд бүхнээс илүү дээгүүр. Түүнтэй залбирлаар холбогдож болно. . . . Тэр хүүхдийн залбирлыг сонсдог уу? Мэдээж Тэр сонсдог. Тэр үүнд нь хариулдаг уу? Мэдээж Тэр хариулдаг. Тэр үргэлж бидний хүссэнээр биш ч гэсэн хариулдаг. Тэр сонсч, хариулдаг” (*Teachings of Gordon B. Hinckley* [1997], 468).

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Даллин Х. Өүкс заасан нь: “Итгэл хэчнээн хүчтэй байлаа гээд энэхүү хүч нь эзнийхээ хүслийн эсрэг зүйлийг бий болгож чадахгүй” хэмээн Аврагч бидэнд [3 Нифай 18:20]-р шүлэгт сануулсан юм. Их Эзэн Есүс Христэд итгэх итгэлээ ашиглах нь тэнгэрийн жаяг, Их Эзэний сайн сайхан, хүсэл, мэргэн ухаан ба цаг хугацаанаас үргэлж хамааралтай байдаг. Тийм учраас бид Их Эзэний таалал болон Түүний цаг хугацаанд бүрэн итгэхгүйгээр Их Эзэнд итгэх жинхэнэ итгэлтэй байж чадахгүй” (“Faith in the Lord Jesus Christ,” *Ensign*, 1994 оны 5-р сар, 100).



6. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би 3 Нифай 18-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

3 Нифай 19

Оршил

3 Нифай 11–18-р бүлгүүдэд цэдэглэгдсэн үйл явдлууд бүгд нэг өдрийн дотор болсон юм. Тэр өдрийн төгсгөлд Аврагч ирсэн тухай болон маргааш нь Тэрбээр эргэж ирэх тухай мэдээ хүмүүсийн дунд тархсан бөгөөд тэд “маргааш нь Есүс өөрийгөө цугласан олонд үзүүлэх тэр газар байж болохын тулд бүхэл шөнөжингөө үлэмж шаргуу хөдөлмөрлөв” (3 Нифай 19:3). Өглөө нь арванхоёр шавь хүмүүст зааж, тэдэнтэй хамт залбирчээ. Нифай дараа нь арванхоёр шавьд баптисм хүртээж, тэд Ариун Сүнснийг хүлээн авч, тэнгэр элчүүдээр хүрээлэгдэв. Энэ үйл явдлын үеэр Есүс Христ үзэгдэж, шавь нартаа залбирахыг зарлиг болгоод Эцэгт хандан цугласан олны өмнөөс залбирав. Шавь нар нь итгэлийнхээ ачаар Ариун Сүнсээр дүүргэгдэв. Тэд ариусгагдаж, Эцэг Хүү хоёртой нэг болов.

3 Нифай 19:1–14

Арванхоёр шавь Аврагч зарлиг болгосны дагуу хүмүүст үйлчилсэн нь

Есүс Христ маргааш танайхаас хэсэг зайд орших ариун сүмд ирэх гэж байгааг мэдвэл танд ямар санагдах болон юу хийхээ төсөөлөн бод. Та тийшээ очихын тулд хэр зэрэг их хүч чармайлт гаргах вэ? Та өөр хүмүүсийг дагуулж явахыг хүсэх үү? Та энэ үйл явдалд зориулан юу бэлтгэх вэ?

3 Нифай 19:1–3-ыг уншаад Аврагч маргааш нь ирнэ гэсэн амлалтад үзүүлсэн нифайчуудын хариу үйлдлийг олж мэд. Олон түмэн цугларсны дараа арванхоёр шавь цугласан олныг арванхоёр хэсэгт хуваан тэдэнд зааж эхлэв. Тэд цугласан олонд өвдөг сөгдөн залбирахыг зааварлаад урьд өдөр нь Аврагчийн заасан тэрхүү үнэнүүдийг тэдэнд заав. (3 Нифай 19:4–7-г үзнэ үү.)



1. 3 Нифай 19:8–9-ийг уншаад судар судлах тэмдгэлэлдээ дараах асуултуудад хариул.

а. Шавь нарын хамгийн их хүссэн зүйл юу байв? Таны туршлагаас харахад Ариун Сүнсний бэлэг яагаад маш их хүсүүштэй зүйл вэ?

б. Аврагчийг явсны дараа арванхоёр шавь нь Америк тив дэх сүмийн ажил хэргийг удирдахаар болов. Яагаад тэд Ариун Сүнсээр удирдуулах нь туйлын чухал байсан бэ?

Судар судлах тэмдгэлэлдээ даалгавраа хийж дууссаны дараа эдгээр асуултуудыг тунгаан бод: Та



залбирахдаа хамгийн их хүсдэг зүйлээсээ цөөнийг нь нэрлэнэ үү? Та Ариун Сүнсний төлөө хэр зэрэг олон удаа залбирдаг вэ?

3 Нифай 19:10–12-ыг уншаад шавь нар залбирсныхаа дараа юу хийснийг олж мэд. 10–12-р шүлэгт дүрслэгдсэн баптисм нь арванхоёр шавийн хувьд хоёр дахь баптисм юм. Сүм нифайчуудын дунд байгуулагдаад олон жил өнгөрсөн бөгөөд эдгээр санваартан ах нар урьд нь баптисм хүртсэн ч тэдний эхний баптисм судруудад цэдэглэгдээгүй юм. Энэхүү хоёр дахь баптисм нь онцгой тохиолдол байсныг Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит тайлбарласан нь: “Сайн мэдээний үндсэн дээр сүмийг шинээр зохион байгуулсан учир Аврагч Нифай болон бусад хүмүүст дахин баптисм хүртэхийг зарлиг болгосон ажээ. Түүнээс өмнө сүм [Мосегийн] хуулиар зохион байгуулагдсан юм” (*Doctrines of Salvation*, эмхэтгэсэн, Брүс Р.Макконки, 3 боть . [1954–56], 2:336).

Шавь нар болон бусад нифайчууд Аврагчийн дэргэд байхаар зохистой байсныг сана. 3 Нифай 19:13-ыг уншаад арванхоёр шавь зөв шударга хүслийнхээ ачаар юуг хүлээн авсныг олж мэд.



2. Ариун Сүнсний бэлгийг авсан бөгөөд түүнтэй хамт байхуйц зохистой амьдарч байгаа хүний амьдралд ирэх адислалуудыг судар судлах тэмдэглэлдээ жагсаан бич. Тэгээд жагсаалтаа Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Роберт Д.Хэйлсийн дараах үгстэй харьцуулаад олсон шинэ санаагаа жагсаалтад нэм.



“Ариун Сүнс нь өдөр тутмын амьдралаа Бурханы хаант улсын арга замуудаар авч явах хүч чадал, зоригийг бидэнд өгдөг бөгөөд Эцэг, Хүү хоёрын тухай бидний гэрчлэлийн эх ундарга мөн. . . .

“Бид өдөр бүр олон шийдвэр гаргах хэрэгтэй болдог бөгөөд эдгээр шийдвэрүүдийг гаргахад илүү сайн сонголтыг хийхэд туслах байнгын хамтрагч Ариун Сүнс бидэнд хэрэгтэй. Манай залуу эрэгтэй, эмэгтэйчүүд дэлхийн муу муухай зүйлсээр бөмбөгдүүлж байна. Сүнсгүй хамтрагч байх нь тэдэнд нүгэл хилэнцийг эсэргүүцэх, шаардлагатай бол наманчлаад шулуун бөгөөд давчуу зам руу эргэн ирэх хүчийг өгөх болно. Бидний хэн нь ч дайсны уруу таталтаас ангид байдаггүй. Бид бүгдэд Ариун Сүнснээс ирдэг хамгаалалт хэрэгтэй. . . . Ариун Сүнсний бэлэгтэй байх нь гэр бүлийн гишүүдэд гэр бүлтэйгээ хамт Тэнгэр дэх Эцэг болон Түүний Хүү, Есүс Христэй үүрд амьдрахаар тэдэн дээр эргэж очиход туслах сонголтууд буюу ухаалаг сонголтууд хийхэд тусалдаг” (“The Covenant of Baptism: To Be in the Kingdom and of the Kingdom,” *Ensign*, 2000 оны 11-р сар, 8).

Та 3 Нифай 19:1–14-р шүлгүүдээс сурсан зүйл дээрээ үндэслэн амьдралдаа ямар адислал авахыг хамгийн их хүсдэгээ мөн яагаад ийнхүү хүсдэгээ тунгаан бод.

3 Нифай 19:9, 13-р шүлгүүд дээр тулгуурлан дараах зарчмыг гүйцээж бич: **Бид чин сэтгэлийн хүсэл болон залбирлаар** _____

_____ чадна.

3 Нифай 19:14–36

Аврагч хүрч ирж, хүмүүс итгэлээрээ дамжуулан цэвэр ариун болохын төлөө залбирсан нь

3 Нифай 19:14–16-г уншаад арванхоёр шавь баптисм хүртэж, Ариун Сүнсээр дүүргэгдсэний дараа юу болсныг мэд.

Шавь нар болон цугласан олон өвдөг сөгдөн суусны дараа, Аврагч арванхоёр шавьдаа залбирахыг зарлиг болгожээ. Тэдний залбирлын тухай шастирыг 3 Нифай 19:17–18, 24–26, 30-аас унш. Энэ нь хүмүүс Есүс Христэд шууд хандан залбирсан тухай сударт тэмдэглэгдсэн цорын ганц тохиолдол юм. Бид Бурхан Эцэгт хандан Түүний Хүү, Есүс Христийн нэрээр залбирдаг. Сударт үүнээс өөр хаана ч биднийг Есүст хандан залбирахыг заасан тохиолдол байдаггүй.

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Брүс Р.Макконки энэхүү онцгой тохиолдолд шавь нар

яагаад Есүст хандан залбирсныг ийнхүү тайлбарлажээ: “Есүс тэдэнд Эцэгт хандан түүний нэрээр залбирахыг аль хэдийн заасан байсан бөгөөд тэд эхэлж залбирахдаа тийн үйлдсэн юм [3 Нифай 19:8–9-ийг үз]. . . . Гэвч энэ удаа ‘тэд Есүст хандан залбирахдаа түүнийг өөрсдийн Их Эзэн бөгөөд Бурхан гэж дуудсан байдаг.’ [3 Нифай 19:18.] Есүс тэдний өмнө Эцэгийг бэлгэдэн төлөөлсөн юм. Тэд Түүнийг хараад Эцэгийг харсан мэт, түүнд хандан залбирахад, Эцэгт хандан залбирсан мэт байсан ажээ. Энэ нь онцгой, өвөрмөц нөхцөл байдал байлаа” (*The Promised Messiah: The First Coming of Christ* [1978], 560–61). Аврагч Өөрөө “Би тэдэнтэй байсан тул тэд надад залбирсан” (3 Нифай 19:22) хэмээн хэлжээ.



3. Хүмүүс өвдөг сөгдөн сууж байхдаа Есүс Христ гурван тусдаа залбирлыг шавь нартаа болон цугласан олонд зориулан хэлэхийг гэрчилсэн ажээ. Дараах жишиг зургийг судар судлах тэмдэглэлдээ хуулж ав. Өгөгдсөн судрын эшлэлүүдийг уншиж, жишиг зургийг гүйцээж бич.

Судрын хэсгүүд	Аврагч юуны төлөө залбирсан бэ?	Та Аврагчийн залбирлаас сурсан зүйлээ амьдралдаа хэрхэн хэрэгжүүлж болох вэ?
3 Нифай 19:19–23		
3 Нифай 19:27–29		
3 Нифай 19:31–34		

3 Нифай 19:24-ийг унш. “Олон үг нуршсангүй” гэдэг нь юу гэсэн утгатай гэж та бодож байна? Юуны төлөө залбирахаа мэдэхийн тулд бидэнд үгс нь өгөгдсөн байдаг залбирлын тухай ахлагч Брүс Р.Макконки ийн заажээ: “Төгс залбирал сүнслэгээр өдөөгдсөн байдаг бөгөөд Сүнс хэрэглэгдэх ёстой үгсийг илчилдэг” (*Mormon Doctrine*, 2 дахь хэвлэл, [1966], 586).

Аврагч залбиралдаа заасан зарим зарчмуудыг илүү сайн ойлгохын тулд 3 Нифай 19:28-ыг дахин харж, энэ зарчмыг заасан үг хэллэгүүдийг тэмдэглэ: **Бид Есүс Христэд итгэх итгэлээ ашигласнаар ариусгагдаж чадна.** Шавь нар ямар арга замуудаар 3 Нифай 19-р бүлэгт тэмдэглэгдсэн үйл явдлуудаар дамжуулан итгэлээ ашигласныг тунгаан бод. Шавь нар нь итгэлийнхээ ачаар Ариун Сүнсээр дүүргэгдсэн юм (3 Нифай 19:13-ыг үзнэ үү). Ариусгагдахын

тулд Ариун Сүнснийг хүлээн авах шаардлагатай байдаг.



Тэргүүн Зөвлөлийн Ерөнхийлөгч Марион Ж.Ромнигийн хэлсэн дараах үгсийг уншаад ариусгагдах гэдэг нь юу гэсэн утгатайг ол: “Дараа нь галын болон Ариун Сүнсний баптисм ирдэг.” [2 Нифай 31:13.] Нифайн ярьсан энэхүү галын болон Ариун Сүнсний баптисм нь Алмагийн ярьсан хүмүүний зүрхэн дэх агуу өөрчлөлтөд нөлөөлдөг [Алма 5:14-ийг үзнэ үү]. Энэ нь тэднийг дэлхийн шинж байдлаас сүнслэг байдалд хөрвүүлдэг. Энэ нь бодгалийг цэвэршүүлж, эдгээж, ариусгадаг. . . Их Эзэн Есүс Христэд итгэх итгэл, наманчлал, усан баптисм бүгд галын баптисмын урьдчилсан нөхцөл бөгөөд зайлшгүй шаардлагатай ч галын баптисм нь эцсийн цэг [үнэмлэхүй төгсгөл] юм. Хүн галын баптисмыг хүлээж авахын тулд хувцсаа Есүс Христийн цагаатгагч цусанд угаасан байх шаардлагатай” (*Learning for the Eternities*, comp. George J. Romney [1977], 133).



4. Ариусгагдана гэдэг нь юу гэсэн утгатайг тунгаан бодоод судар судлах тэмдэглэлдээ дараах асуултад хариул: Есүс Христэд итгэх итгэлээ ашиглах нь биднийг цэвэр ариун болоход хэрхэн тусалдаг вэ?

Есүс цагаатгагч золиослолынхоо урьд орой нэгэн агуу залбирлыг хийсэн нь Тэрээр нифайчууд дээр айлчилсан хоёр дахь өдрөө тэдний дунд хэлсэн залбирлуудтай их төстэй. 3 Нифай 19:23, 29, Иохан 17:9, 11, 21–22-ыг унш. “Бид нэг байж болохын тул” гэсэн хэллэгийг тэмдэглэ. Есүс Христ, Эцэг хоёр хэрхэн нэг байдгийг тунгаан бод. Бид Есүс Христтэй хэрхэн нэг байж чадах талаар эдгээр шүлгүүдээс юу сурч болох вэ?



Эдгээр шүлгүүдэд заасан зарчмуудын нэг бол: **Бид итгэлээр дамжуулан ариусгагдаж, Тэрбээр Эцэгтэй нэг байдгийн адилаар бид Есүс Христтэй нэг болж чадна гэсэн зарчим юм. Бид Эцэг, Хүү хоёртой хэрхэн нэг байж болох талаар** Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Д.Тодд Кристоффэрсоны хэлсэн дараах үгсийг унш: “Бид Бурхан болон Христийн хүсэл сонирхлыг өөрсдийнхөө хамгийн агуу хүсэл болгохоос нааш Тэдэнтэй нэг болж чадахгүй нь тодорхой юм. Тийм хүлцэнгүй байдлыг нэг өдрийн дотор олж авч чадахгүй ч хэрэв бид Эцэг Хүүд байдаг шиг Тэр бидэнд байна гэж баттай хэлэх хүртэл Тэдэнтэй нэг байх хүсэлтэй байвал Их Эзэн Ариун Сүнсээр биднийг сургах болно. Заримдаа би үүнд юу шаардагдах бол гэж бодохоос дагжин чичирдэг ч зөвхөн энэхүү төгс холбоосоор баяр

баяслын бүрэн байдлыг олж болно гэдгийг мэднэ” (“That They May Be One In Us,” *Ensign*, 2002 оны 11-р сар, 73).

Өнөөдрийн хичээлийг 3 Нифай 19:35–36-г уншиж, тунгаан бодсоноор дуусга.



5. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би 3 Нифай 19-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

26-Р ХЭСЭГ: 4 ДЭХ ӨДӨР

3 Нифай 20–22

Оршил

Есүс Христ нифайчуудын дундах үйлчлэлийнхээ хоёр дахь өдөр хүмүүст ариун ёслолыг дахин гүйцэтгэжээ. Эцэг хожмын өдрүүдэд Израилыг цуглуулж, дэлхийн бүх улс гүрнийг адисална гэсэн гэрээгээ гүйцэлдүүлэх болно гэдгийг Есүс Христ гэрчилсэн юм. Тэр мөн эцсийн өдрүүдэд Мормоны Ном ирэх нь Эцэг энэхүү гэрээгээ гүйцэлдүүлж эхэлсний тэмдэг байх болно гэж тайлбарласан ажээ.

3 Нифай 20:1–9

Аврагч хүмүүст ариун ёслолыг дахин гүйцэтгэсэн нь

Хэрэв та Аароны санваар атгадаг залуу эрэгтэй бол дараах асуултуудыг тунгаан бод: Ариун ёслолыг гүйцэтгэхэд туслах нь таны хувьд ямар утга учиртай вэ? Та энэхүү ёслолын ариун мөн чанарыг ойлгосноо Их Эзэнд хэрхэн харуулдаг вэ?

Хэрэв та залуу эмэгтэй эсвэл санваар арай аваагүй байгаа залуу эрэгтэй бол дараах асуултуудыг тунгаан бод: Та зохистой залуу эрэгтэйчүүд ариун ёслолыг гүйцэтгэж байгааг хараад ямар сэтгэгдэлтэй байдаг вэ? Ариун ёслолыг гүйцэтгэж байх үед та ариун ёслолын эрхэм нандин мөн чанарыг ойлгодог гэдгээ хэрхэн харуулдаг вэ?

3 Нифай 20:3–5-д цэдэглэгдсэнээр Есүс Христ нифайчуудын дундах үйлчлэлийнхээ хоёр дахь өдөр хүмүүст гайхамшигтайгаар талх ба дарсыг өгч, ариун ёслолыг дахин гүйцэтгэжээ. 3 Нифай 20:1-ийг уншаад Тэр ариун ёслолыг бэлтгэж, түгээхийнхээ яг өмнө хүмүүсээс юу хий гэж хүссэнийг олж мэд. Зүрх

сэтгэлдээ залбирах нь ариун ёслолоос хүртэх долоо хоног тутмын туршлагад тань хэрхэн нөлөөлнө гэж та боддог вэ?

3 Нифай 20:8-ыг унш. Нифайчууд тэр үед дарс хэрэглэсэн бол сүм одоо ус хэрэглэдгийг анхаар (С ба Г 27:2-ыг үзнэ үү). Мөн талх, ус юу төлөөлдгийг анзаар. Бид ариун ёслолоос тогтмол хүртсэнээр Аврагчийн Цагаатгалыг амьдралынхаа хэсэг болгоход бэлэн байгааг харуулдаг.

3 Нифай 20:8-д цэдэглэсэнээр Есүс Христ ариун ёслолоос хүртдэг хүмүүст юу амласан бэ? Ариун ёслолын талх ба усны хэмжээг бод. Хэрэв та бие махбодоороо өлсөж, цангаж байсан бол ариун ёслолын талх, ус өлсгөлөн болон цангааг тань тайлж чадах уу? Бид ариун ёслолоос хүртсэнээр дүүргэгдэж болно гэдгийг илүү сайн ойлгохын тулд 3 Нифай 20:9-ийг уншаад энэ зарчмыг гүйцээн бич: **Хэрэв бид ариун ёслолоос зохистойгоор хүртвэл, бид** _____-аар дүүргэгдэнэ.


Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Даллин Х.Өүксийн дараах үгсийг уншаад таныг Сүнсээр дүүргэгдсэнээр адислагдах болно гэж түүний хэлсэн арга замуудын доогуур зур.



“Ариун ёслолоос хүртсэнээр ‘дүүрсэн байх болно’ (3 Ниф. 20:8; мөн 3 Ниф. 18:9-ийг мөн үзнэ үү), гэсэн нь ‘Сүнсээр дүүргэгдэх’ болно гэсэн утгатай юм. Аврагчийн энэхүү амлалтад өөрсдийгөө тэнцэхээр болгоцгооё” (3 Нифай 20:9).

Тэрхүү Сүнс болох Ариун Сүнс нь биднийг тайвшруулагч, бидэнд зүг чиг заагч, биднийг холбогч, бидэнд тайлбарлагч, бидний гэрч, биднийг ариусгагч—бидний найдаж болох хөтөч, мөнх амьдрал руу бидний хийж байгаа аяллыг ариусгагч юм.

“... Баптисмын гэрээнүүдээ ухамсартай бөгөөд хүндэтгэлтэйгээр шинэчлэх үл ажиглагдам өчүүхэн мэт санагдах үйлдлээс түүний Сүнсстэй үргэлж хамт байх боломжийг бидэнд олгодог ус болон Сүнсээр хийдэг баптисмын адислалуудын шинэчлэл ирдэг. Бид бүгд энэ л арга замаар удирдагдаж мөн энэ л арга замаар бид бүгд ариусгагддаг билээ” (“Always Have His Spirit,” *Ensign*, 1996 оны 11-р сар, 61).

 **1.** Та ариун ёслолоос хүртэх үед Ариун Сүнсийг мэдэрсэн тохиолдлынхоо тухай бод. Моронай 4:3 болон 5:2 дахь ариун ёслолын залбирлуудыг унш. Долоо хоног бүр ариун ёслолоос хүртэх нь Ариун Сүнсээр дүүрэн байхад тань хэрхэн тусалдаг вэ? Эдгээр арга замуудын заримыг судар судлах тэмдэглэлдээ бич.

3 Нифай 20:10–46

Аврагч Нифайчуудад хожмын өдрүүдэд гүйцэлдэх гэрээнүүдийн талаар сургаж


Өөртөө байдаг хамгийн чухал зан чанаруудын тухай бод. Та ямар зан чанаруудад анхаарлаа төвлөрүүлсэн бэ? Бие махбодын шинж чанар, хувийн зан төлөв эсвэл сүнсний шинж чанарт уу?

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Дэвид А. Бэднарын хэлсэн дараах үгийг уншаад бид хэн болохыг тэр хэрхэн тодорхойлсныг тэмдэглэ: “Та дуу хөгжим, спорт эсвэл машин техникт дуртай байж болно. Бас та нэг өдөр худалдааны эсвэл урлагийн салбарт ажиллаж магадгүй. Хэдийгээр ийм үйл ажиллагаанууд, ажил мэргэжил чухал ч гэсэн эдгээр нь биднийг хэн бэ гэдгийг тодорхойлдоггүй. Хамгийн гол нь бид бол сүнслэг хүмүүс. Бид бол Бурханы хөвгүүд, [охид] бөгөөд Абрахамын үр удам шүү дээ” (“Номлогч болох нь,” *Ensign* ба *Лиакхона*, 2005 оны 11-р сар, 47).

Абрахамын үр удам байх гэдэг нь бид Абрахамын шууд үр удам гэсэн утгатай эсвэл Есүс Христийн сайн мэдээний хуулиуд болон ёслолуудад дуулгавартай байснаар түүний хөвгүүд, охид болж болно гэсэн утгатай юм. Бүгд Абрахамтай хийсэн Бурханы амлалтууд болон гэрээнүүдийг хүлээн авдаг.

3 Нифай 20:11–13-т цэдэглэгдсэнээр Аврагч Израилын угсаа болох Абрахам ба түүний үр удамтай хийсэн гэрээнүүд болон амлалтуудын талаар нифайчуудад заажээ. Тэрбээр **Тэнгэр дэх Эцэг Израилын угсааг цуглуулах гэрээгээ эцсийн өдрүүдэд гүйцэлдүүлнэ гэж заасан билээ.** Та 3 Нифай 20:13-ыг уншихдаа энэхүү цугларалтын зайлшгүй чухал хэсэг болох ямар мэдлэгийг Израилын угсааны хүмүүс олж авахыг ажигла. Энэ мэдлэг яагаад зайлшгүй чухал гэж та бодож байна вэ?

3 Нифай 20:25–26-г уншаад Абрахамтай хийсэн Эцэгийн гэрээний ачаар Лихайн үр удам хэрхэн адислагдсан тухай Аврагч юу заасныг олж мэд. Эцэг Түүнийг нифайчууд дээр айлчилж, тэднийг гэм нүглээс нь аврахаар илгээсний учир нь “[тэд] гэрээний хүүхдүүд байсныг” (3 Нифай 20:26) Аврагч онцолсон ажээ.

 **2.** Та баптисмаар Тэнгэрлэг Эцэгтэй байгуулсан гэрээгээр хэрхэн адислагдсанаа судар судлах тэмдэглэлдээ бич. Та баптисм хүртэж, сүмийн гишүүн болсон учир Абрахамын үр удам бөгөөд Абрахамтай байгуулсан Бурханы гэрээг гүйцэлдүүлэхэд туслах үүрэгтэй.

3 Нифай 20:27-г уншаад дараах зарчмыг заасан хэллэгүүдийг тэмдэглэ: **Бид Абрахамын үр удмын хувьд дэлхийн бүх хүмүүсийг адислах гэрээний үүрэг хариуцлагатай.**



Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Дэвид А.Беднарын дараах үгсийг уншаад бид Абрахамын үр удмын хувьд дэлхийн бүх хүмүүсийг хэрхэн адислахыг олж мэд: “Та бид энэ дэлхийн бүх улс гүрний бүх хүмүүсийг өнөөдөр болон үргэлж адислах үүрэгтэй. Та бид өнөөдөр болон үргэлж Есүс Христийг гэрчилж, Сэргээлтийн захиасыг тунхаглах ёстой. Та бид бүх хүмүүсийг авралын ёслолуудыг хүлээн авахад өнөөдөр болон үргэлж урин дуудах ёстой. Сайн мэдээг тунхаглах нь санваарын хагас цагийн үүрэг хариуцлага биш. Энэ нь хэсэг хугацаанд бидний оролцдог үйл ажиллагаа биш эсвэл бид Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүдийн хувьд л гүйцэтгэх ёстой даалгавар биш. Харин номлолын ажил бол бидний сүнслэг байдал ба өв уламжлалын илрэл юм. Бид Абрахамтай хийсэн Бурханы гэрээ болон амлалтыг биелүүлэхийн тулд мөнх бус амьдралын өмнөх оршихуйд урьдчилан томилогдож, мөнх бус амьдралд төрсөн билээ. Бид санваараа эрхэмлэн биелүүлж, сайн мэдээг номлолын тулд энэ дэлхий дээр, энэ цаг үед аж төрж байгаа билээ. Бид ийм л хүмүүс бөгөөд ийм учраас өнөөдөр энд байгаа юм, мөн үргэлж байх болно” (“Номлогч болох нь,” 47).



3. Дараах асуултуудад судар судлах тэмдэглэлдээ хариулж бич:

- а.** Залуус та нар дэлхий дээрх бусад хүмүүсийг адислахын тулд одоо юу хийж чадах вэ?
- б.** Та өөрийгөө Абрахамын үр удам гэдгээ мэдэх нь яагаад чухал гэж бодож байна вэ?

3 Нифай 21–22

Есүс Христ эцсийн өдрүүд дэх Израилын угсааны цугларалтын тэмдгийг зөгнөн хэлсэн нь

3 Нифай 21–22-т цэдэглэгдсэнээр Аврагч нифайчуудад сайн мэдээ дэлхийд дахин сэргээгдэж, гэгээнтнүүд Түүний Хоёр дахь ирэлтэд бэлтгэх тэр цаг буюу эцсийн өдрүүдийн тухай олон зүйлийг заажээ.



4. Та 3 Нифай 21–22-т цэдэглэгдсэн, хожмын үеийн Израилын цугларалтын тухай Аврагч юу заасныг олж мэдэхийн тулд дараах жишиг зурагны зүүн багана дахь бүх судрыг унш. Дараа нь баруун багана дахь асуултуудаас хоёрыг сонгоод судар судлах тэмдэглэлдээ хариулж бич.

Шүлгүүд	Асуултууд
3 Нифай 21:1–2, 7-г унш. Эцсийн өдрүүдэд Мормоны Ном ирэх нь Эцэг Израилын угсааг цуглуулж эхэлсний тэмдэг байх болно.	а. Мормоны Ном хэн нэгнийг, түүний дотор өөрийг тань Есүс Христ болон сайн мэдээний гэрээнүүд рүү хөтлөхийг (эсвэл цуглуулахыг) та хэзээ харсан бэ?
3 Нифай 21:9-ийг унш. “Агуу хийгээд гайхамшигт ажил” гэсэн хэллэг нь Есүс Христийн сайн мэдээний сэргээлтийг хэлж байгаа юм.	б. Та Есүс Христийн сайн мэдээний сэргээлтийн агуу болоод гайхамшигтай тал нь юу гэж бодож байна вэ?
3 Нифай 21:10–11-ийг уншаад энэхүү дүрслэлд Иосеф Смит хэрхэн тохирч байгааг тунгаан бод.	в. Их Эзэний үгс Иосеф Смитээр дамжин ирсэн гэдэгт итгэх нь яагаад чухал вэ?

Шүлгүүд	Асуултууд
3 Нифай 21:22-ыг унш. Хэрэв хүмүүс наманчилж, зүрх сэтгэлээ хатууруулахгүй бол тэд Израилын угсааныхны дунд тоологдох болно.	г. Хүн Бурханы гэрээт хүмүүстэй хамт цуглуулагдахад наманчлал яагаад чухал гэж та бодож байна вэ?
3 Нифай 22:7–10-ыг уншаад Аврагчтай байгуулсан гэрээгээ мартсаны дараа Түүнд эргэн ирэх Түүний гэрээт хүмүүст өгсөн Аврагчийн амлалтуудыг ол.	д. Их Эзэн Өөрийг нь орхисон хүмүүст үүрдийн нинжин сэтгэл, нигүүлслээ үзүүлдгийг ойлгох нь яагаад чухал гэж та бодож байна?

Та сэргээгдсэн сайн мэдээний адислалуудыг хүлээн авахад нь туслахын тулд Есүс Христ, Мормоны Ном, сайн мэдээний Сэргээлт, Бошиглогч Иосеф Смитийн үүрэг зорилгын тухай гэрчлэлээ хуваалцаж болох хэн нэгнийг бод. Та мөн бусдыг, түүний дотор өмнө нь сайн мэдээнд итгэлтэй байсан ч одоо итгэлгүй болсон хүмүүсийг Их Эзэнд ирэхэд нь хэрхэн урамшуулан дэмжихийг тунгаан бод. Та тодорхой нэг хүнийг бодож олвол хүлээн авсан сүнсний өдөөлтөө ашиглан түүнтэй ажиллах зорилго тавь.



5. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би 3 Нифай 20–22-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

27-Р ХЭСЭГ: 1 ДЭХ ӨДӨР

3 Нифай 23

Оршил

Есүс Христ Исаиагийн үгсийг эш татсаныхаа дараа нифайчуудад бошиглогчдын үгсийг судлахыг зарлиг болгов. Аврагч нифайчуудыг цэдэг хөтлөхдөө хичээнгүй биш байгааг мөн анхааруулав.

3 Нифай 23:1–5

Есүс Христ бошиглогчдын үгсийг судлахыг хүмүүст зарлигласан нь

Энэ жил судар судлах туршлага тань ямар байгааг бод. Судруудыг судалснаар таны амьдралд ирсэн адислалуудыг дүрсэлсэн цөөн үгс эсвэл богинохон өгүүлбэрүүдийг бич. _____

Жагсаалтаа хараад эдгээр адислалууд судар судлахын ач холбогдлын талаар танд юу зааж байгааг эргэцүүлэн бод.

Аврагч Исаиагийн үгсийг эш татсаныхаа дараа (3 Нифай 22-р бүлгийг үзнэ үү) Исаиагийн болон бошиглогчдын үгсийг хичээнгүйлэн судлахыг хүмүүст зарлиг болгов. Та 3 Нифай 23:1–5-ыг уншаад Аврагч биднийг *яагаад* Исаиагийн болон бошиглогчдын үгсийг судлах ёстой гэж хэлснийг олж мэд. Сурч мэдсэн зүйлсээ санахад тань туслах үг хэллэгүүдийг тэмдэглэж ав.

Исаиагийн үгсийг судлахыг бидэнд зарлиг болгосны нэг шалтгаан нь “Израилын угсаа болох [Их Эзэний гэрээт] хүмүүсийн талаар бүх зүйлийг . . . тэр ярьсан” (3 Нифай 23:2) явдал юм. Та Их Эзэнтэй гэрээ байгуулсан учир Израилын угсаанд харьяалагдана. Исаиагийн бичээсүүд танд хамаатай. Бид Исаиагийн үгсийг судлах ёстой өөр нэг шалтгаан бол тэдгээр нь бүгд биелэгдэх учраас тэр юм (3 Нифай 23:3-ыг үзнэ үү).

Есүс Христ 3 Нифай 23:1-т “[Исаиагийн үгсийг] хичээнгүйлэн судал” хэмээн нифайчуудад онцгойлон зарлиг болгожээ.



1. Дараах асуултуудад судар судлах тэмдэглэлдээ хариулж бич:

а. Бошиглогчдын үгсийг унших, тэдгээрийг хичээнгүйлэн судлахын хооронд ямар ялгаатай гэж та бодож байна вэ?

б. Исаиа болон бусад бошиглогчдын үгсийг илүү үр өгөөжтэй, утга учиртай судлахад тань судар судлах ямар аргууд тусалж чадах вэ? (Та зарим судар судлах тусламжуудыг санахын тулд, 1-р хэсгийн нэг дэх өдрийн хичээлийн “Судруудыг судлах нь” хичээлийг давтах хэрэгтэй.)

Далын чөлөөлөгдсөн ахлагч Мэррилл Ж.Бэйтмэн, бошиглогчдын үгсийг судалснаар бидний амьдралд ирдэг зарим адислалуудыг ийнхүү онцлон тэмдэглэжээ: “Хүн судар судалснаар тодорхой адислалуудыг хүлээн авдаг. Хүн Их Эзэний үгсийг судалж, тэдгээрийг дагаснаар Аврагчид илүү ойртож, зөв шударга амьдралаар амьдрах илүү их хүсэлтэй болдог. Мөн уруу таталтыг эсэргүүцэх хүч нь нэмэгдэж, сүнслэг байдлын сул дорой байдлаа даван туулж, сүнслэг

байдлын шарх нь эдгэрнэ” (“Coming unto Christ by Searching the Scriptures,” *Ensign*, 1992 оны 11-р сар, 28).

3 Нифай 23:5-ыг уншаад хэрэв бид судрыг судалж, доторх урилгуудын дагуу үйлдсэн бол бид бүгдэд өгсөн Их Эзэний амлалтыг ол.



2. Таны найз эсвэл гэр бүлийн тань хэн нэгэн судруудыг тогтмол судалж чадахгүй байна гэж бод. 3 Нифай 23:1–5-р шүлгүүдээс сурсан зүйлээ ашиглан та энэ хүнд судруудыг хичээнгүйлэн судалж, үр нөлөө бүхий туршлагатай болоход нь урам дэм өгөхийн тулд хэлэх нэг зүйлийг бич.

3 Нифай 23:6–14

Есүс Христ шавь нараа чухал үйл явдлуудыг цэдэглээгүйн улмаас зэмлэв

Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимбаллын хэлсэн дараах үгсийг унш:



“Их Эзэн Есүс Христ Өөрөө нифайчууд ба леменчүүдэд цэдэг хөтлөхийн асар их ач холбогдлыг онцлон тэмдэглэжээ [3 Нифай 23:6–13-ыг үзнэ үү]. . . .

“Би өөрийн цэдгүүдийг тухай бүр бичиж хөтлөх үүргээ биелүүлээгүйнхээ төлөө эелдэг зөөлнөөр ч гэсэн зэмлүүлээгүйдээ баяртай байна. . . .

“. . . Аврагч чухал үйл явдлуудыг цэдэглээгүй хүмүүсийг зэмлэснийг санагтун” (“The Angels May Quote from It,” *New Era*, 2003 оны 2-р сар, 32, 34–35).

3 Нифай 23-р бүлгийн үлдсэн хэсэг нь Аврагч чухал үйл явдлуудыг цэдэгтээ оруулаагүйн төлөө нифайчуудыг зэмлэсэн тухай Ерөнхийлөгч В.Кимбаллын тайлбарыг агуулдаг. 3 Нифай 23:6–11-ийг уншаад нифайчууд юуг цэдэглээгүйг олж мэд. Нифайчуудад лемен үндэстэн Самуелын энэхүү бошиглолын биелэлтийг бичих нь яагаад чухал байсан бэ? Мормоны Номд энэ цэдэг байгаа нь өнөөдөр бидэнд хэрхэн тусалж байна вэ?



3. Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултад хариул: Амьдралд тань тохиолдсон сүнслэг үйл явдлууд болон сүнсний өдөөлтүүдийг бичиж тэмдэглэх нь яагаад чухал вэ?

Амьдралд тань саяхан тохиолдсон сүнслэг үйл явдлыг тэмдэглээгүй байгаа бол, хувийн тэмдэглэлдээ одоо бич. Хувийн тэмдэглэл нь энгийн дэвтэр эсвэл салдаг хуудастай дэвтэр байхад болно. 3 Нифай 23:12–14-ийг уншаад нифайчууд лемен үндэстэн Самуелын бошиглолын биелэлтийг бичих зарлигийг дагасны дараа Аврагч юу хийснийг олж мэд.

Аврагч “бүх судруудыг нэгтгэн тайлбарласан” гэдэг нь Тэр судруудын утгыг тайлбарласан гэсэн үг юм.

3 Нифай 24:1-ийг уншаад энэ шүлгийн эхний хэсэг, 3 Нифай 23:12–14-т өгүүлсэн зүйл хоёрын хоорондох төстэй зүйлсийг анхаар. Нифайчууд Есүс Христийн заасан зүйлсийг цэдэглэсний дараа, Тэр тэдэнд тэдгээр зүйлсийг тайлбарлан илүү их мэдлэг болон илчлэлт өгснийг анзаараарай.

3 Нифай 23:6–14-р шүлгүүдээс сурсан зүйл дээрээ түшиглэн дараах зарчмыг гүйцээж бич: **Би сүнсний ариун өдөөлтүүд болон үйл явдлуудыг тэмдэглэснээрээ**

урьдаг.

Та энэ зарчмыг өөр хувилбаруудаас гадна ийм байдлаар бичиж болох байсан: Би сүнсний ариун өдөөлтүүд болон үйл явдлуудыг тэмдэглэснээрээ Их Эзэнийг надад илүү олон илчлэлт өгөхөд урьдаг.

Та сурч мэдсэн үнэнээ илүү бүрэн ойлгохын тулд Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Ричард Г. Скоттын хэлсэн дараах хоёр үгийг унш:



“Нягт нямбай хөтөлсөн мэдлэг бол хэрэг болсон үед бэлэн байдаг мэдлэг юм. Та сүнслэг байдлын хувьд нарийн нандин мэдээллийг Их Эзэнтэй ойрхон ариун газар хадгалах хэрэгтэй. Ийм хэвшил нь таны гэрэл хүлээн авах цаашдын боломжийг нэмэгдүүлдэг” (“Acquiring Spiritual Knowledge,” *Ensign*, 1993 оны 11-р сар, 88).

. . . Сүнснээс сурсан чухал зүйлсээ найдвартай газарт тэмдэглэж бай. Та үнэ цэнэтэй сэтгэгдлүүдээ бичиж авах тусам илүү олноор ирэхийг харах болно. Мөн та олж авах мэдлэгээ амьдралынхаа турш ашиглах боломжтой байх болно (“To Acquire Knowledge and the Strength to Use It Wisely,” *Ensign*, 2002 оны 7-р сар, 32).



4. Дараах асуултауд судар судлах тэмдэглэлдээ хариулж бич:

а. Их Эзэнээс хүлээн авсан илчлэлтүүдээ тэмдэглэж байх нь яагаад илүү олон илчлэлт авахад бидэнд тусалдаг гэж та бодож байна?

б. Бидний амьдрал дахь Их Эзэний нөлөөний тухай бичих цаг гаргах нь бид түүнд адислалуудынхаа төлөө талархал илэрхийлэхэд хэрхэн тусалж болох вэ?

Та бичиж тэмдэглэхүйц онцгой эсвэл ариун нандин туршлага танд байхгүй хэмээн санаа зовж байж магадгүй. Далын чөлөөлөгдсөн ахлагч Жон Х.Гробэрг энэ талаар ийн хэлжээ: “Зарим хүмүүс, ‘Надад бичих юм юу ч байхгүй. Надад ямар ч сүнслэг зүйл тохиолддоггүй’ гэдэг. Харин би, ‘Бичиж эхэл, тэгвэл

сүнслэг зүйлс тохиолдох болно гэж зөвлөе. Бичих зүйл үргэлж байдаг, харин бид тэдгээрийг бичсэнээрээ илүү мэдрэмтгий болдог” (“Writing Your Personal and Family History,” *Ensign*, 1980 оны 5-р сар, 48).

Та цаас, дэвтэр эсвэл тэмдэглэлээ ирэх долоо хоногийн турш биедээ авч явбал сүнслэг туршлагаа тэмдэглэж байх талаар сурч мэдсэн зүйлээ хэрэгжүүлж чадна. Сүнсний аливаа өдөөлт, сэтгэгдэл, туршлага эсвэл мэдрэмжүүдээ долоо хоногийн турш бичиж тэмдэглэ. Мөн хүлээн авсан сүнсний өдөөлтүүдээ хэрэгжүүлэх талаар юу бодож байгаагаа бич. Эдгээр үйлдлүүдийг хийснийхээ дараа туршлагаа бич.

Хэн нэгэнд (гэр бүлийн гишүүн, найз эсвэл сүмийн удирдагч) сүнслэг туршлагуудаа бичиж тэмдэглэх төлөвлөгөөнийхөө тухай ярь. Энэ хүнийг өөртэйгөө хамт сүнслэг туршлагаасаа бичихэд урь. Та өөр хүнийг ийм төлөвлөгөө хийхэд урьснаар та хоёр бие биедээ урам дэм өгч, ахиц дэвшлээ хуваалцаж болно. Гэвч та ариун нандин туршлагаа бие бие-тэйгээ хуваалцах нь шаардлагагүй эсвэл зохимжгүй байж болохыг санах хэрэгтэй.



5. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би 3 Нифай 23-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

27-Р ХЭСЭГ: 2 ДАХЬ ӨДӨР

3 Нифай 24–26

Оршил

Есүс Христ 3 Нифай 24–25-д, Малахийн зарим бошиглолыг хүмүүст танилцуул гэсэн Тэнгэрлэг Эцэгийн зарлигийг биелүүлжээ. Малахи Израилын угсааныхан Аврагчийн ирэлтэд бэлтгэхийн тулд наманчилж, Их Эзэнд эргэн ирэх шаардлагатайг тунхагласан юм. 3 Нифай 26:3-т цэдэглэгдсэнээр Есүс Христ хүмүүст “бүх зүйлийг, бүр эхлэлээс тэрбээр алдар суундаа ирэх тэр цагийг хүртэл” тайлбарлав. Мормоны Номд итгэдэг хүмүүст бүр агуу зүйлс үзүүлэгдэх болно хэмээн Мормон заасан билээ (3 Нифай 26:9-ийг үзнэ үү).



3 Нифай 24:1–6

Есүс Христ Хоёр дахь ирэлтийн талаарх Малахийн бошиглолыг эш татсан нь


Есүс Христ Малахийн бошиглолуудын заримыг нифайчуудад ярихдаа гал ба савангийн тухай дурджээ. Дүрэлзэх гал ба нэг ширхэг саванг төсөөлөн бод. Эдгээр хоёр зүйл ариутгалын эсвэл цэвэрлэгээний бодисын хувьд юугаараа ижил төстэйг бод.

3 Нифай 24:2–3-ыг унш. 3 Нифай 24:2-т, Есүс Христийг металл цэвэршүүлэгчийн гал, хувцас угаагчийн савантай зүйрлүүлсэн нь Тэрбээр Хоёр дахь ирэлтээрээ юу хийхтэй холбоотой юм. 3 Нифай 24:3-т, Түүнийг мөнгө цэвэршүүлдэг дархантай зүйрлүүлжээ. Эдгээр шүлгүүдийг ойлгохын тулд мөнгө цэвэршүүлэх явцад мөнгөний дархан хэсэг мөнгийг галын хамгийн халуун хэсэгт барьж, хэрэггүй зүйлсийг шатааж арилгадаг. *Цэвэршүүлэгч* нь мөнгийг сайн харж байхгүй бол мөнгө гал дотор байх хугацаанаасаа ганцхан хором л хэтэрвэл сүйддэг. *Хувцас угаагч* нь саван ашиглаж хувцсыг угаан цэвэр болгож, цайруулдаг хүн. “Левийн хөвгүүд” эртний Израилд санваарыг атгагчид байсан бөгөөд энэ нэр томьёо өнөө үед Их Эзэний бүх хүмүүсийг хэлж байгаа юм.

Дээрх дүрслэл Есүс Христийн Хоёр дахь ирэлтээр юу тохиохыг анхааруулж байгааг тунгаан бод. Судартаа 3 Нифай 24:2–3-ын хажууд: **Есүс Христ**

Хоёр дахь ирэлтээрээ Өөрийн хүмүүсийг цэвэршүүлэх болно гэж бич.

3 Нифай 24:5–6-г уншаад Аврагчийн ирэлтээр хэн устгагдахыг мөн хэн устгагдахгүй эсвэл сүйрэлд өртөхгүй гэдгийг олж мэд. (Энэ хэсэгт гарч байгаа “Иаковын хөвгүүд” гэсэн үг нь Их Эзэнтэй гэрээнд орсон Израилын угсааны хүмүүс гэдгийг анхаар.) Эдгээр шүлгүүдийн заадаг зарчим нь: **Есүс Христ Өөрийн ирэлтээр ёс бусчуудыг шүүх болно** гэсэн зарчим юм.

 **1.** Судар судлах тэмдэглэлдээ дараах гарчгийг бич: *Би Есүс Христийн Хоёр дахь ирэлтэд өөрийгөө бэлтгэхийн тулд юу хийх ёстой вэ?* Та 3 Нифай 24–26-р бүлгүүдийг үргэлжлүүлэн судлахдаа Есүс Христийн Хоёр дахь ирэлтэд бэлтгэхэд тань туслах зүйлсийг энэ гарчгийн дор жагсаан бич.

3 Нифай 24:7–18

Малахи Израилын угсаа Их Эзэнд хэрхэн буцаж очихыг заажээ

Таны нэг сайн найз эсвэл танай гэр бүлийн хэн нэгэн нь хувь хүний үйлдлүүд Шүүлт, Хоёр дахь ирэлтэд эсвэл үүрд мөнхөд түүнд нөлөөлж болох талаар санаа зовохгүй байна гэж төсөөлөн бод. Та энэ хүнд туслахын тулд юу гэж хэлэхээ бод. 3 Нифай 24:7-г уншаад Их Эзэн Өөрөөс нь холдон хөндийрч байгаа Иаковын хөвгүүдэд юу гэж хэлснийг олж мэд. Хүмүүс Их Эзэний ёслолуудаас “зайцан явсан” гэдэг нь юу гэсэн утгатай гэж та бодож байна?


Сүм дэх ёслол бол санваарын эрх мэдлээр албан ёсоор гүйцэтгэгддэг ариун зан үйл юм. Зарим ёслол бидний авралд нэн чухал. Эдгээр ёслолуудыг “авралын ёслолууд” гэдэг. Эдгээр ёслолуудад баптисм, гишүүний баталгаа, Мелкизедек санваарт томилох (эрэгтэйчүүдийг), ариун сүмийн хишиг хүртэх, гэрлэлтийг лацдан холбох нь багтдаг. Бид эдгээр ёслол тус бүрээр Их Эзэнтэй ариун гэрээнүүд хийдэг. Та авралын ёслолуудыг судар судлах тэмдэглэлдээ нэг дэх даалгаврын гарчигны доор жагсаан бич. Эдгээр ёслолууд нь биднийг Хоёр дахь ирэлтэд бэлтгэхэд хэрхэн туслахыг бод.

Хэдийгээр Их Эзэний хүмүүс сайн мэдээний ёслолууд болон гэрээнүүдээс холдон хөндийрсөн ч Их Эзэн тэднийг Өөрт нь эргэж ирвэл 3 Нифай 24:7-р шүлэг дэх амлалтыг тэдэнд өгснийг анхаар. **Хэрэв бид Их Эзэнд эргэж ирвэл Тэр бидэн рүү эргэх болно** гэсэн амлалтыг санахын тулд судартаа тэмдэглэ.

3 Нифай 24:8–10-ыг уншаад Иаковын хөвгүүд Их Эзэнд эргэж ирж, Хоёр дахь ирэлтэд бэлтгэж болохыг харуулсан нэг арга замыг ол. Аравны нэг болон өргөлүүдээ төлөхийг судар судлах тэмдэглэлдээ нэг дэх даалгаврын гарчигны доор бич.

Аравны нэгээ төлөх талаар Ерөнхийлөгч Гордон Б. Хинкли дараах зөвлөгөөг өгснийг унш: “Бид аравны нэгээ төлж чадна. Энэ нь мөнгөний асуудал биш, харин итгэлийн асуудал юм” (“Let Us Move This Work Forward,” *Ensign*, 1985 оны 11-р сар, 85).

Их Эзэнд аравны нэг болон өргөлүүдээ төлөх таны хүсэл хэрхэн Их Эзэнд итгэх итгэлийн тань илрэл болдгийг түр зуур тунгаан бод. 3 Нифай 24:10–12-ыг уншаад аравны нэгээ шударгаар бүрэн төлдөг хүмүүст ирдэг адислалууд дээр анхаарлаа төвлөрүүл.

 **2.** Дараах асуултаудад судар судлах тэмдэглэлдээ хариулж бич:

а. Та аравны нэгийн хуулинд дуулгавартай байснаар ямар адислалуудыг хүлээн авсан бэ?

б. Аравны нэг болон өргөлүүдээ төлөх зарлигийг сахих нь Хоёр дахь ирэлтэд сүнслэг байдлын хувьд бэлтгэхэд тань хэрхэн тусалсан гэж бодож байна?

Эртний Израилын зарим хүмүүс Их Эзэний зарлигуудыг сахих нь тэдэнд ямар нэгэн сайн юм болоогүй хэмээн бувтналдаж байсан. Тэд өөрсдийн хүч чармайлтыг дэмий хоосон эсвэл утга учиргүй өнгөрсөн гэж үздэг байжээ (3 Нифай 24:14-ийг үзнэ үү). Нөгөөтэйгүүр, тэд бардамнагч ёс бусчуудыг “аз жаргалтай,” “дэвжин дээшилсэн,” “эрх чөлөөтэй”



хэмээн маргалддаг байлаа (3 Нифай 24:15). Өөрөөр хэлбэл эдгээр хүмүүс ёс бусыг үйлдэгчид зөв шударга хүмүүсээс илүү сайхан амьдарч байна хэмээн гомдоллодог байв. Их Эзэн тэдний гомдолд хариулахдаа Их Эзэнээс эмээж, Түүний нэрийг боддог, нэг нэгэнтэйгээ ярилцахын тулд хамтдаа цугладаг хүмүүсийн нэр “дурсамжийн номд” (3 Нифай 24:16) бичигдсэн байх болно гэжээ. Тэд бол Их Эзэний ирэлтэд бэлтгэж байгаа хүмүүс бөгөөд Тэрбээр тэднийг Өөрийн

нандигнасан “үнэт чулуу” мэт хэлтрүүлэх болно (3 Нифай 24:16–17-г үзнэ үү). Их Эзэн гомдоллогс-дыг хүлээж, тэгээд “эргэж ирэн мөн зөв шударгыг үйлдэгчид мөн ёс бусыг үйлдэгчдийн хоорондох ялгааг олж харж” чадах үедээ эцсийн үр дүнг нь хар гэж сорьжээ (3 Нифай 24:18). Тэд зөв шударга хүмүүс эцэст үлэмж сайн болсныг харах болно.

3 Нифай 25


Елиа Хоёр дахь ирэлтийн өмнө ирэх болно гэсэн Малахийн бошиглолыг Есүс Христ эш татжээ


3 Нифай 25:1–3-ыг уншаад Хоёр дахь ирэлт яагаад Есүс Христэд итгэгч хүмүүст адислал болохыг олж мэд. Үндэс гэдэг үг 1-р шүлэгт байгаа бөгөөд энэ нь өвөг дээдсийг, харин *мөчир* гэдэг үг тэдний үр удмыг төлөөлдөг. Тиймээс ирэх амьдралд хилэнцэт хүмүүс өвөг дээдэс болон үр хүүхдүүдийнхээ алин-тай нь ч холбогдох адислалыг хүртэхгүй. Тугалнууд “пүнзэнд . . . өсөх болно” гэдэг нь хамгаалагдсан, бүхнээр хангагдсан, хайр халамж эдэлсэн хүүхдүүдийг хэлж байгаа юм.

Аврагч Хоёр дахь ирэлтийн өмнөхөн тохиох нэг үйл явдлын тухай Малахийн бичсэн зүйл болон үүнд Хуучин Гэрээний бошиглогч Елиа оролцох тухай нифайчуудтай хуваалцжээ. 3 Нифай 25:5–6-г уншаад Елиа Их Эзэний ирэлтэд дэлхийг бэлтгэхийн тулд юу хийх болно гэж Малахи заасныг олж мэд.

Елиа дэлхийд эргэн ирсэн нь сайн мэдээний сэргээлтийн чухал хэсэг байсан юм. 1836 оны дөрөвдүгээр сарын 3-нд шинэхэн онцгойлон адислагдсан Көртландын Ариун сүмд Елиа Иосеф Смит, Оливер Каудери хоёрт үзэгдсэн билээ (С ба Г 110-р бүлгийг үзнэ үү). Тэрээр тэдэнд гэр бүлүүдийг үе удамаар нь холбоход шаардлагатай санваарын лацдан холбох хүчийг өгчээ. “Эцгүүдийн зүрх сэтгэлийг хүүхдүүдэд нь, мөн хүүхдүүдийнх нь зүрх сэтгэлийг эцгүүдэд нь эргүүлэх” (3 Нифай 25:6) гэсэн үгс юу гэсэн утгатай гэж та бодож байна вэ? _____

Эдгээр шүлгүүд **бидний зүрх сэтгэл эцгүүд рүүгээ эргэхэд бид Есүс Христийн Хоёр дахь ирэлтэд дэлхийг бэлтгэхэд тусалж байгааг** заадаг.

 **3.** Танд эсвэл танай гэр бүлийн гишүүдэд зүрх сэтгэлээ эцгүүд рүүгээ эргүүлэхэд тусалсан туршлагын тухай судар судлах тэмдэглэлдээ бич. Ариун сүмд лацдан холбуулсан, гэр бүлийнхээ түүхийг судалсан эсвэл нас барагсдын төлөөх баптисмуудад оролцсон зэрэг нь үүнд орж болно. Та ямар нэг туршлагыг санахгүй бол энэ үйлсэд оролцох хүслийнхээ талаар нэг богинохон догол мөр бич. (Судар судлах тэмдэглэлдээ нэг дэх даалгаврын дор та: *ариун сүмийн ёслолуудыг өөртөө болон гэр бүлдээ хүлээн авах, ариун сүмд орох, гэр бүлийн түүхийн мэдээлэл цуглуулах* гэж бич.)




3 Нифай 26

Есүс Христийн илчилсэн илүү агуу зүйлсийг хүлээн авахын тулд хийх ёстой зүйлс

Бид 3 Нифай 26:3-аас Аврагч нифайчуудад “газрын гадаргуу дээр ирэх тэр бүх зүйлийг” заасныг сурдаг. 3 Нифай 26:6–8-ыг уншаад Аврагчийн номлолоос хэр их хэсэг нь Мормоны Номд цэдэглэгдсэнийг олж мэд. Мормон яагаад бүх зүйлийг оруулаагүйг мэдэхийн тулд 3 Нифай 26:9–11-ийг судал.

Их Эзэн бидний итгэлийг сорихын тулд Мормонд эдгээр сургаалуудаас зөвхөн багахан хэсгийг нь оруулахыг зааварлажээ. Бид 3 Нифай 26:1–21-р шүлгүүдээс **Бид Бурханы илчилсэн зүйлд итгэснээр өөрсдийгөө илүү агуу илчлэлт хүлээн авахад бэлтгэдгийг сурдаг.** Бид нэмэлт үнэнийг хүлээн авахаас өмнө аль хэдийн хүлээн авсан үнэнүүддээ итгэх нь яагаад чухал гэж та бодож байна вэ? (Алма 12:9–11-ийг үз.) Бид Их Эзэний илчилсэн зүйлд итгэдгээ хэрхэн харуулж чадах вэ?

 **4.** Дээр тодоор бичсэн зарчмыг хэрэгжүүлэхийн тулд судар судлах тэмдэглэлдээ дараах асуултад хариулж бич: Та Мормоны Номд итгэдгээ харуулахын тулд амьдралдаа юу хийж байна вэ?

3 Нифай 26-р бүлгийн үлдсэн хэсэгт цэдэглэгдсэнээр Мормон Аврагчийн үйлчлэл болон энэхүү үйлчлэл нифайчуудад ямар нөлөө үзүүлснийг товчлон бичжээ. 3 Нифай 26:13–21-ийг уншаад Есүс

Христийн хэлсэн үгсийг хүмүүс хэрхэн хэрэгжүүлснийг тэмдэглэж ав.



5. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би 3 Нифай 24–26-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

27-Р ХЭСЭГ: 3 ДАХЬ ӨДӨР

3 Нифай 27)

Оршил

Нифай үндэстэн арванхоёр шавийн үйлчлэлийн эхэн үед, тэдний дунд амилсан Аврагч үзэгдсэн хоёр дахь өдрөөс хойш, тэдгээр арванхоёр шавь нь хүчит залбирал ба мацаг барилтад нэгдэн цуглажээ. Есүс Христ тэдэнд дахин үзэгдэж, сүм ямар нэртэй байх ёстой тухай тэдний асуултад хариулав. Аврагч тэдэнд Цагаатгал бол Түүний сайн мэдээний гол хүчин зүйл бөгөөд бид наманчилж, баптисм хүртэж, эцсээ хүртэл тэвчсэнээр Цагаатгалаар дамжуулан Түүний өмнө толбогүй зогсох болно гэдгийг заажээ. Түүнээс гадна Тэр шавь нартаа Өөр шигээ байхыг зарлиг болгожээ.

3 Нифай 27:1–12

Есүс Христ арванхоёр шавьдаа Өөрийнх нь Сүм Түүний нэрийг авах ёстойг заажээ

Та нэг шинэ клуб эсвэл спортын нэг багтай болох гэж байна гэж бод. Ямар төрлийн клуб эсвэл баг зохион байгуулахаа шийдээд дараа нь түүндээ нэр сонго. Сонгосон нэр болон байгууллагынхаа төрлийг бич: _____

Мэддэг зарим байгууллагынхаа тухай, тэдгээрийн нэрс ямар утгатай болох мөн зорилго болон ямар хүмүүс бүрэлдэхүүнд нь байдгийг бод.

Нифай үндэстэн арванхоёр шавь үргэлжлүүлэн зааж, хүмүүст баптисм хүртэж байв. Тэднийг нэг удаа залбирал, мацаг барилтад нэгдээд байхад Аврагч тэдэнд дээр дахин иржээ (3 Нифай 27:1–2-ыг үзнэ үү). 3 Нифай 27:3–7-г уншаад шавь нарын асуулсан асуулт болон Аврагчийн хариултыг олж мэд.

Есүс Христ сүмийг Өөрийнхөө нэрээр нэрлэх ямар шалтгаануудыг хэлснийг тэмдэглэ.

3 Нифай 27:8–10-ыг судлаад Аврагч Өөрийнх нь үнэн сүмийн үзүүлэлтүүдийг юу гэж заасныг тэмдэглэ. Гарын авлагадаа байгаа үнэн сүмийн гол онцлогуудыг харуулсан өгүүлбэрийг гүйцээж бич:

Есүс Христийн үнэн сүм бол _____

ЕСҮС ХРИСТИЙН ХОЖМЫН ҮЕИЙН ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

Есүс Христийн сүм Түүний нэрээр нэрлэгдээд зогсохгүй мөн Түүний сайн мэдээн дээр баригдсан байх нь яагаад чухал болохыг бод (3 Нифай 27:8–10-ыг үзнэ үү). Хэрэв сүм Есүс Христийн сайн мэдээн дээр баригдвал Тэнгэрлэг Эцэг Өөрийн ажлыг тэр сүм дотор харуулах болно гэж Аврагч нифайчуудад амласан билээ (3 Нифай 27:10-ыг үзнэ үү). Та хувьдаа Тэнгэрлэг Эцэг Өөрийн ажлыг сүм дотор харуулахыг үзсэнээ тунгаан бод.



1. *Есүс Христийн үнэн сүмийн гишүүн байх нь надад чухал, учир нь . . . гэж судар судлах тэмдэглэлдээ бичээд дараа нь энэ талаарх өөрийн санааг богинохон нэг догол мөрд багтаан бич. 3 Нифай 27:1–12-ыг судлахдаа сурч мэдсэн зүйлээсээ аль болох олон шалтгааныг бичихийг хичээ.*


3 Нифай 27:13–22

Есүс Христ Өөрийн сайн мэдээг тодорхойлоод бид Түүний өмнө гэм буруугүй зогсохын тулд юу хийх ёстойг заажээ

Буруу гэдгийг нь өөрөө мэддэг ямар нэг зүйлийг хийж байгаад баригдсан үеэ бод. Таны хийсэн зүйл үнэнээрээ мэдэгдэхэд танд ямар санагдсаныг эргэн сана. Дараах асуултуудыг тунгаан бод: Хэрэв та зарим буруу үйлээ наманчлалгүйгээр Их Эзэний өмнө шүүгдэхээр зогсвол танд ямар санагдах вэ? Хэрэв танд амьдралдаа үйлдсэн гэм нүглийнхээ алийг нь ч наманчлах арга байгаагүй бол Их Эзэний өмнө шүүгдэхээр зогсох үед танд ямар санагдах бол?


Аврагч Өөрийнх нь сүм Түүний сайн мэдээн дээр баригдах ёстойг нифайчуудад заасныхаа дараа Түүний сайн мэдээ гэж юу болохыг мөн тэдэнд заажээ. *Сайн мэдээ* гэдэг нь “сайн мэдээ” эсвэл “баярт мэдээ”

гэсэн утгатай. Хэрэв бид нүгэл үйлдвэл бид бүгдэд зориулсан баярт мэдээ сайн мэдээгээр дамжин ирнэ.

 **2.** 3 Нифай 27:13–16, 19-ийг уншаад бид бүгдэд баярт мэдээ болох сайн мэдээний бүрэлдэхүүн хэсгүүдийг олж тогтоо. **Есүс Христийн сайн мэдээний суурь нь Тэрээр Цагаатгалыг хийснээрээ Эцэгийнхээ хүслийг биелүүлсэн явдал юм.** Дараах асуултуудад судар судлах тэмдэглэлдээ хариулж бич:

а. Тэр энэ дэлхийд Эцэгийнхээ хүслийг гүйцэлдүүлэхээр ирсэн гэж Аврагч шавь нартаа гэрчилсэн билээ. 3 Нифай 27:14-т цэдэглэснээр Тэнгэрлэг Эцэг Ариун Хүүгээсээ юу хүссэн бэ?


б. Аврагч Эцэгийнхээ хүслийг гүйцэлдүүлсэн учраас хүн төрөлхтөнд юу боломжтой болсон бэ? (ялангуяа 3 Нифай 27:19-ийг үзнэ үү).

 **3.** Энэхүү сайн мэдээний агуу байдалд та илүү талархалтай болохын тулд дараах судрын хэсгүүдээс нэгийг эсвэл илүү олныг уншиж, яагаад Есүс Христийн Цагаатгал тийм сайн мэдээ болох тухай товч тайлбарыг судар судлах тэмдэглэлдээ бич: 2 Нифай 9:8–10; Алма 34:14–16; Хиламан 14:15–18.

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Жэффри Р.Холланд сайн мэдээ нь яагаад бүх хүмүүст сайн мэдээ байдаг тухай ийн гэрчилжээ: “Сайн мэдээ” нь үхэл ба тамаас зугтаж болно, алдаа дутагдал, гэм нүглүүдийг ялж болно, бидэнд найдвар байгаа, бидэнд тусламж байгаа, шийдэх боломжгүй асуудлууд нь шийдэгдсэн, дайснууд нь ялагдсан гэдгийг хэлж байгаа юм. Сайн мэдээ нь нэг л өдөр хүн бүрийн булш хоосорч, хүн бүрийн бодгаль дахин цэвэр болж, Бурханы хүүхэд бүр өөрт нь амьдралыг өгсөн Эцэгтээ эргэн очиж чадна гэсэн мэдээ байсан юм” (“Missionary Work and the Atonement,” *Ensign*, 2001 оны 3-р сар, 8, 10).



Та урьд нь хэн нэгэн хүн бид “сайн мэдээгээр амьдрах” хэрэгтэй гэж хэлэхийг сонсож байсан уу? Хэн нэгэн хүн биднийг “сайн мэдээгээр амьдрахыг” урьвал тэд ихэнхдээ бид аврагдахын тулд зарчмуудын дагуу амьдарч, Есүс Христийн Цагаатгалын хүчийг амьдралдаа урих ёслолуудыг хүлээн авахад урьж байгаа хэрэг юм. 3 Нифай 27:20–21-ийг судлаад бид Цагаатгалын бүх адислалуудыг хүлээн авч, шүүлтэд бэлтгэхийн тулд юу хийх ёстойг олж мэд.

 **4.** Хэрэв бид _____-вал бид **Есүс Христийн өмнө толбогүй зогсох боломжтой байх болно** гэж судар судлах тэмдэглэлдээ бич. Бид Их Эзэний өмнө толбогүй зогсохын тулд заавал дагах ёстой гэсэн 3 Нифай 27:20–21-р шүлгүүд дэх сайн мэдээний зарчмыг ашиглан энэ өгүүлбэрийг гүйцээж бич. (Энэ зарчмын “хэрэв” гэсэн хэсэгт та хэд хэдэн зарчмыг бичиж болно.) Тэгээд дараах асуултын хариулыг судар судлах тэмдэглэлдээ бич: Би Цагаатгалын хүчийг мэдэрч, эцсийн өдөр Бурханы өмнө толбогүй зогсохын тулд “сайн мэдээгээр” бүрэн амьдрахын төлөө одоо амьдралдаа юу хийж чадах вэ?

Та Түүний Цагаатгал болон сайн мэдээний зарчмууд, зарлигууд болон ёслолуудад дуулгавартай байснаар ариун болгогдсоноо мэдэж, Есүс Христийн өмнө нэгэн өдөр зогсох нь ямар байхыг тунгаан бод.

3 Нифай 27:23–23

Есүс Христ шавь нараа Өөртэйгөө адилхан болохыг зааварчлав

3 Нифай 27-р бүлгийн төгсгөлд цэдэглэгдсэнээр Есүс Христ арванхоёр шавьдаа заавар өгч, өөрсдийн хүмүүсийн удирдагчид ба шүүгчид байх үүргийнх нь тухай тэдэнд заажээ. 3 Нифай 27:27-г уншаад Тэрээр шавь нартаа үүргээ шударгаар гүйцэтгэхэд нь туслах ямар зарлигууд өгснийг олж мэд. Дараах асуултуудыг хэсэг зуур бод:

- Бусдыг шүүдэг хүмүүс Аврагч шиг байх нь яагаад чухал байх вэ?
- 3 Нифай 27:21-ийг эргэн хар, Аврагч шавь нартаа юу хийхийг зарлигласан бэ?
- Аврагчийн ажлыг хийх болон Түүнтэй адил болох нь хоорондоо ямар холбоотой вэ?

3 Нифай 27:21, 27-г дахин уншаад **Их Эзэн шавь нараа Өөрийнх нь ажлыг хийж, Өөртэй нь адил болоосой гэж хүсдэгийг** харуулсан үг хэллэгүүдийг судартаа тэмдэглэ.



5. Аврагчтай илүү адилхан болохын тулд Түүний заасан зүйлсийг хэрэгжүүлэхэд тань туслах дараах асуултуудад судар судлах тэмдэглэлдээ хариул:

- а.** Өчигдөр надад Аврагчтай адил байх ямар боломжууд байсан бэ?
- б.** Би өнөөдөр Аврагчтэй хэрхэн илүү адилхан байж чадах вэ?
- в.** Би Аврагчийн ямар ажлуудыг маргааш сургууль дээрээ эсвэл гэртээ хийж болох вэ?



Есүс Христтэй адил болохыг хичээдэг хүмүүс үнэхээр агуу амжилтад хүрдэг хэмээн Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон заажээ: “Тэр хүн бол амьдрал нь Христийн хэв шинжид хамгийн их ойртсон, хамгийн сайн, хамгийн ихээр адислагдсан, хамгийн баяр баясгалантай хүн юм. Дэлхийн эд баялаг, эрх мэдэл эсвэл нэр хүнд үүнд огт хамаагүй. Эзэн Есүс Христтэй адилхан байхад амьдрал нь хэр зэрэг ойртож болох вэ гэдэг нь агуу чанар, адислагдсан байдал, баяр баясгалангийн цорын ганц үнэн сорилт юм. Тэр бол зөв зам, бүрэн дүүрэн үнэн, элбэг дэлбэг амьдрал юм” (“Jesus Christ—Gifts and Expectations,” *Ensign*, 1988 оны 12-р сар, 2).



6. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би 3 Нифай 27-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

27-Р ХЭСЭГ: 4 ДЭХ ӨДӨР

3 Нифай 28–30

Оршил

Есүс Христ тэнгэрт буцахаасаа өмнө арванхоёр шавиасаа тэд Өөрөөс нь юу хүсч байгааг асуухад тэдний ес нь дэлхий дээрх үйлчлэлээ дуусмагц Түүн дээр даруй эргэн очихыг хүсчээ. Гурав нь Түүнийг иртэл хүмүүсийг Христэд авчрах ажлаа үргэлжлүүлэхийн тулд дэлхий дээр үлдэхийг хүссэн аж. Их Эзэн энэхүү зөв шударга хоёр хүсэлд хоёуланд нь хүндэтгэлтэй хандсан юм. Мормон гурван нифай шавийн дэлхий дээрх үйлчлэлийн талаар зарим тодорхой мэдээллийг өгсөн билээ.

Мормон Аврагч нифайчуудын дунд зочилсон талаарх шастирынхаа төгсгөлд Мормоны Ном ирэх нь Их Эзэн Израилын угсаатай хийсэн гэрээгээ биелүүлж буйн тэмдэг байх болно гэдгийг тайлбарлажээ. Мормон 3 Нифайн төгсгөлд, бүх хүмүүсийг наманчилж, Израилын угсаанд тоологдоход урьж, Есүс Христийн үгсийг цэдэглэсэн юм.

3 Нифай 28:1–11

Есүс Христ арванхоёр шавийнхаа хүслийг биелүүлсэн нь

Хэрэв Есүс Христ чам дээр хүрч ирээд “чи надаас юу хүсэх вэ?” гэж асуувал юу гэж хариулахаа тунгаан бод.

Зөв шударга олон хүслээсээ алийг нь Түүнтэй хуваалцахаа товчхон бич. _____

3 Нифай 28:1–3-ыг уншаад Их Эзэн “Чи надаас юу хүсэх вэ?” гэж асуухад Нифай үндэстэн есөн шавь нь хэрхэн хариулсныг олж мэд. Аврагч тэдний хүслийн тухай ямар сэтгэгдэлтэй байсныг анзаараарай.

3 Нифай 28:4–7-г уншаад үлдсэн гурван шавь нь Аврагчаас юу хүссэнийг олж мэд. Аврагч эдгээр гурван шавийнхаа хүслийн тухайд ямар сэтгэгдэлтэй байсныг анзаар. Яагаад Их Эзэн тэднийг хүслийнхээ учир “илүү адислагдсан” гэж хэлснийг тунгаан бод.

3 Нифай 28:8–10-т мөнх бус хүмүүний дунд хөдөлмөрлөх хүслийнхээ улмаас гурван нифай шавийн хүлээн авах адислалуудыг Их Эзэн хэрхэн дүрсэлснийг унш. Дараах үгснийг судрынхаа захад эсвэл судар судлах тэмдэглэлдээ бич: **Их Эзэн биднийг зөв шударга хүслүүдийн маань дагуу**

адисалдаг. Зөв шударга хүслийн ач холбогдлын талаарх Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Нийл А.Максвеллийн дараах үгсийг унш:



“Бидний байнгын хүсдэг зүйлс нь бид эцэстээ ямар хүмүүс болох мөн бид мөнх амьдралд юу хүлээн авах вэ гэдгийг тодорхойлдог. . . .

“Зөв шударга хүсэл эргэлт буцалтгүй тууштай байх хэрэгтэй. Тиймээс Ерөнхийлөгч Бригам Янг “селестиел хаант улсад суудалтай болохыг хүсдэг эрэгтэй, эмэгтэйчүүд өдөр бүр тэмцэх ёстойгоо мэдэх болно” хэмээн хэлжээ (*Journal of Discourses*, 11:14) (“According to the Desire of [Our] Hearts,” *Ensign*, 1996 оны 11-р сар, 21–22).



1. Дараах асуултуудын аль нэгэнд эсвэл хоёуланд нь судар судлах тэмдэглэлдээ хариул:

а. Та зөв шударга хүслээ гүйцэлдүүлэхээр хичээхдээ Их Эзэнээр адислагдсанаа хэзээ мэдэрсэн бэ?

б. Та амьдралдаа Их Эзэний адислалуудыг хүлээн авахад өөрийгөө тэнцэхээр байлгахын төлөө зөв шударга хүслээ дэмжин хөгжүүлэхийн тулд өнөөдрөөс эхлэн юу хийх вэ?

3 Нифай 28:12–35

Мормон гурван нифай шавийн үйлчлэлийг дүрсэлсэн нь

Олон хүн гурван нифай шавийн айлчлал байж болох түүх, домог, ам дамжсан яриануудыг сонссон байдаг. Үлгэр домогт найдахынхаа оронд тэдний үүрэг зорилго юу болох, тэд хэрхэн “Бурханы тэнгэр элчүүдийн нэгэн адил” хүчтэйгээр үйлчлэлээ хийж байгааг судраас олж мэд (3 Нифай 28:30).

3 Нифай 28:12–17-г уншаад гурван нифай шавьд юу тохиолдсоныг олж мэд. 3 Нифай 28:15-д цэдэглэгдсэнээр шавь нар ийнхүү хувирах хэрэгтэй байсны нэг шалтгаан нь юу вэ? _____

3 Нифай 28:18–23-ыг уншиж, гурван нифай шавь зөв шударга хүслээ биелүүлэх боломжтой байхын тулд Их Эзэн тэднийг хэрхэн адисалсныг олж мэд. Бид зөв шударга хүслийнхээ дагуу амьдарвал Их Эзэн биднийг адислах хүсэлтэй байдаг талаар эдгээр шүлгүүд юу заадыг бод.

3 Нифай 28:25–31-ийг судлаад гурван нифай шавийн үйлчлэлээс хэн ашиг тус хүртсэн болон хэн ирээдүйд хүртэх вэ гэдгийг олж мэд. Олсон зүйлээ тэмдэглэ.

3 Нифай 28:36–40

Мормон хувиргагдсан хүмүүсийн мөн чанарыг мэдэж авсан нь

Сайн мэдээний тухай асуулт, сорилт тулгарсан үеийнхээ тухай бод. 3 Нифай 28:36-г уншиж, Мормон гурван нифай шавийг хувирсны дараа тэдний бие махбодод гарах өөрчлөлтийн талаар юуг ойлгохгүй байсныг олж мэд. Дараах асуултын хариултыг тунгаан бод: Танд сайн мэдээний тухай асуулт байвал ихэвчлэн хэнд ханддаг вэ? 3 Нифай 28:36–37-г уншаад Мормон асуултынхаа хариултыг олохын тулд юу хийснийг олж мэд.

3 Нифай 28:37–40-ийг судлаад Мормон гурван нифай шавийн биед гарсан өөрчлөлтийн талаар юу олж мэдсэнийг хар. Гурван нифай шавийн биед гарсан өөрчлөлт эсвэл нөхцөл байдлыг “хувиралт” (3 Нифай 28:17-г үзнэ үү) гэж нэрлэдэг бөгөөд энэ нь бусад хувиралттай төстэй ч хугацааны хувьд илүү урт юм. Хувирсан хүмүүс нь мөнх бус боловч бошиглогч Иосеф Смитийн зааснаар тэдний бие махбод телестиел нөхцөлөөс террестриел нөхцөлд өөрчлөгдөж, мөнх бус бие махбодынхоо зовлон зүдгүүрээс ангижирсан байдаг (*History of the Church*, 4:210-ыг үзнэ үү). Хувирсан хүмүүс нь өөрсдийнхөө сонголтоор мөн Бурханы хүслийн дагуу үзэгдэж бас үзэгдэхгүй байж чадна (3 Нифай 28:27–30-ийг үзнэ үү). Тэд хүмүүсийг авралд авчрахад тусалж, Есүс Христийн Хоёр дахь ирэлт хүртэл хувирсан байдалдаа орших бөгөөд амилуулагдаж, алдар суут хүмүүс болохдоо бас дахин өөрчлөлтөд орох болно (3 Нифай 28:7–8, 39–40-ийг үзнэ үү).

Хэрэв бид Их Эзэнээс ойлголтыг хүсвэл илчлэлт хүлээн авах болно гэдгийг бид Мормоны туршлагаас сурдаг. Та энэ зарчмыг судартаа эсвэл судар судлах тэмдэглэлдээ бичих хэрэгтэй.



2. Та өөрөө эсвэл таны таньдаг хэн нэгэн чин сэтгэлийн залбирлаар дамжуулан Их Эзэнээс хариултыг эрэлхийлсэн туршлагыг судар судлах тэмдэглэлдээ бич.

3 Нифай 29

Их Эзэн Израилын угсаатай хийсэн гэрээгээ эцсийн өдрүүдэд гүйцэлдүүлнэ гэдгийг Мормон гэрчлэв

Мормон Мормоны Номын хүмүүсийн дундах Аврагчийн айлчлалын түүхийг бичсэнийхээ дараа эцсийн өдрүүд дэх Их Эзэний амлалтуудын биелэлтийг бошигложээ. Дараах асуултад хэрхэн хариулснаа тунгаан бод: Та хэзээ Бурханы аль нэг амлалтуудын биелэлтийн талаар мэдэж авсан эсвэл харсан бэ?

Хэзээ ба тэгээд гэсэн үгсийг 3 Нифай 29:1–3-ыг судлах явцдаа тэмдэглэ. Эдгээр үгс Их Эзэн Израилын

угсаатай хийсэн гэрээгээ эцсийн өдрүүдэд сахиж байгааг харуулсан нэг үйл явдлыг олж тогтооход тань туслах болно. (3 Нифай 29:1 дэх “эдгээр үгс” нь Мормоны Номын бичээсүүдийг хэлж байгаа юм.)


Бид 3 Нифай 29:1–3-р шүлгүүдээс **Мормоны Ном ирсэн нь Их Эзэн Израилыг цуглуулах гэрээгээ биелүүлж байгаагийн тэмдэг юм** гэдгийг олж мэддэг.



Мормоны Ном бидэнд Их Эзэн Өөрийн хүмүүсийг Өөрийн ирэлтэд бэлтгэж байгааг нотолдог (3 Нифай 29:2-ыг үзнэ үү). Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Рассэлл М.Нэлсоны хэлсэн дараах үгсийг уншаад Мормоны Ном Аврагчийн ирэлтэд биднийг бэлтгэхэд хэрхэн тусалж байгааг тэмдэглэ:

“Мормоны Ном нь Их Эзэн Өөрийн гэрээт Израилын хүүхдүүдийг цуглуулж эхэлснийг гэрчлэх бодитой тэмдэг юм. . . .

“Тийм ээ, Их Эзэн мартаагүй! Тэр биднийг болон дэлхий даяарх бусад хүмүүсийг Мормоны Номоор адисалсан юм. . . . Уг ном Бурхантай гэрээ хийхэд бидэнд тусалдаг бөгөөд Түүнийг болон Түүний Хайрт Хүүг санахад биднийг уриалдаг юм. Мормоны Ном бол Есүс Христийн бас нэгэн гэрээ мөн” (“Гэрээнүүд,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2011 оны 11-р сар, 88).

 **3.** 3 Нифай 29:4–6-г уншаад дараах үйл ажиллагаануудаас нэгийг эсвэл хоёуланг нь судар судлах тэмдэглэлдээ бич:


а. Есүс Христэд ирэхэд нь хэн нэгэнд тусална гэж бодож байгаа гурван шүлгийг Мормоны Номоос олж бич. Шүлэг бүрд та яагаад уг шүлгийг сонгосноо тайлбарласан нэг эсвэл хоёр өгүүлбэр бич.

б. Илчлэлтийн бэлгүүд, бошиглол, хэлний бэлэг эсвэл Ариун Сүнсний хүчийг ойлгож, хүлээн авахад Мормоны Ном хүнд хэрхэн тусалж болох тухай өөрийн бодлыг нэг догол мөрөнд багтаан бич.

3 Нифай 30

Их Эзэн харийнханыг наманчилж, Түүнд ирэхийг урин дуудсан нь

Мормон харийнханы талаар Есүс Христээс хүлээн авсан зарим тодорхой заавруудыг бичсэнээр Аврагчийн үйлчлэлийн тухай цэдгээ төгсгөжээ. 3 Нифай 30:1–2-ыг уншаад Аврагчаас харийнханд өгсөн заавруудаас аль болох олныг олж тэмдэглэ. Харийнхан Христэд ирснээр тэдний хүлээн авах адислалуудыг бас тэмдэглэ. Хэдийгээр 3 Нифай 30:2 нь сүмийн гишүүн бус хүмүүст зориулагдсан ч бид Есүс Христийн урилгыг Түүний гэрээний дагуу амьдрах хэр зэрэг хүсэлтэй байгаадаа үнэлэлт өгөхөд ашиглаж болно.

 **4.** Дараах зарчмыг судар судлах тэмдэглэлдээ бич: **Хэрэв бид Христэд ирэх аваас Түүний хүмүүсийн дунд тоологдох болно.** “Израилын угсааных болох [Түүний] хүмүүстэй хамт тоологдох” (3 Нифай 30:2) нь яагаад Их Эзэний адислал болохыг судар судлах тэмдэглэлдээ бич.

 **5.** Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би 3 Нифай 28–30-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

4 НИФАЙН ОРШИЛ

Яагаад энэ номыг судлах хэрэгтэй вэ?

Та 4 Нифайг судлахдаа Есүс Христийн сайн мэдээний дагуу нэгдмэл амьдарч байгаа хүмүүст ирдэг адислалуудыг харах болно. Энэхүү ном нь тэдний дунд хийсэн Аврагчийн үйлчлэлийн үеэр уг нутаг даяарх бүх хүн хөрвөгдсөн гэдгийг илчилдэг. Зарлигуудад дуулгавартай байснаар тэд амар амгалан байдал, хөгжил дэвшил, гайхамшигтай сүнслэг адислалуудад баясаж байв. Мормон ийн тунхаглав: “Бурханы мутраар бүтээгдсэн бүх хүмүүсийн дунд үүнээс илүү аз жаргалтай хүмүүс байх аргагүй нь гарцаагүй юм” (4 Нифай 1:16). Мөн та энэ хүмүүсийн бузар, ёс бусын байдал руу алгуурхан унах уналтаас чухал сургамж авах болно.

Энэ номыг хэн бичсэн бэ?

Мормон 4 Нифайн номыг гаргахдаа дөрвөн өөр зохиогчийн цэдгүүдийг нийлүүлэн хураангуйлсан. Эхнийх нь Нифай байсан бөгөөд энэхүү ном нь түүний нэрээр нэрлэгдсэн юм. Нифай бол Их Эзэний Лихайн үр удмын дунд хийсэн үйлчлэлийнхээ үеэр сонгосон 12 шавийн нэг Нифайн хүү билээ (3 Нифай 11:18–22; 12:1-ийг үзнэ үү). Нөгөө гурван зохиогч нь Нифайн хүү Амос, Амосын хүү Амос, Амосын дүү Аммарон нар байв (4 Нифай 1:19, 21, 47-г үзнэ үү).

Энэ ном хаана, хэзээ бичигдсэн бэ?

4 Нифайн эх сурвалж болох анхны цэдгүүд нь МЭ34—МЭ321 оны хооронд бичигдсэн байх магадлалтай. Мормон тэдгээр цэдгүүдийг МЭ345—МЭ385 оны хооронд хураангуйлан бичжээ. Мормон энэ номыг хаана эмхэтгэсэнээ бичээгүй.

28-Р ХЭСЭГ: 1 ДЭХ ӨДӨР

4 Нифай 1

Оршил

Есүс Христийн Америк дахь айлчлал болон үйлчлэлийн дараа хүмүүс Түүний заасан зүйлсийг хэрэгжүүлж, 200 жил нэгдмэл байдал, хөгжил дэвшил, аз жаргалд баясав. Гэвч эцэстээ хүмүүс бардамнаж, улам бүр ёсон бус болж эхлэв. Удалгүй тэд дахин нифайчууд ба леменчүүд болон хуваагдаж, 300 жилийн

дараа нифайчууд, леменчүүд хоёулаа ёс бус болсон бөгөөд маш цөөн хүн зөв шударга хэвээр үлдэв.

4 Нифай 1:1–18

Хүмүүс бүгд хөрвөгдөж, амар амгалан болон аз жаргалыг эдлэв


Таныг үнэхээр аз жаргалтай байхад юу тусалдаг вэ?

Таны бодлоор түр зуурын аз жаргалыг авчирдаг болон мөнхийн аз жаргал руу хөтөлдөг зүйлсийн хоорондын ялгаа юу вэ? Аврагчийн айлчлалын дараах хүмүүсийн тухай Мормон юу бичсэнийг олохын тулд 4 Нифай 1:16-г унш. Та “илүү аз жаргалтай хүмүүс байх аргагүй нь гарцаагүй юм” хэмээх хэллэгийг тэмдэглэх хэрэгтэй.



1. Судар судлах тэмдэглэлдээ *Илүү аз жаргалтай хүмүүс байх аргагүй нь гарцаагүй* гэсэн гарчиг тавиад доод талд нь дор үзүүлснээр тойрог зур. (Та нар тойргийн дотор болон гадна нь юм бичнэ.) 4 Нифай 1:1–2-ыг уншаад хүмүүс тэднийг аз жаргалтай болгох юу хийснийг ол. Олсон зүйлсээ тойрог дотор жагсаан бич.

Илүү аз жаргалтай хүмүүс байх аргагүй нь гарцаагүй



Хүмүүс Аврагчийн заасан зүйлсийг хэрэгжүүлсэн учраас “бүгдээр Их Эзэнд хөрвөгдөж” (4 Нифай 1:2), үлэмж аз жаргалд баясав.

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Ричард Г. Скотт хөрвөлт болон аз жаргал хоорондоо хэрхэн холбогддог тухай тайлбарлажээ. Түүний үгсийг уншихдаа хөрвөгдөх гэдгийг тайлбарласан утгын доогуур зур:



“Та нарын одоогийн болон мөнхийн аз жаргал нь та нарын хөрвөлт ба амьдралд авчрах өөрчлөлтүүдийн нөхцөл байдлаас шалтгаална. Дараа нь та нар хэрхэн жинхэнээр хөрвөгдөх вэ? Ерөнхийлөгч [Марион Ж.] Ромни та нарын дагах ёстой алхмуудыг ийн тодорхойлсон:


“Сүм дэх гишүүнчлэл ба хөрвөлт нь ижил төстэй зүйлс биш юм. Хөрвөгдсөн байх ба гэрчлэлтэй байх нь бас л ижил зүйлс биш байдаг. Ариун Сүнс чин сэтгэлээсээ эрэлхийлэгч нэгэнд үнэний гэрчийг



өгөх үед гэрчлэл ирдэг. Жинхэнэ гэрчлэл итгэлийг сэргээдэг. Энэ нь наманчлал ба зарлигуудад дуулгавартай байх байдлыг бий болгодог. Хөрвөлт нь наманчлал ба дуулгавартай байдлын үр жимс эсвэл шагнал юм' [In Conference Report, Guatemala Area Conference 1977, 8–9].

“Энгийнээр хэлэхэд жинхэнэ хөрвөлт нь *итгэл, наманчлал ба байнгын дуулгавартай байдлын* үр жимс мөн. . .

“Жинхэнэ хөрвөлт бүр дэлхий үймээн самуунтай, ихэнх нь огт аз жаргалгүй байсан ч баяр баясгалантай байж чадах туйлбартай аз жаргалын үр жимсийг бий болгодог” (“Full Conversion Brings Happiness,” *Ensign*, 2002 оны 5-р сар, 25–26).

 **2.** 4 Нифай 1:2–3, 5, 7, 10–13, 15–18-ыг уншаад хүн бүр Их Эзэнд хөрвөгдсөнөөс хүмүүст юу тохиолдсоныг тайлбарласан үг хэллэгүүдийг ол. Өмнөх даалгавраар судар судлах тэмдэглэлдээ зурсан тойргийн гадна талд тойруулаад эдгээр үг хэллэгүүдийг бич.

Нифайчуудын дундах урьд өмнө үзэгдээгүй аз жаргал, хөгжил дэвшлээс бид **бүлэг хүмүүс Их Эзэнд хөрвөгдөхөд энэ нь тэдэнд нэгдмэл байдал ба аз жаргалыг авчирдаг гэдгийг сурч болно.** Та

нар энэ зарчмыг судартаа 4 Нифай 1:16-гийн хажууд эсвэл судар судлах тэмдэглэлдээ бичиж болно.

Хэрэв та нарын эргэн тойрон дахь хүн бүр Их Эзэнд хөрвөгдсөн байсан бол ямар байх байсныг тунгаан бод.

 **3.** Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:


а. Хэрэв гэр бүлийн тань гишүүн бүр 4 Нифайд гардаг хүмүүс шиг амьдардаг байсан бол танай гэр бүлд ямар ашиг тус ирэх байсан гэж та бодож байна вэ?

б. Амьдралдаа гэр бүл, чуулга, анги, найз нөхөд зэрэг зөв шударгад нэгдсэн—бүлгийн нэг хэсэг байснаар адислагдаж байсан үеэ бод. Зөв шударгад нэгдмэл байхад нь энэ бүлэг хүмүүст юу тусалсан гэж та бодож байна вэ? Та болон тантай хамт байсан хүмүүс ямар адислал хүлээж авсан бэ?

4 Нифай 1:19–49

Зөв шударга хэдхэн хүн үлдтэл ёс бус байдал эргэн ирж бас тархав

4 Нифайд тодорхойлсон хүмүүс шиг аз жаргалтай нийгмийг юу устгадаг гэж та бодож байна вэ?

 **4.** Судар судлах тэмдэглэлдээ “Аз жаргалтай нийгмийн устгал” гэж гарчиг тавиад доор нь эхний

даалгаврынхтай адил тойрог зур. 4 Нифай 1:20, 23–24-ийг уншаад хүмүүсийн аз жаргал, амар амгалан байдлыг юу устгаж эхэлснийг ол. Олсон зүйлсээ тойргийн дотор талд бич.

Та нар Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх Ерөнхийлөгч Хэнри Б.Айрингийн хэлсэн дараах үгсийг судартаа 4 Нифай 1:24-ийн хажууд эсвэл судар судлах тэмдэглэлдээ бичиж болно: “Бардамнал бол нэгдмэл байдлын агуу том дайсан юм” (“Our Hearts Knit as One,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2008 оны 11-р сар, 80). Ямар арга замуудаар бардамнал нэгдмэл байдлын дайсан болдог гэж та бодож байна вэ?

Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорфын хэлсэн дараах үгс бардамналын тухай ойлголтыг өгдөг. Бардамнал нь яагаад тийм их хор хөнөөлтэй болохыг тайлбарласан хэллэгүүдийн доогуур зур.



“Бардамнал нь нүгэл юм . . . учир нь бардамнал үзэн ядалт, дайсагналыг өдөөж, биднийг Бурхан болон бусдын эсрэг хандуулдаг. Бардамнал нь харьцуулах нүглээс үүдэлтэй байдаг юм.

Учир нь ‘би хэчнээн агуу мөн хэчнээн агуу зүйлс хийснийг хараач’ гэж эхэлсэн ч ихэнхдээ энэ нь’ тиймээс би чамаас дээр’ гэсэн үгсээр төгсдөг билээ.

“Бидний зүрх сэтгэл бардамналаар дүүрэх нь ноцтой гэм нүгэл юм. Ингэснээр бид хамгийн агуу хоёр тушаалыг зөрчдөг [Матай 22:36–40-ийг үзнэ үү]. Бурханаа шүтэж, хөршөө хайрлахын оронд бид толинд хардаг өөрсдийн төрхийг жинхэнэ шүтээн болгож мөн хайрлаж эхэлсэн байдаг” (“Pride and the Priesthood,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2010 оны 11-р сар, 61).



5. 4 Нифай 1:25–27, 30–35, 38–45-ыг уншаад хүмүүсийн дундах бардамналын үр дагаврыг тодорхойлсон

үг хэллэгүүдийг ол. Судар судлах тэмдэглэл дээрх 4-р даалгаврын тойргийн гадна талд эдгээр үг хэллэгүүдийг бич.

Эдгээр үйл явдлуудаас бид **бардамналын нүгэл зөрчилдөөнийг бий болгож, илүү агуу ёсон бус руу хөтөлдөг гэдэг үнэнийг сурч болох юм.** Та энэ хэллэгийг судартаа бичих хэрэгтэй. Нэг юмуу хоёр хүний бардамнал бүхэл бүтэн бүлгийн аз жаргалд хэрхэн нөлөөлж болох вэ?

Дараах нөхцөлүүдэд хувь хүний бардамнал хэнд сөргөөр нөлөөлж болох талаар эргэцүүлэн бод:

- Залуу эмэгтэйчүүдийн ангийн нэг гишүүн мэргэн ухааны үгэнд дуулгавартай байхаас ирдэг адислалуудын тухай багшийнхаа бэлдсэн хичээлийг сонсохыг хүсэхгүй байна. Тэр мэргэн ухааны үгийн талаар лекц дахин сонсох хэрэггүй гэж бодож байгаа бөгөөд хичээлд оролцохоос татгалзаж, үймүүлж эхлэв.
- Бүлгийн нэг гишүүний хувцасласан байдал нь түүнийг амьдралын боломжгүй гэдгийг харуулж байгаагаас болж найз нь үргэлж шоолж, басамжилдаг.



6. Таны амьдралд бардамналын үндэс суурь байгаа эсэхийг тунгаан бод. Тунгаан бодохдоо Ерөнхийлөгч Угдорфын хэлсэн үгсийг дахин харах нь тустай байж болох юм. Бардамналыг эсэргүүцэж, гэр бүл, чуулга, анги, найз нөхдийнхөө дунд зөв шударга, нэгдмэл байдлыг нэмэгдүүлэхийн тулд та юу хийж чадахаа бод. Өөрийн бодол болон зорилгыг судар судлах тэмдэглэлдээ бич.



7. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би 4 Нифай 1-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

Мормоны

ОРШИЛ

Яагаад энэ номыг судлах хэрэгтэй вэ?

Та Мормоны номыг судалснаар амьдралынхаа турш “ёс бус хийгээд жигшүүрт хэргүүдийн үргэлжийн дүр зургаар” хүрээлүүлж байсан ч Есүс Христийн дагалдагчийн хувьд итгэлтэйгээр амьдарсан Мормоноос үнэ цэнэтэй сургамж авах болно (Мормон 2:18). Түүнчлэн та хожмын үеийн уншигчдад хандан “Есүс Христ та нарыг надад үзүүлсэн, мөн би та нарын үйлийг мэднэ” хэмээн гэрчилсэн Мормоны хүү Моронайн үгсийг судалснаар ашиг тус хүртэх болно (Мормон 8:35). Эдгээр зүйлсийг судалснаар Есүс Христийн сайн мэдээний гэрээнүүд болон зарлигуудын дагуу амьдрахыг сонгохын ач холбогдлын талаар сурах болно.

Энэ номыг хэн бичсэн бэ?

Мормон эхний долоон бүлгийг түүний өдрүүд дэх нифайчууд болон леменчүүдийн дундах дайнууд, ёсон бусын талаарх хураангуй цэдэг болгон бичсэн. Тэрээр мөн амьдарч байсан үеийнхээ үйл явдлуудын “бүрэн шастирыг” Нифайн Их ялтсууд дээр бичжээ. (Мормон 2:18; 5:9-ийг үзнэ үү). Мормоныг “арав орчим настай” байх үед нь цэдэг хөтлөгч Аммарон түүнд яваандаа “энэ хүмүүсийн талаар өөрийн ажигласан бүх зүйлүүдийг сийлбэрлэх болно” гэжээ (Мормон 1:2, 4). Тэр хорин дөрөв орчим настай байхдаа Нифайн ялтсуудыг хариуцах эрхтэй болсон бөгөөд “Аммароны үгсийн дагуу цэдгийг үйлдэв” (Мормон 2:17). Хожим нь Мормон Лихайгаас Аммароныг хүртэлх цэдэг хөтлөгч болон бошиглогчдын бичиглэсэн зүйлсийг агуулсан Нифайн Их ялтсуудыг хураангуйлж эхэлжээ. Мормон амьдралынхаа төгсгөл үед өөрийн хүү “Моронайд өгсөн цөөн хэдэн ялтсуудаас бусад, Их Эзэний мутраар [түүнд] итгэмжлэгдсэн бүх цэдгүүдийг Кумора гүвээнд нуув” (Мормон 6:6). Дараа нь тэрээр леменчүүдийн эсрэг сүүлчийн агуу тулаанд нифайчуудыг удирджээ. Мормон нас барахаасаа өмнө цэдгүүдийг нь дуусгахыг Моронайд зааварлаж, Моронай энэ номын 8–9-р бүлгүүдийг нэмэв.

Энэ ном хаана, хэзээ бичигдсэн бэ?

Мормон 1–7-р бүлгүүдийг Мормон мэ 345–мэ 401 оны хооронд бичсэн байх магадлалтай (Мормон 2:15–17; 8:5–6-г үзнэ үү). Тэрээр өөрийн бичиглэлийг Кумора дахь нифайчууд, леменчүүдийн хооронд болсон сүүлчийн агуу тулааны дараа дуусгажээ (Мормон 6:10–11-ийг үзнэ үү). Моронай амь

насныхаа аюулгүй байдлын төлөө бэдрэн явахдаа Мормон 8–9-р бүлгийг мэ 401-ээс мэ 421 оны хооронд бичсэн байх магадлалтай (Мормон 8:4–6; Моронай 1:1–3-ыг үзнэ үү).

28-Р ХЭСЭГ: 2 ДАХЬ ӨДӨР

Мормон 1–2

Оршил

Хэдийгээр Мормон агуу ёсон бусын цагт өссөн ч итгэлтэй байхыг сонгосон. Итгэлтэй байдлынхаа улмаас тэрээр нифайчуудын цэдгүүдийг хамгаалахаар дуудагджээ. Мормон 15 настай байхдаа “Их Эзэнээр зочлогдон, мөн Есүсийн сайн сайхныг амталж мөн мэдэв” (Мормон 1:15). Тэр жил нь нифайчууд түүнийг их цэргийн удирдагчаараа томилсон байна (Мормон 2:1-ийг үзнэ үү). Тэрээр нифайчуудад наманчлахад нь туслахыг хүссэн боловч Их Эзэн тэдний санаатай эсэргүүцлийн улмаас тэдэнд номлохыг хоригложээ. Нифайчууд Ариун Сүсний бэлэг болон Бурханы бусад бэлгүүдийг алдсан бөгөөд леменчүүдтэй тулалдахдаа өөрсдийн хүчинд орхигдсон байлаа.

Мормон 1:1–5

Мормонд ариун цэдгүүдийг авч явах үүрэг хариуцлага өгөгдсөн нь

Бусад хүмүүс таныг тодорхойлохдоо ямар үгсийг ашиглаасай гэж та хүсэж байна вэ? _____


Таныг урьд нь Мормон гэж тодорхойлж байсан уу? Хэн нэгэн таныг Мормон гэж тодорхойлох нь таны хувьд ямар утга учиртай вэ?

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли зарим хүмүүсийн Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүдийг тодорхойлохдоо хэрэглэдэг *Мормон* хэмээх хочийн талаар ярьсан юм:



“Заримдаа хүмүүс энэ сүмийг зохих нэрээр нь нэрлэхгүй байгаад би харамсдаг боловч тэдний хэрэглэдэг хоч нь гайхалтай эрийн нэр мөн дэлхийн Гэтэлгэгчийн талаар хосгүй гэрчлэлийг өгдөг номын нэр байдаг нь агуу хүндэтгэлийн нэг хэмээн баяртай байдаг.

“Түүний үгсийг уншиж, тунгаан бодсоноор Мормон хэмээх эрийг хэн гэдгийг мэдэж авах хүн бүр



түүний их хэмжээгээр цуглуулж, хамгаалсан түүхийн үнэт цуглуулгыг уншсан хэн боловч *Мормон* гэдэг нь муу нэр биш, харин энэ нь хамгийн агуу сайн буюу Бурханы сайн зүйлийг төлөөлж байгааг ойлгон мэдэх болно” (*“Mormon Should Mean ‘More Good,’” Ensign, 1990 оны 11-р сар, 52–53*).

Бошиглогч Мормон уг нутагт бараг бүх хүн ёсон бус байдалд амьдарч байсан үед төрсөн. Тэр үед Аммарон хэмээх бошиглогч ариун цэдгүүдийг бүгдийг нь нуухаар зарлигдуулжээ (4 Нифай 1:47–49-ийг үзнэ үү). Аммарон 10 настай хүү Мормонтой уулзаж, цэдгүүдийг хариуцах түүний ирээдүйн үүргийн талаар заавар өгөв. Мормон 1:2-ыг уншаад залуу хүү Мормоныг тодорхойлсон Аммароны үгсийг ол.

Мормоныг тодорхойлохдоо Аммароны ашигласан нэг үг бол *хэрсүү* гэдэг үг. *Хэрсүү* гэдэг үг нь буурь суурьтай, чин үнэнч, зөв шударга эсвэл бурханлаг гэсэн утгатай. Та судрынхаа хажуу талд энэ тодорхойлолтыг бичиж тэмдэглэх хэрэгтэй. Амьдралын ямар тохиолдолд эсвэл ямар зүйл дээр та хэрсүү байх хэрэгтэй гэж бодож байна вэ? Хэрсүү хүмүүс хөгжилдөж, инээлдэж болох ч тэд ямар үед хөгжилтэй байж, ямар үед буурь суурьтай байх хэрэгтэйг мэддэг гэдгийг ойлгох нь чухал.

Түүнчлэн Аммарон Мормоныг “ажиглан ойлгохдоо түргэн” (Мормон 1:2) гэж тодорхойлсон. “Ажиглан ойлгохдоо түргэн” байх гэдэг нь ямар утгатай

гэж та бодож байна вэ? Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Дэвид А.Бэднар *ажиглан ойлгох* гэдэг үгийг сударт хоёр янзаар ашигладаг гэдгийг тайлбарлажээ:

“Энгийн мэт санагдах, дутуу үнэлэгдсэн байж болох сүнсний бэлэг буюу ‘ажиглан ойлгохдоо түргэн’ (Мормон 1:2) байх чадвар нь бидний амьдарч байгаа, цаашдаа амьдрах энэ дэлхий дээр танд болон надад амин чухал ач холбогдолтой юм. . . .

“Энэхүү чухал сүнслэг бэлгийн ач холбогдлын талаар эргэцүүлэн бодоорой. Сударт *ажиглан ойлгох* гэдэг үгийг хоёр янзаар ашигладаг. Эхнийх нь ‘харах’, ‘үзэх’ эсвэл ‘анзаарах’—гэж Исаиа 42:20-оос бид сурдаг. . . .

“*Ажиглан ойлгох* гэдэг үгийн хоёр дахь хэрэглээ нь [Сургаал ба Гэрээ 54:6]-д тодорхойлсноор ‘дуулгавартай дагах’, ‘сахих’— гэсэн утгатай. . . .

“Тиймээс бид ажиглан ойлгоход түргэн байх үедээ түргэн харж, анзаарч мөн дуулгавартай дагадаг.—Харах болон дуулгавартай дагах—гэсэн үндсэн зарчмууд нь хоёулаа ажиглан ойлгохдоо түргэн байхад чухал юм. Бошиглогч Мормон үйлдлээрээ энэхүү бэлгийн гайхалтай жишээ болдог билээ” (“Quick to Observe,” *Ensign, 2006 оны 12-р сар, 31–32*).



1. Ажиглан ойлгохдоо түргэн байх зан чанар нь таны өдөр тутмын амьдралд хэрхэн тусалж болох тухай өөрийн бодлыг судар судлах тэмдэглэлдээ бич.

Мормон 1:3–5-ыг уншаад Мормонд өгсөн Аммароны зааврыг тодорхойл. Мормоны хэрсүү бөгөөд ажиглан ойлгохдоо түргэн зан чанар нь энэхүү үүрэг хариуцлагад нь хэрхэн тусалж болох вэ?

Мормон 1:6–19

Хүмүүсийн санаатай эсэргүүцлийн улмаас тэдэнд номлох нь Мормонд Их Эзэнээр хориглогдов

Та маш их үнэ цэнэтэй зүйлээ алдаж байсан уу? Мормон өсвөр насандаа нифайчууд, леменчүүдийн дунд болсон олон тулаан болон уг нутаг даяар тархсан агуу их ёсон бусыг үзэв (Мормон 1:6–13-ыг үзнэ үү). Нифайчуудын ёсон бус нь үлэмж их болсны улмаас тэд Их Эзэнээс ирэх олон үнэ цэнэтэй бэлгээ алдсан хэмээн Мормон цэдэглэв.



2. Судар судлах тэмдэглэлдээ хоёр багана гарга. Эхний багананд “Нифайчуудын алдсан бэлгүүд” гэсэн гарчиг тавь. Мормон 1:13–14, 18-ыг уншаад Их Эзэн ямар бэлгүүдийг нифайчуудаас авсан гэдгийг ол. Олсон зүйлсээ эхний багананд бич. Хоёр дахь баганыг “Их Эзэн яагаад тэдний бэлгүүдийг авсан бэ?” хэмээн гарчигла. Мормон 1:14, 16–17, 19-ийг уншаад Их Эзэн Өөрийн бэлгүүдийг

нифайчуудаас эргүүлэн авсан шалтгааныг ол. Олсон зүйлсээ хоёр дахь багананд бич.

Эдгээр шүлгүүдээс бид **ёсон бус болон итгэлгүй байдал нь Их Эзэний бэлгүүд, Ариун Сүнсний нөлөөг биднээс холдуулдаг гэдгийг сурч болно.** Нифайчуудын эсэргүүцэл туйлдаа хүрсэн байсан хэдий ч Их Эзэний зарлигуудад дуулгаваргүй байх үед энэ зарчим бидэнд мөн хамаатай.

Хэрэв та Мормоны үед амьдарч байсан бол Мормон 1:13–14, 18-д дурдагдсан Бурханы бэлгүүдээс алийг нь алдахдаа хамгийн их харамсах байсан бэ? _____

Мормон 1:15-ыг уншаад нифайчууд Ариун Сүнсний бэлэг болон Бурханы бусад бэлгүүдийг алдаж байхад Мормон юу мэдэрч байсныг ол. Мормон хэдийгээр агуу ёсон бусын дунд байсан ч сүнслэг туршлагуудыг хэрхэн авах боломжтой байсан гэж та бодож байна вэ?

Мормон 2:1–15

Мормон нифайчуудын их цэргийг удирдаж, тэдний ёсон бусын төлөө харамсав

Дараах нөхцөл байдлын талаар эргэцүүлэн бод: 30 настай эр эцэг эхтэйгээ амьдардаг бөгөөд ажил олж хийхгүй байхыг сонгожээ. Харин оронд нь эцэг эхээрээ тэжээлгэж, ихэнх цагаа видео тоглоом тоглох зэрэг үр ашиггүй үйл ажиллагаанд дэмий үрдэг. Мормон 2-оос судлахдаа Мормон хүүг тодорхойлсон тодорхойлолтыг энэхүү хувилбартай харьцуул.

Мормон 2:1–2-ыг уншаад Мормон ямар хариуцлага хүлээж авсан болон үүнийг хүлээж авахдаа хэдэн настай байсныг олж мэд.

Мормон нифайчуудын их цэргийн удирдагчаар томилогдоод удаагүй байхад леменчүүдийн хүчирхэг их цэрэг нифайчуудын дээр ирсэн бөгөөд тэд айж мөн ухрав. Леменчүүд нифайчуудыг бүгд нэг газар цугларах хүртэл нь хотоос хот руу хөөв. Эцэст нь Мормоны их цэрэг леменчүүдийн эсрэг зогсч, тэднийг зугтахад хүргэв (Мормон 2:3–9-ийг үзнэ үү).



3. Мормон 2:10–15-ыг уншаад тулааны дараах нифайчуудын сүнслэг байдлыг олж мэд. Тэгээд судар судлах тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

- Нифайчууд яагаад гашуудаж байсан бэ?
- Мормон 2:14-т өгүүлснээр хүмүүсийн харуусал жинхэнэ наманчлалын илрэл биш байсан гэдгийг Мормон хэрхэн мэдсэн бэ?
- Мормон 2:13–14 дэх наманчлалд харууссан болон харуусал нь өөрсдийг нь яланд хүргэсэн (өсөлт хөгжил нь зогссон) хүмүүсийн хооронд ямар ялгааг та харж байна вэ?

Эдгээр шүлгүүд нь **хэрэв нүглийн харуусал маань биднийг наманчлалд хүргэдэг бол даруу зүрх сэтгэлтэйгээр Христэд ирэхэд биднийг удирдах болно гэдгийг заадаг.** Түүнчлэн зөвхөн нүглийнхээ үр дагаварт харуусах нь яллагдахад хүргэдэг (мөнх амьдралд хүрэх өсөлт хөгжил маань зогсоно) гэсэн зарчмыг тайлбарладаг.



4. Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

- Нүгэл хийсэн хүн дэлхийн харуусал буюу ял руу удирддаг харууслыг хэрхэн үзүүлж болох вэ?
- Нүгэл хийсэн хүн наманчлал руу хөтөлдөг харууслыг хэрхэн харуулж болох вэ?

Алдаа гаргасан эсвэл нүгэл хийсэн гэдгээ мэдэх үедээ та ямар үйлдэл хийдгээ тунгаан бод. Та даруу зүрх сэтгэлтэйгээр Аврагчид ирж, наманчлах аваас амар амгаланг мэдэрч, Бурханы хүсэлд нийцэх болно.

Мормон 2:16–29

Мормон ялтсуудыг авч, өөрийн хүмүүсийн ёс бус байдлын талаар цэдэглэдэг

Мормон леменчүүдтэй хийх тулаанууд үргэлжилж байхад Аммарон нифайчуудын цэдгүүдийг нуусан тэр гүвээнд ойр байгаага мэдэв. Тэрээр Нифайн ялтсуудыг авч, хүүхэд байсан үеэс нь хойш уг хүмүүсийн дунд тохиолдсон зүйлсийг ажиглан ойлгосноо бичиж эхлэв (Мормон 2:16–18-ыг үзнэ үү). Мормон 2:18–19-ийг уншаад Мормоны өсөж торних үеийн сүнслэг нөхцөл байдлыг тайлбарласан зарим хэллэгүүдийг тэмдэглэ.

Мормоны талаар сурсан зүйлээс харахад тэр яагаад “эцсийн өдөр өргөгдөх болно” гэдэгтэй итгэлтэй байсан гэж та бодож байна вэ? (Мормон 2:19). (Энэ нөхцөл байдалд “эцсийн өдөр өргөгдөх” гэдэг нь селестииел биетэйгээр амилуулагдаж, өргөмжлөгдөн Бурханы оршихуйд Түүнтэй хамт үүрд үлдэхээр авчрагдахыг хэлнэ.) _____

Мормоны амьдрал бол **бид ёсон бус нийгэмд байсан ч зөв шударгаар амьдрахыг сонгож чадна гэдгийн гэрчлэл юм.**

Дараах зөвлөгөөг эргэцүүлэн бод: “Та нар хийсэн сонголтуудынхаа хариуцлагыг хүлээдэг. Гэр бүлийнхэн, найз нөхөд тань сонгох эрхээ буруугаар ашиглаж байсан ч Бурхан та нарт санаа тавьж, зөв сонголтуудыг хийхэд туслах болно. Та ганцаараа үлдсэн байлаа ч Бурханы хүслийг дагахдаа шийдэмгий зоригтой бай. Та нар үүнийг хийх аваас бусдад сайн үлгэр жишээ болно” (*Залуучуудын бат бөх байдлын төлөө* [товхимол, 2011], 2).



5. Найз эсвэл гэр бүлийн гишүүн тань хэдийгээр бусад нь Бурханы хүсэлд дуулгаваргүй байсан ч өөрөө дуулгавартай байдалд бат бөх зогсож байсныг харсан үеэ судар судлах тэмдэглэлдээ бич. Мөн тэр хүн болон Мормоны жишээ танд хэрхэн тус болж байгаа тухай өөрийн бодлыг бич.

Залуу Эмэгтэйчүүдийн уриа бол “үнэн болон зөв шударгын төлөө зогсох” явдал юм. Та залуу эмэгтэй эсвэл залуу эрэгтэйн аль нь ч байсан зөв зүйлийн төлөө зогсохдоо илүү шийдэмгий байж болох амьдралынхаа тодорхой нэг хэсгийг бод. Таны эргэн тойрон дахь хүмүүс зөв зүйлийн төлөө зогсохгүй байсан ч та үүний төлөө хичээн чармайх үед Их Эзэн танд туслах болно.



6. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Мормон 1–2-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

28-Р ХЭСЭГ: 3 ДАХЬ ӨДӨР

Мормон 3–6

Оршил

Леменчүүдээс өөрсдийн газрыг эргүүлэн авсны дараа нифайчууд тулаанд дахин бэлтгэв. Мормон нифайчуудад наманчлалыг тунхагласан боловч оронд нь тэд өөрсдийн хүчинд сагсуурч, хөнөөгдсөн ах дүү нарынхаа өшөөг авахаар тангараглав. Их Эзэн Өөрийн хүмүүст өшөө авахыг хориглосны учир Мормон тэдний их цэргийн удирдагч байхаас татгалзсан бөгөөд тэд ялагдав. Нифайчууд ёсон бусад үргэлжлүүлэн байх үед Бурхан Өөрийн шүүлтийг тэдний дээрээс юүлж, леменчүүд тэднийг газрын гадаргуугаас арчиж эхэлсэн юм. Эцэстээ Мормон нифайчуудыг тулаанд удирдахаар эргэн ирсэн боловч тэд наманчлахаас татгалзсан тул леменчүүд тэднийг устгав. Мормон тэдний уналт болон Есүс Христэд эргэж ирэх хүсэлгүйнх нь улмаас гашуудав. Тэрээр уг хүмүүсийн цэдэг эцсийн өдрүүдэд урагш авчрагдах болно гэдгийг бошиглож, үүнийг унших хүмүүст наманчилж, Бурханы өмнөх өөрсдийнх нь шүүлтэд бэлтгэлтэй байхыг ухуулав.

Мормон 3–4

Нифайчууд ёсон бусад өсч байсан учир Мормон тэдний их цэргийг удирдахаас татгалзсан бөгөөд леменчүүд нифайчуудыг газрын гадаргаас арчиж эхлэв

Их Эзэн таныг амьдралынхаа ямар нэгэн юмыг өөрчлөөсэй хэмээн хүсч байгааг та мэдэрч байсан уу? Таны бодлоор өөрөө анзаараагүй байхад тань Их Эзэн танд амьдралынхаа ямар нэгэн зүйлийг өөрчлөхөд тусалж эсвэл урамшуулж байсан уу?

Мормоны үед леменчүүдтэй тулалдсан тулаануудад нь Их Эзэн нифайчуудад нөлөөлж байсныг тэд ихэвчлэн анзаарахгүй, талархахгүй байсан. Леменчүүд болон Гадантоны дээрэмчидтэй гэрээ хийснийх нь дараа Их Эзэн нифайчуудыг 10 жилийн турш зөрчилдөөнгүй байлгасан. Энэ арван жилийн турш тэд ирэх дайралтад бие махбодын хувьд бэлтгэжээ (Мормон 2:28; 3:1-ийг үзнэ үү).

Мормон 3:2–3-ыг уншаад нифайчуудаас Их Эзэний хүсч байсан леменчүүдийн дайралтад өөрсдийгөө бэлтгэх илүү чухал арга замыг ол. Нифайчууд хэрхэн хариу үйлдэл үзүүлсэн бэ? Мормон 3:3 дээр өгүүлсэнчлэн Их Эзэн яагаад нифайчуудын гэм нүглийг үл харгалзан өмнөх тулаануудад тэднийг хэлтрүүлсэн бэ? _____

Мормон 3:4–8-д хэлснээр Их Эзэн нифайчуудыг дахин хоёр тулаанд хамгаалсан. Ёс бус Нифай үндэстэнтэй харьцах Их Эзэний харилцаанаас бидний сурах нэг сургаалт үнэн бол **Өөрийн нигүүлслийн дагуу Их Эзэн бидэнд нүглээ наманчлах хангалттай боломж өгдөг явдал юм.** Эдгээр боломжууд нь Бурханы тэвчээр, сайхан сэтгэл, бүх хүүхдүүд нь Цагаатгалын бүрэн адислалуудад бэлдэх арга замаар амьдраасай хэмээх Түүний хүслийн нотолгоо юм.



1. Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич (хэрвээ хариулт тань ариун нандин, нууцлаг бол хувийн тэмдэглэлдээ бичиж болно):

а. Их Эзэн танд хэрхэн наманчлахыг ухуулж, наманчлах боломжуудыг олгосон бэ? Энэ нь танд Түүний зан чанарын тухай юу заадаг вэ?

б. Мормон 3:3 дахь нифайчуудын адил энэхүү урамшууллыг үл ойшоож, зүрх сэтгэлээ үүний эсрэг хатууруулахгүй байхын тулд та юу хийж чадах вэ?

Амьдралдаа өөрчлөлт хийх, Их Эзэний илгээсэн боломж болон урилга таны анзаарч байснаас илүү ойр ойрхон ирдэг байж болно. Жишээлбэл, ариун ёслолоос хүртэх үед эсвэл бусдад үйлчлэх, өөрийгөө хөгжүүлэх зэрэг Ариун Сүнсний өдөөлтийг мэдрэх үед ирж болно. Эдгээр боломжуудыг хайж, өөрчлөлтийг түргэн хийх үедээ та Их Эзэний гэтэлгэлийн

хүчийг амьдралдаа урих болно. Өөрсөдтэй нь харилцахыг хүссэн Их Эзэний оролдлогуудыг эсэргүүцсэн нифайчуудын эсэргүүцлийг ойлгохын тулд Мормон 3:9–10-ыг уншаад леменчүүдийг ялсан хэдэн ялалтынхаа төлөө тэд ямар үйлдэл хийснийг ол. (Уншихдаа 9-р шүлэг дэх өшөө авах гэдэг үг нь хохирлынхоо өс хонзонг авах гэсэн утгатай болохыг ойлгох нь тустай байж болно.)

Леменчүүдийн дээр байгуулсан ялалтуудынхаа дараа нифайчууд ямар үйлдэл гаргасан бэ? Мормон 3:11–13-ыг уншаад өшөө авахыг (өс хонзон) эрэлхийлсэн их цэргийн тангарагт үзүүлсэн Мормоны хариу үйлдлийг ол.

Мормон нифайчуудын жигшмээр ёсон бус байдлыг үл харгалзан тэдний их цэргийг 30 гаруй жил удирджээ. Тэр үед их цэргийг удирдахаас татгалзсан Мормоны шийдвэр өс хонзон эрэлхийлэхийн ноцтой байдлын тухай бидэнд юу зааж байна вэ? _____

Мормон 3:14–16-г уншаад өшөө авах (эсвэл өс хонзон эрэлхийлэх) тухай Их Эзэний Мормонд заасан зүйлсийг илэрхийлэх хэллэгүүдийг тэмдэглэ. Эдгээр шүлгүүдээс бидний сурах нэг үнэн бол **Их Эзэн өшөө авахаар эрэлхийлэхийг бидэнд хориглодог** хэмээх үнэн юм.



2. Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

а. Танд хийсэн зүйлийнх нь төлөө тухайн хүнээс хариу авах эсвэл өшөө авахыг хүсч байсан уу? Энэ нь яагаад аюултай эсвэл болчимгүй хариу үйлдэл гэж та бодож байна вэ? Та өшөө авахыг хүссэнээр хэн хамгийн их хохирно гэж бодож байна вэ?

б. Шүүлт болон өшөө авалтыг өөрсдөө авснаас Их Эзэнд үлдээх нь яагаад илүү дээр вэ?

Хэдийгээр бид өс хонзонгийн мэдрэмжээ орхих хүсэлтэй байдаг бөгөөд орхих хэрэгтэй гэдгээ мэдэж байгаа ч ихэнхдээ тэрхүү мэдрэмж оргилон гарах үед үүнийг даван туулахад хэцүү байдаг. Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх Ерөнхийлөгч Жэймс Э.Фаустын дараах зөвлөгөөг уншихдаа өс хонзонгийн мэдрэмжийг мэдрэх үед үүнийг даван туулахын тулд юу хийж болохоо мэдэхэд тань туслах хэллэгүүдийн доогуур зур.



“Бид уур хилэнгийн мэдрэмжүүдийг таньж, ухамсарлах хэрэгтэй. Үүнийг хийхэд даруу байдал хэрэгтэй ч хэрэв бид өвдөг сөхрөн Тэнгэрлэг Эцэгээс уучлал гуйвал Тэр бидэнд туслах болно. ‘Үзэн ядалт сүнслэг өсөлтийг маань сааруулдаг’ тул Их Эзэн биднийг өөрсдийн сайн сайхны төлөө ‘бүх хүмүүнийг уучлах’-ыг [С ба Г

64:10] шаарддаг. [Орсон Ф.Витни, *Gospel Themes* (1914), 144.] Бид өөрсдийгөө үзэн ядалт, өшөө хорслоос чөлөөлсөн үед л Их Эзэн зүрх сэтгэлд маань тайвшралыг өгч чадна. . . .

“ . . . Гай зовлон тохиолдоход бид хувийн өс хонзон санах байдлаар хариулах бус харин оронд нь шударга ёсонд даатган орхих ёстой. Үүнийг орхиж, эгдүүцлээр дүүрсэн зүрх сэтгэлээ хоослох нь амаргүй. Аврагч Цагаатгалаараа дамжуулан бид бүгдэд үнэ бүхий амар амгаланг өгсөн ч энэ нь зөвхөн бид уур хилэн, дайсагнал эсвэл өшөө авалтын сөрөг санаа бодлоо хаях хүсэлтэй байснаар ирэх болно”. “Бидний эсрэг зөрчил үйлдсэн тэднийг” [Иосеф Смитийн орчуулга, Матай 6:13], бүр ноцтой нүгэл үйлдсэн тэднийг уучилдаг бид бүгдэд Цагаатгал амар амгалан, тайвшралыг авчирдаг” (“The Healing Power of Forgiveness,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2007 оны 5-р сар, 69).

Та бусдын эсрэг тээж явдаг хорсол, уур хилэн, сөрөг мэдрэмжээ орхих тухай энэхүү зөвлөгөөг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлэх талаараа тунгаан бод.

Нифайн их цэргийг удирдахаас татгалзсаныхаа дараа Мормон эцсийн өдрүүдэд үгсийг нь унших тэдэнд зориулан бичих зүйдээ анхаарлаа хандуулав. Тэрээр бидний хүн бүрийг наманчилж, “Христийн шүүлтийн суудлын өмнө зогсоход” бэлдэхийг хүссэн (Мормон 3:18–22-ыг үзнэ үү).

Мормон 4:1–2-ийг уншаад Нифайн их цэрэг леменчүүдээс өшөө авахыг эрэлхийлэхэд юу тохиолдсоныг ол. Мормон 4:4-ийг уншаад Нифайн их цэрэг яагаад ялалтад (ялах) хүрээгүйг ол. Мормон 4:5-ыг уншаад ёсон бусад үргэлжлүүлэхийн үр дагаврын тухай ямар нэгэн үнэнийг тодорхойл. Та юу олсон бэ? _____

Таны харсан үнэнүүдийн нэг нь **Бурханы шүүлт ёс бусчуудыг дийлэх болно хэмээх үнэн байж болох юм**. Ихэвчлэн “ёс бусыг үйлдэгчдээр ёс бусыг үйлдэгчид нь шийтгэгддэг” (Мормон 4:5). Ёс бусыг үйлдэгчид Бурханы тусламжийг үл тоомсорлож, Түүний тэнгэрлэг хамгаалалтыг эрэлхийлэхээс татгалздаг. Мормон 4:11–14, 18-ыг уншаад Бурханы шүүлт нифайчуудын дээр хэрхэн юүлэгдэж байсныг ол.



3. Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

а. Таны бодлоор Мормон 3–4-т гарсан нифайчуудын нөхцөл байдлын хамгийн харамсалтай зүйл нь юу вэ?

б. Таны өнөөдөр сурсан сургаал болон үнэнүүд өөр хоорондоо хэрхэн холбогдож болох вэ? (Наманчлал, өшөө авалт болон Бурханы шүүлтийн хоорондын харилцааны талаар эргэцүүлэн бод.)

Их Эзэн эдгээр үнэнийг хэрэгжүүлэхийн тулд таныг юу хийгээсэй гэж хүсч байгааг тунгаан бод.

Мормон 5–6

Мормон дахиад нифайчуудын их цэргийг удирдахаар шийдсэн боловч леменчүүд ялалт байгуулав. Мормон өөрийн хүмүүсийн устгалын хойноос гашуудав

Зөв шударгаар амьдарч байгаад нас барсан хүн болон ёсон бусаар амьдарч байгаад нас барсан хүний төлөө гашуудах гашуудлуудын хооронд ялгаа байна уу? Таны бодлоор тэр ялгаа нь юу байж болох вэ?

Мормон Нифайн их цэргийг удирдахаас татгалзаад 13 жил болсны дараа дахин удирдахаар болов. Хүмүүс наманчилж, Их Эзэнд хандан тусламж гуйхаас татгалзсан тул түүнд найдвар үгүй байсан ч тэр тэднийг удирджээ. Леменчүүдийн хэд хэдэн дайралтыг эсэргүүцсэний эцэст нифайчууд зугтав. Хурдан зугтаж чадаагүй хүмүүс нь устгагджээ. Мормон леменчүүдийн хаанд захиа бичиж, нифайчуудад сүүлийн тулаанд цугларах хугацаа өгөхийг хүсэв (Мормон 5:1–7; 6:1–6-г үзнэ үү).

Мормон 6:7–11-ийг уншаад өөрийн хүмүүсийн устгалыг үзээд гашуудсан Мормоны гашуудлыг ойлгохыг хичээ. Ёс бусаар амьдарч буй хүмүүст үхэл яагаад аймшигтай санагдаж болно гэж та бодож байна вэ? _____



4. Мормон 6:16–22-ыг уншаад судар судлах тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

а. Бошиглогч, удирдагчид болон эцэг, эхчүүд маань яагаад бидэнд наманчлахыг хичээнгүйлэн урамшуулдаг вэ?

б. Их Эзэний тэврэлтийн найдвар наманчлахад тань хэрхэн тусалдаг вэ? (Мормон 6:17-г үзнэ үү).

Их Эзэн таныг яг одоо наманчлаасай хэмээн хүсэх ямар нэг зүйл амьдралд тань байгаа эсэхийг тунгаан бод. Та энэ тухай хувийн тэмдэглэлдээ бичиж, биелүүлэхийн тулд зорилго тавих хэрэгтэй.



5. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Мормон 3–6-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

28-Р ХЭСЭГ: 4 ДЭХ ӨДӨР

Мормон 7:1–8:11

Оршил

Нифайчууд, леменчүүдийн хоорондох сүүлчийн тулааны дараа Мормон өөрсдийгөө хэн гэдгийг мэдэж, аврагдахын тулд юу хийх ёстойгоо мэдэхийн ач холбогдлыг Мормоны Номын хүмүүсийн ирээдүйн үр удамд зориулж бичжээ. Мормон дайсныхаа ирээдүйн үр удмыг хайрлах үлэмж их хайрыг агуулан Есүс Христийн сайн мэдээний дагуу амьдрахын ач холбогдлыг, энэ нь “шүүлтийн өдөр та нарын хувьд сайн байх болно” хэмээн заасан (Мормон 7:10). Мормоныг нас барсны дараа Моронай өөрийн хүмүүсийн устгалын талаар бичихээр ганцаараа үлдсэн байлаа.

Мормон 7

Мормоны сүүлийн гэрчлэлд тэр леменчүүдийн үлдсэн хүмүүсийг Есүс Христэд итгэж, Түүний сайн мэдээг дагахыг ухуулдаг

Мормон 6-аас та леменчүүдтэй байлдсан сүүлчийн тулаанд 230,000 нифайчууд амь үрэгдсэн гэдгийг мэдэж авсан. Та ийм тулаанаас амьд үлдсэн боловч найзууд болон гэр бүлийн гишүүд тань үлдээгүй хэмээн төсөөлөн бод. Таны хайртай хүмүүсийг алж, улс үндэстнийг тань эзэлсэн хүмүүсийн үр удмын талаар та ямар сэтгэгдэлтэй байх вэ? Мормон 7:1–4-ийг уншаад леменчүүдийн үр удамд зориулж Мормон юу бичсэнийг олж мэд.



1. Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

а. Леменчүүд болон тэдний үр удмыг юуг мэдээсэй хэмээн Мормон хүсч байсан бэ?

б. Энэ нь найзууд болон гэр бүлийн гишүүдийг тань алсан хүмүүсийн үр удмын тухай ямар мэдрэмжтэй байх байсан таны төсөөллөөс хэр зэрэг ялгаатай байна вэ?

в. Дайснууддаа хандсан Мормоны үгсээс Аврагчийн ямар зан чанарыг та харж байна вэ?

Мормон леменчүүдийн үр удамд зориулж бичихээ үргэлжлүүлэв. Мормон 7:5–7-г уншаад леменчүүдийн үр удамд Аврагч Есүс Христийн тухай итгүүлэхээр Мормоны ухуулгаас дор хаяж гурван үнэнийг олж тэмдэглэ.




2. Өөрийн тодорхойлсон Есүс Христийн тухай үнэнүүдээс нэгийг нь сонгоод тэрхүү сургаалд итгэх нь таны амьдралд хэрхэн нөлөөлснийг судар судлах тэмдэглэлдээ бич.

Мормон өөрийнх нь хүмүүсээс олныг алсан ле-
менчүүдэд хандахдаа буруушаасан үгс хэрэглэх-
дээ өөрийгөө зөвтгөсөн байж болох юм. Гэвч тэр
үнэнийг мэддэг байсан учраас шүүлтийн тавцан
дээр Бурханы өмнө гэм буруугүй болж болохын
тулд юу хийх ёстойг тэдэнд (бидэнд) заан бичсэн.
Мормон 7:8–10-ыг уншаад хүн юу хийх ёстой тухай
Мормоны гэрчилснийг ол. Та тодорхойлсон зүйлсээ
судартаа тэмдэглэх хэрэгтэй.

Эдгээр шүлгүүд нь **Их Эзэн бүх хүмүүнд авралыг
санал болгодог бөгөөд Түүний сайн мэдээний
зарчим, ёслолуудыг хүлээн зөвшөөрсөн хүмүү-
сийг гэтэлгэх болно хэмээн заадаг.** Та энэхүү
зарчмыг судартаа бичих хэрэгтэй. Энэхүү зарчмын
дагуу хэрхэн амьдрахаа мэдэх арга зам бол судруу-
даас суралцах юм хэмээн Мормоны заасныг анзаар
(Мормон 7:8-ыг үзнэ үү). “Энэ цэдэг” хэмээх хэллэг
нь Мормоны Номыг, “Иудейчүүдээс харийнханд ирэх
тэр цэдэг” гэдэг нь Библийг төлөөлж байгаа гэдгийг
ойлгох нь тустай байж болох юм. Үүний адил Мор-
мон 7:9 дэх “үүнд” гэдэг нь Мормоны Номыг, “түүнд”
гэдэг нь Библийг төлөөлж байгаа юм. Та эдгээр ялгаа-
тай шинжүүдийг судартаа тэмдэглэх хэрэгтэй.

Мормон 7-г дүгнэхдээ Мормон хорсолт дайснуу-
дынхаа үр удамд зориулсан урамшуулал болон
найдварын захиас зэрэг бичиглэл дэх Христийн
нинжин сэтгэл, энэрлийн жишээний талаар хэдэн
хором тунгаан бод.

 **3.** Дараах асуултын талаарх өөрийн бодлыг судар
судлах тэмдэглэлдээ бич: Би хэрхэн Мормоны жишээг
дагаж, намайг ад үздэг хүмүүс болон бусад хүмүүст тэдний
мөнхийн үнэ цэнийн талаас нь хандаж чадах вэ?

Мормон 8:1–11

*Мормон эцгийнхээ үхэл, өөрийн хүмүүсийн устгал
болон ганцаар үлдэж байгаа тухайгаа бичив*

Ганцаараа байсан үеийнхээ тухай бод. Ганцаараа
байхад танд ямар санагдсан бэ? Олон жил ганцаа-
раа байна гэж төсөөл.

Мормон 7 болон 8-р бүлгүүдийн тойм эсвэл хуу-
дасны доод хэсэг дэх оныг хар. 7-р бүлэг дэх Мор-
моны сүүлчийн үгсээ бичсэн цагаас 8-р бүлэг дэх
Моронайн ялтсууд дээр бичиж эхэлсэн цагийн хоо-
ронд хэдэн жил өнгөрсөн байна вэ? _____





Мормон 8:1–2-ыг уншаад Кумора дахь агуу тулааны дараа юу тохиосныг олж мэд. Дараа нь Мормон 8:3–9-ийг уншаад хүмүүсийнх нь устгалын дараах Моронайн нөхцөл байдлыг тодорхойлсон хэллэгүүдийг тэмдэглэ. Та үүнтэй төстэй нөхцөл байдалд орсон бол юу мэдрэх байсан тухайгаа тунгаан бод.

Итгэл, жишгүүдээ ганцаардлыг мэдэрч байсан үеэ бод. Тэр үед Аврагчийг дагаж, Түүний зарлигуудыг сахих шийдвэр тань өссөн үү, хэвээр байсан уу, эсвэл буурсан уу? Яагаад?

Моронай өөрийн нөхцөл байдлаас үл хамааран юу хийхээ шийдвэрлэснийг олохын тулд Мормон 8:1, 3-ыг дахин хар. Моронайн үлгэр жишээ **та ганцаараа байсан ч итгэлтэй хэвээр үлдэхийг сонгож болно гэдгийг үзүүлдэг**. Та энэ үнэнийг судартаа бичих хэрэгтэй.

Мормоны Номонд Моронайн адил ганцаараа үлдсэн ч итгэлтэй хэвээр үлдсэн хүмүүс байдаг. Абинадай Ноа хаан болон түүний пристүүдийн өмнө ганцаар зогсож, гэрчилсэн (Мозая 12–17-г үзнэ үү). Алма бол Абинадайн үгсэд итгэж, түүнийг хамгаалахыг оролдсон ганц прист юм (Мозая 17:1–4-ийг үзнэ үү).

Ахлагч Ричард Г. Скотт ганцаар зогсож байсан ч итгэлтэй байхыг сонгосон залуу эрэгтэйн тухай дараах түүхийг хуваалцжээ:



“[Энэ] залуу эрэгтэйн үлгэр жишээг эргэцүүлэн бодоорой. Эцэг эх нь түүнд он жил улиран тохиох явцад нялх байхаас нь эхлээд Бурханы зарлигуудын дагуу гуйвшгүйгээр амьдрахыг зааж байгааг би харсан юм. Тэд үлгэр жишээ,

заавраараа түүнийг болон бусад хүүхдүүдээ үнэнд хүмүүжүүлж байлаа. Тэд сахилга батын өсөлт, зөв зохистой зорилгуудаа хэрэгжүүлэх золиослолыг дэмжиж байв. Энэ залуу эрэгтэй эдгээр чанаруудыг зан төлөвтөө суулгаж өгөхийн тулд сэлэхийг сонгов. Өглөө эрт хийдэг дасгал нь сахилга бат, золиослолыг шаардаж байлаа. Цагийн явцад тэрээр энэ спортод онцгой сайн болох нь тэр.

“Тэгээд сорилтуудтай тулгарч эхлэв. Жишээ нь, аварга шалгаруулах тэмцээн Ням гарагт болдог байжээ. Тэр оролцсон болов уу? Аварга шалгаруулах тэмцээнд багаа хожиход нь туслахын тулд тэр Ням гарагт сэлэхгүй байх дүрмээ дагахгүй байх шалтаг тоочсон болов уу? Үгүй, тэр хүчтэй дарамтан дор байсан ч тэгээгүй. Тэрээр доромжлуулж, бүр бие махбодын хүчирхийлэлд автсан. Гэвч тэр бууж өгөөгүй юм. Найзуудын үл ойшоох, ганцаардал, дарамт шахалт түүнийг гуниглаж, нулимс унагахад хүргэж байв. Гэсэн ч тэр бууж өгөөгүй. Тэрээр бидний хүн нэг бүр юу мэдэх ёстойг буюу ‘Христ Есүс дотор бурханлаг амьдрахыг хүсэгч бүх хүмүүс хавчигдах болно’ хэмээх Тимотод зориулсан Паулын зөвлөгөөний үнэн мөнгийг сурч байсан (2 Тимот 3:12). Он жилийн явцад зуу зуун зөв шийдвэрээр сүлжигдэн бий болсон зөв шударгаар амьдрах тогтмол хэв маяг нь хүч чадал, чадварыг хөгжүүлсэн байна. Тэдгээр шийдвэрийн заримыг агуу сорилтуудтай нүүр тулан байж гаргаж байсан юм. Одоо тэрээр номлогчийн хувьд ажиллах ур чадвар, үнэний мэдлэг, гуйвшгүй үнэнч байдал, сайн мэдээг хуваалцах шийдэмгий байдлаараа бусдаар хүндлүүлж байна. Нэгэн цагт эргэн тойрон дахь хүмүүсээрээ ад үзэгдэж байсан эрэгтэй бусдынхаа хүндэтгэлийг хүлээсэн удирдагч болоод байна” (“First Things First,” *Ensign*, 2001 оны 5-р сар, 8).

Мормон 8:10–11-ийг уншаад Их Эзэн хэцүү нөхцөл байдалтай тулгарч байх үед нь Моронай, Мормон (нас барахаас нь өмнө) нарыг дэмжиж байсан нэг арга замыг тодорхойл. Ерөнхийлөгч Томас С. Монсоны хэлсэн дараах урамшуулал нь ганцаардсан үедээ хүртэл итгэлтэй хэвээр үлдэх шийдвэр гаргахад тань туслах болно.



“Бидний өдөр тутмын амьдралд итгэл маань соригдох нь зайлшгүй юм. Заримдаа бид хийж болох ба болохгүй зүйлсийн тал дээр цөөхүүлээ эсвэл бүр ганцаараа байр сууриа хамгаалан

зогсох шаардлага ч гарч болно. Хэдийгээр цор ганцаар зогсох байсан ч итгэлийнхээ төлөө бат зогсох ёс суртахууны зориг бидэнд бий юү?

“... Бид өөрсдийнхөө итгэдэг зүйлсийнхээ төлөө зогсох зоригтой мөн бэлтгэлтэй байх болтугай. Хэрэв бид ганцаар зогсох хэрэгтэй бол зоригтойгоор Тэнгэрлэг Эцэгтэйгээ байхад би хэзээ ч ганцаардахгүй гэсэн бодит мэдлэгээр хүчирхэгжиг” (“Ганцаар зогсох зоригтой бай,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2011 оны 11-р сар, 74, 78).



4. Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

а. Цор ганцаар зогсож байсан ч итгэлтэй байдлын жишээ болох өөр хүнийг та таних уу?

б. Ерөнхийлөгч Монсоны хэлсэн үгс ганцаараа байхдаа ч итгэлтэй хэвээр үлдэх шийдвэр гаргахад тань хэрхэн туслах вэ?



5. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Мормон 7:1–8:11-р шүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсоны хэлсэн дараах үгсийг унш: “Өнөө үед дэлхийд өгөгдсөн хамгийн чухал бэлгүүдийн талаар би яримаар байна. Миний бодож байгаа энэ бэлэг бол аж үйлдвэр, технологийн шинэчлэлтийн аль ч бүтээлтээс илүү чухал юм. Энэ бол хүн төрөлхтний хувьд орчин үеийн анагаах ухаанд бидний харсан олон гайхамшигт амжилтаас ч илүү агуу үнэ цэнэтэй бэлэг мөн. Энэ нь хүн төрөлхтөнд нисэх хүчний хөгжил эсвэл сансрын нислэгээс ч илүү үнэ цэнэтэй юм. Би _____

бэлгийн талаар ярьж байна.”

Ерөнхийлөгч Бэнсон ямар бэлгийн талаар ярьж байна гэж та бодож байна вэ? _____

Моронай энэ бэлгийн тухай Мормон 8-д заасан. Мормон 8:12–14-ийг уншиж, энэ нь ямар бэлэг болохыг ол. “Энэ цэдэг” гэсэн хэллэг нь Мормоны Номыг төлөөлнө. Мормоны Ном нь Ерөнхийлөгч Бэнсоны ярьсан бэлэг юм. (“The Book of Mormon—Keystone of our Religion,” *Ensign*, 1986 оны 11-р сар, 4-ийг үзнэ үү). Ерөнхийлөгч Бэнсоны хэлсэн үгсийн төгсгөл дэх хоосон зайд *Мормоны Ном* гэж бич.



29-Р ХЭСЭГ: 1 ДЭХ ӨДӨР

Мормон 8:12–41

Оршил

Моронай эцгийнхээ үхэл болон хүмүүсийнхээ устгалын талаар бичсэний дараа Мормоны Номын ирэлтийг бошиглож, үүнийг буруушаах тэдэнд сэрэмжлүүлэв. Моронай олон хүмүүс Бурханаас илүүгээр дэлхийн эд зүйлсэд дурлах агуу ёс бус өдрүүдэд Нифай үндэстний цэдэг урагш гарч ирэхийг харсан. Эцсийн өдрүүд дэх сүнслэг байдлын аюултай үед Мормоны Ном нь “агуу үнэ цэнэтэй” (Мормон 8:14) байх болно гэдгийг тэрээр гэрчилсэн.

Мормон 8:12–32

Моронай Мормоны Ном урагш авчрагдахыг бошиглов

Өөрийнхөө бодлоор хүлээн авч байсан хамгийн гайхалтай бэлгүүдээ бич: _____

Эдгээр бэлгүүд нь яагаад танд адислал болж байгаа тухай бод.

Мормоны Номын үнэ цэнийн талаар Моронай юу гэж заасныг олохын тулд Мормон 8:12–14-ийг дахин хар. Ялтсуудын санхүүгийн үнэ цэнийн талаар тэрээр юу гэж заасан бэ? Моронай ялтсуудыг ашиг хонжооны тулд ашиглахыг Их Эзэн зөвшөөрөхгүй бөгөөд ялтсууд дээр бичигдсэн зүйл нь агуу үнэ цэнэтэй болохыг тайлбарласан.

Мормоны Номын урагш гарч ирсэн арга зам нь энэхүү номын ач холбогдлыг ойлгоход бидэнд тусална. Мормон 8:15–16-г уншаад Мормоны Ном хэрхэн урагш гарч ирэх тухай Моронай юу гэж заасныг тодорхойл.



1. Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

а. “[Бурханы] алдар суугийн төлөө бүхнээ зориулсан” хүнээр л Мормоны Ном нь урагш авчрагдана гэдэг нь ямар утгатай гэж та бодож байна? (Мормон 8:15).

б. Мормоны Ном нь “Бурханы хүчээр” урагш авчрагдана гэдэг нь таны хувьд ямар утгатай вэ? (Мормон 8:16). Мормон 8:16 дахь Моронайн үгсийг уншаад Мормоны Номын тухай та юу мэдэрч байна вэ?

Моронай Мормоны Номыг эсэргүүцэх эсвэл буруушаах тэдэнд сэрэмжлүүлсэн. Мормон 8:17–22-ыг уншихдаа түүний сэрэмжлүүлгийг олж хар. “Их Эзэний мөнхийн зорилгууд Түүний бүх амлалтууд биелэгдэх хүртэл үргэлжилсээр байх болно” гэдгийг мэдэх нь танд яагаад чухал вэ? (Мормон 8:22).

Нифай, Иаков, Инос, Алма зэрэг бошиглогчдыг оруулаад “миний өмнө одсон гэгээнтнүүдтэй” (Мормон 8:23)—Их Эзэн гэрээ байгуулсан гэдгийг Моронай тайлбарласан. Их Эзэн эдгээр бошиглогчдын үгсийг хожмын өдрүүдэд урагш авчирна’ гэдэг гэрээ байгуулсан юм. Мормон 8:23–25-ыг судлахдаа эдгээр бошиглогчид хэний төлөө залбирсныг ол.

Эдгээр бошиглогчид леменчүүд (Мормон 8:24), “тэдний ахан дүүс” болон үр удмынх нь төлөө залбирсан. Түүнчлэн тэд хожмын үед “эдгээр зүйлсийг авчрах” хүн буюу (Мормон 8:25; болон Мормон 8:16-г үзнэ үү) эдгээр хожмын өдрүүдэд Мормоны Номыг дэлхийд авчрахаар сонгогдсон бошиглогч Иосеф Смитийн төлөө залбирсан (С ба Г 3:5–10-ыг үзнэ үү). Эрт үеийн олон бошиглогч Иосеф Смитийн тухай мэдэж байсан бөгөөд Мормоны Номыг орчуулж, хэвлэж гаргах амжилт буюу Бурханы зорилго биелэгдэхийн төлөө залбирсан (Мормон 8:22, 24–25; С ба Г 10:46-г үзнэ үү).

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын Ерөнхийлөгч Бойд К.Пакэр Иосеф Смитийн Мормоны Номыг урагш авчрахад гүйцэтгэсэн үүргийн талаар ийн хэлжээ:



“Иосеф Смит Мормоны Номыг ямар ч тусламж, сүнслэг нөлөөлөлгүйгээр найруулан гаргасан гэж бодох нь тэнэглэл юм.

“Илүү ч үгүй, дутуу ч үгүй тэрээр Бурханы бошиглогч байсан гэдэг нь гагцхүү үнэн!

“Судрууд нь Иосеф Смитээр дамжин ирснээс биш түүнээс ирээгүй. Тэрээр илчлэлтүүд өгөгддөг суваг нь байсан юм. Тэрээр эртний болон өнөө үеийн бошиглогчдын адил энгийн нэгэн байсан. . . .

“Бошиглогч Иосеф Смит боловсролгүй, хөдөөний хөвгүүн байсан. Түүний анх бичиж байсан зарим

захидлыг уншихад үг үсэг, дүрэм болоод илэрхийллийн хувьд чадвар муутай байсан нь харагддаг.

“Түүгээр дамжуулан ирсэн бичгийн аливаа хэлбэрийн илчлэлтүүдийг гайхамшиг гэхээс өөрөөр хэлэх аргагүй” (“We Believe All That God Has Revealed,” *Ensign*, 1974 оны 5-р сар, 94).

Та өөрийгөө 1600 орчим жилийн өмнө амьдарч байсан Моронай бөгөөд Бурханы хүчээр энэ эрин үеийг харах боломжтой байсан гэж төсөөл. Мормон 8:35-ыг уншаад энэ үеийн сүнслэг байдлыг юу гэж бодох байсан талаар эргэцүүлэн бод. Энэ эрин үед Мормоны Ном урагш гарч ирэх энэ үеийг дүрсэлсэн Моронайн бошиглолыг агуулсан Мормон 8:26–32-р шүлгүүдийг унш.



2. Энэ эрин үеийг дүрсэлсэн Моронайн тодорхойлолтоос хоёр эсвэл түүнээс илүүг судар судлах тэмдэглэлдээ бич. Мөн эдгээр тодорхой дүрслэлүүд нь яагаад сонирхолтой мөн манай эрин үетэй тохирч байгааг бич.

Мормоны Номын тухай Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон ийнхүү заасан:



“Мормоны Номыг бидний эрин үед зориулан бичсэн [учир] бид үүнийг сургалтынхаа гол төв болгох ёстой. Эрт үеийн нифайчууд, леменчүүдийн аль алинд нь энэ ном байгаагүй билээ. Энэ нь бидэнд зориулагдсан юм. . . .

“Мормоны Номын гол бичээч бүр ирээдүйн үеийнхэнд зориулан бичсэнээ гэрчилсэн байдаг. . . .

“Хэрэв тэд өнөө үеийг харж, бидэнд агуу үнэ цэнэтэй болох тэдгээр зүйлсийг сонгосон юм бол бид Мормоны Номыг мөн тийм байдлаар судлах ёсгүй гэж үү? Их Эзэн юуны учир үүнийг цэдэгтээ оруулахаар Мормонд (эсвэл Моронай, Алмад) сүнслэгээр нөлөөлсөн юм бол? Энэ эрин үед амьдрахад надад туслах ямар сургамжийг би сурч болох вэ? гэж бид өөрсдөөсөө үргэлж асуух ёстой” (“Мормоны Ном бол манай шашны тулгуур чулуу,” 6).



3. Мормоны Номын үнэ цэнийг хувьдаа тунгаан бодоод судар судлах тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

а. Энэ эрин үеийн нөхцөл байдлын тухай Моронайн бошиглолууд хэр үнэн болох тухай бод (Мормон 8:26–32-ыг үзнэ үү). Бидний эрин үе дэх Мормоны Номын үнэ цэнийн тухай эдгээр бошиглолууд юу зааж байна вэ?

б. Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсоны заасны дагуу Мормоны Ном нь яагаад “өнөө үед дэлхийд өгөгдсөн хамгийн гайхамшигтай бэлгүүдийн нэг” гэж та бодож байна? (“Мормоны Ном бол манай шашны тулгуур чулуу,” 4).

в. Хэрэв найз тань Мормоны Ном таны хувьд яагаад чухал болохыг асуувал юу та гэж хариулах вэ?

Мормон 8:33–41

Моронай эцсийн өдрүүдийг харж, бидний цаг үеийн сүнслэг ёс бус байдлыг зэмлэдэг

Материаллаг, сэтгэл санааны, нийгмийн эсвэл сүнслэг тусламж хэн нэгэнд хэрэгтэй байгааг анзаарсан үеэ бод. Тэр хүнд туслахын тулд юу хийснээ эсвэл юу хийж болох байсныг эргэцүүлэн бод. Тэр хүнд яагаад туслахаар шийдсэн эсвэл туслаагүйгээ тунгаан бод. Яагаад хүмүүс заримдаа тусламж хэрэгтэй нэгэнд тусалдаггүй гэж та бодож байна вэ?

Мормон 8:36–41-ийг уншаад эцсийн өдрүүдэд хүмүүс тусламж хэрэгтэй нэгэнд яагаад туслахгүй вэ гэдэг талаар Моронайн хэлсэн шалтгаануудыг ол. Эдгээр шалтгаануудыг судартаа тэмдэглэж болно. *Чимэглэх* гэдэг үг нь “хөөрхөн болгох” эсвэл “гоёх” гэсэн утгатай болохыг ойлгох нь тустай байж болох юм.

Өнөөгийн өсвөр үеийнхэн Есүс Христийн жинхэнэ шавь байхаас илүү мөнгөөр авч болох зүйлсэд дурлаж, материаллаг зүйлсийн араас хөөцөлдөж байгаа ямар жишээнүүд байна вэ? Мормон 8:38, 41-ийг судлаад хүмүүс бардамнал, ёс бус байдал болон ядуу, тусламж хэрэгтэй нэгнийг үл тоосноос болж ямар үр дагавартай тулгарахыг тодорхойл.



4. Мормон 8:36–41-ээс ямар зарчим сурснаа судар судлах тэмдэглэлдээ тоймлон бич.

Эдгээр шүлгүүдэд заагдсан зарчмын нэг жишээ бол: **Гачигдалтай болон тусламж хэрэгтэй нэгэнд хэрхэн хандсанаар маань Бурхан бидэнтэй хариуцлага тооцох болно** гэсэн зарчим юм.



5. Дараах асуултад судар судлах тэмдэглэлдээ хариулж бич: Танай сургууль эсвэл нийгмийн өсвөр үеийнхний дунд хамгийн нийтлэг байдаг ямар ямар материаллаг, нийгмийн, сэтгэл санааны болон сүнслэг хэрэгцээнүүд байна вэ? Ирэх долоо хоногт тусламж хэрэгтэй нэгэнд тусалж болох зүйлийнхээ тухай бод. Энэхүү зорилгоо судар судлах тэмдэглэлдээ бич.

Сурсан зүйлсээ хэрэгжүүлэх зорилго тавих нь

Сурсан зүйлсээ хэрэгжүүлэх зорилго тавих нь итгэлээрээ үйлдэх, судалсан зүйлүүдээ илүү сайн сурах мөн сүнслэгээр өсөхөд тусалдаг. Зорилго тавихдаа Ариун Сүнсний удирдамжийг эрэлхийл. Зорилгууд тань хичээл зүтгэл шаардсан боловч бодитой мөн гүйцэтгэх боломжтой байх хэрэгтэйг санаарай. Та яг юу хийхээ, хэзээ, хэрхэн хийхээр төвлөж байгаагаа бич.



6. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Мормон 8:12–41-р шүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

29-Р ХЭСЭГ: 2 ДАХЬ ӨДӨР

Мормон 9

Оршил

Моронай Есүс Христэд итгэдэггүй тэднийг наманчлалаар дамжуулан Бурханд ирэхийг дуудсанаар эцгийнхээ бичээсийг дуусгажээ. Тэрээр Бурхан бол өөрчлөгддөггүй, гайхамшгийн Бурхан гэж заасан. Хүмүүс зөвхөн итгэхээ болих үед гайхамшгууд зогсдог гэдгийг тэрээр мөн заав. Тэрээр бүх хүн төрөлхтнийг хэрэгцээт зүйлсээ хүлээн авахын төлөө Есүс Христийн нэрээр Эцэгт хандан залбирахыг урамшуулав.

Мормон 9:1–6

Моронай Есүс Христэд итгэдэггүй тэдгээрийг наманчлахыг уриалан дуудсан нь

Хэрэв та өнөөдөр Бурханы оршихуйд орох гэж байсан бол юу мэдэрч мөн бодох байснаа төсөөл. Ёс бус хүмүүс Түүний оршихуйд юу мэдрэх байх гэж та бодож байна вэ? Мормон 9:1–5-ыг уншаад Есүс Христэд итгэхгүй байхаар сонгосон хүмүүс эцэстээ Бурханы оршихуйд аваачигдах үед юу болно гэж Моронай тодорхойлсныг анзаар.

Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит гэм нүглээ наманчлаагүй ч Бурханы оршихуйд амар тайван байх болно гэж ташаа ойлгодог хүмүүс олон байдаг хэмээн тайлбарласан.




“Наманчлалгүйгээр аврал байх боломжгүй. Хүн нүгэлтэйгээ Бурханы хаант улсад орж чадахгүй. Хүн нүгэлтэйгээ Эцэгийн оршихуйд ирж, Бурханы оршихуйд амьдарна гэдэг нь зүйд нийцэшгүй зүйл байх болно. . . .

“Би энэ дэлхий дээр маш олон хүмүүс, тэдний магадгүй олонх нь, наанадаж сүмд байдаг зарим нь энэ амьдралынхаа турш өөрсөдөө таатай зүйлсийг хийж, Их Эзэний зарлигуудыг зөрчсөн ч яваандаа тэд Түүний оршихуйд орох болно гэсэн бодолтой байдаг гэж боддог. Тэд магадгүй сүнсний дэлхийд наманчилна гэж боддог.


“Тэд Моронайн эдгээр үгсийг унших хэрэгтэй: Тэмээ ухамсарласнаар та нар түүнтэй [Христ] цуг орших болно хэмээн та нар бодно уу? Та нарын

бодгаль та нар Түүний хуулиудыг үргэлж зөрчдөг байсан тэрхүү гэмийнхээ ухамсартайгаар тарчилж байхад, та нар тэрхүү ариун Нэгэнтэй хамт оршихдоо аз жаргалтай байж чадна гэж та нар бодно уу?

“Болгоогтун, би та нарт хэлнэ, та нар Түүний өмнө бузар булайн ухамсартайгаар, ариун бөгөөд шударга Бурхантай хамт орших нь, та нар тамд яллагдсан бодгалиудтай оршсоноос илүү зовлонтой байх болно. Учир нь болгоогтун, та нар Бурханы, мөн түүнчлэн Бурханы алдар суу, мөн Есүс Христийн ариун байдлын өмнө өөрсдийн нүцгэн байдлыг үзэхээр авчрагдах үед, энэ нь та нарын дээр унтаршгүй галын дөл асаах болно” [Мормон 9:3–5] (Doctrines of Salvation, comp. Bruce R. McConkie, 3 vols. [1954–1956], 2:195–196).

 **1.** Дараах асуултад судар судлах тэмдэглэлдээ хариулж бич: Ирэх амьдралд наманчилж болно гэж итгээд энэ амьдралд наманчлахыг хойшлуулах нь яагаад буруу гэж та бодож байна вэ? (Та хариулахдаа Мормон 9:1–5; Алма 12:14; болон Алма 34:32–34-өөс сурсан зүйлсээ ашиглаж болно.)

Мормон 9:6-г уншаад “үл итгэдэг” тэд Моронайн дүрсэлсэн тарчлалаас сэрэмжлэхийн тулд юу хийх ёстойг ол. Мормон 9:6 дахь Бурхан руу эргэж, Түүнээс өршөөлийг гуйх тэдний нөхцөл байдлыг дүрсэлсэн үгсийг тэмдэглэж болно. Энэ эшлэлээс бид дараах зарчмыг сурдаг: **Хэрэв бид наманчилж мөн Бурханы нэрийг дуудвал, Түүний оршихуйд орох үед бид толбогүй байх болно.** Энэ зарчмыг та судартаа эсвэл судар судлах тэмдэглэлдээ бичих хэрэгтэй.

 **2.** Та Аврагчийн Цагаатгалаар дамжуулан ариусгагдаж, толбогүй болсноо мэдсэн бол Бурханы оршихуйд юу мэдрэх байсан тухайгаа төсөөлсөн хэдэн өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ бич.

Наманчлал болон зөв шударга амьдралаар дамжуулан та Бурханы оршихуйд амар тайван байхдаа бэлтгэж чадна. Бурхантай уулзахад одооноос бэлтгэх хамгийн чухал гэж мэдрэсэн зүйлээ тунгаан бод.

Мормон 9:7–20

Моронай Бурхан гайхамшгуудыг гүйцэтгэдэг ба итгэлтнүүдийн залбиралд хариулдгийг тунхаглав


Та ямар нэг гайхамшгийг үзэж эсвэл биеэр амсаж байсан уу? *Гайхамшиг* гэдэг үгийг өөрийн үгээр тодорхойлж бич: _____

Судруудын удирдамжаас эсвэл Библийн толь бичгээс *гайхамшиг* гэдэг үгийг олж тодруул эсвэл өөрийн



тодорхойлолт дээр нэм. Яагаад одоогийн зарим хүмүүс гайхамшигт итгэдэггүй гэж та бодож байна?

Мормон 9:7–8, бичигдсэний дагуу, Моронай Бурхан амьд, илчлэлтүүдийг өгдөг, Тэрээр итгэлтнүүдийн дээр бэлгүүдийг цутгадаг гэдгийг эцсийн өдөр үгүйсгэх тэдэнд хандан бичсэн. Моронай Бурхан байдаг ба Тэрээр “өчигдөр, өнөөдөр, мөн үүрд” адил гэдгийг хүчтэйгээр заасан (Мормон 9:9). Тэрээр бүх насны итгэлтэй хүмүүсийн дунд гайхамшгийг үргэлжлүүлэн үйлдсээр байгаа. Мормон 9:9–11, 15–19-ийг уншаад Моронай Бурхан гайхамшгуудыг үйлдсээр байгаа гэдэгт итгэхэд нь хүмүүст туслахын тулд Бурханы мөн чанарын талаар юу гэж заасныг тодорхойл.

 **3.** Мормон 9:9–11, 15–19-өөс Бурханы мөн чанарын тухай юу сурснаа судар судлах тэмдэглэлдээ бич. Мөн энэхүү асуултад хариулж бич: Өнөө үеийн хүмүүсийн амьдралд гайхамшгуудыг үйлдэх Бурханы хүсэл болон чадварын талаар эдгээр шүлгүүд нь танд юу зааж байна вэ?


Мормон 9:20-ийг уншаад яагаад зарим хүмүүст гайхамшиг тохиолддоггүй шалтгаануудыг ол.

Мормон 9:9–19-д бичигдсэн Моронайн үгс нь дараах зарчмыг заадаг: **Бурхан өөрчлөгдөшгүй учраас Өөрийн хүүхдүүдийн итгэлээр дамжуулан гайхамшгуудыг тохиолгодог.** Та энэ зарчмыг судартаа Мормон 9:19–20-ийн хажууд бичих хэрэгтэй.

Бид амьдралдаа маш олон арга замаар Бурханы гайхамшигт хүчийг харж чадна. Судрууд дээр дүрслэгдсэн зарим агуу гайхамшгуудыг тунгаасны дараа Хүүхдийн хэсгийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлд үйлчилж байсан Сидни С.Рэйнолдс эгч ийн заасан:

“Эдгээр ‘агуу гайхамшгууд’ чухлын адил бид бүгдэд Их Эзэнд итгэх итгэлтэй байхыг заадаг ‘хувийн жижиг гайхамшгууд’ ч гэсэн чухал юм. Эдгээр нь бид амьдралдаа Сүнсний өдөөлтийг таньж, дагаснаар ирдэг. . . .

“Бид бүгд эдгээр жижиг гайхамшгуудыг гэрчилж чадна гэдэгт би итгэдэг. Бид хүүхдүүд алдсан зүйлээ олоход туслахыг гуйн залбираад мөн олдгийг мэднэ. Бурханы гэрчлэгч болон зогсож, Түүний тусламжийг мэдрэх зоригийг хүсдэг өсвөр үеийнхнийг бид мэднэ. Сүүлчийн мөнгөнөөсөө аравны нэгээ төлж, дараа нь гайхамшгаар дамжуулан сургалтын төлбөр, түрээс эсвэл гэр бүлийнхээ хоол хүнсний цуглуулах мөнгөтэй болсон найз нөхдийг бид мэднэ. Бид залбирлынхаа хариултыг хүлээн авсан, урам зориг, амар амгалан авчирсан эсвэл эрүүл мэндээр адисалсан санваарын адислалуудын талаар туршлагауудаа хуваалцаж чадна. Эдгээр өдөр тутмын гайхамшгууд нь бидний амьдрал дахь Их Эзэний нөлөөг бидэнд мэдрүүлдэг” (“A God of Miracles,” *Ensign*, 2001 оны 5-р сар, 12).

 **4.** Өөртөө эсвэл таны мэдэх хэн нэгэнд тохиолдсон Бурхан өнөөдөр ч гэсэн гайхамшгуудын Бурхан хэвээр байгаа гэдгийг нотолсон туршлагыг судар судлах тэмдэглэл дээ бич.

Мормон 9:21–37


Моронай залбирал болон Нифай үндэстний бичээсийн зорилгын талаар заасан нь

Таныг залбирсан учраас танд хэрэгтэй тусламжийг Тэнгэрлэг Эцэг өгсөн үеийг та санаж байна уу? Мормон 9:21-ийг уншаад Тэнгэрлэг Эцэгт хандан тусламж эрэлхийлэн залбирах тухай Моронай юу гэж заасныг ол.


Дараах тодорхойлолтыг уншаад Христийн нэрээр залбирна гэдэг нь ямар утгатай болохыг ол: “Бидний оюун санаа Христийн оюун санаа байж, Түүний үгс бидний дотор оршиж, бидний хүсэл Христийн хүсэл байхад бид Христийн нэрээр залбирдаг (Иохан 15:7). Дараа нь бид Бурханы өгөх боломжтой зүйлсийг гуйдаг. Христийн нэрэн дээр биш учраас олон залбирлууд хариулагдахгүй үлддэг. Тэдгээр нь түүний оюун санааг огт төлөөлдөггүй бөгөөд хүмүүний зүрхний аминч байдлыг илэрхийлдэг” (Библийн толь бичиг, “Залбирал”).

Уншсан зүйл дээрээ тулгуурлан хувийн залбирлаа тунгаан бод. Есүс Христийн нэрээр илүү бүрэн дүүрэн залбирахын тулд та юу хийж чадах вэ?

Моронай Аврагчид итгэсэн мөн гайхамшгуудыг үйлдсэн хүмүүсийн жишээг хуваалцахын тулд Есүс Христ Өөрийн Нифай шавь нартаа заасан зүйлсээ эш татсан. Мормон 9:22–25-д бичигдсэний дагуу Аврагч Өөрийн шавь нарт бүх газар дэлхийгээр явж сайн мэдээг тунхаглахыг зарлигласан бөгөөд гайхалтай “тэмдгүүд итгэдэг тэднийг дагалдах болно” (Мормон 9:24) гэж амласан. Тэгээд Моронай залбирлын талаар үргэлжлүүлэн заасан.

 **5.** Мормон 9:27–29-ийг уншаад бид хэрхэн итгэлээр залбирах тухай Моронай юу заасныг тодорхойл. Тодорхойлсон зүйлсээ судар судлах тэмдэглэлдээ бич. Тэгээд өөрийн залбирлыг сайжруулахдаа эдгээр заасан зүйлсийн нэгийг хэрхэн ашиглаж болохыг тайлбарласан хэдэн өгүүлбэр бич.

Та дараах зарчмыг судартаа Мормон 9:27-гийн хажууд бичих хэрэгтэй: **Хэрэв бид Есүс Христийн нэрээр Тэнгэрлэг Эцэгт хандан итгэлтэйгээр**



залбирах юм бол Тэр бидний авралыг боломжтой болоход туслах адислалуудыг өгөх болно.

Моронай үгсээ төгсгөхдөө эцсийн өдрүүдэд Мормоны Номыг төгс бус хүмүүс бичсэний улмаас зарим хүмүүс үүнийг үгүйсгэх болно гэдэгт санаа зовж буйгаа илэрхийлсэн (Мормон 9:30–34-ийг үзнэ үү). Мормон 9:35–37-г уншаад Мормоны Номын зорилгуудын тухай Моронай юу гэж тунхагласныг ол.

Мормоны Ном урагш гарч ирэх нь хэрхэн Бурхан бол гайхамшгуудын Бурхан, Тэрээр залбирлуудад хариулдаг гэдэгт нэмэлт баталгаа болж буйг тунгаан бод.



6. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Мормон 9-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

Ифер

НОМЫН ОРШИЛ

Яагаад энэ номыг судлах хэрэгтэй вэ?

Та Иферийн номыг судлахдаа Лихайн хүмүүс ирэхээс хэдэн зууны өмнө бөмбөрцгийн баруун хагас руу явж амьдарч байсан бүлэг хүмүүс буюу жаредчуудын тухай сурах болно. Энэхүү ном нь залбирал, илчлэлт, Есүс Христэд итгэх итгэлээ үйлдэл болгох болон сүнслэг мэдлэгийг хүлээж авах хоёрын хоорондох харилцааны тухай чухал зарчмуудыг сурахад тань туслах болно. Түүнчлэн бошиглогчдын хүмүүст наманчлахыг ухуулах үүрэг мөн Есүс Христ болон Түүний бошиглогчдыг эсэргүүцдэг хүмүүст ирдэг үр дагаврыг ойлгоход тань туслах болно.

Энэ номыг хэн бичсэн бэ?

Моронай Иферийн ялтсууд хэмээн нэрлэгдсэн 24 алтан ялтсаас энэхүү номыг хураангуйлсан. Энэ нь жаредчуудын түүхийн цэдгийг бүтээсэн, тэдний сүүлчийн бошиглогч Иферийн нэрээр нэрлэгдсэн (Ифер 15:33–34-ийг үзнэ үү). Мозая хааны өдрүүдэд Лимхайн зарим хүмүүс Зарахемлагийн нутгийг хайж байхдаа Иферийн ялтсуудыг олсон (Мозая 8:7–11; Ифер 1:2-ыг үзнэ үү). Нифай үндэсний бошиглогч, цэдэг хөтлөгчид Иферийн ялтсуудыг Моронайн эзэмшилд ирэх хүртэл доош дамжуулжээ. Моронай хураангуйлалдаа “зууны нэгийг нь ч” багтаагаагүй гэдгээ хэлжээ (Ифер 15:33).

Энэ ном хаана, хэзээ бичигдсэн бэ?

Иферийн номыг бүтээхэд ашигласан эх сурвалж нь Моронай хураангуйллаа хийхээс олон зууны өмнө бичигджээ. Жаредчуудын цэдэг хүмүүс нь далайг гатлахаас өмнө Жаредын ах хүлээн авсан үзэгдлээ бичихэд анх бүтээгджээ (Ифер 4:1-ийг үзнэ үү). Иферийг хүртэл жаредчуудын дунд ямар ч цэдэг хөтлөгч дурдагдаагүй (Ифер 13:3; 15:33). Моронай Иферийн номыг хураангуйлав (Мормон 8:3–6; Моронай 10:1-ийг үзнэ үү). Хэдийгээр Моронай хураангуйллыг хийхдээ хаана байснаа бичээгүй ч жаредчууд “хойд зүгийн энэ нутагт” (Ифер 1:1) устгагдсан гэж бичсэн нь тэрээр тэдний устгагдсан тэрхүү газарт байсан байх магадлалтайг харуулж байна.

29-Р ХЭСЭГ: 3 ДАХЬ ӨДӨР

Ифер 1–2

Оршил

Иферийн ном нь жаредчуудын түүхийг өгүүлэх Моронайн хураангуйлал юм. Жаредчууд бол Лихайн хүмүүсээс хэдэн зууны өмнө бөмбөрцгийн баруун хагаст ирсэн хүмүүс юм. Ноагийн өдрүүд дэх үерийн дараа өршөөгдсөн хүмүүсийн үр удмаас олон нь ёсон бус болсон билээ. Нэг бүлэг хүмүүс “тэнгэрт тулам оройтой” цамхаг барихаар оролджээ (Эхлэл 11:4). Жаред үндэстний цэдэг Бабелын цамхаг барих үеэс эхэлжээ. Их Эзэн хүмүүсийн хэлийг будлиулж, дэлхийн бүх гадаргуу дээгүүр хүмүүсийг тарааснаар өргөн тархсан ёсон бус байдалд нь хариу өгөв (Эхлэл 11:5–8; Ифер 1:33-ыг үзнэ үү). Иферийн номон дахь энэхүү цэдэг нь Их Эзэн Бабелын цамхагт хүмүүсийн хэлийг будлиулах үед Жаред болон түүний ах Түүний тусламжийг эрэлхийлснээр эхэлдэг. Их Эзэн Жаред, түүний ах, тэдний гэр бүл болон найзуудын хэлийг будлиулаагүй бөгөөд амлагдсан нутгийн зүг аглаг буйд дундуур тэднийг удирджээ. Дараа нь Их Эзэн Жаредын ахад өөрийн хүмүүсийг далай дээгүүр авч явах найман хөлөг барихыг зааварлав.



Ифер 1:1–33

Моронай Иферийн удмын бичгийг Бабелын цамхаг дахь Жаредыг хүртэл цэдэглэв

Иферийн ном хаанаас гаралтайг ойлгохын тулд 12-р хэсэг: 1 дэх өдрийн хичээлээс (116-р хуудас) “Мозая 7–24-ийн тоймыг” үзнэ үү. 4 дэх аяллыг үзэж, Лимхайн хүмүүс энэхүү аяллынхаа үеэр юу олсныг анзаар.

Иферийн номын эхлэлийг хараад гарчгийн дор байрлах номын товч тайлбарыг ол. Энэхүү тайлбар нь жаредчуудын цэдгийг Лимхайн хүмүүсийн олсон 24 алтан ялтсаас авсан болохыг тайлбарладаг.

Моронай эцгийнхээ цэдгийг дуусгасны дараа тэр Мормоны Номонд хавсаргахаар жаредчуудын цэдгийг богино болгон хураангуйлав. Ифер 1:1–4-ийг уншаад Моронай жаредчуудын цэдгийн хураангуйлалдаа юу багтаагаагүйг ол. Дараа нь Ифер 1:5-ыг уншаад цэдгийн ямар хэсгийг Моронай өөрийн бичээст оруулсныг ол. Ифер 1:5-д гардаг цамхаг нь Бабелын цамхаг юм. Ифер 1:33-д тайлбарласнаар Их Эзэн цамхаг барихыг оролдсон хүмүүсийн хэлийг тэд бие биенээ ойлгохгүй байж болохын тулд “будлиулсан” (бусниулсан эсвэл ойлгомжгүй болгосон) бөгөөд тэднийг дэлхийн гадаргуугаар тараажээ.

Ифер 1:6–33-т цэдэглэснээр Ифер нэртэй эр жаредчуудын цэдгийг хөтөлжээ. Моронай Иферийн гарал үүслийн бүртгэлийг Бабелын цамхагийн үед амьдарч байсан Жаред нэртэй эрийг хүртэл бүртгэв.

Ифер 1:33–43

Жаредын ах тусламж хүсэн залбирч, түүний гэр бүл, найз нөхөд нигүүлсэл болон удирдамжийг хүлээн авав

Та урьд нь хүмүүс нь таны мэдэхгүй хэлээр ярьдаг улс эсвэл газарт очиж байсан уу? Эргэн тойрон дахь хүмүүсийнхээ ярьж байгаа хэлийг ойлгохгүй байх нь танд ямар санагдах вэ? Та тийм нөхцөл байдалд цөөхөн хэдэн хүнтэй л харилцах боломжтой байвал хэнийг сонгох вэ? Ийм нөхцөл байдал Бабелын цамхагийн үед амьдарч байсан Жаред гэгдэх эр, түүний ах болон гэр бүлийнхэнд нь тулгарсан юм. Ифер 1:33–37-г уншаад Жаредын харилцахыг хүссэн хүмүүсийг ол. Жаредын ах Их Эзэнээс тэдний хэл будиулагдахгүй байх болно гэсэн амлалтыг хүлээж авсныхаа дараа (Ифер 1:34–35-ыг үзнэ үү) тэрээр найзуудынхаа төлөө залбирав (Ифер 1:36–37-г үзнэ үү). Жаредын ахын үзүүлсний дагуу итгэлтэй хүмүүсийн нэг шинж бол Их Эзэний адислалуудыг хүлээж аваасай хэмээн найзуудынхаа төлөө залбирах явдал юм.

Их Эзэн Жаред болон түүний ах, тэдний гэр бүл, найз нөхдийнх нь хэл будиулагдахгүй байхаар адислав. Дараа нь Жаред ахыгаа Бурханд хандан залбирч, тэдний гэр бүл хаашаа явах хэрэгтэйг асуухыг хүсэв. (Ифер 1:38–40-ийг үзнэ үү.)

Ифер 1:40–43-ыг уншаад жаредчуудад аянаа удирдахад нь зориулж өгсөн Их Эзэний зааврыг тодорхойл. Жаред болон түүний ах Их Эзэнээс ирсэн эдгээр удирдамжуудыг дагах нь яагаад чухал байсан гэж та бодож байна вэ?

Ифер 2:1–12

Жаредчууд амлагдсан нутаг руу аянаа эхлэв

Ифер 2:1–3-ыг уншаад жаредчууд амлагдсан нутаг руу аялах тухай Их Эзэний өгсөн удирдамжийг хэр сайн дагасныг олж мэд (Ифер 1:41–42-ыг үзнэ үү). Тэгээд Ифер 2:4–6-г уншаад дараа нь юу тохиолдсоныг ол. Жаредчууд Их Эзэний удирдамжийг дуулгавартай дагасан болохоор Тэр тэдэнд цаашдын зааврыг өгсөн болохыг анзаар. Их Эзэний зарлигуудад дуулгавартай байсныхаа улмаас жаредчуудын хүлээж авсан удирдамж, адислалуудын талаар тунгаан бод.

Жаредчуудын туршлагаас бид дараах зарчмыг сурдаг: **Их Эзэний бидэнд өгсөн зааврын дагуу итгэлтэй үйлдсэнээр бид Түүнээс цаашдын зааврыг хүлээн авч чадна.** Та энэхүү зарчмыг судартаа Ифер 2:6-гийн хажууд бичих хэрэгтэй.

Та залбирч, судраас суралцаж эсвэл сүмийн цуглаанд оролцож байхдаа Их Эзэнээс хүлээж авсан сүнслэг нөлөөлөл эсвэл мэдрэмжээ санаж байна уу? Бид залбирлуудынхаа хариултыг хэр ойрхон хүлээж авдаг талаар Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Ричард Г. Скоттын хэлсэн дараах үгсийг уншихдаа тэрхүү сүнслэг нөлөөлөл эсвэл мэдрэмжээ дотроо санаж байгаарай: “Ховорхон тохиолдолд та [залбирлынхаа] бүрэн хариултыг нэгэн зэрэг хүлээж авах болно. Энэ нь бага багаар багц байдлаар ирэх бөгөөд ингэснээр та ур чадвартаа өсөх болно. Хэсэг бүрийг итгэлээр дагаснаар бүрэн хариултыг автлаа та бусад хэсгүүд рүү хөтлөгдөнө. Энэхүү загвар нь танаас Эцэгийн хариулах чадварт итгэх итгэлээ үйлдэл болгохыг шаарддаг. Заримдаа энэ нь үнэхээр хэцүү байх боловч хувийн өсөлт хөгжлийн үнэлэшгүй үр дүн болдог. (“Using the Supernal Gift of Prayer,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2007 оны 5-р сар, 9).



1. Түрүүн бодсон сүнслэг нөлөөлөлдөө хэрхэн хандсан (эсвэл хандаж болох) тухайгаа судар судлах тэмдэглэлдээ бич. Тэрхүү сүнслэг нөлөөллөө дагаснаар хүлээж авсан (эсвэл авч болох) адислалуудаа багтааж болно.

Ифер 2:7–12-т цэдэглэснээр Жаредын ах болон түүний гэр бүл амлагдсан нутагт ирээд “өөрт нь, үнэн бөгөөд цорын ганц Бурханд үйлчлэх хэрэгтэй, эс бөгөөс тэд арчигдах болно” хэмээн Их Эзэн Жаредын ахад хэлжээ (Ифер 2:8).

Ифер 2:13–15

Их Эзэн Өөрт нь хандан залбираагүйн улмаас Жаредын ахыг зэмлэв

Ифер 2:13–15-ыг уншаад газруудыг хуваасан их тэнгисийн дэргэд жаредчуудыг ирэхэд юу тохиолдсоныг ол. Тэд Их Эзэнийг сонсож, Түүний зарлигуудыг

дагаж байсан болохоор тэд аглаг буйдад Их Эзэнээр удирдагдан явсан юм. Гэсэн хэдий ч тэд их тэнгисийн дэргэд дөрвөн жилийн турш буудалласны дараа Их Эзэн Жаредын ах дээр ирж, залбираагүйнх нь төлөө түүнийг зэмлэв.

Ифер 2:14–15 нь эдгээр зарчмуудыг сурахад тусалдаг: **Биднийг Их Эзэнд хандан залбирахгүй байх нь Түүнд таатай байдаггүй. Их Эзэн биднийг Түүнд хандан тогтмол залбирдаг байгаасай гэж хүсдэг.**

Далын гишүүнээр үйлчилж байсан ахлагч Доналд Л. Стахэлигийн хэлсэн дараах үгсийг уншихдаа та хэр олон залбирдаг тухайгаа бодоорой: “Өршөөл, онцгой тусламж, удирдамж эрэлхийлсэн өдөр тутмын чин сэтгэлийн залбирлууд нь бидний амьдралд нэн чухал бөгөөд гэрчлэлийн маань тэжээл болдог. Бид залбирахдаа яарсан, давталттай, хайхрамжгүй, мартамхай болох үедээ өдөр тутмын амьдралын сорилт бэрхшээлүүдийг амжилттай даван гарахад бидэнд хэрэг болох байнгын чиглүүлэлд нэн чухал Сүнсний дотно байдлаа алддаг (“Securing Our Testimonies” *Ensign* эсвэл *Лиахона*, 2004 оны 11-р сар, 39).

Дараах асуултуудад хувийн тэмдэглэлдээ эсвэл тусдаа цаасан дээр хариулж бич:

- Та хувийн залбирлынхаа давтамжийн талаар ямар бодолтой байна вэ?
- Хувийн залбирал тань чин сэтгэлийн байгаа эсэх талаар та юу гэж бодож байна вэ?
- Та хувийн залбиралдаа Тэнгэрлэг Эцэгтэйгээ үнэн сэтгэлээсээ харилцаж байгаагаа мэдэрдэг үү? Яагаад эсвэл яагаад үгүй гэж?
- Хэрвээ та хувийн залбирлаа сайжруулахын тулд нэг зүйл өөрчилье гэвэл юуг өөрчлөх вэ?

Ифер 2:16-д цэдэглэсэнээр Жаредын ах нүглүүдээ наманчилж, гэр бүлийн гишүүд болон найз нөхдийнхөө төлөө Их Эзэнд хандан залбирав. Их Эзэн түүнийг уучилсан боловч амлагдсан нутаг руу удирдуулахын тулд зөв шударга байдалд үргэлжлүүлэх ёстой хэмээв.

Ифер 2:16–25


Жаредчууд далайг гатлан амлагдсан нутаг руу аялахаар хөлөг онгоц хийв

Гэр бүл, нийгмийн хэцүү нөхцөл байдалтай хэрхэн харилцах, хэрхэн сайн сурах, хэнтэй гэрлэх эсвэл ямар мэргэжлээр сурах зэрэг танд тулгарч байгаа эсвэл ирээдүйд тулгарч болох хувийн чухал шийдвэрийн талаар бод. Их Эзэн танд хэрхэн удирдамж өгөх эсвэл тухайн нөхцөл байдалд тусалж болох тухай та бодож байсан уу? Ифер 2-ын үлдсэн хэсгийг



судлахдаа тодорхойлсон шийдвэрийнхээ талаар тунгаан бодож, Их Эзэний тусламжийг хүлээн авахад туслах зарчмуудыг ол.

Ифер 2:16–17-г уншаад амлагдсан нутаг руу урагшлахын тулд юу хийхийг Их Эзэн жаредчуудаас хүссэнийг ол. Жаредын ах хөлөг онгоцны загвар хийцээс шалтгаалсан гурван асуудалтай тулгарав. Ифер 2:18–19-ийг уншаад Жаредын ахын Их Эзэнд хэлсэн гурван асуудлыг олж тэмдэглэ.

 **2.** Ифер 2:16–19-д уншсан зүйлсээ дүрслэн харахын тулд судар судлах тэмдэглэлдээ таны бодлоор хөлгүүд ямархуу харагдаж байсныг зур.

Дараах хүснэгт нь хөлөгтэй холбоотой асуудлуудад Их Эзэн Жаредын ахад хэрхэн тусалсныг олоход тань туслах болно. Хүснэгт дэх судрын эшлэлүүдийг судлаад мэдээллийг “Асуудлын шийдвэр” гэсэн баганыг бөглөхөд ашигла.

Дүрслэн харах

Та сударт гарч байгаа зүйлсийг оюун санаандаа дүрслэх үед энэ нь эдгээр үйл явдлуудыг илүү бодитой, ойлгомжтой болгоход тусалдаг. Дүрслэн бодох нь судар дахь хүмүүс болон нөхцөл байдалд илүү ойр холбогдоход тань туслах бөгөөд үр дүнд нь юу болж байгааг ойлгоход, илүү үр дүнтэйгээр судлахад тус болно.

Судрын эшлэлүүд	Хөлөг онгоцонд гарсан асуудал	Асуудлын шийдвэр
Ифер 2:20–21	Агааргүй	
Ифер 6:4–9	Залуургүй	
Ифер 2:22–3:6	Гэрэл байхгүй	


Их Эзэний хийсэн зүйлс болон Жаредын ахыг хий хэмээн Их Эзэний хүссэн зүйлс нь асуудал бүрд өөр өөр байсан. Бид асуудал болон шийдвэр бүрээс бидэнд тусламж хэрэгтэй үед Их Эзэн хэрхэн тусалдаг тухай өөр өөр үнэнийг сурах боломжтой. Хүснэгтэд бичсэн шийдвэрүүдээ дараах жагсаалт дахь зүйлстэй харьцуул:

Агааргүй (Ифер 2:20–21). Энэхүү асуудлыг шийдвэрлэхийн тулд Их Эзэн Жаредын ахад юу хийх хэрэгтэйг нь хэлсэн. Жаредын ахад Их Эзэний заавруудыг дагах итгэл байсан.

Залуургүй (Ифер 6:4–9). Энэхүү асуудлыг шийдвэрлэх хариултыг Их Эзэн Өөрөө өгсөн.

Гэрэлгүй (Ифер 2:22–3:6). Энэ асуудлыг шийдвэрлэхдээ Их Эзэн Жаредын ахад хэдэн заавар өгсөн. Жаредын ах асуудлыг шийдвэрлэхийн тулд өөрт байсан мэдээлэл дээр тулгуурлан бодож, биелүүлэхийн тулд Их Эзэнээс зөвшөөрөл хүсэх хэрэгтэй болсон.

Жаредын ахын туршлагаас бид энэ зарчмыг сурдаг: **Бид өөрсдийн асуудлыг шийдвэрлэхийн тулд өөрсдийн талыг хийхээр хичээх үед бид Их Эзэний тусламжийг авч болно.** Өмнө нь бодож байсан хувийн шийдвэрийнхээ тухай бодоход энэхүү зарчмыг мэдэх нь уг шийдвэрийн талаар тусламж, удирдамж хүлээн авахад тань хэрхэн туслах вэ? Их Эзэнээс таныг өөрөө шийдвэр гаргахын тулд юу хийгээсэй гэж хүсэх байх гэж та бодож байна вэ?

 **3.** Залбирал болон амьдралдаа Их Эзэний тусламж, удирдамжийг хүлээн авах тухай Жаредын ахын туршлагаас юу сурснаа тайлбарлан судар судлах тэмдэглэлдээ богино эх бич.

 **4.** Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Ифер 1–2-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

29-Р ХЭСЭГ: 4 ДЭХ ӨДӨР

Ифер 3

Оршил

Их Эзэн Жаредын ахаас “Та нар хөлгүүд дотроо гэрэлтэй байхын тулд намайг хэрхэхийг та нар хүснэ вэ?” хэмээн асуусан. (Ифер 2:23). Жаредын ах хариулахдаа 16-н чулууг нямбайлан бэлдэж, “тэдгээр нь харанхуйд гэрэлтэж болохын тулд” тэдэнд хүрэхийг Их Эзэнээс даруухнаар залбиран гуйв (Ифер 3:4). Жаредын ах агуу итгэлийнхээ улмаас Аврагчийг чулуунуудад хүрэх үед Түүний хурууг харжээ. Их Эзэн Өөрийгөө Жаредын ахад үзүүлээд, харж мөн сонссон зүйлсээ бичихийг түүнд зарлигласан.

Ифер 3:1–20


Их Эзэн хуруугаараа чулуунуудад хүрч, жаредчуудын хөлөг онгоцыг гэрэлтүүлэх болгосон ба Өөрийгөө Жаредын ахад харуулав


Та болон бусад өсвөр үеийнхэн юуны төлөө чин сэтгэлээсээ залбирдгийг харуулах ямар жишээ байна вэ? Эдгээрээс нэгийг сонгоод, энд бич: _____

Ифер 3-аас Жаредын ахын жишээг судлахдаа Их Эзэнээс тусламж авахад танд эсвэл таны найзад тус болох зүйлсийг ол.

Хөлгүүдийг гэрэлтүүлэх талаар Жаредын ахын Их Эзэнд хандсан залбирал болон Их Эзэний хариултын талаар бодож үз. Ифер 2:22–3:1-ийг дахин судал. Гэрэлгүй байх асуудлыг шийдвэрлэхийн тулд Жаредын ах өөрийн зүгээс юу хийснийг тайлбарлах дараах зургуудад тайлбар бич.






 **1.** Хөлгүүдийг гэрэлтэй болгох асуудлыг шийдвэрлэхийн тулд Жаредын ахын гаргасан хичээл зүтгэлийн талаар таныг гайхшруулсан зүйлсийг судар судлах тэмдэглэлдээ бич. Хэдийгээр Жаредын ах маш их хичээл зүтгэл гаргасан ч Их Эзэний тусламжгүйгээр хайлуулсан чулуунууд нь гэрэл гаргахад хэр ашиг тустай байх байсныг эргэцүүлэн бод.

Ифер 3:2–5-ыг уншаад дараах зүйлсийг хий:

- Жаредын ах даруухан, Бурханаас хамааралтай гэдгээ мэддэг хүн байсан гэдгийг нь харуулах хэллэгүүдийг тодорхойлж, тэмдэглэ. “Бидний төрөлхийн чанар үргэлжид хилэнцэт байхаар болсон юм” гэдэг нь бидний дэлхий дээрх нүгэлтэй байдлыг хэлж байгааг мэдэх нь тустай байж болох юм. Адамын уналтын улмаас бид бие махбодын хувьд Бурханаас тусгаарлагдсан. Бид бас нүгэл үйлдэхдээ амархан байдаг. Бурханлаг тусламжгүйгээр бид хэзээ ч Бурханы оршихуйд эргэн очиж чадахгүй.
- Жаредын ах Их Эзэнээс юу хийхийг хүссэнийг олж тодорхойл.
- Жаредын ахын Бурханы тухай мэддэг зүйлсээ гэрчилснийг нь олох юмуу тэмдэглэ.

 **2.** Дараах асуултуудад судар судлах тэмдэглэлдээ хариулж бич:

а. Ифер 3:1–5-аас асуудлуудаа шийдвэрлэхэд нь Их Эзэн тусалж чадна хэмээх Жаредын ахын итгэлийг нотлох ямар нотлоог та олж чадах вэ?

б. Түүний жишээ Их Эзэний тусламжийг гуйхдаа Түүнээс хамааралтай гэдгээ анзаарахад тань хэрхэн тусалж болох вэ?


Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Жэффри Р.Холландын Жаредын ахын итгэлийг онцлон хэлсэн дараах үгсийг унш: “Бурхан болон үүнийг уншигч хүн энэ хүний итгэлийн хүүхэд шиг гэнэн, үнэнч байдлаас гайхалтай зүйлийг мэдэрдэг нь

гарцаагүй. ‘Болгоогтун, Ай Их Эзэн, та үүнийг хийж чадна шүү дээ’ [Ифер 3:5]. Сударт үүнээс илүү хүчтэй, итгэлийн талаар хүмүүнээр өгүүлэгдсэн нэг ч мөр байхгүй байх. . . . Бошиглогч өөрийн чадварын талаар эргэлзэж байсан мөртлөө Бурханы хүчний талаар ямар ч эргэлзээгүй байлаа” (“Rending the Veil of Unbelief,” *Nurturing Faith through the Book of Mormon: The 24th Annual Sidney B. Sperry Symposium* [1995 он], 12).

Ифер 3:6-г уншаад энэ шүлэгт тайлбарлагдсан нөхцөл байдалд орвол ямар байх байсныг төсөөл.

Ифер 3:9-ийг уншихдаа Их Эзэн яагаад чулуунуудад хүрэх хүсэлтэй байсан болон Жаредын ах яагаад Их Эзэний хурууг харж чадсаныг олж мэд.

Ифер 3-аас сурсан зүйлийнхээ дагуу дараах зарчмыг гүйцээж бич: **Бид Их Эзэнд хандан даруухнаар залбирах үед Тэр бидний _____ болон Өөрийн хүслийн дагуу хариулах болно.**

 **3.** Дараах асуултуудын аль нэгэнд эсвэл хоёуланд нь судар судлах тэмдэглэлдээ хариулж бич:

а. Энэ хичээлийн эхэнд бичсэн өөрийн эсвэл бусад өсвөр үеийнхний залбирдаг зүйлсийн тухай бод. Тийм нөхцөл байдалд байгаа хүн Их Эзэний тусламж, зөвлөгөөг эрэлхийлэхдээ Түүнд итгэх итгэлээ хэрхэн үзүүлж болох вэ?



6. Их Эзэнд хандан даруухнаар залбирахад Тэр бидний итгэл болон Өөрийн хүслийн дагуу хариулна гэдэг зарчмын үнэнийг мэдэж авахад тусалсан ямар туршлага таны амьдралд байгаа вэ?

Өөртөө хэдэн хором гарган Их Эзэнд хэр их итгэж найддагаа чимээгүйхэн дүгнэ. Ифер 3:9–12-ыг уншаад Жаредын ахын Их Эзэнд итгэх итгэлийн нотолгоог олж тэмдэглэ.

Ифер 3:11-ийг дахин судлаад бүр Их Эзэн Өөрөө илчлэхээс өмнө Түүний танд илчлэх зүйлсэд итгэж, дагахаар шийдэхэд хангалттай итгэл танд байгаа эсэх талаар бод.



Ахлагч Жэффри Р.Холландын хэлсэн үгсийг уншаад бид Жаредын ах шиг итгэлээ бодитой болгохын тулд хийх ёстой зүйлсийн доогуур зур: “Анхан шатны итгэл нь өмнөх туршлага буюу мэдсэн зүйлсээс бүрддэг бөгөөд энэ нь

итгэлийн үндэс болдог. Гэхдээ гэтэлгэх итгэл ихэнхдээ ирээдүйн буюу мэдэхгүй туршлагаудад хэрэгжих ёстой бөгөөд энэ нь гайхамшигийг бүтээх боломж олгодог. . . . Жаредын ахынх шиг итгэл нь гайхамшиг болон мэдлэгийн *суурь* болдог. Тэр Бурханыг ярихаас өмнө итгэлтэй байх шаардлагатай байсан. Тэр үйлдэл гүйцэтгэх чадвар тодорхой болохоос өмнө үйлдэх шаардлагатай байсан. Тэрээр бүрэн туршлагыг бүтэж эхлэхээс нь ч өмнө тэрийг хүлээн зөвшөөрөх шаардлагатай байсан. Бурханы ойрын болон ирээдүйд шаардаж болох нөхцөлүүдийг шаардахаас нь өмнө бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрөхийг итгэл гэнэ” (*Christ and the New Covenant: The messianic Message of the Book of Mormon* [1997 он], 18–19).

Бабелын цамхагаас эхлээд Жаредын ахад тохиолдсон зүйлсийн тухай бод. Ямар ямар туршлага нь түүний Их Эзэнд итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд тусалсан байж болох вэ? Эдгээр туршлагауд тэр мөчид “ийм үлэмж итгэлээ” (Ифер 3:9) харуулахад нь түүнд хэрхэн тусалсан бэ?



4. Дараах асуултуудад судар судлах тэмдэглэлдээ хариулж бич:

а. Таны амьдралд Их Эзэнд итгэх итгэлийг нэмэгдүүлсэн ямар туршлага тохиолдсон бэ?

б. Тэрхүү туршлага тань ирээдүйд улам илүү итгэлийг хэрэгжүүлэхэд таныг хэрхэн бэлдсэн бэ?

Ифер 3:13–20-ийг уншаад Жаредын ах итгэлийнхээ улмаас хүлээж авсан адислалыг ол. Энэ гайхалтай туршлагаас Жаредын ах Аврагчийн талаар юу сурсан бэ? Ифер 3-аас сурч болох бас нэгэн чухал зарчим бол: **Бид Их Эзэнд итгэх итгэлээ үйлдэл болгох тусам Түүнд улам ойртдог гэсэн зарчим**

юм. Та энэ зарчмыг судартаа Ифер 3:11–20-ийн хажууд бичих хэрэгтэй.

Ахлагч Жэффри Р.Холланд Ифер 3:15–16 болон тэр туршлагаас гарч болох төөрөгдлийн талаар ийн хэлжээ:

“Товчлон тайлбарлах шаардлагатай нэг асуудал бол ‘чиний нэгэн адил ийм үлэмж итгэлтэйгээр хүмүүн миний өмнө хэзээ ч ирж байсангүй; тийм бус аваас чи миний хурууг харж чадахгүй байсан’ хэмээх Их Эзэний үгээс гарч ирж байна. Мөн дараа нь ‘Мөн чиний нэгэн адилаар надад хүмүүн итгэж байсан нь үгүйн учир, өөрийн бүтээсэн хүмүүндээ, би хэзээ ч өөрийгөө үзүүлж байсан нь үгүй’ [Ифер 3:9, 15].

“Жаредын ахаас өмнө амьдарч байсан олон (эсвэл бүх) бошиглогч Бурханыг харсан гэдгийг ойлгосноор төөрөлдөх магадлал гардаг. Бид тэгээд Бурханы тунхаглалыг яаж ойлгох ёстой вэ? . . .

“Энэ асуудлаар Хожмын Үеийн Гэгээнтэн олон зохиолчид ярилцсан бөгөөд хэдэн боломжит тайлбар байгаа ба тэдний аль нь ч —эсвэл бүгд—энэхүү судрын жинхэнэ утгыг тайлбарлахад тусалж болно. Гэхдээ энэ сэдвийн талаар нэмэлт илчлэлт авалгүйгээр ямар ч таамаглал нь зүгээр л хангалтгүй, бүрэн бус таамаглал юм. . . .

“Зарим хүн Их Эзэн урьд нь хүмүүнд тэр түвшинд, тийм хэмжээгээр Өөрийгөө үзүүлж байгаагүй гэж ойлгодог. Энэ таамаглал нь эрт үеийн бошиглогчдын үзсэн бурханлаг үзүүлэлтүүд үүнтэй адилхан ‘бүрэн’ байгаагүй бөгөөд хөшиг нь Христийн төрх, байдлыг харуулах тийм хэмжээгээр авагдаагүй байсан гэж хэлдэг. . . .

“Сүүлийн бөгөөд Жаредын ахын итгэлийн хувьд хамгийн үнэмшилтэй тайлбар бол Христ Жаредын ахад ингэж хэлсэн: ‘Би өөрийгөө хүнд ийм маягаар өөрийнхөө хүслийн дагуу биш, зөвхөн болгоож буй хүний итгэлийн улмаас хэзээ ч үзүүлж байгаагүй’” Ном ёсоор бол бошиглогчид ерөнхийдөө Их Эзэний оршихуйд *уригддаг* бөгөөд зөвхөн Түүний зөвшөөрөлтэйгээр оршихуйд нь ордог байсан. Харин үүнээс ялгаатай нь Жаредын ах хүсээгүй зочны байдлаар биш харин уригдалгүйгээр өөрийгөө хөшигний цаана түлхэн оруулсан мэт санагддаг. Иехова ‘Мөн чиний нэгэн адил ийм үлэмж итгэлтэйгээр хүмүүн миний өмнө хэзээ ч ирж байсангүй; тийм бус аваас чи миний хурууг харж чадахгүй байсан. . . . Чиний нэгэн адилаар надад хүмүүн итгэж байсан нь үгүй’ хэмээн хэлжээ. Их Эзэн Өөрөө урьд өмнө байгаагүй итгэлийг урьд өмнө байгаагүй энэхүү үзэгдэлтэй холбож байсан. Үзэгдэл нь өөрөө ер бусын биш байсан бол энэ нь тэрхүү итгэл ер бусын байснаас гарцаагүй. Мөн тэр үзэгдлийг хэрхэн харсан нь ер бусын байсан. Тэр итгэл гайхалтай байх ганцхан

арга нь уригдаагүй бошиглогчийг өмнө нь зөвхөн Бурханы хүслээр хүмүүсийн очиж чадсан газарт аваачсан чадвар юм” (*Christ and the New Covenant*, 20–23).

Ифер 3:21–28

Их Эзэн Жаредын ахад харсан зүйлсээ бичихийг мөн түүнийгээ битүүмжлэн лацдахыг зарлиглав

Ифер 3:25–26-г уншаад Бурхан Жаредын ахад өөр юу үзүүлснийг тодорхойл. Ифер 3:21–24, 27–28-д бичигдсэнчлэн Их Эзэн Жаредын ахад үзэгдлээр үзсэн зүйлсээ бичиж тэднийг лацдахыг зарлигласан. Их Эзэн бас ирээдүйд Жаредын ахын бичсэн зүйлсэд орчуулагдах боломж олгохоо тайлбарласан. Энэ бошиглол биелсэн нэгэн арга зам бол бошиглогч Иосеф Смит Мормоны Номын нэг хэсэг болох алтан ялтсуудаас Иферийн номыг орчуулж жаредчуудын цэдгийг бүх хүн уншихад боломжтой болгосон явдал юм.

Өнөөдрийн сурсан зүйлсээ хэрхэн хэрэгжүүлж, Их Эзэнд итгэх итгэлээ үзүүлэхийн тулд юу хийж болохоо тунгаан бод. Есүс Христэд итгэх итгэлээ үйлдэл болгосноор Бурхан Жаредын ахад өгсөн шиг танд асар их адислалууд өгөх болно.



5. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Ифер 3-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

30-Р ХЭСЭГ: 1 ДЭХ ӨДӨР

Ифер 4–5

Оршил

Их Эзэн Жаредын ахын үзэгдлийн тухай цэдэг бичиж, лацдахыг Моронайд зарлиг болгов. Моронай эдгээр бичвэрүүд нь хүмүүс Жаредын ахынх шиг итгэлтэй болох үед илчлэгдэх болно хэмээн тайлбарлажээ. Үүнээс гадна, Моронай хожмын өдрүүдэд Мормоны Номын үнэнийг гурван гэрч гэрчлэх болно хэмээн бошиглосон байна.

Ифер 4:1–7

Моронай Жаредын ахын үзэгдлийн талаар бүрэн цэдгийг бичиж лацдав

Ялангуяа танд болон танай гэр бүлийн хувьд үнэ цэнэтэй, бага насны хүүхэд хүрэх газраас хол тавихыг хүсдэг зүйлийнхээ талаар бод. Үүнийгээ хүүхдэд найдаж өгөхөөс өмнө түүнд юуг зааж сургах хэрэгтэй вэ?

Үүний адил Их Эзэнд бидэнтэй хуваалцахыг хүсдэг үнэ цэнэтэй үнэнүүд байдаг боловч Тэрээр биднийг тэдгээр зүйлсийг хүлээн авахад бэлэн болох хүртэл хүлээдэг. Ифер 4-ийг судлахдаа Их Эзэнээс илүү агуу үнэн болон удирдамжийг хүлээн авахад бэлдэхэд тань туслах Моронайн заасан зүйлсийг ол.

Ифер 3-аас та Их Эзэн Жаредын ахад өнгөрсөн, одоо, ирээдүйд байх дэлхийн бүхий л оршин суугчид болон дэлхийн талаарх бүх зүйлсийг үзэгдлээр үзүүлснийг уншсан. Дараа нь Жаредын ахад үзсэн бүх зүйлсээ бичиж, лацдахыг зарлиглажээ. Ифер 4:4–5-ыг уншаад Жаредын ахад үзүүлсэн зүйлсийн талаарх Моронайн дүрслэлийг ол. Моронай Жаредын ахын харсан зүйлсийг болон Их Эзэний төлөвлөсөн хугацаанд гарч ирэх үзэгдлийг лацдахаар Их Эзэнээр зарлигдуулсныг бичив. Эдгээр шүлгүүдэд гардаг үзэгдэл нь Мормоны Номын лацдагдсан хэсэг хэмээн нэрлэгдсэн хэсэгт агуулагддаг.

Моронай Жаредын ахад өгөгдсөн илчлэлт мэдүүлэгдэхээс өмнө байх хэрэгтэй нөхцөл байдлын талаар бошиглов. Ифер 4:6–7 дахь эдгээр нөхцөлүүдийг тэмдэглэх хэрэгтэй.



1. “Бүр Жаредын ахын үйлдсэн лугаа адил, [Их Эзэнд] итгэх итгэлээ хэрэглэх” (Ифер 4:7) гэдэг нь ямар утгатай болохыг тунгаан бодохын тулд Ифер 1–3-ыг дахин хараад Жаредын ахын Их Эзэнд итгэх итгэл, найдвараа харуулсан арга замуудыг судар судлах тэмдэглэлдээ жагсаан бич. Эдгээр жишээнүүдээс таныг хамгийн их гайхшруулсан нэг жишээг сонгож, тодорхойлоод яагаад гэдгийг тайлбарла.

Та тодорхой болзол тавьсны дараа л үнэт зүйлээ хүүхдэд найдан үлдээдэгтэй адил бид сүнслэг бэлтгэлээ үзүүлж, Түүний урьд нь илчилсэн ариун нандин үнэнүүдэд итгэж, Түүнд итгэх итгэлээ бодит болгосноор Их Эзэн Өөрийн хүүхдүүдтэй нэмэлт үнэнүүдийг хуваалцдаг.


Ифер 4:8–19

Моронай цаашид нэмэлт илчлэлт хүлээн авахын тулд бид юу хийх ёстойг заав


Одоо байгаа өрөөнийхөө аль нэг цонхны хөшиг рүү хар. Хөшиг нь харах зүйлийг тань хэрхэн хязгаарлаж байгаа тухай бод.

Моронай бидний хүн нэг бүр хэрхэн илчлэлт хүлээж авахад нөлөөлдөг зарчмын талаар заахдаа цонхны хөшигтэй төстэй гивлүүрийн бэлгэдлийг ашиглажээ. Ифер 4:15-ыг уншаад *гивлүүр гэсэн үгийг багтаасан хэллэгийг ол*. Моронай итгэлгүй байдлыг гивлүүртэй харьцуулсныг анзаар. Итгэлгүй байдал нь ямар талаараа гивлүүртэй төстэй вэ? _____

Ифер 4:15-р шүлэгт гардаг тас татах гэдэг үг нь ураг гэсэн утгатай болохыг ойлгох нь тустай байж болох юм. Их Эзэн та хоёрын хооронд байгаа тэрхүү гивлүүрийг тас татвал ямар байхыг төсөөлөн бод.



Моронай “итгэлгүй байдлын гивлүүрийг тас татахад” туслах, нэмэлт илчлэлтүүдийг хүлээн авах боломж олгох зүйлсийг тайлбарласан. Тэрээр нэмэлт илчлэлт хүлээн авахад маань саад болдог хандлагын талаарх сэрэмжлүүлгээр эхлэв. Ифер 4:8-ыг уншаад Их Эзэн илчлэлтээ өгөхгүй байх, “илүү агуу зүйлийг үзүүлэхгүй” байх шалтгаануудыг олж тэмдэглэ.


 **2.** Дараах асуултуудад судар судлах тэмдэглэлдээ хариулж бич:

- а.** “Их Эзэний үгийн эсрэг мэтгэлцэх” гэсэн нь ямар утгатай гэж та нар бодож байна вэ? (Ифер 4:8).
- б.** Өнөө үед залуу хүн “Их Эзэний үгийн эсрэг мэтгэлцэж” болох ямар замууд байна вэ?


Моронай Их Эзэнээс хэрхэн нэмэлт илчлэлтүүдийг хүлээн авахыг тайлбарлахдаа Их Эзэний Өөрийнх нь үгсийг оруулав. Ифер 4:11, 13–15-ыг судлаад Их Эзэний илчлэлтийг урихын тулд бид юу хийх ёстой болон хэрэв бид эдгээр зүйлсийг хийвэл Тэр хэрхэн хариулахыг заасан хэллэгүүдийг олж тэмдэглэ.

Эдгээр шүлгүүдээс та илчлэлтийн талаар ямар зарчмууд болон үүнийг амьдралдаа хэрхэн урих талаар сурсан бэ? Эдгээр шүлгүүдээс сурсан нэг зарчмаа судартаа Ифер 4:11-ийн хажууд бичиж болно.

Их Эзэний зөвлөгөөнөөс бидний сурч болох нэгэн чухал зарчим бол **бид Их Эзэний үгсэд итгэх агуу итгэлийг үзүүлбэл Тэр Өөрийн цаг хугацаа, арга замаар биднийг нэмэлт илчлэлтээр адислах болно.**

 **3.** Их Эзэн танд илүү ихийг илчлэхээс өмнө урьд нь хүлээж авсан Бурханы үгсэд итгэх итгэлээ яагаад үзүүлэх хэрэгтэй гэж бодож байгаагаа судар судлах тэмдэглэлдээ тайлбарлаж бич. Дараах хэсгүүд дээр Их Эзэний үгсийг дагахыг эрэлхийлснээр Түүнд итгэх итгэлээ хэр сайн үзүүлж байгаагаа 1-10-ын хооронд (10 нь “маш үр дүнтэй”) тоо сонгон дүгнэ:

- а.** Өдөр тутмын залбирал
- б.** Ариун Сүнсээр дамжуулан хүлээн авсан сүнслэг нөлөөллүүдийг дагах
- в.** Салбар, тойрог, дүүрэг эсвэл гадасныхаа удирдагчдыг дэмжин баталж, дагах
- г.** Сүмд эсвэл семинарт Бурханы үгсийг судлах
- д.** Бие даан судар судлах
- е.** Бошиглогчдын үгсийг дагаж, зарлигуудын дагуу амьдрах

 **4.** Дээр дурдсан зүйлсийн нэгэн дээр Бурханд дуулгавартай байх нь Их Эзэнээс нэмэлт илчлэлтийг хүлээж авахыг таны хувьд хэрхэн боломжтой болгосныг судар судлах тэмдэглэлдээ тайлбарлан бич.

Их Эзэний нэмэлт илчлэлт, удирдамжийг урих хичээл зүтгэлдээ Түүний үгсэд итгэх итгэлээ бодит болгох энэхүү зарчмыг хэрхэн хэрэгжүүлэхээ тунгаан бод.

Ифер 5

Ялтсуудыг харж, гэрчлэх гурван гэрчийн талаар Моронай тунхаглажээ

Ифер 5:1–3-ыг унш. Моронай ялтсууд дээрх цэдгийг нэгэн өдөр орчуулах хүн буюу бошиглогч Иосеф Смитэд хандсан эдгээр шүлгүүдэд юу бичсэн бэ? Иосеф Смит Мормоны Номыг орчуулж байхдаа эдгээр шүлгүүдийг уншаад энэ нь түүнд ямар санагдсан болохыг төсөөлөн бод.



Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх, Ерөнхийлөгч Хэнри Б.Айрингийн хэлсэн дараах үгийг уншаад Гурван гэрчийн гэрчлэлийн талаар таныг гайхшруулсан хэллэгийг ол: “Гурван гэрч Мормоны Номын гэрчлэлээ хэзээ ч үгүйсгэж байгаагүй. Энэ нь үнэн байсныг мэдэж байсан болохоор тэд чадаагүй. Тэд ихэнх хүмүүсийн мэддэгээс илүү хүнд хэцүү зүйлстэй нүүр тулгарч, золиослол хийж байсан. Оливер Каудери нас барахаасаа өмнө, бие нь муудаад хэвтэж байхдаа Мормоны Номын тэнгэрлэг гарал үүслийн талаар өмнөхтэйгээ адил гэрчлэлийг үлдээсэн юм. . . . Тэд

Ифер 6

Оршил

Их Эзэний зарлигуудын дагуу бэлдсэний дараа жаредчууд хөлгүүдээ суугаад амлагдсан нутагт хүрэх хэцүү аяллынх нь турш аюулгүйгээр авч явна хэмээн Их Эзэнд найдав. Усан онгоцуудыг нь давалгаанд шидэж, олон удаа далайн гүнд автагдахад хүргэсэн салхийг Их Эзэн үлээлгэсэн бөгөөд тэрхүү салхи нь тэднийг амлагдсан нутгийн зүг түрж өгсөн юм. Шинэ нутагт суурьшсаныхаа дараа хүмүүс Жаредын ахын сэрэмжлүүлгийг үл хайхран өөрсдийн дээр хааныг сонгов.

Ифер 6:1–12


Их Эзэн жаредчуудын хөлгийг амлагдсан нутгийн зүг салхиар туув

Найзтайгаа сайн мэдээг хуваалцах, ёс суртахууны хувьд цэвэр ариун байх, өндөр жишигтэй найз нөхдийг сонгох, амьдралаа зөв дараалалтай байлгаж зэрэг Их Эзэний хүссэн зүйлсийг хийх нь хэцүү мэт санагдах үе бидэнд тохиолддог. Их Эзэний хүссэн зүйлсийг хийх нь хэцүү мэт санагдаж байсан өөр жишээ байна уу? _____

Амлагдсан нутаг руу явсан жаредчуудын аяллын тухай цэдэг Их Эзэний зарлигласныг хийх нь хэцүү санагдах үед таныг удирдан чиглүүлэх зарчмуудыг заадаг. Ифер 2:24–25-ыг уншаад Их Эзэн амлагдсан нутаг руу очих аяллыг нь хэцүү болгох зүйлийн талаар юу гэж жаредчуудад сэрэмжлүүлснийг ол.

Эдгээр хэцүү зүйлсийг тэсэн гарч болохын тулд Их Эзэн жаредчуудад “таваг мэт нягт” (Ифер 2:17) бөгөөд агаар оруулж болохын тулд оройдоо болон ёроолдоо нүхтэй хөлгүүдийг барь хэмээн зарлиглажээ. Ифер 6:1–4-ийг уншаад аяллын бэрхшээлүүдэд Их Эзэн жаредчуудыг өөр ямар замуудаар бэлдүүлсэн болохыг ол.

“Өөрсдийгөө Их Эзэн Бурхандаа даатгах” (Ифер 6:4) гэдэг нь жаредчууд өөрсдийг нь Бурхан халамжлан, хамгаална хэмээн найдсан гэсэн утгатай болохыг ойлгох нь тустай байж болох юм.


 **1.** Дараах асуултуудад судар судлах тэмдэглэлдээ хариулж бич:

а. Жаредчуудын хувьд ийм нөхцөл байдалд Их Эзэнд итгэх нь яагаад хэцүү байсан байж болох вэ?



гайхамшигт туршлагадаа харж мөн сонссон зүйлсээ сүмээс болон Иосефоос удаан хугацаагаар холдсон байхдаа ч үргэлжлүүлэн баталж байсан нь тэдний гэрчлэлийг илүү хүчтэй болгодог” (“An Enduring Testimony of the Mission of the Prophet Joseph,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2003 оны 11-р сар, 90).

Ифер 5:2–3-д гарсны дагуу бошиглогч Иосеф Смит ялтсуудыг хэрхэн ашиглах боломжтой байсан бэ?

 **5.** Алтан ялтсуудын бодит үнэнийг харах боломжтой байсан гурван эрийн адил та ч бас Мормоны Номын үнэнийг гэрчлэгч байж болно. Мормоны Номын гэрч байж болох хэдэн арга замуудыг судар судлах тэмдэглэлдээ бич. Үүнээс гадна Мормоны Номыг гэрчлэх таны гэрчлэл бусад хүмүүст хэрхэн нөлөөлж болохыг бич.

Энэ долоо хоногт Мормоны Номын тухай хэн нэгэнтэй гэрчлэлээ хуваалцах боломжийг залбиралтайгаар эрэлхийл.

 **6.** Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Ифер 4–5-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

6. Бэлтгэх болон Их Эзэнд өөрсдийгөө даатгах нь таны бодлоор яагаад чухал байсан бэ?

Ифер 6:5–11-ийг уншихдаа жаредчуудын хөлгөөр аялах нь ямар байхыг төсөөлөхийг хичээ.



2. Энэхүү бичээсээс сурч болох сайн мэдээний зарчмуудыг тодорхойлоход бэлтгэхийн тулд судар судлах тэмдэглэлдээ дараах асуултуудад хариулж бич:

а. Хэцүү аяллынхаа үеэр жаредчууд Их Эзэнд итгэх итгэлээ хэрхэн үзүүлж байсан бэ? (Ифер 6:7, 9-ийг үзнэ үү).

б. Аяллынх нь турш Их Эзэн тэднийг хэрхэн адисалж байсан бэ?

Усан дээр бараг жил болсны дараа жаредчуудын аялал дуусав. Ифер 6:12-ыг уншаад тэд амлагдсан нутагт ирээд ямар сэтгэгдэлтэй байсныг тодорхойл. Дараах зарчмуудыг гүйцээн бичиж, энэ хичээлээс сурсан зүйлсээ тоймло: **Бид Их Эзэнд итгэж, Түүний хүслийн дагуу үйлдсэнээр Тэр _____**

Энэхүү зарчмыг гүйцээж бичих нэг хариулт нь “бидний амьдралын замыг чиглүүлэх” гэсэн хэллэг байж болно. Энэ зарчмын талаарх өөрийн ойлголтыг гүнзгийрүүлэхийн тулд Их Эзэний хүссэнийг хийхэд хэцүү гэдгийг мэдрэх үедээ хичээлийн эхэнд жагсаан бичсэн нөхцөл байдлууд руу эргэн оч. Их Эзэн жаредчуудыг бэлдсэнтэй адил биднийг ч бас залбирч, бошиглогчдыг дагаж, зарлигуудыг дагах үед амьдралд маань тохиолддог бэрхшээлүүдийг даван туулахад бэлтгэдэг.



3. Хүн Их Эзэнд итгэх итгэлээ хэрхэн үзүүлж болохыг судар судлах тэмдэглэлдээ бич. Их Эзэнээс ирсэн хэцүү зарлигтай тулгарах үедээ бид жаредчуудын жишээн дээр тулгуурлан юу хийх хэрэгтэй вэ?



4. Дараах зарчмыг тунгаан бод: **Хэрэв бид Их Эзэнд итгэж найдвал саад бэрхшээл, зовлон зүдгүүр нь биднийг өсөн дэвжиж, амлагдсан адислалуудыг хүлээн авахад тус болох болно.** (Та судартаа Ифер 6:5–10-ын хажууд үүнийг тэмдэглэж болно.) Дараах асуултуудад судар судлах тэмдэглэлдээ хариулж бич:

а. Амьдралдаа тохиолдсон эсвэл одоо тохиолдож байгаа зовлон бэрхшээлүүдийг итгэлтэйгээр тэвчин гарснаар өсөж хөгжиж, адислалуудыг хүлээн авч байгаа талаараа та ямар мэдрэмжтэй байна вэ?

б. Өөрт тулгарсан хэцүү нөхцөл байдлуудад Их Эзэнд итгэн найдаж, Түүний удирдамжийг хэрхэн илүү сайн дагаж чадах вэ?

Ифер 6:13–18

Жаредчууд хүүхдүүддээ Их Эзэний өмнө даруухнаар алхахыг заав

Та жаредчуудын адил далайг гаталж, урьд нь хэзээ ч очиж үзэж байгаагүй газарт ирсэн гэж төсөөл. Ифер 6:13–18-ыг уншаад дараах асуултуудын талаар бод: Их Эзэний өмнө даруухнаар алхахын ямар жишээ байж болох вэ? Их Эзэний өмнө даруухнаар алхахад тань эцэг эх болон бусад хүмүүс хэрхэн урамшуулсан бэ? Таны бодлоор даруухнаар алхах, дээрээс заалгах хоёрын хоорондын холбоо харилцаа нь юу вэ? Та хэзээ “дээрээс заалгаж” байгаагаа мэдэрч байсан бэ? (Ифер 6:17).



5. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Ифер 6-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

30-Р ХЭСЭГ: 3 ДАХЬ ӨДӨР

Ифер 7–11

Оршил

Жаредчуудын хааныг сонгох нь тэднийг боолчлол руу хөтлөх болно гэж Жаредын ах бошиггосон боловч түүний үгс тэр даруй биелэгдээгүй. Жаредчуудын анхны хаан Ораиха зөв шударга байдалд удирдсан. Хэдий тийм боловч хоёр үеийн дараа Жаред хэмээх нэртэй нэгэн эр нууц бүлэглэл байгуулж, хаан болов. Тэдний хаадын засаглалын үед жаредчууд бошиглогчдыг сонсож, зөв шударгаар амьдарч мөн бошиглогчдыг эсэргүүцэн ёс бусаар амьдрах явдал хэд хэдэн удаа давтагдсан.


Ифер 7

Корихор эцгээсээ хаант улсыг булаан авч, түүний дүү Шуле түүнийг эргүүлэн авдаг. Мөн бошиглогчид ёс бус хүмүүсийг буруушаав

Хүн боолчлолд амьдарвал ямар санагдах байсан гэж та бодож байна? Буруу сонголт хийсний улмаас та үүнтэй адил хязгаарлагдмал мэдрэмжийг мэдэрч байсан уу? Ифер 7–11-ийг судлахдаа бие махбодын болон сүнсний боолчлолоос хэрхэн зайлсхийж болох арга ухааныг ол.




Жаред болон түүний ах өтлөхөд жаредчууд хаантай болохыг хүсжээ. Жаредын ах хаантай болох нь боолчлол руу хөтлөгдөх болно гэж хүмүүст сэрэмжлүүлсэн байна (Ифер 6:19–23-ыг үзнэ үү). Бошиглогчид үргэлж биднийг бие махбод болон сүнсний боолчлол руу хөтлөх үйлдлийн эсрэг бошиглож байсан.

 **1.** Орчин үеийн бошиглогчид сэрэмжлүүлдэг үйлдэл мөн тэдгээр үйлдлүүд нь хэрхэн биднийг бие махбод болон сүнсний боолчлолд хөтөлдөг нэг хоёр жишээг судар судлах тэмдэглэлдээ бич.


Жаредын ахын сэрэмжлүүлгийг үл хайхран хүмүүс хаантай байхыг сонгосон. Ифер 7:1–2-ыг уншаад Жаредын хүү Ораихагын өдрүүдэд Жаредын ахын бошиглол биелсэн эсэхийг олж мэд. Ораиха хааны үед амьдарч байсан, Жаредын ахын бошиглол биелэгдэнэ гэдэгт итгээгүй хүнд та юу хэлэх байсан гэдгээ бод.

Хоёр үе удмын дотор Жаредын ахын бошиглосон сэрэмжлүүлэг биелсэн. Ифер 7:3–7-г уншаад хаан болох хүслээсээ болж эцгээсээ урвасан Корихорын доорх боолчлолд Киб болон түүний хүмүүс хэрхэн амьдарч байсныг ол. Энэ боолчлол нь амин хувиа хичээсний мөн эсэргүүцлийн үр дүн байсан юм.

 **2.** Өнөө үед бошиглогчдын зөвлөгөөг дуулгавартай дагадаггүй, гэвч өөрсдийгөө сүнсний боолчлолд байгааг мэдэрдэггүй тэдэнд та юу гэж хэлэх байснаа судар судлах тэмдэглэлдээ бич. (Хариулахдаа сүнсний боолчлолд орсон тэдгээр нь ихэвчлэн хожим нь түүнийгээ ойлгодог гэсэн санааг нэмж болох юм. Хэн нэгнийг сүнсний боолчлолд оруулж болох орчин үеийн нөхцөл байдлыг бич.)

Жаредчуудын түүхийн энэ хэсэг нь **бошиглогчдын үгсийг үл тоомсорлох нь боолчлол руу удирддаг гэсэн зарчмыг харуулдаг**. Зарлигуудыг эсвэл бошиглогчдын зөвлөгөөг дуулгавартай дагаагүйгээс болоод сүнсний боолчлолд орж байсан тохиолдлуудаа тунгаан бод.

Өөрийнхөө эцэг Кибийн эсрэг гаргасан Корихорын бослого нь үргэлжилсэн дайн, тэмцэлдээн рүү хөтөлсөн. Киб өндөр настай байхдаа Шуле хэмээх хүүтэй болов. Шуле өсөж том болоод тэрээр тэрслүү ах Корихорынхоо эсрэг байлдсан.

 **3.** Та өөрийгөө Шулегийн түүхийг харуулахаар томилогдсон сурвалжлагч байна гэж төсөөл. Ифер 7:8–13-ыг уншаад Шулийн амьдралаас юуг нь илүү тодруулж илтгэх байсан гэдгээ харуулах хэдэн өгүүлбэр судар судлах тэмдэглэлдээ бич.

Шулийн засаглалын үед маш олон бошиглогчид хүмүүст ирж тэдний ёс бусыг сэрэмжлүүлсэн. Ифер 7:23–25-ыг уншаад бошиглогчид юу гэж бошиглосныг болон хүмүүс хэрхэн хариу үйлдэл үзүүлснийг олж тогтоо. Шуле хэрхэн хариу үйлдэл үзүүлсэн бэ? Шуле бошиглогчдыг хамгаалсан нь түүний хүмүүсийг хэрхэн адисалсан бэ?

Ифер 7:26–27-г уншаад хүмүүс бошиглогчдын үгсийг дагахад юу болсныг олж хар. Шуле “эцэг өвгөдийнх нь төлөө Бурханы хийсэн агуу зүйлүүдийг санах” (Ифер 7:27). Их Эзэн таны төлөө хийсэн агуу зүйлүүдийг санахад та Түүнд илүүтэйгээр талархаж мөн зөв шударга амьдрах магадлалтай.

Эдгээр үйл явдлууд нь нэг чухал зарчмыг гэрчилдэг: **Бид шударга бус явдлаа наманчлахад өсөн дэвжиж эхэлдэг.** Дэгжих гэдэг үг нь “найдвар” мөн “амжилт гаргах” мөн энэ нь “материаллаг амжилт” гэсэн утгаар ихэвчлэн хэрэглэгддэг [боловч] материаллаг эд хөрөнгөөр арвин эсвэл амьдралын ямар ч асуудалгүй амар тайван байна гэсэн үг *биш* юм.

“Үнэхээр зөв шударгачууд нь өсөн дэвждэг. Энэ нь тэдний итгэлийг үйлдэл рүү хөтөлдөг бөгөөд хамгийн тааламжгүй нөхцөлөөс ч гэсэн ашигтай талыг гаргаж ирдэг юм. Тэд Их Эзэнийг шан урамшуулал өгөх эсэхийг хүлээдэггүй, харин түүний оронд материаллаг болон сүнслэг аль алинд нь юу хамгийн ашиг тустай вэ гэдэг талаар удирдамжийг Түүнээс асуудаг. Эдгээр удирдамжууд нь ажил мэргэжлээ өөрчлөх, өөр дүүрэг рүү нүүх, сургалт эсвэл шинэ арга барилд суралцах эсвэл байгаа зүйлүүдийг байгаагаар нь хүлээж авах боловч өөрийн хэмжээ хязгаар дотор ажиллах мөн Сүнсний удирдамжийг өөр замуудаар дагах явдал руу хөтөлж болох юм” (Alan Webster, “I Have a Question,” *Ensign*, 1990 оны 4-р сар, 52–53).



4. Дараах асуултуудад судар судлах тэмдэглэлдээ хариулж бич:

- а. Бошиглогчдын үгсийг анхаарснаар та хэрхэн адислагдсан бэ?
- б. Бошиглогчдын үгсэд илүү сайн анхаарч мөн Их Эзэний адислалуудыг хүлээн авахад бэлтгэгдэхийн тулд таны хийж болох нэг зүйл юу вэ?

Ифер 8:1–9:12

Жаред мөн түүний дараа Акиш нууц бүлэглэлээр дамжуулан жаредчуудын хаан болсон нь

Дараах жагсаалтыг унш: таны сонсдог хөгжим, боддог бодлууд, сургууль дээрх биеэ авч яваа байдал, үздэг кинонууд, болздог зан байдал, найзуудтайгаа хийдэг үйл ажиллагаанууд, хэн ч хажууд чинь байхгүй байхад хийдэг зүйлс. Ёс бус зан байдалтай хүн яагаад эдгээр үйл ажиллагаануудын нэгэнд эсвэл ихэнхэд нь оролцдог оо найзууд, эцэг эх болон удирдагчдаасаа нуухыг хүсдэг вэ? Зөв шударга бус нууц үйл ажиллагаануудад оролцохын аюултай тал нь юу вэ?

Ифер 8-ын дагуу Шулийг нас барсны дараа Омер хаан болсон боловч түүний хүү Жаред “эцгийнхээ эсрэг бослого гаргасан” (Ифер 8:2) бөгөөд “зүрх сэтгэлээ хаант улс болон дэлхийн алдар суу дээр тавьсан” (Ифер 8:7). Жаредын охин эцэгтээ хаант улсыг авчрах төлөвлөгөөг түүнтэй хамт зохиов. Тэрээр үзэсгэлэнтэй эмэгтэй байсан ба тэрээр Акиш хэмээх эрийн өмнө бүжиглэхэд тэрээр түүнтэй гэрлэхийг хүсжээ. Жаред Акишт “хэрэв чи миний эцэг, хааны толгойг авчирвал” охинтой минь гэрлэж болох юм гэж хэлсэн ажээ (Ифер 8:12). Акиш найзуудтайгаа нууц бүлэглэлд нэгдэн Омер хааныг алсан байна. Нууц бүлэглэл гэдэг нь хоёр эсвэл түүнээс дээш хүмүүс нэг нэгнийхээ зөв шударга бус үйлдлийн үр дагавраас зайлсхийхийн тулд нууцална гэж тангараг өргөхийг хэлдэг.

Ифер 8:15–18-ыг уншаад нууц бүлэглэлд нэгдсэн тэдгээрийн ард байгаа шалтаг шалтгаан мөн арга барилыг дүрсэлсэн үг хэллэгүүдийг ол.



5. Хоёр эсвэл түүнээс дээш дараах асуултуудад судар судлах тэмдэглэлдээ хариул:

- а. Яагаад зарим хүмүүс нууц бүлэглэлд нэгддэг вэ?
- б. “Бүх төрлийн ёс бусыг” чи үйлдэж (Ифер 8:16) эсвэл ямар ч үр дагавартай тулгаралгүй “хүссэн бүхнээ” (Ифер 8:17) хийж болно гэдэгт итгэх нь яагаад сүнслэг байдлын хувьд хөнөөлтэй вэ?
- в. Ифер 8:18 дахь ямар хэллэг нь нууц хуйвалдаануудын талаарх Их Эзэний сэтгэгдлийг илтгэж байна вэ? Эдгээр бүлэглэлүүд нь яагаад “хамгийн жигшүүрт” гэж тооцогддог бэ?

Ифер 8:20–22, 25 мөн Ифер 9:5–6, 11–12-ыг уншаад нууц бүлэглэлүүдийг дэмжихийн үр дагавруудыг ол. Юу сурснаа дүгнэ: _____

Эдгээр шүлгүүдээс таны тодорхойлох үнэнүүдийн нэг бол: **Нууц бүлэглэлүүдийг дэмжих нь хувь хүний болон нийгмийн устгал руу удирддаг.**

Моронай бидэнд хандан ярихын тулд жаредчуудын дайны тухай бичихээ түр завсарлажээ. Ифер 8:23–24, 26 уншаад Моронай өнөө үеийн хүмүүст нууц хуйвалдаануудын тухай түүний сэрэмжлүүлгийг хэрэгжүүлэхийг хэрхэн урамшуулсныг тодорхойл.

Дараах асуултын хариултыг бод: Нууц бүлэглэл нь улс үндэстэн, нийгэм эсвэл өөр бүлэг хүмүүсийн дунд байх үед яагаад тэдгээр нь “аймшигтай нөхцөл байдалд” (Ифер 8:24) ордог вэ? Нууц байдал нь тэдгээр бүлэглэлүүдэд хэрхэн хүч өгдөг вэ? Нууц бүлэглэлүүдийн тухай үнэнийг мэдэх нь энэхүү ёс бусаас хол байхад нь хүмүүст хэрхэн туслах вэ?



6. Энэ хичээлийн эхний хэсэгт өгөгдсөн үйлдлийн жагсаалтыг эргэж сана. Зөв шударга бус сонголтыг амьдралынхаа энэ үед хийх нь нууц бүлэглэл гэж тооцогдох албагүй ч бусдаас нууцлахыг хүсэх үйлдлүүдийг хийснээр хүмүүст ямар аюул ирж болохыг судар судлах тэмдэглэлдээ бич.

Ифер 9:13–11:23

Нэг хаан нөгөөгөө залгамжилдаг бөгөөд зарим нь зөв шударга, зарим нь ёс бус байдаг

Ифер 9–11-р бүлгүүдэд бичигдсэнчлэн жаредчуудыг олон хаан удирдсан ба зарим нь зөв шударгад мөн зарим нь ёс бусад удирдсан ажээ. Ифер 9:26–35 (Хетийн засаглалын үед) мөн Ифер 11:1–8 (Ком болон Шибломын засаглалын үед)-ыг уншаад энэ



хичээлийн эхэнд яригдсан **бошиглогчдын үгсийг эсэргүүцэх нь боолчлол руу хөтөлдөг** хэмээх зарчмын үнэний баталгааг ол.

Бошиглогчдын үгсэд илүү сайн анхаарал тавих ямар арга зам бодсоноо эргэн сана. Ирэх өдрүүдэд энэ зорилгоо дагаж мөн бошиглогчдын үгсэд дуулгавартай байхын ач холбогдлын тухай гэрчлэлээ хуваалцах боломжийг эрж хай.

 **7.** Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Ифер 7–11-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.


Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

30-Р ХЭСЭГ: 4 ДЭХ ӨДӨР

Ифер 12

Оршил

Жаредчуудын олон жилийн түүхийг өгүүлснийхээ дараа Моронай Бошиглогч Иферийн үйлчлэлийг танилцуулжээ. Моронай тэгээд түүхийн цэдгийг түр орхиж, Есүс Христэд итгэх итгэлээ үйлдлээрээ харуулдаг хүмүүст ирдэг адислалуудыг тэмдэглэв. Тэр бас санаа зовж байсан нэг зүйлээ илэрхийлжээ. Тэр өөрийн болон бусад бичигчдийн бичих чадвар муу байснаас болж хожмын өдрүүдэд Мормоны Номыг унших хүмүүс үүнийг хүлээн зөвшөөрөхгүй хэмээн санаа зовж байсан. Их Эзэн Моронайд өөрсдийгөө Түүний өмнөөс даруусгаж итгэх хүмүүсийн сул талуудыг хүчирхэгжүүлэхээ амласан.



Ифер 12:1–4


Ифер жаредчуудад наманчлалыг тунхагласан нь

Хөлөг онгоц яагаад зангуутай байх нь чухал вэ? Зангуу байхгүй бол онгоцонд ямар аюул эсвэл бэрхшээл тулгарч болох вэ? Зурган дээр байгаа онгоцыг *Миний амьдрал гэж тэмдэглэ*. Дараах асуудлуудын талаар бод:

- Онгоц нь таны амьдралыг дүрсэлдэг бол давалгаа нь юу байж болох вэ?
- Хэрвээ давалгааг бэрхшээл, ёс бус байдалтай харьцуулбал зангуутгүй хүний амьдрал ямархуу байх вэ? (Мормон 5:18-ыг үзнэ үү.)
- Их Эзэн танд зангуу шиг аюулгүй тогтоон барьж байхад туслах юу өгсөн бэ?

Ифер 12-ыг судлахдаа зангуутай онгоц шиг тулгардаг давалгаа, дарамтуудын дунд баг бөх байхын тулд юу хийх ёстойгоо анхаар. Ифер 12-р бүлэг Моронай хүмүүс бошиглогчдыг эсэргүүцсэн үед амьдарч байсан бошиглогч Иферийг танилцуулсанаар эхэлдэг. Ифер 12:1–3-ыг уншиж, эдгээр хэцүү нөхцөлүүдэд Иферийн хийсэн үйлдлийн талаар танд таалагдах зүйлсийг анхаар.

Ифер хүмүүсийг наманчлахыг сэрэмжлүүлэхдээ Бурханд итгэдэг хүнийг бэрхшээл, ёс бусын дунд амьдарсан ч юуны төлөө найдаж болохыг заасан. Ифер 12:4-ийг уншиж, тэр найдвар нь юу вэ гэдгийг тэмдэглэ. (Үүнийг уншихдаа “Бурханы баруун гарт” байх гэдгийг Бурханы оршихуйд буцаж мөнхийн амьдрал хүлээн авах гэсэн үг гэдгийг мэдэх нь тустай.)

 **1.** Дараах асуултуудад судар судлах тэмдэглэлдээ хариулж бич:

- а. “Лавтайяа” найдвартай байх нь юмыг зүгээр л хүсэхээс ямар ялгаатай вэ?
- б. Есүс Христэд итгэх итгэл бидэнд Бурханы баруун гарт байхад “лавтайяа” найдахад маань яаж тусалдаг вэ?
- в. Ифер 12:4-т ямар үгс нь Есүс Христэд итгэх итгэл, найдах найдвартай хүний үйлдлийг тайлбарладаг вэ?

Энэ хичээлийн эхэнд гарсан онгоцны зурагны зангуун дээр нь *итгэл* болон *найдар* гэсэн үгсийг бич.

Ифер 12:4-р шүлэг **бид Есүс Христэд итгэж найдах үед тууштай байж, сайн үйлээр дүүрэн байх хүч чадлыг хүлээн авна** гэдэг зарчмыг заадаг.

Таны хувьд тууштай (хөдөлшгүй), сайн үйлээр дүүрэн байхад хэцүү байж болох үеийг тунгаан бод. Эдгээр нөхцөлүүдэд болон таны амьдралын туршид тус болох үүднээс Ифер 12-ыг судлахдаа Их Эзэн Есүс Христэд итгэх итгэлээ нэмэгдүүлэх боломжийг хай.

Ифер 12:5–22

Моронай итгэлээр ирсэн гайхамшгууд болон аугаа үйлсийн талаар өгүүлэв



2. Дараах өгүүлбэрийг сүнслэг гэрчлэлийг хүсч буй сайн мэдээний үнэнээр судар судлах тэмдэглэлдээ гүйцээж бич: *би . . . -н талаар сүнслэг гэрчлэлтэй болмоор байна*

Зарим хүмүүс аливаа үнэний дагуу амьдрахаасаа өмнө эхлээд бодит нотолгоог нь харж, бүрмөсөн баталгаажуулах хэрэгтэй гэж боддог. Моронай тэр зан чанарын талаар Ифер 12:5–6-д ярьсан. Эдгээр шүлгүүдийг уншиж, өөртөө таалагдсан түүний зөвлөгөөний хэсгүүдийг тэмдэглэ. (Ифер 12:6 бол төгс эзэмших судар юм.)

Ифер 12:6-гийн дагуу бид Их Эзэнээс гэрчлэл авахаасаа өмнө юу үзэх шаардлагатай вэ? “Итгэлийн тань сорилт”-ыг бодоход таны санаанд юу орж ирдэг вэ?



Зарим хүмүүс “итгэлийн тань сорилт”-ыг буруу ойлгож, дандаа бэрхшээл гэж боддог. Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Ричард Г. Скотт “итгэлийн тань сорилт”-ын утгыг ингэж тайлбарлажээ: “Та Моронайн заасан энэхүү зарчмыг хэрэгжүүлснээр итгэлийг илүү үр дүнтэйгээр ашиглахыг сурч чадна: *‘итгэлийн тань сорилт’-ын дарааг хүртэл та нар гэрчийг хүлээн авахгүй*” [Ифер 12:6;] Тиймээс та *итгэлээ сорих* буюу мэдрэмжийн дагуу зохистойгоор үйлдэх болгондоо Сүнсний батлах нотолгоог авна. Тэдгээр мэдрэмжүүд таны итгэлийг хүчирхэгжүүлнэ. Та энэ хэв маягийн дагуу олон дахин давтаж үйлдсэнээр таны итгэл улам хүчирхэгжинэ” (“The Sustaining Power of Faith in Times of Uncertainty and Testing,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2003 оны 5-р сар, 76).

Дараах судрын хэсгүүдийг уншиж, хүмүүсийг итгэлээ хэрэгжүүлсний дараа нь ирсэн адислалуудыг хай:

- Ифер 12:11) Адислал нь юу байсан бэ? _____
- Ифер 12:12–13 Алма Амюлек хоёрт ямар адислал ирсэн бэ? _____
- Ифер 12:19–22, 30–31 Жаредын ахад итгэлээр дамжуулан ямар адислалууд ирсэн бэ? _____

Ифер 12:7, 12, 17, 18 болон 31-д дараа гэдэг үгийг ашигласныг нь анзаарах хэрэгтэй.



3. Ифер 12-д судалсан зүйл дээрээ үндэслэн Моронайн Их Эзэнээс сүнслэг гэрчүүдийг хүлээн авах талаар заасныг өөрийн үгээр судар судлах тэмдэглэлдээ тайлбарлаж бич.

Моронайн заасан нэг зарчим бол: **Хэрвээ бид гэрч авахыг хүсвэл бид эхлээд Есүс Христэд итгэх итгэлээ үйлдэл болгох ёстой.**



4. Дараах жишээний нөхцөлүүдийг уншиж, тэдгээрээс хоёроос дээш нөхцөлтэй хүн хэрхэн Их Эзэнд итгэх итгэлээ харуулж болохыг судар судлах тэмдэглэлдээ бич:

а. Нэгэн залуу эмэгтэй Мормоны Ном үнэн гэсэн баталгаа олж авахыг хүсдэг.

б. Нэгэн залуу эрэгтэй хайртай хүмүүстээ сайн мэдээг хүлээн авахад туслахыг маш их хүсдэг.

в. Нэгэн залуу эмэгтэй Их Эзэнээс өвчтэй аавыг нь адислахыг гуйдаг.



5. Та эсвэл таны таньдаг хэн нэгэн итгэлээ үйлдэл болгон харуулсны дараа гэрч эсвэл гайхамшгийг хүлээн авсан тохиолдлын талаар судар судлах тэмдэглэлдээ бич.

Сүнслэг гэрч авмаар байгаа зарчим эсвэл сургаалаа эргэн санаж бод (энэ хичээлийн 2 дахь даалгаврыг үзнэ үү). Та гэрчээ авахаасаа өмнө хэрхэн итгэлээ үзүүлж болох вэ?



Төгс эзэмших судар—Ифер 12:6



6. Ифер 12:6-г цээжлэхэд тань туслахын тулд түүнийг хэд хэдэн удаа уншаад тэр шүлгээс санаж чадах бүхнээ судар судлах тэмдэглэлдээ бич. Дараа нь бичсэнийгээ шүлэгтэй нь харьцуулж үз. Тэр шүлгийг дахиж үзээд дахиад судар судлах тэмдэглэлдээ бич.

Ифер 12:23–41

Харийнхан Мормоны Номыг хэрхэн хүлээж авах талаар Моронай өөрийн бодлыг илэрхийлсэн нь

Ифер 12:23–41-д бичигдсэнчлэн Моронай өөрийн болон бусад бичигчдийн бичихийн сул дорой байдлаас болж хожмын өдрүүдэд Мормоны Номыг уншигчдыг хүлээн зөвшөөрөхгүй хэмээн санаа зовж байсан. Ифер 12:26–27-д Их Эзэн Моронайн санаа зовсон зүйлд хариулсныг уншихдаа Их Эзэн сул дорой зүйл хүчирхэг болж болохыг хэлснийг нь анхаар. (Ифер 12:27 бол төгс эзэмших судрын шүлгийн товчлол.)

Судар заримдаа сайн мэдээний зарчмыг *хэрвээ* болон *тэгвэл гэдэг үгээр тодорхойлдог*. *Хэрвээ* гэдэг үг биднийг юу хийх ёстойг тайлбарладаг ба *тэгвэл* гэдэг үг бидний үйлдлийн улмаас юу болохыг тайлбарладаг. Ифер 12:27-г уншиж, хэрвээ–тэгвэл зарчмыг олоод доор бич.

Хэрвээ бид _____

-вал Их Эзэн _____

Та эдгээр шүлгүүдийг энэ долоо хоногт багштайгаа илүү дэлгэрэнгүй ярилцана. Та бас Ифер 12:28–41-д оршдог Моронайн итгэл, найдвар ба энэрлийн талаар ярьсныг нь илүү ихээр суралцана.

Төгс эзэмших судар—Ифер 12:27


Ифер 12:27-д гардаг зарчмуудыг санахад тань туслахын тулд дараах үгсийг цаасан дээр бичээд ав: *Хэрэв . . . ирэх . . . сул доройг . . . үзүүлэх болно. . . даруу . . . сул доройг өгдөг; . . . даруусгадаг бүх хүмүүст . . . ач ивээл . . . хэрэв . . . даруусгаж . . . итгэлтэй . . . сул дорой . . . хүчирхэг. . .*

Эдгээр үгсийг анхаарч Ифер 12:27-г унш. Зөвхөн цаасан дээрээ бичсэн үгсийг харахдаа тэр шүлгээс санаж чадах бүхнээ ярьж үз. Тэр цаасаа өнөөдөр эсвэл маргааш харагдахаар газарт хий (жишээ нь халаасандаа эсвэл судрынхаа завсарт). Цаасаа харах бүрдээ Ифер 12:27-г давтаж, цээжлэх хүртлээ цаасаа давтан унш.

 **7.** Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Ифер 12-р бүлгийг судалж энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:



дараах хотуудыг зөв хоёр дахь нэртэй нь тохируулж чадах эсэхээ хараарай (Хариулт нь хичээлийн төгсгөлд байгаа).

Египетийн Кайро хот	Салхит хот
Филиппиний Манила хот	Мянган цамхагтай хот
АНУ-ын Чикаго хот	Мөнхийн хот
Мексикийн Мехико хот	Дорнын сувд
Италийн Ром хот	Харшуудын хот

Өнөөдрийн хичээлээр эцсийн өдрүүд дэх хоёр нэн чухал хотод анхаарлаа хандуулах болно: (1) Иерусалим болон (2) Шинэ Иерусалим. Хожмын өдрүүдэд энэ хоёр хот нь зөв шударга байдлаараа олонд танигдах болно. Ифер жаредчуудад тэдний амьдарч байсан газар нутаг бол Шинэ Иерусалим хэмээх ирээдүйн хот баригдах газар юм хэмээн заажээ.

Ифер 13:2–8-ыг унш. Их Эзэн бошиглогч Иосеф Смитэд Ифер 13:6-д дурдагдсан Шинэ Иерусалим хот АНУ-ын Миссури мужийн Жаксон гүнлэгт баригдана хэмээн илчилжээ (С ба Г 57:1–4; 84:1–4). Ифер эдгээр хотуудын талаар Ифер 13:3, 5-д юу гэж хэлсэн бэ? Тийм хотод амьдрах бол ямар байх байсныг тунгаан бод. Ариун хотууд буюу хуучин болон шинэ Иерусалимд амьдрахын тулд хүн ямар зүйлийг үзсэн байх ёстойг олж мэдэхийн тулд Ифер 13:10–11-ийг судал (Их Эзэнд зориулан баригдахдаа ариун байх болно; Ифер 13:5-ыг үзнэ үү).

Шинэ Иерусалимын өөр нэг нэр нь Сион юм (Мосе 7:62; Итгэлийн тунхаг 1:10). Бид Иерусалим эсвэл Шинэ Иерусалимд амьдрахгүй байж магадгүй ч гэсэн сүмийн бүх гишүүд Сионыг байгуулахыг эрэлхийлж чадна. Бид Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан цэвэр болсноор Бурханы селестиел хаант улс зэрэг ариун газруудад оршиход бэлтгэж болно.

31-Р ХЭСЭГ: 1 ДЭХ ӨДӨР

Ифер 13–15

Оршил

Бошиглогч Ифер Шинэ Иерусалимын тухай бошиглов. Түүнчлэн тэрээр жаредчуудын хаан Кориантумрт ёсон бусын улмаас түүний хүмүүс устгагдах болно хэмээн сэрэмжлүүлж, Кориантумр болон түүний гэрийнхэнд наманчлахыг сануулжээ. Кориантумр болон түүний хүмүүс наманчлахаас татгалзахад дайн болон ёсон бус үйлүүд бүхэл бүтэн Жаред үндэстэн устгагдах хүртэл олон жилийн турш улам ширүүсэв. Ифер, Кориантумр хоёр л амьд үлдэж, Иферийн бошиглол гүйцэлдсэнийг харав.

Ифер 13:1–12

Моронай шинэ болон хуучин Иерусалимын тухай Иферийн бошиглолуудыг цэдэглэв

Хотынх нь онцлогийг харуулсан хоёр дахь нэртэй өнөө үеийн хотуудыг бод. Жишээлбэл, Францын Парис хот нь Гэрэлт хот гэдгээрээ алдартай. Эхлээд

Ифер 13:13–15:34

Жаредчууд Иферийг эсэргүүцэж, устгагдах хүртлээ ёс бус явдал, дайныг үргэлжлүүлэв

Ифер 13:13–19-ийг уншаад Иферийн үеийн жаредчуудын нийгмийн нөхцөл байдал ямар байсныг ол. Кориантумрт илгээсэн Иферийн захидал хийгээд Кориантумр, түүний хүмүүс уг захидалд хэрхэн хариулсныг олохын тулд Ифер 13:20–22-оос суралц.



1. Дараах асуултуудад судар судлах тэмдэглэлдээ хариулж бич:

а. Өнөө үед хүмүүс ямар замаар зүрх сэтгэлээ хатууруулж, Их Эзэний үйлчлэгчдийг эсэргүүцэж байгааг та харсан бэ?

б. Итгэлдээ хүчирхэг хэвээр байж, бошиглогчдын үгсийг анхааралтай сонсохын тулд та юу хийх вэ?

Ифер 13:23–14:20-д цэдэглэсэнээр Кориантумр хаант улсыг нь булаахыг оролдсон Шаред, Гилиад, Либ зэрэг эрстэй тулалддаг. Эцэстээ бүхэл бүтэн Жаред үндэстэн дайнд ууссан байлаа. Кориантумрын сүүлчийн дайсан нь Шиз гэдэг эр байв. Эдгээр дайнуудаас үүдэлтэй жаредчуудын дундах устгалын хэмжээг Ифер 14:21–25 болон Ифер 15:1–2-т нарийвчлан харуулсан байгаа.

Үлдсэн хүмүүсээ устгалаас амьд үлдээхийн тулд Кориантумр юу хийхээр оролдсоныг мэдэхийн тулд Ифер 15:3–6-г унш. Шиз яагаад Кориантумрын хүсэлтийг эсэргүүцсэн болон хоёр армийн хүмүүс хоёулаа яагаад буулт хийхээс татгалзсан талаар бод (түүнчлэн Ифер 14:24-ийг үзнэ үү).

Ифер 15:12–17-г уншаад жаредчуудын нөхцөл байдлын талаар дэлгэрэнгүй мэдэж ав. Та тэдний нөхцөл байдлын талаар ялангуяа эмгэнэлтэй, харамсмаар ямар зүйлийг олж мэдсэн бэ? Ифер олон жилийн турш хүмүүст наманчлахыг сануулсан гэдгийг сана (Ифер 12:2–3; 13:20-ийг үзнэ үү). Ифер 15:18–19-ийг уншаад Их Эзэний наманчлах сануулгыг эсэргүүцсэнээс ирэх үр дагавруудыг тодорхойл. Уншсан зүйлдээ тулгуурлан энэхүү зарчмыг гүйцээж бич: Хэрэв бид Их Эзэний наманчлах сануулгыг эсэргүүцвэл _____

Дээрх зайд дараахтай адил зарчмыг бичиж болно: **Хэрэв бид Их Эзэний наманчлах сэрэмжлүүлгийг эсэргүүцвэл Түүний Сүнс холдон явж, Сатан бидний зүрх сэтгэлд хүчийг олох болно.**



2. Ифер 15:19 болон үүнээс сурсан зарчмаа ашиглан өнөөдөр хэн нэгэн наманчлахыг эсэргүүцэж болохыг харуулсан дараах тайлбаруудаас нэг юмуу хоёрыг сонгон яагаад буруу гэдгийг тайлбарла:

а. Миний үздэг кинонууд сүмийн жишгүүдтэй зохицдоггүй ч надад нөлөөлөхгүй байгаа юм шиг санагддаг.

б. Найзуудтайгаа хамт согтууруулах ундаа уух нь тийм ч муу зүйл биш. Зүгээр л зугаацаж байгаа юм.

в. Энэ чинь зүгээр л бага зэргийн порнограф. Намайг гараад ёс суртахуунгүй юм хийхэд хүргэх зүйл биш ээ. Би ер нь өөрөө хүссэн цагтаа л үүнийг зогсоочихож чадна.

г. Би одоо наманчлах шаардлагагүй. Номлолд явах эсвэл ариун сүмд гэрлэх хүртлээ жаахан хүлээж болно.

Ифер 15:20–32 нь жаредчуудын хоёр арми зөвхөн удирдагчид нь болох Кориантумр, Шиз нар үлдэх хүртэл хоорондоо хэрхэн тулалддаг тухай өгүүлдэг. Тэгээд Кориантумр Шизийг алдаг.

Жаредчуудын түүх нь наманчлахыг дахин дахин ухуулсан Бурханы хичээл зүтгэлийг бүгдээрээ үл ойшоох үед хүмүүст юу тохиолддогийг харуулсан тодорхой жишээ юм. Наманчлахаас татгалзсанаар бие махбодын устгалыг тэр дороо амсахгүй байж болох ч Их Эзэний наманчлалын сануулгыг эсэргүүцвэл гэм буруутайгаа мэдрэх болно.



Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Нийл Л.Андэрсэний хэлсэн дараах үгсийг эргэцүүлэн бод: Аврагч бидний нүглийг уучилж чадах бөгөөд уучлах асар их хүсэлтэй байдгийг би гэрчилж байна. Мэдсээр байж мөхлийг

сонгодог цөөхөн хүнийг эс тооцвол уучлагдахгүй нүгэл гэж байдаггүй юм. Нүглээсээ эргэж, Христэд ирэх онцгой боломж бидэнд бүгдэд нь байдаг. Бурханлаг уучлал бол бидний зүрх сэтгэлээс гэм буруу болон сэтгэл санааны зовлонг арилгаж, үүнийг баяр баясал, ухамсрын амар амгалангаар сольдог сайн мэдээний хамгийн амттай үр жимс юм (“Наманчил . . . Би та нарыг эдгээж болохын тулд,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2009 оны 11-р сар, 46–47).

Амьдралд тань Ариун Сүнсний нөлөөнд саад болж байж болох таны хийдэг ямар нэгэн зүйл байгаа

эсэхийг дүгнэн бод. Сүнсийг хүлээн авч, Сатаны хүчийг эсэргүүцэхэд тань туслах, шаардлагатай өөрчлөлтүүдийг хийхийн тулд Есүс Христийн Цагаатгалын хүчийг хэрхэн татаж болохоо эргэцүүлэн бод.

Ифер 13–15-аас бид **уур хилэн, өс хонзон нь бусдад болон өөрсдөдөө хор хөнөөлтэй сонголтуудыг хийхэд биднийг удирддаг гэдгийг суралцдаг**. Дараах шүлгүүдийг уншаад эсвэл дахин уншаад энэхүү үнэнийг заасан үг, хэллэгүүдийг тэмдэглэ: Ифер 13:27; 14:24; 15:6, 22, 28.

Хяналтгүй уур хилэн гэр бүл эсвэл бусад харилцаануудад ямар үр дагавар авчирч болохыг тунгаан бод. Уур хилэн, өс хонзонгийн мэдрэмжээ орхих хэрэгтэй амьдралынхаа нэг нөхцөл байдлын талаар бод.

Далын гишүүн байгаад чөлөөндөө гарсан ахлагч Дэвид Э.Сорэнсэний хэлсэн дараах үгсийг уншихдаа, уур хилэнгийн мэдрэмж болон өс хонзон эрэлхийлэх хүслээ хэрхэн даван гарч болохыг олж мэд: “Хэн нэгэн биднийг эсвэл бидний хайртай хүмүүсийг гомдоох, тэдэнд муу зүйл хийх үед шаналал зовлон нь бараг л дааж давшгүй мэт байдаг. Энэ нь шаналал зовлон эсвэл шударга бус байдал дэлхий дээрх хамгийн чухал зүйл бөгөөд өс хонзон эрэлхийлэхээс өөр ямар ч сонголт байхгүй мэт санагддаг. Гэвч Христ буюу Энх Амгалангийн Ханхүү бидэнд илүү дээр замыг заадаг. Бидэнд хийсэн муу зүйлийнх нь төлөө хэн нэгнийг уучлах үнэхээр хэцүү байдаг ч уучилсан үедээ бид илүү сайн ирээдүйд өөрсдийгөө нээж өгдөг. Бусдын хийсэн буруу зүйлс бидний замыг дахин хянаж чадахгүй. Бусдыг уучлах үедээ бид хэрхэн амьдрахаа өөрсдөө сонгох

чөлөөтэй болдог. Уучлалт гэдэг нь өнгөрсөн үеийн асуудлууд бидний хувь тавиланг дахин захирахгүй бөгөөд бид зүрх сэтгэлдээ Бурханы хайрыг агуулан ирээдүйд анхаарлаа хандуулж болно гэсэн үг юм (“Forgiveness Will Change Bitterness to Love,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2003 оны 5-р сар, 12).



3. Дараах асуултад судар судлах тэмдэглэлдээ хариулж бич: Хэзээ та эсвэл таны таньдаг хэн нэгэн уучлахыг сонгосны дараа эдгэрэл болон эрх чөлөөг мэдэрч байсан бэ?

Хэрэв та Есүс Христэд хандаж, Түүний Цагаатгалаар дамжуулан уучлалт болон тайвшралын хүчийг хүлээж авбал уур хилэн, өс хонзонгийн ямар ч мэдрэмжийг даван гарч чадна. Тийм тохиолдолд хэрэгтэй тусламжийн төлөө залбирлаар Их Эзэнд хандахаа санаарай.



4. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Ифер 13–15-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

Хичээлийн эхэнд гарсан тохируулах даалгаврын хариу: Египетийн Кайро хот (Мянган цамхагтай хот); Филиппиний Манила хот (Дорнын сувд); АНУ-ын Чикаго хот (Салхит хот); Мексикийн Мехико хот (Харшуудын хот); Италийн Ром хот (Мөнхийн хот).

Моронайн ОРШИЛ

Яагаад энэ номыг судлах хэрэгтэй вэ?

Моронайн номыг судалснаар та Моронайн хүчирхэг жишээ болон гэрчлэлээс эрч хүчийг авах боломжтой. Үүнээс гадна, Моронай болон түүний эцэг Мормоны заасан зүйлсээс та Есүс Христийн сүмийн үндсэн ёслолууд болон заншлыг, зөв шударга үйлийг чин сэтгэлээсээ хийхийн ач холбогдлыг, сайн муугийн хооронд шүүх арга замыг, итгэл, найдвар, энэрлийн уялдаа холбооны талаар суралцах болно. Түүнчлэн та Мормоны Ном үнэн болохыг өөрөө мэдэж авахын тулд залбирч, “Христэд ирж, түүгээр төгөлдөржигтүн” хэмээх Моронайн ухуулгыг унших болно (Моронай 10:32).

Энэ номыг хэн бичсэн бэ?

Моронай өөрийнх нь үгс, Есүс Христийн арванхоёр шавьдаа хэлсэн үгс (Моронай 2-ыг үзнэ үү) болон түүний эцэг Мормоны үгсийг агуулсан (Моронай 7–9-ийг үзнэ үү) энэхүү номыг бичсэн. Нифайчуудын устгалаас өмнө Моронай тэдний цэрэг болон сүмийн удирдагчаар үйлчилж байсан (Мормон 6:12; Моронай 8:1-ийг үзнэ үү). Моронай Мормоны Номын бусад бичээч болон эмхэтгэгчдийн адил Аврагчийг харсан. Тэрээр “Би Есүсийг харсан, мөн . . . тэрээр надтай нүүр тулан ярьсан” хэмээн гэрчилсэн (Ифер 12:39). Моронай гэрчлэлдээ үнэнч, итгэлтэй байсан бөгөөд Христийг үгүйсгэснээс үхсэн нь дээр хэмээн өөрийн хүслийг онцлон хэлсэн байдаг (Моронай 1:1–3).

1823 онд буюу Мормоны Номын цэдгийг дуусгаснаас ойролцоогоор 1,400 жилийн дараа Моронай амилуулагдсан биедээ бошиглогч Иосеф Смитэд үзэгдэж, түүний гэрийн ойролцоох гүвээнд уг цэдэг хадгалагдсан байгааг мэдэгджээ. Тэр үед болон дараагийн хэдэн жилийн турш “Их Эзэн юу хийх гэж буй тухай, мөн түүний хаант улс хэрхэн бас ямархуу маягаар эцсийн өдрүүдэд удирдагдах” талаар Моронай Иосеф Смитэд түүнчлэн зааварлажээ (Иосеф Смит—Түүх 1:54).

Энэ ном хаана, хэзээ бичигдсэн бэ?

Моронай энэ номыг мэ 401-ээс мэ 421 оны хооронд (Мормон 8:4–6; Моронай 10:1-ийг үзнэ үү) амь насныхаа аюулгүй байдлын төлөө бэдрэн явахдаа (Мормон 1:1–3-ыг үзнэ үү) бичсэн байх магадлалтай юм.

31-Р ХЭСЭГ: 2 ДАХЬ ӨДӨР

Моронай 1–5

Оршил

Иферийн ялтсуудыг хураангуйлж дууссаныхаа дараа Моронай “би өөрийг бичнэ хэмээн бодсонгүй” гэж тайлбарласан (Моронай 1:1). Гэсэн хэдий ч тэр эцсийн өдрүүд дэх тэдэнд “чухал байж магад хэмээх тул өөр цөөн хэдэн зүйл бичихээр” болгогдов (Моронай 1:4). Моронай 1–5 нь Моронайн Есүс Христэд итгэх итгэлийг нотолдог. Тэдгээр нь мөн ариун ёслолыг гүйцэтгэх зэрэг сайн мэдээний чухал ёслолуудын зааврыг товч өгүүлдэг.

Моронай 1

Моронай амь насныхаа аюулгүй байдлын төлөө бэдрэн явж, бичиглэлээ үргэлжлүүлэв

Далын гишүүн байгаад чөлөөндөө гарсан ахлагч Дэвид Э.Сорэнсэн өөрийн итгэлийн төлөө бат зогсох зоригтой нэгэн залуу эмэгтэйн тухай дараах түүхийг хуваалцжээ:

“Миний ач охин Жэннифэр сургуулийнхаа хэдэн найзтай хамт оройн хоол идэж, кино үзэхэд уригдсан юм. Бүх охид ямар кино үзэхээ санал нэгтгэйгээр шийдсэн байсан бөгөөд Жэннифэрт ч аятайхан санагдав. Гэвч хоолны үеэр киноны тасалбар авахаар явсан охин өөр киноны тасалбар авчрав. Тэрээр ‘Ёстой гоё бас зөвхөн насанд хүрэгчдэд зориулсан кино юм аа’ гэжээ.

“Жэннифэр байдал ийм хурдан өөрчлөгдсөнд итгэж чадахгүй гайхан байв. Гэхдээ аз болж тэрээр ийм нөхцөл байдалд орохоосоо өмнө насанд хүрэгчдэд зориулсан кино үзэхгүй гэсэн шийдвэрийг гаргасан байсан ажээ. Тэрээр найзууддаа хандан шийдэмгийгээр ‘Би насанд хүрэгчдэд зориулсан кино үзэж болохгүй. Аав, ээж минь зөвшөөрөхгүй’ гэж хэлж чаджээ. Охид түүнд ‘Алив ээ! Аав ээж чинь энэ талаар хэзээ ч мэдэхгүй ээ!’ гэлээ. Жэннифэр үүний эсрэг ‘Ер нь аав ээж энэ талаар мэдэх эсэх нь хамаагүй. Би насанд хүрэгчдэд зориулсан кино үздэггүй!’ гэж хэлжээ.

“Найзууд нь уцаарлаж, түүний санааг өөрчлөхийг хичээж байв. Тэд түүнд ‘чи бүх юмыг баллаж байна’ гэж хэлжээ. Түүнийг санаагаа өөрчлөхгүй болохоор нь тэд тасалбар, хариулт мөнгийг түүний нүүр рүү шидээд насанд хүрэгчдэд зориулсан кино үзэхээр түүнийг орхин явав. Энэ орой найзуудынх нь эсэргүүцлээр дүүрсэн, ганцаардмал орой байсан ч Жэннифэр болон манай гэр бүлийн хувьд гайхалтай

мөч байлаа. Тэр итгэлтэй байдал, хувийн үнэ цэнэ, сүнслэг хүчийг олж авсан юм (“You Can’t Pet a Rattlesnake,” *Ensign*, 2001 оны 5-р сар, 42).

Моронай 1:1–3-ыг уншаад Моронай итгэлийнхээ төлөө хэрхэн ганцаараа бат зогссоныг олж мэд. Моронай, ахлагч Сорэнсэний ач охин хоёр хоёулаа зөв гэж мэддэг зүйлийнхээ төлөө бат зогсохыг сонгож чаддаг хүмүүсийн жишээ болж байна. Та ч бас өдөр бүр итгэл, дуулгавартай байдал, Христийг дагах хүслээ харуулах жижиг мэт санагдах шийдвэрүүдийг гаргаж чадна.



1. Итгэлийнхээ төлөө зогсох эсвэл дуулгавартай байдлаараа дамжуулан итгэлээ харуулахыг сонгож байсан үеийнхээ талаар судар судлах тэмдэглэлдээ бич.

Есүс Христэд итгэх итгэлийнхээ төлөө хэрхэн илүү сайнаар зогсож чадах тухайгаа бод. Моронай яагаад илүү ихийг бичих болсныг мэдэхийн тулд Моронай 1:4-ийг унш. Өөрийнх нь амийг авахаар эрэлхийлж байсан тэдний үр удамд зориулан илүү ихийг бичих Моронайн урам зориг болон үлгэр жишээнээс бид юу сурч болох вэ? Та өөрийн үр удамд зориулан тэдэнд адислал байж болох юу бичих вэ? Моронай 2–5-ыг судлахдаа, Моронайн бичихээр сонгосон зүйлс нь таны хувьд хэрхэн “үнэ цэнэтэй” болж байгаа тухай эргэцүүлэн бод (Моронай 1:4).

Моронай 2

Моронай Ариун Сүнсний бэлэг өгөх зааврыг бичив

Сүмийн гишүүнээр батлуулж, толгой дээрээ гар тавиулан Ариун Сүнсний бэлгийг хүлээж авч байсан туршлагынхаа тухай бод. Энэ ёслолын талаар та юу санаж байна вэ? Моронай 2:1–3-ыг уншаад Ариун Сүнсний бэлэг таны амьдралд хэрхэн адислал болж байгаа талаар эргэцүүлэн бод.

Эдгээр шүлгүүдэд заагдаж байгаа сайн мэдээний нэгэн үнэн бол: **Санваарын зохих эрх мэдэлтэй зохистой гишүүд баптисм хүртсэн гишүүдийн толгой дээр гараа тавьж, Ариун Сүнсний бэлгийг өгч болно** хэмээх үнэн юм.

Моронай 3

Моронай санваарын албанд хүмүүсийг томилох зааврыг бичив

Та хэн нэгний санваарын эрх мэдлийн шугамын бүртгэлийг харж байсан уу? Энэхүү бүртгэл нь тэр хүнийг хэн санваарт томилсон, томилсон хүнийг нь хэн томилсон гэх мэт явсаар Есүс Христэд хүрдгийг үзүүлдэг. Танд санваарын эрх мэдлийн шугамын тань хуулбар байгаа байх эсвэл ах юмуу аавынхыгаа харж байсан байж магадгүй. Арванхоёр

Төлөөлөгчийн чуулгын ахлагч Жэффри Р.Холландын хэлсэн дараах үгсийг уншихдаа эрх мэдлийн шугам Есүс Христ хүртэл явж байгаагийн утга учрын талаар бод:



“Тэнгэрлэг эрх мэдэлтэйгээр үйлдэх нь энгийн нэг нийгмийн хэлэлцээрээс илүү ихийг шаарддаг нь тодорхой. Энэ нь шашны сургалт эсвэл цуглаанаас ирсэн үүрэг даалгавраар бий болох боломжгүй. Үгүй, Бурханы томилсон ажлын хувьд сүмийн суудал дээр сууж байгаа, гудамжинд явж байгаа эсвэл семинарт хамрагдаж байгаа хүмүүст байгаагаас илүү агуу хүч байх ёстой. Олон шударга шашин эрэлхийлэгчид үүнийг мэдэж байсан бөгөөд сэргээлт рүү хөтөлсөн хугацааны турш нээлттэй хүлээн зөвшөөрсөн. . . .

“ . . . Есүс Христийн сэргээгдсэн сүмд бид тойрогдах шинээн дикон, түүнийг тэргүүлдэг бишоп болон бид бүхнийг тэргүүлдэг бошиглогчийн ашигладаг санваарын эрх мэдлийн шугамыг дагуулан харж болно. Тэрхүү шугам нь тасралтгүй гинжин хэлхээгээр Бурханы Хүүгээс Өөрөөс нь ирсэн, тэнгэрээс энэхүү зүйрлэшгүй бэлгийг хуваалцсан тэнгэрлэг үйлчлэгчдэд хүрдэг” (“Our Most Distinguishing Feature,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2005 оны 5-р сар, 44).

Аароны эсвэл Мелкизедек санваарыг хүлээж авах хүн бүр тодорхой үүргүүдийг багтаасан санваарын албанд томилогддог. Моронай 3:1–4-ийг уншаад прист эсвэл багшийн албыг багтаасан санваарын албанд хүмүүсийг хэрхэн томилдгийг олж мэд.

Та судартаа эдгээр шүлгүүдийн хажууд дараах үнэнийг бичих хэрэгтэй: **Хувь хүмүүс эрх мэдэл бүхий хүмүүсээр толгой дээрээ гар тавиулан санваарын албанд томилогддог.**



2. Дараах асуултуудад судар судлах тэмдэглэлдээ хариулж бич:

- а.** Хувь хүн санваарыг атгадаг хүнээр санваарын албанд томилогдох нь таны бодлоор яагаад чухал вэ?
- б.** Сүмд эсвэл гэр бүлдээ санваарын эрх мэдэлтэй байх нь таны хувьд хэрхэн үнэ цэнэтэй байдаг вэ?

Моронай 4–5

Моронай ариун ёслолыг хэрхэн гүйцэтгэхийг тайлбарлав



3. Ариун ёслолын бэлгэдэл болон ариун ёслолоос хүртдэг байсан туршлагынхаа талаар бод. Дараа нь доорх зүйлийг судар судлах тэмдэглэлдээ хий:

- а.** Хамгийн сайнаараа хичээгээд талх юмуу ус адислах ариун ёслолын залбирлыг цээжээр бич.
- б.** Энэхүү ариун залбирлуудыг дахин харж, (Моронай 4:3; 5:2) даалгаврыг хэрхэн гүйцэтгэсэнээ шалгасны дараа таны



хувьд онцгой санагдсан залбирлын нэг хэсгийг бичээд энэ хэсэг нь яагаад таны хувьд утга учиртай болохыг тайлбарла.

Моронай “ирээдүйн нэг өдөр” хүмүүст “чухал” байж магад хэмээн бодсоны учир өөрийн цэдэгт ариун ёслол гүйцэтгэх залбирлуудыг багтаасан (Моронай 1:4). Моронай 4:1–3 болон 5:1–2-ыг уншаад ариун ёслолын талх, ус нь юу төлөөлдгийг тайлбарладаг хэллэгүүдийг олж тодорхойл. Уншихдаа сүм өнөө үед бошиглогч Иосеф Смитэд өгөгдсөн илчлэлтийн үр дүнгээр ариун ёслолд дарсны оронд ус ашигладгийг санах нь тустай байж болох юм (С ба Г 27:2-ыг үзнэ үү).

Энэ өгүүлбэрийг гүйцээн бичиж, ариун ёслолын зорилгыг тоймло: Ариун ёслолын бэлгэдлүүд нь _____

–г санахад бидэнд тусалдаг.

Аврагчийн бие болон цус нь таны хувьд яагаад чухал болохыг гүйцээж бич.

Аврагчийн биеийн үхэл, амилуулалт болох биеийн зовлон шаналал, Түүний цус урсалтаар нотлогдсон сүнслэг зовлон шаналал нь Түүнд итгэх итгэлээ бодитой болгож, наманчилсан бүх хүний нүглийн ангижралыг боломжтой болгосон. **Ариун ёслолын бэлгэдлүүд нь бидэнд Есүс Христийн Цагаатгалыг дурсан санахад тусалдаг.**



4. Дараах асуултуудын нэгэнд эсвэл хоёуланд нь судар судлах тэмдэглэлдээ хариулж бич:

а. Ариун ёслолын турш Аврагчийн Цагаатгалын талаар чин сэтгэлээсээ тунгаан бодох нь танд хэрхэн тусалж, таныг сүнслэгээр хүчирхэгжүүлсэн бэ?

б. Ариун ёслолын турш Аврагчийн Цагаатгалыг дурсан санахад анхаарлаа илүү сайн хандуулахын тулд та юу хийж чадах вэ?

Ариун ёслолоос хүртэхдээ та өөрөө юу хийнэ гэж амладгаа ойлгохын тулд Моронай 4:3-ыг дахин уншаад дараах хүснэгтийг бөглө:

Миний хийхээр гэрээлсэн зүйлс	Гэрээний энэ хэсгийг биелүүлэх нь ийм утга учиртай гэж бид боддог	Гэрээний энэ хэсгийг илүү сайн дагахын тулд миний хийж чадах зүйлс
1.		
2.		
3.		

Бид Моронай 4:3-аас ариун ёслолын гэрээн дэх өөрсдийн хэсгийг итгэлтэйгээр дагаснаар Их Эзэний Сүнс үргэлж бидэнтэй хамт байх болно гэдгийг мөн адил сурдаг.

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Дэвид А.Бэднарын хэлсэн дараах үгсийг уншихдаа түүний дурдсанаар та Ариун Сүнсний бэлгийг хэрхэн мэдэрч байсан тухайгаа бод: “Их Эзэний Сүнс бидний хөтөч байж, мөнх бус аяллын турш удирдамж, заавар, сүнслэг хамгаалалтаар биднийг адисалдаг (“That We May Always Have His Spirit to Be with Us,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2006 оны 5-р сар, 31).

Ням гарагт ариун ёслолоос хүртэхдээ Аврагчийн Цагаатгалын талаар тунгаан бодоорой. Их Эзэний Сүнс үргэлж тантай хамт байж болохын тулд хүснэгтэд бичсэн гэрээний хэсгүүдээ сахихыг хичээгээрэй.



5. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Моронай 1–5-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

Моронай 6


Оршил

Моронай сүмд баптисм хүртэхэд бэлдэх зарим шалгуурыг тайлбарлаж, ялтсууд дээр бичихээ төгсгөл болгоход ойртжээ. Дараа нь тэрээр бусад гишүүдээ халамжлах ёстой гэсэн сүмийн гишүүдийн үүргийг тоймлов. Моронай түүнчлэн сүмийн цуглаануудын зорилгыг тайлбарлаж, сүмийн цуглаанууд нь Ариун Сүнсний нөлөөн дор удирдагдах ёстойг онцлов.

Моронай 6:1–3

Моронай баптисмын шаардлагуудыг илэрхийлэв

Танд хэдэн сарын дараа найман нас хүрэх гэж байгаа дүү байгаа гэж төсөөл. Аав ээж тань танаас баптисмд хэрхэн бэлдэх тухай хичээл гэр бүлийн үдэш дээр заагаач гэж хүсжээ.


-  **1.** Хэрвээ та яг одоо энэ хичээлийг заах байсан бол баптисм хүртэхэд бэлдэхэд нь дүүдээ туслахын тулд юу заах байсан бэ? Бодож байгаа зүйлсээ судар судлах тэмдэглэлдээ бич.



Цэдэгтээ ариун ёслолын залбирлыг оруулсныхаа дараа (Моронай 4–5-ыг үзнэ үү) Моронай баптисмын ёслолын талаар заавар нэмсэн. Моронай 6:1–3-ыг судлаад баптисмын шаардлагуудыг ол. Олж тодорхойлсон шаардлагуудаа судартаа тэмдэглэж болно.

Таны бодлоор баптисм хүртэхийг хүсч буй хүмүүс “зохистой байгаагаа үзүүлэхүйц үр жимс” авчрах гэдэг нь ямар утгатай вэ? (Моронай 6:1). _____

Баптисм хүртэхээсээ өмнө “харууссан зүрх болоод гэмшсэн сэтгэлтэй” байх нь (Моронай 6:2) ямар утгатай болохыг тунгаан бод. Моронай 6:1–3-д гарсны дагуу Моронай **баптисмаар дамжуулан бид Есүс Христийн нэрийг өөрсөд дээрээ авч, эцсээ хүртэл Түүнд үйлчлэх гэрээ хийдэг гэдгийг тайлбарлав.** Есүс Христэд үйлчлэх зорилготой байж, үүнийгээ хүчирхэгжүүлэхийн тулд та юу хийж байгаа вэ?

-  **2.** Баптисм хүртсэнээсээ хойш Есүс Христэд үйлчлэх зорилготой байж, үүнийгээ хүчирхэгжүүлэхийг хичээж байсан зарим арга замуудаа судар судлах тэмдэглэлдээ дүрслэн бич.

Моронай 6:4

Моронай сүмийн гишүүдийг хэрхэн халамжилж, сүнслэгээр тэжээхийг тайлбарлав

Хувь хүмүүс баптисм хүртэхээсээ өмнө хийх шаардлагатай зүйлсийг тайлбарласныхаа дараа Моронай баптисм хүртсэн шинэхэн гишүүд гэрээндээ хэрхэн итгэлтэй хэвээр үлдэх талаар тайлбарлав. Моронай 6:4-ийг уншаад шинэ гишүүд итгэлтэй хэвээр үлдэхэд нь туслах юу хийснийг ол.

Сүмийн бусад гишүүдийн төлөө хүлээсэн ямар үүрэг танд байгаа тухай Моронай 6:4-өөс сурсан зүйлээ тоймлон бич. _____

Бурханы үгээр тэжээгдсэнээс ирэх ямар адислалуудыг Моронай 6:4-т заадаг вэ?

Моронай 6:4-д заасан нэг чухал үнэн бол **сүмийн бусад гишүүдийг санаж, сүнслэгээр тэжээх үүрэг хариуцлага бидэнд байдаг** хэмээх үнэн юм.

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Жэффри Р.Холланд бие биенээ Бурханы үгээр тэжээхийн чухлыг гэрчилсэн юм: “Хэдийгээр эдгээр нь бүгд чухал ч гэсэн ихэнх хүмүүс сүмд зүгээр л сайн мэдээний хэдэн шинэ нотолгоо хайж эсвэл хуучин найзуудтайгаа уулзах гэж ирдэггүй. Тэд сүнслэг туршлагыг хайж ирдэг. Тэд амар амгаланг хүсдэг.

Тэд итгэлээ бэжжүүлж, найдвараа шинэчлэхийг хүсдэг. Товчхон хэлбэл тэд Бурханы сайн үгээр тэжээгдэж, тэнгэрийн хүчээр хүчирхэгжихийг хүсдэг. Ярьж, зааж, удирдахаар дуудагдсан бид тэдэнд чадах чинээгээрээ туслах үүрэгтэй” (“A Teacher Come from God,” *Ensign*, 1998 оны 5-р сар, 26).

Хэчнээн олон хүн таны төлөө залбирч, хичээл бэлдэж, таныг урамшуулж, сүмд идэвхтэй байхыг дэмжиж, сорилт бэрхшээл тулгарахад танд тусалж байсан тухай та бодож байсан уу?



3. Таныг чухал үед санасан эсвэл таныг сүнслэгээр тэжээсэн хоёр юмуу гурван хүний тухай судар судлах тэмдэглэлдээ бич.

Хэн нэгэн таныг санаж, Бурханы үгээр тэжээсэн учраас та хэр их адислагдсан тухайгаа гэр бүлийн гишүүн эсвэл найзтайгаа ойрын хугацаанд ярилц.

Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх, Ерөнхийлөгч Хэнри Б.Айринг чуулгынхаа бусад гишүүдийн төлөөх өөрийн үүрэг хариуцлагыг гүйцэлдүүлэхийн чухлыг санасан тойргийнхоо нэгэн диконы түүхийг ярьсан юм:



“Түүний чуулгын нэг гишүүн манай гэрийн ойролцоо амьдардаг байсан юм. Манай хөрш хүү чуулгын хуралд хэзээ ч оролцож байгаагүй бөгөөд чуулгын гишүүдтэй хамт ямар ч зүйл хийж байгаагүй. Түүний хойд эцэг нь сүмийн гишүүн биш, ээж нь сүмд явдаггүй байлаа.

“Тэдний диконы чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл нэгэн ням гаргийн өглөө хуралджээ. . . . Ерөнхийлөгчийн зөвлөлийн хурлын үер эдгээр 13 настай хоньчид хэзээ ч ирж байгаагүй тэр хүүг санажээ. Тэдний хүлээж авсан зүйлс нь тэр хүүд хэчнээн хэрэгтэй болох талаар тэд ярилцав. Ерөнхийлөгч нь нэг зөвлөхөө тэрхүү төөрсөн хонины араас явуулахаар томилжээ.

“Тэр зөвлөх би хүүг танина, ичимхий гэдгийг нь ч мэдэх бөгөөд тэрхүү үүрэгт ажлын хэцүүг бас мэднэ. Тэгээд тэр хүү манай гэрийн хажуугаар сүмд ирдэггүй хүүгийн гэр рүү замаар бодлогошронгуй явахыг би цонхоороо харж байлаа. Хоньчин халаасандаа гараа хийжээ. Тэр газар ширтэн алхана. Хүрэх газар руугаа очихыг хүсч байгаа эсэхдээ эргэлзэж байгаа мэт тэрээр удаан алхаж байлаа. 20 орчим минутын дараа тэрээр төөрсөн диконы хамт замаар уруудан алхаж байв. Тэрхүү үзэгдэл хэд хэдэн ням гарагт давтагдлаа. Төөрч мөн олдсон хүү удалгүй өөр тийшээ нүүв.

“. . . Олон жилийн дараа би тэрхүү ерөнхийлөгчийн чуулга хуралдсан өрөөнөөс бүхэл бүтэн тив алгасан нэгэн гадасны чуулганд оролцож байлаа. Нэгэн

буурал үстэй эр над руу хүрч ирээд намуухнаар ‘Олон жилийн өмнө миний ач хүү танай тойрогт амьдардаг байсан юм’ гэж хэллээ. Тэрээр надад ач хүүгийнхээ амьдралын талаар хүндлэлтэйгээр ярьсан юм. Тэгээд тэр замаар өгсөн удаан алхаж байсан диконыг олж чадах эсэхийг надаас асуусан. Түүнд талархаж байгааг нь мөн ач хүү нь одоо эрийн цээнд хүрсэн бөгөөд одоо хүртэл тэр талаар санадаг гэдгийг дамжуулан хэлж өгөхийг надаас хүссэн юм” (“Watch with Me,” *Ensign*, 2001 оны 5-р сар, 38–39).

Их Эзэн таныг “санаж” эсвэл “тэжээгээсэй” хэмээн хүсч байж болох тодорхой хүмүүсийн талаар бод. Тэднийг сүнслэгээр тэжээж болох аргаа төлөвлө. Тэдний нэрийг цаасан дээр бичээд санахад тань туслах газарт байрлуул.

Моронай 6:5–9

Моронай сүмийн хурал цуглаануудын зорилго болон хэрхэн удирдан явуулах ёстойг тайлбарлав

Өөрийгөө сүүлийн хэдэн долоо хоног сүмд явах нь утгагүй, уйтгартай болохоор сүмд явахыг хүсэхгүй байна гэж хэлж байгаа өсвөр үеийн хүүхдийн эцэг эх хэмээн төсөөл. Хүүхэддээ сүмд тогтмол явах зөв шалтгаануудыг ойлгож, сүмд явахад нь урамшуулан дэмжихийн тулд юу хэлэхээ эргэцүүлэн бод.

Моронай цэдэгтээ түүний амьдарч байсан өдрүүдэд сүмийн гишүүдийн цугларч байсан шалтгааныг тайлбарлахаар сүнсээр нөлөөлөгджээ. Моронай 6:5–6-г уншаад дараах өгүүлбэрийг хэрхэн гүйцээж бичиж болохыг ол: **Сүмийн гишүүд бид** _____

_____ -н тулд ойр ойрхон цугладаг.

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Даллин Х.Өүкс сүмд явах талаарх хандлагаа өөрчилснөө илэрхийлсэн найзынхаа захианы хэсгээс хуваалцсан юм.



“Нэгэн ухаант найз минь ингэж бичсэн юм:

“‘Олон жилийн өмнө би сүмд явах хандлагаа өөрчилсөн юм. Би зөвхөн өөрийнхөө төлөө сүмд явахаа больж, харин бусдын төлөө явах болсон. Би ганцаараа сууж буй хүмүүст сайн уу гэж хэлэх, айлчлагчдад тавтай морилохыг урьж, . . . ямар нэгэн үүрэг даалгаврыг сайн дураараа хийх болсон. . . .

“Товчхондоо, би долоо хоног бүр бусдаар үйлдүүлэлгүй, идэвхтэй байх зорилготойгоор мөн хүмүүсийн амьдралд эерэг өөрчлөлтүүдийг хийхээр явдаг болсон юм. Ингэснээр сүмийн цуглаануудад

оролцох миний оролцоо илүү их утга учиртай мөн үр дүнтэй болсон.’

“Энэ бүхэн нь авахын төлөө биш, өгөхийн төлөө үйлдэж мөн үйлчлэх үедээ бид илүү аз жаргалтай, үр дүнтэй байдаг гэсэн мөнхийн зарчмыг харуулж байна” (“Unselfish Service,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2009 оны 5-р сар, 107).


Та дээрх өгүүлбэрийг бөглөхдөө дараах санаануудаас заримыг нь бичсэн байж магадгүй.

Сүмийн гишүүд бид . . . -н тулд ойр ойрхон цугладаг

- мацаг барьж залбирах
- бие биенээ сүнслэгээр хүчирхэгжүүлэх
- Их Эзэн Есүс Христийн дурсамжтайгаар ариун ёслолоос хүртэх

Тойрог юмуу салбарынхаа гишүүдтэй хамт мацаг барьж, залбирахын чухлыг танд заасан туршлагаа сана.



 **4.** Дараах асуултуудад судар судлах тэмдэглэлдээ хариулж бич:


- Хэрэв та бусдыг сүнслэгээр хүчирхэгжүүлэх хүсэлтэйгээр оролцвол сүм дэх туршлагауд тань хэрхэн өөрчлөгдөх бол?
- Есүс Христийн дурсамжтайгаар ариун ёслолоос тогтмол хүртэх нь яагаад үнэ цэнэтэй вэ?
- Дээр жагсаан бичсэн зорилгуудын төлөө сүмд очих нь “[таныг] зөв замд байлгахад” хэрхэн туслах вэ? (Моронай 6:4).

Моронай 6:7–8-ыг уншаад Моронайгийн үед байсан сүмийн гишүүд юуг “дагаж мөрдөхдөө чанд”, өөрөөр хэлбэл тэд юунд онцгой анхаарал хандуулдаг байсныг ол. Бид бие биедээ нүглээс хол байж, наманчлах хэрэгтэй гэж урамшуулж, заах нь яагаад чухал гэж та бодож байна вэ?

Моронай бид үнэн хүсэлтэйгээр наманчилж, өршөөлийг ойр ойрхон гуйвал өршөөгдөх болно хэмээн гэрчилжээ. Та энэхүү үнэнийг Моронай 6:8-д тэмдэглэх хэрэгтэй.

Моронай энэ бүлгийг манай сүмийн цуглаанууд хэрхэн удирдагдах ёстойг зааснаар дуусгав. Моронай 6:9-ийг уншаад сүм дэх цуглаануудыг хэн удирдах ёстойг тодорхойл. Сүмийн цуглааны үеэр ялангуяа Ариун Сүнсний нөлөөг мэдэрч байсан үеэ бод.

Сүмийн цуглаанууд Ариун Сүнсний хүчээр удирдагдах ёстой гэдэг зарчим нь танд хэрхэн хамаарах вэ? Танаас сүмийн цуглааны үеэр үг хэлэх эсвэл хичээл заахыг хүссэн бол тухайн цуглаан дээр таны хэлэх үгс Ариун Сүнсний удирдамж ба нөлөөг дэмждэг болохыг батлахад та хэрхэн тусалж чадах вэ?

 **5.** Ирэх ням гаргийн сүмийн цуглааныг хэрхэн утгах төлөвлөгөөгөө судар судлах тэмдэглэлдээ бич. Шүтлэг бишрэлдээ Ариун Сүнсийг урих арга замууд болон өөрийнхөө оролцоогоор бусдыг хэрхэн санаж, тэжээж болох тухайгаа бичиж болно.

 **6.** Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Моронай 6-р бүлгийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

31-Р ХЭСЭГ: 4 ДЭХ ӨДӨР

Моронай 7:1–19

Оршил

Моронай өөрийн эцэг болох Мормоны “хайрт ах дүү нартаа” олон жилийн өмнө өгсөн яриаг бичсэн (Моронай 7:2). Энэхүү хичээл Моронай 7-д оршдог Мормоны ярианы эхний хэсгийг хамарна. Энэ нь үнэн хүсэлтэйгээр шударга үйл хийх талаар түүнийг заасан зүйлс болон биднийг сайн мууг хэрхэн ялгаж



болохын тайлбарыг нь өгүүлдэг. Дараагийн хичээлд та Моронай 7-д буй Мормоны ярианы үлдсэн хэсгийг нь судлах болно.

Моронай 7:1–10

Мормон Есүс Христийг дагадаг хүмүүст үйлдэл ба хүслийн талаар заадаг

Та гаднаас сайн харагддаг боловч дотроо муу зүйлийг үзэж байсан уу? Хүчиллэг эсвэл муудсан алим үүний нэг жишээ байж болно. Өөрөө хоёроос гурван жишээ бодож олоод бич: _____

Гаднаас сайн харагддаг боловч дотроо сайн биш зүйлийг хүмүүсийн гаднах төрх, доторх хүсэлтэй хэрхэн харьцуулж болохыг тунгаан бод. Моронай биднийг шударга үйл хийхэд зүрх сэтгэл маань ямар байдалтай байдаг талаарх өөрийн эцэг болох Мормоны үгсийг нь бичжээ. Моронай 7:2–3-ыг уншиж, Мормоны хандан ярьж байсан сонсогчдыг тодорхойл.

Мормон ах дүү нараа “Христийн амгалан дөлгөөн дагалдагчид” гэж дуудсан бөгөөд тэдэнд хандан ярьж байжээ (Моронай 7:3). Моронай 7:4–5-ыг судалж Мормоныг эдгээр нифайчуудыг Аврагчийн жинхэнэ дагалдагчид мөн гэдгийг нь яаж мэдсэнийг ол.

Хүн зүгээр л зөв шударга юм шиг дүр үзүүлж болдог уу? Тийм бол яагаад, үгүй бол яагаад?

Мормон Моронай 7:6-д үүний талаар ярьсан. Энэ шүлгийг судлахдаа та “үнэн сэтгэлээсээ” гэдэг үгийг тэмдэглэх хэрэгтэй. Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Даллин Х.Өүксийн дараах тайлбар танд үнэн сэтгэлтэй байхын утга учрыг ойлгоход тусалж болно. Түүний тайлбараас танд онцгой анзаарагдах хэсгүүдийг тэмдэглэ.

“Бид зөвхөн зөвийг хийх ёсгүй. Бид зөв шалтгааны төлөө үйлдэх ёстой. Үүнийг орчин үед *сайн үндэслэлтэй байх гэдэг*. Судар дээр энэ зохистой сэтгэлийн хандлагыг *зүрх сэтгэлийн бүх тэмүүлэл* эсвэл *үнэн сэтгэл* зэрэг үгсээр илэрхийлдэг.

“Бурхан бидний үндэслэлийг ойлгож, үүний дагуу бидний үйлдлийг шүүнэ гэдгийг судрууд тодорхой болгодог” (*Pure in Heart* [1988 он], 15).

Мормон үнэн сэтгэлгүйгээр сайн үйлийг хийхийг эрэлхийлж байгаа хүний үр дүнг тайлбарласан. Моронай 7:7–10-ыг уншиж, биднийг зөв сэтгэлгүйгээр шударга үйл хийхийн үр дагаврыг тодорхойл. Эдгээр шүлгүүдээс бид **сайн үйлийн төлөө адислагдахын тулд бид тэдгээрийг үнэн сэтгэлээсээ хийх ёстой гэдгийг сурдаг**. Үнэн сэтгэл гэдэгт

Бурхан болон бусдыг хайрлах хайрын улмаас сайн үйлийг хийх нь хамаардаг.



1. Дараах асуулыг судар судлах тэмдэглэлдээ хариулж бич: Та сайн үйлийг хувиа бодон хийх ба үнэн сэтгэлээсээ хийх хоёрын хооронд ямар ялгаа анзаарсан бэ?



2. Сайн үйлийн төлөө адислагдахын тулд бид тэднийг үнэн сэтгэлээсээ хийх ёстой гэдэг зарчмыг ойлгоход тань туслах дараах жишээг бодож үз: Мормоны Номыг уншиж байгаа таны нэг найз Моронай 7:9-ийг ойлгоход таниас тусламж гуйж, танд “Би үнэн сэтгэлгүйгээр залбирдаг хүнийг ‘энэ нь түүнд ямар ч ашиггүй, учир нь Бурхан тийм нэгийг ч хүлээн авдаггүй’ гэдгийг уншсан” гэж хэлжээ. Би ихэнхдээ үнэн сэтгэлгүйгээр залбирдаг юм шиг санагддаг. Би тэгвэл залбирахаа больсон нь дээр үү?” Судар судлах тэмдэглэлдээ тэр асуултад хэрхэн хариулах болон яагаад тэгж хариулахаа тайлбарлан бич.

Ерөнхийлөгч Бригам Янг үнэн сэтгэлээсээ залбирах хүсэлтэй болох талаар энэ тустай зөвлөгөөг өгсөн: “Залбирмаар санагдах эсэх тань огт хамаагүй, залбирах цаг нь ирэхэд шууд л залбир. Хэрвээ бидэнд залбирмаар санагдахгүй бол залбирмаар санагдгалаа залбирах хэрэгтэй” (*Teachings of Presidents of the Church: Brigham Young* [1997 он], 45).

Ерөнхийлөгч Янгийн зөвлөгөөг залбирлаас гадна хэрхэн бусад тушаалуудыг дагахтай холбож болох талаар бодож үз. Зөв зүйлийг тогтмол хийх нь хүнд тэр тушаалыг зөв шалтгаанаар дагах хүслийг төрүүлэхэд тусалж болно.



3. Мормоны сайн үйлийг үнэн сэтгэлээс хийхийн ач холбогдлын талаар заасныг хэрэгжүүлэхээр дараах тушаалуудын нэгийг сонго: мацаг барих, аравны нэг төлөх, бусдад үйлчлэх, судруудыг судлах, эцэг эхээ хүндлэх, ёс суртахууны хувьд цэвэр байх. (Ёс суртахууны хувьд цэвэр байх гэдэгт интернэт болон нийгмийн мэдээллийн хэрэгслийг ашиглахдаа цэвэр ариун байх нь хамаардаг. Үүнд бас бэлгийн харилцааны нүгэл рүү хөтлөх ямар ч үйлдэл хийхгүй байх нь хамаарна.) Тэгээд дараах асуултаудад судар судлах тэмдэглэлдээ хариулж бич:

а. Та тэрхүү сонгосон тушаалаа үнэн сэтгэлээсээ дагахыг зүтгэснээр хэрхэн адислагдсан бэ?

б. Та тэр тушаалыг үнэн сэтгэлээсээ дагах талаар үе тэнгийнхэндээ ямар зөвлөгөө өгөх вэ?

Моронай 7:11–19

Мормон сайн мууг хэрхэн ялгахыг заасан нь

Бид ямар нэг зүйлийг туршиж үзэхгүйгээр хилэнцэт гэдгийг нь яаж мэдэх вэ? Мормон биднийг тийм нөхцөлтэй тулгарахад бидэнд туслахаар зөвлөгөө өгсөн.



4. Моронай 7:11–13-ыг уншиж, сайн мууг хэрхэн ялгахыг ол. Та өөртөө онцгой санагдсан үгсийг

тэмдэглэж болно. Дараах өгүүлбэрүүдийг судар судлах тэмдэглэлдээ гүйцээж бичсэнээр эдгээр шүлгүүдээс сурсан зүйлсээ товчлон тайлбарла:

а. Бурханаас ирдэг бүхэн . . .

б. Чөтгөрөөс ирдэг бүхэн . . .

Мормон Бурхан биднийг үргэлж сайныг үйлдэхэд урьж мөн татдагийг баталсан. Моронай 7:12-ын дагуу чөтгөр бас биднийг урьж мөн татдагийг анзаараарай. Чөтгөр таныг нүгэл үйлдэхэд урьж мөн татдаг аргуудын заримыг бодож үз.



Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Жэффри Р.Холланд Сатаны биднийг үргэлж хилэнцийг үйлдэхэд урихыг эрэлхийлдгийн учрыг нь тайлбарласан: “Сатан эсвэл Люцифер эсвэл худал хуурмагийн эцэг, түүнийг хэн ч гэж дуудсан байлаа тэр бол бодит бөгөөд хүмүүний төрхөнд хувирсан, хорон санаатны төлөөлөгч мөн. Түүний санаа нь үргэлж бусдыг хорлох зорилготой байдаг. . . . Бурханы хайр, Есүс Христийн Цагаатгал, энх амгалан ба авралын ажлыг тэр мөнхөд эсэргүүцдэг. Тэр хаана ч, хэзээ ч чадах чинээгээрээ эдгээрийн эсрэг тэмцсээр л байх болно. Тэр эцэстээ ялагдал хүлээж, хөөгдөнө гэдгээ мэддэг ч аль болох олон хүнийг өөртэйгөө хамт доош устгалд унагахыг хичээдэг” (“Бид бүгд дуудагдсан,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2011 оны 11-р сар, 53).



5. Мормоны сайн мууг ялгах талаар заасныг ашиглахад бэлтгэхэд тань туслахаар судар судлах тэмдэглэлдээ өөрийн дуртай кино, дуу, хамтлаг, дуучин, интернэтийн сайт, програм, видео тоглоом болон хувийн өмчийн жагсаалт гаргаж бич. (Та энэ жагсаалтыг сонирхлынхоо дагуу өөрчилж болно.) Та энэ хичээлийн төгсгөл хэсэгт энэ тэмдэглэлийг эргэж үзнэ.

Моронай 7:15–17-г уншиж, танд Бурханаас эсвэл чөтгөрөөс ирснийг нь хэрхэн шийдэхийг мэдэхэд туслах үнэнүүдийг ол.

Христийн Сүнснийг мөн Христийн гэрэл гэдэг (Моронай 7:18-ыг үз). Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ерөнхийлөгч Боид К.Пакэр танд Христийн Гэрэлийг илүү сайн ойлгоход туслах тайлбар өгсөн:



“Ариун Сүнс ба Христийн гэрэл нь бие биенээсээ ялгаатай. Тэднийг заримдаа судар дээр адилхан үгсээр тайлбарладаг боловч тэд бол хоёр өөр, тусдаа зүйл юм. . . .

“Бид Христийн гэрлийн талаар мэдэх тусмаа амьдралыг улам илүү ойлгож, бүх хүн төрөлхтнийг улам илүү хайрлах болно. . . .

“Энэхүү дотоод гэрэл гэгээ, зөв бурууг ялгах энэ мэдлэгийг Христийн гэрэл, ёс суртахууны мэдрэхүй эсвэл ухамсар гэдгийн аль байдлаар нь ч хэлсэн хамаагүй, бид тэрийгээ сулруулж намсгахгүй бол энэ нь биднийг үйлдлээ захирахад удирдаж болно. . . .

“Улс үндэстэн, итгэл үнэмшил, угсаа болгоны эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, хүүхэд бүрд, хаана амьдардаг, юунд итгэдэг, юу хийдгээс нь үл хамааран тэдний дотор дуусашгүй Христийн гэрэл оршдог. Үүний хувьд бүх хүн эрх тэгш бүтээгддэг. Хүн бүрд Христийн гэрэл байгаа нь Бурханыг хүмүүсийг ялгаварлан нүүр тал харагч биш гэдгийн гэрчлэл мөн” (“The Light of Christ,” *Ensign*, 2005 оны 4-р сар, 8–10).

Баптисм хүртсэн сүмийн гишүүд бас сайн мууг ялгахад туслах Ариун Сүнсний бэлгийг хүлээн авдаг. Ерөнхийлөгч Пакэр “Ариун Сүнс Христийн гэрлээр дамжуулан ажиллаж болдог” гэж заасан байдаг (“Light of Christ,” 10).

Моронай 7:18–19-р шүлгүүдээс Мормоны бидэнд өгсөн дотоод Христийн гэрэлд хэрхэн хариулах талаар зөвлөгөөг хайж ол. Та эдгээр шүлгүүдээс **бид Христийн гэрлийг дагахыг хичээнгүйлэн эрж хайснаар сайн мууг ялгаж чаддаг** гэдгийг илэрхийлсэн үг хэллэгүүдийг тэмдэглэх хэрэгтэй.

5 дахь даалгаварт судар судлах тэмдэглэлдээ бичсэн жагсаалтаа эргэж хар. Жагсаалт дээр байгаа зүйлсийнхээ тухай сайн тунгааж, “Христийн гэрлээр шаргуу судалж” (Моронай 7:19) эдгээр зүйлсийг Бурханаас ирдэг эсэхийг тодорхойл. Дараах асуултуудыг бодоход тустай байж болох юм:

- Эдгээр зүйлс таныг сайныг хийж, Христэд итгэж, Бурханыг хайрлаж мөн Түүнд үйлчлэхийг хэр зэрэг урьдаг вэ?
- Эдгээрийн аль нэг нь таныг “хилэнцийг үйлдэхийг, . . . Христэд үл итгэхийг, . . . Түүнийг үгүйсгэхийг [эсвэл] Бурханд эс үйлчлэхийг” ятгадаг уу? Моронай 7:17
- Танд эдгээр зүйлсийн аль нэгийг нь амьдралаасаа хасах ёстой юм шиг санагдаж байна уу? Хэрвээ тийм бол та үүнийг яаж хийх вэ?

Мормон таныг сайн бус аливаа зүйлийг амьдралаасаа хасч, “сайн зүйл болгоноос зууран барьж” “Христийн хүүхэд” болно гэдэг амлалт өгсөн (Моронай 7:19).



6. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Моронай 7:1–19-р шүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

Моронай 7:20–48

Оршил

Моронай 7:20–48-д гардгаар Мормон синагогууд дотор сонсогчдооо хэрхэн “сайн зүйл болгоноос зууран барихыг” заахаа үргэлжлүүлэв (Моронай 7:20–21, 25). Тэрээр итгэл, найдвар, энэрлийн ач холбогдлыг тайлбарлав. Тэрээр сонсогчдооо Мормоны тодорхойлсон “Христийн цэвэр хайр” болох энэрлийн бэлгийн төлөө зүрхнийхээ бүхий л эрч хүчээр Эцэгт хандан залбирахыг уриалан сургамжаа дуусгав (Мормон 7:47).

Моронай 7:20–39

Мормон Есүс Христэд итгэх итгэлийн тухай заав

Моронай 7:12–13-ыг дахин уншаад өмнөх хичээлд үзсэн сайн зүйлийг хилэнцтээс хэрхэн ялган мэдэх тухай юу сурснаа эргэцүүлэн бод. Дараах зайд сайн (Бурханаас ирдэг, биднийг Христэд итгэхийг ухуулдаг зүйлс) болон хилэнцэт зүйлсийн (Христэд итгэхгүй, Бурханд үйлчлэхгүй байхыг бидэнд ухуулдаг зүйлс) жишээг жагсаан бич:

Сайн зүйлс	Хилэнцэт зүйлс

Мормон биднийг “сайн зүйл болгоноос зууран барь” хэмээн урамшуулсныг анзаар (Моронай 7:19). Сайн зүйл болгоноос зууран барих гэдэг нь ямар утгатай болохыг тунгаан бод.

Мормон сонсогчдоосоо нэгэн чухал асуултыг асуусан бөгөөд дараа нь өөрөө хариулсан. Моронай 7:20-ийг уншаад Мормоны асуухаар төлөвлөсөн асуултыг ол. Дараа нь Моронай 7:21–26-г судлаад энэхүү асуултын хариултыг ол.

Моронай 7:21, 25-ыг уншихдаа энэ зарчмыг заасан үг хэллэгүүдийг олж тэмдэглэ: **Бид Есүс Христэд итгэх итгэлээ үйлдэл болгосноор сайн зүйл болгоноос зууран барьж чадна.**



1. Дараах асуултуудад судар судлах тэмдэглэлдээ хариулж бич:

а. Моронай 7:22–26-д гарсны дагуу Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлэхэд маань Тэнгэрлэг Эцэг ямар замаар туслахыг хичээдэг вэ?

б. Есүс Христэд итгэх итгэл тань хэзээ сайн зүйл болгоноос зууран барихад эсвэл хилэнцэт зүйлийг орхиход тань тусалсан бэ?

Есүс Христэд итгэх итгэлээ үйлдэл болгодог хүмүүст ирдэг хэдэн сайн зүйлийг Мормон тайлбарлажээ. Моронай 7:32–34-ийг уншаад шүлэг бүрд Есүс Христэд итгэх итгэлтэй байсны үр дүнд ирдэг дор хаяж нэг адислалыг олж тэмдэглэ.



2. Есүс Христэд итгэх илүү агуу итгэлийг үйлдэл болгохын тулд хийж болох нэг зүйлийн тухай бодож мөн залбир. Санаандаа зорилгоо тодорхойлсон бол судар судлах тэмдэглэлдээ бич. Энэ зорилго нь бошиглогчдын үгсийг дагах (Моронай 7:23-ыг үзнэ үү), илүү агуу итгэлтэйгээр залбирах (Моронай 7:26-г үзнэ үү) эсвэл нүглээ наманчлахад (Моронай 7:34-ийг үзнэ үү) тань туслах ямар нэгэн тодорхой хийх зүйл байж болно. Зорилгоо бичихдээ хэрхэн биелүүлэх тухайгаа нарийн тодорхой бич. Түүнчлэн энэ зорилго нь таны амьдралд хэрхэн сайн зүйлсийг авчрахыг бич.

Моронай 7:40–43

Мормон найдварын тухай заав

Моронай 7-д цэдэглэгдсэн сургамжид Мормон мөнх амьдралд хэрэгтэй гурван тэнгэрлэг зарчмыг тодорхойлсон. Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч М.Рассэлл Баллард энэхүү “гурван тэнгэрлэг зарчим нь бид амьдралаа зохион байгуулж болох үндэс суурь болдог” хэмээн заасан. Эдгээр зарчмууд нь “хамтдаа бидэнд гурван хөлтэй сандлын хөл шиг дэмжлэг өгдөг” гэж тэр хэлжээ (“The Joy of Hope Fulfilled,” *Ensign*, 1992 оны 11-р сар, 33).



Дараах материал нь Мормоны тодорхойлсон гурван зарчмыг олоход тань тусална. Эхний зарчим нь дөнгөж сая Мормон 7:20–39-өөс сурсан итгэл юм. Дээрх сандлын нэг хөлийг *Есүс Христэд итгэх итгэл гэж тэмдэглэ*. Хоёр дахь хөл нь юуг төлөөлж байгааг Моронай 7:40-ийг уншаад ол. Уг зарчмыг сандлын өөр нэг хөл дээр бич.

Моронай 7:41–42-ыг уншаад бид юунд найдах хэрэгтэй гэж Мормон заасныг ол. (Моронай 7:41 нь төгс эзэмших судар юм.) Та сандлын хоёр дахь хөл дээр “Мөнх амьдралд найдах” гэдгийг нэмж бичиж болно. Ингэвэл “Мөнх амьдралд найдах найдвар” гэсэн бичиг болно.

Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх, Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф Мормоны ярьсан найдварын тухай ярьсан юм.



“Найдвар бол Сүнсний бэлэг юм. Энэ нь Есүс Христийн Цагаатгал болон Түүний Амиалтын хүчээр дамжуулан бид мөнхийн амьдралд сэргээгдэнэ гэсэн найдвар бөгөөд Аврагчид итгэх итгэлийн маань улмаас ирдэг юм. . . .

“Найдвар бол мэдлэг биш, харин Их Эзэн өгсөн амлалтуудаа биелүүлэх болно гэсэн өнө удаан үргэлжлэгч итгэл мөн. Энэ нь хэрэв бид Бурханы хуулиуд болон Түүний бошиглогчдын үгсийн дагуу амьдарвал бид ирээдүйд хүссэн адислалуудаа авах болно гэсэн өөртөө итгэх итгэл юм. Энэ бол бидний залбирал хариулагдана гэдэгт итгэж, хүлээх явдал юм. Энэ нь өөртөө итгэх итгэл, өөдрөг үзэл, урам зориг, тэсвэр тэвчээртэй шаргуу байдалд илэрхий байдаг” (“Найдварын хязгааргүй хүч,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2008 оны 11-р сар, 25–26).

Моронай 7:40–42-оос сурах нэг зарчим бол: **Хэрэв бид Есүс Христэд итгэх итгэлээ бодитой болговол Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан мөнх амьдралд өргөгдөнө гэсэн найдварыг хүлээн авч чадна** гэсэн зарчим юм.

Моронай 7:43-ыг уншаад Мормоны ярьсан итгэл, найдвартай байхын тулд хүнд ямар зан чанарууд байх ёстойг тодорхойл.

“Хүлцэнгүй даруу, зүрх сэтгэлдээ номхон” байх гэдэг нь үнэхээр даруу, дөлгөөн, Их Эзэний хүсэлд дуулгавартай байхыг хэлнэ. Есүс Христийн Цагаатгалд итгэж найдахад хүлцэнгүй даруу, зүрх сэтгэлийн номхон байдал яагаад шаардлагатай гэж та бодож байна вэ?



3. Есүс Христ болон Түүний Цагаатгалд итгэх итгэл тань танд хэрхэн найдвар өгснийг судар судлах тэмдэглэлдээ дүрслэн бич.

Моронай 7:44–48

Мормон энэрлийн тухай заав

Хичээлийн эхэнд ярилцаж байсан сандал руу эргэн очъё. Моронай 7:44-ийг уншаад Мормоны заасан гурав дахь зарчмыг тодорхойл. Сүүлчийн зарчмыг сандлын үлдсэн хөл дээр бич.

Моронай 7:44–48-д цэдэглэснээр Мормон энэрлийн тухай хүчирхэг тайлбарыг өгсөн. Моронай 7:45–47-г уншаад Мормоны энэрлийг тодорхойлохдоо ашигласан үг хэллэгүүдийг тэмдэглэ. (Моронай 7:45, 47–48 нь төгс эзэмших судар юм.) Мормоны заасан зүйлсийг илүү сайн ойлгохын тулд дараах тодорхойлолтуудын заримыг судартаа тэмдэглэж болно: “удаан тэсвэрлэдэг” гэдэг нь хатуужилтайгаар тэсвэрлэдэг, “атаархаж жөтөөрхөх нь үгүй” гэдэг нь атаархдаггүй, “онгирч хөөрдөггүй” гэдэг нь даруу, хүлцэнгүй, “өөрийнхийгөө эрэлхийлдэггүй” гэдэг нь Бурхан болон бусдыг нэгдүгээрт тавьдаг, “амархан өдөөн хатгагддаггүй” гэдэг нь амархан уурладаггүй, “бүх зүйлд итгэдэг” гэдэг нь бүх үнэнийг хүлээн зөвшөөрдөг гэсэн утгатай.



4. Дараах асуултуудын нэг юмуу түүнээс олон асуултад судар судлах тэмдэглэлдээ хариулж бич:

а. Моронай 7:45–47 дахь тодорхойлолтод тулгуурлан үзвэл энэрэл нь яагаад бидний хүлээн авч чадах хамгийн агуу сүнсэлг бэлэг гэж та бодож байна вэ?

б. Таны бодлоор энэрэл хэзээ ч дуусдаггүй гэдэг нь юу гэсэн үг вэ?

в. Хэрэв бидэнд энэрэл үгүй бол бид яагаад хэн ч биш гэж та бодож байна вэ?


Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Даллин Х.Өүкс 1 Коринт 13 дахь төлөөлөгч Паулын энэрлийн тухай заасныг дурдсаныхаа дараа ийн тайлбарлав: “Энэрэл хэзээ ч дуусдаггүй, түүний эш татсан хамгийн гайхалтай сайн сайхны үйлдлүүдээс ч илүү агуу байх шалтгаан нь ‘Христийн цэвэр хайр’ (Моронай 7:47) болох энэрэл нь нэг удаагийн үйлдэл биш, харин тууштай сахиу нөхцөл байдал юм. Энэрлийг хөрвөлтийн үр дүн болох байнгын үйлдлээр дамжуулан олж авдаг. Энэрэл бол хэн нэгний өөрчлөлт юм. Моронайн тунхагласнаар ‘хүмүүс энэрэлтэй байхаас бусдаар’ Эцэгийн эзэмшлүүдэд тэдэнд бэлтгэсэн тэрхүү байрыг ‘өвлөж авч чадахгүй’ (Ифер 12:34; нэмэлт оруулсан)” (“The Challenge to Become,” *Ensign*, 2000 оны 11-р сар, 34.)

Дараах нөхцөл байдлыг уншаад хэрэв танд энэрлийн бэлэг дутагдвал, хэрэв та энэрлээр дүүргэгдсэн байвал яах тухайгаа эргэцүүлэн бод:

- Бусад сурагчид таныг эсвэл сургууль дээрх өөр хэн нэгнийг шоглодог.
- Ах эсвэл эгч тань үргэлж танд садаа болдог.
- Танай чуулга эсвэл ангийн шинэ багш танд өмнөх багш шиг таалагддаггүй.

Бид амьдралдаа энэрлийг хөгжүүлэх нь хэчнээн чухал болохыг тайлбарласныхаа дараа Мормон бид ийм чухал зан чанарыг хэрхэн олж авахыг тайлбарлав. Моронай 7:48-ыг уншаад энэ зарчмыг заасан

үг хэллэгүүдийг олж тэмдэглэ: **Бид зүрхнийхээ бүхий л эрч хүчээр Эцэгт хандан залбирч, Есүс Христийн үнэн дагалдагчийн адил амьдарвал энэрлээр дүүргэгдэх болно.** Энэрлийн бэлгийн төлөө энгийн байдлаар залбирахаас илүү зүрхнийхээ бүхий л эрч хүчээр залбирах нь яагаад чухал болохыг тунгаан бод.


 **5.** Их Эзэн танд энэрэлтэй байхад тань тусалсныг мэдрч байсан үеийнхээ тухай судар судлах тэмдэглэлдээ бич. Эсвэл хэн нэгэн энэрэлтэй байгааг харсан тухайгаа бич. Үүнээс гадна, Моронай 7:45-д жагсаасан энэрлийн шинж чанаруудын нэгийг өөр дээрээ хэрхэн хөгжүүлэх тухай тодорхой зорилго тавь. Зорилгоо биелүүлэхийн төлөө хичээж байхдаа энэрлийн бэлгийн төлөө залбир.

Төгс эзэмших судар—Моронай 7:41

Шүлгийг бүхлээр нь цаасан дээр бич. Шүлгийг хэд хэдэн удаа унш. Бүгдийг нь цээжээр уншиж чадах хүртлээ үг эсвэл хэллэгүүдийг арилга (эсвэл хас).

Төгс эзэмших судар—Моронай 7:45, 47–48

Энэ гурван шүлгийн үг бүрийн эхний үсгийг цаасан дээр бич. Цээжээр уншиж сурахын тулд цаасаа ашигла. Хэд хэдэн удаа уншсаны дараа шүлгүүдийг цээжээр уншиж чадах хүртлээ үсгүүдийг арилга эсвэл хас. Дараах бүлэг хүмүүсээс илүү энэрэнгүй байхыг хүсч байгаа хүмүүсээ сонго: гэр бүл, сүмийн чуулга эсвэл ангийн гишүүд, сургуулийн ангийнхан, найзууд эсвэл хөршүүд. Моронай 7:45-ыг уншихдаа, сонгосон хүмүүсийнхээ тухай бодож, тэдэнд Христийнхтэй илүү адил хайрыг үзүүлэх арга замуудын талаар эргэцүүлэн бод.

 **6.** Эдгээр хүмүүст илүү агуу энэрлийг үзүүлэх нэг юмуу хоёр аргыг судар судлах тэмдэглэлдээ бич. Ирэх долоо хоногт тэдэнд хандсан илүү агуу энэрлийг хөгжүүлэхэд Их Эзэний тусламжийн төлөө залбир. Долоо хоногийн төгсгөлд туршлагаа найзтайгаа эсвэл гэр бүлийн гишүүнтэйгээ хуваалц.

 **7.** Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Моронай 7:20–48-р шүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

32-Р ХЭСЭГ: 2 ДАХЬ ӨДӨР

Моронай 8–9

Оршил

Моронай 8 бол Мормоны бяцхан хүүхдүүдийг яагаад баптисм хүртэх шаардлагагүй байдаг талаар хүү Моронайдаа бичсэн захидал юм. Энэ захидалд Мормон биднийг Бурхантай хамт амьдрахад хэрхэн бэлдэх талаар бас заасан. Тэрээр нифайчуудын ёс бус байдал болон удалгүй ирэх устгалын талаар санаа зовсноо илэрхийлж захидлаа дуусгажээ. Моронай 9-д Мормоны хүүдээ бичсэн сүүлийн захидал байдаг. Тэр нифайчуудын ёс бус байдлын талаар уй гашуугаа илэрхийлж, Моронайгаас нифайчуудад наманчлахад нь туслахыг шаарджээ. Хүмүүсийнхээ бузар байдлыг үл харгалзан тэр хүүгээ Христэд итгэлтэй байж, мөнх амьдралын амлалтыг санаандаа үүрд суулгахыг урьсан.

Моронай 8:1–24

Мормон хүү Моронайдаа баптисм хүртэх ёстой хүмүүсийн талаар бичсэн

Та Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн хүүхдүүд яагаад найман насанд хүртлээ баптисм хүртдэггүй юм бол гэж бодож байсан уу? Хүү Моронайдаа бичсэн захидалдаа Мормон бяцхан хүүхдүүдийн аврал ба баптисм болон хүүхдүүдийг яагаад найман насанд хүртлээ баптисм хүртдэггүйн талаар чухал үнэнүүдийг заасан. Мормон Моронайд бичсэн захидлаа эхлэхдээ нифайчуудад тулгарч байсан арцалдаан (маргалдаан)-ы талаар ярьсан. Моронай 8:4–6-г уншиж, нифайчуудын хоорондоо маргалдаж байсан сургаалыг хайж ол. (Үүнийг уншихдаа энэ тохиолдолд *ноцтой*-г маш хүнд гэсэн утгатай гэдгийг мэдэх нь тустай байж болно.)

Моронай 8:7-г уншиж, Мормон энэ асуудлын талаар сонсоод юу хийснийг нь тодорхойл. Аврагч Мормоны залбиралд хүүхдүүдийг хариуцлагын насанд хүрэхээсээ өмнө яагаад баптисм хүртэх шаардлагагүйг тайлбарлан хариулжээ. Моронай 8:8–9-г уншиж, Аврагч нярай болон бяцхан хүүхдүүд яагаад баптисм хүртдэггүй талаар хэлсэн зүйлсийг нь хайж ол.

Моронай 8:8-д “Адамын зүхэл” гэдэг нь Уналтын улмаас Адамын Бурханы оршихуйгаас тусгаарлагдсаныг хэлдэг. Зарим нифайчууд баптисмын

сургаалыг ойлгоогүй нь тодорхой байв. Тиймээс тэд бяцхан хүүхдүүдийг баптисмын ёслолгүйгээр Бурханы оршихуйд байхад зохисгүй гэж буруу бодож байсан бөгөөд хүүхдүүдийг бага насанд нь баптисм хүртээх хүсэлтэй байжээ. Нүгэл гэдэг нь “Бурханы зарлигуудад санаатайгаар дуулгаваргүй байх” гэдгийг анхаарах нь энэ шүлгийг ойлгоход тустай байж болно (Судруудын удирдамж, “Нүгэл,” scriptures.lds.org). Энэ сургаалыг илүү сайн ойлгохын тулд та Моронай 8:8-ыг хоёр дахь Итгэлийн тунхагтай холбогдох эшлэл болгож болно.

Моронай 8:10-ыг уншиж, дараах үнэнийг гүйцээх үгсийг хай: _____

_____ -д наманчлал, баптисм шаардлагатай.

Наманчлал болон баптисм хариуцлагатай, нүгэл үйлдэх чадвартай хүмүүст л шаардлагатай тул Мормон бяцхан хүүхдүүдийг хариуцлагатай болохоос нь өмнө баптисм хүртээх нь буруу гэдгийг заажээ. Моронай 8:11–13, 18–22-ыг уншиж, Мормон бяцхан хүүхдүүдэд яагаад баптисм хүртээх нь буруу гэж хэлсэн тайлбарыг хайж ол. Эдгээр шүлгүүд энэ сургаалыг заадаг: **Бяцхан хүүхдүүд Есүс Христийн Цагаатгалаар аврагддаг.**

Их Эзэн хариуцлагатай болж эхлэх насыг найм байхаар тогтоосон (С ба Г 68:25–27; Иосеф Смитийн орчуулга, Эхлэл 17:11 [Библийн хавсралтанд]-ийг үзнэ үү). Сатанд бяцхан хүүхдүүдийг уруу татах хүч өгөгдөөгүй учраас хүүхдүүд найман нас хүрэхээсээ өмнө нүгэл үйлдэж чадахгүй (С ба Г 29:46–47). Хүүхдүүдийн найман нас хүрэхээс өмнө хийсэн алдаанууд нүгэлд тооцогүй.




Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Даллин Х.Өүкс бяцхан хүүхдүүд яагаад нүгэл үйлдэж чадахгүй гэдгийн учрыг ийн тайлбарлажээ: “Бид хүүхдүүдийг хариуцлагын насанд хүрэхээсээ өмнө ‘нүгэл үйлдэх чадваргүй’ гэдгийг нь сургаалаасаа ойлгодог (Моронай 8:8). Тэр хугацаанд хүүхдүүд алдаа гаргаж магад. Бүр ноцтой, засагдах ёстой гэмтэй алдаанууд гаргаж ч магад. Гэхдээ тэдний үйлүүд нүгэлд тооцогдохгүй” (Sins and Mistakes,” *Ensign*, 1996 оны 10-р сар, 65).

Мормон бас захидалдаа бяцхан хүүхдүүдийг “Христээр амьд” ба тэднийг найман нас хүрэхээсээ өмнө нас барах тохиолдолд Есүс Христийн Цагаатгалаар аврагддаг гэдгийг гэрчилсэн (Моронай 8:12–15, 22).

Мормон нярай болон бяцхан хүүхдүүдийг яагаад баптисм хүртэх шаардлагагүй гэдгийг тайлбарлахдаа энэ зарчмын талаар гэрчилсэн: **Бурхан хүүхдүүдтэйгээ харилцах харилцаандаа төгс шударга байдаг юм.** Иймээс Бурхан бүх хүнд аврал хүлээн авах шударга боломж олгоно гэсэн үг.



 **1.** Дараах үйл ажиллагаа танд Моронай 8-ын эхэнд заагдсан сургаалуудыг тайлбарлахыг сурахад тусална. Доороос нэг (эсвэл хоёр) нөхцөлийг судар судлах тэмдэглэлдээ сонгож, Моронай 8:8–24-өөс тухайн хүний асуудалд хариулах нэг юм уу хоёр шүлгийг тодорхойл. Дараа нь тухайн нөхцөлийн хариуд нэгээс хоёр догол мөр бич. Хариултандаа судрын шүлгүүдийг ашигла.

а. Номлогчийн хувьд та үнэнийг чин сэтгэлээсээ эрэлхийлж байгаа нэг эргэтэй танилцжээ. Тэрээр амьдралынхаа турш бяцхан хүүхдүүд Адамын нүглийн улмаас төрөхдөө нүгэлтэй байдаг гэж заалгаснаа тайлбарлав. Түүнчлэн тэр хүн нярай хүүхдүүд баптисм хүртэхгүйгээр нас барахад тэд нүгэлтэй бөгөөд аврагдах боломжгүй гэдэгт бат итгэдэг байлаа.

б. Саяхны нэгэн хөрвөгч найман настай хүүхдүүдийн баптисмыг сайн гэдгийг зөвшөөрдөг боловч “Хүмүүс найман настай эсвэл найман сартайдаа баптисм хүртсэн ч ялгаагүй биз дээ?” гэж асуужээ.

Моронай 8:25–30

Мормон биднийг Бурхантай хамт амьдрахын тулд юу хийх ёстойг заав

Бяцхан хүүхдүүдийг яагаад баптисм хүртэх шаардлагагүйг заасныхаа дараа Мормон хариуцлагын насанд хүрсэн хүмүүсийг баптисм хүртэх ёстойг

заажээ. Тэр бас биднийг Бурхантай хамт амьдрахын тулд баптисмын дараа юу хийх ёстойг заасан.

Моронай 8:25–26-г уншиж, бидний Бурхантай хамт амьдрахын тулд хийх ёстой зүйлс болон хөгжүүлэх ёстой зан чанаруудыг ол. Та эдгээрийг судартаа тэмдэглэх хэрэгтэй. “Даруу байдал” гэдэг нь Бурханы хүсэлд дуулгавартай байх, “зүрх сэтгэлийн хүлцэнгүй чанар” гэдэг нь жинхэнээсээ даруу байх гэсэн утгатайг ойлгох нь тустай байж болно.

Та судар дээрээ Моронай 8:25–26-ийн хажууд дараах зарчмыг бичих хэрэгтэй: **Бид зарлигуудыг итгэлтэй дагаснаар Ариун Сүнснийг хүлээн авах боломжтой бөгөөд энэ нь биднийг Бурхантай амьдрахад бэлтгэдэг.**



2. Дараах асуултууд танд Моронай 8:25–26-г илүү сайн ойлгоход тусална. Бүх асуултуудыг тунгаан бодож дор хаяж хоёрыг сонгож, судар судлах тэмдэглэлдээ хариулж бич:

а. Нүглийн ангижралыг хүлээн авах нь яагаад даруу байдал, зүрх сэтгэлийн хүлцэнгүй чанар руу хөтөлдөг вэ?

б. Та хүлцэнгүй, зүрх сэтгэлдээ номхон байснаар хэрхэн Ариун Сүнсийг амьдралдаа урьж болох вэ?

в. Ариун Сүнсний хамт байх нь танд Бурхантай хамт амьдрахаар бэлтгэхэд хэрхэн туслах вэ?

г. Мормон биднийг үргэлжилдэг хайраар дүүрэн байхыг хүсвэл хичээнгүйлэн залбирах ёстойг заасан. Хайраар дүүрэн байхыг хүсвэл хичээнгүйлэн залбирах нь яагаад чухал вэ?

Моронай 8:27-д цэдэглэгдсэнээр Мормон нифайчуудын дундах бардамналын нүглийг буруушаажээ. Моронай 8:27-г уншиж, нифайчуудын бардамналын үр дүнг хайж ол. Дараа нь энэ үр дүнг Моронай 8:26-д байгаа хүлцэнгүй, зүрх сэтгэлдээ номхон байхын үр дүнтэй харьцуулж үз.

Мормон нифайчуудыг наманчилж, түүний захидалд буй адислалуудыг хүлээн авч болохын төлөө залбирахад нь Моронайг урамшуулан дэмжжээ (Моронай 8:28–30). Мормоны хүүдээ өгсөн зөвлөгөөг ашиглан өөрийн таньдаг сайн мэдээний адислалуудыг хүлээн авах хэрэгтэй тодорхой хүмүүсийн төлөө залбирч, тэдэнд туслах аргуудыг хайж ол.

Моронай 9:1–20

Мормон нифайчууд болон леменчүүдийн ёс бус байдлыг дүрсэлсэн нь

Хүнд туслахыг хичээсэн боловч тэр хүн таны хичээл зүтгэлийг эсэргүүцсэн тохиолдлыг бод. Зарим хүн сайн санаагаар туслахыг хичээхэд хүмүүс үүнийг нь дахин дахин эсэргүүцвэл тэд ямар хариу үйлдэл үзүүлж болох вэ? Хүү Моронайдаа бичсэн Мормоны хоёр дахь захидал Моронай 9-р бүлэгт байдаг.

Үүнийг судлахдаа Мормон хүүгээ нифайчуудын төлөө бууж өгөхгүй байхыг дэмжихийн тулд юу хэлснийг нь ол.

Моронай 9:1-ийг уншиж, Мормон захидалдаа ярилцах нөхцөлийг дүрслэхдээ ашигласан үгийг ол. Энэ тохиолдолд *эмгэнэлт* гэдэг нь маш сэтгэл гонсойлгосон гэсэн утгатайг анхаар. Моронай 9:2–19-д бичигдсэнчлэн Мормон хүмүүсийн дунд тохиолдож байсан сэтгэл гонсойлгосон зарим зүйлийг дүрсэлж, хүмүүсийг хэчнээн их ёс бус болсныг нь үзүүлсэн. Жаредчуудын дундах бошиглогч байсан Иферийн адил Мормон хүмүүсийг нь ялан дийлсэн уур, ёс бус байдлыг үзэв. Тэрээр Их Эзэний Сүнс тэдэнтэй хамт байхаа больсон хэмээн айжээ (Моронай 9:4-ийг үзнэ үү).

Мормон яагаад нифайчууд Бурханы үгийн эсрэг зүрх сэтгэлээ хатууруулж, тэдэнд туслах бошиглогчдын хичээл зүтгэлийг эсэргүүцэж байсан ч тэдний дунд ажилласаар байсныг нь тунгаан бод.

Мормон Моронайд зүрх сэтгэлээ нээлттэй байлгадаггүй хүмүүст хэрхэн номлох ёстой талаар хүчтэй зөвлөгөө өгчээ. Моронай 9:3–6-г уншиж, дараах зарчмыг заадаг үг хэллэгүүдийг тэмдэглэ: **Бидний үйлчилдэг хүмүүс сайнаар хандахгүй байсан ч гэсэн бид Бурханы үйлчлэлд хичээнгүйлэн хөдөлмөрлөх ёстой.** 6-р шүлэг ялангуяа энэ зарчмыг заахад нэн тустай байдаг.

Моронай 9:21–26


Мормон Моронайг итгэлтэй байхыг урамшуулдаг

Хүмүүсийн урмыг хугалж болзошгүй, танай хамт олон, улс эсвэл дэлхийд тохиолдсон явдлуудын талаар бод. Моронай 9:25–26-г уншиж, шантармаар нөхцөлд юу хийх талаар Моронайд өгсөн Мормоны зөвлөгөөг ол.



3. Дараах асуултуудад судар судлах тэмдэглэлдээ хариулж бич: Мормон Моронайд юуг “санаандаа үүрд суулгах ёстой” гэсэн бэ? (Моронай 9:25). Бэрхшээлтэй үедээ эсвэл ёс бус байдлын дунд байхдаа Аврагч болон Түүний Цагаатгалыг санах нь танд хэрхэн тусалж болох вэ?

Мормоны Моронайд өгсөн зөвлөгөөнөөс бид энэ зарчмыг сурч болно: **Хэрвээ бид Есүс Христэд итгэлтэй байвал биднийг бэрхшээл, ёс бус байдлын дунд орсон ч Тэр биднийг дээш өргөж чадна.** “Есүс Христэд итгэлтэй” байх гэдэг нь бүх цагт Аврагчийн жинхэнэ шавь шиг үйлдэхийг хичээж, Аврагч болон Түүний Цагаатгалыг санаж, Түүний зарлигуудыг итгэлтэйгээр сахиыхыг хэлнэ.

 **4.** Судар судлах тэмдэглэлдээ дээрх зарчим нь үнэн гэдгийг үзүүлдэг өөрийн амьдралд эсвэл ойр дотны хүний амьдралд тохиолдсон туршлагыг бич.

Ёс бус байдал эсвэл хэцүү нөхцөлийн дунд орсон байхдаа Христэд илүү итгэлтэй байх нэг аргын тухай бод.

 **5.** Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Моронай 8–9-р бүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо) -нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

32-Р ХЭСЭГ: 3 ДАХЬ ӨДӨР

Моронай 10:1–7, 27–29

Оршил

Моронай леменчүүдийг болон түүний гэрчлэлийг унших хүн бүрийг өөрсдөө Бурханаас асууснаар түүний үгсийн үнэнийг олж мэдэхийг ухуулжээ. Тэрээр Мормоны Ном болон Есүс Христийн талаарх гэрчлэл Ариун Сүнсний хүчээр ирнэ гэдгийг заасан. Моронай Бурханы тавцангийн өмнө түүний үгийг уншигчидтай уулзах болно гэдгийг зоригтойгоор тунхагласан бөгөөд Бурхан түүний үгсийн үнэнийг тэнд батлах ажээ.


Моронай 10:1–7

Моронай биднийг Мормоны Ном болон Есүс Христийн гэрчлэлийг хүлээж авахыг ухуулав

Энэхүү гарын авлагын 1-р хэсэг дэх Мормоны Номын оршил хичээлийг эргэж дүгнэ. Нуман хаалганы тулгуур чулууны зорилгыг болон тулгуурын чулуу нь хэрхэн Мормоны Номтой холбогддог тухай та санаж байна уу? Мормоны Номын оршил хэсэг рүү очоод (номын эхлэл хэсгээс олно) 6 дахь догол мөрөнд байгаа Бошиглогч Иосеф Смитийн мэдэгдлийг унш.

Бошиглогч Иосеф Смит Мормоны Номыг манай шашны “тулгуурын чулуу” гэж дүрсэлсэн нь бидний Мормоны Номын гэрчлэл нь сэргээгдсэн сайн мэдээний бүх үнэнүүдийн гэрчлэлийг тогтоон барьж мөн хүчирхэгжүүлдэг гэсэн утгатай.

Мормоны Номын оршлын сүүлийн догол мөрийг уншаад Мормоны Номын гэрчлэлийг хүлээж авснаар хүмүүн ямар үнэнийг мэдэж болохыг олж мэд.



Тулгуурын чулуу нуман хаалгыг тогтоодгийн адил Мормоны Ном хэрхэн таны гэрчлэлийг тогтоон барьж мөн хүчирхэгжүүлдэг вэ?

Иосеф Смит алтан ялтсуудыг хүлээж авахаас ойролцоогоор 1,400 жилийн өмнө Моронай эцсийн өдрүүдэд Мормоны Номыг хүлээж авах тэдэнд зориулан өөрийн сүүлийн ухуулгыг бичсэнээр эцгийнхээ бичээсийг дуусгажээ (Моронай 10:1–2-ыг үзнэ үү). *Ухуулах* гэдэг үг нь хэн нэгнийг хүчтэйгээр уриалан дэмжих гэсэн үг юм. Моронай энэ үгийг Мормоны Номын сүүлийн бүлэгт найман удаа ашиглажээ. Тэрээр Мормоны Номын үнэн болон тэнгэрлэг байдлын гэрчлэлийг хайж байгаа бүгдийг ухуулсан юм.

Моронай 10:3–4-ийг уншаад Моронай Мормоны Номын гэрчлэлийг олж авахын тулд бидний хийх хэрэгтэй гэсэн зүйлсийг тодорхойл. Та эдгээр зүйлсийг судартаа тэмдэглэх хэрэгтэй. Бидэнд хийх хэрэгтэй гэж Моронайн хэлсэн зүйл бүрийн тухай дараах мэдээллийг судал:

“Эдгээр зүйлүүдийг унш”

Мормоны Номыг үнэн гэх гэрчлэлийг хүлээж авах эхний алхам бол үүнийг унших явдал юм. Далын Ерөнхийлөгчийн зөвлөлийн ахлагч Тэд Р.Каллистэр, Мормоны Номыг бүхэлд нь уншсанаар нэгэн залуу эмэгтэй хэрхэн ашиг тусыг нь хүртсэн тухай түүхийг хуваалцжээ:

“14 настай нэгэн охин хэлэхдээ . . . ангийнхаа нэг найзтайгаа шашны талаар ярилцаж байжээ. Найз нь түүнээс ‘Чи ямар шашинд итгэдэг вэ?’ гэж асуужээ.”

“Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм буюу Мормоны сүмд явдаг” гэж тэр хариулжээ.

“Тэгэхэд найз нь ‘Би тэр сүмийг чинь мэдэх юм байна. Тэр чинь үнэн сүм бишээ’ гэжээ.

“Чи яаж мэддэг юм бэ?” гэж охин асуув.

“Яагаад гэвэл би тэр талаар судалж үзсэн юм” хэмээн найз нь хариулав.

“Чи Мормоны Номыг уншиж үзсэн үү?”

“Үгүй л дээ, би уншиж үзээгүй” гэж найз нь хэлэв.


“Тэгвэл чи манай сүмийг судалж үзээгүй л юм байна. Би Мормоны Номын хуудас бүрийг уншиж үзсэн учраас үүнийг үнэн гэдгийг нь мэднэ” гэж тэр хөөрхөн охин хариулжээ (“Мормоны Ном— Бурханаас өгөгдсөн Ном,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2011 оны 11-р сар, 89).

Мормоны Номын үнэний гэрчлэлийг олж авахын тулд үүнийг унших нь яагаад чухал гэж та бодож байна вэ? _____

“Бурхан хэчнээн нигүүлсэнгүй байсныг сана”

Дараагийн хийх ёстой үйлдэл бол “Их Эзэн хэчнээн нигүүлсэнгүй байсныг санах”: Их Эзэн бидэнд хэчнээн нигүүлсэнгүй байсныг санах нь бидний зүрх сэтгэлийг зөөлрүүлж Ариун Сүнснийг хүлээн авахад бэлтгэдэг. Амьдралдаа Их Эзэний нигүүлслийг мэдэрч байсан үеүдээ тунгаан бод.

Мормоны Номын эхэн хэсэгт Нифай өөрийн бичээсээр дамжуулан Их Эзэний агуу нигүүлслийн жишээг үзүүлэх болно гэж тунхагласан (1 Нифай 1:20-ийг үзнэ үү). Мормоны Номын төгсгөл хэсэгт, Моронай биднээс Их Эзэний нигүүлслийг санахыг хүсдэг (Моронай 10:3-ыг үзнэ үү). Та 1 Нифай 1:20-ийг Моронай 10:3-ын дэргэд холбогдох эшлэл болгон бичиж болно.

 **1.** Судар судлах тэмдэглэлдээ дараах асуултаудад хариулан бич:

а. Та амьдралдаа Их Эзэний нигүүлслийн ямар баталгааг харсан бэ?

б. Их Эзэний нигүүлслийг санаснаар хүн хэрхэн Мормоны Номын гэрчлэлийг хүлээн авна гэж та бодож байна вэ?

Бусдад болон бидэнд үзүүлсэн Их Эзэний нигүүлслийг санах нь бидэнд өгөгдсөн Мормоны Номын захиасуудыг тунгаан бодоход бэлтгэдэг.

“Үүнийг зүрх сэтгэлдээ тунгаан бод”

Моронайн бидэнд заасан дараагийн алхам бол “үүнийг зүрх сэтгэлдээ тунгаан бодох” явдал юм.

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Марвин Ж.Эштон тунгаан бодох нь Ариун Сүнсний амьдралдаа хүлээн авахад бидэнд хэрхэн тусалдгийг ийн тайлбарлажээ:




“Намайг судруудыг судлахад Мормоны Номонд маш олон хэлэгдсэн *тунгаан бодох* гэсэн үг сэтгэлийг минь хөдөлгөж, намайг хурцалдаг. Толь бичигт *тунгаан бодох* гэдэг үгийг оюун санаандаа эргэцүүлэх гүнзгий бодох, хашир бодох, бясалгах хэмээн тайлбарлажээ. . . . Моронай энэ хэллэгийг өөрийн бичээсийг төгсгөхдөө хэрэглэсэн [Моронай 10:3-ыг үзнэ үү].

“Тунгаан бодсоноор бид Ариун Сүнсэнд бидэнд нөлөөлж мөн биднийг удирдах боломжийг олгодог. Тунгаан бодох нь зүрх сэтгэл болон оюун санаа хоёрын хоорондох хүчтэй хэлхээ юм. Бид судруудыг унших үед бидний оюун санаа болон зүрх сэтгэл хөдөлдөг. Хэрэв бид тунгаан бодох бэлгийг ашиглах юм бол бид эдгээр мөнхийн үнэнүүдийг өдөр бүрийнхээ үйлдэлд хэрхэн ашиглаж болохыг ойлгох болно. . . .

“Тунгаан бодох нь оюун санааны үргэлжилсэн эрэл хайгуул юм. Үүнийг ашиглаж сурсан хүмүүст энэ нь гайхалтай бэлэг юм. Хэрэв бид тунгаан бодох бэлгийг ашиглавал мэдлэг, гүн ойлголт мөн бодит хэрэгжилтийг олдог” (“There Are Many Gifts,” *Ensign*, 1987 оны 11-р сар, 20).



2. Судар судлах тэмдэглэлдээ дараах нэг эсвэл хоёр асуултад хариул:



а. Мормоны Номыг уншихдаа тунгаан бодох нь Ариун Сүнсийг мэдрэхэд танд хэрхэн тусалсан бэ?

б. Судруудыг судлахдаа та илүү ойр ойрхон мөн үр ашигтай тунгаан бодохын тулд юу хийж болох вэ?

“Зүрх сэтгэлээсээ, үнэн хүсэлтэйгээр, Христэд итгэх итгэлтэйгээр асуу”

Хүмүүс “зүрх сэтгэлээсээ мөн үнэн хүсэлтэйгээр” гэдэг нь тэд “Бурханаас хүлээн авсан хариултыг үнэн хүсэлтэйгээр үйлдэнэ гэсэн үг юм” (*Миний сайн мэдээг номло* [2004], 126).


Родолфо Армандо Пэрэз Бонилла хэмээх залуу үнэн хүсэлтэйгээр залбирахын ач холбогдлыг сурсан. Тэрээр найман настайдаа баптисм хүртжээ. Гэвч түүний гэр бүл сүмд идэвхгүй байсан ажээ. Тэрээр өсвөр насандаа сайн мэдээний тухай бодож эхэлсэн бөгөөд дараах туршлагыг олж авчээ:


Би хааяа юу зөв болохыг мэдэхийн төлөө залбирдаг байсан ч энэ нь ихэвчлэн чин сэтгэлийн асуулт гэхээсээ илүү урсан өнгөрөх бодол төдий байдаг байсан. Тэгээд нэг үдэш би “үнэн сэтгэлээсээ” залбирахаар шийдсэн юм.

Би Тэнгэрлэг Эцэгт Түүнийг мэдмээр байгаагаас бас Түүний үнэн сүмийн хэсэг баймаар байна гэж хэлсэн. Би “Хэрэв Та надад Иосеф Смит жинхэнэ бошиглогч байсан эсэхийг мөн Мормоны Ном үнэн эсэхийг мэдүүлэх юм бол Таны надаас хүсэж байгаа юуг ч би хийх болно. Хэрэв Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм нь үнэн бол Би үүнийг дагаж хэзээ ч бууж өгөхгүй” гэж амласан юм.

Надад гайхамшигтай үзэгдэл ирээгүй ч би амар амгаланг мэдэрч, унтахаар хэвтсэн. Хэдэн цагийн дараа би “Иосеф Смит бол жинхэнэ бошиглогч, Мормоны Ном бол үнэн” гэсэн өөр бодолтойгоор сэрсэн. Уг бодолтой хамт дүрслэхийн аргагүй амар амгалангийн мэдрэмж ирж билээ. Би дахиж унтаад дараа нь мөн л нөгөөх бодол, мэдрэмжтэйгээр дахин сэрэв.

Тэр үеэс хойш би Иосеф Смит бол жинхэнэ бошиглогч гэдэгт хэзээ ч эргэлзээгүй юм. Энэ нь Аврагчийн ажил гэдгийг мөн Тэнгэрлэг Эцэг бидний чин сэтгэлийн гуйлтуудад хариулдаг гэдгийг би мэднэ (“How I Know,” *Ensign*, 2011 оны 10-р сар, 64).

 **3.** Мормоны Номын үнэний хэр хүчтэй гэрчлэлтэй болмоор байгаагаас бод. Мормоны Номын гэрчлэлийг хүлээн авахын тулд аль хэдийн хийсэн зарим нэг зүйлүүдээ судар судлах тэмдэглэлдээ бич. Тэгээд та Мормоны Номын илүү хүчтэй гэрчлэл хүлээн авахын тулд юу хийж болохоо бич.



Моронай 10:4-ийг судлаад Моронай унших, санах, тунгаан бодох мөн асуух үйл явцыг дагах тэдэнд Бурхан юу хийнэ гэж гэрчилснийг тодорхойл. Та энэ амлалтыг судрууд дээрээ тэмдэглэж болох юм. (Моронай 10:4–5 нь төгс эзэмших судар юм.)

Моронай 10:5–7-г уншаад Моронай Ариун Сүнсээр дамжуулан бид өөр юу мэдэж болно гэж амласныг ол.

Моронай 10:3–7-р шүлгүүдээс бидний сурч болох нэг зарчим бол: **Хэрэв бид итгэлтэйгээр эрэлхийлбэл Мормоны Номын болон Есүс Христийн гэрчлэлийг Ариун Сүнсээр дамжуулан хүлээж авч чадна.** Та үүнийг эдгээр шүлгүүдийн дэргэд судрууддаа бичиж болох юм.

 **4.** Дараах зүйлийг судар судлах тэмдэглэлдээ хий:

а. Унших, санах, тунгаан бодох мөн залбирах нь энэ жил Мормоны Номын гэрчлэлийг тань хэрхэн хүчирхэгжүүлснийг мөн Мормоны Номын заадаг үнэнүүд энэ номын талаарх гэрчлэл хүлээн авахад тань хэрхэн тусалсныг бич.

б. Мормоны Ном үнэн гэдгийг мөн сайн мэдээний бусад үнэнүүдийг гэрчилсэн Ариун Сүнсийг мэдрэснээ бод. Ихэнх илчлэлт нь гайхамшигт арга замаар ирдэггүй гэдгийг санах нь чухал юм. Ихэнх хүмүүс дулаан, амар тайван мэдрэмж

эсвэл үнэний баттай байдал зэрэг Ариун Сүнсний намуун, зөөлөн өдөөлтүүдийг мэдрэх болно. Ариун Сүнс бидэнд сайн мэдээний үнэнүүдийг бага багаар гэрчилж, цагийн аясаар аажмаар ойлгоход маань туслах болно. Ариун Сүнсний гэрчлэхийг мэдэрсэн үеийнхээ тухай бич.

Моронай 10:27–29

Моронай Бурханы шүүлтийн суудлын өмнө бидэнтэй уулзана гэж гэрчлэв

Моронай 10:27–29-ийг уншаад эдгээр шүлгүүд нь хэрхэн дараах зарчмыг зааж буйг бод: **Мормоны Номыг хүлээн авсан тэд үүнд хэрхэн хандсанаараа Бурханы өмнө хариуцлага хүлээх болно.** Бурханы шүүлтийн суудлын өмнө Моронайтай уулзах боломжтой байна гэж төсөөл. Мормоны Номын тухай та түүнд юу хэлэх байснаа мөн энэ нь таны амьдралд хэрхэн нөлөөлснийг тунгаан бод.

📖 Төгс эзэмших судар—Моронай 10:4–5

Моронай 10:4–5-ыг цээжлэх нь Мормоны Номын захиасыг бусадтай хуваалцахад тань их тус болж болох юм. Одоо үг бүрчлэн цээжлэх цаг гарга. Үүнийг хийж болох нэг арга нь шүлгийг хэд хэдэн удаа чангаар унших явдал юм. Дараа нь тэдгээрийг үг үгээр нь цаасан дээр эсвэл судар судлах тэмдэглэлдээ гурван удаа бич. Дууссаныхаа дараа эдгээр шүлгүүдийг цээжээр хэлж чадах эсэхийг үз.



5. Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Моронай 10:1–7, 27–29-р шүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна:

32-Р ХЭСЭГ: 4 ДЭХ ӨДӨР

Моронай 10:8–26, 30–34

Оршил

Моронай Ариун Сүнсээр дамжуулан бүх зүйлийн үнэний гэрчийг хэрхэн хүлээж авах тухай заасныхаа дараа түүний үгсийг унших тэдэнд сүнслэг бэлгүүдийг танин мэдэж, хүлээж авахыг ухуулжээ. Моронай бүх хүмүүнийг Есүс Христэд ирж, Түүний өгөх сайн бэлэг болгоноос зууран барьж, Түүгээр

дамжуулан төгөлдөржихийг ухуулан Мормоны Номын цэдгийг төгсгөл болгов.

Моронай 10:8–26

Моронай Сүнсний бэлгүүд болон тэдгээрийн Их Эзэний ажил дахь зорилгын тухай заав

Та өөрөө хийж чадахааргүй зүйлийг Тэнгэрлэг Эцэг боломжтой болгож өгсөн үеийн талаар бод. Энэхүү төгсгөлийн бүлэгт Моронай Их Эзэн бидэнд өгч болох тусламж болон хүчийг гэрчлэв. Моронай 10:8-ыг уншаад Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүддээ өгдөг сүнслэг чадварууд эсвэл бэлгүүдийг дүрсэлдэг хэллэгийг ол.

Моронай 10:8-д Моронайн өгүүлсэн “Бурханы бэлгүүд” нь түүнчлэн “Сүнсний бэлгүүд” эсвэл “сүнслэг бэлгүүд” гэж нэрлэгддэг. Та судартаа “Бурханы бэлгүүд” хэмээх хэллэгийг тэмдэглэж болно. Судартаа Моронай 10:8-ын хажууд дараах үнэнийг бич: **Бурхан Өөрийн хүүхдүүдэд тус болохын тулд Сүнсний бэлгүүдийг өгдөг.** “Өөрийн хүүхдүүдэд тус болох” хэмээх хэллэг нь Өөрийн хүүхдүүдэд үйлчлэх, тэтгэх гэсэн утгатай.

Моронай 10:9–16-г уншаад Моронайгийн өгүүлсэн сүнслэг бэлэг бүрийг тэмдэглэ. Моронайгийн өгүүлсэн сүнслэг бэлгүүд нь бүхий л сүнслэг бэлгүүдийн хэдхэн жишээ юм гэдгийг мэдэх нь чухал. Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Марвин Ж.Эштон “Бурхан бидний хүн нэг бүрд нэг юмуу түүнээс олон онцгой авьяас чадварыг өгсөн” гэж заажээ:



“Миний хувьд амьдралын агуу эмгэнэлүүдийн нэг нь хүн өөрийгөө ямар ч авьяас чадвар, бэлэггүй хүн хэмээн тооцох явдал юм гэж санагддаг. . . . Бид бие бялдар, оюун ухаан, сурлагын дүнгийн голч, хөрөнгө чинээ, хүч чадал, албан тушаал, гадаад үзэмжээрээ өөрсдийгөө шүүн ямар ч бэлэггүй хэмээн дүгнэдэг нь шударга биш байгаад зогсохгүй үндэслэлгүй зүйл юм. . . .

“ . . . Үргэлж ил тод, анхаарал татахуйц байдаггүй ч маш чухал хэдэн бэлгийг би нэрлэе. Эдгээр бэлгүүд дунд ил тод биш ч жинхэнэ бөгөөд үнэ цэнэ бүхий танд байдаг бэлгүүд байж болно.

“Төдийлөн ил харагддаггүй зарим бэлгүүдийн талаар ярилцъя: асуух бэлэг; сонсох бэлэг; намуун, зөөлхөн дуу хоолойг анхааран сонсож, ашиглах бэлэг; уйлах чадвартай байх бэлэг; зөрчил сөргөлдөөнөөс зайлсхийх бэлэг; бусадтай эв нийцтэй

байх бэлэг; хоосон давталтаас зайлсхийх бэлэг; зөв шударга зүйлсийг эрэлхийлэх бэлэг; бусдыг шүүхгүй байх бэлэг; Бурханаас удирдамж хүсэх бэлэг; шавь байх бэлэг; бусдад анхаарал халамж тавих бэлэг; тунгаан бодох чадвартай байх бэлэг; залбирал хэлэх бэлэг; хүчирхэг гэрчлэл үлдээх бэлэг; Ариун Сүнийг хүлээн авах бэлэг.

“Хүн бүрд Бурханы Сүнсээр бэлэг өгөгдсөн байдгийг бид санах ёстой [С ба Г 46:11–12-ыг үзнэ үү]. Бэлгүүдээ хүлээн зөвшөөрч, хуваалцах нь бидний эрх ба үүрэг юм. Бурханы бэлэг болон хүчүүд бид бүгдэд боломжтой байдаг” (“There Are Many Gifts,” *Ensign*, 1987 оны 11-р сар, 20).

Моронай 10:17-г уншаад сүмийн итгэлтэй гишүүн бүр доод тал нь нэг сүнслэг бэлэгтэй байдаг гэсэн Моронайн заасан зүйлийг анхаар (С ба Г 46:11). Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Роберт Д. Хэйлс ийн заажээ: “Сүнсний бэлгүүд нь . . . мөнх амьдралын зорилгодоо хүрэхэд нь хүн бүрд тусална.



“Эдгээр Сүнсний бэлгүүд нь Ариун Сүнсний бэлэгт багтдаг. Ариун Сүнс нь мөнхийн Бурхан Тэргүүтэний гурав дахь гишүүн бөгөөд Ариун Сүнс хэмээн тодорхойлогддог. Энэхүү Ариун Сүнс нь өөрсдийн үүргийг олж, биелүүлэхийг боломжтой болгох шийдвэрүүдийг гаргахад бидэнд туслах Бурханаас ирсэн бэлэг юм. . . .

“Эдгээр хожмын өдрүүдэд Сүнсний бэлгүүдийн тухай ойлголт нь Сургаал ба Гэрээний 46-р хэсэгт цэдэглэгдсэн илчлэлтээр бидэнд өгөгдсөн. 46-р хэсэг дараах тодорхой Сүнсний бэлгүүдийг тодорхойлдог:

“Учир нь бүгдэд бэлэг бүхэн өгөгддөггүй; учир нь олон бэлэг байдаг, мөн хүн болгонд Бурханы Сүнсээр бэлэг өгөгддөг болой (11-р шүлэг).

“Хүн бүрд нэг юмуу түүнээс олон бэлэг өгөгдсөн гэж бидэнд тодорхойгоор заажээ. Бидэнд ямар бэлэг өгөгдсөнийг бид мэддэг үү? Бид бэлгүүдээ олохыг эрэлхийлж байгаа юу?” (“Gifts of the Spirit,” *Ensign*, 2002 оны 2-р сар, 12).



1. Бурханаас хүлээж авсан сүнслэг бэлгүүдийнхээ тухай бод. Тэгээд дараах асуултуудын хоёрт нь эсвэл бүгдэд нь судар судлах тэмдэглэлдээ хариулж бич:

а. Та хүлээж авсан Сүнсний бэлгүүдээсээ хэрхэн ашиг тус хүртсэн бэ?

б. Та өнөөдөр сүмд сүнсний бэлгүүдийн ямар ямар жишээ харсан бэ?

в. Та бусдын амьдралыг адислахын тулд сүнслэг бэлгээ хэрхэн ашиглаж болох вэ? Таны амьдрал бусдын бэлгүүдээр хэрхэн адислагдсан бэ?

Мормоны Ном урагш гарч ирэхэд сүнсний ямар бэлгүүд харагдаж байсныг эргэцүүлэн бод. Дараах хоосон зайд, зурганд үзүүлсний дагуу Иосеф Смитийн амьдралд харагдаж байсан сүнсний бэлгүүдийг тодорхойлон бич:



Моронай 10:11 _____




Моронай 10:14 _____




Моронай 10:16 _____


Бид сүнсний бэлгүүдийг хүлээн авахын тулд итгэлтэй байх ёстой хэмээн Моронай гэрчилсэн. Бурхан “хүмүүний үрсийн итгэлийн дагуу хүчээр үйлддэг, өнөөдөр мөн маргааш, мөн үүрд хэвээр бөлгөө” хэмээн тэр заасан (Моронай 10:7). Моронай 10:19, 24-ийг уншаад хүмүүс сүнслэг бэлгүүдийг танин мэдэж, хүлээн авахад юу саад болдгийг тодорхойл.

 **2.** Таны бодлоор итгэлгүй байдалд байгаа хүмүүс яагаад Бурханы хүч болон бэлгүүдийг танин мэдэж, хүлээн авч чаддаггүйг судар судлах тэмдэглэлдээ бич.

Моронай 10:20–23-ыг унш. Моронай итгэл, найдвар, энэрэл гэсэн чухал сүнслэг бэлгүүдийн тухай юу заасныг ол. Тэрээр итгэлийн сүнслэг бэлэг нь гайхамшигтай адислалууд руу хөтөлдөг хэмээн гэрчилсэн. Энэ адислалыг олохын тулд 23-р шүлгийн үз. *Зохистой* гэдэг үг нь “хүсүүштэй”, “миний хувьд зохистой болох аливаа зүйл” хэмээх хэллэг нь “миний чамаар хийлгэхийг хүсэх бүх зүйл” гэсэн утгатай болохыг анхаар. Моронай 10:23-т энэ зарчмыг заасан өгүүлбэрийг тэмдэглэх хэрэгтэй: **Хэрэв бидэнд итгэл байвал бид Тэнгэрлэг Эцэгийн биднээр хийлгэхийг хүссэн зүйлсийг хийх боломжтой байна.**

 **3.** Энэ зарчим таны амьдралд хэрхэн биелсэн эсвэл биелж болохыг олж харахын тулд дараах өгүүлбэрдийн нэг юмуу хоёуланг нь судар судлах тэмдэглэлдээ гүйцээж бич:

- а.** Би Моронай 10:23 дахь амлалтыг . . . байхдаа мэдэрсэн.
- б.** Моронай 10:23 дахь амлалт надад . . . -д тусалж чадна.

 **4.** Моронай 10:8–26-аас сурсан хоёр зарчмынхаа тухай бод: **Бурхан Өөрийн хүүхдүүдэд туслахын тулд Сүнсний бэлгүүдийг өгдөг. Хэрэв бидэнд итгэл байвал бид Тэнгэрлэг Эцэгийн биднээр хийлгэхийг хүссэн зүйлсийг хийх боломжтой байна.** Дараах асуултуудад судар судлах тэмдэглэлдээ хариулж бич:

- а.** Энэ хоёр зарчмыг мэдэх нь яг одоо таны амьдралд хэрхэн туслах вэ?
- б.** Эдгээр зарчмууд ирээдүйд ирж болох боломжуудад тань хэрхэн тусалж болох вэ?

Моронай 10:30–34

Моронай бүх хүмүүнийг Христэд ирж, Түүгээр төгөлдөржихийг урьснаар цэдгээ төгсгөв



Энэ амьдралд төгс байх нь боломжтой гэж та бодож байна уу? Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх, Ерөнхийлөгч Жэймс Э. Фауст төгс болох зарлигийг тайлбарлажээ: “Төгс төгөлдөр байдал нь мөнхийн зорилго юм. Мөнх бус байдалд төгс байж чадахгүй ч үүний төлөө зүтгэх нь зарлиг бөгөөд Цагаатгалаар дамжуулан бид уг зарлигийг сахих боломжтой” (“This Is Our Day,” *Ensign*, 1999 оны 5-р сар, 19).

Ерөнхийлөгч Фаустын зааснаар бид төгс байдлыг зорилгоо болгон үүндээ хүрэхийн тулд хичээх боломжтой бөгөөд Аврагчийн тусламжтайгаар ирэх амьдралд уг зорилгодоо хүрч чадна. Бид одоо Аврагчийн цэвэршүүлэх хүчийг амьдралдаа урьж, Түүний Цагаатгалаар дамжуулан эцэст нь төгс болохын тулд юу хийж чадахыг Моронай зааж, өөрийн гэрчлэлийг төгсгөл болгожээ.

 **5.** Дараах хүснэгтийг судар судлах тэмдэглэлдээ зур:

Би юу хийж чадах вэ?	Бурхан юу амладаг вэ?

Моронай 10:30–33-ыг судлаад (а) бид цэвэр, яваандаа төгс болохын тулд юу хийх ёстойг, (б) Бурхан бидэнд туслахын тулд юу хийнэ гэж амласныг ол. Хүснэгтийнхээ тохирох баганад олсон зүйлсээ бич.

Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ хүснэгтийн доод талд эсвэл судартаа Моронай 10:32–33-ын хажууд бич: **Бид Есүс Христэд ирэх үедээ Түүний Цагаатгалаар дамжин цэвэршигдэж, төгс болгогдох боломжтой.**

Христэд ирэх гэдэг нь Түүнд итгэж, амьдралдаа Түүний нөлөөг даруухнаар эрэлхийлснээр эхэлдэг амьдралын турш үргэлжлэх үйл явц юм. Уг үйл явц нь Түүний сайн мэдээг хүлээн авч, Түүнийг өөрийн Аврагч хэмээн хүлээн зөвшөөрч, наманчилж, сайн мэдээний ёслолуудаар дамжуулан Түүнтэй гэрээ хийж, амьдралынхаа турш Түүний зарлигуудад дуулгавартай, итгэлтэйгээр эцсээ хүртэл тэвчсэнээр үргэлжилдэг. Эцэст нь бид Түүний нэгэн адил болох үед Христэд ирдэг бөгөөд дараа нь бид Түүнтэй хамт мөнхөд амьдрах боломжтой болно.

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Жэффри Р.Холланд Моронай 10:30–33-т гардаг Христэд ирэхэд урьсан Моронайн эцсийн урилгыг тоймлон хэлсэн байдаг:



“Моронайн [эцсийн гэрчлэл нь] Христэд итгэх итгэл, Христэд найдах найдвар, Христийн энэрэл буюу энэ гурван Христийн ариун журам, Христийн энэ гурван бүрэн төгс зарчим нь залбирлын хамт биднийг цэвэр болоход удирдах болно гэдгийг онцлон харуулдаг. . . .

“Манай шашны тулгуурын чулуу, бичигдсэн бүхий л номуудаас хамгийн зөв номын эцсийн, сүүлчийн, ганц уриа бол цэвэр бус зүйлд бүү хүр гэсэн уриа юм. Энэ нь ариун, толбогүй, цэвэр байх ёстой. Цэвэр ариун байдал нь зөвхөн бидний зовлон гунгийг хуваалцаж, харууслыг маань өөртөө авсан Хурга, бидний зөрчлийн улмаас шархадсан, бидний алдсын улмаас гэмтсэн Хурга, доромжлуулж, харгислуулсан боловч бидний хүндлээгүй тэрхүү Хурганы цусаар дамжин ирэх боломжтой юм (Мозая 14-ийг үзнэ үү). . . .


“Цэвэр ариун байдал нь Хурганы цусаар дамжин боломжтой болсон. Энэ чинь л [Мормоны Номын] хүсч байгаа зүйл юм” (“A Standard unto My People” [CES symposium on the Book of Mormon, 1994 оны 8-р сарын 9], 15, si.lds.org).

Моронай 10:32–33-ыг дахин уншаад бид төгс байж чадах ганцхан зам бол “Христэд” төгс байх юм гэдгийг онцлон харуулсан хэллэгүүдийг тэмдэглэ. Энэ нь бид өөрсдөө төгс байдалд хүрч чадахгүй гэсэн үг бөгөөд бид Аврагчийн Цагаатгалын хүч болон нигүүлсэлд тулгуурлах ёстой. Бид цэвэр ариун, төгс төгөлдөр болоход яагаад Есүс Христийн Цагаатгал хэрэгтэйг тунгаан бод. Моронай 10:32–33-аас цэвэр байдал болон төгс болох мөнхийн зорилгод хүрэхэд хичээхийг урамшуулсан хэллэгүүдийг олж тэмдэглэ.

Судар судлах тэмдэглэл дэх хүснэгтийнхээ “Би юу хийж чадах вэ?” хэсэгт юу бичсэнээ эргэн хар. Бичсэн нэг үйлдлээ сонгож, амьдралынхаа тэр хэсэгт хэрхэн илүү хичээнгүй байх тухайгаа тунгаан бод.



Моронай 10:34-ийг уншаад Есүс Христэд итгэх Моронайн итгэл, мөнх амьдралыг хүлээж авах найдварыг нь харуулсан нотолгоог ол. Бид ч бас Мормоны Номыг судлах явдлыг амьдралын зорилгоо болгон үүнд заагдсан үнэнүүдийг хэрэгжүүлбэл итгэл, найдвартай байж чадна.

 **6.** Мормоны Номын сургалтын явцын төгсгөлд дараах асуултуудад судар судлах тэмдэглэлдээ хариулж бичээд хариултаа багштайгаа хуваалцахад бэлдээрэй.

а. Энэ жил Мормоны Номыг судлахад таны амьдралд ямар өөрчлөлт гарсан бэ?

б. Ямар хичээл эсвэл зарчмууд “Христэд ирэхэд” тань, Аврагчид итгэх итгэлээ хүчирхэгжүүлэхэд тань тусалсан бэ?

в. Мормоны Номын талаарх таны гэрчлэл юу вэ?

 **7.** Дараах өгүүлбэрийг судар судлах тэмдэглэлдээ өнөөдрийн даалгаврынхаа доор бич:

Би Моронай 10:8–26, 30–34-р шүлгүүдийг судалж, энэ хичээлийг (огноо)-нд дуусгалаа.

Би дараах асуулт, бодол санаа ба ойлголтуудыг багштайгаа хуваалцахыг хүсч байна: